

Зли Рун



ЭЛХИЙН  
СОНГОДОГ  
ЗОХИОЛ



# ЧОНОН СҮЛД

狼图腾

MGW  
BUDAR

**Зян Рун**

**Чонон сүлд**

## Монгол орчуулгын өмнөх үг

“Чонон сүлд” роман Англи, Франц, Герман, Япон, Итали, Испани зэрэг гуч гаруй хэл дээр хэвлэгдсэний дараа Монгол улсад кирилл үсгээр орчуулагдан гарч байна. Энэ нь монгол чонын соёл өөрийн уугуул оюун санааны эх нутаг болсон Монголын талдаа эргэн очиж байгаа гэсэн үг юм. Үүнд би баярлавч баршгүй санагдаж байгааг өгүүлэх юун.

2004 онд “Чонон сүлд” зохиол хятадад хэвлэгдсэн гарсаны дараа ширүүн маргаан дэгдсэн боловч уншигчид халуун талархалтай хүлээн авсанаар Хятадад ойрын жилүүдэд гараагүй гүйлгээтэй номын нэг болж билээ. Тэрчлэн олон улсын зах зээл дээр ч томоохон нөлөө үзүүлсэнийг дурдах нь илүүц биз ээ. Гэсэн атал би өөрийн энэ номыг монгол уншигчдын хайртай бүтээл болоосой гэсэн бодол өвөрлөсөөр өдий хүрсэн билээ. Тийм ч учраас хятад хэлээр хэвлэгдсэн “Чонон сүлдийн” дотор хавтсан дээр “Гарамгайгаараа гайхагдсан тал нутгийн чоно хүн хоёрт болон урьд өмнө үзэсгэлэнт байдлаараа шагшигдаж байсан Өвөр Монголын их талд энэ номыг зориулав” гэж ултай онцлон бичиж байсансан. Тэгвэл кирилл монгол хувилбарын эхэнд “Үзэмж төгөлдөр эрх чөлөөт байдлаа хадгалсаар байгаа Монгол улсын их тал нутагт энэ номыг зориулав” гэж бичмээр санагдлаа.

1967 онд би Бээжин хотоос Хятадын Өвөрмонголын Зүүн Үзэмчин хошууны хил орчмын тал нутагт анх очиж тэнд өөрийн залуу зандан насаа үдэж билээ. Хонины хишигтэй өдрөө алсад сүүмийн харагдах Монгол улсын уулс үүлсийг бараалан харна. Хааяа малчидтай хамсан ганц нэг чоныг элдсээр хил давуулан орхиход өндөр довцгийн орой дээр гарчихаад бидэн рүү эргэн харж байдагсан. Улсын хил хэдийгээр монгол талыг зааглах боловч чонон сүлд болон “Тэнгэрийн нохойн” үзэл санааг тасдан хувааж чадаагүй юм.

Би тал нутагт өнгөрүүлсэн 11 жилийн амьдрал болон монгол малчидтай тогтоосон найсаг дотно харилцаагаа энэхүү “Чонон сүлд” хэмээх романд бичиж оруулсан. Хэдийгээр би хятад хүн боловч монголын уудам тал, монголчууд болон талын хөх чононд чин сэтгэлээс хайртай байдаг.

Би аль эртнээс өөрийн оюун санааны төрсөн нутаг хэмээн үзсээр ирсэн болохоор монголын уудам тал болвоос миний насан үүрд мартаж чадахгүй гэр орон минь билээ.

Би монголын тал болон чонын соёлд халуун хайртай болсон нь түүний байгалийн гайхалтай үзэмжид автаад зогсоогүй, нүүдэлчин соёлын ухамсарт түүнээс ч илүү үнэ цэнэтэй зүйлс байгааг ойлгож ухаарсан хэрэг. Тэр нь нэг талаас чөлөөт бие даасан ухамсрыг шаргуу дээдлэхийн зэрэгцээ нөгөө талаар хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах тал дээр хувь хүний ухамсар тод илэрдэгт байгаа юм. Эдгээр нь чухам л хятадын уламжлалт тариачны соёл болон Күнзийн сурталд сох дутагдаж байдаг ухамсар билээ.

Соёлын хувьсгалын хатуу хүтүү сургамжийг амссаны дараа Хятад улс чөлөөт оюун санааны үнэ цэнийг бага сага ухаарч, эдийн засгийн салбарт өөрчлөлт явуулан, чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Гуч гаруйхан жилийн ахар богино хугацааны дотор хятад орон эдийн засгийн хувьд дэлхий нийтийг гайхашруулсан том дэвшлийг хийж чадав.

Гэсэн хэдий ч хятадын эдийн засгийн түргэн хурдацтай хөгжил тус орны экологийг ноцтой эвдэн сүйтгэсний зэрэгцээ улс төрийн эрх чөлөөний үр хөврөл хараахан гүйцэд боловсроогүй, чөлөөт дэвшилтэт ухамсрыг цаашид ч түлхүү оруулж бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн, нийт үндэстний байгаль хамгаалах ухамсрыг дээшлүүлэх хэрэгтэй байгаа юм.

“Чонон сүлд” ном хэвлэгдэн гарсанаар хятадуудын монголын нүүдэлчин соёл болон чонын соёлын уламжлалын талаарх өрөөсгөл хандлага ямар нэгэн байдлаар өөрчлөгдөж, хятад монгол хоёр үндэстэн түүхэн хувьслын учир шалтгааныг мөшгин ойлгож улмаар бие биесийн соёлыг ухааран харилцан хүндэтгэснээр хоёр орны найрамдлыг бэхжүүлэхэд тустай хэрэг болох нь дамжиггүй.

Францын кино найруулагч Жан Жак Аннойдын найруулж буй “Чонон сүлд” хэмээх кино зураг авалтын шатандаа ид явагдаж байна. Аннойд найруулагч “Чонон сүлдийг” дэлхийн хэмжээний кино болгож монголын нүүдэлчин соёлын гайхамшгийг дэлхий дахинд илтгэн харуулна гэдэгтээ итгэл дүүрэн ажиллаж байгаа. Тэгснээр удтал дуу шуугүй байсан монгол чоно дэлхий даяар өөрийн улианыг удтал уянгалуулах нь гарцаагүй.

“Чонон сүлд” болвоос уран зохиолын бүтээл болохоос биш, амьтан судлалын сурах бичиг биш юм шүү гэдгийг тайлбарлан хэлэхийг хүсэж байна. Энэ зохиолд би Шилийн голын талд удаан хугацаанд амьдрахдаа өөрийн биеэр үзэж туулсан бүхнийг багтаан хожим нь бодит баримтан дээр тулгуурлан боловсруулалт хийсэн болно. (Би хоёр метр урт чонын туламлан өвчсөн арьс үзэж байсан болохыг өнөө хэр нутгийн зарим хөгшид гэрчлэх буй за.) Монголын тал нутаг өргөн уудам болохоор дорно өрнө умард өмнөдийн газар зүйн хэв маяг, ургамал амьтны онцлог шинж зэргийн хувьд мэдээжийн хэрэг зарим нэгэн ялгаа байлгүй яахав.

Эцэст нь дэлхийн банкны ажилтан ноён Тони миний “Чонон сүлд” зохиолыг сонирхон таашааж, дэлхийн банкны зүгээс тус романы кирилл монгол орчуулгын зардал дээр бүхий л талаар дэмжиж тусласан явдалд гялайснаа илэрхийлэх нь зүйтэй. Гадаад орноос хятадад байнга оршин суудаг хятад судлаач хатагтай Брайн бидний ажилд халуун сэтгэлээр туслаж байсанд талархал илэрхийлье. Тус номыг ихэд сонирхон дэмждэг Монгол улсын үндэсний номын сангийн захирал ноён Аким, “Чонон сүлдийн” монгол орчуулгыг гүйцэтгэсэн Д.Болдбаатар, хянан тохиолдуулсан Г.Мэнд-Ооёо болон тус номын хэвлэлтэнд санаа тавин оролцсон нийт монгол анд нөхөддөө халуун талархлыг өргөн дэвшүүлж байна.

*Зян Рун*

*2010 оны 3 сар Бээжин хот*

## Орчуулагчийн өмнөтгөл

Хятадын 2005 оны хамгийн шилдэг зохиолоор шалгарч, монгол хэлийг оролцуулан дэлхийн 32 улсын хэлээр хэвлэгдэн гараад байгаа “Чонон сүлд” романы дэлгэрэнгүй хувилбарыг та бүхний гар дээр өргөн барьж байгаадаа их баяртай байна. “Чонон сүлд” роман нийт хураангуй, дэлгэрэнгүй, хүүхэд залуучуудад зориулагдсан “Бэлтрэгхэн” гэсэн гурван хувилбартай байдаг юм.

2005 оны эхээр хятадын хэвлэлүүдээр энэ номын тухай шүүмжүүд тасралтгүй нийтлэгдэн “Сарын дотор дөчин мянган хувь борлогдлоо”, “Хэвлэгдсэнээс хойш тавхан өдрийн хойно хуурамч ном нь хэвлэгджээ”, “Хятадын төр засгийн тэргүүнүүд энэ номыг шимтэн уншиж байна” гэлцэн шуугилдаж эхлэх болсон нь мөхөс бичээч миний анхаарлыг өөрийн эрхгүй татаж хятадад ажлаар очихдоо нэгийг худалдан авч билээ.

Зохиолч өөрөө хятад улсын хамгийн олон тоот Хань үндэстний төлөөлөл атлаа цөөн тоот нүүдэлчдийн байр суурийг хамгаалан суурьшмал тариачин үндэстнүүд ялангуяа хятадуудыг хоньтой, монгол зэрэг нүүдэлчдийг чонотой зүйрлэн бичсэн энэхүү романыг хятадын нийгэм ийм уриалгахан хүлээн авч буй нь тус улсын хэвлэлийн эрх чөлөө ихээхэн урагшилж байгаагийн илрэл байж таарна гэсэн бодол юуны өмнө төрж байсныг хэлэх юун. Тэгээд энэ сонирхолтой зохиолыг хурдан орчуулж монгол уншигчдынхаа оюуны мэлмийд хүргэхсэн гэж хүсэвч ажил төрөл, цаг завын боломж олдохгүй байсаар нэлээд хугацааг ардаа орхисон байлаа. Харин азаар өнгөрсөн оны намар Дэлхийн банкны байгаль орчныг хамгаалах төслийн ажилтнууд тус романыг орчуулах санал тавьсан нь ёстой загатнасан газар маажихтай адил хэрэг болж билээ.

Дэлхийн олон оронд “Чонон тотем” нэрээр алдаршсан тус номыг “Чонон сүлд” хэмээн орчуулсаны учрыг уншигч та бүхэн төвөггүй гадарлаж буй биз дээ. Юуны өмнө энэ роман нь монгол ахуй, монгол чоно, монгол ухаан, чонон сүлд, тал нутгийн гүн ухааны тухай зохиол болохоор “Тотем” хэмээх индиан гаралтай үгээр нэрлэх нь зохимжгүй гэдгийг бодолцсон хэрэг.

“Хамгийн сайхан ваарыг

Жирийн шавраар урладаг

Хамгийн сайхан шүлгийг

Ердийн үгээр л бичдэг” хэмээн Расул Гамзатов найрагч шүлэглэсэн нь буй. Хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөний онцлог, аргал хоргол, таван хошуу малын тус тусын гүйцэтгэх үүрэг зэрэг монгол хүн бүрийн сайн мэдэх ахуй амьдралын холбоотой мэдлэгийг уран сайхны аргаар сонирхолтой өгүүлэмж болгон дүрсэлсэн нь адал явдлын ангуучлал, хэт уран сэтгэмжийн үерт залхчихаад байгаа дэлхий нийтийн уншигчдыг байлдан дагуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн болов уу гэсэн сэтгэгдэл орчуулгын ажлыг гүйцэтгэх зуур төрж байлаа. Азаар монгол ахуй, монгол ухааны сэдэв далай мэт яндашгүй арвин болохоор манай зохиолчдод ч гэсэн энэ чиглэлийн бүтээлд хүчээ сорин дэлхийн тавцанд өрсөлдөх орон зай хангалттай их байгааг энэ ном бидэнд харуулж байна. Харин тэднийгээ дэлхийн дайдыг

туулах гуурст хүлгэнд мордоход нь орчуулагч бидний үүрэг маш чухал гэдгийг энд онцолсу.

Нөгөө талаар энэхүү роман монгол хятадын дипломат харилцаа тогтоосны жаран жилийн ойг тохиолдуулан хэвлэгдэж байгаа нь тун ч цагаа олсон хэрэг мэт санагдана. Учир юун хэмээвээс энэ зохиолоор дамжуулан хятад хүний санаа бодол улмаар хятадын ард түмнийг ойлгож мэдэх, тэр хэрээр сүүлийн үед зарим нэгэн сонин хэвлэл, цөөн тооны хүмүүсийн санаатай, санаагүй дэвэргэн хөөргөдөөд байгаа хятадын эсрэг буруу ташаа ойлголтыг засаж залруулахад ямар нэгэн хэмжээгээр тус нэмэр болох нь гарцаагүй юм.

Сүүлийн үед байгаль дэлхийн ааш аяг өөрчлөгдөн ган гачиг, зуд турхан жил дараалан нүүрлэх болсон нь манай зарим дарга даамлууд, пүүс компаний эздийн хүчит жийп хөлөглөн, хурдан буугаар зэвсэглээд чоно авлах сайн дурын аяныг өрнүүлсэний гор гарч байгаа болохыг савшим ертөнцийн нарийн уялдаа холбоо, түүний гол гогцоо нь чухам чоно байжээ гэдгийг ой тойнд ортол өгүүлсэн энэ романыг уншсан хэн бүхэнд төрөх нь эргэлзээгүй юм.

Эцэст нь Зян Рун гуай “Чонон сүлд” романы монгол орчуулгын тухайд зохиолчийн эрх энэ тэрийн тухай яриа байхгүй хэмээн зарласан нь монголд хэр зэрэг элэгтэй хүн болохыг харуулж байгаа сайхан жишээ юм. Манай өмнөд хөрш Хятад улс бол оюуны зах зээлийн том гүрэн билээ. Энэ далай мэт том зах зээлээс уншигч олны оюуны мэлмийг гийгүүлэх дуслыг боловч олж ирэхсэн гэдэг нэгэн үзүүрт сэтгэлийг барин, “Дияан”, “Чингис хаан” роман (Чингис хаан олон ангит кинотой ижил агуулгатай), “Бэлтрэгхэн” роман, “Муухай хятад хүн” зэрэг цөөнгүй бүтээлүүдийг бэлэн болгоод ойрын үед уншигч та бүхний гар дээр тавихаар бэлтгэж байна. Тус номын орчуулгын алдаа мэдгийг ариутган шүүж өгсөн Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, номын ах Гомбожавын Мэнд-Ооёо болон бусад холбогдох хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье. Номын цагаан буян ашид арвижин дэлгэрэх болтугай.

*Хятад хэлний дуун хөрвүүлэгч доктор профессор*

*Доржсүрэнгийн БОЛДБААТАР*

*2010 оны 6 дугаар сар 19 –ний өдөр*

## Оршихуйн оюунлаг эрэлхийлэл

Өнөөдөр монгол орны өргөн уудам нутагт алт эрдэнэс, нүүрс, нефть эрж хайх, олборлох чиглэлээр өдий төдий гадаад дотоодын уул уурхайн компаниуд орчин үеийн хүчирхэг техникийн аржгар том дугуй эргэлдүүлэн, араа шүдийг нь эрчлүүлэн их дайралтанд орж эхлээд байна. Хориод жилийн өмнө онгон зэлүүд байсан хангай говь хээр талаар олон салаа замууд буй болж, хурдан “жип” машинууд сүлжилдэж, хуйларсан улаан тоос босгон давхилдаж байна.

Онгон зэрлэг байгалиа унаган төрхөөр нь авч үлдэх, олзворлон хөрөнгөжих хоёр туйл дээр тэмцэл өрнөж эхэллээ. Чухам яг ийм үед бидний түүхийн их хөрш Хятад улсын зохиолч Зян Рунгийн “Чонон сүлд” хэмээх роман монгол уншигчдад цагаа олж хүрч ирлээ.

Хятадын зохиолч Зян Рунгийн энэ зузаан ном нь шуурхай мэдээлэл, адал содон явдал, хурдан товч “комикс” ном даян дэлхийн уншигчдыг байлдан дагуулах болсон цаг үед өрсөлдөн гарч ирснээр барахгүй хятадын төдийгүй, дэлхийн бестселлэр болж байгааг дуулж мэдэх болсон цагаас хойш энэ номын тухай мэдээлэлд чих тавих болсон юм.

Аз болоход авьяаслаг орчуулагч Доржсүрэнгийн Болдбаатарын орчуулж буй “Чонон сүлд” романыг хянан тохиолдуулагчаар намайг сонгохоор болсонд би маш их олзуурхан баярлаж билээ.

Би бол монголын дорнод хээр талд төрж өссөн хүмүүн бөгөөд нутаг ус, газар шороо, байгал эх дэлхийгээ хайрлан ачлахын төлөө ихэнх уран бүтээлээ зориулсан нүүдэлч, малчин язгуурт зохиолч билээ. “Чонон сүлд” романы үйл явдал нь миний төрөлх нутаг болох Дарьгангын хээр талаас холгүй болж байна. Миний бие ихэнх насаа сургууль соёл ном эрдмийн мөр хөөж өнгөрөөсөн боловч, хээр талын нүүдэлчин ахуй, түүний олон мянган жилийн туршид бүтээн цогцлоосон оюун сэтгэлгээний болон соёлын үнэт зүйлсийг өвлөн уламжлахын төлөө үзэг цаасаа нийлүүлдэг зохиолчийн хувьд “Чонон сүлд” романы орчуулгын эхийг редакторын өөнтөгч нүдээр харахын зэрэгцээ, анхны уншигчийн баяр догдлолоор зохиогчийн зүрх сэтгэлийн зовнил шаналал, хайр бахархалыг илүүтэй мэдэрч уншихыг хичээсэн болой.

Дарьгангын хээр тал бол чонын эх орон билээ. Намайг бага байхад хааяа нэг малд орсон чоныг саахалт хотлын эрчүүл мориор өртөөлөн хөөж цуцаагаад ташуураар хоншоордон цохиж намнадаг байсныг тод санадаг юм. Харин хурдан тэрэг, хурц буу зэвсэг элбэгшсэн цаг үеэс, тал нутгийн бартаа саадгүй цэлгэр уудмыг ашиглан хээрийн чоныг арав хориор нь ангуучлан хийморьтой цог золбоотой яваагийн бахархал болгон тэнгэрийн нохойг амралт зугаалгын золиосонд гаргах болсон билээ. Тэгэхдээ тэд

Ижил тэнгэртэйд нь харагдана

Илүү тэнгэртэйд нь алагдана

гэсэн чонын өчил санааг уриа болгодог. Чухамдаа гэвэл энэ үг зөвхөн ангуучдад зориулсан үг биш, харин хүн чоно хоёрын хувь тавилан эн зэрэгцээ тэнгэрлэг оршихуйн учир утгыг илүү хадгалсан учир холбогдолтой юм. Монгол оронд малын дайсан чонотой тэмцэх хөдөлгөөн

нэг үе өрнөж, түүнийг үр үндэсгүй устгах тухай уриалга хөдөлгөөн ч гарч байхад нэгэн алдартай сайн малчин хүнийг сонор соргог байлгадаг хэмээн чоныг өмөөрч байсныг ч тэд санаж байна.

“Чонон сүлд” романы үйл явдал эдүгээгээс 40, 50-аад жилийн тэртээ өвөр монголын тал нутагт өрнөж байгаа боловч, монгол үндэстэн, хээр талын нүүдэлчиний мянга мянган жилийн ахуй амьдрал, оюун сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл, аж төрөхүйн үнэт зүйл болсон нүүдэлчний соёл иргэншлийг; хээр тал нутгийн удам талбай дээрх хүн чоно хоёрын харилцан бие биеэс хамааран оршин буйгаар нь дүрслэн үзүүлжээ. Тал нутгийн нүүдэлч малчдын амьдралын хэв маяг, тэдний ёс жудаг, байгаль дэлхий өвс ургамал, ан амьтантай зохицон амьдарч ирсэн зан үйлийн соёлыг нүдэнд үзэгдэж, гарт баригдахаар тов тодорхойёо, нэгд нэгдгүй бичиглэсэн нь бүүр ч сонирхолтой байна.

Хүн төрөлхтөний утга зохиол өнөөдөр реализмыг үеэ өнгөрөөсөн хэмээн тэртээ хол гээж орхиод бодит дүрслэхүй урт удаанаар нуршин өгүүлэхүйгээс тасран холдож өөр өөр шинэ хийсвэр “изм” рүү уншигчдыг хөтөлсөөр яваа яг ийм цаг үед энэ роман эрхгүйеэ мартагдан алга болж буй хэв маяг, бодит байдлыг гэрэл зураг мэт, кино дэлгэц мэт эргэн буй болгож буй бүхнийг үгээр дүрслэхүйн ид хавийг буцаан авчирсан нь ер гайхалтай. Зохиолын үйл явдал нь хүмүүний хувь тавилангийн ээдрээ, хайр дурлалын гурвалжин, ар араасаа хөвөрсөн адал явдал аль нь ч байхгүй, зүгээр л Өвөр монголын хээр тал дахь хүн байгалийн харилцаа, хүн хийгээд чонын тухай өгүүлэмж юм. Нэгэн бодлын ийм зохиол уйтгартай, уншигчдад залхуутай байж таарнаа даа. Гэтэл энэ зохиол тийм биш. Уншигчдыг чулуу хөөлгөх утга зохиолын сонгомол арга хэрэглүүрийг хэрэглээгүй мөртлөө, хуудас алгасаад явчихаж болохгүй, үг үсэгчилэн уншин мөрдөхөөс өөр аргагүй байдалд уншигчдыг хөтлөн орчуулчихаад огт гаргахгүй хөтлөх тийм нэгэн ид шид энэ романд байна.

Магадгүй, хүн төрөлхтөний шинжлэх ухаан, технологи, бүтээн байгуулалтын дэвшилийн үед, нөгөө талд нь байгаль дэлхий ноцтойгоор өөрчлөгдөн хувьсаж, дулаарал, мөстлөг, ган гачиг хийгээд хуурайшил, аль эсвэл зуд турхан, өвчин тахал, далайн шуурга, цөлжилтийн шар түйрэн хүн төрөлхтөнийг зовоож, орших эс оршихын түгшүүр эзэмдэж буй цаг үеийн дэнсэн дээр цагаа олж хүмүүний зүрх сэтгэл рүү энэ зохиолын үзэл санаа урсан орж ирээд, түгшүүр зовлонг нь хуваалцаж, зохиомол үйл явдалд залхсан уншигчдыг өөрийн эрхгүй амин чухаг зүйл рүү нь хөтөлж байгаад гол учир нь байх авай.

Зохиолч Зян Рунь гуай энэхүү романаараа хээр тал нутгийн онгон байгаль, нүүдэлчин соёл иргэншлийн давуу тал, чоно хийгээд амьд байгалийн оршин үлдэх шалгарал, хүн чонын амьдралын шүтэлцээ хувь заяаг түүхэн урт цаг хугацааны дундаас эрж хайхын хамт өөрийн тариаланч хятад үндэстэний зарим сул талыг зэрэгцүүлэн авч үзээд өөрийн үндэстэний цаашдын хөгжлийн гарцыг эрэлхийлэх оролдлогыг энэ номоороо хийсэн нь ажиглагдана.

Чухам жинхэнэ зохиолч хүмүүн бүтээл туурвилаараа өөрийн улс үндэстэн хийгээд хүн төрөлхтөний цаашдын хувь тавилангийн амин чухал асуудлыг дэвшүүлэн тавьж ирсэн сонгодог уран зохиолын түүхэн үнэ цэнэ “Чонон сүлд” романтай шууд холбогдож байгааг хэлэх хэрэгтэй.

Манай монголын авьяас билигт орчуулагч Д.Болдбаатар “Чонон сүлд” романыг нэн чадамгай



орчуулсныг анхны уншигчийн хувьд бахархан тэмдэглэж байна. Ялангуяа монгол нүүдэлчний амьдралын хэв маяг, зан үйл, эд өлгийн соёлын холбогдолтой мартагдан бүрхэгдсэн үг хэллэг энэ орчуулгатай цуг эргэн сэргэж байгаад орчуулгын үнэ цэнэ оршино. Мөн нөгөө талаар зохиолчийн романы хэл хэллэг, найруулга илэрхийллийн онцлогийг хадгалахын хамт, монгол уншигчийн шимтэн унших таашаалд нийцүүлэн амт шимт, давс хужирыг тааруулан, уламжлалт сайхан найруулгыг сонгосон нь орчуулагчийн ур чадварын чанар чансааг бүрнээ сорьж чадсанаар барахгүй Д.Болдбаатарыг өнөөгийн манай утга зохиолын шилдэг орчуулагчийн зиндаанд дэвшүүлэн гаргаж байна. Миний бие энэхүү гайхамшигтай номын монгол орчуулгын хянан тохиолдуулагчаар ажиллаж, орчуулгыг улам нягт сайн болгоход өчүүхэн хувь нэмэр оруулсандаа олзуурхан баярлаж буйгаа дурдсу.

Цаг хугацаа нисэн ирж, нисэн одож байна. Цаг хугацаатай цуг ирээдүй рүү бид нэн хурднаа яаран одсоор байна. Урсгал дагаж цагийн жамаар урсахын хамт түүхэн цаг хугацааг сөрж, өнгөрсөн цаг хугацаа руугаа, бүр түүхийн эрт балар луугаа эргэн очиж байхыг түүхийн сургамж бидэнд сануулсаар байна. Чухам энэ утгаараа “Чонон сүлд”-тэй язгуур гарвал руугаа эргэн нэг зорчиж, түүхийн хувь тавилан, зам мөр алдаа оноогоо эргэн тунгаахын учир утгыг зохиолч Зян Рунь “Чонон сүлд” романаараа дахин сэрэмжлүүлсэнд анхны монгол уншигч нарын нэгний хувьд гүнээ талархнам. Дээр тэнгэр, доор газар хийгээд хүн чоно, замбуулин дээрх бүхий л юмс бие биеэс хамааран, оршихуйн оюунлаг эрэлхийлэлийг энэ номоос тольдсугай.

Номын цагаан буян арвижих болтугай.

*Зохиолч, яруу найрагч*

*Г.Мэнд-Ооёо*

# Чонон сүлд

## Нэг

*“Цуань Рунчууд өөрийн дээдсээ хоёр нохой байсан гэгцээдэг. Тэд нохойг сүлдээ хэмээн дээдэлдэг байжээ”*

*Фань Вэньлань*

*“Хятад улсын нэвтэрхий товч, нэгдүгээр бөлөг”*

*“Жоу улсын Му ван, Цуань Рунчуудыг дайлаад дөрвөн цагаан чоно, дөрвөн цагаан буга олзлоод харьжээ”*

Чэнь Жэнь цаст хонхороос нэг нүдний дурангаа сунгаж том боохой дээр тогтоохуйд талын монгол чонын шөвөг мэт хурц нүдийг олж үзэв. Чэнь Жэньгийн хамаг биеийн шар үс зэрлэг гахайн хялгас мэт сөрвийн босож өмссөн цамцыг арьснаас хөндийрүүлэх мэт боллоо. Азаар Билиг өвгөн дэргэд байсны авралд эгээтэй л сүнс нь зайлчихсангүй, сөрвийн боссон шар үсний сүвээр хүйтэн хөлс чийхрах ажээ. Чэнь Жэнь тал нутагт ирээд хоёр оныг ардаа орхиж буй боловч монголын талын орог саарал болоод чонон сүргээс ихэд айдаг хэвээр байв. Айл хунараас хол аглаг ууланд ийм олноор сүрэглэсэн чонотой тулгарлаа гээд бодохоор амнаас савсах цан хүүрэг хүртэл дагжин чичирч байх шиг санагдана. Билиг өвгөн тэр хоёр гартаа барьсан нэжгээд ташуурнаас өөр буу, матаа хутга, уурга байтугай ядаж дөрөө зэрэг төмөр эдлэл огт үгүй тул чонон сүрэг тэдний үнэрээр мөшгин ирвэл хоёул насны эцсийг үзэлгүй нартын амьдралыг орхих нь тодорхой байлаа.

Чэнь Жэнь дагжин чичирсээр амьсгаа дарсхийн хажуудаа буй өвгөнийг хяламхийн ширтэв. Билиг өвгөн өөрийн нэг нүдний дурангаар чонон сүргийн бүслэлтийг тайван ажиглана. “Сүр сүлдгүй бээвийчихээд байж байгааг нь хараарай. Танай хятадууд чононоос ухаангүй айдаг болохоор тал нутаг дахь дайн байлдаанд дандаа ялагдаж байсан байж таарна” гэснээ Чэнь Жэнь эс дуу гарахыг үзээд “Унхиагүйтэж байгаад чимээ анир гаргачихвал сайнаа үзэхгүй гэж мэдээрэй” хэмээн зөөлөн зандрав. Чэнь Жэнь атга цас аван гартаа мөхөөлдөс болтол атгалаа.

Уулын нөгөө бэлд сүрэг цагаан зээр араатан чонын арга башрыг гадарласан шинжгүй боловч цаанаа л нэг сонор соргог бэлчээрлэнэ. Чонон сүргийн бүслэлтийн нэг үзүүр тэр хоёрын хэвтэж байгаа цасан хонхорт дөхөж ирэх агшинд, Чэнь Жэнь хөдлөж ч чадахгүй, буй биеэрээ цасан хөшөө болон хувирсан мэт санагдлаа.

Чэнь Жэнь тал нутагт хоёр дахь удаа чонон сүрэгтэй учирч байгаа нь энэ юм. Чонон сүрэгтэй анх тулгарч байсан аюулт агшин санаанд зурсхийн орж ирэх үед бүхий л бие нь зарсхийх шиг боллоо. Түүний оронд өөр ямар ч хятад хүн байлаа гэсэн зүрх нь чичирч цөс нь хагарах байсан буй за.

Хоёр жилийн өмнө Чэнь Жэнь Бээжингээс илгээлтээр малын зах бараадан ирэх үед арван нэгэн сарын сүүлч тохиосон тул ээрэм тал нэгэнтээ цасан хуяг дуулгаа хэдэрсэн байжээ. Илгээлтийн эздийн монгол гэр хараахан хуваарилагдан ирээгүй тул Чэнь Жэнь хоньчин болж

Билиг өвгөнийд түр суурьшив. Тэрбээр сарын дараахь нэгэн өдөр өвгөнийг дагалдан гурван өртөөний чанадад байх аж ахуйн төв рүү сургалтын материал авангаа аахар шаахар ахуйн хэрэглээний зүйлсээ базаахаар явжээ. Буцах болоход өвгөн аж ахуйн хувьсгалт хорооны гишүүний хувиар хуралтай болсон, харин түүний авч яваа сургалтын материалыг багийн төвд даруй хүргэх заавартай тул арга буюу ганцаараа буцах хэрэгтэй болсон юм. Буцах үед нь Билиг өвгөн өөрийн зам сайн мэддэг өндөр бор морио түүнд унуулж машин замаа барьж явбал өртөө хэрийн зайтай газар айл хунар тааралдах тул аюул осол гарахгүй. Харин ойр дөтийг бодож зам товчилж болохгүй шүү гэж олонтоо захисан билээ.

Чэнь Жэнь өндөр борын нуруун дээр гаруут тарга тэвээрэг сайтай монгол морины эрч хүч амтагдаж, салхи татуулан давхимаар урам бах төрөөд иржээ. Нэгэн уулын хяр дээр гарч багийн төв орших Цагаан уулын бараа бүртийн үзэгдэхүйд өвгөний захиасыг ор тас мартан өртөө хол илүү машин замыг даган сажлахаас төвөгшөөж, арай ойр дөт замаар явахаар шийдэв.

Хүйтний эрч улам чангарсаар, замын хагасыг туулах үед ёлтгор наран даарч бээрсэн мэт тэнгэрийн баруун хаяа руу шургалаа. Цасны жавар агаарт дэгдэн хөдсөн дээл дардайтал хөлдсөн тул Чэнь Жэньгийн гараа хөдөлгөх тоолонд шажигнан дуугарна. Өндөр борын хамаг бие цавцайсан цан хүүрэгт будагдаад даргар цасан хунгарт морины явдал зугуухан саарч ирлээ. Сунайтал үелэх довцог толгодыг эс тооцвоос ээрэм тал элчилгүй үргэлжилнэ. Өндөр бор морь цуцсан шинжгүй шогшуулсаар байв. Унасан эзнээ алжаах вий гэсэн шиг ухаант хүлгийн явдал их л зөөлөн аядуу санагдана. Чэнь Жэнь ч гэсэн морины амыг сул тавьж аясаар нь шогшуулсаар байлаа. Өндөр бор морь маань төөрчихвөл яадаг билээ, тэнгэр муухай аашилж, цасан шуурга тавиад хөдөө хээр хөлдөж үхвэл яана хэмээн бодогдоход дотор эвгүйцэн бие зарсхийх боловч харин араатан чонын аюулыг тэр үед ор тас мартчихаад байсан юм.

Нэгэн уулын ам руу дөхөж ирэх үес замын турш сортолзон соотгонож явсан өндөр борын сонор соргог хоёр чих арагш хулмайгаад зөөлөн үүрсэж, алхаа гишгээний хэм алдагдаад ирэв. Чэнь Жэнь анх удаа цаст талыг ганцаараа туулж яваа нь энэ болохоор өмнөө ямар аюул занал байж болохыг гадарлах ч үгүй байлаа. Өндөр борын хамар сархалзан тачигнаж, нүд нь бүлтэгнэн уулын амыг тойрч явах гээд байв. Чэнь Жэнь морины аашийг эс ойлгох тул амыг нь залан чигээр явуулахыг хичээнэ. Өндөр бор урагш гишгэж өгөхгүй дороо эргэцэх боловч цуцсан шинж үгүй, хэрэг гарсан цагт ухасхийн давхихад бэлхэн байв. Харин Чэнь Жэнь хахир өвөл морины хүчийг хайрлан гамнахуйн учрыг гадарлах тул морины амыг татасхийх ажээ.

Өндөр бор морь өмнөө байгаа аюулыг ойлгуулж ядаад арга барагдсан бололтой толгойгоо эргүүлэн Чэнь Жэньгийн эсгий гутлыг хазлав. Чэнь Жэнь гэнэт өндөр борын харцнаас өмнөө байгаа аюулыг бүүр түүрхэн ойлгох шиг боллоо. Гэвч сэхээрэх цаг нэгэнт хожимдож унасан хөлөг нь уулын уужим ам руу алхан орсон байжээ.

Чэнь Жэнь тэргүүн өргөн уулын ам руу лавшруулан хараад айсандаа эгээтэй л морины нуруун дээрээс уначихсангүй. Түүнээс дөч гаруй метрийн зайтай цаст довцог дээр үдшийн бүдэг гэгээн дор монголын хээр талын сүрэг чоно зогдоруу босгоод яахаас буцахгүй шинжтэй анан зогсоцгоож байлаа. Чононууд зарим нь чанх өөдөөс, зарим нь жишүүхэн

шөвөг мэт хурц нүдээр нэвт шувт ширтэх нь зарааны өргөс зай завсаргүй хаггах мэт эвгүй санагдана. Хамгийн наад захад ирвэс мэт нүсэр биетэй хэдэн орог саарал суух нь Бээжингийн амьтны хүрээлэнд харсан чононоос хавьгүй урт том, бахим бүдүүн ажээ. Энэ үед цасан дээр оцойн суусан арван хэдэн том чоно нэгэн зэрэг босоцгоож, сүүлээ өргөцгөөх нь илдээ сугалан, нумаа эвшээлгээд юу юугүй дайран ороход бэлдэх мэт. Чонон сүргийн голд хүзүү, хэнхдэг цагаан азарган чоно суух бөгөөд үсний сор нь цагаан алт мэт хараа булаан гялтганаж арслан барсын сүрийг гайхуулах ажээ. Тэнд лав гуч дөчөөс доошгүй чоно байсан санагдана. Хожим Чэнь Жэнь Билиг өвгөнд чонон сүргийн байр байдлыг нарийвчлан ярьж өгөх үед цаадахь нь духан дээрээ чийхрах хүйтэн хөлсийг долоовор хуруугаар илбэнгээ өгүүлрүүн: “Тэр чонон сүрэг лав уулын цаад бэлд байсан адуун сүрэг рүү довтлох гээд чуулсан байж таарна. Азаар чамтай өлөн чононууд тааралдаагүй байжээ. Өлөн чононы үсний сор гялтганадаггүй юм” гэж билээ.

Чэнь Жэнь тэр агшинд үнэндээ ухаан мэдрэл балмагдаж гүйцээд байв. Ёншгойт хэмээх мөнгөн зоосыг үлээхэд гардагтай төс бүхий ёозгүй дотор жихүүцэм дуу зулайгаар нэвтрэн орсон нь лав сүр сүлд гавлын яс лугаа харшихтай үүсгэсэн авиа буй за. Түүний амь нас хэдэн хором царцаж тасалдаад, тэрхэн агшинд сүнс нь зайлж сүг төдийхөн болон хувирсан махан бие үлдэж хоцорсон мэт өнөө хэр санагдаад болдоггүй юм. Одоо ч гэсэн тэрээр чонын сүрэгтэй анх тулгарсан айдас жихүүцлийг санах болгондоо Билиг аав болон өндөр бор мориндоо өөрийн эрхгүй сэтгэлийн гүнээс түмэнтээ талархсаар явдаг билээ. Өндөр бор болвоос жирийн морь биш, чонон сүрэгтэй олонтоо тулгарч өдий хүрсэн цуутай хурдан анч хөлөг учраас түүнийг авч шидээгүй хэрэг юм.

Аюулын ирмэг дээр ирсэн энэ торгон агшинд өндөр бор харин ч ер бусын тайван байх ажээ. Өндөр бор чоныг хараагүй мэт ер ажирсан шинжгүй гэлдэрнэ. Тэр зориг зүрхээ чангалан, дороо эргэцэх, эсвэл ам булаан давхихын аль алийг ч сонголгүй өнөөдрийн унасан эзэндээ ээлтэй нь аргагүй жигд алхлах нь толгой дээрээ олон давхар шилэн цом өрж тавьсан циркийн сурамгай жүжигчин мэт байлаа. Морины жигд алхаа Чэнь Жэньгийн биеийн тэнцвэрийг олуулж цэх суух боломж олгосноор агтын нуруунаас унаж араатны идэш болгочихоогүй билээ.

Өндөр борын эрэмгий зориг итгэмээргүй ухаан Чэнь Жэньгийн зайлан одсон сүнс сүлдийг эргүүлэн дуудсан уу, эсвэл мөнх тэнгэр түүнд хайр энэрлээ харамгүй хүртээсэн үү бүү мэд, түүний хулжин одсон хийморь сүлд эрч хүч итгэл найдвараар дүүрээд ирэв. Жихүүн агаарт хэдэн хором зоргоор аялаад амжсан сүнс махан биедээ эргэн ирэх үед тэр амьд байгаагаа мэдэрч, ер бусын тайван болсон байлаа.

Чэнь Жэнь эмээл дээр биеэ улам цэхлэн суугаад өндөр бор морь шигээ зориг зүрхээ хөвчлөн, чонон сүргийг хараагүй мэт явах боловч нүдний булангаар хажууханд байгаа хээрийн боохойнуудыг жийрхэнгүй ажив. Тэр монголын талын чонын хурд хүчний тухай чамгүй дуулж мэдсэн болохоор хэдэн арван метр гэдэг тэдний хувьд хэд харайхын төдийхөн зай болохыг юу эс андах билээ. Хүн морь болон чононуудын хоорондын зай улам улам ойртсоор боловч айж эмээсэн төрх огтхон ч гаргаж болохгүй гэдгийг Чэнь Жэнь сайн ойлгож байв. Хоосон хотын аргыг анх сэдсэн гурван улсын үеийн мэргэн чинсан Жү Гө Лян1 лугаа адил сая цэргийг захирах эрдэмтэй, живаа морьтонг дагуулан яваа мэт сүрийг үзүүлвээс сая уран

арга ухаан бодол хослосон тал хээрийн эзэн, монголын хөх чонон сүргийн омгийг дарж чадах бөлгөө.

Азарган чоно, Чэнь Жэньгийн ард хоцорсон уулын зүг бараалан харахад сүрэг нь сонор чихээ мөн адил тэр зүгт сортолзуулна. Чонон сүрэг азарган чонын авлах тушаалыг хүлээж буй нь илт. Харин гартаа барьсан ганц буу мэсгүй энэ морьтон чонон сүргийн өмнүүр ийм омог бардам явж байгаа нь азарган чоно болоод сүргийн бусад гишүүдийн хувьд нэн сэжигтэй санагдах ажээ.

Харуй бүрий улам бүр өтгөрч хүн морь болон чононуудын хоорондын зай улам улмаар ойртсоор байв. Энэ хэдэн арван алхам Чэнь Жэньгийн амьдралд тохиолдсон хамгийн аюултай, адармаатай урт зам шиг санагдана. Тэр дахин хэдэн алхам явтал ард нь нэгэн чоно гэнэт түүний гарч ирсэн цастай довцгийг чиглэн давхих нь бодвол азарган чонын томилсон заншлаач түүнээс өөр отоо бүгээ байгаа эсэхийг тандах гэсэн хэрэг болж таарав. Ийн бодох зуур Чэнь Жэньгийн биед эргэн ирсэн сүнс нь бас л зайлан алдлаа.

Өндөр борын алхаа ч сулраад явчих шиг санагдав. Чэнь Жэньгийн хоёр хөл болоод морины их бие хамтдаа салганан чичирч, тэр хэрээр бие биеийн айдсыг улам мэдэрцгээлээ. Өндөр бор морины хоёр чих арагш хулмайгаад заншлаач чонын зүг жийрхэнгүй харна. Заншлаач чоно байдлыг тандаад ирэхэд хүн морь хоёул чонын сүрэгтэй бараг тулаад ирэх нь гарцаагүй болов. Чэнь Жэнь аварга чонын ангайсан аманд багтаад дээр дор арзайсан хурц шүднээс өөр харагдах зүйл үгүй, хавхийтэл чонын ам хамхигдахад хамаг зүйл дуусах гэж байгаа мэт санагдана. Өндөр бор морь биеэ хураан урагш ухасхийн давхихаар завдаж байв. Гэвч морьтой хүн цастай талд сүрэг чононоос зугатаад хаа хол хүрэх билээ дээ.

Чэнь Жэнь гэнэт тал нутгийн малчид аюул осол тулгарсан үед эцэг тэнгэрээ дууддаг ёсонг санаж “Мөнх тэнгэр минь, авралын гараа сунгаж амийг минь хэлтрүүлж хайрла” хэмээн сүслэн шивэгнэв. Тэр бас Билиг эцгийнхээ нэрийг дуудахаа ч мартсангүй. Билиг гэдэг нь монгол хэлээр билиг оюун гэсэн үг бөгөөд монгол эцэг нь түүнд энэ цаг мөчид талын хүмүүний билиг ухааныг хайрлах ч юм бил үү гэж горьдсон хэрэг. Гэвч Олонбулгийн тал ямар ч чимээ аниргүй дүнсийх ажээ. Тэр горь тасарсан байдалтай толгой өргөн талын гүн хөх тэнгэрийг эцсийн удаа шимтэн харлаа.

Гэнэт хөгшин эцгийнх нь дуу хоолой тэнгэрийн чанадаас сонсогдох шиг болж “Чоно гэдэг амьтан буу, уурга болон төмөр эдлэлээс ухаангүй айдаг” хэмээн хэлж байсан нь чихний хэнгэргийг дэлдэх шиг болов. Өөрт нь төмөр эдлэл байгаа бил үү гэж санах зуур хөлийн улнаас төөнөх мэт санагджээ. Өөрөө томоос том ган дөрөө жийсэн шиг явж байгаа шүү дээ. Тэр тэсгэлгүй баярласандаа хоёр хөл нь бас л салганан чичрэх ажээ.

Билиг эцэг түүнтэй өндөр борыгоо сольж унахдаа эмээлийг нь хэвээр үлдээсэн юм. Өвгөн түүнд ийм том дөрөө сонгож өгсөн нь хэзээ нэгэн цагт энэ мэт хэрэг тохиолдох үе ирнэ гэдгийг зөн совингоороо гадарлаж байсан ч юм бил үү хэн мэдэх билээ. Анх адуу мал унаж сурч байгаа хүнд том дөрөө зүгээр байдаг. Адаглаад муугаар бодоход морь мал булгихад хөл амархан мултраад моринд чирэгдээд үхчихгүй гэдэгсэн. Тийм ч учраас түүний одоо хэрэглэж байгаа ган дөрөө өргөн дугариг тавагтай, ердийнхөөс хавьгүй том хоёр дахин хүнд эд байлаа.

Чонон сүрэг заншлаачаа хүлээн байх зуур хүн морь хоёр бараг тэдний өмнө шахам тулж иржээ. Чэнь Жэнь энэ зуур хоёр хөлөө дөрөөнөөс мултлан, доош тонгойж хоёр дөрөөний сурыг тайлж, гартаа нэг нэгээр барьж авлаа. Үхэл амьдралын торгон агшин чухам энэ л үйлдэлтэй тохиогоод байв. Чэнь Жэнь хүчээ нөөн биеийг огцом эргүүлээд хамгийн олон чоно чуулсан тэр зүг рүү гуугалан хашгирч, хоёр хүнд дөрөөг цээжнийхээ өмнө өргөн, байдаг чадлаар харшуулан дуугаргаж эхлэлээ.

“Дан, дан. . . .”

Ган дөрөөний харших дуу чихний хэнгэрэг хагалах шахам цангинаж, эль хуль хээр талыг цочоон сэрээгээд, цөс чичрээм хурц илд мэт сүрэг чонын зүг цамнан хүрвэй. Олон чонын хувьд энэхүү ер бусын хүчтэй дуу авиа байгалийн аянга цахилгаанаас ч илүү аюултай, талын чонын хамгаас илүү аюун ширвээддэг ган хавхны тасхийх дуунаас ч хавьгүй сэтгэл сэрхийм санагдсан нь лавтай. Чэнь Жэньгийн үүсгэсэн эхний удаагийн дөрөө харшилдах чимээ сүрэг чоныг дагжаан чичрүүлж, удаах хэдэн удаагийн чимээнд азарган чонын удирдлагаар бүгд чихээ хулмайлган, хүзүүгээ хавчаад талын салхи мэт уулын арыг чиглэн зугатацгаав. Заншлаач чоно ч гэсэн өөрийн үүргийг умартан, ижил сүргээ эрэн тэмцжээ.

Ийм сүрдэм олон монголын чонон сүрэг хоёрхон ган дөрөөний харшилдаанд зугатан зайллаа гэж үү хэмээн Чэнь Жэнь өөрийн хоёр нүдэндээ итгэж өгсөнгүй. Агшин зуурын төдийд түүний зориг зүрх бадраад ган дөрөөг улам эрчтэй харшуулах зуур, тал нутгийн малчдын хэвшмэл дохио зангаа болох гараа даллан арагш хараад “Хурдлаарай, хурдлаарай, энд зөндөө олон чоно байна шүү” хэмээн хашгирч гарлаа.

Монгол чоно монгол хэл болоод монгол анчдын дохио зангааг ойлгодог ч юм бил үү? Чонон сүрэг өөрсдийн хамгаас жийрхдэг монгол анчдын тавьсан байж болзошгүй ав хомрогын хүрээнээс улам холдон зугатацгаалаа. Гэвч чонон сүрэг бусад араатан жигүүртэн шиг тал бүртээ тархан зугатаалгүй, өөрсдийн тогтсон жагсаалын журам болох азарган чоно урд замчилж, хамгийн том биетэй нь ар талаа хамгаалсан байдалтай холдож байгааг хараад Чэнь Жэнь бүр гайхаж хоцров.

Чонон сүрэг нүд ирмэхийн зуур ардаа хуйларсан цасан хуй татуулсаар бараа туруу нь үзэгдэхээ больж билээ.

Тэнгэр сунгасан гарын хуруу ялгаж танигдахааргүй харанхуйлахад, өндөр бор морь ойролцоо байх хот айлыг чиглэн ухасхийн давхилаа. Жихүүн салхи энгэр заам, ханцуй нудраганы зай завсраар шурган Чэнь Жэньгийн хамаг биеийн хүйтэн хөлс царцаад мөхөөлдөв.

Чонын амнаас эсэн мэнд мултарсан Чэнь Жэнь тэр цаг мөчөөс хойш талын нүүдэлчин ардууд лугаа адил мөнх хөх тэнгэрийг дээдлэн шүтдэг болсон билээ. Түүнчлэн монголын хээрийн хөх чононоос чөтгөр шүглэсэн мэт эмээхийн зэрэгцээ, түүнийг улам ч хүндлэн бишрэх болсон юм. Монгол чоно түүний хувьд зөвхөн зүрх цөсийг цочоогоод өнгөрсөн хэрэг биш, харин ч түүний сүнс сүлдийг дуудаж өгсөн амьтан гэвээс үнэнд ойртох болов уу. Энэхүү үзэгдэх биегүй, баригдах бараагүй, хий хоосон зүйл чухам л хүмүүсийн сэтгэлийн мухар дахь сүлд шүтээн юм. Тэгснээр Чэнь Жэньд талын нүүдэлчдийн оюун санааны ертөнцөд нэвтрэн орсон мэт бүрэг бараг санагдах болжээ. Хэдийгээр тэр үүд хаалганы завсар зайгаар нь

шагайх төдийхөн болсон боловч түүний сонирхол болоод харц аль хэдийн түүний чанад хязгаарт бэлчин одсон юм.

Түүнээс хойшхи хоёр жилийн хугацаанд Чэнь Жэнь тийм олноор сүрэглэсэн чонотой дахин учралгүй өдий хүрчээ. Өдөртөө хонь мал хариулж явах зуур ганц нэгхэн буюу сайндаа л тав гурван чоно тэртээ холуур үзэгдэх төдий өнгөрч явахыг хардаг байв. Харин тэр чононд бариулсан, ганц хоёр, гурав дөрөв, тэр ч байтугай талаар нэг хөглөрсөн малын сэг зэмийг бол харахаараа л нэг болсон. Айл хунараар орж гарч явахад анчин гөрөөчид чонын туламлан өвчсөн арьс өндөр шонд өлгөөтэй салхины аясаар савлаж байх нь ч тааралдана.

Билиг өвгөн урьдын адил хөдлөх ч үгүй цасан хунгарт хэвтэнгээ нүдээ жийхайлган уулын бэл уруудан бэлчих зээрийн сүрэг болоод тэдний зүг улам бүр ойртон ирэх чонон сүргийг ширтэнгээ Чэнь Жэньд хандан “Тэвчих хэрэгтэй, анчин болох анхны алхам тэвчээр байдаг юм шүү дээ” хэмээн шивнэв.

Билиг өвгөн хажууд байгаа нь Чэнь Жэньд хавьгүй нөмөр нөөлөгтэй санагдана. Тэрээр сормуусан дээр тогтсон цасан ширхэгийг шудраад өвгөний зүг ойлгосоноо илтгэн нүдээ цавчилж, дурангаа өргөөд жишүүхэн уулын бэлд бэлчээрлэж байгаа зээрийн сүрэг болон чонын бүслэлтийн шугамыг ширтэн харваас чонон сүрэг ямарваа нэгэн үйл хөдлөл үгүй нам гүм болжээ. . . .

Тэр нэгэн удаа өндөр бор морьтойгоо чонон сүрэгтэй халз тулгарсан цагаас хойш тал нутгийн малчид үнэн хэрэг дээрээ өдөр тутам чонын бүслэлтэн дунд амьдардаг болохыг гүнээ ухааран ойлгосон юм. Өдөр нь хонио туусаар гэрээс гарахад холгүйхэн цасан дээр том том чонын мөр гарсан байхыг төвөггүйхэн олж үзэж болно. Уулын бэл юм уу, нуга дэвхээ газар бол чонын мөр улам олшрох бөгөөд зэгэлдүү саарал чонын баас ч тааралдах нь бий. Шөнө оройдоо төөрсөн сүнс мэт чонын бараан дүрс харагдахаас гадна, ялангуяа өвлийн шөнө болоход цөөндөө тав зургаа, олондоо хэдэн арван чонын хурц ногоон нүд хонин сүргийн хашаа хорооноос хэдэн арван метрийн зайтай ёлтолзох нь энүүхэнд. Тэрбээр нэгэн удаа Билиг өвгөний бэр Галсмаатай хамт гар чийдэнгийн гэрэлд хорин таван чонын хос нүдийг тоолж билээ. Эртний нүүдэлчид партизаны аянтай адилхан бүх юм нь хөнгөн авсаархан тул өвлийн улиралд үхэр тэрэг, эвхдэг хашаа зэргийг хагас тойрог маягаар босгож түүнийгээ эсгийгээр бүтээгээд хоньдоо жихүүн хүйтэн салхинаас хамгаалах боловч чоныг харин яаж ч чадахгүй нь ойлгомжтой. Хонины хашааны задгай амыг сүрэг ноход болон шөнө орой ээлжлэн манах хүүхнүүд голцуу хүчээр хамгаалж хононо. Заримдаа чоно ноход урцалдан ноцолдсоор монгол гэрийг мөргөн ханын тушаа унтаж байсан хүмүүсийг сэрээх нь бий. Чэнь Жэньд ч гэсэн тийм явдал хоёр удаа тохиолдсон бөгөөд хэрвээ монгол гэрийн хана байгаагүй бол түүний өвөрт дайран ороод ирэх байсан биз. Балар эртний нүүдэлчин хэвшлээр аж төрж байгаа хүмүүс зарим үед хээрийн араатан чонотой хоёрхон эсгий туургаар зааглагдан амьдарч байдаг нь энэ юм. Харин Чэнь Жэнь өнөө хэр чонотой нударга зөрүүлэн учрах тохиол хараахан гараагүй л байгаа билээ. Шөнийн тулаанд гарамгай монголын хээрийн боохой Хуабэйгийн партизаны отрядаас ч илүү арга самбаа ихтэй нь лав буй за. Чонын үзэгдэх нь олонтоо байдаг шөнө оройн цагаар сонор соргог унтах юм шүү гэж өөрийгөө шавдуулахаас гадна, Галсмааг шөнийн ээлжинд гарах үед чоно дайрвал заавал дууддаг юм шүү, гэрээс шалавлан гараад чоныг цохиж нүдэхэд нь туслах болно гэж байнга хэлдэг. Тэр болгонд Билиг

Өвгөн ямаан сахлаа имрэн инээвхийлж чононд ийм сонирхолтой хятад хүн байдаг байх нь ээ хэмээдэг байлаа. Өвгөн цаагуураа Бээжингээс ирсэн оюутан залуу болох Чэнь Жэнь чоныг ер бусын ихээр сонирхдогт тааламжтай байдаг нь илт.

Тэгсээр тал нутагт ирсэний дараах эхний жилийн дүн өвлийн цасан шуургатай шөнө дүлээр хүн нохой чоно гурвын халз тулааныг гар чийдэнгийн гэрэлд ойр дөтөөс харах боломж тохиолдож билээ.

“Чэнь Жэнь, Чэнь Жэнь. . .”

Тэр шөнө Чэнь Жэнь гэнэт Галсмаагийн ийнхүү бачимдуу хашгирах дуу болоод нохдын боорлон хуцах чимээнд өөрийн мэдэлгүй цочин сэрэв. Тэр эсгий гутал, монгол дээлээ хам хум олж өмсөөд, гар чийдэн, ташуур хоёроо авч гарах үед хоёр хөл нь өөрийн мэдэлгүй салганан чичирч байлаа. Хуйрагнан бужигнах цасыг нэвглэн гэрэлтэх гар чийдэнгийн гэрэлд Галсмаа бүсгүй нэгэн том хээрийн боохойг сүүлдчихсэн зогсож байдаг байгаа. Мөнөөх хээрийн зэрлэг амьтан сүүлнээсээ толгой хүртэл нас бие гүйцсэн хүний хэртэй өндөр том, зүү орох зайгүй чихцэлдсэн хонин дунд хавчуулагдсан болохоор Галсмаа бүсгүй рүү эргэж дайрах боломжгүй болсон тул толгойгоо эргүүлэн шүдээ ярзайлган хазахыг оролдохоос өөр чадалгүй болжээ. Захын хоньд хээрийн боохой, цасан шуурганаас айж ширвээдэн, улам бөөгнөрөн чигжсээр, лавсан орох цасыг хайлуулан уур савсуулахын зэрэгцээ чонын цээжин биеийг улам бүр хөдлөхийн аргагүй болгож байв. Чоно урд хөлөөрөө газар самардан, өртсөн хонь болгоныг хазаж хайрах бөгөөд, Галсмаатай олс таталцаж байгаа мэт урагш зүтгэн хонин дундуур туучин гарах, эсвэл гэдрэг ухран түүнийг ноцохоор санаархана. Чэнь Жэнь бүдчин гүйсээр тэдэн дээр хүрч ирсэн боловч чухам юу хийхээ мэдэхгүй хэсэг зуур алмайран зогсов. Галсмаагийн ард хоёр том нохой хоньдоор тусгаарлагдсан тул чоныг хазаад авч чадахгүй, хий дэмий л боргон хуцах боловч хээрийн боохойн омог сүрийг сайн дарж байлаа. Билиг өвгөний тэжээсэн тав зургаан омог сүртэй том ноход болон бусад айлын ноходтой нийлээд хотны захад бусад чонотой үзэлцэх ажээ. Чоно нохдын хуцаж, боргон улих чимээ энэ тэр гэж ялгахын аргагүй. Чэнь Жэнь очиж Галсмаад туслая хэмээн бодсон боловч хөл нь тушаатай мэт хөшчихөөд урагш хөдлөж өгөхгүй байв. Урьд нь чоныг чихдэж авахаас буцахгүй байсан гал халуун хүсэл нь агшин зуурын айдастаа мөс болон хувирчээ. Галсмаа түүнийг өөртөө туслахаар ирсэн гэж санасан бололтой. “Цаашаа холхон бай, чононд ноцуулна шүү. Харин хоньдыг яраад нохойгоо нааш ойртуул” гэдэг байгаа.

Галсмаа арагш цахлан чонын сүүлнээс чаргууцалдсаар халууцаж толгойноос нь уур савсах ажээ. Тэр хоёр гараараа чангааж чонын сүүлийг таслан алдахад чоно цустай амнаасаа уур савсуулан хилэгнэж, болдогсон бол гэдрэг ухасхийн түүнийг хүү татан залгимаар санагдаж байгаа нь лавтай. Чоно урагш зүтгээд нэмэргүйг мэдээд огцом эргэн Галсмаа руу ухасхийн дайрав. Галсмаагийн онигор нүднээс эм ирвэсийнх шиг хорсолтой харц илрээд чонын сүүлнээс зуурсан чигээрээ чирсээр арагш ухран нохдын зүг дөхлөө.

Чэнь Жэньгийн нүд бүрэлзэн харанхуйлах боловч харалгүй чононд ноцуулчих вий хэмээн эмээж, Галсмаа чоно хоёр руу гар чийдэнгээ тусгангаа ташуураа өргөн хоньдыг толгой түрүүгүй цохилж, тараахыг оролдоно. Хоньд харанхуйд байгаа мөнөөх том саарал чононоос үргэн үймэлдэж гар чийдэнгийн гэрлийг бараадан бөөгнөрөх тул Чэнь Жэнь тэднийг хөөж тараах арга үнэхээр тасарлаа. Галсмаа орог саарал чоныг чирч дийлэхгүй хүч алдан урагш



нэлээд хэдэн алхам чирэгдэхийг тэр олж үзэв.

“Ээж ээ. . “ хэмээх хүүхдийн цангинасан дуу хадав.

Галсмаагийн есөн настай хүү Баяр гэрээс гүйн гарч ирсэнээ дууных нь өнгө хүртэл хувираад явчихжээ. Тэр ээжийгээ чиглэн гүйж, эмээл дээрээ сэвхийн мордох лугаа адил хоньдын нуруун дээгүүр харайн гүйсээр Галсмаагийн дэргэд хүрээд чонын сүүлнээс зүүгдэн авлаа. “Чонын хөлнөөс тат, хөлнөөс тат” хэмээн Галсмааг хашгирахад Баяр чонын хоёр хөлнөөс зууран аваад арагш чангаахад орог саарлын урагш зүтгэх хүчийг сааруулж чадав. Эх хүү хоёр арайхийн чонын урагш зүтгэхийг зогсоож чадлаа. Хот айлын ноход хуцаж боргосоор чонодтой ноцолдоно. Нэг хэсэг чоно ийнхүү нохдын гол хүчийг өөр дээрээ татаж байх зуур, нөгөө хэсэг нь хоньд руу дайран орсон бусдынхаа ухрах замыг хамгаалж байжээ. Хонин сүргийн хамгаалалтын шугамын баруун хэсгийг эх хүү хоёр ийнхүү үхэн хатан тогтоогоогүй бол энэ зэгэл саарал амьтан лав хэсэг хоньдыг хонины хашааны баруун талаар хөөн одох байсан нь гарцаагүй.

Билиг өвгөн ч мөн хонины захад гүйн ирж, чимээ өгөх зуур зүүн талд байгаа ноход руу хандан “Барс аа, Барс аа” хэмээн дуудав. Барс хэмээх бусдаасаа хавьгүй өндөр сүрлэг биетэй, эрэмгий зоригтой дөрвөн нүдэт халтар нохой уртаараа чоныг арай гүйцэхгүй боловч том цээж, биеийн өндрөөр илүү гарахаар байлаа. Эзнийхээ дуудахыг сонссон Барс чонотой урцалдахаа больж, өвгөний дэргэд гүйн ирэв. Барс зогтусаад амнаасаа чонын цусны үнэр ханхлуулан аахилна. Өвгөн Чэнь Жэньгийн гар чийдэнг авч бөөгнөрсөн хонин дунд хавчигдсан чонын зүг чиглүүлээ. Барс толгой хаялан, хариуцлага алдсан бие хамгаалагч шиг хэд гийнаснаа багтран уурлаж ухасхийн хоньдын нуруун дээр харайн гараад урагш зүтгэсээр чоно руу чиглэв. Өвгөн Чэнь Жэньд хандан “Хоньдоороо чоныг сайн хашаад өг. Зугатаалгаж болохгүй шүү” хэмээн хашгирчээ. Өвгөн Чэнь Жэньгийн гараас атган хоньдыг хашсаар чоно Галсмаа хоёрын байгаа зүг шахлаа.

Уурлаж догширсон Барс цан хүүрэг савсуулж, цусан шивэр ханхлуулсаар Галсмаагийн дэргэд очсон боловч чоно хоньдод зайгүй шахуулсан болохоор яаж ч чадахгүй байв. Монгол талын сайн анч ноход чонын их бие нурууг шархдуулж арьс үсийг нь гэмтээж болохгүй гэсэн бичигдээгүй хуулийг сайтар ойлгох учраас Барс дэмий л хуцаж боргоно. Галсмаа Барсыг дэргэдээ ирэхийг мэдмэгц биеийг өрөөлдөн хөлөө өргөж өвдгөө угт нь тулган хоёр гараар хүчлэн хөшвөөс чонын сүүл чадхийн хугарав. Чоно цөхрөнгүй гийнаад дөрвөн мөч нь сулавхийхэд эх хүү хоёр элбэн түүнийг хоньдын дундаас чирэн гаргаж ирлээ. Том саарлын их бие татганан шархаа эргэн харах агшинд Барс чонын багалзуурт асан унагаад маажиж тийрэхийг ч эс тоон толгой цээжин дээр нь хөлөөрөө даран авлаа. Нохойн соёо улам гүн шигдэхэд чонын хоёр гүрээнээс цус гожгодон нэг хоёр минут хүчлэн тийчгэнэж байснаа сулавхийн чимээгүй болоод цустай улаан хэл л хоёр шүдний хоорондуур унжаад ирэв. Галсмаа нүүрэн дээрээ үсчсэн чонын цусыг арчаад амьсгаадан зогсоно. Түүний улаа бутарсан царайд чонын цусаар энгэсэг түрхсэн мэт, аль эсвэл балар эртний эмэгтэйчүүдийн зэрлэг догшин атлаа эрэмгий гоо үзэсгэлэн төгс бүрдсэн лүгээ Чэнь Жэньд санагдаж байлаа.

Үхсэн чонын цусны үнэр агаарт тархаад, чонон сүрэг харанхуйд уусан шингэж зугатан холдоход нохдын хуцалдах чимээ ч намжив. Удаж төдөлгүй баруун хойдох нугын тэртээгээс сүрэг чонын гунигтай улих чимээ дуулдах нь лав энэ газар амь тавьсан эрхэм нөхөртөө

эмгэнэл илэрхийлж байгаа хэрэг байж таарна.

“Би ч ёстой хониноос өөрцгүй аймхай хулчгар амьтан юм даа. Тал нутгийн нохой, бүсгүй хүн, есөн настай хүүхдийн хэртэй зориг алга” хэмээн Чэнь Жэнь ичингүйрэн өгүүлэв. Галсмаа инээгээд толгой сэгсрэн “Үгүй дээ, хаанаас. Чи хэрвээ надад ирж туслаагүй бол чоно хоньдыг маань хүйс тэмтрээд дуусгах байсан шүү дээ” гэж билээ. Билиг өвгөн ч инээд алдан “Чам шиг хятад оюутан гар чийдэн барьчихаад хонь мал эргүүлж явахыг би л хувьдаа урьд өмнө үзээгүй юм даг” гэв.

Чэнь Жэнь бие нь хараахан хөрж амжаагүй байгаа чонын биеийг илж үзэв. Тэр Галсмаад туслан чонын сүүлнээс татаж, хятад хүний хувьд цорын ганцхан тохиолдол байж мэдэх улаан нүцгэн гараар улангассан чонотой тулалдах тэр алтан боломжийг алдсандаа үнэн голоос харамсаж байлаа. Олонбулгийн талын чоно үнэхээр харсан хүн сүрдмээр нүсэр том биетэй нь үс ноосондоо баригдсан хүн хар гөрөөснөөс дутах юмгүй, хэдийгээр газар гулдайн хэвтэх боловч сүр сүлд нь хэвээрээ түр зуур согтож ойчоод хэзээ мөдгүй архираад босоод ирэх гэж байгаа мэт харагдана. Чэнь Жэнь Барсын толгойг илж зориг зүрхээ чангалаад доош сөгдөн сууж эрхий дунд хоёр хуруугаараа чонын биеийн уртыг төөлж үзэв. Түүний хоншоороос сүүлний үзүүр хүртэл есөн төө буюу нэг метр наян сантиметр байгаа нь түүний биеийн өндрөөс хэдэн сантиметрээр илүү гэсэн үг юм. Чэнь Жэнь уртаар сүүрс алдлаа.

Билиг өвгөн гар чийдэнгийн гэрлийг тусгаж үзвээс дөрөв таван хонины сүүлийг угаар нь тас хазсан нь цус мөс барьцалдан хөлджээ. “Энэ хоньдын сүүлээр ийм том чонын олз олж ирнэ гэдэг таарсан наймаа боллоо” гэнэ. Айл саахалтын ноход үхсэн чоныг шоглочихож мэднэ хэмээн сэргийлээд, өвгөн Чэнь Жэньтэй хамжин илүү гэрт чирч орууллаа. Чонын сарвуу нохойныхоос хавьгүй том санагдсан тул Чэнь Жэнь өөрийн алгатай харьцуулж үзтэл атгасан нудраганы хэртэй том байх ажээ. Чоно цастай тал болон хад чулуун дундуур тийм хурдан гүйдэг нь арга ч үгүй хэрэг аж. “Би чамд чоно туламлан өвчихийг зааж өгье” гэж өвгөн хэлэв./p>

Галсмаа гэрээс том цартай мах барин гарч ирээд Барс болон бусад нохдыг шагналаа. Чэнь Жэнь ч гэсэн даган гарч ирээд хоёр гараар Барсын данхар толгой болон уужим зоог илэхэд цаадахь нь тааламжтайгаар ястай махыг зажлангаа сүүлээ шарвалзуулан баярлаж буйгаа илтгэх ажээ. “Сая чи айсан уу, үгүй юу?” гэж Чэнь Жэнь Галсмаагаас тэсгэлгүй асууж орхив. “Айлгүй яахав. Чоно хоньдыг маань туугаад явчихвал хөдөлмөр өдрийн хөлсгүй хоцорно гэж айж байлаа. Би чинь ядаж хэсгийн дарга хүн байж хоньдоо алдчихвал ичгүүртэй хэрэг биш гэж үү?” гээд доош тонгойн Барсын толгойг илээд “Барс сайн нохой шүү” гэв. Барс идэж байсан махаа орхиод толгой өргөн эзнийхээ гарыг үнэрлэснээ хошуугаа хормой доогуур нь шургуулан сүүлээ салхи исгэртэл хурдан хурдан шарвалзуулав. Хахир өвөл хавиргаа нийлтэл өлссөн хэрнээ Барс гэрийн эзэгтэйн хайр энэрлийг хоолноос илүүтэй үзэж байгааг Чэнь Жэнь ойлгож байлаа. Галсмаа өгүүлрүүн: Чэнь Жэнь, цагаан сарын дараа би чамд нэг гөлөг олж өгөмз. Нохой тэжээхэд ч арга эв их хэрэгтэй шүү. Чи сайтар тэжээгээд Барстай адилхан болгоод аваарай” гэхэд Чэнь Жэнь дахин дахин талархал илэрхийлэв.

Гэртээ орсоны дараа ч гэсэн Чэнь Жэньгийн айдас сэтгэлд хургасан хэвээрээ “Сая ч үнэхээр их айлаа шүү” гэхэд “Би чиний гараас атгахад салганатал чичрэх нь мэдэгдэж байсан юм аа. Дайн тулалдаанд явбал яаж илд сэлэм барьж чадах билээ? Тал нутагт идээшин амьдаръя

гэвэл чононоос илүү овсгоо самбаатай байх хэрэгтэй. Хожим чамайг чонын авд авч явна аа. Эрт дээр цагт эзэн Чингис хаан маань чонын анд сайн эрсийг цэрэгтээ эн түрүүнд элсүүлдэг байсан юм гэдэг шүү” гэжээ.

Чэнь Жэнь толгой дохин “Би ч түүнд итгэж байна л даа. Хэрвээ Галсмаа морио унаад дайн тулалдаанд явбал Хуа Му Ланиас дутахааргүй сайн байлдах байх аа. Өө нээрэн Хуа Му Лань гэж манай хятадын эртний баатар эмэгтэй жанжин байгаа юм “ гэв.

“Танай хятадын хэн гэлээ, аан тийм Хуа Му Лань чинь тоотой хэдхэн байдаг бол манай монголын Галсмаа айл өрх болгонд л байгаа шүү дээ” гээд өвгөн азарган чоно адил хүд хүд инээлээ.

Тэр цагаас хойш Чэнь Жэнь аль болох ойр зайнаас чонотой ойртон, ажиглаж судлахыг хичээдэг болсон юм. Хээрийн хөх чоно тал нутгийн эзэн хүнтэй ямар нэгэн нууцлаг сэжмээр холбоотой, хэрвээ орог саарал чоныг ойлгочихвол монголын нууцлаг тал болоод малчин ардыг ойлгож болмоор бодол үе үехэн төрдөг болжээ. Тэр дундаа монгол талын хөх чоно хамгийн учир битүүлэг оньс болж таараад байв. Чэнь Жэнь тэр ч байтугай чонын тухай хамгийн үнэн бодитой сэрэл мэдрэмжийг нэмэгдүүлэхийн тулд биечлэн нэгэн бэлтрэг суйлан гаргаж, гарт баригдаж нүдэнд үзэгдтэл тэжээн өсгөө гэсэн бодол төрөх болсноос өөрөө ч гэсэн айх шиг болдог байлаа. Урин цаг наашлахыг дагалдаад түүний бэлтрэгтэй болох хүсэл улам бүр өдөөгдөн бадарч ирэв.

Билиг өвгөн Олонбулгийн талын нэрд гарсан анчин боловч сүүлийн үед ан гөрөөнд тоотойхон явах болсон юм. Анд явлаа ч үнэг туулай мэтхэнийг шоглодог болжээ. Сүүлийн хоёр жил хүмүүс соёлын хувьсгал гэцгээгээд адуу мал ан гөрөөг хослуулсан уламжлалт амьдралын хэвшил шуурганд уруудсан хонин сүрэг адил эх толгойгоо алдчихаад байгаа билээ. Харин өнөө жилийн өвөл сүрэг сүрэг цагаан зээр хил дамнан хүрч ирээд Олонбулгийн талд идээшлэн бэлчих болсон тул Билиг өвгөн өөрийн урьд хэлж байсан амлалтаа хэрэгжүүлэх боломжтой болоод чонон сүргээс ийм ойрхон зайтай хэвтэж байгаа нь энэ юм. Эргээд бодоход түүний эр зориг, билиг оюуныг сургуулилах хамгийн тохиромжтой газар үүнээс өөр хаана байх вэ дээ. Чэнь Жэнь хэдийгээр талын чонотой ийм ойроос тулгарсан ч энэ нь үнэн хэрэг дээрээ жинхэнэ чонын ав биш ээ.

Хэдий ийм боловч Чэнь Жэнь өвгөний ийн сэтгэл гаргасанд баярлаад барахгүй байлаа.

Өвгөн түүнийг гараараа зөөлөн нудраад толгодын зүг заав. Чэнь Жэнь яаравчлан дурангаа толгодын зүг чиглүүлвээс зээрийн сүрэг шалмаг гэгч нь өвс хазлаж байлаа. Нэгэн том саарал чоно сүргээс тасран баруун уулыг чиглэн давхихыг тэр олж үзэв. Түүний сэтгэл сэрхийж өвгөн рүү хандан “Чонон сүрэг дайрахаа больчихлоо гэж үү дээ? Тэгвэл бид нар дэмий хоосон өдрийн хугасыг өнгөрөөсөн байж таарах нь ээ” хэмээн шивнэв.

“Сүрэг чоно ийм сайхан боломжийг хаанаас алдаж түвдэх билээ? Азарган чоно зээрийн сүрэг дэндүү олныг үзээд хүч бүл нэмэхээр энэ чоныг явуулсан байж таарна. Ийм сайхан боломж тэдний хувьд тав зургаан жилдээ ч ганц удаа тохиохгүй. Тийм болохоор энэ сүрэг боохой лавтай нэг сайхан найрлаад авья гэж санасан хэрэг. Харин ч би чамайг өнөөдөр дэмий хоосон авч гараагүй шиг байна. Чи жаахан тэвчиж үз. Анчин хүн чинь тэвчээртэй байсны

хүчинд хангайн хишгийг хүртдэг юм” хэмээн өвгөн хэлжээ.

## Хоёр

*Хүннүгийн хаан туйлын үзэсгэлэн гоо хоёр охинтой байсныг ард иргэд бүгдээр сахиус мэт дээдлэн хүндлэдэг байжээ. Хүннүгийн хаан “Ийм сайхан охидыг тэнгэрт өргөхөөс биш, ямар хувьтай хүний үрд өгөлтэй билээ. Тэнгэр зоргоор таалнам буй за” хэмээн өгүүлээд улсынхаа хойд хязгаарт тахилын өндөр тавцан байгуулж охидоо түүн дээр орхисон ажээ. Удаах онд нэгэн хөгшин чоно өдөр шөнө өнжилгүй тахилын тавцанг сахин ульж, дор нь нэгэн нүх ухаад холдон эс одох болов. Бага охин өгүүллрүүн: “Хаан эцэг биднийг тэнгэрт өргөө хэмээн энд орхиод явсан бүлгээ. Өдгөө энэ чоно ирсэн нь яавч эгэл амьтан бус тэнгэрийн зараал буй за” хэмээгээд доош буухыг завджээ. Эгч нь хирдхийн цочиж “Энэ адгууст өөрсдийгөө тушааваас эцэг эхээс заяасан ариун биеийг талаар бузарлах бус уу?” хэмээхэд дүү нь түүний үгэнд оролгүй доош буун чонын гэргий болоод үр хүүхэд гарган үржиж олишрсоор улс гүрний хэмжээнд хүрчээ. Тиймийн учир тэр улсын хүн ардын дуу чоно улих мэт болсон ажгуу.*

*“Вэй улсын бичиг”*

*Рү Рү Гао Чө нарын шастираас*

Дахин зургаа долоон том чоно хомрогын хүрээнд нэгдэн орсноор гурван талаас хумьсан бүслэлтийн шугам үүслээ. Чэнь Жэнь хөдсөн дээлийн даргар нудрагаар амаа таглан шивэгнэн асууруун: “Аав аа, чонын сүрэг одоо хомроголон дайрна биз дээ?”

Билиг өвгөн “Бас ч зай байна аа. Азарган чоно анасаар байна. Чонын ав хомрого хүнээс илүү хашир болгоомжтой болдог юм. Чи өөрөө азарган чонын юу хүлээгээд байгааг сайтар бодоод үз л дээ” хэмээн хариуд нь намуухнаар өгүүлэв. Хөгшний өтгөн цагаан хөмсөг сөрвөлзөн хөдлөхөд хэсэг цан хүүрэг гөвөгдөн уналаа. Түүний дух нүүрийг халхалж хоёр мөрийг давсан үнэгэн лоовууз цан хүүрэг татуулаад түүний цаанаас өвгөний хонин бор нүд хоёр хув шиг гялтганах ажээ.

Тэр хоёр энэ цастай хонхорт өдрийн хугасыг өнгөрөөсөн билээ. Энэ мөчид тэр хоёр уулын бэлд жишүүдүүхэн бэлчиж байгаа зээрийн сүргийг ажиглаж эхлэв. Сүрэгт мянга хол давсан зээр байх бөгөөд хар эврээ гялтгануулсан хэдэн тарган ооно амандаа өвс зуусан чигээр толгой өргөн агаар үнэрлэж бусад нь цасан дороос өвс малтан идсээр байв.

Энэ уг нь хоёрдугаар багийн зуд турханы үед хэрэглэхээр үлдээсэн нөөц бэлчээр бөгөөд хааш хаашаа өртөө гаруй үргэлжилсэн том талбайтай нөмөр нөөлөг болохоор өвс дэрс өтгөн сахлаг, цасанд дарагддаггүй онцлогтой газар юм.

“Энэ онь байршил онцгой сайн, баруун хойноос ирэх салхины аман дээр болохоор хичнээн их цас орлоо ч хунгарладаггүй болохыг харж байна уу? Намайг найман настай байх тэр жил Олонбулгийн талд урьд хожид үзэгдээгүй айхгар зуд турхан болоод тэгш тал газар монгол гэр далдармаар зузаан хунгар тогтож билээ. Азаар зарим айл хунар нутгийн хашир хөгшдийн заавраар цас өвдөгцөө ороод байхад адуун сүргийг бөөгнүүлж хэдэн мянгаар нь тууж араас нь үхэр сүргээр цасыг дагтаршуулаад хонь ямаа үхэр тэрэг явахтай болсны эцэст гурван өдөр шөнө мацан чармайсаар энэ бэлчээрт хүрэлцэн ирсэн юм даг. Эндхийн цас хоёр тохой зузаан

хэрнээ өвсөн толгой түүнээс гурван хуруу өндөр цухуйж байсансан. Өлсөж туйлдсан үхэр мал мөөрч майлалдан гүйлдээд л, хүмүүс ч мөн өөрцгүй цасан дээр сөгдөн уйлалдаад эцэг тэнгэртээ мөргөн босоход нүүрэн дээр нь цас наалдсан байж билээ. Энд хонь, адуу туурайгаараа цас малтан өвс иднэ. Цас малтаж чаддаггүй үхэр тэдний гаргасан мөрөөр үлдсэн өвсийг түүж идсээр дийлэнх нь эсэн мэнд ирэх онтойгоо золгосон юм даг. Харин цас зуднаар нүүж чадаагүй айл хунарын хүн хар амиа тээгээд гарч чадсан боловч мал сүрэг нь цасанд дарагдаад үгүй болсон гэдэг. Хэрвээ тэр үед энэ нөөц бэлчээр байгаагүй бол Олонбулгийн талын хүн мал бүгд цас зуданд хиарах байсан болов уу. Хожим Олонбулгийн талд хичнээн айхтар зуд турхан боллоо ч гэсэн малчид төдийлөн айж тэвдэхээ больж ийшээ нүүдэллэн ирж гамшгийг өнгөрөөдөг болсон юм даа”

Өвгөн хөнгөн санаа алдаад “Энэ болвоос Олонбулгийн талын хүн малд хайрласан тэнгэрийн хишиг байгаа юм. Урьд нь малчид жил болгон л чанх урд харагдаж байгаа уулын орой дээр гарч эцэг тэнгэр болон уул усны эзэн сахиусыг тахидаг байж билээ. Харин ойрын хоёр гурван жил хувьсгал хөдөлгөөн энэ тэр гээд тийшээ зүглэх зоригтон байхгүй болсон. Гэхдээ хүн бүр л сэтгэлдээ сүслэн залбирдаг байлгүй дээ. Энэ уул тахилгатай болохоор Олонбулгийн талын малчид ямар ч айхтар ган гачиг тохиолоо гэсэн хавар зун намрын гурван улирал эндхийн бэлчээрийг хөнддөггүй юм. Эндхийн бэлчээрийг хамгаалах гэж адуучид л хөөрхий зовдог байх даа. Чонон сүрэг тав зургаан жил өнжөөд л баахан зээр хяддаг нь нэгэн бодлын хүнтэй адилхан эзэн сахиус, эцэг тэнгэрээ тахиж байгаа хэрэг юм. Энэ тахилгат уул хүн мал төдийгүй чононд ч хишиг буянаа харамгүй хайрласан даа. Чоно хүнээс дутахааргүй ухаантай амьтан болохоор хүн мал наашаа зүглээгүй цагт энэ газар орогнодог юм. Өдөр нь уулын орой хавийн хад асган дунд юм уу, эсвэл арын дагтаршсан цастай хэсэгт бүгж байгаад шөнө болохоор осгож үхсэн малын сэг зэмийг цасан дороос ухан гаргаж иднэ. Чоно чинь идэх л юм байвал хүн малд тэр болгон халтай амьтан биш шүү” гэв.

Хэсэг бусаг хөвөн цагаан үүл тэнгэрийн цээлд тааваар зорчино. Өвгөн гүн хөх тэнгэр рүү ихэд сүслэнгүй ширтлээ. Өрнөдийн шашны сэдэвт сонгодог зурган дээрээс л ийм ариун гэгээн харцыг олж харж болох мэт Чэнь Жэньд санагдлаа.

Өнөө жил энэ нутагт цас эрт унасан болохоор өвсний сөл тасраагүй шахам цасанд дарагджээ. Цасанд дарагдсан өвс зооринд хадгалаад удаагүй шинэ даршилсан ногоо шиг дэрсэн толгой болоод хунгар цасны сиймхийгээр үл мэдэг анхилуун үнэр ханхлуулна. Умард хөршийн цас зуд болоод өвс тэжээлийн хомсдлоос дайжин хил даван ирсэн зээрийн сүрэг энэ нутагт ирээд өвөл цагийн баян бүрд лугаа учирсан адил өвсний сөл шимд автан нутаг сэлгэхийг мартсан ажээ. Тэд шимтэй өвсийг цүдийтэл идэж тарга тэвээрэг хангалттай авсан тул төдий л хурдлан гүйж чадахааргүй харагдана.

Талын азарган чоно болоод Билиг өвгөн хоёр л зээрийн сүргийн энэ алдааг олж харж чадсан болов уу.

Энэ зээрийн сүрэг бас ч тийм томд тооцогдохооргүй юм. Чэнь Жэнь анх Олонбулгийн талд ирсэн анхны жил үе үе хэдэн түмээрээ чуулан яваа зээрийн сүргийг хардаг байж билээ. Аж ахуйн нэгэн ажилтны ярьснаар 60-аад оны эхэн үеэр тохиосон гурван жилийн айхтар өлөн зэлмүүн үед умардын цэргийн тойргийн дайчид байлдааны машин автомат буутайгаа ирээд тал хээрийн тоо томшгүй олон зээрийн сүргийг хядаж цэргийн хэрэгцээнд зориулдаг байсан

гэнэ. Түүний уршгаар дийлэнх зээр хилийн чанад руу дайжин оджээ. Сүүлийн жилүүдэд хил хязгаарын байдал түгшүүртэй тул зээрийг олноор нь хядах явдал намжиж Олонбулгийн талын уудам бэлчирт зээрийн сүрэг сүр жавхаатай цахилан явахыг харах боломжтой болжээ. Чэнь Жэнь хонь хариулж явах зуур тоо томшгүй олон зээрийн сүрэг тал хөндийг бүрхсэн шаргал салхи мэт хонь малын захыг шүргэн өнгөрнө. Хонь ямаад хуйлран бөөгнөрөөд тааваараа сүрэглэн өнгөрөх зэрлэг адгууснуудыг айж эмээсэн атлаа атаархангуй ширтэн хардаг байлаа.

Олонбулгийн талын зээрийн сүрэг буугүй хүнээс үргэж айна гэж бараг үгүй. Нэгэн удаа Чэнь Жэнь морьтойгоо хошууран бэлчих зээрийн сүрэг рүү дайран ороод нэгийг бугуйлдан авч хангайн хишгийг хүртье гэж бодсон юм. Гэвч зээр гаргууд сайн анч нохой болоод чононд гүйцэгддэггүй тал нутгийн хамгийн хурдан дөрвөн туурайтан амьтан болохоор түүний санаан зоргоор баригдах юм гэж хаа байх билээ дээ. Чэнь Жэнь ташуураа эргүүлэн хэдэнтээ дайран орсон боловч зээрийн үс хялгасанд ч хүрч чадаагүй. Зээрийн сүрэг түүний хоёр хажуугаар хэдэн арван метрийн зайтай яралзан өнгөрснөө бөөгнөрөн нийлээд цааш давхилдана. Чэнь Жэнь тэр гайхалтай үзэмжийг алмайран гайхсаар хоцорсон юм даг.

Нүдний өмнөх энэ сүрэг дунд зэргийнхэд тооцогдох боловч Чэнь Жэньгийн санахаар хэдэн арван чонын хувьд хавьгүй ахдахаар байв. Чоныг хорвоогийн хамгийн ховдог шунахай амьтан гэлцдэг. Тэгвэл энэ удаа чонын хэр зэрэг ховдог шунахай агаад ав хомрогын тал дээр гаргууд болохыг харах хүсэл нь оволзож байлаа.

Чонон сүрэг энэ удаагийн ав хомрогын боломжийг маш чухалчилж байгаа бололтой үйл хөдлөл нь маш хашир хянуур байх ажээ. Зээрийн сүрэг дэх ганц нэгэн ооно толгой өргөн бараа харуулдах төдийхөнд чонон сүрэг өвсөн дунд навтгасхийн бүтээд амьсгал даран хэвтэцгээнэ.

Зээрийн сүрэг тайвуухан идээшилсэн хэвээр, манай хоёр ч тэвчээртэй хүлээсээр байв. “Зээр гэдэг амьтан хурдан давхилтай, идэш ихтэй болохоор тал нутгийн хувьд их хөнөөлтэй байдаг юм. Чи тэдний хэр зэрэг их өвс идчихэж байгааг харж байгаа биз дээ? Манай багийнхан арайхийж нөөцөлж үлдээсэн бэлчээрийг энэ хэдхэн өдрийн хугацаанд хугаслаад орхилоо. Дахиад хэдэн сүрэг зээр хүрээд ирэх юм бол энэ хавьд малын хамар хатгах өвс үлдэхгүй болно гэсэн үг. Өнөө жил цас их унасан болохоор зуд турхан болохыг ч хэн байг гэх вэ? Тийм болохоор энэ нөөц бэлчээрийг хадгалж байхгүй бол хүн малгүй хэцүүднэ. Харин сүрэг чонын буянаар энэ хавь зээрийн аюулаас гэтэлж байгаа юм” хэмээн өвгөн дөлгөөхнөөр өгүүлнэ.

Чэнь Жэнь цочих шиг болоод “Та чоно авладаггүй чинь ийм учиртай байсан юм бий?” хэмээн асуулаа.

“Чоно авлах нь ч авлана аа. Гэхдээ хамаагүй агнаж болохгүй. Хэрвээ чоно байхгүй болчихвол тал нутаг сүйрлээ гэсэн үг. Тал маань талхлагдаад дуусвал хүн мал яахин амьд гарах билээ? Танай хятадууд ч энэ ёсыг яахин ойлгох вэ дээ?”

“Ийм сайхан ёс байдгийг би одоо ойлгодог болоод байгаа” гэж хэлэхдээ Чэнь Жэньгийн сэтгэл нэг л ер бусын ихээр догдолж, чонон сүлдийн бүдэг бадаг дүрсийг олж харах шиг

санагдлаа. Хоёр жилийн өмнө Бээжингээс наашаа гарахын өмнө тэр тал нутгийн малчин түмний тухай ном хэвлэлийг цуглуулан уншиж байхдаа анх удаа нүүдэлчин үндэстэн чонон сүлдийг дээдэлдэг болохыг олж мэдсэн юм. Харин хань үндэстэн болоод бусад суурьшмал үндэстнүүдийн өширхөн үздэг чоныг нүүдэлчин монголчууд яагаад дээдлэн шүтэж сүр сүлдээ болгож явдгийг одоо л бага сага ойлгож эхлээд байгаа нь энэ билээ.

Өвгөн нүдээ жоохойлгон Чэнь Жэньг хэсэг зуур харсанаа “Танай Бээжингийн илгээлтийн эзэд монгол гэр бариад жил тойрч байгаа боловч бүрээс туурга муутай юм билээ. Хоёулаа ахиу хэдэн зээрийн олзтой болчихвол түүхий эд бэлтгэлийн цэг, ханган нийлүүлэх хоршоонд өгөөд хэд гурван эсгий олж та дөрвийг дулаацуулж өгье” гэв. Чэнь Жэнь хариуд нь: “Яасан сайн хэрэг вэ? Манай гэр хоёр давхар саримгар бүрээстэй болохоор өглөө босоход бэхний шил хүртэл хөлдөөд хагарчихсан байдаг юм” гэв. Өвгөн инээвхийлээд “Чи харж байна уу? Энэ сүрэг чоно удахгүй та бүхэнд том бэлэг барих гэж байна шүү дээ” хэмээн өгүүллээ.

Олонбулгийн талд нэг том ооно арьстайгаа 20 юань хүрдэг нь малчин хүний хагас сарын орлоготой тэнцэх хэмжээний мөнгө юм. Зээрийн арьс гэдэг бол дээд зэргийн савхин хүрэм хийх материал болдог. Түүхий эд бэлтгэлийн цэгийн хүний ярьсанаар нисгэгчийн савхин хүрмийг зээрийн арьсаар хийдэг боловч хятад нисгэгч нарт тийм хувь оногддоггүй. Жил болгон монголын талд агнасан зээрийн арьсыг Зөвлөлт болон зүүн европын улсуудад гаргаж ган, автомашин, зэр зэвсэг зэргээр сольдог ажээ. Харин зээрийн нурууны махаар хийсэн консерв их үнэ хүрдэг болохоор мөн л гадаадад гаргадаг гэнэ. Харин үлдсэн жаахан мах ясыг нь дотоодын хэрэгцээнд нийлүүлдэг бөгөөд өвөрмонголын хошуу сумын махны дэлгүүрийн лангуун дээр нүдний гэм мэт үзэгдээд өнгөрөх мөртлөө хүнсний талонтой хүн авах боломжтой байдаг билээ.

Өнөө жилийн өвөл зээрийн сүрэг олноороо хил даван орж ирсэн нь хил орчмын нэгдэл болоод хошуу сумын удирдлагуудыг баярлуулсан гэж жигтэйхэн. Өдийд орон нутгийн бэлтгэн нийлүүлэх цэгүүд агуулах саваа бэлтгэн зээрийн мах худалдан авахаар зэхээд байж таарна. Удирдах ажилтнууд, анчин, малчид бүгдээрээ л том заарцагтай 2 таарсан загасчин адил олзын уугаа дүүргээд авья гэж бодох нь ч аргагүй. Багийн олонх анчин адуучид хурдан хүлгээ барьж унаад анч нохой ангийн бугаа авч зээрийн авд мордоцгоосон. Чэнь Жэньгийн хувьд хониноосоо холдох аргагүйн дээр буу сум байхгүй. Тэгээд ч адуучид долоо найм, арав хорин уналгын морьтой байдаг бол хоньчин хүнд гурав дөрвөөс илүү сэлгэх унаа морь байхгүй. Тийм болохоор илгээлтийн эзэд анчдыг бүлтийтэл ширтээд хоцрохоос өөр ямар нэмэр байх билээ. Уржигдар орой Чэнь Жэнь анчин Лхамжавын очтол зээрийн сүрэг нүүдэллэн ирээд хэд хонож байгаа болохоор арван нэгэн зээр агналаа. Нэг сумаар хоёр ч зээр онодог байна шүү гэж ярьж билээ. Хэдхэн өдрийн ангийн орлого адуучин хүний гурван сарын цалин хөлстэй тэнцэхээр олз омгийг түүнд өгчээ. Нэг жилийн архи тамхины мөнгөндөө санаа зоволтгүй боллоо. Дахин хэдэн өдөр зээрийн ан хийгээд цоо шинэ “Улаан дэнлүү” маркийн зайгаар явдаг хүлээн авагч худалдан аваад гэрээ гоёж, хуучин байсныгаа оторт авч явна гэж байв. Түүний гэрт Чэнь Жэнь анх удаа зээрийн чанасан мах идэж үзсэн нь тал нутгийн таван тансгийн нэг гэж болохоор ажээ. Сум шиг цахилах зээр урт удаан он жилүүдийн турш чонотой хурд хүчээ сорьсоор махны амт чанар сайжирч гөрөөснийхөөс дутахааргүй амттай болсон байж таарна.



Олонбулгийн талд зээрийн сүрэг нүүдэллэн ирсэнээс хойш Бээжингээс ирсэн илгээлтийн эзэд үнсэнд хаягдсан шалз мэт тоох хүнгүй үлдэж хоцорсон юм. Хоёр жилийн хугацаанд илгээлтийн эзэд бие дааж үхэр хонь хариулж чадахуйц болсон боловч ан авын тухайд наад захын ойлголт байхгүй. Харин өвөрмонголын зүүн хэсгийн хил орчмын бүс нутаг дахь нүүдлийн амьдралын хэвшилд ан ав ихээхэн чухал байр суурь эзлэнэ. Монгол үндэстний өвөг дээдэс Хар мөрөн мужийн дээд эх дэх ойн анчин гөрөөчин овог байснаа улмаар монголын талд шилжин очиж ан гөрөө мал ахуйг хоршин амьдрах болсон юм. Ан ав айл гэрийн чухал орлого төдийгүй зарим үед гол орлогын эх үүсвэр болдог ажээ. Олонбулгийн талын малчдын дотор адуучид хүндтэй байр суурь эзлэдгийн гол учир олонх сайн анчид бүгд адуучин гаралтай байдагтай холбоотой. Илгээлтийн эздээс адуучин болсон нь тоотой хэдхэн бөгөөд голцуу туслах малчин төдийхөн тул сайн адуучин болох яагаа ч үгүй гэсэн үг. Тийм болохоор ан авын олз омгийн энэ ид үед өөрсдийгөө дөнгөж л нэг шинэ малчингийн энд хүрлээ гэж тооцох болсон илгээлтийн эзэд ангийн отгийг бараадан явах хувь хаанаас олдох билээ.

Чэнь Жэнь зээрийн махнаас цадтал идчихээд Лхамжавын өгсөн зээрийн гуаыг ганзгалан Билиг өвгөний гэрт шуугиулан хүрчээ.

Илгээлтийн эзэд хэдийгээр өөрсдийн гэр бараатай болсон боловч Чэнь Жэнь урьдын адилаар хөгшин аавындаа айлчлан очих дуртай. Тэдний гэр уужим саруул, нэг л сэтгэлд өег, хойморт шарын шашны холбоо бүхий хээ хуартай зураг хадаж, шалан дээр марал бугын дүрс бүхий хивс дэвсээстэй. Явган ширээн дээрх мөнгөн аяга болон эрэгнэгэн дээрх гуулин данх, таваг зэргийг гялалзтал арчиж зүлгэсэн харагдана. Энэ газар дээд тэнгэр дэргэдэх нөхрөөс өөр хүнгүй тул улаан хамгаалагчдын “Дөрвөн хуучинсгийг эвдлэн устгах” хөдөлгөөн өвгөний өлгөж зүүсэн хивс зэрэг эдлэл хэрэгсэлд халдаж амжаагүй үе байсан юм. Чэнь Жэньг оролцуулаад нэг монгол гэрт амьдардаг дөрвөн илгээлтийн эзэнЗ залуус Бээжингийн ахлах дунд сургуульд хамт сурч байжээ. Тэдний гурав нь “Хөрөнгөтний урсгалаар замнагч хар бүлгийн” гишүүн эсвэл харгис бурангуй эрдэмтний хүү гэх зэргээр туулсан замнал ижил төстэй тул тун амь нэгтэй амьдарцгаана. Тэд нар хэт даврагч улаан хамгаалагчдад туйлаас таагүй ханддаг болохоор 1967 оны өвлийн эхэн сард ганзага нийлэхээр санаа шулуудан үймээн шуугиан дунд оволзон байсан Бээжингээс холдож, нам сэлүүн амьдралыг шүтэж тал нутгийг зорин иржээ. Тийм болохоор ийнхүү амь санаа нэгтэй байх нь ч аргагүй юм. Билиг өвгөний монгол гэр тал нутгийн овгийн ахлагчийн орд өргөө мэт хайр энэрлийг хүртээдэг болохоор улам ч дотно амар тайван санагддаг байлаа.

Хоёр жилийн турш өвгөнийхөн түүнд гэр бүлийн нэгэн гишүүн мэт дотно хандахын зэрэгцээ Чэнь Жэньгийн Бээжин хотоос тээн авчирсан хоёр чемодан дүүрэн ном, ялангуяа монголын түүхтэй холбоо бүхий сурвалж бичгүүд нь өвгөн болон түүний өргөж авснаас өөрцгүй хятад хүүгийн хоорондын харилцааг улам ойртуулж өгсөн юм. Өвгөн их зочломтгойгоос гадна цөөнгүй үлгэрч туульч нөхөдтэй байсан тул монголын түүх домгийг чамгүй их мэдэх нэгэн ажгуу. Өвгөн Чэнь Жэньгийн номнууд болон түүн дээрх зураг, газрын зураг сэлтийг үзэж, хятад, орос, перс болон бусад улсын зохиолч түүхчдийн бичсэн монголын түүхийн талаар ихэд сонирхох болов. Хятад хэлийг дутуу хагас гадарладаг Билиг өвгөн цаг зав гарвал Чэнь Жэньд монгол хэл зааж улмаар номонд юу бичсэнийг сайтар ойлгодог болох гэж чармайна. Дээр нь өөрийн мэддэг монгол үлгэр домгийг ярьж өгсөөр өнгөрсөн хугацаанд хөгшин хөвөө хятад монгол хоёр бие биесээ нэлээд сайн ойлголцдог болж билээ.

Гэсэн хэдий ч Чэнь Жэнь хятад болон өрнөдийн зарим түүхчид монгол үндэстнийг өширхөж дайсагнасан байр сууринаас бичсэн түүхийн зохиолуудыг түүнд ярьж өгөхөөс жийрхдэг байлаа. Тал нутагт ирсэнээс хойш Чэнь Жэнь Юэ Фэйгийн “Улаанаар урвах мөрөн”<sup>4</sup> дууг амандаа аялахаа ч больсон. Чэнь Жэнь суурьшмал иргэд болон нүүдэлчдийн өшөө хорслын уг сурвалж юу болох, түүнчлэн хүн ам цөөтэй нүүдэлчин монголууд дэлхийн түүхэнд цөмийн дэлбэрэлт адил аймшигтай сүр хүчийг үзүүлж чадсан учир шалтгаан чухам юунд байсныг олох гэж хэрхэндээ чармайна.

Чэнь Жэнь уг нь Билиг өвгөнийхөөс салж явах дургүй байв. Гэвч өвс ургамал жигдэрсэн Олонбулгийн талд мал сүргийн тоо толгой өсөж үржсээр зарим суурьт хонь хургалсаны дараа сүргийн тоо толгой гурван мянгыг давсан тул ганц нэг малчин хариулж дийлэхээргүй болжээ. Тоо толгой олширсон хоньдыг дахин хувааж хариулах шаардлагатай болсон тул Чэнь Жэнь бусад гурван нөхрийн хамтаар шинэ монгол гэр бариад тусдаа амьдрах болсон юм. Азаар хоёр хотны хооронд хонь нохдын дуу бие биесдээ сонсогдохоор ойрхон, цай даргихын төдийд хоёр гэрийнхэн харилцан ирж очиж болохоор ажээ. Тийм болохоор тусдаа гарсаны дараа ч гэсэн Чэнь Жэнь хөгшин аавынхаараа байнга орж гарч, урьдын яриа хөөрөөгөө үргэжлүүлдэг байлаа. Харин энэ удаа зээр болон чонын тухай ярихаар очив.

Чэнь Жэнь тэмээний ноосоор өлзий хээ зээглэж урласан эсгий үүдийг сөхөж зузаан олбогон дээр суугаад сүүтэй цай оочлоно. “Чи битгий хүний агнасан зээрийн маханд нүдээ унагачих гээд байж үз. Би маргааш чамайг дагуулан явж тэрэг дүүрэн зээр агнаад ирэмз. Би ойрдоо уул Хангайгаа хэдэнтээ тойрч үзээд хаана зээр агнаж болохыг мэдэж авсан. Далимаар нь хөгшин аав чинь чамд чонон сүргийг ойроос харуулъя. Чи чинь дандаа л чоно ярьж явдаг биз дээ? Танай хятадууд өвс идсээр байгаад хонь шиг болсон улс. Харин манай монголчууд мах иддэг чоно л гэсэн үг. Тийм болохоор чи жаахан ч гэсэн чонын зүрх зоригтой болвол зүгээрсэн” гэж билээ.

Хоёрдахь өдрийн өглөө эрт Чэнь Жэнь өвгөнийг дагалдан баруун өмнөх том хар уулын бэлд бүгэн хэвтсэн нь энэ. Өвгөн ганц дурангаас өөр буу авах нь байтугай, нохойгоо ч дагуулж явсангүй. Чэнь Жэнь урьд өвгөнийг дагалдан хэдэн ч удаа үнэг авлаж байсан боловч энэ мэт гар нүцгэн ангуучилж байгаа нь анх удаа юм. Дурангаар ан хийж болно гэж үү хэмээн Чэнь Жэнь өвгөнөөс хэдэн ч удаа асуусан боловч инээвхийлэх төдий хариулалгүй өнгөрчээ. Өвгөн залуу шавийнхаа сониучирхал болон эргэлзээнд тулгуурлан өөрийнхөө өвлөсөн мэдлэг чадварыг сургадаг онцлогтой.

Чэнь Жэнь дурангаараа зээрийн сүргийг бүслэн дөхөж байгаа чонон сүргийг олж үзээд хөгшин аавынхаа ямар аргаар ан хийх гэж байгаагийн учрыг олоод бахдан инээхэд хөгшин ч зальжингуй хөхөрнө. Чэнь Жэнь хав загас халиун хөхөч шувуу лугаа ноцолдоход хажууд нь байсан загасчин өвгөнд том олз болсон үлгэрийг<sup>5</sup> өөрийн эрхгүй саналаа. Харин өөрөө туршлага багатай загасчин бол Билиг хөгшнийг үлгэрт гардагт загасчин өвгөнтэй зүйрлэж болох юм. Олонбулгийн талын эрэмгий зориг, цөлх хар ухаантай өвгөн анчин түүнийг энэ газар дагуулан ирээд морьтын хишиг хүртээдэг байна шүү. Чэнь Жэнь чоныг олж харсан цагаас эхлэн хүйтэн жаврыг ажрахаа байгаад, биеийн хамаг цус огшин хөөрөх шиг болж, чонон сүргээс айн жийрхэх нь ор мөргүй алга болов.

Аглаг уулын дээр мэлтийх тэнгэрт бөртийх ч үүлгүй, салхигүй тогтуун атлаа цаанаа л нэг

жиндүү хүйтэн байлаа. Чэнь Жэньгийн хоёр хөл даарч, гэдэс хэвлий цээжнээс жиндэхэд чонын арьсан дэвсгэртэй байсан бол мөн сайхан аа хэмээн бодогдоно. Ийн бодох зуур байн байн санагддаг эргэлзээтэй асуудал тархинд сэрхийн харваж намуухан дуугаар: “Эндхийн хүмүүс цөөнгүй чоно авладаг хэрнээ яахаараа айл хунараар чонын арьсан дэвсгэр харагддаггүй юм бэ? Адуучид өвлийн шөнө хээр хонохдоо хүртэл чонон гудас хэрэглэхгүй юм. Би ганцхан Доржийнд л чонон гудас харсан юм байна. Бас түүний эцэг гутлынхаа гадуур чонын арьсан түрийг угласан яваа харагддаг. Чонын арьс хөл сайхан бүлээцүүлдэг. Хэдэн сар өмсөөд л даарамхай хөл нь хөлс чийхардаг боллоо гэж байсан. Аав аа, хөгшин ээжийн хөл ч гэсэн даарамхай атлаа яахаараа түүнд чонын арьсан түрий хийж өгч болдоггүй билээ?” хэмээн асуулаа.

Хөгшин хариуд нь “Доржийнх зүүн хойд нутгийн цөөхөн үхэр хоньтой тариа тарьдаг айл байсан юм гэнэ лээ. Тэнд хятадууд олонтой болохоор зан заншил нь ч хятаджсан хэрэг. Тэр монголоо мартсан моньд өвөг дээдсийн онгон шүтээн, өөрийн уг сурвалжийг мартаж л дээ. Гэрийн хүн нь үхэхээр хээр тавьж чононд өргөхгүй, модон авсанд хийгээд газарт булчихаж байгаа улс чинь чонын арьсыг бүсэлхийнээс доош газар хэрэглэж дороо дэвсэж унтахаас биш яах билээ? Тал нутагт үнэндээ чонын арьс үс хамгийн хөрслөг зузаан болохоор хүйтнээс найдвартай сайн хамгаалдаг нь үнэн. Давхар хонины нэхий ч ганц чонын арьс шиг дулаан байж чаддаггүй юм. Дээд тэнгэр чоныг таалдаг болохоор хамгийн сайн арьс үс хүртээсэн хэрэг байж таарна. Гэвч монголчууд угаас чоныг дээдлэн шүтэж ирсэн болохоор чонын арьсан дэвсгэр гудас хийдэггүй. Монголоо алдсан улс л тийм юм хийх байх. Тал нутгийн монголчууд хөлдөж үхэж байсан ч хамаагүй чонын арьсан дээр унтаж хэвтэхгүй. Чонын арьсан дээр унтаж хэвтэж байгаа монгол хүн монголчуудын онгон шүтээнийг гутаан доромжилж байгаа болохоор яахин төрөл арилжаад тэнгэрт залрах билээ? Эцэг тэнгэр яагаад чононд талтай байдгийг чи өөрөө сайн бодоорой л доо” гэв.

“Та тэгэхээр чоно бол тал нутгийн хамгаалагч сахиус гэх гээд байна уу?” гэж Чэнь Жэнь асуулаа.

Өвгөн жонийтол инээгээд: “Тэгэлгүй яахав. Тэнгэр бол эцэг маань, тэнүүн тал эх минь юм шүү. Чоно талд хөнөөлтэй бүхнийг алж устгаж байдаг болохоор тэнгэр түүнийг таалж байдаг хэрэг” гэлээ.

Чонон сүрэг нэлээд хөдөлгөөн ороход мань хоёр толгойгоо өргөн хэдэн чонон дээр дурангаа тогтоон харлаа. Гэвч чононууд доош тонгойн дахин хөдлөхгүй хэвтэцгээв. Чэнь Жэнь өндөр өвсөн дундахь чононуудыг сайтар ажиглан харах боловч үнэндээ ямар нэгэн үйл хөдлөлийг дахин олж үзсэнгүй.

Өвгөн түүнд өөрийн нэг нүдний дуранг өгснөөр Чэнь Жэнь хоёр нүдний дурангаар чонын ав хомрогын байдлыг ажиглан харах боломжтой болжээ. Энэхүү нэг нүднийх болгон салгасан Зөвлөлтөд үйлдвэрлэсэн цэргийн зориулалттай хоёр нүдний дуранг Билиг өвгөн хорь гаруй жилийн өмнө Олонбулгийн талд явагдсан Зөвлөлт японы байлдааны талбараас олжээ. Олонбулгийн тал нь Их Хянганы нурууны баруун өмнөд хормойд Бээжингийн чанх хойно, монгол улстай хиллэн оршдог. Эртнээс нааш зүүн хойт нутаг болон монголын хээр талын өмнө зүгт нэвтрэх гол зам байсан тул янз бүрийн нүүдэлчин үндэстэн угсаатнуудын булаалдан байлдах гол талбар болсоор иржээ. Одоо бол нүүдэлчин болон суурьшмал

иргэдийн далд мөргөлдөөний торгон уулзвар гэж болохоор газар юм. Хоёрдугаар дайны үеэр энэ нутгийн умард хэсгээс холгүйхэн Зөвлөлт Японы хооронд ширүүн байлдаан болж байсан удаатай. Дэлхийн хоёрдугаар дайны сүүлчээр Зөвлөлт монголын дайчид зүүн хойт хятад руу нэвтрэх гол зам үүгээр дайран өнгөрсөн болохоор өнөө хэр Олонбулгийн талд голын хатсан сайр мэт танкийн мөрөөр гарсан хэдэн зурвас зам болоод Зөвлөлт японы танк, хуягт тээвэрлэгчийн сэг үлдэж хоцорчээ. Эндхийн малчин айл өрх бүр Зөвлөлт япон хийцийн байлдааны жад, усны багвар, төмөр хүрз, ган дуулга болон дуран зэрэг цэргийн эдлэл хэрэгслийг хэрэглэсээр байдаг бөгөөд байлдааны дуранг бүр ч илүү нандигнан хайрлана. Өдгөө ийм дуран Олонбулгийн талын малчдын чухал үйлдвэрлэлийн хэрэгсэл болон хувирчээ.

Олонбулгийн талын малчид хоёр нүдний дуранг нэг нүднийх болгон салгаж хэрэглэх дуртай. Энэ нь авч явахад авсаархан төдийгүй хоёр хүн хэрэглэж болдог давуу талтай юм. Ер нь малчид өөрсдийн үйддвэрлэн гаргаж чаддаггүй эдлэл хэрэгсэлд онцгой хямгатай ханддаг. Талын монгол малчдын хараа онцгой сайн боловч яахин чонын хурц хараатай зүйрлэж болох билээ. Харин нэг нүдний дуран хүний харааг чоныхоос ч илүү хурц тод болгож чаддаг онцлогтой. Тал нутагт дуран хэрэглээнд нэвтэрсэн цагаас хойш анчдын олз омог нэмэгдэж, алдсан адуу малыг амархан олдог болсон гэж Билиг өвгөн ярьдаг. Өвгөний ажигласнаар чонын хараа ч сүүлийн үед улам гойд хурц болоод байгаа ажээ. Хол яваа чоныг дурангаар тогтоон харах үед заримдаа чоно дурангийн харааг ажиглан зогсож байдаг гэнэ.

Чэнь Жэнь тэдний гэрт хагас жил болсоны хойно Билиг өвгөн чингэлэгийн ёроолыг онгичсоор энэ нэг нүдний дуранг гаргаж өгчээ. Билигийн хүү Бат түүний энэ дуранд нүдээ унагах шахна. Хашир адуучин Бат өнөө хэр дотоод үйлдвэрийн дуран хэрэглэдэг. Дээр үед Зөвлөлтөд үйлдвэрлэсэн энэ дуран олон жилийн настай, будаг нь халцраад гууль нь гарсан ч эдэлгээний чанараа алдаагүй, таталт онцгой сайн болохоор Чэнь Жэнь амь шигээ нандигнаж, улаан торгоор боочихоод үхэр малын эрэл, Билиг өвгөнийг дагалдан ан авд явах зэрэг тоотой хэдхэн тохиолдолд л гаргаж хэрэглэнэ.

Чэнь Жэнь авын талбайг нэгд нэгэнгүй эргүүлж тойруулан харлаа. Анчин хүний нүднээс өөрцгүй энэхүү дурантай болсон цагаас хойш түүний сэтгэлийн гүнд нуугдаж байсан анч чанар нь өдөөгдөн сэрсэн билээ. Хүн төрөлхтний өвөг дээдэс бүгд л анчин гөрөөчин улс байсан. Тийм ч учраас анчин гэдэг бол дэлхий дээр хамгийн анх үүссэн, хамгийн урт настай мэргэжил юм. Хэдийгээр тэр хятадын хамгийн хөгжингүй газар болох нийслэл хотоос бүр балар эртний унаган төрхөө хадгалсан тал нутагт ирээд хөгжил дэвшил гэхээр юм үгүй ч гэсэн хүн төрөлхтний амьдралын эрт балрын тэр л хэвшлээр амьдраад үзмээр санагдах үе Чэнь Жэньд бишгүй тохиодог байв. Түүний анч чанар өдий насанд хүрээд өдөөгдөн сэрсэн нь дэндүү орой мэт, өөрөө суурьшмал тариачин үндэстний үр хойч болж төрсөн нь гунигтай ч юм шиг. Суурьшмал үндэстэн хэдэн арав, магадгүй бүр хэдэн зуун үеэрээ тариа ногоо идсээр хонь мэт сул дорой болон хувирч бүр эрт балрын нүүдэлчин өвгийн цусанд шингээстэй байсан анч чанараа гээснээр хүчирхэг гүрнүүдийн олз төдийхөн болжээ.

Чонон сүрэг дайрах төлөв огт үгүй тул Чэнь Жэнь тэдний тэвчээрийн өмнө бараг л тэсвэр алдаж эхлэлээ. Тэгээд өвгөнөөс “Өнөөдөр чонон сүрэг хомрогolon дайрахгүй, шөнө болохыг хүлээгээд байгаа хэрэг биш биз дээ?” хэмээн асуулаа.

“Дайтаж байгаа тал тэвчээргүй байж яахин болох билээ? Хорвоогийн боломж завшаан гэдэг зөвхөн тэвчээртэй хүн адгуус хоёрт л оногдох учиртай. Тийм болохоор тэвчээрийн ач тусыг ойлгосон хүн завшааныг анаж байдаг юм даа. Чингис хаан тийм цөөхөн цэргээрээ их Алтан улсын нэг сая цэргийг яаж ялсан гэж бодож байна вэ? Түүгээр ч зогсохгүй хэдэн арван улс орныг байлдан эзлэсэн. Тэдэнд ганц чонын омог сүр төдийхөн биш, бас чонын тэвчээр хатуужил байсан юм шүү. Хичнээн хүч чадалтай дайсан ч гэсэн төөрөгдөн алдах үе бишгүй л байдаг. Морь хэмээх том биетэй адгуус алмайтан төөрөгдөж байгаад л өөрөөсөө хавьгүй жижиг чононд бариулж байгаа юм. Тэвчээргүй хүнд чоно, анчин, Чингис хаан болох хувь дутна. Чи дандаа л чоно болон Чингис хааны тухай ярьж өгөөч гэж гуйгаад байдаг хүн эхлээд сайтар тэвчээртэй хэвтэж сур” хэмээн өвгөн намуухнаар хэлэв.

Өвгөн нэлээд уцаарлангуй байгааг хараад Чэнь Жэнь дахин олон юм асуусангүй өөрийгөө хүчлэн тэвчээрээ хурцалж эхлэлээ. Тэр урьд нь олонтоо ажигласан нэгэн чоныг тогтоон харваас яг л үхсэн мэт түрүүчийн янзаараа хэвтсээр л байх ажээ. Өвгөн нэлээд уужирсан бололтой: “Чоно ийм удаан хэвтээд чухам юу хүлээж байгааг чи ойлгож байна уу?” хэмээн асуулаа. Чэнь Жэнь толгой сэгсрэв. “Чоно зээрийн сүрэг цадтал идээд зүүрмэглэхийг хүлээж байгаа юм” гэж өвгөн хэллээ.

Чэнь Жэнь сэртэсхийн гайхаж: “Цатгалан зээр хурдан давхиж чадахгүй. Чоно чинь тэр үеийг хүлээж байгаад дайрах хэрэгтэй гэдгийг хүртэл мэддэг ухаантай амьтан гэж үү дээ?” хэмээн асуулаа.

“Танай хятадууд чоныг яаж ойлгох билээ? Чоно чинь үнэндээ хүнээс ч илүү сийрэгхэн амьтан. Би чамайг дахин нэг шалгаадахъя. Нэг том саарал чоно ганцаараа нэг ооныг барьж дийлэх үү?” хэмээн өвгөн асуув.

Чэнь Жэнь хэсэг зуур бодсоноо “Гурван чонын хоёр нь хөөгөөд нэг нь отоож байвал нэг ооныг барьж магадгүй. Түүнээс биш ганц чоно бол яасан ч барьж чадахгүй” гэж хэлэв.

Өвгөн толгой сэгсрээд “Чи ч итгэхгүй байх л даа. Хашир чоно бол ганцаараа нэгийг өлхөн барьчихдаг юм” гэлээ.

Чэнь Жэнь өвгөнийг улам ч гайхсан байдалтай хараад “Тэр яаж чаддаг хэрэг вэ? Ёстой ухаан санаанд багтамгүй зүйл гэдэг чинь тэр байна даа” гэв.

“Чоно тун уран арга хэрэглэж зээрийг барьдаг. Чоно өдөр нэг зээрийг онилж харсан бол шууд түүнийг хөөхгүй. Шөнө орой болоход зээр өтгөн өвстэй нөмөр газар хэвтээд унтахад нь ч түүн рүү гэтэхгүй. Зээр хэдийгээр унтаад өгсөн ч үнэр сонорын эрхтэн нь сэрүүн байдаг тул өчүүхэн төдий ажиг сэжиг гарангуут яах ийхийн зуургүй дэгдэн зугатаах чадалтай байдаг. Тийм болохоор чоно хөөгөөд ч гүйцэхгүй алдчихна. Чоно холгүйхэн газар хэвтчихээд шөнөжин үхэн хатан хүлээгээд л байна. Тэгсээр үүр цайгаад зээрийн давсаг чинэрчихсэн байх яг тэр агшинд л ухасхийн дайрна даа. Шээж чадаагүй зугатсан зээр удалгүй гүйдэлдээ давсаг нь хагарч хойт хөлийн шөрмөс татаад холдож чадалгүй баригддаг юм. Зээр хэдийгээр хурдан давхилтай амьтан ч гэсэн бас гүйж чаддаггүй үе байдаг болохыг чи одоо ойлгов уу? Хашир чоно, азарган чононууд энэ завшааныг мэддэг учраас ганцаараа байсан ч төвөггүй нэг зээрийг барьчихаж чадна. Харин эсрэгээр хашир ооно шаргачин халуун хэвтэртээ хоргодоод

байлгүй шөнө дүлээр ч гэсэн шээсээ суллагчид учраас чононд хөөгдөөд гүйцэгддэггүй юм. Олонбулгийн талын анчин үүр цүүрээр чононд бариулсан зээрийн гэдсийг яраад үзэхэд давсаг нь үнэхээр хагарсан байдаг” гэж өвгөн хүүрнэв.

Чэнь Жэнь чимээгүйхэн инээд алдаад “Тэнгэр намайг гэсгээсэн ч чононд тийм гайхалтай арга ухаан бий гэдгийг бодож олж чадахгүй юм байна. Ямар гайхалтай чадал тэвчээр вэ? Гэхдээ монгол анчин чононоос ч илүү уран аргатай ажээ” гэлээ.

Өвгөн ч мөн хөгжилтэйгөөр “Монгол анчид чинь чонын шавь нар учраас арга зальтай байлгүй яах вэ?” гэв.

Олонх зээр цүдийтэл идээд гэдэс нь шөнөжин чинэрсэн давсагнаас ч дутахааргүй томорчээ. Заримынх нь дөрвөн мөч бүр сарвайсан харагдана. Өвгөн дурандан харсанаа “Зээр хөдлөж ч чадахааргүй цаджээ. Чоно одоо л дайрна даа. Чи харж байгаарай” гэлээ.

Чэнь Жэнь ихэд догдолж эхлэв. Чонон сүрэг зүүн баруун хойт талаас хагас саран бүслэлтээ хумьж эхлэв. Харин урд талд нь нэг уулын хяр хөндөлсөх ажээ. Хярын цаана хэсэг чоно бүгчихээд ерөнхий давшилт эхлэж зээрийн сүргийг тийш туун аваачихад бүгсэн чононууд өөдөөс нь тосон дайраад зээрийн сүргийг хүйс тэмтэрч орхих биз гэсэн шүү юм Чэнь Жэнь бодож байлаа. Тэр урьд нь хэдэн чоно ганц нэг зээрийг ийм аргаар барьдаг тухай малчдын ярихыг сонсохоороо л нэг болсон. “Аав аа, энэ хярын цаана хэдэн чоно байгаа вэ? Хэрвээ тоо нь цөөн бол энэ бүслэлт амжилтгүй болох биш үү?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Өвгөн их л хоржоонтой инээгээд “Энэ хярын цаана ганц ч чоно байхгүй. Азарган чоно тийшээ ямар ч чоно томилж явуулаагүй байгаа” гэжээ.

>Чэнь Жэньгийн нүдэнд эргэлзээ тодроход “Энэ цаг үе, газар орны нөхцөлд гурван талаас бүсэлсэн нь дөрвөн талаас бүслэснээс ч илүү аюултай” хэмээгээд өвгөн хүд хүд инээв.

“Чоно чухам ямар арга заль хэрэглээд байгааг би нэг л сайн ухааж өгөхгүй байна шүү” хэмээн Чэнь Жэнь хэллээ.

Өвгөн өгүүлрүүн “Уулын хярын цаад руу Олонбулгийн талд зартай цасан хунгар байдаг юм. Тэр жишүү харагдаж байгаа бэл нөмөр нөөлөг газар болохоор шуурсан ч цас тогтохгүй. Орсон цас уулын хярын цаана байдаг хотгор газар ташаан толгой давахаар хунгарладаг юм. Зарим гүн газартаа тугны иш далдрах нь ч бий. Удалгүй чононууд зээрийн сүргийг гурван талаас нь элдсээр цасан хунгар руу тууж шахаанд оруулахад яаж сугаран гарах билээ?” гэв.

Чэнь Жэньгийн нүд харанхуйлан гүн цасан хунгарт толгойгоороо хатган унах шиг болов. Тэр хэрвээ монгол нутгийн гүн рүү дайран орсон хятад цэрэг байсан бол ийм нарийн ов мэх, бэлдсэн занга байгааг лавтайяа гадарлахгүй байсан буй за. Монголчуудыг цагаан хэрмийн дотор олонтоо ялж тал нутаг руу нь үлдэн хөөж чадсан Мин улсын нэрт жанжин Сюй Да яагаад монголын тал руу ороод хамаг цэргүүдээ хиар хядуулах шахсаны учрыг тэр бараг ойлгож эхлэлээ. Түүнчлэн Мин улсын их жанжин Цюй Фү зуун мянган их цэргээ удирдан монголын хээр талыг туучин Хэрлэн мөрний эх хүрсэн боловч дайсныхаа ов мэхэнд автан алагдаж, жанжнаа алдаж сэтгэл санаагаар унасан цэргүүдийг нь монголын морьт цэргүүд

ганцыг ч үлдээлгүй олзлон авч байсан удаатай билээ. . . .

“Чоно дайтахдаа хүнээс ч илүү ухаалаг болохоор манай монголчуудын ав, хомрого, атаатан дайсантай тулалдах зэрэг бүх арга ухаан чононоос үүдэлтэй байдаг юм. Танай хятадад чонон сүрэг байхгүй болохоор дайн байлдаанд тааруу байх нь аргагүй. Дайтахад газар нутаг уудам, хүн ам олон байлаа гээд ямар нэмэр байх билээ? Дайнд ялах ялагдах гэдэг чинь чи өөрөө чоно уу, аль эсвэл хонь уу гэдэгт байдаг юм. . . . .” хэмээн өвгөн намуухан хүүрнэнэ.

Чонон сүргийн ерөнхий давшилт гэнэт эхлэлээ. Хамгийн баруун этгээдэд байсан хоёр том саарал чоно азарган чонынхоо удирдлагаар хагас саран бүслэлтийн цорын ганц үлдээд байсан сэтэрхий болох зээрийн сүргийн ойролцоох намхан довцогийн зүг дайрлаа. Мөнөөх довцогийг эзэлчихвэл бүслэлт бүрэн утгаараа хэрэгжих байв. Энэ гурван чонын довтолгоог суунаг татуулан хөөрөх гурван дохионы сум лугаа зүйрлэж болох юм. Тэднийг дагалдан хөлийн шандас хүчийг нөөхөөрөө нэг болсон чонон сүрэг нэгэн зэрэг ухасхийж зүүн, баруун, умард гурван талаас зээрийн сүргийн зүг шийдэмгий дайрцгаав. Чэнь Жэнь урьд өмнө ийм аймшигтай ширүүн довтолгоог харж байсан нь үгүй. Цэргүүд дайралт хийхдээ уухай хашгирдаг бол анч ноход чанга хуцалдан өөрийн сүрийг бадрааж өстний цөсийг үхүүлэхийг хичээдэг нь магадгүй өөрсдөө айж жийрхсэн буюу өөртөө итгэлгүйн илрэл ч байж болох. Тэгвэл чонын дайралт дуу шуугүй, уухай, улиангүй явагддаг аж. Гэвч тэнгэр газрын хооронд, хүн адгуусны нүд сэтгэлд нэвт шувт шингэсэн хорвоогийн хамгийн эрт балрын, хамгийн харгис агаад зартай айдас болох “Чоно ирлээ!” гэдгийг бүрэн дүүрэн илтгэж байв.

Өндөр өвсийг шуугиулан урагш довтлох чонон сүрэг давалгаа зүсэн урагшлах торпед шиг зүрх зүсэм хурц нүд шүдийг гялалзуулсаар зээрийн сүрэг рүү дайран орлоо.

Цадаглаа идчихсэн зээрийн сүрэг айж цочсондоо тал бүр тийш тарж сарнив. Хурд хэмээгч нь зээрийн чонон сүргийг эсэргүүцэх гол зэвсэг болохоор түүнийгээ алдчихсан тохиолдолд хонь болон гулууз махнаас огт өөрцгүй боллоо гэсэн үг ажээ. Энэ цаг мөчид зээрийн хувьд чонон сүргийг хараад айж сандарч байгаа нь түүний анх чонотой тулгарсан үеийнхээс ч хавьгүй их байгаа гэдэгт Чэнь Жэнь эргэлзэхгүй байлаа. Олонх зээрийн сүнс зайлаад дээд тэнгэрт очсон байж таарна. Тиймдээ ч олон зээр зогсож байсан газартаа дагжих буюу зарим нэг нь бүр өвдөг нугалан сөхөрч унаад хэл нь бултаганан, сүүл нь мөгжигонож байлаа. Чэнь Жэнь тал нутгийн чонон сүргийн оюун ухаан, тэвчээр хатуужил, зохион байгуулалт сахилга бат ямар болохыг орой руугаа ортол ойлгож авчээ. Чонон сүрэг тэгтэл тэвчээр заан түр зуурын өлөн зэлмүүн болоод идэх дур хүслийг тэвчиж, олон жилд ганц тохиолдож мэдэх олз омгийн үүдийг тэсвэртэй хүлээсний хүчинд зээрийн сүргийн гол зэвсгийг ийм амархан хураан авч чаддаг байна шүү.

Түүний тархинд нэгэн хурц бодол гялсхийсэн нь “Мөнөөх агуу их атлаа бичиг үсэггүй Чингис хаанаас авахуулаад Цуань Рун, Хүннү, Сяньби, Түрэг, Монгол, Зөрчид зэрэг үндэстний а үсгийн ацаг танихгүй буюу бичиг үсэгт дутуу хагас тайлагдсан өрлөг жанжингууд дэлхийн цэргийн номлолын хоймрыг эзлэсэн Сүньзийг төрүүлэн гаргаж, түүний Сүньзийн дайтахуйн номлол хэмээх цэргийн урлагийн том бүтээлийг эзэмшсэн Хятад хэмээх том гүрнийг эрхшээлдээ оруулж, төр улсыг нь эзэгнэн захирч байсан нь цөөнгүй билээ. Гэтэл тэд нар цаанаа ийм том сүрэг гарамгай цэргийн сургагч нартай, ийм шалгарсан бодитой цэргийн үзүүлэх сургуулийг явуулах хичээлийн танхимтай болоод чонон цэргийн урт удаан хугацааны

турш хурааж хуримтлуулсан байлдааны шилдэг өв сантай байсан юмсанжээ. Энэ хэдэн цагийн хугацаан дахь цэргийн үзүүлэх сургуулийг харсан нь хэдэн жил Сүньз болоод Клаусвечийн бүтээлийг судалснаас ч илүү ухаарал нэмж, өөрийнх нь зан чанар, сүнс сүлдийг өдөөсөн шиг санагдана. Тэр багаасаа л түүх сонирхож ирсэн болохоор дэлхийн түүхийн том оньсогын нэг болох ази европыг хөндлөн гулдгүй эзлэж манай гаригийн түүхэнд хамгийн өргөн уудам нутагтай Монголын эзэнт гүрнийг байгуулж чадсан жижиг үндэстний цэрэг дайны суу билиг чухам хаанаас үүдэлтэй вэ гэсэн нууцыг тайлах гэж чармайсаар ирсэн билээ. Тэр энэ тухай Билиг өвгөнөөс цөөнгүй асууж байсан боловч боловсрол нимгэн атлаа амьдралын өргөн мэдлэгтэй хурц сийрэг ухаантай мань хөгшин хамгийн эрт балрын атлаа хамгийн боловсронгуй ийм сургалтын аргаар өөрийнх нь сэтгэлийн гүн дэх эргэлзээг тайлж чадсан нь энэ ажгуу” Ийн бодох зуур Чэнь Жэньд тал хээрийн чоно болоод чоныг сүр сүлдээ болгон дээдэлдэг тал нутгийн үндэстнийг бишрэх сэтгэл төрөв өө.

Дайн байлдааны үзүүлэх сургууль цаашид хөврөн үргэлжилсээр л. . . .

Зээрийн сүрэг тэгсээр арайхийж нэг юм хөдөлгөөнд орцгоолоо. Үхэхээс бусдыг үзэж туулсан хашир ооно шаргачингууд өвөл цагт тэр болгон олон тохиогоод байхгүй шимт өвсний амтанд авталгүй гэдэснийхээ хэр хэмжээнд зэхий сайхан тааруулж чадсаны хүчинд зөн совингоороо чоно байхгүй уулын хяр руу биеийг эргүүлж замдаа таарсан ижил сүргээ нэгэн зүгт хурааж чаджээ. Цатгалдахын дээр зузаан цас туучин уулын өөд мацан гүйнэ гэдэг зээрийн сүрэгт хичнээн хэцүү болох нь ойлгомжтой. Энэ нь нэг бодлын хүйс тэмтрэлт, нөгөө талаар оюун ухаанаас тэнэг мулгуу болоод хайхрамж болгоомжгүй занд оноосон шийтгэл гэж болохоор байлаа. Харин Билиг өвгөний хувьд энэ нь чонон сүрэг зөвхөн тэнгэрийн гэсгээлийг оноож тал нутагт ээлтэй буян үйлдэж байгаа хэрэг юм.

Чонон сүрэг гэдсээ язартал идчихээд газарт тэрийн унасан хэдэн зээрийг тоож ч харсангүй харин хуйлран давхих ижил олон сүргийг нь элдэн одов. Том чононууд хэдэн оонын хүзүүнд асан багалзуурыг таслахад хундан ягаан цус дээш олгойдон газраар нэлийн урсав. Жихүүн тал агшин зуурын төдийхөнд зээрийн халуун цусны эхүүн үнэрээр дүүрэх шиг боллоо. Хараа хамар гоц хурц зээрийн сүрэг золиосонд одож буй золгүй хэдийнхээ энэ мэт байдлыг үзээд уулын хяр руу амь тэмцэн зугатацгаана. Хэдэн том ооно тэргүүлсэн тасархай зээр хөтлийн оройд хүрээд хурдаа сааруулан дороо эргэцэн зогсоцгоолоо. Тэдний хэн нь ч урагшаа зүглэж зүрхэлсэнгүй. Учир нь тэд өвсөн толгой ч цухуйн үзэгдэхгүй цасан хунгар ямар аюул занал агуулж байгааг ойлгож цөхөх юм үгүй. Тал нутгийг чамгүй сайн мэдэх зээрийн сүрэг чонын сэдсэн ов мэхийг одоо л ойлгосон бололтой.

Гэнэт толгодын оройд бөөгнөрч байсан зээрийн сүрэг уулын нуранги, усны урсгал мэт эсрэг зүг рүү сад тавин орж ирлээ. Арван хэдэн ооно хоёр талд байгаа аюул заналыг дэнсэлж үзээд арай амь гарах найдлагатай гэж бодсон юм шиг чонын байгаа зүг эргэж бүслэлтийн шугам руу чавхдав. Тэд амь дүйн, эцсээ хүртэл тэмцэхээр эрс шулуудаад тав гурваар мөр зэрэгцэн хурц эврээ мухуйлгасаар чонон сүргийн зүг дайран орлоо. Зугатах тэнхэлтэй бусад нь ч тэдний араас хуйлран дагав. Зээрийн эвэр хичнээн хурц болохыг Чэнь Жэнь урьд нь мэдэх юм. Малчид малын арьс шир боловсруулж, хатгаж цоолохдоо зээрийн эврийг хэрэглэн үхрийн элдсэн ширийг ч төвөггүй цоолчихдог болохоор чонын арьсыг нэвт сүлбэх юухан байх билээ. Зээрэн сүргийн хурц эврэндээ дулдуйдсан дайралт тэр даруй үр дүнгээ өглөө.



Чонон сүргийн бүслэлт зад ярагдаж шар усны үер далан сэтлэн урсахтай ижил харагдана. Чонон сүргийн санаархал ингээд талаар болж байгаа юм болов уу хэмээн бодоод Чэнь Жэньгийн сэтгэл түгшиж эхлэв. Гэвч азарган чоно шар усны үерийн үеэр далангийн хаалтыг нээж усны түвшинг буулгадаг ажилтан шиг бүслэлтийн сэтэрхийний хажууд аажуу тайвуу зогсож байхыг Чэнь Жэнь олж үзлээ. Зээрэн сүргийн дунд хурд хүч, хурц эвэр юугаа хадгалан үлдэж чадсан цөөн хэд нь сэтэрхийг өнгөрөнгүүт азарган чоно бусдыгаа оройлон бүслэлтээ хумин авав. Энэхэн зуур бүслэлтийн хүрээнд хурд хүч, хурц эвэр, хурдан сэтгэх чадваргүй хэд нь үлдэж хоцорчээ. Оройлох толгойлогч, ооно шаргачингуудаа алдаж учир замбараагаа олохоо байсан сүрэг зээр рүү чононууд дахин дайраад уулын хярыг давуулж, урд нь мэлцийх гүн хунгар руу пир пар хийтэл шахаж орууллаа. Нарийн шилбэ, цүндгэр гэдэстэй зээрэнд ямар гашуун тавилан тохиохыг Чэнь Жэнь одоо төвөггүй төсөөлж чадахтай болжээ.

Зээр болон чонон сүрэг тэнгэрийн савсалганд уусан алга болоход мянган зээрийн төвөргөөн, цусан шивэр татуулсан ав хомрого түүнийг дагалдан нам гүм болчихов. Уулын бэлд долоо найман үхсэн зээр болоод өөр хэдэн шархтай зээр тамиргүйхэн тийчигнэнэ. Энэхүү хомроголон дайрах тулалдаан эхнээсээ эцсээ хүртэл ердөө арав хүрэхгүй минут үргэлжилжээ. Чэнь Жэнь энэ бүхнийг хараад удтал урт амьсгаа ч авах тэнхэлгүй зүрх нь пэлбэгэнэн цохилж байв.

Өвгөн босож хэдэнтээ суниагаад цаст хонхрын ирмэгийн сөөг дэрсний хажууд завилан суулаа. Тэр эсгий гутлын түрийнээс ногоон хаш соруултай мод толгойгоо гарган, дүнсэн тамхи хийж асаагаад ёншгойтоор хийсэн цохиураар үнсийг нь хэд дарсанаа утааг гүн соров. Энэхүү хаш соруул, мод толгой зэргийг өвгөн залуу байхдаа хорин үнэгний арьсаар Жанчхүүгээс ирсэн хятад ганзагын наймаачингаас арилжиж авсан гэдгийг Чэнь Жэнь мэдэх билээ. Илгээлтийн эзэд үүнийг сонсоод алдаатай наймаа болжээ гэлцэх боловч өвгөн гаансандаа амь шигээ хайртай нь илт. Тэр ганзагачин хятад газрын холоос дээрэм хулгайн аюул заналтай тулгаран наашаа зүглэж байгаа болохоор амаргүй шүү дээ хөөрхий гэж өвгөн өмөөрнө.

Өвгөн гаансаа хэд сорсоноо “Энэ тамхийг нэрчихээд хоёул гэрийн зүг мордьё доо” гэв.

Чэнь Жэньгийн ангийн хийморь сүр бадраад “Хоёулаа уулын цаад руу өнгийж үзэх юм биш үү? Би чонон сүрэг чухам хэдэн зээр ангуучилсан болохыг үзмээр байна” хэмээн яаран өгүүлэв.

“Хоёулхнаа байж бас очих санаатай юу?” гээд өвгөн цааш нь “Очоогүй ч гэсэн олон зуун зээр амь тавьсан гэдгийг би гадарлаж байна. Янзага, эцэнхий туранхай болон аз нь шовойсон хэд гурваас бусад нь бүгд цасан хунгараас амь гарч чадахгүй. Үлдсэн зээр бүгд тэнгэрт одсон байж таарна. Чи сандрах хэрэггүй ээ. Чонын ходоод хэмжээтэй болохоор манай суурийнхан бүгдээрээ очоод ч зөөж дийлэхээргүй их зээр байгаа” гэв.

“Яахаараа янзага болон эцэнхий туранхай зээр амь мултарч байгаа юм бэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Хөгшин нүдээ сүүмийлгээд “Янзага, эцэнхий туранхай зээр бие хөнгөн болохоор дагтаршсан хунгарт шигдэлгүй амь мултрах боломжтой. Чоно ч тэднийг хөөж зүрхлэхгүй” гээд инээд

алдангаа “Хүү минь, чи өнөөдөр чонын ач тусыг амсаж мэдрээ байлгүй дээ. Чонон сүрэг хүмүүс бидэнд бэлчээр нутгийг хамгаалж өгөхөөс гадна сар шинийн бэлэг хүртэл бэлдэж өгч байгаа биз дээ? Өнөө жил бид хэд сар шинээ сайхан өнгөрөөх боломжтой болцгоолоо. Урьд нь чонын агнасан зээрийг баяд ноёд, тайж язгууртнууд л хүртэх эрхтэй байсан юм. Харин чөлөөлөлтийн дараа малчид тийм эрх эдлэх болсон. Манай Олонбулгийн талд тогтсон жаягаар иймэрхүү ангийн олзыг харсан хүн авах эрхтэй. Чи бид хоёр өнөөдөр хамтдаа харсан болохоор танай гэрийнхэн ахиухан аваарай л даа. Манай монголчууд чинь бусдын ач буяныг дээдлэдэг улс. Тийм болохоор чи үүнээс хойш хятадууд болон монголоо алдсан моншнуудтай адилхан чоныг алж хядахын түйс болдог зангаа орхиорой” гэв.

Чэнь Жэнь омогшин баярлаж болдогсон бол тэрэг дүүрэн зээр ачаад буцмаар санагдав. “Олонбулгийн талд ирээд хоёр жил болохдоо чонын балгийг амсахаараа нэг болсноос биш, ийм ашиг тустай амьтан гэдгийг мэдэлгүй явжээ” гэж тэр хэллээ.

Өвгөн өгүүлрүүн “Манай монголчууд ч чонын ашиг тусыг хүртэхээрээ нэг болсоон” гээд малиагаа газраас аван баруун талд байх алсын уулыг заагаад “Тэр уулын ард манай багт хамаарагддаггүй өөр нэг уул байдаг юм. Өвгөд хөгшдийн ярьдагаар Чингис хааны өрлөг жанжин Мухулай тэр алдартай уулын өвөрт алтан улсын хэдэн мянган цэргийг цасан хунгарт хөөж оруулаад хядсан гэлцдэг. Удаах оны хавар Чингис хаан хүмүүс явуулж дайны олзыг хамуулахад сэлэм, жад, нум сум, төмөр хуяг дуулга, эмээл, ган дөрөө зэрэг зүйлс уул овоо шиг их цугларсан гэдэг. Энэ чинь чононоос суралцсан арга ухаан байгаа биз дээ? Чи монголчуудын хэдэн арван дайн тулалдааныг мэдэх хүн, тэдний дийлэнхэд нь чонын цэргийн аргыг хэрэглэсэн байж таарна” гэлээ.

Чэнь Жэнь түүний үгийг өлгөж аваад “Нээрэн тийм шүү. Чингис хааны отгон хөвүүн Тулуй жанжин Хө Нань мужийн гурван оргилт уулын тулалдаанд гучхан мянган цэргээр их Алтан улсын хоёр зуун мянган цэрэг бүхий гол хүчийг устгасан удаатай. Тэр тулалдаанаас хойш их алтан улс бүрмөсөн хүчин мөхөсдөж сөнөсөн гэлцдэг. Тулуй жанжин эхэндээ алтан улсын цэргүүд хүчтэй, агт тарган болохыг үзээд шууд тулалдалгүй чонотой адилхан завшааныг эрэлхийлэн хүлээгээд байжээ. Тэгээд тэр газар их цас унахад цэргүүдээ дулаан газар олж хоргодуулан мөн л хүлээгээд байсан гэдэг. Тэгсээр алтан улсын цэргүүд даарч бээрэн, зутарч гүйцээд байхад ширүүн дайралт хийсэн нь үнэн хэрэг дээрээ энэ сүрэг чоно лугаа адил илд сэлмийн ирээр биш, салхи цасны хүчээр дайснаа дарсан хэрэг болж таарлаа. Тэгэхээр тэдэнд чонын тэвчээр, эрэмгий зан, эр зориг төгс цогцолсон байжээ. Үнэн хэрэг дээрээ зөрчидийн морин цэргүүд гэдэг чинь мануухайнууд байгаагүй Их Ляо улс, Умард Сүн улсыг мөхөөж хятадын хоёр хааныг олзлон ирж байсан түүхтэй юм шүү. Гэтэл Тулуй гучхан мянган цэрэгтэйгээ тэр том хүчийг бүслэн устгасан байдаг. Хятадын цэргийн номонд дайснаасаа арав дахин илүү хүчтэй байсан цагт сая тэднийг бүслэн устгах боломжтой гэж сургадаг юм. Гэтэл монголын морин цэргүүд чоно адил нэгээр зууг мохоох эрдэм чадалтай байсанд би бишрээд баршгүй. Тэр цагт дэлхий даяараа л бишрэн дагаж байсан биш үү. . “ гэхэд

Өвгөн гаансаа тогшин инээд алдаад “Чи тэр том тулалдааныг мэддэг хэрэг үү? Гэхдээ тэр үед гурван өдөр гурван шөнө балбасан цасан шуурга ямар учиртай орсон болохыг чи лав мэдэхгүй байж таарна. Түүнийг тэнгэр эцэг хайрласан юм. Тэр цасан шуургыг Тулуй жанжны цэргийн хүрээнд хамт явсан бөө дээд тэнгэрээс гуйж залбирсаар оруулсан гэлцдэг.

Монголын түүх домогт энэ тухай өгүүлсэн байгаа. Алтан улс чинь манай монголчуудын эртний өстөн дайсан байсан юм. Алтан улсын хаан өөрсдийн сүлбээтэн болох татаруудтай хамсан Чингис хааны эцэг Есүхэй баатар болон түүний авга эцэг Амбагай хааныг тарчлаан алж байсан түүхтэй. Тэр удаагийн тулалдаанд ялснаар монголчууд өшөөгөө авч уужим амьсгаа авах боломжтой болсон юм. Тэнгэр эцэг чононд яагаад талтай байдгийг чи одоо олж үзэв үү?” гээд өвгөн нуг нуг инээхэд нүүрэн дээрх үрчлээ нь хонины ноос шиг эрчлэнэ.

Тэр хоёр ардаа байх жалга руу ороход өвгөний өндөр бор морь эзнээ хараад баярлан үүрсэж толгой хаялав. Чэнь Жэнь аминд орсон ухаант өндөр бор морийг харах бүртээ магнайг нь илбэж талархал илэрхийлдэг болсон юм. Өндөр бор ч түүний хариуд мөрийг шөргөөх нь их л тааламжтайн илрэл болой. Харин энэ мөчид Чэнь Жэньгийн сэтгэлд чонын магнайг илбэмээр санагдаад байв.

Хөгшин залуу хоёр морьдынхоо чөдрийг тайлж алавхийн мордоод гэрийн зүг шогшуулцгаалаа.

Өвгөн тэргүүн өргөж тэнгэрийн байдлыг ажсанаа “Тэнгэр хангай ч бидэнд хишиг буянаа харамгүй хайрлахаар шийджээ. Маргааш салхи шуургагүй тогтуун байх бололтой. Хэрвээ өнөөдөр цасаар шуураад эхлэсэн бол бид ганц зээрээр ганзага мялааж чадахгүй байх байсан даа” гэжээ.

## Гурав

*Үсүний ванг Күньмө хэмээгүй. Күньмөгийн эцэг Хүннү гүрний баруун этгээд дэх нэгэн ханлигийг захирдаг байжээ. Хүннүчүүд тэдэн рүү дайран алах үеэр Күньмө төрж хээр хаягдсанд хэрээ мах зуун тэжээж, өлөгчин чоно хөхүүлж өсгөв гэнэ. Хүннүгийн хаан түүнийг ихэд гайхан сахиус байх гэж бодоод тэжээн өсгөжээ. Күньмө өсөж том болоод цэрэг удирдан хэдэнтээ том гавьяа байгуулав. Хүннүгийн хаан түүнд эцгийн мэдлийн газар ард иргэдийг өвлүүлж, баруун газрыг сэргийлэн сахиулжээ. . . Хүннүгийн хаан өөд болсоны дараа Күньмө харьяат олныг удирдан хол нүүж Хүннүд алба өргөхөө больжээ. Хүннүчүүд цэрэглэн дайлаад эс ялсан тул сахиус буюу хэмээн хол зай барих болжээ.*

*Сы Ма Цянь “Түүхэн тэмдэглэл зохиолын Даваний шастираас”*

Хоёрдахь өдрийн өглөө үнэхээр салхи шуургагүй тогтуун байв. Монгол гэрүүдийн утаа гоолиг цагаахан хус шиг тэнгэр өөд цойлно. Үхэр хонь тайван хивж, нарны гэрэл өвлийн жаврыг үргээгээд адуу малын бие дээр тогтсон цан хүүрэг хайлмагтан бөнжийснөө улмаар хүдэнтэн цайрч агаарт замхрах ажээ.

Чэнь Жэнь хөрш айлын Гомбод тэр өдрийн хонины ээлжээ ацаглан үлдээв. Гомбо баян чинээлэг гарал үүсэлтэй гэдгээрээ тухайн үед ихэд хавчигдан мал маллах ч эрхгүй нэгэн байсан тул илгээлтийн эзэн дөрөв маань сав л хийвэл түүнд хонины ээлжийг ацаглах дуртай, Галсмаа ч түүнд оногдох цалин цавгийг тоо ёсоор бодож олгоно. Чэнь Жэнь өөр нэгэн хоньчин Ян Көтэй цуг төмөр дугуйтай хөнгөн үхэр тэргээ хөллөөд Билиг өвгөнийд очив.

Чэнь Жэньтэй нэг гэрт амьдардаг хуучин ангийн анд Ян Кө бол Бээжингийн нэртэй их сургуулийн том профессорын хүү юм. Тэдний гэр дэх ном гэж бага шиг номын сантай тэнцэх тул ахлах дунд сургуульд байхдаа Чэнь Жэнь түүнтэй байнга ном сольж уншдаг, уншсан номынхоо тухай бие биедээ ярьдаг байсан болохоор энд ирсэн хойноо амь нэгтэй гэж жигтэйхэн. Ян Кө Бээжинд байхдаа ноомой, ичингүй, хүний өөдөөс эгцэлж харж чаддаггүй нэгэн байсан бол тал нутагт ирж хоёр жил мах ааруул идэж, дөрвөн улирлын турш монголын өндөрлөгийн хурц наранд шаруулсаар нэг л мэдэхэд талын малчдаас өөрцгүй тослог бор залуу болон хөрсжөөд ноомой төрх нь ч ул мөргүй алга болж билээ. Энэ удаа тэр Чэнь Жэньгээс ч илүү хөөрч догдлон үхэр тэргэн дээр суунгуут малиагаар хөллөсөн үхрийн ташаа руу ташуурдангаа “Би өчигдөр шөнө бараг дуг хийж чадсангүй. Чи үүнээс хойш Билиг эцэгтэй хамт анд явахдаа намайг заавал дагуулж явдаг юм шүү. Би бүтэн хоёр өдөр шөнийн турш газар элгэдэн хэвтлээ ч ажрахгүй. Чоно хүмүүст ийм тустай амьтан байсан гэж би урьд өмнө сонсож дуулаа ч үгүй юм байна. Би өнөөдөр өөрийн гараар нэг зээр ухаж гаргадаггүй л юм бол үүнд итгэж чадашгүй нь. . Гэтэл чи өнөөдөр тэрэг дүүрэн зээр тээж ирнэ гээд байдаг” хэмээн ярина.

“Би юу гэж худлаа ярих билээ” хэмээн Чэнь Жэнь инээд алдаад “Хичнээн ухан гаргахад төвөгтэй байлаа ч гэсэн манай үхэр тэргийг эхлээд дүүргэж өгнө гэж хөгшин аав хэлсэн юм чинь. Бид түүгээр цагаан сарын идээ будаа болон гэртээ бүрээс туурга сольж авч болно” гэв.

Ян Кө баярласандаа малиагаа эргүүлэн үхрээ шавдуулж эхлэв. Ян Кө Чэнь Жэньд хандаж “Чи ч хоёр жил чоноор өвчилсөний хэргийг үзэж чадлаа шүү. Үүнээс хойш би ч гэсэн чононоос

ан ав хийх арга ухааныг суралцдаг хэрэг ээ. Алсдаа дайн байлдаан болох үед хэрэг болохыг хэн байг гэхэв. Чиний ярьдагчлан нээрэн ч нэг зүй тогтол байх шиг байна. Хэрвээ урт удаан хугацааны туршид нүүдэллэн амьдраад байвал ямар ч үндэстэн адаг сүүлдээ чоныг дээдлэн шүтэж, түүнээс суралцдаг бололтой. Хүннү, Үсүн, Түрэг, Монгол зэрэг үндэстэн бүгд л тийм байсан тухай түүх шастирт тэмдэглэн үлдээсэн байдаг шүү дээ. Харин манай хятадууд ч дээ, хэдэн арван зуунаар амьдарлаа ч чоныг сүлдээ болгон дээдлэх нь юу л бол?” гэв.

“Тийм ч үгүй байх аа” гэснээ Чэнь Жэнь мориныхоо амыг татасхийгээд “Би л гэхэд тал нутагт ирээд хоёр жил болохдоо талын чоныг бахдан биширдэг болоод байна шүү дээ” гэв.

Ян Кө түүний хариуд мөчөөгөө өгсөнгүй “Хятадын олонх тариачид түүний дотор тариачин гаралтай хүмүүст ган төмрөөс ч илүү хугарч нугаршгүй жижиг тариачны ухамсар нэвт шувт шингэсэн болохоор тал нутагт ирвэл чонын арьсыг өвчөөд дуусгах байлгүй. Хятадын хань үндэстэн тариачин соёлтой, өвс ургамлаар хоол хийж, чоныг яс махнаасаа жигшин үзсээр ирсэн болохоор яахин чонон сүлдийг дээдлэн шүтэж чадах билээ? Хятадын хань үндэстэн эртнээс газар тариалангийн амин сүнс болсон лууг дээдлэн шүтэж түүндээ мөргөн сөгдөж, үнэн голоосоо айж сүрдэн гай барцдыг зайлуулж ирсэн улс. Харин монголчууд шиг чононоосоо суралцаж, чоноо хамгаалж, дээдлэн, хэрэгтэй цагт алж чадна гэж үү дээ? Эднийхний шүтдэг сүлд шүтээн нь үндэстний үзэл санаа, зан чанарт хүрхрэх луу дүүлэх чоно мэт нэвт шувт шингэсэн байна. Тиймдээ ч суурьшмал болон нүүдэлчин үндэстний зан төрхийн онцлогт дэндүү их ялгаа үүсчээ. Урьд нь хань үндэстний их далай дунд аж төрж байхдаа энэ талаар мэддэггүй байснаа тал нутагт ирсэн хойноо өөрсдийн суурьшмал үндэстний сул дорой муу талуудыг харьцуулан гаргаж чадлаа. Чи манай аавыг том профессор гэдэг талаас нь битгий хараарай. Үнэндээ манай өвөө эмээ нар бүгд л тариачид байсан юм шүү. . . ” гэв.

Чэнь Жэнь түүний үгийг өлгөж аваад “Ялангуяа эрт дээр цагт хань үндэстний нэг хувьд ч хүрэхгүй монголчууд дэлхийн түүхийн тавцанг тэднээс илүү доргиож хань үндэстнээс ч давуутай нөлөө үзүүлж чадсан. Өнөө хэр өрнөдөд хятадуудыг монголжуу төрхтөн гэж нэрлэдгийг бид өөрсдөө ч хүлээн зөвшөөрдөг биз дээ? Гэтэл Цин, Хань улсуудын үед хятад орныг анх нэгтгэхэд Монгол үндэстний өвөг дээдсийн бараа сураг ч байхгүй байсан гээд бодохоор би хань үндэстний төлөө тун их шаналах юм. Хятадууд цагаан хэрмээр өөрийгөө хүрээлүүлчихээд өөрсдийгөө дэлхийн төвд оршдог том гүрэн гэж хөөрцөглөсөөр ирсэн. Гэтэл эртнээс нааш өрнөдийнхний нүдэнд хятадууд зөвхөн “Торгоны улс”, “Шаазангийн улс”, “Цайны улс” төдийхөн л байсан. Тэр ч байтугай оросууд хятадыг өчүүхэн жаахан Хятанчуудтай андуураад өнөө хэр “Китай” гэж дуудсаар байгаа. Үнэндээ ч чоно гэдэг бишрэхээс өөр аргагүй амьтан юм байна шүү” гээд Ян Кө цааш залгуулан “Би чиний халдварыг авчихаад түүхийн ном уншихаараа сав л хийвэл Си Рун, Дун И, Бэй Ди, Нань Мань гэсэн сэдвийг харах гээд байдаг болчихжээ. Тэр ч байтугай чонотой нүүр тулгаран учирч, арга самбаагаа соримоор санагдах үе ч бий” гэв.

“Тэр харав уу? Чи байтлаа бүр монголжиж гүйцэх нь ээ. Чонын цус сэлбэн, цус холилдож байж л давуу талтай болдог шиг байна” хэмээн Чэнь Жэнь өгүүлэв.

“Чи намайг уруу татаад тал нутагт авчирсанд би үнэхээр их баярладаг шүү. Чиний ямар үг орой руу минь орсон болохыг чи бараг мартаа биз дээ? Тал нутагт жинхэнэ унаган төрх эрх

чөлөө бий гэж чи хэлж байсан сан” гэж Ян Кө хэлэв.

“Би анх мэдээж тийм үг хэлж байгаагүй байх аа. Чи жаахан хачирлаж байх шиг байна” гээд Чэнь Жэнь мориныхоо амыг сул тавив.

Тэр хоёр тачигнатал инээлдэхэд үхэр тэрэг цас манарган хурдаллаа.

Хүн нохой тэрэг чарга нийлээд цыганчууд шиг хөөр хөгжөөнтэй өнгө төрхийг буй болгов.

Галсмаагийн ахалдаг суурийн дөрвөн хотын найман монгол гэрээс хүн хүч үхэр тэрэг цугларчээ. Найм есөн үхэр тэргэнд том эсгий, олс дээс, модон хүрз, түлээ болон модон иштэй гох дэгээ зэргийг ачаалсан юм. Хүмүүс бүгд л хар бор ажилд өмсдөг хуучин муусайн нөхөөстэй хөдсөн дээлээ өмссөн нь хир дагандаа баригдаад гялтайж харагдана. Гэвч хүн нохой бүгд хөөр баярт автах нь дайны талбараас олз түүдэг монголын их цэргийн дагуул мэт ажээ. Тэрэг хөсгөн дээрээс ая дуу цангинаж, эсгий бүрээстэй хавтгай савтай архи хөсгийн эхнээс адаг хүртэл эмэгтэйчүүдийн гарыг дамжин эрэгтэйчүүдийн аманд хүрнэ. Хэн нэг нь дуу эхлэж монгол ардын дуу, магтаал дуу, цэрэг дайны дуу, сархдын дуу, амрагийн дуу гээд цааш хөвөрч гарлаа. Дөч тавиад монгол ноход үс ноосоо сэгсийлгээд энэхүү төдийлөн олон тохиохгүй холын аянд хүүхэд мэт хөөрцөглөн, тэрэг хөсгийг дагаад хуцалдаж ноцолдон явцгаана.

Чэнь Жэнь, Бат, Лхамжав хэмээх хоёр адуучин болоод өөр бусад тав зургаан үхэрчин хоньчны хамтаар Билиг өвгөнийг овгийн ахлагч мэт бүчин явлаа. Өргөн малигар нүүр шулуун хамартай, түрэг цусных болов уу гэмээр том ногоон нүдтэй Лхамжав өгүүлрүүн: “Би овоо гайгүй бууддаг хэр нь ан авын тал дээр таныг бараадахгүй юм аа. Та ганц сум гарзадалгүй нийт суурийн айлуудыг сайхан цагаалах боломжтой болгочихдог байна шүү. Та Чэнь Жэнь гэдэг хятад шавьтай боллоо гээд хуучин шавь намайгаа мартаж болохгүй байх шүү. Би чонон сүрэг уулын тэнд ав хомрого хийнэ гэдгийг яагаад ч бодож олж чадахгүй юм байна” гэв.

Өвгөн түүн рүү бүлтийтэл ширтээд “Үүнээс хойш чи ан ав хийхдээ суурийнхаа хэдэн хөгшид болоод илгээлтийн эздийг санаж явбал дээр шүү. Ангийн мах үнэртүүлчихээд айл хунарт амсуулж явахыг чинь ер харсангүй. Чэнь Жэнь өөрөө очсоны хүчинд ганц гуя ганзагалсан байна лээ. Монгол хүн чинь бусдыг хэзээ тийм маягаар зочилж байлаа даа. Намайг залуу байхад ангийн олзны дээж болох зээр тарвагыг өвгөд хөгшид болон зочин гийчиндээ эхлээд амсуулдагсан. Их хааны тогтоосон дэг жаяг та нарын үе дээр л мартагдах янзтай даг шүү. Чи дахиад хэдэн чоно агначихвал Баянгол нэгдлийн чонын анчин баатар Бөхөөг гүйцэх гэж байна даа? Сонин хэвлэл дээр гарч, радиогоор яриулж, шагнал урамшил хүртэхийн түйс болж байгаа биз дээ? Та нар байгаа хэдэн чоныхоо бодийг хөтлөж дуусахаар өөд болохын цагт сүнс чинь хаана очих бол гэдгийг бодож үзсэн үү? Арай хятадууд шиг үхэхдээ тохмын чинээ газар малтаж тохойгоор хэмжигдэх биеэ булчихаад өт хорхойн хоол болон хэвтэх чинь дутаа юу? Тэр цагт сүнс чинь тэнгэрт мөн очих байх даа” гээд өвгөн уртаар санаа алдаж “Түрүүчийн удаа би хошууны төвд очиход урд нутгийн хэдэн хөгшид хагас жилийн турш чонын бараа харсангүй. Олонбулгийн талд очиж ясаа тавих юмсан гээд л үглэж дуулж байдаг шүү. . “ гэв.

Лхамжав дух руу унжих үнэгэн лоовуузаа арагш болгоод “Та надад итгэдэггүй юм гэхэд

өөрийн хүү Батдаа итгэнэ байлгүй дээ. Тэр намайг чонын ангуучин баатар болох хүсэлтэй эсэхийг хэлээд өгнө өө. Дээр нэг өдөр аймгаас ирсэн сурвалжлагч надаас тэр тухай асуухад Бат миний хажууд байсан. Би түүнд агнасан чонын тоогоо дарж мэдүүлсэн шүү. Та худлаа гэвэл түүнээс асуу л даа” гэлээ.

Өвгөн Бат руу хандан “Үнэн үү?” хэмээн асуулаа.

Бат хариуд нь “Тэр ч үнэн шүү. Тэр сурвалжлагч бэлтгэн нийлүүлэх цэгээс Лхамжавын хэдэн чонын арьс тушаасан тухай дуулж мэдсэн юм байна лээ. Бэлтгэн нийлүүлэх цэгийнхэн чонын арьсны чанарыг харгалзан үнэ тогтоогоод нэмж хорин сумаар шагнадаг гэдгийг та юу эс андах билээ? Тэр сурвалжлагч данс хараас энэ тухай олж мэдээд аймагтаа очиж Лхамжав удахгүй Бөхөөгийн амжилтыг эвдэх нь гэж радиогоор ярьсан хэрэг. Түүнээс хойш Лхамжав хэл амнаас айгаад агнасан чонын арьсаа хүнээр заруулдаг болсон шүү” гэлээ.

Өвгөн хөмсгөө агируулаад “Та хоёр ч чоно агнана гэдгийг үзүүлж өгөх юм аа. Аж ахуйн хэмжээнд та хоёр л хамгийн олон чоно агнасан байх” гэв.

Бат өөрийгөө өмөөрсөн байдалтай “Манай адуун сүрэгт оногдсон бэлчээр гадаад монголд ойр байдаг болохоор чоно их гэж жигтэйхэн. Тийм болохоор агнаж байхгүй бол улам олшрох янзтай. Тэр жил хамаг унагаа чононд бариулаад дууссаныг та өөрөө мэдэж байгаа биз дээ?” гэж хэлэв.

“Ингэхэд та нар чинь яахаараа цаад муу Жан Зи Юанийгаа адуун дээр үлдээчихээд хоёулаа наашаа хүрээд ирдэг билээ?” хэмээн өвгөн асуулаа.

“Шөнө бэлчээрт чоно их болохоор бид хоёр адуугаа манасан нь дээр. Өдөр цасан дундаас үхсэн зээр ухаж гаргахад цаадахь чинь нэмэр болохгүй гэж бодоод бид хоёр наашаа ирсэн хэрэг” гэж Бат хэллээ.

Тал нутгийн өвлийн нар төдийлөн өндөр манддаггүй болохоор газарт их ойртсон мэт санагдана. Тэнгэр цайвартан, шаргал өвс ч мөн цайраад хунгар цасны өнгө хайлмагтан хөлөрч нарны туяаг гялтгануулан ойлгож байв. Хүн ноход, хөсөг тэрэг цайвар гэрлийн дунд бөртөлзөн харагдана. Эрчүүд бүгд хар нүдний шил зүүгээд эмэгтэйчүүд хүүхдүүд дээлийн нударгаар нүдээ халхлан явав. Хялман туссан хэдэн үхэрчид нүдээ тас аних боловч нулимс нь тогтохгүй урссаар байх ажээ. Харин том халтар банхарууд холуур өнгөрөх туулайг ажих буюу доош тонгойн үнэгний шинэхэн мөрийг шиншилцгээнэ.

Ав хомрогын талбайд ойртох үед ноход цасан дээр тэрийн хэвтэх этгээд зүйлсийг олж үзээд замбараагүй хуцалдан гүйлдэцгээв. Зарим өлөн ноход чонын үлдээж орхисон зээрийн сэг зэмийг идэж эхлэлээ. Билиг өвгөний Барс болон бусад айлуудын зартай хэдэн анч ноход сэрвээний үсээ босгоод энэ тэрүүгээр чонын баас шээсний үнэрийг шиншилж нүдээ эргэлдүүлэн чонон сүргийн тоо толгой болон ямар азарган чоно удирдаж ирсэн зэргийг тогтоох гэж хичээж байгаа бололтой. “Барс Олонбулгийн олонх чоныг таньдаг шиг цаадуул нь ч Барсыг андахгүй таньж байгаа” гэж Билиг өвгөн ярьдаг юм. Тэр сэрвээний үсээ босгодог нь эзэндээ цөөнгүй тооны чонон сүрэг энүүгээр өнгөрсөнийг илтгэсэн хэрэг байв.

Хүмүүс мориндоо мордсон чигээрээ авын талбайд орж доош тонгойн нарийвчлан ажиж эхлэлээ. Уулын бэлд үхсэн олонх зээр чонын сүрэгт идүүлээд араг яс төдийхөн үлдэж хоцорчээ. Билиг өвгөн цасан дээрх чонын мөрийг зааж “Өчигдөр үүгээр чонын хэд хэдэн сүрэг ирсэн байна” гээд мөн газар дээрх чонын үсийг зааж “Хоёр чонын сүрэг хоорондоо тулалджээ. Бодвол хил давж орж ирсэн чононууд зээрийн үнэрээр наашаа ирсэн байж таарна. Тэндхийн чононууд хоол хүнс хомсдоод их ширүүн загнасан бололтой” гэлээ.

Морьд хөтлийн орой дээр гарч ирэв. Хүмүүс царан дээр тавьсан эрдэнэс олсон мэт баярлан дуу алдацгаагаад араасаа ирж яваа хөсөг тэрэг рүү малгайгаараа даллацгаана. Галсмаа бусдыгаа тэргүүлэн тэрэгнээсээ буугаад үхрээ хөтлөн урагш алхааны хурдаа нэмэв. Бусад айлын эзэгтэй нар ч даган тэрэгнээс буугаад үхрээ шавдуулан гуядлаа. Ачаа нь хөнгөрсөн үхэр тэрэг урамтай урагшилна.

Лхамжав уулын хормойд байх ав хомрогын талбайг хараад нүдээ унагах шахаж “Пөөх, энэ чононууд мөн лут юм аа. Ийм олон зээрийг цас руу шахаж оруулсан байдаг. Гэтэл уржнан жил бидний адуучин үхэрчин нийлсэн хорь гаруй хүн морио бахардтал хөөн байж дөнгөж гучаад зээр агнасан юм даг” гэлээ.

Билиг өвгөн морины амыг татаад дурангаа гаргаж нэлийсэн цасан хунгар болон эргэн тойрны уул толгодыг тогтоон ажиглав. Хүмүүс морины амыг татан ийш тийш ажиглангаа өвгөний юу хэлэхийг хүлээж байлаа.

Чэнь Жэнь ч мөн дурангаа гаргаж ирлээ. Уулын хормой дахь цасан хунгарт тоо томшгүй олон зээрийг шигдээн намнадагтай адил эрт цагт цөөнгүй баатар эрсийг булшилж байсан байж таарна. Цасан хунгарын гол дахь тэгш гадар цас мөсөөр хучигдсан өндөр уулсын дундах том нуурын мандал мэт үзэгдэх ажээ. Цасан хунгарын хэвгий хэсгийн арван хэдэн газарт зээрийн сэг зэм үзэгдэнэ. Хамгийн цочирдон сүрдмээр нь уг цасан нуурын долоо найман хэсэг шаргалтаад зарим нь чичигнэн хөдлөж байх ажээ. Тэр бол цасанд шигдээд хараахан далд ороогүй олон зээр болохыг Чэнь Жэнь ялган таньж чадав. Цасан нуурын наад хэсгээр хэдэн арван том жижиг нүхнүүд байх бөгөөд цаашлах тусам улам олширчээ. Тэр бол хүйс тэмтрэгдэх аюултай тулгарсан зээрийн гаргасан мөр болох нь тодорхой. Цасан нуур ердийн нуурнаас ялгаатай нь гэвэл тэнд живсэн болгон тодхон ул мөр үлдээдэгт байгаа юм.

Билиг өвгөн Батад хандан “Та хэд эндээ үлдээд цас малтан зам гаргаж тэргээ бидэн рүү ойртуулахыг бод” гэхчээ Чэнь Жэнь Лхамжав хоёрыг дагуулан “Цасан нуурын” гүн рүү чиглэн алхлаа. Тэр Чэнь Жэньд “Зээр болон чонын мөр гарсан хэсгийг бараадан яваарай. Харин өвс цухуйгаагүй газар огт гишгэж болохгүй шүү” хэмээн захив.

Тэр гурав морио унаж доошоо болгоомжтой уруудав. Цас улам гүнзгийрэхийн хэрээр өвсөн толгой сийрэгших ажээ. Дахин арван хэдэн алхам явсаны дараа цасны гадаргуу дээр савхны толгой шиг жижиг жижиг нүхнүүд үзэгдэж түүний цаанаас өвсний толгой цухуйж байлаа. Бодвол салхинд үлээгдсэн өвсний найгалтаар ийм нүхнүүд үүссэн бололтой. “Эдгээр жижиг нүхнүүд бол дээд тэнгэрээс чононд хайрласан хишиг байгаа юм. Эс бөгөөс ийм зузаан цасны хаана нь үхсэн амьтан байгаа гэдгийг чоно үнэрлэн олох билээ?” гэхэд Чэнь Жэнь инээгээд толгой дохиж байв.



Жижиг нүхнүүд болоод өвсөн толгой аюулгүй гэдгийг илтгэх тэмдэг байжээ. Харин дахин хэдэн арав алхсаны дараа тийм жижиг нүхнүүд болон өвсөн толгой үзэгдэхээ байлаа. Харин зээрийн туурай, чонын тавхайн мөр тодхон үзэгдэнэ. Тарга тэвээрэг сайтай монгол морьд гурван хуруу зузаан цасан хунгарыг чихруулан зүсэн туучсаар ойролцоо хэвтэх зээрийн сэгийг бараадан очлоо. Унасан хүлэг нь цааш явах боломжгүй болоход гурвуул мориноос буутал гүн цасанд шигдэн орцгоов. Тэр гурав дороо гишгэцсээр арайхийн бөгс эргэх зай гаргаж авлаа. Чэнь Жэньгийн хөлийн дор чононд идүүлсэн зээрийн сэг бас ходоодноос цувсан өвс хөлдсөн байх харагдана. Барагцаагаар гуч дөчин зээр энэ хавьд чононд бариулаад түүнээс цааш чонын мөр тасарчээ.

Толгой өргөн харваас Чэнь Жэньгийн урьд өмнө үзэж харж байгаагүй этгээд сонин атлаа эмгэнэлтэй дүр зураг тодорлоо. Найм есөн янзагатай шаргачин түүнээс зуу гаруй метрийн зайнд дагжин чичирч зогсоно. Тэдний эргэн тойронд нэлийсэн цасан хунгар, үхсэн зээр тэрийлдэн хэвгэнэ. Тэр амьд хоцорсон зээр айсандаа хөдлөж ч чадахгүй байх агаад түүний хөл тогтох өчүүхэн газар нь хэзээ мөдгүй доошоо цөмөрч мэдэх юм. Өөр хэдэн зээрний хөл цасанд гүн шигдээд их биеэрээ хунгар элэглэн хэвгэнэ. Тэд хэдийгээр амьд боловч хөдлөх арга тун үгүй болжээ. Эдгээр тал нутгийн салхи шиг хурдан адгуус энэ газар өлсөх даарахын аюулд нэрвэгдээд, ганц алхах тэнхэлгүй эрлэгийн элчийн эцсийн тамлалыг хүлцэн байгаа нь энэ буюу. Цасан гадаргуу дээр их бие хүзүүгээ далд ортол шигдсэн зээрийн эвэр дагзнууд сэрийлдэн үзэгдэх нь сэтгэл сэрдхийлгэнэ. Бодвол тэдний хөл дор бяцхан гүвгэр буюу эсвэл үхсэн зээрийн сэг тээглэн толгой нь цухуйх төдий харагдаж буй нь энэ байлгүй. Чэнь Жэнь дурангаараа зээр аврал эрэн хашгирах боловч дуу гарахгүй байгааг олж харах шиг санагдав. Магадгүй тэр олон зээр аль хэдийн осгож үхээд амь тавих сүүлчийн агшин тэр мэт хадгалагдан үлдсэн ч байж мэднэ.

Цастай бэл болон цасан нуурын мандал мөс адил үзэсгэлэнтэй туяарах хэрнээ цаанаа л нэг ёозгүй санагдана. Энэ бол дээд тэнгэрээс тал хээрийн хүн чоно хоёрт нутаг орноо хамгаалаг хэмээн хайрласан хөнөөлт нууц хүйтэн зэвсэг ч юм бил үү? Олонбулгийн өвөл цагийн дагтаршсан цас гэдэг цасан шуурга нарны гэрэл хоёрын хамтын бүтээл байдаг. Байн байн хуйрагнах цасан шуурга хунгарын дээрх хөвсгөр цасыг туун одоход төмрийн үртэс мэт зузаан ширхэгтэй хэсэг нь тунаж хоцорно. Дороо зөөлөн давхаргыг хучиж тогтсон энэ даргар цас нартай салхигүй тогтуун өдөр үл мэдэг хайлмагтан хөлөрч оройн жаварт эргээд хөлдөж барьцалддаг. Хэдэн удаагийн шуурга өнгөрөхөд цасны гадаргуу гурван хуруу зузаан мөстөн барьцалдаж, цаснаас хатуу, мөснөөс зөөлөн зузаан нимгэн харилцан адилгүй тэгш гадаргууг үүсгэдэг юм. Зарим зузаан мөстсөн хэсгээрээ хүн явж болохуйц боловч зээрийн нарийн шилбийг яахин тэсэх билээ.

Нүдний өмнөхөн дурайх хэсэг газрын дүр зураг бүр ч зүрх чичирч, цөс дагжим харагдах ажээ. Чононууд хөл хүрч болох газрын зээрийг энэ хавиар чирч гулдарсан бололтой зурайсан гүн цасан замууд дурайх нь чонон сүрэг өөрсдийн олзлогсдыг чирсэний ул мөр байж таарна. Цасан замын төгсгөлд яргын талбар үүсэж, чононы найраар өндөрлөжээ. Чонон сүрэг их л цамаан загнаж зөвхөн гэдэс дотор болон зөөлөн махтай хэсгийг шоглосон нь илт. Чонын хөлд цөмөрсөн дагтаршсан цас салхины аясаар хуйсагнаж, хэдэн ч газар чонын баасанд хайлсан цас мөстөөгүй байхыг бодвол чонон сүрэг хүн, нохдын чимээнээр дөнгөж саяхан дайжин одсон бололтой.

Монгол нутгийн чоно цаст талын хээрийн байлдаанд гаргуун болохоор хэнтэй яаж тулалдахаа сайн мэднэ. Цасны гүн хэсэгт шигдсэн зээр ил харагдах боловч чононууд тэдэн рүү дөхөөгүй, ядаж дөхөх оролдлого хийгээгүй байв. Чононуудын чирч гаргасан зээр хэдэн ч том чонын сүрэг идэхэд хангалттай бөгөөд үлдэж хоцорсон хөлдүү зээрийн махыг өвөл тааваараа хүртэж ирэх хавар цас хайлахад тавтай зооглох гэж үлдээсэн байж таарна. Тэгэхээр энэ уудам цасан хунгар, цасан нуур нь чонон сүргийн идэш тэжээлээ нөөцөлж орхисон байгалийн хөргөгч болон хувирчээ. “Олонбулгийн талд чонон сүргийн мөс цасан зоорь хэд хэд байгаагийн хамгийн том нь энэ байж таарна. Энэ мөсөн зоориндоо чонон сүрэг идэш тэжээлээ базааж орхиод хаврын тарчиг цагийг ажралгүй туулдаг юм. Эдгээр тарга тэвээрэг сайтай зээрийн мах хавартай арайхийж золгосон өлөн чонын хувьд туранхай эцэнхий зээрнээс хавьгүй илүү хоол болно” хэмээн Билиг өвгөн өгүүлээд цасан хунгарыг зааж инээн: “Тэгээд бодохоор талын чоно хүнээс илүү амьжиргаатай байгаа биз дээ? Малчид өвлийн эхэн сард мал сүргийнхээ тарга тэвээрэгтэй үед хонь үхрээ нядлан идэш тэжээлээ базаадаг нь явж явж чононоос сурсан арга ухаан байж ч мэднэ” гэв.

Барс болон хэдэн том ноход амьд зээрийг хараад анч зан нь хөдлөж алахаас буцамгүй дайран орсоноо чонон сүргийн зогссон хил хязгаарт хүрээд цааш явалгүй хүзүү сунган хөв хөв хуцалдлаа. Хэдэн аймхай ооно шаргачин нохдоос айсандаа цааш амь хайргүй зүтгэсэн боловч хэд алхалгүй цас цөмөрч хуурай элс шиг цасан хунгарт гүн шигдэн тийчигнэсээр далд оров. Тэд тийчигнэх тусам улам гүн шигдсээр эцэс сүүлдээ юүлүүр шиг том нүх үлдээгээд чимээгүй боллоо. Нэг зээр хунгар цөмрөх агшинд урд хөлөөрөө дагтаршсан цаснаас дүүжигнэсээр амь торгоож хоцорчээ.

Цасан зам гаргасны хүчинд тэрэг хөсөг хөтлийн наад руу бууж ирэв. Тэрэгнүүд гүн цасан хунгарын захад зогсоцгоон нэг эгнээ үүсгээд орчны цасыг цэвэрлэн ачаа бараагаа буулгалаа.

Эрчүүд бүгд Билиг өвгөнийг бараадан ирлээ. Хөгшин өгүүлрүүн “Та нар харж байна уу? Тэр баруун хэсгийн хунгар сайн дагтаршин хөлдөөд зээрийн хоргол, туурайн мөр цөөнгүй байхыг үзвэл олон зээр түүгээр амь гарсан бололтой” гэв.

Хоньчин Санжаа “Чоно бас заримдаа алмай амьтан юм. Хэрвээ азарган чоно тав гурван чоныг томилоод тэр хэсгийг хаачихсан бол зээрийн сүргийг бүхэлд нь ч барьж болох байсан биш үү?” гэхэд

Хөгшин дурамжхан байдалтай “Хэрвээ чи азарган чоно байсан бол лав хамгийн түрүүн өлсөж үхэх байж дээ. Зээрийн сүргийг нэг мөсөн хядчихвал ирэх хавар юугаа идэх болж байна даа? Чоно хүн шиг тийм шунахай амьтан биш ээ. Хүнээс ч илүү тооцоотой байдаг юм шүү” гэв.

“Өнөө жил зээр онцгой их байна. Хэдэн мянгаар нь агнасан ч хүрэлцэх байх. Би ахиу хэдэн төгрөгтэй болоод шинэ гэр барьж авгай авмаар байна шүү дээ” гээд Санжаа хөхрөв.

Өвгөн түүн рүү ёозгүй хялайж “Чиний үр ач нар эхнэр авч тусдаа гарах үед агнах зээргүй болчихсон байвал яах болж байна вэ? Одоогийн залуус улам л хүнээ байгаад байх юм даа” гэлээ.

Хүүхнүүд тэргэн дээрээс юм хумаа буулгаж гүйцэхийг өвгөн үзээд чонын зээр чирсэн хэсгийг цэвэрлэж янзлуулан нарийн зам гаргаж, өөрөө нэгэн цастай довцог дээр зогсон амандаа ямар нэг юм гүвтнэлээ. Тэр дээд тэнгэрээс зээрийн хишиг авахаар гуйн залбирч байгаа байх гэж Чэнь Жэнь таамаглаж байв. Өвгөн нүдээ аниад хэсэг зуур зогссоноо бүгдэд хандан “Цасан доор хангалттай олон зээр байгаа болохоор тэгтлээ битгий их шунаарай. Харин амьд зээр тааралдах юм бол бүгдийг нь тавиад явуулдаг юм шүү. Тэгсэний хойно хөлдүү зээрийг ухаж гаргаарай. Тэнгэр тэдний амийг хэлтрүүлсэн болохоор бид тавьж явуулах учиртай” гэснээ Чэнь Жэнь, Ян Кө хоёрт хандан Чингис хаан ав хомрогын үеэр цөөнгүй ан амьтныг тавьж явуулдаг байсан гэдэг. Манай монголчууд хэдэн зуун жилийн турш ан гөрөө хийсээр ирэхдээ алж хядахыг урьтал болгодоггүй нь чононоос сурсан арга ухаан байгаа юм” гэв.

Билиг өвгөн айл болгонд зээр ухаж гаргах газрыг хуваарилан өгснөөр хүн бүр дор дороо ажиллаж эхэлцгээв. Тэд тал нутагт тогтсон дэг жаягийн дагуу харьцангуй ойр дөт, зээр олонтой ухаж гаргахад хялбар дөхөм газрыг Билиг өвгөн болон хоёр илгээлтийн эзэнд үлдээжээ. Өвгөн Чэнь Жэнь, Ян Кө хоёрыг дагуулан өөрийн гэрийн үхэр тэрэгний дэргэд ирээд дээрээс нь хоёр метр өргөн дөрвөн метрийн урттай хошоод зузаан эсгийг тэврэн буулгав. Эсгийг урьдаар ус сүрчиж норгосон бололтой дарайтал хөлджээ. Чэнь Жэнь, Ян Кө хоёр нэжгээд эсгий чирээд нарийн зөргийг даган урагшлахад Билиг өвгөн урт хусан иштэй төмөр дэгээ бариад араас нь дагалаа. Бат Галсмаа хоёр ч мөн адил эсгийгээ чирсээр цасан хунгар руу дөхөхөд жаахан Баяр аав ээж хоёрынхоо араас урт төмөр дэгээ чирэн алхлана.

Цасан хунгарын захад хүрээд өвгөн хоёр оюутнаар том эсгийг хөр цасан дээр дэлгүүлэхэд лужир зузаан Ян Кө дээр нь гарч хэр зэрэг даацтай болохыг туршиж үзэв. Өргөн даргар эсгий асар том цана мэт Ян Көг гишгэхэд зузаан цас чихран дуугарахаас биш доош шигдэн цөмрөх янзгүй байлаа. Түүнд урамшин хөөрсөн Ян Кө эсгийн дээр дэвхцэхэд үл ялиг хотойхоос биш мөн л доош шигдсэнгүй. Өвгөн сандран түүнийг хориглож болиулаад “Гүн рүү орсон хойно ингэж хөөрцөглөж болохгүй шүү. Хэрвээ цөм гишгэчихвэл хөлдүү зээрнээс өөрцгүй болно гэсэн үг. Ийм юмаар тоглож болдоггүй юм. Чэнь Жэнь чамаас хөнгөн болохоор бид хоёр эхлээд хэд гурван зээр олоод ирье. Дараа нь та хоёр өөрсдөө учраа олцгооно биз” гэхэд Ян Кө эсгийн дээрээс бууж өвгөнийг түшин гаргалаа. Том эсгий хоёр хүнийг өлхөн даагаад зогсохгүй нэмж хоёр зээр тавьсан ч ажрахааргүй янзтай.

Мань хоёр суурьтай зогсож аваад хоёр дахь эсгийгээ татаж авчраад урдуураа гүйлгэн дэвсэв. Ийнхүү хоёр эсгийний амыг зэрэгцүүлэн дэвссэний хойно хоёул том харайн шинээр дэвссэн эсгий дээр гарч зогсоод урт дэгээг түүн дээр тавьлаа. Тэгсэний эцэст саяын үйлдлийг дахин давтаж нөгөө эсгийгээ урдаа чирэн авчирна. Эсгийний байрыг ийнхүү сэлгэн хөгшин залуу хоёр эсгийгээр урласан цасны завиа жолоодох мэт урагшилсаар тэртээ хол байгаа нэгэн зээр рүү дөхөн очив.

Чэнь Жэнь явж явж нүүдэлчин үндэстний цас зудыг гэтлэн туулахын тулд олж нээсэн тээврийн хэрэгсэл болох монгол талын гайхамшигтай шидэт завинд өөрийн биеэр сууж үзэх хувь тохиожээ. Монголын хөдөө талд хичнээн олон малчин энэ шидэт завиндаа суугаад үхэлд хүргэж мэдэх зуд турханы аюулыг гэтлэн гүн цасан дундаас хичнээн тооны хонь нохойны амийг аврахын сацуу, чухам л энэ шидэт завиараа чоно, анчин болон морин цэргийн

бүслэлтээр цасан хунгарт шигдсэн ан амьтан, дайны олзыг татан гаргаа бол доо? Билиг өвгөн угаас энэхүү хар элгийн оюутан залуугаас монголчуудын нууц эрдэм ухааныг нууж хаадаггүй болохоор энэ удаа ч өөрийн гараар түүнд энэхүү зэвсгийг хэрхэн хэрэглэхийг харамгүй зааж байлаа. Тийм болохоор Чэнь Жэнь эрт балраас гаралтай монголын дөрвөлжин цасны завийг жолоодож үзсэн анхны хятад оюутан болжээ.

Эсгий завь улан дороо цас чихруулсаар улам бүр хурдалсаар байв. Чэнь Жэнь үлгэр домогт гардаг шидэт хивс, нисдэг хивсэн дээр суучихаад цасан дээгүүр нисэн хурдлахдаа дагжин чичирч, сандран догдлох, хөөрөн хөвсөлзөх хослоод өөрт нь эрт балрын үлгэр домгийн амьдралтай учрах боломж олгосон тал нутгийн хүн чоно хоёрт өөрийн эрхгүй түмэнтээ талархавч барамгүй санагдана. Цасан нуурын дунд найман нисдэг завь, арван зургаан нисдэг хивс нэгэн зэрэг хөдлөж, хойно урдаа оролцон цас манарган мөс бужигнуулсаар урагшилна. Нохой хуцалдан хүмүүс шуугилдах дуунд тэнгэр тааламжтай инээвхийлэх ажээ. Тэнгэрт зузаан үүл хуралдан жавар тачигнаж эхлэхийг дагалдаад хайлмагтаж байсан цасны гадар дарайтал мөстсөнөөр даргар цасны аюулгүйн баталгаа нэлээд нэмэгдэж хөлдүү зээрийг гаргах ажлыг улам бүр хөнгөвчилж өгөв. Хүмүүс хар нүдний шилээ авцгаан дээш хараад “Тэнгэр минь, тэнгэр минь” хэмээн хашгиралдлаа. Залгуулаад шидэт завины хөдөлгөөн улам бүр эрч далайцтай болж ирэв. Чэнь Жэнь энэхэн агшинд монголын мөнх хөх тэнгэр үнэхээр бодитой оршин байдгийг мэдрэх шиг болж, түүний сүнс тал нутгийн тэнгэрийн хайр энэрлийг дахин хүртжээ.

Гэнэт гүн цасны эрэг хөвөө хавиас Ян Кө, Баяр хоёрын баярласан уухай хадахад Чэнь Жэнь эргэн үзвээс тэр хоёр “Нэг зээр ухаад гаргачихлаа шүү” хэмээн хашгиралдах ажээ. Чэнь Жэнь дурангаа аваад дахин харвал Ян Кө, Баярын заавраар ямар арга хэрэглэснийг бүү мэд нэг том ооно гаргаад хоёул элбэн хөлөөс нь чирсээр үхэр тэргээ чиглэн явж байгааг үзэв. Эрэг бараадан үлдсэн хүмүүс модон хүрзээ барьчихаад цасан хунгарын гүн рүү гүйлдэнэ.

Эсгий завь аюулгүй бүсээс алсран нэгэн том шаргачинд дөхөж ирэхэд түүний нүдэнд горь тасарсан айдас, очийн төдийхөн найдлага сүүмэлзэх шиг үзэгдэв. Түүний эргэн тойронд нэлийсэн цас үргэлжилж, хөлийн доорх ширээн тавцан шиг дагтаршсан цас хэзээ мөдгүй цөмөрч мэдэхээр байлаа. “Эсгийгээ түүний зүг зугуухан дөхүүлээрэй. Айлгаж цочоож болохгүй шүү. Наадах чинь хоёр зээр л гэсэн үг. Тал нутагт амьд явна гэдэг амаргүй. Нэг нэгэндээ амь амьдрал бэлэглэж байх учиртай юм” хэмээн өвгөн өгүүлэв.

Чэнь Жэнь толгой дохиод доош тонгойн түрүүчийн эсгийг цасан хунгарын зүг зөөлөн дөхүүлсээр шаргачингийн хөл дор аваачихад дагтаршсан цас ашгүй цөмөрсөнгүй. Мөнөөх шаргачин урьд нь хүний тус дэмийг хүртэж байсан уу, эсвэл хэвлий дэх үрээ бодоод эцсийн амь гарах найдлагаас зуураад авья гэж санасан уу бүү мэд яадаг ч байсан том эсгий дээр үсрэн гараад пэдхийтэл сөхрөн унахад хамаг бие нь салганан чичрэхийг үзвээс эцэж туйлдан даарч бээрч гүйцсэн бололтой. Чэнь Жэнь сая л нэг юм уртаар амьсгаа авав. Мань хоёр зөөлөн алхалсаар түрүүчийн эсгий дээр хүрээд ар талын эсгийг болгоомжтой чирсээр баруун талын дагтаршсан цастай газар руу чиглүүлэв. Энэ мэтээр арван хэдэн удаа сэлгэсний хойно сая цас цөмрөхөөргүй зээрийн мөр хоргол олонтой газар хүрч чаджээ. “За боллоо. Наадхиа тавиад явуулчих. Хэрвээ наадах чинь дахин босож чадахааргүй бол тэнгэрийн санаа тэр юм биз” гэж өвгөн хэлэв.

Чэнь Жэнь зугуухан явсаар шаргачингийн дэргэд ирэхэд тэр жирийн нэг зээр биш сургуультай согоо мэт үзэсгэлэн гоо агаад өхөөрдөм тормогор хар нүдтэй ажээ. Чэнь Жэнь шаргачингийн толгойг илбэхэд айсан маягтай нүдээ бүлтийлгээд, аврал эрсэн төрх илт байлаа. Чэнь Жэнь хөлийн дор сөгдөн унасан хөөрхийлөлтэй арчаагүй дорой амьтныг илбэж байхдаа сэтгэл нь үл мэдэг чичирхийлж “Өөрөө яахаараа энэ үзэсгэлэнтэй атлаа хүнд хал балгүй амар тайванд дуртай өвсөн тэжээлт амьтныг авран хамгаалъя гэж бодохгүй харин алж хядах зантай чонын талд ороод байгаа билээ?” хэмээн бодов. Тувт л “Чоно шиг хадам ээж”, “Дун Гуо ноёнтон чоно хоёр” зэрэг чоныг өширхөн үзэх үзлээр дүүрсэн үлгэр домог сонсож өссөн Чэнь Жэнь өөрийн мэдэлгүй “Эдгээр зээр яасан өрөвдөлтэй вэ? Ийм гэм зэмгүй амьтдыг алж устгаж байдаг чоно ч мөн муухай амьтан юм даа. Бусдын амийг хэрцгийгээр бүрэлгэж байдаг тэднийг алж устгаж байвал таарна. . “ хэмээн дуу алдчихлаа.

Билиг өвгөний царай барсхийгээд явчихав. Чэнь Жэнь цаашаа хэлэх гэсэн үгээ гүйцээсэнгүй. Тэр өвгөний сэтгэлийн гүн дэх ариун шүтээн, нүүдэлчин үндэстний сүлдэнд харшлах үг хэлсэнээ ойлгожээ. Гэвч ам алдвал яахин барьж болох билээ?

Өвгөн Чэнь Жэньг бүлтийтэл ширтээд зандрангүй дуугаар “Тэгж яривал өвс ч гэсэн амьтай биш гэж үү? Тал нутаг өөрөө амьгүй юм гэж үү? Монгол нутагт өвс тал хоёр том амь, бусад нь жижиг амь байдаг юм. Жижиг амь том амиа түшиглэн амьдардаг болохоор чоно хүн хоёр өөрцгүй жижиг аминд тооцогдоно. Өвсөн тэжээлт амьтан махан тэжээлтнээс ч илүү жигшүүртэй. Чи зээрийг өрөвдөж байгаа мөртлөө өвсийг өрөвдөхгүй байна гэж үү дээ? Зээр дөрвөн хурдан туурайтай болохоор араасаа нэхсэн чонын амаар цус садартал цуцаадаг юм. Зээр ундаасахаараа ус гол бараадан очиж, даарахаараа нөмөр нөөлөг газарт хүрч болно. Харин өвс тэгж чадах бил үү? Өвс хэдийгээр том амь боловч хамгийн гашуун тавилан оногдсон байдаг. Тарчиг хөрсөнд тачир үндсээ шигтгэчихээд сөөмхөн гүйж, ямххан ч хөдөлж чадахгүй. Гэтэл түүнийг гишгэж талхлан, идэж хөнөөх амьтан дэндүү олон. Адууны шээс хүрсэн газрынхаа өвсийг түлж орхино. Өвс ногоо хад чулуурхаг газар ургасан бол цэцэглэж үрээ цацаж чадалгүй өнгөрдөг. Тал нутагт хөөрхий юм гэвэл өвс ногоо л байдаг юм. Тиймдээ ч манай монголчууд өвс ногоо тал нутгаа хамгаас илүү хайрлан өрөвдсөөр ирсэн. Амь хөнөөхийн тухайд гэвэл зээр гэдэг амьтан чинь хадуурын машинаас илүү өвсний амийг сүйтгэдэг. Зээрийн сүрэг энэ тухай бодох ч сөхөөгүй бэлчээрийг талхалж байгаа нь амь таслаж байгаа хэрэг биш гэж үү? Тэр хэрээр талын их амийг таслаж байгаагаас өөрцгүй. Тал нутгийн их амь тасарвал бага аминууд яахин оршин тогтож чадах вэ? Зээрийн хор хөнөөл чононоос илүү аймшигтай шүү. Тал нутагт хар цагаан зуднаас гадна шар зуд гэж байдаг нь чухам үүнийг хэлж байгаа хэрэг. Шар зуд нүүрлэсэн цагт зээр хүн идэж байгаагаас өөрцгүй. . ”

Хөгшний тачир ямаан сахал зээрийн чичрэлтээс ч илүүтэй салганаж байлаа.

Өвгөний хэлсэн үг бүхэн дайны хэнгэрэгийн дэлдэлт адил Чэнь Жэньгийн зүрхийг хүчтэй доргиож сэтгэл нь ихэд тавгүйтэв. Тал нутгийн үндэстэн цэрэг дайны суу билиг, зоримог хатуу зан чанар зэргээрээ тариачин үндэстнээс хавьгүй илүү төдийгүй олон тооны хэвшмэл ухагдхуун нь ч суурьшмал иргэдийг бараадуулахгүй мэт Чэнь Жэньд санагддаг юм. Эрт балраас улбаатай тал нутгийн энэхүү логик нүүдэлчин тариачин хоёр үндэстний хэдэн мянган жилийн турш бие биетэйгээ дайтаж ирсэн үндсэн шалтгааныг илтгэж чаджээ.

Өвгөний энэ үг монголын өндөрлөгөөс Хуа Бэйгийн тэгш талыг өнгийн харсан мэт, чонын шүд шиг тачигнасан хурц агаад мэлзэж мэтгэлцэхийн аргагүй учир зүй төгс байлаа. Хүний савны хариуг хоосон буцаах дургүй Чэнь Жэнь энэ удаа харин хэлэх үггүй гүлдийж хоцров. Түүний хань үндэстний тариачны соёлын ертөнцийг үзэх, оршин тогтнох, амьдралыг ойлгох зэрэг үзлүүд тал нутгийн гүн ухаан, соёлтой мөргөлдөөд агшин зуурын төдийд бутран сарнижээ. Тэнгэрийн ёс гэж байдаг бол тэр жинхэнэ утгаараа нүүдэлчдийн дунд байдаг болохыг Чэнь Жэнь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байлаа. Тал нутгийн нүүдэлчид өвс ургамал, байгаль дэлхий зэрэг том амийг эрдэнэт хүний аминаас илүү дээдлэн үздэг бол суурьшмал иргэд хар амь буюу өчүүхэн амийг хамгаас дээдлэн эрхэмлэдэг билээ. “Гэвч их амь тасарвал бага аминууд яахин оршин тогтож чадах вэ?” гэж өвгөний хэлсэн энэ үгийг амандаа давтан хэлэх зуур зүрх нь чим чим хатгасаар байв. Тэр гэнэт түүхэнд нүүдэлчид суурьшмал иргэдийг алж хядан хөөж, тариан талбайг нь бэлчээр болгон хувиргаж байсан үйлдэл чухам ямар учиртай байсан талаар эргэлзэж эхлэв. Чэнь Жэнь урьд нь түүнийг хоцрогдсон бүдүүлэг зэрлэг хүмүүсийн балмад үйлдэл төдийхнөөр төсөөлж ирсэн юм. Гэтэл өвгөний саяын хэлсэн сав шим ертөнцийн харилцан шүтэлцээний хэмжүүрээр дахин цэгнэж үзвэл “Зэрлэг балмад” гэдэг тодотголыг оноогоод орхиж боломгүй, яагаад гэвэл чухам тэрхүү “Зэрлэг балмадын” цаана хүн төрөлхтний оршин тогтнохын үндэс суурь болсон гүн нарийн соёл иргэншил агуулагдаж байсан ажээ. Хэрвээ “Том амины” байр суурин дээрээс харвал суурьшмал иргэд бэлчээр ойг шатаан, атар газрыг хагалж, алс бөглүү нутгийг ашиглахын тулд тал хээр байгалийн их амийг хөнөөж, улмаар бага амь болсон хүн төрөлхтөн өөрсдөө түүний горьг амсаж байгаа нь зэрлэгийн дээд зэрлэг балмад үйлдэл биш гэж үү? Өрнө дорнодод эх газрыг хүн төрөлхтний эх хэмээн нэрлэдэг. Гэтэл эхийгээ хөнөөх нь ямар соёл иргэншил байх билээ.

Тэр дуу шуу муутайхан “Тэгвэл та яахаараа саяын барьсан зээрийг тавиад явуулчихаж байгаа юм бэ?” хэмээн асуулаа. “Зээр чонон сүргийн анхаарлыг өөр дээрээ татаж тэр хэрээр адуу малын гарз багасаж байгаа юм. Зээр гэдэг өөрөө монголчуудын томоохон туслах аж ахуйн нэг болохоор олон монгол хүн зээр агнасан орлогоор шинэ гэр барьж, эхнэр аван үр хүүхэдтэй болдог. Монголчуудын дийлэнх нь анчид болохоор ан ав хийхгүй бол амьдрал өөрөө давсгүй мах мэт ямар амт шимт байх билээ? Хэрвээ ан хийхгүй бол монголчуудын толгой мангуурч гүйцэх байсан юм. Монголчууд байгаль эхийн их амийг аврахын тулд өвсөн тэжээлт амьтдыг агнадаг нь лав чоно агнадгаас хавьгүй илүү байгаа даа” хэмээн өвгөн өгүүллээ.

Өвгөн уртаар санаа алдаад “Танай хятадуудын ойлгож ухахгүй юм их байна аа. Чи олон ном уншсан л гэнэ. Гэтэл тэр номонд чинь буруу зөрүү ойлголт цөөнгүй байгаа. Хятадууд ном бичихдээ хятадуудынхаа өмнөөс л дуугарах нь тодорхой. Манай монголчууд ч тэгтэл их ном бичихгүй юм. Хэрэв чи овоо монголжлоод ирвэл манай монголчуудын санааг илтгэсэн ном бичвэл сайнсан” гэлээ.

Чэнь Жэнь толгой дохилоо. Тэрээр гэнэт багадаа уншсан олонх үлгэрт гардаг том саарал чононууд, мулгуу тэнэг нь дэндсэн, харгис шунахай амьтад, харин үнэг бол ухаалаг, уран аргатай, өхөөрдөм хөөрхнөөр дүрслэгдсэн байдгийг санав. Харин тал нутагт ирсэн цагаасаа хойш эх байгалийн хүрээлэл дунд “Том саарал чононоос” илүү дээд зэргийн хувьсалтай төгс төгөлдөр амьтан байхгүй болохыг олж мэдэж билээ. Гэтэл ном хэвлэл тэр дундаа хүүхдийн үлгэрт бодит байдлыг дандаа л гуйвуулсан байдаг.

Өвгөн зээрийг түшиж босгоод цастай тал руу зөөлөн түлхэв. Энэ хавийн нимгэн хөр цасан дороос хэдэн бут өвсөн толгой цухуйн үзэгдэх тул өлсөхийн туйлд хүрсэн хөөрхий шаргачин хэд гурав хомхойлон хазлана. Чэнь Жэнь том эсгийнээс хурдан холдов. Шаргачин дагжиж чичрэн хэд алхсанаа сүрэг зээрийн мөрийг бараадан эргэж ч харалгүй онь хөтлийн зүг хурдлан давхисаар тэнгэр газрын савслаганд уусан оржээ. Бат Галсмаа хоёр ч мөн нэгэн шүдлэн зээрийг эсгий дээр чирсээр хөр цас бараадуулав. Галсмаа амандаа “Хөөрхий минь, хөөрхий минь” хэмээн үглэсээр цастай газар өргөж тавиад нуруун дээр нь зөөлөн алгадахад хөтлийг даван цахилж гарлаа. Чэнь Жэнь Галсмаа руу эрхий хуруугаа гозойлгоход Галсмаа түүн рүү харж инээд алдаад “Түүний ээж гүн хунгарт уначихжээ. Тэр ээжийгээ бараадан дороо эргэцээд байхаар бид хоёр удтал ноцолдож байж дэгээний ишээр дарж авлаа” гэв.

Бусад цасны салнууд бүгд нэг дор цугларахад цасан хунгараас амьд мэнд мултарсан зээр бяцхан сүрэг үүсгээд уул даван одоцгоолоо. “Энэ зээр хашир суугаад хэр баргийн чонын хоол болохгүй дээ” хэмээн өвгөн хэлжээ.

## Дөрөв

*Түрэг хэмээгч нь Хүннүгийн нэгэн салаа болой. Ашина овогтон хэмээгдэж тусгай аймаг болон явсаар хожим хөрш улсдаа бут цохигдон устав. Тэр аймгаас арван настай нэгэн жаалхүү үлдэж хоцорсоныг цэргүүд алж түвдэлгүй хөлийг тайраад намагт хаясныг өлөгчин чоно олж тэжээжээ. Өсөж торнисон хойно чоно лугаа нөгцөөд жирэмслүүлжээ. Ван нь тэр хөвгүүний амьд гэдгийг дуулаад хүн явуулан алуулав. Элч түүний цогцсын хажууд нэгэн чоно байхыг үзээд алахаар завдтал чоно Ухасхийн Гао Чан улсын умард зүгийн нэгэн уулнаа дутаан очив гэнэ. Тэр ууланд нэгэн агуй байжээ. . . . Чоно тэр агуйд нуугдаад арван хөвгүүн төрүүлсэн ажээ. Арван хөвгүүн өсөж торниод эхнэр авч олон хүүхэд төрүүлэн тус бүр нэгэн овогтон болов. Ашина хэмээгч тэдний нэгэн буюу.*

*“Жоу улсын бичиг Түрэг”*

Эцэс сүүлдээ хүмүүс өөрсдийн сар шинийн хишгийг хүртэх боломжтой болцгоолоо. Хүйтний эрч чангарч хунгар цасны гадар улам дарайн хөлдөв. Өвгөн анчдад хандан “Тэнгэр биднийг шавдуулж байх шиг байна. Шалавхан хөдөлцгөөгөөрэй” гэхэд хүмүүс дор бүрнээ өөр өөрсдийн оногдсон талбай руугаа ухасхийлдэж ав хомрогын талбарт дахин өөдрөг халуун дүр зураг оволзоод эхлэв.

Өвгөн Чэнь Жэньг дагуулан нэгэн дунд зэргийн цасан хонхорын дэргэд очлоо. Битгий хэт том хонхор руу очоорой. Цасан хонхор том байх тусам унаж үхсэн зээр улам олон байгаа. Долоо найм, арван хэдэн зээр нэг дор унаж үхвэл цасан хунгарт тэр дороо хөлдөхгүй гэдэс дотор нь бээж муудаад дөрвөн хөл нь хөөж сарвайсан байж таарна. Одоо хөлдсөн ч гэсэн мах нь муудчихсан байгаа. Тийм зээрийг бэлтгэн нийлүүлэх цэг дээр авч очвол чанарыг голоод махны үнийг тооцохгүй арьсны мөнгийг олгох болно. Харин бээж муудсан мах чонын хувь дээд зэргийн зоог болдог юм. Энд унаж үхсэн зээрийг Олонбулгийн талын чонод өвлийн турш мартахгүй санаж байх болно. Тийм болохоор бид дуртай зоогийг нь чононд үлдээе” гэлээ.

Өвгөн эсгий дээр хэвгчихээд хусан иштэй дэгээгээ цас руу шааж үзвэл лавгайяа хоёр метр гүн байгаа шинжтэй. Хөгшин энд тэнд хатгаж үзсээр хүчлэн нэг газар дэгээний ишийг тогтоогоод Чэнь Жэньд хандан “Нэгийг дэгээдээд авах шиг боллоо. Хоёулаа элбэж байгаад татъя” гэв. Тэр хоёр нааш цааш холхиулахын хэрээр сул цас үхсэн зээрийн дор чигжсээр их биеийг нь дээш өргөнө. Тэд дээш босоод жишүүлдэн татвал нэгэн зээрийн цастай толгой аажмаар цухуйн үзэгдлээ. Дэгээ нааш ч үгүй, цааш ч үгүй яг зээрийн хоолойг гоходсон тул их биеийн арьс гэмтээгүй байх ажээ. Чэнь Жэнь доош тонгойн зээрийн толгойноос барьж аваад хүчлэн татвал хорь гучин кг хүнд ооно хөлдүү эсгий дээр татагдан гарч ирлээ. Энэ оонын гэдэс дөрвөн мөч хөөж сарвайлгүй хөлдсөн байхыг өвгөн хараад “Маш сайн зээр байна. Лав гайгүй үнэ хүрч таарна” гэлээ.

Өвгөн амьсгаагаа дарж ядан “Цаана нь дахиад байгаа. Чи дэгээдээдэх. Худагт унасан хувинг татах гэж байгаа юм шиг гөхдөх газраа сайтар онолдуулсаны хойно хүчлэн татаарай. Арьс үсийг нь гэмтээчих юм бол ахиу үнэ хүрэхгүй гэж мэдээрэй” гэхэд

Чэнь Жэнь “За за” гээд дэгээний ишийг авч цасан хунгар руу шургуулаад зөөлөн тэмтэрч



үзвээс цаана нь лавтай хоёр зээр байгааг олж мэдэв. Тэр нэлээд тэмтэрсэний эцэст сая зээрийн байр байдлыг тогтоож хүзүүг нь олоод бас л чамгүй ноцолдсоны хүчинд дэгээдэж авах шиг болов. Чэнь Жэнь ингэж нэг тал нутгийн цасан далайгаас анхны “Том загасаа” гөхдөн барьдаг байжээ. Мөртлөө тэр загас нь ердийн цагт хуй салхи мэт хурдан хүлэг унаад ч гүйцэгддэггүй хорь гучин кг хүнд амьтан гээч.

Тэр баярлаж хөөрсөндөө цасан хунгарын захад байгаа Ян Кө рүү хандан “Чи харж байна уу? Би нэг маш том ооно гөхдөөд гаргалаа шүү дээ. Яасан сайхан байна аа?” хэмээн их дуугаар хашгирахад

Ян Кө ч түүний хариуд мөн л их дуунаар “Чи хурдан наашаа хүрч ирээд намайг аваач дээ. Хөгшин аав ч гэсэн жаахан амсхийг” гэлээ.

Цасан далайн энд тэндгүй баярлаж хөөрсөн инээд хөөр цангинан арьс үс сайтай, тарга тэвээрэг тэгширсэн ооно шаргачингуудыг нэг нэгээр нь татан гаргасаар байлаа. Цасны салнууд эрэг рүү эргэн ирж, идэр чийрэг шалмаг залуус нь хоёр дахь удаагийн цасны аялалдаа гарч байна. Бат Галсмаа болон Лхамжавын салныхан хамгийн хурдан шалмаг, онч мэргэн болохоор аль болох том ооно шаргачинг татан гаргаж, бие давжаа буюу бээж муудсан зээрийг олигтой үнэ хүрэхгүй гээд эргүүлэн цасан дунд буцаан шидэлнэ. Ээрэм цасан талд хаврын мал төлөлтийн үеэр л үзэж болох ирмүүн дүр зураг тодров. Алс уулын орой дээрээс тэднийг харж суугаа чонон сүрэг лав багтартлаа уурлаж байгаа нь тодорхой. Тал нутгийн гарамгай ангуучин чоно өөрсдийн олз омгийг хүнд булаалгах цаг мөч бас байдаг байх нь. Чэнь Жэнь ийн бодоод өөрийн эрхгүй хөхин баясав.

Өвгөн, Чэнь Жэнь хоёр хошоод хөлдүү зээр тээсээр цасны хөвөө чиглэн ирэв. Цасан завь ойртон ирэхэд Ян Кө Баяр нар өвгөнийг түшин буулгалаа. Чэнь Жэнь хоёр зээрийг эсгий салнаас түлхэн буулгахад дөрвүүл хамжин өргөөд өөрсдийн үхэр тэргэнд ачив. Тэдний хоёр гэрийн үхэр тэргэн дээр өөр хэдэн зээр ачаастай байхыг Чэнь Жэнь хараад ямар учиртай болохыг асуулаа.

Ян Кө түүний хариуд “Баяр бид хоёр нэгийг ухан гаргасан. Бусдыг нь нөгөөдүүл маань манай хоёр гэрийнхэнд өгч байгаа юм гэсэн. Олонбулгийн тал нутагт тогтсон дэг жаяг юм байх аа” хэмээн өгүүлсэнээ инээд алдан “Бид хөгшин аавыг дагаад морьтын хишиг явганд гэгч болж байх шиг байна аа” гэхэд

Өвгөн ч мөн баяртай инээгээд “Та нар тал нутгийн усыг уусан болохоор ёсыг нь дагаж байх хэрэгтэй дээ” гэжээ.

Өвгөн ядарсан бололтой үхэр тэрэгнийхээ дэргэд суугаад гаансаа гаргаж ирэв. Тэр өгүүлрүүн “Та хоёр одоо өөрсдөө явцгаа. Тун мэдээтэй явдаг юм шүү. Юмыг яаж мэдэхэв, доошоо цөмөрчихвөл гар хөлөө алдлаад амьсгаагаа түгжээрэй. Тэгж чадвал гүн шигдэхгүй. Эсгий дээр үлдсэн хүн дэгээгээ өгөхдөө нүүр нүдийг нь гэмтээчих вий. Тэгж золигтвол алсдаа авгайд тоогдохгүй амьтан болж хоцорно гэж мэдээрэй” гээд хахаж цацан инээгээд Баярыг дуудан түлээ зөөлгөж гал ноцоогоод үдийн хоол хийхээр зэхэв.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр баяр хөөр дүүрэн цасан салны зүг хөдлөв. Цасан далайн хөвөөн дэх

гүн хунгар цасан дунд нэгэн том онгойсон хонгил зам үзүүр нь харагдахгүй онгойн үзэгдэнэ. Ян Кө инээд алдан “Сая аав дэргэд байсан болохоор би чамд хэлээгүй юм. Энэ нүхийг Баяр бид хоёр элбэж ухаад тэр том ооныг гаргаж авсан юм шүү дээ. Баяр тун адтай золиг юм гээч. Та нарыг явсаны дараа бие жижигтэй юм болохоор нэг хөдсөн дээл дэлгэн тавьж байгаад элэглэн мөлхөхөөр цас цөмрөхгүй юм. Тэгсээр тав зургаан метрийн цаахантай үхсэн зээрийн нүх байхыг олж мэдээд надтай элбэж цас малтан тэр нүхээрээ шурган ороод хөлнөөс нь дээс уячихаад гараад ирсэнийг би ганцаараа татан гаргалаа. Зориг гэж ч ёстой чулуу юм аа. Би ч цас нураад дарчих вий гэж тун их айж байсан шүү” гэв.

Чэнь Жэнь түүний хариуд “Би түүнийг мэдэлгүй яах вэ? Цаадахь чинь улаан нүцгэн гараараа чоно сүүлдчихдэг хүүхэд энэ хэрийн цасан хонгил руу орохоос айна гэж байх уу даа? Монгол хүүхдүүд ийм адтай болохоороо л мундаг баатар эрс болж өсдөг байх” гэлээ.

Ян Кө өгүүлрүүн “Би уг нь Баярыг цасан нүх рүү орж болохгүй гэсэн чинь өөдөөс чонын үүр рүү айлгүй орж байсан хүн чинь иймхэн нүхнээс айх юу байх билээ гэдэг байгаа. Тэр долоон настай байхдаа чонын үүр рүү орж бэлтрэг суйлж байсан удаатай гэнэ лээ. Чи чинь бэлтрэг суйлах юм сан гээд байдаг хүн. Үнэхээр тийм юм бол хоёулаа Баярыг аваад явъя л даа” гэв.

Чэнь Жэнь ихэд сандарсан байдалтай “Тэр ч харин үгүй шүү. Бид монголчуудын зан төлвийг хараад атаархахаас илүү юу хийж чадах билээ?” хэмээн өгүүлэв.

Ян Кө, Чэнь Жэнь хэмээх энэ хоёр Бээжингээс ирсэн оюутан монгол нутгийн цасны салан дээр сууцгаалаа. Идэр залуу Ян Кө баярласандаа царайгаа атируулан “Тал нутагт ан гөрөө хийх шиг бахтай зүйл алга аа. Өдөржин хонь малтай хөөцөлдөн шөнийн манаанд гарах хичнээн уйтгартай вэ? Чонотой нэг л зууралдчихвал амьдралын өнгө аяс олон талтай, сэтгэл сэргэм зугаатай юм биш үү?” гэлээ.

“Уудам талд хүн амьтан цөөн, хааш хаашаа хэдэн арван газарб зайнд ганц ч монгол гэр байхгүй болохоор чонотой харьцан ан гөрөө хийж байхгүй бол уйдаж үхнэ биз дээ? Хэдэн өдрийн өмнө нэг сайхан ном олж уншлаа. Түүнд бичсэнээр бол тал нутгийн нүүдэлчид хэдэн мянган жилийн тэртээгээс чоныг сүлдээ болгосоор ирсэн юм байна шүү” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

Тэр хоёр өглөөний цайн дээрээ үхрийн чанасан хавирга идчихсэн болохоор ааг хүч нь амтагдаж байлаа. Манай хоёр залуу луут завины уралдаанчин шиг цан хүүрэг савсуулсаар гар хөлөө зэрэг зэрэг ажиллуулан хойш урагш сэлгэхэд эсгий сал цасны моторт чарга мэт урагш ухасхийв. Ян Кө өөрийн гараар нэг том ооно татан гаргаж ирээд хөөрч баярласандаа гишгэсэн эсгийгээ цөмлөх шахам дэвхцэхэд Чэнь Жэньгийн хүйтэн хөлс чийхран түүнийг тогтоон барьж авлаа. Ян Кө оонын биеийг алгадангаа “Сая хүмүүс зээр дэгээдэн гаргаж байхыг үзээд зүүдлэж байна уу гэж бодож байсан юм. Гэтэл одоо өөрөө зүүд нойрноос сэрэх шиг боллоо. Үнэхээр ийм сайхан зүйл гэж байдаг аа. Чоно гуай, чоно гуай тандаа их баярлалаа” хэмээнэ.

Ян Кө дэгээний ишнээс зуураад өгөх янзгүй тул Чэнь Жэнь аюултай газар түүнтэй булаалдаад байя ч гэж бодсонгүй хүч хавсрагч болон хувирав. Ян Кө залгаагаар гурван том ооно татан гаргаж ирээд ч санаа нь амарч буцан явах шинжгүй марсайтал инээгээд “Хоёулаа

бүгдийг татан гаргасны хойно нэгмөсөн зөөчихвөл бүр амар биш үү?” гээд дэгээдэн гаргасан зээрээ зузаан хунгар цасан дээр тавилав.

Билиг өвгөн нэг гаанс тамхи нэрчихээд дээш босон “Цасан далайн” эрэг дээр байгаа хүмүүсийг дуудан тэрэгний хажуу дахь цасыг цэвэрлүүлж бүр ч том зай гаргуулав. Айл бүрээс ирсэн авгай хүүхнүүд хагархай хэмхэрхий банз, эвдэрхий тэрэгний модон хигээс зэргийг тэр зайнд авчраад хоёр хэсэг түүдэг овооллоо. Мөн цэвэрлэсэн зайндаа хуучин эсгий дэвсээд дээр нь халуун савтай сүүтэй цай, архины лүү, модон аяга, давсны лааз зэргийг авчирч тавив. Санжаа өөр нэг хүүхэдтэй элбэж хөл нь гэмтсэн боловч хараахан хөлдөж үхээгүй байсан хоёр зээрийг гаргаж анчдын үдийн зоогийг бэлэн болгов. Ноход чонын үлдээсэн сэг зэмээр хангалттай хооллож амжсан болохоор арьсаа өвчүүлж өрцөө нээлгэсэн зээрийн шинэ махыг тоож харах ч үгүй ажээ. Нэг түүдэг гал ноцсоны хойно Билиг өвгөн бүсгүйчүүд хүүхдийн хамт төмөр модон шоронд зээрийн шинэхэн мах хатгаж нарийн давс цацан галд шараад цай уунгаа зооглож эхлэв. Хорхой хүрэм цай сүүний ааг, архи махны үнэр түүдгийн утаагаар дамжин цасан далайн голд хүрч анчин залуусыг тавтай хооллохыг даллан дуудлаа. Жин үдийн нар голлоход айл бүрийн эсгий завь хоёр гурван удаа ч ангуучилж амжсан тул айл өрх болгоны үхэр тэргэн дээр долоо найман хөлдүү зээр ачсан харагдана. Эрчүүд бүгд эргэн ирсэний хойно идэж ууж ханасан эмс хүүхнүүд, хүүхэд шуухад бүгдээр эсгий салан дээрээ сууж аваад цасан далайн гүн рүү зээр гөхдөхөөр яаран явцгаалаа.

Зээрийн шинэхэн шарсан мах гэдэг монголын хөдөө талын амттаны дээд аргагүй мөн билээ. Ялангуяа ав хомрогын дараа түүдэг гал ноцоон шинэхэн ангийн дээжээс шарж иднэ гэдэг эртний монгол хаад язгууртнуудын хамгийн бахтай таашаал төдийгүй жирийн анчдын хувьд ч ухарч буцамгүй найр цэнгэл юм. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч анчин гөрөөчний хувиар энэхүү ав хомрогын талбайд үүсгэсэн той найранд оролцох учиртай байжээ. Тэр хоёр Бээжингийн хямд хоолны газар болон шарсан махны зоогийн танхимуудыг ор тас мартаж орхисон байлаа. Ан авын догдлол баяр, алжаал зүдрэлийг арилган, хүн бүрийн хоолны дуршлыг ихэсгэж Чэнь Жэньгийн хувьд монголын хаад язгууртнуудаас ч илүү бахдал жаргалтай мэт санагдана. Учир нь хээрийн чонын найрлаж өнгөрсөн энэ газрын эргэн тойрон тэдний идэж үлдээсэн сэг зэмүүд дүүрэн хөглөрнө. Ийм орчинд хооллож байгаа хүн гэдэг өлөн барс өлөгчин чононоос өөрцгүй ховдог шунахай агаад тэр хэрээрээ сэтгэлийн таашаал цэнгэл эдлэж чаддаг байна. Чэнь Жэнь, Ян Кө хоёрын цээжинд гэнэт монгол хүний омог бах оволзон бадрахад зэрэг шахам тэвчээр алдраад шавайгаа ханатал ууж идэн, уянгалуулан дуулалдах монгол анчдын гараас шимийн нэрмэлийн савыг шүүрэн авч ам руугаа годгодуулан залгилж гаравай.

Билиг өвгөн тэднийг хараад бахтай инээд алдаж “Дахин нэг жил өнгөрвөл би та хоёрын Бээжинд байгаа аав ээж нартай чинь уулзах нүүргүй болох юм байна даа. Би та хоёрыг монголын омголон залуус болгон хүмүүжүүлж орхих нь шиг байна” гэхэд

Ян Кө архи сэнгэнүүлэн “Манай хятадуудад монголчуудын омог жавхаа байдагсан бол сая хүрдэт тэргээ хөлөглөн цавчаал боомтын хаалт саадыг эвдлэн дэлхийн дайдад хүрч чадахсан” гэнэ. Чэнь Жэньгийн ч дуу чангараад “Аав аа, аав аа, аав аа” хэмээн гурвантаа дуудан Билиг “Овгийн ахлагчид” сархдын дээжийг өргөн барьлаа. Өвгөн сархдыг тосон авч гурав том балгаад “Миний хүү, миний хүү, сайн хүү шүү” гэв.

Улаан зээрд болтлоо халсан Бат алгаа дэлгэн Чэнь Жэньгийн ар зоо руу цохиод “Чи . . . чи . . .

монгол хүн . . болох яагаа ч үгүй байна даа. Монгол авгай аваад. . гэрээрээ дүүрэн. . монгол хүүхэдтэй болсон. . цагт сая чамайг монгол хүн хэмээн тооцож болно. Чам шиг хүч. . чадалгүй амьтан ч яаж. . тэгж чадах билээ? Монгол хүүхнүүд. . хөдсөн хөнжил дотроо. . ямар айхтрыг чи мэдэх үү? . . Чононоос айхтар. . гээд бод доо. Монгол эрчүүд. . тэднээс айгаад. . хонь. . хонь. . мэт бүлтэгэнэж. . байдаг юм” гэв.

Санжаа түүний үгийг өлгөж аваад “Шөнө манай эрчүүд хонь шиг номхон, эмс нь чоно шиг болон хувирдаг юм. Тэр дундаа Галсмаа ямар айхтар гэж бодно” гэж хэлэв.

Анчид нирхийтэл инээлдэв.

Лхамжав хөөрсөндөө Ян Көг барьж авч, хөр цасан дээр тонгорон унагаагаад ам хэл нь тультран “Хэзээ. . хэзээ чи намайг. . барилдаад унагаж чаддаг. . болсон үедээ өөрийгөө . . монгол эр хүн гэж тооцоорой” гэхэд

Ян Кө мөчөөгөө өгөх янзгүй дахин барилдаад Лхамжавт тэрий хадтал шидүүлэв. Лхамжав тачигнатал хөхөрч “Танай хятадууд ногоо идсээр хонь шиг болчихсон улс. Харин манай монголчууд мах иддэг болохоор чоно шиг адтай байдаг юм” гэлээ.

Ян Кө хувцсан дээр тогтсон цасыг гөвөнгөө “Чи гайгүй ээ, харж л байгаарай. Би ирэх жил амбан шарын мах худалдан авч ганцаараа идээд чамаас бүтэн толгой илүү өсөхөөрөө чамайг хонь болгоод өгөхөө мэдэх байлгүй” гэхэд

Анчид нэгэн дугаар “Зөв дөө, хө” хэмээн хашгиралдав.

Талын монгол анчид архи уухдаа хоолноос илүү ховдог тул долоо найман том савтай архи хэд тойроод л хоосров.

Ян Кө архи дууссаныг үзээд зориг нь чангарч Лхамжав руу хандан “Би бөхөөр чамайг дийлэхгүй ч гэсэн архиар бол бараадуулахгүй байсан юм” гэв. Лхамжав түүний хариуд “Үнэг шиг зальтай золигийг хараарай. Үнэг хэдий зальтай ч талын чонын ухааныг яаж гүйцэх билээ? Тийм лут юм бол хүлээж байгаарай. Надад архи байгаа” гэхихээд морь руугаа очин эмээлдээ унжуулсан эсгий богцноос том шилтэй талын хар архи, хоёр жүнзтэй гаргаж ирэв. “Би уг нь энэ архиар бусдыгаа дайल्या гэж бодож байсан юм. Тэгвэл одоо харин чамайг торгодог хэрэг ээ” гэж Лхамжавыг хэлэхэд бусад нь “Сайн торгоод өг” хэмээн дэмжив.

Ян Кө дурамжхан инээвхийлээд “Үнэгний заль талын чонын ухаанд хүрэхгүй ажээ. Би торгуулахаас даа” гэлээ.

Лхамжав өгүүлрүүн “Чи аан гэж бай. Манай тал нутгийн заншил ёсоор торгож байгаа эзэн хэд гэж хэлнэ вэ, чи тэр тоогоор уух учиртай юм. Би урьд нь нэг удаа буруу ам гарчихаад монгол хятадаар ус цас шиг ярьдаг нэг сурвалжлагчид айхтар чадуулж билээ. Энэ удаа би чамайг тэрэн шиг болгоод өгөхөө мэдэх байлгүй” гэснээ нэг жүнзэнд архи дүүргэн “Хошоочлон нисэх хайргацай шувууны хос жигүүр хоёр хундагатай” гэв.

Ян Көгийн царай барайгаад “Дөрвөн жигүүрт хос хундага дүүжилчихээр найман жүнз гэсэн

үг байна шүү дээ. Өрөөсөн жигүүрт нь нэг л хундага өлгөөч дээ” хэмээн гуйхад Лхамжав түүний хариуд “Чи хэрвээ хэлсэн үгэндээ эзэн байж чадахгүй юм бол би хошоочин шувуудын хоёр жигүүрт гурав гурван хундага дүүжилчихнэ гэж мэдээрэй” гэж зандаллаа.

Чэнь Жэнь ч олноос хоцорсонгүй дуу нийлүүлэн “Уулга, заавал уулга” хэмээн хашгирахад Ян Кө арга буюу найман хундага талын хар архи гулгуулав. Өвгөн инээд алдан “Тал нутагт анд нөхөртөө том ам гарсан хүн ч сайнаа үзэхгүй дээ” гэнэ.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр өвгөний шарж өгсөн хоёр шортой махыг тосож аваад шүүсийг савируулан идэж гарав. Тэр хоёр одоо шүүрхийвтэр мах идэх дуртай болоод байгаа билээ.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Аав аа, би өнөөдөр анх удаа боохойн хишгийг хүртэж байгаа минь энэ. Өдий насалтлаа ийм амттай сайхан мах идэж үзээгүй санагдана. Эртний хаад болон тэдний үр хойчис яагаад ан авд тэгтлээ дуртай байсны учрыг би одоо л ойлголоо. Тан улсын Тайзун хаан хятадын түүхэнд лут том хаан байсан гэгддэг юм л даа. Тэр хаан ан авд их бахтай байсан гэдэг. Түүний угсаа залгамжлах хунтайз өөрийн түрэг торгон цэргүүдтэй ан ав хөөцөлдөөд явчихдаг байсан юм гэнэ лээ. Тэр хунтайз ордон дотроо гэр бараа бариулчихаад, хонь нядлан чануулж өөрөө чанасан махаа огтлож идэх дуртай байжээ. Тэр энэ бүгдийн төлөө өөрийн хаан ширээ залгамжлах эрхээ ч гаргуунд нь гаргаад Түрэгийн чонон сүлдтэй дайны тугийг мандуулан түрэг цэргүүдийнхээ хамт ан ав хөөцөлдөн тал нутгийн амьдралын зам мөрийг сонгожээ. Тан улсын Тайзун хаан тэр бүхнийг тэвчилгүй угсаа залгамжлах эрхийг нь хассан юм гэдэг. Тал нутгийн амьдралын амт хаан ширээнээс илүү үнэ цэнэтэй байсан гээд та бод доо” гэв.

Хөгшин тэр бүхнийг нүд бүлтийлгэн сонсож байснаа “Наадахь домгоо чи урьд нь надад ярьж өгч байгаагүй юм байна шүү. Тун сонин домог байна. Танай хятадууд бүгдээрээ Тайзун хааны хунтайз шиг тал нутагт сэтгэл зүрхээ зориулбал зүгээр юмсан. Уг нь тэр хүү хаан ширээндээ заларсан бол ч мөн хэрэгтэй байж дээ. Хятадын манж чин улсын хаад бүгд тал нутагт элэгтэй, монголын талд ав хомрого хийх дуртай төдийгүй бүгд монгол хатантай байсан юм гэдэг шүү. Тэд хятадуудыг нааш зүглүүлэн газар хагалуулдаггүй байсан болохоор монгол хятад хоёр дайтахгүй талын зоо нэг хэсэг тэнийсэн байж таарна” гэлээ.

Билиг өвгөн Чэнь Жэньг түүхийн талаар ярихад их л тааламжтай сонсох төдийгүй савыг нь хоосон буцаалгүй монголын түүх домгийг ч харамгүй ярьж өгнө. Тэр өгүүлрүүн “Тал нутагт чонын хишиг хүртээгүй хүн жинхэнэ монгол хүн биш ээ. Ер нь ч чонын хишиг гэж байгаагүй бол монголчууд бид байхгүй байж мэдэх юм. Урьд нь монголчууд ядарч туйлдах цаг үе бүхэнд чонын хоолноос хуваалцан амьд гарч байсан удаатай юм. Чингис хааны дээд өвөг хэн ч билээ дээ, аглаг ууланд арга мухардан бүгж явахдаа идэж уух юм байхгүй өлсөж цангахын туйлд хүрчээ. Тэр чоныг бараадан явж ямар нэгэн амьтан бариад идэж дуусахыг хүлээж байгаад үлдээсэн жаахан сэгийг иддэг байсан гэдэг. Тэр маягаар ууланд хэдэн ч жил болсоны хойно ах нь эрж олоод авч буцсан юм гэнэ лээ. Чоно гэдэг ийм л ач буянтай амьтан байгаагүйсэн бол Чингис хаан ч, монгол үндэстэн ч байхгүй байх учиртай юм. Чонын хишиг амттайгаас гадна бид энэ олон зээрийг арилжаад хэр зэрэг их цагаалгын зүйлтэй болно гэж бодож байна даа. . . Гэхдээ чонын хишиг тэр болгон хүнд заяагаад байдаг эд биш болохыг чи яваандаа ойлгох болно оо” гэжээ.

Тэд хоёр зээрийн ясыг мөлчийгтэл мөлжиж гүйцэхэд түүдгийн гал ч зөнгөөрөө унтрав. Гэвч Билиг өвгөн цас малтуулж үнс нурмыг сайтар булж дарууллаа.

Үүлс өтгөрөн хуралдаад уулын оройгоос салхинд туугдсан цас пансан алчуурын намираа шиг хуйларсаар хүрч ирнэ. Олон айлын лужир анчид тус тусын салаа жолоодоод цасан далайд дахин аялцгаав. Хүмүүс явган шуурга зээрийн унасан хунгарыг дарахаас өмнө үхэр тэргээ дүүргэхээр шавдацгаажээ. Нэг зээрийг амжиж татан гаргаваас зургаан долоон дугуй булантай цай, арван хэдэн хайрцаг Тяньжинд үйлдвэрлэсэн Хайхө нэрт янжуур, эсвэл арван тав зургаан шил талын хар архи арилжин олох боломжтой юм. Анчид Билиг өвгөний заавраар гүн хунгарыг орхиж арай гүехэн хэсгийн зээрийг амжиж гаргахаар ажиллацгаалаа. Өвгөн бас хүмүүсийг дэгээдэхдээ сайн сал жолоодохдоо шаламгай зэргийг харгалзан хэдэн хэсэгт хуваасан юм. Цасны сал эрэг дээр дөхөн ирэхэд бэлдсэн олс дээсний хэрэг гарч, хэдэн лужир эрс цасны завин дээрх хүмүүст олсоо шидэж өгөхөд цаадуул нь тосож аваад эсгийн нэг үзүүрээс бөх уяж, үлдсэн үзүүрийг буцааж шидлэнэ. Тэр үзүүрийг эрэг дээр байгаа хүмүүс тосож аваад хүчлэн татсанаар завь хунгарын хөвөөнөө маш хурдан татагдан ирж байлаа. Үүний эцэст өөр цасны завь руу олсыг шидэж татан гаргах зэргээр хамтран ажилласнаар ажлын эрч эрс нэмэгджээ.

Цасан далай дахь хүмүүсийн сүүдэр уулын бараан хүүшинд шингэх үед айлуудын үхэр тэрэг хөлдүү зээрийг данхайтал ачсан байлаа. Зарим анчид түүдэг асаан гал манаж хоноод ч хамаагүй үлдсэн зээрүүдийг татаж гаргаад овоолон хурааж, буу зэвсэгтэй хүнээр мануулан маргааш тэрэг чаргатай ирж авья гэсэн санал гаргав.

Гэвч Билиг өвгөн тэдний саналыг зад зандран таслалаа. “Эцэг тэнгэр бидэнд ийм л хишиг хүртээх гэж ганц сайхан өдрийн боломж олголоо. Тэнгэрийн таалал хамгаас шударга байдаг юм шүү. Айлын адуу хонийг идсэн чоно амиараа түүнийгээ төлөх учиртай байдаг. Салхи шуурга босох янзтайг үзвээс тэнгэр эдгээр үлдсэн зээрүүдийг чононд үлдээхийг сануулж байгаа юм. Тэнгэрийн тааллыг дагахгүй хэн байлаа даа? Энэ эзгүй хээр нүдгүй шуурга балбаад, сүрэг чоно дайран ирвэл хэн тэсэж гардаг юм бэ?” гэв.

Хариу дуугарах хүн үгүй тул нийт суурийн анчид буцах замдаа оров. Алжааж ядарсан хэрнээ баяр хөөр дүүрэн хүмүүс хүнд ачаатай үхэр тэргийг түлхэж хөтлийг давуулсаны хойно морь, тэргэндээ сууцгаан өөрсдийн суурь байдаг өвөлжөөний зүг явцгаалаа.

Чэнь Жэньгийн хамаг биеийн халуун хөлс царцаж, дагжин чичирнэ. Цастай тал, онь хөтөл, зам харгуй хаа сайгүй хүний мөр, үнс нурам, тамхины иш, архины шил тэрэгний дугуйн мөр дурайсаар айлуудын өвөлжөөг чиглэжээ. Чэнь Жэнь морио давиран Билиг өвгөний дэргэд давхиж очоод “Аав аа, чононууд энэ удаа их хохирол амссан болохоор биднээс өшөөгөө авахгүй биз дээ? Та өөрөө чонын ой санамж гоц сайн болохоор хаана идэж, хэнтэй зодолдон, хэнээс өшөөгөө авахаа сайн мэддэг юм гэдэг биш үү?” хэмээлээ.

“Бид нар энэ удаа шальтай их юм аваагүй дийлэнх хагасыг нь чононд үлдээсэн. Хэрвээ би шуналтай барам байсан бол цасан хунгарт модон шор хатгачихад шуурганы дараа ч гэсэн түүгээр баримжаалаад үлдсэн зээрийг татан гаргаж болох л доо. Би тийм сүнсгүй юм хийгээгүй нь цаагуураа бэлчээр нутгаа бодсон хэрэг. Ирэх жилийн хавар чонон сүрэгт үхсэн зээрийн хөлдүү мах байгаа болохоор хүн малд төвөг удаад байхгүй. Тэгээд ч чоно бидэнд

өглөг үйлдэж байхад бид хуншгүй загнаад яах билээ? Азарган чоно үүнийгээ мэдэхтэй тул санаа амар байж болно” гэлээ.

Орой нь хээр талд цасан шуурга шуурч эхлэхэд хоёрдугаар суурийн илгээлтийн эзэн залуусын гэрт халуу дүүгнэ. Чэнь Жэнь уншиж байсан “Монголын нууц товчоо” номоо хамхиад Ян Көд хандан “Билиг аавын өнөөдөр ярьж байсан чонын үлдээсэн сэг зэмээр хооллосоор амьд мэнд үлдсэн хүн маань Чингис хааны наймдугаар үеийн дээд өвөг Бодончар мэргэн байж шүү дээ. Чингис хааныхан бүгдээрээ Бодончарын удмын Боржигин овгийнхон байсан юм. Ер нь Боржигин овог Бодончар мэргэний үед л түүхийн тавцан дээр гарч ирсэн юм байна лээ. Хойч үеийнхэн нь хэдэн айхтар түүхийн нугачаа хувирлыг туулж өнгөрөөсөн л дөө” гэв.

“Тэгэхээр чиний хэлэх гээд байгаа санаа чинь хэрвээ чоно гээч амьтан байгаагүй бол, тийм цэргийн багш, сургагчгүй Чингис хаан ч, алтан ураг ч, арга ухаан агуу зориг хослосон монголын морин цэрэг ч байхгүй байсан хэрэг үү? Тэр утгаар авч үзэх юм бол талын чоно нүүдэлчин үндэстэнд асар их нөлөө үзүүлжээ дээ” хэмээн Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Хятад болон дэлхийн түүхэнд бүр ч их нөлөө үзүүлсэн гэвэл зохино. Чингис хааны удирдсан монголын морин цэрэг үүссэнээр хятадын Алтан улс, Сүн улсын түүх шал өөрөөр бичигдэж эхэлсэн. Дундад ази, Перс, Орос, Энэтхэг зэрэг улсуудын түүх ч өөрөөр бичигдэх болсон. Хятадын дарь монголын морин цэргийн ази европоор хөндлөн гулд гаргасан замыг дагалдан аялж өрнөдийн феодалуудын цайз хэрмийг зад ниргэсний хүчинд хөрөнгөт ёс тогтнох саад тотгорыг арилгасан биш үү? Түүнээс улбаатай их бууны ам дорно зүг рүү хандаж хятадын хаалгыг зад цохиод эцэс сүүлд нь монголын морьт цэргийг үгүй хийснээр дэлхийн түүх орвонгоороо эргэсэн байна шүү дээ. . . .Гэвч чонын дэлхийд гүйцэтгэсэн үүргийг хүмүүс өөрсдийн бичсэн түүхийн номондоо ор мөргүй орхигдуулсан байна. Хэрвээ дээд тэнгэр түүхийн ном туурвидагсан бол лавтайяа монгол чонын алдар сууг хөх судартаа тэмдэглэн үлдээх байсан нь лавтай” гэлээ.

Үхэрчин Гао Зянь Жун өнөөдрийн гэнэт орж ирсэн олз омогт магнай хагартал баярласнаа нууж ядан “Та хоёр яасан холын юм бодож сэтгэдэг улс вэ? Бидний дав даруй хийж гүйцэтгэх ёстой ажил гэвэл маргааш тэр цасан хунгарт очиж үлдсэн зээрийг татан гаргаж ирвэл зад баяжих биш үү?” гэхэд Чэнь Жэнь “Дээд тэнгэр чононд ээлтэй байдаг хэрнээ бидэнд тэрэг дүүрэн зээр өгсөн нь болоо биш үү? Энэ цасан шуурга гурван хоног нүдээд хунгарын цас лав хагас метр зузаарах байлгүй. Тэр нүд нүүргүй цасан дундаас зээрийн шигдсэн нүхийг олж очно гэдэг өвсөн дундаас зүү эрэхтэй адил хэрэг. Гао Зянь Жун гэрээс гарч тэнгэрийн байдлыг ажиг байснаа буцан орж ирээд “Нээрэн ч тэнгэр хангайн байдал гурван өдөр цасаар шуурах янзтай. Хэрвээ би өнөөдөр явсан бол хамгийн олон зээртэй хунгарт шор хатгахаа мэдэхгүй хаачихав” гэхэд Ян Кө “Чи тэгвэл Галсмаагийн хийдэг хуруудыг идэх хувьгүй болох байсан юм” гэж явуулна. Гао Зянь Жун хэнгэнэтэл санаа алдаад “За яахав, ирэх хаврыг хүлээж байгаад үхэр тэрэг дүүрэн зээр ачаалж аваад, Баянгол нэгдлийн бэлтгэн нийлүүлэх цэг дээр аваачин тушаачихад та хоёр л хэлчихдэггүй юм бол өөр хэн мэдэх билээ?” гэв.

Өвлийн үлдсэн өдөр саруудыг мал сүрэг өнтэй тарган өнгөрөөлөө. Олонбулгийн талын чонон сүрэг зээрийн сүргийг даган бараа туруу нь ч үзэгдэхгүй болоод зуд турханы аюул нүүрлэсэнгүй.

Өвлийн уйтгартай өдөр хоногуудад Чэнь Жэнь хонины хишигт явах, шөнийн ээлжинд гарахаас бусад дийлэнх чөлөөт цагаа тал нутгийн чонотой холбоо бүхий хууч яриа олж сонсоход зориулдаг байв. Тэр нисдэг чонын тухай хууч яриаг тодруулах гэж багагүй цаг завьг зарцуулсан билээ. Ойрноос Олонбулгийн талд нисдэг чонын тухай цуу яриа ихэд газар авч уг хэрэг чухам түүний харьяалагддаг багийн нутагт болжээ. Чэнь Жэнь Олонбулгийн талын чоно чухам яаж нисч чаддаг болсоны учрыг олж хужрыг тунгаахаар шийдсэн юм.

Илгээлтийн эзэд тал нутагт ирсэн даруйдаа л чоно бол тэнгэр заяатай амьтан болохоор нисэж ч чаддаг гэхийг цөөнгүй сонсож дуулж байсан билээ. Хэдэн зуун мянган жилийн турш тал нутгийн малчид үхэгсдийн цогцсыг хээр талд ил задгай оршуулаад түүнийг нь чоно ирж хөнддөг уламжлал тогтсон. Үхэгсдийн цогцсыг чоно хөндөж араг яс төдийхөн үлдсэнээр уг оршуулах ёслол дуусаж байгаа хэрэг юм. Талын малчид чоныг тэнгэрээр дүүлэх эрдэмтэй, үхэгсдийн сүнсийг эцэг тэнгэрт хүргэнэ гэж үздэгийн улмаас ил задгай хүн тавих ёс үүссэн нь төвдийн тасын хавцал лугаа төстэй зан үйл билээ. Илгээлтийн эзэд түүнийг “Дөрвөн бурангуйн” нэг, мухар сүсгийн илрэл төдийхөн зүйл гэж үгүйсгэхэд малчид өөдөөс нь чоно үнэхээр нисдэг юм шүү гэж мэлзэнэ. За тэр эрт балрын зүйл ч яахав, харин саяхан буюу бүр тодруулбал соёлын хувьсгал дэгдээд гурван он тохиож байх үед хоёрдугаар багийн малчин Цэрэндоржийн чулуун хороонд сүрэг чоно нисэн ороод арван хэдэн хонь идэж, хоёр зуу гаруй хонины амь таслалчаад яваад өгсөн байна. Идэж ууж ханасан чонон сүрэг буцахдаа мөн л өндөр чулуун хорооны ханыг даван нисээд явчихжээ. Тэр чулуун хорооны хана зургаа долоон тохой өндөр, хүн ч давж чадахааргүй байтал чоно яахин нисэн ордог билээ? Тэр чулуун хороо одоо ч гэсэн байсаар байгаа тул та бүхэн итгэхгүй бол очоод үзэхэд ч гэмгүй шүү. Хэрэг гарсан өдөр аж ахуйн дарга Өлзий хэсгийн төлөөлөгч Харбарс болон бусад хариуцлагатнуудаа дагуулсаар Цэрэндоржийнд очиж зураг авч, хэмжилт хийсэн байна. Хорооны хана чоно давахааргүй өндөр, эргэн тойронд чоно шургачихаар зай завсар үгүй байжээ. Үзлэгийн эцэст чоно яаж чулуун хороонд нэвтрэн ороод буцаж гарсаныг хэн ч хэлж мэдэхгүй боловч малчид энэ тухай харин сайтар гадарлаж байлаа.

Энэ хэрэг Чэнь Жэньгийн ухаан бодлыг эзэмдсээр энэ үед чонын хорхойдоо улам бүр автах болсон тэрээр нэг өдөр морио унан хэдэн арван газрыг туулан мөнөөх чулуун хороонд очоод сайтар ажиглаж үзсэн боловч ямар нэгэн сэжигтэй шинж тэмдэг олж чадаагүй юм. Чоно яаж чулуун хороонд нэвтэрсэний учрыг олж ядсан Чэнь Жэнь арга барагдаад Цэрэндорж өвгөнтэй орж уулзав.

Өвгөн “Манай бүтэлгүй хүүхдүүдийн хэн нь мөнх тэнгэрийг хилэгнүүлсэн юм бүү мэд, амьтан хүний нүүр харах аргагүй ийм л айхтар юм болчихоод сууж байна даа” гэхэд тэдний дунд сургуульд сурдаг нэг жаалхүү үгийг өлгөж аваад “Энэ чинь аж ахуйгаас гаргасан журмын харгай шүү дээ” гэдэг байгаа. Тэр үед Олонбулгийн талд чулуун хороо дэлгэрээгүй байсан үе л дээ. Аж ахуйн захиргаанаас малчдад шөнийн ээлжинд гарахад олгодог мөнгийг хэмнэх, мал сүргийн аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор төллөх хонины хэдэн суурьт чулуун хороо барьж өгсөний нэг нь энэ юм. Аж ахуйн захиргаанаас чулуун хороонд чоно нэвтрэн орж чадахгүй болохоор шөнө жижүүрлэх хэрэггүй, тайван унтаж болно гэж хэлж л дээ.



Өвгөн өгүүлрүүн “Манайхан хэд хоног шөнө оройдоо хорооныхоо хаалгыг түгжчихээд хонио манадгаа байчихсан юм. Тэр шөнө ноход айхтар сүрхий хуцаад байхаар нь сүрэг чоно ирж гэдгийг мэдсэн боловч аж ахуйн захиргаанаас шөнийн манаагаа татан буулга гэсэн болохоор юу л болоо аж гэж бодоод гарч хараагүй юм. Маргааш өглөө нь хорооны үүдээ нээгээд үзтэл нэлийсэн цус, үхсэн хонинуудыг хараад бүгд л сүнс зайлах шахсан. Хорооны хана ч нэл цусаар будагдсан байдаг шүү. Үхсэн хонинууд хүзүүн дэх дөрвөн том соёоны ормоор хамаг цусаа гадагшаа юүлээд хорооны гадна хүртэл урссан байна лээ. Бас энд тэнд чонын баас үлджээ” хэмээн ярьсан юм. . . . Хожим нь аж ахуйн захиргаанаас гаргасан шийдвэрээ эргэж хараад чулуун хороотой хот айлууд ч гэсэн шөнийн манаанд хүн гаргаж хөлс мөнгөө бодуулж авч байхаар болсон билээ. Сүүлийн жилүүдэд төллөх хоньдын сууринд чулуун хороо олныг барих болсон боловч шөнийн манаа гаргадаг тул чоно хороо даван хонь барьсан хэрэг дуудахаа больсон юм.

Чэнь Жэнь ч цөхрөлтгүй энэ тухай олон малчдаас асуухад хөгшин хөвөө, эр эм ялгалгүй бүгд л чоно нисэхээр барахгүй үхсэн хойноо сүнс нь тэнгэрт залардаг гэлцэнэ.

Хожим нь хэсгийн төлөөлөгч Харбарс хошууны боловсон хүчнийг байцаан шалгах ангид хэсэг хугацаанд асуугдаж байгаад цагаадан хуучин ажилдаа орлоо. Чэнь Жэнь Бээжингээс ирүүлсэн сайн тамхи аваад түүнтэй учран золгосноор нисдэг чоно чухам яаж чулуун хороог нэвтэрсэн учрыг олж мэджээ. Харбарс Өвөрмонголын аюулаас хамгаалах сургуульд тусгай боловсрол олж авсан нэгэн тул хятадаар ус цас шиг ярина.

Тэрээр “Энэ хэрэг одоо хаагдсаан. Гэхдээ түүний сургуульд олж авсан мэдлэг хөдөө нутагт тохирохгүй, малчид ч түүнд итгэхгүй чоно нисдэг юм шүү гээд мэлзээд байдаг. Харин жаахан боловсрол туршлагатай анчид л түүний үзлэг шинжилгээний үр дүнд итгэсэн гэнэ” хэмээн Харбарс инээгээд цааш өгүүлрүүн “Хэрвээ монгол үндэстний уламжлалт шашин шүтлэг, зан заншлыг хүндэтгэн үзэх аваас чоно чулуун хороонд нисэн орлоо гэдэг үг яриаг ор тас үгүйсгэж болохгүй юм л даа. Чоно тодорхой зайнд дүүлэн нисэж чадна” гэв.

Тэр цааш нь өгүүлэхдээ “Тэр өдөр аж ахуйн нийт малчид бүгд л сандралдан тэнгэр хилэгнэж гай гамшиг нүүрлэх нь гэгцгээж байв. Адуучид ууланд адуугаа хаячихаад гэр орноо эргэн, хөгшид хүүхнүүд тэнгэрт сүслэн залбирцгаана. Хүүхдүүд ч гэсэн зодуур амсаад уйлахааргүй алмайрч хоцроод байлаа. Энэ байдал мал аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх нь гэж Өлзий дарга сандраад хоёр өдрийн хугацаанд энэ хэргийн үнэн мөнийг олох үүрэг өглөө. Би аж ахуйн нийт боловсон хүчний хүчийг зохион байгуулаад хэргийн газрыг хамгаалалтад авсан боловч хүн малын хөлд гишгэгдээд ул мөр баларч орхисон байлаа. Би гэдэг хүн томруулдаг шилээ барьсаар ямх сөөм газрыг ч үлдээлгүй ажигласны хүчинд чулуун хорооны зүүн хойд булангийн ханан дээрээс чонын сарвууны хоёр бүдэг мөр илрүүлж олсоноор хэргийн учиг тайлагдсан юм даа. Чи чононууд чулуун хороонд яаж нэвтэрсэн байх гэж бодож байна вэ?” гэхэд

Чэнь Жэн толгой сэгсрэв.

Харбарс хэсгийн төлөөлөгч өгүүлрүүн “Миний олж тогтоосноор хамгийн том биетэй нэгэн чоно хойд хоёр хөл дээрээ босож зогсоод урд хөлөөрөө хана түшин бусдыгаа авирахад дэм болж өгчээ. Бусад чононууд арван хэдэн алхмын зайтай газраас давхин ирээд том чонын

нуруу мөрөөр дамжин харайж чулуун хороонд орж чадсан байна. Дотроос нь харах юм бол тэр чоно нисэн орж ирсэнээс ямар өөрц байх билээ?” гэв.

Чэнь Жэнь хэсэг зуур дуугаа хураан сууснаа “Олонбулгийн талын чоно мөн гайхалтай ухаантайяа. Тал нутагт анхны чулуун хороо барьж эхлэхэд л түүнийг дөнгөх ухаан сийлчихсэн байдаг. Мөн айхтар ухаан шүү. . . .Малчид чоныг нисдэг гэлцдэг нь ч оргүй үг биш. Чоно харайн дүүлэхдээ цаана нь үлдэх тодорхой зайг нисэн туулж байгаа юм. Чоно тэнгэрээр дүүлэн хонин сүрэг дээр буухад хоньд айсандаа сүнс зайлсан нь гарцаагүй. Чонон сүрэг тэр удаа ёстой шавайгаа ханатал цэнгэсэн байж таарна. Хороо дүүрэн хонийг бариад ходоодоо дүүртэл иднэ гэдэг чинь. Харин гадаа хоцорсон тэр чоно юу ч идэлгүй хохироод үлдэж дээ. Бие томтой бусаддаа элэгсгийг бодвол лав азарган чоно байсан байлгүй” гэлээ.

Харбарс хэсгийн төлөөлөгч тас тас хөхрөөд “Үгүй дээ, хаанаас. Миний тогтоосноор тэр чоно ч гэсэн дотогш орж найрласан байна лээ. Тал нутгийн чонон сүрэг хамтын ухамсар маш хүчтэй, маш эвсэг байдгийг чи ч яахин мэдэх вэ? Нэгийгээ хохирооно гэж яасан ч үгүй. Дотор байсан чононууд цадгал идсэнийхээ дараа нэг том чоноо гаргаж, нөгөөгөө оруулаад тэр өлөн боохой бор ходоодоо божийлгож авчээ. Гадаах ханан дээр цустай сарвууны мөр гарсан байна гэдэг чинь дотроос очсон чонынх байж таарна биз дээ? Эхний чоно хонь бариагүй үед хана түшсэн болохоор сарвууны мөр цусгүй байсан. Чи өөрөө тэр үед чухам юу болоод өнгөрсөнийг бодоод үзээрэй л дээ. Чоно ч хүнийг дамшиглаж орхисон байгаа юм шүү. Чонон сүрэг дотогш ороод л хоньдыг хядаж гарсан байж таарна. Хүмүүс бид бодохдоо чулуун хороогоор чононоос хамгааллаа гэсэн чинь хоточ нохдоо гадаа үлдээчихсэн байдаг. Цэрэндоржийн хэдэн ноход хоолойгоо сөөтөл хуцаад хоцорно биз дээ? Ноход чонотой адилхан чулуун хороо давж ороод чонотой урцалдаж чадахгүй. Нохой чинь чононоос хавьгүй тэнэг амьтан шүү дээ” гэлээ.

Чэнь Жэнь “Би ч нохдоос дээрдээд байх юм алга. Тэгвэл чонон сүрэг чулуун хорооноос бүгд яаж мултран гарч чадсан хэрэг вэ? Хамгийн сүүлд бусдынхаа тулгуур болон үлддэг чоно яаж хана даван гарч чадсан юм бол?” хэмээн асуув.

Харбарс тас тас хөхрөөд “Хүн ч нээрэн чононоос тэнэг амьтан байна лээ шүү. Бид анх бүгдээрээ л наад асуултын чинь хариуг олцгоохгүй байсан юм. Хожим нь Өлзий дарга хоньдын цусыг туучин чулуун хороонд орж ирээд сайтар ажигласны эцэст наад асуултын чинь хариуг олсон юм. Мэдэх нь ээ, чулуун хорооны зүүн хойт буланд зургаа долоон хонийг овоолсон байсан. Хамгийн хүч тэнхээтэй арга самбаатай нэг чоно үлдээд үхсэн хоньдыг зуун дээр дээрээс нь овоолж тулгуур хийгээд ханан дээгүүр харайн гарсан байж таарна. Зарим хүмүүс ганц чоно тийм хүнд ажлыг амжуулж дийлэхгүй, хэд хэдэн чоно элбэж байгаад хийсэн байх гэж байсан. Хожим нь Өлзий дарга бүх баг хэсгийн дарга нарыг дуудан авчирч чонон сүрэг хэрхэн чулуун хороог давж ирээд буцаж гарсан үйл явцыг газар дээр нь үзүүлж таниулсаны хүчинд малчид нам тайван болцгоосон юм. Аж ахуйн зүгээс Цэрэндоржийг ч зэмлэж шийтгэлгүй өнгөрөөсөн. Өлзий дарга өөрөө л харин чоныг дэндүү басамжилснаас болж ийм хэрэг гарлаа хэмээн харуусаж байдаг шүү” гэв.

Чэнь Жэньгийн хамаг бие зарсхийлээ. Хэдийгээр тэр Харбарс хэсгийн төлөөлөгчийн шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарт итгэж байсан боловч тал нутгийн чонон сүрэг түүний зүүдний оронд этгээд сонин төрхтэй дүүлэн нисэж байхыг олонтоо үзэх болсон юм.

Тэр үүнээс хойш тал нутагт яригддаг чонын тухай хууч домгуудад сониучирхал төдийхөн хандахаа больж билээ. Тэр өрнөдийн олон эрдэмтэн судлаачид сүм хийддээ үнэнчээр мөргөж байдгийн цаад учрыг ойлгож эхлэжээ.

\* \* \*

Хэд хоногийн дараа Чэнь Жэнь аргалж байгаад багийн мэдлийн хоёр хэсэг хүн тавьдаг газрыг очиж үзжээ. Тэдгээрийн нэг нь Цагаантолгой уулын ар бэлд, нөгөө нь Харчулуут уулын зүүн хойт бэлд оршдог юм. Өнгөцхөн харвал энэ хоёр хүн тавьдаг газар бусад бэлчээр нутгаас тэгтэл ялгагдаад байх юм үгүй. Харин сайтар ажиглах юм бол хоёр оршуулгын газар зам харгуй олны хөлийн газраас хол, аглаг зэлүүд хошуу буюу тахилгат уулын ар зэрэг өлөн чоно, өндөр огторгуйд ойрхон оршдог болохоор үхэгсдийн сүнс тааваараа тэнгэрт зорчих боломжтой болдог буй за. Түүнчлэн тэндхийн газар орны байдал хэвцэг бартаатай, энхэл донхол ихтэй тул үхэр тэргийг сайн донсолгодог байж таарна.

Олонбулгийн талд хэдэн мянган жилийн турш зарим айлууд үхэгсдийнхээ хувцсыг тайлаад эсгийд ороон хүлж тавьдаг бол зарим айлууд хувцсыг нь хөндөхгүй. Тэгээд шарилыг үхэр тэргэн дээр тавиад тэрэгний арал дээр хөндлөн мод уяж өгдөг. Үүр цүүрээр буюу бар цагийн үед үхэгсдийн гэрийн хоёр ахмад настан арал дээр бөхөлсөн модны нэжгээд үзүүрээс барьж мориндоо мордоод оршуулгын газрыг чиглэн хурдан давхиулдаг билээ. Шарил үхэр тэргэний донсолгоонд унасан газар түүний сүнс тэнгэрт халиад адуун сүргийн нуруун дээр босоо заяатай төрсөн монгол үндэстний нэгэн гишүүний энэ насны амьдрал дуусгавар боллоо гэж үздэг. Хэрвээ үхэгсдийг эсгийд ороосон бол хоёр шарилчин мориноос бууж хүлээсийг тайлаад энэ хорвоод анх яаж ирсэн яг л тэр байдлаар тэнгэр харуулж энгэр дэрлүүлэн орхино. Ингэснээр үхэгсдийн бие чонын мэдэлд буюу сахиусны харьяалалд очиж байгаа хэрэг. Үхэгсдийн сүнс тэнгэрт эсэн мэнд хүрсэн эсэх нь энэ насандаа үйлдсэн буян нүглээс хамааралтай гэгцгээнэ. Хүмүүсийн ярих нь гурван өдрийн дараа тэр тухай мэдэж болдог ажээ. Өөрөөр хэлбэл гурван өдрийн дараа талийгаачийн цогцсыг чоно хөндсөн байвал түүний сүнс тэнгэрт хальжээ гэсэн үг. Харин чоно хөндөөгүй хэвээр байвал байдал эсрэгээр болох тул гэрийнхэн нь айж сандарцгаана. Гэхдээ Олонбулгийн талд чоно элбэг тул хэн нэгний сүнс тэнгэрт халиагүй тухай Чэнь Жэнь сонсож байсан удаагүй.

Чэнь Жэнь урьд өмнө Төвдийн тасын хавцлын тухай дуулж байсан боловч монгол нутагт ч мөн нэгэн адил талийгаачийг ил задгай оршуулж, түүнийг нь тас шувууд биш, чоно хөнддөг болохыг огт мэддэггүй байсан юм. Тэр баг сууриудад бараа түгээдэг худалдааны агентаас оршуулгын газрын байршлыг асууж мэдээд бусдад мэдэгдэлгүй хоёр удаа очсон билээ. Гэвч цасанд хучигдаад түүний төсөөлж байсан дүр зураг харагдаагүй юм. Харин нэг удаа дүн өвлийн цаг байсан бөгөөд цасан дээр шинэхэн морь, үхэр тэргэний мөрийг даган явсаар нэгэн өвчнөөр өөд болсон настай бүрлээчийн шинэхэн хөдөөлүүлсэн бололтой цогцсыг олж үзсэн юм даг. Талийгаач цасан талд нялх хүүхэд мэт амгалангаар дээш харан нойрсоод нимгэн зөөлөн цас хамаг бие, хацар нүүрийг нь хадаг мэт хучсан нь амгаланг эдлэж уужирсан мэт санагдав.

Замын турш өөрийг нь эзэмдсээр ирсэн айдас түгшүүр аажмаар ариусал сүсэг болон хувираад Чэнь Жэнь нэг хэсэг алмайрсан мэт гөлрөн зогсов. Талийгаачид үхсэн хүний шинж өчүүхэн төдий ч үгүй харин дээд тэнгэрийн найранд залраад ариун угаалыг үйлдэн, шинэ

амьдралтайгаа золгож байгаа мэт санагдана. Чэнь Жэнь талын монгол үндэстэн чонон сүлдийг дээдлэн шүтдэг болохыг анх удаа үнэн голоосоо итгэж биширлээ. Хүн амь амьдралын төгсгөлд эхээс төрсөн биеэ сэтгэл харамгүй өргөл болгоод, түүнийхээ хүчинд төгс ариусал гэтлэлийг олж чадна гэж хатуу итгэж эцэг тэнгэртээ, тал нутгийн чонодоо сүнсээ даатган өгч чадах монгол үндэстний чин үнэн сүжигт хэн эргэлзэх билээ дээ?

Чэнь Жэнь энэ ариун дагшин газар удаан хоргодож төвдсөнгүй. Талийгаачийн сүнсийг цочоож, тал нутгийн ариун шашин шүтлэгийг гутаах вий гэсэндээ талийгаачид гүнээ хүндэтгэлтэй мэхийн ёслоод морио хөтлөн оршуулгын газраас холдон явж билээ. Тэр үхэр тэрэгний эцсийн цэгийг хүртэл ийш тийш сөөлжин явсаныг ажиглах зуур тэрэгний донсолгоог олж сонсох шиг санагдав. Тэр алцамлан хэмжиж үзвэл дөч тавь гаруй метр зайг туулсан нь тал нутгийн хүмүүний адармаатай амаргүй амьдралын зам мөрийг хураангуйлсан ч юм шиг. Хүний амьдрал гээч ийм ахар богино, эцэг тэнгэр хэмээгч өнө мөнх ажгуу. Чингис хаанаас авахуулаад тал нутгийн жирийн малчин хүртэл энэ насны амьдралдаа хамгийн олонтоо хашгирсан нь “Мөнх хөх тэнгэр! Мөнх хөх тэнгэр! Эцэг тэнгэр минь!” гэсэн уухай байсан байж таарна. Харин хөх чоно болвоос тал нутгийн эзэн хүний гэгээн сүнсийг мөнх тэнгэрт хүргэх элч байдаг ажээ.

Гурван өдрийн дараа талийгаачийн ар гэрийнхэн айж сандралдахгүй байхыг хараад Чэнь Жэньгийн сэтгэлээс том бул чулуу ховхрон унах шиг болов. Тухайн газрын ёс заншлаар гурван өдрийн дараа үхэгсдийн хөдөөлүүлсэн газрыг эргэж очсон малчид үл таних хүн, морины мөр тэр хавиар эргэсэн болохыг төвөггүй гадарласан боловч түүнийг зэмлэсэн хүн гараагүй билээ. Харин талийгаачийн сүнс тэнгэрт халиагүй шинжтэй байвал өөрөө их л эвгүй байдалд орж мэдэх байсан юм. Энэ үеэс Чэнь Жэньгийн сониуч зан хүсэл сонирхол хоёр тал нутгийн нүүдэлчдийн сүлд шүтээн, сахил цээртэй зөрчилдөж эхлэв. Тэр хонио сайтар маллахын зэрэгцээ түүний хүсэл сонирхол, хүндлэл бишрэлийг улам бүр төрүүлэх болсон тал нутгийн нүүдэлчин үндэстний гүн нууц руу дөхөн очлоо.

\* \* \*

Өнөө жилийн хавар хавьгүй эрт айлчлан ирж, хэдэн удаа бүлээн салхи үлээсний эцэст Олонбулгийн тал цасан хучлагаа хуу татан хаялаа. Цасан дор тавтай нойрссон намрын өвс ил гарч, зарим энгэр ээвэр газраар нялх ногоо цухуйжээ. Залгуулаад хаврын хавсрага шуурч эхлэхэд баг суурийн малчид хаваржаандаа буугаад хээрийн түймэр, ган гачгаас сэргийлэх, төл малаа арчилж өсгөх гээд дуусашгүй ажил ундарч гарав.

Гао Зянь Жун энэ удаа ганзага хоосон хоцров. Юу болсон бэ гэхээр аж ахуйн төвд гаднаас шилжиж ирсэн жолооч, барилгачин зэрэг нөхдүүд Галсмаагийн суурийн малчид бэлтгэн нийлүүлэх хоршоон дээр тэрэг тэрэг дүүрэн зээрийн мах тушааж байхыг үзээд шунал нь асаж гүйцэлгүй яахав. Тэд нар анчдаас хаана тийм их хөлдүү зээр байгааг асуухад ухаж гаргаад дууссан гэж амыг нь таглажээ. Цаадуул нь Баярыг чихрээр хуурч байгаад ам алдуулах гэсэн боловч адтай золиг өөр уулын амыг зааж өгөөд молигодчихсон гэдэг. Хожим нь зүүн хойд хятадын тариалан эрхэлдэг орноос гаралтай монгол үндэстэн голцуу тэр хүмүүс талын нүүдэлчдийн хамгийн эмзэг цэг болох архийг барьж авсан нь түлхүүрээ олсон хэрэг болов. Тэд нар нутгийнхаа эрдэнэ шишээр нэрсэн хатуу архийг Санжаад цутгаж умаахан болгож аваад хөлдүү зээр агуулж байгаа газрыг заалгаад авчихжээ. Тэд нар чонон сүрэг Гао Зянь Жун

хоёроос өрсөн хөлдүү зээрийн гулууз хөр цасан дороос дөнгөж цухуйх агшинд хүрээ хороо хатган хонон өнжин ухсаар ганц өдрийн зуур сайн муу том жижиг гэлтгүй гарган авч чаджээ. Тэгээд шөнө дүлээр дөрвөн том ачааны машинд ачаалаад Баянгол нэгдлийн бэлтгэн нийлүүлэх цэгт аваачин тушаасан байна.

Хоёрдугаар багийн адуучид хэдэн шөнө дараалан ууланд чонон сүрэг уй гашуутай улих дуу тасраагүй гэлцэх тул өдөр шөнө алгасалгүй адуунаасаа алхам ч холдохоо больжээ. Ар гэрт үлдсэн авгай хүүхнүүд нь дуу шуугаа хураан уур унтуу болцгооно.

Удалгүй аж ахуйн төвөөс жил бүр уламжлал болон тогтсон бэлтрэг суйлах ажлын зар албан ёсоор зарлагдаж амласан шан урамшуулал өмнөх жилийнхээс хавьгүй их болсон тул цэргийн төлөөлөгч Бао Шунь Гүй зориуд оролцохоор иржээ. Өнөө жилийн бэлтрэгний арьсны үнэ ч суга өссөн гэгцгээнэ. Торго шиг зөөлөн олдоц ховор бэлтрэгний арьсаар бүсгүйчүүдийн дээд зэргийн хүрэм хийдэг юм. Тиймдээ ч умард зүгийн хэдэн мужийн том дарга нарын авгай хүүхнүүдийн дуртай эдлэл, хурган дарга нарын арын хаалга онгойлгох түлхүүр болжээ.

Билиг өвгөн дуу шуугаа хураагаад ойр ойрхон гаансаа нэрж суудаг болов. Тэр хааяа нэгхэн “Чоно ч одоо гаарч өгнө дөө” гэж амандаа үглэхийг Чэнь Жэнь сонсдог байлаа.

*Түрэгийн дээдэс нь Хүннүгийн умар зүгийн Суо хэмээх улсаас гаралтай гэлцдэг. Аймгийн ахлагч Ананбу ах дүү арван долуул. Тэдний нэг Ижинишит чононоос төрсөн ажгуу. Панбучүүд бүгд мунхаг тул улс нь удалгүй мөхжээ. Ижинишит харин цаг уурыг шинэжин, салхи бороог оруулж чадах бөлгөө. Хоёр эхнэр авсан нь зуны эзэн сахиус, өвлийн эзэн сахиус нарын охид ажээ. Тэдний нэг нь жирэмслээд дөрвөн хөвгүүн төрүүлэв. . . .Ийн өгүүлэх нь этгээд мэт боловч явж явж чонын үрс гэдгийг батлах болой.*

*“Жоу улсын бичиг Түрэг”*

Өтгөн хар үүлс умард хилийн шугамыг даван эрчлэн хуйларсаар хөх тэнгэрийг бүрхэх нь түймрийн бараан угаа мэт. Удаж төдөлгүй үүлс зуун газарт үргэлжлэх уулсын сүүдрийг залгих нь том хар нудрага тал нутгийн дээрээс далайн буух лугаа адил. Баруунаа шингэх улбар наран хараахан бүрхэгдээгүй агаад, хуйрагнах цасан ширхэгийг шидлэх умардын салхи нүд ирмэхийн төдийхөнд өргөн уудам Олонбулгийн талыг шилбүүрдэж эхлэв. Хуйрагнасан цасан ширхэг шингэх нарны жишүү туяан дор хэдэн сая живаа царцаан сүрэг шар далавчийг дэвсээр үржил шимт бэлчээр рүү рүү хошууран дайрах шиг харагдана.

Чоно борооноор, муу эр самбаанаар гэсэн монгол ардын хууч үг байдаг. Хэдэн арван жилийн турш хоёр орны хил дамнан нүүдэллэн амьдарсаар ирсэн чонон сүрэг тэдний хувьд ховорхон завшаан болох хаврын хавсарга шуургыг далимдуулан хилийн дээс, гал түймрээс хамгаалах зурвас болон хил хамгаалалтын зам зэргийг гатлан давсаар Олонбулгийн талд хүрэлцэн иржээ. Хилийн чанадад хатуу өвөл болж, өвс тачир зээр цөөрсөний улмаас чонон сүрэг гуринхалж гүйцсэн байлаа. Өнөө жил хилийн наахан чонын нөөцөлсөн зээрийг хэсэг хүн хуу хамаад одсон, хилийн цаана идэш тэжээл хомсдож, цас хайлан нимгэрсэний улмаас зээрийн сүрэг чононд баригдахад амаргүй болсон ажээ. Энэ удаа хил даван орж ирсэн сүрэг чоно, өлөн ховдог яахаас ч буцахгүй амьтас болон хувирчээ. Тэд амь насаа гаргуунд нь гаргаж байгаад ч хамаагүй өшөө хорслоо тайлж мэдэхээр улангассан байв. Харин Олонбулгийн талд уламжлалт бэлтрэг суйлах ажил оволзоод энэхүү сүрэг чонын аюулыг анзаарах сөхөөтөн байсангүй.

Жараад оны сүүлч үеэр цаг уурын мэдээ “Бороо орж ч магадгүй, орохгүй ч байж магадгүй” гэдэг үедээ байсан юм. Ямар сайндаа л Өлзий дарга цаг уурынхан ч дэмий донгосож байгаа биз дээ гэж байх билээ. Билиг тэргүүтэй нутгийн хэдэн хашир өвгөд аж ахуйн дарга нарт өдий төдий хүн хүч бужигнуулан бэлтрэг суйлаад дэмий биш үү гэж хэдэн ч удаа сануулж байсныг эс тооцвол энэ салхи шуурга, чонон сүргийн аюулыг урьдчилан мэдсэн хэн ч байгаагүй юм. Малчид болон мал аж ахуйн үйлдвэрлэлд ихээхэн санаа тавьдаг хил хамгаалах отрядын цэрэг дайчид ч гэсэн энэ байдлыг урьдчилан харж, цаг тухайд нь сэрэмж өгч чадаагүй байлаа. Олонбулгийн талын хил орчмын нутгаар аараг толгодоос өөр халхалж хаацайлах саад үгүй болохоор хахир хүйтэн хавсарга шуурга хүүе хаая гэхийн зуур дайран ирдэг тул угаас цаг уурын дайнд мэргэшсэн талын чонон сүрэг энэ байдлыг гаргууд сайн ашиглаж, удаа дараагийн цахилгаан дайны ажиллагааг явуулж ирсэн туршлагатай.

Олонбулгийн баруун хэсгийн нэгэн нөмөр нөөлөг бэлчээрт энэ хэдэн өдрийн турш шинэ адуун сүргийг эмхлэж байлаа. Тэдгээр нь өвөрмонголын өрхийн морьт цэргийн дугаар

дивизийн дугаар хорооны арван хэдэн адуун сүргийн дундаас ангилан шилж авсан дал наяд аргамаг хурдан хүлгүүд байсан юм. Энэ хэдэн өдөр морьдын шинжилгээний бичиг хүлээгдэж байсан бөгөөд хэрвээ ям өвчин үгүй нь тогтоогдвол замдаа гарахад бэлэн болжээ. Дайны бэлтгэл ажил шахамдуу явагдаж байсан тэр цаг үед, цэргийн агт адгуулах гэдэг маш хариуцлагатай хэрэг байв. Аж ахуйн цэргийн төлөөлөгч болон хувьсгалт хорооноос хариуцлагатай, сонор сэрэмж, эр зориг, морин эрдэм зэрэг бүх талаар шалгарсан дөрвөн адуучныг сонгон хорин дөрвөн цагийн турш хоёр ээлжээр, адуун сүргийг харуулж байлаа. Хоёрдугаар багийн өрхийн цэргийн сумангийн дарга Бат тэр адуучдын хэсгийг ахлан, цэргийн агт нутаг руугаа буцаж гүйхээс сэргийлэн адуун сүргийг унаган сүргээс нь хэдэн арван газрын зайтай адгуулах аж. Ойрын хэдэн өдөр нар салхи найртай дулаан, тунгалаг ус бургилан ураж, хаврын ногоо хамар хатгахаар ургасан болохоор цэргийн агт шинэ нутагтаа идээшин дасаж, нутгаа гүйн тэмцэх явдал хараахан үгүй байв. Дөрвөн адуучин ч хэр чинээгээр хичээсний хүчинд хэдэн өдрийн турш айх аюулгүй амар тайван байжээ.

Хүйтний эрч жаахан сулармагц салхины хурд эрс ширүүсэн нүд нүүргүй балбаад нуурын ус эргээ балбан, мал сүрэг хашаагаа эвдэн сад тавив. Салхины аман дээр байсан монгол гэрүүд хөмөрсөн аяга хөлбөрөх шиг хийсэн хэд бөмбөрөөд талаар нэг таран бутарна. Салхи сөрөн явж байсан мухлаг тэрэгний эсгий чингэлэг хуу татагдан тэнгэр өөд цойлон нисэв. Нүд нүүргүй цасан шуурганд морьтой хүн унасан хүлгийн толгой сүүлийг ч олж үзэх аргагүй болжээ. Цасан ширхэг элсэн бууны амаар цацагдах элс лүгээ адил хурдтай хуйлран, сая живаагаар тоологдох урт цагаан үснүүд уудам огторгуйн энгээр бүжиглэж байх шиг санагдана. Тал нутагт цагаан үст шуурга гэж үүнийг нэрлэдэг нь чухам энэ байдлаас үүдэлтэй юм. Тэнгэр газрын савсалганд оршиж байгаа тал нутгийн хүн мал хоёр цасан шуурганаас ширвээдэн айхгүй байна гэж үгүй. Хүн хашгирах, адуу янцгаах, нохой хуцах зэрэг мянга түмэн чимээ энэ тэр гэж ялгахын эрхгүй холилдох боловч цасан шуурганы аварга түрхрэн түүнээс илүүтэй сонсогдоно.

Бэлтрэг суйлах ажилдаа улайран, хонож өнжихөөр шийдсэн хүмүүс уулын цасанд боогдон гарах аргагүй болоод гэртээ харихаар явсан цөөнгүй хүмүүс замдаа төөрч орхижээ. Малын захыг бараадан үлдсэн хөгшин хөвөө, эмс охид голцуу хүмүүс эрвийх дэрвийхээрээ хөдлөн, алдсан малын эрэлд явах, хонь ямаагаа хашиж тогтоохоор ажиллаж байлаа. Тал нутагт олон жилийн хүч хөдөлмөрийн үр шимийг тогтоож чадах эсэх нь ганцхан өдөр шөнийн хугацаагаар хэмжигдэх үе бишгүй л нэг тохиодог.

Хил даван орж ирсэн чонон сүрэг зохион байгуулалттай довтлох анхны байгаараа цэргийн агтыг сонгожээ. Цасан шуурга босдог тэр өдөр цэргийн агт заасан хугацаанд хөдөлдөг нь боллоо хэмээн Билиг өвгөн ханцуй дотроо сүслэн сууж билээ. Гэвч хожим мэдэх нь ээ, цэргийн агт шинжилгээний бичгээ хүлээгээд нэг өдөр алдсан байжээ. Мөртлөө шинжилгээний бичгийг хүргэх учиртай холбоочин маань цэргийн төлөөлөгч Бао Шүнь Гүйгийн хамтаар бэлтрэг суйлах ажилд дайчлагдсан байв. Өнөө жилийн суйлсан бэлтрэг урьд жилүүдийнх шиг арван хэдээр тогтохгүй, бүр зуу давсан аж. Бэлтрэгээ алдаж, ульж гуринхалсан өлөгчингүүд чонон сүрэгтэй нийлснээр бүр ч улангассан хүчийг үүсгэв.

“Энэ сайхан боломжийг дээд тэнгэрээс азарган чононд хүртээсэн байж таарна. Олонбулгийн домогт цагаан цээжит азарган чоно сайтар тандсаны эцэст өшөө авах байгаа сонгож авсан

хэрэг” гэж Билиг өвгөн хожим ярьж билээ.

Салхи исгэрэх чимээнээр Бат адуучдын отрын жижиг гэрээс бөхийн гарч ирэв. Тэр хэдэн шөнө дараалан адуу манаж хоноод маш их ядарсан тул энэ өдөр амрах учиртай байсан боловч санаа нь зовоод, цурамхийж төвдөхгүй байлаа. Адуун сүргийн дунд өссөн Бат цасан шуурга араатан чонын хор хөнөөлийг хичнээн удаа эс амссан гэх билээ. Хэдэн өдөр дараалан ер бусын амгалан байгаа нь харин ч түүний сэтгэлийг морин хуурын хөвчирсэн чавхдас лугаа адил чивчрүүлээд өвсөн толгой бөхөлзөх төдийхөнд ч толгой нь дүнгэнэн дуугарах ажээ. Хашир туршлагатай адуучид “Жаргалтай цагт сэрэмж, зовлонтой үед тэвчээр хэрэгтэй” хэмээх Монголын тал дахь бичигдээгүй хуулийг яс махандаа хүртэл мэдэрдэг юм.

Бат гэрээс гараад умард зүгийн тэнгэрийн хаяа, салхины чиглэл зэргийг ажиглан айхтар цасан шуурга болох гэж буйг гадарлаад минчгэр улаан царай нь хүрэгтэн, хонин бор нүд нь сэртэсхийв. Тэр яаран гэртээ буцаж ороод бөх нойрсож байсан өөр нэг адуучин болох Лхасүрэнг нударан сэрээгээд гар чийдэнгээ авч, буугаа сумлан, нэхий дээлээ өмсөж, зуухны галаа унтраагаад адуу манаж байгаа хоёр нөхөртөө дах авч гарахаа ч мартсангүй. Мань хоёр буугаа үүрэн, уурга тулж мориндоо мордоод хойхонтоо байгаа адуун сүргийн зүг давхин одов.

Баруун уулын цаагуур нар шингэхэд Олонбулгийн тал нэлэнхүйдээ харанхуйлж ирэв. Хоёр морьтон уулын бэл рүү уруудан доошлоход далайн ширүүн давалгаа, цасны нуранги мэт хүчтэй шуурга өөдөөс балбан, яах ийхийн зуургүй тэр хоёрыг бүчин авчээ. Нүүр нүдгүй хүчтэй шуурганд амьсгаа авч нүдээ нээхэд ч хэцүү тул морьд нь үргэн бусгав. Хоёр морь ямар нэгэн муу зүйлийн үнэр авсан бололтой толгой хаялаад шуурга уруудан зугтахаар завдана. Хоёр хүн хэдхэн алдын зайтай явсан боловч сунгасан гарын хуруу харагдамгүй харанхуй тул Бат бачимдсандаа хэдэнтээ чанга дуудаад ч Лхасүрэнгийн хариу дууг олж сонссонгүй. Цасан шуурганы исгэрээ бүхий л дуу чимээг залгин далдлах ажээ. Бат морины амыг татан хөлөрсөн духаа шудраад, арайхийж тайвширсаны эцэст, уургаа тулж, гар чийдэнгээ асаалаа. Ердийн цагт хайгуулчны гэрэл шиг зуун метрийн цаана байгаа адууг олж үздэг гэрэл энэхэн агшинд арван хэдэн метрээс хэтрэхгүй тусна. Лавсан орох цасан дундаас удаж төдөлгүй цавцайн цайрах хүн морины дүрс тодроод Батын өөдөөс ёлтгор гэрлээ тусгалаа. Мань хоёр гар чийдэнгийн гэрлээ ёлтолзуулан үргэсэн морьдоо залсаар арайхийж нэг юм нийлж авав. Тэр Лхасүрэнгийн малгайны чихийг сөхөн чанга дуугаар: “Эндээ хөдлөлгүй зогсож байгаад адуун сүргээ амдан барьж авъя. Тэгээд зүүн тийш тууж, зэгст нуурын намгаас холдуулахгүй бол баларсан хэрэг болно” хэмээн хашгирав.

Лхасүрэн өөдөөс нь “Миний морь үргээд байхыг бодвол ойролцоо чоно байгаа бололтой. Бид дөрөв сүрэг чоныг яаж барах билээ?” гэжээ.

“Амь насаараа дэнчин тавиад ч хамаагүй тэсээд гарах хэрэгтэй” хэмээн Бат хашгирлаа.

Ийн хэлэлцэж гүйцээд мань хоёр гар чийдэнгээ өндөрт өргөн умар зүг хандуулаад нааш цааш хөдөлгөн нөгөө хоёр адуучин болоод адуун сүрэгт дохио өгч эхлэлээ.

Гэнэт нэгэн саарал зүсмийн морь тэр хоёрын гар чийдэнгийн гэрэлд давхин орж ирээд хэдэн алхмын зуур хурдаа сааруулан авралын одыг олж үзсэн мэт Батыг бараадан зогсов. Саарал морь айж цочсон байдалтай амьсгаадан байх зуур хүзүүн дэх шархнаас урсах цус цээжийг



нэлэнхүйд нь будаж, хэдэн ч газар цусан хонгорцог<sup>7</sup> үүсгэжээ. Лхасүрэнгийн унасан хүлэг саарал морины цусыг үзэж үргэн цочоод хүзүүгээ мухуйлган, салхи уруудан давхилаа. Бат ч морийг давиран араас нь давхихад том саарал морь бараа туруугүй алга болоод өгөв.

Бат арайхийн Лхасүрэнгийн цулбуураас барьж авах үед адуун сүрэг тэдний дэргэд төвөргөн ирлээ. Гар чийдэнгийн гэрэлд үзэгдэх морьд бүгд л мөнөөх саарал зүсмийн морь шиг сүнсээ зайлтал айж үргэсэн шинж байдал илт ажээ. Адуун сүрэг уртаар унгалдан янцгаагаад, хэдэн зуун туурайн төвөргөөнд оволзон босох цасан давалгаа шуурганы ааг омгийг мохоох мэт санагдана. Бат тэр хоёр гар чийдэнгийн гэрлээ адуун сүргийн зүг эмээнгүй тусгах үед Лхасүрэн айсандаа хариугүй унах шахсан тул мориныхоо хүзүүнээс тэврэн авлаа. Хэдийвээр оволзох цасан дунд гар чийдэнгийн гэрлийн хүч улам суларсан боловч адуучдын хурц нүд адуун сүргийг даган давхих чононуудыг олж харжээ. Бараг морь болгоны хажууд нэг хоёр чоно бараадан дагаж, хазаж хайрах бөгөөд арьс үсэнд нь цасан сор гялтганан цайрч харагдана. Чонын хоёр бөөр ердийнхөөс хавьгүй зузаан, цайран харагдах нь харсан хүний зүрх цөсийг үхүүлэм ажээ. Чөтгөр мэт зэвхий саарал чонын сүрэг хэзээнээс нааш адуучин эрсийн зүрхийг чичрүүлсээр ирсэн билээ. Ердийн цагт гар чийдэнгийн гэрлийг хараад бажгадан зугатаадаг чонон сүрэг энэ удаа өшөө хорсолдоо шатаж гүйцсэн азарган чоно, өлөгчингөөс дутахгүй улайрч гүйцээд айж эмээсэн шинж огт үгүй байлаа.

Батын сэтгэл сулавхийгээд хүйтэн хөлс нь чийхарч, чонон сахиустай тулгаран, тэнгэрийн гэгсгээлийг амсах гэж буй мэт санагдав. Хэдийвээр Олонбулгийн талд өсөж өндийсөн малчид өөд болохын цагт чонын өглөг болоод, гэр орныхон нь талийгаачийн шарилыг чоно хөндсөн цагт сая тэнгэрт заларчээ хэмээн санаа амардаг нь мянга мянган жилийн тэртээгээс уламжлан ирсэн заншил боловч эрүүл чийрэг хүн бүхэн чононоос аюуж, насны тоо гүйцээгүй цагт чонын хоол больё гэж яахин бодох билээ.

Бат, Лхасүрэн нар нөгөө хоёр адуучнаа олж үзсэнгүй, бодвол мань хоёр цасан шуурганд осгож бээрээд, айж үргэсэн морь нь аваад давхисан нь лавтай. Тэр хоёр өдрийн ээлжинд гарсан болохоор мэдээжийн хэрэг буу, гар чийдэн, дулаан хувцас ч үгүй гарсан юм. “Тэр хоёр учраа олно биз, адуун сүргээ аврах хамгийн чухал хэрэг болоод байна” хэмээн Бат шийдэмгий өгүүлэв.

Адуун сүрэг Батын тусгасан гэрлийг даган хуйлран давхилдана. Цэргийн агтын дал ная гаруй морьд нийт аж ахуйн хэмжээний арван хэдэн суурийн хэдэн арван адуучны хөлс хүчээ урсган байж өсгөсөн, түүхэнд нэр алдраа дуурсгасан, цэвэр цусны түрэг угшлын үзэмчин адуунууд билээ. Тэд бүгд тэгш сайхан бие галбиртай, өлчир чийрэг, тэсвэр хатуужилтайн дээр давхил сайтай босоо хурдан хүлгүүд юм. Ердийн цагт нэр цуутай адуучид болон аж ахуйн дарга нарын унаа болдог. Энэ удаа цэрэг дайны хэрэгцээ шаардлагаар өрхийн цэргийн морьт дивизийн мэдэлд шилжүүлж байгаадаа аж ахуйн захиргаа цаагуураа их л дурамжхан байсан нь мэдээж. Энэ босоо сайхан буянуудыг чонын хоол болгочих буюу эсвэл нуурын намагт үйлгээд алчихвал адуучин эзэд өөрсдийг нь чоно шиг хүү татаад хаячихаас буцахгүй байж таарна. Бат эмнэг хангал шигээ омголон зантай адуучин эрсийг санаад хамаг биеийн халуун цус дээшээ огших шиг боллоо.

Бат Лхасүрэнг эргэлзсэн байдалтай зогсохыг үзээд морио давиран очиж, уурганы бөгсөөр ар дагз руу нь ширвээд, мориороо түүний морийг шахан, адуун сүргийн зүг дөхүүлэв. Тэр гар

чийдэнгээр түүний нүүр рүү хэдэнтээ чичлэн “Чи байтлаа зугтах санаатай юу? Сайхан мэдээрэй” гэхэд цаадахь нь “Би айгагүй ээ, морь маань үргээд болдоггүй” хэмээн цулбуураараа морио хэд гуядаад гар чийдэнгээ асаан уургаа туялзуулсаар адуун сүргийн зүг дөхөж очив. Мань хоёр гар чийдэнгийн гэрэл тусгаж салхинд уруудах гээд байгаа зарим агтыг уургаар ороолгосоор зүүн зүг рүү шахаж эхлэлээ. Батын багцаагаар энэ хавь нуурын эргээс сайндаа л арав орчим километр зайтай байгаа бололтой. Цэргийн адуунд хээлтэй гүү, байдас, унага, даага, хөгшин морь зэрэг холилдоогүй дан өндөр том биетэй агтууд байгаа тул энэ маягийн хурдтай давхиад байвал хагас цаг бололгүй нуурын эргийн лаг шавар руу шахагдан орох нь гарцаагүй юм. Хамгийн хяслантай нь нуур баруунаас зүүн тийш сунаж тогтсон болохоор салхины чиглэл өөрчлөгдөхгүй тохиолдолд түүнийг тойрч гарна гэдэг амаргүй даваа билээ. Нуур тэр аяараа амаа ангайсан аварга шулам салхи чононд туугдсан тарган адуунуудыг залгихаар хүлээж байх шиг Батад санагдана.

Цасан шуурганы чиглэл умраас чанх урагш огт хувирах шинжгүй улам ширүүсэн шуурлаа. Бат харанхуйн дунд морьдын хөлийн явдал, туурайн төвөргөөн, газрын гадаргуугийн өндөр нам, үе нугачаагаар баримжаалан өөрсдийн хаахна яваа, салхины чиглэл зэргийг тодорхойлж авав. Бэлтрэгээ суйлуулсан өлөгчин чононууд азарган чононоос ч илүү догшин ширүүн авирлахыг хараад Батын сэтгэл улам ч илүү бачимдана. Чонон сүрэг өөрийг нь бүслэн авч, унасан хүлгийг нь тасар татан хаях, морины бүдрээнд шидэгдэн өлөн чонын хоол болох магадлалтайг ч бодох сөхөө байсангүй. Тэр энэ бүхнийг умартан уургаа эргэлдүүлэн гуядаж байлаа. Түүнд тарж бутарсан адуун сүргээ хурааж, чанх өмнө хөндөлсөх нуурыг тойрон гараад айл амьтан бараадуулж, хоточ нохдын хүчээр чонон сүргийг хөөн зайлуулъя гэсэн ганц л бодол эргэлдэнэ.

Адуун сүрэг гар чийдэнгийн гэрэл болоод өөрсдийг нь сүүдэр мэт дагалдах хоёр адуучны хашгичаа гуугачаан дор сэхээ самбаа орж нэг дор бөөгнөрч эхлэв. Нэгэн биерхүү цагаан адуу уртаар унгалдаад шинээр бүрэлдсэн сүргийг магнайлан давхиж эхлэв. Адуун сүрэг өөрийн манлай хүлгийг үзэж хийморь сүр нь бадраад хэдэн зуун мянган жилийн турш чонон сүргийг ялан дийлсээр ирсэн уламжлалт жагсаалын дэгийг үүсгэв. Сүргийн манлай аргамаг хөлөг уртаар унгалдан янцгаахад чонон сүргийн дайралтад бутран сарниад байсан олон адуу бөөр бөөрөө нийлүүлэн салхи ч нэвтрэхийн аргагүй нягтарлаа. Хэдэн зуун морин туурайн эрч хүч чангараад, ширүүн өшгичиж, гишгэж, тангарч эхлэлээ. Энэхүү гэнэтийн хувиралд бэлэн бус байсан чонон сүрэг давуу байдлаа алдав. Хашааны шон шиг бат бөх морьдын хөлд хашигдсан хэдэн чоно нааш цааш гарч чадалгүй газар дээрээ морин туурайд гишгэгдэн, нуруу хөлөө хугачуулж, тархиа зад өшиглүүлээд гаслантай улилдах нь цасан шуурганаас ч илүү сэтгэл сэрхийлгэм ажээ. Хоёр гурван ч чоно адуунд өшиглүүлэн үхэхийг үзээд Бат жаахан уужуу амьсгаа авлаа. Тэр энэ газрыг багцаалж байгаа болохоор салхи шуурга намжсаны хойно наашаа ирж үхсэн чоныг өвчих юм шүү гэсэн бодол ч төрж байв. Адуун сүрэг ийнхүү хэдэн чонын бодийг хөтлөсний эцэст эгнээ жагсаалын байрлалыг сэлгэн, эцэнхий туранхайгаа дундаа хийж, эрэмгий чадалтай хүлгүүд гадуур нь хүрээлэв. Төмөр туурайн тэсрэлттэй хүч чонын цөсийг чичрүүлж, залгаа төмөр нудрага мэт арын хамгаалалтын шугамыг үүсгэлээ.

Нуураас холгүй очих үед морьдын шинээр эмхлэгдсэн жагсаалын журамд Бат сэтгэл хангалуун байлаа. Одоо гагцхүү түрүүнд яваа морьдыг зөв залаад өгвөл үлдсэн давчуу хугацаанд адуун сүргийг нуурын зүүн талаар аюулгүй өнгөрөөж болохоор байв. Гэвч эдгээр

улайрсан чононууд ердийн чононоос огт өөр болохыг бодоод Батын сэтгэлд айдас хүйдэс хургасан хэвээр байлаа. Учир нь улайрсан чонотой тэмцэх тусам улам гаараад өшөөгөө авахаар дайрдаг болохоор тал нутагт тэднээс айхгүй хэн байх билээ. Сая шархадсан чонодын улианыг бусад сүргийн гишүүд лавтайяа сонссон болохоор үлдсэн ахар богино зайд юу ч тохиолдож мэдэх юм. Цөөнгүй морьд чононд хазуулсаныг Бат олж үзэв. Эдгээр цэргийн агт сайтар шигшигдсэний дээр урьд өмнө чонон сүрэгтэй хэд хэд тулгарч байсан болохоор шархадсан морьд нь ч гэсэн сүргээсээ хоцрохгүй эгнээгээ чанд барих тул чононд дахин дайрах боломж олгохгүй ажээ.

Гэвч энэхүү сүрэгт бусдыгаа оройлон чонон сүрэгтэй тэмцэх азарга байхгүй, дан агт морьд байгаа нь тэдний хамгийн эмзэг сул тал байлаа. Монголын хээр талд арван хэдэн агт морьд бүхэнд нэг азарга оногдож ижил олон сүргээ хамгаалж байдаг юм. Урт сайхан дэлээ сагсалзуулж, унаган ижил сүргээсээ бүтэн толгой илүү биерхүү эрэмгий хурдан азарганууд л сая бусдыгаа оройлон аюулыг гэтэлгэх чадвартай билээ. Чонотой тулгарахын цагт адуун сүрэг гүү, унага даагыг голдоо хийж, агт морьд нь азарганыхаа хамт хүрээ үүсгэн, чонон сүрэгтэй халз тулалддаг. Тэд дэл сүүлээ сагсалзуулан, хамар амаа тачигнуулаад, урд хоёр хөлийг босгон цоройж, чонын тархи, их биеийг хэмх өшигчинө. Чононууд зугатах үед азарга толгойгоо мухуйлган элдэж, хазаж хайрахын зэрэгцээ, эрч хүчтэй эрэмгий хурдан азарга чоныг нэг л зуун авах юм бол дээш өргөн газар саваад хөлөөрөө дэвсэн алж чадна. Тийм болохоор талын хамгийн хашир догшин чоно ч азарганаас аюун хулждаг. Өдөр шөнийн аль ч цагт азарга ижил олон сүргээ сонор соргоогоор манаж, чонон сүргийн халдлагад өртлөө ч гэсэн сүргээ тойрон хамгаалсаар хохирол багатай аюулгүй газар хүргэж чаддаг ажээ.

Энэ цаг мөчид Бат азаргаа хичнээн их үгүйлэн санасныг өгүүлэх юун. Харин энэ шуурганд уруудаж байгаа сүрэг тэр аяараа агт морьд тул хэдийгээр ид чадал сайтай боловч эрэмгий чанараа алдсан болохоор чонотой тэмцэх хүч дутмаг байлаа. Байнгын арми хэдэн ч жилийн хугацаанд бэлчээр нутгаас агт морьд дайчлаагүй болохоор хүмүүс цэргийн агтанд азарга байхгүйн гэм хорыг бараг мартаж орхисонд Бат дотроо харамсавч багадаахад санагдана. Энэ тухай санасан хүн байлаа ч цэргийн агт бэлчээр нутагт хэдхэн хоноод явах болохоор яах вэ гэж санасан байлгүй. Энэхүү хий зайг чонон сүрэг гайхалтай сайнаар ашиглаж чаджээ. Азрагагүй адуун сүргийг онилж дайрсан азарган чонын гярхай ухааныг Бат гайхаж барахгүй байлаа.

Бат адуун сүргийн өмнүүр очин түрүү морийг зүүн тийш шахан ороолгоод, хагас автомат винтовоо цээжнийхээ өмнө барин цэнэглэсэн боловч буудаж зүрхэлсэнгүй. Энэ сүрэг залуу морьдоос бүрдсэн тул буун дуугаар чоно үргээх гэсэн биш адуун сүргийг бутрааж мэдэх байв. Лхасүрэн ч гэсэн Баттай адил бэлэн байдалд оров. Цасан шуурга улам ширүүсч хоёр адуучны уурга хүнддэж эхлэлээ. Нуур улам бүр ойртсоор ердийн цагт бол эрэг хавийн намгийн шивгэр үнэртэхээр зайд иржээ. Нүд нь улаанаараа эргэлдсэн Бат эцсийн аргаа хэрэглэхээр шийдэж, хамаг хүчээрээ түрүү морийг шавхуурдан ороолгоод, адуугаа усанд оруулах гэж байгаа мэт аль чангаар исгэрэв. Эзнийхээ санааг ойлгосон адуун сүрэг чанх өмнө нь хоёр хоног тутам очиж ус уудаг нуур байгааг мэджээ. Хаврын эхэн сараас хойш хур тунадас ороогүй болохоор нуурын ус татран ширгээд эргэн тойронд нь тэр аяараа лаг шавар, намгаар хүрээлэгдсэн болохоор ганц хоёр мал услах жимийг эс тооцвол тэр аяараар байгалийн занга сааль тул хавраас хойш цөөнгүй адуу мал шигдэж үхсэн билээ. Урьд нь адуун сүрэг адуучны

исгэрэлтээр шигдэхээргүй дагтаршсан замыг даган айж болгоомжилсоор нуурын усанд хүрч устай залгадаг байсан юм. Өдрийн цагаар ямар ч морь ийм хурдтай нуурын тийш зүглэж зүрхлэхгүй байхсан.

Батын исгэрэлт хэргээ үзүүлж нутаг нугын байдлыг андахгүй мэдэх адуун сүрэг өмнөө байгаа асар том аюулыг урьдчилан мэдэж чадав. Сүрэг адуу уртаар унгалдан янцгааж, дороо хэд эргэцсэнээ ширүүн салхинд туугдалгүй зүүн өмнө зүгийг чиглэн давхилдав. Өмнө нь шавартай намаг хөндөлсөж, ардаас нь ширүүн салхи, шийдсэн чонон сүрэг элдэж байгаа болохоор ганц амь гарах боломж зүүн өмнө зүгт л байлаа. Олон морьдын нүд бүлтэлзэн, ганц нь ч янцгаалгүй, хүзүү сунган уухирдан давхихад, сүрэг тэр аяараа үхэлтэй амь өрсөн уралдаж байгаа мэт айдас түгшүүрт дарагдсан байх ажээ.

Адуун сүрэг чиглэлээ өөрчлөх тэр агшинд тулааны байдал огцом өөрчлөгдөв. Морьд зүүн өмнө зүгийг чиглэснээр, туурайн цохилтын хүч сулран, хамгаалах чадвар сулхан хажуу бөөр нь чонын аманд тулж иржээ. Ширүүн салхины эрчинд цохиулан хурд нь саарснаар адуун сүргийн чононоос хамгаалах чадвар ч хавьгүй буурлаа. Салхи уруудсан, сөрсөн аль ч тохиолдолд чонон сүргийн хурд адуун сүргээс хурдан байдаг болохоор одоо тэд жигүүртэй барс мэт омог сүртэй болжээ. Салхи уруудах үед чоно хурдан ч адуу түүнээс нэг их дутахгүй болохоор хажуу бөөрнөөс нь хазах гэж дайрахаас биш, шууд ар бөгснөөс нь халдаж чадахгүй юм. Ухаалаг адуу гэнэт хурдаа нэмэх юм бол чоно хойт туураинд оногдон үхдэггүй юм аа гэхэд хүнд шархдах нь гарцаагүй. Тийм болохоор хажуугаас хазаж дайрах ганц л арга зам байдаг. Хажуугаас нь халдаж дайрлаа ч гэсэн адууны хурдыг гүйцэхгүй сайндаа л хэд самардаад хоцрохоос биш, гэм хор учруулах боломж бараг үгүй. Харин одоо адуун сүрэг чиглэлээ гэнэт өөрчилснөөр чононуудад халдан дайрах ховор сайхан боломжийг олгожээ. Чонон сүрэг салхи уруудан удаан давхилтай морьдыг элдэж байгаа тул ухасхийн дайрахад л салхины хүчтэй хавсран морьдын ууц нуруу, хүзүү сээрэнд хүрч болохуйц боллоо. Чоно хурц сарвуугаар морины биенээс зууран ган соёогоор түүний амин газраас хазчихаад даруй холдох хэрэгтэй байдаг. Тэр тохиолдолд морь хамаг биеэрээ ганц чоныг няц даръя гэх юм бол магадлал өндөртэй боловч сүрэг чонын тухайд амины гарз болоод хоцрох юм. Түүнийг газар унах агшинд сүрэг чоно дайран ирээд тасар татан хаях болно.

Адуун сүргийн захад байгаа морьд чонын халдлагад өртөн, хавирга сүвээгээ хазуулан цус нөжөө урсгалаа. Аллага хядлагын цусан шивэрт сүрэг чоно улам улангасан догширч, урдаа байгаа бэлэн зэхээний хоолыг хэрхэн барахаа бодохгүй, зөвхөн улам олныг алж хядахын түүс болон дайрна. Шархадсан морьд улам олшрохын хэрээр чононууд адуун сүрэг рүү улам улангасан дайрч эхлэв. Азарган чоноор толгойлуулсан хэдэн том боохой нэгэн морины тал талаас асан дайрч, газар унагаад амьдаар нь арьс махыг хүү татан хаялна. Чоно аман дахь махаа газар тургин хаяад ганц хөлбөрөн босож дараачийн морины бие рүү асан дайрав. Азарган чонын араас сүргийн бусад гишүүд ухасхийн дайрч, цус маханд нь шингэсэн алж хядахын дон бүрэн утгаараа илэрч, аюултай догшин атлаа аз жаргалаар бялхаж байгаа нь илт.

Адуун сүрэг шархандаа баригдан, морьдын халуун цус хүйтэн цасыг нэлэнхүйд нь будлаа. Хатуу ширүүн тал түмэн онд үргэлжилсэн хатуу хахир зангаа энэ удаа ч ил гаргав. Чонон сүрэг монголын талын тачир хөрсөн дээр тоо томшгүй олон амьтны амийг хэрцгийгээр таслаж, олон үеийн туршид цусан тамгаа үлдээсээр ирсэн.

Гар чийдэнгийн ёлтгор гэрлийн дор хоёр адуучин жил болгон тал нутагт тохиодог ээлжит хядлагыг харж байв. Гэвч Олонбулгийн талын нэр нүүрийг тахлан армийн хэрэгцээнд явах гэж байсан адуун сүрэг болохоор энэ байдалтай яавч эвлэрч болшгүй билээ. Тэдний цөөнгүй нь чонын амнаас эсэн мэнд мултарч адуучин эзнийхээ хөлс хүчийг урсган хайр энэрлийг хүртсэн эрдэнэс юм. Бат Лхасүрэн хоёрын хувьд энэхүү хэрцгийллийг үзээд уйлах ч багадааар байсан боловч тэсвэр, тэвчээрээ шавхан, үлдсэн адуунуудаа хамгаалж үлдэхээс өөр зам байсангүй. Энэ бол ердийн чонон сүрэг биш, Олонбулгийн талын хамгийн хашир азарган чоноор толгойлуулсан сүрэг болохыг Бат мэдээд сэтгэл нь улам ихээр шимширч байлаа. Өвөл нөөцөлсөн зээрийн махаа булаалгасан эр чоно, бэлтрэгээ суйлуулсан өлөгчин чононууд бүгд улангасан догширсон боловч азарган чоно хамгаас сийрэг хөдлөж байгаа нь илт ажээ. Тэр сүргийн хамт адуунуудыг чанх өмнө тууж явахдаа яах гэж байгаа нь бүхнээс ил тод байлаа. Адуун сүргийг намаг руу шахан оруулах нь азарган чонон дадсан аргын нэг юм. Бат урьд нь чононууд цөөнгүй зээр, үхэр адууг намаг руу шахан оруулаад идсэн байхыг нүдээр харж байсан болохоор айдас нь улам бүр ихсэж байв. Чононууд адуун сүргийг намаг руу шахан барьж байсан тухай тэр урьд нь хөгшчүүлээс сонсож байснаас биш, өнөөдөр харин тэр хувь тавилантай өөрөө учрах юм гэж яахин санах билээ? Энэ чононууд адуун сүргийг хүйс тэмтрэхээс нааш санаа амрахгүй юм гэж үү гээд Бат цааш ургуулан бодож зүрхэлсэнгүй.

Бат гар чийдэнгийн гэрлээр Лхасүрэн рүү дохин, хамтдаа адуун сүргийн баруун талаар тойрон зүүн талд гараад гэрэл гялалзуулан, уургаараа чонон сүргийн зүг хүчтэй ширвэн шилбүүрдэж гарлаа. Чоно нүд гялбуулсан хурц гэрлээс айдаг. Мань хоёр морьтойгоо гар чийдэнгийн бүдэг гэрлийг гялалзуулан нааш цааш давхисаар зүүн талын ихэнх адууг хамгаалж чадав. Адуун сүрэг асар их айдсаа арай ядан үргээж, амьсгаа авахтай болоод нуурын зүүн талаар тойрон гарахаар давхилдав. Тэд нуурыг тойрон гарч амжваас салхи уруудан давхисаар төллөх хонины сууринд хүрвэл олон монгол гэрүүд, танил дотно хүмүүс, нүд гялбам хурц гэрэл, ширүүн дориун дуутай атлаа дотнын андаас өөрцгүй том монгол ноход байгаа болохоор чонон хүү татахаар ухасхийн ирцгээх нь гарцаагүй, хүмүүс ч гэсэн тэдэнд туслахаар ирэх болно гэдгийг сайтар ойлгосон ажээ.

Гэвч чоно гэдэг тал нутгийн боломж завшааныг алдалгүй эрэлхийлэн хүлээдэг дайны сахиус болохоор олдсон жаахан сиймхийг эцсийг нь хүртэл алдахгүй ашигладаг онцлогтой. Тийм болохоор тэд энэ олдсон боломжийг дээд зэргээр ашиглан хамаг хүчээ шавхаад ч хамаагүй ганц морийг алдаж явуулахгүйг хичээж байлаа. Адуун сүрэг энэ үед нуурын зүүн эргийн хужир мараатай газар хүрээд туурайн давхилтаар цасан дорх сул хөрс сийчигдэн, хүн морьдгүй хахаж цацаж эхлэв. Хүн морьдгүй нус нулимсандаа хутгалдан хахаж цацаж байхдаа үхэл амьдралын торгон заагт ирсэнээ сайтар мэдэж байлаа. Эргэн тойрон хав харанхуй, нуурын бараа харагдахгүй боловч нэгэнт дэргэд ирсэн нь илт болов. Хүн морьд хужирын тоосонд хахаж цацан, нүд бүрэлзэхийг юманд үл бодон гагцхүү урагш зүтгэцгээнэ. Одоо зөвхөн морины туураинд боссон хужиртай тоос нүд хорсгохоо байчих юм бол нуурын зүүн эрэг дээрх намхан хэвгий дээр гарч ирлээ гэсэн үг бөгөөд тэр цагт адуун сүрэг нуурын зүүн эргийн дагуу салхины аясаар урагш давхиж болох юм.

Хүн морьд чононуудтай ийнхүү ана мана ач тач уралдсаар чонон сүрэг гэнэт дайралтаа зогсоохыг үзээд Бат бачимдсандаа бууныхаа ишийг тас зуурав. Түүний арван хэдэн жилийн адуутай ноцолдсон туршлагаас үзэхэд чонон сүрэг эцсийн шийдвэрлэх дайралтдаа бэлтгэж

байгаа нь энэ юм. Хэрвээ энэ л удаа дайрахгүй юм бол тэдэнд өөр боломж байхгүй гэсэн үг болохоор тэд өшөө авах энэ сайхан боломжийг юу боллоо гэж алдах билээ дээ. Хужиртай хөрсний тоос чонын нүдийг хорсгоод адуутай хамт зүг чиггүй хэсэг давхидаг ч болоосой. Хэрвээ адуун сүрэг намхан хэвгий дээр гарч амжих юм бол тэр буу дуугарган адуун сүргийг урагш залан чоныг үргээхээс гадна, тусламж эрж болох юм. Бат чичирсэн гараа захирч чонон сүрэг бөөгнөрсөн хэсэг рүү гал нээвэл Лхасүрэн ч гэсэн дагаж буудах болно.

Бат гараа хөдөлгөж завдахаас өмнө адуун сүрэг айсан байдалтай янцгаалдаж, өөрийнх нь морины явдал ч саараад ирэв. Бат хорсож анилдсан нүдээ нухлаад гар чийдэнгийн гэрлийг урагш тусган харваас хэдэн том чоно туурайнд гишгүүлэхээс ч үл айн түүний морины урдуур хөндөлсөн халхалж байв. Бат эргэн харваас Лхасүрэн ч гэсэн хэдэн чононд ээрэгдчихсэн айж үргэсэн морио давирна. Улайрсан чононууд эцэс сүүлдээ хүнтэй морь руу халдахаас буцахгүй болжээ. Бат Лхасүрэн рүү гар чийдэнгээ хэдэнтээ дохин наашаа нийл гэсэн боловч айж үргэсэн морь нь булгиж тангараад ойртох янз алга. Хэдэн том чоно Лхасүрэнгийн унасан морь руу дайрч, хазаж дайрахын зэрэгцээ түүний хөдсөн дээлийн хормойг ч хүү татаж амжжээ. Лхасүрэн айсандаа хэрэг болохоос өнгөрсөн уургаа газар хаячихаад гар чийдэнгээрээ ойртсон чононууд руу цохилж нүдсээр гэрлийг хагалж, их биеийг нь шамшилгаж орхив. Гэвч ээлж дараалан дайрах чонын халдлага зогссонгүй. Нэг том саарал чоно түүний унасан морины хонгон дээрээс хазан авахад хамраа тачигнуулан амгайгаа хазлаад эзнийхээ аясаар аюулыг сөрөхөө болин, хүзүүгээ хэд шилгээгээд баруун өмнө зүг рүү хар эрчээр давхихад Лхасүрэн ч мориныхоо амыг дийлэлгүй давхин одлоо. Хэдэн том чоно тэдний дайралтад саад болж байсан нэг хүн зугатахыг хараад араас нь хэсэг хөөснөө буцаж адуун сүрэг рүү дайрав.

Энэ мөчид адуун сүргийг ганцаараа харгалзан үлдсэн Батын морь руу чононууд сүрэглэн дайрлаа. Батын унасан өндөр хар морь хамраа тачигнуулан, нүдээ бүлтэлзүүлээд биедээ олсон шархыг ч анзаарах сөхөөгүй, байдаг тэнхээгээрээ өшигчиж, тангаран, хазаж хайран тэмцэлдэв. Чонын бүслэлт ч тэр хэрээр улам ширүүсэн олны хүчээр том хар морь руу улайран дайрцгаана. Бат ийм аюултай байдалд орчихоод үзэлцээд алдахаас биш зугатаад гарах боломжгүй болсныг ойлгов. Бат өөрийн амь шигээ хайрладаг уургыг газар хаяад тонгочин эргэцэх морины нуруун дээр өрөөсөн гараараа урд бүүргээс зуурч, нөгөө гараар эмээлдээ уясан төмөр бөгжтэй малиагаа тайлан авч үхрийн суран оосрыг бугуйндаа эгэлдрэгэлэн барив. Тэр саяхан л жирийн адуучин байсан бол яг одоо чонотой үхэх сэхэхээ үзэн тэмцэлдэхээр санаа шулуудсан монгол баатар болон хувирчээ. Тэр хавь ойрдоо хэрэглээгүй өвөг дээдсээс уламжлагдан ирсэн чоно намнах нарийн эрдмийг хэрэглэхээр зэхэв. Түүний барьсан малиа нь морин цэргийн сэлэмнээс дутуугүй урт, хэдэн үе улиран ирсэн эд бөгөөд чоно намнах хурц зэвсэг тул Билиг өвгөн түүнд өвлүүлэн өгсөн юм. Малианы их бие хүрзний иш шиг бүдүүн, хэдэн үе төмөр бөгжний завсар зайгаар хуралдсан хир даг шиг зүйл бол олон үеийн эцэг өвгөдийн алсан чонын хатсан цус байлаа. Хэдэн том чоно морины хоёр хажуугаас ээлжлэн дайрах нь морин дээрээс чоно цохих хамгийн боломжтой зайнд орж ирсэн хэрэг байв. Энэ нь өнөө шөнийн хувьд Батын чоно агнахад хамгийн тохиромжтой үе тохиосон бөгөөд одоо гагцхүү зориг зүрх, гарын онч мэргэн хоёр л мэдэх хэрэг болов.

Бат анхаарлаа хөвчлөн, амьсгаагаа түгжиж, гэрлийг сэмээрхэн баруун тийш эргүүлэн тусгаад,

малиагаа толгой дээрээ өргөн, завшааныг анаж байгаад нэгэн чонын хамгийн эмзэг амин цэг болох соён дээр нь буулгаж орхив. Араа шүдээ ярзайлган дээш цоройн дайрч байсан тэр чоно дөрвөн шүдээ хэмх цохиулан тэсгэлгүй өвдсөндөө тэрий хадан унажээ.

Том саарал чоно цастай газар хэд хөлбөрөөд амаараа дүүрэн урсах цусаа долоож, тэнгэр өөд харан зовиуртай улих нь голдоо ортол өвдөж байгааг илтгэнэ. Эртний монголын хээр талд чонын хувьд хурц шүд гэдэг амь наснаас ч дутуугүй үнэ цэнэтэй эд билээ. Чонын хамгийн хурц зэвсэг нь дээд доод дөрвөн соёо бөгөөд энэ хэд байхгүй бол чонын омог сүр, зүрх зориг, ухаан билиг, уран арга, хэрцгий догшин, атгаг хорон, ховдог шунахай, сонор соргог, тэсвэр тэвчээр, хүч чадал зэрэг зан чанар, онцлог шинжүүд бүгд алга болсонтой адил хэрэг болно. Шүдгүй болсон чоно гэдэг тал нутгийг захирах онцгой эрх дархаа алдан, алж хядах унаган хэв шинж нь үгүй болсноос өөрцгүй тул түүнийг тэнгэр ч ивээхээ больдог. Тийм чоно өөрийн дуртай том адгуусыг барьж, анч ноход болон өөр бусад чононуудтай ана мана үзэлцэн, махыг том томоор зулгаан, цусыг гүд гүд залгилж, хагуу хахир тал нутагт цаг тухай бүрт алдсан энергиэ нөхөж чадахаа байдаг. Чингэснээр түүний тал нутаг дахь хамаг байдаг омог бахархал, чонон сүргийн дундахь байр суурь, хүндлэл талаар боллоо гэсэн үг. Түүнд зөвхөн шүдгүй амаараа амиа хоохойлсон болж, ижил олон сүргийнхээ ан амьтан барьж, найрлан цэнгэхийг бүлгийтэл харан суух л хувь оногдох болно. Түүнд зөвхөн өлсөж, цанган, даарч хөрөн, турж эцсээр үхлээ хүлээх ганц зам л үлдэж байгаа юм.

Бат адуун сүрэг нэг нэгээрээ урж тасдуулах цусан шиврийн дунд энэхүү хорон аргаар чонон сүргийг үлдээлгүй алж талын хүний ааг хүчийг амтлуулж чадахгүйдээ хорсож байлаа. Бусад чононууд хараахан сэхээ орж амжаагүй завшааныг ашиглан малиагаа дахин буулгахад өөр нэгэн том чонын сарьсан хоншоорыг тас цохиж орхив. Тэр чоно цасан дээр түгдийн унаад хөдлөлгүй гулдайн хэвтэнэ. Батын чоно алах эрдэм чадал болон шархадсан чонын улиан бусад чоныг айлган үргээж дахин дайрахаа больсон боловч түүний урагшлах замыг хөндөлссөн хэвээр байлаа.

Бат өөр рүүгээ довтолсон чононуудын довтолгооныг няцаачихаад урдаа байгаа адуун сүрэг рүү хартал бүх том чононууд морьдын зүүн талд цугларан их л бачимдангуй байхыг үзвэл ардаа хоцорсон чононуудын ялагдлыг мэдсэн бололтой. Чонон сүрэг цахилгааны утас салхинд жингэдэг шиг этгээд маягтай улилдах нь амь насанд заналхийлсэн айдас түгшүүрийг илтгэх ажээ. Азарган чонын удирдлагаар боохойн сүрэг талын чонын хамгийн харгис хэрцгий, хамгийн их цус урсгасан, ухаан санаанд багтамгүй, амь өрссөн арга хэрэгсэл болох, улайрсан ширүүн дайралтыг адуун сүргийн зүг чиглүүлэв. Ялангуяа мөнөөх бэлтрэгээ алдсан өлөгчин чононууд өөрийгөө ч гаргуунд гаргахыг юман чинээ саналгүй хавьтсан ойртсон адууны хавирга сүвэргэнээс хүү татан зулгаана. Энэ нь чоно морьдын аль алины хувьд амь өрссөн хэцүү тулгаралт байлаа. Чонын хувьд морины хажуу хавирганаас зүүгдэнэ гэдэг дээсэн дөрөөн дээр дэнжигнэхээс өөрцгүй юм. Учир нь үргэсэн адууны хойт хөлд оногдон гишгэгдэх аваас яс махаа няцлуулж, гэдэс гүзээгээ ч хүү татуулж мэдэх гэмтэй. Харин хурц араа шүдтэй чононуудын хувьд адууны гэдсийг хүү татчихаад холдон зайлах нь аминд өлзийтэй. Энэ нь адууны хувьд бүр ч аминд халтай. Учир нь айсан морь чоныг өшиглөөд онохгүй бол шархандаа түүртэж ижлээсээ гээгдэн чонон сүрэгт бариулна. Чоныг онож өшиглөлөө ч гэсэн чонын хүнд бие, хурц шүдэнд гэдэс нь хүү татагдаж, гарцаагүй үхэлд хүргэнэ гэсэн үг.

Адуу чонон сүрэг ийнхүү амь дүйн тэмцэлдсээр байлаа.

Адуунд гишгэгдэгсдийн олонх нь өлөгчин чоно байх ажээ. Тэд эрэгчин чононоос биеэр хөнгөн тул бүх биеэрээ зүүгдэн асаж байж л адууны гэдсийг хүү татах боломжтой юм. Өлөгчин чононууд өшөө хорсолдоо шатан, үхэхийг юман чинээ бодолгүй, энэлж шархалсан эхийн сэтгэл эр зоригоор тэтгэгдэн дайрах ажээ. Тэд адуунд өшиглүүлж, гэдэс дотроо няцлуулж, хөх дэлэнгээ гишгүүлсэн ч хамаагүй, зууралдсан адуутай хамт зүйл дуусахаар сэтгэл шулуудна.

Адуунд гэдсээ зад тийрүүлэн газар унасан нэгэн өлөн хөх чоно, араа шүдээ ярзайлган цастай газар хэд ульсанаа урд хоёр хөлөөрөө маажлан ойролцоо уначихаад хараахан үхээгүй байгаа адууны зүг дөхөн очиж, амьдаар нь залгихаас ч буцахгүй улайрах нь энэхүү эцсийн боломжийг алдахгүй гэсэн хэрэг байв. Түүний ам шүд бүрэн байгаа цагт хоолны саваа хага өшиглүүлэх хамаагүй ховдоглон дайрч байгаа нь тэр байлаа. Адууны шинэхэн мах чонын амаар орон хагархай гэдсээр дамжин цастай газар шууд унаж эхлэв. Ходоодны хэр хэмжээ нь алдагдсан чоно энэ хорвоогийн хамгийн өлөн ховдог, хамгийн их адууны махыг залгиж чадах тэнхээтэй байдаг ажээ. Тэр чонын хувьд энэ шөнө хамгийн хав бахтай атлаа хамгийн зовиуртай хоололт болсон байж таарна.

Хаврын нялх ногоо болон намрын хатсан өвсийг цадтал идэж цүрийтэл ус уусан морьдын гэдэс чононд хүү татуулахаар ходоод гэдэс нь юутай хээтэйгээ сархийтэл цастай газар унана. Гэвч түүний босоо төрөөд хурдлан давхих заяатай хойд хоёр хөл нь ходоодоо хага гишгэж, бүдүүн нарийн гэдэстэйгээ орооцолдоод тасар татаж хаях ажээ. Ийнхүү хэвлийн хөндий дэх хамаг эрхтнээ талаар нэг тараан хаясаар улмаар өрцөн дэх уушиг зүрхээ хүртэл уудлан шидлэж няц гишгээд үхэх нь дамжиггүй. Амь насаа гаргуунд нь гарган дайрах чоно гэдэг амьтан атаатан дайснаа ийнхүү хорлонтой алдаг ажээ. Чоно ийм л маягаар адуунд өөрийнхөө амь насыг егүүтгэх ямар байдгийг үзүүлж байв. Морь нэг талаар чононд алуулж байгаа хэрэг, нөгөө талаар өөрийнхөө амийг егүүтгэж байгаа хэрэг билээ. Тийм болохоор түүний үхэл зовиуртай, гомдолтой, эмгэнэлтэй ажгуу.

Чонон сүргийн энэхүү эцсийн улайрсан дайралт адуу морьдын зохион байгуулалтай эсэргүүцлийг бүрмөсөн эвдэж орхилоо. Тал нутаг асар том алааны талбар болон хувираад гэдсээ цувуулан давхилдах морьд адаг сүүлдээ цастай газар хөлбөрөн унаж, халуун хий цусаар дүүрэн байсан өрц хэвлий нь хэдхэн хормын зуур мөс цасанд хучигдана. Газар тонгорцоглон унасан морьд тийчигнэхийн хэрээр хавь ойрын цасыг халуун цусаараа будаж байв. Цусанд будагдсан хэдэн түмэн цасан ширхэг айж үргэх адуун сүрэг рүү сүрчээд, тэднийг сүүлчийн замд нь үднэ.

Бат чонон сүргийн энэхүү өшөө авсан дайралтанд айн балмагдаж гүйцээд, хүйтэн хөлс нь хөлдүү мөс болон хувирч байв. Тэр одоо адуун сүргийг аврах хөг өнгөрснийг ойлгожээ. Гэвч тэр толгойд давхих хэдэн морьдыг хамгаалан үлдэх санаатай морио хүчтэй давиран, жолоогоо дугтарваас унасан хөлөг нь урдаа байгаа чонын дээгүүр ухасхийн харайгаад түрүү морины зүг давхив. Ялагдсан цэрэг уул нурахтай адил гэгчээр адуун сүрэг тарж бутраад, салхи уруудан зугатаж байлаа. Зүрх нь амаараа гартал айсан морьд урдаа аюулт намаг байгааг ч хайхрах сөхөөгүй хар хурдаараа давхисаар байх ажээ.



Нуурын ойролцоох налуу хэвгий, улам ширүүсэх цасан шуурга, морьдын давхилтад улам эрч нэмээд, адуун сүрэг уулнаас өнхрөх хад чулуу мэт хар хурдаар намаг балчиг руу туучин оров. Агшин зуурын төдийд нимгэн зайрмаг хагачин, шавар балчиг үсчээд, адуун сүрэг тэр аяараа намагт шигдэн, цөхрөнгүй янцгаалдаж, тэлчлэн тийчигнэцгээж эхлэв. Чононоос үргэж айсан, өширхөж хорсох нь туйлдаа хүрсэн тул адуун сүрэг намаг балчигт шигдээд үл ялиг эргэлзсэнээ хамаг хүчээ шавхан, зунгааралдсан шаварт улам гүн шигдэхийг ч юманд эс бодон урагш зүтгэцгээж эхлэв. Тэд бүгдээрээ намагт шигдэж үхсэн ч хамаагүй гагцхүү чонын хоол болж өстнийхөө бах тавыг хангахгүй юм шүү гэж эрс шийдсэн янзтай. Адуучин эзэндээ агтлуулж эрэмгий шинжээ алдсан энэхүү адуун сүрэг амь насны сүүлчийн мөчид хамтдаа зүйл дуусан чонын улайрсан дайралтыг эсэргүүцэж байгаа нь энэ ажээ. Эд уг нь эртний монгол талын эрс хатуу амь юмсан.

Гэвч хахир хатуу тал нутаг угаас сул доройг таашаадаггүй болохоор энэ удаа ч тэднийг хөөрхийлөн үзэхгүй байлаа. Шөнө агаарын хэм буурахыг дагалдаад намгийн зах хөвөө зайрмагтан хөлдсөн боловч бүхэлдээ мөстөөгүй болохоор шавар балчиг урьд өмнөхөөс ч илүү зуурангитсан байжээ. Цасан шуургатай холилдоод улам зууранги болсон лаг шавар морьдын хөлийг бумбадан хөхөж, явахад тун бэрх болж ирэв. Сүрэг адуу намаг дундуур малтаж маажин зүтгэсээр л. Ганц алхах зуур хөлийн мөрөөр хүйтэн цас чигжиж, адуун сүрэг тэр аяараа намаг балчгийг цас мөстэй холин зуурч байгаагаас өөрцгүй ажээ. Адуун сүрэг эцэстээ хүч тамираа баран хөдлөж ч чадахаа байлаа. Хамгийн түрүүчийн морь бүр хүзүүгээ хүртэл шигдээд зөвхөн толгой нь цухуйн харагдана. Энэ мөчид адуун сүрэг цаазын тавцанд үхэх ялаа хүлээн зогсох ялтан мэт хүйтэн мөс хөр цастай барьцалдсан лаг шаварт хөдлөхгүй хүлэгджээ. Арга мухардсан байдалд орсон адуун сүрэг горь тасарсан байдалтай янцгаалдаж, хүйтэн лаг шаврын дээгүүр амьсгалын уур дэгдээд, морины арьс үсэн дээр цавцайсан цагаан хяруу болон буулаа. Одоо тэднийг хэн ч аварч чадахгүй, чонон сүргийн хядлагыг хэн ч зогсоож чадахаа өнгөрсөн болохыг адуун сүрэг сайтар ойлгожээ.

Бат унасан хүлгээ болгоомжтойгоор намгийн зүг залах гэсэн боловч өндөр хар морь зайрмагтсан мөс рүү гишгэж үзсэнээ хамраа тачигнуулан, толгойгоо бухаад хойш ухран хавьтах юм биш. Бат гар чийдэнгийн гэрлийг намгийн зүг тусган харваас цасан шуурганы ялимгүй намдах сиймхийгээр адуун сүргийн байр байдлыг бүрэг бараг харж болохуйц ажээ. Хэдэн морьд тамирдангуй толгой сэжих нь адуучин эзнээсээ эцсийн удаа аврал эрэх мэт. Бат савхин гутлын өсгийгөөр морины гэдэс рүү хүчтэй давиран өндөр харыг урагш алхуулав. Гэвч өндөр хар морь болгоомжтой тав зургаа алхсанаа урд хөл нь лаг шаварт гүн шигдэхэд цочин арагш ухасхийгээд намгийн эрэг хүрээд сая зогсов. Бат түүнийг малиагаараа яаж ч ороолгож гуядаад урагш ганц алхам гишгэх янзгүй. Бат мориноосоо бууж адуун сүргийнхээ дэргэд очин буугаараа чононоос хамгаалъя гэж бодсон боловч унасан мориноос холдчихвол өндрөөс малиагаар цохих, өндөр харын туурай зэрэг давуу байдлаа алдаж, хүн морь хоёулаа чонын хоол болох нь тодорхой. Тэгээд ч тэр аравхан сумтай болохоор нэг хоёр чоно аллаа ч гэсэн сүрэг чоныг яаж устгаж дийлэх билээ. Тэр сүрэг чоныг хөөж явууллаа ч шөнөжин орох цас адуун сүргийг лаг шаврын дунд барьцалдуулан хөлдөөх нь лав. Тэгвэл тэр багийн төв рүү очиж туслах хүч дуудан ирүүлж болохгүй юу? Энэ айхтар цасан шуурганаар хүн болгон хонь малаа харж хандах гээд түүнтэй наашаа ирж адууг шавраас татан гаргах хүч бүл хаанаас байх билээ. Батын нулимс цувран дорно зүг харж дээд тэнгэрээс аврал эрэн “Тэнгэр минь, мөнх хөх тэнгэр минь аврал энэрлээ хайрлан адуун сүргийг минь авран гаргахад туслаач” гэлээ.

Гэвч тэнгэрийн ааш аяг улам ширүүсэн, шуурганы эрчийг нэмсээр Батын дуу хоолойг дарах ажээ.

Бат хурганы арьсан нудрагаар хөлдсөн нулимсыг шудраад, малиагаа бугуйндаа эгэлдрэгэлэн, бууныхаа оосрыг султган тайлж, гар чийдэнгээ барьсан чигээрээ чонон сүргийн дайран ирэхийг хүлээж байв. Энэ мөчид түүний толгойд ахиу хэдэн чоно алах ганц бодол эргэлдэх ажээ.

Нэлээд удсаны эцэст Бат даарсандаа мориныхоо нуруун дээр хавчганаж эхлэв. Гэнэт чонон сүрэг сүг мэт сүүтэгнэн түүний араар тойрсоор, намгийн зүүн хөвөөнөө өчиж зогсоод бүдэг цасан мананд далд орлоо. Тэгсэнээ удалгүй нэгэн гуринхатсан чоно ганцаараа адуун сүргийн дэргэд очин мөсний нимгэн зузааныг тандана. Бат тэр чоныг бие давжаа гээд буудсангүй. Чоно арван хэдэн алхам явсанаа гэнэт хурдаа нэмэн адуун сүргийн зүг хурдлав. Түүнийг адуун сүргийн дэргэд харахан очоогүй байхад гэнэт нуурын эргээс хэсэг хуйларсан цас босож, морьдын зүг довтолгоод нуурын мандлыг тэр аяар бүрхэн тэнгэр газрыг тэр энэ гэж ялгахын аргагүй болов. Энэ бүхэн урт цагаан үстэй зэрлэг хүмүүс, түүдгийн дэргэд амьд хүн амьтныг хүлж орхиод дуулж бүжиглэж байх шиг санагдана.

Бат цасан шуурганд нүдээ ч нээж чадахгүй, давжигнан чичирсээр байлаа. Гоц сонор өндөр хар морь ч гэсэн цасан шуурганд дагжин чичирч, толгойгоо сэжин хамраа тачигнуулна. Харанхуй шөнө цасан шуургатай хамсан цусан горхи үүсгэх тал нутаг дахь их хядлагыг далдлах ажээ.

Хариугүй осгож бээрэх шахсан Бат гэрлээ унтраан өөрийгөө далдлаад, доош тонгойн бууныхаа амыг намаг руу чиглүүлж байснаа гэнэт дээш өргөн гохоо зугуухан дарлаа. Нэг сум, хоёр сум, гуравдахь сум...

## Зургаа

*Түрэгчүүдийн зэр зэвсэг нь нум, годоль, хуяг, жад, илд, сэлэм болой. Тэдний засал чимэг овойж товойлгон урласан байх нь олонтой.. Тугийнх нь дээр алтан чонын толгой зурсан амуй. Хамгаалагч эрс юүгээн Фүлид хэмээх нь хятадаар чоно гэсэн утгатай юм. Уг нь чоноос төрсөн болохоор үүрд түүнийг эс мартагын тулд ийн нэрийджээ.*

*“Жоу улсын бичиг Түрэг”*

Бүүдгэр наран сиймгэр үүлсийг нэвглэн гийгүүлэхэд Олонбулгийн уудам талд цас хялмаалсан хэвээр байлаа. Цасан шуурга хоёр өдөр шөнийн турш тасралтгүй нүдсээр ааг омог нь дарагдахад агаарт будрах цасан үзэгдэхгүй үүлсийн доогуур хэдэн тас шувуу алгуурхан эргэлдэнэ. Хавар эртийн урин амьсгал цаст талын дээгүүр зэрэглээтэн сүүүмэлзэнэ. Сүрэг ятуу бургасан шугуйгаас дэрхийн нисэхэд мөчир дээрээс цан хүүрэг будран унаж, холтосны унаган өнгө тодрох нь цагаан дэвсгэр дээрх хүрэн улаан шүр мэт нүд булаана. Умард хилийн уул нурууд цэлмэг тэнгэртэй залгалдаад, хэд гурван үүлсийн сүүдэр нүд алдам цасан талын дээгүүр алгуурхан нүүдэллэх ажээ. Удаж төдөлгүй тэнгэр цэлмээд Олонбулгийн буурал талд урьдын нам гүм байдал сэргэлээ.

Лхасүрэн, Чэнь Жэнь хоёр Батын шархыг сувилан бүтэн өдөр хань бараа болж хонов. Гэвч нүдний өмнө тодрох үзэсгэлэнт талд Батын ярьсан аймшигт зүйлс болоод өнгөрсөн гэхэд итгэж боломгүй. Хэдийгээр хөдөө талд хүн болгон л аймшигт цасан шуургатай хоёр өдрийн турш тэмцэлдсэн боловч Багтай тохиосон үйл явдал Чэнь Жэньгийн сэтгэлд яагаад ч бууж өгөхгүй байв.

Чэнь Жэнь тал нутгийн хавар эртийн сэнгэнэсэн хүйтэн агаарыг цээж дүүрэн амьсгалсаны дараа дотор жаахан онгойх шиг болов. Өдөржин улаан шороогоор шуурч нүд хорсгодог хаврын хар хавсарга энэ удаагийн цасан шуурганаар ор мөргүй арилжээ. Цас хайлахаар гол нуурын ус эргээ халин мэлтэлзэж, цэцэг ногоо дэлгэрээд бог мал хаврын ногоонд цадах цаг хаяанд ирэх нь тэр. Малын гурван янзын таргаас хаврынх онцгой чухал. Хавар олигтой тэнхрээгүй мал зуны усан тарга, намрын тосон тарга тэвээргийг бүрэн авч чаддаггүй юм гэж Билиг өвгөн байнга ярьдаг. Намар өвс шаргалтахаас өмнө хонины сүүл гурван хуруу өөхлөөгүй бол урт өвлийг давж чаддаггүй болохоор хөдөөний малчид онд орохооргүй хонь ямаагаа нядлаад дотор газар руу хямд үнээр борлуулдаг билээ. Зуд турхантай зарим жилийн өвлийн эхэн сар гэхэд л мал сүргийн тал илүү хувь хорогдох нь ч бий. Өөрөөр хэлбэл хөдөө нутагт жилийн ажлын үр дүн хавраас голлон шалтгаалдаг. Тийм болохоор энэ айхтар цасан шуурга хаврын хахир хатууг зөөллөж ашиг тусаа өгөөсэй билээ дээ.

Чэнь Жэнь өөр хэдэн илгээлтийн эзэд болон аж ахуй, баг, хэсгээс томилогдсон төлөөлөгчидтэй хамт зудын гамшгийн хохирлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдхүүнд багтан нуурын эрэгт хүрэлцэн иржээ. Хувьсгалт хороон дарга бөгөөд цэргийн төлөөлөгч Бао Шүнь Гүй, аж ахуйн дарга Өлзий, адуучин Бат, Лхасүрэн, олон нийтийн төлөөлөгчид болон ослын газрыг цэвэрлэхээр ирсэн хүдэр бадриун малчин залуус бүгдээрээ замын турш баргар царайлан явсанаа нуурын эрэг дөхөөд ирэхэд бүгдээрээ дуу шуугаа хураан таг чиг болцгоов. Цэргийн агт зорьсон газраа хүрэлгүй бүгд амь тавьсанд цэргийн болон орон нутгийн удирдлага онцгой бухимдуу байгаа болохоор Чэнь Жэньгийн сэтгэл ч их хүнд байлаа. Батын

өндөр бор морь бараг эрэмдэг болохын даваанд тулсан тул аж ахуйн төвийн мал эмнэлгийн цэг рүү эмчлүүлэхээр явуулаад өөр морь сольж унажээ. Батын тос түрхсэн нүүрний цаанаас харахын эцэсгүй айхтар хөлдсөний ул мөр бэлээхэн харагдана. Хамар нүүрний арьс нэлэнхүйдээ харлаж хүрэнтээд, завсар зайгаар нь шүүс гоожжээ. Хуурсан хальсны цаанаас нимгэн хөрстэй ягаан арьс цухуйх нь харахад нүд халтирмаар. Тэр бүснийхээ ард нэгэн модон хүрз хавчуулчихаад Бао Шүнь Гүйгийн хажууд алжаангуй шинжтэй морио давиран бусдадаа замчилж байлаа.

Шуурга арилсаны маргааш өдөр Лхасүрэн түүнийг нуурын өмнөх нэгэн хунхуйгаас хүн морьгүй хөлдөж үхдэгийн даваан дээр олсон юм. Лхасүрэн түүнийг шархтай морин дээр тэгнэн гэрт нь аваачжээ. Бат ажлын хэсгийнхэнд хэргийн байдлыг үзүүлэхийн тулд өвчнөө тэсвэрлэн замчлан ирж байгаа нь энэ юм. Нөгөө хоёр адуучин хэдийгээр хамаг бие нь осголттой олдсон боловч одоо тусгаарлан байцааж байгаа ажээ.

Чэнь Жэнь Билиг өвгөний дэргэд морьгнуудаас нэлээд хоцорсхийгээд “Аав аа, дарга нар Бат тэд нарыг хэрхэн шийтгэх бол?” хэмээн асуув.

Өвгөн нудрагаараа ямаан сахал дээрх уур цанг шудрахад хонин бор нүдэнд нь өрөвдөнгүй шинж байдал тодорлоо. Өвгөн алсын уулсыг ширтээд аажуухан “Илгээлтийн эзэд та нар тэднийг шийтгүүлмээр байна гэж үү? Аж ахуйн захиргаа, цэргийн төлөөлөгч нар илгээлтийн эзэд та бүхний саналыг сонсох гэж наашаа дагуулж ирсэн байж таарна” гэлээ.

“Бат сайн хүн болохоор цэргийн агтыг аврахын тулд амь насаа хүртэл гаргуунд гаргах шахжээ. Харамсалтай нь ийм айхтар хэрэг боллоо доо. Тэр цэргийн агтыг аварч чадсан эсэх хамаагүй, тал нутгийн баатар эр гэдгээ харуулж чадсан. Би танайд нэг жил гаруй амьдарсан болохоор тэр миний ах шиг байдаг гэдгийг мэдэхгүй хүн байхгүй. Тийм болохоор Бао Шүнь Гүй миний саналыг авч хэрэгсэхгүй байх. Тэгээд ч илгээлтийн эзэд өөр өөр санаа бодолтой байгаа. Та харин ядуу малчин гаралтай, хувьсгалт хорооны гишүүн хүн тул таны санал жин дарж таарна. Тийм болохоор би таны байр суурин дээр хатуу зогсоно оо” хэмээн Чэнь Жэнь хэллээ.

“Бусад илгээлтийн эзэд юу ярьж байна вэ?” хэмээн өвгөн ихэд санаа зовнисон байдалтай асуув.

“Манай багийн илгээлтийн эзэд бүгд шахуу Бат тэд нарын талд байгаа. Энэ айхтар цасан шуурга, сүрэг чонын өмнө хэн ч байсан тэсч гарахад бэрхтэй. Тийм болохоор түүнийг шийтгэж болохгүй гэж байна лээ. Ганц нэг хүн байгалийн саад бэрхшээлийг ашиглан армийн эсрэг, хувьсгалын эсэргүү хорлон бусниулах ажиллагаа үйлдсэн байж мэдэх тул энэ дөрвөн адуучны нийгмийн гарлыг нягтлан шалгаж үзэхэд гэмгүй гэж байдаг шүү” гэлээ.

Билиг өвгөний царай улам барайгаад дуу шуугүй шогшуулав.

\* \* \*

Морьгнууд нуурын зүүн талаар тойрон Батын хамгийн сүүлд буу тавьсан газар хүрэлцэн ирлээ. Чэнь Жэнь урт амьсгаа татан цуст яргаллын талбайг харах сэтгэл зүйн бэлтгэлээ

хангав.

Тохой зузаан цас шөнийн аллагын ул мөрийг дарж амжсан болохоор дусал ч цус үзэгдсэнгүй. Ядаж намагт шигдсэн морьдын толгой харагдмаар юм гэж бодоход бас байдаггүй шүү. Нуурын мандал болон намгийн дээгүүр тогтсон зузаан цас морьдын сэгийг хүний нүдэнд харагдахааргүй далдалж чаджээ. Хүмүүс мориноос буулгүй дуугаа хураачихаад энэ цасан хөнжил дор юу болоод өнгөрснийг зөвхөн сэтгэлдээ төсөөлж байлаа.

“Тун харамсалтай юм болжээ” гэж Билиг өвгөн нам гүмийг эвдэн малиагаар нуурын зүүн эргийг заагаад “Хэрвээ жаахан л явсан бол аюулыг гэтлэж болох байж шүү. Та нар хар даа. Бат хойт талын бэлчээрээс адуун сүргийг энэ хүртэл туун ирнэ гэдэг тун амаргүй хэрэг байжээ. Нүдгүй цасан шуурган дунд тэр олон чоно дайраад байхад хүн айдаггүй юм гэхэд унасан морь айж үргэнэ биз дээ? Бат эхнээсээ эцсийг хүртэл адуун сүрэгтэйгээ хамт байж өөрийн үүрэг хариуцлагад үнэнч байж чаджээ” гэлээ.

Монгол өвгөн ийнхүү нэр нүүрээ ч бодолгүй өөрийн хүүг өмгөөлөв.

\* \* \*

Чэнь Жэнь ч гэсэн Бао Шүнь Гүй руу дөхөж очоод “Бат нийгмийн өмчийг хамгаалахын тулд ганцаараа чонон сүрэгтэй тулалдан амь насаа алдах шахдаг нь сонин хэвлэл дээр бичүүштэй баатарлаг хэрэг мөнөөс мөн” гэлээ.

Бао Шүнь Гүй нүдээ бүлтийлгэн “Юуны чинь баатарлаг хэрэг гэж вэ? Тэр хэрвээ цэргийн агтыг эсэн мэнд хамгаалаад үлдсэн бол жинхэнэ баатарлаг үйл болох байсан юм” гээд Бат руу хандан их л ууртайгаар “Чи тэр өдөр яах гэж адуун сүргийг нуурын ар талд байлгаж байсан хэрэг вэ? Өдий олон жил адуу маллачихаад салхи шуурга босвол уруудаад нуур руу орно гэдгийг тооцоолж болсонгүй юу? Чиний хамгийн том хариуцлага чинь энд л байгаа юм” гэлээ.

Бат түүний өөдөөс харж чадалгүй “Тийм ээ, би хариуцлага алдлаа. Хэрвээ орой болгон адуугаа нуурын зүүн эрэгт туун ирж байсан бол ийм хэрэг болохгүй байсан юм” гэв.

Лхасүрэн морио давиран их л дурамжхан байдалтай “Аж ахуйн захиргаанаас биднийг адуун сүргээ тэндхийн нөөц бэлчээрт аваач. Хаврын ногоо ч эрт цухуйдаг. Цэргийн агт хол зам туулах болохоор сайн тарга тэвээрэг авахуулаад өрхийн цэргийн морьт отрядынхны нүдийг хужирлах хэрэгтэй энэ тэр гэсээр тийш явуулсан шүү дээ. Аж ахуйгаас зохион байгуулсан хувьсгалыг эрчимжүүлж, үйлдвэрлэлийг түргэсгэх хурал дээр Бат хэлсэн үгэндээ адууг тэнд бэлчээх нь осолтой хэрэг гэж хэлж байсныг би сайн санаж байна. Гэтэл аж ахуйн дарга нар хавартаа ихэвчлэн баруун хойноос салхилдаг, яг энэ хэдэн өдөр чанх хойноос салхилахгүй байлгүй гэхийг та ч өөрөө зөвшөөрч байсан биш үү? Гэтэл гарсан ослыг ганцхан Бат хариуцах гэдгийн учир юусан билээ?” гэв.

Аж ахуйн хэдэн дарга нар бүгд дуугаа хурааж орхив. Өлзий дарга хоолой засаад “Лхасүрэнгийн хэлж байгаа нь оргүй үг ч биш шүү. Бид бүгдээрээ л цэргийн агтыг олигтой тарга тэвээрэг авахуулж, зорьсон газарт нь амар сайн хүргээд дайны бэлтгэлд өөрсдийн хувь

нэмрээ оруулах гэсэн хэрэг шүү дээ. Хэрвээ тэр сүрэг чоно дайраагүй бол Бат маань адуугаа эсэн мэнд зорьсон газарт нь хүргэх байсан. Салхи шуурга, чонон сүрэгтэй хавсарна гэдэг зуун жилд ч тэр болгон тохиохгүй айхтар осол юм. Би үйлдвэрлэлийн ажлыг хариуцдаг болохоор энэ удаагийн ослын хариуцлагыг хүлээх учиртай” гэв.

Бао Шүнь Гүй малиагаар Лхасүрэнгийн хамрыг шөргөөж “Чи ч гэсэн багагүй хариуцлага хүлээх байх шүү. Билиг гуайн хэлдгээр адуун сүрэг жаахан зай л туулчихсан бол аюулыг гэтлэн давах байсан юм. Та гурав аюулын өмнө айж зугаталгүй Баттай хамт адуугаа туусан бол энэ ослоос сэргийлж болох байжээ. Хэрвээ чи дараа нь Батыг олж амийг нь авраагүй бол чамайг ч гэсэн хорьж байцаах байсан юм” гэв.

Билиг өвгөн өөрийн ташуураар Бао Шүнь Гүйгийн малиаг доош дарж буулгаад “Бао төлөөлөгч өө, та хэдийгээр тариачин гаралтай монгол үндэстэн ч гэсэн монгол малчны дэг ёсыг сахивал дээрсэн дээ. Манай хөдөө нутагт хүний хамрыг малиагаар шөргөөж юм ярьдаг хүн байхгүй. Харин дээр үед бол ван гүн, тайж ноёд тийм зан гаргадаг байсан. Та итгэхгүй бол цэргийн салбар тойргийн даргаас асуугаарай. Дараачийн удаа ажил шалгахаар ирэхэд нь цугтаа очиж асуусан ч болно” гэлээ.

Бао Шүнь Гүй малиагаа буулгасан боловч зүүн гарын долоовор хуруугаар Лхасүрэн, Бат нарын хамар руу чичлэн “Чи, бас чи хурдан бууж цас цэвэрлэхгүй юу? Би морьдын сэгийг харж, чононуудын хэрхэн айхтар авирласныг үзмээр байна. Хамаг хариуцлагыг ганц чоно руу түлхээд өнгөрнө гэж бодоо юу? Хүний хүчин зүйл хамгаас чухал гэж Мао даргын хэлсэн үг байдаг юм шүү” хэмээн зандрав.

Хүмүүс бүгдээрээ мориноос бууцгаан мод төмөр хүрзээр цас цэвэрлэн морины сэгийг гаргаж ирцгээлээ. Бао Шүнь Гүй мориноосоо буулгүй “Цахлай” маркийн зургийн аппаратаараа зураг авч баримтжуулангаа “Сайн цэвэрлээрэй. Хэд хоногоос аймаг хошуу болон армийн ажлын хэсэг ирж шалгана гэсэн шүү” хэмээн зандчина.

Чэнь Жэнь хөр цасыг гишгэлэн Өлзий, Билиг, Бат Лхасүрэн нартай цуг нуурын дунд хэсгийн хэдэн цасан довцгийг чиглэн алхав. Намгийн дээгүүр тэс хөлдөөд хүмүүсийн хөлд цас шаржигнан дуугарна. “Хамгийн голд байгаа хэдэн морьд чононд бариулсан гэдгийг батлах юм бол чонон сүргийн хэр зэрэг айхтар байсныг мэдэж болно” хэмээн өвгөн хэлэв.

“Чи буудаад ч нэмэргүй байсан юм уу?” гэж Билиг өвгөн Батаас асуулаа.

“Нэмэргүй ээ, би аравхан сумтай гарсан болохоор удаж төдөлгүй дуусчихсан. Ядаж шуургатай тул сум айхтар чанга дуугарахгүй. Чоно эхлээд зугатаасан боловч буудаж дууссаны дараа эргээд ирнэ билээ. Их харанхуйд гар чийдэнгийн зай дуусаад би сүүлдээ юм харахаа байсан” гэж Бат дуу шуу муутайхан өгүүлэв.

Тэр гараараа хөлдсөн нүүрийн хатсан хальсыг дарсанаа “Тэр үед олон юм бодох сөхөө байгаагүй. Тас харанхуй нүдгүй шуурган дунд адуу буудчих вий гэж л айж байлаа. Салхи намжаад намаг хөлдөөгүй бол чоно гатлаж чадахгүй цөөхөн хэдэн морь ч гэсэн амьд гараасай гэж найдлага тавьж байв. Тийм болохоор би арай дээгүүр буудсанаа санаж байна” гэжээ.

Билиг өвгөн Өлзий дарга нар гүн сүүрс алдацгаав.

Хамгийн дотор талд байх нэг том цасан довцгийн дэргэд ирээд Бат хэсэг зуур эргэлзсэнээ модон хүрзээрээ морины толгойн хэсгийн цасыг малтан зайлуулав. Тэнд байгсдын дотор зарсхийгээд явчихлаа. Нэгэн цагаан морины хүзүүг тас хазаад хэсэг махыг нуруу руу салбайтал унжуулжээ. Цагаан морины нүд байдгаараа бүлтийн хөлдсөн нь тухайн үеийн айдсыг тэр чигээр хадгалан үлджээ. Морины толгой дор цус нь ховхлон зайлуулахын аргагүй нэлийн хөлдсөн байлаа. Бүгдээрээ сэхээ самбаагүй ажилласаар намгийн лаг шавартай барьцалдан хөлдсөн адуун сүргийн тал шахууг цаснаас цэвэрлэн гаргаж амжив. Морины бие чононд хазуулсан биш, хэвлий хэсгээрээ тэсрэх бөмбөгт өртсөн мэт хоёр хавирга нь сэрийн гэдэс дотор нь хэдэн метрийн хол цацагджээ. Үс арьс, туурай зэрэг энд тэнд хөглөрсөн нь чоно зөвхөн зүрх элэг зэрэг зөөлөн эд эрхтнийг идэж бусдаар бол бах таваа хангасан байдалтай хөөрхий морьдыг шоглосон болох нь илэрхий. Хүн өшөөтөн дайснаа түмэн хэсэг тасчин, судас шөрмөсийг нь сугалах ёсыг арай чононоос сурсан юм биш байгаа даа хэмээн Чэнь Жэнь бодож байлаа. Эсвэл хүний адгууслаг таашаал, чонын араншин хоёр нэг эх үүсвэртэй ч юм бил үү? Хүн төрөлхтний тэмцлийн түүхэнд хүн хүндээ чононоос өөрцгүй хандаж байсан ил далд баримт бишгүй нэг бий шүү дээ. Анх удаа нүдээрээ чонын ийм өргөн цар хүрээтэй хэрцгийлэл үйлдсэнийг үзээд Чэнь Жэньгийн дотоод сэтгэлийн гүн дэх адгууслаг чанар өдөөгдөн даруйхан мориндоо мордож нэг чоныг уургалан барьж аваад шөрмөсийг нь сугалмаар санагдав. Чонотой ойр дөт байсан хүн өөрөө чоно болон хувирч мэдмээр ч юм шиг. Эсвэл хүний чонын араншин адгууслаг чанар илт дээшилдэг юм болов уу?

Хүмүүс энэ байдлыг мэлрэн зогсох зуур Чэнь Жэньгийн гар хөл нь хөрөөд ясандаа хүртэл янгинах шиг санагдав.

Билиг өвгөн хоёр гараараа модон хүрзийг тулангаа их л бодлогоширонгуй “Энэ бол миний амьдралдаа үзсэн хоёр гуравт тооцогдохоор том чонон сүрэг байжээ. Хамгийн голд байгаа морийг ингэж шоглосон байхыг үзэхэд бусад морьдыг ямар болгосон нь харалтгүй ойлгомжтой.” гэв.

Өлзий дарга царайгаа барайлгаад “Энэ бол аж ахуй даяар зартай хурдан хөлөг байсан юм. Би түүнийг хоёр жил унахдаа гурван ч чоно уургалан алж байсан удаатай. Би сумангийн дарга байхдаа цэргүүдтэйгээ дээрэмчдийн араас явж байхдаа ч ийм хурдан хүлгийг үзээгүй юм даг. Энэ чонон сүргийн хэрэглэсэн арга тактик тэр жилийн адууны дээрэмчдийнхээс ч илүү төгс нарийн болжээ. Чоно цасан шуурга, нуурын намаг хоёрыг хавсран хэрэглэх юм гэж хэн санах вэ? Хэрвээ би чононоос илүү ухаантай байсан бол яахин адуун сүргээ алдаж ийм хайран сайхан морь үхэх билээ? Энэ асуудлыг би хариуцах учиртай. Тэр үед би Бао Шүнь Гүйг ятгах учиртай байсан юм” гэлээ.

Чэнь Жэнь тэр хоёрын ийн намуухан дуугаар ярилцахыг сонсох зуур бодолдоо автсан хэвээр байлаа. Хятадад хүмүүс бар, ирвэс, цөөвөр чоныг л хамгийн харгис хэрцгий гэлцдэг. Гэхдээ бар ирвэс нь сүрэглэдэггүй ховор амьтад болохоор тэдний өдөөсөн хэрэг цөөхөн байдаг. Харин чоно бол өргөн тархсан сүрэглэж амьдардаг, тэдний тарьсан балаг маш их болохоор түүхийн туршид хүн төрөлхтөнд учруулсан аюул занал хамгийн арвин байж таарна. Тал нутагт ирсэний дараа эндхийн хүн малын хамгийн заналт дайсан нь чоно байлаа. Гэсэн атлаа

тал нутгийн үндэстэн яахаараа чоныг сүлдээ болгон дээдлэн шүтсээр байдаг юм бол хэмээн Чэнь Жэнь саяын шинэ байр суурин дээрээсээ эргэцүүлэн бодож үзэв.

Намгийн дийлэнх хагасыг цэвэрлэхэд нуурын мөсөн дээгүүр цус нэлийн, яс үс, салсан үе мөч хөглөрөх нь ширүүн бөмбөгдөлтөд өртсөн дайны талбарыг санагдуулна. Тушаал хүлээн байлдааны даалгавар гүйцэтгэх гэж байсан сүрэг халуун амь ийнхүү тал нутгийн дайны золиос болон хоцорчээ. Бусад адууны хувьд ч цагаан морины хувь тавилан давтагдаад, морьд шавааралдан эх толгой нь мэдэгдэхгүй болсон хэсэгт зөвхөн толгойгоор нь баримжаалан тоог гаргах боломжтой байлаа. Хоёр адуучин мөсөн дээр сөхрөн суугаад зузаан нудрагаараа адууны толгой дээрх цасыг зайлуулан хайртай хүлэгнүүддээ харуусан, халуун нулимсаа урсгах ажээ. Тэнд байгсад бүгдээр энэхүү нүд халтирам байдалд сэтгэл шимширцгээнэ. Чэнь Жэнь болон Бээжингээс ирсэн бусад хэдэн илгээлтийн эзэд ийм зүйлтэй учирч байгаагүй тул айж балмагдан бие бие рүүгээ нүд далдиран харж байлаа. Тэд бүгдээрээ “Бидний хэн нэг нь тэр айхтар цасан шуурганаар ийм олон чонотой учирсан бол яах байсан бол? Арай цэргийн агтын дунд ийм байдалтай болчихсон хэвтэж байх байсан юм биш биз?” гэж бодсон нь лавгай.

Чэнь Жэньгийн нүдний өмнө Наньжингийн их хядлагын аймшигт дүр зураг тодрох шиг болов. Тэр чонын араншин дундаас фашизм болон японы зандалчдын илт дүрийг олж үзэв. Чэнь Жэньгийн бие эвгүйрхэн уур хорсолдоо багтраад огиудас хүрэн, чоныг харааж зүхэн алж хядмаар санагдав. Тэр дахин Билиг өвгөний өмнө биеэ барьж чадалгүй “Энэ сүрэг адуу ямар хөөрхийлөлтэй болоо вэ? Чоно үнэхээр муухай амьтан юм аа. Фашистууд, японы зандалчдаас илүү муухай амьтад юм. Тэднийг түмэн хэсэг тасчин хаявал таарна” гэгчхжээ.

Өвгөн царай барайлган Чэнь Жэньг бүлтийн ширтэх боловч их л биеэ барьсан шинжтэй “Японы милитаризм бол япон хүний өөрийн яс чанараас үүдсэн болохоос биш чонотой ямар ч холбоогүй. Би тэдэнтэй нүдэлдэж байсан болохоор мэдэлгүй яахав? Японд тал нутаг, чонон сүрэг байхгүй. Тэд чонын барааг ч хараагүй мөртлөө хүн алахдаа нүд цавчдаггүй улс. Би Зөвлөлтийн улаан армид газарчлан Гирин муж ордог засмал зам хүрэхдээ япончуудын хийсэн булай үйлийг харсан юм. Тэр замыг тавьсан хүмүүсийн яс замын хоёр хажуугаар ярайгаад, тэдний хагас нь монголчууд, нөгөө тэн хагас нь хятадууд байсан гээд бод доо” гэлээ.

Өлзий түүний үгийг өлгөн аваад “Энэ удаагийн том осолд ганц чоныг буруутгах аргагүй. Хүмүүс чонын гол хоол хүнсийг булаан авч яваад, тийм олон бэлтрэгийг суйлсан болохоор өшөөгөө авч байгаа хэрэг. Тэгээд ч хүмүүс бид нар өөрсдөө адуун сүрэгтээ эзэн болж чадсангүй. Чоно аминдаа хайртай амьтан болохоор арга мухардаагүй цагт хүнтэй халз тулгаран тэмцэнэ гэж байдаггүй юм. Хүнд анч ноход, хурдан буу, хуйвгай уурга байдаг болохоор чоно хамгаас их айдаг. Тэгээд ч дийлэнх чоно хүний гарт л үхдэг шүү дээ. Гэтэл японы зандалчид руу манай хятад улс дайрч байсан удаа байхгүй. Харин ч эсрэгээр тэгтэл их туслаж байсан байхад манай хятад хүмүүсийг нүд цавчихгүй алж хядаж байсан биш үү?” гэж хэлэв.

Өвгөн их л дурамжхан байдалтай Чэнь Жэнь рүү хяламхийн хараад “Хятадууд морины нуруун дээр тэгшхэн суучихаж чадахгүй, сав л хийвэл дохилзож байгаад годройтоод уначихдаг янзын улс шүү” гэлээ.



Өвгөн Чэнь Жэньг хэр барагтай бол загнаад байдаггүй. Харин энэ удаагийн хэлсэн үгийн цаад өнгө нь түүний ухааны сүвийг нээж өгчээ. Өвгөний сэтгэл дэх чонон сүлд хүлэг морины нуруун дээрх морьтон баатраас ч илүү бат суурьтай болохыг ойлголоо. Тал нутгийн үндэстний чонон сүлд хэдэн мянган жилийг улаачлан, хичнээн олон үндэстэн ястанг дамжин өнөөг хүрэхдээ хувиралт бууралтгүй ирсэн атал дал наян ажнай хурдан хүлгийн үхлээс болоод гуйвж дайвна гэж юу байх билээ дээ? Чэнь Жэнь гэнэт “Шар мөрөн зуун хорлолтой атлаа баялгийн ундарга болдог”, “Шар мөрөн эргээ халивал хүмүүс загасны хоол болно”, “Шар мөрөн бол хятад үндэстний эх мөн”, “Шар мөрөн бол хятад үндэстний соёлын өлгий мөн” гэсэн үгсийг саналаа. Хятадууд Шар мөрний үер усны гамшгийг ханатлаа амссан мөртлөө түүнийг амьдралынхаа эх булаг хэмээн дээдлэсээр ирсэн бус уу? Тэгэхээр хорлол энэрэл хоёр хослон оршиж, чухам л хорлолтой эх нь хятад үндэстнийг тэжээж тэтгэсээр оршин хөгжих эх булаг болсоор иржээ. Тийм болохоор тал нутгийн үндэстний чонон сүлдийг хятад үндэстний Шар мөрөн лугаа адил хүндэтгэвэл зохилтой ажгуу.

Бао Шүнь Гүй ч хашгичиж зандчихаа байгаад морио унан ослын талбайг хянамгай ажиглаж эхлэв. Олонбулгийн чонон сүрэг ийм хэрцгий догшин авирлаж, ийм олон сайхан адууг хэмлээд хаячихна гэж бодоогүй байсан тул царай нь улам бүр барайж байв. Түүний зургийн аппаратаа барьсан гар салганан чичирч, байн байн байрлалаа сольж байхыг Чэнь Жэнь харж байлаа.

Билиг, Өлзий хоёр гол хэсгийн морьдын сэгийг тойруулан ямар нэгэн чухал баримт сэжүүр хайсан мэт ухаж төнхөх ажээ. Чэнь Жэнь тэд нар руу яаран очиж туслангаа Билиг өвгөнөөс “Аав аа, та юу хайж байгаа юм бэ?” гэхэд өвгөн “Би чонын жимийг хайж байна. Цасыг мэдээтэй зайлуулаарай” гэлээ. Чэнь Жэнь эвтэйхэн байрлал олж зогсоод доош тонгойн хайж эхлэв. Хэсэг хугацаа өнгөрсөний эцэст хүмүүс чонын мөрөөр гарсан дөрвөн хуруу зузаан барьцалдан хөлдсөн жимийг олж үзэцгээв. Бүрхсэн цасыг зайлуулахад том нь үхрийн туурайн мөр шиг, жижиг нь том нохойн сарвуунаас ч том болох нь илхэн харагдав. Тэр тодхон мөрнүүдийн зарим нь адууны цусанд бялдсан байлаа.

Өлзий, Билиг хоёр хүмүүсийг дуудан ирүүлээд чонын жимийн цасыг цэвэрлүүлэв. Хэрвээ чонын жимийг цэвэрлэчихвэл чонон сүргийн хэр зэрэг олон болохыг тогтоож болно гэж Билиг өвгөн хэллээ. Цэвэрлэсээр байтал чонын жим шулуухан биш, хагас саран хэлбэртэй болох нь илрэв. Дахин хагас цаг цэвэрлэсний эцэст нөгөө хагас саран хэлбэр маань бүтэн дугуйран нийлээд зангидсан нударгын хиртэй сарвууны мөрнүүд цас цустай холилдон дурайх нь тамын орны эрлэгийн элч нарын явсан чөтгөрийн тойрог мэт сэтгэл сэрхийлгэм ажээ. Нэг метр гаруй өргөн, тавь жаран метр урттай тэрхүү чонын жим адууны сэг хамгийн их овоорсон төв хэсгийг ороон тогтжээ. Чонын энэхүү жирийсэн цустай мөрийг хараад хүмүүсийн дотор өөрийн эрхгүй зарсхийн хоорондоо тэр тухай ярилцана.

“Би өдий наслахдаа ийм том чонын жимийг үзээгүй юм байна шүү”

“Энэ бол чонон сүрэг биш, чөтгөр шулмын чуулган гэж л ийм байдаг байх даа”

“Ёстой аймаар чонон сүрэг байжээ”

“Наанадаж дөч тавиад чоно байсан байх шүү”

“Бат чи ч мөн бөх зүрхтэй хүн юм аа. Ийм олон чонотой ганцаараа үзэлцээд байдаг. Хэрвээ би байсан бол сүнсээ зайлтал айж мориноосоо унаад чонын хоол болох байсан даа”

“Тэр шөнө цас ихтэй харанхуй байсан болохоор би хичнээн чоно байгааг яахин багцаалах билээ?”

“Манай бэлчээр нутагт цаашид амьдрахад бэрх болох нь ээ”

“Эмэгтэйчүүд бид нар шөнө орой ганцаараа явж болохгүй нь байна шүү”

“Аж ахуйн төвийн цагаачид гэж ёстой олиггүй амьтад юм аа. Чонын хавар нөөцөлсөн махыг хуу хамж явснаас болоод ийм айхтар гай удлаа даа. Би хэрвээ азарган чоно байсан бол тэдний тэжээсэн гахай, тахиаг зүйл дуусгах байсан юм”

“Хэний санаачлагаар тэр олон хүмүүсийг бэлтрэг суйлах ажилд дайчилсан юм бэ? Түүнээс болоод өлөгчин чононууд улангассан байна шүү дээ. Өнгөрсөн жил бэлтрэг бага суйлсан болохоор адуун сүрэгт ийм айхтар хохирол учраагүй”

“Аж ахуйн удирдлага хэдэн удаагийн чонын ав хомрого зохион байгуулахгүй бол аягүйдвэл хүн рүү дайрдаг болох нь байна шүү”

“Хуралдахаа багасгаж, чоноо их авлаж байвал зүгээр юм”

“Ийм маягаар сэглэж идвэл ямар ч том мал сүрэг тэдний ховдог хүслийг гүйцээхгүй байх даа”

“Аж ахуйн удирдлагад тариачин гаралтай хүмүүс ирж монголоо алдсан юм хийгээд байхаар тэнгэр энэ чонон сүргийг наашаа ирүүлж биднийг шийтгэж байгаа нь энэ дээ”

“Амаа жаахан мэдэхгүй бол улс төрийн хэрэгт унана шүү”. . . . .

Бао Шүнь Гүй Өлзий дарга Билиг өвгөн хоёрыг дагалдан чонын жимийг нарийвчлан ажиглаж зураг авч байснаа байн байн зогсож тэдэнтэй ярилцана. Түүний баргар царай жаахан тавираад ирэв. Билиг өвгөн түүний “Хүний хүчин зүйл хамгаас чухал” гэсэн үзэл онолыг нэлээд гуйвуулав бололтой гэж Чэнь Жэнь таамаглаж байлаа. Ийм айхтар байгалийн гамшгийг хүний хүчин зүйл дийлж гарна гэж үү? Ямар ч том ажлын хэсэг ирээд шалгалаа гэсэн энэхүү яргын талбарыг үзээд цасан шуургыг ашигласан чонон сүргийн дайралтыг хүний хүч дийлэхгүй, жинхэнэ давагдашгүй хүчин зүйл байжээ гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм. Чэнь Жэнь Өлзий дарга, Бат нарт санаа зовниж байснаа арай уужирлаа.

Чэнь Жэнь энэхүү тойрог хэлбэртэй чонын жим ямар учиртай болохыг бодож эхлэв. Энэхүү толгойтой үс арзасхийм чонын жим түүний сэтгэлд дурайн тодроод түүнийг дагалдан сүрэг чоно зүрхийг нь тойрон давхилдаж, амьсгаа авах боломжгүй давчдуулж байх шиг. Тэд нар чухам ямар учир зорилготой ийм жим гаргасан юм бол оо? Талын чонын үйл хөдлөл бүхэн учрыг олж хужрыг тунгаахуйяа нэн бэрх оньсого байдаг билээ.

Даарсандаа гүйж дулаацсан юм болов уу? Магадгүй л юм. Тэр шөнийн цасан шуурганаар

айхтар хүйтэн байсан болохоор хол газар гүйж харайсан чононууд зогсохоороо даарсан байж мэднэ. Тэгээд цадтал идэж аваад тойргоор гүйлдэн дулаацсан байж таарах нь.

Эсвэл хоолоо шингээх гэсэн байж ч болох юм. Идсэн хоолоо гүйж энерги болгон хувиргаад дахин адууны махаа зооглосон байж болох биш үү? Чононд тал нутгийн зурам солонготой адил хүнсээ нөөцлөх нүх гэж байдаггүй. Нэгэнт илүү гарсан ангийн нөөцийг ходоодныхоо хэр хэмжээг тултал идэхээс өөр арга түүнд байхгүй. Тийм болохоор гүйж хоолоо сайн шингээгээд ходоодны илүү гарсан зайг дахин дүүргэдэг хэрэг байх нь. Тэгвэл түүний ходоод ган төмрөөр бүтсэн, эсвэл пүрштэй, резинэн юм болов уу? Арай мухар олгой байдаггүй, байлаа ч гэсэн мухар олгойн үрэвсэл тусдаггүй хэрэг үү? Тэгвэл ёстой аймаар юм аа.

Эсвэл дараачийн тулалдаанд бэлтгэн сүргээ тоолж байсан хэрэг үү? Бас л боломжтой хувилбар. Чонын жимийн ул мөрөөс харахад чонон сүрэг маш зохион байгуулалт, сахилга багтай болох нь тодорхой байлаа. Метр гаруй өргөнтэй тэр жим энэ тэрүүгээр өргөсч нарийссан хэсэг бараг үгүй. Тэгэхээр сүргийн тооллого хийсэн байх боломж тун их байна. Чоно ганц нэгээрээ, гурав таваараа, их сайндаа долоо наймаараа сүрэглэн ан хийх, айл хунарын мал сүрэг рүү дайрах нь элбэг боловч ийм олноороо сүрэглэн явах нь маш ховор байдаг юм. Чоно яахаараа өөрийн дур зоргоор, партизаны маягтай дайтдаг байснаа гэнэт байнгын армийн зохион байгуулалтад шилжин хүмүүстэй дайтдаг билээ гэдгийн учрыг Чэнь Жэнь олж ядаж байв. Дээр үед найман замын цэргийн дөрөвдүгээр шинэ арми ийм маягийн шилжилтийг хийх гэж хичнээн юм болж байлаа даа. Гэтэл чононд байгалиас ийм төрөлхийн авьяас байдаг гэж үү? Чоно өөрийн өвөг дээдсийн тал нутагт явуулсан хатуу ширүүн тэмцлийн явцад олж хуримтлуулсан туршлагыг дараа дараачийн үедээ өвлүүлэн үлдээх чадалтай юм болов уу? Гэтэл үг ярианы чадваргүй чоно өвөг дээдсийн туршлагыг яахин өвлөн авч чаддаг юм бол? Чоно гэж үнэхээр ухаан санаанд багтамгүй амьтан юм аа.

Бүр эсвэл тулалдааны ялалтаа тэмдэглэсэн юм болов уу? Эсвэл өргөн найр үүсгэхийн өмнөх ёслол ч байж мэдэх. Ер нь тийм магадлал байж болох юм. Чонон сүргийн хүч шавхсан тулалдааны дараа адуун сүргээс ганцыг ч үлдээлгүй хүйс тэмтрэн өшөөгөө авч том ялалт байгуулсан хэрэг шүү дээ. Сүрэг өлөн чоно ийм тарган адуун сүргийг барьчихаад баярлалгүй ч яахав? Чонон сүрэг тэр үед лав магнай хагартал баярлаад адуун сүргийн гол хэсгийг тойрон шулмын бүжгээ бүжсэн байж таарна. Тэд нарын баяр хөөр удаан үргэлжилсэн тул намгийн мөсөн дээр шулмын тойрог мэт энэхүү чонын жим гарчээ.

Хүний байр сууринаас чонын сэтгэлийг өнгийн харж үзвэл түүний үйл хөдлөлд нуугдаж байдаг олон эргэлзээтэй зүйлийг зүй зохистой тайлан ойлгож болохыг Чэнь Жэнь олж мэдэв. Нохой эзнийхээ санааг ойлгодог, хүн чонын санааг таньж мэддэг болохоор чоно ч эргээд хүний санааг ойлгодог юм болов уу? Тэнгэр, газар, хүн салшгүй цогц болохоор хүн, нохой, чоно гурвыг ч яахин салган ойлгож болох вэ? Хэрвээ энэхүү аймшигтай яргын талбарт ирээгүй бол яахин япон, хятад, монгол хүмүүсийн далд мөн чанар болоод “Хүн хүндээ чоно” гэсэн өрнөдийн итгэл үнэмшлийг ойлгож чадах байсан билээ. Тийм болохоор чоныг судлая гэвэл хүнээс эхлэ, хүнийг судлая гэвэл чононоос эхлэ. Чоно судлал хэмээгч хүн судлалтай холбоо бүхий том асуудал бус уу?

Морьгнууд Батыг дагалдан осол гарсан замын дагуу умар зүгийг чиглэн явцгаав. Чэнь Жэнь Билиг өвгөнийг бараадан очоод асууруун “Аав аа, чоно яах гэж тийм жим гаргасан юм бол

оо?” гэхэд өвгөн ийш тийш сэртэлзэн харсанаа жолоогоо татан хүмүүсийн сүүлийг барин хоцроод “Би Олонбулгийн талд жар гаруй жил амьдрахдаа ийм чонын жим хэд хэдийг үзсэн билээ. Багадаа энэ тухай ааваасаа асууж байсан удаатай. Манай аавын ярьсанаар бол чоно гэдэг амьтан дээд тэнгэрээс Баян тахилгат хайрхан болоод Олонбулгийн тал нутгийг хамгаалах гэж ирсэн элч ажээ. Хэн байгаль дэлхийтэй зүй бус харьцан сүйтгэх аваас дээд тэнгэр, Баян хайрханы эзэн сахиус хилэгнэж чонон сүргийг илгээн шийтгэдэг гэнэ. Чонон сүрэг тэнгэр хайрханы хишгийг хүртээд түүнийг тойрон баярлалдан гүйлдсээр тэнгэр мэт, нар сар лугаа адил тойрог үүсгэдэг байна. Энэ тойрог нь чонын тэнгэртээ сүслэдгийн илрэл, орчин цагийн талархлын захидалтай ижил юм. Тэнгэр түүний сүслэлийг хүлээн авсаны дараа сая тавтай найрладаг гэнэм. Чоно тэнгэр өөд харан удаан улихад саранд дугуй хүрээ үүсэн тэр шөнөдөө салхи босож ан гөрөө хийхэд нь тустай болдог. Чоно хүнээс илүү тэнгэрийн аашийг мэдэж, дүгрэгийг харж, төгрөгийг зурж чаддаг болохоор тэд тэнгэртэй харьцаж чаддаг байна” хэмээн ярив.

Чэнь Жэнь угаас ардын домог үлгэрт дуртай болохоор энэ тухай сонсоод ихэд баясав. Билиг өвгөний чонын гүйдлийн дүгрэг жимийн тухай тайлбар нь уран зохиолд л байж болох шинжлэх ухааны үндэслэлгүй мэт санагдаж болох л доо. Гэвч чоно урт удаан хугацааны ан гөрөө хийх явцдаа, чулуу чийгтвэл бороошдог, сар хүрээ татвал салхи босдог зэрэг байгалийн зүй тогтлыг ойлгож мэдсэн байх боломжтой. Тал нутагт нар сар нь хүрээ татдаг, хүмүүс нь хол байгаа хүнийг нааш ир гэж дуудахдаа гараа даллан дугуй үүсгэж дохидог гээд бодоод байвал энэ дугуй хүрээнд их нууцлаг дохио агуулагддаг юм байна гэж бодоод Чэнь Жэнь ихэд олзуурхлаа. “Талын чоно тойрог хүрээ үүсгэн гүйж тэнгэртэйгээ харьцдаг гэхээр ямар гайхалтай юм бэ? Би энэ тухай бодоод ч толгой хүрэхгүй юм байна” гэж тэр хэлэв.

Өвгөн өгүүлрүүн “Талын чоно үнэхээр гайхалтай шүү. Би түүнтэй насаараа тэмцэлдэж байгаа мөртлөө түүнийг даван гарч чадаагүй л байна. Энэ удаа ийм айхтар осол эндэл гарах юм гэдгийг би хувьдаа мэдэхгүй явсан шүү дээ. Чоно чиний хамгийн бодож санаагүй газраар сүрэглэн гараад ирдэг юм. Тэдэнд тэнгэр туслахгүй бол өөрсдөө тэр болгоныг яахин хийж чадах билээ?” гэжээ.

\* \* \*

Өмнө явж байсан морьтнууд зогсож зарим нь бууж цас малтаж эхлэв. Чэнь Жэнь Билигийг дагалдан явж очвол дөрөв таваараа цувран үхсэн морьдын сэг байхыг олж үзэв. Нэлээд холхон нэг хүн “Чоно байна. Үхсэн чоно байна” гэхэд Чэнь Жэнь Батын ярьдаг чоно морьдын гэдсийг хүү татсан газар мөн болохыг мэдэв. Эндээс адуун сүргийн сүйрэл эхэлсэн болохыг санаад түүний зүрх түг түг цохилж эхлэв.

Бао Шүнь Гүй морин дээрээс ташуураар даллан “Битгий хамаагүй яваад бай. Бүгдээрээ нааш ир. Энд байгаа хоёр морины сэгийг ухаж гаргахад болно. Дараа нь чоноо ухаж гаргая. Бүгдээрээ гурван сахилга, найман санамжийг санаж байгаа биз дээ. Олсон олзыг улсад тушаана шүү” гэлээ.

Хүмүүс бүгдээрээ тэр хоёр морины дэргэд цугларан цасыг нь зайлуулж эхлэв. Хоёр морины сэгийг ухаж гаргахад ходоод гэдэс, зүрх уушиг, элэг бөөр зэрэг дотор эрхтэн бүгд туурайндаа гишгэгдэн, няцраад хэдэн арван метрийн тэртээд цацагджээ. Энэ хоёр үхсэн морьдыг чонон

сүрэг зэмдэглээгүй аж. Учир нь чонон сүрэг нуурын тэндэх бөөн морьд дээр уур хилэнгээ гаргаж, өшөө хорслоо тайлж цадтал идсэн учраас наашаа ирээгүй байлаа. Гэхдээ Чэнь Жэнь цасыг зайлуулж байхдаа энэ хоёр морьд нуурын эрэг орчмын морьдоос илүү зовиуртай, сэтгэл шимшрэм үхжээ хэмээн бодож байв. Учир нь тэр хоёр морьдын нүдэн дэх айдас зовиур нуурын эрэгт үхсэн морьдоос хувь илүү тод харагдана.

Бао Шүнь Гүй уурандаа багтран “Энэ чонон сүрэг японы зандалчдаас дутуугүй хэрцгий ажээ. Адууны гэдсийг хүү татчихаар морьд өөрөө өөрийгөө егүүтгэнэ гэдгийг чоно л бодож олох байх даа. Амиа золин гэдсээ хүүлдэг японы самуурай нартай адилхныг сэтгэдэг байна шүү. Монголын чоно дэндүү аймаар юм аа. Би тэднийг хүйс тэмтрээд өгөхөө мэдэх байлгүй” хэмээн хашгичив.

Чэнь Жэнь түүний үгийг таслан “Өөрийн амийг золих үзлийг гагцхүү японы самуурай нараас гаралтай гэж ярих нь буруу шүү дээ. Дун Цүнь Рүй, Хуан Жи Гуан, Ян Гэнь Сы нарын хүмүүс дайсан лугаа амиа зольж байсан түүх бий шүү. Түүнийг самуурайн үзэл санаа гэж хэлэх үү? Аливаа нэг хувь хүн болоод үндэстэнд үхэхээс ч үл буцан, дайсантайгаа үзэлцэх үзэл санаа байхгүй бол бусдын ноёрхолд автан боол нь болохоос өөр арга зам байхгүй. Чонын амиа золих үзлээс зөв суралцах юм бол баатарлаг үзэл болох тул түүнийг магтан дуулваас зохилтой. Харин буруу зөрүү хэрэглэвэл самуурай болон фашист үзэл рүү халтиран орох юм.” гэхэд

Бао Шүнь Гүй хэсэг гүлдгэнэж байснаа “Хн, нээрэн ч тийм юм байна шүү” гэлээ.

Өлзий царай барайлган Бао Шүнь Гүй рүү хараад “Чоно ийм үхэн хатан дайрсан байхад Бат адуун сүрэгтэйгээ түүнийг яахин давж гарах билээ? Харин ч тэр хойноос энэ хүртэл амь дүйн тэмцэлдсээр ирсэн нь их юм болжээ. Энэ удаа хүний амь нас үрэгдээгүй нь тэнгэрийн аврал боллоо. Дээд газрын ажлын хэсэг ирээд ч зөв зүйтэй дүгнэлт гаргах байлгүй” гэж хэлэв.

Бао Шүнь Гүй толгой дохин анх удаа их л зөөлөн дуугаар “Бат чи тэр үед морины чинь гэдсийг чоно хүүлчих вий гэж айсангүй юу?” хэмээн асуулаа.

Бат хайхрамжгүй байдалтай “Тэр үед надад тийм юм бодох сөхөө байсангүй. Ямар сайндаа намаг руу дайран орох гэж байх билээ?” гэв.

“Чоно чам руу дайраагүй юм уу?” хэмээн Бао Шүнь Гүйг асуухад

Бат түүн рүү төмөр бөгжтэй малиагаа сунган харуулаад “Би энэ малиагаараа хоёр чоныг цохиж алаагүй бол тэд намайг ч гэсэн хүү татах байсан л даа. Лхасүрэн тэд нарт ийм зэвсэг байгаагүй болохоор айж зугатаасан хэрэг биш юм шүү” гэв.

Бао Шүнь Гүй түүний малиаг тосон авч эргүүлж тойруулан үзэж байснаа “Сайхан эд байна. Ийм юмаар чоныг дэлсэхэд яаж тэсэх билээ? Бүр ч сайн дэлсдэг байсан юм. Чиний эр зориг, эрдэм чадал үнэхээр гаргуун ажээ. Дээд газрын ажлын хэсэг ирэхээр чи тэдэнд чоно хэрхэн намаснаа ярьж өгөөрэй” гэлээ.

Бао Шүнь Гүй түүнд малиаг нь буцаан өгөөд Өлзий даргад хандан “Танай эндхийн чоно ч арай өөр юм аа. Хүнээс илүү сэтгэсэн байна шүү. Тэд нар ямар ч үнэ цэнээр хамаагүй адуун сүргийг нуурын намаг руу оруулах бодолтой байсан нь тун илт байна. Чи хар даа. . .” гээд тэр хуруу даран тоолж “Чоно цаг агаар, газар зүйн байрлал, цаг хугацааны хүчин зүйл, өөрийн болоод өрөөлийн байдлыг цэгнэх зэргийг мэдэж байна. Цэргийн урлагийн талаас гэвэл стратеги, тактик, шөнийн дайн, давуу хүчний төвлөрөл гээд бүхий л юм байна шүү дээ. Дээр нь бас төлөвлөгөө зорилго, дэс дараатайгаар адуун сүрэгтэй тулалджээ. Энэ удаагийн жишээг цэргийн сурах бичигт ч оруулж болох биш үү? Чи бид хоёр цэрэгт байсан улс. Манай найман замын цэргийн хэрэглэж байсан бүхий л арга тактикийг тэд эзэмшжээ. Худалч хүнд бараг л окоп, фронтын шугам хоёрыг хэрэглэх дөхсөн юм биш үү? Би тал нутгийн чоныг ийм элдэвтэй гэж урьд нь бодож байгаагүй юм байна. Сайндаа л хар муйхраар дайран хэд гурван хонь нухдаг биз гэсэн шүү юм бодож байсан сан” гэхэд

Өлзий түүний хариуд “Би цэргээс халагдан наашаа ирэхдээ дайны талбар дээр байгаагаас өөрцгүй юм шиг санагддаг шүү. Жилийн дөрвөн улиралд биеэсээ буу салгахгүй чонотой тулалдсаар одоо цэрэгт байснаас илүү мэргэн бууддаг болсон. Чоно цэргийн номын дундах гол гол эрдмүүдийг гаргуун сайн хэрэглэдэг гэж чиний хэлдэг яахын аргагүй үнэн. Би ч арван хэдэн жил чонотой үзэлцсэний хэрээр багагүй ухаан суусан шүү. Одоо намайг дээрэмчдийг бүслэн устга гэж явуулах юм бол би хавьгүй илүү ажиллах байх аа” гэлээ.

Чэнь Жэньд тэдний яриа ихэд сонин санагдаж “Тэгвэл хүмүүс цэргийн номыг чононоос сурсан байж болохгүй юу?” хэмээн асуув.

Өлзийгийн нүд гялалзан Чэнь Жэнь рүү ултай нь аргагүй хараад “Тийм ээ, хүмүүс цөөнгүй цэргийн номыг чононоос суралцсан байдаг юм. Эрт дээр цагт тал нутгийн үндэстэнгүүд чононоос суралцсан цэргийн номоо цагаан хэрмийн доторх суурьшмал иргэдтэй тулалдахдаа хэрэглэдэг байж л дээ. Хятадууд ч гэсэн нүүдэлчдээс морь унах, нум сум харвах дээл бүс өмсөж зүүх сэлтээс гадна, тэдний цөөнгүй цэргийн номыг суралцсан байдаг юм даа. Би Хөххотод мал аж ахуйн чиглэлээр давтан суралцах хэдэн жилийн хугацаанд цөөнгүй цэргийн ном үзсэн. Тэгээд Сүньзийн цэргийн урлаг, чонын цэргийн урлаг хоёрын хооронд бараг ялгаа байхгүй гэсэн дүгнэлтэд хүрч билээ. Тухайлбал цэрэг хэмээгч зальхайн ёсон буюу гэдэг ч юм уу, эсвэл дайснаа өөрөөсөө дутуугүй таньж мэд, цэргийн эрхэм хурдад буй, дайсныхаа санаанд ороогүй үед гэнэдүүлэн дайр гэх мэт. Энэ бүхнийг чинь захын чоно л мэддэг биз дээ?” гэлээ.

“Гэсэн атлаа хятадын цэргийн номонд нүүдэлчид болон талын чонын тухай ганц үг дурсаагүй байдаг нь шудрага хэрэг мөн гэж үү?” хэмээн Чэнь Жэнь мэтгэв.

“Манай монголчууд соёлын хувьд хоцрогдоод Монголын нууц товчооноос өөр нөлөө бүхий ном байхгүй байгаа нь л хамгийн эмгэнэлтэй хэрэг дээ” хэмээн Өлзий хэллээ.

Бао Шүнь Гүй, Өлзийд хандан “Тал нутгийн мал аж ахуйг удирдахад чоныг судлаж, түүний цэргийн аргыг таньж мэдэхгүй бол болохгүй нь байна шүү. За үг олдож үхэр холдлоо. Тэнд байгаа үхсэн чоныг үзэцгээе. Би ч хэдэн зураг татаж авья” гэжээ.

Хоёр дарга явсаны дараа Чэнь Жэнь модон хүрээ түшин зогсоод гөлөрч орхив. Энэ удаагийн ослын газар дээр хийсэн үзлэг түүний нүүдэлчин үндэстэн болон Чингис хааны цэрэг дайны гайхамшигийн талаарх сонирхлыг улам дэврээж орхилоо. Яахаараа Чингис хаан болон түүний үр ач нар зуун хэдхэн мянган цэргээрээ ази европын өргөн уудам нутгийг хөндлөн гулд эзлэж чадсан хэрэг вэ? Тэд Тангудын хэдэн зуун мянган цэрэг, Их алтан улсын сая цэрэг, өмнөд Сүн улсын сая гаруй усан болоод явган цэргийг устгаж, Орос Кипчакын хамтарсан цэргийг бутниргээд дундад азийг байлдан эзлэж, Унгар, Польш, Орос улсыг бүрэн эрхшээлдээ оруулсан. Тэр дунд Хятад, Перс, Иран, Энэтхэг зэрэг эртний том соёлт гүрнүүд байгаа шүү дээ. Ямар сайндаа л Ариун Ромын эзэнт улсын Пап лам ураг барилдах хятадын бодлогыг ашиглан Мэри гүнжийг Чингис хааны жич хөвүүнд өгч байх билээ. Чухам монголчууд л дэлхийн түүхэн дэх хамгийн өргөн уудам нутаг дэвсгэртэй улс орныг байгуулж чадсан юм. Анх өөрийн бичиг үсэггүй, төмөр зэвээ ч хийчихэж чаддаггүй нүүдэлчин жижиг үндэстэн яахаараа тийм аугаа их цэргийн хүчин чадал болоод цэргийн урлагийн сод билиг ухааныг төрүүлэн гаргаж чадсан юм бол оо? Энэ бол манай гаригийн түүхэн дэх хамгийн үл тайлагдах оньсогуудын нэг юм. Тэр тусмаа Чингис хаан болоод түүний үр ач нарын цэрэг дайны амжилтын гайхамшиг нь олноор цөөнийг дийлж, хүчээр ялалт байгуулж байсан хэрэг биш, харин ч эсрэгээр цөөнөөр олныг дагуулж, билиг оюунаар ялалтыг байгуулж ирсэн байдаг. Арай тэд нар морьдын хурд, чонын ухаан, зан чанар болоод чонон сүлдээс үүдэлтэй үндэсний хүчирхэг ухамсрыг ашигласан хэрэг биш биз дээ?

Чэнь Жэнь энэ хоёр жилийн хугацаанд чонотой харилцаж, чонын тухай маш олон домог яриаг сурвалжлан олохын зэрэгцээ чононууд зээр болон адуун сүргийг хэрхэн хомроглон барьсан бодит жишээг үзэж танилцах зуур Чингис хааны цэрэг дайны гайхамшигт амжилтын нууц чухам чонотой холбоотой болохыг эргэлт буцалтгүй ойлгож авсан юм. Дайн гэдэг бол бүлэг хүмүүсийн зэвсэгт үйлдлийн нэрийдэл мөн. Дайн ав хомрог хоёр мөн чанарын хувьд ялгаатай. Шүдээ хүртэл зэвсэглэсэн дайтагч талууд довтолгоо, хамгаалалтыг хослуульж байдаг. Харин ав хомрогын үед хүн идэвхтэй байрлал эзлэн, бусад олонх ан амьтад алагдах хувь тавиланг хүлээдэг. Туулай, тарвага, зээр зэргийг агнахад үхэх сэхэхээ үзсэн тулалдаан болдоггүй. Үүнийг ан гөрөө гэхээс биш, дайн тулалдаантай зүйрлэх юм биш. Ан гөрөө хийхэд хэдийгээр зарим нэгэн цэргийн арга ухааныг суралцаж болохоос биш, тэр талын жинхэнэ эрдэм чадварыг дайны талбар дээрээс л суралцах боломжтой билээ.

Чэнь Жэнь цааш эргэцүүлэн бодсоор л. Монголын тал барс, цөөвөр чоно, ирвэс, арслан, заан зэрэг амьтад сүрэглэн амьдрах бололцоогүй. Байгалийн хатуу ширүүн нөхцөлд тэд зохицон амьдарч чадахгүйгээс гадна, эрэлхэг зоригтой агаад оюунлаг тал нутгийн хүн чоно хоёр тэдэнд оршин амьдрах бололцоо ч олгохгүй юм. Талын хүн чоно хоёр бол монголын тал нутгийн биологийн хатуу ширүүн өрсөлдөөний явцад шалгаран үлдсэн цорын ганц өрсөлдөгч нар ажээ. Бусад түүхийн сурах бичигт монголын цэргийн эрдмийн нууц ав хомроготой холбоотой гэдэг үзлийг Чэнь Жэнь эрс няцаадаг болжээ. Хамгийн оновчтой дүгнэлт нь “Нүүдэлчин үндэстний цэргийн гоц эрдмийн далд нууц нь тухайн үндэстэн урт удаан хугацааны туршид чонон сүрэгтэй явуулсан хатуу ширүүн тасралтгүй оршин амьдрахын төлөөх дайнаас үүдэлтэй юм” гэвэл зохилтой билээ. Нүүдэлчдийн чонотой явуулсан хүч тэнцүү тулалдаан хэдэн түмэн жилээр үргэлжилжээ. Энэхүү урт удаан хугацааны нөр хэцүү дайны явцад хүн чоно хоёр цэргийн шинжлэх ухааны үндсэн зарчим, итгэл үнэмшлүүдийг батлан гаргаж чадсан байна. Тухайлбал: “Дайснаа өөрөөсөө илүү судлах, цэргийн эрхэм

хурдад буй, цэргийн мэх цээргүй, дээр хэмээвээс тэнгэрийн хэлийг мэдэж, дор хэмээвээс газрын зүйг ухмуй, байнгын бэлэн байдалд байх, дуу нь зүүнтээ довглох нь баруунтаа, цэргийн хүчийг төвлөрүүлэх, нэг нэгээр нь довлон цохих, бүхлийг задлах, дайсныхаа санаандгүй үед гэнэдүүлэн дайрах, дийлэхийг дайрч, дийлэхгүйгээс зугатах, арван хурууг шархдуулснаас нэг хурууг тасласан нь дээр, дайсан дайрвал би ухрана, дайсан суувал би үймүүлнэ, дайсан ядарваас би цохино, дайсан ухарваас би элдэнэ” гэх мэт. Чоно хэдийгээр дэлхийн өнцөг булан бүрт байдаг боловч суурьшмал иргэд шиг өндөр хана хэрмээр өөрийгөө хүрээлээгүй монголын тал нутаг чонын хамгийн тааламжтай орших газар, хүн чонын оюун ухаан авхаалж самбаагаа сорих гол дайны талбар болдог юм.

Чэнь Жэньгийн бодол ийнхүү хөврөх зуур тэр Хятадын таван мянган жилийн соёл иргэншлийн түүхийн хонгил замын аман дээр зогсож байгаа мэт санагдав. Монголын талд хүн чоно хоёр өдөр шөнөгүй их багаар дайтаж л байдаг. Хүн чонын дайны практикийн давгамж дэлхийн өөр бусад суурьшмал соёл иргэншилт улсууд дахь хүн чоно болоод хүн хүний хоорондын дайнаас хавьгүй илүү ажээ. Дээр нь нүүдэлчдийн овог аймаг хоорондын тулалдаан болон харь улс руу хийсэн түрэмгий аян дайн тэдний цэрэг дайны авьяас билигийг улам хурцалж өгдөг байна. Тийм болохоор монгол талын нүүдэлчид дэлхийн бусад суурьшмал болон нүүдэлчин үндэстнүүдээс цэрэг дайны үйлд мэргэшиж, байгалиас энэ талын давуу байдлыг олж авсан байдаг ажээ. Хятадын Жоу, Чүньцю, Жаныгуо, Цин, Хань, Тан, Сүн зэрэг улсын түүхээс үзэхэд хүн ам, улсын хүчин чадлын хувьд зүйрлэшгүй давуу байдалтай тэдгээр соёлт гүрнүүд монголын өндөрлөгт орших жижиг нүүдэлчин үндэстнүүдийн өмнө хүчин мөхөсдөн улсын язгуур доройтож, улмаар сүйрэн мөхсөн байдаг. Улмаар Сүн улс мөхсөнөөр Чингис хааны монгол үндэстэн хятад нутгийг бүрэн эрхшээн зуун оныг үдсэн түүхтэй билээ. Хятадын хамгийн сүүлчийн феодалын эзэнт гүрэн манж Чин улсыг ч гэсэн өөр нэгэн нүүдэлчин үндэстэн байгуулсан. Суурьшмал хятад үндэстэнд чоно хэмээгч сургагч багш байхгүй, чонотой хоршсон хамтын хатуу ширүүн бэлтгэл үгүй, хэдийгээр Сүнзийн цэргийн ном хэмээх арга байдаг боловч тэр нь зөвхөн цаасан дээр л үлдсэн төдийгүй, уг чанартаа чонын цэргийн номноос санаа авсан зүйл билээ.

Чэнь Жэнь хэдэн мянган жилийн турш Хятад үндэстэн умардын халдлагын улмаас хэдэн арван саяараа үхэж үрэгдэн, хэдэн мянган оны турш цагаан хэрмийг байгуулан, засаж сэлбэх гэсээр олон төр улсын сан хөмрөг хоосорч байсны цаад мөн чанарыг олох шиг санагдлаа. Түүний оюуны сүв нээгдэхийн хэрээр сэтгэлд нь их л гунигтай хүнд санагдаад явчихав. Сав шим ертөнцийн шүтэн барилдлага хүн төрөлхтний түүх болон хувь заяаг ч эрхшээж байдаг ажгуу. Аливаа нэгэн үндэстний улс гэрээ батлан хамгаалах чадвар нь тухайн үндэстний оршин тогтнохын эх үндэс билээ. Хэрвээ монголын тал, чоно хоёр байгаагүй бол дэлхийн түүх шал өөрөөр бичигдэх байсан бус уу?

Хүмүүс шаагилдан нэг тийш гүйлдэхэд Чэнь Жэнь сая гүн бодлоосоо сэрж морио унан тийш давшилаа.

Хоёр үхсэн чоныг цасан дундаас гарган ирсэн нь тэдний адуун сүргийг намаг руу шахсаны өр төлөөс байлаа. Чэнь Жэнь нэг чоно руу дөхөн очиход Бат, Лхасүрэн хоёр өөр нэг чоныг цаснаас салгангаа хүмүүст чонын амиа золиослох аймшигт үйлдлийг тайлбарлан ярьж байв. Ил гарсан тэр чоно ихэд сунагар биетэйг үзвэл өлөгчин болох нь илт. Бөгсөн бие нь адуунд



гишгүүлэн няцлагдсан боловч чинэрсэн хөхнөөс дуссан сүү нь цустай холилдон хөлджээ.

Билиг өвгөн ам нээж “Хөөрхий дөө, энэ чонын бэлтрэгийг хүмүүс суйлчихаар бусад өлөгчингүүдтэй чонон сүргийг дуудан ирүүлж өшөөгөө авах гэж яваад амь алдсан байна. Тал нутагт аливаа бүхний үр үндсийг тасалж болдоггүй юм. Айж сандарсан туулай хүртэл чоныг хазаад авдаг байхад өлөгчин чоно амиа гаргуунд гаргалгүй яах билээ?” гэж хэлэв.

Чэнь Жэнь бусад илгээлтийн эздэд хандан “Түүхэн сурвалжид тэмдэглэснээр өлөгчин чоно үнэн хэрэгтээ их өрөвчхөн байдаг юм гэнэ лээ. Тэд нар цөөнгүй хүүхдийг өсгөн тэжээсэн түүх бий шүү. Хүннү, Гаочө, Түрэгийн дээд өвгүүд бүгд чонын тэжээвэр хүүхдүүд байсан гэдэг” хэмээн ярьлаа.

Бао Шүнь Гүй түүний үгийг таслаад “Юуны чинь чонын тэжээвэр хүүхэд гэж донгосоод байна вэ? Чоно хүн барьж байсан болохоос биш тэжээж байсан түүх гэж хаана байсан юм бэ? Хүн чоно хоёр нэгэн тэнгэрийн дор орших учиргүй тул тэднийг хүйс тэмтрэх хэрэгтэй. Бэлтрэг суйлах ажил бол миний тушаалаар хийгдсэн юм. Жилд нэг удаа явагддаг бэлтрэг суйлах ажил нь чонын хор хөнөөлийг багасгах хамгийн үр нөлөөтэй уламжлал. Тоо толгойг нь багасгах төдийхөн хангалтгүй, бүрмөсөн устгах хэрэгтэй. Тийм болохоор манай аж ахуйн нутагт байгаа бүхий л чонын үүрэн дэх бэлтрэгийг суйлан устгавал зохилтой. Чоно өшөө авдаг л гэх юм. Би чонон сүргийг хүйс тэмтрээд дуусгахаар яаж өшөөгөө авахыг хараарай л даа. Одоо би өөрийн гаргасан тушаалаа цуцална гэж байхгүй ээ. Энэ ослын ажлыг нэг тийш болгочихоод дахин бэлтрэг суйлах ажиллагааг үргэлжлүүлнэ. Хоёр өрх болгон нэг бэлтрэгний арьс тушаана шүү. Бэлтрэг олддоггүй юм бол том чоно ч байсан болно. Хэрвээ өгсөн үүрэг гүйцэтгэхгүй бол цалин цавагтай чинь ярина гэж мэдээрэй” гэлээ.

Бао Шүнь Гүй үхсэн чонын зургийг хэдэн удаа авсаны дараа түүнийг тэргэнд ачууллаа.

Хүмүүс өөр нэгэн чонон дээр явж очлоо. Чэнь Жэнь тал нутагт ирээд хоёр жил болохдоо үхсэн амьд чоно болон туламлан өвчсөн арьс зэргийг үзэхээрээ нэг болсон боловч ийм чоныг огт үзэж байгаагүй юм. Тэр чоно ирвэс шиг зантгар толгойтой түүнээс ч нүсэр зузаан биетэй ажээ. Цасыг цэвэрлэсний дараа өтгөн зэгэл шаргал үсэн дундаас хар сортой хялгас зогдор зүү адил сэрийн харагдана. Чонын бөгсөн бие адуунд зад өшиглүүлээд газраар нэг цус мөстөн хөлджээ.

Бат мөнөөх үхсэн чоныг өшиглөтөл хөдөлгөх юм биш. Тэр хөлсөө арчингаа “Энэ мөн тэнэг амьтан шүү. Ийм сайхан том биетэй амьтан чинь адууны гэдсэнд хүрсэн л бол гүйцээх байсан юм. Гэтэл түүний оронд амиа алдчихаад хөдөө хээр хөсөр хэвтэж байдаг” гэлээ.

Билиг өвгөн түүнийг сайтар сонжин харж байснаа доош тонгойн чонын хүзүүн дэх цустай үсийг ярваас хоёр хуруу хэрийн том цустай шарх ил гарч ирэхэд илгээлтийн эзэд бүгд давхийн цочлоо. Энэ бол тал нутагт чононд бариулсан зээрийн хүзүүнд байдаг дөрвөн соёоных нь ул мөр юм. Өвгөн өгүүлрүүн “Энэ чоно адуунд өшиглүүлээд үхлүүт хүнд шархтсаныг өөр нэгэн чоно ирж зүйл дуусгажээ” гэв.

Бао Шүнь Гүй хараал зүхэл урсган “Чоно ч шархдсан нөхрөө устгадаг дээрэмчид шиг адгийн амьтад юм л даа” гэлээ.

Билиг өвгөн нүдээ бүлгийлгээд “Дээрэмчид үхэхээрээ тэнгэрт хальдаг бил үү? Тэгвэл чоно бол тэнгэр заяатай амьтан юм шүү. Энэ чоно адуунд гэдсээ зад өшиглүүлчихээд үхье гэхээр үхэж болдоггүй, амьд ч гарах найдлагагүй болчихоор үхсэнээс долоон дор болох биш үү? Амьд чоно нь түүнийг харж нүд халтираад зүйл дуусгаснаар тэр бие амар сүнс нь тэнгэрт заларсан байж таарна. Азарган чонын энэ үйлдэл харин сайн сэтгэлээс үүдэлтэй юм. Тэр шархтай амьтан хүний гарт орж үйл тамаа эдлэхээс сэргийлж байгаа хэрэг. Чоно бол үхсэн ч гутамшгийг хүлцдэггүй амьтан болохоор өөрийн ахан дүүсийг амар нүд аниг гэж бодсон байж таарна. Танай тариачин гаралтай улс үхсэн ч бууж өгдөггүй нь хэд билээ дээ? Тэгвэл чонын энэ хатуу чанга зоригийг бодоод тал нутгийн өвгөд бид нулимс унагаж байдаг юм шүү” гэж хэлэв.

Өлзий дарга Бао Шүнь Гүй руу их л дурамжхан байдалтай харж “Тал нутгийн чонын дайчин чанар юунд байдаг гэж бодно вэ? Гол хүчин зүйлийн нэг нь азарган чоно хүнд шархдсан нэгнээ зүйл дуусгаж сүргийн ачааллыг хөнгөлж байдаг юм. Тэгснээр сүрэг нь эрч хурдаа хадгалж чаддаг. Чи чонотой тэмцэхдээ энэ онцлогийг сайтар харгалзан үзэх нь чухал шүү” гэв.

Бао Шүнь Гүй ч ямар нэгэн зүйл ухаарсан бололтой толгой дохиод “Нээрэн ч тийм юм байна шүү. Байлдаж байгаа ангид шархтныг дамнах цэрэг, асрагч, сувилагч, эмч, машин тэрэг, эмнэлэг гээд зөндөө зүйл хэрэгтэй шүү дээ. Би арын албанд ажиллаж байсан болохоор нэг шархтай цэрэгт арван хэдэн хүн үйлчлэх хэрэгтэй болохоор ачаалал хүнд байдгийг мэдэлгүй яах вэ? Дайн тулалдааны үеэр тийм олон хүн хүч зарцуулж байгаа болохоор дайтах чадварт ч нөлөөлнө. Энэ утгаар нь авч үзвэл чонон сүрэг хүнээс ч илүү маневрлах чадвартай байдаг ажээ. Гэвч шархтангуудын цөөнгүй нь эрэлхэг цэрэг байдаг учраас эмчлээд авбал армидаа нэмэртэй биш үү? ” хэмээн өгүүлэв.

Өлзий дарга санаа алдаад “Чонын энэ үйлдэлд цаанаа учир зүй байдаг л даа. Нэгд чоно бол үржих чадвар сайтай. Нэг төрөхдөө долоо найм, арван хэдэн бэлтрэг төрүүлж дийлэнх нь эсэн мэнд торнидог. Нэг жил би арван нэгэн өсгөлүүн том бэлтрэгнүүдээ дагуулсан өлөгчин чоныг харж билээ. Ээжээсээ хагас төө гаруй намхан, хурдаар бол дутахгүй юм байна лээ. Эм бэлтрэг хоёр жил болоод л үржилд ордог. Үнээ гурван жилд сайндаа л таван тугал гаргадаг бол өлөгчин чоно хэдэн бэлтрэг гаргах билээ? Миний санахад салаа цэрэгтэй тэнцэх хэмжээний бэлтрэг гаргана. Тийм болохоор чонон цэргийн тоо хүнийхээс хурдан өсдөг юм. Хоёрдугаарт чоно хурдан өсөж торнидог. Нэг настай бэлтрэг ирэх хавар гэхэд бүх юмыг чаддаг болсон байна. Нэг настай бэлтрэг хонь барьж байхад нэг настай хүүхэд борвиныхоо бааснаас салаагүй байдаг биз дээ? Сүргийн нөөц ийм л хангалттай болохоор шархтай нэгнээ хурдан нүд аниулдаг. Миний санахад чоно чоноо алдаг нь нэг талаар байгалийн нөхөн үржлийн тэнцвэрийг хадгалж төлөвлөгөөт төрөлтийн бодлогыг хэрэгжүүлж байгаа хэрэг. Тэгсэний хэрээр жинхэнэ шалгарсан нэг нь л байгаль дэлхийдээ оршин амьдрах боломжтой. Талын чонын омог сүр түмэн онд буурахгүй байсаар ирсэний нууц чухам энд байдаг юм” гэлээ.

Бао Шүнь Гүйгийн царайд инээмсэглэл тодроод “Өнөөдрийн энэ шалгалтаар чонын үнэхээр айхтар болохыг мэдэж авлаа. Байгаль цаг уурын гамшгийг цаг уурын мэдээ хэлээд өгдөг. Тэгвэл чонын гамшгийг юунаас мэдэж болох билээ? Тариалангийн бүсээс ирсэн бид мэтийн

хүмүүс чонын талаар тун өрөөсгөл мэдлэгтэй байдаг юм байна. Энэ удаагийн осол үнэхээр хүний хүчин зүйлээс ахадсан хэрэг байжээ. Дээд газрын шалгалтын хүмүүс газар дээр нь ирээд энэ бүхнийг өөрсдөө ойлгоно биз” хэмээн хэлэв.

Өлзий дарга “Жаахан юм ойлгочих сэхээтэй улс ирээсэй билээ дээ” гэж хэллээ.

Бао Шүнь Гүй өгүүлрүүн “Тэдний ирсэн ирээгүй хамаагүй, бид хэдэн удаагийн томоохон ав хомрого зохион байгуулахгүй бол манай аж ахуй чонын идэшний диваажин болон хувирах нь байна шүү. Би дарга нараас ахиухан сум олж ирье” гэлээ.

Хүмүүсийн нэг талд хэдэн илгээлтийн эзэд маргалдаж эхлэв. Гуравдугаар багийн анхан шатны боловсролтой, Бээжингийн “Зүүнтнийг засах” улаан хамгаалагчдын отрядын дарга асан улаан хувьсгалч Ли овогт хэлэхдээ “Чоно бол ангийн дайсан мөн юм байна. Ер нь дэлхий дээрх харгис этгээдүүд бүгд чонон санаатай. Чоно ард нийтийн өмч болсон үхэр, адуу, хонин сүргийг хүртэл алж устгаад зогсохгүй, анд нөхрөө хүртэл алдаг ажээ. Бид олон түмний хүчийг зохион байгуулж чоныг агнан тэдэнд пролетарийн диктатур ямар байдгийг үзүүлэх хэрэгтэй. Тэгснээр тэднийг үндсээр нь устгавал зохино. Түүнчлэн чоныг өрөвдөн хайрлаж, үхэхээрээ чононд биеэ өгдөг тал нутгийн улирсан баларсан ухагдхуун, уламжлал, ёс заншлыг халах хэрэгтэй.. . “ хэмээн ярьлаа.

Түүний үгийн өнгө илт Билиг өвгөн рүү чиглэснийг үзээд Чэнь Жэнь яриаг таслан “Чиний үг арай дэндэж байгаа юм биш үү? Ангийн тэмцлийг хоёр хөлтний хүрээнд авч ярина уу гэхээс биш чоныг түүнд хамруулбал чи өөрөө хүн үү, эсвэл чоно уу гэдэг дээр хүрнэ биз дээ? Чи аугаа их пролетари ангийн удирдагчийг бас чонотой адил авч үзэх гээ юу? Тэгээд ч чоно байтугай хүн өөрөө хүнээ алдаг биз дээ? Харин ч дэлхийн нэг хоёрдугаар дайны үед хүн хүнээ хичнээн олон саяар хүйс тэмтэрсэн билээ? Синантроп хүнээс өдийг хүртэл хүн хүнээ алсан тоог харьцуулан гаргавал чононоос илүү хэрцгий дүр зураг харагдах байх даа. Чи жаахан ном уншиж байвал зүгээр юм” гэчихэв.

Улаан хамгаалагч Ли малиагаа өргөн Чэнь Жэньгийн хамрыг шөргөөгөөд “Чи ахлах сургууль төгссөн гэдгээрээ онгирох санаа байна уу? Чиний уншсан чинь бүгдээрээ хөрөнгөтөн, феодал, засварлах үзэлтний номнууд шүү дээ. Хорт өвснөөс өөрцгүй. Чи тэр эцэг шүү юмныхээ нөлөөнд автаад сургууль дээр үг дуугүй гүлдийсэн юм явдаг байсан мөртлөө энэ хоцрогдсон бүдүүлэг газар ирээд усанд орсон загас мэт жаргалаа эдлэж байгаа биш үү? Эндхийн дөрвөн хуучинсаг чамд нэвт шингэсэн байна” хэмээн хашгирлаа.

Чэнь Жэньгийн омог бадран өлөн чоно шиг дайран ороод мориноос нь татан унагамаар санагдав. Гэвч тэр чонын тэвчээрийг бодон түүн рүү хяламхийн харчихаад эсгий гутал руугаа ташуураараа хоёр тоншин цааш яваад өгөв.

Харуй бүрий болохын алдад тал нутгийн тарган мах, сүүтэй цайны амтанд орсон илгээлтийн эзэд өлсөж даарсандаа давжигнатал чичирч эхлэв. Аж ахуйн шалгалтын хэсгийн дарга нар, олонх малчид болон илгээлтийн эзэд үхсэн чоно ачсан морин тэргийг даган буцах замдаа орлоо. Харин Чэнь Жэнь, Бат, Лхасүрэн хоёртой цуг хайртай уургыг нь эрэх далимаар адуунд өшиглүүлсэн чоно байж юуны магад хэмээн үлдэв. Цаад хоёр нь чонын тухай өөр сонин сайхан зүйл ярьж өгөх болов уу гэж тэр битүүхэндээ горьдож байлаа.



## Долоо

*“Хөх чоно бидэнд зарлиг уламжлавай. Үүрээр долон мэт гэрэл Ухань хааны майхныг нэвтлэн тусахуй дор нэгэн хөх үстэй, хөх дэлтэй азарган чоно гэрлээс гарч Ухань хаанд би чамд газарчласугай хэмээжээ. Түүнээс хойш Уханий цэрэг хөдлөвэй. Тэр хөх үстэй, хөх дэлтэй азарган чоно цэргийн өмнө явж, их цэрэг түүнийг даган явав. Түүнээс хойш Ухань хаан хөх үстэй, хөх дэлтэй азарган чоно лугаа дахин учирвай. Чоно Ухань хаанд та цэрэгтэйгээ түргэн морд гэвэй. Ухань хаан даруйхан морджээ. Чоно та олноо дагуулан яв, би өмнө чинь явж танд замчилсугай хэмээжээ. Түүнээс хойш Ухань хаан дахин мордож хөх үстэй, хөх дэлтэй азарган чонотой хамт Шиндү, Тангудыг дайлжээ”*

*Ухань хааны тууж Хань Ру Линий “Эсгий гэрийн түүврээс” дам ишлэв.*

Монголын тал нутагт уулын энгэр бэлээрх тарвага ичээндээ орсон өвлийн эхэн сард өргөн цар хүрээтэй ав хомрог болдог. Туулайнаас том өөх тос ихтэй тарвага нь чонын дуртай идэш, хүнсний гол эх үүсвэрийн нэг юм. Тарвага ичээндээ орсон хойно чоно мал сүрэг рүү улангасан дайрдаг болохоор анчид түүнд тохирох хариуг нь барих хэрэгтэй болдог. Өвлийн эхэн сард чонын арьс үс хөрсжиж, өнгөлөг сортой болдог тул чухам энэ үед агнасан чонын арьс худалдаа бэлтгэлийн цэгт тушаахад хамгийн өндөр үнэ хүрдэг ажээ. Тийм болохоор өвлийн эхээр чоно агнах нь малчдын нэмүү орлогын эх үүсвэр болно. Ав хомрог залуу малчдын хувьд моринд эрэмгий, уурганд хавгай, эр зоригтойгоо харуулах сайхан боломж болдгоос гадна багийн удирдлагын удирдан зохион байгуулах чадвар, цэрэг дайны авьяас зэрэг ямар байгааг харуулдгаараа чухал ач холбогдолтой. Эрт дээр цагт ав хомрог нь тал нутгийн аймгийн ахлагчид, хаад ноёдын аймаг угсааны хэмжээнд цэрэг дайны хээрийн сургууль зохион байгуулах уламжлал болон тогтжээ. Мянган жилийн тэртээх уламжлал өнөөг хүртэл тасалдалгүй ирсэн нь энэ юм. Анхны цас унасны дараа ав хомрогын бэлтгэл ажил үндсэндээ дууссан байдаг. Цасан дээр чонын мөр тодхон үзэгддэг болохоор чонон сүргийн ул мөрөө далдлах санаархал бүтэлгүйтдэг байна. Чоно хэдийгээр урт хөлтэй боловч шинэ цасанд боогдоод төдийлөн хурдалж чаддаггүй тул өөрөөсөө урт чацтай моринд гүйцэгдэхдээ амархан байдаг. Өвлийн эхэн сарын шинэ цас чонын хамгийн барцадтай үетэй давхцдаг болохоор малчид энэ боломжийг ашиглан хүн малд учруулсан хохирлыг бага боловч нимгэлэн, чонын ааг омгийг дарж өгдөг ажээ.

Гэвч тал нутагт тогтсон дэг жаягийг хүн чоногүй сайтар ойлгох болжээ. Сүүлийн жилүүдэд чоно улам хэрсүүжээд жилд нэг удаа болдог ав хомрогын цагийг андахаа больсон тул шинэ цас унаад өвсний сөл тасрах үед чонон сүрэг хилийн чанад руу зугатаах буюу эсвэл цасанд боогдсон аглаг ууланд зээр туулайхан агнаж, бүр арга ядсан үед өлөн гэдэсний өвдөх мэт зовиурыг тэвчин өгөр яс, үдээр шиг арьс химлэсээр өдөр хоногийг өнгөрөөх болжээ. Тэгээд цас дагтаршин хатуурч, хүмүүс ч мартагнах тийшээ хандах үед гарч ирээд мал сүрэг рүү дайрна.

Аж ахуйн захиргааны хурал дээр Өлзий дарга “Түрүү жилүүдийн ав хомрогоор хэдэн залуу чоныг эс тооцвол хашир том чоно бараг агнаж чадаагүй. Үүнээс хойш бид чононоос суралцан тогтсон цаг улиралд биш, чонын санаанд ороогүй үед гэнэдүүлсэн маягтай ав хомрогыг зохион байгуулж байвал зохино. Тухайлбал ав хомрог зохион байгуулдаггүй хавар цагт бид яагаад чоныг хомрогolon устгаж болохгүй байх билээ. Энэ үед хэдийгээр арьсны

чанар төдийлөн сайн байж чадахгүй боловч хөөвөр гуужихаас нэг сарын өмнө байгаа болохоор бэлтгэн нийлүүлэх хоршооноос сумны урамшууллаа авч болох биш үү?” гэж хэлжээ.

Чонон сүрэг цэргийн агтыг хөнөөсөн хор нөлөөллийг арилгах, дээд удирдлагаас Олонбулгийн талын чоныг устгах зааврын үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд аж ахуйн захиргаанаас нийт гишүүдийн хүчийг дайчлан өргөн цар хүрээтэй ав хомрогыг эхлүүлэх шийдвэр гаргажээ. Бао Шүнь Гүй тэр хурал дээр “Одоо хэдийгээр хаврын мал төллөлтийн давчуу ажлын цаг үе болохоор хүн хүч гаргахад хэдий хүчирдэлтэй боловч чоныг авлан устгахгүйгээр бид олон шатны удирдлагадаа хэлэх үггүй болно” гэж хэлсэн ажээ.

Өлзий дарга “Чоно нэг том сүйтгэл учруулсаны дараа хүмүүс өшөөгөө авахаар ирнэ гэдгийг мэддэг тул гол хүчээ ухруулсан байдаг нь түрүү түрүүчийн туршлагаас харахад илхэн байна. Тэд нар одоо хил орчимд бүгчихээд бэлчээр нутагт жаахан л хөдөлгөөн орох юм бол хил даван зугатах нь мэдээж. Тийм болохоор энэ хэдэн өдөртөө тэднийг оролдоод хэрэггүй орхичих хэрэгтэй. Тэгээд идсэн морьдын мах нь гүйцэд шингээд ирэхээр энд орхисон адууны сэгийг заавал санагалзах болно. Тарвага зурам ичээнээс гараагүй цаг болохоор тэд орхисон адууны мах руугаа эргэн ирэх нь гарцаагүй” гэхэд

Билиг өвгөн түүний үгийг толгой дохин зөвшөөрч “Би чоныг төөрөлдүүлэхийн тулд нэг хүнтэй хамт хэдэн хавх тавьсан байгаа. Азарган чоно шинэ тавьсан хавхыг хараад хүмүүс ав хомрого хийхгүй хамгаалалтад шилжжээ гэж төөрөлдөх болно. Урьд нь аж ахуйн захиргаанаас ав хомрого зохион байгуулахдаа нохойны хөл хавчуулагдах вий гээд чонын хавхнуудаа сугалан авдаг байсан. Харин энэ удаа ав хомрогын үед хавх тавьсан болохоор хичнээн хашир азарган чоно ч гэсэн төөрөлдөж таарна. Хэрвээ хэдэн чоно хавханд орчихвол чоно учраа олохоо байгаад адууны махны ойр явж ч чаддаггүй, очиж ч чадахгүй хэцүү хэрэгтэй тулгарах үед нь бид гэнэт хомроголлон дайрваас хэдэн хашир том чоно бүхий томоохон сүргийг агнаж болох юм” гэж хэлжээ.

“Эндхийн чононууд тун хашир хор хаясан, хавх тавьсан газар ойртдоггүй. Хашир чоно, азарган чононууд нь махны хортой хэсгийг хазаж тэмдэг тавиад өлөгчин болон бэлтрэгнүүд түүнд хүрдэггүй. Зарим азарган чоно минийн цэнэгийг сугалах адил хавхыг гаргаад тавьчихсан байдаг ч гэлцэх юм. Энэ бүгд үнэн үү?” хэмээн Бао Шүнь Гүй өвгөнөөс асуулаа.

“Оргүй ч юм биш ээ. Бэлтгэн нийлүүлэх хоршооны зарж байгаа чонын хор дэндүү хурц үнэртэй болохоор нохой ч үнэрийг нь ялгачихаж чадна. Тийм болохоор би нохой хордоод үхчихвий гээд чонын хорыг хэрэглэхэд нэг л сүжиггүй. Би хавх тавих өөрийн гэсэн нандин аргатай тул түүнийг илрүүлэн олдог чоно байх нь юу л бол” хэмээн Билиг өвгөн хариулав.

Аж ахуйн захиргаа штаб болон хувираад үйлдвэрлэлийн асуудлын оронд цэрэг дайны хэргийг хэлэлцэж байгаа мэт Бао Шүнь Гүйд санагдаж байлаа. Тэр жил морин цэргийн сумангийн дарга байсан Өлзийг дээд удирдлагаас аж ахуйн даргаар томилон ирүүлсэн нь нүдээ олж, өөрөө ч эндхийн цэргийн төлөөлөгч болсон нь яв цав тохирсон мэт. Бао Шүнь Гүй үзгээрээ сэнжтэй аягаа цохиод хурлын нийт гишүүдэд хандан “Ингэж тогтлоо” хэмээн хэлэв.

Аж ахуйн захиргааны тогтоолд “Багууд болон хувь хүн аж ахуйн захиргааны зөвшөөрөлгүй бэлчээр нутгийн хойд хэсгээр чоно авлах буюу ялангуяа буу дуугаргаж чоно үргээж болохгүй.

Аж ахуйн захиргаанаас өргөн цар хүрээтэй ав хомрогыг зохион байгуулна. Багууд мэдэгдэл авсаны дараа хөдлөхөд бэлэн байх хэрэгтэй” гэж заажээ.

Багуудын малчид хаврын төл хүлээн авалт, зуны ноос хяргалт, намрын өвс хадлан, өвлийн идэш бэлтгэхтэй адил хариуцлагатайгаар морьдоо сонгон, нохдоо цатгаж, уурга, сэлэм, буу сумаа зэхэж эхлэв.

\* \* \*

Өглөөнөөс авахуулан бараан үүлс алсын уулсын оргил шилийг хучаад Олонбулгийн тал дүнсийн харагдана. Намуухан салхины аясаар агаарт цас бударна. Монгол гэрийн тооноор цухуйх төмөр яндангууд багтраа өвчин туссан хүн бүгшүүлэн ханиах мэт утаагаа тургилж аргал хоргол, унгас ноос хөглөрөх хороо хотыг дүүргэх ажээ. Энэ хаврын хүйтэн урсгал талын энд хоргодчихоод дулаарах шинж огт үгүй мэт. Золоор мал сүрэг тарга тэвээрэг сайтай, хагас хуруу тосон таргаа хадгалсан хэвээр тул цас хайлж өвс цухуйх цагтай мэнд золгож мэдэхээр байлаа. Цасан дор нялх ногоо цухуйсан тул хоньд хөлөөрөө түүнийг малтан идэж өл залгахтай болжээ.

Хоньд хашаа хороондоо тааваараа хивж хэвтчихээд гарах дургүй байцгаана. Гурван хоточ нохой шөнөжин хуцаж хоноод өлсөж даарсан байдалтай гэрийн үүдэнд дагжин зогсоцгооно. Чэнь Жэнь хаалгаа нээн гарахад анч Шар өөдөөс угтан цээж рүү нь цоройн самардаж, эрүүг долоон, сүүлээ шарвагануулах нь идэш хоол гуйж байгаа хэрэг юм. Чэнь Жэнь түмпэнгийн хагас шахам мөлжсөн ясыг тэдэнд хаяж өгөв. Гурван нохой ясыг булаацалдан авч газарт хэвтээд урд хоёр хөлөөрөө дарж, толгойгоо гилжийлгэн тас тас мэрг хазлан залгина.

Чэнь Жэнь махны түмпэнгээс хэдэн хэрчим цул мах аваад Ирвэст хаяж өгөв. Ирвэс үс шингэн гилгэр, хошуу шөвгөр, нуруу сунагар, чац урт, бэлхүүс нарийн гээд аргагүй л Хянган үүлдрийн анч нохойн хэв шинж бүрдмэл ажээ. Хоёр анч нохой хурдан шалмаг хөдөлгөөнтэй, уралцаж ноцолдохдоо гаргуун, ан харсан даруйдаа ороо нь орсон мэт сэргээд ирдэг зантай билээ. Тэр хоёр үнэг барихдаа гаргууд төдийгүй, ялангуяа анч Шар эцэг эхээс ан хийх чадварыг өвлөн авсан ажээ. Тэр үнэгний сүүлэнд хууртагдахгүй шууд угаас нь зууж аваад үнэгийг урагш үхэн хатан чангаахад огцом амаа тавьчихдаг. Үнэг эрчиндээ годройтон унаад амин цэг нь ил гарангуут ухасхийн дайрч хүзүүдэн алаад арьс хөрсийг гэмтээхгүй анч эзнийхээ ганзагыг мялаадаг эрдэмтэй нохой байгаа юм. Харин бүтэлгүй ноход бол үнэгний сүүлэнд хууртан хөлөө гэмтээх, арьс үсийг нь сэглэн анчин эзэндээ зодуулах шийтгэл хүлээх нь ч бий. Анч Шар, Ирвэс хоёр чононоос ч бэргэн айлгүй урцалдан ноцолдож байгаад анчид бусад нохдыг гүйцэн ирэх боломж бүрдүүлдэг.

Анч Шарыг Билиг өвгөн Галсмаа хоёр Чэнь Жэньд бэлэглэсэн бол Ирвэсийг Ян Кө сууж байсан айлаасаа дагуулан иржээ. Олонбулгийн малчид аль өнгөтэй өөдтэй болгоноо Бээжингээс ирсэн илгээлтийн эздэд өгөхийг хичээдэг болохоор хоёр гөлөг өсөж том болоод хавь ойрд алдартай анч ноход болжээ. Хожим Бат, Чэнь Жэнь, Ян Кө хоёрыг үнэгний анд дагуулж явах дуртай болсон нь энэ хоёр нохойн ач тус билээ. Анч Шар, Ирвэс хоёр өнгөрсөн өвөл таван том сайхан үнэг агнасан болохоор Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч гал улаан үнэгэн лоовууз хийлгэн өмсчээ. Цагаан сарын дараа Ирвэс зургаан гөлөг төрүүлсэний гурвыг Билиг өвгөн, Лхамжав болон өөр нэг илгээлтийн эзэн авч одов. Одоо үлдсэн гурвын нэг нь охин,

бусад нь эр бөгөөд хоёр шар, нэг хар паацайсан хөөрхөн юмнууд болжээ.

Угийн няхуур нямбай Ян Кө, Ирвэс болон түүний гөлөгнүүдийг онцгойлон хайрлах тул өдөр болгон шахам ясны шөлөнд өвдөл цөвдөл, шар будаа чанаж тэднийг хооллосоор амуу будааны цэгээс илгээлтийн эздэд олгосон нормыг хэтрүүлж орхих гээд байдаг байв. Тухайн цаг үед Олонбулгийн илгээлтийн эздэд Бээжин хотын жишгээр хүн болгонд сард 15 кг амуу будаа олгох нормтой байсан билээ. Харин нэр төрлийн хувьд Бээжингээс тэс ондоо нь юу гэвэл 1,5 кг хуурсан будаа, таван кг гурил, үлдсэн 8,5 кг нь дан шар будаа байлаа. Тэр шар будааныхаа дийлэнхийг Ирвэст чанаж өгчихөөд илгээлтийн эздэд маань өөрсдөө малчидтай адилхан мах голцуу иднэ. Харин малчдын амуу будааны норм илгээлтийн эздийнхээс таван зуун граммаар бага байжээ. Ясны шөлөнд шар будаа чанаж нохой тэжээх аргыг Галсмаа тэдэнд зааж өгсөн юм. Тэр бүхний хүчинд Ирвэс сүү сайтай тул гөлөгнүүд нь ч бусад айлуудынхаас хавьгүй тарган цатгалан харагдана.

Тэдний хотонд өөр нэгэн жинхэнэ монгол үүлдрийн тав зургаан настай, данхар толгой, баравгар цээжтэй, барсын хүрхрээ мэт дуутай айхтар догшин нохой бий. Түүний хамаг бие сорви дайранд баригдаад, ялангуяа толгой нуруун дээгүүр зурвас зурвас үсгүй халцгай сорви тогтсон нь харахад эвгүй. Монгол нохой уг нь нүдний дээр хоёр шаргал хөмсөгтэй байдаг боловч энэ нохойн өрөөсөн шар хөмсөг чононд уруулан алга болсон тул анх харсан хүнд гурван нүдтэй мэт харагддаг. Чэнь Жэнь, Ян Кө хоёр түүнийг анх харсан өдрөөсөө Арслан хэмээн нэрийдэх болсон билээ.

Энэ хэрцгий догшин нохойг Чэнь Жэнь ханган нийлүүлэх хоршооноос юм худалдан авахаар явах замдаа олж иржээ. Тэр өдөр буцах зам зуур үхэр нь үргэсхийгээд байхаар Чэнь Жэнь эргэн харвал чоно мэт том хар нохой хэлээ унжуулчихаад түүний араас дуу шуугүй дагаж байхыг хараад сүнсээ зайлтал айж билээ. Тэр шилбүүрээр түүнийг хөөж туусан боловч холдолгүй дагасаар гэрт нь хүрч ирсэн юм. Бусад адуучид түүнийг хонь малд ам хүрдэг муу зуршлаасаа болоод эзэндээ хөөгдөн хээр гадуур хоёр жил болсон зэрлэг нохой байгаа юм гэж харсан даруй таньжээ. Тэр ийнхүү хээр талаар явахдаа тарвага туулай ангуучлан, мал адгуус болон чонын сэг зэмээр хооллон явсаар бүр зэрлэгшиж гүйцсэн аж. Хожим нь хэдэн ч айлд урван очсон боловч хонь барьдаг муу зуршил нь арилалгүй хөөгдсөөр байжээ. Малчид түүний урьд нь хэдэн том чоно барьсан гавьяаг санагалзаагүй бол бодийг хөтлөх байсан нь лавтай. Хонь барьдаг нохойг тал нутгийн тогтсон дэг жаягаар үгүй хийх учиртай бөгөөд тийм нохой хээрийн боохойтой нийлчихвэл хотны нохдыг хууран бүр ч илүү хөнөөл учруулдаг гэмтэй байдаг. Малчид түүнийг хөөж явуул гэж байсан боловч Чэнь Жэнь түүнийг харин ч их хөөрхийлөн өрөвдөхийн зэрэгцээ нөгөө талаар ихэд сониучирхан ажиглах болсон юм. Цас мөсөөр хучигдсан хахир хатуу тал нутагт чонон сүрэгтэй ижилсэн амьдарна гэдэг тун их ур ухаан шаардсан хэрэг биш гэж үү? Тэгээд ч Билиг өвгөнийхөөс салж нүүгээд чонын эрлэг Барс байхгүй болсон болохоор найдвартай түшиг тулгуураа алдсан мэт санагдах болоод байсан үе л дээ. Чэнь Жэнь нөгөө малчдад “Өөрсдийнх нь ноход нас залуу болохоор үүн шиг харахад сүрдмээр том нохой маш их хэрэгтэй байгаа юм. Хэрвээ дахин хонь барих юм бол өөрөө төлөх болно” гэж хэлээд үлдээсэн ажээ.

Энэ хэдэн сарын хугацаанд Арслан дахин хонь барьсангүй, өөрийгөө ихэд хичээж байгаа бололтой хонин сүргээс нэлээд зай барьж байхыг Чэнь Жэнь ажиглав. Билиг өвгөний



ярьсанаар бол сүүлийн хэдэн жил хар бор ажил хийхээр ирсэн цагаач иргэд цөөн тоотой эзэнгүй тэнэмэл нохдыг барьж авч алсаар дуусгах дөхөж байна. Тэд нар тэнэмэл нохдыг хоолоор хууран байшин савандаа аваачаад дүүжлэн алаад махыг нь иддэг ажээ. Энэ нохой ч тэдэнд баригдан амь алдахын даваан дээр мултран гарсан бололтой. Тийм болохоор энэ нохой зэрлэг нохойн амьдралаар замнахыг зүрхлэхээ байжээ. Зэрлэг ноход чононоос айдаггүй атлаа нохойн мах иддэг хүнээс айдаг. Энэ нохойн дуу шөнө орой хамгаас илүү сүртэй сонсогдохоос гадна зарим үед ам нь чонын цусанд будагдсан байх үе цөөнгүй. Түүний ачаар Чэнь Жэнь, Ян Кө хоёрын хонин сүрэг чонын хөнөөлийг бага амсах болжээ. Тал нутагт шөнийн манаа, гэр орноо сахих, ан ав хийх нь нохойн гол үүрэг байдаг. Өдөр хонь хариулахдаа нохдыг дагуулан явдаггүй, хавар хургатай хоньдыг чулуун хороонд хашиж ноходтой хавьтуулахыг больсон тул Арслан муу зуршлаа гээхэд ч тус нэмэр болсон бололтой.

Чэнь Жэньгийн гэрийн бусад илгээлтийн эзэд ч Арсланд их л дотно хандан цадтал хооллоно. Гэвч тэр шинэ эзэн өөрийг нь гэртээ авчирсан ачлалд талархсан сэтгэл ер харагдахгүй. Тэр Анч шар, Ирвэс хоёртой эрхлэн наадахгүй, эзнээ хараад сүүлээ шарвагануулна ч гэж бараг үгүй ажээ. Өдрийн сэлүүн цагаар тал хээрээр ангуучлан гүйх буюу эсвэл монгол гэрээс холхон өвсөн дунд хэвтчихээд алс тэнгэрийн хаяаг харуулдан бодлогошрох нь эрх дураар амьдралыг эрэлхийлэх мэт.

Заримдаа Чэнь Жэнь түүнийг нохойноос илүү чонотой төстэй араншинтай болохыг нь олж харах шиг болно. Нээрэн ч чоно бол нохойны өвөг шүү дээ. Хятадын баруун хойд нутагт амьдарч байсан Цуань Рун хэмээх нүүдэлчин үндэстэн өөрсдийн өвөг дээдсийг хоёр цагаан нохой байсан гэж үзэж нохойг сүлдээ болгон дээдлэдэг байжээ. Түүнийг сонсоод хүчирхэг тал нутгийн үндэстэн яахаараа өөрсдийн гаршуулсан нохойг сүлдээ болгодог билээ хэмээн гайхширч байсан нь бий. Магадгүй хэдэн мянган жилийн өмнө нохойны зан араншин чоныхоос өөрцгүй догшин ширүүн байсан эсэхийг хэн мэдлээ. Эртний Цуань Рун үндэстний шүтээн цагаан нохой нь тэгэхээр цагаан чоно ч байсан юм бил үү? Арай өөрийнх нь олж ирсэн энэ том хар нохой чонын зан араншингаа гэж чадаагүй юм болов уу гэж ч заримдаа бодно. Ямар ч байсан түүний зан араншинд өвөг шинж нь түлхүү илэрчээ.

Чэнь Жэнь үргэлж л түүнд ойртон үсийг илбэн, хүзүүг маажих боловч нүд нь гөлийчихөөд сүүлээ үл мэдэг шарвагануулахаас өөр ямар нэгэн хариу үйлдэл бараг хийхгүй. Түүнд хүний хайр энэрэл, бусад ноходтойгоо ойлголцох хэрэггүй мэт, чухам юу хүсээд байгааг Чэнь Жэнь огт ойлгохгүй. Яавал түүнийг анч Шар, Ирвэс хоёртой адилхан сэргэлэн цовоо, хүний хайр энэрлийг дааж, насан туршдаа санаа зовохгүй амьдруулж чадах бол гэдгээ ч тэр мэдэхээ больжээ. Арай тэр нохойн амьдралаас уйдаад чонын амьдрал руу тэмүүлээд байдаг юм биш байгаа даа гэж Чэнь Жэнь нөгөө талаас нь ургуулан бодох ч үе бий. Хэрвээ тэр чонон сүрэгтэй нийлчих юм бол мал сүрэгт тун халтай хэрэг болох юм. Харин түүний хувьд чоно нохойн аль аль нь хүлээж авахгүй буюу өөрөө аль алинтай нь нийлье гэж бодохгүй байгаа нь хамгийн том эмгэнэл гэлтэй. Тэр нохойн хэв шинж бүрдсэн чоно, эсвэл чоно нохойн араншинг тал талаар нь өөртөө шингээсэн амьтан юм болов уу гэж бодох боловч тоймтой хариуг олж чадахгүй. Ямар ч байсан түүнд сайнаар хандан, алгуур ажигласаар сайн нөхөд болохыг эрмэлздэг байлаа.

Чэнь Жэнь нөгөө хоёрыгоо босоод нохдыг залгуулан хооллож, гөлөгнүүдтэй тоглон сэтгэлийн

хөдөлгөөн багатай Арсланг эрхлүүлэхийг хүлээлээ.

\* \* \*

Нэг ангийн дөрвөн нөхөр тоонот гэрт толгой холбон амьдраад жил гаруй болжээ. Тэдний хоёр нь хоньчин, бусад нь адуучин, үхэрчин хийдэг байлаа.

Дайчин нямбай зантай Жан Зи Юань адуучин болоод Бат, Лхамжав хоёртой хамт таван зуу гаруй адуу маллана. Адууг үхэр хоньтой бэлчээр булаацалдуулахгүйн тулд байнга шахам алсын оторт гарах хэрэгтэй болдог. Айл хунараас хол араатан чоно хөлхөлдсөн аглаг уул, атар онгон талд хоёр хүний бөгс эргэх зайгүй шахам отрын гэрт жижиг төмөр тулганд цай хоолоо бэлдэн, жинхэнэ эрт балрын хэв шинжтэй амьдрах нь олонтой. Адуучны ажил аюул эрсдэлтэй, хариуцлагатайн хэрээр бусад малчдынхаа дунд нэр хүндтэй, морин дэл дээрх үндэстний бахархал болсон мэргэжил билээ.

Морь уургалах нь харууштай, амаргүй арга техник болохын хувьд чоно барих, намнах гоц нарийн зэвсгийн эрдмийн төрөлд тооцогдож болох юм. Адуучин хүн унаа юүлэх, адуу дэллэх, агтлах, даага сарваа сургах гээд тэр болгонд уурга хэрэг болно. Эртнээс нааш тал нутгийн үндэстнүүд адуу уургалахдаа хавтай бөгөөд мориныхоо нуруун дээр урт уургаа суналзуулан давхиж, завшааныг анаж байгаад уурганыхаа хуйвыг адууны хүзүүнд углахдаа алдана гэж бараг үгүй. Энэ аргаар хурдан морьтой анч нохойгоор хань бараа болгосон тохиолдолд чононд дөхөж очиж байгаад уургалж болдог. Уургалсан чоныг гулдран чирсээр анч нохойгоор бариулан алдаг тул тал нутгийн чоно уурганаас үхтлээ айдаг. Уурга барьсан адуучныг харахаараа ухаан зулаггүй зугатах буюу бут сөөгөнд нуугдан амь гарахыг бодно. Чоно өдөр бүгэн нуугдаж байгаад шөнө анд гардаг нь уургатай холбоотой гэж Чэнь Жэнь боддог байлаа. Уурга нь хэдэн мянган жилийн өмнө үүссэн болохоор талын чонын ааш араншинд нөлөөлөхөөр урт хугацаа өнгөрсөн байж таарна.

Чэнь Жэнь урьд нь сонин сэтгүүл дээрээс бусад аймаг хошуудын малчдын хэрэглэдэг уурганы зургийг цөөнгүй харж байсантай харьцуулахад Олонбулгийн малчдын уурга уран нарийн хийц, эдэлгээ даах чадвар зэргээрээ хамаагүй давуу мэт санагддаг байв. Олонбулгийн тал монголын алдарт Унаган голын сав газрын хойхонтой оршдог, түүхэн дэх монголын алдарт хурдан Үзэмчин үүлдрийн морьдын гол нутаг билээ. Морь бол монголчуудын оршин амьдрахуйн гол хань бараа, дайчин анд нөхөр байсаар ирсэн болохоор уургандаа хүндэтгэлтэй хандах нь ч аргагүй юм. Олонбулгийн уурга ердийнхөөс хавьгүй урт гилгэр шулуун байдаг. Хоёр урт зассан хус модыг залгаж хийсэн урт уурга тав зургаагаас долоо найман метрийн урттай байх бөгөөд Чэнь Жэнь есөн метр урт уурга ч үзэж байсан удаатай. Урт байх тусмаа чоно уургалахад дөхөм байх нь ойлгомжтой. Тэгш уурга үе булцуугүй хулс модтой төстэй харагддаг. Адуучид уургыг засаж боловсруулахдаа яр булцууг харуулдан тэгшлэх бөгөөд зарим тахир муруйг нойтон үхрийн баасаар шавж дэвтээгээд хүнд юмаар даруулан тэгшилдэг.

Адуучид морин дэл дээр уургаа барин давхихад давхил дунд хуйвандаа дийлдэн үзүүр нь нахилзаж, амьд могой хөдлөх мэт. Талын чоно ижил сүргийн бусад гишүүдийгээ уурганд чирэгдэн үхэхийг харсан нь цөөнгүй байж таарна. Тэдний нүдэнд уурга гэдэг урт гүрвэлзэх могой мэт харагддаг байж таарна. Тал нутагт гэгээн цагаан өдөр морь унаад ганцаараа

явахдаа гартаа уурга л барьсан бол хөгшин хөвөө хэн ч байлаа гэсэн тэнгэрийн сахиусыг залсан мэт чонон сүргийн өмнүүр омог бардам явах эрхтэй болдог.

Адуучин болоод жил тойрсон атлаа Жан Зи Юань морь уургалахдаа адууны толгойг онож өлгөх нь ховор тул унасан хүлгээ юүлж чадахгүй Батын гарыг харах нь олонтоо. Хааяа нэг эмнэг догшин адуу уургалчихаад эвийг нь олж арагш цахлан сууж чадахгүйн улмаас уургаа цуг алдаад хэдэн хэсэг хугачуулах явдал ч тохиолдоно. Тэр хонь уургалж сургуулилах гээд үргээж сандчаан, эм хонины хээл хаяулах шахаад Билиг өвгөнд зад загнуулсанаас хойш дахин хавьтахаа байсан юм. Хожим өвгөн түүнийг үхэр тэрэгний арлын толгойг уургалж сургуулил гэснээр овоо гаршиж, одоо хамт байгаа гурвынхаа морийг төвөггүй уургалчихдаг болсоны хүчинд том давааны ард гарчээ. Жан Зи Юань гэртээ тогтоно гэж бараг үгүй. Сардаа ганц долоо хоног л гэртээ байвал их юм. Гэртээ ирээд үхсэн мэт баахан унтаж байгаад босохоороо уулзаж учирсан хүн, морь, чонын тухай яриа дэлгэнэ.

Адуучид энэ тэрүүгээр их явдаг болохоор үзэж дуулсан нь ч чамгүй их. Багаас тэдний мэдэлд найм есөн морь зүсэлж өгөхөөс гадна, сүргийн дундаас аль дуртайгаа унах эрхтэй байдаг. Адуучин хүн өдөртөө нэг хоёр удаа унаа юүлэх тул морины хүчийг нөөлгүй хүссэн газраа довтолгоод л оччихно. Адуучдын очсон айл болгон тэднээс унаа юүлээд өгөөч, захиа занга байна шүү, эмч дуудаад өгөхгүй юу, сураг занги байна уу гээд л гуйлга тасрахгүйгээс гадна тэдэнд охид хүүхнүүд их л талтай байдаг болохоор дөрөв тавхан морины мэдэлтэй үхэрчин, хоньчингууд тэдэнд атаархана гэж жигтэйхэн. Гэхдээ адуу маллана гэдэг амь насанд ч халтай хэцүү ажил тул цэргийн хүн чононоос дутуугүй овсгоо самбаа, эр зориг тэсвэр хатуужил, эр бяргүй л бол багийн зүгээс адуучин болгоно гэж горьдолтгүй. Мань дөрвийн дундаас нэг нь адуучин болсон нь харин ч их юм болохоор нөгөө гурав нь горьдоод ч ямар нэмэр байх билээ. Чэнь Жэньгийн цуглуулдаг чонын тухай аман ярианы дийлэнхийг Жан Зи Юань түүнд ярьж өгсөн юм. Жан Зи Юанийг буцаж ирэх болгонд Чэнь Жэнь амттай шимтгэй бүхнийг түүний өмнө дэлгээд чонын тухай сонирхолтой яриаг хөврүүлнэ. Адуучин хүн чонотой тэмцэх фронтын тэргүүн шугамд байгаа болохоор түүний тухай их л зөрчилтэй ойлголтыг өвөрлөж явах нь бий. Тийм болохоор Чэнь Жэнь, Жан Зи Юань хоёр дээр заримдаа Ян Кө нэмэгдчихээд шөнөжин маргалдах нь ч энүүхэнд. Жан Зи Юань адуун сүрэг рүүгээ буцахдаа Чэнь Жэнь, Ян Кө хоёроос ганц хоёр ном зээлж аваад явна.

Гао Зянь Жун зуун дөчин үхэр хариулдаг. Үхэрчин гэдэг биед их амар ажил тул тал нутгийн малчид үхэрчний ажлыг сумын даргын албаар ч солихгүй гэлцэх нь бий. Тугалнуудаа гэрийн үүд бараадуулан адууны дэлээр томсон дээсээр уячихад үнээнүүд орой хүрч ирээд хөхүүлнэ. Харин амбан шарнууд л өвс усны соргогийг эрж хайгаад гэртээ ирэхгүй алга болчих тохиолдолд байдаг тул алдагдсан үхрийн эрэлд гарна гэж нэлээд төвөгтэй ажил байдаг. Үхэр нэг гөжүүдлэхээрээ хүзүүгээ гүрдийлгэн, нүдээ улаанаар эргэлдүүлээд яаж ч ташуурдлаа гэсэн газарт шаасан гадас шиг хөдлөхгүй зогсон, малчин эзнийхээ уурыг барах тохиолдол ч хааяа бас бий. Гэхдээ үхэрчид чөлөөт цаг ихтэй байдаг болохоор хоньчин, ямаачин нар ажил төрөл барагдахгүй үедээ тэдний тус дэмийг авна. Тэргэнд хөллөж нүүдэл суудал хийх, сааль сүүг сааж цагаан идээ бэлтгэх, аргалыг түлэх, арьс үсийг ашиглах, махыг нь идэх гээд тоочоод байвал үхэргүй бол монгол айлын амьдрал хэцүүдэх тул морин дэл дээрх үндэстний айл гэрийн амьдрал үхрийн нуруун дээр тогтдог гээд хэлчихвэл нэг их хилсдэхгүй болов уу. Үхэрчин, адуучин, хоньчин, ямаачид тус тусынхаа мөрийг хөөж яваа мэт боловч ямар нэгэн

гүн сэжмээр салшгүй холбогдсон байдгийг энэ жишээ бэлээхэн харуулах буй за.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр хамтдаа 1700 гаруй хонь малладгийн дийлэнх нь Олонбулгийн ууцан сүүлт хоньд юм. Цэлцгэр том сүүл нь тослог атлаа идэхэд шандуун бус, мах нь амттай агаад шивтэргүй зэрэг онцлогтой. Өлзий даргын ярьдагчлан “Олонбулгийн талын бэлчээрийн өвсний шим тэжээл аймагтаа толгой цохидог тул эндхийн хонины махны чанар сайн байдаг” ажгуу. Эрт дээр цагт хаанд ийм хоньдоор алба барьдаг байсан тул Хубилай хаан Бээжинд нийслэллэн суусны дараа Олонбулгийн хоньдоор зоог шүүсээ бэлдүүлдэг байжээ. Өнөө ч гэсэн улсын удирдагч нар ард түмний хурлын их ордонд арабын улсуудын төрийн тэргүүн нарыг дайлахдаа Олонбулгийн хонины махыг хэрэглэдэг тул цаадуул нь улсын их хэргийг хэлэлцэхээ умартан төрийн зоогонд хаанахын ямар мах хэрэглэсэн бэ хэмээн асуудаг гэлцдэг. Олонбулгийн чононууд том биетэй, хүнээс дутуугүй ухаантай байдаг нь эндхийн хонины сүүл их зооглосонтой холбоотой байх гэж Чэнь Жэнь хааяа боддог байлаа. Сүрэгт Шинжааны нарийн ноост хонийг нутгийн шилмэл омгийн хоньтой эрлийзжүүлэн гаргаж авсан өөр нэг ноосны чиглэлийн сайн үүлдрийн хоньд байдаг нь нутгийн хоньдоос гурав дөрөв дахин их үнэ хүрдэг боловч мах нь сулбагар амт муутай гээд эндхийн малчид төдийлөн тоож иддэггүй.

Хорь гучин хоньдод ганц оногдохоор цөөн тоотой хэдэн ямаа байдаг. Ямаа хэдийгээр өвсний үндсийг ухаж төнхөн бэлчээр сүйтгэдэг халтай боловч ноолуур нь өндөр үнэтэйгээс гадна, хурц эвэртэй сэрхнүүд чонотой айхгүй үзэлцэж чаддаг тул хонин сүрэгт цөөн тооны ямаа байлгаснаар ганц нэг чонын халдлагаас хамгаалахад тустай байдаг ажээ. Тийм болохоор монголын хонин сүргийн манлайд хэдэн сэргэр эвэртэй ямаад явдаг нь ийм учиртай билээ. Ямаа гэрсэг өвсний сайн мууг андахгүйн дээр чоно дайрахад чанга майлан, эзэндээ сэрэмж өгдөг. Харин хоньд бол аймхай мулгуу талдаа болохоор чоно гэдсийг хүүлж байсан ч дуу шуу гаргадаггүй. Монголын малчид тал нутгийн түмэн бодисын хөгжлийн онцлогийг гаргууд шинжин, хоорондохь зөрчлийн ашигтай талыг аль болохоор ихэсгэн, гэм халтай талыг аль болохуйц бага түвшинд барьж чадсаныг Чэнь Жэнь олж мэдсэн юм.

Хоёр хоньчин ээлжлэн хонины хишигт явж, үлдсэн нь шөнийн манаанд гардаг. Шөнийн манаанд гарсан нь хонины хишигт явсанахаа наян хувьтай тэнцэхүйц цалинг авна. Хоёр хоньчин хоорондоо зохицоод нэгийгээ өөр ажил албатай үед нөгөөх нь нэг хоёр өдрөөр ч хонины хишиг, шөнийн манааны албыг бүрэн хариуцан гүйцэтгэх явдал бишгүй нэг тохиолдоно. Хэрвээ хороо хашаа бат бөх, хоточ сайн ноходтой бол хаврын улирал шөнийн манаанд гаралгүй унтаад өгсөн ч болно. Харин зун, намар, өвлийн цагт үхэр тэрэг, шон зэргийг эсгийгээр бүрхэн босгосон явуулын хашаа хороонд хонио хаших тул чононоос сэргийлэн заавал шөнийн манаанд гарахгүй бол болохгүй. Чонын халдлага ширүүн үед шөнийн манаанд гарна гэдэг тун амаргүй хэрэг болон хувирна. Гар чийдэнгээ асаачихаад нохойгоо дагуулан хонины хашаагаа эргэж шөнөжин хоолой сөөтөл хашгирч хонох ч энүүхэнд. Шөнийн манаанд гарах нь чононоос сэргийлж байгаа хэрэг бөгөөд нийт малчдын хөдөлмөр өдрийн хөлсний гуравны нэгтэй тэнцдэг тул үнэн хэрэг дээрээ чононд зориулж байгаа мөнгө юм гэж Өлзий дарга байнга ярьдаг. Шөнийн манаанд гарна гэдэг ихэвчлэн эмэгтэйчүүдэд оногддог тул өдөр нь гэр орны хүнд ажилтай зууралдан өнждөг тэд нар жилийн дөрвөн улиралд тухтай унтаж амрах үе гардаг болов уу. Шөнийн явдалтай чоно, өдрийн ажилтай хичнээн олон айлын хэдэн үеийн бүсгүйчүүдийг ийнхүү хөлдөө чирэн зовоосон бол доо.

Тийм ч учраас монгол айлын эзэгтэй нарын олонх нь эмгэг хуучинд баригдаж, идэр залуухнаараа хорвоог орхих нь байдаг боловч тэр болгоныг даван туулсаар төмөр мэт бие бялдартай болсон нь ч цөөнгүй байдаг. Хөх чоно үржих чадвар сайтай бол тал нутгийн хүн ардын өсөлт тэр болгон түүнийг гүйцэж чаддаггүй. Харин ч эсрэгээр тал нутгийн монгол үндэстэн эртнээс нааш хүн амын хэт өсөлтөнд автаж байгаагүй болохоор хүнсний хомсдолд айхгар учирч байсан нь үгүй билээ. Энэ утгаар нь авч үзвэл чоно тал нутгийн хүн амын хэт өсөлтийг хязгаарласаар ирсэн ажээ.

Махыг нь идэж, арьс нэхийг өмсөн, хорголыг түлж, хариулсан эзэд нь өдөр шөнийн хорин дөрвөн цагт хөдөлмөр өдрийн хөлс авчихдаг болохоор хонин сүрэг бол тал нутгийн мал аж ахуйн үндэс, эрт дээр цагаас нүүдлийн амьдралын үндсэн баталгаа болсоор иржээ. Хавь ойрын хэдэн арван километр газар хүний бараа харагдахгүй уудам тал нутаг ногоон цагаан аль ч хүрмээ өмссөн ялгаагүй өглөөнөөс орой болтол хонин сүргээ бараадан явдаг болохоор хоньчин гэдэг уйтгартай нэгэн хэвийн зүдгүүртэй ажил билээ. Ярьж хөөрөх ч хүн байхгүй, чоно хүрээд ирэх вий гэж сэртэлзээд тухтай ч ном унших боломж тэр болгон гардаггүй юм. Чэнь Жэнь заримдаа өөрийгөө ихэд өтлөөд Сү Үгээс<sup>9</sup> ч илүү өвгөрсөн мэт бодогдох үе цөөнгүй. Мянга түмэн оныг ардаа орхисон тал нутаг бахь байдгаараа боловч хүмүүс балар эртний тэр л хэв маягаар нүүдэллэн, чонотой тэмцэлдсээр атлаа эцсийн шийдвэрлэх ялалтыг байгуулж чадаагүй л байна. Тэр заримдаа өөрийгөө тал нутагт тэнүүчлэн ирсэн синантроп хүн чонотой тулалдаж байгаагаар төсөөлөх дуртай. Тийм ч учраас хэзээ нэгэн өдөр гартаа элчийн тэмдэг барьсан Сү Ү эсвэл ангийн арьс хэдэрсэн синантроп хүний аль нэг нь өглөөний манан дундаас гараад ирлээ гэхэд тэр төдий л их гайхахгүй буй за. Харин тэд анх уулзан учрахдаа дохио зангаа ашиглан ярих эхний сэдэв нь мэдээжийн хэрэг чоно байх болно. Олонбулгийн талын цаг хугацаа чулуужиж орхисон мэт минут секундын ч алдаа заана гэж үгүй. Чухам юу энэхүү онгон ариун талын эрт балрын унаган төрхийг чухам энэ л янзаар нь хадгалуулж чадна вэ? Арай дахиад л нөгөө чоно биш биз?

\* \* \*

Хонь хариулах алба Чэнь Жэнийг уудам талд гагцаар суугаад бодлын хөлгийг сэлүүн тэнгэрт зоргоор дүүлэн нисгэх боломж олгодгоороо бас ч гэж давуутай юм. Тэр өөрийн Бээжингээс авчирсан хоёр чемодан номуудаас гадна Ян Көгийн нэг чемодан түүхийн шилдэг ном болон бас бус хориотой номуудыг уншиж амжсан төдийгүй идсэн өвсөө эргүүлэн хивдэг хоньд лугаа адил тэднийхээ утга агуулгыг бэлчээр дээр эрэгцүүлэн боддог байлаа. Ийнхүү эрэгцүүлэн бодох зуур эртний судар номуудад нялх ногоо лугаа адил шим шүлт чамгүй их байх шиг санагдана. Өдөр хонины хишигт явахдаа Чэнь Жэнь ийнхүү хоног хугацааг эргэцүүлэл бясалгалын дунд өнгөрүүлнэ. Заримдаа эргэн тойронд чоно гарцаагүй байхгүй гэдгийг мэдсэн тохиолдолд хэд гурван хуудас ном гүйлгэн унших нь ч бий. Билиг өвгөний хэлдэгчлэн монгол хүн болон монголын талыг ойлгохын тулд эхлээд заавал чоныг таньж мэдэх хэрэгтэй гэж үү? Түмэн оны тал нутаг унаган төрхөө хадгалан урагш хөгжилгүй, тал нутгийн үндэстэн том үндэстнүүдийн эгнээнд шилжин ордоггүйн нууц бас л чонотой холбоотой юм болов уу? Энэ тун ч магадлалтай байж мэдэх юм. Адаглаад л чонон сүрэг жил бүр хөдөө талынханд шууд болон дам асар их хохирол учруулж, мал аж ахуйд анхны хуримтлал үүсгэх бололцоо олгодоггүй тул бүдүүлэг нөхөн үйлдвэрлэлийн түвшинд эргэцэн, бахь байдгаараа байж, худалдаа, арилжаа, газар тариалан, аж үйлдвэрийг хөгжүүлэх

хангалттай хөрөнгө мөнгө, хүн хүч гаргана гэж ярилтгүй болно. Ингээд бодохоор чонотой холбогдох асуудлын хүрээ хязгаар дэндүү өргөн ажээ. . . . . Гэсэн атлаа чоныг таньж мэдэх гэдэг бас л дэндүү хэцүү хэрэг хэвээр байсаар. Чонын улианыг сонсож болохоос бус, очоод ажиглах боломж бараг үгүй. Тийм болохоор Чэнь Жэнь ойрын өдрүүдэд нэг бэлтрэг барьж тэжээвэл өглөөнөөс орой болтол, нялх балчраас өсөж том болох хүртэл нь сайтар ажиглан судалж болох биш үү гэсэн нэг бодол улам хүчтэй төрөх болсон юм.

\* \* \*

Тэр хэд хоногийн өмнө хурга зуугаад зугатдаг өлөгчин чоно болон түүний хаана байгаа нь эс мэдэгдэх хэдэн бэлтрэгний тухай бодож эхлэв.

Тэр нэгэн өдөр хонио сайтар ажиглан харваас амар жимэр байх тул өвсөн дээр дээш харан хэвтчихээд энгүй тэнгэрийн уудамд элин халин нисэх талын бүргэдийг ажиглан харж байсан билээ. Гэтэл гэнэт хоньд үргэн хуйлрах чимээнээр цочин өндийгөөд харвал нэг том чоно хонин сүрэг рүү дайран орж, нэг хурганы хүзүүнээс зуун аваад ар нуруун дээрээ шидчихээд, хургыг зуугаастай хэвээр толгойгоо гилжийлгэн жалга дагасаар Хар чулуут уулыг чиглэн бараа сураг тасарч билээ. Ганц хурганы цангинасан майлаан хэдэн зуун хонь хурганы дуу дуугаа авалцсан их найрлыг өдөөх чадалтай байдаг. Гэтэл чоно хурганы хоолойноос зуугаад дуу гаргах сөхөө өгөөгүй ажээ. Чоно чимээ аниргүй яваад өгсөн тул хонин сүрэг урьдын адил нам тайван болж ихэнх хоньд сая чухам юу болсныг мэдсэн шинжгүй байлаа. Хургаа алдсан хонь ч бас юу ч мэдээгүй өнгөрчээ. Чэнь Жэнь дүүлэн нисэх чадвартай хулгайч харсаар байтал мөнгөний хэтэвчийг нь булаагаад одсон мэт бүр алмайрч хоцорлоо.

Амьсгаа нэлээд намжсаны дараа тэр морио унан чонын гарч ирсэн газарт очиж үзвэл нэг хонхрын өвс чонын хэвгэрт налжээ. Хэрвээ чоно хол газраас нааш мөлхсөн бол Чэнь Жэнь олж харах нь дамжиггүй байсан юм. Тэгэхээр өлөгчин чоно энэ газар аль эрт ирж нуугдчихаад хонин сүрэг боломжтой байрлалд нь ойртон ирэх агшинд ухасхийн дайрсан байж таарах нь. Чэнь Жэнь нарны байдлаар баримжаалан үзвэл мөнөөх чоно лавтай гурван цаг тэсвэртэй хүлээжээ. Өдийд өлөгчин чоно хурга барьж бэлтрэгнүүддээ ан барих аргыг заах хэрэгсэл болгодог. Нөгөө талаар хурганы мах нүдээ нээгээгүй бэлтрэгнүүдийн хувьд зөөлөн шимтэй хоол болж өгдөг юм.

Чэнь Жэнь уурандаа багтрах шахаж байсан боловч нөгөө талаар дотроо олзтой мэт бодогдож байв. Учир юу гэвээс Ян Кө тэр хоёр тав гурав хоноод л нэг хурга алдаад байсныгаа талын бүргэд болон тас шувуудтай холбон сэжиглэсээр байжээ. Тэр золигнууд хүүе хаая гэхийн зуургүй доош шунган нисэж ирээд, хөөрхий хургыг агаарт аван одно. Гэвч бүргэд доош шунган нисэхдээ хонь мал үргээж их л сүртэй юм болдог болохоор малчин эзэн нь харахгүй байна гэж үгүй. Тийм болохоор мань хоёр энэ хэргийн учрыг олж ядан байжээ. Харин Чэнь Жэнь өөрийн нүдээр чоно хэрхэн хургыг барьж байгаа болон түүний хэвтэж байсан хонхрыг олж тогтоосноор дээрх тайлагдашгүй оньсогоны нууц олдлоо.

Малчид яаж ч сануулан сэрэмжлүүлж байлаа гэсэн Чэнь Жэнь алдаа гаргахгүй байж яахин чадах билээ? Цэргийн мэх цээргүй гэдэгчлэн талын чоно тухайн орчинд тохирсон арга мэхийг сонгон олж чаддаг. Чононд бүргэдийн жигүүр байхгүй боловч тал нутгийн дүүлэгч хулгай хэмээвээс чухам чоно ажээ. Тэр хүний нүдийг бүлтийлгэн, анхаарал сэрэмжийг чинь

дээшлүүлэхийн хэрээр ухаарал нэмнэ.

\* \* \*

Чэнь Жэнь Арслангийн хүзүүг маажихад цаадахь нь төдийлөн тааламжтай бус байгаа янзтай.

Агаарт цас будрахад Чэнь Жэнь гэрт явж ороод Ян Кө, Гао Зянь Жун хоёртой тулгаа тойрон суугаад цайндаа мах хөшиглөн, Галсмаагийн өгсөн хуруудыг идэцгээв. Чэнь Жэнь энэ завшааныг ашиглан цаад хоёрыгоо хамт явцгааж бэлтрэг суйлья хэмээн ятгав. “Бид цаашид чонотой тулгарч тулалдах нь тодорхой тул эртхэн нэг бэлтрэг олж тэжээгээд чонын зан чанарыг ойлгож авбал дайснаа улам илүүтэй таньж мэдэж болох биш үү?” гэсэн шалтгийг тэр гаргаж ирлээ.

Гао Зянь Жун тулганд мах шарангаа их л төвөгшөөнгүй янзтай “Бэлтрэг суйлна гэдэг ч тоглоом биш шүү. Хэд хоногийн өмнө Лхамжав тэд нар бэлтрэг суйлах гэж чонын үүрийг угаж байтал өлөгчин чоно дайран гарч ирээд гарыг нь тас хазах шахсан байдаг шүү. Гурван том эр долоон нохойтой арайхийж тэр чоныг алсан байна лээ. Чонын үүр их гүн болохоор тэд нар хоёр өдөр ноцолдож байж бэлтрэгнүүдийг гарган авсан гэдэг. Хургаа харамласан хонь эзнээ мөргөх нь байдаг байхад бэлтрэгээ хамгаалсан чоно амь дүйн тулалдах нь гарцаагүй. Бидэнд ядаж буу байх биш, төмөр хүрз малиагаар түүнийг яахин дөнгөх вэ? Чонын үүрийг ухна гэдэг ч амаргүй хэрэг байна лээ шүү. Түрүүчийн удаа би Санжаатай хамт хоёр өдөр чонын үүр малтаад адагт нь хүрч чадаагүй юм даг. Арга ядаад гаднаас нь баахан угаж байгаад таглаад явчихсан. Аягүй бол тэр хөөрхий бэлтрэгнүүд угаанд бүтээд үхсэн байхыг хэн мэдэх билээ? Өлөгчин чоно биеэрээ нүхээ таглаж хэвтчихдэг болохоор алзахгүй гэж Санжаа хэлж байсан л даа. . . . .Тэгээд ч чоно тун зальтай амьтан болохоор бэлтрэгтэй үүрийг олж очно гэдэг тун амаргүй. Арван чонын үүрний ес нь хоосон гэж малчид хэлэлцдэг. Тэгээд мөртлөө байнга нүүж сэлгэж байхыг яана гээч. Малчид хүртэл арга яддаг ажлыг бид бүхэн яаж барах вэ?” гэлээ.

Ян Кө харин их л уриалгахан байдалтай “Би чамтай цуг явна аа. Надад үзүүрийг нь ирлэсэн гарт эвгэйхэн богино төмөр царил байгаа. Чи бид хоёр ганц өлөгчин чоныг барахгүй байхдаа яадаг юм бэ? Дээр нь чинжаал хутгаа хэдэн цаасан буутай авч явдаг юм шүү. Чичиж сүлбээд, тэслэж дэлбэлж байгаад ганц муу чоныг хөөгөөд явуулчихалгүй хаачдаг юм бэ? Хэрвээ хоёулаа нэг том боохой агначихвал мөн мундаг аа” гэхэд

Гао Зянь Жун ихэд егөөдсөн байдалтай “Сайхан сэрүүн зүүдлэж байна аа. Нүд амаа сэглүүлж, чонын галзуу өвчин тусчихвал наад амь насанд чинь тулсан хэрэг болох байлгүй” гэв.

Ян Кө толгой сэжлээд “Зүгээр дээ, би ч их хувьтай хүн шүү. Сургууль дээр бүлэг зодоон болоод бид тавын дөрөв нь шархадчихаад байхад би ганцаараа зүгээр гарсан юм даг. Айж бэргээд байвал аливаа ажил урагшлахгүй шүү дээ. Манай хятадууд чам шиг аймхай хулчгар болохоор нүүдэлчин үндэстэнгүүд байнга л шахам дотор газрыг эзэгнэн суудаг байсан шүү дээ. Лхамжав өөрийгөө махсаг чоно, биднийг өвс иддэг хонь гэдэг биш үү? Бид харин өөрсдөө бэлтрэг суйлаад аваад ирвэл тэр юу гэхийг нь харья л даа. Би өрөөсөн нүдээ алддаг байлаа ч хамаагүй энэ бооцооны төлөө үзээд алдана” гэлээ.

“За тохирлоо шүү. Харин үгнээсээ буцавзай” гэж Чэнь Жэнь санууллаа.

Ян Кө аягаа ширээ рүү тавиад чанга дуугаар “Хүүе, тэгээд хэзээ явах юм бэ? Шалавлахгүй бол аж ахуйгаас биднийг чонын ав хомрогонд дайчлаад явчихна шүү. Би хувьдаа тэр ав хомрогонд оролцохыг маш их хүсэж байна” гэлээ.

“Тэгвэл хоолоо идчихээд явъя. Эхлээд сайтар тандах хэрэгтэй” гээд Чэнь Жэнь босов.

Гао Зянь Жун амаа шудраад “Одоо бас Гомбод хонины ээлжээ ацаглаад дахин нэг хөдөлмөр өдрийн хөлс байхгүй болов оо, хөөрхий” гэв.

Ян Кө их л дамшигласан янзтай “Түрүүчийн удаа Чэнь Жэнь бид хоёр тэрэг дүүрэн цагаан зээр ачиж ирсэн маань хэдэн хөдөлмөр өдрийн хөлстэй тэнцсэн билээ дээ? Дандаа л хорголоо тоолж байдаг юм шүү” гэлээ.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр морио эмээллэх гэж байтал Баяр шарга морьтойгоо давхин ирээд “Өвөө Чэнь Жэньг гэртээ хүрээд ирээч гэж байна” хэмээн хэл дуулгалаа. Чэнь Жэнь “Аав намайг дуудуулсаныг бодоход их л чухал хэрэг болж дээ” гэв. Ян Кө өгүүлрүүн “Аягүй бол чонын ав хомроготой холбоотой хэрэг байж таарна. Чи хурдан очоод далимаар нь бэлтрэг суйлах арга ажиллагааны нууцыг асууж мэдээд ир” гэжээ.

Чэнь Жэнь даруйхан мориндоо мордлоо. Баярын нуруу намхан тул Ян Кө түүнийг өргөн мордуулах гэтэл зөвшөөрсөнгүй үхэр тэрэгний арал дээр гишгэж байгаад өөрөө мордон Чэнь Жэньтэй дөрөө харшуулан давхин одов.



## Найм

*Зүүн Хань улсын Мин Ди хааны үед Вэнь Шань Зюнээс баруун тийш Бай Лан (Цагаан чоно) Фань Мү. . . . зэрэг зуун гуч гаруй түмэн өрх, зургаан зуу гаруй түмэн иргэн сайн дураараа харьяат нь болцгоожээ. . . . Тэд гурван бүлэгт шүлэг зохион Хань улсын хаанд өргөвэй. . . Тэдгээрийг нийлүүлээд “Цагаан чонын дуу” хэмээн нэрлэжээ. Түүнд “Цагаан чонын ван. . . . .журам дор эедэвэй” хэмээх санааг өгүүлсэн болой.*

*Жан Чуань Си*

*“Хятадын эртний түүхийн товч”*

Чэнь Жэнь мориноосоо хараахан буугаагүй байхдаа Билэг өвгөний монгол гэрээс хониныхоос нэг л өөр махны үнэр хан хийхийг мэдрэв. Тэр ихэд гайхаж, яаран мориноос буугаад гэрт орлоо. Билэг өвгөн “Байзаарай байзаарай” хэмээн уулга алдав. Чэнь Жэнь яаран зог тусаад зүүн, баруун, хойд талын хивсийг эвхэж, өргөн том ширмэл ширдэг дээр адууны элдээгүй шир дэвсээд түүн дээр долоо найман чонын хавх хөглөрүүлэн тавьсан байхыг олж үзэв. Монгол гэрийн голд байрлуулсан том тогооноос уур савсан, өтгөн шөл бургилан буцална. Галсмаа мэнчийтэл улайчихаад зуухны хажууд бохирон сууж, галдаа аргал түлээ нэмж байлаа. Түүний тав, зургаан настай охин Цэцэг жар, дал орчим шагайгаар наадан сууна. Бат чонын хавх зүлгэнгээ гэртээ шархаа сувилж байгаа бололтой, нүүрэн дээрх хөлдөнгийн цаанаас шинэ мах түрэн гарчээ. Билигийн эмгэн Өлзий ч гэсэн чонын хавх зүлгэж байв. Чэнь Жэнь өвгөнийг чухам юу чанаж байгааг мэдсэнгүй. Өвгөн хажуудаа зай гаргаад Чэнь Жэньг дэргэдээ суулгав.

Чэнь Жэнь тоглоом наргиан болгож асууруун: “Та юу чанаж байгаа юм бэ? Арай чонын хавх чанаж идэх гэж байгаа юм биш биз дээ? Таны шүд ч тэгвэл мөн бөх хэвээрээ байх нь ээ” гэв.

Билиг өвгөн ч хариу инээмсэглэн: “Чи бараг л таах дөхлөө, би чонын хавх чанаж байгаа юм. Гэхдээ миний шүд түүнийг яаж химлэж дийлэх билээ. Харин чонын шүд айхтар хурц шүү. Чи энэ хавхны амсрыг чоно яаж мэрсэнийг хар даа” гэлээ.

Чэнь Жэнь их л гайхсан байдалтай асууруун: “Та чонын хавх чанаж яах гэж байгаа юм бэ?” гэв.

“Чоно барих санаатай” гээд Билиг өвгөн том тогоог зааж өгүүлрүүн: “Би чамайг нэг шалгаадахья! Эндээс ямар мах үнэртэж байх шиг байна даа?” гэв.

Чэнь Жэнь толгой сэгсрэв. Хөгшин зуухны хажуугийн том түмпэнтэй махыг заагаад: “Адууны мах байгаа юм. Би нуурын тэндээс олж ирлээ. Том тогоо дүүрэн адууны шөл буцалгаад түүндээ чонын хавхаа дахин дахин чанадгийн цаад учрыг чи мэдэж байна уу? Хавхны зэвний үнэрийг дарах гэж байгаа юм” гэхэд Чэнь Жэнь сая л учрыг ойлгож баярлан өгүүлрүүн: “Уухайс, тэгвэл ч чоно гарцаагүй хавханд орж таарна даа. Чонын ухаан явж явж хүний ухааныг гүйцэхгүй юм аа” гэлээ.

Өвгөн тачир цагаан сахлаа имрэнгээ: “Хэрвээ бид ингэж л бодож тооцоолж чадахгүй бол

чоныг дийлнэ гэж ярилтгүй. Чонын хамар нохойныхоос үнэрч байдаг юм. Өчүүхэн төдий төмөр болон хүний үнэрийг мэдэх аваас бүх ажил талаар боллоо гэсэн үг. Би нэг удаа хавхаа сайтар цэвэрлэсэн ч чоно ердөө орж өгдөггүй. Түүний учрыг бодоод байсан чинь би хавхаа тавьж суухдаа санамсаргүй цэрээ хаячихсан юм байна лээ л дээ. Би хэрвээ хаясан цэрээ цастай нь хамаад авчихсан бол зүгээр байх байсан юм. Гэвч би хөлөөрөө цасан дээр унасан цэрээ гишгэлээд одоо ч гайгүй чоно үнэртэхгүй байлгүй гэж бодоод өнгөрснөөс хамаг хэрэг үүдэлтэй байжээ” гэв.

Чэнь Жэнь ихэд гайхан санаа алдаад: “Чонын хамар тийм айхтар үнэрч байх нь ээ” хэмээн асуулаа.

“Чоно угаасаа сэргэлэн, дээр нь хүлчин 10 чөтгөр тусалж байдаг болохоор тэмцэхэд ч амаргүй дээ” гэв .

Чэнь Жэнь “Хүлчин чөтгөр” гэж чухам юу болохыг асуух гэтэл аав нь доош бөхийн суугаад тогооноос чанасан хавхнуудаа гаргаж ирэв. Чонын хавх нүсэр том болохоор тогоонд ганцхан ширхэгийг л чанаж болох ажээ. Чэнь Жэнь өвгөнд туслан модон саваагаар хавхыг хавчин гаргаж ирээд тос даасан тааран шуудайн дээр тавин дараа нь дахин нэгийг тогоонд хийв.

Хөгшин өгүүлрүүн: “Өчигдөр манай гэрийнхэн бүгдээрээ хавх цэвэрлэж өнжицгөөлөө. Би урьд нь нэг удаа чанасан, энэ хоёр дахь удаа болж байгаа юм. Ингээд бас болоогүй ээ. Жаахан азнаж байгаад адууны дэлийг адууны тосонд дүрж байгаад хоёр удаа арчиж зүлгэсний эцэст сая ажил дуусаж байгаа хэрэг. Тэгээд хавхаа тавих үедээ гартаа бээлий өмсөж дээгүүр нь хуурай хомоол цацаж өгнө. Чонотой тэмцэнэ гэдэг чинь байлдаж байгаагаас өөрцгүй. Маш болгоомжтой байх хэрэгтэй шүү дээ. Эмэгтэйчүүдээс ч илүү, тэр тусмаа Галсмаагаас ч илүү нарийн нямбай ажиллагаа шаарддаг юм” гээд өвгөн инээд алдав.

Галсмаа, Чэнь Жэньг харж аяганы шүүгээ рүү заагаад “ Чи миний чанасан сүүтэй цайнд дуртайг мэдэж байна л даа. Гэвч миний гар тостой байгаа тул чи өөрөө хийгээд уучих” гэлээ. Чэнь Жэнь хуурсан будаанд дургүй, харин Галсмаагийн тавьсан аарууланд хамгаас дуртай болохоор дөрөв таван хатаасан ааруул аягандаа хийгээд, дээрээс нь сүүтэй цай дүүргэв. Галсмаа өгүүлрүүн: “ Уг нь аав Батыг чонын хавх тавиулахаар явуулах гэж байсан юм л даа. Гэвч түүний нүүр царай хүн харахын эцэсгүй болсон тул чамайг дагуулаад явхаар боллоо” гэхэд Чэнь Жэнь инээд алдан: “ Чонотой холбоотой зүйл дээр аав ямар намайг дутаадаг биш дээ! Тийм биздээ, аав аа” гэлээ.

Өвгөн Чэнь Жэнь рүү хараад “Хүү минь! Чи гэж чонын хорхойтой амьтан, дээр нь миний нас хөгширсөн болохоор энэ талын эрдмийг чамд өвлүүлье гэж бодсон юм. Гэхдээ анчин хүн чинь жаахан зөв сэтгэлтэй байж л чоно авладаг юм шүү дээ. Чоно бол тал нутгийг хамгаалах гэж тэнгэрээс илгээгдсэн амьтан. Чоно байхгүй бол тал нутаг хамгаалах эзэнгүй орхигдоно. Чоно байхгүй бол Монгол хүний сүнс тэнгэрт очиж чадахаа болино гэсэн хөгшин аавынхаа үгийг санаж яваарай, хүү минь” гэв.

Чэнь Жэнь асууруун: “Аав аа! Чоно тал нутгийг хамгаалагч сахиус юм бол та яахаараа чоно авладаг юм бэ? Та аж ахуйн хурал дээр ч гэсэн чоныг ихээр авлахыг зөвшөөрсөн гэсэн шүү дээ” гэлээ.

Хөгшин өгүүлрүүн: “Чоно дэндүү олширох юм бол сахиус биш шулам болон хувирна. Хүн шулмыг алахад хилэнцгүй гэдэг. Хэрвээ талын адуу мал бүгд шулмын хорлолд автаад дуусах юм бол хүн ч гэсэн амьд үлдэхийн аргагүй. Тэр хэрээр тал нутаг маань авралгүй болж байгаа юм. Манай Монголчууд ч гэсэн дээд тэнгэрээс тал нутгийг хамгаалахаар ирсэн элч нар юм шүү. Тал нутаг байхгүй бол Монгол хүн ч байхгүй, Монгол хүн байхгүй бол тал нутаг ч байхгүй гэсэн үг” гэв.

Чэнь Жэньгийн сэтгэл сэрдхийж улам лавшруулан: “Таны хэлж байгаагаар чоно болон Монголчууд тал нутгийн хамгаалагч нар юм биз дээ?” гэхэд хөгшний нүд сэртэсхийн нэг л сэжигтэйгээр Чэнь Жэньгийн нүүр рүү хараад: “Тийм ээ! Гэвч танай хятадууд үүнийг яаж ойлгох билээ дээ?” гэв.

Чэнь Жэнь ч мөн ихэд сандран: “Аав аа, та намайг их хань үндэстний үзлийг хамгаас илүү эсэргүүцдэг. Цагаан хэрмийн чанадаас тариачид тал нутагт нүүдэллэн суурьшиж атар газар хагалахыг дэмждэггүй гэдгийг юу эс андах билээ дээ?” гэв.

Хөгшний нүүрэн дээрх үрчлээ зугуухан тэнийгээд морины дэлээр чонын хавхыг зүлгэнгээ “Монголчууд ийм цөөхөн учир тал нутгийг хамгаална гэдэг амаргүй. Чоныг агнахгүй бол Монголчууд улам л цөөрнө. Чоныг хэт их агнах юм бол Монгол хүн улам цөөрөх болно” гэжээ.

Өвгөний үгэнд гүн нарийн утга нуугдсан болохоор тэр даруй ойлгоход амаргүй байсан тул Чэнь Жэнь нэлээд эргэлзэнгүй байдалтай асууя гэж бодсон зүйлээ хэлэхийг болив.

Бүх хавхнуудаа янзлаж гүйцсэний дараа өвгөн Чэнь Жэньд хандан “Чи өнөөдөр надтай яваад чонын хавх яаж тавьдагийг сурч ав” гээд өвгөн гартаа өмссөнтэй адил бэрзээнтэн бээлийг Чэнь Жэньд өгөв. Дараа нь босч нэг хавх аваад гэрийн гадна байх төмөр дугуйтай морин тэргэн дээр тавив. Тэргэн дээр адууны тос шингээсэн навтархай эсгий дэвсээстэй байх ажээ. Чэнь Жэнь, Баяр нар ч гэсэн өвгөнд туслан хавхыг гадагшаа гаргаваас хавхан дээрхи адууны тос тэр даруй царцан хөлдөж чонын хавхыг төмөр гэж танихын аргагүй болгожээ. Чонын хавхаа зөөж тэргэн дээр гаргасаны дараа хөгшин монгол гэрийн хажуугаас нэгэн жижиг ууттай адууны хомоол авч тэргэн дээр тавилаа. Бүх зүйл жин тан болсоны эцэст тэр гурав мориндоо мордов. Галсмаа тэдний араас хэд алхангаа Чэнь Жэньд хандан өгүүлрүүн: “Чэнь Жэнь, Чэнь Жэнь! Чонын хавх тавихдаа тун болгоомжтой байхгүй бол хуруу гараа тас татуулсан хүн байдаг юм шүү” хэмээн захилаа. Түүний дууны өнгө нь хүү Баяртаа хандаж байгаагаас огт өөрцгүй санагдав.

Барс болон хэдэн том нохой чонын хавхыг хараад анч зөн нь сэргэж цуг явахаар дагав. Бат яаран сандран Барсын хүзүүнээс татахад Галсмаа ч гэсэн нэг том нохойг хүзүүдэж авлаа. Билиг өвгөн нохдоо зандарч үлдээгээд тэрэгний морио хөтлөн гурвуул дөрвөн морьтой нуурын зүг шогшиж гарлаа.

Үүлс уулсын толгой шүргэн алдаж цас хялмаална. Хөгшин дээш харан хэсэг байзнасны дараа нүүр нь чийгтэхэд бээлийгээ авч гараараа нүүрээ угаагаад “Ойрдоо ажил гэсээр нүүрээ ч угаах зав тэр болгон гарахгүй юм. Цасаар нүүрээ угаахаар сэтгэл сэргээд сайхан шүү. Зуухны илч бараадсаар нүүрэнд бүр утаа шингэж орхижээ” гэлээ.

Чэнь Жэнь ч гэсэн өвгөнийг дуурайн цасаар нүүрээ угаалаа. Нүүрээ угаах зуур дээлийн нудрагыг үнэрлэн үзвээс аргал хорголын утааны үнэр нэвт шингэсэн нь өвгөний ажлыг баллаад хаячихгүй байгаа даа гэж бодоод өвгөнөөс “Биед шингэсэн утааны үнэр гайгүй байгаа даа” хэмээн асуулаа.

Хөгшин өгүүлрүүн: “Гайгүй дээ. Зам зуур утааны үнэр алга болчихно. Харин очсон хойноо л өмд дээлээрээ хөлдүү адууны маханд хүрч тун болдоггүй юм шүү” гэлээ.

Чэнь Жэнь өгүүлрүүн: “Чонотой тулалдана гэдэг ч амаргүй ажил юм аа. Өчигдөр шөнөжин чоно нохой урцалдаад ерөөсөө олигтой унтаж амарч чадсангүй” гэлээ.

Хөгшин түүн рүү хандан “Тал нутаг яаж танай Хятад газартай ижил байх билээ. Дотор газрын хүмүүс байшин балгасандаа тайван сайхан унтах боломжтой. Гэтэл тал нутаг гэдэг дайн тулалдааны талбараас өөрцгүй. Манай Монголчууд дээд тэнгэрээс дайтах одонд төрсөн улс байгаа юм даа. Нойр ихтэй хүн бол сайн цэрэг болж чадахгүй, тийм болохоор чи хэвгэнгүүт унтчихдаг, нохойн дуунаар сэрдэг тийм сонор болох хэрэгтэй. Чоно гэдэг амьтан унтаж байхдаа хүртэл чих нь сортолзоод өчүүхэн чимээ сонсох төдийд л ухасхийгээд зугатах чадвартай байдаг юм. Тийм болохоор чонотой тулалдъя гэж бодож байгаа бол чонын энэ чадвараас суралцах хэрэгтэй. Харин энэ тал дээр хөгшин аав чинь хашир чоно шүү” гээд хөгшин нуг нуг хийн инээж: “Эр хүн гэдэг чинь нойр хоолны хэрийг тааруулж, ан аваа хийчихдэг, гаанс тамхи татахын зуур дуг хийгээд авдаг байх хэрэгтэй. Олон булгийн чононуудын хараалыг ч идэж гүйцсэн хүн дээ, би. Хэрвээ намайг үхэх юм бол чононууд өгөр хэдэн ясыг минь үлдээхгүй мэргэ дуусгах байлгүй. Тийм болохоор би тэнгэрт хамгийн түрүүнд залрах хүн байгаа юм. Хэ хэ. . . . .” гэв.

Чэнь Жэнь суниах зуур “Манай илгээлтийн эздээс мэдрэлийн ядаргаа туссан хүн мэр сэр гарах боллоо. Нэг охин бүр өвчлөөд Бээжин рүү буцсан гэнэ лээ. Энэ маягаараа байх юм бол хэдэн жилийн дараа манай илгээлтийн эздийн тал илүү нь чононоос айгаад дотор газар руу буцах байх даа. Би харин үхэх юм бол чонын хоол болохгүй галд чандарлуулаад л дуусах болно” гэв.

Өвгөн инээсэн хэвээр “Хэ хэ, танай Хятад хүмүүс ч мөн үрэлгэн төвөгтэй улс шүү. Хүн үхэх болгонд авс хэрэгтэй гэнэ. Тэр их модоор хичнээн олон үхэр тэрэг хийж болох билээ” гэлээ.

Чэнь Жэнь өгүүлрүүн: “Би харин үхэхдээ авс хэрэглэхгүй чандарласан үнсээ талд цацуулаад л гүйцэх нь тэр” гэв.

Өвгөн инээд алдан: “Чандарлахад ч гэсэн чамгүй их мод шатаах хэрэг гарна шүү дээ. Бас л үрэлгэн хэрэг, манай Монголчууд чинь арвич зангаараа бараг хувьсгал хийсэн улс. Үхэхээрээ үхэр тэргэн дээр ачуулаад зүүн зүгийг чиглэн тэрэгний донсолгоонд сэгсрэгдээд ямар газар унанав, тэндээ үлдээд чонын хишиг болдог юм даа” гэв.

Чэнь Жэнь ч мөн инээн: “Тэгэхээр аав аа, оршуулах ёслол чинь чонын амаар дамжин тэнгэрт залрахаас гадна бас цаагуураа мод хэмнэх сайн талтай байх нь ээ. Нээрэн тал нутагт чинь төдий л их мод байдаггүй юм байна шүү” гэхэд

“Мод хэмнэхээс гадна цаанаа бас идсэн махныхаа хариуг барьж байгаа юм” хэмээн өвгөн хариулав.

“Идсэн махныхаа хариуг барина” гэсэн үгийг Чэнь Жэнь анх удаа сонсож байгаа тул цаад санааг ер ухсангүй. “Идсэн махныхаа хариуг барина гэж юу гэсэн үг вэ?” хэмээн асуулаа.

Өвгөн өгүүллрүүн: “Тал нутгийн Монгол хүн насан туршдаа мах иддэг болохоор хичнээн олон амьтны аминд хүрч, нүгэл хилэнц хураах билээ? Харин тэр бүхний хариуд өөрийн биеийг тал нутагтаа өргөвөөс сая шудрага хэрэг болж сүнс ч гэсэн амаржаад тэнгэрт залардаг юм” гэлээ.

Чэнь Жэнь инээн алдан: “Энэ ч нээрэн шудрага хэрэг байна шүү. Би хэрвээ чононоос айгаад Бээжин явчихдаггүй юм бол бас өөрийн биеийг чононд өргөх ч юм бил үү, хэн мэдлээ. Сүрэг чоно ганц хүнийг идэхдээ цай уухын зуур л зүйл дуусгадаг байх даа. Тийм болохоор чононд биеэ өргөх нь чандарлуулахаас ч хурдан бүтэх хэрэг байна” гэв.

Өвгөн ихэд баясан инээснээ тэр даруй нүүрэнд нь зовнингуй төрх илрээд: “Олонбулгийн талд урьд нь Хятад хүн бараг үзэгддэггүй байсан юм. Аж ахуйн хэмжээнд зуун гуч дөчин Монгол айлын долоо найман зуу гаруй хүмүүс бүгдээрээ Монгол үндэстэнгүүд. Соёлын хувьсгалын дараа танай Бээжингээс илгээлтийн эзэн зуу гаруй залуус ирсэн. Харин ойрын үед цэргийнхэн, жолооч, тэрэгчин, барилгачин гэх мэт дотор газрын хүмүүс олноор суурьших боллоо. Тэд бүгдээрээ чоныг үзэн ядаж, чонын арьсанд үхэлддэг болохоор хожим буун дуу гарах болгонд чонын тоо цөөрсөөр чононд биеэ өргөх ч боломжгүй хэрэг болж таарна даа” гэлээ.

Чэнь Жэнь хариуд нь их л баясгалантайгаар: “Аав аа, та санаа зоволтгүй ээ. Удахгүй дайн болоод атомын бөмбөг хаях юм бол хүн чоногүй бүгдээрээ үхэх юм чинь” гэхэд

Өвгөн гараараа бөөрөнхий дүрс зураад: “Тэр бөөрөнхий бөмбөг 11 гэдэг чинь ямаршуу эд байдаг юм бэ?” гэв.

Чэнь Жэнь дохио зангаа оролцуулаад ч өвгөнд атомын бөмбөгийн учрыг ойлгуулж чадсангүй.

Нуурын чанх ард байх мөнөөх хэдэн үхсэн адууны дэргэд ирээд Билиг өвгөн мориныхоо амыг татаж, Баярт тэрэгний морины жолоог атгуулан зогсоов. Дараа нь тэр хоёр чонын хавх, бяцхан гаапуу, адууны хатсан хомоолтой уут зэргийг авч Чэнь Жэньг дагуулан үхсэн морьдын зүг очлоо. Өвгөн морины нуруун дээрээс энэ тэрийг сайтар ажиг шинжинэ. Хэдэн үхсэн моринд хээрийн амьтан хүрсэн бололтой биеийг бүрхсэн нимгэн цасны цаанаас шархны ул мөр үзэгдэхийн сацуу эргэн тойронд хэдэн амьтны хөлийн мөр үлджээ. Чэнь Жэнь тэсгэлгүй: “Чонон сүрэг ирж үү?” хэмээн асуулаа.

Өвгөн хариулахыг төвдсөнгүй нарийвчлан ажигласаар байв. Хэдэн морьдыг сайтар ажсаны дараа тэр өгүүллрүүн: “Чонон сүрэг хараахан ирээгүй байна. Том чонон сүрэг хилийн зурвасын цаагуур байгаа гэж Өлзий айхтар таамагласан байна шүү. Тэр чонон сүрэг ч мөн айхтар тэвчиж байна даа” гэлээ.

“Аав аа, энэ хөлийн мөрнүүд ямар учиртай юм бэ?” гэж Чэнь Жэнь цасан дээр гарсан

мөрнүүдийг заан асуулаа.

Хөгшин өгүүлрүүн: “Эдгээрийн олонхи нь үнэгний мөр байна, бас нэг өлөгчин чоно иржээ. Энэ хавиар хэдэн бэлтрэгтэй өлөгчин чоно яваад байгаа юм” хэмээн өвгөн хэсэг зуур бодолхийлснээ: “Би уг нь азарган чоныг бас хэдэн том чонотой нь цуг авлая хэмээн бодсон боловч түүнээс наана үнэгнүүд гүйгээд жаахан амаргүй хэрэг болох бололтой” гэлээ.

“Тэгвэл бид дэмий ирсэн хэрэг болж байна уу?”

“Үгүй ээ. Бидний гол үүрэг бол чонон сүргийг төөрөгдүүлэхэд байгаа юм. Тэд нар хүн хавх тавьчихаар ав хомрогонд мордох зав байхгүй гэж бодоод аргаа өөрчлөн адууны мах идэхээр ирнэ. Харин чонон сүрэг наашаа ирэх зуур бид нар ав хомрог хийх боломжтой болж байгаа юм даа” гэв.

Чэнь Жэнь “Аав аа, тэгэхээр нэг том чоныг барих арга байгаа юу?” хэмээн асуулаа.

“Яахаараа байдаггүй билээ?” гээд хөгшин өгүүлрүүн: “Бид нар авчирсан хавхнуудаа сайн чанга тавьж чадах юм бол үнэг биш ганцхан чоныг барьж болно шүү дээ” гэв.

Өвгөн морио унан хэд тойрсоноо нэг үхсэн морины хажууд хавх тавих газрыг сонголоо. Чэнь Жэнь ч ухасхийн мориноос буугаад цас цэвэрлэхэд туслав. Өвгөн доош тонгойж гаапуугаар өнгөцхөн хөлдсөн газрыг цохиж дөч орчим сантиметр өргөн, 15 сантиметр гүн нүх ухаад голд нь дахин жижиг нүх гаргав. Дараа нь адууны тос шингээсэн бээлийтэй гараар хавхыг нүхний голд тавиад уян даравч, ган шүд бүхий хавхны шийрийг хөлөөрөө гишгэн тэнийлгээд тэвхийг нь хавхны хэлэнд болгоомжтой суулгав.

Өвгөн өчүүхэн л болгоомж алдвал гар хөлөө таслуулж мэдэх энэ аюултай атлаа хүч шавхсан үйлдлийг хэрхэн хийж байгааг Чэнь Жэнь сэтгэл түгшин харж байлаа. Өвгөн хөлөө өргөн хөлс нь бурзайн амьсгаадсаар цасан дээр бохирон суугаад биен дээр нь тусах вий гэсэн шиг нудрагаараа хөлсөө зөөлөн шудрав. Өвгөн өөрийг нь дагуулан ирсэний хүчинд Чэнь Жэнь хавхаар хэрхэн чоно агнадгийн зүй тогтлыг ойлгож авлаа. Чоно хавхны хэлэн дээр гишгэхэд доош сууж, түүнийг торгоож байсан тэвх мултраад, ган хавх хэдэн зуун жингийн хүчээр чонын хөлийг хавчиж, ясыг хугалан, шөрмөсийг тасладаг аж. Ийм айхтар эд болохоор чоно ган хавхнаас тэгтэл их айдаг нь арга ч үгүй юм. Хэрвээ талын чоно ган хавхны харших чимээнээс тэгтэл их айдаггүйсэн бол өөрөө анх чонын сүрэгтэй андуу учрахдаа амь насаа гарцаагүй алдах байсан билээ.

Одоо зөвхөн өнгөлөн далдлалтын ажил үлдсэн бөгөөд өвгөн ч энэ тал дээр огтхон өө сэв үлдээж болохгүй. Билиг өвгөн сая нэг уужирсан байдалтай: “Чонын хавхыг цасаар хучиж болдоггүй юм. Нэгд цас хомоолоос хүнд болохоор доош суух гэмтэйгээс гадна наранд хайлж урссан ус нь хавхыг хөлдөөгөөд ажиллагаагүй болгодог гэм байдаг. Чи цаад хомоолоо аваад аль” гэлээ.

Өвгөн уутыг авч нунтагласан хомоолыг атгаад хавхны дээгүүр тавьсан даавуун дээр цацахад сэвсгэр хөнгөн адууны нунтаг хомоол хавхны амсарыг бүрхэн хучлаа. Ингэснээр хавхны амсар дээр тавьсан даавуу хөлдөх аюулгүй болжээ. Дараа нь өвгөн хавхны төмөр гинжийг

нэгэн үхсэн адууны араг яснаас уячихаад одоо цасаар булж болно гэж хэлэв. Тэр Чэнь Жэньд хавхны уян даравч болон гинжийг цасаар хэрхэн булж, хомоолоо сэвсгэр цасаар болгоомжтой дарсаны эцэст адсагаар зөөлөн илбэж цасыг тэгшлэн орчноос огт ялгагдахгүй болгох аргыг зааж өгөв.

Цас хялмаалан орсоор байсан болохоор удаж төдөлгүй бүхий л ул мөрийг далдалж орхив. Чэнь Жэнь асууруун: “Энэ хавх яахаараа гагцхүү үнэг биш чоныг л авлаж чаддаг билээ?” гэхэд өвгөн хариуд нь “Төмөр тэвхийг гүн суулгаж өгсөн болохоор үнэг хөнгөн тул гишгээд ч хөдөлгөхгүй. Харин чонын бие хүнд болохоор гишгэнгүүт л хавчаад авах болно доо” гэлээ.

Өвгөн ийш тийш эргэн тойрныг ажиглан хараад хөлөөрөө алцамлан хэмжиж хоёр алхмын зайтай баруун зүүн хоёр этгээдэд нэжгээд газар сонгон аваад: “Чи энэ удаагийн хавхыг өөрөө тавиадах” гэв.

“Хоёр хавхны хооронд яагаад ийм ойр зайтай байдаг билээ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Өвгөн хариуд нь: “Чоно гэдэг амьтан амь насныхаа төлөө юугаа ч хайрладаггүй болохоор хавханд хавчуулагдсан хөлөө ястай нь тас хазаж орхиод гурван хөлөөрөө доголоод гүйгээд явчихдагийг чи ч яахин мэдэх вэ дээ? Тийм болохоор би түүнд хоёр хавх бэлдэж байгаа хэрэг. Чонын хөлийг хавчингуут дороо эргэлдэхдээ хоёрдох хөл нь нөгөө хавханд хавчуулагдаж таарна. Чонын хойд урд хоёр хөл хавчуулагдах юм бол тэр хоёр хөлөө тас хазаж хаялаа ч гэсэн яахин зугтаж чадах билээ дээ?” гэв.

Чэнь Жэньгийн сэтгэл сэр хийн дагзны үс нь тэр аяараа босоод ирэх шиг санагдлаа. Тал нутагт өрнөх чоно хүн хоёрын дайн ийм харгис хатуу байдаг ажгуу. Чоно хүн хоёр харгисаар харгисыг довтолж, харгис хатуугаар харгис хатуугийн өшөөг авч, ов залиар ов залиг дийлдэг ажээ. Энэхүү хорыг хороор гэсэн нэхэл хатуутай өшөө хонзон явсаар хүн өөрөө чононоос өөрцгүй, чононд ойр байсан хүний сэтгэл төмөр чулуунаас илүү хатуу, хүйтэн цэвдэг болж хувирдаг юм гэж үү? Чэнь Жэнь хэдийгээр чонын харгис хэрцгийг үзэн яддаг боловч өөрийн биеэр овжин агаад энэрэлгүй ган хавхыг тавих үед хоёр гар нь өөрийн мэдэлгүй салганан чичирч байхыг мэдрэв. Энэхүү занга дэндүү нууцгай ажээ. Түүнийг чонын хорхой хөдөлгөм тарган үхсэн адууны өмнө тавьж, түүндээ адууны мах, тос хомоолын үнэр шингээсэн билээ. Тийм болохоор хичнээн овгой чоно ч гэсэн үүнд хууртагдан ган хавханд хөлөө хавчуулж, ясаа хугалуулаад, дараа нь арьсаа өвчүүлэн хүүр яс нь хөдөө хээр хаягдах болно гэдэгт Чэнь Жэнь хатуу итгэж байлаа.

Өвгөн нуг нуг инээгээд: “Айгаад байна уу? Тал нутаг гэдэг чинь дайны талбар шүү! Цус үзэж чадахгүй бол сайн дайчин болж чадахгүй гэдгийг битгий мартаарай. Чоно овжин аргаар сүрэг адууг хөнөөсөнд сэтгэл чинь шимшрэхгүй байгаа хэрэг үү? Хүн түүнээс илүү хорон арга сэдэж чадахгүй бол чоныг яахин дийлэх билээ?” гэжээ.

Чэнь Жэнь сэтгэлээ тогтоон, уужим амьсгаа аваад цасыг шийдэмгий зайлуулан нүх ухаж гарлаа. Яг хавхаа тавих үед түүний гар дахиад л үл мэдэг чичирхийлж эхлэв. Анх удаа чонын хавх тавьж байгаа болохоор гар хуруугаа тас хавччих вий гэж айсан хэрэг байлаа. Өвгөн түүнд зааварлангаа бүдүүн малиагаа хавхны амны завсар хийсэн тул хавх мултарлаа ч гэсэн түүний хуруу гарыг биш харин малиаг хавчих байв. Чэнь Жэнь ийнхүү бодоод хамаг бие нь уужран

өвгөний хамгаалалтанд байгаа болохоор гар нь чичрэхээ байж, эхний удаа хавхыг амжилттай тавьж чадав. Чэнь Жэнь хөлсөө арчихдаа өвгөний духанд түүнийхээс ч илүү хөлс чийхарсан байхыг олж үзэв.

Өвгөн аажуу тайвуухан: “Хүү минь, гурав дахь хавхыг чи миний оролцоогүйгээр тавиад үз! Чи чадах юм байна” гэхэд Чэнь Жэнь толгой дохижээ. Тэр өвгөнтэй цуг морь тэргэн дээрээс хоёр хавх авч үхсэн морьдын хажууд очоод өөр газар сонгон болгоомжтойгоор тавив. Үлдсэн дөрвөн хавхыг хөгшин залуу хоёр хошоодыг тавьжээ. Харин өвгөн Баярыг Чэнь Жэньд тусла гэж явуулав.

Харуй бүрий болохын алдад тэнгэр хараахан цэлмээгүй л байв. Билиг өвгөн Чэнь Жэньгийн тавьсан хавхыг нарийвчлан сонжиж үзээд инээд алдан: “Огт мэдэгдэхээргүй болсон байна шүү. Би хэрвээ хашир чоно байлаа ч гэсэн чиний тавьсан хавханд ормоор болжээ” гээд Чэнь Жэньг ултай, тогтуун харсанаа “Цаг орой болжээ. Одоо бид юу хийх хэрэгтэй билээ?” хэмээн асуулаа.

Чэнь Жэнь хэсэг зуур бодолхийлсэнээ: “Бид өөрсдийнхөө ул мөрийг арилгаж, авчирсан багаж хэрэгслээ ганцыг ч үлдээлгүй авч явах хэрэгтэй” гэхэд өвгөн сэтгэл хангалуун байдалтай: “Чи ч айхтар сурах янзтай даг шүү” гэжээ.

Тэр гурав хамгийн хойд хэсгээс нь нямбай шалган, сайтар цэвэрлэсээр морин тэрэг байгаа газар хүрэв. Чэнь Жэнь багаж хэрэгслээ хамах зуур асууруун: “Аав аа, ийм олон хавх тавьсан юм чинь хэдэн чоно орох бол?” гэхэд өвгөн хариуд нь “Анчин хүн ангийн тоогоо тааварладаггүй юм. Төд өдийг агнана гээд таагаад байвал ганц ч чоно хавханд орохгүй. Хүн зөвхөн өмнөх хэргээ сайн гүйцэтгээд, хожим юу болохыг тэнгэрт даатгасан нь дээр байдаг юм даа” гэлээ.

Тэр гурав мориндоо мордон, морин тэргээ хөтөлсөөр гэрийн зүг явав.

Чэнь Жэнь асууруун: “Бид нар маргааш өглөө ирэхэд чоно орсон байх болов уу?”

Хөгшин өгүүлрүүн: “Чоно орсон ороогүй тэр чоныг авлаж болохгүй. Хэрвээ орсон байлаа ч түүнийг чонон сүрэгт заавал харуулах хэрэгтэй. Хэрвээ хүн ирж хавхтай чоныг авч яваагүй бол тэд нарын сэжиг улам ихээд үхсэн морьдыг тойрон эргэлдээд байх болно. Сангийн аж ахуйгаас бидэнд төд өдөн чоно агна гээгүй, зөвхөн чонон сүргийг дагуулан авчрах хэрэгтэй гэсэн үүрэг өгсөн шүү дээ. Тийм болохоор чоно ороогүй байлаа ч гэсэн бид нар тэднийг хүлээгээд л байх хэрэгтэй. Маргааш чи ирээд хэрэггүй, би холоос ажимз” гэлээ.

Тэр гурав гэрийн зүг зөөлөн шогшуулцгаав. Энэ зуур Чэнь Жэньд бэлтрэг суйлах бодол нь эргээд төрсөн тул өвгөнөөс тэр талын эрдэм заалгахыг боджээ. Бэлтрэг суйлах гэдэг зөвхөн тал нутагт л байдаг адармаатай, бэрхшээлтэй, маш нарийн арга ажиллагаа шаардсан ангийн төрөл бөгөөд талын Монгол үндэстэн чонон сүргийн тоо толгойг хязгаарлах гол арга юм. Нэг үүрэнд магадгүй долоо найм, арван хэдэн бэлтрэг ч байх боломжтой бөгөөд Олонбулгийн талын чонон сүргийн идэш их, үржих чадвар ч сайтай байдаг билээ. Хавар нэг үүр бэлтрэг суйлна гэдэг сүрэг чоныг устгаж байгаагаас өөрцгүй хэрэг. Чонон сүрэг бэлтрэгээ хамгаалахын тулд хамаг байдаг арга ухаанаа сүвэгчлэн амь насаа ч хайхрахгүй тэмцэх



чадвартай байдаг ажгуу. Чэнь Жэнь бэлтрэг суйлахын аюул осол, аз сорьсон хэргүүдийг цөөнгүй сонсож байсан болохоор сэтгэл зүйн хангалттай бэлтгэлтэй болжээ. Хоёр хаврын нүүр үзээд байгаа гэхэд аж ахуйн хэмжээний зуу гаруй илгээлтийн эздээс бэлтрэг суйлж чадсан азтай аавын хүү өдий болтол ганц ч гараагүй билээ. Тэр өөрийн биеэр бэлтрэг суйлья гэж бодож ч зүрхэлдэггүй харин Билиг өвгөний зав чөлөө гайгүй бол хэдэн удаа тийм ажилд цуг явж арга туршлагаас нь суралцъя хэмээн санадаг ажээ. Харин адуун сүрэгт том гай тохиолдсоноос хойш өвгөн чонын бэлтрэгний тухай бодох сөхөөгүй болжээ. Тийм болохоор Чэнь Жэнь өвгөнөөс тэр талын туршлага асууж сураглахаас өөр арга замгүй болоод байгаа юм.

Чэнь Жэнь өгүүлрүүн: “Ааваа, би хэд хоногийн өмнө мал хариулж явтал нэг өлөгчин чоно намайг харсаар байтал хурга зуугаад Хар чулуут уулын зүг яваад өгөхийг үзсэн юм. Миний санахад тэр хавьд бэлтрэгтэй чонын үүр байгаа бололтой. Би уг нь маргааш таньтай цуг очъё гэж бодож байсан юм” гэлээ.

Өвгөн хариуд нь: “Маргааш би очиж чадахгүй ээ. Аж ажуйн удирдлага надаас хэл чимээ хүлээж байгаа учраас, энүүгээрх ажил дийлдэх юм биш” гээд өвгөн түүн рүү харснаа: “Өлөгчин чоно үнэхээр Хар чулуут уулын зүг явчихсан гэж үү?” хэмээн асуулаа.

“Тиймээ” гэж Чэнь Жэнь хэлэхэд

Өвгөн сахлаа имрэнгээ: “Чи араас нь морьтой хөөсөн үү?” гэхэд Чэнь Жэнь: “Үгүй ээ, тэр дэндүү хурдан гүйж байсан учраас би хөөгөөд ч гүйцэхгүй байсан юм” гэхэд хөгшин: “Тэгвэл яамай даа! Хөөсөн бол чоно чамайг маллчих байсан юм. Араас нь хүн хөөж байгаа тохиолдолд чоно шууд үүр рүүгээ дутаадаггүй юм” гээд хэсэг зуур бодолхийлснээ: “Тэр өлөгчин чоно ч айхтар зальтай амьтан ажээ. Өнгөрсөн жилийн хавар манай багийнхан тэнд гурван ч газар бэлтрэг суйлсан юм. Өнөө жил мэдээж тийшээ очих хүн байхгүй шүү дээ. Гэтэл тэр өлөгчин чоно тэнд үүрээ зассан байдаг. Чи тэгвэл маргааш ахиу хэдэн хүн нохой аваад тийшээ яв л даа. Харин эр зоригтой, туршлага сайтай малчдыг дагуулж явах хэрэгтэй шүү. Харин та хоёр хоёулхнаа явна гэвэл дэндүү аюултай гэж мэдээрэй” гэв.

“Бэлтрэг суйлахад хамгийн осолтой нь юу вэ?” гэж Чэнь Жэнь асуулаа.

Хөгшин өгүүлрүүн: “Бэлтрэг суйлахад төвөг бэрхшээл байхаар барах уу. Эхлээд чонын үүрийг хайж олно гэдэг маш амаргүй. Харин би чамд чонын үүр олох нэг арга зааж өгье! Чи маргааш үүр цүүрээр босоод Хар чулуут уулын өндөрлөг газар очиж хэвтээд хүлээж бай. Гэгээ орохын алдад дурангаараа тогтоон ажиглаваас шөнөжин хээрээр гүйсэн өлөгчин чоно үүрэндээ ирээд бэлтрэгээ хөхүүлэх нь лавтай. Чи өлөгчин чоныг харсан тэр газар үүр байгаа болохоор тэр хавьдаа сайтар хайгаарай. Сайн анч нохойтой хайвал гарцаагүй олох болно. Үүрээ олчихлоо гэхэд бэлтрэг суйлна гэдэг бас л амаргүй хэрэг. Үүрэн дотор нь өлөгчин чоно байж байх вий! Тун болгоомжтой байдаг юм шүү” гэлээ.

Өвгөний нүдний харц гэнэт сүүмийгээд өгүүлрүүн: “Хэрвээ чонон сүрэг энэ олон адууг хядаагүй бол би чамайг бэлтрэг суйлахаар явуулахгүй байх байсан юм. Бэлтрэг суйлна гэдэг Олонбулгийн талын хөгшчүүдийн төдий л таашаадаггүй хэрэг байгаа юм даа” гэжээ.

Чэнь Жэнь ч гэсэн цааш асууж зүрхэлсэнгүй. Өвгөн өргөн цар хүрээтэй бэлтрэг суйлах ажлыг таашаадаггүй байсан болохоор энэ удаа түүнийг бэлтрэг суйлахаар явуулахгүй байх вий хэмээн дотроо эмээж байсан билээ. Гэвч бэлтрэг суйлна гэдэг тун нарийн ажиллагаа шаардахаас гадна түүний эцсийн зорилго нэг чонын бэлтрэг олж тэжээх явдал байв. Одоо жаахан л шавдахгүй бол чонын бэлтрэг хөхнөөс гараад нүдээ нээчихвэл тэжээхэд амаргүй болно. Яадаг ч байсан бэлтрэг нүдээ нээж хорвоог хараагүй, өөрийн дайснаа ялгаж таньж амжаагүй байхад чонын ертөнцөөс нь салган хүний орчинд авчрах хэрэгтэй. Гэвч Чэнь Жэньгийн санахад байгалийн төрөлх чанар илүү хөгжсөн чонын бэлтрэг болжмор тэжээхээс ч амаргүй байх вий хэмээн айж байлаа. Хар багаасаа амьтанд ухаангүй хайртай байсан Чэнь Жэнь бага байхдаа олон ч удаа болжмор барьж тэжээж байсан. Гэвч болжмор гэдэг амьтан шандас заах тул торон дотроо нүдээ аньчихаад юм идэж уухгүй байсаар амьсгаа хураах нь олонтой. Тэгвэл чонын бэлтрэг гэдэг болжмор барихаас ч амаргүй, түмэн бэрхийг туулан байж авчирсан хойно хэд хоног бололгүй нүд аньчихвал ямар сайн байх билээ дээ. Тийм болохоор Чэнь Жэнь Батаас сайн асууя, яагаад гэвэл тэр аж ахуй даяар нэрд гарсан сайн анчин, түүний дээр хэд хоногийн өмнө чонон сүргийн дайралтанд өртөн уур унтуудаа шатаж яваа тул түүгээр бэлтрэг суйлах аргыг заалгавал бүтнэ хэмээн боджээ.

Хөгшний гэрт ирэхэд харуй бүрий болсон байлаа. Дотогш ороход гоёмсог хивс хоймроо дэлгэж гурван зул барьсан нь гэрийг нэлэнхүйд нь гэрэлтүүлнэ. Явган ширээн дээр тогооноос дөнгөж гаргасан хоёр түмпэн дүүрэн хонины шинэ гэдэс, чанасан мах тавьсан нь өдөржин ажил хийгээд ирсэн хөгшин хөвөө гурвын гэдсийг хоржигнуулан, хорхойг хүргэнэ. Чэнь Жэнь хөдсөн дээлийг тайлан ширээний хажууд суугаад авав. Галсмаа нэг түмпэнтэй махыг түүн рүү дөхүүлэхэд Чэнь Жэньгийн идэх дуртай хонины тарган хошного хийсэн байлаа. Харин өвгөний өмнө тавьсан түмпэнд түүний зооглох дуртай өвчүү чанаж тавьжээ. Тэр мөн Бээжингээс авчирсан цуунд дарсан цагаан мөөгийг Чэнь Жэньгийн өмнө тавьлаа. Чэнь Жэнь чанасан махыг ийм амтлагчтай хольж идэх хамгаас дуртай бөгөөд ер нь энэ хоёр айлын гол хэрэглэдэг амтлагч болон хувирсан юм. Чэнь Жэнь монгол хутгаар тарган хошного огтлон амтлагчдаа дүрээд ам руугаа хийх агшинд толгойдоо эргэлдэх чонын бэлтрэг суйлах бодлыг ор тас мартаж орхив. Төхой шахам урт хонины тарган хошного гэдэг тал нутгийн таван тансаг амттаны дээж билээ. Хэдийгээр тарган нэртэй боловч тэгтэл айхтар шандуун биш, голд нь гүзээ, нарийн гэдэс, цоройн мах зэрэг дотор дайвруудыг нарийн зүсэж чихсэн нь монгол зоогийн ширээнд хүндтэй байр эзлэдэг юм.

“Монголчууд цоройн махыг хүртэл хаялгүй хямгатай атлаа, амттай болгон идэж чаддаг байх гэж” хэмээн Чэнь Жэнь хэлэхэд

Өвгөн толгой дохингоо “Өлссөн чоно хонины үс ноос, шийр туурайг ч үлдээлгүй идчихдэг юм шүү дээ. Тал нутагт зуд турхан, ган гачиг болоход хүн чоно өөрцгүй идэх юм олдохгүй үе бишгүй тохиодог. Тийм болохоор хонины махыг гамтай идэх учиртай юм” гэлээ.

“Тэгвэл монголчууд хонины махыг ийм цэвэрхэн иддэг аргыг чононоос сурсан байж таарах нь ээ” гээд Чэнь Жэнь инээв.

Бүгдээрээ зүйтэй зүйтэй гээд инээлдэхэд Чэнь Жэнь ч бас амжуулаад гурван том хэрчим хошного ам руугаа гулгуулав.

Галсмаа түүнд нь их л сэтгэл өег байгаа бололтой. Тэр өөрийг нь огт нэрэлхдэггүй гэж магтдагийг Чэнь Жэнь саналаа. Өөрийнх нь байдал одоо лав өлөн чононоос өөрцгүй байгаа даа гэж бодоод тэр жаахан эвгүйрхээд идшээ татав. Билигийн гэрийнхэн бүгдээрээ хонины тарган хошногонд ухаангүй дуртайг мэдэх тул ганцаараа нэг хошногоны талыг идчихэж яахин болох билээ? Галсмаа чанасан цусан дундаас өөр нэгэн хошног гаргаж ирээд инээд алдан “Чамайг хамт ирнэ гэдгийг мэдээд би хоёр хошног чанасан юм. Чононоос суралцах гээд байгаа юм бол үлдээлгүй идээрэй” гэхэд гэрийн бусад хүмүүс нирхийтэл инээлдэв. Баяр Галсмаагийн гаргаж ирсэн хошногыг шүүрэн аваад өөрийнхөө аяганд хийчихлээ. Чэнь Жэнь энэ нутагт ирээд хоёр жил болохдоо Галсмаатай ямар харьцаатай байхаа төдийлөн ялгаж мэддэггүй юм. Энгийн жишгээр авч үзвэл тэр бэргэн нь болох учиртай ч заримдаа төрсөн эгч шиг нь, заримдаа болохоор авга, нагац эгч шиг нь ч юм шиг санагдах үе бий. Үргэлж л нэг зангаараа, ёстой л тал шигээ тэнүүн цайлган хүн гэж түүнийг хэлэх байх даа.

Чэнь Жэнь бүтэн тарган хошног ганцаараа идэж, араас нь аяганы хугас сүүтэй цай залгилаад Галсмаагаас “Танай Баяр чоныг сүүлдэн авч, үүрнээс нь бэлтрэг суйлан, ардаг догшин адуу унаад л ёстой чулуу шиг зоригтой хүүхэд шүү. Та тэр бүхнээс айдаггүй юм уу?” хэмээн асуулаа.

Галсмаа инээд алдан “Монгол хүүхдүүд чинь бүгд л тийм байдаг хойно өөр яалтай билээ? Бат бага байхдаа хүүгээсээ ч илүү зоригтой байсан гэдэг. Баярын шургаж орсон үүрэнд том чоно байгаагүй, бэлтрэгнүүд хүн хазаж чадахгүй юм чинь айгаад байх юу байх вэ дээ? Харин Батын шурган орсон үүрэнд өлөгчин чоно байсныг тэр татаад гарган ирсэн гэж ярьдаг юм шүү” гэхэд

Чэнь Жэнь ч чамгүй их гайхаад Батаас асууруун “Та урьд нь яахаараа энэ тухай надад ярьж байгаагүй билээ? Одоо хурдан яриад аль” гэлээ.

Бат ч зан сайтай байгаа бололтой инээд алдан урдаа тавьсан архианаас нэг том балгаад “Намайг арван гурван настай байх тэр жил аав хэдэн нөхдийн хамт хайсаар байж нэг бэлтрэгтэй үүр олоод ухах гэснээ өлөгчин чоно байж магадгүй гэж айгаад гал асаан утсан юм. Тэгээд өлөгчин чоно гарч ирэхгүй болохоор байхгүй юм байлгүй гэж бодоод намайг шүдэнз, шуудай бариулан бэлтрэг суйлуулахаар дотогш оруулж билээ. Тэгээд хоёр алд орчим явж байтал хоёрхон тохой зайтай том чонын нүд гялалзахыг хараад айсандаа хариугүй өмдөө норгочих шахсан. Би нэг шүдэнз асаагаад сайн хартал нөгөө чоно чинь сүүлээ хавчаад айсан нохойноос өөрцгүй амьтан байж байлаа. Шүдэнз унтрах агшинд чоно над руу дайрахад, ухарья гэхээр ухарч болдоггүй, ингээд л дуусдаг байж гэж бодлоо шүү. Гэтэл тэр чоно над руу дайрсан хэрэг биш. Толгой дээгүүр минь харайгаад гадагш зугатах гэсэн хэрэг байж л дээ. Гадаах хүмүүс бэлтгэлгүй байж байгаад аав минь чононд бариулчихна гэж бодсон уу, би толгойгоо дээш өргөсөн чинь чонын хүзүүг хавчаад нүхний хананд шахаад авсан байлаа. Чоно сандарсандаа миний хувцас хунарыг маажлан урна. Би ч самбаачлан чононд уруулахгүй санаатай хүзүү толгойг нь хананд шахан, ноцолдсоор байж урд хоёр хөлөөс нь барьж авлаа шүү. Одоо чоно урж ч чадахгүй, маажиж ч чадахгүй болсон боловч би хамаг тэнхээгээ барчихаад хөдөлж чадахаа байчихав”

Бат бусдад тохиолдсон хэргийг ярьж байгаа мэт их л тайвуухан цааш үргэлжлүүлж “Гадаах хүмүүс намайг гарч ирэхгүй удаад байхаар аав сандарсандаа дотогш шурган гал гаргаваас

миний толгой дээгүүр нэг чонын толгой цухуйж байхыг хараад сүнс нь зайлчихгүй хаачих вэ? Тэр чонын толгойг сайн хавчаарай гэж надад захиад сүвээнээс минь татан гадагш татаж билээ. Би ч чонын толгойг хавчин урд хоёр хөлийг нь тас зуурсаар гадагш чирээд байлаа. Аав ч гадна байгаа хүмүүсийг хөлнөөс татаарай гэж хашгирсан юм даг. Аавыг нүхний гадна чирэн гаргахдаа хүмүүс чухам юу болсныг ойлгоцгоожээ. Тэд нар хутга, бороохой шийдмээ бэлдчихээд нүхэн дээр хүлээж байгаад аав бид хоёр чоныг үүрнийх нь амсар дээр чирч гаргах агшинд хутгаар тэвхдэн хатгаж, бусад нь цохиж балбасаар алж билээ. Дараа нь би жаахан амсхийж байгаад чонын үүр рүү дахин ороход зөвхөн хүүхэд л багтахаар бачуухан байсан юм даг. Харин мухартаа нэлээд уужим зайтай, хонины арьс ноос зулж дэвссэний дээр есөн бэлтрэг унтаж байлаа. Өлөгчин чоно бэлтрэгнүүдийнхээ унтаж байгаа мухрын наагуур шороо овоолон халхлаад өөрөө гадуур нь хэвтэж байсан ажээ. Галаар утахад үүрний адар дээрх нэгэн жижиг нүхээр утаа гадагшлан өлөгчин амьд үлдсэн байв. Би шороог малтан бэлтрэгнүүдийг шуудайд хийж чирсээр чонын үүрнээс мөлхөн гарч ирсэн. . . . .”

Чэнь Жэнь энэ болсон явдлыг амьсгаа даран чагналаа. Гэрийнхэн нь хавь ойрд энэ тухай сонсоогүй болохоор их л айж түгшсэн янзтай байцгаана. Энэ болсон явдал түүний урьд өмнө бэлтрэг суйлахтай холбоотой хэргүүдээс их л өөр тул “Би өлөгчин бэлтрэгнүүдээ хамгаалаад үүр рүү нь шургасан хүнтэй үхэлдэн тулалддаг гэж сонссон юм. Гэтэл тэр өлөгчин яахаараа өөрийг чинь ноцдоггүй билээ?” хэмээн асуулаа.

Өвгөн хариуд нь: “Үнэндээ тал нутагт чоныг дийлж чадах нь ганц хүн л юм болохоор талын чоно хүнээс их айдаг юм шүү дээ. Чоно утаанд баахан бахардаад байж байтал дахин гал барьсан хүн ороод ирэхээр айлгүй яах вэ? Тэгээд ч тэр өлөгчин анх төрсөн хоёр настай л байсан болов уу даа, хөөрхий минь. Хэрвээ чи энэ тухай асуугаагүй бол хэн ч сөхөж ярихгүй байх байсан юм” гэлээ.

Галсмаагийн царай дахь инээмсэглэл ул мөргүй арилаад нүдэнд нь нулимс цийлгэнэж байлаа.

Баяр Галсмаад хандан: “Чэнь Жэнь тэд нар маргааш уул руу бэлтрэг суйлахаар явах гэж байгаа гэсэн. Тэдний бие том болохоор үүрэнд нь шурган орж чадахгүй шүү дээ. Би өнөөдөр тэднийд хоночихоод маргааш өглөө цуг уул руу гаръя” гэхэд ээж нь “За яахав, чи харин мэдээтэй яваарай” гэв.

Чэнь Жэнь гараа сэгсчин “Болохгүй ээ, осол гарвал яах билээ, та нар чинь ганцхан хүүтэй шүү дээ” гэхэд

Галсмаа хариуд нь “Энэ хавар манай хэсгийнхэн ганцхан удаа бэлтрэг суйлсан болохоор цаана нь гурван удаагийн ажил үлдчихээд байгаа. Хэрвээ энэ хэвээрээ байх юм бол цаад Бао Шүнь Гүй чинь намайг загнаад унана” гэлээ.

Чэнь Жэнь хариуд нь “Тэглээ ч гэсэн болохгүй ээ. Би танай хүүг дагуулж явснаас ганзага хоосон буцаад ирсэн нь дээр” гэв. Өвгөн ач хүүгээ өвөртөө тэврэнгээ “Баяр энэ удаа яваад хэрэггүй ээ. Миний хавханд ганц хоёр чоно орох байлгүй. Бэлтрэгний арьс биш, том чонын арьс тушаахад нормоо биелүүлж болно” гэлээ.

*Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртө чоно ажгуу. Гэргий Гоо марал ажээ. Тэнгис гатлаж ирээд Онон мөрний эх Бурхан Халдун уулнаа нутаглаж байхдаа Батцагаан нэрт нэгэн хөвгүүн төрүүлжээ.*

*Монголын нууц товчооноос*

Үүр цүүрийн гурван цаг хагасын үед Чэнь Жэнь, Ян Кө нар хоёр том нохой дагуулан Хар чулуут уулын ойролцоох нэгэн довцог толгой дээр авиран гараад, морьдоо довцогийн ар дахь далд газар чөдөрлөж орхив. Арслан, Анч шар нэрт хоёр сайн анч нохой ийм эрт боссон тул эрхгүй ангийн хийморь нь сэргээд, цастай газар элэглэн хэвтэж, ямар ч дуу шуу гаргалгүй ийш тийш сонор соргогоор ширтэн харна. Тэнгэрийг үүлс бүрхсэн учир сар, одны гэрэл ч үзэгдэхгүй. Түнэр харанхуй тал ер бусын хүйтэн агаад аймшигтай. Эргэн тойрон хэдэн арван газар тэр хоёроос өөр хүн байхгүй. Энэ агшинд чонон сүрэг гараад ирвэл довглоход хамгийн ашигтай цаг үе байв. Холгүйхэн орших Хар чулуут уул асар том араатны сийлбэр мэт тэр хоёрын сүрийг дарах тул Чэнь Жэньгийн ар нуруугаар хүйт даана. Тэр ардаа байгаа хоёр мориндоо санаа зовохын зэрэгцээ өөрийн энэ эрсдэлтэй алхмыг бодоод айх сэтгэл төрөв.

Гэнэт зүүн хойд талаас чонын улих чимээ гарч, түнэр харанхуй уулын хөндийн эргэн тойронд цуурайтаад удтал уянгалан сонсогдов. Хэдэн минутын дараа чонын улиан аажмаар замхарч нам гүм талд алсаас нохой хуцах чимээ сонсогдож эхэллээ. Чэнь Жэньгийн хажууд хэвтэх хоёр нохой урьдын адил дуу чимээ гаргахгүй. Тэр хоёр анд явах үедээ хуцаж болохгүй гэсэн бичигдээгүй хуулийг сайн ойлгох ажээ. Ер нь анч ноход шөнө хонь мал харж байх үедээ чанга хуцдаг боловч ууланд ан хийж байх үедээ огт чимээ анир гаргадаггүй. Чэнь Жэнь нэг гараа Арслангийн суганд хийж дулаацуулахын зэрэгцээ нөгөө гараар түүний хүзүүгээр нь тэвэрч байв. Нааш хөдлөхийн өмнө Ян Кө нохдыг хэр тааруухан хооллосон юм. Анд гарахдаа анч нохдыг цадтал нь хооллох эсвэл ор тас сойж болдоггүй. Учир нь их цадах юм бол омог сүр нь мохох бөгөөд хэт өлссөн нохойн биеийн хүч тамир сулардаг гэмтэй. Ноход идэш нь таарсан бололтой удаж төдөлгүй Чэнь Жэньгийн гар бүлээцээд ирэв. Тэр ч байтугай бүлээн гараараа нохойн хамрыг илэхэд цаадах нь тааламжтай янзтай сүүлээ хөдөлгөнө. Хажууд нь чонын ангууч нохой байгаа болохоор Чэнь Жэньгийн сэтгэл нэлээд уужуу тайвуу байлаа.

Залгаагаар хэдэн өдөр шөнийн явдалд Чэнь Жэнь сульдан ядарчээ. Уржигдар орой Ян Кө хэдэн дотно илгээлтийн эзэн малчидтай уулзан тэднийг цугтаа бэлтрэг суйлахаар явья гэхэд цаадуул нь: “Хар чулуут ууланд чонын үүр байхгүй. Тэгээд ч тийм эрт босно гэж төвөг” гэхээр үл барам өөрсдийг нь битгий яв хэмээн ятгаж билээ. Тэгээд мань хоёр шарандаа өөрсдөө уул руу гарахаар шийдэцгээсэн юм. Энэ мөчид өөрсдийнх нь тэжээсэн хоёр нохойноос өөр хань бараа болох юмгүй нэлээд эвгүй санагдаж байлаа.

Ян Кө, Анч шар нэрт нохойг тас тэвэрч Чэнь Жэньд шивнэн өгүүлрүүн: “Анч шар хүртэл нэлээд айж байх шиг байна. Хамаг бие нь чичрээд байхыг бодвол чонын үнэр авсан юм биш байгаа даа” гэлээ.

Чэнь Жэнь, Анч шарын толгойг илбэж зөөлөн дуугаар: “Битгий ай! Битгий ай! Үүр цайлаа. Чоно гэгээтэй үед хүнээс айдаг. Бид чинь уурга авч яваа шүү дээ” гэв.

Чэнь Жэньгийн гар ч гэсэн Анч шарын биетэй адил чичирч эхлэв. Гэвч тэр өөрийгөө тайвшруулан: “Бид хоёр дайсны ар талд очсон аюултай үүрэг гүйцэтгэж байгаа тагнуулууд шиг санагдаж байх чинь. Одоо миний нойр огт хүрэхээ больчихлоо” гэв.

Ян Кө ч гэсэн зоригоо чангалан “Чонотой тулалдана гэдэг байлдаж байгаагаас өөрцгүй. Биеийн хүч, оюун ухаан, эрч хүч, авхаалж самбаа гээд л гоо бүсгүй хэрэглэхээс бусад гучин зургаан арга 12 бараг тэр чигээрээ багтсан байна шүү!” гэлээ.

Чэнь Жэнь хариуд нь: “Битгий омогшоод бай! Гучин зургаан аргыг хэрэглээд ч чоныг дөнгөх нь юу л бол” гэв.

Ян Кө өгүүлрүүн: “Тэр ч харин үнэн байх шүү. Бид нар тэгвэл одоо ямар арга хэрэглэж байгаа юм бэ? Өлөгчин чоно үүрэндээ буцан бэлтрэгнүүдээ хөхүүлэх сэжмийг ашиглаж чонын үүрийг олсон шүү дээ. Гучин зургаан аргын дотор ийм зүйл байдаггүй байх аа. Хөгшин аав ч үнэхээр овжин зальтай юм аа. Мөн айхтар арга бодож олсон байгаа юм шүү” гэлээ.

“Хэн чоныг тийм олон адуу мал бариад идчих гэсэн юм бэ? Аав түүнд нь л өширхсөн байж таарна. Би энэ удаа түүнтэй хамт чононд хавх тавихаар явахдаа аав хэдэн жил ч тийм ажил хийгээгүй гэдгийг олж мэдсэн юм. Хөгшин аав угаас чоныг хүйс тэмтрэн устгахыг таашаадаггүй шүү дээ” гэв.

Үүр зугуухан цайж, Хар чулуут уул аварга том амьтны чулуун сийлмэл биш харин асар том хад асганаас бүтсэн болох нь зугуухан тодорч эхэллээ. Зүүн зүгээс тодрох гэгээ үүлсийн сэжүүрийг нэвглэн гийгүүлж эхлэхэд алсын бараа улам илүү тодорлоо. Хүн ноход цастай газар элэглэн хэвтсээр. Чэнь Жэнь нэг нүдний дурангаа авч ийш тийш харахад газрын чийг их тул дурангийн шил цантана. Хэрвээ өлөгчин чоно газрын уур цангаар халхлан үүрэндээ сэмээрхэн буцчихвал тэд бүтэн шөнийн турш дэмий хүлээсэн хэрэг болно гэж санаа зовж байв. Азаар газрын цан хүүрэг сарнин нимгэн хүдэн болон хувираад, өвсний толгой дээгүүр нааш цааш найгалзана. Хэрвээ ямар нэгэн амьтан явж өнгөрөх юм бол харин ч манан дунд бүртэлзээд тод харагдах нь гарцаагүй болов.

Гэнэт Анч шар толгойгоо баруун тийш хандуулаад зооны үсээ босгон, хамаг биеэ чангалан мөлхөж эхлэхэд Арслан ч гэсэн баруун тийш дагаж харлаа. Чэнь Жэнь ямар нэгэн зүйл болсныг ойлгож дурангаа баруун талын өвстэй нуга руу чиглүүлэв. Уулын хормой бэл болон нугын залгаа нам дор газар баахан шаргал хулс, зэгс ургаад зүүн хойд зүг хөвөрчээ. Нөмөр нөөлөг ийм газар чононд их таатай бөгөөд тал нутгийн малчидтай партизаны дайн хийхдээ халхавч болгон ашигладаг. Өвөл хаврын хатсан зэгс чонын нуугдаж унтдаг оромж болдог бөгөөд тэр нь харин анчид болон анч нохдын чоно авлах тохиромжтой газар нь юм гэж Билиг өвгөн байнга ярьдаг билээ. Анч шар, Арслан хоёр хатсан зэгс чонын хөлд шажигнах чимээг лав сонссон буй за. Цаг хугацаа чиглэл нь ч таарч байгаа тул өлөгчин чоно үүрэндээ ирж байгаа байх гэж Чэнь Жэнь бодлоо. Тэр зэгсний захыг нарийвчлан ажиглаж чонын шурган гарч ирэхийг хүлээсээр байв. Зэгс ихэвчлэн нам дор газар ургадаг учраас хавар цас хайлаад ус тогтож мэдэх тул чоно тэнд нүхээ ухдаггүй гэж өвгөн хэлж байсан удаатай. Чонын үүр ихэвчлэн өндөрлөг, ус орохооргүй газар байрладаг. Тиймээс чоно тэндээс шурган гарч ирвэл чонын үүр ойролцоох уулын бэлд байж таарна хэмээн Чэнь Жэнь таамаглав.

Хоёр нохой хатсан зэгсийг цоо ширтэн нэг хэсэг хөдөлгөөнгүй болоход Чэнь Жэнь нохойны харсан зүг ажиглах зуур зүрх нь түг түг цохилж эхлэв. Нэг том чоно зэгсэн дундаас цээжин биеэ цухуйлгаад ийш тийш харж байлаа. Хоёр нохой тэр даруй доош навтасхийн эрүүгээ доош газар наав. Хоёр хүн ч гэсэн аль болох навтайн хэвтэцгээв. Чоно уулын бэлийг нарийвчлан ажигласнаа дараа нь зэгсэн дундаас шурдхийн гарч зүүн хойд зүгт байрлах нэгэн жалгыг чиглэн хурдлав. Чэнь Жэнь дурангаараа чонын араас ажиглахад энэ чоно түрүүчийн удаа харсан өлөгчин чоно лугаа төстэй мэт санагдав. Чоно нэлээд хүч гарган хурдлан явахыг үзвээс урьд шөнө хэн нэгэн айлын хоттой хониноос цадталаа идсэн шинж илт байлаа. Хэрвээ өнөөдөр энэ өлөгчин чоно ганцаараа байх юм бол хошоод хүн, анч нохой байгаа болохоор айгаад байх юм байхгүй. Ялангуяа Арслан ганцаараа ч энэ өлөгчин чоныг өлхөн дөнгөнө гэж тэр бодож байв.

Өлөгчин чоно уулын бэл өөд өгслөө. Одоо түүний гүйсэн зүгт гарцаагүй чонын үүр байж таарна гэж Чэнь Жэнь бодов. Гэвч чоно гэнэт хурдаа сааруулан зогсоод биеийг эргэж баруун, зүүн тийш харж байснаа хүн, нохой нуугдаж буй зүгт харснаа хөдөлгөөнгүй болж хоцров. Манай хоёр сандарсандаа амьсгаа ч авч чадсангүй. Чонын зогсож буй газар зэгснээс хавьгүй өндөр тул биднийг харчихсан байж мэдэх юм. Чоно сая уулын бэл рүү өгсөх үед нохойтойгоо хамт хэдэн алхам хойш ухарчихгүй дээ, мөн ч туршлага нимгэн байна даа хэмээн Чэнь Жэнь өөрийгөө голж байв. Тэгээд ч чонын сонор сэрэмж ийм их гэж хэн мэдэх билээ дээ. Чоно цээжээ өргөн өөрийн олж тогтоосон дайсны байрлалыг нарийвчлан ажиглав. Тэр өөрийн зогсож байсан газартаа хоёронтоо эргэлдсэнээ уулын зүүн хажууг чиглэн яваад удаж төдөлгүй нэг нүхэнд шурган оров.

Уухайс, үүр нь байна. Энэ удаа ч бид өлөгчин чоныг бэлтрэгнүүдтэй нь хамт барьж авах боломжтой боллоо доо хэмээн Ян Кө алга ташин баясав.

Чэнь Жэнь ч гэсэн их догдолсон байдалтай босож ирээд: “Алив, мориндоо мордоорой!” гэв.

Хоёр нохой Чэнь Жэньг тойрон аахилан дэвхцээд, эзнийхээ ямар нэгэн тушаал өгөхийг хүлээх мэт байв. Чэнь Жэнь сандарсандаа нохойдоо юу гэж хэлэхээ мэдэхгүй гараараа чонын үүрний зүг заагаад үл мэдэг исгэрэв. Хоёр нохой тэр даруй уулын уруу чавхдаж, зүүн талын хэвгийг байрлах чонын үүрэнд давхин хүрлээ. Мань хоёр ч гэсэн уулын уруу нисэх мэт хурдлан, морьдын чөдрийг тайлж, эмээлийн бүүргээс барин уургаа тулж мориндоо мордоод чонын үүрийг чиглэн хөдөллөө. Хоёр нохой нэгэнтээ чонын үүрэнд хүрч очоод ширүүхэн хуцалдаж байв. Тэр хоёрыг ойртон очиход Арслан галзуу нохой мэт соёо шүдээ ярзайлган чонын үүр рүү давхин орсоноо буцан гарч ирээд эргэн дайрах боловч гүн орж зүрхлэхгүй байлаа. Анч шар ч гэсэн нүхний амсар дээр чанга хуцан сүрийг үзүүлж, газар малтан цас шороо бужигнуулна. Мань хоёр мориноос хөлбөрөн буугаад чонын үүр рүү гүйн очоод хартал дал наян сантиметр орчим зууван нүхний амсар дээр мөнөөх өлөгчин чоно улайрсан байдалтай нохдыг эсэргүүцэн хамгаалж, хүдэр том биетэй Арслан руу хазахаар завдан ухрааж, хоёр нохойг хавьтуулах янзгүй догшрох нь айдас хүрэм ажээ.

Чэнь Жэнь уургаа хаяж хоёр гараараа төмөр хүрзийг шүүрэн аваад чонын толгой руу цохиход чоно бултаж үүр рүүгээ буцан орлоо. Өлөгчин чоно шүдээ ярзайлган дахин дайран гарч ирэх үед Ян Кө богино царилаар түүнийг цохисон боловч оносонгүй. Ийнхүү хэдэнтээ ухарч дайрсны эцэст Чэнь Жэнь чонын толгой руу хүрзээ буулгахад Ян Кө ч хувь дутсангүй. Гэвч

чоно урьдын адил улайрч догширсон хэвээрээ, биеэр метр орчим хэртэй ухрахад Арслан дайран ороод цээжиндээ хазуулж, цусаа савируулсаар гарч ирэв. Улангассан нохой нүдээ улайлган чонын үүр рүү улам гүн дайран ороход зөвхөн сүүл нь цухуйх төдий үзэгдэнэ.

Чэнь Жэнь гэнэт уургаа санаж газраас түүнийг шүүрэн авав. Ян Кө ч тэр даруй Чэнь Жэньгийн санааг ойлгон өгүүлрүүн: “Зөв дөө хө. Хоёулаа түүнийг уургалаад авдаг хэрэг” гэлээ. Чэнь Жэнь уурганы сурны орооцолдоог гарган нүхний амсар дээр бэлдээд хүлээж байв. Одоо чоно ухасхийн гараад ирэхэд нь түүнийг уургалж татаад гаргаад ирвэл Ян Кө төмөр царилаараа түүнийг балбаж, хоёр нохой түүн рүү дайрахад чоно гарцаагүй үхэхээр санагдана. Чэнь Жэнь сандарсандаа амьсгаа ч авах тэнхэлгүй болжээ. Гэвч тэр хараахан уургалж завдаагүй байтал Арслан чононд хазуулаад ухрахдаа уурганы хуйванд хөл нь орооцолдож, залгаад толгойдоо шархадсан чоно нүхнээсээ дайран гарч ирэхдээ уурганы хуйвны үзүүр дээр гишгэж орхив. Чоно уурганы хуйванд хүрээд цахилгааны утсан дээр гишгэсэн мэт бондгосхийн цочиж, үүр рүүгээ гүн шургаад дахин толгой цухуйлгасангүй. Чэнь Жэнь яаран сандран чонын үүр рүү шагайн үзвээс доошоо гучин таван градус орчим хэвгий, цаашаа хоёр метр орчим яваад өөр тийш мурийж цаашаа хэр гүн нь мэдэгдэхгүй болов. Ян Кө уурласандаа чонын үүр рүү гурвантаа чанга дуугаар хашгирсан боловч онгойн харлах чонын үүр түүний дууг залгин авав. Чэнь Жэнь чонын үүрний өмнөх тэгш газар дээр лагхийн суугаад “Би ч ёстой тэнэг амьтан юм аа. Уургаа эртхэн санасан бол энэ чоно аль хэдийн амь тавьсан байхгүй юу! Чонотой тулалдахад алдаа огт гаргаж болохгүй, маш овсгоотой байх хэрэгтэй юм байна даа” гээд харууссан гэж жигтэйхэн.

Ян Кө ч гэсэн Чэнь Жэньгээс илүү гонсойж үзүүрлэсэн төмөр царилыг газар хатгаад, их л уурсангуй: “Завхарсан юм. Энэ чоно бидэнд буу байхгүйг үзээд элэг барьж байх шив дээ. Хэрэв буутай байсан бол муу золигийн гавлыг хага буудахгүй юу” гэв.

“Одоо чинь нэгдүгээр зэргийн дайны бэлэн байдалтай байгаа болохоор буун дуу гаргаж болохгүй гэж аж ахуйн удирдлага тушаасан. Тийм болохоор буу байгаад ч ямар нэмэр байх билээ” гэж Чэнь Жэнь өгүүлэв.

“Ийм маягтай байгаад ямар нэмэр байх билээ дээ. Хоёулаа цаасан буу тэсэлбэл ямар вэ?” гэж Ян Кө хэлэв.

“Цаасан буу чинь буу дуугаргаснаас өөрцгүй шүү дээ” гээд Чэнь Жэнь тайвширч “Хэрвээ бид хойд зүгт байгаа чононуудыг айлгаад, үргээчихвэл чонын ав хомрогоны төлөвлөгөө баларна гэсэн үг. Аж ахуйн хүмүүс бид хоёрыг харааж зүхээд зогсохгүй юм болох байлгүй. Тэгээд ч цаасан буу ямар чоныг алж чадах биш” гэлээ.

Ян Кө ч мөчөөгөө өгөх янзгүй “Чоныг алж чаддаггүй юм аа гэхэд түүний сүнсийг нь зайлтал айлгана биз дээ. Дээр нь бас утаж болно. Энэ газар хил хамгаалах зурвасаас гуч дөчин километр зайтай болохоор чонон сүрэг ч яахин сонсох билээ. Чи хэрэв санаа зовоод байгаа бол цаасан бууг үүр рүү шидсэний дараа би хөдсөн дээлээ тайлаад үүрний амсрыг халхалж байя. Гадна түүний чимээ огт сонсогдохгүй” гэлээ.

“Хэрвээ чоно гарч ирэхгүй бол яах болж байна вэ?” хэмээн Чэнь Жэнь асуув.



Ян Кө бүсээ тайлангаа “Гарцаагүй гарч ирнэ ээ. Би адуучдын ярихыг сонссон юм. Чоно буун дуу, дарийн үнэр хоёроос онцгой их айдаг. Хэрвээ гурван ширхэг цаасан буу шидчих юм бол зургаан удаа дэлбэрэх дуу нүхэнд битүү нүргээд, гадаа орчноос хэд дахин илүү байх болно. Чонын үнхэлцэгийг хагалах нь гарцаагүй. Чонын үүрэнд зай давчуу, дарийн үнэр мөд гарахгүй хахаж цацах нь гарцаагүй. Гурван цаасан буу дэлбэрсэний дараа чоно хахаж цацсаар гарч ирнэ гэдэгт би мөрийцсөн ч бэлэн байна. Чи харин уургалж авахаар бэлдээд байж бай. Чонын араас баахан бэлтрэгнүүд ч гараад ирнэ тэгэхээр болж байгаа биш үү” хэмээн хэлэв.

“За тэгье. Одоо харин хоёулаа сайн бэлдэнэ шүү. Ойролцоо өөр нүх байна уу гэдгийг би үзээдэхье. Зальтай туулай гурван үүртэй гэдэг, тэгвэл зальтай чоно хэдэн ч үүртэй байх юм билээ. Хүний бодоогүйг боддог амьтан шүү” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

Чэнь Жэнь мориндоо мордон хоёр нохойгоо дагуулаад чонын үүрний эргэн тойронг сайтар ажиглавал цагаан цасан дунд чонын хар нүх олдох нь амар байх гэж боджээ. Гэвч ойр орчимын 100 метр газраас Чэнь Жэнь болон ноход өөр ямар ч өөр нүх олсонгүй. Чэнь Жэнь мориноосоо буугаад хоёр морио холхон аваачиж тушчихаад чонын үүрний өмнө очиж уурга, төмөр хүрз, малиа зэргийг бэлдэж тавьлаа.

Арслан их л зовиуртай байгаа бололтой доош тонгойн өөрийн шархаа долоохыг Чэнь Жэнь олж үзэв. Түүний цээжин дэхь хоёр хуруу орчим чононд хазуулсан шархны арьс салбарсан болохоор зовиуртай байх нь аргагүй. Гэвч нохой огт гаслахгүй ажээ. Мань хоёрт ямар нэгэн шархны эм, боолт байхгүй болохоор нохой өөрийгөө анагаах уламжлалт аргыг хэрэглэн хэлээрээ шархаа долоон шүлсээрээ ариутгаж, цусаа тогтоон өвчнөө намдаах ажээ. Гагцхүү гэртээ эргэж очсоны дараа түүнд шархны эм түрхэж, боож өгөх боломжтой юм. Энэ нохойны бие дэхь олон сорви чононд хазуулсанаас үүдэлтэй тул тэр чононд ийнхүү өширхдөг нь ч аргагүй билээ. Арслан бол чононоос дутхааргүй сүр хүчтэй монгол нохой болохыг Чэнь Жэнь тэр үед ухаараагүй явсан ажээ.

Ян Кө ч гэсэн бэлтгэлээ хангаж гүйцээд хөдсөн дээлээ нөмөрч гурван хэлхээ хүчтэй цаасан бууг барьчихаад, амандаа “Тэнгис гол” нэрийн тамхийг асаан зуугаад хүлээж байв.

Чэнь Жэнь түүнийг шоолон “Чи ч анчин хүн биш, харин хонгил замын дайн явуулж байгаа япон цэрэгтэй адилхан байх чинь” гэв.

Ян Кө ч гэсэн хүд хүд инээж “Усыг нь уувал ёсыг нь дага гэдэг юм аа хө! Монгол дээл өмссөн, морьтой анчин зогсож байгааг харахгүй байна уу? Чонын үүрэнд лав хорт хий эсэргүүцэх төхөөрөмж байхгүй нь лавтай” гэв.

Чэнь Жэнь хариуд нь “За тэгвэл чи наад хийн бөмбөгөө шидээд үз. Хэрэг болох нь уу, үгүй юу үзье” гэлээ.

Ян Кө татаж байсан тамхиараа цаасан бууны утсыг шатааж, пис пас хийлгэн, утаа суунаглуулсаар чонын үүр рүү шидчихэв. Залгуулаад үлдсэн хоёрыг асааж шидэхэд гурван цаасан буу чонын үүрний гүнд унасны эцэст хөдсөн дээлээр амсарыг нь таглалаа. Удаж төдөлгүй чонын үүрэн дотор цаасан буу дэлбэрэх чимээ зургаантаа сонсогдоход хөл доорхи газар үл мэдэг чичирхийлнэ. Чонын үүрэнд лавтайяа аянга нижигнэж утаа тортог дүүрч

байгаа нь лавтай. Монголын хээр талын чонын үүр урьд өмнө ийм сүртэй дэлбэрэлтэд өртөж байсан нь үгүй биз ээ. Харамсалтай нь тэр хоёр чонын үүрний гүн дэхь улианыг сонсож чадсангүй. Мань хоёр хорслоо тайлсан шинжтэй амьсгаа авав.

Ян Кө даарсан янзтай хоёр гараараа мөрөө тэврэн “Хэзээ амсрыг нээвэл болох вэ?” гэж асуулаа.

Чэнь Жэнь хариуд нь “Жаахан таглаж бай. Эхлээд жаахан амсар гаргаад утаа савсаж байна уу эсэхийг хараадахъя. Түүний дараа бүхэлд нь нээж болно” гэлээ.

Чэнь Жэнь хөдсөн дээлийн сэжүүрийг нээж үзвэл олигтой утаа үзэгдэхгүй тул дахин түүнийг таглав. Тэр Ян Көг дагжин чичирч байхыг үзээд бүсээ тайлан түүнтэй өөрийн дээлийг хуваан нөмөрье хэмээн боджээ.

Гэвч Ян Кө гараа савчин “Мэдээтэй байгаарай чоно одоо гарч ирэх болж байгаа шүү. Чи бүсээ тайлах юм бол хөдлөхөд амаргүй болно. Би тэснэ ээ, зүгээр” гэлээ.

Хоёр хүн ийн ярьж байх зуур Анч шар, Арслан хоёр босож ирээд хүзүүгээ баруун хойд зүг рүү зунган гаслах нь ихэд сандралдаж байгаа бололтой. Хоёр хүн яаран тэр зүг харваас баруун хойд зүгт хорь орчим метр зайтай газар доороос цэнхэр утаа суунаглаж байв.

Чэнь Жэнь ухасхийн босоод чанга дуугаар “Болох оо байлаа шүү. Тэнд өөр нэг нүх байсан байна. Чи энэ нүхээ харж байгаарай! Би очиж үзчихээд ирье” гээд төмөр хүрзийг авч утаа гарч байгаа зүг хоёр нохойгоо дагуулан гүйв.

Утаа олгойдох газар дороос гэнэт нэг чонын толгой цухуйснаа газар газар ангиллын пуужин сүрхийн хөөрөх мэт уулын хормой дахь зэгстэй газрыг чиглэн хурдалсаар удаж төдөлгүй далд оров. Арслан түүний араас ухасхийн шурган орж, зэгсний оройг найгуулсаар чанх хойшоо яваад өглөө.

Чэнь Жэнь чонын арганд автах вий хэмээн айгаад нохойгоо буцаад ир хэмээн дуудсан боловч чоныг орхилгүй хөөн одов. Анч шар зэгсний хаяанд тулаад цааш орж зүрхэлсэнгүй, бэлгэдлийг бодон хэдэнтээ хуцсанаа эргэн ирлээ.

Ян Кө хувцсаа өмсөнгөө Чэнь Жэньг дагалдан утаа савсаж байгаа газрыг чиглэн алхав. Тэр нүхийг дөнгөж шинээр малтсан бололтой шинэхэн шороо, чулуу ил гарсан нь мань хоёрыг мэл гайхуулж, цэл хөхрүүлжээ. Ердийн цагт газрын гадаргуугаас ялгагдахгүй энэ нүх хэрэгтэй цагт өлөгчин чоно ухаж малтаад, гарч зугтах нөөц амсар байсан бололтой.

Ян Кө уурласандаа гүрээний судсаа гүрвэлзүүлж: “Үхэж байсан өлөгчин чоно биднийг ганц баллалаа шүү” хэмээн хараана.

Чэнь Жэнь уртаар санаа алдан: “Зальтай туулайн гурван үүрийг хэдий нууцгай ч гэсэн олж болдог. Харин зальтай чоно хэдэн үүртэйг хэн яаж мэдэх билээ. Энэ үүрний байрлал их оновчтой байгааг харж байна уу? Их хэвгий газар ухсаны дээр залгуулаад зэгс байгаа болохоор хэдхэн алхаад л аюулаас дайжих боломжтой юм. Энэ үүрийг маш сайн бодож

сонгосон болохоор найм, арван зальтай туулайн үүрнээс илүү давуутай ажээ. Түрүүчийн удаа Бао Шүнь Гүй чоныг ойрын, шөнийн, довглох, партизаны, хөдөлгөөнт зэрэг олон дайн хийж чадна гэж байсан. Дараа би түүнтэй уулзахдаа чоно бас хонгил замын, халхавчилсан дайн зэргийг хийж чаддагаас гадна энэ хоёр аргыг хослуулан хэрэглэдэг юм байна гэдгийг хэлж өгье байз. “Цэрэг хэмээгч зальхай ёсон билээ” гэсэн үг байдаг шүү дээ. Тэгвэл чоно хэмээгч энэ хорвоогийн хамгийн зальхай цэргийн бодлоготон ажээ” гэв.

Ян Кө ч гэсэн амьсгаадсан хэвээр “Манай хятадын кинонд Хуа Бэйгийн хонгил замын тулалдаан, халхавчилсан тулалдаан зэргийг хорвоо дэлхийд урьд өмнө байгаагүй ховор нээлт юм шиг л сүр бадраагаад байдаг. Үнэн хэрэгтээ чоно гэдэг амьтан хэдэн түмэн жилийн өмнө энэ аргуудыг нээчихсэн юм байна шүү дээ” гэв.

“Чи арай ингээд бууж өгөх гэж байгаа юм биш биз дээ” хэмээн Чэнь Жэнь асуухдаа ганц хамсаатан нь яваад өгөх юм биш байгаа даа хэмээн айж байлаа. Чонын үүрээр оролдоно гэдэг ганц хүний хийх ажил яавч биш билээ.

“Яалаа гэж дээ. Тал нутагт ганцаараа хонь хариулна гэдэг уйтгартай. Харин чонотой ухаан бодол, эр зоригоор тэмцэлдэнэ гэдэг зугаатайгаас гадна ухаан тэлж өгдөг. Би чинь хоньчин хүн болохоор чоно намнана гэдэг миний үндсэн үүрэг” гэж цаадах нь хэлжээ.

Тэр хоёр том нүхний амсар дээр явж очиход үүрнээс савсах утаа арай намдсан боловч дарийн үнэр хахаж цацам хэвээр байлаа.

“Энэ айхтар дуу чимээ, дарь хүхрийн үнэрт бэлтрэгнүүд гараад ирэх болсон баймаар юм даа. Арай үүрэндээ бүтээд үхчихсэн юм биш байгаа даа” хэмээн Ян Кө дотогш шагайнгаа өгүүлэв.

“Би ч гэсэн бас тэгж бодож байна. Хоёулаа дахиж хагас цаг хүлээе. Хэрвээ гарч ирэхгүй бол бүтэхээсээ өнгөрнө байх шүү. Ийм гүн нүхийг яаж ухах билээ дээ. Гүн худаг ухахаас ч амаргүй хэрэг болж таарна. Чи бид хоёр гурван өдөр шөнө ухаад ч адагт нь хүрч чадахгүй. Гэтэл чонын сарвуу ийм том нүхийг ухчихдаг мөн айхтар хүчтэйеэ. Тэгээд ч бэлтрэгнүүд бүгдээрээ үхчихсэн байвал нүхийг ухаж малтаад ч ямар хэрэг байх билээ дээ” гэж Чэнь Жэнь өгүүлэв.

Ян Кө санаа алдангаа “Баяр байсан бол мөн сайхан аа. Түүнийг оруулчихгүй юу?” гэв.

Чэнь Жэнь ч бас санаа алдан “Би Баярыг дагуулан ирж сэтгэл түвдээгүй юм аа. Энэ дотор өөр том чоно байхыг хэн байг гэх билээ? Монголчууд мөн амаргүй улс шүү. Галсмаа ганц хүүтэй атлаа түүнийг чонын сүүлнээс татуулж, чонын үүрнээс бэлтрэг суйлуулахаар явуулж байдаг. Одоо эргээд санахад “Хүүгээ хайрлаад байвал чоно намнаж чадахгүй” гэсэн хятад даяар дэлгэрсэн зүйр үг бараг л монголын хээр талаас гаралтай болов уу даа. Монголчууд тэртэй тэргүй хятадыг зуу гаруй жилийн турш ноёрхож байсан юм чинь. Би урьд нь энэ үгийн утгыг сайтар ухаж ойлгодоггүй байсан юм. “Хүүгээ хайрлавал чоно намнаж чадахгүй” гэхээр нь өөрийн хүүгээ өгөөш болгоод чоныг дуудан ирүүлнэ гэсэн үг үү гэж боддог байлаа. Тэгвэл дэндүү утгагүй, зүйд нийцэхгүй хэрэг болох биш үү! Гэвч хожим хүүхдээрээ аюулыг сөрүүлэн чонын үүрнээс бэлтрэг суйлуулахыг хэлсэн болохыг ойлгосон юм даа. Ийм гүн,

бачуухан чонын үүрэнд хүүхдээс өөр хэн орж чадах билээ дээ. Монгол хүүхнүүд хятад хүүхнүүдтэй адил хүүхдээ эрхлүүлдэг бол энэ үндэстэн аль хэдийн мөхөөд өгөх байжээ. Тиймдээ л монгол хүүхдүүд бүгдээрээ эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужилтай эрс болон өсдөг ажээ” гэв.

Ян Кө их л хорсолтойгоор “Тал нутгийн чоно үржих чадвараар хятадуудаас ч илүү. Дээр нь ийм хэцүү бэрх үүр ухаж бэлтрэгээ төрүүлдэг нь биднийг ганц чадаж байна даа. Хоёулаа жаахан юм идвэл яасан юм бэ? Өлсөж байх чинь” гэлээ.

Чэнь Жэнь мориныхоо хажууд очин эмээлийн ганзаганаас уясан бэрзээнтэн цүнхийг авч нүхний дэргэд буцан ирэв. Анч шар энэхүү хир даг болсон шар цүнхийг хараад сүүлээ хөдөлгөн аахилсаар гүйж ирлээ. Чэнь Жэнь анд явах үедээ нохойн хоолыг энэ цүнхэнд хийж явдаг юм. Тэр цүнхийг онгойлгож дотроос нь хэсэг мах авч Анч шард шидэж өгөөд, үлдсэнийг Арсланд үлдээв. Тэр хараахан эргэж ирээгүй болохоор Чэнь Жэньгийн сэтгэл зовнисоор байлаа. Өвөл хаврын зэгс гэдэг чонын үүрлэх гол газар учраас Арслан сүрэг чонын дунд яваад орчихсон бол юу болох нь ойлгомжтой. Арслан хонин сүргийг хамгаалах гол хүч учраас энэ удаа золгүй явдалтай учирвал ямар сайн байх билээ.

Анч шар тааламжтай нь аргагүй сүүлээ хөдөлгөн махаа иднэ. Энэ нохой туулай, үнэг, хярс, зээр зэргийг үзэх юм бол ер бусын зоримог болдог. Түүнээс гадна олон ноходтой цуг ганц нэг чонотой таарах юм бол оройлон ордог боловч хүчин мөхөс үедээ ганцаараа дайрна гэж үгүй. Тэр сая Арсланд тусалж зэгс рүү орсон чоныг хөөгөөгүй нь өөр чонын сүрэг байж магадгүй гэж айснаас болсон хэрэг юм. Түүний энэхүү амиа хоохойлох чадвар нь амьдрах аргынх нь илрэл гэлтэй. Чэнь Жэнь энэхүү шударга журам тааруухан атлаа эзнийхээ санааг сайн ойлгодог нохойдоо хайртай байдаг юм. Гэвч энэ хавраас тэр Арсланд илүү сайн болоод байгаа билээ. Тэр хэдийгээр эзэнтэйгээ ойлголцохдоо маруухан боловч араатан зан нь илүү хүчтэй илэрдэг юм. Хахир хатуу өрсөлдөөнтэй энэ орчлонд аль нэгэн үндэстэнд араатнаас дутахгүй хатан зориг, зан чанар юу юунаас илүү чухал билээ. Ийм урьдчилсан нөхцөл үгүй үед билиг оюун, эрдэм боловсрол байгаад ямар хэрэг байх вэ. Үндэстний зан чанар доройтохоор бусад үндэстэнтэй ураг барилдах, цагаан хэрэм барих эсвэл тэдэнд тал засаж бууж өгөх адаглаад л оготно зурам мэт үржих чадвартаа дулдуйдан оршин тогтнохоор санаархдаг бус уу! Тэр босоод дурангаа баруун хойд зүгийн зэгс рүү чиглүүлэн Арслангийн араас харуулдав.

Гэвч Арслангийн бараа туруу ч алга байлаа. Чэнь Жэнь өврөөсөө Галсмаагийн түүнд өгсөн хурганы арьсан уут гаргаж ирсэн нь ус чийг нэвтрүүлдэггүй өвөртөлж явахад дулаахан мөртлөө хувцас бохирдуулдаггүй эд байлаа. Тэр дотроос нь хэвийн боов, борц, хэдэн хурууд гаргаж ирээд Ян Көтэй хувааж идлээ. Тэр хоёр хоол идэх зуураа цаашид яах ийхээ бодоцгоож байв.

Ян Кө хэвийн боов хугалан амандаа хийнгээ “Энэ чоно гэдэг амьтан маш зальтай болохоор хүний санаж бодоогүй газар бэлтрэгтэй үүр нь байж таарна. Хоёулаа тийм үүр олоод авах юм бол яасан ч орхиж болдоггүй юм шүү. Утаад болдоггүй юм бол арав хорин хувин ус ээлжлэн цутгаж байгаад бэлтрэгнүүдийг гаргаад ирье л дээ” гэв.

Чэнь Жэнь түүнийг шоолонгуй янзтай хараад “Чи энэ элс, чулуурхаг газрын хаанаас тэр их ус

олж ирэх гээ вэ?” гэлээ.

Ян Кө хэсэг зуур бодож байснаа: “Нээрэн, тэртэй тэргүй чонын үүрэнд том чоно байхгүй юм чинь хоёулаа Анч шарыг дотогш оруулаад бэлтрэгнүүдийг нэг нэгээр зуулган гаргаж ирвэл яасан юм бэ?” гэлээ.

Чэнь Жэнь писхийтэл инээд алдаад: “Нохой аль эрт чононоос урваад хүнд дассан амьтан. Түүний үнэрч хамар өлөгчин чоно байхгүй бэлтрэгтэй үүрнүүдийг олж нэг нэгээр нь зуугаад гаргаад ирдэг бол тал нутагт чоно гэдэг амьтан байхгүй болно биз дээ. Чи чинь хоньчин болсон биш улам тэнэг болоо шив дээ” гэв.

Ян Кө мөчөөгөө өгөлгүй: “Хоёулаа туршаад үзье л дээ. Нэг их хэцүү юм байгаа биш” гэчихээд тэр Анч шарыг нүхний амсар дээр дуудан аваачихад үүрэн дэхь дарь хүхрийн үнэр нэлээд намдсан байлаа. Ян Кө гараараа чонын үүр рүү зааж “Туу, туу” хэмээн турхирав. Анч шар Ян Көгийн санааг ойлгосон бололтой айн хулгаад арагш цахлана. Ян Кө хоёр хөлөөрөө Анч шарын биеийг хавччихаад гараараа урд хоёр хөлийг нь барин чонын үүр рүү зүтгүүлэхэд цаадах нь айсандаа сүүлээ хавчаад гаслан тийчигнэв. Тэр өрөвдөлтэй нүдээр Чэнь Жэньг харах нь энэ хэцүү албаас чөлөөлөхийг гуйж байгаа мэт ажээ.

Чэнь Жэнь “Харсан биз дээ. Одоо боль доо. Хувьсал гэдэг амаргүй. Эргэн хувьсах түүнээс ч хэцүү байдаг юм. Нохой гэдэг амьтан буцаж чоно болно гэж байхгүй шүү дээ. Хэрвээ түүнийг буцаан хувьсгая гэх юм бол дорой буурай, залхуу тэнэг амьтан л болж хувирна. Хүн ч гэсэн адилхан биш үү” гэхэд

Ян Кө Анч шарыг тавьж “Арслан байхгүй нь мөн харамсалтай хэрэг ээ. Хэрэв тэр байсан бол чононоос дутахгүй эр зоригтой болохоор дотогшоо давхиад л орох байсан юм” гэв.

Чэнь Жэнь “Хэрвээ тэр дотогшоо орж зүрхлэвэл бэлтрэгнүүдийг бүгдийг хазаад алчих байлгүй. Гэтэл надад амьд бэлтрэг хэрэгтэй байгаа шүү дээ” гэхэд

Ян Кө толгой дохин “Тэр ч тийм шүү. Тэр золиг чоно харах л юм бол алчих гээд байдаг юм” гэлээ.

Анч шар махаа идэж гүйцээд ойр хавиар гүйж энэ тэрүүгээр үнэртэн, жаахан этгээд сонин зүйл харагдвал түүн рүү сарьж тэмдэг үлдээх ажээ. Тэр улам холдсоор, Арслан ч эргэж ирдэггүй. Чэнь Жэнь, Ян Кө хоёр үүрний дэргэд юу хийхээ мэдэхгүй, дэмий хүлээсээр л байлаа. Чонын үүрэнд өчүүхэн ч чимээ анир алга. Тэр нүхэнд дор хаяж долоо найман бэлтрэг байгаа. Олонхи нь утаанд бүтээд үхсэн байдаг юм гэхэд ганц нэг нь ч гэсэн амьд мэнд гараад ирмээр юм даа. Тэд нар далд зөн совингоор гадагш тэмүүлэх нь лавгай. Дахин хагас цаг өнгөрсөний дараа чонын бэлтрэг гарч ирэхгүйг үзээд тэр хоёр дотроо “Энэ үүрэн дэхь бүх бэлтрэгнүүд бүтэж үхээгүй л юм бол угаас ямар ч бэлтрэг байхгүй байсан байж таарлаа” хэмээн бодоцгоож байлаа.

\* \* \*

Тэр хоёр юм хумаа хураагаад буцахаар зэхэж байтал ар талд байх довцгийн цаана Анч Шар

ямар нэгэн ангийн үнэр авсан бололтой айхтар хуцахыг олж сонсоцгоов. Чэнь Жэнь, Ян Кө хоёр мориндоо мордон Анч шарын байгаа газрыг чиглэн давхицгаалаа. Довцгийн орой дээр гараад харваас Анч шарын хуцах чимээ сонсогдох боловч чухам хаана байгаа нь үзэгдсэнгүй.

Тэр хоёр нохойн хуцах чимээгээр баримжаалан цааш явсан боловч морины туурай цасан дорхи нуранги чулуунд бүдрэх тул морины амыг татасхийхээс өөр аргагүй болов. Өмнө талд нь ганга жалга сүлжилдэн, бут сөөг сүглийгээд, цасан дээр том жижиг олон амьтны мөр байгаа нь энэ газар туулай, үнэг, чоно, хярс, үен зэрэг амьтад хөлхдөгийг илтгэнэ. Цасан дорх сул чулуудын завсар зайгаар босоо хүний бэлхүүсээр татам улалж, сондуул зайгүй ургасан нь дотор газрын эзгүй уулан дахь чимээгүй хотыг санагдуулах ажээ.

Мань хоёр хэдийгээр жолоо татасхийн явах боловч морь нь байн байн цасанд халтиран бүдэрч байлаа. Энд мал сүргийн дуртай бэлчээрийн өвс нэгээхэн бээр ч үгүй тул Чэнь Жэнь, Ян Кө хоёр үүгээр урьд өмнө хонио туун ирж байгаагүй юм.

Анч шарын дуу улам ойрхон сонсогдох боловч тэр хоёр түүний барааг олж харсангүй. “Энд ангийн мөр элбэг болохоор Анч шар нэг үнэг барьчихсан байж мэдэх юм. Хоёулаа хурдан явцгаая” гэхэд Ян Кө “Тэгвэл ч ганзага хоосонгүй хэрэг шүү” гэлээ. Тэр хоёр нэг сондуулыг ороон жалга уруудан тойрвоос Анч шарыг олж харжээ.

Энэ удаа Анч шар сүүлээ өргөчихөөд бүр том нэгэн чонын үүр рүү хуцан дайрахыг үзээд тэр хоёрын дотор сэрхийлээ. Чоно байж мэдэх тэр нүхнээс хүйт даах шиг болоход Чэнь Жэньгийн толгойтой үс арзасхийх шиг болов. Тэд чонон сүргийн отоон дунд орчихоод тоо томшгүй олон өлөн чононууд цоо ширтэх мэт санагдахад хамаг биеийн шар үс зэрлэг гахайн хялгас мэт сэрийн бослоо.

Тэр хоёр морьдоо тушчихаад, багаж хэрэгслээ аван нүхний өмнө явж хүрэв. Энэ урагшаа харсан байрлалтай чонын үүр нэг метр өндөр, жар гаруй сантиметр өргөн ажээ. Чэнь Жэнь урьд нь ийм том чонын үүр үзээгүй бөгөөд дунд сургуульд Хэбэйгийн Пин Шань уулнаа тариачдын ажилд туслахаар очихдоо үзсэн японыг эсэргүүцэх дайны хонгил нүхний амсар ч ийм том байгаагүй санагдана. Бут сөөгөөр битүү хучигдсан том жалганы жижиг сархинагт нуугдсан энэхүү үүрийг ойртож ирэхээс нааш олно гэдэг санашгүй хэрэг байлаа.

Анч шар хоёр эзнийгээ хараад бүр хөөрч Чэнь Жэньг тойрон давхих нь шан харамж горилж буй бололтой. “Анч шар шан горилсон янзтай байгааг үзвээс тэр сая энд бэлтрэгнүүдийг олж харсан нь илт байна. Өнөөдөр ч чи бид хоёр хоосонгүй бололтой” хэмээн Чэнь Жэньг хэлэхэд

Ян Кө хариуд нь “Энэ эвгүй газар чонын үүр байж тун болзошгүй” гэлээ. “Чонын шивтэр ихтэй тул гарцаагүй байгаа” хэмээн Чэнь Жэнь батлав.

Чэнь Жэнь доош тонгойн нүхний амсрын өмнөх сул шороон дээрх мөрнүүдийг ажиглав. Энэхүү амсрын өмнөх сул шороо нүх ухах явцад үүссэн тул хэр гүн болохыг түүгээр баримжаалж болдог юм. Сул шороо цасанд дарагдаагүй, зөндөө олон хөлийн мөрнөөс гадна яс үс хөглөрчээ.

Чэнь Жэнь өөрийн олж үзье гэсэн зүйлийг хараад зүрх нь түг түг цохилгов. Тэр Анч шарыг

харуулд зогсоогоод Ян Көтэй цуг доош тонгойн нарийн ажиглаж гарав. Анч шар хэдийгээр амсрын шороон дээрх ул мөрийг бусниулаад хаячихсан боловч хоёр гурван том чонын мөр болон тав зургаан бэлтрэгний мөр үлдсэн болохыг мань хоёр төвөггүй ялган таньжээ. Бэлтрэгнүүдийн мөр хоёртын мөнгөн зоос шиг тун хөөрхөн. Тэд нүхний амсар дээр тоглож байгаад нохойн дуугаар буцаж орсон байдал тун тод үлджээ. Энэ цасгүй сул шороо тэдний хувьд өлөгчин чонын засаж өгсөн тоглоомын талбар нь байж таарна.

Амсрын шороон дээр бэлтрэгний шүдний ором бүхий яс, арьс үс хөглөрчээ. Нүхний амсраас холгүйхэн хоёр сантиметр орчим урт, савхны хирийн бүдүүн тослог хар бэлтрэгний баас хэдэн ширхэг үлдсэн нь зөгийн балаар зуурсан талхан эмийг санагдуулна.

“Миний хайж явсан бэлтрэг энэ үүрэнд байсан байж шүү дээ. Гэтэл чи бид хоёр өдий насласан том эрчүүд атлаа тэр өлөгчин чононд сайхан хууртагдаж дээ” гээд гуяа алгадлаа.

Ян Кө ч мөн сэхээ орсон бололтой амсрын сул шороог малиагаар цохиж “Тэгж таарлаа. Тэр өлөгчин чоно уг нь наашаа ирж яваад овооны оройд хоёр хүн байхыг үзэн чиглэлээ өөрчлөөд чи бид хоёрыг хоосон нүхэн дээр аваачсан байх нь. Тэгээд бэлтрэгээ харамласан янзтай ноходтой үхэн хатан үзэлцдэг байна шүү. Муу золигийн өлөгчин биднийг ганц сайн чадаж дээ” гэхэд

Чэнь Жэнь “Би ч түүнийг гэнэт чиглэлээ өөрчлөхөд анхандаа жаахан сэжиглэсэн юм л даа. Гэтэл үнэн голоосоо жүжиглэхэд нь сүүлдээ эргэлзээ арилсан. Мөн айхтар овжин амьтан байжээ. Хэрвээ чи түүний үүрэнд гурван цаасан буу тэслээгүй бол харанхуй болтол тэндээ бүгээд бид хоосон хоцорч таарах байсан юм” гэлээ.

Ян Кө өгүүлрүүн “Чи бид азаар хоёр сайн нохойгоо дагуулан иржээ. Хэрвээ тэд байгаагүй бол хоёулаа чононд чадуулаад дуусах байж” гэв.

“Одоо байдал бүр ч дордлоо. Тэр өлөгчин чоно чи бид хоёрын хугас өдрийн цагийг дэмий үрүүлээд дээр нь бас гурван “Хийн бөмбөгийг” маань гарздуулсан шүү дээ. Энэ үүр түүрүүчийнхээс ч илүү гүнзгий гэдэг нь илт байна” хэмээн Чэнь Жэнь гансрангуй янзтай хэлэв.

Ян Кө доош тонгойн нүх рүү удтал ширтэж байснаа “Цаг бага үлдсэн “Хийн бөмбөг” байхгүй болохоор одоо өөр ямар арга байх билээ? Тийм болохоор энэ нүхэнд өөр ямар нэгэн гарц байгаа эсэхийг сайтар үзье. Тэгээд бүхий л амсар гарцыг битүүлэн таглаад маргааш ахиухан хүн хүч дагуулан ирцгээсэн нь дээр. Чи ч гэсэн ааваас өөр ямар арга чарга байгааг асуугаарай” гэлээ.

Чэнь Жэнь сэтгэл шулуудсан байдалтай “Би нэг арга туршаад үзье. Энэ чонын үүр Пин Шань уулын хонгил замтай бараг адил шахуу юм. Бид нар Пин Шаний хонгил зам руу ороод байсан хэрнээ энэ нүх рүү яагаад орж болдоггүй билээ? Тэгээд ч манай Арслан нөгөө өлөгчинтэй хөөцөлдөөд алга болсон тул өдийд энэ үүрэнд өөр чоно байхгүй байж таарна. Чи миний хөлнөөс бүсээрээ уячихаад зугуухан суллаад байгаарай. Аз таарвал ганц бэлтрэг ч гэсэн суйлаадахья. Арга ядахад чонын үүр ямар бүтэцтэй байдгийг харж яагаад болохгүй байх билээ?” гэв.

Ян Кө толгой сэгсрээд “Чи чинь аминаасаа уйдаа юу? Хэрвээ өөр чоно байвал яах болж байна вэ? Энэ нүх тэр өлөгчингийнх биш, өөр чонын үүр байвал яана? Би түрүүчийн удаа чононд зүрхээ зүсүүлчихээд байна” хэмээн хориглов.

Чэнь Жэньгийн сэтгэлд хоёр жилийн турш бугшсан хүсэл улам оволзоод айдас хүйдсийг дарж орхижээ. “Монгол хүүхдүүд хүртэл чонын үүрэнд шургаад байхад бид айгаад байвал дэндүү ичгүүртэй хэрэг биш гэж үү? Би гар чийдэн, төмөр царил хоёроо бариад орох тул нэг хэсэгтээ аргалж болох байх. Харин чи надад сайн туслаарай” хэмээн шүд зуун өгүүлэв.

“Хэрвээ нүх рүү шургана гээд байгаа бол би чамаас бие томтой, хүч ихтэй болохоор түрүүлээд орё” гэж Ян Кө хэлэв.

“Наадхи чинь харин миний давуу тал шүү дээ. Чи том биетэй болохоор нүхэн дотор гацчихаж мэднэ. Тийм болохоор гадаа үлдсэн нь дээр” гэж Чэнь Жэнь амыг нь таглав.

Чэнь Жэнь хөдсөн дээлээ тайлахад Ян Кө түүнд гар чийдэн, царил зэргийг өгөөд хоёр бүсээ нийлүүлэн зангидаж Чэнь Жэньгийн хөлнөөс уялаа. Чэнь Жэнь нүх рүү шургахын өмнө “Чонын үүрэнд эс орвоос бэлтрэгийг яахин барих билээ?”<sup>13</sup> гэж хэлэв. “Хэрвээ үнэхээр том чоно тааралдвал хөлөө тийчигнэн хашгирч дохио өгдөг юм шүү” хэмээн Ян Кө дахин дахин захилаа.

Чэнь Жэнь элэглэн мөлхсөөр дөчин градус орчим хэвгий нүх рүү шурган ороход чонын шивтэр шинхэг сэнхийн ханхлаад амьсгал авахын эцэсгүй санагдав. Чонын нүхний хана мөлгөрдүү боловч зарим газар үс хялгас нь наалдаж хоцорчээ. Газарт бэлтрэгний мөр хаа сайгүй үзэгдэнэ. Чэнь Жэнь дахин хэдэн метр урагшилвал бэлтрэг суйлчихаар санагдахад тун их догдлов. Түүний бие бүрэн далд ороход Ян Кө бүсээ зугуухан султгангаа гайгүй биз хэмээн хашгиран асууна. Чэнь Жэнь хариуд нь бүсээ султгаад байгаарай гэж хашгирах зуур хоёр тохой дээрээ тулан ямх ямхаар урагшилсаар байлаа.

Нүхний амсраас хоёр метр шахам холдоход чонын үүр зугуухан тохойроод нарны гэрэл тусахаа болив. Чэнь Жэнь гар чийдэнгээ асаан өмнөө өргөөд цааш ахилаа. Тойрууг өнгөрсөний дараа хонгил зам тэгшрээд ирсэн боловч хавьгүй бачуухан болсон тул толгой бөхийн цээжээ хавчин байж сая урагшлах боломжтой болжээ.

Энэ хавийн ханыг чонын сарвуугаар бус ган царилаар ухсан болов уу гэлтэй амсрын хананаас хавьгүй гөлгөр байлаа. Төмөр царилаараа дээш хатгаж үзвэл сул шороо бараг унахгүй тул нурангид даруулах вий гэсэн айдас арилав. Чоно хоёр сарвуугаар уулын хатуу чулуулагт хөрсөнд тийм гүнзгий нүх ухсан гэдэгт итгэж боломгүй санагдана. Нүхний хана чонын орж гарах тоолонд үрэгдсээр өндөг шиг мөлийж орхижээ. Энэхүү мөлгөр гадаргын байдлаас барагцаалан үзвэл хичнээн зуун жилийн настай байж мэдэх уг үүрэнд хэдэн арван үеийн том жижиг, эрэгчин эмэгчин чононууд орж гарч байсан нь илэрхий. Чэнь Жэнь чонын ертөнцөд бүрэн нэвтрэн орсон мэт санагдахад цээж давчдан, амьсгаа нь оволзов.

Цааш ахих тусам түүний айдас улам нэмэгджээ. Түүний хамрын доорх хэдэн бэлтрэгний мөрөн дээр том чонын сарвуун мөр парвайн харагдав. Хэрвээ энэ үүрэнд том чоно байвал ганц төмөр царил юу болох билээ. Энэ давчуу үүрэнд чонын соёо түүнд хүрч чаддаггүй юм



гэхэд хоёр хүчирхэг урд сарвуу түүнийг сэгчээд хаяж мэдэх биш үү? Ингэж бодох зуур түүний ууц нуруугаар хүйт даах шиг болно.

Чэнь Жэнь цааш явахаа азнан зогслоо. Хэрвээ тэр хөлөө тийчигнэн бүсийг хөдөлгөвөөс Ян Кө түүнийг суга татан гаргах нь ойлгомжтой. Гэвч түүний өмнөхөн долоо найман хөөрхөн бэлтрэг байж мэдэх тул орхиод буцчихаж түвдсэнгүй шүд зуун цааш мөлхөв. Нүхний хана түүнийг хариугүй хавчихаар бачуухан болж ирэхэд өөрөө анчин хүн биш, булш ухагч мэт санагдана. Агаар улам бүгчимдэн чонын шивтэр бүр ч айхтар үнэртэхэд түүний айдас нэмэгдлээ. Археологчид өөр шиг нь ийм давчуу нүхэнд хавчигдан өөд болсон булш ухагчдыг цөөнгүй олж байсан билээ.

Түүний өмнө өлөгчин чоно мөлхөөд багтахуйц умгар нүх тааралдахад тэр цаашаа явж чадахаа байжээ. Чоно тал нутгийн цорын ганц дайснаасаа сэргийлж ийм хамгаалалт хийсэн нь илт байв. Энэ жижиг амыг чоно шороогоор битүүлэн, утаа усны аюулаас сэргийлдэг байх нь гэж Чэнь Жэнь бодов.

Энэ хамгаалах зориулалттай бэхлэлтэнд хашигдсан Чэнь Жэнь шууд буцан явж төвдсөнгүй жаахан өргөсгөх санаатай төмөр царилаар нүдэж үзэв. Гэвч чоно чухам ийм газарт хамгийн давчуу амсар гаргасан нь тун нүдээ олсон хэрэг болжээ. Чэнь Жэнь хэдэн удаа цохиод хад чулууг эмтлэх аргагүй гэдгийг мэдэв. Тэр амьсгаа давчдан хадыг сэтлэх хүч байхгүй болсон бөгөөд нурааж чадлаа ч амьдаараа чонын өгөөш болох магадлалтай юм.

Чэнь Жэнь чонын шивтрийг цээж дүүрэн амьсгалаад хүчилтөрөгчийн дутагдлыг бага зэрэг нөхөж чадав. Тэр бэлтрэг барьж чадахгүйгээ мэдээд бүр шалчийж орхилоо. Мань эр шулуухан ухарч төвдсөнгүй давчуу амсрын цаахан ганц бэлтрэг байж мэдэх юм гээд тогтуухан ажлаа.

Тэр эцсийн найдвараа алдалгүй давчуу нүх рүү толгой баруун гар хоёроо шургуулаад гар чийдэнгээ тусгаж үзэв. Давчуу нүхнээс цааш чонын үүр дээш өгсөөд өөр юу ч харагдахаа болиход түүний урам бүрмөсөн хугарчээ. Дээш байрлалтай чонын үүр өлөгчин чоно бэлтрэгнүүдээ хөхүүлэхэд тохиромжтой хуурай, дулаанаас гадна байгалийн үер, хүн ус цутгахаас хамгаалах боломжтой юм. Тэр хэдийгээр чонын үүрний нарийн бүтэцтэй байх гэдэг дээр бүрэн сэтгэлзүйн бэлтгэлтэй байсан боловч энэ бүхнийг нүдээр үзсэний эцэст бүр ч илүү гайхжээ.

Чэнь Жэнь чих тавин чагнаваас нүхэнд өчүүхэн ч чимээ анир алга. Бэлтрэгнүүд бүгд унтаад өгсөн эсвэл гадны үл таних чимээг сонсоод нам гүм дуугаа хураах байгалийн зохилдлоготой байж ч мэдэх юм. Хэрвээ тэр амьсгал нь айхтар давчдаагүй бол чонын үүрнээс холдохын өмнө “Хөөрхөн бэлтрэгнүүд минь, хаалгаа тайлаарай. . .” хэмээн дуулъя хэмээн санажээ. Харамсалтай нь энэ удаа хятад залуу монгол чонын бэлтрэгийг суйлах хувь дутав. Түүний амьсгал давчдан толгой эргэхэд сүүлчийн хүчээ шавхан хөлөө тийчигнэлээ. Ян Кө яарч догдолсондоо олс татаж байгаа хүн шиг түүнийг суга татан нүхнээс гаргаж ирэв.

Чэнь Жэнь гэж шороон царайлсан амьтан нүхний аман дээр амьсгаадан суугаад Ян Көд хандан “Ёстой аргагүй юм байна аа. Чөтгөр шулмын үүр л гэж тийм байдаг байх. Адаг төгсгөлийг харж чадсангүй” гэхэд цаадахь нь их л гонсгор байдалтай дээлийг нь нөмөргөв.

Тэр хоёр ойролцоо нэг хоёр зуун метрийн дотор эрж хайсаар өөр нэг нүхэн гарц олж гол нүхний хамтаар өлөгчин чоно даахааргүй том чулуугаар бөглөж завсар зайгаар шороогоор чигжин битүүмжлэв.

Чэнь Жэнь явахдаа төмөр царилаа нүхний аманд хатгасан нь өлөгчин чононд хандан “Маргааш тэд илүү олон хүн хүч дагуулан ирээд үзүүлж өгнө өө” гэсэн сануулга өгсөн хэрэг байлаа.

Харуй бүрий болохын хэрд Арслан эргэж ирсэнгүй. Тэр овжин зальтай өлөгчин чононд ганц Арслангийн эр зориг юу болох билээ гэж бодохоос тэр хоёрын хүйтэн хөлс чийхрана. Чэнь Жэнь, Ян Кө хоёр Анч шарыгаа дагуулан гэрийн зүг гэлдрэв. Хотондоо эргэж ирэхийн алдад харанхуй болсон тул Чэнь Жэнь, Ян Көд багаж хэрэгслээ өгч Гао Зянь Жунд мэндээ мэдүүлэхээр явуулаад, өөрөө Билиг өвгөнийх рүү морины амыг эргүүлжээ.

*Монголчуудын зарим түүхэн сурвалжийн гар бичмэлүүдэд тэмдэглэсэнээр “. . . . .Тайчууд овогтон нь Хайдугийн хөвгүүн Чархай Линхугаас үүсчээ. Хайду гурван хөвгүүнтэй байсны ууган нь Байшингар догшин, Чингис хааны дээдэс нь түүнээс салан гарчээ. . . . Дэд хөвгүүн Чархай Линху. Чархай Линху түүний ах Байшингар догшин үхсэний хойно бэргэнээ буулган авчээ. Тэр нь Думбинай сэцэний эх бөлгөө. . . Тэднээс хоёр хөвгүүн төрсөн нь Дэлт Чоно, Өлөгчин Чоно болой. . . Тэд Чонос овог болжээ”*

*Рашид Ад Дины Судрын чуулган*

Өвгөн үг дуугүй гаансаа татан Чэнь Жэньгийн яриаг сонсож дуусаад түүнийг хэсэг зуур зэмлэв. Хоёр хятад оюутан цаасан буугаар чонын үүрийг дэлбэлсэн нь хэр зэрэг сүр хүч, үр дүнтэй байсныг мэдээгүй боловч ихэд уурласан юм. Өвгөн мөнгөн ёншгойтоор гаансны толгойг дарж шор шор хийлгэн соров.

Тэр Чэнь Жэнь рүү хандан ямаан сахлаа чичигнүүлээд “Та нар хэдэн цаасан буугаар өлөгчин чоныг үүрнээс нь хөөн гаргаад том нүгэл үйлдсэнээ мэдэж байна уу? Танай хятадууд монголчуудаас илүү дарь тэслэдэг болохоор тэр муу өлөгчин чононд шороо овоолон өөрийгөө хамгаалах цаг ч олдоогүй байж таарна. Ядаж монгол чоно дарийн утаанаас жигтэйхэн их айдаг юм. Тэр үүрэнд бэлтрэгнүүд байсан бол гарцаагүй үүрнээсээ зугатан гарч ирээд та нарт баригдах байсан. Хэрвээ ийм маягаар бэлтрэг суйлаад байвал хэдхэн жил бололгүй тал нутагт чоно гэдэг амьтан үзэгдэхээ болино. Чоныг агнаж бололгүй яах вэ? Харин ийм аргаар бол хэрхэвч болохгүй. Ийм аргаар агнаад байвал тэнгэр хилэгнэн тал нутаг сүйд болно гэсэн үг. Үүнээс хойш дахин цаасан буу хэрэглэж болохгүй, ийм арга байдаг гэдгийг бусад адуучдад зааж өгч яасан ч болохгүй шүү. Цаадуул чинь та нарыг дууриагаад хүнээ байж гүйцнэ. . . ” гэлээ.

Чэнь Жэнь өвгөнийг тэгтэл уурлана гэж бодоогүй юм. Өвгөний зэмлэл түүнд чонын үүрэнд цаасан буу дэлбэлэн бэлтрэг суйлахын ноцтой хор уршгийг сайтар ухааруулжээ. Энэ арга нийтэд дэлгэрвээс чонын үүрийн дотоод байгууламж хичнээн нарийн бүтэцтэй байгаад ч цаасан бууны хүчтэй дуу болон дарийн утааг яахин тэсэж чадах билээ? Тал нутагт угаас баяр ёслолын үеэр цаасан буу хэрэглэдэггүй байсан тул энэ төрлийн бараа цагаач иргэд болон илгээлтийн эзэдтэй цуг энэ газар дэлгэрсэн юм. Өвөрмонголд буу сумыг ихэд хямгатай хэрэглэдэг боловч цаасан бууг дотор газраас зөөвөрлөн авчрахад элдэв хориг саад байхгүй. Хэрвээ цаасан буунд чинжүү, нулимс асгаруулагч бодис зэргийг холин чоно агнахад ашиглаж эхлэвэл тал нутгийг хэдэн түмэн жил эзэгнэсэн чонон сүргийн хувь тавилан ээдрээтэй болж үр үндэс нь тасрах аюултай ч байж мэдэх юм.

Дарь балар эртний нүүдлийн амьдралын хэв шинжээ хадгалсан хэвээрээ байгаа тал нутагт урьд өмнө байгаагүй хөнөөлтэй болох нь ойлгомжтой. Нэгэн үндэстний сүлд шүтээн үгүй болсноор тухайн үндэстний оюун санаа ч устаж, улмаар түүнийг дагалдан монгол үндэстний оршин тогтносоор ирсэн тал нутаг ч газрын зургаас арчигдан алга болох магадлалтай бус уу?

Чэнь Жэнь их л айсан байдалтай духан дээрх хөлсөө арчаад “Аав аа, та битгий уурла даа. Би дахин чонын үүрэнд цаасан буу дэлбэлж, энэ аргыг өөр бусдад зааж өгөхгүй гэдгээ

тэнгэрийн нэрийг барьж андгайлъя” гэв. Чэнь Жэнь хоёр ч удаа ийн батлан өгүүлэв.

Тал нутагт итгэл хэмээх эзэн Чингис хааны үеэс уламжилж ирсэн хүн байхуйн гол хэмжүүр юм. Ам өчиг андгай тангараг угаас хүнд жин дардаг учир овог аймгуудын итгэлцлийн баталгаа болсоор иржээ. Зарим монгол эрчүүд архинд халаад алдсан ам өчгөөсөө болж анч сайн нохой, аргамаг хурдан хөлөг, ангийн хурц хутга, амраг хонгор бүсгүйгээ ч алдаж байсан тохиолдол цөөнгүй бий гэлцдэг.

Өвгөний нүүрний үрчлээс бага зэрэг тэнийгээд Чэнь Жэньгийн зүг хандан: “Чи хонь малаа хамгаалахын төлөө чоно агнах гэснийг чинь би ойлгож байна л даа. Гэхдээ тал нутгийг хамгаалах нь мал сүргээ хамгаалахаас ч илүү чухал юм шүү. Одоо цагийн залуу малчид чоно авлана гэж хөөрцөглөхөөс биш цаад нарийн учрыг яаж ойлгох билээ? Ядаж хүлээн авагчаар хэн нэгнийг чоно авласан баатар боллоо гэж өргөмжлөөд байх юм. Тариачин гаралтай улс мал аж ахуйг удирдан залах гээд байхаар ямар нэмэр байх вэ? Цаашдаа тал нутгийн малчид ч сайнаа үзэхгүй дэг ээ” гэв.

Галсмаа Чэнь Жэньд гурилтай шөл аягалж өгөөд өмнө нь даршилсан таана мангир дөхүүлэв. Тэр зуухны хажууд сөхрөн суугаад хадам аавдаа шөл аягалангаа “Одоо аавын үгийг тоох хүн ч олдохоо байсан байх аа. Бусдыг битгий чоно авла гэдэг мөртлөө өөрөө цөөнгүй чоно нудардаг хүний үгэнд хэн итгэх билээ?” гэлээ.

Өвгөн муухан мушгинаад бэрийн үгийг өлгөж аван “Чи аавынхаа үгэнд итгэдэг биз дээ?” хэмээн Чэнь Жэньгээс асуув.

Чэнь Жэнь хариуд нь: “Би итгэлгүй яахав. Чоно байхгүй бол тал нутаг сүйрлээ гэсэн үг. Зүүн өмнө зүгт холын хол газар Австрали нэртэй нэг улс байдаг юм. Тэндхийн уудам талд анх туулай байдаггүй байж л дээ. Гэтэл нутгийн хүмүүс тэжээвэр туулайгаа алдаж зэрлэгшүүлсэн нь чоно байхгүйн улмаас тоо толгой нь тоймоо алдсан байгаа юм. Тэгээд бэлчээрийн өвс ургамлыг ихэд сүйтгэн тус орны мал аж ахуйд ихээхэн сүйрэл учруулжээ. Австралийн засгийн газар түүнтэй тэмцэхийн тулд янз бүрийн арга хэмжээ авсан боловч үр дүнгээ өгдөггүй. Эцэс сүүлдээ туулай шургаж орохооргүй хашаа барьж бэлчээр нутгаа хамгаалдаг болсон байна. Гэвч тэр уудам талыг бүхэлд нь хашиж туулайг өлсгөн устгах их хэмжээний мөнгө засгийн газарт хаанаас байх вэ? Би анх Өвөрмонголын энэ сайхан талд туулай лав элбэг байх гэж бодож байсан боловч манай Олонбулагт төдий олон биш болохыг олж мэдсэн юм. Энэ чинь чонын л ач тус шүү дээ. Би хонь хариулж явахдаа туулай барьж байгаа чоныг бишгүй л нэг харсан. Хоёр чоно нэжгээд туулай барих тохиолдол ч байдаг шүү” гэв.

Өвгөний харц зөөлрөн их л тааламжтай сонсох зуур амандаа “Австрали, австрали” хэмээн үглэж байлаа. Дараа нь тэрээр “Чи маргааш надад газрын зураг авчраад тэр австрали гэдэг улсаа заагаад өгөөрэй. Үүнээс хойш чоныг хүйс тэмтрэх тухай яриа гаргасан хүнд австрали улсад тохиолдсон бэрхшээлийг ярьж өгч байя. Туулай жилд хэд хэдэн удаа үржих чадвартай байдаг болохоор бэлчээр нутагт мөн ч халгаатай шүү дээ. Нэг туулай чонын бэлтрэгнээс хавьгүй олон зулзага төрүүлнэ. Өвөл тарвага зурам иччихдэг бол туулай бэлчээрийн өвс сүйтгээд гүйж л байдаг. Туулай чинь чонын өвөл цагийн гол хоол нь болохоор тэр хэрээр хонь малын гарзыг хааж байгаа хэрэг. Чоно тэгтэл их устгаад байгаа хэр нь туулай өсөж үржээд л

байдаг юм. Хэрвээ чоно байхгүй бол тал нутагт гурав алхаад л туулайн үүр тааралдах байсан нь гарцаагүй” гэв.

Чэнь Жэнь залгуулан авч “Би танд маргааш өөрийн нэгэн том газрын зургийг бэлэглэмз. Та сайн Австрали улсыг харж аваарай л даа” гэжээ.

“За чи эртхэн харьж амар даа. Хэд хоног завгүй ажилласан хүн” гэснээ Чэнь Жэнь явах шинжгүйг хараад Билиг өвгөн “Чи надаас тэр хэдэн бэлтрэгийг суйлах аргыг асуух санаатай байгаа юм уу?” хэмээн асуув.

Чэнь Жэнь тээнэгэлзэнгүй толгой дохиж “Би анх удаа бэлтрэг суйлж байгаа болохоор та надад ямар ч байсан нэг арга зааж өг” гэлээ.

“Чи дахин дахин бэлтрэг суйлаад байхгүй гэвэл арга зааж өгч бололгүй яахав” хэмээн өвгөн хэлэв.

“Би хэлсэндээ байж чадна аа” гэж Чэнь Жэнь ам өчгөө баталгаажууллаа.

Өвгөн цайгаа балган хоржоонтой инээснээ “Чи надаас энэ тухай асуугаагүй бол тэр хэдэн бэлтрэгийг барьж авна гэдэг санааны гарз болох байсан юм. Харин чи цаад өлөгчингөө алалгүй үлдээдэг юм шүү. Заавал хүйс тэмтрэн дуусгах гээд яах билээ” гэхэд

“Би яахаараа тэр хэдэн бэлтрэгийг барьж авч чаддаггүй билээ?” хэмээн Чэнь Жэнь лавлан асуулаа.

Өвгөн царайгаа төв болгоод “Та нар цаад үүрийг нь тэслээд, наад үүрэнд нь шурган орж өөрсдийн үнэрээ шингээгээд зогсохгүй, чулуугаар таглан орхисон болохоор мөнөөх өлөгчин өнөө орой өөр талаас нүх малтаж ороод бэлтрэгнүүдээ зуун гаргаж нөөц үүрэнд аваачих болно. Тэгээд тэндээсээ жинхэнэ хүн амьтан олохооргүй өөр үүр рүү нүүх нь гарцаагүй” гэхэд

Чэнь Жэньгийн зүрх хүчтэй цохилон “Тэр түр зуурын үүрийг олоход амархан уу?” хэмээн асуулаа.

Өвгөн хариуд нь “Хүн олдоггүй юм аа гэхэд хоёр анч нохой аваад очиход олохгүй хаачих билээ? Чи тэр өлөгчин чонотой нэгийгээ үзэхээр хатуу шийджээ дээ, янз нь” гэв.

“Аав аа, та маргааш бидэнтэй цуг явахгүй юу? Цаад Ян Кө чинь чононд хууртагдсаар байгаад зүрх нь үхэж гүйцсэн байна лээ” гэж Чэнь Жэнь өгүүлэв.

Өвгөн инээд алдан “Би маргааш тавьсан хавхаа эргэх учиртай. Өчигдөр шөнө бидний тавьсан хавханд нэг том чоно орсоньг би хөдөлгөөгүй юм. Хойгуур байгаа чонон сүрэг өлсөөд наашаа хөдөлсөн гэнэ лээ. Маргааш хавхнуудаа бүгдийг мялаасан байхыг хэн байг гэх вэ? Чи хоёр өдөр сайн нойр авч ав хомрогдоо бэлтгэ. Наад хэргийг чинь ав хомрогын дараа боломз” гэв.

Чэнь Жэньгийн царай цонхийхыг өвгөн хараад дууны өнгө намсан “За яахав, маргааш та нар

өөрсдөө тэр хавиар хэд эргэхгүй юу даа. Чонын үнэр хурц болохоор анч ноход дор нь олчихно. Тэгээд ч шинэ үүр тэгтэл гүн байж чадахгүй болохоор ухахад төвөгтэй биш. Ер нь бэлтрэг суйлах гэдэг чинь аз эз мэдсэн ажил шүү. Хэрвээ та нар энэ удаа ухан гаргаж чадахгүй бол би Баяртай цуг очиход болох байлгүй” гэжээ.

Баяр их л хэвлүүхэн байдалтай “Таны яриад байсан тэр үүрний хавчиг хэсгээр би лав багтаж таарна. Чонын үүрэнд хурдан шургаад л гарахгүй бол бүтэж үхэх шахдаг юм. Хэрвээ өнөөдөр та нар намайг дагуулаад явсан бол гарцаагүй бэлтрэг суйлах байсан юм даа” гэлээ.

Гэртээ буцаж очиход Ян Кө түүнийг хүлээж байлаа. Чэнь Жэнь түүнд Билиг өвгөний таамаглал болон аргыг хоёронтоо давтан яриад ч түүний санаа амрах янзгүй.

Шөнө дунд нохой хуцалдах чимээнээр Чэнь Жэнь сэрж үзвэл Арслан эргэн ирсэн байлаа. Ашгүй тэр чонон сүрэгтэй тааралдаагүй ажээ. Тэр гэр тойрон гүйж хонины хашаагаа эргэж байхыг сонсоод хоол өгч шархыг нь боох учиртай гэж санасан боловч нойрондоо дийлдээд босож чадсангүй. Арслангийн хуцах чимээ намдахтай зэрэг шахам бөх унтаад өгчээ.

Чэнь Жэньг өглөө сэрэхэд Ян Кө, Гао Зянь Жун хоёр Доржтой зуухны хажууд суучихсан цай уунгаа бэлтрэг суйлах тухай ярилцаж байлаа. Гуравдугаар хэсгийн үхэрчин Дорж бол хорин дөрөв тав орчим насны шавхийсэн залуу бөгөөд бага сургуулиа дүүргээд л малчин болохоор санаа шулуудан иржээ. Багийн нябогийн албыг давхар залгуулдаг төдийгүй нутгийн зартай анчдын нэг юм. Түүний эцэг зүүн хойд орны хагас малжсан тариалангийн бүс нутгаас гаралтай хүн бөгөөд сангийн аж ахуй анх байгуулагдахад энэ нутагт ирж суурьшсан зүүн хойд орны цөөхөн монгол үндэстний нэг ажээ.

Олонбулгийнхан зүүн хойд орны монголчуудтай зан заншлын хувьд ихээхэн зөрүүтэй болохоор хоорондоо гэрлэж бараалах нь маш ховор байдаг. Хагас малжсан зүүн хойд орны монгол үндэстэнгүүд нутгийн аялгатай хятад хэлээр ус цас шиг ярьдаг болохоор Бээжингийн илгээлтийн эзэн залуус энэ нутагт анх ирэхэд монгол хэлний орчуулагч багшийн үүрэг гүйцэтгэж байжээ. Гэвч Билиг тэргүүтэй нутгийн хөгшид тэдэнд тал муутайхан байдаг болохоор илгээлтийн эзэд ч гэсэн тэдэнтэй учиргүй наана уу, цаана уу болоод байдаггүй юм. Ян Кө хар өглөөгүүр Доржийг олж ирсэн нь түрүүчийн удаагийнх шиг дахин хууртагдаж, аюулд өртөхгүйн тулд түүгээр бие хамгаалагч, зөвлөх болгох гэсэн нь тодорхой.

Чэнь Жэнь яаравчлан босож хувцаслаад Доржтой амар мэндээ мэдэлцэв. Цаадахь нь Чэнь Жэньг шоолонгуй байдалтай “За чи чинь байтлаа чонын үүр рүү бэлтрэг суйлахаар орсон гэх шив. Чи цаашдаа болгоомжтой байхгүй бол өлөгчин чоно чиний үнэрээр мөшгин хаа явсан газар чинь дагаад байдаг болчихдог юм шүү дээ” гэлээ.

Чэнь Жэнь сандарсандаа хилэн цамцаа буруу харуулан өмсөөд “Тэгвэл бид тэр өлөгчин чоныг алахаас нааш би амьд үлдэхгүй хэрэг үү?” хэмээн асуулаа.

Дорж инээд алдаад “Би чамайг айлгасан юм аа. Чоно хүнээс айдаг болохоор тэр өлөгчин чоно чиний үнэрийг авах юм бол дахин чам руу халдаж чадахгүй. Хэрвээ чоно үнэр авсан болгоноо бариад байдагсан бол би л хамгийн түрүүнд чонын хоол болох байсан байлгүй. Би арван гурав дөрөвтэйгөөсөө чонын үүрэнд шурган бэлтрэг суйлж байсан хүн өнөө хэр мэнд

мэлтийгээд л явж байна даг” гэхэд

Чэнь Жэнь сая нэг санаа амарсан байдалтай “Чи чинь манай багийн аварга анчин хүн. Ойрын хэдэн жил нийт хичнээн чоно агнав даа?” хэмээн асуулаа.

“Бэлтрэгийг оролцуулахгүй жар далан чоно болсон байхаа. Дээр нь долоо найман үүрний бэлтрэгийг суйлсан”

“Долоо найман үүрний бэлтрэг гэхээр тавь жараад юм болох байлгүй. Чи чинь тэгэхээр нийтдээ зуун хорь гучин боохойн бодийг хөтөлсөн юм байна шүү дээ. Гэтэл чамаас чоно өшөөгөө авах гэж ирээгүй хэрэг үү?”

“Яалаа гэж дээ? Энэ арваад жилийн хугацаанд манай гэрийн долоон найман ноход чононд бариулсан. Хонины тухайд гэвэл бүр ч тоогоо алдсан байх”

“Чоныг ийм ширүүн алаад дуусгачихвал үхсэн хойноо яах болж байна вэ?”

“Манай Их Зуу аймгаас ирсэн монголчууд танай хятадуудаас бараг өөрцгүй дээ. Хүн үхэхээр авсанд хийгээд оршуулчихдаг. Харин эндхийн монгол үндэстнүүд дэндүү хоцрогдсон бүдүүлэг улс байдаг юм. . . . .”

“Эндхийнхэн үхэгсдээ чононд өргөдөг нь түвдийн тас шувуунд өгдөгөөс өөрцгүй. Харин чи чоныг нь хядаад дуусгачихвал эндхийн хүмүүс чамайг үзэн ядах биш үү?”

“Олонбулаг шиг чоно элбэгтэй газар агнаад дуусгана гэж юу байх билээ. Төр засгаас ч нэг чоно агнах зуун хонь аварсантай ижил, арван үүр бэлтрэг суйлах арван суурь хонь хамгаалсантай ижил гээд л малчдыг чоно агнах ажилд уриалан дуудаад байгаа шүү дээ. Баянговь коммуны нэгэн чоно агнагч баатар нэг жилд таван үүрний бэлтрэг суйлсан нь миний арван жилийн олз омогтой тэнцэхээр юм байна лээ. Баянговьд манай нутгаас шилжиж очсон хүмүүс их болохоор чоно агнасаар овоо цөөрүүлсэн бололтой дог шүү”

“Тэндхийн мал аж ахуйн байдал ямархуу байна даа?” хэмээн Чэнь Жэньг асуухад

Дорж хариуд нь “Манай эндхээс хавьгүй тааруу шүү. Туулай, оготно элбэгшээд бэлчээрийн чанар муудсан байдаг” гэлээ.

Чэнь Жэнь хөдсөн дээлээ өмсөөд гадагш гарч харвал Арслан хонины хорооны өмнө арьсыг өвчсөн хурганы мах идсэн шиг байх ажээ. Хаврын цагт гурав тав өнжөөд л нэг хурга өвчин эмгэгээр эндэх тул нохойн хувьд сайхан идэш болдог юм. Хөдөөний ноход үхсэн хурганы мах идэхээс биш амьд хурганд ам ч хүрэхгүй. Харин энэ удаа Арслан үхсэн хурганы махыг мөлжингөө хашаанд тонгочих хурганууд руу байн байн харж байхыг Чэнь Жэнь олж мэдлээ.

Чэнь Жэнь түүний нэрээр дуудахад сүүлээ хөдөлгөн махаа идэхээс биш босож ирсэнгүй. Харин анч Шар, Ирвэс хоёр түүний дэргэд гүйн ирээд өвөр түрий өөд нь эрхлэн асав. Ян Ке тэд нар Арслангийн шархыг боож өгсөн нь долооход их л тээртэй байгаа бололтой. Түүний шархны байр байдал уул руу дагуулан явах боломжтой санагдлаа.

Өглөөний цайгаа уучихаад Чэнь Жэнь хөрш айлын Гомбо дээр очин хонины ээлжээ ацаглав. Чэнь Жэнь, Ян Кө хоёр дахин бэлтрэг суйлахаар явах гэж байгааг мэдээд Гао Зянь Жун ч тэднээс хоцрохыг бодсонгүй, өөрийн үхрүүдээ Гомбын хүүд даатган үлдээхээр боллоо. Учир нь Олонбулгийн талд бэлтрэг суйлах гэдэг нэр төрийн хэрэг байдаг юм.

Мань дөрөв багаж хэрэгсэл, нэг өдрийн хоол сэлтийг зэхэж, хоёр нохойгоо дагуулсаар Хар чулуут уулын зүг хөдөлцгөөлөө. Энэ жилийн хаврын хүйтэн жавар цасны нуранги дарсан мэт хургачихаад зөөлрөх янзгүй. Дөрөв таван өдрийн турш зузаан үүлс тэнгэрийг бүрхээд зэврүүн салхинд малчдын нүүр онгож гүйцжээ. Дорж салбархай унгирал мэт үүлсийн сэжүүрийг харан нүүрэнд нь баясал тодроод “Ийм хүйтэн зэврүүн өдөр чононд идэш олдоход амаргүй байж таарна. Өчигдөр манай хотны ноход айхтар хуцаад байсан. Лав нэг том сүрэг чоно наашаа орж ирсэн байх аа” гэлээ.

Тэр дөрөв Чэнь Жэнь, Ян Кө хоёрын морьдын үлдээсэн мөрөөр баримжаалан хоёр цаг явсаар өргөст бут ургасан уулын жалганд хүрэлцэн ирлээ. Тэр хоёрын чонын үүрэнд хатгаж орхисон царил хуучин байрандаа байх бөгөөд харин нүхний өмнөх талбай дээр чонын хэдэн шинэ том мөр үлдсэн боловч амсрыг тагласан чулуу хөдлөөгүйг бодоход хүрзийг хараад айн зугатсан нь илт. Хоёр нохой чонын нүхний дэргэд ирээд илт сэргэн энэ тэрүүгээр шиншлэн гүйх бөгөөд Арслан бүр ч бачимдуу янзтай байх нь өшөөгөө авахын хүслэнд шатаж байх шиг санагдана. Чэнь Жэнь ойролцоох уулын бэл рүү гараараа заагаад “Туу туу” хэмээн хашгирлаа. Хоёр нохой өөр өөр тийш чонын мөрийг мөшгин давхиж одов.

Мань дөрөв нөгөө нүхэн дээр очвоос чонын шинэхэн мөр үзэгдэх боловч мөн л дарсан чулууг хөдөлгөөгүй байх ажээ. Дорж тэр гурвыг өөр нүх байна уу үзээд ир гэж явуулаад хэд алхаагүй байтал хойд талын довцгийн цаана Арслан, анч Шар хоёр хуцалдах чимээ сонсдов. Чэнь Жэнь хүрзээ мулт татан аваад, мань дөрвүүл хойт талын довцгийг чиглэн давхицгаав.

Довцгийн оройд гараад харвал хоёр нохой нь тэр дор хуцалдан шороо манарган ухаж байлаа. “Бэлтрэгнүүдийг олчихжээ” гэж Дорж чанга дуугаар хашгирахад тэр дөрөв замдаа тээглэх хад чулууг ч хайхралгүй давхилдсаар нохдын өмнө хүрэлцэн ирлээ. Дөрвүүл мориноос хөлбөрөн бууж ирэхэд хоёр ноход нь эзэддээ зай тавьж өгөлгүй шороо малтсаар, Арслан хоншоороо нүх рүү шургуулан цаана байгаа амьтныг гаргаж ирэхээр чармайна. Чэнь Жэнь Арслангийн бөгснөөс татан нүхнээс гаргаж авлаа.

Гэвч түүний нүдний өмнө харагдах байдал хамаг урмыг хугалж орхилоо. Тэгш газар гучин сантиметр диаметртэй нүх түүний урьд өмнө үзсэнээс хавьгүй давчуу ажээ. Нүхний өмнө сул шороо хөглөрөхийг эс тооцвол тавцан гээд байх зүйл үгүй байлаа.

“Энэ чинь яаж чонын үүр байх билээ? Сайндаа л туулай, тарваганы үүр байлгүй дээ” гээд Гао Зянь Жун уруулаа мушиганууллаа.

Дорж аажуу тайвуухнаар “Чи шорооны байдлыг ажаад шинэхэн үүр болохыг харахгүй байна уу? Өлөгчин чоно бэлтрэгнүүдээ энэ үүрэнд хийсэн байж таарна” гэлээ.

Чэнь Жэнь ихэд эргэлзэнгүй байдалтай “Чонын шинэ үүр ч гэсэн ийм бачуу байхгүй байлгүй дээ. Өлөгчин чоно өөрөө яаж багтах вэ?” хэмээн асуулаа.



Дорж хариуд нь “Өлөгчин чоно нарийхан болохоор өөрөө багтана аа. Тэр эхлээд бэлтрэгнүүдээ энэ үүрэнд орхичихоод хэдэн хоногоос илүү том үүр ухах байжээ” гэв.

Ян Кө хүрээ эргэлдүүлэн “Чоно туулайн үүрний алин ч байсан яах вэ? Өнөөдөр ганц ч гэсэн амьд юм олж барьвал цагаа дэмий гарздаагүй гэсэн үг. Алив та нар холдож бай, би ухаадахья” гэлээ.

Дорж түүнийг хориглож “Би наад нүхний чинь хэр зэрэг гүн болохыг хэмжээд, амьтан байгаа эсэхийг хараадахья” гэхихээд уурганы бөгсийг нэг метр орчим шургуулаад зугуухан төнхөж байснаа царайд нь баясал тодорч Чэнь Жэнь рүү хараад “Нэг зөөлөн юм байна шүү. Чи өөрөө төнхөөд үз дээ” гэлээ.

Чэнь Жэнь уургыг тосон аваад зөөлөн төнхөж үзвээс нэг зөөлөн юм тулж байхыг мэдэрлээ. Чэнь Жэнь ч учиргүй баярлан “Нээрэн нэг юм байна. Хэрвээ чонын бэлтрэг байвал мөн сайхан аа” хэмээн хөөрцөглөв. Ян Кө, Гао Зянь Жун нар ч гэсэн өөрсдөө туршиж үзээд нэг юм байна гэж батласан боловч чонын бэлтрэг гэж багтай хэлэх хүн гарсангүй.

Дорж уурганы бөгсийг нүхэнд тултал хатгаад амсартай чацуу хэсгээс атган авч буцаан гаргаж ирээд нүхний чиглэлийн дагуу газарт тавив. Тэгээд нүхний адаг орчим хөлөөрөө зураас татаад их багтай “Энд мэдээтэй ухагтун. Бэлтрэгийг шархдуулчихавзай” хэмээн хэллээ.

Чэнь Жэнь Ян Көгийн гар дахь хүрзийг булаан аваад “Хэр зэрэг гүн байгаа бол?” гэхэд

Дорж хоёр гараараа дохиж занган “Нэг хоёр тохой орчим байгаа. Бэлтрэгний амьсгалд газрын хөрс гэссэн байж мэдэх тул битгий ширүүн хөдлөөрэй” гэв.

Чэнь Жэнь цасыг зайлуулаад хүрээ зөөлөн гишгэхэд газрын хөрс доошоо налмагасхийн цөмөрлөө. Ноход ч цөмөрхийн зүг хуцалдан ухасхийцгээв. Чэнь Жэньгийн хамаг биеийн халуун цус дээш огшоод Хань улсын хааны бунханг ухан гаргаснаас илүүтэй ихээр догдлон баясаж байлаа. Сул хөрсний цаанаас зөөлөн хар үстэй бэлтрэгнүүд цухуйн гарч ирлээ.

“Бэлтрэг байна, бэлтрэг байна” хэмээн Бээжингээс ирсэн илгээлтийн эзэн гурав маань хэдэн секунд дуугаа хурааж байснаа хашгиралдаж гарав. Чэнь Жэнь, Ян Кө хоёр бүр ч балмагдаж орхилоо. Хэдэн өдөр шөнийн айдас түгшүүр дагуулсан зүдэргээтэй ажлын эцэс төгсгөл, цус урсгасан амаргүй тулаанаар төгсөх байх гэж бодож байтал ганц хүрз гишгэх төдийхөнд шийдэгдэх юм гэж хэн санах билээ? Өмнө нь байгаа жаахан амьтад чонын бэлтрэг мөн гэдэгт тэр хоёр нэг л итгэж өгөхгүй байцгаав.

Ул мөрөө хэр барагтай бол үлдээдэггүй, цэргийн арга ухаанд төгс боловсорсон, овжин зальтай талын эзэн монгол чоно Бээжингээс ирсэн гурван илгээлтийн эзэн залууст үүрнийхээ амыг ийм амархан задласанд тэд магнай хагартал баярлахаас ч яах билээ.

“Би чонын бэлтрэгнүүдийг гартаа оруулаад авлаа гээд бодохоор зүүдлээд байгаа мэт санагдаад байх чинь” гэж Ян Кө үглэнэ.

Гао Зянь Жун ч инээд алдан “Бээжингээс ирсэн хоёр сохор муур 14 монголын амьд чонын

бэлтрэг барьчих юм гэж хэн санах вэ дээ? Би уг нь та нарт өөрийн зэвсгийн эрдмийг өнөөдөр ганц сайн үзүүлье гэж бодож байсан маань талаар болох нь” гэв.

Чэнь Жэнь бие дээрх сул шороог нь зайлуулан тоолвоос долоон бэлтрэг байлаа. Алганд арай багтамгүй хар толгойтой долоон бяцхан амьтан бие биедээ наалдаад огтхон ч хөдлөхгүй ажээ. Бэлтрэгнүүд нүдээ нээхэд сормуусыг дамнасан зэгэл саарал салсны цаанаас хар нүд гялалзана. Тэр сэтгэлдээ “Би та нарыг хичнээн удаан эрэв дээ. Ингэж нэг олдог байна шүү” хэмээн шивнэжээ.

“Төрөөд хорин хэд хоносон бэлтрэгнүүд байна. Удахгүй нүдээ нээх гэж байжээ” хэмээн Дорж хэлэв.

“Эд нар унтаж байгаа юм болов уу? Яахаараа огт хөдлөдөггүй билээ?” гэж Чэнь Жэнь асуулаа.

Дорж хариуд нь “Наадуул чинь хар багаасаа сэргэлэн зальтай турсаганууд. Нохой хуцаж, хүн хашгирах чимээнээр сэрсэн байж таарна. Одоо наадуул чинь үхсэн царай гаргаад байгаа нь тэр. Чи итгэхгүй бол нэгийг нь бариад үз л дээ” гэлээ.

Чэнь Жэнь амьдралдаа анх удаа чоно барьж үзсэндээ итгэмээргүй ч юм шиг, биед нь хүрч зүрхлэлгүй соотгор чихнээс нь татан нүхнээс татан гаргалаа. Бэлтрэг дөрвөн хөлөө унжуулчихаад эс тийчигнэх нь чонын үр биш үхсэн муурын зулзага гэмээр байх ажээ.

Бэлтрэгийг нөгөө гурвынхаа өмнө тавихдаа нохойн гөлгийг харахаараа нэг болсон тэрээр чонын бэлтрэг чухам юугаараа өөр болохыг харангуут олж мэджээ. Дөнгөж төрсөн гөлөгний үс жигд гөлгөр харсан хүний хайр булаам байдаг бол бэлтрэг зэрлэг амьтны үр төл гэсэндээ өтгөн тачир зэгэл ноолуурын дунд урт богино харилцан адилгүй хар сортой үс гялалзуулна. Толгой нь барагшин адил тас хар. Нүдээ хараахан нээгээгүй атлаа жижиг цагаан шүд ярзайлгажээ.

Нүхэн дотроос ухаж гаргасан болохоор шороо чонын шивтэр холилдон ханхлах нь эрүүл салхинд өсөж торнидог нохойн хөөрхөн гөлөгтэй бүр ч харьцуулахын аргагүй. Гэвч Чэнь Жэньгийн нүдэнд монголын тал дахь хамгийн үнэ цэнэтэй, ховор нандин бяцхан амь шиг харагдана.

Чэнь Жэнь түүнийг ийнхүү нэлээд удаан барьж зогсоход цаадахь нь амьсгалах ч үгүй, тийчигнэх ч үгүй үхсэн юм шиг байсаар байв. Харин цээжин дээр нь дарж үзэхэд зүрх нь пэл пэл цохилох нь мэдэгдэнэ.

“Наадхиа газар тавиад үз дээ” хэмээн Дорж хэлэхэд Чэнь Жэнь доош тавьтал нөгөөх бэлтрэг амь орон өөрөө явдаг тоглоомон машин адил хүн нохойн хөл сийрүү газрыг тэмцэв. Анч шар хэд харайлган түүнийг зууж авахаар завдахад эзэд нь зандран зогсоолоо.

Чэнь Жэнь ухасхийн бэлтрэгийг шүүрэн аваад бэрзээнтэн цүнхэндээ хийж орхив. Анч шар бэлтрэгийг хазаж алаад өшөө хорслоо тайлуулаагүйн төлөө Чэнь Жэньд их л дурамжхан байгаа бололтой гомдонгуй харна. Харин Арслан бэлтрэгнүүдийг харан гөлрөөд, сүүлээ

шарвагануулж байхыг Чэнь Жэнь олж үзлээ.

Чэнь Жэнь цүнхний амыг онгойлгоход илгээлтийн эзэн залуус өндөгтэй шувууны үүр олсон Бээжингийн захын дүүргийн дэггүй багачууд шиг хөөрцөглөөд үлдсэн бэлтрэгнүүдийг чихдэн авч түүн рүү чихэж орхив.

Чэнь Жэнь цүнхээ товчлоод морины урд бүүргэнд дүүжлэн явахаар завдав. Дорж ийш тийш ажиглаж байснаа “Өлөгчин чоно энэ хавьд биднийг ажиглаж байж мэдэх тул бид буцахдаа тойруу замаар явж, түүнд өөрсдийнхөө хотыг мэдэгдүүлж болохгүй” гэв. Гурван залуу маань тэдний цүнхэндээ хийсэн нь шувууны өндөг биш, хятадуудын нэрийг сонсох төдий царай нь хувхайрдаг чонын бэлтрэг болохыг сая ухаарцгаажээ.

## Арван нэг

*“Чархай Линху ахыгаа үхсэн хойно бэргэнээ буулган аваад хоёр хөвгүүн төрүүлсэний нэгийг Дэлт Чоно, нөгөөг нь Өлөгчин чоно хэмээн нэрлэсэн ажгуу. Судрын чуулган номонд энэ хоёр нэрийн утгыг эрэгчин чоно, эмэгчин чоно хэмээн тайлсан нь буй. Чонос овог энэ хоёр хөвгүүний хойч болой. Чоносын “с” нь олон тоог илтгэх бөгөөд чонын бүлэгтэн гэсэн санаа юм”*

*Хань Ру Линь “Чингис хааны арван гурван жигүүрийн магадлал”*

Мань гурав мориндоо санд мэнд мордоод Доржийг дагалдан зэгсэн дундуур туучиж, морины мөр үлдээхгүй гэсэндээ хужир мараатай тангийн урдуур тойрон гэрийн зүг явцгаалаа. Замын турш Бээжингээс ирсэн гурван илгээлтийн эзэн залуусын сэтгэл ялалтын омогшлоор бялхах бус баян айлын хөрөнгөнөөс хулгай хийчихсэн мэт нэг л зовиуртай байлаа. Өлөгчин чоно өөр бусад хамсаатнаа дагуулан мөрөөр нь мөшгин ирээд үхэх сэхэхээ үзэлцэн тулалдахыг хэн байг гэх билээ.

Гэвч Чэнь Жэнь хоньчин эзний хувиар өлөгчин чонын хоол болсон хөөрхий хурганыхаа өшөөг авч байна гэж бодоод сэтгэлийн тэнцвэрээ бага зэрэг хадгалах ажээ. Нэг үүр бэлтрэг суйлна гэдэг сүрэг хонийг аварч байгаагаас өөрцгүй. Хэрвээ тэр энэ долоон бэлтрэгийг илрүүлэн суйлаагүй бол хожим тэд болоод тэдний дараа дараачийн үе нь хичнээн олон мал сүрэгт гэм хор учруулахыг хэн мэдэх вэ?

Бэлтрэг суйлах гэдэг монгол талын малчдын чонотой явуулдаг дайны үр нөлөөтэй арга хэрэгсэл бөгөөд нэг үүр бэлтрэг устгасан нь сүрэг чоныг зүйл дуусгаснаас өөрцгүй юм. Энэ долоон бэлтрэгийг суйлах хэдий амаргүй байсан боловч бие гүйцсэн долоон том чоныг устгахаас хавьгүй амар байж таарна. Монголчууд эртнээс нааш үр нөлөөтэй аргыг нээж олсон мөртлөө чонын гай барцад яахаараа багасдаггүй билээ? Ийн эргэлзэн бодоод Чэнь Жэнь Доржоос энэ тухай асуулаа.

Дорж өгүүллүүн: “Чоно ухаантай амьтан болохоор хэзээ төрөхөө хүртэл андахгүй мэддэг юм. Чоно нохой хоёр арван мянган жилийн өмнө нэг төрлийн амьтан байсан гэлцдэг шүү дээ. Гэхдээ чонын ухааныг нохойтой зүйрлэх аргагүй. Нохой цагаан сарын дараа хоёр долоо хоног орчим болоод гөлөглөдөг бол чоно харин цас хайлж, мал төллөх үеэр бэлтрэгээ төрүүлдэг. Мал төллөлт монголчуудын хувьд хамгийн завгүй бачим үе болохоор хүн бүр энэ ажилд хамаг анхаарлаа хандуулсан байдаг. Төл мал гэсээр хоол ч идэх завгүй байгаа хүн чинь яахин чонын бэлтрэг суйлах гээд явж байх билээ. Тэгээд төл хүлээн авалт дуусаад хүмүүс жаахан зав чөлөөтэй болсон үед чонын бэлтрэгнүүд өсөж бойжоод үүрэндээ ч байхаа больсон байдаг. Өлөгчин чоно бэлтрэгээ төрүүлэх гэж үүрээ барааддаг болохоос бусад нь огт хээр гадаа л амьдардаг юм шүү дээ. Бэлтрэг нэг сарын дараа нүдээ бүрэн нээгээд, дахин нэг сар өнгөрөхөд ээжийгээ дагалдан энэ тэрүүгээр давхиж чадахуйц торнисон байдаг. Тийм болохоор тэр үед нь бэлтрэг суйлах гэж очоод хоосон хад мөргөнө гэсэн үг. Хэрвээ чоно зун, намар өвлийн аль нэгэн цагт бэлтрэгээ төрүүлдэг байсан бол хүмүүст хангалттай цаг зав байх болохоор төрүүлсэн бэлтрэгнүүдийг нь суйлсаар зүйл дуусгах байсан биз. Чоно хавар бэлтрэгээ төрүүлснээр тэднийг хурга ишигний махаар тэжээхийн зэрэгцээ яаж ангуучлахыг зааж өгөх боломжтой болдог. Нялх төлийн мах бэлтрэгнүүдийн дуртай хоол төдийгүй арван

бэлтрэг төрүүлээ ч сүү хүрэлцэхгүй гэхийн зовлон байхгүй болж байгаа юм. . . ” гэхэд

Ян Кө мориныхоо эмээлийн бүүргийг алгадаж аваад “Чоно минь, чоно минь, би чамайг бүр биширч гүйцлээ. Хэзээ бэлтрэг төрүүлэхээ хүртэл андахгүй мэддэг байна шүү. Нээрэн ч хаврын мал төллөлтийн үе шиг хэцүү бэрх цаг хэзээ байдаг билээ дээ? Төллөх малаа дагаж, хурганы уугаа үүрчихээд нэг удаа дөрөв таван шинэ төлийг уутлан гэр рүүгээ өдөрт арван хэдэн удаа харайлгасаар сүгтээ тултал ядардаг биш үү? Бид нар сонин дээрээ соохолзоод л эхний удаа бэлтрэг суйлах ажлын ард гарлаа. Харин дараа бол яасан ч чадашгүй нь. Өнөөдөр эртхэн харьж унтах минь” гэв.

Ян Кө хэдэн ч удаа эвшээлгэхийг хараад Чэнь Жэнь ч мөн өөрцгүй нойр их хүрч байх тул гэртээ хариад хэвтээд өгмөөр санагдана. Гэвч чонын тухай ярианаас салмааргүй байсан тул хүчлэн нойроо сэргээгээд Доржоос дахин “Тэгвэл энэ нутгийн хөгшид яахаараа бэлтрэг суйлахад төдийлөн таагүй ханддаг юм бэ?” хэмээн асуулаа.

Дорж хариуд нь “Манай энд дээхэн айл болгон шахуу нэг нэг ламтай байсан болохоор шашин шүтлэг ихтэй л дээ. Шашны ёсонд чоно гэлтгүй амьтны аминд хүрэх насанд цөвтэй гэж үздэг. Харин зүүн хойд орны монголчууд өөд бологсдоо хөдөөлүүлэх ёс үгүй болохоор чоноо хядаад дууссан гэдэг. Би ч тэдний нэг болохоор хятадуудтай адилхан хөрс шороонд нойрсохыг эрхэмлэдэг болсон” гэлээ.

Чонын үүрнээс хэдий нэлээд холдсон боловч араас нь сүг мэт нэгэн хий үзэгдэл дагаад байгаа мэт санагдаад, замын турш Чэнь Жэньгийн санаа бодол үймрэн, сэтгэлийн мухарт үл мэдэг айдас хүйдэс хургасаар байжээ. Чононоос асар хол нийслэл хотод өсөж торнисон тэрбээр долоон монгол чонын хувь тавиланг шийддэг байх гэж. Бэлтрэгнүүдийн эх болох өлөгчин маш зальтайгаас гадна, эд мөнөөх цагаан цээжит азарган чонын үр төл ч байж мэдэх юм. Эсвэл монгол талын угшил сайтай өөр нэгэн эрэгчингийн үр хойч ч юм бил үү? Хэрвээ өөрөө чонын хорхойтон болж салахгүй зууралдаагүйсэн бол энэ хэдэн бэлтрэг эрүүл энх өсөн торниод хожим тал нутагт алдар суугаа дуурсгасан эрэлхэг дайчид болох байсан биз ээ.

Харин өөрийнх нь оролцоо энэ хэдэн бэлтрэгний хувь тавиланг орвонгоор нь эргүүлж, түүний улмаас өөрөө тал нутгийн хөх чононуудтай бат бөх тавилангаар холбогдон тайлагдашгүй өс хонзонг зангидаж орхилоо. Олонбулгийн талын чонон сүрэг мөнөөх овжин зальтай өлөгчин чоно лугаа гүн шөнөөр түүн дээр ирэн сүнс сүлдийг нь амраахгүй мөшгөөд байх болов уу? Тэр өөрөө том буруу алхам хийснээ ухаарч эхлэжээ.

\* \* \*

Тэд үдээс хойш гэртээ эргэн ирлээ. Чэнь Жэнь чонын бэлтрэг хийсэн цүнхийг гэрийн хананд өлгөчихөөд дөрвүүл зуух тойрон сууж, гал өрдөн цай буцалгаад чанасан мах идэнгээ энэ долоон бэлтрэгийг яах ийхийгээ ярьцгааж байлаа. Дорж тэдэнд хандан “Чонын бэлтрэгийг яах ийх тухай ярилцаад байх юу байсан юм бэ? Би цайгаа уучихаад хоёрхон минутад эд бад хийгээд орхиё” гэв.

Чэнь Жэнь удахгүй чоно тэжээх гэсэн амаргүй ажилтай тулгарах болсоноо сайн мэдэж байлаа. Тэр бэлтрэг тэжээх бодол өөрт нь төрсөн цагаас авахуулан хавь ойрын малчид, дарга

нар болон бусад илгээлтийн эздийн ширүүн эсэргүүцэлтэй тулгарна гэдгийг таамаглаж байсан юм. Улс төр, шашин шүтлэг, үндэстний онцлог сэтгэл зүй, үйлдвэрлэл, аюулгүй байдал зэрэг бүхий л өнцгөөс бодож үзэхэд чоно тэжээх гэдэг урьдаас таамаглаж боломгүй, осолтой хэрэг байв. Соёлын хувьсгалын эхээр Бээжин хотын амьтны хүрээлэнгийн нэгэн ажилтан эхээсээ хагацсан барын бамбарыг амлуулж өсгөсөн жингэртэй цуг нэг торонд байлгасны төлөө харгис бурангуй ангитай эвлэрэнгүй хандсан гэдэг улс төрийн хэрэгт уначихаад айхтар шүүмжлэлд өртөж байсан удаатай. Тэгвэл чонын бэлтрэгийг хонин сүрэг болон нохдын дунд тэжээж өсгөнө гэдэг жинхэнэ дайсан нөхрөө эс ялгасан улс төрийн хэрэг болж хувирна биз дээ.

Чоно гэдэг малчдын өшөөт дайсан төдийгүй өвгөд хөгшдийн хувьд дээдлэдэг сүлд шүтээн, тэдний сүнсийг тэнгэрийн оронд аваачин амаржуулдаг зууч юм. Сүлд шүтээндээ дээдлэн мөргөж явахаас бус, яахин гэрийн ноходтой адилхан тэжээж болох билээ. Шашин шүтлэг, сэтгэл зүй, үйлдвэрлэлийн аюулгүй байдлаа ч бодолцон үзэхэд чоно тэжээснээр толгой цустаж мэдэх тул Билиг өвгөн өөрийн хөвгүүнээс өөрцгүй ханддаг хятад хүүгээ өрөөсөн нүдээрээ ч харахаа больчих юм биш байгаа даа.

Гэвч Чэнь Жэньд монгол үндэстний шашин шүтлэг, сүлд шүтээнийг гутаан доромжлох гэсэн санаа огт үгүй, харин ч тэдний чонон сүлдийг хүндлэн дээдлэж, чоно гэдэг нууцлаг амьтанд сэтгэл зүрхээ зориулсан болохоороо л бэлтрэг тэжээг гэдэг бодол нь өдөр ирэх тусам улам бүр батжсаар байгаа билээ.

Чонын ул мөр учир битүүлэг болохоор тэр өөрийн гараар нүдэнд үзэгдэж гарт баригдахуйц амьд чоныг тэжээхээс нааш түүний чонын тухай мэдлэг үнэн худал нь магадтай бус, ардын ам дамжсан домог яриа болон жирийн хүний ойлгоцын хүрээгээр хязгаарлагдахаар үл барам хятад үндэстний чоныг өширхөн үзэх хэлбэрүү үзэлтэйгээ зууралдсаар хоцрохыг хэн байг гэх вэ?

1967 оны эхээр Бээжингийн хэсэг илгээлтийн эзэд болон дотор газрын өөр бусад хүмүүсийг дагалдан Өвөрмонголын талд ихээхэн хэмжээний буу сум орж ирсэн билээ. Түүний хэрээр талын чоно цөөрсөөр байгаа тул хэдэн жилийн дараа долоон бэлтрэгтэй чонын үүр олоход амаргүй болж таарна. Малчдын зүгээс ганц чонын бэлтрэг олж авна гэдэг бүтэшгүй хэрэг тул зөвхөн өөрөө л тэжээх ганц зам байгаа юм. Цаашдаа хүлээх боломжгүй тул чонын бэлтрэгийг гартаа оруулсан энэ завшааныг ашиглан нэг чоно тэжээдэг хэрэг. Харин малчид, ялангуяа өвгөд хөгшдийн сэтгэлийг сэвтээхгүйн тулд тэдний хүлээн авч болохуйц нэгэн шалтгийг гаргаж ирэх хэрэгтэй.

Тэгээд тэр олон хоног тархиа гашилган байж “Чоныг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, нохойтой эвцэлдүүлж үзье” гэсэн боломжийн байж мэдэх нэгэн шалтгийг гаргаж ирсэн билээ.

Хил хамгаалах отрядын тав зургаан овчарк өндөр сүрлэг, хурд хүч ихтэй болохоор Олонбулгийн тал нутагт их нэр хүндтэй байдаг. Тэднээр үнэг чоно авлуулахад харсан болгон руугаа хавгай бахгай дайран ороод, алдана гэж бараг үгүй. Нэгэн удаа Жао овогт отрядын дарга хошоод байлдагчийг, немц овчарктай дагуулаад өрхийн цэргийн ажил байдалтай танилцахаар ирэх зам зуур нөгөө хоёр нь дөрвөн үнэг агнасан байж билээ. Ажил шалгах

далимаараа ангийн ийм их олз омогтой байсанд нутгийн анчид ихэд атаархсан байдалтай байсан юм. Хожим малчид тийм үүлдрийн нохойны ганц гөлөг олж тэжээе гэж ихэд хүсэмжлэх боловч тухайн цаг үед немц овчаркийг зөвхөн цэргийн зориулалттай тэжээдэг байсан болохоор тийм амар яаж олдох билээ.

Чэнь Жэнь немц овчаркийг эр чоно жингэр нохой хоёрыг эвцэлдүүлэн гаргаж авсан гэж сонссон болохоор эр бэлтрэгийг, нэг гичийтэй хамт байлгаж байгаад бэлэн зэхээний овчарктай болчихно. Дараа нь төрсөн гөлөгнүүдээ малчдад бэлэглэхээр чоно тэжээх боломжтой юм байна гэдгийг батлаж болох биш үү гэж бодсон юм. Тэгээд ч монголын талд дэлхий дээр байхгүй хамгийн шилмэл үүлдрийн чоно байгаа болохоор Зөвлөлт, Германд гарган авснаас ч илүү сайн овчарк буй болгох боломжтой. Ингэснээр монголын мал аж ахуйн хөгжилд ахиц дэвшил авчрахыг хэн байг гэх билээ.

Чэнь Жэнь цайны аягаа доош тавиад Доржид хандан: “Чи зургаан бэлтрэгийг эд бад хийчихээд надад харин хамгийн торниун эр бэлтрэг үлдээчихээрэй. Би түүнийг тэжээх гэж байгаа юм” гэлээ.

Дорж Чэнь, Жэньг чоно үзсэн мэт арван секунд орчим гөлрөн байснаа сая нэг юм “Чи тэгээд чоно тэжээх гэж байгаа юм биз дээ?” хэмээн асуулаа.

Чэнь Жэнь хариуд нь “Би нэг бэлтрэг тэжээж өсгөөд эм нохойтой эвцэлдүүлэн хилийн отрядынхаас ч илүү шилмэл омгийн овчарк гарган авах санаатай байгаа юм. Хэрвээ туршилт маань амжилттай болвол айл болгонд нэг гөлөг өгч болно шүү дээ” гэв.

Доржийн нүд амьтан олж харсан анч нохойн нүд шиг сортолзож амьсгаа дээрдэн “Наадахь чинь харин бүтдэг юм бол муугүй санаа байна шүү. Хэрвээ бид өөрсдийн овчарктай болчих юм бол үнэг чоно авлахад хичнээн дөхөм байх билээ. Бид нар овчаркныхаа гөлгийг зараад байхад л баяжиж гүйцнэ биз дээ” гэхэд

Чэнь Жэнь “Харин манай багийнхан чоно тэжээлгэхгүй гэх болов уу гэдгээс л айж байна” гэжээ.

“Чоно тэжээдэг нь явж явж чоно авлан нийгмийн өмчийг хамгаалахын төлөө биз дээ? Хэрвээ эсэргүүцэх хүн гардаг юм бол үр төлийг нь гардан авсан цагт биднээс гөлөг авна гэж горьдохын хэрэггүй” гэж Дорж хэлэв.

Ян Кө түүний үгийг өлгөж аваад “Чи бас чоно тэжээх санаатай хэрэг үү?” хэмээхэд

Дорж шийдсэн байдалтай “Та нар тэжээх гэж байгаа юм бол би яагаад болдоггүй билээ?” гэв.

Чэнь Жэнь алга ташин “Уухайс даа, хэрвээ хоёр айл зэрэг тэжээх юм бол амжилт олох магадлал бүр их болно гэсэн үг” гээд хэсэг бодлогоширч байснаа “Гэхдээ цагаа болохоор эр чоныг эм нохойтой эвцэлдүүлнэ гэдэг амаргүй хэрэг болох байх даа” гэлээ.

“Наадахь чинь гайгүй дээ. Надад нэг сайн арга байгаа. Гурван жилийн өмнө би нэг боломжийн сайн жингэр олж аваад гэрийнхээ хамгийн сайн эр нохойд гишгүүлье гэж

шийдсэн юм. Харин манай арван нохдын найм нь эр, тэдний дунд сайн ч бий, муу ч байдаг. Хэрвээ авчирсан жингэрээ тааруухан нэгтэй нь нийлүүлчих юм бол ямар олиг байх билээ. Би нохдын ороо орох цагаар гэрийн ойролцоо хоёр алд гүн хаягдмал худагт нөгөө жингэрийг гэрийнхээ хамгийн сайн эр нохойтой хамт орхиод ойр ойрхон хоол ус дөхүүлсээр хорь хоногийн дараа гаргаж авсан юм. Гэтэл тэр жингэр хээлтээд цагаан сарын дараа найман сайхан гөлөг гаргаж билээ. Би дөрвөн эм гөлгийг хаданд савж алчихаад үлдсэн дөрвийг нь өнөө хэр тэжээсээр байгаа. Манай арван хэдэн нохдын дунд тэр дөрөв л хамгийн хүч тэнхээ, сүр жавхаатай нь шүү дээ. Би тэр дөрвийнхөө хүчинд жилийн турш овоо хэдэн үнэг чоно авлачихдаг юм. Харин чи өөрийн бэлтрэгээ багаас нь эм гөлөгтэй хамт тэжээхийг мартаж орхивзой” хэмээн Дорж хэлэв.

Чэнь Жэнь ч уухайн тас зөвшөөрөлгүй яах вэ?

Бэрзээнтэн цүнхэн дэх чонын бэлтрэгнүүдийн бие хөшиж, өлссөн бололтой, үхсэн дүр үзүүлэхээ байж, гарахаар оролдон тонгочиж эхэлжээ.

Чэнь Жэньгийн хүндлэн биширдэг үнэ цэнэтэй долоон бяцхан амины тав нь удахгүй хорвоогийн нарыг харахаа болино гэж бодохоор сэтгэл нь өөрийн эрхгүй хүндрээд явчихав. Түүний нүдний өмнө Бээжингийн амьтны хүрээлэнгийн товгор хээ хуартай хашаа харагдах шиг болж, монгол талын цэвэр үүлдрийн энэ таван бэлтрэгийг тэнд аваачаад өгчихвөл хичнээн сайхан билээ гэж бодогдов. Тэр уг нь ганц бэлтрэг олж тэжээе гэсэн бодолтой байсан хүн чинь энэ долоогийн дундаас хамгийн өсгөлүүн нэгийг сонгоод авчихад л болох байтал илүү харж билүү долоодог нь ч юу билээ дээ.

Тэр энэ нэг үүрийн долоон бэлтрэгийг бүгдийг аваад ирдэг нь Дорж, Гао Зянь Жун хоёрыг дагуулж явснаас болсон хэрэг. Гэвч тэр хоёрыг дагуулж яваагүй тохиолдолд өөрөө ганц бэлтрэг бариад ирж чадах байсан бил үү? гээд бодохоор бас л яасан ч тэгэхгүй байж таарах гээд байдаг. Үүр дүүрэн чонын бэлтрэг суйлан авчирна гэдэг ялалт, эр зориг, эрх ашиг, нэр төр болон хүмүүс түүнийг өөр нүдээр харах зэрэгтэй тэнцэх болохоор тэр заавал авчрах л байсан. Тэгээд бодохоор энэ долоон амь элсэн ширхэгнээс хөнгөн бооцоо төдийхөн зүйл ажээ.

Энэ мөчид энэ долоон бяцхан амьтанд ихэд дассан болохоо мэдээд түүний зүрх чим чим базлалаа. Тэр хоёр жилийн турш бэлтрэгтэй больё гэж санасаар бэтгэрэх нь холгүй байсан болохоор энэ долоогийн амийг үлдээмээр санагдана. Долоон бэлтрэгийг тэжээхийн тулд хичнээн олон амьтны мах хэрэгтэй байх вэ гээд бодохоор ёстой боломжгүй зүйл тэр байлаа.

Тэр үлдсэн таван бэлтрэгийг буцаагаад үүрэнд нь аваачаад тавьчихвал яах вэ гэсэн бодол түүнд төрөв. Гэвч одоо Ян Көгөөс ондоо түүнд хань бараа болох хүн байхгүй. Ирэх буцахын дөрвөн цаг зарцуулах болохоор ганцаараа морьтойгоо гэлдэрнэ гэвэл бүр ч бардаггүй хэрэг. Нөгөө өлөгчин чоно өдийд лав үүрнийхээ хажууд ирчихсэн галзуурахад ганц хуруу дутуу амьтан улиад сүйд болж байгаа. Тэгэхээр эргээд явна гэдэг үхлээ эрснээс өөрц юу байх билээ.

Чэнь Жэнь цүнхээ барьчихаад гэрээсээ зугуухан гарч явав. “Дахин хэд хоносны дараа эдний учрыг олъё доо. Би хэдэн өдөр эднийг жаахан харж баясмаар байна” гэхэд



Дорж “Чи энэ хар хүйтэнд наадуулаа юугаар тэжээх гэсэн юм бэ? Наадуулыг чинь угжихгүй бол удахгүй үхээд өгөх болно” гэхэд

Чэнь Жэнь царайгаа барайлгаад “Би үнээний сүүгээр эднийг угжина аа” гэжээ.

Гао Зянь Жунгийн царай барайлгаад “Тэгж ч ярихгүй шүү. Үнээний сүү гэдэг чинь хүнд зориулагдсан эд. Харин түүгээр чоно тэжээдэг ёсон гэж хаана байх билээ? Түүнийг сонсох юм бол багийн захиргаанаас надаар үхэр хариулуулахаа болих байлгүй” гэв.

Ян Кө тэдний эвийг олох санаатай “Доржоор тавынх нь учрыг олуулах хэрэгтэй. Цаад Галсмаа чинь төлөвлөгөө биелэхгүй байна гээд үглэж дуулаад байсан. Хэрвээ таван бэлтрэгний арьс аваачаад тушаачихвал бид далдуур бэлтрэг тэжээх нэр нүүртэй болно гэсэн үг. Эс бөгөөс багийн бусад малчид энэ долоогийн барааг амьдаар нь харчих юм бол чи ганцыг ч тэжээх боломжгүй болно шүү. Чи бид хоёр оготны хамраас цус гаргах зүрхгүй улс чинь, Доржийг байгаа дээр учрыг нь олуулчих хэрэгтэй” гэжээ.

Чэнь Жэньгийн нүд арган уртаар санаа алдаад “Өөр ямар арга байх билээ дээ?” гэв.

Чэнь Жэнь буцаж гэртээ ороод аргалын хайрцгаа султган бэлтрэгнүүдийг түүн дотор хийв. Бэлтрэгнүүд ийш тийш тийчигнэсээр аргалын хайрцагны буланд хүрээд үхсэн дүр эсгэж гулдайн хэвтэх нь тулаад ирсэн гай барцдыг даван туулах гэсэн арга байлаа. Бэлтрэгнүүд цахилгаанд цохиулсан мэт ширүүн хар үс нь хүртэл дагжин чичрэх ажээ.

Дорж бэлтрэгнүүдийг туулайн бүжин адил шилдэн өргөж үзсэнээ Чэнь Жэньд хандан: “Дөрвөн эр гурван охин бэлтрэг байна. Хамгийн биерхүү эр бэлтрэгийг чамд өгөөд, үүнийг харин би өөрөө авъя” гэхихээд үлдсэн тавыг нь цүнхэнд буцаан хийлээ.

Дорж бэлтрэгнүүдийг барин гэрийн өмнөх уужим зайд хүрээд цүнхнээс нэг бэлтрэг сугалан гаргаж гэдсийг нь харж байснаа “Энэ охин бэлтрэгийг эхлээд тэнгэр өөд илгээе” гэхихээд баруун хөлөө нугалан сууж, гараа огцом дээш савчаад бяцхан бэлтрэгийг тэнгэр өөд шидэж орхив. Энэ үйлдэл нь тал нутгийн малчид хавар хэрэгцээнээс илүү гарсан нохойн гөлөгний сүнсийг тэнгэрт илгээдэгтэй адил юм. Чэнь Жэнь, Ян Кө хоёр энд ирснээс хойш иймэрхүү ёс заншлыг бишгүй нэг үзэж байсан, чонын бэлтрэгийг ч ийм маягаар бодийг хөтөлдөг гэж сонссон боловч харин өөрсдийн барьж ирсэн бэлтрэгийг ийн зүйл дуусгаж байгааг анх удаа үзэж байгаа юм. Чэнь Жэнь, Ян Кө хоёрын царай гэрийн хажуугийн цагаан цаснаас дутахгүй цонхийн цайсан байлаа.

Дээш шидэгдсэн чонын бэлтрэг ийм эрт тэнгэрт заларья гэж бодоогүй бололтой. Тувт үхсэн юм шиг хөдлөхгүй байсан хөөрхий чонын бэлтрэг дээш шидэгдэх тэр агшинд зөн совингоороо чухам юу болох гэж байгааг гадарласан бололтой түгжиж байсан амьсгаагаа гаргаад дөрвөн мөчөө сарвалзуулах нь ээжийн өвөр, аавын хүзүүгээр тэврэн авья гэж бодсон уу, эсвэл амь аврах ганц ширхэг чонын хялгаснаас зулгаан авахаар чармайж байгаа мэт санагдана.

Охин бэлтрэгний зэгэл саарал аниастай нүд айсандаа огцом нээгдэн, цус хурсан улаан нүд нь цухалзах шиг Чэнь Жэньд санагдлаа. Хөөрхий бэлтрэг агаарт шидэгдэхдээ нүд нь хэдийгээр

нээгдсэн ч бараан үүл болон нүдэнд нь хурсан цусны өнгөнд халхлагдаад тэнгэрийн унаган хөх цэнхэр өнгийг олж үзээгүй нь лавтай. Бэлтрэг амаа ангайгаад хөөрлийн дээд цэгт хүрсэний дараа доош унахад цасгүй халцгай газар түүнийг угтан тослоо.

Бэлтрэг пидхийтэл газар унаад булбарай зөөлөн бие нь тийчлэж ч амжилгүй хөдөлгөөнгүй болов. Нүд, чих хамраас нь уураг холилдсон ухаа ягаан цус бултайн үзэгдэнэ. Чэнь Жэньгийн зүрх амаараа сугаран гарах гэж байгаа мэт санагдаад хамаг бие нь хөдөлгөөнгүй болжээ.

Гурван нохой бэлтрэгний дэргэд гүйлдэн ирэхэд Дорж хашгиран зандраад хэд алхан нохдыг халхалсан нь чонын бэлтрэгний нандин арьсыг цаадуул нь хөндөхөөс сэргийлсэн хэрэг байв. Арслан нөгөө хоёрыгоо үхсэн бэлтрэгийг зуугаад явчих вий гэж сэргийлсэн байдалтай архирч байгааг Чэнь Жэнь санамсаргүй олж мэджээ. Эрэмгий зоригт Арслан дайсныхаа хүүрийг даажигнахгүй харин ч чонын бэлтрэгийг хайрлаж байгаа шинжтэй байв.

Дорж өөр нэгэн бэлтрэгийг цүнхнээс гарган ирэх агшинд нөгөөх нь эгчийнхээ халуун цусны үнэрийг авсан бололтой дахин үхсэн дүр эсгэхээ болиод харин ч тийчигнэн, мөгжгор бяцхан сарвуугаараа түүний гарыг цагаан судал гартал самардаж байв. Дорж бэлтрэгийг шидэх гэснээ гэнэт болиод Чэнь Жэньд хандан “Алив чи одоо үүнийг эд бад хийгээдэх. Тал нутгийн хоньчин хүн чоно алаагүй нь чамаас өөр хэн байх билээ? Үүнийг алчих юм бол зориг чинь ч чангараад явчихна” гэв.

Чэнь Жэнь арагш ухраад “Чи янзалсан нь дээр байх аа” гэхэд

Цаадахь нь “Танай хятадууд ч мөн дүүрсэн зориггүй улс шүү. Чоныг тэгтлээ үзэн яддаг мөртлөө ганц бэлтрэг алчихаж чадахгүй байж яахин олигтой байлдаж чадах билээ? Тэгж их хүч заран байж цагаан хэрмийг босгодог нь аргагүй. Алив намайг харж бай. . . ” гэхихээд түүнийг тэнгэр өөд илгээв. Түүнийг газар хараахан бууж ирээгүй байтал дараагийнх нь залгаад дээш хөөрөв. Доржийн хийморь сэргээд амандаа “Дээд тэнгэрт одож буян заяагаа эдлэх болтугай” хэмээн үглэнэ.

Чэнь Жэньгийн зориг бадрах байтугай харин ч хийморь сүлд нь үхээд өгөх шиг санагдаж байлаа. Нядалгааны хутга барьдаг үндэстэн хадуур барьдаг үндэстнээс төмөр цусанд илүү ойр дөхөм байдаг нь энэ хоёр үндэстний сэтгэл зүйн хамгийн том ялгаа болохыг тэр гүнээ ухааран ойлгов. Эртний хятад үндэстэн яагаад өөрийн үндэстний дотор нэгэн нүүдэлчин угшлыг үлдээж болоогүй юм бол доо? Өөрийн улсын хил хязгаарын дотор нүүдлийн мал аж ахуй эрхлэх хэсэг нутгийг үлдээгээд хятад үндэстний “Гусак” угшлыг буй болгосон болоосой. Үнэндээ цагаан хэрэм босгож, атар газрыг хагалан хил хязгаараа хамгаалснаас нүүдлийн мал аж ахуйгаар хил хязгаараа хамгаалсан бол хавьгүй дээр байх байсан юм. Тал нутгийн үндэстэн энэхүү хахир хатуу орчиндоо хэдэн зуун мянган жилийн турш өөрсдийн эр зоригийг дадуулан буй болгожээ.

Таван хөөрхөн бэлтрэг агаар тэнгэрт хөөрсөөр цус нөжтэйгээ хутгалдан газарт унав. Чэнь Жэнь таван үхсэн бэлтрэгийг арагт хийн барьчихаад дээш харан тэнгэр тэдний сүнсийг авралдаа багтаах болтугай хэмээн удтал сүслэн зогсов.

Дорж их л бахтай байгаа бололтой доош тонгойн ээтгэр монгол гуталдаа гараа арчаад “Өдөрт

таван чонын бодь хөтлөнө гэдэг тэр болгон тохиохгүй завшаан шүү. Хүмүүс бид чонотой харьцуулахад бас ч болоогүй. Хэрвээ боломж тохиох юм бол нэг нас бие гүйцсэн чоно зуу гаруй хонийг эд бад хийчихдэг юм. Түүний хажууд таван бэлтрэг зүйл дуусгах ч юухан байх вэ? Үг олдож үхэр холдох нь. Би ч хонь руугаа явья даа” гэхихээд нөгөө өөрийн мэдлийн бэлтрэгийг авах гэв.

Чэнь Жэнь түүнд хандан “Байзаарай, чи бидэнд наад бэлтрэгнүүдээ өвчиж өгөөд яв” гэхэд “Тэр бололгүй яахав. Ажил хийвэл дуустал гэдэг биз дээ? Би одоохон өвчөөдөхье” гэлээ.

Арслан арагны хажууд үхсэн бэлтрэгнүүдийг сахин зогсоод Дорж руу хоёронтоо архиран дайрахаар завдав. Чэнь Жэнь түүнийг хүзүүдэн хориглолоо.

Дорж бэлтрэгнүүдийг өвчингөө “Бэлтрэгний арьс дэндүү жаахан болохоор туламлан өвчиж болдоггүй юм” гэнэ. Тэр удаж төдөлгүй таван бэлтрэгний арьсыг өвчиж дуусгаад гэрийн унинд тэлж хатаалаа. “Энэ тун сайн арьснууд байна. Хэрвээ ийм дөчин арьстай бол нэг сайхан хөнгөн зөөлөн дээлийн дотортой болохгүй юу. Тийм дээлийг хичнээн төгрөгний үнэ хүрнэ гэж бодож байна даа” гэлээ.

Дорж цасаар гараа угаачихаад үхэр тэргэн дээрээс хүрз авч “Та хэд юу ч сураагүй амьгад юм даа. Би та нарт туслахаас биш. Нохой бэлтрэгний махыг иддэггүй болохоор жаахан гүнзгий булсан нь дээр. Хэрвээ нөгөө өлөгчин үнэрээр нь мөрдөөд хүрээд ирвэл танай хонь мал сүйд боллоо гэсэн үг шүү”

Тэр хэд монгол гэрээс хэдэн арван метрийн зайтай нэгэн газар метр шахам гүнзгий нүх ухаж таван бэлтрэгийг булчихаад дээрээс нь шингэн бодис цацаж үнэрийг нь дарлаа.

Ян Кө Доржоос “Тэжээх бэлтрэгэндээ үүр барьж өгөх хэрэгтэй юу?” хэмээн асуухад “Газар нүх ухаж өгөөд байлгасан нь дээр байх” гэв. Чэнь Жэнь, Ян Кө хоёр монгол гэрийн баруун талд арван хэдэн алхам зайтай газар жаран сантиметр гүн, хагас метр өргөнтэй нүх ухаж, адсага дэвсэн бэлтрэгээ тавив.

Бэлтрэг газар нүхэнд оронгуут амь орох шиг болж, энэ тэрийг үнэрлэх нь төрсөн гэртээ буцан ирлээ гэж бодсон бололтой. Тэр нэлээд тайвширсан байдалтай адсаганы буланд атиран хэвтээд ах дүүсээ эрэх мэт үнэрлэж шиншсэн хэвээр байв. Чэнь Жэнь нөгөө бэлтрэгийг үлдээж түүнд хань бараа болгоё гэж бодсон боловч Дорж аль хэдийн өвөртлөж аваад давхин одсон байлаа. Гао Зянь Жун бэлтрэгийг хяламхийн харсанаа мориндоо мордон үхрээ хашихаар яваад өгөв.

\* \* \*

Чэнь Жэнь, Ян Кө хоёр үүрнийх нь хажууд сөхрөн суучихаад бэлтрэгийг зовнингүй байдалтай ажиглана. “Чи бид хоёр энэ бэлтрэгийг өсгөж том болгож чаддаг л байгаа даа. Цаашдын төвөг бэрхшээл ч мөн их байна шүү” хэмээн Чэнь Жэньг өгүүлэхэд

Ян Кө “Муу үг модон улаатай гэж юу болохыг чи удахгүй харах болно оо. Одоо чинь улс орон даяар чонон сүргийг устгаж барахаас наана тулааны талбараас ухрахгүй гэж дуулалдаж

байгаа үе шүү дээ. Гэтэл чи бид хоёр өшөөтөн чоныг өмөгт нөхрөө мэт тэжээн өсгөж байдаг” гэв.

Чэнь Жэнь түүний хариуд “Засгийн хуулиас хол энэ аглаг бөглүү газар тэр ч харин гайгүй байх аа. Харин Билиг аав л бидэнд чоно тэжээхийг зөвшөөрөхгүй байж мэднэ гэж айгаад байна шүү” гэлээ.

“Үнээнүүд маань эргэн ирсэн болохоор би жаахан сүү саагаад ирье, наад бэлтрэг чинь харангадах гэж байгаа” хэмээн Ян Көг хэлэхэд

Чэнь Жэнь гараа сэгсрэн хориглоод “Ирвэст амлуулсан нь дээр. Нохой чинь барын бамбарыг хөхүүлээд байдаг юм чинь чонын бэлтрэгийг яагаад хажиглах билээ?” гэснээ бэлтрэгийг үүрнээс нь гарган цээжиндээ тэврэв. Өдөржин сүүгээ хөхөөгүй бэлтрэгний гэдэс хонхолзоод бяцхан сарвуунууд нь мөс шиг хүйтэн юм болжээ. Одоо өлсөж даарч, айсандаа дагжин чичрээд анх үүрнээс нь гаргаж ирж байснаас ч илүү жаахан болсон шиг санагдана. Чэнь Жэнь түүнийг эхлээд дулаацуулах санаатай өвөртөө хийлээ.

Харуй бүрийн орчимд тэр хоёр Ирвэсийн үүрэнд бэлтрэгийг хөхүүлэхээр очив. Тэр хоёрын урьд нь цас овоолон барьсан нохойн үүр халуун наранд хайлж урссан болохоор шинэ үүрийг монгол гэрийн урд хураалттай аргалыг хонхойлон, адсага дэвсээд гадуур нь хатсан адууны ширээр халхалсан нь Ирвэсийн гурван гөлөгтэйгөө төвхнөх дулаан оромж болоод байгаа юм.

Ян Кө ясны шөлөнд чанасан шар будаагаар Ирвэсийг цатгасны дараа тэр үүрнийхээ дэргэд гүйж очоод хамраараа адууны ширийг шөргөөн дотогш шурган ороод, хана налан цагариглан хэвтэхэд гурван гөлөг хөхийг нь олж угзчин хөхөж гарав.

Чэнь Жэнь сэмээрхэн Ирвэсийн дэргэд дөхөн очоод доош тонгойн, нүдийг халхлах санаатай толгойг нь зөөлөн илбэж эхлэв. Ирвэс эзэндээ эрхлэх дуртай учраас их баяртай гарыг нь долоож байлаа. Ян Кө нэг гөлгийг холтгоод нэг гараараа нохойн дэлэнг шувгарч, нөгөө гарын алгандаа тосож дүүргэхийн алдад Чэнь Жэнь өврөөсөө бэлтрэгийг гарган ирэв. Ян Кө нохойн сүүг бэлтрэгний толгой, нуруу, сарвуу зэрэгт түрхлээ.

Энэ бол эхээс хагацсан хурга ишгийг өөр хонь ямаанд амлуулахдаа хэрэглэдэг тал нутгийн эртнээс уламжилж ирсэн арга юм. Ян Кө, Чэнь Жэнь хоёр ч гэсэн чухам энэ л аргаар чонын бэлтрэгийг Ирвэст амлуулья гэж боджээ. Гэвч нохой гэдэг хонь ямаанаас хавьгүй ухаалаг, үнэрч амьтан билээ. Хэрвээ Ирвэсийн гөлөгнүүд бүгдээрээ эзэнтэй болсон буюу эсвэл бүгд үхчихсэн бол энэ бэлтрэгийг амлуулаад авч мэдэх л юм. Харин одоо өөрөө гурван гөлөгтэй болохоор бэлтрэгийг өөртөө хавьтуулахгүй янзтай. Чонын бэлтрэгийг үүрэнд нь оруулж ирсэн цагаас эхлэн тэр толгойгоо өргөж, гөлөгнүүдээ харахаар өндөлзөнө. Чэнь Жэнь, Ян Кө хоёр зандах аргадахыг хослуулан байж Ирвэсийг дарж байлаа.

Өлсөж даарсан бэлтрэгийг Ирвэсийн хөхний толгой бараадуулан орхиход, сүүний үнэр авсан бэлтрэг үхсэн мэт унхиагүй байдлаа гээгээд мах харсан том чоно шиг сэргэн дөрвөн мөчөө сарвалзуулсаар ховдоглон дайрлаа.

Бэлтрэг гөлөгнүүдээс хагас сарын хойно төрсөн болохоор бие бялдрын хувьд хавьгүй давжаа

харагдана. Гэвч тэр хүч тэнхээний хувьд гөлөгнүүдээс хавьгүй илүү, хөхийг булаан хөхөхдөө ч тэднийг хавьтуулахгүй ажээ. Жингэр нохойны хоёр эгнээ дэлэнгийн хөхний товч том жижиг болохоор сүүний гарц нь ч харилцан адилгүй. Бэлтрэг сүү хөхөх гэж яарахгүй харин дэлэнг өөд уруугүй шиншлэнгээ нөгөө хоёр гөлгийг холдуулан унагаж байгааг хараад Чэнь Жэнь, Ян Кө хоёр үнэхээр их гайхаж байлаа.

Хэсэгхэн хугацааны зуур нам гүм байсан нохойн үүрэнд зэрлэг балмад дээрэмчин дайран орж ирсэн мэт гөлөгнүүд энд тэнд шидэгдэн унахад бэлтрэг тэдний дээгүүр гишгэчин хоёр эгнээ дэлэнгийн хөхнүүдийг нэг нэгээр амссаар эцэст нь Ирвэсийн хамгийн их сүүтэй хөхийг олж ховх ховх сорж гарав. Тэр нэг хөхийг сороод ханахгүй урд сарвуугаараа өөр нэгэн хөхийг дарах нь хойноос ирээд хот минийх гэсэн шинжтэй байх ажээ. Гурван паацгар гөлөг удаж төдөлгүй чонын бэлтрэгт шахагдан хоолгүй хоцорлоо.

Тэр хоёрын нүд бүлтийн алмайрч хоцров. Ян Кө нүдээ бүлтийлгэн “Чонын авир ямар аймаар юм бэ? Муу золиг чинь нүдээ нээгээгүй байхдаа л ийм түрэмгий байдаг байна шүү. Тэр үүрэндээ байхдаа бусад ах дүүсдээ ийм түрэмгий ханддаг байсан болохоор хамгийн том биетэй байх нь аргагүй юм байна.” гэв.

Чэнь Жэнь түүнийг бахдалтайгаар ширтэн гүн бодолд орж байснаа “Хоёулаа сайн хараад авья. Энэ дунд хүнд юм бодогдуулахаар зүйл зөндөө байна шүү. Энэ нохойн үүрийг дэлхийн түүхийн хураангуй багц гэж хэлж болохоор байгааг харж байна уу? Лү Сюнь зохиолч өрнөдийн хүмүүст араатанлаг шинж зонхилсон байдаг бол, манай хятадуудад малжуу шинж давамгайлсан гэж хэлсэн байдгийг би сая гэнэт саналаа” хэмээн чонын бэлтрэгийг заагаад “Араатанлаг шинж гэдэг чинь энэ мөн шүү дээ” гэснээ нохойн гөлөгнүүдийг зааж “Харин энэ бол малжуу хэв шинж юм. Өдгөөгийн өрнөдийн хүмүүсийн дийлэнх нь Герман, Англо-Саксон зэрэг нүүдэлч, анч бүдүүлэг үндэстнүүдийн үр хойч нар юм шүү дээ. Эртний Грек, Ромын өндөр хөгжилтэй соёл иргэншил нэг хоёр мянган жил хөгжсөний дараа тэд зэрлэг араатан лугаа балар ой шугуйгаас гарч ирээд эртний Ромын эзэнт гүрнийг баллаад өгсөн. Тэд нар хутга сэрээ хэрэглэн, мах бяслаг, шар тос иддэг байсан юм. Тийм болохоор одоогийн өрнөдийн хүмүүсийн биед эрт балрын адгууслаг, араатанлаг шинж эртний тариачин үндэстнийхээс илүү нэвт шингэсэн байдаг. Зуу гаруй жилийн өмнө хятадын малжуу шинж өрнөдийн араатанлаг хэв шинжид дарангуйлагдсан юм. Тийм болохоор хэдэн мянган жилийн түүхтэй аугаа их хятад үндэстэн тал нутгийн цөөн тоот үндэстэнд шившигтэйгээр бутцохигдож байсныг гайхаад байх юм алга” гэж хэлэв.

Чэнь Жэнь бэлтрэгний толгойг илбэж байснаа залгуулан “Зан чанар гэдэг гагцхүү хувь хүний хувь тавилан төдийгүй бүхэл бүтэн үндэстний хувь заяаг ч шийдэх чадалтай ажээ. Тариаланч үндэстний малжуу хэв шинж, бүтэлгүй зан чанар нь тэдний хувь заяаг шийддэг юм байна. Дэлхийн эртний дөрвөн том соёл иргэншил бүгдээрээ газар тариалан эрхэлдэг байсны гурав нь ор мөргүй арчигдан алга болсон. Харин хятадын соёл иргэншлийн өдий хүртэл устаж үгүй бололгүй оршин тогтносоор байгаа нь тус орон газар тариалан эрхлэхэд тохиромжтой Хөх, Шар хоёр мөрний сав газар оршдог, дэлхий дээр хамгийн олон хүн амтай болохоор бусад соёл иргэншилдээ устгагдаагүй хэрэг. Энэ нь талын нүүдэлчин үндэстэн Хятадын соёл иргэншилд оруулсан асар их хувь нэмэртэй холбоотой байж ч мэдэх юм. Гэхдээ энэ нарийн хэлхээ холбоог би хараахан сайтар бодож олоогүй л байна. Тал нутагт хоёр жил байх

хугацаанд энэ бүхний цаана их л нарийн учиг сэжим байгаа болохыг улам бүр илүүтэй сайн мэдрэх боллоо. . . ” гэв.

Ян Кө ч толгой дохин “Хараажаар чоно тэжээх нь чоныг судлаж болохоос гадна, хүний зан чанар, чонын зан, адгуусны зөн, малжуу чанаруудыг харьцуулан судлах боломж олгодог юм байна. Хот газар болон газар тариалангийн бүсэд ийм боломж байхгүй сайндаа л хүн малтай ойр байх боломжтой шүү дээ” гэлээ.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Гэхдээ хүний зан чанар, малжуу чанарыг чоно болон адгуусны зантай харьцуулан судлахгүйгээр олигтой ямар үр дүн гарах билээ?” гэхэд

Ян Кө инээд алдан “Тийм шүү хө. Чоно тэжээсэн эхний өдөр л ийм их үр дүн гарч байгаа болохоор хоёулаа энэ бэлтрэгээ тэжээгээд байдаг хэрэг ээ” гэв.

Нохойн үүрэнд бужигнаан үүсэн, гөлөгнүүд нь чонын бэлтрэгт дээрэлхүүлэн гийналдах чимээ Ирвэсийн сэжиг сэрэмжийг улам ихэсгэсэнд тэр чухам юу болоод байгааг харах санаатай Чэнь Жэньгийн гараас мултрахаар тийчигнэв. Чэнь Жэнь жингэр нохой бэлтрэгийг хазаад алчих вий хэмээн санаа зовоод толгойг нь чанга дарсан хэвээр нэрээр дуудан үсийг илбэсээр бэлтрэг подойтол хөхөж дууссаны дараа сая гараа султгав.

Ирвэс толгойгоо өргөн бэлтрэгийг олж хараад зовнингүй шиншилж байснаа чонын үнэр өөрийнх нь сүүний үнэртэй холилдсон байхыг олж мэдээд хэсэг зуур эргэлзсэн байдалтай байлаа. Тэр бэлтрэгийг хамраараа шөргөөн босохыг хичээх нь гэрэлтэй газар гаргаад юу болоод байгааг сайтар харъя гэж бодсон нь илт.

Чэнь Жэнь, Ирвэсийг дарж буцаан хэвтүүлж, бодит байдалтай эвлэрч эсэргүүцээд хэрэггүй шүү хэмээн өөрийнхөө санааг ойлгуулав. Ирвэс тийчигнэн гийнах нь түүний үүрэнд эзэд нь сая уулан дээрээс барьж ирсэн чонын бэлтрэгийг оруулаад, өстөн дайсных нь үрийг өөрт нь хүчээр амлуулах гэж байгааг мэдсэн шинжтэй ажээ.

Талын нохдыг дотор газрын ноходтой зүйрлэх аргагүй юм. Дотор газрын ноход чоно, барсыг үзээгүй байдаг болохоор бамбарыг өөрт нь амлуулахад удаж төдөлгүй дасчихдаг. Харин тал газар чоно, нохдын тэмцэлдэх талбар учраас яахин өстөн дайсныхаа үрийг тийм амар амлуулах билээ. Ирвэс хэдэн ч удаа тийчигнэн босох гэсэн боловч Чэнь Жэнь дарж хэвтүүлсээр байв. Ирвэс уурлаж бачимдан, тун дургүй шинжтэй байх боловч эзнийхээ өөдөөс яаж ч чадалгүй, эцэс сүүлдээ амьсгаадан хэвтээд өгөв.

Тал нутагт хүн нохойны хувь заяаг бүрэн эрхшээдэг бөгөөд бүр эрт балар цагт сүр хүчийг үзүүлэх, хоол ундаар урвуулах аргыг хослуулан хэрэглэсээр зэрлэг нохойг гаршуулж чадсан ажээ. Эзнийхээ аясаар байж чадахгүй нохой гэрээсээ хөөгдөн эзгүй талд өлсөж, даарч үхэх буюу чонын хоол болдоггүй юм бол эзэндээ алагдах тавилан хүлээж байдаг. Тийм болохоор нохой араатанлаг чанараа аль хэдийн гээгээд малжуу хэв шинж давамгайлж, хүнгүйгээр оршин амьдарч чадахгүй амьтан болон хувирчээ. Түүнтэй агаар нэг нь юу хэмээвээс хүний нийгэмд хэт хатуу дарангуйллын нөхцөлд дэндүү урт удаан амьдарсан хүмүүс хүний зан чанарт агуулагдаж байдаг араатанлаг чанараа гээгээд аажмаар малжуу хэв шинж давамгайлсан ноомой иргэд болдог ажгуу. Ноомой иргэд олшроод ирэхээр үндэстний дотоод

дахь ноёрхлыг амжилттай хэрэгжүүлж болох боловч гадаадын хүчирхэг дайснууд халдан түрэмгийлэх үед тухайн үндэстэн эсэргүүцэх чадвараа гээсэн байдаг. Тэгснээр халдан түрэмгийлэгчдийн албат харьяат болох буюу эсвэл бүрмөсөн үгүйрэн устаад, хожмын хүмүүс археологийн аргаар тэдний сүйрч баларсаны ул мөрийг олж тогтоох ганц зам үлддэг байна. Хичнээн олон гялалзсан суурин соёл иргэншлийн ул мөрийг өнөөдөр зөвхөн музейн танхимаас л үзэх боломжтой болчихоод байгаа билээ дээ?

Нохойн үүр зугуухан нам гүм боллоо. Ирвэс бол Ян Кө, Чэнь Жэнь хоёрын тэжээсэн анхны жингэр болохоор түүнийг хээлтэй, төрөх болон хөхүүл бүхий л үед нь анхаарал тавьж, хоол ундыг огт таслахгүй байсаар ирсэн. Тийм болохоор Ирвэсийн дэлэн сүү сайтай. Ялангуяа бусад айлууд түүний гөлгийг аваад явсан үед сүү нь хангалттай байдаг болохоор өөр нэг бэлтрэгийг түүнд хөхүүлэхэд санаа зоволтгүй элбэг хүрэлцэх юм.

Гурван гөлөг хэдийгээр чонын бэлтрэгт шахагдаад зөвхөн тааруу сүүтэй хөх оногдсон боловч зугуухан хөхсөөр цадаж авлаа. Тэр гурав цадсаны хойно эхийнхээ хүзүү нуруу руу асан хоорондоо ноцолдож эхлэхэд чонын бэлтрэг ховдоглон хөхсөөр байх ажээ. Чонын үүрэнд долоон бэлтрэг бие биетэйгээ өрсөлдсөөр чадал тэнхээ муутай нэг нь өлсөж үхдэг байх нь гэж Чэнь Жэнь бодож байв. Бэлтрэг гэдсээ яз хөхөхөөс нааш санаа амрахгүй бололтой. Нохойн үүрэнд ороод ч тэр өөрийн чадварыг харуулж, тааламжтай гийнан жингэрийн сүүт ховх ховх сорох нь бод мал барьсан өлөн чоно гэдэснийхээ хэмжээг мэдэлгүй бүхэл хахлаар нь залгиж байдгаас өөрцгүй санагдана.

Яах ийхийн зуургүй бэлтрэгний гэдэс хамгийн том гөлөгний гэдэснээс ч илүү цодойгоод явчихыг Чэнь Жэнь хараад илж үзвээс арьс нь цаас мэт нимгэрэн цүдийсэн байлаа. Чэнь Жэнь бэлтрэгний гэдсийг хагарах вий гэж айгаад хүзүүнээс нь атган татвал цаадахь нь амаа султгах шинжгүй жингэрийн хөхийг амандаа зуун сунгахад Ирвэс өвдсөн бололтой зөөлөн гийнав.

Ян Кө ч яаран хоёр хуруугаараа бэлтрэгний завьжийг шахан амыг султгаад сая нэг юм уужирсан байдалтай санаа алдаж “Малчид чоно цадахаа мэддэггүй гэж ярилцдаг үнэхээр үнэн ажээ” гэхэд

Чэнь Жэньгийн царайд баясал тодроод “Бэлтрэг хоолонд ийм сайн, амьдрах чадвар сайтай болохоор тэжээж ядаад байх зүйл алга. Одоо түүнийг сайн хооллоод сайтар харгалзаад байх л үлдэж” гэв.

Чэнь Жэнь чонын үүрнээс дөнгөж авчирсан бэлтрэгний биенээс аймшигтай өрсөлдөх чадвар, харгис хатуу зан чанар болон түүнээс улбаалан биед нь нэвт шувт шингэсэн чонын зан чанарыг өөрийн нүдээр таньж мэдэж авчээ.

\* \* \*

Харуй бүрий болохын алдад Чэнь Жэнь чонын бэлтрэгийг нэгэн охин гөлөгтэй цуг үүрэнд нь хийлээ. Бэлтрэг нүдээ нээхдээ охин гөлгийг олж хараад яваандаа ижилдэн дасаг гэсэн бодлыг өвөрлөх болсон юм. Хоёр бяцхан амьтан бие биесээ үнэрлэж байснаа нохойны сүүний үнэр дасгав бололтой бөөрөө нийлүүлэн унтаад өглөө.

Арслан, Чэнь Жэньгийн дэргэд зогсчихоод эзнийхээ үйл хөдлөл нэг бүрийг нүд салгахгүй ажиглангаа сүүлээ ер бусын ихээр шарвагануулах нь чонын бэлтрэгийг тэжээхээр авчирсанд тааламжтай байгааг илэрхийлж буй хэрэг юм. Юмыг яаж мэдэхэв гэж болгоомжилсондоо тэр нэгэн хуучин ширээний тавцанг бэлтрэгний үүрэн дээр тавиад дээр нь том чулуугаар даруулж орхив.

Зөөлөн бодь зантай Гомбо хоньдыг хашчихаад Чэнь Жэнь тэр хоёрын бэлтрэг сүйлсэн сургаар гар чийдэнгээ барьсаар орж ирлээ. Тэр монгол гэрийн уинд тохоостой бэлтрэгний арьснуудыг хараад их л гайхсан байдалтай “Манай Олонбулагт хятад хүн бэлтрэг сүйлж байсан тохиолдол урьд нь огт байгаагүй юм. Ийм юм гэж байдаг аа, бас” гэнэ.

Тэр гурав зуухаа тойрон суугаад гоймонтой шөл идэж байтал ноход хуцалдан морин төвөргөөн сонсогдоод явчихав.

Жан Зи Юань эсгий үүдийг сөхөн, модон хаалга онгойлгоод орж ирэхэд гартаа хазаар ногт хоёр барьсан харагдана. Тэр зуухны доохонтой сөхрөн суугаад “Аж ахуйн төвөөс мэдээ ирлээ. Хил орчмын том чонон сүрэг хоёр хуваагдан наашаа гарсан тул нийт аж ахуйн гурван багийн хүн хүч гурав хуваагдан ав хомрого хийхээр боллоо. Манай багийнхан Билиг өвөөгөөр ахлуулан баруун хойд зурвасыг хариуцахаар болсон. Аж ахуйгаас бидэнд нэмэлт хүн хүчээр туслана гэж байна лээ. Тийм болохоор бүх хүмүүсийг шөнийн нэг цаг гэхэд Билиг өвөөгийн гэрт цуглар гэж багийн захиргаанаас мэдэгдэж байна. Аж ахуйн захиргаа бүх айлуудын хүмүүс хөгшин хөвөө улсдаа хонь малаа даатгаж үлдээгээд ав хомрогод оролц гэсэн. Адуучид отооны газрыг тойрон уналгагүй айлуудад морь мал хүргэж байна. Та нар эртхэн унтаад цагаасаа хожимдолгүй очоорой” гэхчээд цай цүй ч амсалгүй гарч, мориндоо мордон одов.

Гао Зянь Жун аягаа доош тавингаа “Арайхийж нэг бэлтрэг бариад иртэл, араас баахан сүрэг чоно ороод ирдэг байна шүү. Бид нар ч чонотой зууралдсаар насыг барах улс байх аа даа” гэхэд Ян Кө “Тал нутагт хэдэн жил амьдарсаны хойно бид өөрсдөө чоно болон хувирахыг хэн байг гэх билээ дээ?” гэв.

Тэр гурав дор бүртээ оногдсон ажлаа хийж эхлэв. Гао Зянь Жун гурван морио өвсний амбаарын дор авчраад гурван сэрээ өвс тавьж өглөө. Ян Кө бургасан сагнаас хонины ястай мах гаргаж нохойндоо хаяж өгөөд эмээл, олонцог, уурга сэлтийг нягтлан шалгав. Чэнь Жэнь хоёр анч нохойныхоо хүзүүвчийг гаргаж ирлээ. Тэр хоёр урьд нь багахан хэмжээний чонын ав хомрогонд оролцож байсан болохоор нохойн хүзүүвч, уяа ямар чухал болохыг мэдэх юм.

Чэнь Жэнь Арслангийн хүзүүнд хүзүүвчийг зүүж, төмөр гархинд оосрыг сүвлэн оруулаад хоёр үзүүрийг гартаа холбон зангидав. Тэр Арсланг хөтлөн хэд алхсанаа хонины хорооны ар тал руу зааж “Туу” гэлээ. Арслан ухасхийн гүйх агшинд тэр оосрын нэг үзүүрийг суллахад төмөр гархинаас мултран хоцорлоо. Арслан хүзүүвчтэйгээ харанхуйд уусан алга болоход Чэнь Жэнь оосрыг гартаа атгасан хэвээр зогсоно. Нийтийн ав хомрогын үеэр нохойгоо залж чиглүүлэх энэ арга нь анч нохойгоо дураар аашлан нийтийн дэгийг эвдэхээс сэргийлэх сайн талтайгаас гадна, олон хүн нохойгоо зэрэг тавихад хөлтэй нь орооцолдон хурдыг сааруулдаггүй онцлогтой юм.

Ян Кө ч бас Анч шардаа хүзүүвч зүүж өгөн оосрыг султган тавих дасгал нэг удаа хийлгэлээ.



Хоёр нохой дуулгавартай, барьсан оосор нь зангираа эрчлээ үгүй болохоор ноход чөлөөтэй гүйн одож байв.

## Арван хоёр

*“Чингис хаан өөрийн хөвгүүддээ ан ав хийхээр дамжуулан дайн байлдаан хийх арга чадвараа боловсруулахыг сургадаг байжээ. Монголчууд хүнтэй байлдаагүй үедээ ан гөрөөс авладаг. Тийм учраас өвлийн цаг бол их ав хомрогын үе болох бөгөөд монголчуудын ав хомрог нь дайн байлдаан хийхтэй тун төстэй. Юуны урьд хаан, хатад, татвар хийгээд бараа бологсодтойгоо цуг авын хүрээнд орж, тоолшгүй олон зүйлийн араатан гөрөөсийг намнан харвахаар цэнгэл болгодог. . . . . Үүнчлэн хэд хэдэн өдөр авласаар араатан гөрөөс цөөрөх үест үлдсэн цөөн хэдийг дараа удаагийн ан ав хүртэл үржин олируулахын тулд өвгөд настайчууд нь хаандаа бараалхаж амийг нь хэлтрүүлэн талбин явуулдаг байна”*

*Доссоны “Монголын түүх номноос”*

“Олон ван өөр өөрийн цэргийг авч, ав хомрогын жагсаалаар урагшлах зам зуур тохиосон олон улс орнуудыг байлдан авсугай хэмээн зөвлөлдөв. Мөнх хаан иймэрхүү ав хомрогын жагсаалаар голын эргийг даган урагшилжээ”

Рашид Ад Дин “Судрын чуулганы хоёрдугаар ботиос”

Баахан морьтнууд анч нохойгоо дагуулан тас харанхуй шөнөөр Билиг өвгөний хойноос баруун хойд зүгийг барин урагшилна. Хүн болгон шахам нэгээс хоёр нохой хөтөлжээ. Баруун умрын салхи намуухан үлээж, бараан үүл талын энг нэлэнхүйд нь хучсан тул тэнгэрт ганц ч одны гэрэл эс үзэгдэнэ. Эргэн тойрон түнэр харанхуй болохоор морины туурайд огло үсрэх цас ч харагдахгүй. Чэнь Жэнь нүдээ бүлтийлгэн хараад ч сохорсон мэт бүртийх дүрс олж үзсэнгүй. Хоёр жилийн хугацаанд бишгүй л шөнө орой явж байсан боловч ийм харанхуй шөнийг үзэж байсан удаа үгүй билээ. Тэр шүдэнз асаан өөрийн нүдний харааг шалгамаар санагдав.

Чэнь Жэнь, Билиг өвгөн рүү дөхөж очоод намуухан дуугаар “Аав аа, би нударган дотроо гар чийдэн асааж нүдний хараагаа шалгаж болох уу?” гэхэд “Тэгээд үзээрэй!” гэж өвгөн зандарлаа. Түүний дууны өнгөнд их тулалдааны өмнөх зовнил, бачимдал дүүрэн ажээ. Чэнь Жэнь амаа хамхиад морин туурайн чимээгээр баримжаалан явсаар байв.

Морьтнууд шөнийн харанхуйг зүсэн урагшилсаар л. Тал нутгийн хүн, чоно бүгдээр шөнийн тулалдаанд гаргуун ажээ. “Энэ чонон сүрэг өлөн гэдэсний зовиурыг тэвчин ийм харанхуй шөнөөр гарч ирдэг айхгар золигнууд юм даа” хэмээн Чэнь Жэнь бодно. Бүх юм Билиг өвгөний урьдчилан төлөвлөсний дагуу өрнөж байлаа. Буурал талд үхэхээс бусдыг үзсэн хашир өвгөн, азарган чоно хоёрын тулалдааныг үзэх хувь байдаг байжээ хэмээн Чэнь Жэнь баярлаж байлаа.

Морьтнууд уруудсанаа эргээд дээш өгсөх үед Билиг өвгөн Чэнь Жэньгийн дэргэд хүрэлцэн ирээд нударгаараа амаа таглан зөөлөн дуугаар өгүүлрүүн: “Сайн анчин хүн сонор соргог байх хэрэгтэй. Чонын нүд, чихнээс дутахгүй хурц соргог байж чоно агнаж чадна” гэхэд

Чэнь Жэнь ч мөн нударгаар амаа таглаж “Энэ хавьд юм яривал чоно сонсохгүй хэрэг үү?” хэмээн шивнэв. Өвгөн хариуд нь “Энэ хавьд өгсүүр салхи сөрөн явж байгаа болохоор зөөлөн ярихад гэмгүй” гэв. Чэнь Жэнь түүнээс “Аав аа, сонсголоо баримжаалан зорьсон газраа хүрч

чадна гэж үү?” хэмээн асуулаа. Өвгөн хариуд нь: “Дан ганц чихэндээ найдаж болохгүй. Морин туурайнд цас, халцгай газар, хайрга чулуу зэргийн аль нь өртөж байгаагаар баримжаалан хаана яваагаа мэдэж болно. Дээр нь бас салхины үнэрийг сайн ялгах хэрэгтэй. Салхинд цас, өвс, элс, хужир мараа, чоно үнэгний шивтэр, хот айлын бууц гээд тэр чигээрээ шингэсэн байдаг юм шүү дээ. Тийм болохоор хичнээн харанхуй шөнө ч гэсэн аав чинь замаа муухан олоод байдаг юм аа” гэв.

“Аав аа, би хэзээ тань шиг болно доо” гээд Чэнь Жэнь санаа алдлаа.

Морьтнууд даваа өгсөж байгаа завшааныг ашиглан асууруун: “Манай аж ахуйд танаас өөр хэн ийм чадварыг эзэмшсэн бэ?” гэхэд

Өвгөн хариуд нь “Хэдэн өвгөн адуучин, цөөн тооны хашир чоно л чадна даа” гэлээ.

“Тэгвэл хүн чоно хоёрын аль нь илүү мундаг вэ?” хэмээн Чэнь Жэнь мөшгөн асуув.

Өвгөн өгүүлрүүн: “Хүн яаж чоныг гүйцэх билээ. Урьд нэг айхтар чоно мал сүрэгт мөн их гай удсан даа. Хайртай морийг нь хүртчихсэний улмаас вантан нутгийн хэдэн сайн анчдыг явуулаад, хагас жил хөөцөлдөн байж барьж авсан чинь ямар чоно байсан гэж санана. Тэр чонын өрөөсөн нүд ширгэсэн, нөгөө нүд нь харалган байж билээ” гэв.

Даваан дээр гарч ирэхэд өвгөн дуугаа хураав. Морьтнууд даваа уруудан явсаар нэгэн том нугад орж ирэв. Билиг өвгөн морио шавдуулан ухасхийхэд морьтнууд түүний араас чимээгүй давхицгаав. Хүүхэд эмэгтэйчүүдийн инээж хөхрөх дуу сонсогдохгүй нь сайтар сургуулилсан байнгын армийн морин цэргүүд байлдааны үүрэг гүйцэтгэж байгаатай адил ажээ. Үнэн хэрэгтээ энэ бол энд тэндээс цугларч эмэгтэйчүүд хүүхдийг эгнээндээ багтаасан цоохор цэргүүд байлаа. Хэрвээ тал нутгийн идэр баатрууд нэг дор цугларсан бол ямаршуухан байх бол доо? Тал нутгийн үндэстэнд дээр доргүй цэрэг дайны авьяас нэвт шингэсэн байдгийг Чэнь Жэнь мэдэх билээ. “Иргэн бүхэн цэрэг” гэдэг уриа хятад нутагт зөвхөн мөрөөдөл төдийхөн байдаг бол монголын уудам талд хэдэн мянган жилийн тэртээгээс бодит хэрэг болон хувирчээ.

Товлосон газар ойртох тусам морьд хатираад улам яарч байгаа шинж илт болов. Саяхан чонон сүрэг цэргийн агтыг хүйс тэмтэрч томоохон ялалт байгуулсан болохоор Олонбулгийн хүмүүс хамаг хүчээрээ тэмцэхээр ийнхүү яваа билээ. Хүнээс илүү сонорч чоно руу өөрсдийнх нь үндсэн арга болох шөнийн дайралтыг хийгээд үр дүнд хүрэх болов уу? хэмээн Чэнь Жэнь санаа зовнино. Хэдэн жилийн өмнө аж ахуйгаас байн байн томоохон ав хомрого зохион байгуулах боловч төдий л үр дүн гавиагүй тул аж ахуйн том тэрэгний жолооч нар ямар сайндаа “Ав хомрого л гэх юм. Засаа үгүй илжигний орилохоос өөр юу байх вэ дээ” хэмээн егөөдөж байх билээ.

Түрүүчийн удаа цэргийн агт чонын хомрогонд орсны дуулиан тасраагүй болохоор энэ удаагийн ав хомрогын үр дүн дээд удирдлагын санаанд нийцэхээргүй бол аж ахуйн дарга нар хуу хусагдаж магадгүй байгаа юм. Чонотой тэмцэх талаар гаршсан өөр нэгдэл аж ахуйгаас чадварлаг боловсон хүчнийг Олонбулгийн аж ахуйд татан ирүүлж ажиллуулах чигтэй байгаа гэж зарим хүн ярьдаг болжээ. Тийм болохоор Өлзий дарга, Билиг өвгөн зэрэг аж ахуйн хашир

адуучидтай хамт өөрсдийн юу чаддагаа үзүүлэн Олонбулгийн чонон сүргийн ааг омгийг дарахаар шийдсэн нь энэ юм.

Билиг өвгөн дайчилгааны хурал дээр хэлэхдээ: “Энэ удаагийн ав хомрогоор наанадаж арван хэдэн том чоныг туламлан өвчдөггүй юм бол бусад нэгдэл аж ахуйн чоно агнагч баатруудыг манай Олонбулагт томилон ирүүлэх болно” гэж билээ.

Үүрийн хярааны өмнөхөн тэнгэр улам харанхуйлан хүйтэрлээ. Ян Кө, Чэнь Жэнь рүү дөхөн ирээд чихэнд нь “Морьгнууд тарахаар бүслэлтийн зай завсар улам ихсээд ирнэ. Чононууд тэр хооронд морин туурайн хажуухнаар өнгөрсөн ч бид харахгүй шүү дээ. Билиг өвгөн чухам ямар уран арга хэрэглэх гээд байгаа юм бол доо?” гэснээ бугуйндаа зүүсэн фосфортой цагийг хараад “Бид нар хоёр цаг гаруй явсан байна. Одоо тарах болсон баймаар юм” гэлээ. Чэнь Жэнь түүний ханцуйд толгойгоо шургуулан хуучин швейцар цагны бүдэг сүүмэлзсэн гэрлийг харав. Тэр нүдээ нухлахад сэтгэлд хургасан айдас нь улам нэмэгдлээ.

Гэнэт Чэнь Жэньд хужир мараатай газрын ойролцоох хатсан шарилжны үнэр сэнхийтэл үнэртэв. Билиг өвгөн болон морьгнууд бүгд жолоогоо татан зогсоцгоолоо. Өвгөн хэсгийн дарга нар болон анчидтай хэдэн үг сольсоноо тус тусын хэсгээ аван хоёр талаар эгнээ үүсгэв. Зуу гаруй морьтон цуваа жагсаалаас хөндлөн эгнээнд шилжихэд захын морьдын туурайн чимээ сонсогдохоо болив. Чэнь Жэнь өвгөнийг даган явсаар байлаа.

Гэнэт өвгөний гар чийдэн Чэнь Жэньгийн нүдийг гялбуулан гялсхийн асахад хоёр талын захын гэрлүүд хүртэл хариу дохио өгөв. Өвгөн гар дахь гар чийдэнгээ гурвантаа дохиход хоёр талын гэрлүүд ч давалгаалан дохилоо.

Энэ үед өвгөн гэнэт хүнгэнэсэн бүдүүн хоолойгоор “Уу. . хай. . Хайяа. .” хэмээн хашгирах дуун шөнийн хүйтэн агаарыг зүсэн цууриатлаа. Агшин зуурын төдийхөнд нам гүм тал тэр аяараа “Уухай” хадаах эрэгтэй, эмэгтэй, хөгшин, хөвөө хүмүүсийн дуунд дарагдав. Хамгийн ойр байх Галсмаагийн хэсгийн хэдэн хүүхний дуу илүү тод, цангинан дуурсана. Тэр дундаас Галсмаагийн дуу илүү тод ялгарах бөгөөд бүх хүмүүс шөнийн манаанд гарч чоно үргээхдээ хашгирдаг чадвараа гарган далайн түрлэг мэт уухайлах дуун тал хөндийгөөр нэг дуурслаа.

Үүнтэй зэрэгцээд зуу гаруй сүрлэг том анч ноход уяанаасаа алдуурах шахам чанга дуугаар хуцалдах нь тэнгэр газрыг доргиож олон арван их буугаар зүүн хойд зүг галлах мэт сүртэй.

Дууны сүр хүчийг залгаад гэрлийн дайн эхлэлээ. Гэнэт хурц, бүдэг, цагаан шар есөн зүйлийн гар чийдэнгийн гэрэл зүүн хойд зүгийг чиглэхэд түнэр харанхуй ноёлж байсан цаст тал тоо томшгүй цагаан гэрэлд умбах нь зүрх зүсэм хурц илд мэсийн гялбаанаас ч илүү сүр хүчийг үзүүлэх ажээ.

Дууны давалгаа, гэрлийн цацраг, хүн, нохдын хоорондын том орон зайг бөглөж агшин зуурын төдийд хүн, морь, нохой, дуу, гэрлээр сүлжигдсэн мултрахын аргагүй том хүчирхэг ангийн тороор чонон сүргийг бүслэн хумьж эхлэв.

Чэнь Жэнь, Ян Кө болон бусад илгээлтийн эзэн залуус тал нутгийн энэхүү ер бусын үзэмжийг гайхан биширч гар хөлөө гозолзуулан дуу алдав. Хүмүүсийн дайчин зориг бадраад,

уухайн түрлэг улам өндөр хадлаа. Энэ бол адуун сүргийн сүйрсэн газрын зүүн хэсэг болохыг Чэнь Жэнь таньж чадав. Билиг өвгөн хүмүүсээ намгийн зүүн хойд талд авчраад ав хомрогын эгнээг эмхэлжээ. Хүн, морьд намгийг тойрон зүүн хойд хэсгийн давчуухан зай руу бүслэлтийн шугамаа хумьлаа.

Билиг өвгөн морио давиран гар чийдэнгээ тусгаж цасан дээрх чонон сүргийн ул мөрийг шинжинэ. Нөгөө талаар хомрогын хүрээний нягтралыг шалгаж хүмүүсийн байрлалыг хэлж өгнө. Чэнь Жэнь өвгөнийг салахгүй даган ажиглах ажээ. Өвгөн морины амыг татан уртаар амьсгаа аваад “Чонон сүрэг дөнгөж сая үүгээр явсан байна. Овоо хэдэн боохой байх шиг байна шүү. Чи энэ шинэхэн мөрүүдийг хар л даа. Энэ удаа сүрэг чоныг бариад авбал энэ олон хүнийг шөнөжин дааруулсаны хэрэг гарах юмсан” гэлээ. Чэнь Жэнь түүнээс “Та яагаад чонон сүргийг энэ намаг руу шахаагүй юм бэ?” хэмээн асуулаа. Өвгөн хариуд нь “Тэгж яаж болох билээ? Чонон сүрэг шөнийн харанхуйд ирж адууны махыг зооглочихоод үүр цүүрээр арилаад өгөх болно. Харанхуй шөнөөр чоныг бүслэн барина гэвэл энэ харанхуйд яаж уургалах билээ? Нохой ч чоныг сайн харж чадахгүй тул чонон сүрэг тал бүр тийш тарж бутраад олдохоо байна гэсэн үг. Яг үүр цүүрийн өмнөхөн бүслэн дайрч байгаа нь тэднийг үүрийн гэгээ тусах үед ав хомрогын хүрээ рүү оруулах зорилготой юм” гэлээ.

Баруун зүүн хоёр талаас гар чийдэнгээр дохио өгөхөд Билиг өвгөн урд бүүргээ түшин дөрөөн дээрээ зогсоод бусад хэсгийн дарга нарт тушаал өгнө. Түүний дохио нь урт богино, хөндлөн гулд, чагт болон бөөрөнхий хэлбэртэй тул ойлгоход нэн бэрх. Хагас саран хүрээ хумигдсаар хүн морьд, нохойн дуу улам чангаран, гар чийдэнгийн гэрэл агаар зүсэн солбицно. Хүн, ноходгүй бүгд чонын мөрийг олж үзээд дуу нь өндөрсөн их дайны өмнөх догдлол хөөрт автлаа.

Чэнь Жэнь их л гайхсан байдалтай “Та сая ямар дохио өгсөн бэ?” хэмээн асуулаа. Өвгөн дохио өгөнгөө “Би баруун талын хүмүүсийг хурдаа жаахан сааруул, зүүн талын хүмүүс жаахан шалавлаж, уулын тэндэх хүмүүстэйгээ нийлж ав. Бас голын хүмүүс дэндүү яараад хэрэггүй гэсэн юм” гэлээ.

Чэнь Жэнь толгой өргөн ажиглаваас уул завсарлан түнэр харанхуйг яраад, тэнгэрийн зүүн хаяа сүүмийн туяарч эхлэв.

Ноход чонон сүргийн үнэрийг авчихаад улам улангасан хуцалдахад, Арслан хүзүүнийхээ оосрыг хазлан, урагш цамнаж эхлэв. Чэнь Жэнь оосроос тас зууран уурганыхаа бөгсөөр толгойг нь тоншин жаахан номхрууллаа. Олонх чонын мөр том том харайсан бололтой зүүн хойд зүгийг чиглэсэн боловч зарим нэг нь өөр тийш одсон байхыг хараад Билиг өвгөн холбогдох дохиог өгнө. “Урьд гар чийдэн байхгүй үед яаж болдог байсан юм бэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа. Өвгөн хариуд нь “Бамбар ашигладаг байсан юм. Модон ишинд эсгий баглаж уяад шар тосонд дүрсэн нь гал хүрэнгүүт асчихдаг. Өөдөөс дайрахаар үс ноосыг нь хайрчихдаг болохоор чоно бамбараас айна гэж жигтэйхэн” гэв.

\* \* \*

Орчны байдал бүдэг бадаг тодрох үед Чэнь Жэнь урьд нь хэд хэдэн удаа хонио оторлож байсан бэлчээрт ирсэн болохыг мэдлээ. Хойд талд гурван тал нь уулаар хүрээлэгдсэн нэгэн

налуу хотгор байдаг нь бодвол Билиг өвгөний хэлсэн ангийн хүрээ бололтой. Адуучид уулын ард отон хүлээж байгаа бөгөөд чонон сүрэг хотгор руу орж, араас нь морьтой хүмүүс, ноход бүслэлтээ хумин авахад ав хомрог бүрэн утгаараа явагдаж эхлэх юм. Гэхдээ Чэнь Жэнь чухам хичнээн чоно хомрогын хүрээ рүү орсоньг мэдээгүй, хэрвээ дэндүү олон чоно байгаа бол улангассан араатан эргэж ноцоод хүмүүс тэдэнтэй халз тулалдах нь гарцаагүй. Тэр эмээлээсээ малиагаа авч бугуйндаа оосроос нь зүүгээд Баттай адилхан чоно авлана гэж горьдовч гар нь үл мэдэг чичирч байлаа. Умрын салхи ширүүсч, үүлс хурдан нүүж эхлэх үед завсар чөлөөгөөр нь тусах гэрэл эргэн тойрныг овоо тод гийгүүлэв. Уулын ам руу ойртон очих үед хүмүүс дуу алдан шуугилдахад, өглөөний бүүдгэр гэрэлд сайтар тогтоон харваас хорь гаруй том чоно ийш тийш сэртэлзэн, налуу хотгор руу орох эсэхээ шийдэж ядсан байдалтай шогшино. Уулын амны ойролцоо өөр нэгэн сүрэг чоно орчны байдлыг сэжиглэсэн янзтай дороо эргэцэж байлаа. Тэд лав баруун умрын салхиар дамжин ирсэн аюултай үнэрийг шиншилж мэдсэн нь илт ажээ.

Чэнь Жэнь Билиг өвгөний цаг хугацааны хүчин зүйлийг тооцсон болон анчдыг зохион байгуулж байгаа чадварыг биширч гүйцэв. Чонон сүрэг газрын байршил, ангийн хүрээг ажиглаж мэдэх үед бүслэлтийн цагариг улам хумигдаад сүр хүчээ алдсан гар чийдэнгийн оронд адуучдын уурганы хуйв намилзан үзэгдэнэ. Хагас саран бүслэлтийн хоёр үзүүр хотгорын амтай залгалдсан болохоор чонон сүрэг үндсэндээ бүрэн бүслэгдсэн хэрэг байлаа. Хятадын эх газар суурьшмал амьдралд бүрэн шилжиж эхлээгүй байхад тал нутгийн хашир анчид цэргийн номонд гаргууд мэргэшээд байсан байж таарах нь. Анх чонон сүргээр номоо заалгаж эхэлсэн тэд нар одоо түрүүлж гарсан чихнээс сүүлд гарсан эвэр урт гэгчийн үлгэр болжээ. Хэдэн чоно нөхцөл байдлыг ойлгосны эцэст өчүүхэн ч эргэлзэж тээнэгэлзэлгүй бусдыгаа удирдан арагшаа ухасхийн дайрав. Энэ хэдэн чоно саяхан адууны мах цадталаа идсэн болохоор омог сүр нь бадарч алалцахаас буцахгүй төрхтэй харагдана. Чонын давхисан мөрөөр цас будран босов. Чонон сүргийн энэхүү шунгасан дайралтыг тогтооход бэрх мэт. Хүмүүс дуу алдан хашгиралдахад малчид уургаа сунган тэднийг угтан дайрлаа. Үлдсэн хүмүүс тэдний оронд гарсан зайг яаравчлан бөглөв.

Чонын дайралтын эрч сулраагүй боловч өмссөн зүүсэн нь тод, барьсан уурга нь цөөн бүсгүйчүүд голцуу хэсэг рүү чиглэлээ ялимгүй өөрчлөв. Галсмаа тэргүүтэй онгосон нэхий дээлтэй охид хүүхнүүд өчүүхэн ч айсан шинжгүй дөрөөн дээрээ босож зогсоод, хоёр гараа даллан уухай хашгиралдах нь угтан ирэх чонодыг улаан гараараа бариад авахаас буцах шинж алга. Гэхдээ тэдэнд уурга байхгүй болохоор чонон сүрэг бүслэлтийн хамгийн эмзэг энэхүү хэсэг рүү хамаг хүчээ төвлөрүүлэн дайрлаа. Бүслэлтийн үр дүн ингээд талаар болох юм биш байгаадаа гэж бодоод Чэнь Жэньгийн зүрх хариугүй зогсох шахав.

Энэ мөчид Билиг өвгөн ч дөрөөн дээрээ өндийн босоод гараа толгой дээгүүрээ даллан “Нохдоо тавь” хэмээн хашгирахад ангийн урт хүрээний энд тэндээс “Туу, туу, туу!” гэх чимээ сонсоно. Ноход хөтөлсөн хүмүүс нэгэн зэрэг шахам уяагаа султгаваас эрч хүч бадарч, нүд нь улаанаар эргэлдсэн анч ноход зүүн баруун, өмнө зүгээс чонон сүргийн зүг дайрлаа. Эзнийхээ өмнө гавьяа байгуулахаар яарсан ноход чанга чанга хуцалдан хойно урдаа орон уралдан давхилаа. Хүмүүс дахин эгнээгээ эмхэлж аваад морьдоо ташуурдан, уургаа туялзуулсаар нохдын араас хөдөлцгөөв. Морьдын туурайгаар цастай товх онги онги шидэгдэж, идэр чийрэг монголын морьтон баатрууд цагтаа дэлхийн дайдыг доргиож байсан эрч хүчтэй

“Уухайн дуугаа” хадаагаад чонон сүргийн зүг дайралтаа эхлэлээ.

Чонон сүрэг энэхүү сүрлэг дайралтад омог нь дарагдав. Азарган чоно огцом зогссоноо сүргээ дагуулан уулын амыг чиглэн хурдлаад, цаана хүлээж байсан хэсэг чонотой нийлэн баахан давхив. Тэгсэнээ хэд хуваагдан бутарсан нь гурван талын өндөрлөг газар руу давуу байрлал эзлэх гэсэн хэрэг байлаа. Хагас саран тойрог тэгшрэн хумигдсанаар хотгор руу орсон амыг бүрэн хааж Билиг өвгөний урьдчилан төсөөлж байсан ав хомрогын ончтой нөхцөл нэгэнт бүрэлджээ.

\* \* \*

Авын хүрээ байрлах уулын оройд аж ахуйн дарга Өлзий, цэргийн төлөөлөгч Бао Шүнь Гүй нар өвсний цаана бүгчхээд алган дээр тавьсан юм шиг налуу хотгорын байдлыг ажиглаж байлаа. Бао Шүнь Гүй догдолсондоо цастай газрыг алгадаж аваад “Билиг гуай дандаа л чоныг өмөөрч байдагсан. Гэтэл ийм том чонон сүргийг урьдаас төлөвлөсөн газарт яг тогтоосон цагт хөөгөөд оруулаад ирэх юм гэж хэн санах билээ дээ? Би урьд нь ийм олон чоно нэг дор байхыг огт харж байгаагүй юм байна. Ёстой гайхалтай өвгөн юм гээч” гэнэ.

Өлзий дарга ч гэсэн уртаар амьсгаа аваад “Лав л дөч тавиад чоно байх шиг байна. Урьд жилүүдэд арав хорин чоно хомрогын хүрээнд орсон бол тун сайн гэдэг байсан шүү дээ. Билиг гуай ч өөрөө Олонбулгийн талын азарган чоно шиг болчихсон хүн л дээ. Жил жилийн ав хомрогыг түүгээр удирдуулахгүй бол анчид гарах дургүй байдаг юм. Чонон сүрэг цэргийн агтыг сүйдлэсэнд мань өвгөний уур үнэхээр хүрсэн юм шиг байна лээ” гэснээ Бат руу эргэж “Цаадуулыгаа буу тавьж болохгүй гээрэй. Дээшээ буудаж ч болохгүй гэдгийг сануул. Өнөө жил олон хүн цугларсан болохоор буу алдаж хүн шархдуулбал балрах нь тэр” гэхэд Бат “Би бусдадаа хэдэн ч удаа сануулсаан” гэв.

Тэдний архан талд адуучид анчид морин дээрээ тушаал хүлээн зогсоцгооно. Эд бол аж ахуйн хэмжээнд шигшигдэн ирсэн шилдэг анчид болохоор уурга малианы эрдэмд гаргуун, цөөнгүй боохойн бодийг хөтөлсөн хүмүүс ажээ. Тэд энэ удаа өөрийн амь мэт хайрладаг алдартай уургач хурдан морьдоо барьж унасан харагдана. Цэргийн агтны сүйрэлд харууссан уур хорслоо өнөөдөр гаргах сайхан боломж бүрджээ. Анчдын унасан хурдан хүлгүүд нохдын хуцах дууг сонсоод, удахгүй болох тулаанд бэлтгэн дүүхэлзэнэ. Тэд толгой сэжин, туурайгаар цастай хөрсийг цавчихад цээжний хөх мах болон дөрвөн мөчний шандас хавхны уян даравч мэт хөвчрөөд эзэн нь жолоогоо дугтрах төдийхөнд л урагш ухасхийн дайрахад бэлэн болжээ. Анчдын хөтөлсөн ноход ч гэсэн сонор соргог, сургуультай анч банхрууд байлаа. Тэд уулын нөгөө этгээдэд нохдын хуцалдахыг сонссон боловч толгой гилжийлгэн эзнээ хүлээхээс өөр дуу авиа гаргахгүй нь иймэрхүү тулаан олныг үзэж туршлага зааж байгаа шинж илхэн.

Өлзий Бат хоёр зугуухан босож тушаал өгөхөөр завдав.

Чонон сүрэг хамаг хүчээ нэгтгэн баруун хойд талын өндөрлөг хэсэг рүү довтолгов. Тэсвэр тэвчээр, биеийн хүч, уушигны багтаамж зэргээр зүйрлэхийн аргагүй талын чоно өндөр өөд зүтгэхдээ морь, нохдыг дагуулахгүй хурдан байдаг юм. Тал газар чононоос хурдан давхилтай морь, ноход өөд газар түүнийг барааддаггүй болохоор чонон сүрэг энэ дадсан аргаараа тэднийг ардаа орхиё гэж бодсон хэрэг. Чоно уулын оройд гарчих юм бол нэг сайхан амьсгаа

аваад хамгийн эгц уруу замаар уулын жалга судгийг даган бараа туруугүй алга болдог. Хүн морь, ноход уулын оройд гарч ирэх үед чонын бараа үзэгдэхээ больсон байх буюу эсвэл бууны тусгал хүрэхээргүй зайд очсон байх нь олонтоо.

Чонон сүрэг ийнхүү уулын орой чиглэн давхиж байх зуур араас нь хөөх морьтнууд болон ноход хол хаягдаж эхлэлээ. Чонон сүргийг хэдэн хурдан боохойнууд нь дагуулан азарган болон хэдэн том чононууд тэдний араас давхиж байв. Өлзий дарга хүзүү цээжиндээ цайвар үстэй нэг чоныг заан Батад хандаж “Тэр азарган чоно бусдыгаа оройлон цэргийн агтыг сүйдлэсэн болохоор түүнийг чамд өгчихье. Эхэлцгээх үү дээ” гэв.

Чонон сүрэг хоёр зуун метрийн дотор орж ирэхэд Бат арагш ухарч уургаа тулан мориндоо мордлоо. Өлзий ч мөн мориндоо мордон “Дайраад!” хэмээн хашгирав. Бат уургаа дээш огцом өргөх нь дохионы туг мэт гозосхийв. Адуучид бүгдээр нохдоо суллан “Туу, туу!” хэмээн турхираад хэдэн арван морьтнууд араас нь ухасхийлээ. Морьтнуудын гуравны хоёр нь ашигтай өндөрлөг газрыг завдан эзлэснээр хагас саран бүслэлтийн хүрээ үүсээд Билиг өвгөний удирдсан хэсэгтэй залгалдаж амжив. Харин үлдсэн хэсэг нь чонон сүргийн зүг ухасхийн дайрлаа.

Уулын ар талд бүгсэн хүмүүс байх болов уу яах бол гэж зовниж явсан чонон сүрэг тэдний барааг харангуут бүр учраа олохоо больж балмагдав. Чонон сүрэг явж явж өөрсдийн хамгийн гаргуун сайн хийдэг хомрогын хүрээ рүү яваад орчихжээ. Энэхэн мөчид тэд нар өөрсдийнх нь хомрогын хүрээнд орсон зээрээс ч илүү айж бухимдаж байгаа нь илт. Чонон сүрэг уурандаа багтран дахин буцаж эргээд тэртээ дээрээс хар эрчээр мөшгин ирж байгаа хүмүүстэй нэгийгээ үзэлцэхээр дайрлаа. Үхэхээс үл буцахаар санаа шулуудсан чонон сүрэг ноход руу халдан орж, хэд хэдэн нохойг хөлбөртөл дайрав. Уулын бэлд чоно, нохдын шүд хавиралдан, цас, цус, үс ноос нь хийсч бутраад, улиан гаслаан холилдон сонсогдлоо. Илгээлтийн эзэд чоно, нохдын ийм сүртэй тулалдааныг урьд өмнө үзэж байгаагүй болохоор балмагдсандаа дуу ч гарч чадсангүй.

Бат довцгийн орой дээр гарангуут мөнөөх азарган чоныг олж хараад уургаа сунган түүн рүү довтолгов. Гэвч тэр азарган чоно уулын уруу биш дөрөв таван том чоныг дагуулан баруун тийш чанх хөндлөн давхиж гарчээ. Бат ч гурван анчин дөрөв таван нохой дагуулан түүний араас салахгүй давхилаа. Гэвч газрын байдлыг андахгүй сайн мэдэх азарган чоно өөрийн сонгосон бүслэлтийг сэтлэх хоёрдахь хувилбараа сонгосон нь тун эвгүй бартаа бүхий замтай ажээ. Цасан дор дарагдсан сул хайрга чулуу чонын гишгэлтэд гулган доошлоход мөнөөх хэдэн чоно том сарвууныхаа хүчээр түүнийг даган доош хурдан гулсаж пир пархийх чимээ үүсгэлээ. Нохойн сарвуу чоныхоос жижиг тул арай ядан даган гүйх боловч бараадах янзгүй. Харин морин туурай тэр чулууны гулсалтанд тогтож тэсэхгүй тул адуучид нэг их хол яваагүй байтал нэг нь морьтойгоо доош гулсан унаад уургаа хугачиж орхилоо. Нөгөө хоёр нь арга буюу мориныхоо амыг татан унасан нөхрөө татан босгов.

Бат өшөө авах сэтгэлдээ шатаад уургаа шүүрэн авч бөгсөөр нь таяг мэт газар тулсаар морио хөтлөн чонын араас гүйлээ. Тийн гүйх зуур “Хөөгөөрэй, хөөгөөд байгаарай” хэмээн хашгирна. Нэг уулын хярыг давтал нохой гаслах чимээ гарав. Тэр мориндоо яаран мордсоор давхин очвол нэг нохой чононд бариулан газар тийчигнэн хэвтэх бөгөөд өөр нэг нь чихээ салбайтал уруулчихаад цусаа гоожуулчихсан, үлдсэн гурав нь айсандаа зооны үсээ босгон



арагш ухарч байлаа. Чононууд уургатай хүн үзээд баруухантай байх нэгэн зэгстэй газар руу шурган алга болоход Бат өөр нэгэн анчинг гурван нохойн хамт дагуулан араас нь мөшгин хөөлөө.

Өлзий түүнийг уулын хяр даван одохыг үзээд Бао Шүнь Гүйг дагуулан ав хомрогын ажлыг удирдан, чонон сүргийг алдалгүй авлахаар хамгийн өндөр нэгэн газрыг сонгон олж зогсов. Олон хатуу сорилтыг давсан монгол анчид эцсийн үр дүн чухал гэдгийг ухамсарлаж, өөрт ногдсон үүргээ чанд биелүүлдэг тул гавьяа байгуулья гэж ухалздаггүй зантай билээ. Хомрогын гадаад хүрээнд зогсож байгаа хүмүүс дотор байгаа анчдын олз омог их байгааг харах боловч өөрийн байраа орхин тийш очихыг түвдэхгүй ажээ. Ганц нэг чоно дотоод хүрээнээс алдууран гарч ирвэл хоёр анчин угтан очиж уургалан авах буюу түүнийг буцаан оруулж байлаа. Тэдний оронд гарсан зайг өөр анчид нөхөн бөглөх учраас хомрогын нийт хүрээ огт сулрахгүй.

Хотгорын төвд хүн морь, нохой, чоно бужигналдан ноцолдож, хэд хэдэн газар унасан чоно ноход шархнаасаа халуун цусаа садруулан хөдөлгөөнгүй болжээ. Зуун жар далаад нохой, дөч гаруй чоныг бүслэн авсанд цаадуул нь нуруу нуруугаа нийлүүлэн цагариг үүсгээд урцалдан дайрна. Олонх чоно нохдын мөр цээж шархдан биеийг нь даган цус урсана. Нохдын гадна хэдэн арван идэр уургачид зогсчихоод хамгийн дотор талд байгаа чоныг уургалан авч байлаа. Чоно ид улангасан ноцолдож байхад аль нь нохой, аль нь чоно болохыг ялгах аргагүй тул уургачид тэдэн рүү уурга сунгаж зүрхлэхгүй ажээ. Чоно хүч тамираа бараагүй тоо толгой маш олон хэвээр байгаа тул энэ үед уухайлан дайраад тал бүр тийш бутаргачихвал, хүн нохойн давхар бүслэлт ч нэмэргүй тул тэд ийнхүү хүлээнэж байгаа юм.

Зарим нэгэн туршлагатай анчин аль нэгэн чоно цоройн гарч ирэх агшинг анаж байгаад толгой цээж, бэлхүүсийн аль нэгийг уургалан татахад түүнтэй ноцолдож байсан ноход ухасхийн хүзүүнд нь асаад зүйл дуусгана.

Илгээлтийн эзэд, эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй хамт бүслэлтийн гаднах шугамд зогсож байлаа. Чэнь Жэнь, Ян Кө хоёрыг Билиг өвгөн баруун өмнө талын уулын бэлийн өндөрдүү газар зогсоосон тул бүх юм ил тод бөгөөд манай хоёр эртний Ромын мэсчин боолчууд зэрлэг араатан лугаа тэмцэлдэж байгааг харж буй мэт зүрх нь пэл пэл цохилж байлаа. Тэр хоёр өөрсдийнх нь зүг нэг чоно мултран гараад ирээсэй тэгвэл уургалж үзэх юмсан гэж бодох боловч талын чонын хурд хүч хоёр хүнд зэрэг уургалах боломж олгохгүй гэдгийг мэдэх тул дотроо эмээцгээнэ. Азаар дотор хүрээний хүн нохдын тоо илт давуу болохоор түүнийг даван гарч ирэх чоно хараахан үгүй ажээ. Том чононууд уурганы хуйванд татагдан, нохдод хазуулан унасаар байв. Чонон сүрэг цөхрөнгүй янзтай улилдсан даруйдаа өөрсдөө арга тактикаа өөрчлөн, үсчиж цовхчихоо болиод толгойгоо навгайлган ноходтой уралцах болсон тул уургачдад тэр болгон боломж гарахаа больжээ.

Чэнь Жэнь дурангаар хоёр талын тулалдааныг ажиглахад чонон сүрэг хэдийгээр тун найдваргүй байдалд орсон ч гэсэн өөрийн ухаанаа алдан арчаагүй байдалд ороод, бүслэлтийн гол хүч болох нохдоос нэгийг хороовол нэмэр, хоёрыг хороовол хожоо гэсэн муйхар байдлаар тэмцэх биш, аль болохоор олныг устгахыг эрмэлзэж байгаа нь илт байв. Чонон сүрэг тав гурваараа бүлэг болчихоод асар хурдан хөдлөх тул дайрах болгондоо цус үсчүүлнэ. Хэдэн том монгол чоно өөрсдийн хамгийн эцсийн арга болох хөнгөн шархаар хүнд шархыг солих, хүнд

шархаар амиа солихоор шийдсэн нь илт. Тэд ноходод хазуулах хий зай гаргаж өгөөд өөрийн шархыг үл харгалзан өрсөлдөгчийнхөө хүзүү, гэдсийг хүү татаж байлаа. Том чононуудын хамаг бие цус болсон боловч газар унах нь тун ховор, харин тэдэнтэй уралцсан ноход гаслаж гангинан холдох нь бусдынхаа сэтгэлийг үймүүлнэ. Арван хэдэн удаа халз тулгарсаны эцэст чонон сүрэг дийлэх маягтай тул ийш тийш бүслэлтийг сэтлэхээр дайрахад, ноход жийрхэнгүй байдалтай болж ирлээ.

Энэ мөчид дотоод хүрээний ойролцоо зогсож байсан Билиг өвгөн чанга дуугаар “Барс аа, Барс аа! Туу, Туу!” гэнгээ арагшаа харан гараараа даллав. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч даруй түүний дохиог ойлгон “Арслан! Туу, Туу!” хэмээн хашгиралдлаа. Нүд нь улаанаар эргэлдсэн хоёр том нохой чанга чанга хуцалдан чонон сүргийн гол хүч болох нэгэн азарган чоно руу дайран ороод, Барс түүнийг нүсэр биеэрээ мөргөн унагахад Арслан хүзүүнд нь соёогоо зоох агшинд дөрвөн хэсэг цус олгойдон түүний биеийг будаж чонон сүргийн зүрхийг үхүүлэв. Амь тавин тэлчлэх азарган чоно сарвуугаараа Арслангийн толгой, цээж, хэвлийг маажлан цусыг урсгах боловч хашир нохой дайснаа амь тавьтал тас зуусан хэвээр байлаа. Сүрэг чоно энэ сүрлэг догшин нохойны ямар айхтар болохыг мэдэх тул түүн рүү халдаж чадахгүй ажээ. Барс өөрийнх нь мөргөж унагасан өрсөлдөгчийг Арслан тийм амархан гартаа оруулахыг үзэж уур нь шатах боловч түүнийгээ өөр нэгэн чононд гаргахаар ухасхийн дайрлаа.

Ноход ч энэ далимд сэхээ орон түүний араас чонон сүрэг рүү хошууран дайрцгаалаа. Арслан, Барс хоёрын дайран орсон зайгаар адуучид уургаар чонон сүргийг балбан тарааснаар тэд уурга нохдын аман дор ил гарч ирлээ.

Дотоод хүрээнд өөрийгөө чонотой зүйрлэх дуртай Лхамжав хэдэн ноход, нэг чонотой уралцаж байхыг хараад довтлон орж цээжээр нь уургалж, хуйвыг эрчлэн чангалаад жолоо эргүүлэн чирч одов. Том таар шуудай мэт гулдайсан чоно босож чадалгүй бачимдахдаа сарвуугаар газар маажласан нь цастай газрыг анжсаар хагалсан мэт хоёр хэсэг нарийн гуу үүсгэх ажээ. Лхамжав ийнхүү чирч явахдаа анч нохдоо дуудаж байлаа.

Тал нутагт чоно уургалах амаргүй түүнийг алах гэдэг бүр ч хэцүү байдаг юм. Лхамжав зориуд зөөлөн цастай хэсгээр чоныг чирсэн нь анч нохой дайран орж ирэхийг хүлээсэн хэрэг байлаа. Хэдэн нохой түүнийг тойрон хуцалдах боловч цагаа болоход дайран орох зоригтон үгүй ажээ. Лхамжав Арслан өөр нэгэн чоныг зүйл дуусахыг үзээд түүн рүү дөхөн очиж “Арслаан, туу!” хэмээн турхирав. Хэн нэгэн хүн нэрээр нь дуудахыг сонсоод Арслан өөрийн ноцож байсан чоныг алалгүй орхиод гүйж ирэв. Тэр уургалагдсан чонын араар тойрон урд хоёр хөлөөрөө цээж толгойг нь дарж байгаад гүрээнийх нь судсыг тас хазахад чоно өөдөөс нь тийчилсэн боловч яаж ч чадсангүй. Лхамжав үсрэн буугаад ийш тийш харан “Чирч яваа чононуудаа наашаа аваад ир, энэ нохой чонын амь таслахдаа үнэхээр гаргуун юм” хэмээн хашгирлаа. Өөр нэгэн хэсэг дээр Барс ч мөн ийм ажлыг амжуулж байв. Хэд хэдэн чоно чирсэн уургачид энэ хоёр ноход руу чирсэн чоноо авчирч тушаалаа.

Энэхүү тулалдааны явцад Арслан Барс хэмээх энэ хоёр нохой уран чадвараа гайхуулсанаас гадна, эскимосчуудтай адил үс ноосондоо баригдсан хэдэн том ноход мөн л хүмүүсийн хараанд өртөж байв. Доржийн тэжээсэн найман алдартай анч нохой тун сайн гар нийлэн дайтах бөгөөд хурд хүч сайтай нь чоныг ээрэн хоргооход нүсэр том биетэй нь дайран орж мөргөсний эцэст зэрэг дайран, хамгийн зэрлэг догшин нь хүзүүнд асаж амийг таслах ажээ.

Тэд ерөөсөө бутран салахгүй, наймуулаа нэг чоно руу дайрах тул дээрх маягаар гурван чоныг хөнгөхөн намначихав.

Ноход тав гурваараа чонотой тулалдаад завгүй тул хэн нэгэн хүн чоно уургалсан тохиолдолд бусад нь мориноосоо буугаад хөл сүүлнээс нь татах буюу нөгөө нь малиагаар чонын толгойд буулган амийг таслаж байлаа. Ав хомрогын баруун хойд хэсэгт тав зургаан анчин хоёр том чоныг улаачлан хөөцгөөнө. Нэгэн залуу адуучин эр уургаараа нэг чоныг гуядан хөөсөөр цагаан хөөс сахруулж орхижээ. Чоно хамаг хүчээ шавхан гүйсээр морьтон ард хоцроход, өөр нэгэн морьтон залгаж аван хөөсөөр Лхасүрэнгийн дэргэдүүр өнгөрөх агшинд тэр уургаа сунган ухасхийж хуйваа толгойд нь угласан боловч чангалалгүй өргөн шидвээс чоно долоо найм хөлбөрөөд арайхийн босож ирэв. Бусад адуучид түүнийг уургаар ороолгон хөөхөд өөр нэгэн анчин түүнийг уургалан авч шидэлнэ. Чоно хөлбөрөн унах тоолонд адуучид хөөрөлдөн хашгиралдах нь бүтэн жилийн турш чононоос болж амссан уур бухимдлаа гаргаж байгаа нь энэ ажгуу.

Хоёр том чоно адуучдад ийнхүү шидэгдсээр ухаан балартан хаашаа явахаа мэдэхээ байж орхив. Нэг нь бүр гурав, дөрвөн удаа шидэгдсэн хойно гүйж ч чадахаа байсан тул Лхасүрэн уургаа газар орхиж, эмээлээсээ сэвхийн буугаад морины нуруун дээр харайх ирвэс лугаа адил чонын бие дээр мордон хоёр чихнээс нь атгаж газар мөргүүлсээр ам хамрыг нь нэл цус болгожээ. Бусад адуучид ч мориноосоо бууцгаан чонын бие дээр сандайлан суугаад амьсгалах аргагүй болгосны эцэст нь Лхасүрэн хутгаа гаргаж ирээд чонын бодийг хөтлөв. Өөр нэгэн чоныг гурван адуучин залуу хонь адил унаж, сандайлан суусны эцэст тонилголоо.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр бусад адуучин залуустай хамт уургаа туялзуулан харж зогсохоос биш хэдэн жилд ч тэр болгон тохиохгүй энэхүү нөр их ав хомрогонд гар дүрэн оролцох хувь дутжээ. Хамгийн харамсалтай нь тэдний дундаас ганцаараа ав хомрогын дотоод хүрээнд орох боломжтой болсон Жан Зи Юань ганц ч чоно уургалж чадсангүй. Нэгэн чоно түүний урдуур гүйх агшинд уургалах гэтэл чоно огцом эргэн морины хөлийг шүргэн өнгөрөөд уургыг нь хугалчих шахав. Өөр хоёр илгээлтийн эзэн адуучин тэдэнтэй цуг гадаад хүрээнд зогсож байтал нэг чоно бүслэлтээс сугаран тэр хоёрын дундуур гараад талийж өгдөг байгаа.

Билиг өвгөн байдал үндсэндээ цэгцрэхийг үзээд Чэнь Жэнь, Ян Кө хоёрын дэргэд хүрч ирээд өгүүлрүүн: “Танай арван хэдэн илгээлтийн эзэд өнөөдөр овоо зай бөглөж үүргээ сайн биелүүллээ. Та нар байгаагүй бол дотор байгаа уургачдаас энд зогсох байсан шүү дээ” гэснээ Чэнь Жэнь, Ян Кө хоёрын гонсгордуу байгааг хараад инээд алдан “Танай тэр том анч нохой миний тоолсноор хоёр том чоныг барьж, уурганд чирэгдсэн хоёр чонын амийг таслаж том гавьяа байгууллаа. Тийм болохоор та хоёрт хоёр чонын арьс оногдоно. Үлдсэн нь манай эндхийн тогтсон жишгээр уургалсан эзэндээ очдог юм” гээд тэр хоёрыг дагуулан уулын уруу явцгаав.

Энэ удаагийн ав хомрогоор зургаа долоон хурд хүч, авхаалж самбаатай чоно, бултаж дайран, уурганы хуйвыг тас хазах зэргээр бүслэлтийг сэтлэн гарсаныг эс тооцвол чонон сүргийг бүрэн устгаж чаджээ.

Гадаад хүрээний хүн морьд гурван талаас бууж ирэн, талбайн дунд байгаа ангийн олзыг харцгаана. Билиг өвгөн ханцуй шамлан Ян Кө, Чэнь Жэнь нартай хамт тэдэнд оногдох хоёр

чонын арьсыг туламлан өвчиж өгөв. Галсмаа Барс болон Санжаагийн нохойны алсан гурван чонын арьсыг Санжаа, Гомбо нартай хамсан туламлан өвчлөө.

Чэнь Жэнь өвгөнөөр битүү өвчих аргыг заалгасан болохоор энэ удаа Ян Көдөө багшлахаар болсон байв. Эхлээд хурц монгол хутгаар эрүүний арьсыг салгасны дараа толгойг өвчиж гаргалаа. Дараа нь Ян Көгөөр соёог нь жийрэглэн бариулаад өөрөө хутгаар арьс махыг салгангаа өмд тайлах мэт доош шувтлан өвчсөөр дөрвөн мөч сүүлэнд нь хүргээд хутгаар огтчин таслав. Эцэст нь дотогш харсан үсийг эргүүлэн гадагш харуулснаар туламлан өвчих ажиллагаа дууслаа.

Өвгөн түүний өвчсөн арьсыг харж байснаа “Халим үлдээлгүй нэлээд боломжийн цэвэрхэн өвчжээ. Та хоёр гэртээ хариад хуурай өвс чихэж уургын үзүүрт хатган хатаахад харсан хүн болгон өөрсдийг чинь анчид байна гэж бодно шүү дээ” гэв.

Арслан, Анч шар хоёр эздийнхээ өмнө оцойн сууцгаана. Арслан байн байн цээж хөлөн дээрх чонын цус өөрийн шархаа долооно. Анч шар ч гэсэн түүний толгой дээрх чонын цусыг долоож өгөх ажээ. Анч шарын бие дээр шарх болон чонын цус байхгүйг үзвээс нохдын дунд биеэ оторлон явсан нь илт. Гэвч хэдэн анчин түүнийг чоно сайн хоргоож, хонго руу нь дайрдаг. Хэрвээ түүнийг байгаагүй бол Лхамжав чоно уургалж чадахгүй байсан юм гэж ярихыг сонсоод Ян Кө ихэд баясан “Лхамжавыг давах сайхан шалтагтай боллоо. Тэр чинь нохойны хүчинд л чоно агнадаг хүн байж шүү дээ” гэлээ.

Чэнь Жэнь өврөөсөө хэдэн “Цагаан бүжин” нэрт чихэр гаргаж ирээд Арсланд гурвыг Анч шард хоёрыг хаяж өгөв. Тэр энэ удаагийн ав хомроогоор хоёр нохойгоо юм дуулгах байх гэж совин татаад байсан билээ. Хоёр нохой хөлөөрөө цаасыг салган толгой өргөн шажигнуулан идэхэд бусад нохой шүлсээ гоожуулан тэсгэлгүй цаасыг долоох ажээ. Бээжингийн илгээлтийн эзэд тал нутагт ирсэн цагаас хойш эндхийн ноход хорвоод чихэр хэмээх амттан байдгийг мэдэх болсон юм. Тэр олон нохдын өмнө Бээжингийн чихэр иднэ гэдэг тэдний хувьд ер бусын их нэр төрийн хэрэг байлаа. Галсмаа тас тас хөхрөн түүний өмнө хүрч ирээд “Чи ч тусдаа гарснаас хойш хүний хүүгийн хүрэн бөөрийг харуулдаг болоо шив дээ” гээд Чэнь Жэньгийн өврөөс хоёр чихэр авч, Барсдаа хаяж өгөв. Чэнь Жэнь балмагдсандаа өвөртөө байсан бүх чихрээ түүнд өгчихлөө. Галсмаа их л баясгалантайгаар нэгийг авч задлаад амандаа хийнэ.

Чонын хүүр, морьдын бие болон хүн нохойн амнаас цагаан уур савсах нь ав хомрогын талбай тэр аяараа халуу дүүгж байгаа мэт. Хүмүүс айл хотоороо гал болон нэгдэж өөр өөрсдөд ноогдох чонын арьсыг өвчицгөөв. Тал нутагт тогтсон дэг жаягийн дагуу олзоо хэл амгүй хуваажээ. Малчид угаас ой санамж сайтай болохоор хэний нохой аль чоныг барьсан, хэн гэдэг анчин хэдэн чоно уургалсан зэргийг андахгүй мэдэж байв. Нэг чоныг хамжин уургалсан хоёр хүн жаахан маргаан үүсгэхэд Билиг өвгөн очоод “Эр улс байна, чонын арьсаа арилжчихаад хамт сайхан ууцгаачихгүй юу” гэж ганц үг хэлээд л эвлэрүүлчихэв. Харин чонын арьс олж хүртээгүй анчид, малчид хэний арьс том, хэний нохой сайн байсан зэргийг бахдан хэлэлцэнгээ бусдын арьс өвчихийг харцгаах ажээ. Сайн нохойтой айлын тулам арьс өө сэвгүй, тааруу нохойтой айлын өвчсөн арьс андашгүй сэглэгдсэн байв. Хамгийн их олз омогтой нэг нь бусдыгаа урьж найрладаг болохоор тал нутагт ав хомрогонд оролцсон хүн хоосон хоцроно гэж байдаггүй билээ.

Хүмүүс газарт сууцгаан амарснаар ав хомрогын талбай ажин түжин болов.

Ав хомрогын үед бүсгүйчүүдийн ажил аанай л мундахгүй адаглаад л өөрийн гэрийн нохдын шархыг боож сувилна. Эрчүүд ан авын үед л нохойгоо хэрэглэдэг бол бүсгүйчүүд шөнийн манаанд гарахад ноход хамгийн үнэнч туслагч нар байдаг. Гөлөг байх үеэс нь өсгөж тэжээсэн болохоор нохойгоо үхэж, шархдахад бүсгүйчүүдийн зүрх хамгаас илүү энэлнэ. Чононд бариулж үхсэн нохдыг тэнд нь оршуулснаар сүнс нь тэнгэрт очдог гэж үздэг. Тэдний сүнсийг тэнгэрт илгээгч нь өөрсдийнх нь өстөн дайсан чоно байх юм гэж хэн бодох вэ? Билиг өвгөн ярихдаа “Энэ нь ч шудрага хэрэг юм. Тал нутагт чоно байхгүй байсан бол айл болгон тийм олон нохой тэжээж мах гарздах хэрэггүй болохоор гарсан гөлөг болгоныг тэнгэрт илгээх байсан биз. Тийм болохоор нохой чононд талархах учиртай” гэдэг билээ.

Тал нутгийн монгол хүн ямар ч сайхан нохойн арьсанд шунадаггүй тул үхсэн ноход тал нутагтаа тайван хэвтсээр. Нохой гэдэг тал нутагт хүний хамгийн ойр дотны журамт нөхөр билээ. Тал нутгийн амьжиргааны хоёр гол эх үүсвэр мал аж ахуй, ан агнуурт нохой шиг хэрэгтэй амьтан үгүй. Хонь хариулахад хоточ нохойн үүрэг их, хятадын тариачдад газар хагалахад үхэр хичнээн чухал байдгаас өөрцгүй юм. Нохой эзнийхээ санааг үхрээс илүү сайн ойлгодог болохоор элчилгүй уудам талд сэтгэл санааны хувьд ихээхэн бараа түшиг болж байдаг.

Монголын талд хүн ам цөөн газар нутаг өргөн уудам атлаа аюул бэрхшээл их тул нохой эзэндээ сэрэмж өгдгөөрөө маш их ач тустай. Тэр тусмаа Галсмаа Барсынхаа амь аварсан ачийг дурсан ярих дуртай. Нэг жилийн намар орой тэр зуухны үнсээ асгахдаа цогтой нурам үлдсэнийг мэдэлгүй орхисон нь баруун умрын ширүүн салхинд ноцон гэрийн өмнөх хатсан өвсийг хуйхалж эхэлжээ. Тэдний хадам ээж Өлзий нь хэдэн хүүхэдтэй байсан болохоор гэртээ орж үйл үртэсний ажилтай зууралдаж байгаад энэ тухай бодол санаанд ч орсонгүй. Гэнэт Барсын хуцаж хаалга мөргөх дуунаар гарч харвал гал хэдэн арван алхам газрын өвсийг юу ч үгүй хуйхалж орхисон байлаа. Дахиад жаахан удсан бол багийн намар өвлийн нөөц бэлчээр рүү орж юутай хээтэй нь хуйхлах байсан тул өөрөө ч шоронгийн хаалга татах нь гарцаагүй болох байжээ. Барс цагийг нь олж түүнд сэрэмжлүүлсэн тул тэр нойтон эсгийгээр балбасаар хээрийн түймрийг нөөц бэлчээрт орохоос өмнө унтрааж чадсан байна. “Хэрвээ тэр үед Барс байхгүй бол балрах байсан” гэж Галсмаа дандаа ярьдаг.

Хөдөөний эрчүүд архи ууж согтоод, хээр гадаа хөлдөж үхэх явдал мэр сэр гардаг. Харин нохойтой явсан тохиолдолд тийм асуудал байхгүй гэж Галсмаа мөн Чэнь Жэнь, Ян Кө хоёрт ярьж билээ. Учир нь нохой гэртээ гүйн ирээд эзэгтэйн хормойноос зулгаан газарчилсаар хунгар цасанд унасан эзнийхээ амийг авардаг байна. Олонбулгийн талд эзнийхээ аминд орж байсан ноход айл болгонд шахуу байдаг.

Тийм болохоор тал нутагт нохой алж махыг идэх, арьс үсийг хэрэглэх явдлыг үл тэвчдэг юм. Хөдөөний малчид энэ явдлаас болж тариачин гаралтай хятад иргэдтэй түнжин хагарах явдал цөөнгүй.

“Эрт дээр цагт хятад цэргүүд тал нутагт ирээд нохой алж, махыг нь идсэнээс болж нутгийн

иргэд босон тэмцэж байсан түүхтэй. Өнөө хэр малчдын нохойг гадны цагаач иргэд нухчихаад махыг идэж, арьсыг нь зүүн хойд орон юм уу, эсвэл дотор газар руу ачаад явуулах явдал бишгүй тохиолдоно. Монгол нохойн арьс зузаан, үс ноос сахлаг болохоор умард зүгийн хятад хүмүүсийн эдлэх дуртай нохойн арьсан малгай, дэвсгэр хийх хамгийн сайн түүхий эд болдог. Гэтэл хятадуудын бичсэн номонд энэ тухай ерөөсөө дурьдахгүй шүү” гэж Билиг өвгөн уурсангуй ярьдаг.

Тэр Чэнь Жэньгээс “Хятадууд яахаараа хүнийг нохой гахайгаар дуудаж, нохойгоо алж махыг нь хүнсэнд хэрэглэдэг юм бэ?” гэж асуугаад эвгүй байдалд оруулна.

Чэнь Жэнь энэ тухай нэлээд удаан бодсоны эцэст нэгэн орой гал бараадан суугаад тэднийхэнд энэ тухай тайлбарлан өгч билээ. “Хятадууд мал аж ахуй эрхэлдэггүй, ан ав ч гэх юмгүй дийлэнхийг нь хядаад дууссан болохоор нохойн ач тусыг сайн мэддэггүй юм. Дээр нь хүн ам олонтой болохоор нохойг хань бараа болгохын хэрэггүй. Түүний олж тогтоосноор нохойтой холбоо бүхий арван хэдэн хараал зүхлийн голцуу хэвшмэл хэллэг байдаг байна. Тухайлбал: Чонон зүрх нохойн уушигтай, нохой гахайнаас долоон дор, нохой тоож шиншихгүй, гичий жингэрээс гарсан, нохой эзнээ хараад омогшдог, нохой хамартаа хүрэхээр усч, тахиа нохой тэнгэрт гарах, нохойн нүдээр бусдыг харах, нохойн гуя, усанд унасан нохойг балбах, нохойн толгойг ширээн дээр тавихаар шороон дээр өнхрөх, нохойн амнаас зааны шүд цухуйдаггүй, эсгий хийх газар нохой хэрэггүй, нохой руу шидсэн бууз эргэж ирдэггүй. . . Одоо бүр байтлаа улс төрийн уриа лоозонд ч хэрэглэдэг болоод улс даяар Лю Шао Цигийн нохой толгойг хага цохъё, Лю Шао Ци нохойг цохиод алья гэх мэтээр уриа лоозон хашгирах боллоо. Өрнөдийн хүмүүс ч гэсэн хятадуудын нохойд яагаад ийм дургүй байдгийг ойлгодоггүй гэсэн.

Нохой хятадуудын амьдралын хэв маягт тэр болгон тохирдоггүй болохоор түүнийг харааж зүхэх нь олонтой. Та бүхэн эртний хятадад Күнз хэмээх Богд хүмүүн байсныг санаж байгаа биз дээ? Хятадын олон үеийн хаад хүртэл түүний хөрөгт мөргөсөөр ирсэн түүхтэй. Күнз Богдын тогтоосон дэг жаягийн дагуу хятад хүмүүс хэдэн зуу, мянган жилийн турш амьдарсаар ирсэн төдийгүй номын хүн болгон түүний зохиосон “Шүүмжлэл өгүүлэл” гэдэг номыг одоогийн Мао даргын улаан номтой адил дээдлэн шүтсээр иржээ. Түүнийг дагаж дээдлэхгүй хүнийг бүдүүлэг хэмээн гадуурхаад зогсохгүй, заримдаа хар толгойтой нь ч ярьдаг байсан үе бий. Күнз ёс суртахуун, дэг ёсыг ихэд чухалчилдаг байсан. Гэтэл нохой танихгүй л хүн байвал хөгшин залуу, ядуу, баян, эр эм гэлтгүй хуцан дайрч, хазаж авахаар завддаг нь дэг ёсыг эрхэмлэдэг хятад хүмүүсийн хувьд эвгүй уур хүрэм хэрэг юм. Хоёрдугаарт Күнз гэр бүлийн хатуу журмыг сахиж, тэнгэрийн эшийг самууруулахгүй байхыг захидаг. Гэтэл нохой ураг садангаа ялгахгүй, хамаагүй явалддаг болохоор үр хүүхдээ түүнээс муу зүйл сурчих вий гэж цээрлэдэг юм. Гуравдугаарт Күнз цэвэрч нямбай байдлыг дээдлэхийг сургадаг бол нохой хүний өтгийг иддэг нь хятад хүний хувьд тэвчишгүй үзэгдэл байдаг. Дээр нь хятадад ядуу хүмүүс өөрсдийгөө яая гэж байдаг болохоор нохой тэжээх явдал их ховор. Харин баячууд хашаа хороогоо харуулах гэж нохой тэжээж, тэднээр ядуусыг айлгадаг болохоор олонх ядуус нохойг үзэн яддаг байжээ. Тийм болохоор хятадууд нохойг хараан зүхэж, махыг нь хүнсэнд хэрэглэдэгт гайхаад байх зүйлгүй. Харин ч нохойн махыг их амттай гэх юм билээ. Хятадууд нохойн мах, гахай болон хонины махнаас юугаараа өөр байх билээ гэцгээдэг. . . Хамгийн гол нь хятадууд нүүдэлчин биш, бусдыг өөрсөд шигээ байлгах дуртай суурьшмал үндэстэн болохоор нохойг үзэн ядаж, махыг нь хүнсэнд хэрэглэдэг байж

таарна” хэмээн ярьж билээ.

Билиг өвгөн Бат хоёр түүний яриаг эвгүйрхсэн шинжгүй удтал дуугүй сонсоцгоожээ. Өвгөн хэсэг зуур дуугаа хурааж сууснаа “Хүү минь, хятад монголчуудын хооронд чам шиг юмны наад цаадхийг ухаардаг хүн байвал мөн сайн сан даа” гэсэн юмдаг. Галсмаа харин санаа алдаад “Ноход танай хятад газар төрөхөөрөө өөрийн давуу талаа алдаад муу муухайгаа харуулан ганц балардаг хэрэг байх нь ээ. Би хэрвээ нохой болвол танай хятад газар төрөхгүй, чононд бариулдаг байсан ч монгол газраа идээших болно” гэлээ.

“Би ч гэсэн тал нутагт ирсэн хойноо л сая нохой гэдэг эзнийхээ санааг сайн ойлгодог, хүний хамгийн үнэнч дотны анд болохыг мэдэрлээ. Гагцхүү хоцрогдсон бүдүүлэг суурьшмал үндэстэн л идэх ёсгүй зүйлийг тэр дундаа нохойн махыг хүнсэнд хэрэглэдэг ажээ. Хятад орон баян чинээлэг болох тэр цагт хүнс хоол хангалттай арвижаад ирэхээр нохойн мах идэхээ больж, өөрийн сайн анд нөхрөө болгох вий. Би тал нутагт ирснээсээ хойш нохойноос ганц өдөр холдож чадахааргүй хайртай болсон шүү. Хэрвээ хэн нэгэн хүн манай гэрийн нохойг алаад идчихсэн байвал Ян Кө бид хоёр түүнтэй нэгийгээ үзэлцэн идсэн хоолыг амаар нь буцан гартал гөвшөөд өгөхөө мэдэх байлгүй. . . .” гээд Чэнь Жэнь зодоон цохион хийх юм яриад явчихсандаа өөрийн эрхгүй балмагдав. Тэр угаас хүн хэлээрээ мал хөлөөрөө гэдэг зарчмыг эрхэмлэж явдаг атлаа ийм чонын араншин ханхалсан үг хэлчихжээ.

Галсмаа түүнээс “Чи тэгвэл Бээжинд буцан очихоороо нохой тэжээсэн хэвээр байх уу?” гэхэд Чэнь Жэнь инээд алдан “Би насан туршдаа танайхантай адил нохойг хайрласан хэвээр байх болно. Бээжингээс ирүүлсэн үнэтэй чихрүүдийг өөрөөсөө харамлан Баяр та хоёрт ч өгөлгүй, нохойгоо шагнадаг гэдгээ нуух юу байхав” гэхэд Билигийнхэн нулимсаа гартал хөхрөлдөв. Бат түүний ар зоо руу цохиж аваад “Чи ч бүр монголжиж гүйцэх нь ээ” гэлээ.

Нохойн тухай тэр шөнийн ярианаас хойш хагас жил гаруй хугацаа өнгөрсөн боловч Чэнь Жэнь өөрийн амлалтаа хэзээ ч мартаагүй юм.

Ав хомрогын талбай нам гүм болоод алжааж ядарсан шархтай ноход их л зовиуртай байгаа бололтой. Хэдэн ноход үхсэн анд нарынхаа хүүрийг шиншлэн эргэж тойрох нь гашуудлын ёслол үйлдэж байгаа мэт. Нэгэн жаалхүү үхсэн нохойгоо тас зуураад томчуулын аргадахыг ч эс сонсон орь дуу тавин уйлж байна. Хүүгийн нулимс нохойн бие дээр ойгоод газарт уусан алга болов. Жаалхүүгийн цурхиран уйлах дуун талын энгээр тасралтгүй цангинахад Чэнь Жэньгийн нүд ч бүрэлзээд ирлээ.

## Арван гурав

*Лу Лунгийн Зе Ду Ши түшмэл Лю Рэнь Гун Хятанчуудын байдлын үнэн магадыг мэдээд үргэлж жанжин сонгож цэрэг боловсруулж, намрыг тохиолдуулан хятанчуудын нутагт гүнзгий ороод Зай Син Лин давааг өнгөртөл цохисонд Хятанчууд эмээжээ. Хяруу унах болгон Рэнь Гун даруй хүмүүн томилон, цагаан хэрмээс цааших хээрийн өвсийг галдсанаар Хятанчуудын морьдын олонх үхжээ.*

*Сы Ма Гуан “Засагт туслах нэвтэрхий толь”*

Монголчуудын ёс заншлын хуульд: “Өвс ургаж бүхий цээртэй үед газар хөндсөн, гал алдан өвс шатаасныг бүхий гэрээр нь хүйс тэмтэрмүй” хэмээн заажээ.

Пэн Да Я “Хар татаарын хэргийн товчоон”

Бао Шүнь Гүй, Өлзийн болон аж ахуйн бусад дарга нарын хамтаар ав хомрогын олз омгийг үзэж дуусаад Билиг өвгөний дэргэд хүрэлцэн ирэв. Тэрээр мориноосоо буугаад баярласан янзтай өвгөнд хандан “Том ялалт байгууллаа шүү. Энэ удаа та хамгийн том гавьяа байгууллаа. Би дээд байгууллагад энэ тухай мэдүүлнэ” гээд өвгөнтэй гар барихаар завдав. Билиг өвгөн чонын цустай хоёр гараа дэлгэн “Ийм болчихоод байхад бусадтай яаж гар барих билээ?” гэв. Бао Шүнь Гүй харин ч өвгөний гараас шүүрэн атгаж “Чонын цусанд хүрч таны буянаас хүртье” гэлээ.

Өвгөний царай гэнэт барайн “Юуных нь гавьяа байх билээ дээ, баахан нүгэл хураачихаад байхад чинь. Үүнээс хойш чоныг энэ маягаар хядаад байх юм бол зээр, туулай, тарвага зурам дийлдэхээ байж, тэнгэр хилэгнээд тэр бүхний горьг бид бүхэн адуу малтайгаа амсах болно” гээд цустай гараа дэлгэн тэнгэр өөд ширтэн, урт сүүрс алдлаа.

Бао Шүнь Гүй эвгүйрхэн зогссоноо цааш эргэн Арсланг олж хараад “Энэ нөгөө айхтар нохой юу? Ямар том биетэй юм бэ? Энэ л бусад нохдыгоо оройлон дайраад азарган чоныг нь устгаснаар чонон сүргийн ааг дарагдсан шүү. Тэр нийт хэдэн чоно устгасан бэ?” гэхэд Чэнь Жэнь “Дөрөв” хэмээн хариулахад Бао Шүнь Гүй “Уухайс даа, та хоёр хонь барьдаг нэг том хар нохойг олж тэжээсэн нь тал нутгийн дэг ёсонд нийцэхгүй байна. Түүнийг устгаж өгөөч хэмээн бусад айлууд гомдол мэдүүлээд байсан юм. Энэ нохойгоо та хоёр санаа амар тэжээнэ биз дээ. Харин дахин хонь барих юм бол арьсыг нь улсад тушаагаад махны мөнгийг нь өөрсдөө төлцгөөгөөрэй. Харин наад нохойн амийг хэлтрүүлье” гэжээ.

Чэнь Жэнь “Энэ удаагийн ав хомроогоор бидэн шиг хэрэггүй улс алга байлаа. Илгээлтийн эзэд бид энэ том хар нохойноос ч нэмэргүй гэж үү?” гэхэд бүгдээрээ нирхийтэл инээлдэцгээв.

Өлзий дарга ч мөн инээд алдан “Чи ч мөн айхтар монголжжээ” гэхэд Билиг өвгөн мөн их баясгалантайгаар “Энэ хүү ч тал нутагт их элэгтэй шүү. Алсдаа овоо хүн болж мэднэ” гэв. Өлзий “Та хоёр саяхан хэдэн чонын бэлтрэг суйлсан гэв үү?” гэхэд Ян Кө бодож санасан юмгүй “Тийм ээ, Өчигдөр долоон бэлтрэг суйлсан. Билиг аав бидэнд зааж өгсөний хүч шүү дээ” хэмээн хэлэв. Бао Шүнь Гүй түүнийг дуулаад “Долоон бэлтрэг гэдэг чинь намар болоход л сүрэг чоно болох байжээ. Овоо залуус юм. Хэд хоногоос бэлтрэгний арьсаа надад



өгчихөөрэй, би боломжийн үнэ өгч дээр нь хэдэн сумаар урамшуулъя” гэчихээд газар байсан хоёр туламласан арьсыг авч “Энэ хоёр арьс л бусдаасаа хавьгүй том юм гээч. Би та хоёроос хамгийн өндөр үнээр авна гэж захилаа шүү. Миний нэг дарга дайтаж явахдаа цас мөсөн дээр хэвтсээр хөл нь бүлээцэхээ байсан гэнэ лээ. Түүнд чонон өмд хийж өгвөл яадаг бол гэж бодоод байгаа юм” гэхэд Чэнь Жэнь “Бид хоёр үүдэндээ хэд хоног өлгөж хээрээс олсон нохойгоо цагаатгах гэсэн юм л даа” хэмээн амыг нь таглав. Бао Шүнь Гүй доогтой инээгээд “За тэгвэл тав зургаа хоногоос би өөрийн биеэр очиж авъя даа” гэлээ.

Авын хүрээний энд тэндгүй нэлийн хөлдсөн цус болон шийрэндээ хэсэгхэн арьстай чонын шулдан гулууз хөглөрнө. Бао Шүнь Гүй анчдаар чонын өвчсөн махыг хоёр хоёроор нь тонолжлуулан хураалгасан нь босоо хүний хэртэй өндөр болов. Бао Шүнь Гүй тал талаас нь дөрөв таван зураг дарсаны хойно анчдыг өөрсдийн туламлан өвчсөн арьсыг барин хоёр талаар нь зогс хэмээн тушаалаа. Гуч гаруй хүн агнасан чонын арьсаа өндөр өргөхөд дийлэнхийн сүүл газар шүргэх ажээ. Тэдний урдуур шархнаасаа цус гоожуулсан анч ноход амьсгаадан зогсоцгооно. Бао Шүнь Гүй өөрөө хамгийн том урт арьсыг барьж хүмүүсийн дунд хамгаас өндөрт өргөн зогсоод Чэнь Жэньгээр зургаа даруулав. Харин Билиг өвгөн баруун гартаа чонын арьсаа сугавчилчихаад муухан мушийж зогсоно. Чэнь Жэнь хоёр зураг даржээ.

Бао Шүнь Гүй урагш тав зургаа алхаад анчдад хандан “Би аймаг хошууны хувьсгалт хороо болон цэргийн салбар тойргийн удирдлагыг төлөөлөн та бүхэнд баяр хүргэж байна. Та нар бүгдээрээ чонын ангууч баатрууд учраас удахгүй зураг чинь сонин дээр гарах болно. Тэгээд нэг дор ийм олон чоно алахаар болсон байна гэдэг бол манай Олонбулагт чонын аюул хэр зэрэг нүүрлээд байгааг олон түмэнд мэдүүлэх байх аа. Гадаад монголын хилийг даван орж ирсэн эдгээр чонон сүрэг манай цэргийн агтыг сүйдэлсэн билээ. Манай Олонбулгийн аж ахуйн удирдлага, малчид болон илгээлтийн эзэд бүгдээрээ чонон сүргийн өмнө толгой бөхийлгүй шийдэмгий зориг, шилдэг зохион байгуулалттайгаар тэдэнд үхлийн цохилт өгсөөр байх болно. Энэ удаагийн чоно авлах хөдөлгөөний гараа амжилттай эхлэлээ, цаашид бид Олонбулгийн чоныг үндсээр нь бүрэн устгатлаа тэмцэцгээе гэдгийг та бүхний өмнө би уриалж байна” гээд үгийнхээ төгсгөлд тэрээр гараа даллан “Цөөвөр чононуудыг үндсээр нь устгатал цөхрөлтгүй тэмцэцгээе” хэмээн өндөр дуугаар хашгирав.

Доржийнхон болон цөөн тооны илгээлтийн эздээс бусад нь үг дуугүй зогсоцгооно. Бао Шүнь Гүй хүмүүсийг тараагаад өөрөө газар суун Батаас сураг чимээ хүлээлээ.

Бао Шүнь Гүй газар завилангаа Өлзий даргад хандан “Одоо хил хязгаарын байдал түгшүүртэй байгаа болохоор дээрээс өрхийн цэргийн бэлтгэл сургуулилыг шавдуул гэж шаардаад байсан юм. Гэтэл санаандгүй явж байгаад байлдааны бэлтгэл сургууль хийчихдэг байна шүү” гэхэд Өлзий дарга хариуд нь “Манай монголчууд угаас дайн байлдаанд гарамгай болохоор буу тараагаад өгчихвөл бүгдээрээ дайтахаар мордож чадна. Чи өнөөдөр нэг сумаар хоёр туулай буудаж, чоно авлахын хажуугаар байлдааны бэлтгэл сургууль хийчихлээ шүү дээ. Энэ тухай хоёр мэдээлэл бичээд дээшээ явуулчихвал дарга нар сэтгэл хангалуун байх болно” гэлээ.

Илгээлтийн эзэд бүгд Чэнь Жэнь, Ян Кө хоёрын хажууд цуглараад тэдэнд оногдсон чонын арьсыг ихэд атаархсан байдалтай сонжино. Ян Зюнь Ли нэрт нэг залуу “Танай гэрийн энэ том нохой байгаагүй бол илгээлтийн эзэд монголын их цэргийн барлагууд шиг ичгүүртэй юм

болох байлаа шүү” гэхэд Чэнь Жэнь “Манай хятадууд эртнээс нааш дайтах чадвар, эр зоригороо нүүдэлчдэд хүрдэггүй байсан шүү дээ. Хүн гэмээ мэдэж байгаа бол бусдаас суралцах л хэрэгтэй. Тэдний барлаг цэрэг ч болдог бай хамаагүй газар дээр нь намнах дайтах эрдмийг суралцана гэдэг чинь ховорхон завшаан биш үү?” гэв. Ян Зюнь Ли мөчөөгөө өгөхгүй янзтай “Нүүдэлчид хэдийгээр хоёр ч удаа хятад нутгийг бүхлээр нь эзэгнэж байсан боловч адаг сүүлдээ хятадын дэвшилтэт соёлын өмнө бууж өгөө биз дээ? Тал нутгийн нүүдэлчид хэдийгээр нэгэн үеийн тэнгэрийн бахархал байсан боловч явж явж хавчаахай нумаа татаж харвах намнахаас өөр эрдэм чадал гэж байдаг бил үү?” 15 гэв.

Чэнь Жэнь түүний үгийг няцаан “Тэр ч тийм биш шүү. Чи соёлыг эрхэмлэн зэр зэвсгийг хэрэггүй гэх гээ юу? Үе үеийн хаант төр зэр зэвсэг байхгүй бол соёлоо яахин цогцлоон босгох билээ? Хэрвээ цэрэг зэвсэг байхгүй бол хичнээн ч гайхамшигтай соёл овоолоостой ваарны хэлтэрхий төдийхөн болон хувирна биз дээ? Хань улсын төр цэрэг зэвсгийнхээ суурин дээр улсаа соёлоор засаж байсан удаатай юм шүү. Дэлхийн олон соёлт том улс гүрнүүд цэрэг зэвсгийн хувьд хүчирхэг, бүдүүлэг үндэстнүүдийн дайралтан дор мөхөж байсан түүх олон бий. Бичиг соёл нь байтугай үндэстэн өөрөө мөхөж байсан жишээ ч байдаг. Чи Хань үндэстний соёл тал нутгийн нүүдэлчдийг буулган авсан гэх гээд байна уу? Монгол үндэстэн харин ч өөрийн бичиг соёл, сүлд шүтээн, үндэстнийхээ зан заншлыг өнөө хэр хадгалж чадсан учраас тал нутгийнхаа эзэн суусаар ирсэн юм. Хэрвээ монгол үндэстэн хятадын суурьшмал соёлд ороод атар хээр нутгаа хагалаад дуусгасан бол Хятадын унаган соёл аль эрт элсэн далайд умбах байсан байлгүй. Хрушев оросын хөдөө аж ахуй аж үйлдвэрийн соёлоор Казакстаны нүүдэлчний соёлыг эзлэн түрэмгийлэхээр дайраад адаг сүүлд нь дэлхийд ховорхонд тооцогдох сайн чанарын бэлчээрийг элсэн цөл болгон хувиргасан шүү дээ. . . ” хэмээн мэтгэлцэв.

Эрчүүд нь бас л бөөн маргаан дэгдээх төлөвтэйг хараад илгээлтийн эзэн бүсгүй Сүн Вэнь Зюань тэдний яриаг таслаж “За больцгоо доо. Хэдэн арван километрийн цаана мал хариулж явсаар ганц уулзахаараа маргалдаад эхлэх юм. Эрчүүд та нар тал нутагт ирээд чонын араншинтай болж гүйцэж шүү. Сав л хийвэл маргаж тэмцэлдэх санаатай” гэв.

Арслан олон хүмүүс цуглараад өөрийнх нь барьсан олзыг илэхэд төдийлөн тааламжтай байгаа бус бололтой тэдэн рүү дөхөж ирэв. Сүн Вэнь Зюань илгээлтийн эздийн нохой болохоор өөрийг нь хазахгүй биз гэж найдаад өврөөсөө ааруул гарган түүн рүү шидээд “Арслан, Арслан сайн нохой шүү” хэмээн дуудлаа.

Арслан дуу шуугүйхэн сүүлээ ч хөдөлгөлгүй олон хүмүүс рүү дөхөв. Сүн Вэнь Зюань айсандаа арагш хэд ухрахад Чэнь Жэнь түүнийг хориглосон боловч нэгэнт оройтоод Арслан хуцан дайрахад бүсгүй айсандаа газарт лагхийтэл сууж орхилоо. Ян Кө уурандаа шатаж “Муу хар золигийг дээ” гээд малиагаа далайхад Арслан цохивол цохиг гэсэн янзтай зогссоор байлаа. Гэвч нэгэн амьсгаагаар дөрвөн чоныг барьсан нохой яаж ч мэднэ гээд малиагаа доош буулгав.

Сүн Вэнь Зюань амьсгаадан “Үүнээс хойш танай гэрээр хэн шагайж зүрхлэх билээ? Хэрвээ наадахь чинь чоно барьж чаддаггүйсэн бол арьсыг өвчөөд махыг нь идчихмээр золиг байна” гэхэд Чэнь Жэнь өмнөөс нь уучлал гуйсан янзтай “Энэ нээрэн ч чоно шиг зантай сонин нохой шүү. Гэхдээ та нар манайхаар орж гараад байвал таньдаг болоод урахгүй” гэлээ.

Олонх илгээлтийн эзэд тарж явсаны дараа Чэнь Жэнь Арслангийн толгойг илээд “Чи харав уу? Манай нөхдүүд чамд дургүй болсон байна шүү дээ” гэхэд Ян Кө дуугаа намсгаад “Зуудаг нохой тэжээсний төлөө хүмүүс ингэтлээ айж байгаа юм чинь манай бэлтрэг том болчихвол манайхаар шагайх хүн гарахгүй байх аа” гэхэд

Чэнь Жэнь хариуд нь “Ирэхгүй бол тэр л биз, амьтад зарим нэг хүнээс ч илүү зугаатай шүү дээ. Хоёулаа чоно нохойтойгоо амьдраад байна даа” гэлээ.

Жан Зи Юань Арслангийн дэргэд ирээд толгойг нь илэнгээ “Би Арсландаа улам л хайр хүрээд байдаг болчихлоо. Хүнд жаахан ч гэсэн чонын араншин байх хэрэгтэй юм байна. Би тэр чоныг уургалж чадаагүй нь арга техник дутсан хэрэг биш, харин зориг хүрэхгүй алдчихсан юм” гэв.

Арслан чонын овоолсон мах руу дөхөн очоод гөлрөн зогслоо. Хэдэн арван ноход түүнээс айсан бололтой сүүлээ шарвагануулахад ганцхан Барс л омог бардам хүрч ирээд түүний хошуу амыг шиншилнэ. Арслан аж ахуйн удирдлага болон малчдын магтаал сайшаалыг хүртсэнээр бусад ноход ч түүнд дотносох боллоо. Гэвч түүний нүдэнд нэг л гунигтай төрх тодрохыг хараад Чэнь Жэнь хүзүүгээр нь тэврэн яаж аргадахаа мэдэхгүй байжээ.

\* \* \*

Бао Шүнь Гүй, Билиг өвгөнийг анчид олноор цугларсан хүрээнд урьж аваачив. Өвгөн хүрээний голд хоргол хомоол зэргийг ашиглан өөрийн боловсруулсан арга тактикийг ярьж тайлбарлана. Бао Шүнь Гүй байн байн асуулт тавьж, үе үе дуу алдан гайхширах зуур “Энэ удаагийн арга тактикийг чонон сүрэг цэргийн агтыг үгүй хийснээс ч уран нарийн бодож гаргасан болохоор цэргийн шинжлэх ухааны сурах бичигт ч оруулмаар юм боллоо. Та бол жинхэнэ цэргийн бодлоготон хүн юм. Цэргийн хороон дарга хүн ч энэ удаагийн ав хомрогыг ийм гайхалтай зохион байгуулахгүй байх шүү” гэхэд Чэнь Жэнь ярианд оролцон “Хэрвээ Чингис хааны үед байсан бол манай Билиг аав Мухулай, Зэв, Сүбээдэй нартай эн зэрэгцэхүйц өрлөг жанжин байх байлгүй” гэлээ.

Өвгөн гараа савчин сэгсрээд “Нүгэл хүү минь, алдас болно шүү. Тэд чинь бүгд бэрх улс байсан тулдаа л нэг удаагийн дайралтаар долоо найман улсын хэдэн арван хот балгад, хэдэн буман хүнтэй цэргийг бутниргэсэн байж таарна. Хэрвээ тэд нар байгаагүй бол монголын уудам тал аль эрт бусдын гарт ороод тариан талбай болон хувирах байсан юм. Над шиг хөгшин боолыг яахин тэдэнтэй зүйрлэж болох билээ” гэв.

Үд болох дөхсөн боловч Бат хараахан эргэж ирээгүй, хүмүүс буцахаар зэхэж байлаа. Энэ үед нэгэн хүн морио байн байн ташуурдсаар давхин ирэхийг үзвээс адуучин Бөхөө ажээ. Тэр амьсгаадсаар Өлзий дарга, Бао Шүнь Гүй нарт хандан “Бат та нарыг хүрээд ирээч гэж байна. Та нарын өглөө бүслэсэн чонын хагас нь үүр цүүрээр хулжин зугатаад баруун хойд уулын тэртээх зэгсэн дунд нуугдсан байжээ” гэхэд Билиг өвгөн нүдээ бүлтийлгэн “Тийм олон чоно байна гэж үү?” хэмээн асуулаа. Бөхөө хариуд нь “Бат бид хоёрыг тоолж үзэхэд лав хорь гаруй чонын шинэхэн мөр байна лээ. Цэргийн агтыг хөнөөдөг азарган чоно лав тэдэн дунд байгаа даг гээд Бат тэндээ хараад үлдсэн” гэв.

Өлзий Бао Шүнь Гүйд хандан “Хүн морьд шөнөжин явсан болохоор ядарч байгаа. Ноход маань ч гэсэн шархтай. Тэр зэгс хэдэн мянган мүйб болохоор бид яахин бүслэж дийлэх билээ? Энэ удаа орхичихъё доо” гэхэд

Бао Шүнь Гүй, Билиг өвгөн рүү сэжиглэнгүй хараад “Гаднаас шилжиж ирсэн иргэд болон илгээлтийн эзэд өөрийг чинь чоныг хамгаалах талдаа байдаг хүн гэж ярьж байсан шүү. Та энэ удаа тэр чононуудыг санаатай тавиад явуулчихсан юм биш биз дээ? Та нарын хүн хүчээр тэр хорь гаруй чоныг бүсэлж аваад бидэн рүү шахах боломжтой байсан” гэж хэлэв.

Өлзий үгийг тосож аваад “Чи арай л дэндүүлж байна. Өнөө өглөөний наашаа авчирсан чононууд олон цөөн нь яг таарсан байна лээ. Баншны мах хүртэл ихдэхээрээ гурил нь хагардаг биз дээ? Хэрвээ тэр чононуудыг бүгдийг туугаад оруулаад ирсэн бол бид дийлэхгүй байсан юм” гэв.

Бао Шүнь Гүй, Билиг өвгөн рүү хандан “Та л тэр чононуудыг санаатай тавьсан байх аа даа” гэлээ.

Билиг өвгөний нүд ч бүлтийн “Чоно авлах гэдэг та нарын хийж иддэг гурилтай шөл биш байх шүү. Гадаа тийм харанхуй, хүмүүсийн хоорондын зай тийм их байхад гараад явчихдаггүй чоно гэж хаана байх билээ? Хэрвээ чи өөрөө энэ ав хомрогыг удирдсан бол ганц чоно ч барьж чадах нь юу л бол?” гэхэд

Бао Шүнь Гүйгийн царай цэлдийтэл хөхрөөд малиагаараа алгаа цохин “Хүн морьдын хүч хүрдэггүй юм бол буу зэвсэг маань байгаа шүү дээ. Яадаг ч байсан тэр зэгсэнд байгаа чононуудыг өнөөдөр алдаж болохгүй. Энэ удаагийн авыг би өөрөө удирдана” гэлээ.

Бао Шүнь Гүй морио унан өндөрлөг газар очиж зогсоод тэнд байгсдад хандан “Нөхөд өө, баруун хойд уулын тэртээх зэгсэнд өөр нэгэн сүрэг чоно байгааг илрүүлжээ. Бидний дунд чонын олзгүй хоцорсон хүмүүс байгаа шүү дээ. Тэр дундаа илгээлтийн эзэн нөхөд удирдлагын зүгээс тэднийг үйлдвэрлэлийн тэргүүн фронтод ажиллуулдаггүй гэж гомдоллоод байсан удаатай. Энэ удаа та бүхэн тэргүүн фронтод очих боломж олдлоо. Нөхөд өө, цөмөөрөө цуцалтгүй хөдөлмөрлөж, тасралтгүй тулалдах дайчин уламжлалыг бадраан тэр чонон сүргийг хүйс тэмтрэн устгацгаая!” гэв.

Хүмүүсийн дундах хэдэн илгээлтийн эзэд болон цөөн тооны анчин дороо өндөлзөнө.

Бао Шүнь Гүй чанга дуугаар өгүүлрүүн “Би та бүхэнд одоо өөрийн төлөвлөгөөгөө танилцуулъя. Энэ төлөвлөгөө нэг их хүч шаардаад байхгүй ээ. Бүгдээрээ очоод тэр зэгсийг шатаачихаар чононууд гүйлдэн гараад ирэнгүүт сум хайрлахгүй буудах юм шүү” гэдэг байгаа.

Малчид зэгс шатаана гэдэг үгийг дуулаад бүгдээрээ давхийн цочицгоов. Тал нутагт өвс галдан шатаана гэдэг маш цээртэй хэрэг билээ. Анчид ангийн нүхийг угаж л гал тавихаас биш, хээр талыг түймэрдэж байсан тохиолдол үгүй тул дор дороо шуугилдаад явчихав.

Билиг өвгөн юун түрүүнд ам нээж “Талыг түймэрдэнэ гэдэг тэнгэрийг хилэгнүүлэх нүгэл мөн. Тэнгэрийн нүүрийг харлуулчихаад түүнээс хишиг горьдоно гэж юу байх билээ? Гол усаа

бохирдуулвал эзэн савдаг нь ирэх жил хүн малд хур бороо хайрладаг бил үү? Лам, бөө нар бүгд л түймэр тавихыг зөвшөөрдөггүй юм. Эрт дээр цагт хээрийн түймэр алдсан хүнийг хааны цаазаар гэр орныхонтой нь цаазалдаг байсан гэдэг. Манай улсын хуулиар ч хээрийн түймэр тавихыг цаазладаг биш үү?” хэмээн хэлэв.

Галсмаа нүүр нь минчийтлээ улайчихаад “Гал тавина гэдэг чинь тал нутагт хамгийн цээртэй хэрэг. Ердийн цагт галаар наадсан хүүхдийн бөгсийг улайтал алгаддаг байж томчууд бид нар өөрсдөө гал тавихаар юу болох билээ? Хэрвээ үүнээс хойш хүүхдүүд галаар наадаж байгаад тал нутгаа шатаачихаад, Бао төлөөлөгч л ингэдэг шүү дээ гэвэл та өөрөө хариуцлагыг нь хүлээх юм уу?” хэмээн уурслаа.

Лхамжавын хүзүү хүртэл хүрэнтэн “Эрт дээр цагт хятад цэргүүд л монголын тал нутгийг санаатай шатааж байсан гэдэг. Энэ бол хятадуудын гаршсан арга мөн. Харин одоо хятад хүмүүс тийм арга хэрэглэж зүрхлэхгүй байтал яахаараа монгол хүн бусдыгаа удирдаад монголын талыг шатаах гэдэг билээ? Бао төлөөлөгч өө, та чинь монгол хүн биз дээ?” хэмээн асуув.

Санжаа ч мөн дутсангүй “Одоо цастай болохоор түймэр авалцахгүй байх л даа. Гэхдээ бид өөрсдөө талаа шатаагаад байвал сүүлд түймрээс сэргийлэх тухай яриад яах билээ? Тэгээд ч чонын арьс үс шатчихвал олигтой үнэ цэнэ хүрэхгүй” гэлээ.

“Чоныг түймэрдэн устгана гэдэг туйлын боломжгүй сонголт. Хэрвээ чоногүй болчихвол зуд турханы үеэр үхсэн малын сэг зэмийг хэн идэж устгах вэ? Тал нутаг өмхий самхайгаар дүүрэн хижиг, тахал дэгдээд хүн хүртэл амьдрах аргагүй болно шүү дээ. Хэрвээ чоно үгүй бол тарвага туулай талын өвсийг там болтол зулгаах байлгүй” хэмээн Лхасүрэн хэлэв.

Жан Зи Юань тэндээс “Манай суурийн гурван адуучин бүгд наашаа ирсэн болохоор адуу маань ууланд эзгүй хэцүүдэж байгаа. Чонон сүрэг ар хударгаар дайрвал баларлаа гэсэн үг. Тийм болохоор би буцалгүй горьгүй нь. Осол гарвал надаас өөр хэн хариуцах билээ?” гэж хэллээ.

Бао Шүнь Гүй чанга дуугаар хашгиран “Цөмөөрөө чимээгүй байцгаа. Хэн ч буцаж болохгүй. Чоно агнана гэдэг олны төлөө хөнөөлийг устгаж, улсын эд баялгийг хамгаалахын тулд хийж байгаа ажил мөн. Дайралт бол хамгийн сайн хамгаалалт мөн гэсэн ч үг бий. Тийм болохоор бид чоныг алж устгаж дуусгах юм бол тэд бидний ар хударгаар дайрна гэж юу байх вэ? Чоно авлах нь зөвхөн арьсных нь төлөө ажил биш ээ. Арьс үсийг нь шатаасан чоно ч гэсэн байлдааны олз мөн. Бид дахин нэг чонын махыг овоолж байгаад хэдэн сайхан зураг дарж дарга нартаа харуулмаар байна. Хэн миний тушаалыг эсэргүүцнэ вэ? Түүний онооноос хасна гэж мэдээрэй. Бүгдээрээ хөдөлцгөө” гэв.

Лхамжав нүдээ бүлтийлгэн “Чиний яаж шийтгэх хамаа алга, би л явж чадахгүй дэг. Адуу руугаа явах минь” хэмээн хэлэхэд бусад адуучид нь ч “Буцъяаа” хэмээн орилолдов. Бао Шүнь Гүй ташуураа агаарт эргэлдүүлэн “Хэн чинь эндээс дураараа явнав, түүнийг адуучны ажлаас нь хална шүү. Дахин өөр ажилд орно гэж горьдолтгүй” гэж хашгирна.

Билиг өвгөн, Өлзий дарга руу арга тасарсан байдалтай хараад “За одоо орилолдоод яах

билээ? Би энэ ав хомрогын ахлагч болохоор адууны сууриуд руу нэг нэг хүн буцаагаад үлдсэн нь Бао төлөөлөгчтэй хамт явахаас даа” гэлээ.

Лхамжав, Жан Зи Юаньд хандан “Тэгвэл би адуу руугаа буцъя даа. Чи ажил дууссаны дараа хоёр өдөр амарна биз” гэхихээд өөр найм есөн адуучны хамтаар давхин одов.

\* \* \*

Морьтнууд Бао Шүнь Гүйг дагалдан гурван давааг давбаас тэртээ дор нэлийсэн зэгстэй тал тэднийг угтлаа. Зэгсний эргэн тойрон битүү цас цавцайна. Ван Ли Зюнь нарын тав зургаан илгээлтийн эзэн Бао Шүнь Гүйг тойрон гал тавьж ан хийхэд маш тохиромжтой газар байна гэцгээлээ. Ван Ли Зюний онгод хийморь бадарсан бололтой газар дээрээ шүлэг сэцлэн “Ассан галыг ашиглан

Араатан чоныг устгахад

Аливаа нөхцөл бүрджээ

Ариун салхи минь хаана байна” хэмээн уянгалуулж гарлаа.

Бат морьтойгоо Бао Шүнь Гүй, Өлзий дарга нарын өмнө давхиж ирээд “Их олон чоно байх шиг байна лээ. Би тэднийг үргээгээгүй болохоор бүгд эндээ байгаа” гэлээ. Бао Шүнь Гүй ташуураараа зэгстэй газрыг заагаад “Хэсгийн ахлагч нар дуулж бай. Нэгдүгээр хэсэг зүүн талд, хоёрдугаар хэсэг баруун талд, гуравдугаар хэсэг хойд талд байраа эзлэ. Дөрөвдүгээр хэсэг урд талд тойрон очоод зүүн урд хэсгээс эхлэн гал тавьж чонын ухрах замыг таслах хэрэгтэй. Гал тавьчихаад салхиныхаа дээхэн хол очиж зогсоорой. Бусад хэсгүүд тэдний тавьсан галын утааг харж байгаад гурван талаас гал тавиарай. Хүн ноход бүгдээрээ галын хажууд хүлээж байгаад чоно гарч ирэнгүүт нохдоо тавьж чоныг буудаарай. За ажилдаа орцгоо” гэв.

Дөрөвдүгээр хэсгийн илгээлтийн эзэд хошуучлан ухасхийхэд малчид араас нь дагалаа. Бусад хэсгүүд ч гэсэн заасан зүг рүү хөдөлцгөөв.

Чэнь Жэнь Билиг өвгөнийг дагалдан зэгстэй газрын байр байдлыг сайтар ажиглан харав. Олон жил хээрийн түймэрт өртөөгүй энэ газар босоо хүн давахаар өндөр зэгс байхаас гадна өнгөрсөн жилийн метр гаруй өндөр зэгснүүд зэрэглэн ургажээ. Шинэ, хуучин зэгсний аль аль нь голдоо хүртэл хатсан бололтой.

Өвгөн өгүүлрүүн “Зэгсэнд байгаа чононууд хүн нохдын байр байдлыг ажиглаж байгаа боловч айхгүй байгаа. Зэгс ийм өтгөн шигүү, өндөр ургасан болохоор ноход хурдан гүйж чадахгүй, хүн ч уурга хэрэглэх аргагүй. Дотор ойрын юм харагдахгүй боловч морьдын зэгс шажигнуулах чимээнээр тэд хүний хаана явааг мэдчихдэг юм. Дотор нь чонын жимүүд олон байгаа болохоор хүмүүс морьд ноходтойгоо дотогш оронгуут тэд өөрийн чинь ард нуугдаж чадна. Өвөл цагийн зэгс гэдэг чонын гол оромж болохоор тэднийг барина гэдэг амаргүй байдаг. Олонбулгийн чононууд хээрийн түймэрт дайрагдаж байсан боловч хүн өөрөө түймэр тавина гэж яахин санах билээ. Манай энд урьд өмнө ийм юм байгаагүй юм чинь. Гадны

хүмүүс л ийм монголоо алдсан юм сэдэж таарна. Чонон сүрэг ч баларч гүйцлээ л дээ” хэмээн халаглав.

Гэнэт нэг хүн “Гал тавиарай” хэмээн хашгирахад Чэнь Жэнь өвгөний морины цулбуураас чирч зэгсэн дундаас холдлоо. Зүүн өмнө зүгээс өтгөн хар утаа олгойдоход зүүн, баруун, умард зүгийн арван хэдэн газар нэгэн зэрэг гал тавьлаа. Бао Шүнь Гүй хүмүүсээр зэгс сүлжүүлэн шатаалгасны дараа талбайн гүн рүү шидүүлж байв. Хатсан зэгс тосны агуулах дэлбэрэх мэт дүрсхийн шатахад хэдэн алд өндөр галын дөл өтгөн хар утааг агаарт тургилаа. Хэдэн мянган мү газар галан далайд умбаад шатсан навч, ишнүүд дээш шидэгдэх нь нарыг халхлам олон тооны сарьсан багваахайнууд зүүн өмнө зүг нисэлдэх мэт харагдана. Бао Шүнь Гүй өндөр газар зогсчихоод хөөрцөглөн орилох нь эгээ л долоон зуун газар үргэлжилсэн дайсныхаа хүрээг галаар довтолж шатаасан зүүн Ү улсын их жанжин мэт өөрийгөө бодож байгаа бололтой.

Билиг өвгөн зэгстэй газрын баруун хэсгийн эрчлэх утаан дунд зүүн зүг рүү харан газар сөхрөн суучихаад нус нулимсаа урсган амандаа ямар нэгэн юм гүвтнэж байв. Чэнь Жэнь хэдийгээр сайн сонсоогүй боловч түүний чухам юу хэлж байгааг гадарлаж байлаа.

Салхи гэнэт эргэж өтгөн хар утааг өвгөний зүг тургив. Чэнь Жэнь, Ян Кө хоёр элбэн өвгөнийг түшин босгоод өтгөн утаан дундуур зүтгэсээр цастай газар хүргэлээ. Өвгөний нүүр утаа тортог болоод нүд дүүрэн нулимс мэлтрэх ажээ. Чэнь Жэнь өвгөнийг нүд далдиран харахдаа сэтгэлээрээ түүний зүрхний гүн дэх шаналлыг мэдрэх шиг санагдав. Нүдний өмнө бишрэн сүрдмээр чонон сүлд тодроод өтгөн хар утааг дагалдан тэнгэр өөд хөөрөхдөө монгол хүний хагуу чанга сүнсийг аван одох шиг. Гэвч тэдний үлдэж хоцорсон үр хойч нь монголын талдаа нүгэл, буяныг хослон үйлдсээр нүүдэлчин үндэстний омог бахархал хэвээр байсаар байх буй за.

Гал түймэр өндөр зэгсийг үндэстэй нь хуйхлан шатааж үнс нурмыг хийсгэн зүүн өмнө зүгийн нэгэн цастай бэлчээр рүү тургилаа. Их гал дүрэлзсээр их үд болохын хэрд сөрвийх төдийхэн зэгс ч үлдэж хоцорсонгүй. Галын дөл намжихад хэдэн мянган мү газар үнс нурам болон харлана. Гэсэн хэдий ч зүүн, баруун, умар зүгээс нохой хуцах болон буун дуу сонсогдсонгүй.

Ширүүн салхи утааг туун одоход шатсан талбай аажмаар хөрөв. Бао Шүнь Гүй морьтнуудыг нэгэн эгнээгээр талбайг самнаж үхсэн чононуудыг цуглуулах үүрэг өглөө. Зарим хүмүүс хорь гаруй чоно байгаа гэж таамаглахад нөгөө хэсэг нь өглөөнийхөөс ч олон байж мэднэ хэмээн мэдэмхийрнэ. “Шатсан хуйхлагдсан ямар ч сэг байсан надад авчирч тушаагаарай. Би зургийг нь авч дээш мэдүүлнэ. Нийт аймаг хошууны хүмүүс биднийг чонын арьсны төлөө ан хийдэггүй, тэднийг хүйс тэмтрэн устгахын тулд ийм арга хэрэглэсэн болохыг мэдэг” хэмээн Бао Шүнь Гүй хэллээ.

Морьтнуудын захад Чэнь Жэнь Билиг өвгөний араас дагангаа “Аав аа, та хэдэн чоно шатаж үхсэн байх гэж бодож байна вэ?” хэмээн сэмээрхэн асуухад өвгөн хариуд нь “Бэлчээр шатаана гэдэг танай хятадуудын л хийдэг ажил шүү дээ. Монголчууд бид галаас их айдаг улс, тийм болохоор түймэр тавьж хэдэн чоно алж болохыг яахин мэдэх билээ? Бао Шүнь Гүй түймэр тавьсан газраа хагалаад эхлэх вий гэхээс л би айж байна. . . . .” хэмээн хариуллаа.

Тэр хоёр морьтнуудыг бараадасхийн жаахан бөртөйсөн овгор үнс нурмыг ч уурганы үзүүрээр хатган эргүүлж тойруулан үзэж байлаа. Нэг тийм бөртөйсөн зүйлээс юу ч олохгүй байх тусам өвгөний амьсгаа уужрах ажээ.

Салхи намжих төлөвтэй боловч морин туурайд гишгэгдсэн үнс пургиж хүн, морьд, ноход бүгд нус нулимсандаа хутгалдан найтаалгаж гарав. Зарим ноход унтраагүй халуун нурам дээр гишгэчихээд гаслаж гангинана. Морьтнууд талбайн хагасыг самнаад юу ч олж үзсэнгүйд Бао Шүнь Гүй ихэд бухимдан “Зугуухан тайван хайгаарай. Ганц ч овгор нурам үлдээж болохгүй шүү” хэмээн хашгирлаа.

Билиг өвгөний царай бүр уужраад явчихав. Чэнь Жэнь түүнээс тэсгэлгүй “Чоно аль эрт зугатаад явчихсан юм болов уу? Эс тийм бөгөөс яахин ганц хоёрыг ч олдоггүй билээ?” гэхэд өвгөн их л горьдонгуй нүдээр түүн рүү ширтэж “Мөнх тэнгэр л чононд тусласан байж таарна” хэмээн хэлэв. Гэнэт нэг хүн нэлээд холоос “Энд нэг үхсэн чоно байна” гэхэд өвгөний царай тэр даруй барайгаад Чэнь Жэньг дагуулан тэр зүг явлаа. Морьтнууд бүгд цугларсаны дараа Бао Шүнь Гүй их л догдолж байгаа бололтой Билиг өвгөнийг чоно мөн эсэхийг үзээч гэж ойртуулав.

Хүрээний голд нэгэн шатсан амьтны атирсан сэг хиншүү хярвас ханхлуулан хэвтэх ажээ. Хүмүүс дор бүртээ шуугилдахад Ван Ли Зюнь ихэд хөөрсөн байдалтай “Галын дайралт амжилттай боллоо. Нэгийг олсон юм чинь нэлээд хэдийг олох нь гарцаагүй” гэв. Лхасүрэн “Энэ ч чоно биш дээ. Чоно хэзээ ийм жижиг биетэй байх билээ?” гэхэд Бао Шүнь Гүй өлгөж аваад “Чоно галд шатаад жижгэрэлгүй яах вэ?” хэмээн мэтгэлээ. “Бага залуу чоно байхыг ч хэн мэдлээ” хэмээн Ван Ли Зюнь хошуу нэмэрлэв.

Билиг өвгөн мориноосоо буугаад малиагаараа сэгийг эргүүлэн үзэхэд нөгөө тал нь ч гэсэн авах юмгүй шатжээ. Энэ амьтан лав зузаан зэгсэн дэвсгэр дээр хэвтэж байсан тул хамаг бие нь түлэгдэж гүйцжээ. Билиг өвгөн ам нээж “Энэ яаж чоно байх вэ? Бага залуу чоно бүр ч биш, харин хөгшин нохой байсан байна шүү дээ” гэлээ.

Бао Шүнь Гүй өвгөн рүү их л сэжиглэнгүй харж “Та яаж мэдээ вэ?” хэмээн асуув.

“Чи энэ шүдийг нь хар л даа. Чонын шүд нохойныхоос урт хурц байдаг. Чи итгэхгүй байгаа бол зургийг нь аваад дээшээ мэдүүлэхгүй юу? Жаахан юм гадарладаг хүн бол шатсан нохойн зураг авч чоно агналаа гэж хөөрцөглөснийг чинь дор нь л мэдчих байх шүү” хэмээн өвгөнийг өгүүлэхэд

Бао Шүнь Гүй их л сандран “Юу ч болсон тэмдэг тавиад орхичих. Дахиад өөр хэдийг олох юм бол чоно нохойн алин болох нь ялгагдана” гэлээ.

Өвгөн сэтгэл шимшрэнгүй байдалтай “Энэ хөгшин амьтан өөрийгөө явцгүй боллоо гэдгийг мэдээд энд ясаа тавихаар ирж дээ. Энд нөмөр нөөлөг, чоно элбэгтэй л газарсан. Гэтэл энэ хөгшин амьтныг тоогоогүй юм байх даа” хэмээн сүүрс алдлаа.

Бао Шүнь Гүйгийн дуу дахин цахиртаж “Бүгдээрээ нэг эгнээгээр дахин самнацгаая” гэхэд хүмүүс дахин бөртөйсөн үнс нурам болгоныг онгичоод юу ч олж чадсангүй. Илгээлтийн эзэд



дотроо эвгүйрхэн галаас бусад аргыг хэрэглэж үзсэн хашир анчид ч гэсэн Бат арай байдлыг худлаа мэдүүлсэн хэрэг биш биз дээ? хэмээн эргэлзэж эхлэжээ.

Бат ч хүмүүсийн асуултанд шахамдахдаа “Мао даргын нэр, мөнх тэнгэрийн нэрийг барин андгайлья. Бөхөө бид хоёр нүдээрээ харсан юм шүү дээ. Та нар ч гэсэн шинэ мөр байхыг үзээ биз дээ?” гэхэд

Бао Шүнь Гүй “Мөн сонин юм аа. Арай жигүүр ургаад нисчихнэ гэж баймааргүй юм” хэмээн шогшров.

Билиг өвгөн инээмсэглэн “Чоно нисдэг болохыг одоо мэдэв үү? Тэр адтай амьтан болохоороо жигүүргүй ч байсан нисчихэж мэднэ” гэлээ.

Бао Шүнь Гүй дүрсхийтэл уурлан “Тэгвэл өглөө яагаад тийм олон чоно агнаж чадсан юм бэ?” гэхэд өвгөн хариуд нь

“Тэр чононууд цэргийн агтны хариуд ирж байгаа хэрэг. Түүнээс олныг агнана гэвэл мөнх тэнгэр зөвшөөрөхгүй. Мөнх тэнгэрийн таалал хамгаас шудрага байдаг юм даа” гэж хэлэв.

Бао Шүнь Гүй түүний үгийг таслаад “Юуны чинь тэнгэр мэнгэр вэ? Наадахь чинь дөрвөн бурангуй ёсны нэг шүү. Алив тэр үлдсэн газрыг одоохон самнаад дуусга” гэлээ.

Гэнэт эгнээний эхэнд явж байсан хоёр адуучин дуу алдан “Баларсан юм боллоо шүү. Хоёр бух шатаад үхчихсэн байна” хэмээн хашгирлаа.

Морьтнуудын царай барайн тэр зүг хошууран давхилдав.

Бух бол монголын тал нутаг дахь хамгийн эрх тааваараа, хүмүүсийн хүндэтгэлийг хүлээдэг адгуус билээ. Тал нутгийн туршлагатай малчид бүр тугал байхаас нь сайтар шилж сонгон авдаг. Нас бие гүйцсэн бух зуны цагт нийлүүлгийн үеэр айлуудын хотонд очин үнээ дагахаас бусад цагт ижил сүрэгтээ баригдалгүй уудам талынхаа энгээр хээрийн зэрлэг амьтан мэт зоргоор сэлгүүцэн бэлчдэг. Бухын бие хүдэр бадриун, арьс зузаан, хүзүү лухгар, эр бяр тэнцүү, ирт мэс шиг хурц эвэртэй тул хичнээн их өлссөн чоно ч түүн рүү халдаж зүрхэлдэггүй юм.

Тийм болохоор бух тал нутгийн халдах дайсангүй амьтан гэж хэлэхэд хилсдэхгүй. Бух ихэвчлэн хоёроороо ижилсэн, шимтэй өвсийг даган бэлчиж, шөнө бөгсөө нийлүүлэн унтаад өгдөг. Эр бяр, эрэлхэг зориг, үржил хөгжил, эрх чөлөө аз жаргалын бэлгэ тэмдэг болсон бух гээч амьтан тал нутгийн онгон сэтэртэй амьтан ажгуу. Монголын бөх гэсэн үг нь угтаа бухнаас гаралтай гэлцэх нь бий. Бух тал нутгийн эмс хатад олонтой, гэр бүлийн хариуцлага үүрдэггүй, эрхэмсэг гүнтэн болохоор тал нутгийн эрчүүд түүнд битүүхэн атаархдаг. Тэр үржлийн ажлаа гүйцээчихээд эмс охид, үр хүүхдүүдээ тал нутгийн хүмүүст даатгаж орхиод явж одно. Тийм болохоор тал нутагт Бөхөө гэсэн нэртэй эрс олон байдаг. Тал нутгийн малчид бухын өнгө зүс ямар байгаа нь малын хишиг буянг илтгэдэг гэж үздэг учраас бухаа онголон дээдлэсээр ирсэн юм. Бухын тоо толгой хэдэн суурь үхэрт ганц оногдохоор цөөхөн байдаг. Малчид бух шатаад үхчихжээ гэдгийг дуулаад айхтар том гашуудлын мэдээ ирсэн мэт хар

хурдаараа давхилдлаа.

Малчид мориноосоо буугаад хоёр том хар юмыг тойрон зогсоцгоолоо. Бухын дөрвөн хөл сарвайн, үс хялгас нь шатаж бөөгнөрөөд, хуруу зузаан шир нь яст мэлхийн хуяг шиг язайсны завсар зайгаар шаргалдуу өөх цухуйна. Нүд нь шатсан чийдэнгийн шил шиг харлаад, хэл нь хагас тохой бултайн, ам хамраас нь хар шүүс гоожсоор байх ажээ. Үхэрчид болон бүсгүйчүүд эврийнх нь хэлбэрээр тэр хоёр бухыг таньж уурандаа шатаж гарав.

Галсмаа хамгийн түрүүнд ам нээж “Завхарсан юм болжээ. Энэ чинь манай багийн хамгийн сайн хоёр бух шүү дээ. Манай хэсгийн үхрийн бараг тал нь энэ хоёр бухны үр төл байгаа юм. Тал хээрээ түймэрдэж болно гэж үү? Манай тал нутаг таны гарт үрэгдэж дуусах нь байна шүү” гэв.

“Энэ хоёр бол талын улаан үүлдрийн жинхэнэ монгол үхрүүд байсан юм. Эднээс угшилтай үнээний сааль сүү элбэг, амбан шарын мах амт чанар сайтай байдаг. Би энэ хэргийн талаар хошууны удирдлагад дуулгаж шалгалтын хэсэг авчирч үзүүлнэ ээ. Ер нь хүний учруулсан хохирол чонхоос илүү гарч гүйцэх нь шиг байна.” хэмээн Билиг өвгөн уурсан өгүүлэв.

Өлзий дарга өгүүллрүүн “Хэдэн жилийн өмнө аймгийн мал аж ахуйн товчооноос энэ хоёр бухыг аваад явья гэхээр бид оронд нь эдний үр төл болох хоёр эр бяруу өгч байсан удаатай. Энэ удаа ч том гарз боллоо шүү” гэлээ.

“Зэгсэн дотор нөмөр нөөлөг болохоор бухнууд тайван хэвтэж байсан байж л дээ. Тэгээд гэнэт гал бадрахаар удаан хөдөлгөөнтэй амьтад чинь яаж гарч амжих билээ? Тэр айхтар утаа тортогт угаартаад үхсэн байж таарлаа. Тал нутагт урьд өмнө ийм хэрэг гарч байгаагүй. Тэнгэрт сүслэхгүйн хариуг амсаж байгаа нь энэ дээ.” хэмээн Лхасүрэн хэлэв.

Шатаж харласан үхрийн арьс дахин язарсаар үхрийн бие дээр тэнгэрийн бичиг шулмын хэл мэт этгээд хээ тодров. Эмэгтэйчүүд хурганы арьсан нудрагаар нүүрээ таглан холдож, эрчүүд хижиг тахал үзсэн мэт Бао Шүнь Гүйгээс зай барив. Бао Шүнь Гүйгийн хамаг бие, нүүр царай нь хөө тортог болчихсон үхсэн үхрийн дэргэд зогссоор байв. Гэнэт тэр “Бух шатаж үхдэг нь чононоос болсон хэрэг. Та нар юу ч гэж донгосдог бай хамаа алга, би Олонбулгийн чоныг устгаж үгүй хийж л таараа” хэмээн зуунгидуу хашгирав.

Харуй бүрий болохыг дагалдаад хавар эртийн жихүүн хүйтэн нөмрөн авлаа. Өлсөж даарсан морьтнууд нохдоо дагуулан гэрийн зүг сажлацгаах нь ялагдсан цэргийн жанжин ядарсан цэргүүдээ дагуулаад буцаж байгаа мэт гунигтай. Цагаан цээжит азарган чоно өөрийн сүргийг дагуулан бүслэлт болон галын цагирагаас хэрхэн мултарсаныг мэдэх хүн нэг ч байсангүй. Хүмүүс элдвээр хэлэлцсээр нисэн одсон гэдэг шалтаг дээр нэгджээ. Өлзий дарга хэлэхдээ “Энэ удаагийн бүслэлтийн хүрээ дэндүү өргөн байсан болохоор хүн ноход хүрэлцэн ирэхийг хараад л сүргээ дагуулан хулжин одсон байж таарна” гэж дүгнэжээ.

Адуучид адуун сүргийн зүг давхилдлаа. Чэнь Жэнь, Ян Кө хоёр гэртээ байгаа бэлтрэгийг санаад Жан Зи Юань, Гао Зянь Жун хоёрыг дуудан дөрвүүл гэрийн зүг дөт замаар дөрөө харшуулан хурдаллаа.

Ян Кө давхих зуураа “Шөнө дунд гарахын өмнө бэлтрэгт хоёр зүсэм ялз чанасан хонины мах тавьж өгсөн юм сан. Тэр идэж чадсан болов уу? Дорж бэлтрэгийг сар болж байж хөхнөөс гардаг гэж байсан шүү дээ” гэхэд Чэнь Жэнь “Гайгүй байх аа. Өчигдөр гэдсээ цүдийтэл хөхсөн болохоор өнөөдөр мах идэхгүй байсан ч алзахгүй. Харин бид нар өдөржин байхгүйг өлөгчин чоно эзгүйчилсэн байх вий гэдгээс л би их айж байна” гэлээ.

Жан Зи Юаний морьдоос бусад нь тарга тэвээрэг тааруухан тул тэд хэр тааруухан хатируулсаар шөнө дундын өмнөхөн гэртээ эргэн ирцгээлээ. Арслан, Анч шар хоёр идүүрийнхээ өмнө хоол горьдон зогсоцгооно. Чэнь Жэнь мориноос үсрэн буугаад хоёр том нохойд хэдэн яс хаяж өгөв. Жан Зи Юань, Гао Зянь Жун хоёр гэрт орж нүүрээ угаачихаад хоол цай бэлдэж эхлэв.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр бэлтрэгний үүрэн дээр явж очлоо. Үүрийг дарсан ширээний тавцанг холдуулан гар чийдэн тусгаваас бэлтрэг нүхний мухарт тайван унтаж байв. Охин гөлөг өлссөндөө нүхний ханыг маажлан хөхөө эрэхэд Ирвэс бачимдсан байдалтай үүрийг тойрон эргэлдэнэ. Чэнь Жэнь охин гөлгийг түүнд өгөхөд ирвэс зуусаар үүр рүүгээ авч одов.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр сайтар нягтлан харваас чанасан хонины мах алга болоод бэлтрэгний гэдэс цодойсон хэвээр, ам хамар нь тос даажээ. Тэр нүдээ анин завьжаа тамшаалан унтах нь амтат зүүдэнд умбаж байгаа янзтай. “Энэ золиг тавьсан махыг ганцаараа цохьчихсон янзтай байна шүү” гэж Ян Көг хэлэхэд Чэнь Жэнь уужим амьсгаа аваад “Өлөгчин чоно ч одоо ирэхээсээ өнгөрсөн бололтой” хэмээн хэллээ.

## Арван дөрөв

*Сүрэг хоньтой Мигүүлэй хэмээгч нэгэн монгол хүн байжээ. Нэгэн шөнө чоно сүрэгт нь халдаж дийлэнхийг сүйдэлжээ. Маргааш нь нөгөө монгол хүн хааны ордонд очиж энэ учрыг айлтгавай. Өгөөдэй хаан “Чоно хаашаа одов” хэмээн асуужээ. Яг энэ үед хэдэн мусульманчууд тэр газраас нэгэн чоныг амьдаар нь бариад хүлэн авчирч гэнэ. Хаан зуун балыш өгч мөнөөх чоныг худалдан аваад тэр монгол хүмүүнд “Энэ чоныг алавч чамд ашиггүй” хэмээгээд зарлиг буулган түүнд мянган хонь өгөөд “Би энэ чоныг талбиж үүссэн нөхцөл байдлыг хань нөхдөд нь дуулган тэднийг эндээс зайлуулж өөр тийш явуулсугай” хэмээв. Чоно тавигдсаны дараа нохойд баригдан үхжээ. Хаан нохой чоно барьсаныг сонсоод ихэд хилэгнэн зарлиг буулгаж тэр нохойг даруйхан алуулав. Хаан ордондоо хариад гаслаж зовнин бодлогоширсоор олон түшмэдэд хандан “Миний өвчин өдөр ирэхүйеэ хүндэрч байгаа болохоор энэ чоныг талбиад үхлээс хэлтрүүлбээс мөнх тэнгэр намайг ивээж тэтгэх болсугай хэмээсэн бөлгөө. Гэвч чоно нохойн амнаас хэлтэрч эс чадсан тул би бас аюул барцдаас хэлтрэхүйеэ бэрх болжээ” хэмээн өгүүлэв.*

*Рашид ад Дин “Судрын чуулган,*

*Өгөөдэй хааны тэмдэглэлээс”*

Хавь ойрд сураг алдраад байсан нарны туяа тоононы нүдээр тусахад Чэнь Жэнь нүдээ нээн харвал тал нутгийн жихүүн тэнгэр дээр мэлтийнэ. Тэр ухасхийн босож дээлээ хэдрээд бэлтрэгний үүр рүү очив. Гадаа гарахад нарны хурц туяанд түүний нүд гялбана.

Гомбын хургатай хоньд хашаанаас гаран баруун хөтлийн зүг бэлчихэд өөр нэгэн сүрэг баруун талд тааваар идээшилж байгаа харагдав. Төллөөгүй хоньд цөөхөн үлдсэн болохоор сүрэг тааваар урагшлах ажээ. Гомбо чонын арьсыг үхэр тэргэн дээр тавьчихаад Ян Кө, Жан Зи Юань хоёрт өвс хэрхэн чихэх аргыг зааж өгч байхыг хараад Чэнь Жэнь тэдэн рүү дөхөн очив. Гомбо гуай өвсний хашаанаас тэвэр өвс авчраад түүнээс хэсгийг авч туламласан арьс руу чихэн чонын хэлбэр дүрсийг сэргээх ажээ. “Ингэж чихсэнээр чонын арьс үрчийж хатаад чанараа алддаггүй юм” хэмээн өвгөн өгүүлнэ. Хоёр арьсанд өвс чихэж гүйцээд Гомбо хамрыг нь цоолон нарийн сур сүвлэлээ.

Гомбо Жан Зи Юанаас “Уурганы иш хийхээр зэхсэн хус байхгүй биз” хэмээн асуухад Жан Зи Юань “Байгаа” гээд түүнийг үхэр тэрэгний хажууд дагуулан очлоо. Өвгөн дөрөв таван уургын хусан дундаас долоон метр орчим урт ишийг сонгон авав. Дараа нь туламласан арьсны хамарт сүвлэсэн сурыг урт ишний үзүүрт уяд гэрийн өмнө гурав дөрвөн метр зайтай газар нүх ухан тэгшхэн суулгаад чулуу шороогоор сайтар чигжив. Хоёр туламласан арьс хусан ишний оройд савлах нь салхины аясаар намирах дохионы туг мэт үзэгдэнэ.

“Ингэснээр арьсыг салхинд хатаахаас гадна хавь ойроор өнгөрсөн хүмүүст айлын эзний ангийн олз хийморийг гайхуулдаг юм. Урьд цагт ийм хоёр арьс өлгөсөн айлыг харсан адууны хулгайчид халдаж чаддаггүй байсан гэдэг.” хэмээн Гомбыг өгүүлэхэд Чэнь Жэнь, Ян Кө, Жан Зи Юань гурав чонын арьсанд татагдан алмайран зогсоцгоолоо.

Хавар цагийн салхи хоёр чонын арьсыг хөндлөн гулд савчуулна. Намирсан үснүүд нь салхины

аясаар налаад хоёр арьс тал нутагт дүүлэн яваа амьд чоно шиг харагдах ажээ.

“Чоно хэдийгээр үхсэн боловч сүр сүлд нь яг хэвээрээ байна. Энэ хоёрын омог сүр бадран шунган дайрч байгаа төрхийг харсан хүний зүрх салгалмаар байна шүү” хэмээн Ян Кө гайхширан өгүүлэв.

Чэнь Жэнь ч гэсэн Ян Кө, Жан Зи Юань хоёрт хандан “Энэ хоёр чонын арьсыг хараад надад эртний түрэгийн алтан чонын толгой бүхий дайчин туг дэрвэж байгаа мэт санагдчихлаа. Чонон тугаа дэрвүүлэн дайрах тал нутгийн морьтон баатруудын биеэр талын чонын цус гүйж, чононоос суралцсан эр зориг, эрч хүч, оюун ухаанаараа бүх дэлхийг байлдан эзлэж байсан байж таарна. Дэлхийн түүхэнд түрэгийн морин цэргүүд хамгийн эр зоригтой, билиг оюун төгс байсан гэдэг. Баруун түрэгчүүд Тан улсын их цэрэгт бутцохигдон нутгаасаа хөөгдөөд өөр газар нутаг олж суурьшсан. Тэгээд хэдэн зуун жилийн дараа дахин хүчээ авч монголчуудын морин туурай хүрч амжаагүй Зүүн ромын эзэнт гүрний нийслэл Константинополь болон эртний Египетийг эзлэн, ази европыг дамнасан Османы эзэнт гүрнийг байгуулж, өрнө дорнын худалдааны их замыг таслаж байсан түүхтэй. Тэд өрнө дорнын худалдаанд ноёрхлоо тогтоон, өөрсдийн улсын хүчин чадал болон зэр зэвсгийн хүчээр европчуудыг хэдэн зуун жилийн турш толгой өндийх аргагүй дарлаж байлаа. Бүхий л дэвшилтэт соёл иргэшил болон өрнөдийн ойн чоно, дорнодын талын чонын дайралтад автан газар дундын тэнгисээс далай руу шахагдан гарч улмаар бүр ч хүчирхэг далайн чоно болон хувирчээ. Тэд өрнөдийн худалдааны болон далайн дээрэмчдийн хөлөг онгоцыг хөлөглөн их далайд дорно дахинд хүрдэг замыг бэдрэн явахдаа сохорсон биш завшив гэгчээр америк тивийг нээсэн билээ. Тэд европоос хэд дахин баялаг газар нутгийг эрхшээж, Инк, Майяачуудын алт мөнгөний нөөцийг дээрэмдсэнээр европын капитализм хөгжих анхны хуримтлалыг бий болгож чаджээ. Үр дүнд нь өрнөдийн далайн чоно дэлхийн хамгийн хүчирхэг том чоно, хөрөнгөтэй чоно, аж үйлдвэрийн чоно, шинжлэх ухаан техникийн чоно, соёлтой чоно болон хувираад буцаж дорно дахин руу эргэн халдаж Османы эзэнт гүрнийг сүйрүүлэн эцэс сүүлдээ тал нутгийн чоныг ч дайран мөхөөсөн байна. Тэдний өмнө дорно дахины суурьшмал хоньд юу болох билээ дээ. . .” хэмээн их л догдлонгуй өгүүлэв.

“Чоно судлал бол маш том шинжлэх ухаан юм гэдгийг би улам сайн ойлгох боллоо. Чиний чононд амиа тавиад байдаг ч аргагүй юм байна шүү” хэмээн Жан Зи Юанийг хэлэхэд Ян Кө өлгөж аваад “Гурвуулаа их сургуульд суралгүй энэ чиглэлээ хөөгөөд байвал сонирхолтой биш үү?” гэв.

Гомбо өвгөн хусан ишний дор их л сүслэнгүй байдалтай чонын арьсыг харж зогссоноо “Салхи чонын үсийг самнан доторх шороо тоосыг гөвж цэвэрлэдэг юм. Салхинд хэд хоног байлгасан чонын арьс үс их сайхан сэргэнэ. . . Та нар хар даа, хоёр чонын арьс амилаад тэнгэр рүү дүүлж байгааг. . . замдаа сайн яваарай даа” хэмээн өгүүлээд хонины хашаагаа цэвэрлэхээр явлаа. Чэнь Жэнь, Ян Кө, Жан Зи Юань гурав түүнд талархан хоцорлоо.

Тал нутгийн хаврын салхи Чэнь Жэньгийн хоёр чихийг шуугиулан алсад чоно улих шиг аль эсвэл соёлын хувьсгалын өмнөхөн Бээжингийн баруун дүүргийн Ши Кү сүмийн гуулин бүрээн дуу гунигтай эгшиглэх шиг санагдахад сэтгэл нь хөвсөлзөөд ирэв. Хоёр чонын туламласан арьс агаарт дэрвэхийг харваас хаврын салхинд үс нь намилзан зөөлрөөд нарны гэрэлд гялалзах нь гоёж гоодчихоод тэнгэрийн найранд явж байгаа мэт. Хоёр чонын арьс

агаар тэнгэрт мөр зэрэгцэн хурдалж, хааяа хааяа тэврэлдэн хөлбөрөөд зовлонгоос гэтэлсэний амгаланг эдлэн байх шиг. Чонын арьсанд өвс чихсэн бус, харин ч тэндээс эрч хүчтэй амьдрал бахтай бяр чадал мэдрэгдэнэ. Монгол гэрийн яндангаас гарсан цагаан утаа тэдний зүг хийсэхэд хоёр чоно үүл мананг хөлөглөн, салхи зүсэн хурдлана. Тэд тэнгэр рүү, тэнгэрийн чоно од руу, эрх чөлөөний диваажин руу тал нутгийн хүмүүний сүнсийг тээн одож байгаа юм.

Чэнь Жэнь ийнхүү тэнгэрийн нохдыг өлийн ширтэхэд эргэн тойрны уул толгод, монгол гэр, үхэр тэрэг, хонины хашаа хороо үзэгдэхээ байлаа. Түүний нүдэнд зөвхөн Готын сүмийн хурц шовх орой мэт тугны ишин дээр дүүлэх чоно харагдах бөгөөд түүний санаа бодол хурц үзүүрт өлгөгдөн тал нутгаас цойлон тэнгэрт нисэн одвой. Тал нутгийн хүмүүс хэдэн зуун мянган жилийн турш чонын арьсыг уурганы үзүүрт хатган өлгөдөг нь зөвхөн салхинд хатааж хол ойрын хүмүүст өөрийн олз омгийг гайхуулах төдийхөн байсан юм гэж үү? Тэд эрт балрын бөө мөргөлийн уламжлалын дагуу чонын сүнсийг зовлонгоос гэтэлгэж байсан юм биш үү хэмээн Чэнь Жэнь бодлоо. Тал нутгийн хүмүүс өөрийн онгон сүлд, шүтээндээ ариун ёслол үйлдэж байгаа нь энэ биш биз? Чэнь Жэнь өөрийн мэдэлгүй тэрхүү эртний онгон шүтээний ёслол үйлдчихээд гүн бишрэлд автав. Тал нутгийн оюун санаа, сүсэг бишрэл өөрийг чинь агаар мэт хүрээлэн авахын цагт сүнсний бачуурал тэмүүлэл байдаг л бол түүнийг өөрийн эрхгүй мэдэрдэг ажээ. . . .

Ян Кө, Жан Зи Юань хоёр ч дээш өлийн харсаар хүзүү нь хөшиж орхив. Жан Зи Юань өгүүлрүүн “Бидний өмссөн зүүсэн, эдлэж хэрэглэж байгаа нь малчдаас ямар ч ялгаагүй, тэр ч байтугай зүс царай хүртэл онгож борлосон. Гэвч бид талын хүмүүс болох яагаа ч үгүй, тэр ч байтугай манай гэрээс нэг л өөр үнэр ханхлаад байдаг юм. Харин одоо энэ хоёр арьсыг өлгөснөөр холоос харсан хэн боловч жинхэнэ талын монгол айл байна гэж бодохоор боллоо. . . . .” гэв.

Чэнь Жэнь хүзүүгээ сэжлэн гараараа илэнгээ “Бээжингээс нааш гарахын өмнө би тал нутгийг

Хөх тэнгэр нь цэлийж

Хөрст дэлхий нь ногоороод

Урин салхи өвсийг ганхуулахад

Үхэр хоньд ярайн харагдана гэдэг дуунд гардаг шиг амар амгалангаар төсөөлж ирсэн сэн. Гэтэл Мүлө нэрт энэхүү эртний дуу нь Сяньбигээс гаралтай юм байна лээ. Харин жинхэнэ тал нутаг амаргүй ширүүн нөхцөлтэй, тал нутгийн оюун санаа гагц чонын биенд цогцолсон байдаг ажээ” хэмээн өгүүлэв.

Ян Кө толгой дохин “Тал нутгийн жинхэнэ шилдэг дуунууд бүрэн уламжлагдан ирж чадаагүй. Гагцхүү өөрсдийн санаанд нийцэх ганц нэгийг нь л хятад хүмүүс хуулбарлан үлдээсэн байх. Би хэдэн ч малчдаас асууж үзэхэд саяын дууг мэддэггүй юм байна лээ” гэлээ.

Жан Зи Юань дээш харан чонын арьсыг хэдэнтээ тойронгоо “Энэ хоёр чоныг нохой барьсан гэдгийг хэн хүнгүй мэднэ. Гэтэл би Олонбулгийн адуучин мөртлөө ганц чоно яагаад агнаж

чаддаггүй билээ? Хэн намайг сайн адуучин гэх вэ дээ?” хэмээн санаашрав.

Арслан өөрийнх нь агнасан чоно агаар тэнгэрт амилан сэргэхийг үзээд их л ууртай байгаа бололтой. Тэр хойд хоёр хөлөө нийлүүлчихээд дээш харан байн байн хуцахад хоёр чоно түүнээс айсан шинжгүй дэрвэсээр байлаа. Тэр арга тасарсан байдалтай харц нь зөөлрөхөд чонын үзэсгэлэнт байлдааны нөмрөгт агаархсан янз илэрхий. Төллөх хоньд аажмаар холдож Ян Кө хурганы уугаа үүрээд мориндоо мордон араас нь явлаа. Харин хургатай хоньд хүн нохдын хараанд өртөх зайд тархан бэлчив. Чэнь Жэнь, Жан Зи Юаньд хандан “Чи чоно агнахын түүс болж байснаас надтай очиж чонын бэлтрэг харахгүй юу?” гэв.

Тэр хоёр бэлтрэгний үүрэн дээр очоод ширээний тавцанг зайлуулан харваас охин гөлөг адсаган дээр бөх нойрсох нь огт өлсөөгүй шинжтэй. Харин бэлтрэг нүхний мухарт оцойн суугаад хөхөө хүлээж байлаа.

Нарны туяа тусахад бэлтрэг их л цовоо янзтай урд сарвуугаар нүхний ханыг маажилж гарав. Тэр хэдэн ямх дээш мацсанаа нүхний мухар руу эргэн тонгорцоглолоо. Гэвч тэр эргэн босоод гүрвэл мэт хана тэмтчин авирах нь хөхөө эрж байгаа бололтой. Сул шороонд тогтолгүй дамартай утас мэт эргэн ойчих бэлтрэг нүхний сүүдэр л түүнийг урагш ахиулахгүй байгаад уурсах мэт гийнана.

Жан Зи Юань анх удаа амьд бэлтрэг харж байгаа болохоор их л гайхаж байгаа бололтой барьж үзэхийг завдав. Чэнь Жэнь түүнд хандан “Битгий яар. Түүнийг авиран гарах нь уу, үгүй юу гэдгийг харъя. Хэрвээ гараад ирдэг юм бол нүхийг нь гүнзгийлэн ухах хэрэгтэй” хэмээн хэлэв.

Бэлтрэг хоёр удаа ойчоод дахин авиралгүй, энэ тэрүүгээр шиншлэн эргэлдэх нь ямар нэгэн арга хайж байгаа бололтой. Тэр хэд эргэснээ охин гөлгийг олж түүний нуруу, толгой дээгүүр гишгэн дээшээ авирч эхлэв. Түүний хөлөөр нурсан сул шороо гөлөгний хамаг бие дээгүүр цацагдахад цаадахь нь цочин сэрж гаслан, биеэ гөвөхдөө бэлтрэгийг унагаж орхилоо. Тэр охин гөлөг рүү шүдээ ярзайлган архирав. Жан Зи Юань инээд алдан “Муу золиг чинь, хар багаасаа чонын зангаа тавихгүй нь байна шүү. Тун ухаантай байна” гэлээ.

Энэ хоёр өдөр бэлтрэгний нүдний салслаг бүрхэвч нимгэрээд харлан гүйлгэнэх нь нүдний өвчин олсон болов уу гэлтэй. Гэвч бэлтрэг түүний дохио зангааг ойлгон нүдний өмнөх зүйлсийг ялган таньж байгаа шиг Чэнь Жэньд санагдав. Тэр алгаа дэлгэн баруун зүүн тийш болгоход бэлтрэг алдахгүй даган харж байв. Түүний орчноо мэдрэх чадварыг өдөөхийн тулд тэрбээр нэг нэг үеэр нь “Бэлт. . . рэг . . . ээ . . хоо. . лон. . доо. . “ хэмээн хашгирахад цаадахь нь муур шиг чихээ соотгонуулан айсан гайхсан байдалтай толгойгоо гилжийлгэнэ.

Жан Зи Юань “Би түүнийг чонын үүрээ санах нь уу, үгүй юу гэдгийг хараадахья” гээд гараа хясааны яс шиг нийлүүлэн амандаа ойртуулаад чоныг дууриан “Ау . . . ау . . “ хэмээн улихад бэлтрэг давхийн цочиж ухаан зулаггүй гөлөгний бие дээгүүр мацан авирсанаа цөхөрсөн бололтой нүхний мухарт шигдэх нь эхийн өврийг үгүйлсэн мэт. Хоёр залуу бэлтрэгт чонын ертөнцийг нь санагалзуулаад дэмий юм хийснээ ухаарав.

Жан Зи Юань өгүүллрүүн “Манай энд Бээжингийн амьтны хүрээлэн биш болохоор бэлтрэг

тэжээнэ гэдэг амаргүй юм байна даа. Түүнийг чонын ертөнцөөс бүрэн таслаж байж л төрөлх араншинг бага багаар засаж болно. Гэтэл энэ нүүдлийн орчин нөхцөлд шөнө болонгуут л чоно улиад байхаар түүний чонын араншин өөрчлөгдөж болно гэж үү? Бэлтрэг томрохоороо хүн урж мэдэх тул мэдээтэй байдаг юм шүү” гэхэд

Чэнь Жэнь хариуд нь “Би чонын араншинг нь үгүй хийх гэсэн хэрэг биш ээ. Тэгвэл харин ч утгагүй зүйл болно шүү дээ. Би зөвхөн амьд чоныг илж тэврэн, ойр зайнаас харьцаж, түүний араншинг ойлгож авмаар байна. Чонын үүрэнд эс орвоос бэлтрэгийг яахин барьж болох билээ? Тэр тусмаа бэлтрэг тэжээсэн хүн түүнд уруулахаас айж яахин болох вэ? Миний ганц айж байгаа юм гэвэл малчид л намайг ойлгохгүй байх вий?” гэж хэлэв.

Бэлтрэг дээш авирсаар байх тул Чэнь Жэнь түүний шилэн дээрээс татан гаргаж ирэв. Жан Зи Юань түүнийг хоёр гардан тосож аваад сайтар ажиглан харж байснаа хүзүүг нь зөөлөн илбэв. Бэлтрэгний шингэн үс яаж ч илбээд арагш налахгүй эргэж сөрвийх ажээ.

“Өөрөө адуучин хүн байж хоньчны гараас бэлтрэг барьж үзэх ч гэж дээ. Лхамжав бид хоёр уг нь бэлтрэг суйлах гэж хоёр удаа яваад бүтээгүй юм. Манай хятадаас монголд ирж бэлтрэг суйлж байсан хүн гэвэл зуун мянганы нэг хувьд ч хүрэхгүй байх шүү. Хятадууд чоныг үзэн ядсаар байгаад түүний мөн чанарыг ойлголгүй хоцорчээ. Харин түүний чадвараас суралцсан үндэстэн гэвэл ихэнх нь нүүдэлчид л байдаг. . . ” хэмээн Жан Зи Юань өгүүлэв.

Чэнь Жэнь үгийг нь өлгөж аваад “Дэлхийн түүхэнд европыг дайлаар одож байсан дорно дахины хүмүүс гэвэл нүүдэлчид л байна. Тэр дундаа европынхныг айлган чичрүүлж байсан чонон сүлдтэй гурван нүүдэлчин үндэстэн нь Хүннү, Түрэг, Монгол гурав юм. Харин дорно дахин руу халдаар ирсэн европчууд бас л нүүдэлчдийн үр хойч нар байсан. Эртний Ром хотыг үндэслэгчид нь өлөгчин чонын тэжээсэн хоёр шаалуухүү<sup>17</sup> байсан биш үү? Тийм болохоор өнөө хэр Ром хотын сүлдэн дээр тэр өлөгчин чоно шаалуухүү нарыг дүрсэлсэн байдаг юм. Хожим хүчээ авсан Герман, Англо Саксон зэрэг том үндэстний цусаар чонон араншинтай цус урсаж байгаа. Харин сул дорой зан араншинтай хятад үндэстэн энэхүү эрэлхэг зоригтой, дайчин давшингуй цусаар өөрийгөө сэлбэх хэрэгтэй. Хэрвээ чоно байхгүй байсан бол дэлхийн түүх шал өөрөөр бичигдэх байсан. Чоныг ойлгохгүй бол нүүдэлчин үндэстний оюун санаа зан чанарыг ойлгохгүй, тэр тусмаа тэдний суурьшмал иргэдээс юугаараа өөр болон давуу сул талуудыг ойлгож мэдэж чадахгүй хоцорно” хэмээн хэлэв.

“Би чиний ямар зорилгоор чоно тэжээх гээд байгаагийн учрыг ойлголоо. Тийм болохоор малчдыг ятгахад туслах болно оо” хэмээн Жан Зи Юань хэллээ.

Чэнь Жэнь бэлтрэгийг өвөртлөчихөөд чонын үүр рүү явав. Ирвэс бэлтрэг хөхийг нь хөхөж байгааг мэдчихээд Чэнь Жэньг гэнэдүүлэн ухасхийж хазаад авахаар завдав. Гэвч бэлтрэг том угжны шил шиг түүний хөхнөөс салахгүй зууралдах тул Ирвэс хэдэн ч удаа биеэ хөлбөрөх гэж оролдоод түүнийг салгаж чадахгүй, хазаж ч чадахгүй ажээ. Хоёр залуу түүнийг хараад инээд ч хүрэх шиг, уур ч хүрэх шиг санагдаж байлаа. Чэнь Жэнь бэлтрэгний хоёр завьжнаас шахан түүнийг хөхнөөс салгав. Жан Зи Юань тас тас хөхрөн “Цус сорогч л нэг ийм байдаг байх даа” гэнэ.

Чэнь Жэнь Ирвэсийг дарж байж бэлтрэгийг цадтал хөхүүлсэний хойно босож ирээд



“Бэлтрэгийг гөлөгнүүдтэй хамт тоглуулах хэрэгтэй юм байна” гэв. Хоёул дөрвөн паацгар амьтныг тэврээд ойролцоох хуурай өвстэй газар руу явцгаалаа. Чэнь Жэнь бэлтрэгийг нохойн гөлгөн дунд тавихад тэр хамаг хурдаараа хүнгүй газрыг чиглэн паацганав. Бэлтрэгний дөрвөн мойтгор хөл биеэ даахгүй тул гэдсээ газраар чирэн урагшлах нь үстэй яст мэлхий урагшаа явж байгаа мэт харагдана. Нэг эр гөлөг түүнийг даган гүйхэд тэр шүдээ ярзайлган архирч сүрдүүлэв.

Чэнь Жэньгийн сэтгэл сэрхийж “Тэр сүү хөхөж байхдаа ээжийгээ гэж бодоод цадсан хойноо төрөл бишээ мэддэг байх нь. Түүний нүд хараахан нээгдээгүй боловч хамар нь бусдыг танихдаа гоц ажээ” хэмээн өгүүлэв.

“Тэр төрсөн гэртээ өөрийн эх, ах дүүстэйгээ цуг биш байна гэдгээ ялгаж байна” хэмээн Жан Зи Юань хэллээ. Чэнь Жэнь ч мөн “Сая түүнийг нүхнээс гаргаж ирэх үед үхсэн царай гаргаж байдаг шүү” гэж хэлэв.

Тэр хоёр бэлтрэгний ард дөрөв таван метрийн зайтай газар түүний үйл хөдлөлийг ажиглаж байлаа. Бэлтрэг цастай болон хар газар хэдэн арван метр мөлхсөнөө эргэн тойрны аргал, хомоол, өгөр яс зэргийг шиншилж эхлэв. Тэр болгонд нохой сарьсан байх тул тэднийг орхиж дараагийн зүйл рүү очно. Тэр хоёр түүнийг зуу гаруй метр дагахдаа зүг чиггүй яваад байгаа биш болохыг мэдэрлээ. Түүний зорилго монгол гэр, хонины хашаа хороо, хүн нохойн үнэрээс аль болохоор дайжин холдох гээд байгаа нь илт байв. Энэ нүдээ ч нээгээгүй бяцхан амьтанд байгалийн унаган чанар, зөн совин ийм хүчтэй илэрч байгаа нь аймшигтай атлаа биширмээр санагдана.

Амьтдын дундаас Чэнь Жэнь бялзуухайг их үнэлдэг билээ. Тэр ерөөсөө гэршиж гаршдаггүй онцлогтой. Чэнь Жэнь багадаа том жижиг арван хэдэн бялзуухай барьж тэжээхээр оролдож байсан боловч тэд юм идэж уулгүй нүдээ аньчихаад үхлээ хүлээдэг. Тэдний эрх чөлөөг үхлээс илүүд үздэг зангаас болоод ганцыг ч тэжээж чадаагүй юм. Харин чоно бол эрх чөлөө амь насыг ижилхэн нандигнан дээдлэнэ. Тэд хүнд баригдсаны дараа урьдын адил ууж идэж, унтаж амарсаны дараа завшааныг эрэлхийлэн оргож шинэ амьдрал эрх чөлөөтэйгөө золгодог. Чэнь Жэнь шаар шавхруугаар амь зогоон нүхэн гэрт хоригдож байдаг мэсчин боолуудын зан чанарыг олж харах шиг болов. Тэд бол үндэстэн хэмээх элсэн дундах алт байсан бол тэр зан чанар чонын хувьд түгээмэл, төрөлхийн агаад үе дамжин ирдэг. Ийм зан чанарыг шингээсэн чоно тухайн үндэстэнд адгуусны өвөг, сүлд шүтээн, дайны сахиус хэмээн хүндлэгдэж тэр хэрээрээ хэмжээлшгүй гүн гүнзгий нөлөө үзүүлж байдаг нь тодорхой юм. Үлгэр жишээ хязгааргүй хүчтэй гэж бүгд л ярьцгаадаг. Тэгвэл сүлд үлгэр жишээнээс ч илүү хүч ялгаруулан шүтээний сууринд залагддаг ажгуу.

Энэ бяцхан бэлтрэгний булбарай бие өөрийг нь мянган оны төөрөгдлийн мананг гэтэлгэн, оньсогоны тайлалд аваачсанд Чэнь Жэнь маш их догдолж байлаа.

\* \* \*

Гомбо морьтойгоо давхин ирээд хурга ишгийг эхэд нь хөхүүлэе хэмээн Чэнь Жэньг дуудав. Нялх төл сүргийн голд унтацгааж, эм хонь ямаад таран бэлчжээ. Чэнь Жэнь бэлтрэгээ үүрэнд хийж орхиод, мориндоо мордож хонь руугаа явлаа. Хоёул хоёр мянга гаруй хоньдоо

хураахад хонь хурганы майлалдах дуун чих дөжрөөнө. Эхээ олсон хурганууд сөгдөн хөхөхөд элбэрэлт эхийнх нь бүлээн сүү булгийн ус шиг ундарна. Тэр хоёр цаг арай хүрэхгүй хугацаанд хургыг эхэд нь амлуулж гүйцэв. Энэ ажил өдөрт их бага үдийн алдад хоёр удаа хийгдэнэ. Хэрвээ хурга ишиг эхээ олохгүй төөрвөл харангадаж үхэх аюултай. Хурга ишиг амлуулах нь төл малыг тоолох давхар ашигтай байдаг. Хурганууд нарнаас зайлан тарваганы үүрэнд ороод унтчих гэм байдаг тул амлуулахаар далимдуулан тэднийг алдахаас сэргийлнэ. Нэг удаа Чэнь Жэнь гурван дутсан хургыг хавь ойрын тарваганы нүхэнд унтаж байхад нь олж авч билээ.

Гомбо их л сэтгэл хангалуун байдалтай “Олонбулаг маань өвс соргог, ус тунгалаг, хоньд жилбэ сайтай болохоор хургаа голох явдал гарахгүй мөн ч амар шүү. Хэрвээ бэлчээрийн чанар муудаад хоньд жилбэгүйтэн хургаа голвол аж ахуйгаас нэмэлт хүч дайчлан ирүүлж хургаа амлуулна гэж дуусашгүй ажил ундрах байсан даа. Зуд турханы үеэр хэдхэн өдөрт хургаа, ишиг мянга түмээрээ үхдэг болохоор явж явж хүний гай барцад чонын гамшгаас ч илүү аймаар хэрэг. Олонбулгийн аж ахуйн хуучин удирдлага айхтар улс байжээ. Тэд тал нутаг, чоныг сайн мэддэг болохоор хонь мал гэхээсээ өмнө бэлчээр нутгаа их боддог байсан юм. Гол ажлыг л эвгэйхэн нугалчихвал төл чинь өөрөө өсөөд ирдэг юм шүү дээ. Олонбулгийн хоньчид түүний хүчээр хичнээн амар байна вэ дээ. Хэд хоногоос би өөрөө ганцаараа хургаа амлуулаад байж чадах байх аа. . . . .” гэв.

Энэ бүхнийг сонсоод нэг их орж гараад байдаггүй Гомбо бэлчээр нутгаа арван хуруу шигээ мэддэг болохыг Чэнь Жэнь даруй ойлгожээ.

## Арван тав

*Чингис хаан ав хийхийг маш их чухалчилдаг. Ав хийх нь цэргийн их ноёдын зайлиггүй үүрэг.*

*Ан авын хишигийг хүртэж, биеэ боловсруулах нь цэрэг хүмүүний гүйцэтгэвээс зохилтой үүрэг. Авлах дундаа тэд яаж ан гөрөөсийг гүйцэх, хэрхэн барих, яаж жагсаалаа байршуулах, яаж хүний олон цөөнийг үзэж тохируулан хомрого хийхийг сурдаг. . . . Байлдаан хийхгүй үест тэднийг ан аваар зоригжуулж байх хэрэгтэй. Энэ нь зөвхөн хээрийн араатныг авлаж ангийн олз олохын төлөө бус, ан авын далимаар морь унаж нум тэлэхэд дасган, хүчир зовуурийг багасгахад тустай юм гэж тэр үргэлж ярьдаг байжээ.*

*Жувейни “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” дээд дэвтэр*

Хаврын урин салхи Олонбулгийн талыг илбээд хонин цагаан үүлс аядуухан нүүдэллэнэ. Нэгэн хэвийн уйтайхан тал нутаг түүний аясаар нэг бүүдийж нэг гэгээ татаж, цагаан шаргал өнгө ээлжлэн сүлэлдэж байлаа. Нар хэсэг үүлний цаагуур орох үест Жан Зи Юаний хөвөнтэй дээлийг нэвт жиндээх мэт болсноо хурц туяа үүлсийг яран гарч ирэхэд зуны эхэн сарын зулай төөнөм өдөр мэт өмссөн хувцас зузаадах шиг санагдана. Тэр энгэрийн шармал товчийг тайлах гэтэл хэсэг бөөн үүлний сүүдэр тусаж хаврын салхи хавирга нэвт гэдгийг сануулаад авчээ.

Цас мөс хайлсан боловч хаврын нялх ногоо цасан дор нарны туяа үзэлгүй шарлаж, толгой хэсэг нь үл мэдэг ногоорсоныг эс тооцвол тал нутаг тэр аяараа шаргалтан байлаа. Агаарт намрын шарласан өвсний ааг ханхалж, гуу судгаар хайлсан цас горхилон урсаад нуга бэлчээрт тоо томшгүй олон балчиг шалбааг тогтоон, мянга түмээр тоологдох цагаан үүлсийг тольдох нь халыг харсан хүнд Олонбулгийн тал тэр чигээрээ нүүж байна уу даа гэж бодогдмоор.

Жан Зи Юань, Бат хоёр энэхүү өвстэй толгойн арван хэдэн бут сөөгний ард нуугдан чоно ирэхийг цаг гаруй хүлээж байлаа. Цэргийн агт осолдсоны дараа зэгсэн дунд чонон сүрэг байгаа тухай худал мэдээлсний улмаас Бат аж ахуй даяар хүний нүүр харах аргагүй шахам болсон тул уур унтуугаа гагцхүү чононд гаргадаг болжээ. Жан Зи Юань ч гэсэн ав хомрогын үеэр нэг чоныг хажуугаараа гүйлгэн алдсан болохоор даагаа нэхэх бодол өвөрлөх болсон юм. Тэр хоёр хэдэн өдөр сайхан амарсаны дараа хоёр ширхэг хагас автомат буугаа үүрэн нуурын ойролцоох нэгэн толгодыг сахин суугаа нь энэ. Нуурын ойр орчмын намгийн цас мөс хайлаад үхсэн адуу доош живчих болохоор одоо л амжиж ам хүрэхгүй бол чононд өөр боломж олдохгүй хэмээн Бат тооцоолжээ.

Толгодын өмнө мяралзах цөөрмийн ус тэр хоёрын нүдийг гялбуулсан тул нүдээ арчингаа дурангаараа өмнөх уулын хормой бэл хавиар үзэгдэх сэжигтэй хар, шар, саарал зэрэг бөртийсөн дүрс болгоныг нэгжин харна. Гэнэт Бат толгойгоо доош навтайлгаад “Зүүн хөтлийн тийш хар даа” гэхэд Жан Зи Юань амьсгаа дарсан чигээр дурангаа зөөлөн шилжүүлэн харваас тэртээх уулын чанадаас хоёр чонын толгой, хүзүү, цээж зугуухан цухуйхыг хараад зүрх нь өөрийн эрхгүй пэл пэлхийтэл цохилон.

Тэр хоёр ангаа салахгүй ажиглана. Чоно хөтлийн цаанаас цээжин хэсгээ цухуйлгасан чигээр алхаагаа татаж, орчин тойрны сэжигтэй бүхнийг гүйлгэн харж байлаа. Чоно долоо найман

боролзгоны цаагуур өөрсдөө ан ав хийж байгаа мэт нуугдан хэвтэх нь өчүүхэн ч хий зай алдахгүй ажээ. Хошоод хүн чоно хоёр талын боролзгоны бутны ард нуугдчихаад завшааныг хүлээцгээнэ. Тал нутгийн анчин нуугдах байраа сонгохыг хүртэл чононоос суралцсан болохыг Жан Зи Юань олж мэдэв. Хүн ямар ч арга заль хэрэглэж мэдэх тул чоно яарамгүй шөнийг хүлээж байгаа бололтой.

Боролзгоно гэдэг нь сэхээтэн залуусын өгсөн нэр бөгөөд монголын талд хаа сайгүй тааралдах этгээд агаад үзэсгэлэнтэй үет ургамал юм. Тал нутгийн тэгш нуга, довцог толгодын энд тэнд хэсэг бусаг ташаан толгой давам өндөр ургасан нь зайгүй шигүү тутрага аль эсвэл намхан зэгс мэт. Намар болоход боролзгоны толгой хунгийн өд мэт халиурч, оройн нарны туяанд галын дөл лугаа адил намилзан байх нь намхан толгодын тачир өвсний дунд тахиан сүрэгт нийлсэн тогоруу мэт үзэсгэлэнтэй тул талын энг бүрхсэн хээрийн цэцэгсээс ч илүү нүд баясгадаг. Өвөл болоход боролзгоны хатсан түрүү салхинд зулгаран одоод хатуу иш шилбэ нь чонын хялгас мэт хугарч нугаралгүй цасан дунд торойн үлдэнэ. Цасан шуурганы үеэр ялимгүй гудайх боловч салхи намжингуут европын хаадын үнэт титэм адил тэргүүнээ тэнгэр өөд ихэмсэг бардмаар өргөдөг. Тал нутгийн айл хунар болгон энэ бутлаг өвсөөр шүүр хийдэг нь эдэлгээ даахуйц бөх эд байдаг билээ.

Боролзгоно нь тал нутгийн үзэсгэлэнг нэмэхээс гадна хэсэг бусгаар хүрээлэн ургадаг нь гайхалтай. Боролзгоны хүрээний гадаад тойрог өтгөн шигүүгээс гадна, горьтгоор зурж байгаад үр цацчихсан юм шиг нэгэн жигд, харин дотор талдаа ямх өвсгүй шахам хов хоосон зай үлдсэн байдаг. Боролзгоны том хүрээ метр гаруй байх нь бий. Малчид адуу малаа хариулж явахдаа багшиг боролзгоны бут олж тухлан суухад дарагдсан хэсэг нь тухлаг олбог, бусад нь түшлэг гарын тавиур болон хувирах тул их л тааламжтай сайхан байдаг. Монгол гэрт хэдийгээр буйдан гэж үгүй боловч талын эзэн монгол хүн тааралдсан газар бүхэндээ буйдан эзэгнэн суух боломжтой нь энэ юм. Илгээлтийн эзэд тал нутагт ирэнгүүтээ л боролзгонд их л талтай болсон бөгөөд түүнд буйдан өвс, дугуй сандал өвс гэсэн нэр хүртэл өгсөн юмдаг.

Хэлбэр дүрсийн хувьд өвөрмөц боролзгоно нь торж торойх зүйл ховорхон тал нутгийн анчин хүн, чоно хоёрын хувьд, амарч тухлах, бүгж нуугдах байгалийн халхавч болж өгдөг. Тал нутгийн баатруудын үзэж дуулсан нь ижил төстэй болохоор чоно хүнээс эрт тал нутгийг эзэгнэж, боролзгоныг ашиглаж ирсэн нь тодорхой. Чоно байнга боролзгоны ард нуугдаж байгаад зээр болон хонин сүрэг рүү дайрдаг гэж Бат ярьдаг билээ. Жан Зи Юань ч гэсэн боролзгон дундаас хэд хэдэн чонын баас олсон нь түүний боролзгонд их дуртай гэдгийг илтгэнэ. Боролзгоныг дээд тэнгэр биеэ халхалж байг хэмээн чононд хайрласан хишиг юм хэмээн Билиг өвгөн ярих дуртай.

Энэ үед хүн чоно хоёр биеэ халхлахдаа гарамгай болохоор чоно хүнийг харахгүй, харин чоныг түрүүлж харсан хүн түүнийг буудаж чадахгүй байсаар байлаа. Бат эргэлзэж, Жан Зи Юаний санаа зовниж эхлэв. Тэр хоёр энэ бутанд ирж нуугдахаас өмнө чононууд өөрсдийг нь олоод харчихсан юм биш байгаа даа? Тал нутагт чонотой харьцахдаа юу ч болж мэднэ гэсэн бодолтой байх хэрэгтэй юм. Энэ бол талын чоно монголын дайчин эрст зааж өгсөн хамгийн наад захын цэргийн дүрэм билээ.

Бат хэсэг зуур бодлогоширч байснаа огт хөдөлсөнгүй өмнөх уулын байр байдлыг ажиглаад харин Жан Зи Юанийг хажуугийн уул толгодын газрын онцлогийг сайн тогтоохыг санууллаа.

Тэр хоёр гүдгэрийн ард байгаа морин дээрээ очиж чөдрийг тайлаад, морьдоо хөтлөн доош уруудаж, баруун өмнө зүгийг чиглэн сэмээрхэн явцгаалаа. Чононоос нэлээд холдсоны дараа морин дээрээ сэвхийн мордоод салхиных нь доогуур чонын нуугдаж байгаа газрын зүг тойрон очив. Чийгтэй зөөлөн газар морин туурайн чимээ сонсогдохгүй, салхины исгэрээн хүн морьдын үйл хөдлөлийг далдлах ажээ. Өөрсдөө хонь руу халдаж байгаа чононоос өөрцгүй мэт Жан Зи Юаньд санагдав.

Бат хөтлийн хажуу талаас байр байдлыг сайтар ажиглан явсаар хагас цагийн дараа гэхэд чонын архан талд дөхөн очив. Бат хөтлийн орой дээрх хэдэн чулуу болон бут өвсийг олж хараад мориноос бууж хөтлийн өөд авирч эхэлжээ. Хөтлийн орой руу нэлээд дөхөн очоод морио чөдөрлөлгүй тушиж орхив. Жан Зи Юань ч гэсэн түүний санааг ойлгон морио тушлаа.

Тэр хоёр буугаа цэнэглэж бариад доош бөхийн толгодын оройг чиглэв. Тэгснээ доош тонгойн чонын бараа харагдтал мөлхлөө. Тэр хоёр чононд зуугаад метр дөхөн очиход сүүл бөгсөн бие нь цухуйн харагдахаас биш, цээж хэвлий зэрэг амин газар нь боролзгонд халхлагдаад асар том шувууны торонд чимээгүй хэвтэх нохой мэт харагдана.

Бат Жан Зи Юань хоёрын түрүүхэн хэвтэж байсан газар хоёр чонын анхаарлыг гойд татаж байгаа бололтой өвсний завсраар тийш харан, хоёр чихээ мөн тэр зүгт сортолзуулна. Гэвч байн байн толгойгоо дээш өлийлгөн агаар шиншлэх нь бусад зүгт ч ихээхэн сонор сэрэмжтэй байгаа нь илт.

Бат Жан Зи Юаньд зүүн талын арай ойрхоныг нь бууд гэж дохиод өөрөө нөгөөг нь онилон шагайв. Салхи хүүгэн үлээхэд боролзгоно найган халиурч чонын биеийг бүрэн халхаллаа. Жан Зи Юань өрөөсөн нүдээ аних агшинд чоно харагдахаа болив.

Тэр хоёр салхи намжихыг хүлээж байлаа. Өөрийнх нь буу дуугарах агшинд гохоо дараарай гэж Бат Жан Зи Юаньд байн байн сануулж байсан билээ. Өөрөө онохгүй байсан ч Бат алдалгүй буудчих юм чинь гээд Жан Зи Юань харин ч тайван байжээ. Бат бол аж ахуй даяар алдартай анчин болохоор хоёр зуун метрийн дотор байгаа чоныг алдана гэж үгүй. Олонбулгийн чоно дөрөв, таван зуун метрийн холуур буу үүрчихсэн яваа хүнээс айж зугатдаггүй, харин гурван зуун метр ойртсон тохиолдолд заавал зугатдаг нь Батаас болсон хэрэг гэж олон анчин ярьж байхыг тэр сонсож байсан. Өмнө нь байгаа чононууд хоёр зуун метрийн дотор байгаа болохоор тэр тайван гэгч нь хөдөлгөөнгүй байг шагайн ониллоо.

Салхи намжин, чонын бие боролзгоны цаанаас ил гарч ирэх агшинд зүүн этгээдээс нэгэн сунайсан урт чоно гарч ирээд хэвтэж буй хоёр чонын өмнүүр хөтлийг уруудан гүйлээ. Хоёр чоно ч могойд хатгуулсан мэт ухасхийн босоод толгойгоо унжуулан мөнөөх чонын араас давхицгаав. Саяын түрүүлж гүйдэг чоно бол нөгөө хоёрынхоо ар талыг хамгаалж байсан харуул байсан тул хоёр хүний бараа хараад ийнхүү дохио өгсөн нь тэр ажээ. Харуулд гарсан чоно амаргүй амьтан байснаас гадна, хамгийн том биетэй азарган чоно бололтой. Гурван чоно ойролцоох эгц хөтлийг чиглэн довтолгоцгоов.

Бат ухасхийн босож мориндоо мордоод хоёул жолоо дугтран давирсаар араас нь хөөцгөөлөө. Хөтлийн орой дээр гартал маш эгц налуу тул Жан Зи Юань айсандаа өөрийн эрхгүй жолоогоо татав. “Бүүрэгнээсээ бариад доошил” гэж Бат хашгирчихаад өөрөө огт айсан

шинжгүй, харин ч зориг зүрх нь улам бадрав бололтой гал уснаас халшрахгүй монголын морьтон баатрын эрэмгий төрхийг үзүүлж жолоогоо татасхийн доош уруудлаа.

Жан Зи Юаний толгойд “Эр зоригоо харуулах эсвэл аймхай хулчгараараа дуудуулах нь энэ мөчид шийдэгдэнэ” гэсэн бодол зурсхийж зүрхээ чангалан шүдээ зуугаад морины амыг султ тавив. Уулын уруу давхиулахад тарвага зурамны нүх, үлий гээд юу эс мундах билээ? Тийм болохоор морь унаж яваа хүний хувьд маш цээртэй хэрэг юм. Хэрвээ нэг л бүдрэх юм бол үхдэггүй юм аа гэхэд хүнд бэртэж мэднэ. Гуравдугаар хэсгийн адуучин Жэнь Линь уулын уруу давхиж байгаад морь нь бүдрэн шидэгдэж далны ясаа хугалаад зогсохгүй мориндоо даруулан одоо хэр Бээжинд эмчлүүлж байгаа. Хэрвээ толгойгоороо унасан бол юун Бээжин рүү буцах манатай юм болох байжээ.

Монгол адуучин гэдэг энэ хорвоогийн хамгийн эрэмгий зориг шаардсан мэргэжил болохоор Жан Зи Юань энэ ажилдаа үнэн голоос дуртай. Монгол адуучид бол энх цагийн дайчид, эрслэн босох дайны цагт баатрууд болон хувирцгаадаг. Монгол эмэгтэйчүүдийн зориг зүрх хятад эрчүүдээс хавьгүй илүү боловч өнөө хэр Олонбулагт ганц эмэгтэй адуучин байхгүй. Тал нутгийн хэдэн зуун мянган жилийн нүүдлийн амьдралын явцад хоёр адуучин адуун сүргээ ээлжлэн адгуулах жишиг тогтсон бөгөөд илгээлтийн эздийг адууны суурьт ажиллуулахаар туршжээ. Хоёр жилийн хугацаанд хоёрдугаар багийн дөрвөн илгээлтийн эздээс нэг адуучин нь шархдан буцаж, нөгөөх нь хүнд хүчрээс шантран өөр ажилд шилжээд үлдсэн хоёр нь өнөө хэр хоёр монгол адуучны туслах хийсээр байгаа билээ. Үлдэж хоцорсон хоёр илгээлтийн эзэн бие дааж адууны суурь хариуцъя гэх нь байтугай тэр талаар бодож ч зүрхэлдэггүй. Жан Зи Юаний тухайд алсдаа жинхэлээд Бат, Лхамжав хоёрын аль нэгтэй цуг нэг сүрэг адуу маллая гэсэн бодол бол бий.

Хоёр жилийн турш хөр цасыг туучин, хөхөө өвлийн жаврыг сөрсөний хүчинд адуу маллах арга ажиллагаанд овоо суралцсан хэдий ч эмнэг хангал сургах, хээрийн нохойг номхотгох зориг зүрх дутсаар байгааг тэр сайн мэднэ. Ав хомрогын үеэр зүрх алдснаас биш, арга техник дутсан хэрэг огт биш юм. Чоно уургалах тэр агшинд зүрх нь пэл пэлхийтэл цохилоод эхэлсэнийг тэр өнөө хэр мартаагүй.

Жан Зи Юань жинхэнэ адуучин болохоор зориг шулуудав. Тэр өөрийн бие дээр Хань, Тан улсын үед хятадын зоригтон баатрууд Хүннүг үлдэн хөөж, Түрэгийг нухчин дарсан ид хав сэргэх нь үү үгүй юу гэдгийг туршиж үзэхээр шийджээ.

Морь нь хөтлийн уруу чавхдах мэт доошлов. Хүн морьд чөлөөт уналтын хурдад ойртох агшинд адууны нуруун дээр тогтохын эцэсгүй ажээ. Тэр урд бүүрэгнээсээ тас зууран, арагш морины хондлойд наалдах шахам цахлаад, хоёр дөрөөг унасан хүлгийн чихэнд тулган жийж, үнэндээ адууны нуруун дээр хэвтснээс өөрцгүй явлаа. Жан Зи Юань эцэстээ хоёр хөлөөрөө урд бүүргийг хавчин авсан бөгөөд энэ агшинд тэр зүрх алдсан бол хамаг хүсэл нь тэнгэрт замхран одох байв. Хэд хоногийн дараа тэр энэ газартаа эргэн очиж явсан замынх нь дагуу зургаа долоон тарвага зурмын нүх байсныг олж үзээд зүрх нь амаар гарах шахсан юмдаг. “Мөнх тэнгэр зоригтой хүнийг таалдаг болохоор тарвага зурамны нүхийг зайлуулсан хэрэг байж таарна” хэмээн Бат ярьж билээ.

Хөтлийн хормойд хүрэх үед тэр Батыг гээг даран нэхэж явлаа. Бат түүн рүү баяртай мишээх

нь алтан медаль хүртээснээс ч илүү үнэ цэнэтэй санагджээ.

Олонбулгийн уургач хурдан хүлгүүд гүйцэхээрээ улам шамддаг, хоцрохоороо хор шар нь буцалдаг зантай юм. Хөтөл уруудахад чоно морьдын зай гуравны нэгээр хорогдсон байх тул улам омогшин, цагаан зээрийн хурдаар цахилж гарах нь тэр. Чоно хөтөл дээр гарахын алдад Бат газрын байдлыг гүйлгэн хараад “Чононууд удахгүй салж зугатах болно шүү. Тэр давжаа биетийг орхичихоод хоёр том чоныг хөөх юм шүү. Удалгүй би аль нэг чоныг буудваас чи урдуур нь барьсхийгээд буудаарай. Эхлээд баруун талынхыг нь буудацгаая” гэхэд хоёулаа буугаа шагайцгаав. Явдал сайтай морины нуруунаас буу шагайхад харин ч амар байдаг юм. Гурван чоно морин төвөргөөн ойртохыг сонсоод толгодын орой өөд амь тэмцэн зугатлаа. Чоно морины гүйдлийг удаан тэсэхгүй тул удахгүй салж дутаана гэдгийг Бат юу эс андах билээ? Хэрвээ тэд салж дутаагаад бууны хараанд жишүүлдэн орж ирвэл буудахад улам амар болох юм.

Чононууд араас нэхэгч улам ойртон ирж буйд маш их бачимдаж салж зугатахаар завдаж байгаа бололтой. Тэгэх аваас нэг морьтон нэг л чонын араас хөөх боломжтой. Тэдэнд гурван зуун метр дөхөн очих үед азарган чонын хоёр талд явсан чоно баруун зүүн тийш салж зугатав. Бат баруун талын том чоныг буудсан боловч оносонгүй. Жан Зи Юань жаахан шагайсхийж байгаад жаахан өмнө талыг нь барин хоёр удаа угсруулан буудахад нэг сум газарт тусан шороо манаргаж, нөгөө нь чулуу онон оч манасхийлгэлээ. Чоно айсандаа зогтуссан боловч сэхээ орон ухасхийх агшинд Батын буу тасхийв. Чоно толгойгоороо газар хатган унахад түүний цээжинд онгойсон нүх гарчээ. Жан Зи Юань баярлан уухай хашгирав. Харин Бат их л харууссан байдалтай “Баларсан юм. Энэ чоныг туламлан өвчиж болохооргүй болжээ” гэв.

Тэр хоёр мориныхоо амыг залан азарган чоныг хөөж эхлэхэд Бат түүнд хандан “Чи буудаад хэрэггүй шүү. Би энэ чоныг аргалъя” гэлээ. Хоёр уургач морь эздийнхээ нэг боохой нудрахыг үзээд их л омогшин толгодын өөд хар эрчээрээ чавхдав. Гэвч хэдэн арван метр давхиад амьсгаадан эрч нь суларч эхлэлээ. Азарган чоно өгсүүр газар өөрийн давуутай эр чадалдаа эрдэн том том харайн улам эрчээ аван хурдлав. Бат, Жан Зи Юань хоёр ташуурдаж давиран шавдуулахад ердийн цагт тэр болгон ташуурын амт үзээд байдаггүй хоёр хурдан хүлэг амнаасаа цагаан хөөс сахруулан хурдаа нэмлээ. Азарган чонын ааг эрч мохох болоогүй бололтой тавиухан хурдлана. Жан Зи Юань доош тонгойн үзвээс чонын сарвууны мөр морьдын харайлтаас хол сунасан байлаа. Азарган чоно толгодын орой тэнгэрийн хаяа хоёрын нийлэх завсар руу улам ойртсоор байв. Хэрвээ толгодыг даван уруудвал анчин эрс дахин түүнийг харна гэдэг худлаа болох юм.

“Мориноос буугаарай” гэж хашгираад Бат морины амыг татан зогсоов. Аливаа уургач морьд эрчээрээ давхиж байгаад огцом зогсох чадвартай байдаг нь энэ удаа ч гэсэн хэргээ гаргажээ. Хоёр морь хэд алхаад зогтусахад унасан эзэд нь урагш шидэгдэн алдаад тогтлоо. Бат ухасхийн үсрэн бууж газар элгэдэн хэвтээд амьсгаагаа түгжин, буугаа шагайж эхлэв. Жан Зи Юань ч гэсэн буугаа барьсан хэвээр газар хэвглээ.

Давхиж явсан азарган чоно араас нэхэх морин туурайн чимээ сонсогдохоо больсоныг үзээд хурдаа сааруулав. Талын чонын хүзүү богино учраас арагш харахын тулд заавал биеэ эргүүлэх хэрэгтэй болдгийн дээр өгсүүр газар хурдалсаар ааг амьсгаадаа багтарсан тул нэхэн хөөгчийн байр байдлыг ажингаа түр амсхийе гэж бодсон бололтой. Тэнгэрийн хаяа толгодын

орой хоёрын уулзварт нэхэн хөөж байсан үеийнхээс гурав дахин том чонын дүрс буудлагын танхимын бай мэт тодрон гарч ирлээ. Ихэнх тохиолдолд азарган чоно анчинд ийм боломж олгодоггүй юм. Харин Бат унасан хүлгээ огцом зогсоосноор чоно анчныг ямар шинэ арга заль хэрэглэх гэж байгааг эргэн харна гэж бодсон нь оножээ.

Батын буун дуу гарах агшинд чоно урагш тонгосхийн үзэгдэхээ байлаа. “Хайран юм. Дэндүү хол болохоор амин газар нь оносонгүй. Гэхдээ холдоогүй байх аа. Хурдан хөөцгөө” гэж Бат хэлээд мориндоо мордон толгодын оройд гарч үзэхэд хэсэг газар тунасан цус байхаас биш чонын бараа туруу ч үзэгдэхгүй болжээ. Дурангаа гаргаж ирээд ийш тийш ажигласан боловч бас л үзэгдэх бараагүй тул цусны ул мөрийг даган шогшуулав. “Хэрвээ нохойгоо аваад ирсэн бол хичнээн сайхан бэ?” гэж Жан Зи Юань шогшроно. Тэр хоёр адуун дээрээс шууд гарч ирсэн болохоор юуных нь нохой байх билээ. Учир нь монгол нохой үхэрчин, хоньчинг дагана уу гэхээс биш, адуучдыг даган явдаггүй юм.

Тэр хоёр доош тонгойн мөр харна гэсээр их л удаан урагшилж байв. “Би чонын урд хөлийг буудсан болохоор гурван хөлийн мөр гарсаныг харж байна уу?” гэж Батын хэлэхэд Жан Зи Юань “Гурван хөлтэй амьтан чинь хэдий хэр хол явж чадах билээ?” гэж хэлэв. Бат цагаа харсанаа “Тийм ч биш шүү хө. Тэр хэрвээ ойролцоо нэгэн чонын үүр олоод хэвтчихвэл чи бид хоёр ухаж гаргана гэж юу байх билээ?” гэв.

Цусан зам нэг хэсэг тодрон, нэг хэсэг баларсаар цаг гаруй явсаны эцэст хэсэг зүлгэн дээр шөрмөс нь унжиж, яс нь язайн харагдах чонын урд хөл хэвтэж байсан нь манай хоёрыг бүр балмагдуулж орхив. “Чоно гүйхэд тээртэй юм гээд урд хөлөө тастаад хаясан байхыг харав уу?” хэмээн Бат хэллээ.

“Жан Зи Юаний зүрхийг чонын урд сарвуу базаад авах шиг санагдахад “Хортой суманд бугалгаа харвуулсан сайн эр гараа тайраад хаяж байсан гэдэг домог байдаг боловч би өөрийн нүдээр хараагүй. Харин шархтай хөлөө тас хазаад хаяж байгаа чоныг би гуравдахь удаагаа харж байна” гэхэд

Бат “Хүн болгон адилгүй бол чоно болгон ижил байдаг юм даа” гэв.

Тэр хоёр цааш мөрдөхөд чонын дуссан цус багасан, алхаа нь улам холдсон шинж илт болов. Чоно цэргийн хориотой бүс болох хил хамгаалалтын засмал замыг чиглэн явсан нь тэр хоёрын санааг ихэд зовоож байлаа. “Энэ их адтай чоно юм гээч, Хоёулаа түүний араас хөөгөөд байж болохгүй нь ээ” гэж Батын хэлэхэд тэр хоёр засмал замын наагуур амдахаар ухасхийцгээв.

Хойшлох тусам өвс улам өтгөрөн халиураад алсаас харахад асар том зэгэл шаргал чонын арьсыг дэлгээд орхисон мэт харагдана. Энэ асар том зэгэл шаргал “Чонын арьсан” дундаас зэгэл шар чоныг хайна гэдэг хураалттай ноосон дунд дарагдсан хургыг олж гаргахаас амаргүй мэт Жан Зи Юаньд санагдаж байлаа. Хүн байгаль дэлхийтэйгээ тэр болгон зохицон амьдарч чаддаггүй бол тал чоно хоёр ус сүү шиг уусан нэгдэж чаддаг ажээ. Нэг муу доголлон чоно тэр хоёрын хамар доогуур гараад явчихаж байхад хоёр том морьтой хүн түүнийг олж харж чаддаггүй байх гэж. Чоно тал нутаг, мөнх тэнгэртэй нарийн шижмээр холбогдсон байдгийг Жан Зи Юань дахин нэг удаа мэдэрлээ. Чонын амь дээсэн дөрөөн дээр дэнжигнэх бүрийд



тал нутаг нь түүний аминд орж хөгшин эм тахиа мэт далавчаа дэлгэн түүнийг энгэртээ бөөцийлдөг. Монголын уудам тал, түүний хөх чоно хоёр мянган он, түмэн жилийн турш сэтгэл хувиршгүй амраг хосууд мэт бие биесээ хайрлан энхрийлсээр ирсэн ажгуу. Тал нутагтаа чононоос илүү хайртай гэдгээ илтгэх хүсэлтэй Монгол хүн тал нутагт чонын эзлэх байр суурийг хүртэх яагаа ч үгүй мэт. Харин ч хятадуудтай хил залгаа нутагт бэлчээр нутгаа хагалан тариа тарьж эхэлсэн монголчууд улам олширсоор байгаа бус уу? Хөлөө хуга буудуулсан чоно багийн хэмжээнд хамгийн хурдан хоёр хүлгийг ардаа орхин ийм урт хугацааны турш давхиад байна гэж бодохоор Жан Зи Юаний ухаан санаанд нэг л багтаж өгөхгүй байв. Түүний хажууд Батаас гадна өөр нэгэн багшийн багш байгаа мэт санагдахын учир ингээд барилгүй алдчихыг яахин хүсэх билээ.

Энэ зуур нэлээд удаан шогшуулсан хоёр морины хүч тэнхээ сэргэн хурдаа нэмж эхлэлээ. Тал нутгийн хил хязгаарыг эмжин хөндөлдөг хойд талын том хөх уул улам бүр ойртсоор. Гүн жалга судаг ихтэй, өвс ургамал тачир, хүйтэн жавартай тэр уул Олонбулгийн чонын найдвартай оромж болдог хэмээн малчид хэлэлцдэг нь оргүй үг биш. Хөөрхий доголлон чоно тэнд очоод яаж шүүхэн амь зуух юм бол доо. Тэр өөрийн хэмжүүрээр чоныг ийн дэнслэн үзэв. Хүн хэзээ нэгэн цагт чоныг ул мөргүй устгаж болох л юм. Гэхдээ хорвоод монгол чонын хатуу зориг, нугаршгүй зан чанарыг эвдэх хүч гэж хаана байх билээ. Хоёр морьтон хил хамгаалах ангийн засмал зам дээр гарч ирэв. Нэрэн дээрээ засмал зам гэж байгаа боловч нэдэр дээрээ хилийн эргүүлийн шалгадаг элсэн зурвас төдийхөн юм л даа. Цэргийн зориулалттай жийп машин болон байлдааны том тэрэгнүүд бараа материал зөөж давхисаар гүн ховил гаргасан нь асар том элсэн шаргал луу эвхрэн хэвтэж байгаа шиг харагддаг. Монголын талын хүүхдийн зулай шиг эмзэг өнгөн төрхийг энэхүү элсэн зам тодоос тод илтгэн харуулна. Зүлэгтэй хөрс хэдийгээр чийгтэй боловч элсэн зам хатаж гандаад, умрын салхи дэгдэнгүүт зуун газрын тэртээ эвхрэн хэвтэх аварга луу дүүлэн босож, хүн морьдыг амьсгаа авч, нүдээ харахын эцэсгүй элсэн шуурга балбаж эхэлдэг.

Мань хоёр элсэн замыг даган зүүн тийш давхихад чонын ул мөр үзэгдсэнгүй. Тэгсээр нэгэн хөтлийг давгал гуч гаруй метрийн тэртээд нэгэн чоно элсэн замын нөгөө талд гарахаар мацаж байгааг олж үзэв. Ердийн цагт ганц үсрээд давах бартаа түүний хувьд амьдралын сүүлчийн давшгүй даваа болон хувирчээ. Доголон чоно дээш мацан гарч чадалгүй доош унахдаа шархаа хөндөн атисхийв.

“Бууцгаая” гэж Бат хэлчихээд замын хажууд үсрэн буув. Жан Зи Юань ч гэсэн мориноос буунгаа Батын үйл хөдлөл болон эмээлээс дүүжилсэн том малиаг ажиглан харж байлаа. Гэвч Бат малиагаа ч авсангүй, урагшаа ч очсонгүй, морио идэшлэг гэсэн шиг зөнд нь орхичихоод замын хажуугийн өндөр ирмэг дээр суун тамхиа асаагаад шунамгай нь аргагүй сорж гарлаа. Жан Зи Юань тамхины утааны цаанаас түүний үймэрсэн харцыг олж харав. Тэр морио сул тавьчихаад Батын дэргэд суун нэг тамхи гуйж аваад тайван сорлоо.

Чоно замын ховилоос арайхийн дээш мацан гараад жишүүхэн оцойн суухад цус нэвчсэн цээжний доохон хэсэгт элс барьцалдсан байх бөгөөд хатан зоригт талын чоно нэхэн хөөгч хоёр дайсныхаа өөдөөс тэргүүнээ омог бардам өргөлөө. Чоно өөрийн хэн болох агаад дадал зуршлыг мартаагүй бололтой биедээ наалдсан элс шороо, хатсан өвс зэргийг хүчлэн сэгсрэх нь байлдааны хувцсаа цэвэр цэмцгэр байлгахыг хичээсэн хэрэг бололтой. Гэвч тэр яс нь

цухуйсан хугархай хөлөө яаж ч чадахгүй байгаа бололтой цээжнийхээ өмнө агийлгачихаад дагжин чичирнэ. Гэсэн атлаа чонын шийдэмгий зориг төгс догшин ширүүн харц мохоогүй, амьсгалын тоо бүр нь эрслэн тэмцэх эцсийн хүчийг хурааж байх ажээ. Энэхүү буурал талд, өөрөөр хэлбэл тал нутгийн байр суурин дээр зогсох аваас шудрага журам хэмээгч чухам л чонын талд байгаа мэт санагдсан тул Жан Зи Юань өөрийн эрхгүй харц далдирав. . . . .

Бат тамхиа барьсан чигтээ чоныг бодлогошрон ширтэхэд харцанд нь багшийгаа шархдуулсан шавийн эмзэглэл шаналал тодорно. Гурван хөлт чоно араас нэхэн хөөгч гар хөдөлгөх шинжгүйг үзээд цааш эргэн өрөөсөн сарвуугаар замын хажуу ирмэгийг малтахад өнгөн хөрсний цаана дөнгөж гуравхан сантиметрийн гүнд элс, шар шавар цухуйн гарч ирэв. Чоно хэсэг өнгөн хөрсийг хуулаад гарсан сэтэрхийг даган, цааш хатуу ширгэн дээр үсрэн гараад имж мэт гурван хөл дээрээ догонцон үсэрсээр тэртээд харагдах түймрээс хамгаалах зурвас болон хилийн баганыг чиглэн одлоо.

Түймрээс хамгаалах зурвасыг жил болгон монголын хилээс орж ирэх хээрийн түймрээс сэргийлэхийн тулд трактороор зуун арван метрийн өргөнтэй хилийн шугамтай зэрэгцүүлэн хагалдаг нь өнөө болоход ямх өвс ургахаа байсан юм. Олонбулгийн малчид үүнтэй их л эвлэрэнгүй ханддаг бөгөөд энэ нутагт ганц ашигтай хагалсан газар гэвэл энэ л байна хэмээн өвгөд настангууд хуучлах дуртай.

Баруун зүгийн салхинд түймрээс хамгаалах зурвасаас боссон шар түйрэн түймрээс ч илүү аймшигтай боловч азаар нарийхан талбайг хамардаг болохоор бас ч танагтай өнгөрдөг.

Доголон чоно амарч гүйсээр өндөр өвсөн дунд бараа нь үзэгдэхгүй болов. Цааш түүний гүйдэлд саад болох зүйл үгүй билээ.

Бат босож хэсэг зуур дуугүй ажиглан харж байснаа доош тонгойн Жан Зи Юаний хаясан тамхины ишийг авч шүлсдэн унтраагаад өөрийнхтэйгөө нийлүүлэн чийгтэй газар ухсан нүхэнд хийж шороогоор булав. “Тал нутагт түймрээс сэргийлж явах хэрэгтэй шүү” хэмээн түүнд анхааруулаад “Явцгаая. Нөгөө чоноо очиж авъя” гэв.

Тэр хоёр мориндоо мордон шүүр өвстэй хөтлийг чиглэн дуу шуугүй довтолгоцгоолоо.

## Арван зургаа

*Хунтайз Чэнь Цян дуу хөгжим өнгөнд дуртай бөгөөд ан гөрөө хийх бахтай бөлгөө. . . .Бас түрэг үг болон хувцас заслыг нь дууриах дуртайн учир, дагагсад дотроос түрэгчүүдтэй төсөөтэй төрсөнийг сонгож таван хүнээр нэг бүлэг болгон гэзэг гөрж, нэхий дээл өмсгөн хонь хариулуулж, таван чонын толгойтой их туг болон далбаа хийж, эсгий гэр барин хунтайз өөрөө суугаад хонь барьж авчран махыг нь чанаад зүүсэн хутгаа сугалан мах огтлон идмүй. Бас дагагсаддаа “Би Түрэг хааны үхэхийг дууриасугай, харин та нар түрэгийн бэлбэсрэлийн ёслолыг үйлдсүгэй” хэмээгээд газар дээр тэрийн хэвтсэнд бүгдээрээ дуу талбин уйлсаар морь унан тойрон явж, түүний биеийг хармуй. . . . Хунтайз өгүүллрүүн “Нэгэн өдөр төр бариваас хэдэн түмээр нь морьт цэрэг дагуулан Алтан хотын баруунаа хүрч авлаад, дараа нь гэзгээ талбин түрэг болсугай. . . ” хэмээжэй.*

*Сы Ма Гуан “Засагт туслах нэвтэрхий толь”*

Хаврын бороо өнгөрсөний дараа хаваржааны ойролцоох энгэр нөмөр болон нуга дэвхээ газрууд нарны илчинд эврээд өтөг бууцны үнэр ханхална. Өвлийн хүйтэнд хөлдөж үхсэн болон хээрийн нохойд бариулсан амьтны сэг зэм, хатсан өвс ногоо, энд тэнд хөглөрөх аргал, хоргол, хомоол, чоно, нохой, туулай тарвага зэргийн баас цасны усанд дэвтэн хар хүрэн бордоо болон хувираад тал нутгийн хөрсөнд шингэнэ.

Эртний буурал тал нутаг энэхүү агаараар амьсгалж амьдарч буйн учир хаврын хаварт дээш дэгдэх өтөг бууцны үнэрт Чэнь Жэнь тэгтэл аягүйрхээд байдаггүй билээ. Хүн адгуусны ялгадас, хүмүүн чоно хоёрын тулалдах явцад үлдсэн илжирч муудсан мах, хатсан цус, өгөр яс зэрэг нь тачир нимгэн хөрсний хувьд юугаар ч орлуулшгүй ялзмаг, органик бодис, мөн кальци, фосфорын бордоо болон хувирч доош шингэж байдаг юм. “Хотоос шалгалтаас ирсэн дарга нар болон яруу найрагчид хээр талын хаврын цэцгийн үнэрт дурладаг бол би харин өтөг бууцны үнэрт дуртай. Нэг хонь дунджаар долоон зуун тавин килограмм өтгөн шингэн ялгаруулдаг нь өвсний ургацад хичнээн тустай байх билээ. Аргал сэрүүн, хомоол халуун чанартай, хоргол хоёр жил илчээ хадгалдаг ч гэж ярьдаг. Хэрвээ малын тоо толгойг зөв зохицуулаад байвал үхэр хоньд бэлчээр сүйтгэхгүй харин ч эргээд бэлчээрийн нөхөн сэргэлтэд тустай. Эртний овог аймгийн сайн удирдагч нар элсэрхэг газрыг үржил шимтэй болгон хувиргадаг байжээ” хэмээн Өлзий дарга ярьдаг.

Хавар цагийн Олонбулгийн тал ийнхүү ус бордоогоор хангалттай болохоор өвс ногоо ургана гэж ёстой үзүүлээд өгнө. Хагас сар үргэлжлэх нарны бүлээн илчинд талын зоо тэнийн, нуга энгэр тэр аяараа ногоон өмсгөлөө өмсөв. Хаврын өвс ногооны иш үржилт хөрснөөс цухуйн талын тачир өнгөн хөрсийг бөхлөснөөр түүний доорх говь цөлийн элс шаврыг өөд нар үзэхээргүй болгоно. Чэнь Жэнь Билиг өвгөний шарга морийг унан хаврын ногоог бахдан харсан шиг зөөлөн хагируулах зуур өргөн уудам талын энд өрнөх хүн чоно хоёрын хатуу ширүүн өрсөлдөөн нь эцсийн эцэст эх болсон талын нэгэн салшгүй амин лугшилт болж байдгийг мэдрэв.

Хонь ямаад дэлэгнэн, хурга ишигний үс гялалзаад, үхэр малын дуу хүнгэнэж, агт морьдын үс гуужжээ. Ийнхүү тал нутгийн мал сүрэг өвс бэлчээрийн өмсгөл шинэчлэгдэхийг дагалдан өнгө зүс засдаг билээ. Олонбулгийн талд хаа сайгүй нялх төлийн дуу цангинана. Өнөө

жилийн хаврын хахир хагууд цөөнгүй төлийн гарзтай байсан боловч эцсийн дүндээ төл хүлээн авалт зуун нэгэн хувьтай гарчээ. Учир нь өнөө жил санаанд оромгүй олон эм хонь ихэрлэж, суурь болгон мянга давсан хурга ишиг хүлээн авав. Ингэснээр өнөр баян Олонбулгийн тал бэлчээрийн даац хэтрэх асуудалтай тулгарлаа. Хэрвээ өвс бэлчээрийн даац, малын тоо толгойн тэнцвэрийг хадгалах үүднээс малыг улсын хэрэгцээнд тушаах буюу олноор зарах гэхээр малын тоо толгойг өсгөх дээрээс өгсөн даалгавар тасалдах аюул тулгарна. Аж ахуйн удирдлага хэдэн ч удаа энэ талаар хуралдсаны эцэст Өлзий дарга “Энэ асуудлыг шийдэх цорын ганц арга зам бол шинэ ус бэлчээр олж ашиглах явдал юм” гэж үзжээ.

Чэнь Жэнь, Өлзий дарга, Билиг өвгөн нарыг дагалдан шинэ нутаг бэлчээр үзэж хайхаар явав. Өвгөн түүнд өөрийн тарга хүч сайтай морийг унуулжээ. Өлзий хагас автомат буюу үүрч, Билиг өвгөн Барсыг дагуулан гарсан бол Чэнь Жэнь Анч шарыг гэрээ харуулахаар үлдээгээд Арсланг авч явлаа. Анч, нүүдэлчин удмын хүмүүс алс хол гарахдаа буу зэвсэг анч нохдоо авч гарахаа мартдаггүй. Хоёр анч нохой их л баяртай байгаа бололтой энэ тэрүүгээр гүйлдэн шиншлэхэд Чэнь Жэнь ч тэднээс дутуугүй хөгжилтэй байв. “Хоньчин эзэн, хоточ ноход бүгдээрээ сарын турш гэртээ уягдаад уйдаж гүйцээ шив дээ” хэмээн Билиг өвгөн инээн өгүүлэхэд

Чэнь Жэнь “Аав та биднийг авч гардаг нь сайн хэрэг боллоо” гэв.

Өвгөн “Би чамайг ном шагайсаар нүдгүй болох вий гэж санаа зовох юм” гэлээ.

Аж ахуйн төвөөс зүүн хойд зүгт хааш хаашаа гуч дөчин километр үргэлжилсэн аглаг зэлүүд уул байдаг. “Тэр ууланд бүр эртнээс хүн мал нутагладаггүй, их бага горхи нууруудтай, дөрөө шүргэм өндөр өвсийг олон жилийн турш хадаагүй тул ширэлдэж гүйцжээ. Өвс нь соргог, ус нь тунгалаг тэр сайхан нутагт нэг айхгар гэм бий нь шумуул гэж тоймгүй олон, зун намартаа үхэр бариад идчихдэг гэнэ. Аглаг уулын ширэлдсэн өтгөн өвсөнд хөл хүрэнгүүт мина гишгэсэн мэт хэдэн арван түмэн шумуул бүчин гарч ирдэг. Шумуулаас нь айгаад хүн мал тийшээ зүглэдэггүйгээс гадна, хаврын шинэ ногоо хуучин он жилүүдийн ширэлдэж хатсан өвсөн дундаас нарны гэрэл үзэх гэж үйлээ үзсээр урт нарийхан байдаг болохоор мал идээд ч тарга тэвээрэг сайн авдаггүй юм” гэж Өлзий дарга ярив.

Аж ахуйн хашир дарга Өлзий чанар бус тооны хойноос хөөцөлдөж байгаа одоогийн явуургүй бодлогын нөхцөлд эрт орой хэзээ нэгэн цагт Олонбулгийн тал бэлчээрийн даац хэтрэх асуудалтай тулгарна гэдгийг мэдэж байсан тул энэ газрыг нөөгөөд байжээ. Олон жилийн турш энэхүү аглаг уулын бэлчээр түүний санаа бодлыг эзэмдэн, хэзээ нэгэн цагт хээрийн түймэр олон жилийн хур өвсийг шатаачихвал ирэх жил нь нэг багийн бүх малыг бод боггүй тууж оруулаад хэдэн мянган малын туурайгаар газрыг нь сэндчүүлэн, өвсийг хуу хамуулан идүүлвээс хөрс бэхжин үржил шимтэй болж, түүний хэрээр өвс намсан, шумуул устах юм. Тэгээд дахин хэдэн жил өнгөрөхөд тэр газрыг аж ахуйн бүх малын зуслан болгож, хуучин бэлчээрийг хаваржаа намаржааны зориулалтаар ашиглаж болно. Ингэснээр аж ахуйн хэмжээнд малын тоо толгой нэг дахин нэмэгдсэн ч бэлчээрийн даац хэтрэх асуудал нэг хэсэгтээ тулгарахгүй гэж сэтгэлийн мухартаа бодсоор иржээ.

Хэдэн жилийн турш Олонбулгийн талд хээрийн түймэр хэд хэдэн удаа дэгдсэн боловч энэ

аглаг уулыг тойрон өнгөрсөөр ирсэн юм. Харин өнгөрсөн жилийн намар аглаг уулыг хээрийн түймэр дайраад араас нь бороо орсноор тос даасан хар юм болон хоцорчээ. Өлзий дарга Бао Шүнь Гүйгийн дэмжлэгтэйгээр тэр хэсгийн бэлчээрийг ашиглах төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлтэл малчид тэндхийн шумуулаас айгаад зүглэх ч хүсэлгүй байцгаав. Хэрвээ Билиг өвгөн л тэр газрыг болно гэж хоёрдугаар багийн малчидтайгаа цуг ирж суурьших юм бол хамаг хэрэг бүтэх тул өнөөдөр түүнийг дагуулан ус бэлчээр үзэхээр яваа нь энэ юм.

Тэр гурав хөрш багийн өвөлжөөг дайран гарах үед Чэн Жэньгийн морины алхаа удааширсан тул доош тонгойн харвал намрын өвс дөрвөн хуруу хиртэй өтгөн сахлаг хэвээр байлаа. “Та өвс бэлчээр хүрэлцэхгүй байна гээд л байдаг. Гэтэл адуу, хоньд өвөлжин хөлөөрөө малтаж идсэн атал ийм их өвс үлдсэн байна шүү дээ” хэмээн тэр Өлзийд хандан хэлэв.

Өлзий дарга доош тонгойн харсанаа “Наадуул чинь дандаа өвсний гуурс, шилбэ байна. Мал голоод орхичихжээ. Идээд ч шим шүлтгүй болохоор тарга тэвээрэг авдаггүй юм. Идье гээд малтвал үндэстэйгээ сугараад бэлчээр сүйднэ гэсэн үг. . . Дотор газрын хятад хүмүүс олшроод мах өөхний хэрэгцээ ихэссэн тул манай өвөрмонголоос үхэр хонины мах шаардах боллоо. Гэвч нэг тонн мах бэлтгэхийн тулд дал наян тонн өвс хэрэгтэй. Дотор газар биднээс мах шаардахын хэрээр талын өвс ногоо барагдсаар эцэс сүүлдээ амь тавих дээр тулна. Дээрээс хэт шахуу үүрэг даалгавар өгсөний гор гарч зүүн өмнөд хэдэн хошууны нутаг бэлчээр цөлжиж гүйцсэн байдаг шүү. ” хэмээн өгүүлэв.

“Миний санахад мал аж ахуй газар тариалангаас илүү нарийн арга ажиллагаа шаарддаг юм шиг” гэж Чэнь Жэнь хэлэхэд

Өлзий дарга өгүүллрүүн “Би ч хувьдаа нутаг бэлчээрээ цөлжих вий гэж үнэхээр их санаа зовох юм. Тал нутаг маш эмзгээс гадна ямаа, адуу, царцаа, оготно, туулай, тарвага, зээр, тариачин, атар хагалах, хүн ам олшрох, хүнийрхүү хандлага, бэлчээрийн даац хэтрэх зэрэг сөрөг хүчин зүйлүүд маш их байдаг. Тэр дундаа мал аж ахуй мэддэггүй хүн удирдахаар хүрч ирэх л хамгаас халтай даа” гэв.

Билиг өвгөн толгой дохиж “Тал бол том амь атлаа хүний нүдний цэцгийнээс эмзэг байдаг юм. Хэрвээ талын хөрсийг хуулаад хаячихвал сохроод цасан шуурганаас айхтар шар түйрэн тавиад эхлэнэ гэсэн үг. Тал нутаг тэр чигээрээ сүйрч, үхэр мал, хүн, чонын жижиг амь оршин тогтнох аргагүй болохын цагт цагаан хэрэм Бээжинд ч аюул тулгарах болно доо” гэв.

Өлзий сэтгэл түгшсэн байдалтай “Урьд би хэдэн жил болоод Хөххот руу хуралд очдог байсан юм. Тэндхийн тал айхтар цөлжөөд баруун талын цагаан хэрмийн хэдэн зуун километр тасархай бүгд элсэнд булагдсан байна лээ. Дээрээс зүүн хэсгийн тал нутагт шахуу үүрэг өгөөд эхэлбэл тэр хавийн цагаан хэрэмд ч аюул тулгарна гэсэн үг. Умард хөршийн засгийн газар аль газар ямар төрлийн хэдэн тоо толгойтой мал бэлчээх зэрэг тал дээр маш хатуу чанга хуультай байдаг юм гэдэг шүү. Тэглээ гээд үлдсэн жаахан тал нутгийг цөлжилтөөс хамгаална уу гэхээс биш, нэгэнт цөлжсөн газрыг дахин нөхөн сэргээнэ гэдэг ч хүндхэн хэрэг байх аа” гэв.

Билиг өвгөн өгүүллрүүн “Хүний шунал ихдээд дөргүй бух шиг тэнэг улс олширсон цагт хичнээн учир зүй яриад нэмэргүй. Тэнгэр тийм тэнэг улсуудыг гэсгээж чоноор бэлчээрийн

даацыг тэнцвэржүүлж байдаг юм” гэхэд

Өлзий дарга толгой сэгсрээд “Тэнгэрийн хууль ч сүр хүчээ алдаад байна шүү. Одоо хятад улс атомын бөмбөгтэй болсон болохоор дээрээс чоныг устга гээд тушаавал хурдан шийдчихэж мэднэ” гэлээ.

Чэнь Жэньгийн сэтгэлд шороон шуурга хуйсагнах шиг болж “Би хэдэн ч өдөр чонын улиан, нохойн хуцахыг сонссонгүй. Аав аа, та чоныг айлгаснаас болоод манай үүгээр үзэгдэхээ байчихаа юу даа? Тал нутаг чоногүй болчихоор нэг л эль хуль юм шиг болчихлоо” гэв.

“Гучин чоно алсан гэдэг чинь дөрөв таван үүрний бэлтрэгтэй тэнцэнэ. Олонбулгийн чоно элбэг хэвээрээ байгаа. Тэд ав хомрогоноос айсан хэрэг биш, харин өөр амжуулах ажил байж таарна” хэмээн Билиг өвгөн хэлэв.

Чэнь Жэньгийн сэтгэл сэргэж “Тэд ямар ажил амжуулж байгаа хэрэг вэ?” хэмээн асуулаа.

Өвгөн тэртээд байх нэгэн толгодыг заагаад “Цөмөөрөө тийшээ очиж үзэцгээе” гээд Чэнь Жэньгийн морийг ташуурдаж “Хурдан давхиарай. Хаврын морийг сайн хөлөргөвөл үс нь хурдан гуужаад тарга тэвээрэг сайн авдаг юм” гэлээ.

Тэр гурав толгодын орой өөд хар эрчээрээ давхилдахад, морьдын туурай хэдэн зуун нялх ногоог үндэстэй нь булгалан хаяхдаа шим шүүсэнд нь будагдав. Ашгүй энэ замаар дахин хэдэн сарын турш өөр морьд ирэхгүй нь яамай даа. Чэнь Жэнь сүүлдэсхийн явахдаа “Тал нутаг адуун сүргээс айдаг” гэсэн үг ямар жинтэй болохыг ойлгож авав. Монголчууд гэж үнэхээр зөрчлийн эргүүлгэн дунд амьдрах юм даа.

Гурван морьтон толгодын орой дээр гарахад энд тэндгүй тарвага хошгорох дуу сонсогдоно. Тарвага бол тал нутгийн уугуул амьтдын нэг бөгөөд Олонбулгийн уул толгодын талаас илүүд нь тарваганы нүх тааралддаг. Жил бүрийн намар Чэнь Жэнь өвгөн анчны агнасан тарваганы өөхтэй тарган махыг иднэ. Тарвага нь ойн хүрэн баавгай адил зузаан өөхөндөө дулдуйдан өвөл ичдэг амьтан юм. Тарваганы мах тал нутгийн бусад амьтдынхаас өвөрмөц, өөх мах алагласан, шивтэргүй тул үхэр хонины махнаас илүү амттай зөөлөн, тал нутгийн тансаг амттаны нэгд тооцогддог. Нэг тарвага том халуун савнаас арай томхон биетэй боловч түмпэн дүүрэн махтай байх учраас нэг айлынхан хувааж идэхэд өлхөн хүрдэг.

Чэнь Жэнь нүдний өмнө ярайх олон тарвагануудыг хараад алмайрч орхив. Арван хэдэн сундалсан гүвээ толгодын энгээр жар далаас цөөнгүй том жижиг тарвага оцойн зогсох нь модны хожуул шиг үзэгдэнэ. Тарваганы нүх түүнээс ч олон бөгөөд ширээний тавцангийн хиртэй газрын өвсийг шороо чулуугаар дарж орхижээ. Бусдаас том тарваганы дошин дээр хүрэн шаргал үстэй бурхи ганцаараа эзэгнэн зогсоход түүнээс арай жижиг буюу бөөгнөрсөн дошин дээр чонынх шиг зэгэл шаргал үстэй нагайнууд хошгорно. Нагайнуудын ойр хавиар туулай мэт жижигхэн толгойтой мөндөл зургаа долоогоороо гүйлдэж байлаа. Тарваганууд хүний бараа харчихаад үүрэндээ орохыг яарахгүй хойд хоёр хөл дээрээ оцойн суучихаад чанга чанга дуугаар хошгироход мөгжгор сүүлнүүд нь оцго оцго хийх нь сүрийг үзүүлэн эсэргүүцэж байгаа эсвэл өдөж байгаагийн алин болохыг бүү мэд.

Хоёр нохой нүхнээсээ нэлээд холдсон нэгэн тарган бурхи руу дайран очиход цаадхи нь ойролцоох дошин дээр гүйн хүрч туулай нүдээрээ харж байснаа нохдыг тав зургаан метрийн зайд ирэх агшинд яарамгүй дотогш шурган орж нуугдав. Тэгээд нохдыг арван хэдэн метрийн зайд очих агшинд гарч ирээд доогтой хошгирно.

“Энэ бол манай Олонбулгийн хамгийн олон тарвагатай газар байгаа юм. Тоо толгойг нь барагцаалах аргагүй. Умард хилийн засмал замын урд биеэр үүнээс ч их тарвагатай нэг газар байдаг. Урьд энэ уул ядуусын аминд ордог газар байж билээ. Намар тарваганы тарга тэвээрэг гүйцэхээр ядуус энд ирж хавх, урхи тавин тарваганы мах идэж, арьсыг нь арилжин мөнгө, хонины махаар солино. Танай хятадууд тарваган хүрмэнд дуртай тул намар болгон Жанчхүүгийн наймаачид тал нутагт хүрэлцэн ирээд тарваганы арьс цагаан мөөг авдаг. Тэр цагт тарваганы арьс хурганы арьснаас гурав дахин илүү үнэтэй тул олон ядуусын аминд орсон доо хөөрхий. Эзэн Чингис хаан хүртэл тартагтаа тулсан үедээ тарваганы махаар гол зогоож байсан юм гэдэг шүү” хэмээн Билиг өвгөн ярьлаа.

Өлзий өгүүлрүүн “Тарваганы өөх ч мөн амттай шүү. Тал нутгийн зурам, үен, солонго зэрэг амьтад ичээндээ өвс нөөцөлдөг бол тарвага зөвхөн өөхөндөө дулдуйдан өвлийг ичиж өнгөрөөдөг” гэв.

Билиг өвгөн “Тарвага өвөлжин үүрэндээ байсан болохоор хамаг таргаа гэсэн байгаа. Харин хар мах нь хэвээрээ байж таарна. Энэ хавар өвсний гарц сайн байгаа болохоор хэд хоноод л сайн махалж гүйцэх бололтой” хэмээн өгүүлэв.

Чэнь Жэнь гэнэт ухаараад “Ойрдоо чоно манай тэрүүгээр үймүүлэхгүй байсан нь тарвага гарсантай холбоотой юм бий. Гэхдээ тарваганы нүх ийм гүн, дээр нь нүхнээсээ холддоггүй байтал тэд яаж барьж идэж чаддаг юм бол оо?” хэмээн асуулаа.

Өвгөн инээд алдаад “Чоно тарвага барихдаа ч адтай шүү. Нэг том чоно үүрийг нь өргөсгөн ухаад өөр хэдэн чоно бусад нүхийг нь манаж байгаад нэг бүл тарвагыг бариад идчихдэг юм. Эсвэл арай давжаа биетэй нэгийгээ үүрэнд нь оруулан мөндөл зуулгаад ч гараад ирэх нь бий. Хярс бас үүрэнд нь шурган ороод тарвага барьчихдаг. Би жил болгон тарваганд явахдаа зургаа долоон хярс хавхаар барьдаг. Бас нэг удаа тарваганы үүрний ойролцоо нэг залуу чоныг хавхаар барьсан юм даг. Монголчуудын хүүхдийг чонын үүрэнд оруулан бэлтрэг суйлдаг нь үнэн хэрэг дээрээ чоно хярснаас сурсан чадвар юм шүү дээ. Тарваганы нүх гүехэн бол өвөл даарна. Тийм болохоор тарваганы нүх хэдэн алд гүн байдаг юм” гэснээ “Ингэхэд чоно өвөл үүрэнд амьдардаггүй хэр нь яагаад түүний нүх тийм гүн байдгийн учрыг чи мэдэх үү?” хэмээн асуухад Чэнь Жэнь толгой сэгсрэв.

Өвгөн өгүүлрүүн “Олонх өлөгчин чоно тарваганы үүрийг өргөсгөн ухаад бэлтрэгээ төрүүлдэг юм” гэлээ.

Чэнь Жэнь давхийн цочиж “Чоно үнэхээр хорон муухай амьтан юм аа. Нэг бүл тарвагыг идчихээд үүрийг нь өөрийн болгон эзэгнэдэг байна шүү” гэв.

Өлзий чонын адтайг үнэн голоосоо бахадсан байртай тас тас хөхөрсөнөө Чэнь Жэнь рүү хараад “Чоно тийм л хорон байхгүй бол тарвагыг яахин захирч чадах билээ. Чоно тарвага

иддэг нь тал нутагтаа том гавьяа байгуулж байгаа юм шүү. Тарвага чинь тал хөндийг там болтол нүхлэдгийг чи бэлээхэн харж байгаа биз дээ? Дээр нь жилд зургаа долоон мөндөл гаргадаг болохоор том нүх ухах хэрэгтэй. Тэр хэрээр хичнээн чулуу шороогоор бэлчээрийн өвсийг дарж сүйдлэх билээ. Оготно, туулай, тарвага, зурам дөрөв тал нутагт хамгаас халтай амьтад байдаг юм. Тэр дундаа тарвага гуравдугаарт орох болов уу. Тарвага удаан гүйдэлтэй болохоор хүн ч гэсэн хөөвөл гүйцчихнэ. Гэсэн атлаа яагаад хавх тавьдаг гэж бодно вэ? Тарвага нүх олонтой, тэдгээр нь хоорондоо холбоотой байдаг болохоор хүний бараа харахаараа аль ойр дөт нэгэн рүү шургаад орчихдог. Дээр нь идэш гэж дийлдэхгүй, намар болохоор гол төлөв өвсний үрийг иддэг. Жилдээ хэдэн мүй газрын өвсийг идэж байж сая өвлийг өнтэй давах тарга тэвээрэг авна. Тарваганы нүх бүр ч халтай болохоор адуучдын зүрхэнд орж гүйцсэн. Жил болгон хичнээн морь түүнд бүдрэн хөлөө хугалж, тэр хэрээр хэдэн адуучин гэмтдэг бол доо” гэлээ.

“Тэгвэл чоно тарвагыг алж устгаснаар тал нутгийнхаа өмнө үнэхээр гавьяатай амьтан юм байна шүү” гэж Чэнь Жэнь хэллээ.

Өлзий залгуулан өгүүлрүүн “Тарваганы үүрний гай ганцаар дуусахгүй ээ. Шумуул түүнд орж өвөлждөг юм. Монголын дорнод бүсийн шумуул дэлхийд зартай. Зүүн хойд нутгийн ойн шумуул хүн барьдаг, дорнод талын шумуул үхэр иддэг гэсэн үг бий шүү. Зуд турхан, хар зуд жил болгон тохиогоод байдаггүй л дээ. Харин шумуул жил өнжихгүй гарч ирдэг. Мал малчин хоёрт чононоос илүү шумуул тун халтай. Жилийн хугацаанд шумуул үхэр хоньдын тарга тэвээргийн гуч дөчин хувийг сорж авдаг. Монголын талын өвөл цагийн гучин дөчин хэмийн хүйтэнд гунан үхрийн эвэр тас хөлддөг байтал шумуул яаж тэсэх билээ? Гол нь тарваганы үүрэнд л хамаг учир байгаа юм. Цаг хүйтрэхээр тарвага шумуул хоёр нэг үүрэнд зэрэг иччихнэ. Тарвага хэдэн алд гүн нүх ухаад түүнийгээ битүүлчихээр гадаа цас мөсний жавар тачигнаж байлаа ч гэсэн дотор пүнхийсэн дулаахан байдаг. Тарвага нүхнийхээ мухарт ууж идэх юмгүй дугжирч байхад шумуул тарваганы цусыг сорсон шиг дулаахан өвөлжинө. Цас гэсэж хавар болохоор тарвага шумуул хоёр зэрэг үүрнээсээ гардаг. Манай Олонбулагт нуур цөөрөм элбэг болохоор шумуул тэнд үржиж олширсоор зун гэхэд шумуулын диваажин болон хувирна. . . . Тийм болохоор тарвага бол мал аж ахуйд ихээхэн хөнөөлтэй амьтан мөн байгаа биз? Чоно тарваганы маханд дуртай болохоор түүнийг алж устгах гол хүч болдог юм. “Тарвага нүхнээс гарахаар чонын бараа тасардаг” гэсэн хуучны үг бий. Тарвага гарч ирсэнээр мал сүрэг нэг хэсэгтээ санаа амар бэлчих боломжтой болдог. ” гэв.

Чэнь Жэнь хоёр жилийн турш шумууланд бариулж гүйцсэн болохоор энэ тухай сонсоод хамаг бие нь хорсож загатнаад, арьс махаа урж шалбалж байсан нь санаанд оров. Илгээлтийн эзэд нээрэн ч чононоос илүү шумуулаас их айдаг. Хожим Бээжингээс шумуулын тор ирүүлсний хүчинд санаа амар унтаж чаддаг болсон билээ. Малчид түүний хэрэглэдэг шумуулын торыг шохоорхоно гэж жигтэйхэн тул, хойтон жилийн зун гэхэд айл болгон тийм тортой болоод “Ялааны гэр” хэмээн нэрлэжээ.

Чэнь Жэнь тал нутгийн аймшигт шумуул тарваганы үүрэнд өвөлждөг гэж үнэхээр санаагүй юм. Тэр Өлзийд хандан “Та хоёр ч үнэхээр тал нутгийн мэргэжилтэнгүүд юм аа. Тарваганы нүх шумуулын оромж болж, харин чоно тэдний эрлэг болдог тухай ямар ч номон дээр байдаггүй шүү дээ. . . . .” гэж хэлэв.



Өлзий хариуд нь “Тал нутаг олон шижмээр холбогдсон нарийн бүтэцтэй шүү. Харин чоно гэдэг том учиг бүх сэжмийг зангидаж байдаг. Энэ том учгийг гэмтээх юм бол тал нутгийн мал аж ахуй өнгөрлөө гэсэн үг. Чоно тал нутгийн мал аж ахуйд тоо томшгүй тустай үйлийг бүтээдэг нь түүний балгаас хавьгүй илүү гарна” гэхэд

Билиг өвгөн ч инээд алдаад “Тарвага ч бас ашиггүй амьтан биш ээ. Түүний арьс, мах, өөх тос үнэт түүхий эд болохоор малчдын чухал ашиг орлогын эх үүсвэр болдог. Манай улс тэр бүгдээр гадаадаас машин тэрэг, их буу хүртэл арилжиж авдаг гээ биз дээ. Чоно ухаантай амьтан болохоор тарвагыг ор мөргүй идэж дуусгадаггүй, хойтон жилээ бодон үлдээж байдгаас гадна хүн ч гэсэн томыг нь агнаад жижиг мөндлүүдэд гар хүрдэггүй” гэв.

Гурван морьтон ширүүхэн хатирахад зарим зоригтой тарваганууд араас нь хошгирсоор хоцорлоо. Талын бүргэд тэдний дээрээс шунган дайрах боловч хоосон буцаж харагдана. Зүүн хойд зүг рүү явах тусам хүн амьтны хөл татраад худгийн амсар байтугай адууны хомоол ч үзэгдэхээ байлаа.

\* \* \*

Тэр гурав нэгэн довцгийн оройд гарч үзвээс алсад хэдэн ногоорон харагдах уулын бараа үзэгдэв. Зам зуурт тааралдах уул даваанууд хэдийгээр хаврын гоёлоо өмссөн боловч ногоон шар өнгө холилдон байж билээ. Харин тэртээ алсад ногоорох уулс үлгэрийн сэдэвт жүжгийн тайз засал мэт үзэсгэлэнтэй дурайн харагдана. Өлзий ташуураа өргөн “Хэрвээ өнгөрсөн жил энд ирсэн бол харлаж харагдах байсан юм. Харин өнөө жил өнгө засаад ногоон торгон тэрлэгээ өмссөн байгаа биз дээ?” гэв. Гурван морьтон ногоон уулсын зүг ширүүхэн хатируулж гарав.

Тэд хоёр хөтлийг даваад нов ногоон толгод дээр гарч ирэв. Толгодыг бүрхсэн нялх ногоонд хуучин оны бог өвс холилдоогүй болохоор тарианы намхан чих мэт анхилуун үнэр ханхлуулна. Билиг өвгөн хэсэг үнэрлэж үзсэнээ нэг л биш санагдахад доош тонгойн нарийвчлан ажиглаж эхлэлээ. Хоёр нохой ч ангийн үнэр авсан бололтой энэ тэрүүгээр шиншлэн гүйж эхлэв. Өвгөн доош тонгойн морин туурайн хажуугаарх төө шахам урт нялх ногоог ажиглав.

Өвгөн толгой өргөн “Та нар үнэрлээд үз дээ” гэв. Чэнь Жэнь урт амьсгаа аван үнэрлэхэд намар морин хадуураар өвс хадахад ханхалдаг үнэр сэнхийх шиг болов. “Хэн нэгэн хүн энд ирж өвс хадсан юм биш биз дээ? Хэн наашаа өвс хадахаар ирдэг билээ?” хэмээн асуулаа.

Өвгөн мориноосоо буюгаад урт малиагаар өвс яран нэг юм хайж эхлэв. Удаж төдөлгүй өвсөн дундаас шар ногоон өнгийн нэг зүйл олж аваад хуруугаараа имрэн үнэрлэж үзсэнээ “Энэ бол зээрийн баас байна. Саяхан энд хэсэг зээр бэлчиж байжээ” гэхэд Өлзий Чэнь Жэнь хоёр ч мориноосоо бууж өвгөний гар дахь зээрийн баасыг барьж үзэв. Хавар зээрийн баас хорголорхуу биш, нялцгайдуу бөөн юм байдаг ажээ. Мань хоёр ихэд гайхан энэ тэрүүгээр явж үзвээс хэсэг бусаг талбайн өвсийг хадуураар хяргасан мэт идэж орхижээ.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Би өнөө жил хаваржааны хавиар ерөөсөө зээр хараагүй юм. Гэтэл энэ хавиар өвсний сайныг сорчилж байж шүү. Зээр ч бэлчээрийн өвсийг хяргаад хаячихдаг

амьтан ажээ” гэлээ.

Өлзий буугаа сумлаад намуухан дуугаар “Жил болгон цагаан зээр хаваржааны өвсийг хонь малтай булаалдан идээд байдаг атлаа өнөө жил үзэгдэхээ байсан нь эндхийн өвсийг сорчилж байсан хэрэг байх нь ээ. Яг надтай адилхан бодсон байна шүү” гэв.

Билиг өвгөн жоохойтол инээж “Зээр ч өвсний соргогийг анддаггүй амьтан даа. Зээрийн сорчилсон бэлчээрт хүн мал ирэхгүй бол хайран юм болно. Та ч энэ удаа оножээ” хэмээн хэлэв.

“Энэ юу ч биш ээ, та тэндхийн усыг юу гэж бодно гээч” гэж Өлзий дарга хэллээ.

Чэнь Жэнь санаа зовнисон байдалтай “Одоо төл мал нялх байгаа болохоор хол замын аяыг даахгүй. Тэднийг хөрвөжиж гүйцэхийг хүлээгээд сар гаруй болох хооронд эндхийн өвсийг зээр идээд барчих биш үү?” гэхэд

“Санаа зоволтгүй ээ. Чоно гэж хүнээс ухаалаг амьтан эднийг юу боллоо гэж зүгээр орхих билээ. Одоо зээр хараахан төллөж гүйцээгүй болохоор хээлтэй шаргачин нялх янзага хоёр хурдан давхиж чаддаггүй болохоор чонын хувьд хамгийн ашигтай үе байдаг юм. Хэд хонолгүй чонон сүрэг тэднийг эндээс хөөгөөд явуулах болно” гэж Билиг өвгөн тайван өгүүлэв.

“Өнөө жил зээр бэлчээр нутаг булаацалдахгүй, чоно хонь мал руу халдахгүй болохоор төл бойжилт гайхалтай сайн байхаас өөр яах билээ” гэж Өлзий дарга хэллээ.

Чэнь Жэнь чоно гэхийг дуулаад нөгөө хоёрыгоо мориндоо мордохыг шавдуулав. Гурван морьтон нэгэн намхан хөтлийг давсаны дараа “Өмнө харагдах давааг өнгөрөөд том тал угтана. Тэнд чоно зээрийн аль аль нь байж мэдэх тул сэрэмжтэй яваарай” гэж Өлзий нөгөө хоёртоо сануулав.

Давааны орой дөхөхийн алдад гурвуул бууж, морио хөтлөн доош тонгойж нохойгоо хүзүүдээд уулын оройд байх хэдэн үхэр чулууг бараадан очигцоов. Хоёр том нохой ангийн үнэр авсан бололтой эзнийгээ бараадан навгайн явцгаана. Үхэр чулууны дэргэд тэр гурав морьдоо тушчихаад бул чулууны дорх өвсөн дунд хэвгэн шинэ бэлчээр нутгийн байдлыг дурандан ажиглав.

Чэнь Жэнь энэхүү хятадын хувьд магадгүй хамгийн сүүлчийн атар онгон тал байж мэдэх бэлчээр нутгийн байгалийн үзэмжийг хараад амьсгаа дээрдэн бахдаж, өөрийн зүүд нойрондоо мөрөөдөж явдаг Донын хасгуудын уудам талыг хүртэл ор тас мартаж орхилоо. Энэхүү хөдөө талын үзэсгэлэн түүний тархи толгойноос чонын тухай бодлыг ч үргээн хөөжээ.

Нүдний өмнө хоёр хөлтний мөр тамгалаагүй хэдэн арван километр үргэлжилсэн уудам нам дор газар ногоорон харагдана. Хотгорын зүүн хэсгийн үелсэн намхан аараг толгодууд үргэлжилсээр Их Хянганы нурууны хормойг чиглэн оджээ. Алсад номин, хөх, хүрэн уулс хөшиглөн сунайсаар гал улаан тэнгэрийн хаяа үүлсийн давалгаа лугаа сүлэлдэнэ. Хотгорын өмнө, умар, баруун этгээдийн налуу хэвгий гурван талаар хүрээлэх өндөр уул нуруудын

хормойтой залгалджээ. Тэнгэрийн нэхсэн нов ногоон хивсийг цэнхэр, цагаан, шар, улаан цэцгэн хээ чимнэ.

Хотгорын зүүн өмнөд сугаас нэгэн жижиг гол эх авч, могой мэт мушгиралдан талын энг эмжин урсжээ. Цалин туяа цацруулан мяралзах жижиг голын ус мөнгөн ээмэг, бугуйвч, сондор зэргээс бүрдсэн инж бэлэг эсвэл тал нутагт богтлогдон ирсэн аглаг ойн гоо монгол бүсгүй хадмын гэр рүү яаралгүй, талын үзэмжид автаад, цэцэг түүн явсан мөр мөшгөөрлөн үлдсэн мэт ажгуу. Жижиг гол ийнхүү тахирлан урссаар эцэстээ талын зүрхэнд орших тэнгэрийн өнгөт нууранд цутгажээ. Нуурын тунгалаг мандалд хөвөн цагаан үүлс зүсээ тольдоно.

Тэр бол Чэнь Жэньгийн зүүд нойрондоо ч төсөөлж байгаагүй хунт нуур байлаа. Өргөн нуурын мандалд арван хэдэн нүд гялбам цагаахан хун өтгөн зэгсээр хүрээлэгдсэн их усны голд тааваар хөвж, орчлонгийн дундахь энэхүү тэнгэрийн орны амар жаргалыг эдлэн буй нь дурангийн хараанд тодхон үзэгдэв. Хунгуудын эргэн тойронд хэдэн зуу, мянгаар тоологдох галуу, нугас болон бусад нэрийг нь үл мэдэх усны шувууд хуран чуулжээ. Тав зургаан хун шувууд дэрхийн нисэхэд бусад шувуудын чуулган дагаж хөөрөөд нуурын мандал дээгүүр шаагилдах нь шинэ бэрийг угтах хөгжмийн чуулга мэт харагдана. Амгалан нуурын мандал дээгүүр ариухан цагаан өднүүд бутран хөвөв.

Хунт нуурын баруун хойд талын нэгэн сэтэрхийгээр мэлтэлзсэн усны халиа хавь ойрын хэдэн түмэн мү зэгстэй талбайг услана.

Энэ магадгүй хүний гараар хөндөгдөөгүй хунт нуур, умард хилийн унаган төрхөө хадгалж хоцорсон хятадын хамгийн сүүлчийн байгалийн онгон дагшин үзэмж байж мэдэх юм. Чэнь Жэнь энэ бүхнийг алмайран харах зуур түүний сэтгэлд бахдал зовнил ээлжилнэ. Хэзээ нэгэн өдөр энэ газар хүн мал суурьшихаар унаган үзэмж нь алдагдаад түүнээс хойш хятад хүн ийм сайхан байгалийн үзэмжийг харах боломж үгүй болно гэсэн үг. “Хэрвээ хил хамгаалалтын хориотой бүс өөрийнх нь хэвтэж байгаа газраар дайран өнгөрдөг бол мөн сайхан аа” гэж Чэнь Жэнь өөрийн эрхгүй харуусан бодлоо.

\* \* \*

Өлзий Билиг хоёр дурангаараа ийш тийш ан амьтан хайсаар байв. Өвгөн гутлын хоншоороор Чэнь Жэньгийн шилбийг ёвроод жижиг голын баруун талын гуравдахь тохой тийш хар гэв. Чэнь Жэнь арайхийж нэг юм өөрийн зүүд зөнгийн орноос эргэн ирээд байрлалыг дахин лавласны эцэст жижиг голын тохой руу дурандлаа. Голын дугуйрсан тохойн эрэг дээр хоёр зээр усанд уначихаад хойд хоёр хөл нь шаварт шигдсэн бололтой урд хоёр хөлөөрөө газар самардан дээш гарах гэж үйлээ үзэн зүтгэж байлаа. Голын тохойн зүлгэн дээр арван хэдэн зээр гэдсээ хүүлүүлээд үхсэн хэвтэнэ. Чэнь Жэнь голын эргийн өндөр өвсийг самнан хараад өөрийн эрхгүй зүрх нь түг түгхийн цохиллов. Түүний хэдэн өдөр дараалан барааг нь хараагүй том чононууд үхсэн зээрнээс холгүйхэн зүүрмэглэж байх ажээ. Голын тохойн өвс харьцангуй өндөр байдаг болохоор тэнд чухам хэдэн чоно нуугдаж байгааг багцаалах аргагүй байлаа.

Өлзий, Билиг хоёр хотгорын булан тохой бүрийг дурангаараа сайтар нягтлан харав. Зүүн өмнөх уулын энгэрт тарж бутарсан зээрийн сүрэг хоёр гурваараа бэлчиж, бараг ихэнх

шаргачингууд янзагаа дагуулан явна. Нэг шаргачин дөнгөж төрсөн янзагаа долоох зуур ийш тийш сэртэлзэн харж байхыг Чэнь Жэнь олж үзэв. Сая төрсөн янзагаа хөл дээрээ тэнтэр тунтар тогтож ядна. Хэрвээ хөл дээрээ нэг тогтоод авбал хээрийн нохойд гүйцэгдэхээргүй хурдан гүйж чаддаг билээ. Гагцхүү энэхүү хөл дээрээ тогтох хэдэн минутын хугацаа л түүний хувьд үхэл амьдралын торгон агшин болдог юм. Ийм хол зайнаас чоно зээр хоёрын алийг түрүүлж агнах бол гэдгийн учрыг Чэнь Жэнь нэг хэсэгтээ олж чадахгүй мунгинав.

“Чоно хүнийг яаж ч чадахгүй гэдгийг мэдээд дугжирч байхыг харав уу? Ийм хол зайтай байгаа болохоор хүний бараа харангуут чоно, зээр хоёр арилаад өгөх болно” хэмээн Билиг өвгөнийг хэлэхэд Өлзий дарга “Харин тэр хэдэн үхсэн зээр бидний үдийн хоол болох нь дээ” гэж хэлэв.

Гурван морьтон голын тохойг чиглэн хөдлөв. Морьтой хүн болон нохдын барааг харангуут чонон сүрэг тал бүр тийш бутран зүүн талын өндөр уулын хормойд байх зэгсэн дунд шурган алга боллоо. Зээрийн сүрэг ч нүд ирмэх зуур даваа гүвээг даван одож, шаварт шигдсэн хоёр болон дөнгөж төрсөн янзагатай зээр л үлдэж хоцров.

Мань гурав тав зургаан метр өргөн гармаар гатлан нэг мү орчим өргөн голын тохойд дөхөн очлоо. Метр хирийн гүн голын ус ёроол нь харагдахуйц тунгалаг ажээ. Зарим газраараа лаг шавартай голын эрэг мөн метр орчим өндөр. Голын тохойн элсэн тантай хэсэг нэлээд налуу байв. Голын эргийн зүлгэн дээрх арван хэдэн үхсэн зээрийн дотор гэдэс, гуяны махыг чоно иджээ. Нэг зээр шаварт шигдчихээд хөдлөж чадахгүй, харин өөр хэдэн зээр хүзүүнээсээ цусаа гоожуулан хөлөө жийн үхжээ. “Зээр өглөө ус уухаар ирэхэд нь чонон сүрэг дайрсан байна” гэж Билиг өвгөн хэллээ.

Чонын бүслэн дайрах тактикийг Чэнь Жэнь цөөнгүй харж байсан боловч гурван талаар усаар хүрээлэгдсэн голын тохойд хомрогolon дайрсныг анх удаа үзэж байгаа нь энэ юм. Тэр морин дээрээсээ чонын хэрхэн дайрсныг таамаглах гэж оролдов.

“Чи хар даа, чонон сүрэг мөн ухаалаг дайрч шүү. Тэд лав урьд шөнө нь энд ирж өвсөн дунд бүгээд зээрийн сүргийг ус руу орсон хойно голын тохойн гармыг таглан бүслэсэн зээрээ бүгдийг нь барьж чаджээ. Голын тохой гэдэг хүүдийний амыг чоно уячихаар уут дүүрэн мах тэдний өвөрт ороод ирсэн байна шүү дээ” хэмээн Өлзий дарга тайлбарлав.

Билиг өвгөн инээд алдан “Энэ удаа ч гэсэн тэнгэр чононд тусласан болохыг харж байна уу? Голын тохой мушгирахын тоогоор авын хүрээ үүсгэсэн байна. Би чамд чононыг тэнгэрийн хөвүүн гэж хэлдэг нь үнэн байгаа биз?” хэмээн хэлэв.

“Ийм нандин ав хомрогын талбайг өөр хаанаас олох билээ? Гэтэл энд арван хэдээрээ үүссэн байдаг ажээ. Тэнгэр чононд үнэхээр талтай юм гээч. Чоно ч гэсэн ухаалаг амьтан болохоор тэнгэрийн хайрласан хавхыг маш гайхалтай ашиглаж чаджээ” гэж Чэнь Жэнь дуу алдав.

“Чоно цаг агаарын хувирал болон газрын байрлалыг ашиглан довтлохдоо хүнээс хамаагүй илүү шүү” хэмээн Өлзий дарга хэллээ.

Хоёр том нохой энд тэндгүй хөглөрөх ангийн шинэхэн махыг хараад ухасхийхийг яарсангүй.

Тэр тусмаа чонын идсэн сэгийг харах ч үгүй ажээ. Барс хараахан амьсгаа хураагаагүй байгаа нэгэн оонын дэргэд хүрч очоод хүзүүг нь дарж аваад Билиг өвгөн рүү харахад цаадахь нь толгой дохиод “Ид ид” гэлээ. Барс хавхийтэл хазаж оонын амийг таслаад гуяны махнаас нь том том үмхлэн идэж гарлаа. Арслан энэхүү цус асгарсан ангийн талбарыг хараад омог сүр нь бадарч, зооны үсээ босгоод голын хөвөөний лаг шаварт шигдсэн хоёр амьд зээр рүү ухасхийн дайрахад өвгөн Чэнь Жэнь хоёр хашгиран зогсоов. Арслан дурамжхан янзтай нэгэн үхсэн зээрийг урд хоёр хөлөөрөө гишгэж ийш тийш харж байснаа өөр нэгэн тохойд шархдсан зээр байхыг хараад түүн рүү ус самран зүтгэв. Чэнь Жэнь түүнийг хориглох гэтэл өвгөн болиулаад “Энэ нохойгоор зэрлэг адгуус бариулж байвал өөрийн хонин сүрэг рүү дайрахгүй байж мэднэ” гэв.

Тэр гурав голын хөвөө рүү явцгаалаа. Билиг өвгөн эмээлээсээ нэгэн эвхээстэй сур тайлж аваад бугуйл зангидав. Чэнь Жэнь гутлаа тайлан ус руу ороод зээрийн хүзүүнд бугуйлын гогцоог углахад Өлзий дарга Билиг өвгөн хоёр хамжин эрэг дээр татаж гаргаад газар унаган дөрвөн хөлийг нь агдлан хүлэв. Гурвуул тэр зээрийг цус булингартай голын тохойноос татан гаргаад цэвэрхэн зүлгэн дээр төхөөрч орхилоо.

Билиг өвгөн “Гурвуулаа нэг зээрийг төхөөрч идээд нөгөөг нь ганзгалаад харьцгаая” гэхэд Өлзий дарга хутгаа гарган нөгөөг нь янзлав. Өвгөн ийш тийш харж байснаа Чэнь Жэньг дагуулан хуурай мөчир гишүү олж ирэхээр явлаа.

Тэр хоёр морио унан баруун хойд уулын гуу жалга руу орвоос энд тэндгүй метр хэрийн өндөр гүйлсний мод ургасан байх бөгөөд түүний дор хатсан мөчир гишүү элбэг байх ажээ. Гүйлсийн цэцэг дөнгөж зулгараад байгаа тул сэнгэнэсэн үнэр нь ханхалж, жалгын ёроолд гүйлсний хатсан яс хөглөрнө. Хөгшин залуу хоёр том том мөчир гишүү баглаж мориндоо ачаад эргэн ирцгээв. Өлзий зээрийн арьсыг өвчиж, махыг нь шулаад голын эргээс жаал жуул таана, хөмүүл түүж ирчихсэн сууж байлаа. Шинэ нутагт ургасан хөмүүл савхны хиртэй бүдүүн болохыг Чэнь Жэнь олж харав.

Эмээл хазаарыг нь авсан гурван морь биеэ шилгээгээд голын налуу эрэг дээр очиж ус ууж гарахыг харсан Билиг өвгөн ихэд баясч “Мөн сайхан устай газар юм гээч. Зуслангийн газар ус сайтай бол болох нь тэр” гэв. Гурван адуу гэдсээ цүрийтэл ус ууж аваад хамраа тачигнуулан нялх ногоо шир ширхийтэл зулгаана.

Ширгэн дээр түүдгийн гал дүрэлзэн асахад хунт нуурын эргийн цэнгэг агаарт анх удаа таана, хөмүүл, халуун ногоогоор хачирласан зээрийн шарсан махны анхилуун үнэр ханхлав. Нуурын эргээр хээрийн түймэрт шатаагүй үлдсэн хуучин зэгс болон босоо хүний хэртэй өндөр шинэ зэгс шивээлэн ургасан тул шарсан мах архиар даруулан зооглонгоо хунт нуурын үзэмжийг бахдан харах боломжгүй нь харамсалтай. Чэнь Жэнь нарийн мөчирт шорлон хатгасан зээрийн шинэхэн махыг эргүүлж тойруулан шарна. Тэр гурав үүр цүүрээр наашаа гарсан болохоор өлөн гэдэс нь хоржигнож байсан билээ. Чэнь Жэнь зээрийн махыг халуун ногоо, таана хөмүүлтэй шарж идэн, өвгөний дашмагтай архинаас гүд гүдхийтэл залгилах зуур тал нутгийн байгалийн үзэмж, хээрийн хоолны амтанд бүрмөсөн мансуурч гүйцжээ. “Би хоёр дахь удаагаа чонын үлдээсэн хишгийг хүртэж байгаа маань энэ л дээ. Үнэхээр өгүүлж барамгүй амттай шүү. Тэр тусмаа чонын ан хийж байсан газар гээд бодохоор хийморь сэргэмээр. Эртнээс нааш олон хаад монголын талд ан хийхээр ирдэг байсанд гайхаад байх

юм алга” хэмээн тэр хэлэв.

Билиг өвгөн, Өлзий хоёр зээрийн бүтэн гуяыг зүсэж завсар зайгаар нь давс, амтлагч цацаад гал дээр эргүүлэн шарж болсон хэсгийг нь огтлон авч идээд дахин шарна. Өвгөн их л бахтай мах огтлон идээд архи тонгойлгон ууж “Бидний энэ шинэ нутаг бэлчээрийг чоно харгалзаж байсан нь яамай даа. Дахин хорь хоноход төл мал хөрвөжиж замын ая даахуйц болохоор багийнхнаа аваад наашаа нүүдэг хэрэг ээ” гэв.

Өлзий дарга хэрчим маханд таана хөмүүл ороож идэнгээ “Танай багийнхан тантай цуг ирдэг болов уу даа?” хэмээн асуулаа.

Өвгөн хариуд нь “Зээр чоно ирчихээд байхад хүн идээшихгүй яах вэ? Өвс соргог болоод л зээр наашаа нүүдэллэн ирсэн хэрэг. Зээр цөөн бол чоно наашаа зүглэнэ гэж байхгүй шүү дээ. Би гэртээ багийн хурал зарлаж дарга удирдлагуудыг зээрийн махан буузаар дайल्या. Тэд нар эндхийн ус унд ийм сайн гэдгийг дуулах юм бол хэсгүүд наашаа уралдаад л нүүж таарна. Зуслангийн бэлчээрийн өвснөөс гадна ус сайн байх л хамгаас чухал байдаг юм. Тогтоол юм уу, булингартай устай газар мал өвчин олох нь их. Тийм нөхцөлд зуны усан тарга авахуулж яахин чадах вэ?” гэв.

“Хэрвээ наашаа нүүхдээ дурамжхан байвал би тэднийг үүгээр дагуулан ирж болох юм шүү” хэмээн Өлзий дарга өгүүлэв.

Өвгөн тас тас инээж “Хэрэггүй дээ. Над шиг хөгшин чоныг наашаа нүүнэ гэхээр бусад том бага чононууд дагаад л явж таарна. Азарган чоныг дагасан сүрэг алздаггүй байх аа” гээд Чэнь Жэнь рүү харж “Чи энэ удаа аавыгаа дагаж гараад башийж байгаа биз дээ?” хэмээн асуув.

“Аав гэж азарган чоныг дагаснаар амтат мах, аагтай сархдыг хүртлээ. Ян Кө тэд нар тантай цуг явна гээд надтай булаацалдаж байдаг шүү” гэж Чэнь Жэнь хэллээ.

“За тэгвэл ингэж тогтлоо. Би аж ахуйн төв ороод нүүх бэлтгэлийг базаалгая. Ойрын хэдэн жил дээрээс дааж давшгүй үүрэг даалгавар өгөөд мөн ч хэцүү байлаа даа. Харин энэ шинэ нутаг бэлчээрийг ашигласнаар дөрөв таван жилдээ уужуу амьсгаа авч болохоор боллоо” хэмээн Өлзий дарга хэлэв.

Чэнь Жэнь асууруун “Дахин дөрөв таван жил өнгөрөхөд манай аж ахуйд өөр шинээр ашиглачих бэлчээр нутаг байгаа юу?” гэхэд

“Байхгүй ээ” гээд Өлзий даргын нүд сүүмийж “Хойд талаар улсын хил, баруун болон өмнө зүгт өөр нэгдлийн нутаг залгадаг. Зүүн хойд талын хадархаг уулаар би явж үзсэн. Ашиглачих бэлчээр алга юм билээ” гэв.

“Тэгээд цаашдаа яах болж байна вэ?” гэж Чэнь Жэнь дахин асуулаа.

“Малын тоо толгойг хязгаарлан ашиг шимийг өсгөхөөс өөр арга байхгүй. Тухайлбал Шинжааны сайн үүлдрийн хонь үржүүлж болох юм. Сайн үүлдрийн хонины ноосны гарц манай эндхийнхээс хоёр дахин илүү, чанар сайтай болохоор гурав дахин илүү үнэтэй байдаг.

Манай эндхийн нэг жин ноос нэг төгрөг гаруй үнэтэй байдаг бол сайн үүлдрийн хонины ноос дөрвөн төгрөг хүрдэг. Хэр зэрэг ялгаатай байгаа нь харагдаж байгаа биз дээ? Гэтэл манай аж ахуйн гол орлогын эх үүсвэр чинь хонины ноос шүү дээ” хэмээн Өлзий дарга өгүүллээ. Чэнь Жэньд түүний энэ санаа тун их таалагдав. Гэвч Өлзий дарга санаа алдаад “Хятадын хүн ам дэндүү олширч байгаа болохоор дахин хэдэн жил болоход манай бэлчээр нутаг хүрэлцэхгүй болж мэдэх юм. Бидний хөгшчүүл ч яахав, тэтгэвэртээ гараад өгцгөөнө. Харин та нарын үе дээр яана даа” гэв.

Билиг өвгөн нүдээ бүлтийлгээд “Та малын тоо толгойн даалгавраар дараад хэрэггүй гэдгийг дээд дарга нарт хэлж болдоггүй юм уу? Энэ маягаараа бол удахгүй хүн мал элсэнд дарагдаж гүйцнэ шүү” гэлээ.

“Одоо чинь тариачин гаралтай боловсон хүчин эрхийг атгаж байгаа болохоор та бидний үгийг хэн тоож сонсох вэ? Тэд чинь хөдөөний гаралтай биднээс илүү боловсрол мэдлэгтэй, хятад хэлэнд ус цас шиг улс. Тэгээд ч нутгийн удирдах ажилтнууд чоно уралдан агнаад малын тоо толгойгоор өрсөлддөг болсон. Тал нутгийн онцлогийг ойлгодоггүй дарга нар хурдан дэвшээд байх янзтай даг шүү” гээд Өлзий дарга толгой сэгсрэв.

Гурван морь цадсан бололтой толгой тонгойн дугхийнэ. Арслан хамаг бие нь усан хулгана, хошуу амаа цустчихаад эзнээсээ арван хэдэн алхмын тэртээд саалийн хувин шиг гэдсээ цүндийлгэн зогсоно. Барс түүний юу хийгээд ирснийг мэдсэн бололтой уур хилэн нь бадран уралцахаар завдахад Чэнь Жэнь өвгөн хоёр зандран салгав.

Өлзий дарга нөгөө хоёрыгоо дагуулан хотгорын голоор туучин явах зуур нийт багийн дөрвөн хэсгийг хаана хаана нутаглуулах талаар Билиг өвгөнтэй зөвлөлдөж явлаа. Чэнь Жэнь замын турш байгалийн үзэмжийг бахдан тал нутгийн дундах диваажинд, эсвэл диваажингийн дундах тал нутгийн чухам алинд байгаагаа ч ялгах сөхөөгүй, болдогсон бол шулуухан үлдчихмээр санагдаж байлаа.

\* \* \*

Тэр гурав анх үдэлсэн газраа эргэн ирээд үлдсэн зээрийг өвчиж, махыг нь шулж авлаа. Анх харахад үлгэрийн өнгө төрхөө гайхуулж байсан энэ сайхан газар одоо үхсэн зээрийн сэг зэмээр дүүрсэн нь сэтгэлд нэг л бүрсгэр санагдана. Чэнь Жэнь хэсэг зуур гуниглаж байснаа тэвчилгүй “Чоно өвөл ч яах вэ, хавар идэх гэж зээрийг хяддаг байж болох юм. Харин зун яахаараа өдий олноор нь алдаг юм бэ? Голын бусад тохойнуудаар ч цөөнгүй зээр байгаа бололтой. Эд хэд хонолгүй өмхийрч муудна шүү дээ. Чоно дэндүү муухай шунахай биш үү?” хэмээн асуув.

“Чоно өдий олон зээрийг алж хяддаг нь зугаа гаргаж, сүрээ үзүүлэх гэсэн хэрэг биш ээ. Тэд чонон сүргийн дундахь хөгшин хөвөө, дорой буурайдаа идэш бэлдэж байгаа нь энэ. Барс болон цоохор ирвэс монголын талд яагаад идээшдэггүй, чонон сүрэг энд ноёлж байдгийн учир нь тэд маш хамтач сэтгэлтэйд байгаа юм. Бар ан хийчихээд өлөгчин, бамбар зэргийг гаргуунд нь гаргачихдаг. Харин чонон сүрэг өөрсдөөсөө гадна, сүргийн хурдыг гүйцэхгүй хөгшин, доголон, сохор, өлөгчин болон өвчтэй нэгийгээ хамт бодолцож байдаг юм. Өнөө шөнө азарган чоно ганц улихад л Олонбулгийн талаар гуринхлан явсан чононууд нааш хүрч

ирээд энэ хөглөрсөн зээрийг эд бад хийж орхино. Чоно өөрийгөө болон өрөөл бусдыг бодож явдаг болохоор дайрч давшихдаа хүчтэй байх нь аргагүй. Заримдаа азарган чоно ганц улихын төдийд хэдэн зуун чоныг цуглуулан дайрах нь ч бий. Эрт дээр цагт тал нутагт бар байсныг чонон сүрэг хөөн зайлуулсан юм гэж хөгшчүүл ярьдаг. Чоно хүнээс илүү гэрсэг, эв нэгдэлтэй амьтан даа.

Монголчууд Чингис хааны үед л чонон сүрэг шиг эв нэгдэлтэй, багц сум шиг бат чанга байсны ачаар хүн цөөтэй атлаа хүчээ төвлөрүүлэн тал нутгийнхаа төлөө эрслэн босож, дэлхийн дайдыг эзлэж байсан түүхтэй юм. Хожим монголчууд эв нэгдлээ алдан, алтан ургийнхан өвөр зуураа тэмцэлдэж, ганц сум шиг салж, бусдын идэш болж ирсэн. Чонын дайтах аргаас суралцаж болох боловч тэдний хамтач сэтгэлийг сурна гэдэг амаргүй ажээ. Манай монголчууд энэ тал дээр л тун бүтэлгүй улс даа. За за, энэ талаар ярина гэхээр сэтгэл хөндүүрлээд байдаг юм. . . . . ” гээд өвгөн санаа алдав.

Чэнь Жэнь хунт нуурын үзэсгэлэнт бэлчээрийг хараад гүн бодолд автлаа.

Өвгөн зээрийн шулсан махыг арьсанд нь боож хоёр шуудайд хийлээ. Чэнь Жэнь өвгөний морийг эмээллэж өгөхөд Билиг гуай Өлзий хоёр нэжгээд шуудайтай махыг эмээлийн ардуур ганзгалаад сураар даруулан хүлэхэд гурван морьтон гэрийн зүг хөдөлцгөөв.



*Тэд яг л Хүннүчүүдийн араатан дээдэс чонотой адилхан “Тотем” цохолбор*

.....

*Түрэг, Монгол үндэстнүүдийн эртний үлгэр домогт гардаг өвөг дээдэс нь чоно байсан тухай бид мэднэ. Монголын нууц товчоонд гардагчлан Монголчуудын өвөг дээдэс нь Бөртэ чоно билээ. Тэгвэл “Өвгөсийн түүхэн тэмдэглэлд өгүүлснээр түрэгчүүдийн шүтээн дээдэс нь цацарсан гэрлийн дундаас гарч ирдэг хөх үс дэлтэй аварга азарган чоно ажээ.*

*(Франц) Рени Гроссе*

*“Тал нутгийн эзэнт гүрэн”*

Дээд шатны байгууллагаас Олонбулгийн цэргийн агт осолдсон хэргийг хэрхэн шийдвэрлэх тухай чиг гарчээ. Аж ахуйн үйлдвэрлэлийн ажлыг хариуцаж байсан Өлзийг захиргааны зүгээс хатуу донгодон шийтгэж, гурвалсан удирдлагын гишүүнээс чөлөөлөн анхан шатны нэгжид ажиллуулахаар болов. Бат, Лхасүрэн нарын дөрвөн адуучинг мөн хатуу донгодон Батын өрхийн цэргийн салаан даргын албан тушаалыг цуцалжээ. Өөр нэгэн тушаалаар Бао Шүнь Гүйг аж ахуйн хувьсгал болон үйлдвэрлэлийн ажлыг гардан хариуцах нэгдүгээр дарга болгон томилов.

Өлзий аж ахуйн ажлаа өгөхөд Бао Шүнь Гүй, Жан Зи Юань хоёр түүнийг дагалдан мал аж ахуйн баг дээр очив. Өлзийгийн ачаа бараа гэж анчны богцноос томгүй шахам эд ажээ. Соёлын хувьсгалаас өмнө Өлзий өөрийн албан ажлаа баг, хэсгүүд дээр төвлөрөн явуулах дуртай байлаа. Мал аж ахуйн баг дээр түүний дөрвөн ээлжийн монгол дээл гутлыг хэдэн айлын авгай хүүхнүүд оёж шидэж өөрсөд дээрээ хадгална. Олон жилийн турш тэр ийм маягтай олон түмний дунд хариуцлагатай ажиллаж байсан болохоор ажлаас мултарлаа гээд хотойгоод байх юм үгүй ажээ. Өлзийгийн нэр хүнд олны дунд хэвээрээ боловч ажил амжуулах хурд хавьгүй буураад ирэв. Өлзийд нэгэн хөгшин цагаан морь оноож өгсөн нь хаврын адаг сар болчихоод байхад бээрэгнээд үс нь гуужихгүй байгаа нь зуны эхэн сард хөвөнтэй дээлнээсээ салдаггүй хөгшин хүнийг санагдуулна.

Жан Зи Юань түүнд өөрийн унаж явсан хурдан морио өгөх гэсэн боловч цаадахь нь зөвшөөрөхгүй харин ч түүнийг хурдан харьж ажил төрлөө бод гэв. Жан Зи Юань аж ахуйн төв орж гар чийдэнгийн зай аваад буцах замдаа шинэ хуучин хоёр удирдлагатай тааралдан зам нийлсэн нь энэ юм. Өлзий дарга Билиг өвгөнийд суух болсон гэдгийг дуулаад, тэр санаа нь нэлээд уужирчээ.

Бао Шүнь Гүй, Өлзийгийн урьд эдэлж байсан өндөр шарга морийг унасан нь үс нь гуужиж гүйцжээ. Тэр морины амыг татаж сая Өлзийтэй зэрэгцэн алхуулна. Тэр шинэ эзнийхээ хэвгйдүү суухад дасахгүй байгаа бололтой амгайгаа булаалдана. Заримдаа зориуд алхаагаа сааруулан хуучин эзнийхээ өвдгийг үнэрлэн зөөлөн агаад гунигтай үүрсэх ажээ.

“Өлзий гуай, би өөрийг чинь удирдлагын бүрэлдхүүнд хэвээр үлдээх гэж чадлаараа

чармайсан шүү. Над шиг малын дөргүй, хөдөө тосгонд өссөн хүн ийм том аж ахуйг авч явна гэдэг яаж амар байх билээ?” хэмээн Бао Шүнь Гүй яриа өдөв.

Өлзий байн байн морио давирсаар духанд нь хөлс бурзайжээ. Хөгшин морь унана гэдэг хүсэхэд биш тул Жан Зи Юань байн байн түүний өмнөөс ташуурдаж өгнө. Өлзий гараа сунган шарга мориныхоо магнайг илбэн тайтгаруулаад Бао Шүнь Гүйд хандан “Энэ хэргийг улс төржүүлэлгүй үйлдвэрлэлийн осол гэж тогтоосон нь миний хувьд тэнгэрийн умдаг атгаснаас өөрцгүй. Энэ айхтар том осол болсон болохоор намайг тушаалаас буулгахгүй бол шат шатны удирдлагуудад амаргүй байж таарна” гэв.

“Өлзий гуай минь, би энд ирээд жил гаруй болохдоо мал аж ахуй гэдэг газар тариалангаас шал өөр юм байдгийг ойлгосон. Хэрвээ дахин ганц хоёр тийм осол гарах юм бол би ч гэсэн энд удаан тогтохгүй байж таарна. Өөрийг чинь анхан шатанд ажиллуулъя гэхээр нь би хоёрдугаар баг руу өгч байгаа юм. Та малаа мэддэг хүн Билиг өвгөнийд суурьшвал миний санаа амар байх болно. Элдэв асуудал тулгарвал танаас асууж байхад ч дөхөмтэй” хэмээн Бао Шүнь Гүй чин сэтгэлээсээ өгүүлэв.

Өлзийгийн царай туяаран “Хоёрдугаар багийг шинэ нутагт суурьшуулах талаар хувьсгалт хороо шийдвэрээ гаргасан уу?” хэмээн асуулаа.

“Шийдсэн, аж ахуйн захиргаанаас энэ ажлыг ерөнхийд нь надад даалгаж хэзээ нүүж суух, бэлчээрээ хэрхэн хуваарилах асуудлыг Билиг гуайд хариуцуулахаар болсон. Тэр хүрэх зам хол, ууландаа чоно ихтэй, шумуул нь барьчих гээд байдаг, ямар ч дэд бүтэц байхгүй гээд л эсэргүүцэх хүн цөөнгүй гарсан шүү. Хэрвээ үүнтэй холбоотой ямар нэгэн асуудал гарвал надтай л ярих юм шиг байна лээ. Тийм болохоор би барилгын ангийг авч очоод мал ариутгалын цөөрөм, ноосны агуулах, багийн контор, мал эмнэлгийн цэг зэргийг бариулж, хэд хэдэн давааны замыг засуулахаар болоод байгаа” гэж Бао Шүнь Гүй хариуллаа.

Өлзий хэсэг зуур бодлогоширон явав.

“Энэ бүхэн таны алсын хараатайн хүч шүү. Улс орон даяар үхэр, хонины махаар гачигдаад байгаа болохоор дээрээс шахуу үүрэг өгөөд байгаа. Дээр нь дөрвөн багийнхан бэлчээр хүрэлцэхгүй байна гээд байгаа энэ үед шинэ нутаг бэлчээр ашиглахгүй юм бол өнөө жилийн үүрэг даалгаврыг биелүүлэх аргагүй байлаа” хэмээн Бао Шүнь Гүй ярина.

“Төл мал хөрвөжиж гүйцээгүй тул нүүдэл суудлын аяыг одоохондоо даахгүй. Тийм болохоор чи ойрдоо юу хийе гэж бодож байна даа?” хэмээн Өлзий асуув.

Бао Шүнь Гүй огтхон ч эргэлзсэнгүй “Сайн анчдыг цуглуулан чоно авлах зохион байгуулалттай сургууль хийлгэнэ. Би дээд удирдлагаас нэлээд олон сумны зөвшөөрөл авсан. Олонбулгийн чонон сүргийг ор мөргүй болгоод өгөх бодол байна. Би сүүлийн арван жилийн гарз хохирлын мэдээг тулгаж үзэхэд дийлэнх нь чононоос үүдэлтэй байдаг юм байна. Зуд турхан, ган гачиг, өвчин хижгээс илүү хөнөөлтэй нь харагдаж байна лээ. Малын тоо толгойг өсгөхөд чоно устгах, бэлчээр нутгийг өргөтгөх нь юу юунаас илүү чухал болохыг би ойлгосон. Шинэ нутаг бэлчээрийн чоныг устгахгүй бол ашиг тусаа өгөхгүй” гэхэд

Өлзий түүний үгийг таслан “Тэгж ёстой болдоггүй юм шүү. Чоно бидэнд хохирол учруулдаг нь үнэн л дээ. Гэхдээ чоныг устгачих юм бол нөхөж болшгүй том сүйрэлд хүргэх болно” хэмээн хэлэв.

Бао Шүнь Гүй тэнгэрийн байдлыг ажигласнаа “Та Билиг гуай болон бусад настнуудтай хамт чоныг өмөөрч байдаг тухай би сонссоон. Өнөөдөр тэр тухай санаа оноо байдаг бол хамаагүй ярь л даа” гэлээ.

Өлзий хоолойгоо засаад “Санаа оноосох ч юу байх вэ дээ. Би эцэг өвгөдөөс уламжлан ирсэн энэ сайхан тал нутгаа өөрсдөө сүйдэлчих вий гэж л санаа зовнидог юм. Би чонын тухай арван хэдэн жил ярьсан, цаашдаа ч ярих л болно. . . Би энэ аж ахуйн ажлыг арван хэдэн жил удирдахдаа мал сүргийн тоог нэг дахин өсгөж бусад аж ахуйнуудаас хоёр дахин олон малыг улсын хэрэгцээнд тушаасан байдаг юм. Миний гол туршлага гэвэл мал аж ахуйн үндэс болсон бэлчээр нутгийг хайрлах явдал хамгаас чухал гэдгийг ойлгосон. Гэхдээ бэлчээрийн даацыг хэтрүүлэлгүй адуун сүргийн тоо толгойг зохистой барина гэдэг л хамгаас амаргүй. Хонь үхэр хивдэг болохоор шөнө өвс иддэггүй. Харин адуу өдөр шөнө өглөө оройгүй идэж байдаг болохоор өвс тэжээлд маш гарлагатай. Нэг хонинд жилд хорин мүй газар хангалттай бол адуунд хоёр зуун мүй газраас наашгүй. Морин туурай хөрсөнд тун халтай. Сүрэг адуу нэг газар хагас сар болоход тэр хавийнхаа газрыг талхлаад дуусгадаг. Зун бороо хур элбэг болохоор өвс хурдан ургадаг. Зунаас бусад улиралд суурь хэсгүүд нэг газар сараас илүү удаан байлгүй оторлон нүүж байх хэрэгтэй. Үхэр сүрэг гэж бэлчээрт бас л айхтар халтай. Үхэр орой хотлохдоо тараад тавиухан харихгүй цуварч явдаг болохоор хүнд туурайн мөрөөр хөрс гэмтэж хэд хонолгүй хот айлын хавь ойр халцгай замууд дурайдаг. Дээр нь хонь ямаа гишгэлсээр хотны эргэн тойрны нэг хоёр газар 18 ширхэг өвсгүй халцайж хоцорно. Отор нүүдэл гэдэг л талын зоог амраах ганц сайн арга юм шүү дээ. Тал нутагт бэлчээрийн даац хэтрэх гэдэг хамгаас халтай зүйл байгаа юм” гэснээ

Бао Шүнь Гүй их л анхааралтай сонсож байгааг үзээд цааш залгуулан өгүүллрүүн “Бэлчээр нутгаа хамгаалах өөр нэгэн туршлага маань чоныг хэтрүүлэн агнахгүй байх явдал мөн. Тал нутагт өвсөнд гарлагатай амьтад дэндүү олон. Тэднээс хамгийн ноцтой нь гэвэл оготно, туулай, тарвага, зээр байгаа юм. Эдгээр амьтад өвс бэлчээрийг жинхэнэ сүйдэлж өгдөг. Чоно байхгүй бол зөвхөн оготно, туулай хоёр л талын хөрсийг улаанаар нь эргүүлээд хаячихаж чадна. Бэлчээр нутгаа сайн хамгаалвал байгалийн гамшгаас сэргийлэх боломж аяндаа нэмэгдээд ирдэг. Манай аж ахуйд л гэхэд цас зуд цөөнгүй тохиолдож байсан. Гэтэл зарим аж ахуйнууд ганц удаагийн зуднаар хамаг байдаг мал сүргээ тавиад туучихсан тохиолдол байдаг шүү дээ. Манай аж ахуйн нутаг бэлчээр өвс сайтай дээр нь морин хадуураар сар хүрэхгүй хугацаанд хангалттай хадлан бэлдээд нөөцөлчихдөг болохоор зуд турханд алздаггүй. Өвсний гарц сайн байхад цасанд дарагддаггүй, бэлчээр нутаг сайн бол хөрсний нүүдлээс сэргийлж, горхи булаг татардаггүй болохоор ямар ч гантай жил хүн мал ундаасахын зовлон үздэггүй юм. Өвс бэлчээр сайтай бол мал тарга тэвээрэг сайн авч тэр хэрээр манай аж ахуйд сүүлийн хэдэн жил айхтар өвчин тахал дэгдээгүй биз дээ. Аж ахуйн үйлдвэрлэл сайн бол машин тоноглол худалдан авч, худаг ухаж, хашаа хороогоо сэлбэн байгалийн гамшгийг эсэргүүцэх боломж эрс нэмэгдэнэ” гэв.

Бао Шүнь Гүй дахин дахин толгой дохиж “Нээрэн ч бодууштай юм байна шүү. Бэлчээр

нутгаа хайрлах нь мал аж ахуйн үндэс гэдгийг би ойлгож авлаа. Би аж ахуйн удирдах боловсон хүчнүүдийг баг хэсгүүдээр явуулж, отор нүүдлийг ойр ойрхон зохион байгуулж байя. Мөн адуучдыг нэг газар байлгалгүй уулын ам суга газраар оторлуулъя. Мөн баг хэсгүүдийн нутаг бэлчээрийг шалгаж нэг газрын өвсийг халцайтал зулгаалгасан бол цалинтай нь ярьж, бэлчээр ашиглалт сайн газрыг урамшуулан туршлагыг нь нийтэд танилцуулж байх болно. Би хагас цэрэгжлийн маягаар Олонбулгийн талыг аятайхан авч явж болно гэж санагдаад байгаа юм. . . . Харин чонон сүргийг ашиглаж бэлчээр нутгийг хамгаална гэхээр санаанд буухгүй байгаа юм даа. Чоно ер нь ямар үүрэгтэй амьтан юм бэ?” хэмээн асуулаа.

Бао Шүнь Гүй овоо юм ойлгосныг хараад Өлзийгийн царайд инээмсэглэл тодрон “Чи нэг бүл зурам бүтэн жилийн хугацаанд том иргээс ч илүү өвс идчихдэг гэдгийг мэддэггүй гэж үү? Намар болохоор зурам үүрэндээ өвөлжин идэх өвсийг нөөцлөж авдаг юм даа. Би намар зурамны нүхийг ухаж үзэхэд дотор нь хэдэн том тэвэр сайн өвс болон өвсний үр нөөцөлсөн байж билээ. Зурам нэг удаа арван хэдэн гөлчгий гаргадаг, жилд дөрөв таван удаа төрдөг болохоор нэг үүр зурам арав дахин олширдог гэсэн үг. Тэгэхээр тэр болгонд хичнээн их өвс гарздахыг тооцоод үзээрэй л дээ. Тарвага тал хөндийг там болтол нүхлэдгийг чи юу эс андах вэ? Дээр нь тэд манай аж ахуйн зуун мянган малаас хэд дахин их өвс тэжээлийг идэж сүйтгэдэг. Манай аж ахуй дотор газрын нэг хошуунаас том нутаг дэвсгэртэй атлаа илгээлтийн эздийг оруулаад ч мянга хүрэхгүй хүн амтай. Ийм цөөхөн хүн хүчээр хэдэн арван сая оготно, тарвага, зурам, туулай зээрийг яахин агнаж барах билээ” гэхэд

Бао Шүнь Гүй “Би өнөө жил тийм олон туулай хараагүй ээ. Аж ахуйн төвийн ойролцоох хэдэн бор оготныг тооцвол зурам ч нэг их үзэгдэхээ больжээ. Харин тарвага бол ч олон байна аа. Зээрийн тухайд хэдэн арван түмээрээ сүрэглэн явахыг хэдэн ч удаа харсан. Бас гурав дөрвөн зээр буудаж билээ. Тэр олон зээр бэлчээр нутаг сүйтгэж байхыг хараад сэтгэл өвдмөөр шүү” гэв.

Өлзий өгүүлрүүн “Олонбулгийн өвс өндөр, өтгөн шигүү болохоор зурам, туулай зэргийг хэрэг болгон хайхгүй бол тэр бүр харагдахгүй л дээ. Намар болохоор тал нутгийн хаа сайгүй хэсэг бусаг өвс хөөлөөд овоолж тавьсан байдаг нь зурам ичээндээ нөөцлөхөөр зэхэж байгаа нь тэр. Зээр ч яах вэ өвс идэхээс биш нүх ухаж элс шороо ил гаргадаггүй нь бас ч гэж танагтай. Харин тарвага, зурам, туулай өвсөнд гарлагатайгаас гадна нүх ухаж, үржиж олширдог болохоор хэрвээ чонон сүрэг байгаагүй бол тэд хэдэн ч жил бололгүй Олонбулгийн талыг орвонгоор нь эргүүлээд элсэн цөл болгон хувиргах байсан биз. Чи хэрэв чонотой дагнан хөөцөлдөөд байвал тав гурван жил бололгүй наад даргын албан тушаалаасаа хусагдана гэж мэдээрэй” гэхэд

Бао Шүнь Гүй хүд хүд инээгээд “Би муур, бүргэд могой л оготно зурам барьдаг гэж сонссоноос биш чонын тухай дуулаагүй юм байна шүү. Эсгий хийх газар нохой хэрэггүй гэгчээр чоно тийм жижиг юмаар оролддог гэж үү дээ? Оготно зурам тэдний хувьд шүд чигчлэх төдийхөн байтал яахаараа барих гэж улайрдаг билээ? Би л хувьдаа итгэшгүй юм байна” гэв.

Өлзий санаа алдаад “Танай тариалах орноос ирсэн улс энэ тухай мэдэхгүй байх нь аргагүй л дээ. Та нар жаахан судалгаа тооцоотой хөдлөхгүй бол том алдаж мэднэ шүү. Би хөдөө талд

өссөн болохоор чоныг мэдэлгүй яахав. Чоно үхэр, хонь, адуу, зээр гээд том амьтдыг барих дуртай нь үнэн. Гэхдээ адуу малыг хүн хариулж, аягүйдвэл амь насанд нь ч хүрч мэднэ. Зээр хурдан хөлтэй болохоор гүйцэгдэхгүй. Тэгэхээр оготно зурам л тэдний хувьд гарын дор амьтан болж байгаа юм. Урьд цагт ядуус ган гачигтай жил зурмын махаар өл залгаж байсан удаатай. Би ч багадаа барлаг байсан болохоор гэдэс өлсөхийн эрхээр зурмын мах бишгүй л нэг идэж явлаа. Тал нутгийн томоохон зурам тохой хэрийн урт, нэг жин гаруй махтай болохоор гурав дөрвийг идэхэд өлхөн цадчихдаг юм. Олныг барьсан тохиолдолд махыг нь борцлоод идэхэд их амттай шүү. Чи хэрвээ итгэхгүй бол би хэдийг бариад шарж өгье л дөө. Мах нь зөөлөн амттай байдаг юм. Дээр үед Сү Ү болон Чингис хаан хүртэл зурмын махаар хооллож байсан удаатай” гэхэд

Бао Шүнь Гүйгийн царай эвгүйрхэхийг хараад яриагаа үргэлжлүүлэн “Нэг жил Гуандун газрын гаралтай том дарга хилийн отрядын ажлыг шалгахаар очсон юм. Тэр өдөр би тэнд цэрэг ардын хамтарсан хамгаалалтын ажлыг ярихаар очоод байлаа. Тэр дарга надаас зурмын мах амттай юу гэж асуулаа. Би амттай гэтэл үдийн хоолон дээр өөр юм идэхгүй зурмын махаар дайлаарай гэж билээ. Би нэг малчин өрхийн цэргээр зурмын нүхэнд ус цутгуулан цагийн дотор арван хэдэн зурам барьж өгсөн. Түүнийг өвчөөд бидний гурван хүн зурмын мах шарж идэхэд өрхийн цэргүүд нүдээ бүлтийлгэн гайхаж билээ. Тэд их сайхан амттай гэсэн мөртлөө идэж зүрхлэхгүй байсан. Тал нутгийн өвс ус цэвэр ариун болохоор түүнийг иддэг зурмын махнаас сэжиглэх юу байх вэ? Гуандунгийн хархын махнаас илүү амттай байна шүү. Тэнд аваачиж зарвал булаацалдаад л авах юм байна. Харамсалтай нь Гуандун дэндүү хол, галт тэргээр амьд зурам тээвэрлэхийг зөвшөөрөхгүй. Хэрвээ болдогсон бол өвөрмонгол амьд оготно зурмыг Гуандун руу зарж, бэлчээр нутгаа хамгаалахаас гадна, тэндхийн хүмүүсийг дээд зэргийн махаар хангах боломжтой хэмээн ярьж байж билээ. . . . .” гэхэд

Бао Шүнь Гүй инээд алдаад “Сонин л хэрэг байна. Хэрвээ манай аж ахуй Гуандун руу зурам гаргадаг болчихвол хонины ноос махнаас ч илүү орлого олж болно шүү. Харин барихад амархан уу?” хэмээн асуув.

Өлзий хариуд нь “Амарханаар барах уу? Ус цутгах, урхи тавих, хүрзээр ухах гээд олон арга бий. Тэр дундаа сургуультай нохой бол тэсгээхгүй шүү дээ. Талын анч ноход зурам барих дуртай, анч эм нохой гөлгөө эхлэж зурам барихад сургадаг юм. Гэсэн атлаа хөдөөний ноход оготно зурмын мах иддэггүй. Харин чоно бол тэгж цамаархахгүй, зурмын мах өөхтэй, барихад амархан болохоор хавар, зун, намарт чонын гол идэш тэжээл болдог. Нэг жил бид үйлдвэрлэлийн ажлыг шуурхайлж, малчдын хариуцлагыг дээшлүүлснээр чононд мал барих сиймхий бараг олгоогүй юм. Хожим би малчидтай нийлэн хэдэн чоно агнатал их цатгалан янзтай байхыг үзээд гэдсийг нь яран үзвэл хорь гаруй зурам, нэг тарвага идсэний мах нь шингээд дан толгой сүүл нь үлдсэн байж билээ. Тэгэхээр чоно жилдээ хичнээн тарвага зурам идэж устгадаг болохыг тооцоод үзээрэй л дээ. Би аймаг хошуу, өөртөө засах орны удирдлагыг ирэх болгонд энэ тухай ярьдаг боловч тэд нэг л сайн итгэж өгдөггүй юм. Тариачин гаралтай улсын чонын тухай үзлийг өөрчлөх ч амаргүй шүү” хэмээн ярив.

Жан Зи Юаний сонирхол улам өдөөгдөн ярианд оролцож “Би хоёр жил адуу хариулж явахдаа шороо тоос босгон оготно зурамтай хөөцөлдөж яваа чоныг бишгүй л нэг харсан. Чоно оготно зурам барихдаа нохойноос хавьгүй илүү. Нэгд чоно зурам элбэгтэй газар очиж хэвтээд

тааралдангуут ухасхийн алгадаж унагаад залгиж орхидог. Арван хэдэн зурам алгадаж залгиад өлхөн цадчихна. Нөгөө нэг арга нь нүхийг малтдаг. Чоно зурмыг үүр рүүгээ орохыг харах юм бол хэд хэдээрээ элбэн ухсаар хэдэн арваад зурмыг гаргаж иднэ” гэхэд

Өлзий үгийг нь өлгөн “Өлөгчин чоно бэлтрэг хоёр зурам идэх хамгаас дуртай. Бэлтрэг хөхнөөс гарахын өмнө өлөгчин чоно оготно зурам барьж ирээд тэднийг сургуулилдаг. Бэлтрэгтэй өлөгчин чоно сүрэгтэйгээ нийлэн ан хийнэ гэж бараг үгүй. Бэлтрэг тохой хэрийн өндөр, овоо хурдан гүйдэг болох үедээ хүнээс айна гэж жигтэйхэн. Тийм сүрэг бэлтрэгээ дагуулсан өлөгчин чоныг буудчихвал анчин үлдсэн бэлтрэгийг нь хурга шиг барьж авахад ядах юмгүй. Тийм болохоор өлөгчин чоно томорсон бэлтрэгнүүдээ хүн малын хөлөөс зайдуухан газар аваачдаг. Тэр тохиолдолд амь насанд аюулгүй боловч амь зогоох идэх юм хэрэгтэй болно оо доо. Том чоно, азарган чоно тэдэнд бага сага мах яс хүргэж ирэхийг эс тооцох юм бол, тарвага зурам л тэдний хувьд өл залгах хоол болдог юм” гэж яриу.

Өлзий Бао Шүнь Гүйг төвөгшөөсөн шинж үгүйг хараад яриагаа үргэлжлүүлэв. “Одоо өлөгчин чоно бэлтрэгнүүдээ дагуулан хүнгүй эль хуль газар тарвага зурам барингаа тэднийг ан авд сургаж байгаа. Тэгэх далимаараа бор ходоодоо божийлгоод авдаг юм. Бэлтрэг хоёр тохой өндөр боллоо ч чонон сүргийн хэдэн арван километр хол давхиаг гүйцэхгүй тул тарвага зурам барих нь тэдний хувьд өлзийтэй. Би талд нэг сүрэг бэлтрэг зурам барьж байхыг харсан юм. Зурмыг чарлуулан хөөцөлдөж байгаа нь оготно барьж байгаа муурнаас илүү эвсэг харагдаж билээ. Зун болохоор бүжин туулай бэлтрэгнүүдээс хурдан гүйж чадахгүй тул тэдний хоол болох нь олонтой. Нэг үүрний долоо найм, бүр олондоо арван хэдэн бэлтрэг хичнээн олон зурам, туулай идэж байж том чоно болох билээ дээ?” гэв.

“Түүнээс гадна” гээд Өлзий нэлээд ултайхан дуугарч “Хэрвээ чонон сүрэг гэж байдаггүй бол тал нутгийн хүн мал хоёр томоохон байгалийн гамшгийн үеэр балрах байсан юм. Тал нутагт арав, зуун жилд тохиогоогүй айхтар зуд турхан нүүрлэсэн цагт мянга түмэн мал хорогдоод, цас хайлсаны дараа тэдний сэг зэм өмхийрөн, цаг тухайд нь булахгүй бол өвчин хижиг дэлгэрч, бүтэн аймаг хошууны хүн харын амь насанд заналхийлж мэднэ. Харин чоно элбэгтэй газар түүнийг хурдан устгаж цэвэрлэснээр өвчин хижиг дэлгэрдэггүй. Манай Олонбулагт угаас айхтар өвчин хижиг дэгдээд байдаггүйн учир энд байгаа юм. Эрт дээр цагт манай тал нутагт дайн дажны хөл тасрахгүй хэдэн мянган хүн морьдын үхсэн хүүр сэгийг чоно л устган ариутгадаг байжээ. Чоно гэдэг амьтан байхгүй бол монголчууд өвчин хижгээр хиараад дуусах байсан гэж хөгшчүүл ярьдаг шүү дээ. Олонбулгийн өвс бэлчээр сайтай байдаг нь чонон сүргийн ач. Хэрвээ чоно байхгүй бол Олонбулгийн мал аж ахуй хаанаас ийм өөдтэй байх вэ? Өмнө талын нэгдэл чоноо хядаад дуусгаснаас болж бэлчээр нутаг нь талхлагдаад, мал ахуй нь өөдлөхөө больсон дог шүү” гэв.

Бао Шүнь Гүй хар цагаан дуугүй явна. Гурван морьтон нэгэн хөтлийн оройд гарч ирвээс өргөн нугын ногоон өвс, өнгийн цэцэгсийн үнэр хамар цоргив. Агаарт тогтон жиргэх хайргацай шувуу огцом доошлон өвсөн дунд буухад бүр олон хайргацайн сүрэг дэрхийн нисэж агаарт хөөрөн тогтоод уран жиргэлдэв.

Өлзий цээж дүүрэн амьсгаа аваад “Та нар хар л даа. Энэ нутаг хэдэн мянган жилийн өмнөх өнгө төрхөө хадгалаад хичнээн үзэсгэлэнтэй байна вэ? Магадгүй хятад орны хамгийн үзэсгэлэнтэй унаган тал байж мэдэх юм. Тал нутгийн хүн чоно хоёр хэдэн мянган жилийн

турш тэмцээний хүчинд энэ унаган төрхийг нь хадгалж ирсэнийг бидний үеийнхэн сүйтгэх учиргүй” гэлээ.

“Та бусад хэсгийн илгээлтийн эздэд лекц семинар зохион байгуулж, тал судлал, чоно судлалын талаар ярьж байвал сайнсан” хэмээн Жан Зи Юань хэлэв.

Өлзий царай барайж “Над шиг буусан даргад лекц семинар зохион байгуулах эрх хаанаас байх вэ? Харин залуус та нар ахмад малчдаас сайн суралцах хэрэгтэй. Тэд нар надаас ихийг хэлнэ шүү” гэлээ.

Дахин нэг хөтөл давсаны дараа Бао Шүнь Гүй сая ам нээж “Өлзий гуай, та тал нутагтаа хайртай, арван хэдэн жилийн турш чамгүй их ажлын амжилт олсоныг хэн ч үгүйсгэхгүй. Гэвч таны үзэл бодол улирч баларсан хуучин цаг үетэйгээ зууралдаад хол явахаа больжээ. Одоо чинь цаг өөр болж атомын эрин зуун гэж ярьдаг болсон үе. Гэтэл балар эртний юм яриад байвал ноцтой асуудалд орооцолдож ч мэднэ. Би энэ аж ахуйд ирээд нэлээд юм эрэгцүүлэн бодож үзсэн. Манай аж ахуйн нутаг дэвсгэр дотор газрын нэг хошууны нутгаас том хэр нь мянгаадхан хүн тэжээж байгаа нь тэндхийн нэг тосгоны хүн амд ч хүрэхгүй байгаа нь дэндүү чамлалттай хэрэг. Нам улсдаа ахиухан баялаг бүтээе гэвэл энэхүү хоцрогдсон нүүдлийн мал аж ахуйн хэвшлийг өөрчлөх л хэрэгтэй. Би саяхан аж ахуйн өмнөд биеэр явж үзтэл хэд хэдэн газар хэдэн арван мянган мүй хар хөрстэй газар байдаг юм байна. Би хүрээр малтаж үзтэл лав хоёр тохой хэрийн зузаан юм байна лээ. Гэтэл тийм сайхан газар үхэр хонь адгуулж байгаа нь дэндүү хайран биш үү? Би аймгийн төв рүү хуралд суухаар явахдаа өөртөө засах орны газар тариалангийн товчооны мэргэжилтнээс тэр тухай асууж үзэхэд тэнд тариа тарих бүрэн боломжтой. Өргөн цар хүрээтэй биш, хэдэн зуу, мянган мүй тариалахад хөрсний эвдрэл гарахгүй гэж байна лээ” гэсэнээ

Бао Шүнь Гүй Өлзийгийн дуу шуугүй явахыг хараад цааш залгуулан “Тэндхийн голоос суваг шуудуу татан услах бүрэн боломжтой гэдгийг би тогтоосон. Манай аж ахуйгаар нэг хөглөрөх үхэр хонины өтөг бууц гэдэг чинь дээд зэргийн бордоо гэсэн үг. Тэнд тариа тарихад эхний жилдээ л шар мөрний хавиас илүү ургац хураах боломжтой. Хэдэн жилийн дараа манай аж ахуйн газар тариалангийн орлого мал аж ахуйгаасаа даван гарахыг хэн байг гэх билээ дээ? Тэр цагт хүн амын идэш тэжээлийг өөрсдөө хангаад зогсохгүй улсаа ч дэмжих боломжтой болно. Одоо улс орны хэмжээнд үр тарианы хэрэгцээ хангамж хүрэлцэхгүй байгаа. Манай нутагт л гэхэд нэг айлын гурван сарын хэрэгцээт үр тариаг олгож чадахгүй байх жишээтэй. Гэтэл энэ аж ахуйд ирээд тийм сайхан хар хөрсөнд тариа тарилгүй жилийн нэг сар адуу мал бэлчээгээд өнгөрдөг болохыг үзээд миний сэтгэл маш их шимширсэн шүү. Би эхний ээлжинд хэдэн газарт тариа тарьж үзээд боломжтой нь батлагдвал томоохон хөдлөөд үзнэ. Өмнө талын хэдэн нэгдлийн бэлчээрийн өвс хүрэлцэхгүй болохоор хэдэн хар хөрстэй газар тариа ногоо тарьж үзэхээр шийдсэн гэнэ лээ. Миний санахад энэ бол Өвөрмонголын талын нутгийн гарц мөн” гэв.

Өлзийгийн царай барайгаад уртаар санаа алдаж “Би ийм юм болно гэж мэдээд байсан юм аа. Танай нутгийнхан бэлчээрийн даацаа тооцолгүй мал сүргээ өсгөөд, чоныг бодлогогүй агнасны уршгаар сөөм өвс ургахгүй болохоор тариа ногоо тарьж эхэлсэн биз дээ? Танай нутаг хэдэн арван жилийн өмнө мал аж ахуй эрхэлдэг байсан. Гэтэл газар тариалан эрхлээд арван хэдэн жил бололгүй идэх хүнс чинь хомсдож байна. Энэ хил хязгаарын сайхан талыг өөрийн

нутаг шигээ болгочихоод чи өөр хаана очиж газар хагалах гээ вэ? Шиньжааны элсэн цөл дотор газрын бүхэл бүтэн мужаас илүү том нутагтай, говьд хүн амьтан суурьшдаггүй. Гэтэл тэр бүх газрыг үр ашиггүй байлгасаар байгаа хэрэг үү?” гэхэд

Бао Шүнь Гүй “Та тэр тал дээр санаа амар байж болно оо. Би өөрийн нутгийн сургамжийг санаж тариалж болох талбайг бэлчээр нутгаас сайтар зааглаж өгнө. Газар тариалан мал аж ахуй хоёрыг сайтар хослуулна гэсэн үг. Би бэлчээр нутгаа хамгаалсаны үндсэн дээр мал аж ахуйг эрхлэх юм. Мал аж ахуй байхгүй бол газар тариаланд бордоо дутагдах болно шүү дээ.” гэхэд

“Тариачид наашаа ирээд шимт хөрсийг харахаар хэнд ч захирагдахаа болино. Чиний үед хязгаарлаж болдог юм, гэхэд дараачийн үед захирагдах болов уу?” хэмээн Өлзий уурслаа.

“Юм чинь үе үеэрээ байдаг болохоор би дараа үед юу болохыг яахин мэдэх билээ?” хэмээн Бао Шүнь Гүй өгүүлэв.

“Чи тэгээд чоныг яах гэж байна вэ?” хэмээн Өлзий асуулаа.

Бао Шүнь Гүй хариуд нь “Та чононд ууч хандаж байгаад том алдаанд орсон. Би таны замаар явж яахин болох вэ? Хэрвээ дахин нэг цэргийн агт сүйдвэл би ч өөрөө таны замаар орно гэсэн үг” гэлээ.

Алсад хот айлын бараа харагдав. Бао Шүнь Гүй “Аж ахуйн захиргааны хэдэн нөхдүүд мөн ч харлачихсан дотортой улс шүү. Танд ийм хөгшин морь цохож олгоод хайран цаг үрчих юм” гэснээ Жан Зи Юаньд хандан “Чи Өлзий гуайд сайн морь барьж өг гэж намайг хэлж байна хэмээн Батад дуулгаарай” гэлээ.

“Багийн төв хүрэх юм бол Өлзий даргад ийм морь унуулах хэн байх билээ?” хэмээн Жан Зи Юань хэллээ.

“Миний ардах ажил хэцүүдлээ. Билиг гуайнд очоод хүлээж байя. Та хоёр араас тайван гэлдрээд очицгоо” гэж Бао Шүнь Гүй хэлчихээд жолоогоо дугтрахад шарга морь ухасхийн давхилаа.

Жан Зи Юань морины амыг татан пөг пөг шогшуулах хөгшин морьтой зэрэгцээд “Бао Шүнь Гүй уг нь танд их сайн байдаг. Дээшээ хэдэн ч удаа утсаар ярьж таныг удирдах бүрэлдхүүнд үлдээгээч гэж гуйж байсан гэж захиргааны хүн ярьж байна лээ. Харин цэргийн хүн байсан болохоор жаахан бүдүүн хадуун талдаа л даа” гэж Өлзийд хандан хэлэв.

Өлзий өгүүлрүүн “Бао Шүнь Гүй шиг гав шув хийсэн хүнийг газар тариалангийн бүсэд ажиллуулсан бол сайн дарга байж мэднэ. Харин мал аж ахуй дээр ирээд сайн ажиллах тусам тал нутгийг сүйдэлчих гээд байх юм” гэлээ.

“Би хэрвээ дөнгөж ирээд байсан бол түүний санаа бодлыг дэмжих байсан юм. Одоо чинь дотор газар зөндөө олон хүн өлсөж үхэж байна. Гэтэл тал нутагт ийм их эдэлбэр газар ашиглалтгүй байж байдаг. Илгээлтийн эздийн дунд түүнийг дэмждэг хүн олон бололтой дог



шүү. Харин одоо би асуудлыг өөрөөр хардаг болсоон. Таны ярьдаг бүхэн хамаагүй алсыг харсан юм байна лээ. Суурьшмал үндэстэн бэлчээрийн даац, газар нутаг хүний харьцаа, тэр тусмаа сав шим ертөнцийн харилцан шүтэлцээ зэргийг огт ойлгодоггүй. Тал нутагт хэдэн зуу, мянган жил оршин тогтносоор ирсэн тал нутгийн логик хөгжлийн бодит зүй тогтолд нийцдэг гэж манай Чэнь Жэнь ярьдаг юм л даа. Манж Чин улсын эхэн болоод дунд үед хэрэгжиж ирсэн тал нутгийн талаарх хоёр зуун жилийн бодлого маш ухаалаг байжээ. Тариачдыг тал нутагт суурьшуулж болохгүй, тэгвэл түүнээс ч илүү гарз хохирол амсахыг урьдчилан харж чаджээ” гэж Жан Зи Юанийг хэлэхэд

Өлзийд “Талын логик” гэдэг үг ихэд таалагдав бололтой хэдэн удаа амандаа бувтнан хэлж цээжлэв. Дараа нь тэр “Манж Чин улсын хожуу үед тал нутгийн бодлого, дотор газрын хүн амын түрэлтийг даалгүй тал нутаг зүүн болон баруун хойд зүгт шахагдаж эхэлсэн юм. Одоо хариугүй говь цөлтэй хаяа нийлэх нь шиг байна. Хэрвээ цагаан хэрмээс хойш тэр чигээрээ говь цөл болон хувирвал Бээжин хот яах болж байна вэ? Бээжин урьд нь монголчуудын том нийслэл, өдгөө дэлхийн том хот шүү дээ гэж бодохоор монголчууд бид хүртэл сэтгэл өвдөөд байна шүү дээ. . . . .” хэмээн өгүүлэв.

Жан Зи Юань адуун сүрэг холгүй худгийн аман дээр ус ууж байхыг үзээд хуучин аж ахуйн даргын унааг сольж өгөхөөр ухасхийлээ.

## Арван найм

*Бүх азийг эрхиээлдээ багтаах гэсэн эртний Хань, Тан улсуудын мөрөөдлийг арван гурав, дөрөвдүгээр зууны үеийн Юань гүрний хаан Хубилай, Төмөр хоёр хаан буурал хятадын эрх ашгийн төлөө хэрэгжүүлж чаджээ. Тэгснээр Бээжин хот Орос, Туркестан, Перс, бага Ази, Гуулин, Төвд, Энэтхэг хятадын хойгийг багтаасан эзэнт гүрний нийслэл болон хувирсан юм.*

.....

*Бусдыг ноёрхсон эзэнт гүрэн байгуулсан үндэстэн төдий л олонгүй. Харин Ромчуудтай эн зэрэгцэхүйц тийм үндэстэн гэвэл Түрэг, Монгол хоёр билээ.*

*(Франц) Рени Гроссе*

*“Тал нутгийн эзэнт гүрэн”*

Чэнь Жэньгийн хутгаж буй сүүтэй зутангаас мах, сүү, шар будааны содон үнэр ханхалж гэрийн гадаа байгаа том ноход, жижиг гөлөгнүүд байж ядсандаа зөөлөн гаслалдана. Чэнь Жэнь энэ түмпэнтэй зутанг бэлтрэгт зориулан чанасан бөгөөд гөлөгний хоол бэлтгэх энэ аргыг түүнд Галсмаа зааж өгсөн юм. Тал нутагт нохойн гөлөг хөхнөөс гарахын өмнө хойно зайлшгүй сүү махтай зутангаар тэжээж эхлэх хэрэгтэй байдаг. Энэ бол гөлгийг өсгөлүүн болгох гол арга бөгөөд хөхнөөс гарсаны дараах гурав, дөрвөн сар түүний яс бөхжих үе тохиодог болохоор тэр үеийг алдчих юм бол дараа яаж ч тэжээгээд өсдөггүй гэж Галсмаа ярьдаг.

Нэгэн удаа чулуун хороо барьж байх үед Галсмаа ойролцоо байсан нэгэн сэгсгэр туранхай давжаа биетэй нохойг зааж “Энэ Барстай нэг эхээс цуг төрсөн юм шүү дээ. Ямар ялгаатай байгааг харж байна уу?” гэж билээ. Чэнь Жэнь нохдын дунд ч гэсэн Ү Сун, Ү Да Лан 19 нар шиг тэс өөр харилцан адилгүй ах дүү нар байх юм гэж огт бодож байгаагүй юм. Чонын сүрэг дунд амьдардаг тал нутагт нохой зөвхөн сайн үүлдрийн байх хангалттай биш, түүнийг юугаар яаж тэжээх вэ гэдэг маш учиртай ажгуу. Тийм болохоор тэр бэлтрэгийг тэжээхдээ цалгардалгүй Галсмаагийн туршлагыг бүрэн хэрэгжүүлж эхэлсэн нь энэ.

Галсмаагийн ярьсанаар, гөлөг хөхнөөс гарсан энэ зурвас хугацааны турш тал нутгийн бүсгүйчүүд өлөгчин чонотой уралдаж эхэлдэг байна. Өлөгчин чоно тарвага, зурам, хурга ишиг барьж бэлтрэгээ тэжээн тэднийгээ ан хийлгэж сургах гээд сэхээ самбаагүй ажилладаг. Тэдэнд зуух, гал, тогоо байхгүй болохоор бэлтрэгнүүддээ зутан чанаж өгөх боломжгүй боловч чонын ам төмөр тогооноос илүү тустай байдаг ажээ. Өлөгчин чоно шүд, ходоод, шүлсээрээ тарвага зурмын махыг зутагнуулж бэлтрэгнүүддээ тэжээдэг нь тэдэнд хамгаас тохиромжтой хоол болж хаврын нялх ногоо мэт хурдан өсөж торнидог бөлгөө.

Тал нутгийн бүсгүйчүүлд ноход нь шөнийн манаанд хамжилцан цалин цавагтай залгуулдаг болохоор өлөгчин чононоос ч илүү шаргуу ажиллах шаардлагатай. Тал нутагт айлын нохойн өнгө зүснээс тухайн гэрийн эзэгтэйн ажил үйлтэй, алхаг залхуу алин болохыг мэдэж болдог. Хожим Чэнь Жэнь Барсыг амаа олохгүй магтах болсон нь Галсмааг магтаж байгаагаас өөрцгүй хэрэг юм. Чэнь Жэнь урьд нь Барсаас дугуугүй том нохой тэжээж өсгөх юм сан гэж

боддог байсан бол өдгөө өлөгчин чононоос илүү сүрлэг сайхан чоно бойжуулахаар санаа шулууджээ.

Бэлтрэг тэжээж эхлэснээс хойш түүний амьдралд багагүй өөрчлөлт оров. “Чэнь Жэнь бүр байтлаа эмэгтэй хүнээс дутахгүй няхуур нямбай болон хувирлаа шүү” гэж Жан Зи Юань ямар сайндаа түүнийг егөөдөж байх билээ. Чэнь Жэнь нээрэн ч хүндэтгэн хайрлууштай өлөгчин чоно Галсмаа хоёроос илүү сэтгэл тавих хэрэгтэй гэдгээ ухаарчээ. Тэр гэрийн ажлаа ахиу хийнэ хэмээн ацаглаж Гао Зянь Жунгаас үхэр саах зөвшөөрөл олж авав. Мань хүн өдөр болгон мах хярж хөшиглөхийн зэрэгцээ яс төлжүүлэхийн тулд зөвхөн үнээний сүү төдийгүй кальцийн бэлдмэл нэмэх хэрэгтэйг ч ухаарчээ. Түүнийг бага байхад ээж нь кальцийн бэлдмэл уулгадаг байсан болохоор энэ талын бага сага мэдлэгтэй тул хярсан маханд бага сага үхэр хонины мөгөөрс холихоо мартажгүй. Нэг удаа аж ахуйн төв орохдоо ариун цэврийн станцаас нэг шил кальцийн бэлдмэл олж ирээд орой болгон гурилын модоор няцлан зутанд хольж хийнэ. Энэ тухай өлөгчин чоно Галсмаа хоёр бодоо ч үгүй биз ээ. Махтай зутангийн тэжээллэг чанар Чэнь Жэньд хангалтгүй санагдсан тул хэсэг шар тос, давс хольж самарна. Зутангийн сайхан үнэр хамар цоргиход өөрөө ч нэг аяга цохичихмоор санагдах боловч цаана нь гурван бяцхан гөлөг байгааг санаад шүлсээ гүдхийтэл залгив.

Тэр бүхний хүчинд бэлтрэг хурдан бойжиж, Энхамгалан хааны шаазан дүрс шиг гэдэс нь цодойгоод намрын мөөг шиг бондойн нохойн гөлөгнүүд түүний хамраар татахуйц болон өсчээ.

Чэнь Жэнь анх түүнийг зутангаар тэжээх гэж байхдаа махан тэжээлт араатан иддэг болов уу гэж санаа зовниж байлаа. Учир нь махтай зутан нэртэй боловч шар будаа зонхилно. Гэвч бүлээн зутанг бэлтрэгний өмнө тавингуут уухилан дайрч толгойгоо шаачихаад савны ёроолыг гялайтал долоогоод толгойгоо өргөсөн нь үнэхээр санаанд оромгүй хэрэг байв. Чоно будааны зутангаар хооллоно гэж тэр үнэхээр бодоогүй юм. Гэвч мах, сүүний хольцгүй дан будааны зутанг бол бэлтрэг тоож ч шиншлэхгүй болохыг тэр удалгүй олж мэдсэн билээ.

Бэлтрэгний зутан бүлээсчээ. Чэнь Жэнь зутантай түмпэнг хатавчны хажуу дахь тогооны тавиур дээр тавиад хаалгыг онгойлгон гараад хурдхан хаачихав. Арслангаас бусад ноход бэлтрэг бүгдээрээ түүнийг бүчин авлаа. Анч шар, Ирвэс хоёр түүний цээж рүү цоройн, амаа ангайлган аахилж эрүүг нь долоон саймширна. Гурван паацгар гөлөг Чэнь Жэньгийн шилбийг урд хөлөөрөө маажлан өмдний шуумагнаас зуув. Харин бэлтрэг хаалганы завсар руу хамраа шургуулан, гэрээс ханхлах зутангийн үнэрийг шиншлэнгээ дотогш орох гэж самардана.

Улаан цурав олон хүүхэдтэй ганц бие аав энийгээ гэсээр тэрийгээ орхичих гээд байх шиг Чэнь Жэньд санагдах үе олонтой. Тэр бэлтрэгтэй илүү хайртай боловч өөрийн гараар тэжээж буй хөөрхөн гөлөгнүүдийг гомдоочих вий гэж санаа зовнино. Тийм болохоор бэлтрэгийг хооллохоос өмнө гөлөгнүүдээ эрхлүүлэх хэрэгтэй.

Чэнь Жэнь анч Шар, Ирвэс хоёрыг ээлжлэн гэдсээр нь тэврээд хэд эргүүлсэн нь хоёр том нохойдоо хайртай дотноо илтгэн урамшуулж буй нь юм. Цаадуул нь тун тааламжтай байгаа бололтой эрүүг нь мөлчийтөл долоов. Дараа нь тэр гөлөгнүүдийн сугаар тэврэн агаарт өндөр өргөв. Газар тавьсаны дараа нэгийг нь ч үлдээлгүй толгойг нь илэх учиртай. Тэр бэлтрэг

тэжээснээс хойш нохдоо ийнхүү урамшуулан тайвшруулдаг болсон юм. Бэлтрэгийг авчрахаас өмнө ингэдэггүй, хааяа л нэгхэн эрхлүүлдэг байж билээ. Бэлтрэгийг олж ирснээс хойш нохдоо ийнхүү эрхлүүлж байхгүй бол эзнийх нь хайр халамж өөр бяцхан амьтан руу шилжсэнийг мэдсэн ноход түүнийг хазаад алчихаж ч мэднэ. Нүүдлийн амьдралын нөхцөлд бэлтрэг тэжээнэ гэдэг дарьтай торх сахин суугаа мэт өдөр хоногийг айж түгшин өнгөрөөх юм гэж тэр яахин санах вэ? Өдийд төл хүлээн авалтын зав чөлөөгүй үе тул тэднийхээр орж гарах малчид бараг үгүй. Олонх малчид түүний бэлтрэг тэжээж байгааг мэдээгүй, мэдлээ ч хэрэг болгон ирж үзэх хүн үгүй байв. Харин хожим яадаг бол? Бар унасан хүн бууж болдоггүй гэсэн үг бий. Тэгвэл чоно унасан хүн бууж бүр ч болохгүй бус уу?

Тэнгэр дулаарахын хэрээр борцолсон мах голдоо ортол хатжээ. Дутуу мөлжсөн ястай мах хатаж хорчийгоод урь идсэн боловч хаврын тарчиг цагт нохойны хүнсэнд тохиромжтой. Чэнь Жэнь махны сагс руу явахад сүрэг ноход араас нь дагав. Хамгийн урд явах Арслангийн толгойг Чэнь Жэнь сүвээндээ наалаа. Арслан эзэндээ улам дасаад байгаа болохоор хоол өгөх гэж байна гэж мэдээд түүний сүвээг шөргөөн тааламжтай байгаагаа илтгэнэ. Тэр сагснаас хэдэн дутуу мөлжсөн яс гарган нохдын хэр хэмжээнд тааруулан хувааж өгөөд гэрийн зүг алхав.

Бэлтрэг гэрийн үүдийг мэргэ маажласаар байх ажээ. Нэг сар гаруй тэжээсний хойно бэлтрэг тохой гаруй өндөр болж, дөрвөн хөл нь тэгшрээд чонын төрхөө олжээ. Цэнхэр салс бүрэн арилж, зэвхий шар нүд нь зүү шиг хурц харцаар төөнөх нь хамгийн содон шинж болов. Чонын хошуу шөвийн сунаж, хоёр чих нь муурынх шиг хэлбэрээ өөрчлөн соотойжээ. Магнай нь бөмбөгний гадар мэт дугуй хэвээр. Тэр гөлөгнүүдтэй арван хэд хоног цуг байсан болохоор бүр дасаад тоглож наадна. Гэвч Чэнь Жэнь хүн харгүй буюу шөнө оройн цагаар зугатчих вий гэж айгаад түүнийг нүхэнд нь хийдэг байлаа. Анч шар, Ирвэс хоёр энэ хээрийн амьтантай эвлэрсэн боловч тэгтэл саймшраад байхгүй. Бэлтрэг Ирвэсийн хөх рүү дайрахад цаадахь нь хошуугаараа шөргөөн годройтуулж орхино. Харин Арслан түүнд их л дотно тул бие дээгүүр нь авиран гараад үс ноос, чихнээс нь үгтээж, бааж шээж байсан ч эцэг нь мэт үл тоох тул бэлтрэг чонын үүрэнд байгаа мэт тааваараа өсөн торнино. Гэвч бэлтрэг нүд нээхээс өмнө үнэрлэх сэрлийн тусламжтай өөрийн үүрнээс ондоо газар байгааг мэдсэн нь Чэнь Жэнийг гайхшруулна. Чонын үнэрлэх сэрэл хараанаас илүү гоц хөгжжээ.

Чэнь Жэнь бэлтрэгийг тэврэн авлаа. Харин бэлтрэг хоол руугаа дайрч байх үед түүнд ойртож яасан ч болдоггүй юм. Чэнь Жэнь гэрт ороод бэлтрэгийг зуухны өмнө тавив. Бэлтрэг гэрийн тооноор тусах гэрэлд дасаад тогооны тавиур дээрх зэс түмпэнтэй зутанг олж харлаа. Чэнь Жэнь хуруугаа зутанд дүрж амсвал бэлтрэгний идэхэд яг сайхан тохирсон байх ажээ. Чоно халуун зүйлийг үзэж чаддаггүй. Бэлтрэг нэг удаа халуун зутанд амаа түлчихээд айсандаа сүүлээ хавчин гадагш гараад цас үмхэлж байж билээ. Түүнээс хойш мөнөөх зутангийн савыг үзэж чадахаа байсан тул энэ зэс түмпэнгээр сольсоноос хойш айхаа больсон юм.

Бэлтрэгийн орчны мэдрэмжийг сайжруулахын тулд Чэнь Жэнь үе үеэр таслан “Бэлт. . . рэг . . . ээ . . . хоо. . . лон. . . доо” хэмээн чанга дуугаар дуудав. Энэ үгийг дуулангуут бэлтрэг дээш цоройлох нь команд сонссон анч нохойноос ч хавьгүй илүү шалмаг ажээ. Чэнь Жэнь идүүрийг газар тавьчихаад хоёр алхмын зайтай цомцойн сууж, түмпэнгийн ирмэгийг гишгэж асгахаас сэргийлэн галын хайчаар хавчив. Бэлтрэг ч толгойгоо түмпэн рүү шургуулаад идэж

уухыг ёстой үзүүлж өглөө.

Энэ хорвоо дээр чоно л идшийг тэнгэр мэт дээдэлдэг амьтан байх даа. Түүний хажууд иргэн идэш хоолыг тэнгэрээ мэт үздэг гэсэн яриа жирийн нэг хэтрүүлэг төдийхөн юм. Хүн зөвхөн хэт өлссөн үедээ л зэрлэг араатан шиг идэш хоол руу дайрдаг байж мэднэ. Харин өдөр болгон цадтал идэж байгаа энэ бэлтрэг ямар ч үед одоо л сайн идээд авахгүй бол удалгүй тэнгэр нураад ирэх гэж байгаа мэт өлөн чонын төрхөө хэзээ ямагт хадгалах ажээ. Чоно хоол идэж байхдаа хавьтсан ойртсон бүхэн рүү ярдаглана. Өдөр болгон өөрийг нь сэтгэл тавин тэжээж байгаа Чэнь Жэнь ч хоолыг нь булаан амийг нь авах гэж байгаа дайсан мэт хандах нь бий.

Энэ нэг сарын хугацаанд Чэнь Жэнь бэлтрэгтэй их л дасалцан, түүнийг өргөж, тэвэрч, маажиж, чимхэн толгой мөрөн дээрээ суулгах нь байтугай, хамраа хошуунд нь хүргэж, хуруугаа аманд нь хийхэд хүртэл яадаг ч үгүй болжээ. Харин түүнийг хоол идэж байх үед нь холхон суучихаад харж байхаас өлзийтэй юм үгүй. Тэр үед өчүүхэн жаахан л хөдлөх юм бол шүдээ ярзайлган зооны үсээ босгоод хойд хоёр хөл дээрээ атиран урагш ухасхийн уралцан дайрахад бэлэн мэт архирна. Чэнь Жэнь түүний энэ ярдаг занг өөрчлөхийн тулд эрдэнэ шишийн ишээр хийсэн шүүрний толгойгоор биед нь зөөлөн хүрч үзсэн юм. Гэвч шүүрний толгойг жаахан хөдөлгөх төдийхөнд л бэлтрэг уурсан дайрч ирээд түүний гараас шүүрийг булаан авч ноцоход Чэнь Жэнь айсандаа хэдэн алхам ухрав. Бэлтрэг хурга барьсан адил толгойгоо савчин шүүрийг ноцсоор хэдэн ширхэг өвсийг таслан хаясан юм даг. Чэнь Жэнь ч мөчөөгөө өгсөнгүй хэд хэдэн удаа туршиж үзэхэд бэлтрэг шүүрийг нэгэн тэнгэрийн дор хамт байшгүй өшөөтөн дайсан мэт санаж урж ноцсоор өвсийг нь талаар нэг тараан хаяжээ. Гао Зянь Жунгийн шинээр худалдан авсан шүүрнээс мухар иш үлдсэнд хорсохдоо бэлтрэгийг хэд гөвшөөд авч билээ. Түүнээс хойш Чэнь Жэнь бэлтрэгийг хоол идэж байхад толгойг нь илэх бодлоосоо хэсэг зуур татгалзжээ.

Чэнь Жэнь энэ удаагийн сүүтэй зутанг урьдынхаас хоёр дахин их чанасан бөгөөд жаахан үлдээчихээр нь жаал цийдэм, махны өвдөл цөвдөл зэргээр сэлбэж гөлөгнүүдээ тэжээе гэж боджээ. Гэвч бэлтрэгний идэж байгаа янзыг харвал шальгай юм үлдэхгүй нь бололтой. Бэлтрэгний идэж ууж байгаа байдал төрх нь талын чонын хэдэн мянган жилийн араншинг бүрэн өвлөснийг илтгэнэ. Чонын идэж байгаа нь хүртэл дайны цагийн цэргийн хүний төрхтэй ижил. Магадгүй цэргийн хүн эсрэгээр чонын эл байдлыг дууриасан байж ч мэдэх юм. Учир нь түүний үлдээсэн хоол дайны нөхцөл байдлаас шалтгаалаад хойд насандаа идэх хувь болон үлдэхийг хэн мэдэх билээ. Бэлтрэгний хоол идэж байгаа янз нь үйл тамаа үзэн байж үмх хоолтой залгасан хэрмэл тэнүүлчинтэй адил харагдсанд Чэнь Жэньгийн сэтгэл шимшрээд явчихав. Хэрвээ идэш хоолны төлөө ингэж л зүтгэдэггүй юм бол барс, баавгай хүртэл оршин тогтнох аргагүй монголын хахир хатуу талд чоно гээч амьтан яахин тэсэж үлдэж чадах вэ?

Чэнь Жэнь энэ бүхнээс талын чонын оршин тогтнохын төлөөх тэмцэл хичнээн хатуу бэрх гэдгийг ойлгож мэджээ. Үржих чадвар сайтай талын чонын үр төлийн аравны нэг хүрэхгүй хувь нь үлдэж хоцрох тавилантай байдаг гэлцдэг. “Тэнгэр заримдаа талын чоныг хатуу чангаар гэсгээх явдал цөөнгүй. Өвдөгцөө цас унагаж тал нутгийн олонх чоныг осгоож, өлсгөж алдаг. Заримдаа талын түймэрт сүрэг чоно шатаж үхэх нь ч бий. Байгалийн гамшгийн бүсээс арай ядан амь зулбан гарч ирсэн чонон сүрэг уурандаа өөр нутгийн чонон сүргийг

тасчин хаях явдал цөөнгүй. Дээр нь хүмүүс хавар бэлтрэг суйлж, намар, өвөл гэлтгүй хомрогolon устгах тул тэр бүхний хойно тоотой хэдэн чоно л үлдэж чадна. Цатгалан чононууд өлөн чонон сүрэгт бариулаад дуусдаг болохоор одоо үлдэж хоцорсон нь өлөн чонын хойчис юм. Монголын тал угаас дайны талбар байсаар ирсэн болохоор хамгийн хүч чадал, ухаан билиг төгс, идэж ч чаддаг, дайтаж ч чаддаг атлаа цатгалан үедээ өлөн байхын зовлонг мартдаггүй чоно л үлдэж хоцрох боломжтой байдаг юм” хэмээн Билиг өвгөн ярьдаг.

Бэлтрэг хоол руу хомхойрон дайрах нь идэш тэжээл гэдэг чонын хувь тавиланд хичнээн чухал болохыг Чэнь Жэньд сайтар ойлгуулжээ. Оршин тогтнохын төлөөх хатуу ширүүн өрсөлдөөн дунд хэдийгээр сайн үүлдрийнх байлаа ч гэсэн хоолоо булаан олж идэж чадахгүй, өлөн зэлмүүн байхын аймшигийг ганц яс, үртэс махан дээр ч харуулж чадахгүй юм бол чонын ертөнц дэх Ү Да Лан болон хувирч эцэстээ байгалийн шалгарлаар хасагддаг ажээ.

Монгол талын чононд оршин амьдрахуйн цэвэр ариун итгэл үнэмшил олон байдгаас хамгийн ил тод нь идэш хоолны төлөө амь насаа гаргуунд гаргахаас буцахгүй болон омог бардам амиа авч явах зан чанар болохыг Чэнь Жэнь зугуухандаа ойлголоо. Чэнь Жэнь бэлтрэгийг хооллож байхдаа нохойн гөлөгнүүдийг тэжээх үеийн өглөгийн эзний дүр төрхийг бүрэн алддаг юм. Бэлтрэгт угаас бусдын гар харж амьдрах ухамсар үгүй болохоор хоол барьж ирэх эзнээ хараад сүүл годгонуулан баясалдах нохойн гөлөгний налигануур зан огт илэрдэггүй. Бэлтрэг идэж байгаа бүхнээ хүний өглөг хишиг бус өөрөө эрийн сайндаа олж авсан мэтээр үзэх тул Чэнь Жэньгийн ачлалд өчүүхэн ч талархана гэж үгүй. Тэр ч байтугай олдсон хоолоо хамгаалахын тулд амь насаа ч хайрлахгүй тулалдахад бэлэн байх ажээ. Чэнь Жэнь бэлтрэг хоёрын харилцаанд тэжээж өсгөнө гэсэн үг тохирохгүй харин бэлтрэгний хувьд түр зуур хоригдож байгаа гэвэл үнэнд арай ойртох юм. Бүрэн толгой даан амьдрах болон гаршин дасахгүй гэсэн үзэл санаа бэлтрэгийг хоолны төлөө үхэн хатан тэмцэх зан чанарыг суулгаж өгчээ. Тийм болохоор Чэнь Жэнь бэлтрэгийг том болтол нь тэжээж чадах болов уу гэдэгтээ эргэлзэн хүйтэн хөлс нь чийхарлаа.

Чэнь Жэнь эцэстээ бэлтрэгийг хоол идэж байх үед нь илэх бодлоо бүрмөсөн таягдан хаяж, түүний энэхүү омог бардам унаган занг нь хүндэтгэж үзэж байхаар шийджээ. Бэлтрэг цадсаныхаа дараа хоолыг шилж идэж байхыг Чэнь Жэнь олж мэдсэн юм. Тэр бяцхан хямсаа мэт хэлнийхээ шөвгөр үзүүрээр махны өвдөл цөвдлийг түүн амандаа хийнэ. Тэгсээр зутан шөлөнд зөвхөн шар будаа л үлдэх ажээ. Чэнь Жэнь дахин нарийвчлан хараад баясал тодорлоо. Бэлтрэг цагаан шаргал зутан дундаас цагаан өөх болон мөгөөрсийг хүртэл ялган түүж чаддаг ажээ. Бэлтрэг хоол идэх зуур гахай хоншоороороо онгичдог шиг, хамраараа зутанг төнхчин дундаас нь мах, өөх, мөгөөрсний өвдөл цөвдлийг олж амандаа хийсээр байх ажээ. Сүүлдээ ганц ч өвдөл цөвдөл үлдээгүй байхад хүртэл тэр толгойгоо өөд татахгүй байлаа. Чэнь Жэнь хүзүү сунган түүний юу хийж байгааг хараад бараг инээд алдах шахав. Бэлтрэг хошуугаар зутанг дарж хонхойлгоод тунасан сүүг ууж байлаа. Тэр толгойгоо өргөх үед холимог зутангийн шим шүлт юу ч үгүй болоод зөвхөн шар будааны шаар шавхруу төдийхөн үлджээ. Энэ жаахан амьтан ийм шунаг атлаа ухаалаг байх гэж хэмээн бодоод Чэнь Жэнь уур ч хүрэх шиг, инээд ч хүрэх шиг болов.

Чэнь Жэнь арга буюу түмпэнд атга мах, жаахан сүү, ус хийгээд яаж ч зуурсан нэг л зутагнаж өгөхгүй байлаа. Тэр түмпэнг авч гараад нохойн идүүрт хийхэд гөлөгнүүд ухасхийн дайрсан

боловч удаж төдөлгүй дурамжхан байгаа бололтой гаслалдаж эхлэв. Мал ахуй гэгч амаргүй ажлын дотор нохой хооллоно гэдэг бас л адармаатай. Дээр нь нэг чоно нэмэгдэхээр бүр ч хэцүү мэт түүнд санагдана. Гэвч энэ булууг тэр өөрөө хар толгой дээрээ овоолсноос хойш яая гэхэв.

Бэлтрэг бүр сарвайтлаа цадсан болохоор газар хэвтчихээд гөлөгнүүдийн хоол идэхийг харна. Тэр цадсан хойноо яаж ч байсан гэмгүй тул Чэнь Жэнь түүнийг “Бэлтрэг ээ, бэлтрэг ээ” хэмээн дуудав. Бэлтрэг дээш хөлбөрөн, толгойгоо газар наачихаад түүнийг томоогүй янзтай харна. Чэнь Жэнь түүний сугаар тэврэн дээш тав зургаан удаа өргөхөд бэлтрэг айж баярласан янзтай амаа ангайх боловч сүүлээ тас хавчин хөл нь чичирч байлаа. Гэвч бэлтрэг Чэнь Жэньгийн энэхүү нөхөрсөг үйлдэлд овоо дасаад байгаа юм. Чэнь Жэнь бэлтрэгийг толгой дээгүүрээ давуулан мөрөн дээрээ суулгахад их л айсан бололтой захнаас нь тас зуурав.

Чэнь Жэнь газар завилан суугаад бэлтрэгний гэдсийг дээш харуулан иллээ. Жингэр нохой өлөгчин чоно бяцхан үрийнхээ гэдсийг долоон хоол шингээхэд тусладаг энэ үүрэг одоо Чэнь Жэньд өвлөгдөн иржээ. Чэнь Жэньд өөрт нь ингэх зугаатай байдаг бөгөөд бэлтрэг их тааламжтай байгаа бололтой зөөлөн гийнаж, унгаж хэхэрнэ. Хоол идэх үедээ их л хэрцгий догшин болчихдог бэлтрэг энэ удаа нохойн гөлөгнөөс өөрцгүй номхроод урд хоёр хөлөөрөө түүнийг хурууг зууран долоож, зөөлөн хазлах ажээ. Ийнхүү зөөлөн илэхэд бэлтрэгний харц уясан талимаарч, өөрийг нь халамжтай хойд эхийн багцаанд үнэлж байх шиг.

Зовлонгийн эцэст бэлтрэг түүнд хувь илүү цэнгэл амсуулна. Алс тэртээх балар цагт аль эсвэл одоо ч гэсэн хаа нэгтэй өр нимгэн өлөгчин чоно хэлээрээ подойтол цадсан “Шаалуухүүгийн” гэдсийг долооход чармай нүцгэн жаал хөлийн хуруугаа хөхөн тас тас хөхөрч байгаа дүр зураг Чэнь Жэньгийн нүдэнд харагдах шиг боллоо. Сүрэг бэлтрэг мань тарган жаалыг яах ч үгүй харин ч үмх мах зуун ирээд түүнд өгөх шиг. Эртнээс нааш хичнээн олон өлөгчин чоно шаалуухүү нарыг өсгөж, хэдэн хүн чонын бэлтрэгийг тэжээж байсан бол доо. Олон жилийн турш дуулж сонссоор ирсэн чонын тухай домогт өөрөө оролцон түүний уян зөөлөн сайн зан чанарыг биеэрээ мэдрэн, гараараа тэмтрэх боломж ийнхүү тохиодог ажээ. Түүний сэтгэл огшин Хүннү, Гаочө, Түрэг, Ром, Энэтхэг болон өдгөөгийн Зөвлөлтөд олдсон шаалуухүү нарын өмнөөс чононд гүн хүндэтгэлээ илэрхийлмээр ч юм шиг. Тэр доош тонгойн хамраа бэлтрэгний чийгтэй хоншоорт хүргэхэд цаадахь нь нохойн гөлөг мэт эрүүг долоож сэтгэлийг гижигдэв. Энэ нь бэлтрэг түүнд улам дасаад тэр хоёрын сэтгэлийн зангилаа бөхжиж байгаагийн нэгэн илрэл байлаа. Чэнь Жэнь энэхүү цэвэр ариун нөхөрлөлийг тааламжтай эдлэхийн сацуу өөрийнх нь амин сүнс бүр эрт балар үе рүү хөврөн одох шиг. Тэр өөрөө насан өндөр болсон хэр нь хүн төрөлхтний идэр бага насны зэрлэг томоогүй сэтгэлийг өвлөн авсан мэт санагдлаа.

Энэ бэлтрэг эхээс хагацан хөдөө хээр хөсөр хаягдсан байхыг олж ирээгүй шүү дээ гэдэг эмзэглэл хааяа нэг түүний сэтгэлийг шаналгана. Хэрвээ хөдөө хээр үхэх гэж байхад нь олж ирсэн бол байгалийн унаган хайр хэмээн тооцож болох боловч үүрнээс нь хулгайч мэт булаан авч ирсэн нь нэг л хиймэл зохисгүй мэт санагдана. Тэр өөрийн ангууч зан болон судалгаандаа ашиглахын тулд өдгөө хүртэл яруу алдраа дуурсгасаар ирсэн хүн, чоно хоёрын нандин харилцааг хүчээр өөдөө сөөргөө урсгалд оруулчихаагүй байгаа даа. Заримдаа бэлтрэгний эх

өлөгчин чоно өшөөгөө авах гээд ирэх юм биш байгаа гэж зовних үе цөөнгүй. Энэ магадгүй шинжлэх ухаан, соёл иргэншлийн явц дундахь хүйтэн цэвдэг явуургүй үйлдэл ч байж мэдэх юм. Гэвч түүний энэхүү хүйтэн цэвдэг бусармаг үйлдлийг тэнгэр ойлгоосой билээ. Түүний цаад санаа гэвээс бэлтрэгээр дамжуулан тал нутгийн нүүдэлчин угсаатны чонон сүлдний оюунлаг ертөнцөд нэвтрэн орох гэсэн юм шүү дээ.

Арслан хоолоо идэж гүйцээд Чэнь Жэнь рүү зугуухан дөхөж ирэв. Чэнь Жэнь бэлтрэгний гэдсийг илэх үед Арслан дэргэд нь ирчихээд сониучирхан харах буюу заримдаа гэдсийг нь долоож өгдөг. Чэнь Жэнь Арслангийн толгойг илэхэд цаадахь нь завьжаа шазайлган эрхлэв. Чэнь Жэнь бэлтрэг тэжээж эхлэснээс хойш Арслан тэр хоёрын харилцаа илт дотносч билээ. Арай өөрийнх нь биед ч гэсэн зэрлэг араншин, чонын зан чанар байдгийг тэр шиншлэн мэдсэн юм биш байгаа даа. Зэрлэг араншин, чонын зан чанартай хүн нохой хоёр жинхэнэ чонотой нийлчихээд зэрлэг араншин, чонын зан чанараар дүүрэн тал нутагт хамтран амьдарч байна гээд бодохоор сонин хэрэг болох биш үү гээд бодтол түүний дэврүүн сэтгэл өтөл насны өндөрлөг рүү авиран хүрэх шиг болов. Тэр эрт балраас эдүгээ үеийг хүртэл эрэгцүүлж нэг бодоход эрт балрын мэдрэмж хавьгүй үнэнд ойрыг ухаарахын хэрээр түүний амь нас ч төдий хэрээр уртсах ажээ. Орчин үеийн хүмүүс балар эртний орчинд гайхамшгийг ангуучлахыг хүсдэг нь далд мэдрэхүйн гүнд нийтлэг ойлгоцоос тэс анги байдлаар өөрийнхөө насыг сунгах гэдэг юм биш биз дээ? Чэнь Жэньгийн амьдрал гэнэт Шаалуухүүгийн үлгэрээс ч өвөрмөц сонирхолтой санагдаад явчихлаа.

Талын чонын амьдралыг ухаангүй сонирхож эхлэсэн цагаас хойш түүний цусан дахь арчаагүй сул дорой чанар багасаад судсаар нь нэг л танил бус атлаа чонын араншин дүүрэн цус гүйж эхэлсэн билээ. Түүний хэрээр амь нас нь ч эрч хүчээр дүүрч урьдын нэгэн хэвийн уйтгартай санагддаг байсан амьдралдаа одоо хавьгүй сэтгэл хангалуун явах болжээ. Тэр аажимдаа “Цагаан соёот” зохиолд үхлийг сөрөн зогсож байгаа чоныг гол баатраа болгосныг ойлгож эхэллээ. Амь нас нь дээсэн дөрөөн дээр дэнжигнэж байсан Ленин яахаараа амьдралынхаа сүүлчийн мөчүүдэд эхнэрээрээ Жек Лондоны “Цагаан соёот” зохиолыг уншуулж байсан байх билээ? Ленин хүн, чоно хоёрын тэмцлийн тухай сонссоор өнө мөнх нойрсоход харь үндэстний чонон сүлд түүнийг Маркстай уулзуулахаар авч одсон байж болох биш үү? Энэ хорвоогийн эрч хүч дүүрэн аугаа хүн хүртэл аглаг тал, араатан чононоос амьдралын мөн чанарыг эрэлхийлж байхад өөр шиг нь эгэл хүмүүнийг өгүүлэх юун.

Чэнь Жэньгийн санаа бодол холын холд хөвөрсөөр. Амьдралын мөн чанар хөдөлгөөнд бус, тэмцэлд байдаг болохыг тэр ухаарчээ. Сүүн тэжээлт амьтдын амь насны үндэс болсон хэдэн зуун сая эр эс үхэн хатан тэмцэлдээд, нэг өндгөн эсийг бүрхэн авч алалдсаар тэдний цорын ганцаас бусад нь үхдэл болон хувирдаг. Тэдгээрийн доторх хөдөлгөөнтэй атлаа тэмцэх чадваргүй сул дорой хэсэг нь шигшилтийг даалгүй хоцроод шээдэг сүвээр гадагш хаягдана. Харин тэмцэх чадвар хамгийн сайтай ганцхан баатарлаг эс л хэдэн зуун сая ахан дүүсийнхээ хүүрэн дээгүүр гишгэчин туучсаар өндгөн эс рүү нэвчин орж, анхны ураг бүрэлддэг байнам. Тэр зуур өндгөн эс тасралтгүй дотоод шүүрэл ялгаруулан тэмцэх чадвар султай эр бэлгийн эсүүдийг алсаар байдаг. Амь нас тэмцлийн дунд бүрэлддэг болохоор амьдралын мөн чанар тэмцэл ажгуу. Газар тариалан гэдэг өөрөө аядуу хөдөлмөр учраас эртнээс нааш олон олон аугаа суурьшмал соёл иргэншлүүд мөхсөөр ирсэн байдаг бол нүүдлийн мал аж ахуй, далайн аялал, аж үйлдвэрлэл зэрэг нь цаг мөч бүхэн хайр найргүй ан гөрөө, дайн тулалдаан, далайн



байлдаан, бизнесийн хагуу ширүүн өрсөлдөөн дунд орших хэрэгтэй болдог. Өдгөө дэлхий дахинд дэвшин хөгжсөн үндэстнүүд бүгдээрээ нүүдэлчин, далайчин болон аж үйлдвэржсэн үндэстнүүдийн үр хойч нар юм. Умард азийн хүйтэн цэвдэг үржил шим муутай орчинд хоёр том гүрний дунд хавчуулагдан орших хүн амын хувьд цөөн тоотой монгол үндэстэн өдгөө хүртэл мөхөлгүй оршин тогтносоор ирсэн нь эртний Египет, Вавилон болон энэтхэгийн олон суурьшмал үндэстнүүдээс илүү амьдрах, тэмцэх хүч чадалтай байсных юм.

Бэлтрэг Чэнь Жэньгийн хөл дээр тогтохгүй тонгочиж эхлэсэн нь сарих гэсэн хэрэг байлаа. Тэр мөн Арсланг хараад түүнтэй тоглохыг хүсчээ. Чэнь Жэнь гараа султгавал бэлтрэг үсрэн бууж сарьчихаад Арслан дээр очиж ноцолдов. Гөлөгнүүдийн хувьд уул шиг том Арслан тэднийг тааваар наадуулна. Бэлтрэг Арслангийн нуруун дээр гарчихаад гөлөгнүүдийг дээш гаргалгүй түлхэн унагаад сэтгэл ханахгүй архирч сүрдүүлэх нь уулын эзний дүрийг илтгэнэ. Хоёр эр гөлөг түүн рүү гэнэдүүлэн дайрч чих сүүлнээс нь хазан газар унагахад нөгөө эм гөлөг ч хамжилцан гурвалжин дөрвөлжин ноцолдоон болж тоос шороо босгов. Гэнэт нэгэн эр гөлөг гаслахыг үзвээс бэлтрэг үнэнээсээ уурлан түүний хөлийг хазан цус гоожуулжээ.

Чэнь Жэнь асуудлыг шудрагаар шийдэх санаатай бэлтрэгийн шилнээс өргөн шархадсан гөлөгний өмнө авчраад, толгойг нь дарж шархыг долоолгох гэсэн боловч цаадахь нь буруугаа хүлээх янзгүй, харин ч шүдээ ярзайлган архирсанд гөлөгнүүд айсандаа Ирвэсийг бараадан зугатлаа. Ирвэс уурандаа шатаж байгаа бололтой гөлөгнийхөө шархыг хэд долоосноо бэлтрэгний өмнө давхин ирээд чанга дуугаар хуцан урахаар завдав. Чэнь Жэнь бэлтрэгийг ум хумгүй шүүрэн тэврэхдээ хоёр том нохой хэзээ нэгэн өдөр түүнийг хазаад алчих вий гэж зовнин зүрх нь түг түг цохилж байлаа. Тусгай торон хашаагүй нөхцөлд ийм түрэмгий амьтныг тэжээнэ гэдэг үнэхээр амаргүй хэрэг ажээ. Чэнь Жэнь Ирвэсийн хүзүү толгойг илэхэд бага зэрэг тайвширсан бололтой бэлтрэгийг газар тавихад тоосон шинжгүй гөлөгнүүдтэйгээ тоглосоор холдон явав. Бэлтрэг дахин Арслангийн нуруу өөд мацахад цаадахь нь тоглог тоглог гэсэн шиг амгалан налайх нь гайхалтай.

\* \* \*

Нохдоо хооллож гүйцээд Чэнь Жэнь нүүх суухдаа бэлтгэн үхэр тэргээ янзаллаа. Гэтэл Билиг өвгөн үхэр тэргэн дээр хэсэг мод аччихсан тэднийхийг чиглэн ирж яваа харагдав. Чэнь Жэнь яаран сандран тэргэн дээрээсээ үсрэн бууж бэлтрэгийг нүхэнд нь хийгээд дээрээс нь мод чулуугаар даржээ. Түүний зүрхийг бул хар чулуу дараад байгаа мэт түг түг цохилно.

Анч шар, Ирвэс хоёр гөлөгнүүдтэйгээ сүүлээ шарвагануулан өвгөнийг тосоход Чэнь Жэнь үхэр тэргийг нь салгаж хүнд мужааны багажийг тэргэн дээрээс буулгаж өгөв. Отор нүүдлийн өмнө өвгөн ёс юм шиг илгээлтийн эздийн үхэр тэргийг засаж сэлбэж өгдөг юм. “Аав аа, . . . . Би үхэр тэргээ засаад аргалчих байх аа. Үүнээс хойш та өөртөө ингэж төвөг удаж хэрэггүй” хэмээн Чэнь Жэнь сэтгэл түгшингүй хэлэв.

“Аргалчихна гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? Энэ удаа бид замгүй газраар хоёр гурав хоногийн хол зам туулна. Нэг л айлын тэрэг чарга саатвал бусдынхаа ажлыг хойш чангаана гэсэн үг” хэмээн өвгөн өгүүлэв.

“Аав аа, та ороод аяга цай ууж бай. Тэр хооронд би тэргээ суллаадахья” хэмээн Чэнь Жэньг

Өвгөн хариуд нь “Та нарын чанасан хар цай амнаас уначих гээд байдаг юм” гэснээ хүнд чулуугаар даруулсан ширээний тавцангийн зүгт очиж царайгаа барайлгаад “Би эхлээд та нарын тэжээсэн бэлтрэгийг хараадахъя” гэв.

Чэнь Жэньгийн сүнс зайлах шахан “Та хараад хэрэггүй байх аа. Дотогш орж цай уу” гэв.

“Нэг сар гаруй болчихоод байхад би яагаад харж болдоггүй билээ?” хэмээн өвгөн нүдээ бүлтийлгэн дуугаа өндөрсгөв.

Чэнь Жэнь зоригоо чангалан “Аав аа, би энэ бэлтрэгийг том болгосон хойно монгол нохойтой эвцэлдүүлж овчарк нохой гарган авах гэсэн юм л даа. . . ” гэхэд

Өвгөн уурандаа шатан чанга дуугаар “Битгий донгос. Гадаадын чоно л гэрийн нохойтой эвцэлддэг юм байгаа биз. Харин манай монгол чоныг тэгнэ гэж бүү горьд. Монгол чоно жирийн жингэрийг тоож шиншилнэ гэж сэрүүн зүүдлэхээ больж үз. Нохойгоо чонын хоол болгох чинь дутаа юу?” хэмээн бачимдсандаа ямаан сахал нь чичирхийлж “Та нар улам бүр болохоо байж байна шүү. Би өдий жар гаруй наслахдаа тал нутагт чоно тэжээсэн хүнийг дуулаагүй юм байна. Чоныг нохойтой ижилсүүлэн тэжээж болдог хэрэг үү? Чонотой харьцуулбал нохой юу юм бэ? Нохой хүний өтөг иддэг бол чоно шарилыг нь зооглодог амьтан. Нохой өтгийг нь иддэг болохоор хүний боол зардсан төдийхөн бол чоно шарилыг нь зооглодог болохоор хүний сүнсийг тэнгэрт аваачих хувилгаан сахиус гэгддэг юм. Чоно нохой хэмээх тэнгэр газар шиг ялгаатай хоёр амьтныг нэг дор хорьчихоод тэжээж болно гэж яаж бодоо вэ? Мөртлөө тэднийг эвцэлдүүлэх юм гэнэ. Хэрвээ манай монголчууд танай хятадын дээдэлдэг лууг мэгжтэй эвцэлдүүлнэ гэвэл та нар яах бол? Хувилгаан сахиусанд халдсан нүгэлд унана биз дээ? Та нар монголчуудын өвөг дээдэс, тэнгэр шүтээнд халдсаны нүглийг амсах болно. Тэр бүхэн чинь өвгөн миний хар толгойд ч тусах юм бил үү. . . . ” гэв.

Чэнь Жэнь өвгөний ингэтэл уурлаж бухимдаж байхыг ерөөсөө хараагүй юм. Бэлтрэг хэмээх дарьтай торх дэлбэрээд Чэнь Жэньгийн зүрх сэтгэлийг бутниргэж орхилоо. Хашир чоно шиг хэрсүү өвгөн уурандаа урдах чулууг өшиглөж хөлөө гэмтээгээд зогсохгүй, бэлтрэгийг дараад алчих вий дээ. Өвгөн хөмхий зуун их л хорссон байдалтай “Би та нарыг бэлтрэг тэжээж байгаа гэдгийг дуулаад тал нутгийн дэг жаяг, хориг цээрийг ойлгохгүй дотор газрын хятад оюутнууд хэд хоног зугаагаа гаргаж байгаад болино биз гэж бодож байсан юм. Гэтэл хэрэг явдал бүр бишдээд Дорж хүртэл өөр нэгэн бэлтрэгийг нохойтой эвцэлдүүлэх гэж авсан гэнэ. Ингэж яаж болох вэ? Өнөөдөр та нар миний нүдэнд наад бэлтрэгнийхээ учрыг олоодох. . . . . ” гэлээ.

Чэнь Жэнь маш том гай барцад тарьсанаа ухаарлаа. Мянга мянган жилийн турш талын чоныг тэжээж байсан түүх үгүй ажээ. Сайн эрийг алж болохоос ялж чадахгүй гэсэн үг байдаг. Тэгвэл чононд сүслэж болохоос биш тэжээж болдоггүй амьтан байжээ. Гэтэл нэгэн хятад залуу монголчуудын өвөг дээдсийн нутагт, мөнх тэнгэрийнх нь дор араатны хаан, амьдрах ухааны багш, дайны сахиус, тал нутгийг хамгаалагч сүлд хэмээн дээдлэсээр ирсэн чоныг гэрийн нохойтой ижилсүүлэн тэжээж эхэлсэн нь үнэхээр тэнгэрийн ёсонд харш зүйлийг үйлджээ. Хэрвээ Чэнь Жэнь энэ хэргийг эрт дээр цагт үйлдсэн бол нүгэлт буруу номтон

хэмээн гэсгээгдэж таван морины сүүлэнд тасар татуулан үхээд өгөр ясыг нь нохойд хаяж өгөх байсан буй за. Одоо ч гэсэн энэ нь улсын цөөнх үндэстний бодлогод харшилж, нүүдэлчин монголчуудын сэтгэлийг сэвтээсэн үйлдэл бус уу? Өөрийг нь тал нутгийн чонон сүлдийн нууцлаг оюун санааны ертөнцөд хөтлөн оруулсан монгол өвгөн болох Билиг аавыгаа ингэтэл уурлуулж гомдоосондоо тэр бүхнээс илүү гэмшин айж байлаа. Тэр тусмаа өвгөний заавар зөвлөлгөөгөөр чонын бэлтрэгнүүдийг суйлан гаргасан билээ. Тийм болохоор тэр өөдөөс нь маргаж мэтгэн ямар нэгэн тайлбар тавих арга байсангүй. Чэнь Жэнь арга барагдсан байдалтай “Аав аа. . . хэмээн дуудав. Өвгөн ханцуйгаа сэгсрэн “Битгий намайг аав аа гэж дуудаад бай” гэхэд Чэнь Жэнь цөхрөнгүй байдалтай “Аав аа, аав аа. Энэ бүхэн миний түмэн буруу. Би тал нутгийн дэг жаягийг ойлгохгүйдээ таныхаа өмнө ийм нүгэл үйлдлээ. . . .Аав аа, би энэ хөөрхий амьтны учрыг яаж олох юм бэ? Та надад хэлж өгөөч дээ” гээд түүний нулимс жолоогоо алдан бөмбөрч бэлтрэгний саяхан эрхлэн тоглож байсан газар дуслалаа.

Өвгөн Чэнь Жэньг зог тусан гөлөрч хэсэг зуур бэлтрэгний учрыг хэрхэн олохоо шийдэж ядан байх шиг. Чэнь Жэнь нохойтой ижилсүүлэх гэсэн биш, ерөөсөө л чононд ухаангүй хайртай болсондоо бэлтрэгийг тэжээж эхэлсэн гэдгийг Билиг өвгөн сайн мэдэж байлаа. Хирийн монгол залуусаас илүү чоныг сонирхон хайрладаг болохоор хүү шигээ санаж зааж сургасаар ирсэн Чэнь Жэнь хэмээх энэ хятад залуу өөрийнх нь хувьд эвлэршгүй ийм том нүглийг үйлдсэн байх гэж. Ядаж өвгөн ийм хэрэгтэй учирч байгаагүй болохоор хэрхэн шийдэх аргыг үнэхээр хэлж мэдэхгүй тулгамджээ.

Өвгөн тэнгэр өөд харан уртаар санаа алдаад “Танай хятад оюутнууд Бурхан сахиусанд сүжиггүй болохоор сүнсээ боддоггүй гэдгийг чинь би мэднэ л дээ. Энэ хоёр жилийн хугацаанд чи тал нутаг болон чононд их элэгтэй болсон хэдий ч аавынхаа сэтгэлийг ойлгох мөн ч болоогүй байна даа. Аав чинь хөгшин ямааны насгүй болоод чадал хүч жил ирэх тусам л доройтож байна. Тал нутгийн хатуу хүтүү нөхцөлд хүнд хүчир ажилд нухлагдсаар монгол настангууд өвчин эмгэгт баригдан өндөр наслах нь төдийлөн олон биш. Хэдхэн жилийн дараа аав чинь энгэрээ дэрлэн, тэнгэртээ зорчих нь лавтай. Гэтэл чи яахаараа аавын чинь ариун сүнсийг тэнгэрт аваачдаг чоныг нохойн хороонд хорьдог билээ? Чиний энэ нүгэл аавын чинь хар толгой дээр тусаад тэнгэр сүнсийг минь таалахаа больж үхсэн хойно говь цөлийн дорх харанхуй хар там руу илгээвэл яах вэ? Тал нутагт хүн болгон чамтай адилхан чонондоо боол зардсан лугаа адил ханддаг болчихвол монголчуудын сүнс хаана очих болж байна даа?. . . .” гэв.

“Аав аа, би бэлтрэгэнд яахин боол мэт хандаж зүрхлэх билээ? Би л өөрөө түүний боолоос өөрцгүй болчихоод байна шүү дээ. Би өдөр болгон түүний төлөө үнээ сааж, мах үйн, зутан буцалгаж Монгол вангийн агиас өөрцгүй л үйлчилж байгаа. Түүнийг даарч хөрөн, нохой гахайд уруулчих вий гэж санаа зовоод, тайван ч унтаж чадахаа байсан. Гао Зянь Жун намайг ямар сайндаа бэлтрэгнийхээ боол болчихлоо гэж байх вэ дээ. Би хятад хүн хэрнээ чоныг хамгаас дээдлэдэг болохыг та юу эс андах вэ? Мөнх тэнгэрийн таалал хамгаас шударга болохоор таныг юу боллоо гэж гэсгээх билээ?” гэж Чэнь Жэнь дуу шуу муутайхан биеэ өмөөрөв.

Өвгөн Чэнь Жэньгийн үгэнд итгэв бололтой хэсэг зуур гөлрөн зогслоо. Хэрвээ Чэнь Жэнь бэлтрэгт үнэхээр сүлд шүтээн шиг, вангийн агь лугаа адил хандаж байгаа бол ариун сахиусыг

тахиж байгаагаас биш яахин түүнийг гутаасан хэрэг болох билээ? Өвгөн энэ асуудалд хэрхэн хандахаа шийдэж ядан буй бололтой. Яаж ч бодсон өнгөн талаасаа түүний үйлдэл монгол талын уламжлал болон дэг жаягт тохирохгүй боловч Чэнь Жэньгийн цаад сэдэл үнэн сэтгэлийн улбаатай гэдэг нь тодорхой. Талын монголчууд хүний сэтгэлийн өнгийг ихэд чухалчилдаг юм. Өвгөний чонынх шиг ууртай харц зугуухан зөөлөрч ирэв. Энэ цөлх хар ухаантай монгол өвгөн чонон сүлдэнд сүслэгч хятад залуугийн хүслийг болгоож хоёрхон сарын настай бяцхан амийг өршөөгөөсэй билээ гэж Чэнь Жэнь үнэн голоосоо хүсэж байлаа.

Түүний сэтгэлд найдварын оч улсхийхэд нулимсаа шудраад уртаар амьсгаа татаж, айдас бачимдлаа даран “Аав аа, би үнэндээ талын чонын мөс чанарыг ойлгон, чоно яахаараа тийм айхгар ухаалаг, тал нутгийн үндэстнүүд эртнээс нааш түүнийг яагаад шүтэж ирсэний учрыг олох гэж л бэлтрэг тэжээж эхэлсэн юм л даа. Манай хятадууд чоныг жигшин зэвүүцдэг болохоор хамгийн өөдгүй хүнийг л чонотой зүйрлэн чонон сэтгэл, нохойн уушигтай амьтан гэж хэлэлцдэг болохыг та яахин мэдэх билээ? Түүгээр ч зогсохгүй эмэгтэйчүүдийг хууран мэхлэгчийг өнгөнд дуртай чоно, сувьдаг шунахай хүнийг чонон сэтгэлт, америкийн империализмыг сувьдаг чоно гэж нэрлэдэг. Хүүхдээ айлгахдаа хүртэл чоно ирлээ шүү гэнэ. . . . .”

Чэнь Жэнь өвгөний төрх байдал түрүүчийнхээс хавьгүй зөөлөрсөнийг үзээд зориг орж цааш залгуулан өгүүлрүүн “Хятадуудын нүдэнд чоно хамгийн харгис муухайгийн туйл мэт үзэгддэг бол монголчууд харин түүнийг хувилгаан сахиус мэт шүтэж, амьддаа түүнээс суралцан, үхсэн хойноо ч шарил цогцсоо түүнд даатгадаг. Би эхэндээ энэ бүхний учрыг төдийлөн ойлгодоггүй байсан юм. Тал нутагт амьдрах хоёр жилийн турш та надад чонын тухай үлгэр домог ярьж, чонын ав хомрогод дагуулан явж байгаагүй бол би лав түүнд ийм элэгтэй болж, наад цаад учир жанцанг нь ойлгохгүй байсан байх аа. Гэвч би чоныг холоос харж, өөрийн ухаанд найдсан төдийхнөөр нарийн ширийн олон зүйлийг ойлгохгүй үлдэх тул өөрийн гараар тэжээж, өдөр болгон түүнтэй харьцаж байя гэж бодсон юм. Бэлтрэгийг тэжээх нэг сарын хугацаанд би урьд нь олж мэдээгүй олон зүйлийг харж, чоно үнэхээр бишрэн хүндлэхээс өөр аргагүй лут амьтан болохыг улам бүр мэдрэх боллоо. Гэтэл манай аж ахуйн илгээлтийн эздийн олонх нь чонын тухай хуучин ойлголтоосоо салаагүй хэвээр байгаа. Тал нутагт ирсэн илгээлтийн эзэд чоныг ойлгохгүй байхад дотор газрын хэдэн зуун сая хятад хүмүүс түүнийг яахин ойлгох вэ? Хожим улам олон хятад хүмүүс тал нутагт ирээд бүх чоныг хядаад хаячих юм бол тал нутгийн хувь тавилан хаашаа эргэх билээ? Монголчууд түүний горьг амсахаар үл барам хятадууд өөрсдөө бүр илүү их балгийг хүртэх болно. Энэ сайхан тал нутаг ээрэм цөл болох вий гэж би улам илүү санаа зовних боллоо. . . . .” гэв.

Өвгөн мод толгойгоо гарган чулуун дээр завилан суув. Чэнь Жэнь ухасхийн шүдэнз аваад өвгөнд тамхи асааж өгөв. Өвгөн тамхиа хэд сорсоноо “Үнэндээ аав чинь л чамайг уруу тагчихсан даа. . . .Гэтэл одоо яадаг ч юм билээ? Хүү минь, чи чоно тэжээсний төлөө аавыгаа бодох биш, цаад Өлзийг, өөрийн багийг бодох хэрэгтэй. Муу Өлзий дарга маань ажлаасаа бууж, дөрвөн адуучин донгодуулж өнгөрсөн нь юунаас болсныг чи юу эс андах вэ? Дээд газраас түүнийг чононд элэгтэй хандаж ав хомрогыг сайтар зохион байгуулдаггүй гэж зэмлээд зогсохгүй аавыг чинь хүртэл хөгшин чоно, азарган чоно, манай багийг чонын үүр уурхай болж гүйцлээ гэсэн гэдэг шүү. Гэтэл яг ийм эгзэгтэй цаг үед манай багийн нэг илгээлтийн эзэн чоно тэжээгээд эхлэхээр юу болох вэ? Бусад гурван багийн залуус тэжээхгүй

байхад заавал чи тэжээдэг нь хоёрдугаар багийн муу нөлөөнд автсан хэрэг биш гэж үү гээд асуудлыг босгоод ирвэл яах вэ? ” гэв.

Тамхины угааны цаанаас өвгөний гунигтай харц тодрон дууны өнгө улам хүндрээд “Тэгээд ч чиний бэлтрэг тэжээсний балгаар өлөгчин чоно сүрэг чоно дагуулан наашаа ирэх нь гарцаагүй. Олонбулгийн өлөгчин чоно үр төлдөө харам, маш үнэрч болохоор бэлтрэгнийхээ хойноос бэдэрсээр танай хотонд өшөөгөө авахаар ирвэл яах вэ? Олонбулгийн чонон сүрэг нэг улайрахаараа юу хийдгийн горьг манай баг саяхан амсахаараа нэг болсон. Хэрвээ дахин томоохон осол гарах юм бол Өлзий дарга болон багийн удирдлагууд дахин өөд нар үзнэ гэж горьдолтгүй. Чонон сүрэг танайхыг онилоод сиймхий тааруулан хамаг хоньдыг чинь хядчихвал бэлтрэг тэжээж чоно дуудан нийгмийн өмчийг сүйтгэсэн гэдгээрээ чи яланд унаж шоронд сууж таарна. . . . ” гэлээ.

Чэнь Жэньгийн нэлээд уужирч байсан сэтгэл дахиад л хүндрээд явчихав. Цөөнх тоот үндэстний нутагт чоно тэжээнэ гэдэг үндэстний бодлогод харш төдийгүй чоныг өдөөн дуудаж, үйлдвэрлэлийг санаатай хорлон сүйтгэсэн хэрэг биш гэж үү? Хэрвээ түүний хөрөнгөтний үзэлтэн гэгддэг аавынх нь асуудалтай холбогдоод ирвэл улам даамжраад бүр ч олон хүнийг хомрогондоо оруулж болох талтай. Өнөөдөр тэр бэлтрэгээ өөрийн биеэр тэнгэрт илгээхээс өөр аргагүй болсоноо мэдээд гар нь үл мэдэг чичрэв.

Өвгөн уртаар санаа алдан “Бао Шүнь Гүй гэж монголоо алдсан амьтан хятадуудаас ч илүү чоныг үзэн ядаж, чоно л агнахгүй бол албан тушаал дээрээ үлдэхгүй гэсэн бодолтой явдаг. Тэр чиний чоно тэжээхийг зөвшөөрнө гэж үү? Чи сайн бод доо” гэлээ.

Чэнь Жэнь эцсийн найдлагаа алдалгүй өгүүлрүүн “Миний бэлтрэг тэжээдэг нь чоныг улам сайн дөнгөхийн тулд шинжлэх ухааны үндэслэлтэй туршилт явуулж байгаа юм гээд түүнд хэлж өгч болохгүй юу?” гэхэд

Өвгөн хариуд нь “Тэр өнөөдөр манайд ирж хонох юм гэсэн. Чи маргааш түүнтэй уулзаж энэ тухайгаа өөрөө хэлж үз” гэснээ өвгөн босож мөнөөх чулууг хараад “Чи чоно тэжээгээд том болсон хойноо чамайг болон бусад хүн харыг барьчихвал яана гэж бодсонгүй юу? Чонын шүд хортой болохоор уруулсан хүн амь алдаж ч мэднэ. Би бэлтрэгийг чинь харчихвал сэтгэл тавгүйрхээд байж мэдэх тул өнөөдөр явж тэргээ засах минь” гэжээ.

Өвгөн тэрэг засаж байх зуур хар цагаан дуу гарсангүй. Чэнь Жэнь амаргүй байдалд байгаа хөгшин аав болон Өлзий дарга нарт төвөг удаж болохгүй гэдгийг ойлгосон боловч газар дээр нь бэлтрэгийг үгүй хийх сэтгэлийн бэлтгэл дутаж байлаа.

\* \* \*

Өвгөн Чэнь Жэньтэй хамжин хоёр тэрэг засаад гуравдахийг эхлэх гэж байтал гурван том нохой хуцалдахыг үзвээс Бао Шүнь Гүй Өлзийтэй цуг урд хойноо орон давхилдсаар ирж байлаа. Чэнь Жэнь нохдоо хорих зуур Бао Шүнь Гүй мориноос бууж өвгөнд хандан өгүүлрүүн “Эмгэн чинь таныг наашаа ирсэн гэхээр би ч бас Чэнь Жэньгийн тэжээсэн бэлтрэгийг үзье гэж бодлоо. Аж ахуйн хувьсгалт хороо Өлзий гуайг танайд суулгахаар болсон. Аж ахуйн зарим удирдлага түүнийг барилгын хэсэгт томилон биеийн хүчний ажил хийлгэх

санаа байсан даг шүү” гэв.

Тал нутаг дахь сураг чимээ морин туурайнаас ч хурдан тархах юм даа гэж бодох зуур Чэнь Жэньгийн зүрх хүчтэй оволзов.

Өвгөн хариуд нь “Чи асуудлыг ингэж шийддэг нь овоо доо” гэлээ.

“Шинэ нутаг бэлчээр ашиглаж байгаа тухай аймаг хошууны удирдлага ихээхэн анхаарч өнөө жилдээ үр ашгийг нь гарга гэсэн заавар чиглэл өгсөн. Ийм том газар нутгийг ашиглах болсноор бэлчээрийн даац нэг дахин нэмэгдэж байгаа нь тун сайн хэрэг юм. Та хоёр анхнаасаа энэ хэргийг хошуучлан гүйцэтгэсэн болохоор Өлзий гуай танайд сууснаар цаашдаа яах ийхийгээ зөвлөлдөж байхад дөхөмтэй байж мэднэ” хэмээн Бао Шүнь Гүй хэллээ.

“Өлзий маань цаг ямагт тал нутгаа гэсэн бодлыг сэтгэлдээ тээж явдаг болохоор энэ хэргийг ганцаараа сэдсэн юм” гэж Билиг өвгөн хэлэв.

“Би тийм болохоор л энэ хэргийг дээш уламжилсан. Дарга нар түүнийг гавьяагаараа гэм нүглээ цайруулахыг харж байя гэж байдаг шүү” гэж Бао Шүнь Гүй хэлэв.

Өлзий муухан инээвхийлээд “За тэр гавьяа энэ тэр ч яахав. Бодит ажил руугаа орцгооё. Нүүдэл суудлын зам хол болохоор айл хунаруудад амаргүй байж таарна. Аж ахуйгаас ачааны тэрэг болон хоёр дугуйт тракторыг хоёрдугаар багт ирүүлэхээс гадна хүн хүч гарган зам харгуйг засуулах хэрэгтэй байна. . . . .” гэв.

Бао Шүнь Гүй түүний хариуд “Би өнөө орой багийн хариуцлагатны хурлыг зарласан. Түүн дээр энэ тухай хэлэлцэнэ биз” гэснээ Чэнь Жэнь рүү хандан “Би чиний тушаасан хоёр чонын арьсыг хүнээр сайхан элдүүлээд хуучин даргадаа өгүүлсэн чинь их баярлаж байна гэнэ. Бээжингийн илгээлтийн эзэн залуу ийм том чоно агнадаг нь мундаг хэрэг байна гээд талархал дамжуулсан байна лээ” гэв.

“Миний чоно агнана гэж юу байх билээ? Та чинь нохой агнасан гэдгийг өөрөө харсан шүү дээ. Нохойн гавьяаг өөртөө нялзаах эвгүй биш үү?” хэмээн Чэнь Жэнь улалзав.

Бао Шүнь Гүй түүний дал мөрийг алгадаад “Танай нохой агнасан болохоор чи авласнаас өөрц юу байх вэ? Доод шатныхны гавьяаг дээд удирдлага мартахгүй байдаг нь манай армийн ялгуусан уламжлал мөн. За одоо чиний тэжээсэн бэлтрэгийг үзэцгээе” гэлээ.

Чэнь Жэнь Билиг өвгөн рүү хартал цаадахь нь үг дуугарахгүй байх тул яаран өгүүлрүүн “Бэлтрэг тэжээх нь ардын зан заншилд харш болохоос гадна чонон сүргийг дуудан ирүүлж дааж давшгүй хохирол учруулж мэдэх аюултай тул би тэжээхээ байсаан” гээд тэр чулууг зайлуулан ширээний тавцанг өргөв.

Дээш мацаж байсан паацгар бэлтрэг олон хүмүүсийн барааг хараад үүрний мухар руу шигдэн шүдээ ярзайлган ярдаглах боловч сэрвээнийх нь үс чичрэн дагжиж байлаа. Бао Шүнь Гүйгийн нүд гялалзан дуу алдаад “Уухайс, ийм том болчихсон юм уу? Дахин нэг сар тэжээхэд түрүүчийн тушаасан бэлтрэгний арьснаас хоёр дахин том болох юм байна. Эртхэн

мэдсэн бол алалгүй байлгаж байдаг байж л дээ. Жаахан том байлгаж байгаад нядлавал арван хэдэн арьсаар сайхан бэлтрэгний арьсан хүрэм хийж болох юм байна. Үүний арьс хөхүүл бэлтрэгнийхээс хавьгүй хөрсжсөн болохыг харж байна уу? . . . ” гэдэг байгаа.

Чэнь Жэнь нүүрээ үрчийлгээд “Тэгвэл би тэжээж чадашгүй нь ээ. Бэлтрэгний идэш дийлдэхгүй, өдөрт том түмпэн махтай зутан идэж аяга үнээний сүү уух юм” гэв.

“Чи чинь тоонд яасан хариугүй амьтан бэ? Жаахан шар будаа хэрэглээд том чонын арьстай болчихвол хичнээн аштай юу? Ирэх жил багуудад суйлсан бэлтрэгээ алалгүй хоёр гурав дахин том болж байгаад нядал гэх юм байна шүү” хэмээн Бао Шүнь Гүй хэллээ.

“Тийм амар юм гэж хаана байх билээ? Хөхүүл бэлтрэгийг гичий нохойд амлуулах хэрэгтэй. Гэтэл бидэнд тийм олон бэлэн зэхээний жингэр хаанаас олдох вэ?” хэмээн өвгөн ёозгүйхэн өгүүлэв.

Бао Шүнь Гүй хэсэг бодож байснаа “Нээрэн ч тийм юм байна шүү” гэлээ.

Чэнь Жэнь бэлтрэгийг шилдэн дээш гаргаж ирэв. Тэр бяцхан амьтны хамаг бие чичрэн тийчлэж тэлчлэх ажээ. Чоно арга мухардсан үедээ л эргэж дайрахаас биш, төрөлхийн хүнээс маш их айдаг амьтан юм.

Тэр бэлтрэгийг газар тавихад Бао Шүнь Гүй алгаараа хэд илсэнээ инээд алдан “Би анх удаа чоно илж үзлээ. Паацайчихаад сонин байна шүү” гэв.

“Чэнь Жэнь нэг сарын хугацаанд чамгүй бөөцийлсөн нь илт байна. Жирийн бэлтрэг өдийд ийм том байдаггүй юм. Чи өлөгчин чононоос илүү сайн өсгөж чаджээ. Чи тааралдсан хүн болгоноор чонын тухай болсон явдлыг яриулж их л элэгтэй болсон гэж сонссон чинь бүр байтлаа бэлтрэг тэжээчихсэн сууж байдаг байна шүү. Арай чоносох донтой болчихоогүй биз дээ?” хэмээн Өлзий асуулаа.

Билиг өвгөн бэлтрэгийг их л шимтэнгүй ажиглангаа мод толгойгоо далд хийн нүхний аман дээрх утааг алгаараа цохин сарниулаад өгүүлрүүн “Би өдий наслахдаа хүний тэжээсэн бэлтрэгийг анх удаа харж байна. Чэнь Жэнь хүү ч үнэхээр сэтгэл тавин овоо болгожээ. Тэр сая надаас зөвшөөрөл эрж баахан гуйж шалсан юм. Гэвч хонин сүргийн дэргэд чоно тэжээвэл юу болох билээ? Манай багийн малчдаас чоно тэжээхийг зөвшөөрөх хүн нэг ч гарахгүй л болов уу. Өнөөдөр та хоёрыг байгаа дээр энэ хүүхдийн шинжлэх ухааны үндэслэлтэй чоно тэжээе гэдэг чин хүслийг яавал дээрийг тогтож авбал ямар вэ?” гэлээ.

Бао Шүнь Гүйд чоно тэжээх их л сонин байгаа бололтой хэсэг зуур бодолхийлж байснаа “Өдийд алчихвал арьсаар нь юу ч хийж болохгүй хайран юм даа. Хөхүүл бэлтрэгийг өдий зэрэгтэй өсгөнө гэдэг амаргүй шүү. Миний санахад нэгэнт л эхэлсэн юм чинь тэжээж байг. Судалгааны зориулалтаар чоно тэжээсэн гэж хэлэхэд болохгүй нь ч юу байх вэ? Дайснаа устгахын тулд түүнийг илүү сайн судлах хэрэгтэй гэсэн Мао даргын маань үг ч байдаг. Би чонын тухай сайтар ойлгоцтой болохын тулд танай үүгээр байн байн ирэх хэрэгтэй болох нь шиг байна. Чи чинь байтлаа чоныг монгол нохойтой эвцэлдүүлэх санаатай гээ биз дээ?” хэмээн асуув.

“Уг нь тийм бодолтой байсан чинь аав байж болшгүй хэрэг гэсэн юм л даа” гэж Чэнь Жэнь хэллээ.

“Тал нутагт урьд өмнө тийм хэрэг болж байсан уу?” гэж Бао Шүнь Гүй Өлзийгөөс асуулаа.

“Тал нутгийн нүүдэлчид чоныг дээдлэн шүтдэг болохоор яахин нохойтой эвцэлдүүлье” гэх вэ хэмээн Өлзий хариулав.

“Энэ чинь шинжлэх ухааны туршилт болохоор болохгүй юм ч юу байх вэ? Хэрвээ монгол овчарк гараад ирвэл Зөвлөлтийнхөөс ч илүү мундаг байж мэдэх юм шүү. Монгол чоно дэлхийд хамгийн шилдэг үүлдрийнх гэж тооцогддог болохоор түүнээс гарсан эрлийз нохой амаргүй амьтан байж таарна. Армийнхан ч их сонирхох нь лавтай. Хэрвээ энэ туршилт бүтэлтэй болвол манай улс гадаадаас мөнгө зарж овчарк худалдан авахын хэрэггүй болох юм. Малчид маань монгол овчарктай болчихвол чонон сүрэг халдаж зүрхлэхээ байх ч юм бил үү? Үүнээс хойш малчид эсэргүүцсэн ч гэсэн шинжлэх ухааны сорилт туршилт явуулж байгаа юм гэж хэлээрэй. Харин Чэнь Жэнь чи аюулгүй байдлаа онцгой анхаарах хэрэгтэй шүү” гэж Бао Шүнь Гүй хэлэв.

“Бао дарга зөвшөөрсөн болохоор чи одоохондоо тэжээж бай даа. Хэрвээ элдэв асуудал гарах юм бол чи Бао даргад төвөг удалгүй хариуцлагыг өөрөө бүрэн даах ёстой шүү гэдгийг чамд анхааруулаад хэлчихье. Чи хүн мал руу дайрахаас сэргийлж төмөр гинж олж уяхгүй бол энэ маягаар байлгаж болохгүй байх аа” гэж Өлзий гуай сануулав.

“Нээрэн тийм шүү. Хүн мал ноцуулчих вий. Тийм хэрэг гарах юм бол газар дээр нь нам буудаарай” хэмээн Бао Шүнь Гүй хэллээ.

Чэнь Жэнь сандарсандаа зүрх нь амаараа гарчих шахаад “Тэгэлгүй яахав. Харин малчид бүгдээрээ үүнийг эсэргүүцэх болохоор та бүхэн жаахан дэмжлэг үзүүлбэл сайнсан” гэж гуйлаа.

Өлзий түүний хариуд “Танай өвгөн аавын хэлсэн үг биднийхээс хавьгүй жинтэй бууж таарна” гэв.

“Би л энэ хүүхдийг буруу тийш залсан болохоор жаахан ч гэсэн хариуцлага үүрэхээс дээ” гээд өвгөн толгой сэгсрэн халаглалаа.

Өвгөн мужааныхаа хэрэгслийг Чэнь Жэньд үлдээгээд үхэр тэргээ хөллөн гэрийн зүг гэлдрэхэд Бао Шүнь Гүй, Өлзий хоёр ч араас нь даган явав.

Чэнь Жэнь хүнд өвчнийг даваад тамиргүйдсэн хүн шиг чонын үүрний хажууд лагхийтэл суулаа. Тэр бэлтрэгийг тас тэврэхэд цаадахь нь өвдсөндөө шүдээ ярзайлган ярдаглана. Чэнь Жэнь бэлтрэгний чихийг маажиж өгөхөд загатнасан газрыг олсон бололтой зан нь зөөлрөөд өрөөсөн нүдээ аньж хүзүү толгойгоо сунган өрөөл татанхай амьтан шиг хамаг бие нь чичирхийлж, их л тааламжтай байдлыг илтгэх ажээ.



*Хань улсын Ү Ди хаан зарлиг болруун “Хүннүчүүд урьд Хань гүрэн асар уудам хэмээвч өлсөж ундаасахыг үл тэвчмүй. Нэг чоныг хомрогоноос алдвас мянган хонины хохирол болмуй за хэмээлддэг бөлгөө. Тэднийг хоёронтоо цэрэглэн ялагдаад хуягт цэрэг эндэж сарнисанд хаан миний сэтгэл ямагт зовних болой” хэмээжээ.*

*Сы Ма Гуан*

*“Засагт туслах нэвтэрхий толь”*

Бао Шүнь Гүй Бат, Лхасүрэн нарын таван анчин болоод Ян Көгийн хамтаар долоо найман нохой дагуулсаар шинэ нутаг бэлчээр рүү түрүүлэн оржээ. Майхан сав, тогоо шанага, таваг хул зэргийг ачсан төмөр дугуйтай хоёр хөнгөн морин тэрэг тэдний араас дагалдана.

Шинэ нутгийн баруун талын уулан дээр авиран гараад Бао Шүнь Гүй анчдын хамт дурангаараа хотгорын эргэн тойрны гуу жалга, голын салаа, булан тохой, довцог толгой, нуга дэвхээ газруудыг нэгд нэгэнгүй ажиглан харсан боловч ганц чоно, зээрийг олж харсангүй. Харин хотгорын гол дахь нуурын мандалд сүрэг галуу, нугас болон хэдэн хун шувуу тайван хөвж байлаа.

Анчид зуны эхэн сар чоно алах гэж хорхойсохгүй боловч нүдний өмнө дурайх өвсний үнэр хамар цоргисон номин ногоон талыг хараад бүр алмайрч орхив. Ян Кө ч өөрцгүй бүлтийтэл гайхангаа бусдыгаа харвал бүгдээрээ нүдээ унаган алдах ажээ. Уул руу уруудан буухад өвс ногоорон халиурч, анхилуун үнэр хиргүй тунгалаг агаарт шингээд ширхэг тоос ольё хэмээвэл алтны элс хайхаас амаргүй мэт ажгуу. Морин туурай, тэрэгний хүрд байтугай чирсэн уурганы бөгс хүртэл өвсний шүүсэнд будагдан ногоорчээ. Морьд шимт өвсийг хазлах гэж амгайгаа булаалдана. Чэнь Жэньгийн яриад байсан зулаастай юм шиг өнгийн цэцэгс зулгараад тал дан ногоон өнгөөр дурайх нь Ян Көгийн хувьд жаахан харамсалтай байв.

Бао Шүнь Гүй том алтны уурхай олсон юм шиг дуу алдаад “Үнэхээр ногоон хашыг дүүргэсэн эрдэнийн бумба шиг өвс ус жигдэрсэн сайхан нутаг гэж энэ байх даа. Цэргийн тойргийн дарга нарыг энд авчран галуу нугас агнуулж, хээрийн шарсан мах амтлуулах хэрэгтэй юм байна шүү” гэх нь чихэнд чийртэй агаад “Хунт нуур” бүжгэн жүжгийн хар хувцастай шулам нүдний өмнө үзэгдэх шиг болов.

Морьгнууд уулнаас уруудан нэгэн довцгийг давсан хойно Бао Шүнь Гүй дуугаа намсган “Зүүн тийш хар даа. Тэр судагт сүрэг хун шувуу идэшилж байх шиг байна. Цөмөөрөө очиж нэгийг агная” гэгчхээд хоёр анчинг дагуулан давхиад явчихав. Ян Кө хориглоод дийлсэнгүй арга буюу дагаж явлаа. Тэр нүдээ нухлан харваас зүүн өмнө талын нэгэн судагт бөөн цагаан цэг зуны талд бэлчих цасан цагаан хурганууд шиг хараа булаах нь саяын дурангаар хардаг хунгуудаас ч илүү өнгөлөг санагдана. Ян Көд буу байсан бол хий буудаж тэднийг үргээхсэн гэж дотроо байж ядан байлаа. Хэсэг ширүүн давхисны эцэст цагаан цэгүүд хөдлөхгүй байсанд Ян Кө чанга хашгирмаар санагдав. Энэ үед анчид морины хурдаа сааруулан буугаа доош буулгаад ямар нэгэн юм ярилцав. Бао Шүнь Гүй морины амыг татаж дурангаа гарган харж эхлэлээ. Ян Кө ч мөн дурангаа авч хараад нүдний өмнө тодрох үзэмжинд бүр балмагдаж

орхив. Цагаан хурга шиг гялалзах тэр зүйлс бол судгийг бүрхсэн цээнийн цэцэгс байхыг хараад тэр бүр нүдэндээ итгэсэнгүй. Урьд нь хуучин нутгийн гуу судгаар хэд гурван цээнийн цэцэгс ургасан байдаг боловч тал хөндийг бүрхэн ийм олноороо байгааг анх удаа харж байгаа болохоор сүрэг хун агшны төдийхөнд цэцэгс болон хувирсан юм биш байгаа даа ч гэж эргэлзэх шиг.

Бао Шүнь Гүйгийн баяр бахдал өчүүхэн ч буурсан шинжгүй чанга дуугаар хашгичин “Тэнгэр минь, би хэзээ ч ийм үзэсгэлэнтэй цээнийн цэцгийг хараагүй юм байна шүү. Хот газрын цэцэрлэгт хүрээлэнд хүний ургуулсан цээнээс хавьгүй урт агаад гоё чамин ажээ. Хурдан очиж үзэцгээе” гэхэд морьд газар дэлдэн хурдлалаа.

Цэцэгсийн өмнө хүрч очоод Ян Кө, Цю өвгөн цэцгийн хувилгаан аршууд лугаа учирсан адил нүд нь эрээлжлээд явчихав. Нэгэн гуу судгийн хонхорт тунасан шимт хурдаст гуч дөч гаруй бут цээнэ цэцэг бадамлан дэлгэрчээ. Цэцэгсийн бут болгон метр гаруй өндөр, тэвэр шахам бүдүүн аж. Чигчийн чинээ бүдүүн хэдэн арван иш газраас саглайн цухуйж тохой хэртэй өндөрсөхөд өтгөн навчис битүү хучсаны дээр мандарваа лугаа адил том цагаан цээнийн цэцэгс дэлгэрчээ. Цэцгийн хувилгаан гараар урласан том сагстай цэцэг шиг нягт шигүү бутнуудыг алсаас хараад хунтай эндүүрэхээс ч аргагүй байлаа. Ян Кө ойртон очиж үзвэл цэцгийн хүйс шигүү, саглагар агаад мэлмэрсэн дэлбээнүүд нь мандарваа цэцгээс илүү өнгө жавхаатай, сарнай цэцгээс хавьгүй эрхэмсэг төрхийг илтгэнэ. Тэр амьд байгалийн дунд хунт нуурын тэнгэрийн дагинас мэт хүний гараар ургуулсантай зүйрлэхийн аргагүй гоё чамин цэцэгсийг анх удаа үзэж байгаа нь энэ юм.

Бао Шүнь Гүй ч мөн өөрцгүй алмайрч гүйцээд “Үнэхээр ховор эд гэдэг чинь энэ байна даа. Хотод аваачиж зарвал хэд хүрэх бол? Хэдэн бутыг шилжүүлэн суулгаад цэргийн тойргийн том дарга нарт үзүүлбэл их баярлаж таарна. Хуучин кадрууд мөнгөнөөс илүү цэцэгт дуртай байдаг юм. Ийм цэцгийг бэлэглэвэл юунаас ч илүү баярлана. Ян Кө танай Бээжингийн төрийн тэргүүнийг хүлээн авах зочид буудалд ч ийм сайхан цэцэгс байхгүй байж мэднэ дээ” гэлээ.

Ян Кө хариуд нь “Төрийн тэргүүнийг хүлээн авах зочид буудал байтугай гадаадын хааны ордны цэцэрлэгт ч ийм сайхан цэцэгс лав байхгүй” гэв.

Бао Шүнь Гүй анчид руу эргэн хараад “Энэ нандин цэцэгсийг сайн харж хандаж байхын тулд гүйлсийн мод тайрч ирээд шивээлэн хаших хэрэгтэй” гэж тушаав.

“Бид цаашид отор нүүдэл хийгээд яваад өгөх хойгуур хүн хар авчихгүй биз дээ?” хэмээн Ян Көг хэлэхэд

Бао Шүнь Гүй “Надад арга байгаа тул санаа зовох хэрэггүй” гэлээ.

Ян Көгийн царайд түгшүүр тодрон “Та арай бүгдийг нь зөөгөөд явчихгүй биз дээ. Хөрснөөс нь шилжүүлэх л юм бол үхчихэж мэдэх юм шүү” гэв.

Морьтнууд нэгэн голын тохойд ирэхэд энд тэндгүй зээрийн эвэр, туурай, арьс үс хөглөрөх боловч чоно толгойны ясыг ч үлдээлгүй идсэний ул мөр үзэгдэнэ. “Нэлээд том сүрэг чоно

энд ан хийсэн бололтой. Чонын баасыг үзвээс хөгшин болоод доголон чоно хүртэл иржээ” хэмээн Бат хэлэхэд Бао Шүнь Гүй түүнээс “Чонон сүрэг тэгээд хаашаа одсон хэрэг вэ?” хэмээн асуулаа.

“Зээрийн сүргийг дагаж уул руу юм уу, хилийн зурвас руу явсан байж мэдэх юм. Эсвэл тарвагачлахаар уул руу ч гарсан байж болох талтай. Одоо янзаганууд чононд гүйцэгдэхгүй болсон болохоор чоно өлсөөд барьсан зээрээ ийм цэвэрхэн янзалжээ” хэмээн Бат хариуллаа.

“Танай аав Өлзий гуай хоёр хэдэн зуун зээр, хэдэн арван чоно байна гээд байсан чинь яахаараа хорь хоногийн дотор ул мөргүй алга болчихдог билээ?” хэмээн Бао Шүнь Гүй асуув.

“Тийм олон чоно ирчихээд байхад сүрэг зээр энд юугаа хийх билээ?” гэж Бат хэлэв.

“Чонон сүрэг таны бараанаар бажгадан зугатсан байж таарна. Чоныг их өширхдөг хүнд тэр бараагаа ч харуулдаггүй юм шүү. Билиг гуай чононд их ууч ханддаг мөртлөө нэг хөдлөхөөрөө сүрэг чоно агнаж байхыг та харсан биз дээ?” гээд Лхасүрэн инээд алдлаа.

“Та чонын ач тусыг одоо харав уу? Хэрвээ чонон сүрэг байгаагүй бол энэ сайхан бэлчээр нутгийг зээр юу ч үгүй талхлаад хаях байсан юм. Манай хонин сүрэг зээрийн шивгэртэй өвсийг тоож үнэрлэх ч үгүй. Морьд хүртэл энэ нутагт сэтгэл хоргодоод байгааг харав уу? Өнөөдөр жодгороо босгож, морь нохдоо амрааж өнжөөд маргааш уул руу гарвал ямар вэ?” хэмээн Бат санал гаргалаа.

Бао Шүнь Гүй юу ч болсон гол гатлая гэв. Бат голын гүехэн гармыг олж хэдэн анчидтай хүрзээр хоёр эргийг тэрэг гатлахуйц болтол сэтлээд анчдын отог зүүн уулын хормойд бэрзээнтэн майхнаа босгов. Бат хоёр анчнаар майхны гадаа тогоо тавиулан цай чануулаад Бао Шүнь Гүйд хандан “Би өмнөд уулын жалганд ганц нэг шархтай зээр үлдэж үү, үгүй юу үзчихээд ирье. Анчин улс байна даа. Эхний өдөр борцны шөл ууна гэж юу байх вэ?” гэхэд Бао Шүнь Гүй уухайн тас зөвшөөрлөө. Бат хоёр анчныг ноходтойгоо дагуулан өмнөд уулын зүг давхицгаав. Арслан Барс хоёр энд зээр агнаж байсан болохоор анч омогшил нь бадран хошуучлан довголгоно.

Ян Кө түрүүчийн үзсэн хунгуудад сэтгэл хоргодох тул тэдний ард үлдээд үдлэсэн газрын ойролцоох довцог дээр гаран нуурын зүг дурандав. Тэр Бао Шүнь Гүй, Билиг өвгөн нарыг хоёр өдөр шалсаны эцэст багийн хүн морьд шинэ нутагт хөл тавихаас өмнө завдаж хил орчмын онгон дагшин хунт нуурын үзэмжийг бахдан харах боломжийг олж чадсан нь энэ юм. Энэ мөчид хунт нуур Чэнь Жэньгийн дүрслэн ярьж байснаас ч илүү үзэмжтэй харагдана. Чэнь Жэньгийн гатлаж үзээгүй зүүн эргийн өндөрлөг дээрээс зэгсийг өнгийн нуурын үзэмжийг бүхэлд нь тольдон харах боломжтой байлаа. Тэр довцгийн орой дээр суучихаад амьсгаа даран дурандана. Ийн бодол бэлчээн суух зуур морин төвөргөөн түүний араар тачигнан өнгөрөв.

Бао Шүнь Гүй их л хөөрүү дэвэргэн янзтай “Хөөе, чи хунг бодсоор сууна уу? Хоёулаа нуурын эрэг дээр очиж ганц хун агнаж хорхойгоо дарцгаая. Эндхийн малчид хун байтугай тахианы мах иддэггүй болохоор надтай явах хүн олдохгүй байна. Тэд нар идэхгүй юм бол хоёулаа хуваагаад цохичихье” гэхэд түүний гарт хагас автомат буу гялалзахыг Ян Кө олж үзэв.

Ян Көгийн зүрх палхийгээд гараа савчин “Хун чинь маш ховор амьтан шүү дээ. . . .Түүнийг яасан ч алж болохгүй. Би танаас гуйж байна. Би багаасаа л “Хунт нуур” бүжгэн жүжигт дуртай болохоор гурван жилийн хүнд хэцүү өлсгөлөнгийн үеэр хүртэл Зөвлөлтийн нэг гавьяат жүжигчин хятадын бүжигчинтэй хамтран тоглосон “Хунт нуурыг” үзэх гэж нэг өдрийн хичээлээ таслан үүр цүүрээр дугаарлан байж нэг тасалбар худалдан авч байсан удаатай. “Хунт нуур” үнэхээр сайхан шүү. Дэлхийн алдар суутай, соёлтой хүн болгон хун шувууг хайрладаг байтал жинхэнэ хунт нууран дээр ирчихээд хунг нь алж махыг нь иднэ гэдэг чинь юу гэсэн үг вэ? Та тэгснээс эхлээд намайг алчих” гэлээ.

Бао Шүнь Гүй ийм мугуйд хүнтэй таарна гэж бодоогүй явсан тул хамаг баяр хөөр нь ор мөргүй алга болжээ. Тэр нүдээ улаанаар эргэлдүүлэн “Арван жилийн боловсролтой амьтан байж юуныхаа “Хунт нуур” энэ тэр гэж хөрөнгөтний үзэл суртал яриад байна вэ? Миний сурсан мэдсэн чамаас дордохгүй байх шүү. Манай улс “Хунт нуур” тоглохыг хориглоод “Улаан хувьсгалын эмэгтэй цэргүүдийг” тоглуулах болсон гэж дуулаагүй юм уу?” хэмээн асуув.

Лхасүрэн ч Бао Шүнь Гүйгийн буу барьсан байхыг хараад гүйн ирж хориглонгоо “Манай монголчууд эрт дээр үеэс хун шувууг ихэд дээдлэн шүтсээр ирсэн юм. Түүнийг агнаж яасан ч болохгүй. Бао дарга аа, та чинь чоно агнана гээд байсан биз дээ? Уулын чоно таны буун дуунаар ор мөргүй хулжин алга болж мэдэх юм шүү. Тэгвэл бидний наашаа ирсэн талаар болох биш үү?” гэлээ.

Бао Шүнь Гүй мэлрэн мориныхоо амыг татаад Лхасүрэн рүү эргэж “Хэрвээ чи сануулаагүй бол том алдаа гаргах байж шүү” гээд буугаа түүнд өгөнгөө Ян Көд хандан “Тэгвэл хоёулаа нуурын эрэг рүү очиж байдлыг тандацгаая” гэв.

Ян Кө сүр сүлдгүй амьтан морио эмээллээд түүний араас нуурын зүг явлаа. Нуурын эрэг рүү дөхөн очиход галуу, нугас зэрэг олон өнгийн шувууд дэрхийн нисээд тэр хоёрын толгой дээр ус сацлав. Бао Шүнь Гүй зэгсний цаана юу байгааг харах санаатай дөрөөн дээрээ босож зогслоо. Энэ мөчид хоёр хун зэгсний толгой шүргэн, далавчаа дэвсээр түүний толгой дээгүүр гурван метр орчим нам өндөрт нисэн өнгөрөв. Бао Шүнь Гүй цочсондоо лагхийтэл суухад шарга морь нь үргэн түүнийг газар чулуудан алдлаа. Хун шувуу хүнээс айсан янзгүй эргийн дагуу нэгэнтээ тойрон нисээд зэгсний цаадахь нуурын мандал дээр бууцгаав. Бао Шүнь Гүй морины амыг татан, бөгсөө хайвж хазайсан эмээлээ тэгшлээд инээд алдан “Энд буугаар байтугай чавхаар ч хунг агначихаж болмоор юм шив дээ. Шувуудын хаан хунгийн махыг зоогловол амьд явсаны хэрэг бүтлээ гэсэн үг. Би эхлээд чоноо агнаж гүйцээд дараа нь эдний учрыг олно оо, гайгүй” гэлээ.

Ян Кө их л эмээнгүй байдалтай “Та сая цээнийн цэцэгсийг эрдэнэсээс өөрцгүй нандигнаад байсан атал манай улсад төдийгүй дэлхийд ховор ийм сайхан амьтдыг яагаад хамгаалдаггүй билээ?” хэмээн асуув.

Бао Шүнь Гүй түүний хариуд “Би чинь тариачин хүн болохоор бодит байдлыг гол болгодог. Хүний хувьд хүртэж болох зүйл л нандин эрдэнэ болохоос биш, хүртээмжгүй зүйлсийг хайрлах юу байх билээ. Цээнэ цэцэг хөлтэй биш байж л байна. Харин хун шувууд далавчтай болохоор хүн малын хөлөөс дайжин умар зүгт нисэн очоод Монгол, Зөвлөлтийн засварлах үзэлтнүүдийн эрдэнэ болон хувирах болно. . . .” гэлээ.

“Цаадуул чинь хунг үнэхээр дээдэлдэг болохоороо л агнахгүй байгаа юм шүү дээ” хэмээн Ян Кө хэлэхэд

Бао Шүнь Гүй их л бухимдангуй янзтай “Би чиний ийм мугуйдыг мэдсэн бол наашаа дагуулан ирдэггүй байж л дээ. Би чиний тэр “Хунт нуурыг” чинь үхэр, адуу усладаг цөөрөм болгоод өгөхөө мэдэх байлгүй” гэв.

Ян Көд хэрвээ энэ мөчид буу байсан бол нуурын агаар дээгүүр шүршиж хунгуудыг нь хил давуулан хөөгөөд тэднийг хайрладаг ард түмэнтэй, “Хунт нуурыг” зохиосон улс руу нь үдэн явуулмаар санагдах боловч уураа арайхийн дарлаа. Болжмор шувуудаа хүртэл барьж идчихээд өмхий бах л нутагшин үлдсэн энэ газар хун шувуудын орогнох орон зай хаанаас байх билээ.

Лхасүрэн тэр хоёрыг эргэн ирээч хэмээн гараараа даллан дуудав. Тэр хоёр яаран очвоос Санжаа зүүн өмнө уулнаас эргэн ирчихсэн үхэр тэргээ хөллөж байлаа. “Бат тэд нар өмнөд ууланд хэдэн зэрлэг гахай агнаад үхэр тэргээр зөөх хэрэгтэй болчихлоо. Бао даргыг очиж үзэхгүй юу гэж байна” хэмээн тэр хэлэв. Бао Шүнь Гүй гуяа алгдан эг маггүй хөхрөөд “Талд зэрлэг гахайн мах хүртэх юм гэж хэн санах билээ? Алив, Ян Кө явцгаая” гэлээ. Ян Кө зэрлэг гахай агнасан хүний тухай дуулж байснаас биш үзсэн удаа байхгүй тул Санжаагийн заасан зүгт Бао Шүнь Гүйг дагалдан давхицгаав.

Тэр хоёр Батын тэнд хараахан хүрээгүй байхдаа зэрлэг гахайн сэндийлсэн газрыг олж харав. Голын хөвөө, уулын хормойн гуу судгийн хэдэн арван мүй газрын хар шороот хөрс жолооноос алдуурсан анжистай үхэр явсан мэт энд тэндгүй онгилогдон сийчигджээ. Зэрлэг гахай үндсийг нь таслан идсэн өвс ногоо гандан хатаж, хөрсөнд булагдаад, сайн чанарын бэлчээр тэжээвэр гахайд онгилогдсон төмсний талбай шиг харагдана. “Зэрлэг гахай ч үнэхээр муухай амьтан юм даа. Хожим тариа ногоо тариалахаар сүйтгээд хаячихаж мэдэх юм байна шүү” хэмээн Бао Шүнь Гүй хараал зүхэл урсгалаа.

Хоёр морьтон цааш Батын зүг довтолгов. Бат уулын хормойд тамхилан, ноход үхсэн гахайн махыг зулгаалдаж байв. Тэр хоёр мориноос буун харвал Батын хажууд хоёр бүтэн гахай зэрэгцүүлээд тавьчихсан байх ажээ. Өөр хоёр гахайн махыг ноход хуваан идэх бөгөөд Арслан, Барс хоёр хамгийн том тарган гуяыг хүртэцгээнэ. Хоёр зэрлэг гахай метр гаруй урт тэжээвэр гахайнаас хавьгүй давжаа боловч шингэн шаргалдуу хялгастай, хошуу нь тэжээвэр гахайныхаас хавьгүй урт, сэрийсэн яс үзэгдэхгүй нь тарган цатгалан болохыг илтгэнэ. Зэрлэг гахайн соёо бодож төсөөлж байснаас төдийлөн урт биш. Тэдний хүзүүнд нохдын соёоны ул мөр тодхон үлджээ.

Бат алсад байх нэгэн жалгыг заагаад “Хоёр том нохой чонын үнэрийг аваад мөшгин хөөсөөр тэр жалганд хүрвэл онгилогдсон газар гурав, дөрвөн чононд бариулсан гахайн сэгийг олж үзэв. Хоёр нохой маань чонын араас мөшгихөө больж, энэ жалганд ирээд сүрэг гахайг туун гаргаж ирсэн боловч том бодонгийн соёо айхтар хурц тул хөөж зүрхэлсэнгүй. Би ч мөн чоныг үргээчих вий гээд буудаж чадсангүй. Ноход энэ хэдэн давжаа гахайг алсанд би хоёрыг өөрсдөд нь хувааж өгчихөөд үлдсэн хоёрыг наашаа чирч авчирлаа” гэж яриу.

Бао Шүнь Гүй зэрлэг гахайн тарган бие дээр гишгэлэн инээд алдаад “Та нар овоо ажиллажээ. Энэ шүдлэн гахайнуудын мах ч амттай зөөлөн байж таарна. Өнөө орой би та нарыг архиар

дайлна аа. Энд чоно элбэг болохоор маргааш хэдэн боохой унагавал сайнсан” гэлээ.

“Энэ зэрлэг гахайнууд хэдэн зуун километрийн тэртээх ойгоос голын эрэг дагасаар наашаа ирсэн шиг байна. Хэрвээ Олонбулгийн чонод байгаагүй бол энэ хавийн бэлчээр нутгийг энэ гахайнууд баллах байсан юм шүү” хэмээн Бат хэллээ.

“Зэрлэг гахайн мах ч сайхан байх шүү. Хожим олуул болохоор зэрлэг гахай агнан идэж байвал үхэр хонины маханд хэмнэлттэй байх бус уу? Манай суурин газрынхан үхэр хонины мах гэхээсээ илүү гахайн маханд дуртай байдаг юм” гэж Бао Шүнь Гүй хэлэв.

Санжаа үхэр тэргээ хөтлөн ирэхэд хэдүүл элбэн хоёр гахайг тэргэн дээр ачив. Бат нохдоо гахайн махтай нь үлдээчихээд өөрсдөө түрүүлэн отог руугаа буцлаа. Нөгөөдүүл нь ч гал хөс түлчихсэн байх тул тэргэн дээрээс гахайг буулган өвчиж, махыг нь шулж авав. Тал нутгийн малчид гахайг өвчөөд ширийг нь идэлгүй хаядаг ажээ. Удалгүй түүдэг галын дээгүүр гахайн шарсан махны тааламжтай үнэр ханхийв. Зэрлэг гахай тэжээвэр гахай шиг өөхгүй боловч сэмжний өөх чамгүй их аж. Ян Кө Бао Шүнь Гүйг дууриан сэмжний өөхөнд хар мах ороон шарвал тос даан шажигнаад амттай гэдэг нь жирийн гахайн шарсан махтай зүйрлэх ч юм биш. Ян Кө анчдыг мах шулж байх зуур чамгүй их таана, хөмүүл, зэрлэг сонгино түүж ирсэн болохоор хээрийн амтлагчтай тал нутгийн ангийн шарсан мах сэтгэлд нэн өег таатай санагдана. Тэр Чэнь Жэньгийн үзээгүй хун шувууд, цээнийн цэцэгсийг харан, тал нутгийн ховор зоог болох зэрлэг гахайн махыг хүртсэн болохоор Чэнь Жэньтэй уулзахаараа өөрийн амны хишиг морь сайтайг гайхуулан ярья хэмээн бодож байлаа.

Түүдэг галын дэргэд Бао Шүнь Гүй нөгөөдүүлийгээ архиар дайлангаа хун шувуу нь хаадын зоог гэнэ лээ гэж ярих боловч анчид бүгдээрээ толгой сэгсрэн түүний урмыг хугалж орхив. Олонбулгийн малчид тэнгэрт дүүлэн нисдэг болгоныг дээдлэн хүндлэх тул араатан гөрөөсийг л агнана уу гэхээс биш жигүүртэн шувууд руу буу шагайдаггүй ажээ.

Анч ноход отог дээрээ эргэн ирээд ойр хавийг сэрэмжтэй шиншилнэ. Цадтал идэж архинд халамцсан долоон эр босож ирээд үлдсэн гахайг янзлан том түмпэнд махыг нь хийлээ. Зүрх элэгнээс бусад дотор эрхтнийг нохдын дараачийн хоол болгон газар хаяжээ.

\* \* \*

Шар бүрийн алдад Ян Кө майхнаас ганцаараа сэмээрхэн холдож хунт нуурын үзэмжийг тольдож болохуйц газар хоёр гараараа өвдгөө тулан дурангаа бариад, удахгүй нэрийн төдийхөн болж хоцрох “Хунт нуурыг” шимтэнгүй ажиглав.

Хунт нуурын мандал намуухан бидэртэн долгилж, баруун хэсгийн яралжууд дорно зүгийн гүн хөх тэнгэрийг тольдоход зүүн талын яралж нь жаргах нарны улбар туяаг цацруулна. Яралж зөөлөн мяралзахад мана, маргад, утаат болор, биндэрьяа, сувд эрдэнэсийн улаан, ногоон, шар, цэнхэр, цагаан өнгө алаглан сүлэлдээд эрхэм тансгийг илтгэх ажээ. Ян Көгийн нүдний өмнө бардам үзэсгэлэнт хун шувуу үхээд тэнгэр өнгө өнгийн эрдэнэсийг дэвсэн өөрийн хайртай жигүүртэн болон хунт нуурыг сүүлчийн замд үдэж байгаа дүр зураг харагдах шиг болов.

Яралжууд урт үзэгдлийн оршил хөгжим шиг зугуухан бидэртэхэд хүн түүний цаадахь эмгэнэлт жүжгийн гол баатрыг харахаас халширам мэт. Энэхүү тэнгэрийн хөшгөөр дэвсгэр болгосон бүжгэн жүжгийн гол баатар битгий гарч ирээсэй билээ хэмээн Ян Кө сэтгэл дотроо сүслэн залбирлаа. Гэвч хар ногоон зэгсний цаанаас том хун шувууд нуурын булан тохойд нэг нэгээрээ гарч ирэв. Нэг, хоёр, гурав. . . нийт арван хоёр хун шувуудын өмнө асар тэнгэрийн дорх өнгө алагласан нуурын мандал зүйргүй том тайз болон хувирав. Хун шувууд бүүдгэр хөх шөнийн өмсгөлөө хэдрэн тэргүүн дээрх алтан гэрэл ч сүүмийн ягаарсан байлаа. Асуултын тэмдэг мэт тахийх тэдний хүзүү тэнгэр, газар, ус, хүмүүн, энэ хорвоогийн түмэн бодисоос энэ тэрийг асуун шалгаах мэт. Асуултын тэмдгүүд нуурын мандлаар намуухан хөлхөлдөж, өөрийн хариултыг аядуухан хүлээсээр л. Гэвч тэнгэр газрын хооронд нам гүмхэн хэвээр, гагцхүү нуурын мандалд туссан арван хэдэн асуултын тэмдгийн урвуу дүрс салхины аясаар үлээгдэн ор мөргүй сарнина. . . . .

Энэхэн мөчид талын зэрлэг догшин чоно түүний сэтгэлд нэг л эвэргүү дотно санагдлаа. Тэд өөрийн хурц шүдний хүчээр тал нутагтаа атомын эрин зуун хүртэл оршин тогтнохдоо тал нутгийн атар онгон хунт нуурын үзэмжийг түүнд харуулах боломж олгосон юм. Энэ бүхнийг амжиж үзсэнээрээ Чэнь Жэнь тэр хоёр орчин цагийн хамгийн хувьтай хятад залуусын нэг билээ. Хэрвээ чонон сүрэг илүү зэрлэг догшин, овжин ухаалаг байвал хүн мал тал нутагтаа эзлэн түрэмгийллээ үргэжлүүлсээр байж мэдэх л юм. Харин нүүдэлчдийн энэхүү түрэмгийллийг өдөөн шахамдуулагч нь эцсийн эцэст хятадын суурьшмал үндэстнүүд билээ. Ян Көгийн сэтгэл шаналан шархирахын хэрээр чононд улам бүр талархах сэтгэл төрнө. Чонон сүргийн мөхөл тал нутгийн сүйрлийг ёрлохоор үл барам хүн төрөлхтний сэтгэл дэх гоо сайхныг ч баллаж мэдэх юм. Дурангийн харааг нулимс бүрхэхэд онгон ариун хунт нуур алсран одлоо. . . . .

\* \* \*

Маргааш өдөр анчид өдөржин зүүн уулын жалга судаг бүрийг самнан нэгжээд юу ч олж чадсангүй. Гуравдахь өдөр тэд аглаг ууланд очиж их үд болоход хүн морьдгүй эцэж цуцаад байтал гэнэт буун дуу тасхийхийг сонслоо. Бао Шүнь Гүй, Бат, Ян Кө гурав ухасхийн буун дуу гарсан зүг хурдлан очвоос зүүн уулын хярыг даван хоёр чоно гарч ирэв. Хоёр чоно хярыг даган хурдлаж байснаа хүн морьдын барааг хараад хад асгатай уулын оройг чиглэн давхив. Бат дурангаараа харж байснаа “Энэ хоёр сүргийн хурдыг гүйцэхгүй хөгшин чононууд ажээ” гэхэд Бао Шүнь Гүй их л догдлон хөөрч “Хөгшин залуу нь ямар хамаа байх билээ. Арьсыг нь өвчөөд авна гэдэг ялалт гэсэн үг” гэхэд Бат тэдний араас хөөнгөө “Арьс нь гуужиж амжаагүй хөөрхий амьтсыг харахгүй байна гэж үү дээ?” хэмээн амандаа бувгнав.

Хярын хоёр талаар анчид нохойтойгоо дээш мацав. Арай биерхүү хөгшин чонын зүүн урд хөл сайн тэнийхгүйг бодвол урьд өмнө анч нохойд шөрмөсөө тас хазуулсан бололтой. Арай давжаа биетэй өлөгчин чонын үс ноос ноолролдоод мэхийтэл эцэж туржээ. Барс, Арслан болон бусад ноход хазгар доголон, хөгшин чоныг хараад эргэлзсэн байдалтай хурдаа хаслаа. Харин дөнгөж нас бие гүйцэж байгаа нэгэн залуу нохой элэг барьж болно гэж бодсон бололтой ухасхийн араас нь давхив.

Хоёр хөгшин чоно хайрга чулуу элбэгтэй барсгар хаднуудын дунд ороод явчихав. Чонын алхах тоолонд хад чулуу нурах чимээ сонсогдоно. Цааш явахын эцэсгүй болсон тул анчид

мориноосоо буун буугаа бариад гурван талаас бүслэн авав. Олон тулалдааны ард гарсан Арслан, Барс хоёрын алхаа ойр, дуу чанга ажээ. Харин тэргүүн гавьяад шамдсан залуу нохойг дуудаад ч нэмэргүй урагш хар хурдаараа зүтгэнэ. Хөгшин азарган чоно том хадны дээр хойд хоёр хөлөөрөө тулчихаад биеэ огцом эргэн зайлж араас нь үсрэн дүүлэх залуу нохойг түлхэхэд цаадахь нь тэнцвэр алдан унаж хоёр хадны завсар хавчуулагдан гарч чадалгүй гаслалаа. Хэдийгээр түүний шарх айхтар хүнд биш боловч татан гаргахад амаргүй тул анчид тэнд нь гаслуулан орхисоор цааш гэтэцгээв. Анч ноход сэрвээний үсээ босгон сандралдахад хөгшин өлөгчин самбаачлан нэг нүх рүү шурган оржээ.

Азарган чоно гурван тал эгц, нэг тал нь арай хэвгий өндөр цохионы хоёр ширээ нийлүүлсэн мэт тэгш орой дээр цомцойн суухад сүүмэг агаад овжиндуу нүдний харцанд эцсээ хүртэл үзэлцэхэд бэлэн төрх тодорно. Ноход гурван талаас нь хуцан дайрах боловч өндөр цохионд хөл алдахаас айгаад хэн нь ч дээшилж чадахгүй ажээ. Хүмүүс ч чоныг бүслэн авахад Бао Шүнь Гүй чонын арга тасарсан байдлыг хараад их л омогшингуй янзтай “Та нар хөдлөлгүй намайг харж бай” гэгчхээд бууныхаа жадыг угсран сумлаад буудахаар ойртлоо.

Бао Шүнь Гүй нохдын архан талд очих үед хөгшин чоно цохионы арай хэвгий талын хайрга чулуутай хэсэг рүү үсрэв. Хөгшин чоно дөрвөн хөллөн сул чулуун дээр буугаад сарвуугаар чулуунаас зуурч, цээж хэвлийгээр нурангийг даган гулсахад том жижиг чулуудын тоосон дунд дарагдан үзэгдэхээ болив. Хүмүүс арай ядан хавцлын ирмэг дээр очоод өлийн харвал тоос тортог намжсан боловч хөгшин чонын бараа туруу ч үзэгдэхээ байжээ. “Юу болох нь энэ вэ? Чоно дарагдаад үхчихэв үү? Эсвэл зугатаад явчихна гэж баймааргүй юм даа” хэмээн Бао Шүнь Гүйг асуухад “Үхсэн амьдын алин ч болов чонын арьс олдохоо өнгөрсөн бололтой” гэж Бат сулхан дуугарлаа. Бао Шүнь Гүй тэндээ үг дуугүй хэсэг зуур зогсов.

Ян Кө дуугаа хураан зогсох зуур дунд сургуульд байхдаа үзсэн “Чонын соёт уулын таван баатар” кино өөрийн эрхгүй санагдана.

Чонын нүхийг сахин үлдсэн хоёр нохой хуцаж гарав. Бао Шүнь Гүй гэнэт сэхээ ороод “Өөр нэг чоно байгаа шүү дээ. Өнөөдөр ямар ч байсан ганзага хоосон буцаж болохгүй” гэв.

Лхасүрэн Санжаа хоёр чулуунд хавчуулагдсан нохойны дэргэд очоод хоёр хөлөөс нь татан гаргаж ирэв. Залуу нохойн хажуу хавирганы арьс зулгаран цус шүүрснийг хамт өссөн өөр нэгэн нохой долоож өгнө.

Анчид чонын нүхэн дээр ирж үзвэл салхи усанд идэгдэж үүссэн багавтар хадан агуй ажээ. Тал нутгийн адгуусан амьтдын түр хоргодох байр болсон агуйн амны өмнөх чулуун дээр бүргэдийн сангас цайран харагдана. Бао Шүнь Гүй чулуун агуйг сайтар ажсанаа толгой маажиж “Баларсан юм боллоо. Ухна гэвэл нурж ч мэдэх юм байна. Утаад бас нэмэргүй юм. Батаа яавал дээр вэ?” хэмээн асуулаа.

Бат уурганы бөгс шургуулан төнхөж үзэхэд сул чулууны нурангинаас өөр чимээ сонсогдсонгүй тул тэр толгой сэгсрээд “Цагийн гарз болох нь. Ухаж төнхөж байгаад хүн нохойгоо даруулчихвал сүйд болно гэсэн үг” гэхэд “Хэр зэрэг гүн агуй байна вэ?” хэмээн Бао Шүнь Гүй асуув. Бат хариуд нь “Гүн нь ч гайгүй юм байна л даа” гэв. Бао Шүнь Гүй өгүүлрүүн “Та нар тэгвэл хатсан өвс түүгээд ир. Утаад үзье. Тэгээд утаа хаагуур гарахыг харж



байгаад тэр хэсгийг бөглөчихье. Би халуун ногоо авч яваа. Чоно түүний утаанд яаж тэсдэг юм бэ? Хурдан явцгаа. Ян Кө бид хоёр нүхний амыг сахиад сууж байя. Хэдэн айхтар чонын ангуучид дагуулаад гурван өдрийн хугацаанд ганцыг ч агнаагүй гэвэл аж ахуй даяар шоолж мэднэ” гэлээ.

Анчид мөчир гишүү, хатсан өвс шарилж түүхээр салж явахад Бао Шүнь Гүй, Ян Кө хоёр нүхийг сахин үлдлээ.

“Энэ хөгшин өлөгчин эцэж тураад хөгшин ямааны насгүй болсон. Ядаж зуны чонын арьс ноолуургүй гээд худалдаа бэлтгэлийн анги авдаггүй. Тийм болохоор түүний амийг хэлтрүүлчихвэл яасан юм бэ?” гэж Ян Көг хэлэхэд

Бао Шүнь Гүйгийн царай барайн тамхины утаагаа үлээгээд “Үнэндээ хүн гэдэг чонын хаана ч хүрэхгүй. Би цагтаа цэрэг удирдаж байсан хүн. Дайтаад ирэхийн цагт урваж оргох явдал гарахгүй гэхийн баталгаа байхгүй. Гэтэл чоно яахаараа үхэн үхлээ тэмцэж чаддаг байна вэ? Олонбулгийн чононууд эр эм хөгшин хөвөөгүй бүгд хүний зүрх чичрэм сайн цэргүүд юм шүү. . . . Харин чиний зуны чонын арьс хэрэггүй гэдэг ч юу л бол. Манай нутагт зузаан үс ноостой чонын арьсан дээр унтахаар хөөрдөг гэлцдэг болохоор нимгэн тачир арьсыг илүүд үздэг юм. Үхэх сэхэхээ үзсэн тулалдаанд ядуу дорой гэж өрөвдөх юмгүй, алаад л дуусгах хэрэгтэй байдаг. Тийм болохоор өр зөөлөн сэтгэл гаргаад хэрэггүй” хэмээн хэлэв.

Бат хамт явсан хүнтэй цуг олсоор хуурай мөчир баглан ирэхэд Лхасүрэн нар ч хатсан өвс, шарилж хормойлон авчрав. Бао Шүнь Гүй хатсан өвс модыг нүхний аман дээр асаан утаж гарлаа. Анчид түүдгийг тойрон суугаад дан дээлийнхээ хормойгоор утааг нь дотогш сэвэн оруулна. Өтгөн утаа агуйн амаар ороод удаж төдөлгүй энд тэндээс нь утаа суунаглаж эхлэв. Анчид хахаж цацсаар утаа савсах газар бүхэн рүү өвс чихэхэд алдагдсан утаа улам багасаад иржээ.

Бао Шүнь Гүй атга дүүрэн нунтаг халуун ногоог гал руу хийгээд хахаж цацуулам өтгөн утааг нь агуйн ам руу сэвэн орууллаа. Хадан агуй зуухны ам мэт хэдэн чулуунуудын дор байрласан тул хүн ноход салхины дээр гарч зогсов. Хар утаа утаа агуйн дотогш орсоор дүүрэхэд анчид зориуд ганц хоёр гарах жижиг нүх үлдээжээ. Гэнэт агуйн доторх хөгшин өлөгчин хахаж цацаж эхлэхэд анчид малиагаа бэлдэн, ноход дайрахаар зэхлээ. Нүхэн дотор багтраа өвчтэй хөгшин хүн бүгшүүлэн ханиалгахтай ижил дуу улам тод сонсогдов. Гэвч хөгшин чонын толгой ч цухуйх янзгүй. Ян Кө утаанд нүд хорсон нулимсаа урсгах зуур чонын гайхалтай тэвчээрийг бахархан бодож зогсжээ. Хэрвээ хүн байсан бол цэвэр агаарт үхье гээд гараад ирэх байсан байж таарна.

Гэнэт хагас метр хэртэй чулуу сархийн нурж хэдэн ч өвс шавраар бөглөсөн нүхнээс утаа савсаж эхлэлээ. Нурсан чулуу агуйн аман дээр утаа сэвж байсан анчдын гарыг цохих шахав. Хүмүүсийн хүйтэн хөлс чийхрахад “Агуй нурж байна. Хурдан нуугдаарай” хэмээн Бао Шүнь Гүй хашгирав.

Агуйн дотор бүгшүүлэх чимээ намжаад таг чиг болчихов. Агуйн ам хаагдсан тул гушуун 20 утаа тэнгэр өөд цойлох ажээ. “Та ч мөн хийморьгүй байна даа. Энэ өлөгчин танаас арьсаа харамлаад чулуунд даруулан үхчихлээ шүү дээ” хэмээн Батыг хэлэхэд “Чулууг зайлуулж тэр

чоныг гаргаад ир” хэмээн Бао Шүнь Гүй хашгирлаа.

Олон өдөр аяншиж ядарсан анчид чулуун дээр суучихаад хөдлөх янз алга. Бат сайн янжуур гарган бүгдэд тараангаа Бао Шүнь Гүйд ч нэгийг сарвайгаад “Та чонын арьсны төлөө биш, устгахын төлөө явдаг гэдгийг хүн бүхэн мэднэ. Энэ чоно үхчихсэн болохоор болоо биш үү? Бид хэд маргааш өглөө болтол ухаад ч гаргана гэдэг худлаа. Та бид хэдийг дагуулан сүрэг чоныг хөөн зайлуулаад нэг хөгшин чоныг хаднаас нисгэн үхүүлж, нөгөөг нь нүхэнд утаж алсан гэдгийг бид хэд батлана. Тэгээд ч зуны чонын арьс олигтой үнэ хүрдэггүй юм” гээд бусад руугаа харан “Та нар батлана биз дээ?” гэхэд цаадуул нь ч “Тэгэлгүй яах вэ” гэлээ. Бао Шүнь Гүй өөрөө ч ядарсан бололтой уртаар амьсгаа аваад “За яахав. Жаахан амарч байгаад буцацгаая” гэлээ.

Ян Кө нурангийн өмнө гөлрөн зогсоход сүнс нь аварга хаданд даруулаад хамаг биеийн цус дээшээ огших шиг болов. Тэр чулуун нурангийн өмнө өрөөсөн өвдгөө сөгдөн монгол баатруудын ёсолгоог үйлдэх гэснээ цэхлэн зогсов. Ян Кө Батаас нэг тамхи гуйж аван хэд сорсоноо утааг нь дээш савсуулан бариад чулуун нуранги руу хандан гурвантаа мөргөснөө их л хүндэтгэлтэйгээр хадны завсар хавчуулав. Аварга том чулуун булш шиг хадан агуйн завсар зайгаар савсах утаа тал нутгийн хөгшин өлөгчин чонын сүнсийг тэнгэр өөд аван одлоо.

Анчид хүндэтгэн зогссон боловч Ян Көтэй адилхан “Хүжийг” өргөсөнгүй. Хүний татсан тамхи монгол малчдын хувьд бузар эдэд тооцогдох тул сахиусанд өргөж яахин болох билээ. Гэвч тэд Ян Көгийн энэ ёс бус үйлдлийг хориглоогүй юм. Анчид гар дахь тамхиа унтраацгаан үг дуугүй тэнгэр ширтэн зогсоход тэдний хиргүй тунгалаг харц утаанаас түргэн хөгшин өлөгчингийн сүнсийг энхжингийн орноо хүргэлээ. Бао Шүнь Гүй хүртэл тамхины гал хурууг нь цонотол ганц ч сороогүй ажээ.

“Урьд цагт Чингис хааны морин цэргүүд үхэхдээ хүртэл энэ хоёр хөгшин чоно шиг дайсныхаа зүрхийг чичрүүлдэг байсныг одоо харж байна уу? Та ч гэсэн тал нутагт амь бөхтэй орших монгол хүний үр хойч болохоор монголынхоо сахиус шүтээнд хүндэтгэлтэй хандаж баймаар юм даа. . . . .” хэмээн Бат Бао Шүнь Гүйд хандан хэллээ.

Ян Кө санаа алдаад “Үхэл хүртэл тэмцлийн аугаа хүч байдаг ажээ. Чонон сүлд хичнээн олон үхлээс үл халшрах монгол баатруудыг хүмүүжүүлэн гаргаа бол? Эртний хятадын хүн ам монголчуудаас хэдэн зуу дахин олон боловч хааны ордон жирийн иргэдийн гэр орон хаана боловч ноёрхсон “Сайн үхсэнээс муу амьд яв”<sup>21</sup> гэдэг итгэл үнэмшил суурьшмал үндэстэн болох тэдний хувьд өнөө хэр амь бөхтэй зууралдсаар амиа хоохойлох арга, гүн ухаан болтлоо хөгжжээ. “Сайн үхсэнээс муу амьд яв” гэдэг энэхүү үндэсний ухамсар олон зуун хятадын урвагч зальхайчуудыг хүмүүжүүлэн гаргасан нь нүүдэлчдийн хувьд бол жигшин зэвүүцмээр зүйл юм. Тан улсын дунд хожуу үеэс хятад хүмүүсийн хийморь сүлд доройтон удаа дараа мөхсөн төрийн боол төдийхөн болж хувираад Цин Ши Хуан, Хань улсын Ү Ди хаан, Тан улсын Тан Зун хааны омог сүр хаашаа хулжин одсон юм бол доо? Арай Тан улсын дунд хожуу үед хятадууд дотор газрынхаа чонон сүргийг алж устгачихаад үндэсний ухамсар зан чанарыг доройтуулчихсан хэрэг биш биз дээ?” хэмээн бодлоо. Ямар ч байсан тэр Чэнь Жэньтэй шөнийн турш ярьж хөөрөх шинэ ярианы сэдэвтэй болжээ.

Анчид майхандаа очихын алдад Бао Шүнь Гүй Батад хандан “Та нар түрүүлж очоод ус

буцалгаж бай. Би нэг хун агнаад ирье. Орой би та нарыг сайхан дайлна аа” гэхэд Ян Кө бачимдан хашгирч “Бао дарга аа, хунг битгий алаач гэж би танаас зөндөө гуйсан шүү дээ” гэв. Бао Шүнь Гүй эргэж ч харсангүй “Би нэг хун алж энэ хэдэн өдрийн уурыг заавал гаргах хэрэгтэй байна” гэлээ.

Ян Кө түүнийг хориглох санаатай араас нь давхисан боловч Бао Шүнь Гүйгийн морь давхил сайтай болохоор нуурын эрэгт түрүүлэн хүрчээ. Нуурын дээгүүр галуу нугас ганганан нисэлдэж буу морьтой хүмүүсээс айж үргэх шинж үгүй. Нуурын зэгсэн дундаас долоо найман хун дэрхийн нисэх нь хөөрөх зурвасаас хүчээ авсан онгоцнууд шиг тэнгэр өөд цойлон далавчаа дэвж Бао Шүнь Гүйгийн толгой дээр сүүдрээ тусгалаа. Ян Кө Бао Шүнь Гүйгийн өмнө хүрч очихоос өмнө буун дуу гурвантаа дараалан тасхийгээд аварга цагаан шувуу Ян Көгийн морины өмнө нэвсийн унав. Морь нь үргэн булгиж, Ян Көг нуурын эргийн чийглэг хөрсөн дээр авч шидлээ.

Хун зүлгэн дээр цусаа гоожуулан тийчигнэнэ. Ян Кө бүжгэн жүжигт хунгийн гунигтай үхлийг цөөнгүй харж байсан боловч нүдний өмнөх хөөрхий хун омог бардам байдлаа ор мөргүй гээгээд хүзүүгээ таслуулсан гэрийн тэжээвэр галуунаас өөрцгүй, босож ирэх санаатай далавчаа савчих нь амьдралын төлөө тэмцэх байгалийн зөн совин түүнийг сүүлчийн агшинд ийн тийчлүүлж байгаа бололтой. Хунгийн цээжин дэхь сумны ороор цус садрахад Ян Кө түүнийг тэврэн авахаар ухасхийсэн боловч хий мөргөөд улаан цус горхилон урссаар зүлэгт ногоон хөрс рүү шингэсээр байх ажээ. . . . .

Ян Кө арайхийн шархтай хунг барьж авахад түүний зөөлөн хэвлий халуунаа алдаагүй боловч үзэсгэлэнт хүзүү нь амьд асуултын тэмдэг хэлбэрээ алдан нурууны ясыг нь сугалсан цагаан могой шиг Ян Көгийн шуун дээр эвхрээд цустай цагаан өд сөд нь хүний хөл ховор хүрсэн хунт нуурын мандал дээгүүр хөглөрч байлаа. Ян Кө хунгийн толгойг болгоомжтой өргөхөд томорсон хүүхэн хараан дахь хөх тэнгэр уур хилэнтэй хар зүгийн тэнгэр болон хувирах шиг санагдав. Эрхэмсэг агаад цэвэр ариун, түмэн бээрийг туулан нисэх чадалтай амь, хүн төрөлхтөнд шавхагдашгүй төгс мөрөөдлийг бэлэглэгч үзэсгэлэнт хун тэжээвэр тахиа шиг алууллаа гэж үү дээ хэмээн бодоход түүний нулимс нүдний аягыг дүүрээд ирэв.

Ян Кө уур хилэнгээ барьж ядахдаа нуурын усыг туучин зэгсэн дундахь хунгуудад аюул түгшүүрийг дуулгамаар санагдлаа. Оройн нар жаргахад Бао Шүнь Гүй тогоо дүүрэн хунгийн махны хажууд бөртийн суухад түүнтэй ярьж хөөрөх хүн ч үгүй байлаа. Анчид зэрлэг гахайн махыг шарж идэх зуур Ян Көгийн хутга барьсан гар чичирсээр байх ажээ.

Хунт нуурын тэнгэрт сүрэг хунгийн гаслантай ганганалдах чимээ шөнөжин тасраагүй юм.

Шөнө дунд майхны гаднахь хэдэн ноход чоно шиг улих чимээнээр цочин сэрэв. Нохдын дуу намжихад зүүн уулын тэртээгээс хөгшин чонын тасалдангуй улиан бүдэг бадаг сонсогдлоо. Хөгшин чонын жиндүү хүйтэн улилт Ян Көгийн сэтгэлд нэвчих шиг санагдана. Тэр хөгшин чоно ангал хаднаас үсрээд хүнд шархдан мацсаар дээшээ гарч дээ, зайлуул. Тэр лав өдийд өөд болсон өлөгчингийн чулуун булшны өмнө элэг эмтрэмээр улин гаслах боловч чулууг зайлуулан эцсийн удаа барааг нь харах хүч тамираа алдсан байж таарна. Ижлээ алдсан хун болон хөгшин чоно хоёрын улиан ганганаа уусан нэгдэж “Тал нутгийн эмгэнэлийн дууг” хайлна.

Ян Кө ч үүр цайтал нулимсаа мэлмэрүүлэн хэвтжээ.

Хэд хоногийн дараа Лхасүрэн аж ахуйн төвөөс эргэн ирэхдээ Бао Шүнь Гүй ачааны машин дүүрэн шахуу цээнийн цэцэгсийг үндэстэй нь ачаад хот руу явсан болохыг дуулгаж билээ.

*Эцэг хааны морьт цэрэг чоно мэт эрэлхэг байтал дайснууд нь хонь лугаа адил аймхай хулчгар байж билээ.*

*Культегиний хөшөөний бичээс*

Зуны эхэн сарын нарны туяа хотгорын дээгүүр хөвөх сэмжин цагаан үүлсийг нүд гялбам гийгүүлнэ. Агаарт хонь малын хазласан агь таанын үнэр хамар сэтлэм сэнгэнэж хүмүүсийн нүдийг хорсоно. Чэнь Жэнь өлөгчин чоныг сүргээ дагуулан ирж бэлтрэгээ булаан, хонин сүргээс өшөөгөө авах вий гэж их л айх тул шинэ нутаг бэлчээрийнхээ байр байдлыг сайтар ажин шинжлээ.

Хоёрдугаар багийн гучаад өрх айл хотгорын баруун хойд уулын хормойг түшин бууцгаажээ. Айлууд хоёр хоёроор таван зуун метр хүрэхгүй зайтай айлсан буусан нь хэсгүүдийн зайг ч ихээхэн ойртуулсан байлаа. Хот айлууд ийнхүү ойрхон айлссан нь урьдын хэдэн арван километр зайтай байсныг бодвол хаяа хатган бууснаас өөрцгүй юм. Билиг Өлзий хоёр айлуудыг ийнхүү ойрхон айлсуулсан нь шинэ нутгийн чонон сүрэг ээлж дараалан халдан дайрахаас сэргийлсэн хэрэг байлаа. Олонбулгийн чонон сүрэг ийм ойрхон шигүү айлуудын хүн нохойн хамгаалалтыг яаж ч чадамгүй мэт Чэнь Жэньд санагдана. Хэрвээ нэг л хот айл чонон халдлагад өртвөөс тоо томшгүй олон ноход тэдэн рүү бүчин дайрах юм. Чэнь Жэнь ийнхүү бодоход санаа нь бага зэрэг уужирсан болохоор нүдээ жонийлгон шинэ нутаг бэлчээрийн байр байдлыг ажиглаж эхлэв.

Багийн хэдэн арван суурь хонь мал хотгорт орж ирснээр атар онгон тал ганц өдрийн дотор л байгалийн асар том бэлчээр болон хувирчээ. Дөрвөн зүгээс дуу хуур цангинан адуу малын дуу холилдож уудам хотгор тэр аяараа хүн малын хөөр баяраар дүүрээд ирэв. Чэнь Жэнь, Ян Кө хоёрын хонин сүрэг урт зам туулан ядарсан болохоор гэрийн архан байх довцог толгойд тааваар бэлчинэ. “Энэ нутаг өнгөрсөн зуны бэлчээрээс тэнгэр газар шиг ялгаатай болохоор миний сэтгэлд шинэ газар орон нээсэн омогшил дүүрээд харамсахаас илүү уужрал тайвшралыг мэдэрч байна. Заримдаа зүүд нойрондоо хонин сүргээ туусаар энхжингийн оронд хүрээд ирсэн юм шиг санагдах юм” хэмээн Чэнь Жэнь уясангуй өгүүллээ.

“Би ч мөн өөрцгүй ертөнцийн диваажин, тал нутгийн хунт нуурт хүрэлцэн ирсэн юм шиг л санагдаад байна. Хэрвээ Бао Шүнь Гүй, илгээлтийн эзэд болон гадны цагаачид байдаггүйсэн бол Олонбулгийн малчид хун шувуудтай эв найртай хаяа хатган амьдрах байсан юм. Хун шувууд нисэлдэх тэнгэрийн хаяан дор хонин сүргээ хариулж явах хичнээн романтик билээ. Энхжингийг оронд цагаахан хун байгаа ч үү, үгүй ч үү. Хэдэн жилийн дараа чоно сүүлдэхээс сийхгүй монгол эхнэр авчихаад бэлтрэг суйлахаас айдаггүй хэдэн монгол хятадын эрлийз хүүхдүүдтэй болчихвол насны хэрэг бүтлээ гэсэн үг” хэмээн Ян Кө өвсний үнэрийг уртаар амьсгалаад “Би байтугай Тан улсын хунтайз хүртэл Түрэг хүн болохоор мөрөөддөг байсан гэдэг биз дээ. Тал нутгийнхан нохойгоо хайрлаж эдлэж чаддаг бол манай Бээжинд хаа сайгүй нохойн толгойг хага цохиж байгаа. Над шиг харгис эрдэмтний “Нохойн гөлөг” тал нутагт хөлөө олон амьдрах шиг амар жаргал үгүй байх аа” гэлээ.

“Илгээлтийн эзэн байхгүй бол сайхан аа гэдэг чинь юу гэсэн үг вэ? Чи тэгэхээр өөрөө хэн

болж байна вэ?” хэмээн Чэнь Жэнь сөргүүлэн асуулаа.

“Чин сэтгэлийн угаас чонон сүлдийг дээдлэн шүтэж эхэлсэн цагаас хойш би монгол хүн болон хувирсан юм. Монголчууд тал нутгаа өөрийн амь наснаас илүүтэй хайрладаг болохоор энд ирсэн цагаас хойш надад суурьшмал иргэд нэг л зэвүүн санагдах болсон. Нүүдэлчид суурьшмал үндэстнүүдтэй хэдэн мянган жилийн турш дайтсаар ирсэнийг гайхаж ядаад байх зүйл үгүй. Би хэрвээ эрт дээр цагт төрсөн бол Ван Жао Зюнь 22 лугаа адил сайн дураараа цагаан хэрмийн чанадад түүний бараа бологчоор ч хамаагүй очих л байсан. Тэгээд хэзээ нэгэн өдөр дайн дэгдвэл тал нутгийн их амины төлөө эрслэн босоод тэнгэрийн ёс, тал нутгийн дэг жаягийг хамгаалан байлдах байсан юм” хэмээн Ян Кө хариулахад

Чэнь Жэнь инээд алдан “За тэр нь ч юу вэ? Түүхийн турш суурьшмал үндэстнүүд нүүдэлчидтэй дайтаж байлдсаны эцэст эвлэрээд ураг барилдсаар ирсэн тул бидний цус ч хольцтой л байж таарна. Энэ нутаг бэлчээр Олонбулгийн хүн малыг дөрөв таван жилдээ санаа амар байлгаж чадна гэж Өлзий гуай хэлж байсан. Тэр энэ тал дээр том гавьяа байгуулсан болохоор дахин дэвшээд гараад ирээсэй билээ. Өлзий, Билиг нарын тал нутгийн хүчин тал нутгийг тонон дээрэмдэх үзэлтнүүдийг дийлэх болов уу гэдэг л миний санааг их зовоож байна” гэв.

“Чи дэндүү утопи үзэлтэй юм аа. Хятадын ирээдүй суурьшмал иргэдийн тоог таван зуун саяас доош байлгасан цагт л сая гэгээтэй байх болно гэж манай аав нэг удаа ярьж байсан сан. Гэтэл тариачдын энэ замбараагүй өсөлтийг хэн зогсоож чадах билээ? Монголын мөнх тэнгэр хятадын хурмаст тэнгэртэй хамжаад ч чадахгүй юм байх аа. Ойрын хорин жилд тариачдыг ажилчин, хотын иргэн, сэхээтэн болгох нь битгий хэл хотын сэхээтнүүдээ болдогсон бол бүгдийг нь хөдөө хөөж гаргаад хоёрдугаар зэргийн тариачин болгочих юмсан гээд байгаа биз дээ. Тэр бодлогын золиосонд бидний хэдэн сая илгээлтийн эзэд хотоос хөөгдөн гараад байгаа. Тийм байтал Өлзий, Билиг нарын энэ өчүүхэн хүч түүний хажууд тэрэгний дугуй тосох голиотой адил байлгүй.” хэмээн Ян Кө өгүүлэв.

Чэнь Жэнь нүдээ бүлтийлгээд “Чонон сүлд чиний сэтгэлд жинхэнэ байраа олоогүй янзтай байх чинь. Чонон сүлд гэдэг бол арав, зуу, мянга, түмийн эсрэг ганцаараа тэмцэж чадах оюун санааны хүчийг хэлж байгаа юм. Чонон сүлд бол тал нутгийн их амийг хамгаалах сүлд, ер нь ч энэ хорвоод их амь нь бага амиа захирч, тэнгэрийн бошго хүний амийг эрхшээж байдаг. Тэнгэр газрын их амь тасарваас хүний өчүүхэн амь юу болох билээ. Чонон сүлдийг жинхэнээсээ шүтэе хэмээвэл тэнгэр газар, байгаль дэлхий, тал нутгийн их амины талд зогсож, ганц чоныг боловч үлдээхийн төлөө тэмцэх л хэрэгтэй. Аливаа зүйл туйлдаа хүрэхээр урваж хөрвөдөг байгалийн хуульд итгэдэг л бол мөнх тэнгэр тал нутгийн өшөөг авч л таарна. Тал нутгийн амины талд зогсож байхад хамгийн муугаар бодоход их амийг сүйтгэгч нартай хамт зүйл дуусаад сүнс маань тэнгэрт очиж чадах юм. Хүн хэрвээ ингэж амьдарч чадваас үхсэн ч санаа амар байх бус уу? Тал нутгийн олонх чоно энэ утгаар бол дайтсаар үхэж байгаа юм шүү” гэлээ.

Ян Кө хэсэг зуур бодлогоширлоо.

Бэлтрэг хараа цуцам шинэ орчныг их л гайхан догдолж байгаа бололтой гол руу ус уухаар цувран явах үхэр сүргийг харж байснаа заримдаа сувдран цайрах хонин сүргийг толгой

гилжийлгэн ажна. Тэгснээ нуурын мандал дээгүүр эргэлдэн нисэх шувуудын чуулганыг бараалан харж зогсов. Тэр нэг дор ийм олон зүйлийг харж байгаагүй болохоор лав нүд нь эрээлжилж байгаа бололтой. Хуучин нутагт Чэнь Жэньгийнх Билиг өвгөнийхөөс наанадаж хоёр километр хол зайтай байсан болохоор бэлтрэг сайндаа л сүрэг үхэр, хонь, ганц чулуун хороо, хоёр монгол гэр болон зургаа долоон үхэр тэрэг хардаг байсан билээ. Зам зуур тэр араг дотор хоригдоод хоёр өдөр нэг шөнө юу ч олж хараагүй байж таарна. Тэгсээр нарны туяа дахин олж үзэх үед байдал тэс ондоо болон хувирчээ. Бэлтрэг хөөрөн цовхчих бөгөөд хэрвээ төмөр гинжээр уяагүйсэн бол ноходтой хээр талаар хөөцөлдөн тоглож замдаа тааралдсан нохойн гөлөгнүүдтэй урцалдах байсан биз ээ.

Чэнь Жэнь Өлзийгийн саналын дагуу бэлтрэгийг гинжилдэг болов. Бэлтрэгний хүзүүн дэх үхрийн суран хүзүүвчийг төмөр гархитай холбон гинжлээд нөгөө үзүүрт бэхлэсэн гархийг газарт хоёр тохой гүн суулгасан хайлаасан шонгийн үзүүрт углан орхидог болжээ. Энэ төмөр гинжнээс үхэр ч мултран гарч чадахгүй тул бэлтрэг үүрнээсээ зугатъя гэж бодоход төмөр гинж нь шонд ороогдон богиноссоор адаг сүүлдээ амь алдаж ч мэдэх юм.

Нүүхийн өмнөх нэг долоо хоногт бэлтрэг эрх чөлөөгөө хасуулж метр хагасын урттай гинжээр оосорлогдон бяцхан хоригдол болжээ. Бэлтрэг долоо хоногийн турш төмөр гинжинд уурлан хазсаар энд тэндгүй шүлсдэж орхихыг Чэнь Жэнь сэтгэл өвдөн харж байлаа. Гэвч тэр төмөр гинжийг тас хазан, бүдүүн шонг суга татаж чадахгүй болохоор гурван метрийн радиустай задгай шоронд өдөр хоногийг өнгөрөөх болсон юм. Чэнь Жэнь түүний салхинд гарах хугацааг уртасган зовиурыг нь хөнгөлөхийг оролдоно. Хааяа нэгхэн нохойн гөлөг түүний хүрээнд орж ирэх нь бэлтрэгний хувьд хамгийн баяртай үе байх боловч тэр тэсгэлгүй хазаж гаслуулан хөөж явуулаад адаг сүүлд нь ганцаараа үлдчихдэг. Гагцхүү Арслан л байн байн түүн дээр ирж тойрогт нь хэвгэн гэдэс толгойн дээрээ гишгүүлэн чих хөл сүүлээ хазуулна.

Бэлтрэгний хийдэг өөр чухал алба гэвэл монгол гэрийн үүдэнд тавьсан идүүр дүүрэн хоол өмнө авчирч тавихыг хүлээх явдал юм. Бэлтрэг чухам яагаад өөрийн ийнхүү хоригдох болсны цаад шалтгааныг ойлгосон эсэхийг бүү мэд, гагцхүү түүний нүдэнд гөлөгнүүд яагаад чөлөөтэй тааваараа явж байхад өөрөө ийн хоригдох болов гэж бухимдангуй төрх илрэхийг Чэнь Жэнь олж хардаг юм. Тийм ч учраас гөлөгнүүдэд уураа гарган цусыг нь хольдог байж таарна. Балар эртний үед хонь, нохдын дэргэд чоно тэжээхдээ хүмүүн бусаар л хандаж байхгүй бол жаахан цалгардвал хүн мал шархдуулаад алуулах тавиланд унадаг байсан байж мэднэ. Чэнь Жэнь хэдэн ч удаа бэлтрэгт энэ тухай намуухан тайлбарлан өгүүлсэн боловч цаадахь нь уясан зөөлрөх янзгүй. Энэхүү шудрага бус хандлага нь бэлтрэгний сэтгэл зүйд ноцтой нөлөөлөх вий гэж Чэнь Жэнь, Ян Кө хоёр санаа зовох болов. Төмөр гинжээр уяулсан бэлтрэг чөлөөтэй хөгжих хувийн зан чанараа алдчихаар тийм орчинд өссөн амьтныг жинхэнэ чоно гэж тооцож болох уу? Тэгвэл лав Чэнь Жэнь, Ян Кө нарын ойлгохыг хүсдэг жинхэнэ талын чононоос маш их ялгаатай болж таарна. Тэр хоёрын шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа эхнээсээ авахуулаад нөхцөл байдал тохирохгүй ноцтой асуудалтай тулгарчээ. Хэрвээ аль нэгэн суурин газрын төмөр тор болон чулуун хороонд чоно тэжээвээс харьцангуй эрх чөлөөтэй төдийгүй хүн малд ч гэм хор учруулахаас зайлж болохсон. Чэнь Жэнь, Ян Кө хоёр зарим талаар “Чоно унавал бууж болдоггүй”<sup>23</sup> гэсэн байдалд орсон бөгөөд ерөөсөө тэр хоёрын шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа эхнээсээ бүтэх учиргүй байсан ч юм бил үү. Ян Кө нэг удаа бэлтрэгийг тавиад явуулчих санаагаа цухуйлгасан боловч Чэнь Жэнь түүнийг

эрс эсэргүүцсэн юм. Ян Кө угтаа бэлтрэгээс салж чадахааргүй хайртай болсон байлаа.

Тал нутагт үхэр сүргийн нийлүүлгийн үе дахин ирлээ. Тал нутгийн эрх чөлөөний бэлгэдэл болсон хэдэн хүдэр чийрэг бух шөнө дөлөөр үнээнүүдийн үнэрийг мөшгисөөр шинэ бэлчээрт сүр дуулиантай ирж ижил ханиа сонгон авчээ. Бэлтрэг өмнөө ирсэн том бухнаас айн өвсний араар нуугдав. Бух уухирдан нэг үнээний араас мордоход бэлтрэг бүр ч сүнс нь зайлав бололтой арагш ухасхийн цахлахдаа гинжиндээ татагдан хоолой боогдоод нүд цагаанаар эргэлдэж хэл нь бултганалаа. Бэлтрэг сав л хийвэл хүзүүн дэх гинжээ мартчихдаг бөгөөд бух өөр нэгэн үнээ рүү явахад сая нэг юм тайвшрав.

Чоно шинэ хориондоо дасаж байгаа бололтой шонгоо тойрон тоглодог болжээ. Шинэ нутагт хаа сайгүй тохой өндөр өвс ургасан нь урьдын халцгай хэвтрээс нь хавьгүй дээр болох нь ойлгомжтой. Бэлтрэг тэнгэр өөд харан хэвтээд хажуудаа байгаа өвсийг зулгаах зэргээр өөрийгөө хагас цаг шахам зугаацуулчихна. Амьдрах эрч дүүрэн бэлтрэг өөрийн гэсэн бяцхан хүрээнд эрч хүчээ сэлбэх хөдөлгөөнийг олж аваад өдөрт хэдэн ч удаа шонгоо тойрон эцэж цуцахыг мэдэлгүй хурдлан давхина.

Ингэж хар хурдаараа давхиж байснаа гэнэт огцом зогсоод нар буруу хурдлаж гардаг. Ийнхүү цуцтал гүйсний эцэст зүлгэн дээр тэрийн хэвтээд нохой шиг хэлээ гарган аахилна. Бэлтрэг ойрдоо ердийнхөөс хэд дахин урт хугацаагаар гүйж байгаа нь биеийн халуунаа ихэсгэн ноолуураа гуужуулах зорилготой болохыг Чэнь Жэнь ойлгожээ. Бэлтрэгний ноолуур том чоныхоос хавьгүй орой гууждаг гэж Билиг өвгөн хэлдэг юм.

Бэлтрэгний гүйсэн мөрөөр өвс халцран тойрог жим үүсчээ.

\* \* \*

Гэнэт зүүн талаас морин төвөргөөн пижигнэн Жан Зи Юань толгойгоо цагаан даавуугаар боочихоод давхин ирж байлаа. Манай хоёр сандран тосож очвол Жан Зи Юань “Битгий ойртоорой” хэмээхэд унасан даага нь эргэцэн үргээд хүн хавьтуулах янзгүйг үзвээс дөнгөж сургаад байгаа бололтой. Манай хоёр түүнд өөрөө буух боломж олгох гээд жаахан зай тавьж өгөв.

Монгол морьд дундаа үзэмчин морьд их омголон билээ. Даагыг гурван нас хүрэхийн өмнөх хавар голцуу сургадаг. Хавар эрт морьд туранхай боловч залуу даага том хүн даахтай болсон байдаг. Хэрвээ энэ үеийг л өнгөрөөчихвөл эмээл тохож амгай зүүгээд сургана гэж ярилтгүй. Тийм морийг бусдаар чихдүүлэн эмээл тохож амгай зүүгээд мордлоо ч гэсэн булгиж бусгаад авч шидэхээс нааш зогсоно гэж үгүй. У Зө Тяний 24 морь сургадаг цуст аргыг хэрэглээд ч нэмэргүй л болов уу? Тийм болохоор нэг л эмнэгшсэн хангал морийг хээрийн салхинаас өөр зайдлах эзэн үгүй болдог.

Жил бүр адуучид номховгор даага сарваануудыг үхэрчин хоньчин нарт өгч номхруулаад нэг жил үнэ өртөггүй унах эрх олгоно. Тэр хүн түүнийг жил унаад өөрийн урьд унаж байсан морьдыг гүйцэхээргүй бол унаган ижилд нь буцаан тавьдаг. Харин тэр моринд нэр хайрлах эрхтэй. Олонбулагт адуунд нэр өгөхдөө сургасан эзний ард тухайн морины өнгө зүсийг нэмдэг. Тухайлбал: Билигийн улаан, Батын цагаан, Лхамжавын хар, Лхасүрэнгийн буурал,



Санжаагийн бор, Доржийн шарга, Чэнь Жэньгийн буурал гэх мэт хөвөрч өгнө дөө. Морины нэг л тогтсон нэр түүнийг насан туршид дагалддаг. Эмнэг хангалыг сургасан эзнийх нь нэрээр овоглох нь нэг ёсондоо тал нутагт эр зоригийн урамшуулал болдог тул Олонбулагт адууны нэр давхцана гэж бараг л үгүй. Хамгийн олон эмнэг сургасан хүн тал нутагт олны хүндлэл хүлээх бөгөөд шинээр сургасан даагыг сайн гэж үзвэл өөрийн урьд сургаж байсан өөр нэгэн мориор сольж авч болно. Үхэрчин, хоньчингууд өөрийн мэдлийн дөрөв таван морьдын хөгшин болон хашин нэгийг шинэ сургасан даагаараа солих нь олонтой.

Тал нутагт морин эрдэнэ бол монгол хүний амь наснаас өөрцгүй эрхэм. Сайн морь, сайхан адуу үгүй бол хунгар цас, гал түймэр, дайсны дайралтаас дайжин, эм эмнэлгийн туслалцаа үзүүлж, дайн байлдаан гамшиг зовлонгийн байдлыг мэдэгдэн, шуурганд уруудсан мал сүргээ яахин тогтоож чадах билээ. Тийм болохоор ч Билиг өвгөн морьгүй монгол мохдог хэмээн ярих дуртай.

Үхэрчин хоньчингууд сайн морьтой больё гэж бодвол сургаж авахаас өөр замгүй. Малчид бусдын сургасан морь унахыг гутамшиг гэж үздэг. Тийм болохоор Олонбулагийн малчид өөрийн сургасан морио унах бөгөөд зарим гав шув хийсэн үхэрчин хоньчин дүүхэлзсэн сайхан морь уначихаад залуу адуучдын нүдийг унаган алдах нь ч бий. Адуун сүргийн дундах шандас сайтай омголон даагануудыг адуучид голцуу л өөрсдөө сургадаг. Адуучид моринд гарамгай болохоор хамгийн олон эмнэг хангалыг сургаж хүссэн морио сольж унах эрхтэй. Гэвч эмнэг догшин мориноос шидэгдэн нүүр нүдээ хөхрүүлэх, ясаа хугалж, махаа таслуулах явдал цөөнгүй. Гэвч Олонбулгийн шандастай догшин эмнэг хангалын дундаас алдартай хурдан хүлгүүд төрөн гарах нь олонтой тул адуучид түүнийг сургаж авах гэж булаацалдах нь холгүй юм болно. Олонбулагт олон сайн адуутай адуучны байр суурь, нэр хүнд, танил тал илүү байдаг. Чонын үүрэнд шургаж, эмнэг хангалтай ноцолдон, араатан чоныг агнаж, хүчит бөх барилдан дайны талбар дээр дархан цолоо мандуулахыг тал нутагт монгол эрчүүдийн эрхэмлэх хэв шинж хэмээн үзнэ. Монголын тал эртнээс нааш тэмцлийн талбар байсаар ирсэн тул тэр хэрээрээ эр зоригтны эх орон ажгуу. Монголын их хаан олон овог аймгийн дундаас оройлон гарч ирснээс биш үе залгамжлаагүй. Монголчууд түүхэндээ бүтэлгүй Хунтайж нарыг сэтгэлийн мухраас хүлээн зөвшөөрдөггүй байсан болохоор эр зоригтой авга, ах дүү нар болон эрэлхэг жанжин, эрдэмт сайд нар түүнийг үлдэн хөөгөөд орыг залгадаг байсан юм.

Жан Зи Юань морины хүзүүг маажин анхаарлыг сатааруулж байгаад хөлөө дөрөөнөөс мултлан сэвхийтэл үсрэн буув. Эмнэг морь үргэн бусгаад эмээлээ аваад шидчих шахлаа.

Жан Зи Юань жолоо цулбуураа богиносгон хумьж хойд хөлөнд нь оногдчихолгүй зайлаад нэлээд ноцолдон байж үхэр тэрэгний хүрдэнд уяж авав. Эмнэг морь толгой сэжин тонгочихдоо үхэр тэргийг яйжгануулна.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр сая нэг уужим амьсгаа авлаа. “Муу золиг чи ийм айхтар эмнэг морь сургах гэдэг чинь аминаасаа уйдаа юу?” хэмээн Ян Кө асуухад Жан Зи Юань “Өглөө тэр намайг авч шидэн дух руу өшиглөөд ухаан алдуулсан шүү. Ашгүй Баг дэргэд байсан тулдаа гайгүй. Хавар хоёр удаа сургах гээд дийлэлгүй дараа нь дахин ноцолдож байж овоо номхруулсан юм. Гэтэл хаврын нялх ногоонд цадаад бас л дийлдэхээ больчихжээ. Унаган туурай нь бөхжиж гүйцээгүй юм болохоороо нармайг минь цөм өшиглөчихсөнгүй. Хэрвээ нас бие гүйцсэн адуунд өшиглүүлсэн бол яаж амьд гарах билээ? Цуутай азарганы үр сүүтэй

гүүний унага болохоор хоёр гурван жилийн дараа алдартай хурдан хүлэг болно доо. Олонбулгийн талд алдартай хурдан хүлэгтэй болохын тулд амь өрөн үзэхгүй бол яаж болох вэ?” гэлээ.

“Муу золиг дандаа санаа зовоож байх юм. Чи хэзээ эмнэг сургаад толгойгоо боохоо больсон цагт сая сайн адуучин боллоо гэсэн үг” хэмээн Чэнь Жэнь үг нэмэв.

“Хоёр жилийн дараа гэхэд болно биз дээ. Өнөө хавар би зургаан эмнэг сургасан. Бүгд л сайн морь болох шинжтэй тул та хоёр хол явахдаа морь малын тал дээр айлтгүй болсоон. Би та хоёрын унааг ч сайн морьдоор сольж өгнө” гэж Жан Зи Юань хэллээ.

Ян Кө инээвхийлэн “Чиний зориг зүрх нэмэгдэхийн хэрээр айхтар том үгтэй болох нь байна шүү. Бусдын хазсан боов амттай байдаг бил үү? Би өөрийн унах сайн морио өөрөө сургаад авч чадна. Өнөө жил бэлтрэг гэсээр явтал эмнэг сургаж чадсангүй. Ирэх жил л болохоос биш” гэв.

Чэнь Жэнь ч мөн “Та хоёрын чонын зан чанар улам илүү нэмэгдээд байна шүү. Зосыг дагавал улайна, чоныг дагавал зоригжино гэвэл таарах юм байна даа”<sup>25</sup> гээд инээд алдлаа.

Морьд ус ууж ханаад Чэнь Жэньгийн гэрийн урдахь нуга руу явцгаав. Энэ довцгоос хотгорын байдлыг нэлэнхүйд нь тольдон харж болдог. “Та нарт урьд нь адуун сүргийн тухай арван удаа ярьж байсан. Харин одоо өөрсдөө үзэх анги байгаа биз дээ. Урьд нь багийн захиргаа адуун сүргийг холхон бэлчээ гээд байдаг байсан бол одоо та хоёрт монгол морьд гэж ямархуу байдгийг үзүүлэх боломжтой боллоо” хэмээн Жан Зи Юань өгүүлэв.

Шинэ нутаг өргөн уудам, өвс соргог ус тунгалагтайн дээр нэг л багийн мал сүрэг тул захиргаанаас адуун сүргийг усласны дараа хонь үхрийн бэлчээрт түр байлгахыг зөвшөөрсөн билээ. Адуун сүрэг араас хөөж туух хүн үгүй тул доош тонгойн өвс шир ширхийтэл зулгааж эхлэв.

Нэгэн дүүхэлзсэн өндөр азарга Чэнь Жэнь, Ян Кө хоёрын харцыг өөрийн эрхгүй татлаа. Азарганы үс гуужиж гүйцээд шинэ торгон дээл өмссөн юм шиг өнгө засчээ. Азарганы хөдлөх тоолонд гилгэр арьсны цаадахь чийрэг булчингууд зангирах нь гулилзсан мөрөг загас хөвж буй мэт. Адуун сүргийн бусад морьдоос ялгарах гол онцлог нь хүзүү рүү асгаран цээжийг бүрхэх урт дэл байдаг. Хүзүү сээрний уулзвар дахь дэлний үс хамгаас урт байдаг тул өвдөг, туурайг даван газар чирэгдэх нь ч бий. Тэд газар тонгойн өвс хазлахад урт дэл цээжин биеийг нэлэнхүй бүрхээд толгой нүүргүй үлгэрийн амьтан мэт харагддаг. Харин салхи сөрөн давхихад намирсан урт дэл талын морин цэргийн хар сүлд мэт харсан дайсны цөсийг чичрүүлэх омог сүртэй. Азарганы омголон зангаас эмээгээд сургаж, уургалан унахыг зориглох хүн гэж бараг үгүй. Талын монголд азарга үржил нийлүүлгийн болон унаган ижлээ хамгаалах гэсэн үндсэн хоёр үүрэгтэй. Азарганы гэр бүлийн хариуцлага өндөр, эрсдлийг өөр дээрээ дааж байдаг болохоор омголон догшин зантай байхаас ч яах билээ. Бух үржлийн ажлаа дуусгачихаад яваад өгдөг бол азаргыг монгол талын жинхэнэ сайн эртэй зүйрлэж болох юм.

Удалгүй азарганы ширүүн ноцолдоон эхлэлээ. Жил болгон монгол азарга өөрийн охин үр

төлөө сүргээс таслан хөөж өөртөө шинэ байдсан гүү хураахын төлөө ширүүн тэмцэл явуулдаг.

Тэр гурав чоно уясан шонгийн дэргэд суугаад азарганы ноцолдооныг амьсгаа даран харахад бэлтрэг ч мөн хажууд нь оцойчихоод цасанд хоригдсон өлөн чоно мэт дагжин чичирч, азарганы ноцолдооныг харж байлаа. Бэлтрэг омголон ширүүн азарганаас зөн совингоороо айх боловч тэдний ноцолдооныг анхааралтай ширтэнэ.

Таван зуу гаруй морьдтой энэ том сүрэгт арван хэдэн азарга байдгаас хамгийн эр чадалтай азарганд дал ная гаруй морьд байдаг бол сул дорой нэг нь арваадхан морьдыг өөртөө хураасан байдаг ажээ. Өөртөө хурааж чадсан гүү болон үр төлөөс нь гол төлөв нэг азарга адуу бүрддэг. Монгол адуу үржлийн тал дээр хүнээс илүү ухаалаг соёлтой. Адуун сүрэг ойр цусан төрлийн үржил хавьтлыг хатуу цээрлэдэг болохоор сүргийн чанар тэмцэх чадварыг сайжруулж, тэр хэрээр хатуу хахир тал нутагт чонон сүргийн дайралтаас өөрсдийгөө хамгаалах боломжийг эрс нэмэгдүүлдэг байна.

Зуны эхэн сард шүдлэн байдсын ороо орохын цагт азарга энэрэлт эцгийн нүүрийг буруулан өөрийн сүргээс үлдэн хөөж эхийнхээ дэргэд очихыг хатуу чанд хориглоно. Дэл сүүлээ намируулсан төрсөн эцэг нь хайртай охиноо чоно үзсэн юм шиг хазаж хайрч байдаг гээд бод доо. Байдаснууд хазагдан хөөгдөөд унгалдан бөөгнөрөлдөхөд ганц нэг нь эхийгээ бараадан очих боловч амсхийх завдал өгөлгүй агсран уурласан азарга давхин ирээд өшигчиж тангаран өчүүхэн ч нүүр өгөхгүй. Ижил сүргээсээ хөөгдөн гарсан байдаснууд эцгийн энэрлийг үүрсэн гуйх боловч азарга ууртай нүдээ дүрлийлгэн, хамраа тачигнуулж, эрчит дөрвөн туурайгаа цавчлах нь охиноосоо нүүр буруулсаныг илтгэнэ. Төрүүлсэн үр рүүгээ тэмүүлсэн гүү тэр даруй азарганы туурайн амтыг хүртдэг. Гэвч тэд азарганы цаад санааг ойлгож байгаа болохоор удаж төдөлгүй төвийг сахисан байр сууринд шилждэг билээ.

Азарганууд байдсан гүүнүүдийг өөрийн сүргээс хөөн гаргасны дараа цусан төрлийн холбоогүй азарганууд тэднийг өөрийн сүрэгт хураахын төлөөх эр бяр, авхаалж самбаа шалгасан хатуу ширүүн тэмцэл эхлэнэ дээ. Азарганууд хойд хоёр хөл дээрээ цоройн ноцолдоход адуун сүргээс цээж илүү өндөр цухуйн харагдана. Тэд өөрийн хүчирхэг зэвсэг болсон урд хоёр хөлөөрөө өрсөлдөгчөө цавчиж, түлхэн цохиход хүнд туурайнууд харшин тачигналдаж, бяр тэнхээ дутуу нэг нь барахгүй гэдгээ мэдээд зугатна. Эр чадал амтагдсан азарга түүний араас элдэн хөөдөг. Ирт туурайн хүч мохвол араа шүдээ ашиглах буюу өөрийн араатан чонын тархийг зад өшиглөх хүчтэй хойд туурайгаар тангарна. Энэ бүх ширүүн тулалдааны явцад аль нэг нь толгойгоо хагалж, цээж нь хавдаад хөл доголох боловч улайрсан азарганууд хэр барагтай бол бууж өгөх шинжгүй.

Нэгэн байдас унаган ижилдээ нийлэхэд уурссан эцэг нь түүнийг өөртөө хураахаар тэмцэлдэх өөр нэгэн азаргатай хамт араас нь ухасхийлээ. Азарганууд энэ тохиолдолд л анх удаа санаа нийлэн байдсыг байх ёстой газар руу нь хөөв.

Хоёр догшин азарга нэгэн согоо шиг чилгэр цагаан байдсыг булаацалдан ноцолдож эхлэлээ. Байдасны хольцгүй цасан цагаан үс, согоо хархан нүд, гувай чилгэр бие, марал буга шиг хөнгөн алхаа зэргийг харсан Ян Кө дуу алдаж “Үнэхээр сайхан амьтан байна даа. Би хэрвээ азарга байсан бол түүний төлөө амиа өгөхөөс ч буцахгүйсэн. Хайртай амрагаа булаан авах нь ураг гуйхаас илүү амттай байж таарна. Золиг гэж. Тал нутгийн адуун сүргийн үржлийн

тогтолцоог хүртэл чоно зааж өгсөн байх нь ээ. Чоно бол адуун сүргийн хамгийн том дайсан нь. Хэрвээ чоно гэж байдаггүйсэн бол азарга ингэтлээ агсран догширч, байдаснууд ширүүн булаалдааны бай болохгүй байж шүү дээ” гэв.

Хоёр азарга Ромын дугуй цэнгэлдэх доторх хоёр догшин арслан мэт дээр дороо орон ноцолдоно. Жан Зи Юань дороо хөлөө дэвслэн гараа үрээд “Энэ цагаан байдасны төлөө хоёр азарга хэдэн өдрийн турш тэмцэлдэж байгаа юм. Хүний хайр булаам энэ цагаан байдаст би “Цасан гүнж” гэдэг нэр өгсөн. Гүнж маань үнэхээр өрөвдөлтэй, өнөөдөр нэг нь сүрэгтээ хураагаад байж байтал маргааш нөгөө нь ирээд булаагаад явчихна. Хоёр азрага хүч тамираа бараад байтал магадгүй өөр нэг зальхай гуравдагч этгээд гарч ирээд аваад явчихвал бас л өөр айлын бэр боллоо гэсэн үг. Үнэндээ юуных нь гүнж байх вэ дээ, боол зардсанаас өөрцгүй. Азраганууд нааш цааш булаацалдсаар ийм сайхан өвсийг ч идэж чадалгүй турж эцсэнийг харав уу? Хэд хоногийн өмнө үүнээс ч үзэсгэлэнтэй байсан юм. Жил бүрийн хавар болдог энэхүү ширүүн тулалдаан болоход зарим байдас тэртэй тэргүй унаган ижилдээ буцаж болохгүй юм чинь гэж боддог юм болов уу, шулуухан хамгийн хүчтэй азарганы сүрэгт нийлэн асуудлыг бусдад болоод өөрт амар шийдчихдэг. Байдаснууд чононд бариулсан унага дааганы цусан шивэрт сэг зэмийг цөөнгүй үзсэн бол вохоор аль нэгэн сүрэгт харьяалагдан аав болон нөхрийн хамгаалал дор байхгүй бол чонын хоол болж мэдэхийг ойлголгүй яахав. Монгол морьдын омголон зан болоод азарганы дайчин зориг нь явж явж чоноос үүдэлтэй юм” гэлээ.

“Атар талын омголон азарганд ижил сүрэг рүү нь чоно халдах вий гэхээс өөр айх юм үгүй, ёстой л дээрх тэнгэр, дэргэдэх газартаа л захирагддаг амьтан билээ. Монголын адуун сүрэг дэхь зарим нэгэн агт морийг эс тооцвоос зэрлэг адуун сүргээс бараг ялгагдаад байх юм гэж үгүй. Би адууны зах бараадаад багагүй хугацаа өнгөрсөн боловч хүй нэгдлийн хүмүүс тэднийг анх яаж сургаж гаршуулаа бол гээд бодохоор ухаан санаанд багтдаггүй юм. Адууг агтлачихаар унаж эдлэхэд амар дөхөм болдгийг яаж олж мэдсэн юм болоо? Морь агтлах гэдэг тун амаргүй ухаан бөгөөд унагыг дааган насанд нь агталдаг. Түүнээс эрт засвал унага дийлэхгүй, жаахан оройтвол сайтар цэвэршдэггүй гэмтэй юм. Морийг агтлахдаа эхлээд хуухнагийг зүсэхэд олон нарийн судастай залгаа бүхий засаа цухуйн гарч ирдэг. Түүнийг хутгаар зүсвэл халдвар орох гэмтэй, гараар татчихаар өөр бусад эрхтнээ гэмтээчих гээд байдаг. Адуучид түүнийг гараар мушгин таслаад үзүүрийг нь зангидан халдвар орохоос сэргийлнэ. Хэрвээ жаахан халдвар авах юм бол унага үхдэг. Эр унагыг дааганд нь агталж, шүдлэнд нь сургадаг. Энэ нарийн арга ухааныг эртний хүмүүс анх яаж олж эзэмшсэн юм бол оо?” хэмээн Жан Зи Юанийг асуухад

Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч юу мэдэх билээ, толгой сэгсрэхэд Жан Зи Юань залгуулан өгүүлрүүн “Би энэ талаар нэлээд удаан бодсон л доо. Эртний хүмүүс магадгүй, чононд бариулж шархадсан зэрлэг адууны унагыг олж эдгэрүүлээд өсгөж том болгосон байх. Унага байхад нь ноолж номхруулах гэж оролдож байсан ч том болсон хойно нь унахыг зориглох хэн байх билээ. Дараа нь чононд бариулж шархадсан өөр нэгэн унагыг гаршуулж өсгөх зэргээр хэдэн ч үе өнгөрсөн юм бүү мэд. Тэгсээр нэгэн удаа чононд засаагаа хазуулсан эр унага тааралдаж түүнийг дааганд нь сургаад үзтэл уналгаа эдэлгээнд хурдан гаршсан ч юм бил үү? . . . Тэгээд л үүнээс санаа авсан байж таарна. Тэртэй тэргүй балар эртний хүмүүсийн зэрлэг адууг сургах үйл явц, дэндүү нарийн урт удаан явагдсан байж таарна. Энэ нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явц дахь том алхам болохоор хятадын эртний дөрвөн том нээлтээс ч эрт, түүнээс хавьгүй чухал ач холбогдолтой хэрэг болжээ. Эртний хүмүүсийг морьгүй байна гээд

төсөөлвөл орчин цагийн хүмүүс машин, галт тэрэг, танкгүй байгаагаас хэцүү байх тул нүүдэлчдийн хүн төрөлхтөнд оруулсан энэхүү хувь нэмрийг үнэхээр үнэлж барамгүй биш үү?” гэв.

Чэнь Жэнь их л догдлонгуй байдалтай түүний үгийг таслаад “Би чиний үзэл бодлыг зөвшөөрч байна. Тал нутгийн хүмүүс зэрлэг морийг гаршуулсан нь эртний тариачид зэрлэг тутаргыг тарималжуулснаас амаргүй байсан байж таарна. Адаглаад л зэрлэг тутарга гүйж, булгин, хүнийг өшигчиж тангараад алчихгүй шүү дээ. Нэг үгээр хэлбэл зэрлэг ургамлыг тарималжуулна гэдэг биед амар хөдөлмөр бол зэрлэг адууг сургаж гаршуулах хөлс цус асгаруулсан тулалдаан юм. Суурьшмал үндэстнүүд өнөө хэр нүүдэлчдийн энэхүү агуу их дайны ололтыг эдэлсээр байгаа биш үү?” гэхэд

Ян Кө түүний үгийг өлгөж аваад “Дайтаж чаддаг, ажиллаж сурч ч чаддаг нүүдэлчид гэдэг мөн лут улс юм аа. Нүүдэлчдийн соёл иргэншлийн хөгжлийн түвшин суурьшмал үндэстнүүдийг гүйцэхгүй боловч хэзээ нэгэн цагт тэдэнд хөгжих боломж олдвол зэрлэг адуунаас ч хурдан давхиж суурьшмал үндэстнүүдийг гүйцэж чадна. Хубилай, Энхамгалан, Тэнгэр тэтгэсэн зэрэг хаадууд олонх хятад хаадуудаас илүү хурдан хятадын соёлыг сурч эзэмшээд тэднээс хавьгүй их зүйлийг бүтээн, түүхэн гавьяа байгуулж чаджээ. Харамсалтай нь тэд эртний хятадын соёлоос суралцсан бөгөөд түүний оронд эртний Герег, Ром юм уу, эсвэл орчин үеийн өрнөдийн соёлоос суралцаж чадсан бол үзүүлээд өгөхгүй юу” гэлээ.

“Үнэндээ орчин цагийн дэлхий ертөнц дээрх дэвшилтэт үндэстнүүд бүгдээрээ нүүдэлчдийн удам хойчис шүү дээ. Тэд өнөө хэр сүүгээ ууж, бяслаг болон шарсан үхрийн махаа зооглон, зүлгээ арчилж, нохойгоо тэжээгээд, бухтай тулалдан, морьдоо уралдуулж, биеийн тамираар хичээллэн, эрх чөлөө, ардчилсан сонгууль, эмэгтэйчүүдийг хүндлэх зэрэг эрт балрын нүүдэлчдээс өвлөгдөн ирсэн зан заншлаа хадгалсан хэвээрээ байгаа. Нүүдэлчдийн урагш тэмцэх хатуу тууштай зан чанаруудыг тэд өвлөн аваад зогсоогүй, харин ч бадраан дэгжээж чадсан юм. Хүн болох багаасаа, хөлөг болох унаганаасаа гэдэг үг үндэстэнд ч мөн хамаарах юм шүү. Балар эртний нүүдэлчид өрнөдийнхний хүүхэд нас байжээ. Тэгвэл бид эртний нүүдэлчидтэй хамт байгаа нь өрнөдийн хүүхэд ахуй насыг харж, энэ талын хичээлийг нөхөж үзснээс өөрцгүй. Тэгснээр өрнөдийнхөн яагаад оройхон гараад ширүүхэн дайрсаны учрыг олж цөхөх юм үгүй. Өрнөдийн дэвшилтэт техникийг сурахад төдийлөн хэцүү биш ээ, манай хятад ч өөрийн хиймэл дагуулыг хөөргөчихөө биз дээ? Харин өрнөдийнхний цусанд шингэсэн дайчин давшингуй, эрсдлийг зоригтой сөрж чадах үзэл санаа болон зан чанарыг л сурахад хамгаас амаргүй юм. Хятад үндэстний иргэний зан чанарт нэгэн томоохон асуудал байгаа болохыг Лү Сюнь26 аль эрт олж хараа биз дээ? . . . .” гээд Чэнь Жэнь санаа алдав.

“Би адуучин болсноос хойш монгол хятад хоёр үндэстний зан чанарын ялгааг хамгаас илүүтэй ихээр мэдрэх болсон юм. Би чинь сургуульд байхдаа юм юмны л зах зухтай гэгддэг байсан чинь тал нутагт ирээд муур шиг нялцгай амьтан байснаа мэдсэн шүү. Би амьхандаа л өөрийгөө хатуужууль хэмээн бодсон боловч бидэнд төрөлхөөс дутуу дулим нэг зүйл байгааг хожим олж мэдсэн юм даа. . . .” хэмээн Жан Зи Юань өгүүллээ.

Чэнь Жэнь санаа алдаад “Үнэхээр төрөлхөөс дутуу дулим гэдэг чинь зөв шүү. Хятадын жижиг тариачны аж ахуй нь өрсөлдөөнөөс эмээдэг аядуу хөдөлмөр юм л даа. Күнзийн суртхаал нь хаан эзэн сайд түшмэд, эцэг үрийн салшгүй хэлхээг номлож, харц ард нь эзэн

дээдэстээ, ядуу буурай нь баян чинээлэгтээ үг дуугүй захирагдаж, дарангуй хүчирхийллээр өрсөлдөөнийг нухчин дарснаар хаан эзний эрх сүр болон газар тариалангийн аядуу зөөлөн байдлыг хамгаалсаар ирсэн. Хятадын жижиг тариачны аж ахуй, Күнзийн соёл нь оршин тогтнох, ухамсар гэдэг хоёр талаас хятад үндэстний зан чанарыг доройтуулсан юм. Хятад үндэстэн хэдийгээр эртний гялалзсан соёл иргэншлийг бүтээн буй болгож чадсан боловч түүнийхээ өр төлөөсөнд үндэстний зан чанараа гаргуунд гарган, хөгжих эрч хүчээ алджээ. Дэлхийн түүх газар тариалангийн соёл иргэншлийн бүдүүлэг үе шатыг даван гарах үед хятад улс хоцрогдож гүйцээд бусдын алганы амтыг үзэх тавилантай болсон юм. Гэвч бидний хэдэн азтай нөхдүүд монгол талын балар эртний нүүдлийн амьдралын сүүлнээс атган үлдсэнээр өрнөдийн хүчээ аван хөгжсөний нууц түлхүүрийг атгаж авсан байхыг хэн байг гэх билээ?” гэлээ.

Нугын дээр эртний дайнч морьд салахгүй зууралдан тулалдсаар л. Ийнхүү удтал тулалдсаны эцэст үзэсгэлэнт “Цасан гүнж” маань ялсан талын азарганы сүрэгт хураагдан очжээ. Ялагдсан тал тахимаа өгөлгүй уурсан давхиж ирээд байдсыг хэдэнтээ тангаран газар унагахад хөөрхий цасан гүнж хэнээс аврал эрэхээ мэдэлгүй газарт хэвтсэн чигээр уртаар унгалдан янцгаав. Цасан гүнжийн эх гүү түүнд туслах санаатай ухасхийсэн боловч догшин шулам мэт ууртай азарга нь хэд өшиглөөд сүрэгт эргүүлэн нийлүүллээ.

Тэр бүхнийг харсаар нүд нь халтирсан Ян Кө Жан Зи Юаньд хандан “Танай адуучид энэ бүхнийг зохицуулахгүй юугаа хийж байдаг байна вэ?” гэхэд

Жан Зи Юань түүний хариуд “Чи яаж зохицуулах гээ вэ? Хүн очиход ноцолдохоо болих боловч яваад өгөнгүүт чинь эргээд л тулалдаад эхлэнэ шүү дээ. Тэгээд ч хэдэн мянга, түмэн жил үргэлжилсэн адуун сүргийн оршин тогтнохын төлөөх энэхүү тулалдааныг хэнбугай ч байсан зогсоож чадахгүй. Бүх л зуны туршид азарганууд байдаснуудыг сүргээс хөөж гаргаад, цусан төрлийн холбоогүй байдаснуудыг сүрэгтээ хурааж гүйцэхээс нааш энэ эцэс төгсгөлгүй тулалдаан зогсоно гэж үгүй. Зун намрын зааг гэхэд хамгийн хүчирхэг догшин азарга өөртөө хамгийн олон байдсан гүүг хурааж, хүч чадлаар сул дорой азарга бусдын гологдмол байдсыг л сүрэгтээ нэгтгэж чаддаг юм. Тэр ч байтугай ганц байдсыг өөртөө хурааж чадаагүй золгүй азарга хүртэл байдаг юм шүү. Зуны турш явагдах энэхүү хатуу ширүүн тулалдааны явцад хамгийн эрэлхэг азарга тодрон гараад хурд хүч сайтай, ааш араншин агсам ширүүн атлаа ухаалаг үр төлөө үлдээх боломжтой болно. Сайн морьд ийнхүү зөвхөн өрсөлдөөн тулалдааны явцад төрөн гардаг төдийгүй энэхүү тулалдаанаар азарганууд зориг зүрх, дайтах чадвараа хурцлан ижил олон сүргийнхээ омог сүрийг нэмж чаддаг байна. Энэ нь азаргануудын хувьд чонон сүрэгтэй тулалдан ижил сүргээ тэднээс хамгаалах чадвараа сургуулилж байгаа хэрэг юм. Хэрвээ морьд жилдээ нэг удаа ийнхүү байлдааны сургууль хийдэггүй байсан сан бол монгол морьд тал нутагтаа оршин тогтнох аргагүй байсан билээ” гэв.

“Хурдан давхилт хуйлран дайрахаараа дэлхий дахиныг чичрээсэн монгол морьдыг бас л чоно хүмүүжүүлэн гаргасан байх нь ээ” хэмээн Чэнь Жэньг хэлэхэд

Жан Зи Юань “Тэгэлгүй яахав. Талын чоно монгол баатрууд төдийгүй монголын байлдааны морьдыг ч хүмүүжүүлэн гаргасан. Эрт дээр цагт хятадын олон үеийн төр морьт цэргийн асар том армитай байсан боловч тэднийг морины жүчээнд тэжээдэг байжээ. Бид хөдөө тосгонд ч цөлөгдөн ажиллаж байсан улс тосгоныхон яаж морь тэжээдгийг мэдэхгүй хаачихав. Морьдоо

жүчээнд хийчихээд өдөр шөнөгүй тэжээж услана. Дотор газрын морьд чоно үзэх нь байтугай хоорондоо ч ноцолддоггүй. Нийлүүлэг нь ч гэсэн үхэн хатсан тэмцлийн дор явагдахгүй, гүүгээ шонгоос уячихаж байгаад азаргаа хөтлөн ирээд нийлүүлчихэд л болох нь тэр. Түүний эцэст ямар унага гарахыг хэн ч мэдэхгүй. Тийм морьдын унага хувийн ааш араншин болоод тэмцэх чадвартай байж чадахгүй” гэлээ.

Ян Кө инээд алдаад “Бүгд хүний зохион байгуулалтаар явагдаж байгаа юм чинь яаж ухаантай унага төрөх билээ? Ашгүй бид гурав тиймэрхүү маягаар төрчихөөгүй нь яамай даа. Одоо хэр нь хөдөө тосгонд тиймэрхүү маягийн гэрлэлт байсаар байгаа шүү дээ. Харин тосгоны эмэгтэйчүүд ажлын морийг бодох юм бол бас ч гэж нөхөршүү юм нь ямархуу хүн байгааг эрхбиш мэддэг байх аа” гэв.

“Наадахь чинь хятадын хувьд бас ч гэж дэвшил шүү” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

“Дотор газрын ажлын морьд өдөр нь ажиллаад, шөнө унтдаг нь тариачдын ажил амралтын хэвшлээс огт ялгагдах юмгүй. Тийм болохоор хятадын хөдөлмөрч тариачин, хөдөлмөрч морь хоёр монгол талын баатар эрс болон байлдааны морьдыг ялахгүй байх нь аргагүй шүү дээ” хэмээн Жан Зи Юань хэллээ.

Ян Кө санаа алдаад “Тэнэг морьтой улс байлдааны талбарт яаж ялах билээ? Тэнэг морьд буй болж байгаагийн шалтгаан нь тэнэг хүндээ л байж таарна. Мунхаг цэрэг тэнэг морио уначихаад шөнө дунд гүн хөвийг чиглэх гэдэг л болох байх даа” 27гэхэд

Гурвуул гашуунаар инээцгээв.

Жан Зи Юань цааш нь “Дайчин зан чанар гэдэг аядуу хөдөлмөрч зан араншингаас хавьгүй чухал юм аа. Дэлхий дээр хөдөлмөр шингээлт хамгийн ихтэй байгууламж болох цагаан хэрэм дэлхийн хамгийн цөөн хүн амтай жижиг үндэстний морин цэргийг дийлэхгүй л байсан шүү дээ. Хөдөлмөрлөхөөс өөр байлдаж чадахгүй байгаад ямар хэрэг байх билээ. Тэдгээр агт морьд шиг бусдын гарын аясаар унаж эдлүүлээд, чонотой тулгарсан цагт азарга шиг өшиглөж тангаран, хазаж хайрч чадахгүй толгой хаялан зугатна биз дээ. Адуу хариулаад чамгүй урт хугацаа өнгөрөхөд адуун сүрэгт азарганаас дутахааргүй нуруу туруу, бие бялдар, араа шүд, дөрвөн туурайтай агт морьд ч бас байдаг юм аа. Хэрвээ тэд азаргатай адил чонотой тулалдах юм бол тэднийг хавьтуулахгүй байх бүрэн боломжтой. Гэвч тэд нар яахаараа чонын барааг харангуут бажгадан зугатдаг вэ гэхээр тэдний бахдам эр зоригийг хамт агталчихаж л дээ” гэлээ.

Ян Кө түүний үгийг их л дэмжсэн байдалтай “Цагаан хэрэм барина гэдэг үхширмэл хөдөлмөр бол эднийхний морин цэргүүд хэдэн зуу, мянган километр тойрон явж чадах амьд тулалдаан хийх юм л даа. Нэг удаа монголын морин цэргүүд цавчаал боомтыг дайраад бүтэхгүй болохоор нь өмнө тийш ямар ч бэлтгэлгүй байсан Зы Жин Гуань боомт руу дайран ороод Бээжин хотыг өмнө талаас нь дайран эзлэж байсан түүхтэй юм” гэв.

“Бид урьд нь хөдөлмөрийг хэт дээдлэх боловсролыг олж авчээ. Хөдөлмөр хүнийг төдийгүй, бүхнийг буй болгосон гээд л байдаг. Ажилч хичээнгүй хятадын ард түмэн ч гэсэн энэ ёсондоо хэт авгчихсан. Үнэндээ гагц хөдөлмөрт тулгуурлаад хүнийг буй болгосон гэдэг чинь

худал үг. Хэрвээ бич тэмцэх чадваргүй, гагцхүү хөдөлмөрлөөд л байх юм бол зэрлэг араатны идэш болохоос биш яахин бүхнийг бүтээн буй болгож чадах билээ. Бичин хүний нээсэн чулуун сүх хөдөлмөрийн багаж уу, байлдааны зэвсэг бил үү? Эсвэл аль аль нь мөн юм уу?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

“Юуны өмнө зэвсэг мөн. Гэхдээ түүгээр бас хушга хагалж идэж болно л доо” хэмээн Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь инээд алдаад “Хөдөлмөр бол яахын аргагүй эрхэм дээд, нэр төрийн хэрэг мөн л дөө. Ажилч хичээнгүй зан чанар нь хятад үндэстний нэгэн давуу тал, ирээдүйн сэргэн мандлын том капитал ч мөн. Гэвч хөдөлмөр хэмээгч бүхнийг чадагч, гэм хоргүй зүйл ч бас биш. Хөдөлмөр дотроо боолын хөдөлмөр, боолчилсон хөдөлмөр, дарангуйллын маягтай хөдөлмөр, засан хүмүүжүүлэх хөдөлмөр, үхэр морины хөдөлмөр ч гэж байна. Ийм хөдөлмөр ариун дээд агаад нэр төрийн хэрэг мөн гэж үү? Үүнийг магтан дуулах хэрэгтэй бил үү? Боолын эзэд, феодал язгууртнууд л ийм хөдөлмөрийг магтан дуулах байх даа. Өөрөө хуруу гараа хөдөлгөдөггүй атлаа бусдын хөдөлмөрийг мөлждөг хүн ч гэсэн бусдаас чанга хөдөлмөрийг магтан дуулах нь байдаг юм шүү” гэхэд

Ян Кө их л ууртайгаар “Би тийм хүнийг үнэн голоос үзэн яддаг. Тийм амьтдыг чулуун сүхээр тонилгож байвал таарах юм” гэлээ.

Чэнь Жэнь бодлогоширонгүй байдалтай “Түүний дотор бас үр ашиггүй, эвдэн бусниулсан, хорлон сүйтгэх шинж чанартай хөдөлмөр ч гэж байна. Хоёр мянган жилийн өмнө А Фаний ордонг байгуулахын тулд Сычуань мужийн бүхий л ой модыг сүйтгэсэн байх жишээтэй. Ямар сайндаа “Сычуаний ой сүйрлээ, Афаний ордон бослоо” гэж дуулж байх вэ дээ. Дэлхийн олон сууршмал соёл иргэншилт үндэстнүүд атар газрыг хагалах гэж хөдөлмөрлөсөөр тэр бүхний уршгаар үүссэн цөл нь тухайн үндэстэн болоод соёл иргэншлийг үгүй хийж байсан түүх цөөнгүй. Түүнчлэн дэлхий дээр олон чухал зүйлийг хөдөлмөр буй болгож чадахгүй. Тухайлбал: Энх тайван, аюулгүй байдал, бат бэх батлан хамгаалалт, эрх чөлөө, ардчилал, тэгш эрх болон түүний тогтолцоо зэргийг хөдөлмөр буй болгож чадахгүй. Тэр тусмаа эрх чөлөө, ардчилал, тэгш эрхийг хүчтэй шаардан хэрэгжүүлж чадах үндэстний зан чанарыг хөдөлмөр буй болгож чаддаггүй юм. Хөдөлмөрлөхөөс бус тэмцэж чадахгүй үндэстэн гэдэг барлаг, энгийн номхон иргэн, ажлын мал төдийхөн гэсэн үг. Эрх чөлөө, ардчилал, тэгш эрх гэдэг тэдний тэмцлийн уриа дуудлага болж чадахгүй. Дэлхий дээр хамгийн олон хүн амтай, ажилч хичээнгүй, түүхийн турш хамгийн урт удаан хугацаанд ажиллаж хөдөлмөрлөсөөр ирсэн хятадын ард түмэн ажил хөдөлмөрийн түүх хамгийн богинотой өрнөдийн үндэстнүүд шиг дэвшингүй хөгжилтэй соёл иргэншлийг бүтээн буй болгож чадаагүй л байна шүү дээ. . . ” хэмээн хэлэв.

Азарганы ноцолдоон түр завсарлаад бор гэдсээ борлуулахаар явгаалаа. Байдаснууд энэ сиймхийгээр эхийнхээ дэргэд гүйн очиход том гүүнүүд тэднийг их л сэтгэл шимшрэнгүй хошуугаараа шөргөөлөө. Гэвч эцэг нь тэднийг ууртай нүдээр ширвэж, хамраа тачигнуулахад айсан байдаснууд өөрийн шинэ сүргийн зүг довтолгон хүрээд хоёр талаас эхтэйгээ гунигтай харцыг солилцоно.

“Би үүнээс хойш адуун сүргийн дундаас их зүйл сурч болохыг ойлголоо. Эрт дээр цагт



дэлхий дахиныг донсолгож байсан монголын морьт цэргүүд бүгдээрээ адуун сүрэг хэмээх их сургуулийн төгсөгчид байж шүү” хэмээн Ян Кө үнэн сэтгэлийн угаас өгүүллээ.

\* \* \*

Гао Зянь Жун үхэр тэргэндээ суучихаад их л баяр хөөртэйгөөр эргэн ирэв. Тэр дуу шуутайгаар “Цөмөөрөө баяжсаан. Би өнөөдөр хувингийн талаар шахам зэрлэг нугасны өндөг оллоо” хэмээн хашгирав. Нөгөө гурав нь ч тосож очоод хүнд модон хувинг тосож авахад дотор нь дал наяд зууван дугуй өндөгнүүд хийжээ. Тэдний зарим нь хагарч, ан цав гараад алтан шаргал уургаа савируулжээ.

“Чи ч сүрэг нугасыг нэг дор үгүй хийчихдэг хүн юм аа” хэмээн Ян Кө дуу алдав.

Гао Зянь Жун түүний хариуд “Ван Зюнь Ли тэд нар ч гэсэн уралдаж түүцгээгээд байна лээ дэг. Нуурын баруун өмнө тал болон голын элсэн тангийн тэрүүгээр арван хэд алхаад л зэрлэг нугасны өндөг зулаастай байна. Нэг үүрэнд гэхэд арван хэдээрээ байна лээ. Түрүүлж очсон зарим нь хэдэн хувинг түүчихээд байхад би юу боллоо гэж хоцрох вэ? Адуу ус уухаар очихдоо тэр өндөгнүүдийг няц гишгэлээд нүд халтирмаар болсон байдаг шүү” гэв.

“Өөр үлдсэн бол цугаараа очиж түүгээд идэж бараагүйг нь давслаад орхичихье” хэмээн Чэнь Жэньг хэлэхэд

“Саяын түүсэн газар ч байхгүй байх аа. Дөрвөн сүрэг адуу яваад өнгөрөхөөр юу болох билээ. Харин нуурын зүүн эргээр бол байж мэдэх л юм” гэж Гао Зянь Жун өгүүлэв..

Ян Кө Жан Зи Юань руу харан хашгичиж “Адуучид та нар сохор юм шиг юугаа харж байдаг юм бэ?” гэв.

“Голын эргээр нугасны өндөг байх юм гэж хэн санах билээ дээ?” хэмээн Жан Зи Юань хариулав.

Гао Зянь Жун гэрээс холгүй бэлчих адуун сүргийг хараад Жан Зи Юаньд хандан “Адуугаа гэрийн үүдэнд шахам бэлчээж яахин болох билээ. Энэ хавийн өвсийг идээд барчихвал манай үхэр яах болж байна вэ? Хурдан адуугаа тууж холдуулчихаад нугасны өндөг ирж ид” гэлээ.

“Наадахь чинь саяхан сургасан ардаг догшин эмнэг уначихаад бууж суухад амаргүй байж таарна. Тэгээд ч сая бид хоёрт баахан хичээл заасан болохоор шагналгүй горьгүй” гэснээ Чэнь Жэнь Жан Зи Юаньд хандан “Явалгүй азнаж бай. Бид гурав ийм их өндгийг идэж барахгүй” гэлээ.

Гао Зянь Жун хэлрүүн: “Наашаа ирцгээ дээ. Цөмөөрөө хагарсан бүтэн өндөгнүүдийг ялгаадахья. Би хоёр ч жил хайрсан өндөг идсэнгүй. Энэ удаа цөмөөрөө шавайгаа ханатал идэцгээе. Манай гэрт багагүй зэрлэг сонгино байгаа болохоор түүнийг хайрсан өндөгтэй холивол жинхэнэ хангайн хишиг болох биш үү? Ян Кө сонгино арилгаж, Чэнь Жэнь өндөг хагалаад Жан Зи Юань арагтай хуурай аргал оруулж ир. Би өөрөө ахлах тогооч хийнэ” гэлээ.

Хагархай болон бүтэн өндөг бараг тэнцүү байсан тул хүн болгон долоо найман хагарсан өндөг хайрч идээд ганц шавай ханах шиг болжээ. Удаж төдөлгүй зэрлэг сонгино, өөхөн тос, нугасны өндөгний холилдсон үнэр монгол гэрээс ханхалж, талын салхийг хөлөглөн одвой. Ноход үүд бараадан сүүл шарвагануулахад бэлтрэг төмөр гинжээ хажигнуулан, шүдээ ярзайлгаад үсчин цовхорно. Чэнь Жэнь өөхөн тосонд хайрсан нугасны өндгийг бэлтрэг идэх нь үү, үгүй юу гэдгийг үзмээр санагдлаа.

Тэр дөрөв амаа олохгүй идэцгээж байтал гэнэт гэрийн гадаа Галсмаагийн дуу цангинаж “Ийм амттай юм идэцгээж байгаа мөртлөө намайг дууддаггүй байна шүү” хэмээн хашгирав. Тэр Баярыг дагуулан нохдыг ярж зайлуулсаар орж ирлээ. Чэнь Жэнь, Ян Кө хоёр тэдэнд хоймор эсгий олбог дэвсэж өгөөд хайрсан өндөг аягалангаа “Малчид иймэрхүү зүйл идэхгүй болов уу гэж бодсон юм. Та нар амсаад үз л дээ” гэлээ.

“Хол саахалтын зайнаас хүртэл үнэртээд хорхой хүргээд болдоггүй. Манай нохой шүлсээ гоожуулаад дагаад ирсэнийг харж байна уу? Идэж чадалгүй яахав. Иднэ шүү харин ч” гэж Галсмаа хэлчихээд савх аван ам руугаа хийж үзсэнээ “Тун амттай байна” гэлээ. Баяр бэлтрэг адил бүр ч шунамгай үмхэлнэ. Аяган дахиа бараагүй мөртлөө дуусчих вий гэсэн шиг тогоо руу өнгөлзөнө. Талын малчид өглөөгүүр цагаан идээ, мах цайгаар хооллоод орой л нэг юм шөл устай хоол идэхээс биш, өдрийн хоол гэж иддэггүй билээ. Тийм болохоор ээж хүү хоёр лав их өлссөн бололтой. “Ийм амттай хоолыг гуанзанд л идэж байсан санагдана. Одоо хот орно гэлтгүй энд сайн идээд авдаг хэрэг ээ” хэмээн Галсмаа хэлэв.

Олонбулгийн талын малчид хятад хоолтой таарах болгондоо гуанздах гэж ярина. Гуанздах ч дуртай гэж жигтэйхэн. Сүүлийн үед малчдын хоол хүнсэнд дотор газрын амтлагч ногоонууд нэвтрээд амтат чинжүү, жан, бөөрөнхий сонгино идэх дуртай болсон. Зарим малчид лаажуу ч идэхээс буцахгүй. Харин малчид цуу, сармис, цагаан гаанд дургүй, даалиуг бол эвгүй үнэртэй гээд амандаа ч ойртуулахгүй.

“Бид нар тэгвэл та нарыг байнга л “Гуанздуулж” байхаас даа” гэж Чэнь Жэнь яаран өгүүлэв.

Гао Зянь Жун ч Галсмаагийн тавьсан ааруул өрмөнд их дуртайгаас гадна, тэдний хоолыг буудаж, сүүтэй цайнд чанасан мах хөшиглөж идэх дуртай нэгэн. Галсмаагийн гарын монгол хоолонд орж гүйцсэн тэрээр энэ удаа аяганы хариуг барих боломжтой болжээ. Мань хүн малийтал инээд алдаад “Манайд хувин дүүрэн өндөг байгаа болохоор та хоёрыг цатгаад явуулж бололгүй яахав” гэснээ тав зургаан шинэ өндөг хагалан тэр хоёрт шарж өгөв.

“Аав ийм юманд ойртохыг ч зөвшөөрдөггүй болохоор би танайд л ирж идэж байя” хэмээн Галсмаа хэллээ.

“Өнгөрсөн жил аав аж ахуйн нэг даргынхаас арван хэдэн өндөг захиулан авчруулж байсан. Тэр ямар учиртай юм бэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Галсмаа өгүүлрүүн “Нэг морь хийтэй өвчин олсоныг аав хамрыг нь чимхэж мэдсэн юм. Тэгээд толгойг нь өргөж байгаад шүдэнд нь өндөг хагалан хэдэн удаа цутгаад л зүгээр болгож орхисон” гэв.

“Бидний нөлөөгөөр малчид иймэрхүү зүйл идээд сурчихвал хэдхэн жилийн дараа энд хун байтугай нугас ч үзэгдэхээ байх юм байна даа” гэж Ян Кө Жан Зи Юаньд хандан шивэгнэн хэлэв.

Баяр амаараа тос савируулан шүлэнгэтэн идэх зуур Гао Зянь Жунд хандан “Би иймэрхүү зүйл хаана байдгийг мэдэх болохоор маргааш хамт очиж түүцгээе. Харин надад дахин ийм хоол хийж өгөөрэй. Болдог толгойн тарваганы хуучин үүрэнд байж л таарна. Би хургаа хайхаар явж байхдаа голын хөвөөнд ч зөндөө байхыг үзсэн” гэлээ.

Гао Зянь Жун ч их л баяртайгаар “Яасан сайн хэрэг вэ? Голын хөвөөний болдог толгойн хаягдсан нүхийг адуу гишгээгүй байж таарна” хэмээн өндгөө хайрангаа Чэнь Жэньгээр бас хэдийг хагалууллаа. Бас нэгэн тосоо савируулсан том хайрсан өндөг тогооноос гарахад Гао Зянь Жун түүнийг хоёр хуваагаад ээж хүү хоёрын аяганд нэг нэгээр нь хийж өгөхөд цаадуул нь хөлсөө цувируулан идэцгээв. Тостой тогооноос хиншүү ханхлан өөр нэгэн хагалсан өндөг шархийн доош уналаа.

\* \* \*

Хайрсан өндгийг гаргасны дараа Чэнь Жэнь хусуурыг тосон аваад “Би та нарт өөр нэг юм үзүүлье” гэхчээд тогоонд өөхөн тос хийж нүдлэсэн өндөг шарж эхлэлээ. Удаж төдөлгүй тэрээр тогооноос шар цагаан нь ялгарсан хоёр нүдэлсэн өндөг гаргаж ирэв. Галсмаа хүүтэйгээ зуухны хажууд сөхрөн суугаад тэр бүхнийг бүлтийтэл ширтэн суулаа. Чэнь Жэнь тэдэнд нэг нэгээр нь жантай хутган өгөв.

Галсмаа амтархан идэнгээ “Энэ чинь бүр ч илүү амттай юм байна гээч. Чи бид хоёрт дахин нэжгээдийг хийгээд өгөөч” гэхэд Ян Кө инээд алдан “Би удахгүй та хоёрт жууцайтай шарсан өндөг гэдэг хуурга хийгээд өгнө өө. Тэгж байтал Жан Зи Юань өөрийн нугасны өндөг сонгинотой шөлөө хийж өгөх байлгүй. Бид дөрөв та хоёрт өөрсдийн гараа гаргалгүй яахав” гэлээ.

Монгол гэрт хиншүү хярвас, ногооны анхилуун үнэр дүүрч, тэр зургаа амаараа гартал идээд сая аяга савхаа хойш тавьлаа. Энэхүү найрын эцэст хувин дүүрэн нугасны өндөгний дийлэнхийг “нугаслажээ”.

Шинэ нутагт нүүж ирээд байгаа болохоор гадна дотнох ажил дийлдэх юм биш явалгүй горьгүй гэж Галсмаа хэхэрснээ инээд алдан “Харин энэ тухайгаа аавд дуулгаж болохгүй шүү. Хэд хоногоос та бүхэн манайд очиж хуурсан будаатай өрөм идээрэй л дээ” гэв.

Гао Зянь Жун Баярт хандан “Маргааш хамтдаа явж нугасны өндөг түүнэ шүү” гэлээ.

Чэнь Жэнь Барсыг гүйцэн очоод аманд нь том хайрсан өндөг чихэхэд цаадахь нь газар хаян шиншлэж байснаа эзнийх нь саяхан идэж байсан амттан мөн болохыг таньж баяртайгаар амандаа хийгээд амтархан зажлангаа сүүлээ шарвагануулан талархахаа ч мартсангүй.

Хүмүүс тарсаны дараа Чэнь Жэнь бэлтрэгээ санаж түүн рүү гүйн очлоо.

Гүйж очоод хартал бэлтрэг нь алга. Чэнь Жэньгийн хар хөлс чийхраад сайтар хайваас цаадахь нь өвсөн дунд наалдан хэвтсэн тул харагдаагүй ажээ. Хоёр танихгүй хүн баахан нохой дагуулаад ирэхээр айсандаа ийнхүү нуугдсан байж таарна. Бэлтрэг төрөлхийн далдлах, нуугдах чадвараа гээгээгүйг үзээд Чэнь Жэнь уужим амьсгаа авав. Бэлтрэг танихгүй хүмүүс, нохдын холдон явахыг хараад огло үсрэн босож Чэнь Жэньгийн бие дэх шарсан хайрсан өндөгний үнэрийг шиншилж, тостой гарыг долоов.

Чэнь Жэнь дотогш орон Гао Зянь Жунгаас зургаа долоон хагархай өндөг авч хайрах тосны хэмжээг нэмээд бэлтрэг болон гөлөгнүүдэд өндөг хайрч гарлаа. Хэдийгээр цаадуулыгаа цатгаж чадахгүй боловч амсуулья гэж бодсон ажээ. Талын ноход зарим үед жижиг сажиг идээ боовонд махнаас ч илүү дуртай байдаг тул түүгээр тэжээх нь нохдоо эрхлүүлэх нэг төрлийн арга юм. Чэнь Жэнь хайрсан өндгөө дөрвөн том, гурван жижиг хэсэг болгон хуваав. Дөрвөн томыг гурван том нохой болон бэлтрэгэнд, гурван жижгийг гөлөгнүүдэд өгөх гэсэн юм. Ноход үүдэн дээр чихэлдэх тул Чэнь Жэнь бэлтрэгний хувийг хойш тавьчихаад галын сэтгүүрээр тэдний духыг зөөлөн тоншиж дайраад байлгүй дугаарлан зогсохыг анхааруулав. Тэр хамгийн том нэг хэсгийг авч Арсланд өгөхөд цаадахь нь түүнийг зуучихаад сүүлээ овоо шарвагануулах янзтай ажээ.

Ноход ч санаа нь амарсан байдалтай зүлэг рүү тоглохоор явахад Чэнь Жэнь хөргөсөн өндгөө аваад идүүрт хийн бэлтрэг рүү очлоо. Энэ нь талын чонын хувьд хүртэж үзээгүй хоол болохоор Ян Кө, Жан Зи Юань, Гао Зянь Жун нар ч бэлтрэг идэх эсэхийг үзэхээр иржээ. Чэнь Жэнь өндөр дуугаар “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн дуудлаа. Идүүрийг түүний өмнө тавингуут бэлтрэг хурга шүүрэх өлөн чоно мэт ухасхийн өөхөн тос савируулсан хайрсан өндгийг хавхийтэл үмхээд гүдхийтэл залгиж орхилоо.

Мань дөрөв ч их гонсгор хоцорцгоов. Жан Зи Юань их л урамгүй байдалтай “Чоно ч мөн өрөвдөлтэй амьтан юм даа. Аливаа зүйлийг гэдэс рүүгээ хийхийг л жаргал гэж боддог бололтой. Түүний үгсийн санд “амтлах” гэсэн ойлголт байхгүй юм байна” гэлээ.

“Тийм сайхан өндгийг шал дэмий үрчихлээ дээ” хэмээн Гао Зянь Жун ч халаглангуй өгүүлэв.

“Чонын хүүхэн хэл ходоодондоо байдаг ч юм бил үү хэн мэдлээ” хэмээн Чэнь Жэнь жаахан хошигнон хэлэхэд цаад гурав нь нирхийтэл инээлджээ.

Чэнь Жэнь гэртээ ороод юм хумаа янзлахад нөгөө гурав нь дор бүрдээ мал сүргийнхээ хойноос явцгаав. Чэнь Жэнь Жан Зи Юаньд хандан “Би морийг чинь чихдэж байгаад мордуулах уу?” гэхэд

“Хэрэггүй дээ. Эмнэг бас ч гэж ухаантай шүү. Намайг одоо сүрэг рүү буцах гэж байгааг мэдэх болохоор номхорчихсон байгаа” хэмээн Жан Зи Юань хэллээ.

“Чи ийм жижиг адуу уначихаад яаж морио юүлэх юм бэ?” гэж Чэнь Жэнь асуулаа.

“Адуучид болгон нэг хоёр номхон морьтой байдаг болохоор нэрээр нь дуудах буюу хондлой дээр нь уурганы бөгсөөр шүргэхийн төдийд зогсчихдог юм. Заавал хөөж уургалах гэхийн хэрэггүй. Хэрвээ тийм морь байдаггүйсэн бол адуучин хүн ороо хангал морины нуруун

дээрээс шидэгдчихвэл хээр явгараад үлдэх байлгүй. Тэр тусмаа аглаг ууланд өвлийн хүйтэнд хөлдөж үхэж ч мэднэ” гэлээ.

Жан Зи Юань солих угаасан хувцсаа Чэнь Жэньгээс авсан Жек Лондонгийн “Далайн чоно” номтой хамт бариад гэрээс гарлаа.

Тэр мориндоо сэвхийн мордож, адуун дундаасаа морио юүлж аваад агтаа туусаар баруун өмнө орших их уулсыг чиглэн оджээ.

## Хорин нэг

*Тоба Тао 429 онд зүүн говийн Рү Рү Монгол аймгуудын халдлагад хариу цохилт өгөхөөр шийдсэн үед түүний зарим мэргэн зөвлөх нар сэрэмжлүүлэн айлтгаруун “Өмнөд төрийн хаант улсын хятад хүмүүн тохиолыг завишин манай цэргийг хавчин цохих болуузай хэмээсэнд тэр хятад хүмүүн болвоос явган цэрэг, бид болвоос морьтон болой. Унага тугал хэрхэн чоно шарнууд 28 лугаа эсэргүүцэлдмүй хэмээн дөхөмхөн хариулжээ.*

*Рене Гроссе “Тал нутгийн эзэнт гүрэн”*

Чэнь Жэнь хэдэн суурь хонь нуурнаас услаад холдохыг үзэж хоньдоо тэр зүг зугуухан эргүүлэв. Хонин сүрэг хошууран хөдлөхийг хараад тэр мориндоо мордон нуурын эрэг дээр очжээ. Нуурын зүүн хойд талын хэсэг зэгсийг хяргаж, элс шороо цацан хиймэл элсэн тан үүсгээд хонь мал услахад дөхөм болгожээ. Ус цүрийтлээ уусан морьд усан дотор нүдээ аньчихаад ялаархан зогсож эрэг рүү гарах шинж алга. Галуу, нугас зэрэг усны шувууд нуурын мандалд усаар тоглоцгоон, нэрийг нь үл мэдэх хэдэн бяцхан шувууд морьдын гэдсэн доогуур нааш цааш сүлжилдэнэ. Морьд ядаж сүүлээ ч хөдөлгөхгүй тэдний аясаар тоглуулах ажээ. Гагцхүү хун шувууд л морьдын булингартуулсан уснаас жийрхэн зай барьж, нуурын чанх голд буюу нөгөө эргийн зэгсийг бараадан хөвцгөөнө.

Нуурын эргийн налуу руу хоньд майлалдсаар ус руу явж орцгоов. Зуны улиралд хоньдыг хоёр хоногт нэг удаа усалдаг болохоор цангасан хоньд цагаан тоос татуулан майлалдсаар ус руу дайрна. Хүн мал шинэ нутагт орж ирээд арав хоноогүй байхад нуурын эрэг хавийн өвс малын хөлд гишгэгдэн халцарчээ. Хонин сүрэг морьдын хажуу хавиргаар дайран ус ууцгаана.

Хоньд ус ууж ханаад эргийн дээш гарахад залгуулаад өөр нэгэн ангасан суурь хонь улбар тоос татуулсаар орж ирэв.

Нуурын эргээс хоёр километр зайтай нэгэн налуу өндөрлөг дээр гурав дөрвөн майхан барьсан бөгөөд хэдэн арван хөлсний ажилчид шуудуу татаж байлаа. Бао Шүнь Гүйн заавраар хонь угаах цөөрөм, ноосны агуулах болон багийн нүүдлийн захиргааг бариулж байгаа ажээ. Хэдэн хөлсний ажилчин шуудуу татаж, газар хагалан ногооны талбай байгуулж байхыг Чэнь Жэнь харлаа. Алсад байгаа өөр нэгэн уулын бэлээс шар өнгийн том чулуунуудыг олборлон ажлын талбар руу ачааны машинд дүүргэн ачна. Чэнь Жэнь атар онгон талыг сэглэсэн онгойсон хар нүхнүүдийг хараад байх хүсэл үгүй тул хоньдоо туусаар баруун хойд зүгийг чиглэв.

Хонин сүрэг нэг хөтлийг даван хотгороос гарч явав. Зуны өдөр урт тул ойр хавийн бэлчээрийг мөлжилгүй малаа холхон бэлчээж байвал намрын эхэн сар хүртэл нутаг сэлгэнэ гэхгүй амар байх болно шүү гэж Билиг өвгөн хэсгүүдийн дарга нарт сануулсан билээ. Тэр хотгорын гадна дотнох бэлчээр нутгийг сэлгэн идээшлүүлж, өвсний гарцыг сайжруулахаас гадна, хэт сул хөрсийг дагтаршуулан шумуулаас сэргийлж болох юм гэж үзсэн байна. Чэнь Жэньгийн хонин сүрэг хагас саран хэлбэр үүсгээд баруун уулын энгэрийг даган бэлчлээ.

Нарны туяан дор мянга гаруй хурга ишиг цоморлигоо дэлгэсэн цагаан удвал цэцэгс мэт номин ногоон талд нүд баясгам харагдана. Хурга ишигний буржгар үс сэвсийгээд, эхийн сүүт

хөхөхийн хажуугаар нялх ногоонд цадсан хурганы сүүл хөхүүл эхийнхээ сүүлнээс дутахааргүй томорсон харагдана. Саяхан дэлгэрсэн шар цэцэгс уулын энгэрийг нэлэнхүйд нь бүрхээд зүлгэн дээр суусан Чэнь Жэньгийн нүд шар өнгөөр эрээлжлэнэ. Алд дэлэм өндөртэй үй түмэн шар цэцэгс урт шилбэн дээрээ ганхан найгаад, түүний салаа мөчир дэх хараахан нээгдээгүй цоморлиг дэлгэрэх цагийг тэсэн ядан хүлээж байх шиг. Чэнь Жэнь ийнхүү атар онгон талын шар цэцэгс хүний тарьсан шар цэцэгсээс том байдгийг гайхан суух зуур мөрний өмнөд нутгийн шилэмдэг цэцгийн талбайд байгаагаас өөрцгүй санагдана.

Чэнь Жэнь босож морио унаад шар цэцэгс ягч ургасан газарт очин дэлбээг нь түүлээ. Ойрын өдрүүдэд амттай зөөлөн шар цэцэгс Бээжингээс ирсэн оюутнуудын улирлын чанартай хоолны хачир нэмэр болоод байгаа болохоор тэд шар цэцэгт хонины махан хуурга, шар цэцэгт бууз, банш, шар цэцэгт сонгины зууш, шар цэцэгт хар шөл зэргийг хийж идэх болсон билээ. Өвлийн турш ногоосож гүйцсэн илгээлтийн эзэд тал нутгийн хээрийн цэцэг хуарыг ийнхүү яргуйссан ямаа шиг ховдоглон идэхийг харсан малчид нүдээ бүлтийлгэн гайхах боловч шар цэцгийн амтыг төдийлөн таашаахгүй. Өглөө нааш гарахад Гао Зянь Жун түүнд хоёр хоосон цүнх өгсөн. Ойрын хэдэн өдөр тэр Чэнь Жэньг ном уншуулахгүй байгаа бөгөөд Ян Кө тэр хоёроор цэцэг ногоо түүлгэн, гэртээ ирэхэд нь халуун усанд сойж наранд хатаагаад өвлийн хэрэгцээндээ нөөцөлж байгаа юм. Энэ хэдэн өдөр тэд хагас шуудай шахам цэцэг түүж хатаажээ.

Хонин сүрэг тааваар идээшилж байхыг ашиглан Чэнь Жэнь цэцгийн цоморлигийг түүсээр нэг цүнхээ дүүргэж орхив. Ийнхүү түүж байхдаа тэр хөлийн дор нь хэдэн хэсэг чонын баас байхыг олж үзээд доош тонгойн нэгийг сайтар шинжин харлаа. Гадил адил бүдүүн зэгэл саарал тэр бааснууд хатаж орхисон боловч хэдхэн хоногийн өмнөх гэдэг нь андашгүй ажээ. Чэнь Жэнь завилан суугаад чонын баасны талаар бага сага зүйл ойлгох санаатай сайтар бодолхийлж гарав. Хэдхэн хоногийн өмнө түүний сууж байгаа энэ газар нэгэн том чоно үдлэн буусан болохыг тэр ойлгожээ. Тэр энд яах гэж ирсэн юм бол доо? Чэнь Жэнь эргэн тойрноо сайтар гүйлгэн харваас сэг зэм, үс ноос харагдахгүйг бодвол лав амьтан барьж идээгүй бололтой. Өвс ногоо халиурч, хэсгүүдийн хонин сүрэг байнга шахам өнгөрдөг энэ газар чоно бүгэн отоход тохиромжтой байж мэдэх юм. Түүний сэтгэл сэрхийн эвгүйрхэж яаран сандран босоод ийш тийш харвал ойр хавийн хэдэн өндөрлөг дээр хоньчид сууцгаан, өөрийнх нь хонин сүрэг налайн бэлчих тул эргэн суулаа.

Чэнь Жэнь чонын баасыг ялган таних боловч нарийвчлан судлаж байсан удаа үгүй юм. Тэр чонын баасыг хугалж үзвээс зээр хонины үс ноос болон үлийн цагаан оготны жижиг шүднээс өөр хонины ясны хэлтэрхий ч алга ажээ. Чэнь Жэнь мөнөөх баасыг үйрүүлэн үзтэл өөр ямар нэгэн хатуу зүйл гарсангүй. Чоно өөрийн залгисан хонь, зээр, тарвага зурамны мах, арьс, яс, шөрмөс зэргийг үлдээлгүй шингээгээд зөвхөн үл шингэх үс ноос, шүд төдийхнийг л үлдээдэг ажгуу. Дахин нарийвчлан ажиглаваас бүдүүн ширхэгтэй ноос үс л байхаас биш, нарийн ноос ноолуурыг ч шингээчихдэг бололтой. Түүнтэй харьцуулахад нохойн ходоод чоньхоос хавьгүй тааруу ажээ. Нохойн баасанд шингээгүй хоцорсон ясны хэлтэрхий энэ тэр зөндөө л үлдсэн байдаг.

Чоно гэдэг тал нутаг дахь үхэр, адуу, хонь, тарвага, зээр, туулай, зурам, тэр ч байтугай хүний хүүрийг хүртэл идэж цэвэрлэдэг тал нутгийн цэвэрлэгч болохыг ухаараад Чэнь Жэнь улам ч

их хирдхийн гайхав. Чонын ам, ходоод, гэдсээр шимэгдэн үгүй болсон тэжээллэг зүйлсээс зөвхөн үс ноосны төдийхөн үлдээд бичил биетэнд хүртэл хувь ноогддоггүй байна шүү. Түмэн оны турш тал нутаг ийм цэвэр цэмцгэр байдаг нь гагц чонын ач гавьяа биш гэж үү?

Урин салхины сэвшээнд шар цэцэгс найгана. Чэнь Жэнь чонын баасыг имрэн үзэхэд чонын ходоодны хүчилд түлэгдэн, нарийн гэдсэнд шимэгдсэн хонины ноос дөнгөж сая газар дороос гарсан занданшуулсан шарил шиг болон хувирчээ. Ноосны ширхэг уян хатан чанараа алдаад яльгүй имрэхэд чандарласан яснаас ч дутамгүй бутарч салхины аясаар хуруун завсраар хийсэн талын хөрсөнд шингэнэ. Чонын баас тал нутгийн нэгэн амины сүүлчийн үлдэгдлийг ийнхүү талд нь бүрэн хүлээлгэн өглөө.

Чэнь Жэнь хэсэг зуур бодолд автав. Мянга түмэн жилийн турш тал нутгийн нүүдэлчид чоно хоёрын сүнс тэнгэрт халихын цагт булш бунхан хөшөөний бичээс зэргийг үлдээдэггүй байжээ. Хүн чоно хоёр тал нутагтаа төрж, амьдарч, дайтаж үхэж байсаан. Төрөхийн цагт тал нутаг ямар байсан, үхэхийн цагт тэр л янзаараа үлддэг ажээ. Хэдэн арван улсын асар том хот балгадыг эвдлэн сүйтгэж байсан талын баатруудын амь тал нутагтаа ийнхүү хун галууны өднөөс ч хөнгөн зөөлнөөр шингэн оддог нь тал нутагт археологийн хайгуул хийх хожмын хүмүүсийн тархийг гашилгаж гүйцдэг байх даа. Гэвч хун галууны өднөөс ч хөнгөн тал нутгийн хүмүүний амь байгаль дэлхий, мөнх тэнгэрийн амийг дээдэлдэг нь Тайшань уулнаас ч нүсэр хүнд сац суврага, Цин Ши Хуаний газар дорх ордон, Таж махал зэрэг аварга бунхнуудыг байгуулсан хүмүүсээс ч илүү хожмын үеийнхэнд үлгэр дууриаллыг үзүүлнэм бус уу. Тал нутгийн хүмүүс хөх чонын ачаар хун галууны өднөөс ч илүү хөнгөрөн эцэстээ эх байгальдаа уусан шингэдэг ажгуу. Тэд бие биесээ нөхвөрлөн махан бие үгүй болохын цагт тал нутагтайгаа нэгэн амьд нэгддэг байх нь.29

Чэнь Жэньгийн гарын салаагаар нунтаг баас салхинд хийссээр л, магадгүй энэ нунтаг дотор хэн нэгэн талын хүний үс хялгас явж байгаа ч юм бил үү? Тал нутагт сар улирал болгон хэн нэгнийг ил задгай хөдөөлүүлсээр л байдаг. Чэнь Жэнь гараа өндөрт өргөн хөх тэнгэрийг ширтээд тэнгэрт залрах тэдгээр сүнснүүд амгалан жаргалаа эдлэхийн ерөөл талбив.

Үхрийн эврэн сам хэлбэрт хонин сүрэг цэцэгсийг самнан уулын бэлийг өгсөв. Чэнь Жэнь тэр хэдэн чонын баасыг хаяж төвдөлгүй нөгөө цүнхэндээ хийчихээд мориндоо мордон хонин сүргийн зүг давхилаа.

Холгүй орших нэгэн довцгийн орой дахь хэдэн цайвар бараан үхэр чулууг алсаас харахад эрт дээр үеийн цагаан хэрмийн дээрх дохионы галын тавцан мэт үзэгдэнэ. Бүр алсад орших нэгэн толгодын оройд бас хэдэн үхэр чулуу хөглөрөх нь энэ хэсгийн уул тал цагаан хэрмийн үлдэл тасархайн ул мөрийг агуулж байгаа мэт. Тэр гэнэт хятадын “Дохионы гал олон мужийн захирагч нараар тоглодог”, “Чонын утаа дөрвөн зүгт босох” гэсэн хэлц үгнүүдийг саналаа. Тэр нэлээд ултай толь бичгүүдийг сөхөж үзэхэд чонын утаа гэдэг нь чонын баас шатаахад гарсан утаа хэмээн тайлбарласан байж билээ. Гэвч сая түүний имэрч үзэхэд үс ноос төдийхөн голлосон чонын баас яахаараа тэнгэрт олгойдсон дохионы галыг үүсгэж чаддаг билээ. Арай чонын баасанд өөр найрлага байдаг юм биш биз дээ? Гэнэт түүний зүрх хүчтэй цохилоход тэрээр нүдний өмнө байгаа энэхүү дохионы галын тавцанг ашиглан бэлэн байгаа чонын баасаа шатаагаад “Олон мужийн захирагч нараар” тоглож яагаад болдоггүй байх билээ хэмээн санах. Хоёр мянган жилийн турш хятадын ард түмний хараад зүрх нь чичирдэг



байсан “Чонын галыг” өөрийн нүдээр харж яагаад болохгүй гэж. Чэнь Жэньгийн сониучирхал улам нэмэгдэж ахиу хэдэн чонын баас түүгээд “Дохионы галын тавцан” дээр чонын утаа үүсгэж үзмээр санагдав.

Чэнь Жэнь зугуухан бэлчих хонин сүргийн урдуур амдан цаг шахам хайсаар дөрвөн хэсэг чонын баас олсон нь нийлээд цүнхний ёроолыг л дүүргэлээ.

Түүний эргэлзээ улам бүр ихсэв. Чонын баас шатдаг байлаа гэж бодоход хурдан гүйдэлтэй араатны тэр их өтгийг хаанаас олж цуглуулах билээ. Ядаж чонын гүйдэл барьцгүй, баас нь хаа ч байж мэдэх тул хангалттай ихээр цуглуулж олно гэдэг туйлын амаргүй хэрэг байж таарна. Чонон сүрэг зээрийн ав хомрог хийж өнгөрсөн газарт чонын баас олоход ийм амаргүй байгаа юм чинь үхэр, хонь цөөхөн цагаан хэрмийн ойролцоо бол бүр ч ярилтгүй юм. Тэгвэл цагаан хэрмийн тоо томшгүй харуулын цамхагууд дээрх дохионы галд хичнээн их чонын баас хэрэгтэй байх вэ? Чоно бол хоол боловсруулах эрхтэн гойд сайн, тэр хэрээр маш бага ялгадас гаргадаг араатан болохоор цагаан хэрмийн тэр олон дохионы галын түлшийг хангахын тулд асар том чонон сүрэг хэрэгтэй байж таарна аа даа. Чэнь Жэнь нэлээд явсан боловч дахин чонын баасны бараа харсангүй. Тэр хонин сүргээ нэгэн уудам энгэрт тогтоочихоод аварга үхэр чулуунуудын зүг гүйлээ.

Чэнь Жэнь аварга чулуунуудын дор гүйж хүрээд дээш харваас хоёр хүний хэртэй өндөр, хажуу хавиргаар жижгэвтэр чулуу зөндөө тул дамжаад дээш гарах боломжтой ажээ. Тэр жалганаас хэсэг хатсан мөчир гишүү баглаж үүрээд хадны дор авчирлаа. Чэнь Жэнь цүнхээ жишүүхэн барьчихаад чулуу дамжин авирч хадны орой дээр гарав. Тэгээд мөчир гишүүдийг ч дээш гаргалаа. Хоёр ширээний тавцан нийлүүлсэн мэт хад асганы тэгш орой бүргэдийн сангасанд цайрна.

Жин үд болохын хирд хонин сүрэг зүлгэн дээр тайвуухан хэвтэцгээв. Чэнь Жэнь “Дохионы галын тавцан” дээрээс ийш тийш дурандан харахад ганц ч чонын бараа олж үзсэнгүй. Ойр хавийн хонин сүргүүд хоёр гурван километр зайтай, хамгийн ойр нь л гэхэд километр хагасын цаана байгаа тул хоорондоо нийлнэ гэж айлтгүй ажээ. Чэнь Жэньгийн санаа амран түлээгээ өрөөд дээрээс нь чонын бааснуудаа асгалаа. Ногооны сөл гүйцсэн зуны эхэн сар түймэр гарна гэж айлтгүй, тэгээд ч асга хадны оройд гал тавихыг харсан хүмүүс залуу хоньчин юм шарж идэж байна гээд түүнийг зэмлэхгүй нь лавтай.

Чэнь Жэнь уужим амьсгаа аваад Маогийн өврийн улаан ном шиг жижиг хавтага гаргаж ирэхэд дотор нь хоёр зуруул, арван хэдэн ширхэг шүдэнз байх ажээ. Энэ бол Олонбулгийн тамхи татдаггүй малчдын биедээ зайлшгүй авч явах зориулалттай зүйл бөгөөд биеэ хамгаалах, гал асааж мах шарах болон дохио өгөх зориулалттай юм. Чэнь Жэнь шүдэнзээ хавирахад голгүй хатсан мөчир чад падхийн аслаа. Хэрвээ чонын баас өтгөн утаа суунаглуулаад эхэлвээс түүхэнд хятад хүн монгол талын өр зүрхэнд суунаглуулсан анхны чонын утаа болох юм гэж бодохоос түүний зүрх түг түг цохилно. Багийн хүмүүс, тэр дундаа илгээлтийн эзэд энэхүү дохионы галын тавцанд суунаглах өтгөн утааг хараад өөрийн эрхгүй чонын утааг сэтгэлдээ ургуулан санаж таарна. Яагаад гэвэл чонын утаа гэдэг энэ үг хятад хүний ухаан санаанд сэтгэл сэрхийлгэсэн үг болон хадагдсан юм. Хятадын түүх соёл дахь “Чонын утаа” гэдэг үг сэрэмжлэх дохио, айдас, дайн дэгдэлт, харийн түрэмгийлэл гэсэн олон утгыг агуулна. “Чоно ирлээ” гэхэд хятадад хүүхэд үүхэдгүй айдаг бол “Чонын утаа” гэдэг үг

нийт хятад үндэстнийг айлган чичрээнэ. Хятадын дотор газар Хань үндэстний хичнээн төр улс чухам энэхүү чонын утаанаас болж мөхөж байсан бол доо.

Хэрвээ тэр үнэхээр чонын утааг асааж дөнгөдөг юм бол багийн илгээлтийн эзэн залуус дээш хэрхэн мэдүүлж амаар айлган, үгээр үхүүлэх бол гэдгээс тэр жаахан эмээж эхлэв. Бэлтрэг тэжээгээд сэтгэл ханахгүй чонын утааг үүсгэж байгаа хүний чонон санааг яахин төсөөлж барах билээ. Чэнь Жэнь өрөөсөн хөлөө өргөн савхин гутлаараа бургилан хөөрөх чонын утааг унтраахаар зэхнэ. Дайны байдалтай хил хязгаарын түгшүүртэй бүс нутагт дохионы галаар олон мужийн захирагч нараар тоглох нь дайсандаа дохио өгч сэрэмжлүүлж байгаа хэрэг биш гэж үү? Ийн бодоод Чэнь Жэньгийн духан дээр хүйтэн хөлс чийхарлаа.

Гэвч хатсан мөчир дүрэлзэн ассан боловч чонын баас хэвээрээ шахам байсаар л байв. Зэгэл саарал чонын баас харлах боловч сүртэй утаа суунаглуулж, дөл авалцан шатахгүй ажээ. Гал улам бадрахад чонын баас хамар цоргисон хонины зунгаг, чонын шинхэг ханхлуулан шатаж эхлэв. Гэсэн атал сүртэй хар утаа суунаглуулсангүй шар эсгий шатаахад гардаг бордуу утаа суунаглах нь мөчир гишүүний утаанаас цайвардуу санагдав. Мөчир тэр аяараа дүрэлзэн асахад чонын баас ч оргүй шатаад утаа гэх юм бараг үзэгдэхгүй боллоо. Юуных нь өтгөн хар утаа байх билээ. Ядаж суунагласан цагаан утаа ч байдаггүй юм байна. Хүний зүрх чичрүүлсэн дохионы галын чонын утаа гэдэг үг хаанаас гарсан юм бол доо? Аварга лууг санагдуулам суунагласан бараан утаан багана ч байдаггүй шүү. Хуурай мөчир дээр шар эсгий шатаахад үүсдэг цайвар утаа ялгараад л өнгөрлөө шүү дээ.

Чэнь Жэнь өргөсөн хөлөө буулган духандаа чийхарсан хүйтэн хөлсийг арчаад уужим амьсгаа авав. Хоньчдын өвлийн цагт дулаацдаг түүдэг галаас нэг их ялгаагүй тул тэгтлээ айж сандраад байх зүйл үгүй байсан ажээ. Түүдэг гал ор мөргүй шатаж дууссан боловч түүний хүсэн хүлээж байсан өтгөн утаа ор мөргүй хэвээр. Тэр өндөр хадны оройд зогсоход зүүн хэсгийн уудам тал аядуу амгалан дүр зургийг илтгэнэ. Үхэр тэрэг зугуухан сажилж, адуун сүрэг нуурын усанд нүдээ анин ялаархаад, хүүхнүүд хонио хярган, хар ажилчид чулуугаа малтсаар байх ажээ. Ойролцоо байх нэгэн хоньчин түүний тийш сониучирхан харахыг эс тооцвоос саяын гал хүмүүсийн анхаарлыг татсан шинж огт алга. Монгол гэрийн яндангаар гарсан цагаан утаа чанх дээш суунаглана. Гэтэл жинхэнэ чонын баасаар шатаасан чонын утаа монгол гэрийн тооноор аядуухан суунаглах цайвар утаанаас илүү хүний анхаарлыг татаж чаддаггүй байх гэж.

Чонын утаа хэмээгч нь цаанаа ёгт санааг илтгэсэн ор мөргүй худал ухагдхуун байсныг үзээд Чэнь Жэньгийн урам маш их хугарав. Эртний дохионы галын тавцан дээрх чонын утаа гэгч нь жинхэнэ чонын баасаар шатаадаг зүйл биш байсан байж таарна гэсэн түүний таамаглалыг саяын туршилт ямар нэгэн хэмжээгээр батлаж өгчээ. Тэр тэнгэр баганадсан өтгөн утааг хуурай нойтон түлээг холин шатаагаад дээрээс нь жаахан тос өөх нэмээд өгөхөд үүсгэх бүрэн боломжтой юм. Чийгтэй аргал хоргол хүртэл өтгөн утаа суунаглуулдагийн дээр нойтон түлээ, өөх тос, чийгтэй аргал, хоргол чонын бааснаас хавьгүй амархан олдоно. Чонын баас шатаан чонын утааг гаргадаг байжээ гэж нэртэй цуутай эрдэмтдийн барим тавим нотлосон зүйлс үнэний оргүй дэмий хоосон зүйл, аймхай хулчгар хятадын энгийн номхон иргэд өөрийгөө айлгахын тулд гаргасан дэмий балай үг яриа гэдгийг тэр одоо багтай хэлж чадахаар боллоо.

Түлээний үнс болон чонын баасны үнс урьхан салхинд үлээгдэн “Дохионы галын тавцангаас” хийслээ. Чэнь Жэнь өөрийн шатаасан чонын утаанаас тэгтэл айсангүй, харин ч хятадын нэр хүнд бүхий толь бичиг дэхь чонын утааны тухай тайлбарт уур хүрч гүйцэв. Хятадын суурьшмал соёл иргэншил умард зүгийн тал нутгийн соёл иргэншлийн талаарх ойлголт дэндүү гүехэн, талын чонын талаарх ойлголт хэтэрхий нүдэн балай чихэн дүлий байсаар иржээ. Чонын утааг чонын баас овоолон асаагаад гаргаж авдаг байжээ гэсэн ийм энгийн зүйлийг жаахан чонын баас олж шатаагаад л мэдчихэж болох биш үү? Гэвч эртнээс нааш хэдэн зуун сая живаа хятад хүнээс үүнийг яагаад ганц нь ч туршиж үзээгүй юм бол доо? Нөгөө талаас нь бодож үзвэл энэ энгийн хялбар зүйл цаагуураа тийм ч амархан хэрэг биш байж таарна. Хэдэн мянган жилийн хятад үндэстний суурьшмал соёл иргэншлийн түрэлтийн явцад тэд чоноо устгаад үгүй болгочихсон болохоор хаанаасаа ч чонын баас хайж явах билээ дээ. Өтөг түүгч өвгөн үхэр, хонь, гахай, морь, нохой хүний аргал хоргол хомоол, өтөг баасыг цуглуулж явахдаа хааяа нэгхэн чонын баастай тааралдлаа ч таньж мэдэхгүй өнгөрч таарна.

Чэнь Жэнь “Дохионы галын тавцангийн” өндөр хадан дээр суучихаад ухаан санаагаа төвлөрүүлэн наад цаадахь учрыг эрэгцүүлж эхлэв. Чонын утаа нэгэнт чонын баасыг шатааснаар үүсдэггүй юм бол эртний хүмүүс дохионы галын тавцан дээр шатааж үүсгэдэг тэнгэр баганадсан хар утааг яагаад тийн нэрлэх болов. Чонын утаа хэмээх хоёр үг чонон сүргээс ч илүү айдас дагуулан дохио сэрэмж өгдөг байсан болохоор чонын утаа гэдэг үг заавал чонотой холбоотой байж таарна. Чонын утаа нь тэгвэл “Чоно ирлээ” гэдгийг сануулж байсан өтгөн утаа төдийхөн юм болов уу? Цагаан хэрэм талын чонон сүргийг торохгүй тогтоож чадна. Харин “Чоно ирлээ” хэмээх энэ хоёр үг нь үнэн хэрэгтээ чонон сүргийг хэлсэн хэрэг биш, чонын толгойт тугаа мандуулдаг, чонон сүлдийг дээдэлж, чононоос үлгэр жишээ аван, чонын стратеги, тактик, уран ухаан, харгис хатуу зан чанарыг өвлөсөн Хүннү, Сяньби, Түрэг, Монгол зэрэг тал нутгийн чонын араншинт морьт цэргүүдийг хэлсэн байж таарах нь. Тал нутгийн нүүдэлчид эртнээс өдгөөг хүртэл чонон сүлдээ дээдлэн, өөрийгөө чонотой зүйрлэх дуртай байдаг. Тэд хятадуудыг хоньтой зүйрлэн, нэгээр зууг ялах омогшлоороо суурьшмал үндэстний хонины зан чанарыг басамжлан үздэг. Эртний хятадын суурьшмал үндэстнүүд ч гэсэн тал нутгийн морин цэргүүдийг аймшигт чоно мэт үзсээр ирсэн билээ. Тийм болохоор чонын утаа гэдэг үгийн хамгийн анхны утга нь “Дохионы галын тавцан дээрээс чонон сүлдийг шүтдэг тал нутгийн нүүдэлчдийн морин цэргүүд цагаан хэрэм рүү халдлаа шүү гэдгийг илтгэх гал утаан дохио” байсан ажээ. Харин чонын утаа, чонын баас хоёр хоорондоо ямар ч холбоогүй зүйл байж.

Ер нь энэ дэлхий дээр зөвхөн хятад хэлэнд л “Чонын утаа” гэсэн энэ үг байдаг байх гэж тэр бодлоо. Хорвоо дэлхийд оготно муурнаас, хонь чононоос айдаг нь үнэн билээ. “Чонын утаагаар” өөрсдийн хамгийн их айдаг тал нутгийн нүүдэлчдийн довтолгооныг бэлгэдсэн нь хятад үндэстний хонины араншин болоод тэжээвэр амьтны зан чанарыг илтгэн харуулж байгаа юм. Тал нутагтаа халуун хайртай, нүүдэлчин гаралтай манж нар цагаан хэрмийг даван орж эзлэснээр тал нутаг суурьшмал иргэншил хоёрын зөрчлийг сааруулан чонын утаа яваандаа замхарсан байх нь. Гэвч талын соёл, суурьшмал соёлын хоорондын гүн гүнзгий зөрчил үндсээрээ шийдэгдээгүй билээ. Тал нутгийн тухай ойлгоцгүй хятадууд төр улсаа дахин төвхнүүлснээр чонын утааг бүрмөсөн үгүй хийжээ. Түүний оронд суурьшмал иргэдийн атрыг хагалан талыг шатаасан утаа бүр ч хүчээ аван оргиллоо. Энэ нь чонын утаанаас ч илүү аймшигт дарь хүхрийн үнэр төдийгүй цагаан хэрмийг эвдлэн сүйтгэснээс ч хавьгүй ноцтой

өөрийгөө егүүтгэсэн дайн юм. Хэрвээ цагаан хэрмээс хойшхи умард зүгийн тал цөлжөөд монголын элсэн говьтой хаяа хатгачихвал Бээжин хот юу болох билээ гэсэн Өлзийгийн үг түүний чихэнд хангинах шиг боллоо.

Мянга мянган жилийн турш тал нутгийг дайсагнан үзсээр ирсэн суурьшмал үндэстнээр тал нутгийг нандигнан хайрлуулдаг больё гэвэл цагаан хэрэм аварга элсэн манханд дарагдсаны хойно л бүтэх хэрэг болов уу гэж бодоод Чэнь Жэнь уртаар санаа алдлаа. Суурьшмал үндэстнүүд цээлийн ус ширгэж, цэгээн чулуу хагарсан хойно л сая нулимс унагах дуртай улс бөгөөд манж нар дотор газарт эзэн суусны хойно суурьшмал соёл иргэншилд уусан нэгдээд улс орныг түгжигдмэл битүү байлгаж чадсандаа омогшин, өрнөдийн дэвшилтэт соёл иргэншлийг хяхаж хавчин, өөрчлөлт шинэчлэлт хийхийг зөвшөөрөхгүй байж билээ. Тэгээд эцэс сүүлдээ хүчирхэг гүрнүүдийн хүнд их буут усан онгоц улсын хаалгыг зад татан орж ирэхэд арга буюу газар нутгаа тасдан өгч, хаан эзэн нь хүртэл нийслэл хотоос хөөгдөн гарсаны эцэст сая хэдэн арван жил өөрчлөлт хийх гэж ядсан биз дээ. . . . .

Чэнь Жэнь хөлийн дор үнс тортог болон хувирсан чонын баасыг хараад үнэхээр урам хугарлаа.

Тал нутгийн жин үд болоход зуны нар улам ч зулай халан төөнөв. Тал хөндийг бүрхсэн өвс ногоо нарны элчинд намсан, хад чулууны ан завсар улам тодрох шиг. Чэнь Жэнь дутуу шатсан үнс нурмыг хадны завсар унагаад өөрөө доош буулаа. Үдийн наранд байж ядсан хоньд нуруугаа нарны эсрэг харуулаад, толгойгоо өвс рүү шургуулан газар наалдуулж зүүрмэглэнэ.

Чэнь Жэнь чулууны сүүдэр бараадан нозоорох боловч чонын баас олдсон газар яахин зүүрмэглэж болох билээ. Холгүйхэн нэг азарган чоно түүнийг нарны илчинд цохиулан нойрсохыг анан хүлээж байгаа ч юм бил үү? Тэр усны саван дахь цийдэмнээс хэд балгатал нойр нь арай сэргээд ирэв. Тэр хонины хишигтэй өдөр болгон савтай цийдмээ авч явдаг бөгөөд энэ нь зуны улиралд малчид төдийгүй гэрт үлдсэн хүүхэд нохдын уух дуртай ундаа билээ.

Морин туурай тачигнасаар Дорж түүнийг чиглэн ирлээ. Тэр цагаан тэрлэг дээр ногоон дурдан бүс жавхайтал бүсэлжээ. Дорж минчигэр улаан нүүрнийхээ хөлсийг шудрангаа “Өө чи байсан юм уу, хадан дээрээс утаа суунаглаад байхаар хэн нэг нь тарвага урхидчихаад боодог хийж байгаа юм байна гэж бодлоо л доо. Би ч өөрөө өлсөж байсан юм” гэлээ. Чэнь Жэнь түүний хариуд “Миний тарвага урхидна гэж юу байхав дээ. Нойр хүрээд байхаар нь жаахан сэргэх санаатай гал хөс түлж өөрийгөө зугаацуулж байсан хэрэг. . . . Чи харин хоньдоо яачихаа вэ?” гэхэд Дорж арын энгэрийг даган бэлчих хоньдыг заагаад “Хоньд маань тогтчихсоон. Миний нойр хүрээд болдоггүй тул чамтай хууч хөөрөх гэж ирлээ. Би зэргэлдээх хоньчинд харж байгаарай гээд захичихсан тул алзахгүй ээ. Тэр толгодын орой дээр хоёр хоньчин шатар тавьж байхыг харж байна уу?” гээд Дорж чулууны сүүдэрт тухлав.

Монгол малчдын дунд буга барих гэдэг хөлөгт тоглоомоос гадна, монголын морьт цэргүүд өрнө дахинаас авч ирсэн шатар ихээхэн дэлгэрсэн болохыг Чэнь Жэнь олж мэджээ. Харин хятад шатар мэдэх хүн бараг үгүй. Хятад шатар ханз үсэгтэй болохоор түүнийг мэдэх монгол ховор. Харин өрнө дахины шатар үсэг бичиггүй, ялангуяа морь нь морин хууртай адил морины толгойн сийлбэр байдаг тул сурахад дөхөмтэй. Тийм болохоор монголчууд морин

толгойтой шатрыг нь илүү эрхэмлэдэг юм гэж Билиг өвгөн ярьдаг билээ. Монголын морьт цэргүүд дэлхийн дайдыг морин туурайгаар тамгалж явсаны ул мөр, нөлөө өнөө хэр тал нутагт оршсоор л байх ажээ. Тал нутгийн нүүдэлчид хятадуудаас хавьгүй эрт дэлхийн олон улс оронтой харьцан, өрнө дахинаас дайны олзоо тээн авчирч байсан дорно дахины үндэстэн билээ. Монголчууд дэлхий дахинаа тойготныг сөхрүүлж, толгойтныг бөхийлгөж явах тэр үед Ромын пап лам хүртэл монголчууд руу элчээ илгээн хүндэтгэл үзүүлж байсан. Монголчуудын ийн хүчирхэгжин мандсаны буянаар өрнөдийнхөн дорно дахиныг бүрнээ басамжлан үзэж байгаагүй байж таарна гэж Чэнь Жэнь дотроо байнга бодно. Тэр тал нутагт хүрэлцэн ирсэний дараа малчдаас монгол шатар сурч билээ.

Өвөрмонголын талд зуны улиралд өдөр урт гэж жигтэйхэн. Үүр цүүрийн гурав хагас гэхэд гэгээ ороод орой найм ес хүргэж байж сая харанхуй болдог. Хонин сүргийн үе мөчинд шүүдрийн ус тааруу гэж үзээд нар бүр дээр мандан өвсний чийг хатсан найм есөн цагийн үед сая бэлчээнэ. Тэгсэн атлаа харуй бүрийгээс орой болох хүртэл халууны эрч буурсан үед хонь малаа сайн идээшлүүлбэл тарга тэвээрэг сайн авдаг гээд тэр болтол хотлуулахгүй. Тийм болохоор зуны улиралд хоньчид өвөл цагаас хоёр дахин урт хугацаагаар ажилладаг гэсэн үг. Өглөөний цай ууж аваад оройн найм есөн цаг хүртэл халуунд халж, хар хөлсөө цувуулан өлсөж цангахын туйлд хүрдэг болохоор хоньчид зуны улирлыг төдийлөн таашаахгүй. За тэгээд зуны ид халуун шатах үеэр шумуул олшроод ирэх юм бол амьдын там гэж түүнийг хэлэх байх. Бээжингийн оюутнууд тал нутагт ирсэнийхээ дараа зунтай харьцуулах юм бол хахир хатуу өвөл нь биеэ нөөж болох жаргалтай үе гэдгийг олж мэджээ.

Чэнь Жэньгийн хувьд шумуул ихсэхээс өмнө хамгийн амаргүй даваа гэвэл өлсөж цангах явдал байдаг байв. Малчид хоолгүй хоосон явсаар ходоод гэдэсний өвчлөл ихтэй. Илгээлтийн эзэд эхэндээ зуны улиралд хонинд явахдаа хуурай хүнс авч явдаг байснаа яваандаа олны жишгийг дагах болсон юм. Тарваганы боодог гэхийг сонсоод мань хоёрын ходоод хоржигноод явчихлаа.

“Шинэ нутаг ч тарвага элбэгтэй юм билээ. Баруун уулын энгэрт тарваганы нүх элбэг болохоор өнөөдөр багцааг нь харж байгаад маргааш тэрүүгээр хонио эргүүлэх далимдаа арван хэдэн урхи тавьчихвал үд дундын үед тарваганы боодог цохиж болох байх шүү” гэж Дорж өгүүлэв. Урхинд тарвага орчихвол өлсөх, нозоорох асуудлыг шийдэж болох тул Чэнь Жэнь ч уухайн тас зөвшөөрлөө. Өөрсдийнх нь хоёр хонин сүрэг тогтуун хэвтэцгээхийг хараад Дорж Чэнь Жэньг дагуулан баруун хойдох толгодын орой дахь хэдэн цагаан чулууны ард нуугдав. Эндээс эргэж хоньдоо харуулдаж болохоос гадна, урагш уулын энгэр дэх тарваганы нүхийг дурандах боломжтой ажээ. Мань хоёр дурангаа гарган ажиглаж эхлэв. Уулын энгэр дэхь хэдэн арван тарваганы дошин дээрх өөхөн чулуу болон цагаан шороо гялтганан үзэгдэнэ. Олонбулгийн тарваганууд нүхээ маш гүн малтдаг болохоор гүний хүдрийг хүртэл ил гаргах нь бий. Зарим малчид тарваганы дошин дээрээс утаат болор аранжин зэс хүртэл олж байсан удаатай билээ. Түүний ул мөрөөр Бээжингээс хайгуулын анги ирж судалгаа хийж байсан боловч хил орчмын бүс нутаг болохоор хараахан уурхай нээлгүй орхисон байж таарна.

Удаж төдөлгүй тарвага хошгоролдох чимээ гарахыг үзвээс нүхнээс гарахаар зэхэн тандалт хийж байгаа нь тэр юм. Хэрвээ ямар нэгэн этгээд чимээ анир сонсогдохгүй бол тэд зэрэг шахам ил гарч ирнэ. Ийнхүү хэсэг зуур хошгорч байснаа уулын энгэрээр хэдэн арван том жижиг тарваганууд нэгэн зэрэг ил гарцгаалаа. Дош болгон дээр нэжгээд нагай шовойн

зогсоод амар тайвныг илтгэн нэгэн хэмээр хошгороход мөндөлнүүд үүрнээсээ арван хэдэн метрийн зайтай өвсөн дунд эрхлэн наадацгаана. Хөх тэнгэрт талын хүрэн бүргэд элин халин нисэхийг нагайнууд сэрэмжтэйгээр ажиглах ажээ. Агаарын хүчит дайсан нь алгуур доошлоход нагай түгшүүрийн дохио өгөхөд мөндөлнүүд үүр рүүгээ хурдлан ороод аюул холдсон цагт сая ил гарч ирнэ.

Чэнь Жэнь жаахан ширүүхэн хөдөлтөл Дорж түүний нурууг доош дараад шивнэн өгүүлрүүн “Хамгийн хойд талын сондгой дошны наахан талд нэгэн том чоно байгааг харж байна уу? Боохой хүн хоёр адилхан боодог идье гэж бодож л дээ” гэлээ. Чоно гэхийг дуулаад Чэнь Жэньгийн нойр сэргэн тэр зүг дурангаа чиглүүлэв. Түүний заасан дошин дээр нэг том бурхи урд сарвуугаа цээжиндээ хумьчихаад ийш тийш харан хошгорох боловч үүрнээс холдон өвс идэж зүрхлэхгүй ажээ. Талын тарваганы бурхинууд тусдаа, нагайнууд нь мөндлүүдтэйгээ тусдаа үүрэнд амьдардаг юм. Мөнөөх бурхины дошийг халхалсан өвс салхины аясаар найгахад хэдэн цайвар шаргал чулуу цухуйхаас өөр зүйлийг ялгаж танихад нэн бэрх ажээ. “Би хэдэн чулуунаас өөр ямар ч чоно олж үзэхгүй байна” гэж Чэнь Жэнь хэлэв.

“Яг тэр чулуунуудын чинь хажууд нэг чоно байна. Тэр лав маш удаан хүлээсэн байж таарна.” гэж Доржийг хэлэхэд Чэнь Жэнь дахин сайтар ажсаны эцэст чонын нурууг бүрэг бараг олж харлаа. Тэр тэсгэлгүй “Чиний нүд ч мөн хурц юм аа. Би бол олж харахгүй юм байна шүү” гэлээ.

“Чоно тарвагыг яаж барьдаг аргыг мэдэхгүй бол ямар ч хурц хараатай байгаад нэмэргүй л дээ. Чононы хувьд тарвага барих амаргүй учраас салхины дороос гэтэн хамгийн том бурхины нүхэн тушаа бүгж хэвтдэг. Энэ хурганы хиртэй том бурхи ганц чоныг өлхөн цатгачихаар байгааг чи харж байна уу? Тийм болохоор чи чоно олж харья гэвэл бурхины сондгой нүхний салхин дор байгаа өвсөн дундаас хайх учиртай юм. . . . .” гэж Дорж хэлэв.

Чэнь Жэнь их л баясан “Би өнөөдөр бас л нэг арга ухаан заалгалаа. Энэ тарвага хэзээ өвс идэж, чоно түүнийг барихыг хармаар байна. Чонын бараа харсан бурхи энэ олон нүхний хамгийн ойр руу ухасхийгээд орчиход л гүйцэх биш үү?” гэхэд Дорж түүний хариуд “Тэнэг чонын тарвага барина гэж юу байхав. Хамгийн ухаалаг чоно л сая тарвага барьдаг юм. Азарган чоно арга ухаантай болохоор тарвагыг нүхэндээ шургахаас өмнө яаж барихыг чи удахгүй үзнэ ээ” гэлээ.

Мань хоёр эргэн харвал хоньд нь тайван тогтуун байх тул тэвчээртэй хүлээхээр шийджээ. “Хэрвээ өнөөдөр нохойгоо аваад гарсан бол чоно тарвага барихыг анаж байгаад нохойгоор туулган араас нь морио унаад нэхэхэд боодогтой хоцорч болох байсан юм” хэмээн Дорж харамсангүй өгүүлэв. “Хоёулаа өөрсдөө хөөгөөд үзвэл нэмэргүй юу?” хэмээн Чэнь Жэньг хэлэхэд Дорж хариуд нь “Уулын хяр дээр шахам байгаа чоно цаашаа уруудаад давхихад чи бид хоёр гүйцнэ гэж үү? Тэгээд ч энэ их тарваганы нүхэн дундуур морьд хурдан давхиж чадахгүй” гэлээ. Чэнь Жэнь ч арга буюу дуугаа хураалаа.

“Маргааш хоёулаа урхи тавья аа. Өнөөдөр чи түүний хэрхэн тарвага барихыг хараад ав. Хагас сарын дараа бороо цутгаад шумуул элбэгшихээр чоно тарвага барихаа больдог юм. Учир нь шумуул чонын нүд чихийг хазлаад ингэж тайван хэвтүүлж чадахгүй л дээ. Тэсэлгүй огло үсрээд босчихоор тарвага үүр рүүгээ оролгүй хаачихав. Тэр үед чоно хонь, малыг шоглон

хүмүүс биднийг амраахаа болино” гэж Дорж хэлэв.

Бусад тарвагануудынхаа тааваар өвс зулгаахыг харсан бурхи тэвчиж ядсан бололтой дошноос арван хэдэн метрийн зайтай очин хэд хазласнаа эргэн гүйж ирээд чанга хошгорно. “Тарвага биеэ халхлахын тулд дошныхоо ойролцоо өвсийг идэхгүй байгааг харж байна уу? Тал нутгийн амьтад өчүүхэн л болгоомж алдах юм бол амиа алддаг болохоор мөн ч амаргүй шүү дээ” хэмээн Дорж өгүүлнэ.

Бүгсэн чоно улам доош навтайн бурхины барааг харж чадахгүй тул зөвхөн сонсголоороо байгаа байрлал болон үйл хөдлөлийг багцаалж байхыг Чэнь Жэнь догдлонгуй ажиглаж байлаа.

Бурхи хэд гурван удаа дошноосоо холдон эргэж буцсаны эцэст аюул үгүй хэмээн санаа амраад хэсэг сахлаг өвстэй газар руу гүйн очив. Тав зургаа орчим минутын хойно бүгсэн чоно ухасхийн босч ирлээ. Хамгийн хачирхалтай нь тэр чоно шууд бурхи руу ухасхийсэнгүй уулын уруу хэдэн чулуу пижигнүүлэн өнхрүүлэхэд дошноосоо хорь гаруй метр холдсон бурхи түүнийг сонсоод эргэн ухасхийлээ. Энэ мөчид удтал хүлээсэн чоно түүнтэй зэрэг шахам дошин дээр нь давхиж очив. Бурхи өөр нүх рүү ухасхийх гэсэн боловч амжсангүй чоно түүний шилэн дээрээс хазан дошных нь өмнө сэгсрэн унагаж багалзуурдан алаад толгой өргөв. Тэр агнасан бурхиа зуун хярыг даван алга болжээ. Чоно ердөө хагас минут хүрэхгүй хугацаанд энэ бүхнийг амжуулсан байна.

Уулын энгэрээр ганц ч тарваганы бараа туруу үзэгдэхээ байжээ. Мань хоёр босож суухад Чэнь Жэньгийн нүдний өмнүүр чонын тарвага барьж байх үеийн гялалзсан үйл хөдлөл харагдах шиг болж бүр алмайрч орхилоо. Чонын арга ухаан үнэхээр сэтгэшгүй гайхамшигтай ажээ. Тэр “Зүйлийн үүсэл” номыг уншиж байсан боловч өөрийн амьдралын явцад нүдээрээ харсан бодит байдал гайхамшигтай бүхний тайлбарыг тэр дундаас олж мэднэ гэдэг худал ажгуу.

Нар баруунаа хэлбийхэд хонин сүрэг хэвтрээсээ босож баруун умрыг чиглэн бэлчиж эхлэв. Тэр хоёр хэдэн үг сольчихоод хоньдоо гэрийн зүг буцаахаар завдаж байлаа. Мань хоёр босож морьд руугаа очих зуур Чэнь Жэньгийн хоньд захаасаа хуйлрахыг үзээд дурангаар харваас зүүн талын шаргалдуу өвсөн дундаас нэг том чоно дүүлэн гарч ирээд ойролцоо байсан нэгэн хонийг хүзүүдэн дарж унагалаа. Чэнь Жэньгийн царай барайн хашгирахыг завдтал Дорж хориглон болиулав. Чэнь Жэнь ч сэхээ орон хашгирахаа болиод дурангаараа харваас чоно хонины гуянаас тийчигнүүлэн зулгаана. Тал нутгийн хоньд цусаа үзлээ ч майлж орилдоггүй дорой амьтан болохоор хүзүүнээсээ цусаа гоожуулан урд хөл нь тийчигнэх боловч ямаа шиг орилон тусламж эрэхгүй ажээ.

“Сүргээс ийм хол байгаа болохоор давхиад очлоо ч хонийг аврахаас өнгөрсөн. Хонийг гүйцэд идээд сарвайтал цадсаны дараа хөөж уургалья. Муу хар боохой чи ахынхаа хамар дор хонины гэдэс хага ярна гэнэ ээ?” хэмээн Дорж ер бусын тайван өгүүлэхэд мань хоёр чоныг эртхэн үргээчих вий хэмээн чулуу сандайлан сууцгаалаа.

Энэ цагаандаа гарсан өлөн чоно хоньчин эзэн нь удаан хугацаагаар хоньдоосоо холдон явахыг үзээд шар цэцэгсийн дундуур мөлхсөөр сүргийн захад очиж ухасхийн дайраад тарган хонийг

нударсан нь энэ юм. Тэр толгойн орой дахь хүн морьдыг харсан боловч дутаагаагүй ажээ. Чоно өрөөсөн нүдээр хяламхийн хүн морьдын зайг багцаалан цаг мөчтэй уралдан үмх мах хоолой давуулахаар хомхойрно. Өөрийнх нь тэжээсэн бэлтрэг хоол иднэ гэж ховдоглон дайрч байдгийн учрыг гайхаж цөхөх зүйлгүй юм байна гэж Чэнь Жэнь бодож байлаа. Тал нутагт цаг хугацаа гэдэг махтай тэнцдэг болохоор шалир шалир зажилдаг өлөн чоно шальтай удаан наслахгүй нь ойлгомжтой.

Чэнь Жэнь малчдын хониороо чонын олзтой хоцорсон тухай дуулж байсан боловч энэ нөхцөлд тэр аргыг хэрэглэхээс өөр замгүй болжээ. Нэг том чоно жилдээ арван хэдэн хонь ямаа, унага даага идчихдэг тул түүний амиар нэг хонь солих нь ашигтайгаар барах уу? Хониор чоныг сольж чадсан малчныг багийн захиргаанаас загнаж шийтгэхгүйгээр үл барам харин ч шагнаж магтах нь тодорхой. Харин чоноо барьж авч чадахгүй бол хонины гарзтай хоцрох нь гэдгээс л Чэнь Жэнь их эмээж байв. Хагас минут хүрэхгүй хугацаанд чоно хонины өрөөсөн гуяыг арьс ноостой нь хамт гэдэс рүүгээ хийчихийг Чэнь Жэнь дурангаараа харж суулаа. Хонь нэгэнт амь гарах найдлагагүй болсон тул одоо чоно аль болох их мах гэдэс рүүгээ оруулаасай гэж хүсэх л үлджээ. Тэр хоёр морины чөдрийг тайлан цулбуураа атгачихаад сэтгэл түгшин хүлээсээр байлаа.

Чоно ижил сүргийн нэг гишүүнийг барихад ойр хавьд байсан арван хэдэн хоньд үргэн зугатав. Гэвч сүрэг удаж төдөлгүй нам тайван болоход хэдэн хоньд майлан дагжиж, туурайгаа тачигнуулсаар дөхөн ирэх нь чононд эсэргүүцэл үзүүлж байгаа, аль эсхүл сониучирхан харж байгаагийн алин болохыг бүү мэд. Тэдгээр хоньд дуу шуугүй харж зогсоход араас нь арван хэдэн хонь нэмэгдэн ирээд тойрон харцгаалаа. Адаг сүүлд нь хэдэн зуун хоньд чоно болон түүн бариулж цусандаа хутгалдан хэвтэх нөхрийгөө тойрон гурван метрийн диаметртэй тойрог үүсгээд хүзүү сунган сониучирхан харна. Тэдний царайд “Чоно чамайг барих нь маньд ямар хамаа байх билээ” гэх буюу “Би үхэхээр чи үх” гэсэн байдал илт тодрох ажээ. Хонин сүрэг айдаст автах буюу бусдын зовлонгоор бах таваа хангахаас бус чоныг мөргөөд авах зоригтон ганц ч үгүй байлаа.

Чэнь Жэньгийн бие зарсхийн уур хилэндээ байж ядав. Энэхүү дүр зураг Лү Сюний нэгэн зохиолд хятадын зарим мулгуу иргэд японы зандалчид элэг нэгтнийг нь егүүтгэж байхад хүзүү сунган сониучирхаж байсныг дүрслэн бичсэнтэй яг адилхан мэт санагдана. Нүүдэлчид хятадуудыг хоньтой зүйрлэдэгт гайхаад байх зүйл үгүй ажээ. Чоно хонь барих нь жигшүүртэй хэрэг боловч хонь, малтай адилхан амиа хоохойлж айж хулчийдаг хүн сүрэг гэдэг тэднээс ч илүү сэтгэл эмтэрмээр бус гэж үү.

Дорж бүр ч эвгүй байдалд оров бололтой. Багийн зартай анчин хүн атлаа илгээлтийн эзний хонийг орхиулчихаад тарвага барьж байгаа чоно харуулахаар дагуулж явсан хойгуур чоно нэг хонь барьчихдаг байж шүү. Эхгүй өнчирсөн хурга тарга тэвээрэг олигтой авч чадахгүй тул өвөл эсэн мэнд онд орох эсэх нь магадгүй. Багийн хэмжээнд гарсан энэхүү ослын улмаас Чэнь Жэнь зэмлэл хүртээд зогсохгүй өөрөө ч хариуцлагаас мултрах аргагүй юм. Хамгийн баларсан нь гэвэл чоно тэжээсэн хоёр хүний хоньд руу чоно яахаараа дайрдаг билээ. Хонио олигтой хариулахгүй чоно тэжээсээр байгаад түүнийхээ горыг амсаж байгаа нь тэр гээд хэн нэг нь дээшээ алтан хошуу өргөвөл яах билээ. Одоо ч багийн хэмжээнд бэлтрэг тэжээхийг эсэргүүцдэг хүн болгон үүнийг сайхан далим болгоно доо гэж бодоод Чэнь Жэнь улам илүү



айдаст авглаа.

Дорж чоныг дурандсаар эцэстээ нэлээд барьцтай санагдав бололтой. “Энэ үхсэн хонийг над дээр тооцчихно биз. Харин чонын арьсыг би өөрөө авна шүү. Чонын арьсыг Бао Шүнь Гүйд өгчихөөр цаадахь чинь бид хоёрыг магтаж л таарна” гэв.

Чоно мань хоёрын зүг хяламхийнгээ улам ч шуурхайлан үмхэлнэ. “Ямар ч сэргэлэн чоно өлсөхөөрөө ухаан мэдрэлээ алдчихдаг юм. Тэр ингэтэл цадчихаад яаж зугатна гэж бодсон юм бол доо? Энэ тэнэг амьтан хэдэн өдөр тарвага барьж чадалгүй өлсөхийн туйлыг үзэж л дээ” гэж Дорж хэлэв.

Чоно хагас хонины махыг цохиод голийсон юм болохыг Чэнь Жэнь үзээд асууруун “Одоо болсон байлгүй дээ?” гэхэд Дорж “Яарах юу байхав. Одоохон мордоно. Харин хоёулаа өмнө талаас нь хойшоо чигтээ хөөх юм шүү. Тэндхийн хоньчид чонын замыг тосож таарна” гэлээ.

Дорж хэсэг зуур харж байснаа сая ам нээж “Мориндоо” гэхэд хоёр хүмүүн уурга тулан мориндоо мордоод толгодыг уруудан хонин сүргийн өмнүүр ороон давхилаа. Том чоно ч ийм юм болно гэдгийг мэдэж байсан тул морьтнуудын барааг хараад хэд том үмхэлсэнээ үхсэн хонийг үлдээчихээд хойд зүгийг барин хурдаллаа. Гэвч хэдэн арван метр давхисны дараа чоно гуйвж эхлэв. Тэр гэнэт маш том алдаа хийснээ ойлгов бололтой зогтусаад доош тонгойлоо. “Хурдан давхихгүй бол болохоо байх нь байна шүү. Цаадахь чинь идсэн махаа гулгиж байна.” хэмээн Дорж хэлэхийг сонсоод Чэнь Жэнь гайхан харваас чоно саяын идсэн махаа гулгин гаргаж байх ажээ. Мань хоёр энэ ховор завшааныг ашиглан хурдлан давхисны хүчинд чононд тун ойртон ирж чадлаа.

Чэнь Жэнь өлөгчин чоно идсэн махаа гулгиж бэлтрэгээ тэжээдгийг мэдэхээс биш ийм аргаар биеэ хөнгөлдөг болохыг бодож ч байгаагүй юм. Өлсөхийн туйлд хүрсэн чоно бас ч тэнэг амьтан биш байжээ. Хэрвээ чоно амжиж гэдсээ суллагч хвал саяын осол жинхэнэ бодит зүйл болон хувирах юм. Доржийн морь түүнийхээс ч хурдан тул мань хүн давхиан дундаа гуугачин хашгирч хойд энгэрийн хоньчдод чимээ өгнө. Дорж улам ойртон чононд цааш гулгих чөлөө олгоогүй тул ухасхийн түрүүчийнхээс хурдлан давхив. Чэнь Жэнь хурдлан давхих зуур чоно зүлгэн дээр нэлээдгүй их мах гулгин гаргасныг олж харжээ. Түүнд улам ч балмагдан морио ташуурдан шавдуулав.

Чонын гэдсэнд чамгүй их мах үлдсэний дээр шинээр идсэн хоол нь энерги болон хувирч завдаагүй болохоор эцсийн хүчээ шавхан давхиж завдахгүй байгаа нь илт. Доржийн хурдан хүлэг чонотой бараг ижил хурдаар салахгүй дагах тул гэнэт чиглэлээ өөрчлөн талын чонын шийдсэн мэх болох эгц энгэрийг зүглэв. Гэвч хоньчин Санжаа уулын энгэрийн цаад талаас уурга гозолзуулан гарч ирээд чонын явах замыг тасалжээ. Чоно дагжин чичирч хэсэг зуур эргэцсэнээ ойролцоох хонин сүргийн зүг довтолголоо. Тэр хоньдын дундуур зүсэн хурдалж, уургач морь, уурганы хуйв хоёроос зайлах санаа төрөх юм гэж Чэнь Жэнь яахин санах билээ.

Гэвч чонын эргэлзэх агшинд Доржийн хурдан хүлэг эрчээ аван дөхөж, Санжаа ч хоньдын наагуур халхалж амжжээ. Чоно дахин чиглэлээ өөрчлөхийг завдах хооронд Дорж тонгосхийн уургаа сунгаад түүний богино хүзүүгээр уургалан авчээ. Чоно толгой сэжлэн мултрах гэхэд Дорж уурганыхаа хуйвыг чивчиртэл чангалаад хоолойг нь боож авав. Дорж чононд амьсгаа ч

авах завдал өгөлгүй мориныхоо амыг эргүүлэн чоныг чирэн давхилаа.

Чонын хоолой уурганы хуйванд чивчрэн боогдож амнаас нь цустай хөөс цахран хэлээ унжуулаад тэмцэх чадал үгүй болжээ. Дорж морио давиран эгц хэвгий өөд өгссөнөөр түүний байдал улам ч хэцүүдэв. Чэнь Жэнь чонын араас харахад хамаг бие нь салганан чичирч байхыг үзвэл амь тавихад ойртсон бололтой. Энэ удаагийн ослын хариуцлагаас мултрах шиг боллоо гэж бодоод тэр уужим амьсгаа авчээ. Тал нутгийн энгээр тэмцэж явсан том чоно хэдхэн минутын зуур ийнхүү амь тавьж байгааг хараад тэр сэтгэл догдолж яахин түвдэх билээ. Өршөөлгүй талын амьдран орших нөхцөл дэндүү хатуу чанга болохоор жаахан л алмайтсан бүхэн ийнхүү амиа алддаг буюу. Хэрвээ энэ чоно хүн байсан бол эр зориг эрдэм чадлынхаа хувьд яахин шигшигдэн үлдэх билээ гэж бодохоос түүний сэтгэл өөрийн өөрийн эрхгүй шимширнэ.

Уулын бэлийн дунд хавьд очиход чоно цустай хөөс сахруулан зовиуртай уухирдах боловч хөдлөх тэнхээгүй болжээ. Дорж мориноосоо үсрэн буугаад уурганыхаа ишийг өөр рүүгээ богиносгон татлаа. Тэгээд чоныг дэргэдээ ирэхэд гартаа зэхэн барьж байсан малиагаар толгой дундуур нь дэлсэж ухаан алдуулаад гутлын түрийнээс монгол хутгаа гаргаж ирэн чонын цээж рүү дүрлээ. Чэнь Жэньг мориноос үсрэн буухад чоно нэгэнт амь тавьжээ. Дорж чоныг хоёронтоо өшиглөж үзсэнээ толгойны хөлсөө шударчихаад газар суун тамхилж гарав.

Санжаа үхсэн чоныг харан Доржийн авхаалжтайг жаал магтсанаа түүний хонийг гэрийн зүг буцаан туулаа. Чэнь Жэнь ч өөрийн хонин сүргээ гэрийн зүг эргүүлчихээд буцаж ирэн Доржийн хэрхэн чоно өвчихийг харав. Зуны халуунд туламласан арьс муудах гэмтэй тул ердийн маягаар өвчиж дэлгэн хатаадаг юм. Чэнь Жэньг мориноос буухад Дорж чоноо өвчихөөд арьсыг зүлгэн дээр дэлгэн тавьсан байв.

Чэнь Жэнь “Би анх удаа чоныг уургалан чирч алахыг үзлээ. Чи өөртөө яагаад тийм итгэлтэй байв аа?” хэмээн асуухад Дорж нуг нуг инээгээд “Энэ ч жаахан алмай чоно юм гээч. Жаахан сэргэлэндүү чоно бол толгой сэжин уурганаас мултраад байдаг юм” гэв. “Чиний хараа ч мөн гайхалтай байна шүү. Над шиг хүн тав гурван жил сургуулилаад ч чиний энд хүрэхгүй байх аа. Ядаж миний унаа гэж надтайгаа таарсан амьтан юм. Хойтон хавар л олигтой хэдэн даага сургаж авахаас биш. Тал нутагт сайн морьгүй бол ч амбан явахгүй дэг шүү” гэхэд Дорж “Бат гэж хуурай ах чинь байхад тэр талаар юу алзах билээ” гэж хэлэв.

Чэнь Жэнь гэнэт Доржийн тэжээсэн бэлтрэг юу болж байгааг мэдэх санаатай асууруун “Ойрдоо ажил гэж дийлдэхгүй, танай бэлтрэгийг ч очиж үзэж чадахаа байлаа. Хүн харын хэл ам гайгүй шүү байна уу?” гэхэд

Дорж толгой сэгсрэн “Ярих ч юм биш ээ. Уржийн уржигдар цохиод алчихсан” гэв. Чэнь Жэньгийн дотор палхийгээд “Яалаа гэнэ ээ? Чи өөрөө түүний бодийг хөтлөчихөө юу? Яагаад тэр билээ? Юу болсон юм бэ?” хэмээн сандран асуулаа.

Дорж санаа алдаад “Би мэдсэн бол чам шиг урт гинжээр оосорлож байх хэрэгтэй байжээ. Манай бэлтрэг танайхаас давжаа биетэй номхондуу болохоор гөлөгнүүдтэй сар гаруй хамт байсаар дасчихсан юм. Таньж мэдэхгүй хүмүүс түүнийг гөлөг гээд ялгахгүй л дээ. Аандаа өсөж томроод овчарк нохойноос өөрцгүй болоход манайхан ч их сайн байдаг байв. Бэлтрэг

манай дөрвөн настай хүүхдэд дасаад сав л хийвэл хамт тоглож байдаг байлаа. Гэтэл уржийн уржигдар манай хүүтэй тоглож байгаад гэдсийг нь ураад хэсэг арьсыг нь сэнжлээд хаячихдаг байгаа. Хүүхэд ч айсан гэж жигтэйхэн уйлж унжаад сүйд боллоо. Чонын шүд нохойныхоос илүү хортой болохоор би ч айсандаа малиагаараа дэлсээд алчихсан. Тэгээд хүүгээ тэврэн Сяо Пэнгийн очиж хоёр тариа хийлгээд овоо уужраад байна. Харин хүүгийн маань гэдэсний хавдар буугаагүй байгаа шүү” гэлээ.

Чэнь Жэнь их л зовнигуй байдалтай “Санаа амарч болохгүй шүү. Хэдэн өдөр дараалан тариа хийлгэхэд ч гэмгүй. Галзуу нохойн өвчингөөс тариа хийлгэж байж л сэргийлж чадна” гэлээ.

“Малчид бид чинь нохойд хазуулахын төдийд л тариа хийлгэдэг улс чинь чононд хазуулчихаад яаж санаа амар байх билээ. Чоно ч нохойноос шал өөр амьтан юм аа. Нутаг нугынхан чоно тэжээж болохгүй гээд байдаг нь цаанаа учиртай юм байна шүү. Зан нь засрахгүй байсаар нэг муу юманд хүрч мэднэ. Танай бэлтрэг том биетэй догшин зантай тул шүд нь бүр ч хортой байж таараа. Тийм болохоор чи ч гэсэн түүнийгээ үгүй хийсэн нь дээр дээ. Уяатай гэж санаа амарч байгаад ноцуулчихвал амь насаа алдахыг ч хэн байг гэхэв” хэмээн Дорж хэллээ.

Чэнь Жэнь нэлээд айсан бололтой хэсэг зуур бодолхийлж байснаа “Арайхийж нэг юм өдий том болгочихоод үгүй хийнэ гэхээр хайран юм даа. Өөрөө л мэдээтэй байхаас. Анхнаасаа үзэж чаддаггүй байсан Гао Зянь Жун хүртэл түүнд дасчихаад өдөржин эрхлүүлэн тоглож байдаг болсон шүү” гэлээ.

Хонин сүрэг бүр холдсон тул Дорж арьсаа эвхэн эмээлийн урдуур тохчихоод морио унан гэрийн зүг хөдлөв.

Чэнь Жэнь чонын үлдээсэн хонины сэгэн дээр очоод хармаанаасаа эвхдэг тонгороого гаргаж чонын ам хүрсэн хэсгийг огтлон уушиг зүрхнээс бусад дотор эрхтнийг ялган хаялаа. Тэгээд үлдсэн хэсгээр нохдоо тэжээхээр ганзагалан гэрийн зүг явав. Тэр морины зөөлөн алхаанд гүн бодолд дарагдана.

Хоёрдахь өдөр Дорж хониор чоно сольсон дуулиан багийн хэмжээнд дуулдав. Бао Шүнь Гүй чонын арьсыг хүлээн аваад Доржийг амаа олохгүй магтахын хамт аж ахуйн захиргаанд мэдэгдэн гучин сумаар урамшуулан шагнажээ. Хэдэн хоногийн дараа гуравдугаар хэсгийн нэгэн залуу хоньчин хонин сүргээрээ өгөөш болгон чоно агнах санаатай нэлээд хол орхин оджээ. Гэтэл түүнтэй нэгэн хашир чоно тааран хонины өрөөсөн гуя хүртчихээд хурд хүч нь улам нэмэгдэн давхин одсон тул хөөж гүйцэхийн завдалгүй бараа туруугүй болсон байна. Билиг өвгөн багийн хурал дээр тэр хоньчныг зад загнан сар хонь нядлаж идэх эрхийг хасан шийтгэж билээ.

## Хорин хоёр

*Манж, дагуур, эвенк үндэстний зарим бөө нар хар чонын сахиулсаныг шүтмүй. Тэр нь эрэлхэг баатар ялагдашгүй байж, муу хүмүүн, муу хэргийг үхэн жигшиж, харгис муу, догшин самууныг дардаг бөөгийн хамгаалах сахиулсан буюу хавсрагч болой. Аливаа аюул түгшүүр зусар зальхай, шөнийн харанхуйд балмадлан түйвээх шулам чөтгөрийг бүр л түүний оюун билиг болон эрэлхэг баатарт түшиглэн харанхуй дотор сөнөөн устгамуй. Тэр хэдий галзуу чоно боловч ад чөтгөр, буг шулмын эрлэг болой.*

*Фү Юй Гуан “Бөөгийн тухай өгүүлэхүй”*

Чэнь Жэнь хонины ээлжтэй шөнө манаагаа Арсланд даатгачихаад гэртээ орж ном уншин, тэмдэглэл бичих боломжтой болдог. Тэр нөгөө хоёрыгоо тавгай унтуулах гэж явган ширээгээ үүдний дэргэд аваачин дэнгийн наагуур хоёр зузаан ном босгон халхалдаг юм. Аниргүй талд чонын улиан сонсогдохгүй болохоор гурван том нохой ч хуцалгүй чихээ сортолзуулан соргог манаанд зогсоцгооно. Тэр шөнө нэг л удаа гарч гар чийдэнгийн гэрэлд хонин сүргээ эргэхэд Арслан баруун хойд талыг холдолгүй манаж байх тул санаа амарчээ. Чэнь Жэнь Арслангийн толгойг илэн урамшуулав. Гэртээ орсон хойноо ч хажуулж түвдсэнгүй шөнө дундаас хойш хүртэл ном уншсаар сая нэг юм унтжээ. Удаах өдөр сэрэнгүүтээ түүний хийх ёстой хамгийн эхний ажил бэлтрэгээ хооллох явдал байлаа.

Шинэ нутагт нүүж ирсэн цагаас хойш бэлтрэг үүр цүүр болонгуут л ан отсон мэт монгол гэрийн үүдийг ширтэн оцойн суучихаад хоолоо хүлээдэг болжээ. Бэлтрэгийн нүдэнд идүүр нь амьд ангаас өөрцгүй тул тэр том чоно шиг завшааныг тэвчээртэй хүлээсээр байна. Тэгээд “Ан” нь нүдний өмнө дөхөн ирэхэд ухасхийн барьж аваад ам руугаа чихэхээ бодохоос биш эзний хишиг гэсэн ойлголт түүний хувьд үгүй юм. Ийнхүү бэлтрэг чонын унаган зангаа хадгалан үлдэж чаджээ. Чэнь Жэнь ч зориуд айсан маяг гарган хэд ухрах боловч үргэлж инээд алдчихна.

Өвөрмонголын талд бороошихын өмнө айхтар халдаг боловч өнөө жил онцгой халуун байлаа. Монголын нар эрт мандаж, нам өндөрт хөөрдөг болохоор арван цаг гэхэд л дотор газрын жин үд шиг халдаг юм болов уу гэж Чэнь Жэньд санагдана. Хурц нар гэрийн ойролцоох өвсийг голгүй болтол хатааж орхижээ. Шумуул хараахан гараагүй боловч махны өтнөөс томрон биежсэн батганууд зөгийн сүрэг мэт хүн малын өмнүүр ээрнэ. Батгана хүн малын толгой түрүү, ам хамар, шарх сорви руу дайрах буюу гэрт өлгөсөн нойтон маханд өтөө цацахыг санаархдаг. Хүн, нохой, чоно гурав байнга л толгой сэжин, гар сүүлээрээ түүнийг үргээх гэж тун яршигтай. Сэргэлэн цовоо анч Шар нүдний өмнөх батгана руу цахилан үсэрч амандаа зажлаад тургиж хаяна. Удаж төдөлгүй түүний эргэн тойронд тарвасны үрийн хальс мэт үхсэн батганууд хэд хэдээрээ хөглөрчээ.

Нарны хор улам шатахад халууны униар дэгдээд, хөндий тал тэр аяараа асар том тогоо ногоон цай шиг өвсийг хуурч байгаа мэт. Ноход монгол гэрийн хойд талын давчуухан сүүдрийг бараадан амаа ангайн аахилахад хоёр бөөрөн тушаа цүлхэлзэнэ. Арслан гэрийн сүүдэрт байхгүй байгааг үзээд хэдэн удаа нэрээр нь дуудахад ирэхгүй байгааг бодвол лав голын тийшээ сэрүүцэхээр явсан бололтой. Арслан шөнө үүргээ их хариуцлагатай биелүүлдэг болсон тул хүмүүс түүнийг зэрлэг нохой шиг үзэхээ аль хэдийн байсан бөгөөд үүр цайж

“Алба дууссаны дараа” түүнийг тоох хүн үгүй тул анч Шар, Ирвэс нартай адил гэрийн буг болоод үлдэхгүй өөрийн тааваар хүссэн газар руугаа яваад өгдөг юм.

Энэ мөчид бэлтрэг л хамгаас их хэцүүдэж байлаа. Төмөр гинжнээс уягдаад халхлах зүйлгүй түүнийг хортой нар заналтай нь аргагүй төөнөнө. Бэлтрэг чонын хүрээн доторх өвсийг гишгэж талхалсан тул улаан халцгай газар улан дороос нь хайруулын таваг мэт хайрна. Хөөрхий бэлтрэг чихэрлэж шарсан туулайн бөөр тосгүй тогоонд түлэгдээд хагарах гэж байгаа мэт өрөвдөлтэй. Зоргоор явах эрхээ хасуулсан тэрбээр элчилгүй наранд өдөр болгон төөнөгдөж давхар ялыг амсана.

Гэрийн хаалга онгойх бүрт ухасхийн хойд хоёр хөл дээр цоройхдоо хоолой нь боогдон хэл нь булталзаад урд хоёр хөл нь сарваганах ажээ. Энэ тэсвэрлэшгүй хүнд нөхцөлд түүний хувьд сүүдэр, уснаас илүүтэй хоол л чухал мэт. Хоолыг тэнгэр мэт дээдэлдэг бэлтрэг энэ хэдэн өдрийн халуунд идэш нь багасах биш харин ч ихэссэн мэт Чэнь Жэньд санагдах болов. Бэлтрэг идүүрээ өөрийн тойрогт тавиач гэсэн мэт цоролзоно. Тэгээд идүүрийг ухасхийн өөрийн болгож авуугаа Чэнь Жэньг үлдэн хөөгөөд явуулчихдаг.

Чэнь Жэньд нэг хэцүү асуудал тулгарав. Зуны улирал болонгуут тал нутгийн заншлаар малчид цагаан идээг түлхүү хэрэглэн, улаан идээний хэрэглээ эрс багасдаг. Өглөөний цай, оройн хоолон дээр чанасан мах үзэгдэхээ болино. Гурилан боов, нарим будаа, хуурсан будаа, ааруул, бяслаг, шар тос, өрөм зэргийг голчлон хүнсэндээ хэрэглэнэ. Малчид зуны цагт цагаан идээгээ эрхэмлэдэг бол илгээлтийн эздийн хувьд тэр амаргүй даваа байлаа. Юуны өмнө махны оронд цагаан идээ идэж сурах хэцүүгээс гадна түүнийг бэлдэнэ гэдэг тун амаргүй ажил. Үүр цүүр, үдшийн бүрийгээр хэдэн цаг үнээ сааж авсан сүүгээ хөөрүүлэн боловсруулж, шахаж, зүсэн, хатаах гээд гар ажиллагаа маш их. Илгээлтийн эздийн хувьд цагаан идээ бэлдэх гэж үйлээ үзэж байснаас нарим будааны зутангаа чанаж, махгүй ногоотой шөл, бууз, банш, хуушуур зэргээ хийж идэж байх нь хамаагүй амар санагдана. Зуны улиралд малчид цагаан идээгээ бэлдэхэд илгээлтийн эзэд зэрлэг сонгино, агь, хөмүүл, таана, мангир, шар цэцэг, багваахай цэцэг болон халгай түүж иддэг. Мах магнаг болсон энэ цагаар малчид илгээлтийн эзэд бүгдээр хоолны бүтэц найрлагаа өөрчлөх нь сонин байж мэдэх боловч Чэнь Жэнь бэлтрэг хоёр л хамгийн ихээр хэцүүдэх болов.

Зун малчид хааяахан хонь мал гаргадаг ч хэт халуунд өт батгана шаваад амархан бээж муудах гээд байдаг. Малчид хааяа нэг нядалсан малын махаа хоёр хуруу бүдүүн зүсээд ялаа өт цацахаас сэргийлэн гурилд дүрж сэрүүн газар дүүжилж хатаадаг. Тэгээд орой болоход хоёр годгор мах хөшиглөн хоолондоо хэрэглэнэ. Харин уйлагнасан усан бороо хэдэн өдөр дараалан шавшчихвал хатаасан мах амархан бээж муудаад, өтөнд идэгдэх энүүхэнд. Зун бол хоньдын усан тарга авдаг үе бөгөөд намар залгуулан тосон тарга авахуулах хэрэгтэй. Энэ хоёр тарга гүйцээгүй зуны хонины өөх тос тааруу, амт сулхан байдаг тул малчид ч тийм махыг төдийлөн таашаадаггүй юм. Түүнчлэн ноосыг нь хяргасан зуны хонины арьс олигтой үнэ ханш хүрдэггүй тул элдээд хавар намар өмсөх сармай дээл хийж болно. Зун хонь нядлах тун гарлагатай даа. Малчид зун хонь нядалдаггүй нь тариачид хавар тариа ногооны чихийг огтолж иддэггүйтэй агаар нэгэн адил хэмээн Билиг өвгөн ярьдаг.

Олонбулгийн тал хэдийгээр хүн ам цөөхөн, мал сүрэг олонтой боловч тухайн үеийн бодлого малчдыг дураараа мал нядлахыг зөвшөөрдөггүй байв. Тос усны хомсдолтой, махыг хэмжээтэй

хуваарилдаг байсан хятад оронд нэг хонь гэдэг тун үнэтэй амьтан байж билээ.

Намар, өвөл, хаврын турш махаар халгиж байсан илгээлтийн эзэд, цагаан идээнээс өөр идэх юмгүй суучихаар арга мухардан харж үзэхийг гуйхаас өөр аргагүй болно. Тэгээд хэсгээс хонь нядлах зөвшөөрөл хүсэхэд батлаж өгөхгүй. Галсмаа Чэнь Жэньг гэрт нь очих болгонд тас тас хөхрөн нойтон өрөм, элсэн чихэртэй хуурсан нарим будаатай хольж амыг нь таглаад буцахад уут дүүрэн цагаан идээ өгч хонь нядлах хүсэлтийг нь аргалаад явуулна. Хааяа нэг зарим хэсгийн илгээлтийн эзэд ганц хонь цохуулж авахаараа өрөөл махыг нь бусад хэсгийнхээ залууст амсуулж махсааг дарах боловч тэр хэрээр айлуудын годгор борц улам багассаар байх ажээ.

Хүн ч яахав болдог юм гэхэд бэлтрэг гэж хэцүү амьтан гарч иржээ.

Энэ өдөр Чэнь Жэнь бэлтрэгний ходоодыг нэг үнэр орсон годгор махаар аргалаад хоосон идүүрийг нь гэртээ авч орон арга бодов. Тэр цай уух зуураа тогоонд хэдэн хэрчим борц хөвөхийг харж хэсэг зуур эргэлзсэнээ түүнийг авч бэлтрэгний идүүрт хийчихэв. Бэлтрэг нохойтой адил махгүй шар будааны зутан шөлийг тоож шиншлэхгүй, ядаж яс ч гэсэн хийхгүй бол дороо тонгочин төмөр гинжээ хазлаад байдаг юм.

Чэнь Жэнь хоёр аяга борцтой шөлийг давсалсан жууцайгаар даруулж идээд үлдсэнийг нь бэлтрэгний идүүрт хийж борцыг нь ил гартал хутгав. Тэр идүүрийг үнэрлэж үзвэл махны үнэр төдийлөн ханхлахгүй тул дэн барих зориулалттай өөхөн тосноос бага зэргийг хийж хутгалаа. Зуны халуунд савтай өөхөн тос хайлж хуршсан нь бээж ялзарсан маханд дуртай чонын хувьд таатай хэрэг болжээ. Ян Кө тэр хоёр манаанд гарахдаа ном унших гэж нөөцөлсөн хоёр сав өөхөн тос намар болтол тэсэх үү гэдэг нь эргэлзээтэй. Чонын ходоодыг борлуулахын тулд ном унших үнэт цагаасаа хумслахаас өөр яах билээ. Гэвч тэр ном уншихгүй байна гэдэг худал тул цагаа болохоор нүүрээ улалзуулаад Галсмаагаас бадар барьдаг байх даа. Билиг өвгөн Галсмаа хоёр тэдний ном уншдаг дэнгийн тос барагдсан гэдгийг дуулвал аль байдгаа тэмрэх нь лавтай. Зуны ажил барагдахгүй болохоор тэр өвгөнд түүхэн үйл явдлыг ярьж, түүнээс холбогдох үлгэр домог сонсдог нь ч цөөрсөн юм.

Чэнь Жэнь вааран савнаас том халбага өөхөн тос халбагадаж идүүрт хийж хутгав. Тэр үнэрлэж үзвэл хуршсан тос ханхийх нь чонын амтат хоол бэлэн болсныг батлана. Мөн зэс тогоотой шар будааны өтгөн зутанг нохойн идүүрт хийсэн боловч өөхөн тос хийж төвдсөнгүй. Зуны улиралд мах магнаг болохоор талын ноход өлөн зэлмүүхэн өдөр хоногийг өнгөрөөдөг.

Үүдээр гарахад ноход шавааралдан хүлээнэ. Чэнь Жэнь эхэлж нохдыг хооллож, идүүрээ гялалзтал долоосны хойно гэрээсээ хоолыг нь авч бэлтрэг рүү дөхөн очив. Тэр ийн явах зуур дадсан ёсоор “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн хашгирахад цаадахь нь өөрийгөө боомилох нь холгүй үсчин цовхчих ажээ. Чэнь Жэнь идүүрийг чонын тойрогт орхичихоод хэдэн алхам ухран бэлтрэг борцтой гурилтай шөлийг хэрхэн идэхийг ажиглан зогсов. Бэлтрэг энэ удаагийн хоолонд тун сэтгэл хангалуун байгаа нь илт.

Чэнь Жэнь өөрийнх нь тэжээж өсгөсөн ачлалыг бэлтрэг марталгүй, адаглаад л өөрийг нь үнэн сэтгэлээс хайрладаг хүмүүн төрөлтэй анд нөхөр нь юм шүү гэдгийг мэдүүлэх гэж хооллох болгондоо нэрээр нь чанга дууддаг юм. Алсдаа тэр эхнэр хүүхэдтэй болохоор төрсөн

үрсдээ ийм халамжтай байж чадах болов уу ч гэж хааяа эргэлзэх үе бий. Балар ойд хүний орхисон улаан нялзрай үрийг хөхүүлэн өсгөж өөрсөдтэйгээ ижилсүүлж чаддаг чононд ямар нэгэн татах увдис бий гэдэгт тэр хатуу итгэнэ. Хэрвээ хүн чонын төрлийн хүрээ хязгаараас гаталсан ямар нэгэн далд увдис үгүй бол тийм гайхамшигтай “Домгууд” яахин буй болох билээ. Чэнь Жэнь чоно гэжээж эхэлсэн цагаас хойш домог үлгэр мэт хүсэл мөрөөдөл дунд байнга умбан явах болжээ. Тэр дунд сургуульд байхдаа Зөвлөлтийн нэгэн зохиолчийн чонын тухай зохиолыг уншиж байсан юм. Түүнд өгүүлснээр нэг анчин шархтай чоныг эдгээгээд ойд нь тавьж явуулжээ. Хожим нэг өглөө хаалгаа нээгээд гартал гэрийн үүдэнд нь долоон үхсэн туулай орхичихоод цааш одсон чонын мөр цасан дээр дурайж байсан гэнэ. . . . . Энэ бол түүний урьд өмнө чонын тухай үзэж сонсож байсан ном зохиолоос тэс өөр хүн чоно хоёрын үерхлийг өгүүлсэн анхны зохиол байлаа. Бусад ном зохиолуудад чоно шиг хадам эх, хурга барьсан чоно, чоно хүүхдийн гэдэс хүү татсан тухай л өгүүлдэг. Тэр ч байтугай Лү Сюнь хүртэл тэр уламжлалаас гарч чадалгүй чонын хатуу харгисыг бичсэн билээ. Тийм болохоор мань хүн тэр зөвлөлтийн зохиолын амтанд орж өнөө хэр мартаж чаддаггүй юм. Тэр анчин болчихоод хунгар цас туучин балар ойд очин чонон андуудтайгаа цасан дээр ноцолдон тоглож, том чоно хөлөглөчихөөд цасан талаар дүүлэн нисэж байгаагаар байнга төсөөлөн бодох дуртай. . . . .

Харин тэр одоо алгаараа тэмтэрч, алагаараа харж болохуйц жинхэнэ чонон андтай болжээ. Тэр бэлтрэгээ цаггачих л юм бол зүлгэн дээр өнхрөн ноцолдох бүрэн боломжтой бөгөөд хэдэн ч удаа тэгж үзсэн билээ. Энэ бол түүний мөрөөдлийн зөвхөн хагас нь бөгөөд бэлтрэг том болохоороо баахан эрлийз гөлөгнүүд үлдээчихээд талын чонон сүрэгтээ очиж нийлээсэй гэдэг мөрөөдлийнхөө нөгөө хагасыг төсөөлөхөөс ч айдаг юм. Чэнь Жэнь сүрэг овчарк дагуулчихсан морио унан талын гүнд очоод “Бэлтрэг ээ, хоолондоо, би ирлээ шүү” хэмээн дуудахад харуй бүрийн дундаас ган төмөр шиг хөх туяа цацруулсан барс шиг лужир азарган чоно ижил сүргээ дагуулан эзэн лугаа удаан уулзаагүйг санагалзан ульсаар гарч ирлээ гэж хүртэл зүүдлэж байсан удаатай. Гэвч анч ноход, хурдан буу, хуйвтай уурга бүхий анчид олонтой тал нутаг гэдэг аглаг ой биш болохоор бэлтрэг өсөж том боллоо ч гэсэн долоон туулай барьчихаад түүний гэрийн үүдэнд авчирч орхино гэдэг юу л бол. . . . .

\* \* \*

Хэдийгээр Чэнь Жэньгийн элэнц эцэг жинхэнэ тариачин гаралтай хүн боловч өөрийнх нь цусанд нүүдэлчдийн цусны хольц шингээстэй болохыг тэр олж мэджээ. Хэрвээ тэр жинхэнэ суурьшмал үндэстний үр хойч, хятадын Күнзийн сурталт жижиг тариачны удам байсан бол бодит байдал, бодит хэрэглээ, бодит ашиг зэргийг эрхэмлэхээс бус, хий хоосон мөрөөдөлд умбахыг жигшин үзэх учиртай байхсан. Чэнь Жэнь мөрөөдлийнхөө хагасыг биелүүлсэн боловч хүсэл сонирхол, эр зоригтоо дулдуйдан биелүүлэхэд бүр ч амаргүй нөгөө хагаст хүрэхсэн. Тал нутаг өөрийнх нь дарагдаад удсан мөрөөдөл хүсэл болон адал явдлыг ангуучлах үзэл санааг өдөөн дуудаасай гэж тэр үнэн голоос хүсдэг байв.

Бэлтрэг идүүрээ мөлийтөл долоож орхив. Тавин сантиметр гаруй томорсон бэлтрэг цадсаны хойно улам ч сүр жавхаа нэмээд ижил чацуу гөлөгнүүдээс хагас тохой өсгөлүүн болсон харагдана. Тэр идүүрийг гэрийн үүдэнд буцаан тавиад чонын тойрогт эргэн ирж бэлтрэгний хүзүү сээрийг илж таалах учиртай. Чэнь Жэнь бэлтрэгийг хэсэг тэвэрч сууснаа өвөр дээрээ

дээш харуулаад гэдсийг нь илж гарав. Тал нутагт чоно нохдын тулалдааны явцад нэг л хүү татуулах юм бол гарцаагүй үхдэг тул гэдэс гэдэг хамгийн эмзэг амин газар байдаг. Тийм болохоор чоно ноход өөрийн итгээгүй өөр төрөлтний өмнө гэдсээ ил харуулна гэж огт үгүй юм. Хэдийгээр Доржийн бэлтрэг хүүг нь хазчихсан боловч Чэнь Жэнь өөрийн бэлтрэгтээ хуруу гараа долоолгон хазлуулж байв. Бэлтрэг өөрийн ахан дүүстэйгээ ноцолдож байгаа мэт түүний хуруу гарыг өвгөн цусыг гоожуулалгүй хазлана гэдэгт ч тэр мөн итгэдэг. Жаахан бэлтрэг өөрийн гэдсийг түүн рүү ил харуулж байхад тэр хуруу гараа зөөлөн ноолуулж яагаад болдоггүй байх билээ. Тэр чонын харцнаас итгэл, үерхлийг олж харав.

Жин үд ойртоход талын хурц нар өвсөн толгойг хуйхлам шарж эхлэлээ. Бэлтрэг халуунд үйлээ үзэж байгаа бололтой амаа ангайн шүлсээ гоожуулан аахилна. Чэнь Жэнь гэрийн хаяагаа сайн шуучихсан болохоор асар том шувууны тор шиг салхи нэвтрээд сэрүү татна. Тэр гэртээ ном унших зуур бэлтрэгт туслах эсэхээ шийдэж ядаад байн байн түүн рүү харж байлаа. Талын чоно угаас хагуу ширүүн уур амьсгалаас халширч байсан удаагүй. Хахир өвөл, халуун зуныг давж чадахгүй бол яахин энэ нутагт оршин амьдарч чадах билээ дээ. Гэвч халуун зун чоно хадны нөмөр сүүдэр барааддаг байж таарна. Зуны халуунд хоньдоо сэрүүн газар бараадуулахаас өмнө өвсөн дунд бүгсэн чоно байгаа эсэхийг сайтар үзэж байгаарай гэж Билиг өвгөн захидаг биш үү.

Тэр бэлтрэгийг яаж сэрүүцүүлэх аргаа мэдэхгүй боловч эхлээд түүний халуунд хэр зэрэг тэсвэртэй болохыг туршиж үзэхээр шийдэв. Монгол гэрийн хаяагаар халуун салхи нэвчиж, үхэр сүрэг идэшлэхээ болиод голын эрэг бараадлаа. Алсад бэлчих хонин сүргүүд салхи сөрөн хэвтэцгээнэ. Уул толгодын оройгоор гурвалжин цагаан “Майхнууд” босоцгоожээ. Хоньчид шилбүүрнийхээ ишийг тарваганы нүхэнд ташуу хатгаад үзүүрт нь дан тэрлэгээ тайлж унжсан хормойг нь хоёр чулуугаар даруулаад энэхүү түр сүүдрэвчүүдийг босгодог. Түүний сүүдэрт их тааламжтай байдгийг Чэнь Жэнь ч мэдэх юм. Тийм майхны дор хоёр хоньчин сэрүүцэн, нэг нь унтаж нөгөө нь хоньдоо харж байдаг билээ. Тийм гурвалжин цагаан майхан тал нутгийн хамгийн халуун үед л гарч ирдэг. Чэнь Жэнь аажимдаа сууж чадахаа байлаа.

Бэлтрэг халуунд байж ядахдаа зогсож, хэвтэж чадахгүй байгаа бололтой. Халцгай газар халуун илчээр төөнөхөд бэлтрэг дөрвөн хөлөө ээлжлэн өргөж, ийш тийш харсаар нэгэн гөлөг үхэр тэрэгний сүүдэрт тайван дугжирч байхыг хараад тэчъяадан гинжээ харжигнуулав. Чэнь Жэнь гэрээс гарахад бэлтрэг үнэхээр чихэрлэж хуурсан туулайн бөөрийн самар шиг болцойсныг үзээд наршчих юм бол аж ахуйн малын эмч чоныг яасан ч эмчилж өгөхгүй гэж бодлоо. Тэгээд яадаг хэрэг билээ? Тал нутагт салхи ихтэй болохоор цув өмсөнө үү гэхээс биш, шүхэр хэрэглэдэггүй. Нэг үхэр тэрэг түрээд авчирчихвал гинж нь хүрдэнд орооцолдоод боомилоод үхчихвэл яах вэ? Бэлтрэгэнд гурвалжин майхан босгоод өгчихье гэтэл түүнийг харсан зарим хүн “Ангийн дайсантай амь нэгдлээ” гэвэл юу гэж хэлэхэв. Тэгвэл бэлтрэг тэжээхийн эсрэг байсан малчид, илгээлтийн эзэд бүгд түүн рүү хоморголон дайрах биш үү? Тэгээд ч хүмүүс ажилдаа улайраад бэлтрэгийг жаахан мартагнаж байгаа үед түүнийг дахин сануулахаар үйлдэл хийж яахин болох билээ.

Чэнь Жэнь модон хувингаас цэв хүйтэн ус идүүрт нь хийгээд аваачиж өгвөл бэлтрэг нэгэн амьсгаагаар долоон ууж орхилоо. Дараа нь Чэнь Жэньгийн сүүдэрт хоргодон хортой нарнаас зайлсхийв. Тэр өнчин хүүхэд мэт өрөвдмөөр хөлийг нь дэрлэн явуулах санаагүй нь илт. Чэнь



Жэнь жаахан зогстол ар шил нь хорсон түлэгдэх янзтай. Тэр тэндээс холдон хагас хувин ус авчирч чонын хүрээнд цацахад халцгай газар халуун жигнүүр мэт уур савсуулав. Хэдэн ч цаг хөл дээрээ зогссон бэлтрэг гадрагын халуун буурсныг үзээд хэвтэж амарлаа. Гэвч удаж төдөлгүй халцгай газар хатаж халаад бэлтрэг дороо эргэцэж эхлэв. Чэнь Жэнь үнэхээр арга тасарч орхив. Тэр байн байн ус цацаад байя гэтэл хонины хишигтэй өдөр яах болж байна вэ?

Чэнь Жэнь гэрт ороод бэлтрэг нь наршиж үхэх вий гэж санаа зовох тул ном ч унших сөхөө байсангүй. Бэлтрэгийг уяж сургасан нь хүн малд аюулгүй болсон боловч амь насанд нь халтай хэрэг болжээ. Хэрвээ суурьшмал газар чоно тэжээсэн бол ядаж ханын сүүдэр бараадуулаад уяж болохсон. Арай нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд чоно тэжээх арга үнэхээр байдаггүй юм биш байгаа даа. Ядаж Билиг өвгөн хүртэл чоно тэжээж үзээгүй тул хэнээсээ энэ талын туршлага судлах билээ.

Чэнь Жэнь бэлтрэгийг ажин тархиа гашилгах боловч олигтой арга ердөө олсонгүй.

Бэлтрэг ч халцгай хүрээндээ эргэцэх зуур арга сүвэгчилж байгаа бололтой. Тэгсээр тэр халцгай хүрээний гаднахь өвс арай жийрэгтэй санагдсан уу, биеийг буруу харуулан хойд хөл, их биеэрээ өвсөн дээр хэвтэхэд толгой урд хөл нь тойрог дотор үлдлээ. Гинж хэдийгээр хүзүүг нь эрчлэн чангаах боловч бэлтрэг жаахан амсхийв бололтой. Хурц нар ар зооноос хайр найргүй шарах боловч дороос төөнөх халууны илч хамаагүй буурчээ. Бэлтрэгний энэ ухаалаг үйлдэл түүнд найдлага төрүүлсэн болохоор Чэнь Жэнь түүнийг үнсээд авмаар санагдлаа. Халуун улам шатахаар хэд хоноод л бэлтрэгний шонгийн байршлыг сольж өгч байх хэрэгтэй юм байна гэдгийг тэр ойлгожээ. Эхийн нөмөр нөөлөггүй бэлтрэг өөрт тулгарсан асуудлыг ийм ухаалгаар шийдвэрлэж байхад сүргийн дунд өссөн чононууд ямар байх нь ойлгомжтой. Чонын оршин амьдрах чадвар хүний төсөөлж байснаас ч хавьгүй илүү юм гэдгийг Чэнь Жэнь бахдан биширч байлаа. Тэр хөнжлөө түшин ном уншиж эхлэв.

Гэрийн гадна морин туурай тачигнаж хоёр морьтон гэрээс хорь гаруй метрийн зайтай давхицгаалаа. Чэнь Жэнь ч адуучид байх шиг байна гээд нэг их тоосонгүй. Гэтэл хоёр морьтон замаас гажин шулуухан чонын хүрээг чиглэн очиход бэлтрэг айсандаа гинжнээсээ чаргуулдан цахлав. Түрүүнд явсан морьтон бэлтрэгийг уургалж аваад огло үсэртэл огцом татлаа. Уурганы ширүүн таталт бэлтрэгний амийг авахаар байсан боловч төмөр гинжинд тээглэн хүзүүг нь арай таслалчсангүй. Бэлтрэг газар саван унахад ард нь байсан адуучин уурганыхаа үзүүрээр түүнийг годройттол ширвэлээ. Урд байсан этгээд малиагаа гартаа барин мориноос буухаар зэхэв. Чэнь Жэнь айсандаа чанга хашгиран гурилын ганжингаа шүүрэн аваад шуугин очлоо. Нөгөө хоёр хүн түүний яахаас ч буцахгүй байдлыг хараад морио ташуурдан тоос манаргасаар давхин оджээ. Тэдний нэг нь эргэн хараад “Унага барьдаг муухай амьтныг тэжээнэ гэнэ ээ. Би хэзээ нэгэн өдөр наадхийг чинь заавал ална даа” хэмээн хашгирлаа.

Анч шар, Ирвэс хоёр тэдний араас дайраад уурганы бөгсөөр ширвүүлэн үлдэв. Хоёр морьтон адуун сүргийн зүг довтолгон оджээ.

Чэнь Жэнь тэр хоёрын чухам хэн болохыг таньж чадаагүй боловч нэг нь Билиг өвгөнд шийтгүүлдэг хоньчин, нөгөө нь дөрөвдүгээр хэсгийн адуучин залуу байх шиг санагджээ. Тэдгээр ширүүн дориун залуус бэлтрэгний амийг авахаар шийдсэн нь илэрхий. Монголын

морин цэргийн аянга мэт ширүүн дайралтын горьг Чэнь Жэнь ийнхүү өөрийн биеэр мэдрэв.

Чэнь Жэнь бэлтрэгний дэргэд явж очвол цаадахь нь сүүлээ хавчин дөрвөн хөл дээрээ зогсож чадахааргүй бөмбөгөнөн чичирнэ. Тэр Чэнь Жэньг хараад муурын савраас амьд үлдсэн дэгдээхэй том тахиаг бараадан ирэх шиг налмагасхийн уналаа. Чэнь Жэнь ч түүнийг чичирсэн гараараа тэврэн авахад хүн чоногүй дагжицгаана. Тэр бэлтрэгний хүзүүг илж үзвээс айхтар гэмтчихээгүй боловч уурганы хуйвны мөрөөр цусан гувруу үүсжээ. Бэлтрэгний зүрх түг түг цохилох бөгөөд Чэнь Жэнь аргадаж илэхийг хослуулан, арайхийж хоёулангийнхаа чичрээг намжаалаа. Тэр гэртээ орж ганц годгор мах гарган бэлтрэгийг тайвшруулав. Бэлтрэг махаа идэж дууссаны дараа Чэнь Жэнь түүнийг тэврэн нүүрийг нь цээжиндээ наагаад сэрвээг нь иллээ. Бэлтрэг айсан байдалтай Чэнь Жэньг харж байснаа гэнэт түүний эрүүг долоож эхлэв. Бэлтрэг түүнийг хоёрдахиа долоон анх удаа талархал илэрхийлж байгаа нь энэ тул Чэнь Жэнь ёстой л хайрыг үзээд халгана гэгч болов. Чоно амийг аварсан ачтандаа долоон туулай агнаж талархал илэрхийлсэн тухай домог зохиомол зүйл биш бололтой.

Гэвч түүний тувт санаа зовниж байсан хэрэг биеллээ олж эхлэхийг үзээд сэтгэл нь хүндрээд явчихлаа. Олонх малчид түүний чоно тэжээх болсонд төдийлөн таатай хандахгүй зай барих болсон төдийгүй Билиг өвгөн хүртэл тэднийхээр тоотой орж гарах болсныг тэр мэдрэх болсон юм. Малчдын хувьд тэр Бао Шүнь Гүй болон гадны хар ажилчдаас өөрцгүй тал нутгийн дэг ёсыг эвдэгч болон хувирчээ. Чоно хэдийгээр нүүдэлчин үндэстний оюун санааны сүлд шүтээн боловч махан бодийн хувьд харгис хэрцгий дайснаас нь өөрцгүй юм. Оюун санаа болон махан бодийн аль ч талаас авч үзсэн тал нутгийн малчид чоно тэжээхийг зөвшөөрдөггүй. Тийм болохоор тэр чоно тэжээсэн нь оюун санааны хувьд гутамшиг, махан бодийн хувьд дайсантай нөхцсөнөөс өөрцгүй хэрэг болжээ. Тэр өөрөө ч тал нутгийн тэнгэрлиг ёс, нүүдлийн соёлын хориг цээрт халдсанаа ухаарч байлаа. Чэнь Жэнь бэлтрэгийг хамгаалж чадах эсэх, чоныг цаашид тэжээх ёстой үгүйг хүртэл мэдэхээ байжээ. Гэвч тэр тал нутгийн амин сүнс болсон чонон сүлдийн нууц, үнэ цэнийг сурвалжлан тэмдэглэж үлдээхийг үнэн голоосоо хүсэх тул хятадын төдийгүй дэлхийн түүхэнд асар их нөлөө үзүүлсэн чонон сүлд аажмаар үгүй болж байгаа тал нутгийн нүүдлийн амьдралтай хамт устаад чонын амаар дамжин ариусдаг монгол хүний цогцос шиг үзэгдэх бараагүй болохыг харж яахин төвдөх билээ. Энэ магадгүй хамгийн сүүлчийн боломж байж мэдэх тул Чэнь Жэнь өөрийн үзэл бодолд үнэнч байж “Чонон шүдийг” тас зуун, зүтгэхээр хатуу шийджээ. Тэр Арсланг хайсан боловч эргэж ирээгүй л байлаа. Хэрвээ тэр гэртээ ойр байсан бол өөрийн хэсгийн малчдаас бусад нь тэдний хотонд ийн аймшиггүй халдаж зүрхлэхгүй юмсан. Арслан байсан бол танихгүй хүмүүсийн морьдыг дахин наашаа зүглэхгүй болтол хашраагаад өгөх байсан нь лавтай. Саяын хоёр морьтон Арсланг гэртээ байхгүй байгааг анаж мэдээд наашаа дайрсан болохыг тэр анзаарав.

Нар туйлдаа хүртэл халж гүйцээгүй боловч хотгор өөртөө хураасан хамаг илчийг тэр аяар бэлтрэгний бяцхан хүрээнд овоолчихсон мэт. Бэлтрэг хэдийгээр дороос төөнөх халууны асуудлыг шийдэж чадсан боловч сая шархдсан хүзүү нь халцгай тойрогт үлдээд шаналгаж байгаа бололтой босож хэд тойроод дахин жаахан хэвтэнэ.

Чэнь Жэнь тайван ном уншиж болохгүй тул босож гэрийн ажил хийж эхлэв. Тэр жууцай

хэрчин, нугасны өндөгтэй холиод гурил зуурч хуушуур хийсээр хагас цагийг ардаа орхив. Тэгсээр толгой өргөн бэлтрэгийг хараад тэр бүр алмайрч орхижээ. Бэлтрэг бөгсөө оцойлгочихоод тоос шороо манарган нүх ухаж байлаа. Чэнь Жэнь гараа арчихаад гэрээс гүйн гарч чонын хүрээний ойролцоо явган суугаад ажиглаж эхэллээ.

Бэлтрэг хүрээний өмнө талд сүүлээ годгонуулан биеийн доогуур шороо манарган зайлуулсаар цээжин биеийг далдартал нүх ухаж амжсан байлаа. Хэсэг азнаснаа бэлтрэг нүхнээс гарч ирээд урд хоёр хөлөөрөө ухсан шороог тэврэн хойш зайлуулна. Хамаг бие нь шороонд дарагдсан бэлтрэг Чэнь Жэньг ширтэн харахад түүний харцанд араатанлаг шинж, догдлолоос гадна алт мөнгөний уурхай олсон мэт шунамхайрал дүүрэн тодров.

Бэлтрэг арай модон шонг ухаж унагаад сэрүүн газар бараадах гэсэн хэрэг биш биз дээ гээд бодтол түүний ухсан байршил биш болж таарав. Бэлтрэг модон шонгийн харалдаа дор ухаагүй, ухаад ч тийм гүн шонг яаж унагах билээ. Харин тэр хүрээнийхээ чанх урд талд шон руу нуруугаа харуулан нарны гэрлийн чанх эсрэг ухаж байв. Чэнь Жэнь бэлтрэгний санааг ойлгоод тэсгэлгүй баярлажээ.

Бэлтрэг нүхнээс зөндөө сул шороо ухан гаргаад аахилан гадагшлуулсанаа дахин дотогш ухсаар байлаа. Түүний хоёр нүд байдгаараа гялалзан Чэнь Жэньг тоох ч сөхөө алга. Чэнь Жэнь тэр бүгдийг харсаар эцэстээ тэсгэлгүй “Бэлтрэг минь, тайван ух даа. Хөлөө гэмтээчих вий” гэхэд бэлтрэг түүн рүү хяламхийн хараад нүдээ тааламжтай анивхийлэх нь өөрийн энэхүү үйлдэлд дотроо маш маадгар байгаа бололтой.

Нүхнээс ухан гаргасан шороо амь чийгтэй тул халцгай газраас хавьгүй сэрүүн байж мэднэ. Чэнь Жэнь атга шороо авч үзвэл нээрэн ч чийгтэй бүлээн байлаа. Бэлтрэг нарны халуун хүний хөнөөлөөс амиа хоохойлох нүх ухдаг нь мөн ухаантай байна шүү хэмээн Чэнь Жэнь бодов. Нүхний байршлыг хүртэл оновчтой сонгон хүрээний өмнө талд амыг хойшоо харуулан ухсанаар чийгтэй сэрүүн байдлыг хадгалж чадахаар болжээ. Тэгээд ч нүх ухаж байх хооронд хортой нар түүний цээжин биеийг төөнөж чадахгүй ажээ.

Бэлтрэг гүнзгийлэн ухах тусам нарны илч улам буурна. Тэр харанхуйн баяр баясгаланг амсаад өөрийн зорилгодоо дөтлөж байгаа бололтой. Харанхуй гэдэг чонын хувьд сэрүүн, аюулгүй болоод амар жаргал байдаг ажээ. Тэр одоо дахин нүсэр том үхэр, адуу, хүний халдлага дайралтанд өртөхөөргүй боллоо. Чоно ингэж бодсон бололтой улам ч эрчтэй ухаж гарав. Дахин хорин минут өнгөрөхөд нүхний гадна чонын сагсгар сүүл годгонохоос биш их бие нь тэр аяараа нүхэнд далдлагдсан байлаа.

Чэнь Жэнь чонын ер бусын оршин амьдрах чадвар болон арга ухааныг биширч гүйцэв. Тэр хятад ардын “Луунаас луу л төрдөг, гарьдаас гарьд л гардаг, оготны зулзага нүх ухаж чаддаг” гэсэн зүйр үгийг өөрийн эрхгүй санажээ. Оготны зулзага адаглаад аав ээжээсээ нүх ухахыг сурдаг байлгүй дээ. Гэтэл нүдээ нээгээгүй байхдаа эхийн халуун өврөөс салсан энэ бяцхан амьтан хэнээсээ нүх ухахыг сурах билээ. Ядаж түүний эргэн тойронд байгаа ноход нүх ухаж чаддаггүй. Тэгвэл чононд нүх ухах ухааныг хэн зааж өгсөн байж таарах вэ? Тэр тусмаа нүхний байршил, чиг болон хэмжээ дамжааг ийм гайхалтай сайн олдог байна шүү. Хэрвээ шонгоос хэт хол ухсан бол гинж түүний ажиллахад маш тээртэй байхсан. Гэтэл бэлтрэг шон хүрээ хоёрын яг гол дунд байршлыг сонгосон байдаг. Түүний ачаар тэр гинжтэйгээ өлхөн

багтахаар нүх ухаж орлоо. Тал нутгийн том чоно ч гэсэн байршлыг ийм оновчтой сонгох магадлалгүй байтал тэр үүнийг хэнээр заалган, тооцон гаргаж чадав аа.

Чэнь Жэнь ийн бодох зуур сэтгэл нь сэрхийн гайхширна. Гуравхан сарын настай бяцхан бэлтрэг эцэг эхийнхээ зааваргүй үхэл амьдралын дэнсэн дээр тавигдсан асуудлыг бие даан шийдэж чаджээ. Энэ нь нохой байтугай хүнээс ч ухаалаг үйлдэл юм. Чонын гени ийм айхтар удамшдаг юм болов уу? Чонын удамшил зөвхөн суурь төдий болохоос биш, түүний оюуны чадавх онцгой сайн юм байна гэсэн дүгнэлтэд Чэнь Жэнь хүрчээ. Гэтэл овоо боловсролтой нас биед хүрсэн хүн хүртэл хагас өдрийн турш бодсоны эцэст бэлтрэгтээ оновчтой газар нүх ухаан, хортой нарнаас хамгаалах арга сэдэн гаргаж чадаагүй л байгаа юм даа. Орчин үеийн боловсролтой залууд чонын бэлтрэг оршин амьдрах чадварын тухай онц хүнд хичээлийг амжилттай зааж чадлаа. Бэлтрэгний арга ухаан түүнээс хавьгүй илүүг хараад Чэнь Жэнь бахдан санаа алджээ. Тэр бэлтрэгт ийм айхтар давагдсанаа үнэн сэтгэлийн угаас хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Бэлтрэг түүнтэй эрхлэн тоглох үедээ нэг л ер бусын “Ижил тэгш” байр суурин дээр байдгийг гайхаад байх зүйл алга ажээ. Ер нь ч бэлтрэг угаас түүнийг огт авч хэлэлцдэггүй байж мэдэх юм гэсэн бодол энэ мөчид түүнд төрөв. Бэлтрэгний нэг л гаршиж өгдөггүй нүдний харцанд “Чи битгий омогшоод бай. Намайг том болохоор яахыг хараарай” гэсэн шиг айдас хүрмээр санаа агуулагддаг билээ. Бэлтрэгийг том болохоор яадаг шүү юм билээ гэсэн далд айдас нь Чэнь Жэньгийн сэтгэлд улам даамжирлаа.

Нөгөө талаас нь харвал тэр бяцхан бэлтрэг тэжээж байгаа биш, хүндэтгэн бишрүүштэй залуу багштай болсон мэт санагдаж сэтгэл нь баяраар гийлээ. Бэлтрэг түүнд эр зориг, арга ухаан, туйлбартай зан, тэвчээр, амьдралыг хайрлах үзэл, байгаа байдалдаа ханахгүй, үл шантран, хатуу хахир нөхцлийг даван туулж, хүчирхэг хувийн онцлогийг хэрхэн буй болгохыг зааж өгнө гэдэгт тэр хатуу итгэлтэй байлаа. Хятад үндэстэн лууг шүтэн дээдлэхээс гадна, чонон сүлдтэй байсан болоосой гэж тэр дотроо бодож байв. Хэрвээ тэгсэн бол өч төчнөөн удаа улс гэрээ мөхөөж гутамшгийг амсах байсан гэж үү? Түүнчлэн өнөө хэр ардчилал, эрх чөлөө, баян хүчирхэг, аугаа сэргэн мандлын төлөө толгойгоо гашилгахгүй л байсан болов уу?

Бэлтрэг гүнзгийлэн ухах тусам сэрүүцэн амсхийж, анх төрөх үеийн харанхуй чийгтэй орчинг мэдэрсэн шиг сүүлээ годгонуулан ажилласаар байх аж. Бэлтрэг зөвхөн сэрүүцэх, бие хамгаалах нүхээ малтаж байгаа бус, хар нялхын сайхан дурсамжууд, хайртай эх, ханчиртай гэдсэнд багтан гарсан ах дүүсээ эрж байх шиг Чэнь Жэньд санагдав. Нүх малтаж байгаа бэлтрэгний сэтгэлд хөөрөл, уужрал, хүсэл мөрөөдөл, харуусал жаргал холилдон байгаа мэтээр тэр төсөөлж байлаа. . . . .

Чэнь Жэньгийн нүдний аяга чийгтэн, сэтгэл нь хүчтэй эмзэглэлд автав. Тэр бэлтрэгийг улам бүр өхөөрдөн хайрлах боловч үнэн хэрэгтээ түүний эрх чөлөөтэй, жаргалтай гэр бүлийн голомтыг самарсан гэм нүгэлтэн нь өөрөө билээ. Хэрвээ тэр түүний амьдралд гар дүрээгүй бол бэлтрэг өдийд аав, ээжийгээ дагалдан аль дуртай газраараа сэлгүүцэн явах байсан сан. Олонбулгийн зартай цагаан азарган чонон үр хойч байж мэдэх энэхүү ухаалаг бэлтрэг чонон сүргийнхээ дунд өсөж торнисон бол бас л нэг сүргийн манлай болох байсан болов уу хэмээн Чэнь Жэнь таамаглана. Гэвч түүний гялалзсан ирээдүйг газрын мухраас гарч ирсэн хятад залуу бүрэн үгүй хийгээд хаячихжээ.

Төмөр гинжний хязгаартай хэмжээ бэлтрэгийг цааш ухах аргагүй болголоо. Чэнь Жэнь ч

гинжийг уртасгая гэж санасангүй. Эндхийн ширгэн дорх элсэрхэг сул хөрсийг дахин гүнзгийлээд ухчих юм бол үхэр адууны хөлд цөмрөөд бэлтрэгийг дараад алчихаж мэднэ. Бэлтрэгний хөөрлийг тасалсанд нүхнээс уурсан гарч ирээд төмөр гинжийг хазлав. Хүзүүвч нь түүний шархтай хүзүүг хөндөхөд хүртэл болихгүй ядарч цуцталаа гинжтэй ноцолдов. Бэлтрэг чийгтэй шороон дээр хэсэг амарсанаа ухсан нүх рүүгээ шагайн харахад Чэнь Жэнь түүнийг дахин ямар арга ухаан сэдэхийг анхааралтай ширтэнэ.

Бэлтрэг хэсэг амьсгаагаа дарсанаа дахин нүх рүү шургав. Удаж төдөлгүй нүхнээс шороо чулуу цацлагдаж эхлэлээ. Чэнь Жэнь ч ихэд гайхан доош тонгойгоод нүх рүү өнгийн харав. Бэлтрэг нэгэнт гүнзгийлж чадахгүйг мэдээд хоёр хажуу руу өргөсгөн ухаж байлаа. Бэлтрэг нэгэнт хайртай ээж хамт төрсөн ахан дүүсдээ хүрч чадахгүйгээс хойш өөрийн тавтай хэвтэх амар жаргалын оронг буй болгохоор шийджээ. Чэнь Жэнь ч байдгаараа алмайрч гүйцээд энэ бүхэнд итгэж чадахгүй байв. Бэлтрэг байршлыг сонгон, өөрийн бие өлхөн багтах байгууламжийг бодож төлөвлөн, гүйцэтгэхдээ эндүү ташаа, илүү дутуу үйлдэл гаргахгүй байгаа нь гайхалтай. Чонын энэхүү авьяас чадвар чухам хаанаас үүдэлтэй вэ гэдгийг л Чэнь Жэнь ойлгохгүй байжээ. Чухам хүн төрөлхтний хувьд дэндүү олон “Ойлгомжгүй зүйл” байгаа учраас л эртнээс нааш эдүгээг хүртэл талын нүүдэлчин үндэстнүүд чоныг сүлд шүтээнийхээ байранд залсан байж таарна.

Ингэсээр чонын биеэ хамгаалан сэрүүцэх нүх бэлэн боллоо. Бэлтрэг үүрэндээ тавтай хэвтчихээд Чэнь Жэньг яаж ч дуудсан гарч ирэх янзгүй. Тэр үүр рүү шагайн харахад бэлтрэгний гөлгөнөсөн ногоон нүд зэрлэг чоньхоос өөрцгүй аймшигтай харагдана. Бэлтрэг энэ мөчид өөрийн эхээс мэндлэхдээ үнэрлэсэн чийгтэй харанхуй нүхэнд хайртай ах дүүсийнхээ хамтаар халамжит эхийнхээ өвөрт эргэн очсон мэт тухлажээ. Тэр хүн малын бүслэлтээс айж бэмбэгэнэхгүй чонын ертөнцдөө эргэн очоод толгой хоргодох оромжтой болсондоо сэтгэл нь маш их уужирсан байдалтай харагдана. Бэлтрэг араатан чоньхоо амтат зүүдэнд умбан амгалан нойрсох боломжтой боллоо. Чэнь Жэнь ухсан шороонуудыг тэгшлэн элсэрхэг хөрсийг чонын хүрээнд цацав. Бэлтрэг Чэнь Жэньг санаандгүй байтал шинэ оромжоо буй болгосон нь түүний оршин амьдрах чадварт итгэх итгэлийг сэргээв.

Харуй бүрийн үеэр Гао Зянь Жун, Ян Кө нар гэртээ эргэн ирээд чонын шинэ нүхийг харж маш их гайхацгаажээ. “Ууланд хонь хариулж явахдаа хүн малгүй шарагдаж, ангаж үхэх шахсан болохоор бэлтрэг ч энэ халуунд сүйд болсон байх гэж бодож байсан юм. Гэтэл ийм жаахан амьтнаас тэр том ухаан гарна гэж яахин санах билээ? Ёстой онцгой амьтан гэдэг л энэ байх даа” хэмээн Ян Кө дуу алдав.

“Үүнээс хойш, төмөр гинж, модон шон, хүзүүвч зэргийг сайн шалгаж болгоомжтой байх хэрэгтэй юм байна шүү. Хэрвээ бэлтрэг хожим бидний сэрэмж алдах үед молигодод алга болчихвол малчид болон цуг суралцагсад маань элэг доог болгож мэдэх юм” гэж Гао Зянь Жун санууллаа.

Тэр гурав дор бүрнээ өөрт ногдох жууцай, нугасны өндөгтэй хуушуураас хэмнэж бэлтрэг рүү авч очлоо. Ян Кө “Хоолондоо” хэмээн хашгирахад цаадахь нь нүхнээсээ ухасхийн түүний өгсөн хуушуурыг үмхээд буцаж оров. Бэлтрэг нэгэнт өөрийн эзэмшил газрыг буй болгосон болохоор түүнд хэнийг ч халдахыг зөвшөөрөхгүй болжээ.

Арслан өдөржин гадуур явсаар сая нэг юм эргэн ирлээ. Түүний гэдэс цүдийж амаа тостсоныг үзвэл ямар нэгэн амьтан барьж идсэн бололтой. Олон өдөр тос өөхний бараа хараагүй анч Шар, Ирвэс болон гурван гөлөг түүн рүү очиж хошуу амыг нь долооно.

Бэлтрэг Арслангийн дууг сонсоод шурдхийн гарч ирэв. Арслан ч түүн рүү дөхөн очиход цаадахь нь хошуу амыг нь долоолно. Арслан түүний үүрийг олж үзээд их л сониучирхсан бололтой хэд тойрч үзсэнээ хошуу сунган дотогш шиншлэв. Бэлтрэг хуурай аавынхаа нурууг ноолж ноцон тоглолоо. Тэр баярласандаа хүзүүнийхээ зовиурыг мартаж өөрийн араатанлаг амьдрах хүчийг ноцооно.

Тал нутагт нар шингэнгүүт халууны уур замхраад сэрүүн салхи сэн татаад явчихдаг. Ян Кө цамцаа углачихаад хоньдоо тосохоор явахад Чэнь Жэнь ч түүний араас гарлаа. Цадсан хонь ямааг ширүүн туух цээртэй тул мань хоёр салхинд зугаалж байгаа мэт тайвуухан алхсаар хашаа хороогүй задгай хотонд нь оруулав. Зуны шөнө хонин сүрэг монгол гэрийн хойхон дэнж дээр хэвтэж хонодог юм. Ер нь зуны шөнө хамгийн эгзэгтэй үе байдаг тул чонон сүрэг бэлтрэг байгааг олж мэдээд өшөөгөө авах гэж дайрах вий хэмээн манай хоёр их л санаа зовж байлаа.

Чонын амьдрал шөнө эхэлдэг тул бэлтрэг өөрийн хөдөлмөрийн үр дүнг бахдан нааш цааш гүйж тонгочно. Хоёр найз зүлгэн дээр суучихаад харанхуйд очтон гялалзах бэлтрэгний хоёр ногоон нүдийг харж байлаа. Чонон сүрэг бэлтрэгийг олж мэдчихээд, бэлтрэгээ алдсан өлөгчин чоно ойролцоох жалганд бүгэн хэвтэж байгаа эсэхийг тэр хоёр яахин мэдэх билээ.

Чэнь Жэнь Ян Көд өдрийн болсон явдлыг ярих зуур “Ямар нэгэн аргаар мах олохгүй бол бэлтрэг олигтой өсөхгүй, Арслан ч гэрээ сайн харахгүй болохоор аюул болж мэдэх юм байна” гэхэд Ян Кө “Би өнөөдөр Доржийн урхидсан тарваганы боодгийг идлээ. Хэрвээ тэр олныг барьсан бол би нэгийг гуйж авчраад нохой, бэлтрэгэндээ өгөх байлаа. Гэтэл хонин сүргийн бараанаар тарвага айгаад урхинд орох янзгүй юм” гэв.

“Би одоо олон зүйлд санаа зовж байгаа болов чонон сүрэг хоньд руу дайрах вий гэхээс хамгийн их айж байна. Өлөгчин чоно гэдэг энэ хорвоогийн хамгийн үрсэг амьтан болохоор бэлтрэгээ суйлуулсаны дараа өшөөгөө авах гэж улайрдаг. Хэрвээ өлөгчин чоно юмыг яаж мэдэх вэ сүргээ дагуулан ирээд хоньдыг маань хядаад хаячихвал бид ганц баларна шүү дээ” хэмээн Чэнь Жэнь түгшингүй өгүүлэв. “Чоно заавал ирж өшөөгөө авдаг хэмээн малчид ярилцдаг. Өнөө жил арван хэдэн үүрний бэлтрэгийг суйлсан болохоор тийм тооны өлөгчин чоно өшөө авах завшааныг эрэлхийлж байгаа даа. Малчид төдийгүй бусад хэсгийн илгээлтийн эзэд ч гэсэн энэ бэлтрэгийг ал гээд байдаг. Өнөөдөрхөн хүртэл би Сяо Пэн тэд нартай энэ хэргээс болоод ам мурийгаад авсан. Хэрвээ үүнээс болж ямар нэгэн том хэрэг үүсвэл нийт багийн илгээлтийн эздийн нэр сүрэнд муухай гэж байдаг шүү. Бид ингэж зовж байхаар бэлтрэгийг суллан тавиад гинжээ тасдаад явчихжээ гэчихвэл болоо биш үү?” хэмээн Ян Кө санаа алдсанаа бэлтрэгийг тэвэрч толгойг нь илээд “Гэхдээ би ч бэлтрэгэндээ маш их дасчээ. Өөрийн ганц эрэгтэй дүүгээ ч ингэж хайрладаггүй хүн шүү дээ” гэлээ.

“Манай хятадууд яахаараа юу ч хийсэн энэ тэрээс айж эмээж байдаг юм бэ? Бид нэгэнт чонын үүрэнд орж, бэлтрэгийг нь суйлан гаргасан юм чинь эцсийг нь хүртэл тэжээгээд үзэх хэрэгтэй” гэж Чэнь Жэнь сэтгэл шулуудсан байдалтай хэлэв.

“Би хариуцлагаас айсан хэрэг биш л дээ. Бэлтрэг маань өдөржин хоригдол мэт уяатай, уйтгартай байхыг хараад л сэтгэл өвдөх юм. Чоно шиг эрх чөлөөтэй амьтныг цаг мөчгүй гав дөнгөнд хийчихээд чиний сэтгэл төвдөхгүй байна уу? Би харин сэтгэлдээ жинхэнээсээ чонон сүлдэнд сүслэх болсон шүү. Аав чиний чоно тэжээхийг эсэргүүцсэний учрыг би ойлгосоон. Энэ нь үнэндээ шүтээнийг бузарлаж байгаагаас өөрцгүй хэрэг” хэмээн Ян Кө хэллээ.

Чэнь Жэньгийн сэтгэл маш их хямрах боловч аман дээрээ мөчөөгөө өгсөнгүй Ян Кө рүү дайрч “Би түүнийг тавьж явуулах хүсэлгүй гэж хэн хэлээ вэ? Гэхдээ одоо тавих цаг нь биш ээ. Надад тодруулж мэдэх олон асуудал байна. Бэлтрэгийн эрх чөлөө гэдэг ганц чонон асуудал. Харин алсдаа тал нутаг маань чоногүй болчихвол ямар эрх чөлөө ч хэрэггүй биз дээ. Тэр цаг ирвэл чи ч өөрөө харуусах байх даа” гэлээ.

Ян Кө хэсэг зуур бодлогоширч байснаа эвлэрэнгүй атлаа эргэлзсэн дуугаар “За яахав. Тэгвэл цөмөөрөө тэжээцгээе л дээ. Гэхдээ би хэдэн цаасан буу олж ирье ээ. Чоно нь талын морин цэргүүд шиг дарь хүхэр болон их бууны галаас үхтлээ айдаг гэлцдэг. Хэрвээ Арслан маань чонон сүрэгтэй тулалдаад эхэлвэл би тэдэн рүү цаасан буугаа асааж байгаад ар араас нь шидэн хөөж явуулъя” гэв.

Чэнь Жэнь ч мөн уужраад “Үнэндээ чиний чонон араншин, аюулыг сөрөх зориг надаас хавьгүй их л дээ. Чи монгол хүүхэн авч сууна гээд байдаг. Тэд өлөгчин чононоос айхтар гэдэг шүү дээ” гэлээ.

“Байз гэм хө. Аягүй бол монгол хүүхэн маань уурлаж цамнаад бэлтрэгтэй хамт гаргаад хөөчихвөл би гэдэг амьтан яах билээ? Адаглаад толгой хоргодох монгол гэрээ бэлдэх хэрэгтэй байна шүү дээ” гээд Ян Кө гараа савчин хэлжээ.

## Хорин гурав

*Дун Жун Шү өчрүүн: Цин улс болвоос адилгүй болой. Шэнь, Шангийн ёсоор явж, Хань Фэйгийн сургаалыг эрхэмлэн, хааны ёсыг үтээрч, чоно шарнууд мэт ховдгоор зуршил болгомуй. . . . .*

*Сы Ма Гуан*

*“Засагт туслах нэвтэрхий толь”*

Ян Кө нүргэлэн шуугих ажлын талбар руу нуруугаа харуулчихаад хотгорын гол дундах хунт нуурын үзэмжийг тайвуухан ажиглана. Тэр ардаа байгаа ажлын талбарыг эргэн харж зүрхэлсэнгүй. Бао Шүнь Гүй хун шувуу агнасан тэр өдрөөс хойш тэр зарим шөнө хунгийн цусанд будагдсан нуурын цэнхэр мандал улаан хоормогоор эргэлдэж байна гэж зүүдлэх болсон билээ. . . . .

Өвөрмонголын тариалангийн бүс нутгаас ирсэн гуч гаруй хөлсний ажилчид энэ нутагт суурьшаад байгаа юм. Тэд өөрсдийн толгой хоргодох шавар тагзыг яах ийхийн зуургүй барьж босгожээ. Хөлсний болоод улирлын чанартай ажил эрхэлдэг эдгээр хүмүүсийн дээд үе нь жинхэнэ малчид байсан боловч яваандаа тариачин хятадуудтай холилдон суурьшаад мал аж ахуй, газар тариаланг холимог маягаар эрхэлж явсаар аажимдаа бүрэн газар тариалан эрхлэх болсон боловч үржил шим муутай тачир хөрс тэднийг тэжээх нөхцөлгүй болоход нүүдлийн шувууд мэт мал аж ахуйн бүсийг зорин ирсэн нь энэ юм. Тэд монгол хятад хэлний аль алинаар ус цас шиг ярьдаг төдийгүй мал аж ахуйн зах зухыг мэддэг, жинхэнэ тариачин эрс тул дотор газрын хятад тариачдаас илүү энд идээшин амьдрах чадвартай. Чэнь Жэнь, Ян Кө хоёр хоньдоо нуураас услах далимаараа тэдний байраар орж энэ тэрийг хуучилдаг. Бороошихоос өмнө амжиж ноосны агуулах, хонь угаах цөөрөм барьж дуусга гэсэн хатуу үүргийг Бао Шүнь Гүй өгсөн болохоор тэд одоохондоо нуурын хун шувуудыг гэх сөхөөгүй байгааг Ян Кө олж мэджээ.

Ян Кө, Чэнь Жэнь хоёр ойрдоо эртний хятадын Хань үндэстний “Атар хагалж хилийг сахих”, “Цагаачлалыг дэмжин хилээ бөхлөх” болон Манж Цин улсын хожуу үеийн төрөөс хэрэгжүүлсэн “Атар хээрийг хагалах” бодлогыг шүүмжлэн хэлэлцэх болсон билээ. Тал хээрийг мэрэн нүүдэлчдийг шахах бодлого үнэн хэрэг дээрээ одоо ч гэсэн хэрэгжсээр байгаа юм. Хятадын сонин хэвлэлүүдээр Хрушевын атрыг эзэмших бодлогын уршгаар олон арван сая гектар бэлчээр нутгийг цөлжүүлж, тухайн газрын ард иргэдийн амьдрал ахуйг доройтуулсан тухай шүүмжлээд байдаг хэр нь яахаараа дотооддоо яг ижил бодлого явуулаад байдгийн учрыг Ян Кө огт ойлгодоггүй. Харин ч сүүлийн жилүүдэд “Атар хээр рүү цэрэглэн халдах ялгуусан дуу” бүр ч эрчээ хүчээ аван сонсогдох боллоо. Ян Кө зүүн хойд нутаг болон Шиньжааны атрыг эзэмших цэргийн ангид элсэлгүй тал нутгийг сонгосон нь оросын ой талын тухай зохиол уншиж, кино, уран зураг, бүжиг зэргийг үзэж, орос дуу сонсож өссөнийх ч байж мэднэ. Оросын агуу их зохиолч, найруулагч, зураач, хөгжимчин болон бүжигчдийн оросын ой талдаа халуун хайртайг илтгэсэн бүтээлүүд түүнийг ой талын “Амьтан” болгон хүмүүжүүлжээ. Тэр зүүн хойд нутаг болон Шиньжааны атрыг хагалах цэргийн ангиас зугатан



зайлж чадлаа гэсэн чинь атар онгон талыг хагалан эзэмших их үйл хэрэг дээр буучихжээ. Суурьшмал үндэстний хагалах сэндийлэх араншин нийт улсын бүхий л тал хээрийг хагалан цөлжүүлэхээс нааш засрахгүй байж мэднэ.

Ян Кө хар ажилчдын навтгар байшин барих чадварыг үнэхээр биширдэг юм. Эхний өдөр очиход юу ч үгүй цулгүй байсан газарт дараачийн өдөр босоо хүний хэртэй хана өрсөн байж билээ. Тэгсээр шинэ нутагт хэдэн эгнээ шавар тагз баригдсан нь нүдэнд орсон бог мэт харахад эвгүй. Хэдэн сайхан цагаан монгол гэр барьчихсан бол байгалийн үзэмжинд өнгө нэмэх байсан юм. Гэтэл түүний оронд эдгээр шавар тагзнуудыг босгосон нь хунт нуурын тайз заслын дунд гахайн хороог оруулсантай адил утгагүй санагдана. Ян Кө энэ байдалтай эвлэрч чадахгүй тул барилгын ажилчдын ахлагч Ван гуайтай уулзан тагзнуудаа ядаж цагаан өнгөөр будчихвал монгол гэрийн өнгөнөөс ялгарахгүй биш үү хэмээн зөвлөжээ. Ван гуай өөдөөс нь арсайтал инээгээд “Чи өөрийн мөнгөөр шохой худалдан аваад ирдэг юм бол би хүн гаргаад будуулж болох юм” гэжээ. Тал нутагт шохой үйлдвэрлэдэггүй болохоор мөнгө нь байгаад ч хаанаас худалдан авах билээ. Ян Кө түнтийтэл уурлаад өнгөрчээ. Уулын хормой дахь чулуу олзворлох газрын цар хүрээ ч өргөжих янзтай. Монголын уул толгодын өнгөн хөрсийг ганц хоёр тохой хуулахад л цаанаас нь өгөршиж хагарсан хад чулуу цухуйн гарах тул түүнийг царилаар гөнжин олзворлох боломжтой. Түүнээс биш тэсэлж дэлбэлж, лантуудахын хэрэг гэж үгүй. Долоо найман хар ажилчин ухсан нүхнээс чулуу зөөхөд уулын хормойн гурав, дөрвөн хэсэгт булшны хөшөө мэт цайвар шаргал өнгийн хураалттай чулуун овоо босчээ.

Хэд хонолгүй барилгын ажил улам эрчээ аван өрнөхөд хорь гаруй хүнтэй нэмэлт хүч дугуйт трактороо пажигнуулсаар уужим хөндийд орж ирлээ. Тэд ачааны тэргэн дээр улаан ногоон өнгийн хиртэй пүүгээнүүдээ дүүрэн ачаад заримынх нь эхнэр хүүхдүүд зүүн хойд орны тэжээвэр галууг тэвэрсэн байх нь энэ нутагт шилжин суурьшаад байгалийн өнгө төрхийг өөрчлөн хувьсгах төлөв илт байлаа. Ян Көгийн сэтгэл шимширсэн байдалтай Чэнь Жэньд хандан “Энэ сайхан байгалийн унаган төрхөө хадгалсан бэлчээр нутаг тун удахгүй зүүн хойд бүсийн бохир заваан тосгоны өнгө төрхөнд шилжиж, хорвоод хосгүй хунт нуур маань тэжээвэр галууны цөөрөм болж хувирах нь дээ” гэхэд

Чэнь Жэнь ч мөн өөрцгүй байдгаараа үрчийгээд “Хүн ам нь хэт олширсон үндэстний хувьд оршин тогтнох явдал л эн тэргүүний хэрэгцээ байдаг болохоор урлагийн эд эсээ тэтгэх шим тэжээл хүрэлцдэггүй шиг байна” гэжээ. Эдгээр хөлсний ажилчдын олонх нь Бао Шүнь Гүйгийн нутгийн айлууд бөгөөд болдогсон бол тосгоныхноо бүгдийг аваад ирэхсэн гэж ярьж байсан тухай Ян Кө олж сонсчээ.

Хэд хонолгүй хөлсний ажилчид шавар тагзныхаа урд газар хагалан дөрвөн суваг шуудуу ухаж, арван хэдэн мү ногооны талбайгаа хашиж хятад байцаа, бөөрөнхий байцаа, улаан лууван, цагаан лууван, анхилуун ногоо, өргөст хэмх, сонгино, сармис зэргийг тариалсан нь энэ нутгийн илгээлтийн эздийн хувьд ховор эд тул худалдан авахаар урьдчилан тохирчээ.

Бэлчээр нутаг дахь үхэр тэрэгний замыг ноос зөөвөрлөдөг чиргүүлтэй салга амбангууд өргөсгөөд буцаж ирэхдээ хонины унгас, гүйлсний үр, эмийн ургамал, жууцай халиар түүхээр хомхойрсон аж ахуйн захиргааны ар гэрийнхнийг ачиж ирнэ. Атар онгон бэлчээр үүрээ эвдүүлсэн зөгийн сүрэг шиг хүн малын хөлд дарагдаад хаа сайгүй зүүн хойд орны монголжуу хятад аялгууг сонсож болохоор болжээ. Чэнь Жэнь Ян Көд хандан “Хятадын суурин соёл хоёр

гурван зуун жилийн хугацаанд манж үндэстнийг уусгаж чадсан бөгөөд тэдний уугуул нутаг болох зүүн гурван муж хар шороон хөрстэй тул суурин соёл үндэслэх боломжтой байсан юм. Тийм болохоор тэр уусгалт нэг их том асуудал үүсгэхгүй. Харин хятадын соёл тачир нимгэн хөрстэй монголын талыг уусгачихвал жинхэнэ шар гамшиг гэж тэр болох байх шүү” гэж хэлжээ.

Бао Шүнь Гүй ч энэ шинэ нутгийн хөгжих боломжийг олж харчихсан тул өдөржин барилгын талбайгаас салахаа байжээ. Хойтон жилээс бусад багуудыг ч гэсэн наашаа оруулж зусуулаад суларсан бэлчээрийн хар шороот хөрсөнд тариа ногоо тарихаар төлөвлөж эхлэв. Тэр цагт хангалттай идэх гурил махтай болчихоор уугуул нутгийн хамаатан садан, найз нөхдөө наашаа татаж, ус өвс жигдэрсэн энэ сайхан газар жинхэнэ Бао овогтын мэдлийн аж ахуйг байгуулж болох биш үү? Ингэж бодоод Бао Шүнь Гүй барилгын ажлыг хэт яаравчлуулах боловч хөлсний ажилчид нь ч өөдөөс үг яриа гаргана гэж үгүй.

Тэдний ухсан суваг шуудуунд шөнө явсан морьд бүдэрч унасан хэрэг гарсан тул түүнийг тэгшилж бул хэмээн Билиг тэргүүтэй нутгийн өвгөд байнга шахам тэдэнтэй ам мурийна. Ногооны газрыг хашсан шуудууг булсан боловч түүний оронд хүний бэлхүүсээр татахуйц өндөр шороон хашаа босчээ. Өлзий энэ сайхан нутгийг мэдсэн бол эзэмшдэггүй байж хэмээн халаглаж өдөржин уруу царайтай амьтан явдаг болов.

Ян Кө ардаа нүргэлэх барилгын ажлын чимээнээс арай ядан анхаарлаа хөндийрүүлээд хунт нуурын үзэмжийг сэтгэлдээ тод хадгалан үлдэх гэсэн мэт нүдний өмнөх байгалийн үзэмжийг удгал ширтэн харав. Сүүлийн үед түүний хунт нуураар өвчлөх Чэнь Жэньгийн чононд хорхойсдогоос ч хавьгүй илүү болжээ. Магадгүй жилийн дараа л гэхэд гол нуурын нөгөө эргийн уудам орон зайг бусад багууд эзэмшээд илүү олон хар ажилчид барилга барин язганах юм байна гэдгээс тэр жийрхэнэ. Хэрвээ нуурын эргэн тойрны зэгсийг хадаад хаячихвал хунгуудад биеэ далдлах байгалийн халхавч үгүй болно.

Нуурын мандлаар хунгийн дэгдээхэй хөвж буй эсэхийг үзэхээр тэр нуурын эрэгт очив. Улирлын энэ үед хун өндгөө дарсан байх учиртай. Ашгүй нуурын эрэгт хэдэн үхрээс өөр мал сүрэг үгүй, бяцхан гол алсын ойн тунгалаг усаар малын хөлд булингартсан усыг сэлбэж амжсан тул нуурын мандал ер бусын тунгалаг байлаа. Усны шувууд түрхэн боловч амсхийж авсан байлгүй.

Гэнэт зэгсэн дунд олон хэлийн шувууд ганганалдаад явчихав. Зэрлэг галуу нугас нуурын мандлыг шүргэх шахам зүүн зүгт нисэлдэхэд хун шувууд ч тэднээс хоцорсонгүй хойд талын намгийг чиглэн нислээ. Хэн нэгэн хүн хун агнасан юм болов уу гэж бодоод Ян Кө ч яаран дурангаа гаргалаа.

Арван хэдэн минутын дараа нуурын мандал дээгүүр японыг эсэргүүцэх дайны үед хэрэглэж байсан өнгөлөн далдлалттай сал хөвөн гарч ирлээ. Хоёр салан дээр зэгсээр сүлжсэн малгай тор өмссөн хоёр хүн суужээ. Салан дээр ч гэсэн бөөн зэгс дэвссэн болохоор холоос сайн л хичээж харахгүй бол түүнийг эргэн тойрны зэгснээс ялган таних аргагүй байлаа. Тэр хоёр чамгүй олз олсон бололтой нэг нь зэгсэн малгайгаа тайлахад нөгөөх нь төмөр хүрзээрээ сэлүүрдэн эрэг рүү дөхөхийг Ян Кө тодхон харав. Зургаан хийтэй олгой хаймар дээр хэдэн хаалганы хавтас барьж бөхлөсөн сал эрэг рүү дөхөн ирлээ. Тэдний нэг нь барилгачдын ахлагч

Ван овогт, нөгөө нь түүний зээ дүү Арь Шүнь болохыг Ян Кө сая танив. Арь Шүнь салан дээрх зэгснүүдийг ярж зайлуулахад угаалгын түмпэн дүүрэн том жижиг шувууны өндөгний дунд амтат гуаны хирийн хоёр том өндөг байх нь хараа булаам содон ажээ. Тэр хоёр өндөг цагаан хаш сийлмэл мэт гялалзана. Ян Көгийн сэтгэл сэрхийн “Хунгийн өндөг байх нь” хэмээн сэтгэлдээ дуу алдав. Хэсэг зэгсний дороос хунгийн цустай өд сөд цухуйх нь түүний сэтгэлийг улам ч хирдхийлгэв. Ян Көгийн халуун цус толгой руу нь огшиж хар хурдаараа гүйж очоод салыг хөмрөн унагамаар санагдах боловч уур хилэнгээ арайхийж дарав. Үхсэн хунг ямар амилуулаад босгоод ирэх биш харин яадаг боловч тэр хоёр өндгийг аврах учиртай гэж тэр боджээ.

Сал эрэг рүү дөхөн ирэхэд Ян Кө өндөр дуугаар “Хэн та нарыг хун агнаж өндгийг нь авахыг зөвшөөрсөн юм бэ? Алив цугаараа багийн захиргаа явна аа” хэмээн хашгирлаа.

Ван гуай гэж нуруугаар төдийлөн өндөргүй боловч монголжуу хууз сахалтай сэргэлэн эр билээ. Тэр Ян Көг бүлтийтэл ширтэж “Бао дарга агна гэсэн юм. Тэгээд юу гэх гээ вэ? Барилгын бригадынхан ан хийвэл та нарын үхэр хонинд хэмнэлттэй юм байгаа биз дээ” гэжээ.

“Өмхий бах л хунгийн мах идэхийг санаархдаг гэдгийг хятад улс даяар мэдэхгүй хүн байхгүй. Чи өөрөө хятадын иргэн юм байгаа биз дээ?” хэмээн Ян Кө асуулаа.

Ван ахлагч зэвүүн мушилзаад “Хятад улсын иргэн болохоор энэ хунг дайсныхаа нутаг руу нисгэхгүй гэсэн юм. Чи байтлаа түүнийг дайсны нутгийн гүн рүү явчихаасай гэж боддог хэрэг үү?” хэмээн хариу асууж Ян Көгийн амыг таглажээ.

Хун шувууг эрэг дээр чирэн гаргахад түүний цээжинд нэг сум зоолттой байхын дээр салан дээр хулсан хавчаахай, хэдэн сум байгаа нь Ян Көгийн сэтгэлийг хирдхийлгэв. Буун дуу гаргаагүй нь ийм учиртай байжээ. Энэ хоёр хүн буугүй байж яахин хун агнасан юм бол доо гэж тэр их гайхаж байсан юм. Гэтэл тэд бүр ийм балар эртний зэвсэг хэрэглэсэн байжээ. Галт зэвсгийн үед түүний харсан хулсан хавчаахай дуу шуугүй болохоор шувуудын аминд буу зэвсгээс ч илүү хөнөөлтэй тул дахин дахин хэрэглэх боломжтой байж мэдэх юм. Энэ эвгүй хүмүүстэй жаахан эв гавыг нь олж харьцахгүй бол болохгүй нь гэдгийг Ян Кө ойлгожээ.

Тэр уур унтуугаа арай ядан дарж, их л төв царайгаар мөнөөх хавчаахайг барин өгүүлрүүн “Их хатуу таталттай эд юм гээч. Та нар үүгээр хун агнаа юу?” хэмээн асуулаа.

Ван ахлагч Ян Көгийн дууны өнгө зөөлрөхийг үзээд их л маадгар байдалтай “Тэгэлгүй яах вэ? Наад хавчаахайг чинь би ноос савдаг хулс ашиглан хийсэн юм. Их чанга эд болохоор хүн ч төвөггүй алчихаж мэдэх байх шүү” гэхэд Ян Кө нэг сум аваад “Би туршиж үзэж болох уу?” хэмээн асуув. Ван даамал эргийн нэгэн өвсөн сондуул дээр сандайлан ангийн олз зөөх Арь Шүнийг харангаа нэг тамхи асааж “Наад сумыг чинь хийхэд их хүчир байдаг юм. Чи яахав нэгийг харваж үз. Харин олныг бол болохгүй шүү, би дараа дахин ан хийх юм” гэлээ.

Ян Кө мөнөөх хавчаахайг дахин сайтар ажиглав. Хуруу зузаан, гурван хуруу өргөн хавчаахайн хөвчийг хэдэн нарийн сурыг харандааны хиртэй болтол гөрж хийжээ. Сумны годилыг бургасаар зорж, бөгсөнд нь энэ хавиар нэг хөглөрөх нугасны өд наасан байна. Харин сумны

зэвийг нөөшний нимгэн төмрийг ашиглан хийсэн бөгөөд дээр нь бүр “Соустай” хэмээх бичиг хүртэл дурайж байгаа нь Ян Көг маш их цочирдуулав. Нимгэн төмрийг гурвалжлан зэв хэлбэртэй болгоод илүү гарсан хэсгийг годилын үзүүрт бөгжлөн тогтоож жижиг хадаасаар хадан бөхлөсөн аж. Годилын үзүүрийг ялимгүй зорж шовхолсон нь зэвний бөгжинд яв цав сууж өгчээ. Ян Кө зэвийг гараараа имэрч үзэхэд жижиг жад мэт хатуу, хурц байлаа. Тэр сумыг гараараа дэнсэлж үзэхэд толгой хэсэг нь арай хүнд тул салхинд даялах нь харьцангуй бага байж таарна.

Хавчаахай их хатуу тул Ян Кө хамаг хүчээ шавхаад ч төдийлөн сайн тэлж чадсангүй. Тэр арван хэдэн метрийн цаана байгаа нэг сондуулыг чиглүүлж байгаад харватал түүний хажууханд тусаж газарт шигдэв. Ян Кө гүйж очоод сумыг сугалж шаврыг арилган үзвээс сум хурц хэвээр байх ажээ. Тэр гэнэт монголын уудам талын харваж намнах нь хавтай эрт балар цагт эргэн очсон мэт санагдлаа.

Ян Кө Ван даамлын өмнө дөхөн очоод “Та хэр зэрэг холоос хунг харвасан бэ?” хэмээн асуув.

“Зургаа долоон алхам байсан байх аа”

“Тийм ойрхон очоод байхад хун ажиглахгүй байна гэж үү дээ?”

Ван ахлагч гаансаа тогшингоо “Уржигдар би зэгсэнд орж удтал хайсаар хунгийн өндөгтэй үүр олсон юм даа. Өнөөдөр өглөө эрт зэгсэн тор, малгай өмссөнөөс гадна манан ихтэй байсан тул хун анзаараагүй байх. Хун босоо хүний хиртэй зэгс овоолж дотор нь эм хун өндгөө дараад, эр нь ойролцоо манаанд гарч байсан” гэлээ.

“Та тэгээд эр хун агнав уу? Эсвэл эмэгчнийг алав уу?”

“Бид хоёр доошоо навтайсан тул эмэгчнийг олж үзсэнгүй. Харин нэлээд удаан хүлээсний эцэст эрэгчин хун бидний салны урдуур хөвөн гарч ирэхэд би зүрхэнд нь ганц сум зоосон. Тэр хэд тэлчлээд л нам болно лээ. Эм хун ч тэр чимээнээр нисэн одоход бид үүрэнд нь очиж энэ хоёр өндгийг авсан юм” гэлээ.

“Энэ цагаачдын оршин тогтнох болоод эвдэн сүйтгэх чадвар үнэхээр лут юм аа. Буугүй мөртлөө хавчаахай, завьгүй мөртлөө сал хийчихнэ. Тэгээд өнгөлөн далдлалт хийж байгаад бүгж хэвтсэний эцэст ганцхан сумаар л амьтны амь хөнөөжээ. Хэрвээ эд нар хурдан буу трактороор зэвсэглэх юм бол энэ тал нутаг юу болох бол доо? Тэдний өвөг дээдэс нь малчин хүмүүс байтал хятадын суурьшмал соёлд уусан нэгдсэн хойно монголын тал нутгийн дайсан болон хувирдаг байжээ. Хэдэн мянган жилийн турш хятадууд өөрсдийн харь үндэстнийг уусган нэгтгэх чадвартаа эрэмшин онгирсоор ирсэн. Гэвч бид сайндаа л өөрөөсөө соёлын хувьд доогуур үндэстнийг уусган нэгтгэж, түүнээс үүдсэн гамшгийн чанартай хор хохирлын талаар ганц үг ган хийхгүй байсаар өдий хүрчээ” хэмээн Ян Кө бодоод тэр хор хохирлыг нүдээр үзсэн сэтгэлд нь цус дусалж байв.

Арь Шүнь ч салаа цэвэрлэж гүйцээд сууж амрав. Ян Кө одоо нөгөө хоёр өндгөнд л хамгаас илүү санаа зовних ажээ. Эмэгчин хун үхээгүй юм чинь өндгөн дээрээ эргэж ирж таарна. Хэрвээ ангаахайнууд өсөж том болоод эхийгээ даган алс холын Сибирь нутаг руу нисчихвэл

болох нь тэр.

Ян Кө өөрийгөө албадан инээмсэглээд Ван гуайд хандан “Та ч лут эр юм аа. Дараа надад бага сага зүйл зааж өгч байгаарай л даа” гэв.

Цаадахь нь маадайн инээж “Юу шалих вэ дээ. Шувуу агнах, тарвага, чононд урхи хавх тавих, эмийн ургамал мөөг түүх зэргийгээ бол ч чадалгүй яахав. Энэ бүхнийг манай өвөг дээдэс чаддаг байсан юм. Хожим манай зүүн хойт нутагт хятад хүмүүс олноороо очиж суурьшаад ан амьтныг цөлмөж, газар ч хүрэлцэхээ больсон тул бид урьдын чаддаг байсан энэ аргаараа тал нутагт хүрэлцэн ирж амь зууж байгаа юм даа. Бид хэдийгээр монгол үндэстэнгүүд боловч хүний нутагт бас л арга ядаж байгаа улс. Бээжингийн залуус та нар эндхийн харьяалалтай болохоор бидний талд хандсан юм хум ярьж байвал эндхийн монголчууд биднийг хөөгөөд явуулчихгүй нь лавтай. Тэд та нарын үгэнд орно. Хэрвээ чи үүнийг зөвшөөрөх юм бол би чамд жилдээ төвөггүй ганц хоёр мянган төгрөг хийгээд байх арга чарга зааж өгч бололгүй яахав” гэлээ.

“За тэгвэл би танд шавь орлоо шүү” хэмээн Ян Кө хэллээ.

Ван гуай түүн рүү нэлээд дөхөж очоод “Малчид болон илгээлтийн эзэд та нарын гэрт багагүй өөхөн тос байдаг гэх юм. Чи бидэнд жаахныг өгч болох уу? Манай дөч тавин ажилчид өдөржин хүнд ажил хийчихээд хар захын өндөр үнэтэй амуу будааг өдөр болгон тосгүй ногоотой хуурч иднэ. Гэтэл та нар өөхөн тосоор дэн барьж байхаар бидэнд хямдхан зарж бай л даа” гэв.

Ян Кө инээд алдан “Тэр бололгүй яахав. Манайд л гэхэд хоёр вааран савтай өөхөн тос байгаа. Тэгвэл наад хоёр хунгийн өндгийг чинь хагас сав өөхөн тосоор сольж авч болох уу?” гэхэд Ван гуай “Тэр бололгүй яахав. Энэ хоёр өндгийг би авч очоод л идчихэж орхино биз. Тэгснээс чи ав даа” гэлээ. Ян Кө тэрлэгээ яаран тайлж хоёр өндгийг боогоод Ван гуайд хандан “Би маргааш өөхөн тосоо танд хүргэж өгье” гэлээ. Ван даамал “Танай Бээжингийнхэн ч хэлсэн үгэндээ хүрдэг байлгүй дээ” гэв.

Ян Кө уртаар санаа алдан “Цаг эрт байна. Та хоёр надад салаа зээлүүлээч. Хунгийн үүр босоо хүний хиртэй өндөр байдаг гэхэд нэг л итгэмгүй байна шүү. Би өөрөө очиж үзмээр байна” гэлээ.

Ван гуай Ян Көгийн морийг хяламхийн харсанаа “Бололгүй яахав. Харин чи надад морио өгч бай. Энэ хун бараг хонины хэртэй хүнд тул би мориор чинь гал зуухандаа хүргэе” гэжээ.

Ван гуай босож ирээд “Зүүн талыг барьж явсаар хойш эргэтэл зэгсэн дунд салны явсан мөр байгаа. Түүнийг дагаад яваад байтал хунгийн үүрийг олж харах болно. Чи харин сал залж чадах уу?” хэмээн асуулаа.

Ян Кө салан дээр гараад хүрзээр хэд сэлүүрдтэл их л тогтвортой ажээ. “Би Бээжинд байхдаа Бэйхайгийн цөөрөмд байнга завиар зугаалдаг байсан. Дээр нь хэдэн мянган метр сэлэхэд алзахгүй тул живээд үхчихгүй байх аа” гэлээ.

“Чи тэгвэл эргэж ирээд салаа сайтар бөхлөн уяарай” хэмээн Ван гуай захичихаад морин дээр мордон үхсэн хунг эмээлийн урдуур дүүрээд барилгын талбайг чиглэн явлаа. Арь Шүнь ч том түмпэнгээ барьсаар араас нь сажлав.

Тэр хоёр холдон явсаны хойно Ян Кө хунгийн өндөг боосон тэрлэгээ авч салан дээр тавиад зүүн эргийн зэгсийг чиглэн хөвжээ.

Нуурын өргөн мандал нүд гялбам хөвөн цагаан үүлсийг тольдоод умар зүгийн намаг дундаас нэгэн бүдүүн зоригтой бор галуу нааш чиглэн нисч ирлээ. Усны шувууд нууранд туссан үүлсийг яран хөвөх нь цагаан олбогон дээр суусан лугаа адил санагдана. Ус, зэгсний үнэр холилдон сэнгэнээд нуурын цээлд орох тусам ус улам тунгалагшин өдрийн бодол шөнийн зүүд болсон хунт нуурандаа хүрч ирсэн мэт ээ. Хэрвээ Чэнь Жэнь, Жан Зи Юань хоёрыг наашаа дагуулаад ирсэн бол мөн сайхан аа. Тэр гурав нуурын үзэмжинд татагдан өдөржин шөнөжин хөвсөн ч бэлэн байж таарна.

Сал нуурын зүүн эргийн зэгсэнд дөхөн очиход голын ус энэ хавиар цутгадаг нь мэдэгдэхээр ажээ. Хойшоо урсгалтай голын эрэг дагуу хулс зэгс битүү ургасан аж. Тэр голын урсгал даган хэсэг хөвтөл усны мандлаар цагаан, зэгэл, хүрэн бор, алтан шар, ал улаан өнгийн өднүүд хөглөрнө. Заримдаа зэгсэн дундаас хэдэн зэрлэг нугас хөвөн гарч ирсэнээ түүний барааг хараад буцаж далд орно. Өндөр зэгснүүд шувуудын өндгөө гаргаж, дэгдээхэй цурваануудаа амар тайван өсгөх оромж нь болдог ажээ. Их үдийн нар өндөр зэгсэнд халхлагдах тул сэвэлзсэн салхинд Ян Көгийн хамаг биеийн хар хөлс сэврэв.

Нэг зэгстэй тохойг ороотол гол нэг хэсэг өргөсөн, нэг хэсэг нарийсна. Дахин жаахан сэлүүрдтэл ус хоёр салаалав. Ян Кө зогсон сайтар ажиглаваас нэг салаанд сал явсаны ул мөр тодхон үлдсэн тул түүнийг дагалдан сэлүүрдлээ. Өмнөх мандал улам өргөссөөр түүний өмнө нуурын дундах нэгэн жижиг нуур тодрон гарч ирэв. Түүний зүүн хойд талын хэсэг зэгс налсаныг дагуулан харваас түүний цаана хоёр метр гаруй өндөр, метр гаруй өргөн том зэгсэн бухал байх ажээ. Ян Көгийн зүрх “Оллоо” гэсэн шиг хүчтэй цохилон. Урьд өмнө үзэх нь байтугай кино, зурган дээрээс ч харж байгаагүй хунгийн үүр гээч энэ ажээ. Тэр нүдэндээ итгэж ядан дахин дахин нухлав.

Түүний амьсгал давчдан хоёр гар нь салганалаа. Ян Кө төмөр хүрзээр дайвалзуулан сэлсээр нуурын налсан зэгснүүдийг яран хунгийн үүрнээ хүрлээ. Тэгсээр асар том зэгсэн баганы дэргэд очин салаа бөхлөөд хүрзээ тулан уужим амьсгаа авав. Тэр хүзүү сунган ижил хань, ихэр үрээ алдсан эмэгчин хун байгаа эсэхийг харав. Гэвч хунгийн үүр маш өндөр тул юу ч харагдах янзгүй.

Тэр өмнөө байгаа ер бусын өндөр том шувууны үүрийг харан алмайрчээ. Урьд нь тэр хунгийн үүрийг нуурын зэгсэн дундахь хоосон зайд ердийн шувууныхаас өөрцгүй аяга хэлбэртэй юм байдаг байх гэж төсөөлж байсан юм. Гэвч нүдний өмнөх хунгийн үүрийг хараад өөрийнхөө ургуулан бодох чадвар дэндүү ядмагийг ойлгожээ. Жигүүртний хааны үүр байр сууриндаа тохирсон төдийгүй ур хийц ч чамгүй өөр байлаа. Энэ бол ур сэтгэл шингэсэн ер бусын бөх бат цэнгэлийн орон ажээ.

Ян Кө эмэгчин хунг үүрэндээ байхгүй гэдгийг баттай мэдсэний дараа мөнөөх аварга эдийг

нарийвчлан сонжиж гарав.

Хун үүрээ нуурын дундах хамгийн өтгөн ягч зэгстэй газар тун оновчтой сонгон барьжээ. Хос хун энд үүрээ барьснаар бусдаас биеэ далдалж, идэш тэжээлээ олон, эрэгчин нь харуулд гарахад тун тохиромжтой юм. Хэрвээ хоёр зальхай барилгачин өнгөлөн далдалсан салаар усан зам татуулан ирж хулгайгаар дайраагүй бол жигүүртний хааны өргөөг жирийн хүн олох аргагүй байхсан.

Ян Кө түүнийг түлхэж үзвэл метр гаруй бүдүүн мод адил хөдлөх янз алга. Түүнийг хэдийгээр усан дотор барьсан боловч аварга том залгалт мод мэт суурь нь нуурын ёроолд бат шигджээ. Тэр нэлээд нарийн ажигласны эцэст хунгийн үүрний ямархуу бүтэцтэй болох талаар жаахан төсөөлөлтэй болов. Хос хун хамгийн бүдүүн зэгстэй газрыг сонгон түүний хоорондуур тасалсан зэгсийг сүлжин давхарлах маягаар өндөрлөдөг бололтой. Тэд сууриа маш шигүү сүлжээд түүнийг биеийн жингээр усанд далд оруулна. Энэ мэт үргэлжлүүлэн сүлжсээр эцэстээ усны мандал дээр цухуйн гарч ирдэг байх. Тэр хүрзээрээ усны гүнийг хэмжиж үзвээс лавтай нэг метр хагас гүн байлаа. Түүн дээр усны мандалд ил гарсан хоёр метрийг нэмбэл лав дөрвөн метр өндөр байж таарах нь. Энэ бол жигүүртний вант улсын доторх хамгийн нүсэр байгууламж байж таарна.

Төлжиж гүйцсэн зэгс гэдэг хулснаас өөрцгүй тослог уян төдийгүй ялзарч мууддаггүй онцлогтой. Ян Кө намар хонь хариулж явахдаа долоо найман жилийн өмнөх нэгэн хаягдсан худгийн амыг нурангиас хамгаалан жийрэглэсэн зэгс бүрэн ялзраагүй байхыг үзсэн удаатай. Тэр хүрзээр хунгийн үүрний усан дорх суурийг хатгаж үзэхэд мөн л хөдөлшгүй бат бөх ажээ.

Тэгэхээр суурь усан дээр ил гарч ирэхэд хос хун мөн л давхар давхраар сүлжсээр дээд хэсгийг гүйцээдэг байж таарна. Энэхүү нягт шигүү сүлжсэн шувууны үүр аварга том хөмөрсөн араг мэт ажээ. Ил гарсан хэсгийг нэхсээр зэгсэн толгойноос тохой хэрийн дор хүрээд зогссон тул хавь ойрын зэгснүүдтэй хаяа залгана. Ян Кө хунгийн үүрний амсраас барин гутлын өлмийг хоёр тохой хэрийн өндөрт байгаа завсар шургуулан өлийн харав. Эм хунгийн хэвтэр ялимгүй хонхор боловч жирийн шувууных шиг тийм гүн бус ажээ. Дээр нь нялх зэгс, шувууны өд сөдийг дэвссэн болохоор зөөлөн гэж жигтэйхэн.

Тэр салан дээр эргэн буугаад хунгийн үүрийг бахдан ажиглав. Ажилч ухаалаг хос хун уран барилга гоо зүйн ийм гүн нарийн мэдлэгтэй байдаг гэж үү? Монголын тал ховор амьтдын диваажин төдийгүй, ухаантан хүчтэний өлгий тул суурьшмал иргэдийн олж мэдээгүй олон нандин эрдэнэсийг агуулж байдаг ажгуу. Хунгийн үүр зэгсэн толгойд шахуу байрласнаар агаар салхи нэвтэрч, алсыг харах боломжтой зэрэг өөр олон давуу талтай болохыг тэр ухаарав. Ид зуны халуунд шумуул, усны могойн халдлагад өртөхгүй. Хунгийн дэгдээхэй нүдээ нээнгүүт хөх тэнгэр хөвөн үүлсийг хардаг байж таарах нь. Намрын сэрүүн болоод өмнө орныг зорин нисэхдээ тэд лав цас мэт цавцайн цайрах хулсан сахлыг олж үзэх тул хичнээн хол нисэн очлоо ч ийм үзэсгэлэнтэй сайхан төрсөн нутгаа мартаж чадна гэж үү?

Урин салхины аясаар нуурын зэгс найган ганхахад хунгийн үүр ихэмсгээр сүүхийх нь эрдэнийн сууринаа залраад түмэн албатын хүндлэлийг хүлээх хаан эзэн мэт. Омог бардам хун шувуу хорвоогийн хамгийн өндөрт элин хальдаг жигүүртэн боловч ганц модгүй тал нутагт уулсын тэргүүн шүргэх бүргэд шувуунаас ч илүү омог бардам гэдгийг Ян Кө бас л

анзаараагүй явж дээ. Ян Кө уулын орой дахь талын бүргэдийн үүртэй арван хэдэн удаа тааралдсан нь түүний үүрийг их л нууцлагаар төсөөлж байсныг ор мөргүй үгүй болгож билээ. Үүр ч гэж дээ хэдэн мөчир навчийг адсага, хөдөсний тасархайтай нийлүүлсэн нь хунгийн үүртэй харьцуулах аваас гудамжин дахь гуйлгачингийн хэвтэшнээс өөрцгүй санагдав.

Ихэмсэг хун шувуу тэнгэрийн цээжнээс газрын элгэнд хүртэл ариун үзэсгэлэнгийн дээд байсаар байдаг ажгуу. Хэрвээ энэ дэлхийд хун шувуу гэж үгүйсэн бол хүний хорвоогийн тайзан дээр “Хунт нуур” амилж, Уланова бүжиж, Чайковскийн яруу аялгуу эгшиглэн хүмүүсийн хамаг сайхан хүсэл мөрөөдлийг тэнгэрт аваачих байсан гэж үү? Ян Кө нүдээ бүлтийлгэн хунгийн сэнтийн нарийн ширийн бүхнийг ажиглана. Алсдаа улсын эрдмийн театрын өмнөх том талбайд жигүүртний хааны аварга үүрийг урлаж хун шувуу болоод хунт нуурыг хайрладаг хүмүүсийн сүлдэт багана болгохсон. Тэрхүү сүлдэт баганы оройд ариун нандины бэлгэдэл хос хун шувуу үүлсийг яран дүүлж байгааг дүрслэхсэн гэж тэр санав. Гагцхүү тэгж чадваас тэр хүн төрөлхтний сэтгэл дэх ариун хайр болон гоо сайхны сүлд болон мөнхрөх боломжтой.

Нуурын салхи сэрүүсэн хулс зэгсний ногоон өнгө бараантав. Ян Кө хоёр өндгөндөө хүний биеийн бүлээн илчийг шингээх санаатай цээжиндээ наалаа. Энэ хорвоод өмхий бахнууд улам олшроод тайзан дээрх улаан хувьсгалч эмэгтэй цэргүүдийн хурц жад хун шувууны хувилгаан гүнж нарыг хөөгөөд явуулчихсан. Гэвч энэ дэлхий дээр бас чамайг хайрладаг, дээдлэн биширдэг хүн бас байдаг юм шүү.

Ян Кө хунгийн үүр рүү болгоомжтой авиран өрөөсөн гараараа нэг өндгийг толгой дээрээ өргөн доош зөөлөн тавьлаа. Дараа нь өврөөсөө нөгөө өндгийг авч тавив. Тэр салан дээрээ эргэн буугаад уртаар амьсгаа авлаа. Сүлдэт баганы орой дахь хоёр өндөг зэгсэн дундахь хос эрдэнийн чулуу мэт нүд гялбам гэрэл цацруулан огторгуй өөд цойлоод тэнгэрийн энгээр дүүлэн нисэх жигүүртний хатан хааныг дуудан ирүүлнэ гэдэгт тэр итгэнэ.

Тэртээ огторгуйд ганц цагаан цэг эргэлдэн нисэхийг хараад Ян Кө салны бөхөлсөн олсыг тайлан гол руу сэллээ. Тэр хүрзээрээ өндөр зэгсийг яран сэлнэ. Хүний гараар сүйдэн унасан энэ зэгс хурдан сэргээд ил гарсан хунгийн үүрийг халхалчихдаг ч болоосой.

Ян Көг холдох тусам ганц хун улам доошилсоор эрэг дээр хүрэхийн үед зэгсэн дунд үзэгдэхээ больжээ.

Ян Кө барилгачдын гал зууханд очтол Арь Шүнь нагац ах гуравдугаар хэсэг рүү өвчтэй үхэр худалдан авахаар морийг чинь унаад явчихсан гэв. Гал зуухны байшингийн гадаа том газар зуух ухаад дээр нь асар том тогоо байрлуулжээ. Газар дээр хэсэг бусаг хунгийн өд хөглөрч, уур савсах том тогоонд зангидсан нударга шиг том том хунгийн мах даргилна. Том тогоотой махан дотор хөөрхий хунгийн толгой уйлан өнхрөхийг Ян Кө олж үзэв. Нэгэн хятад хувцастай залуу эмэгтэй тогоо руу халуун ногоо, сонгино, цагаан гаа хийж байснаа хямд үнэтэй хагас шил цууг мөнөөх ихэмсэг тэргүүн рүү цутгаж орхидог байгаа. Ян Көгийн ухаан балартмаар санагдахад ардаа байсан үхэр тэргэн дээр лагхийтэл суучихлаа.

Мөнөөх хүүхэн Арь Шүньд хандан “Наад Бээжингийн залуу оюутнаа дотогш түшээд



оруулчих. Аяга хунгийн шөл ууж биеэ тэнхрүүлмээр болсон хүн байна” гэлээ. Ян Кө ч гараа савчин Арь Шүньг түлхэн холдуулаад уурандаа тогоотой шөлийг өшиглөөд хөмрүүлчихмээр санагдана. Тэр тогооноос ханхлах үнэрийг тэвчиж чадамгүй байлаа ч өшиглөн хөмрүүлж уураа гаргаж яахин болох билээ. Яагаад гэвэл эд бол ядуу дунд тариачид, харин өөрөө хөдөө хээр засан хүмүүжигдэхээр ирсэн “Нохойн гөлөг” билээ. Одоо тэр ямар нэгэн арга сүвэгчилж байгаад тэр завийг эвдлэх учиртайгаа ойлгожээ.

Хар хөлсөө цувруулсан хөлсний ажилчид увуу цувуу эргэн ирээд шинэ махны үнэр авч шүлсээ гоожуулах шахам шуугилдаж гарцгаалаа.

“Өмхий бах хунгийн маханд санаархана гэдэг байх аа”

“Хунгийн мах идсэн болгон өмхий бах байх гэж үү дээ?”

“Тэгээд юу болж таарах билээ?”

“Газар дэлхийн хаан”

Нэгэн атигар давжаа биетэй хүн өмхий бах шиг бүлтгэр нүдээ эргэлдүүлэн тогооч бүсгүйн бөгс бөөрийг сэмхэн илээд арсайтал инээн “Өмхий бах хунгийн махыг идэж яагаад болохгүй гэж вэ? Идэж л таарна даа” гэж хэлж дуусаагүй байтал галын хайчны амт үзэв.

Барилгачид мах хараахан болоогүй байгааг үзээд цээж нүцгэлэн хиртэй нүүр гарын алчуураа мөрөндөө тохоод нуурын эргийг чиглэв. Бас хэдэн хүн саланд суун нуурын цээлийг зорилоо. Хэд гурван усч нөхдүүд нуурын голыг чиглэн пүл палхийтэл нохой самардан сэлэхэд саяхан нам гүм байсан нуурын мандал дээгүүр үймэрсэн усны шувууд ганганалдан нислээ.

Адилхан монголчууд байж тариалангийн бүсээс ирсэн энэ хүмүүс яахаараа монгол үндэстний лус савдгийн хорлолоос цээрлэдэг заншлыг ийм хурдан мартчихсаны учрыг Ян Кө ойлгохгүй байв. Бээжингийн илгээлтийн эзэн залуус нэгдэл, аж ахуйнуудад хуваарилагдахаас өмнө аймгийн зарим удирдлага болох хятад монгол дарга нар тэднийг хүлээн аваад “Тал нутагт очсон хойноо нутгийн ардын зан заншлыг хүндэтгэн үзээрэй. Ялангуяа монголын хээр тал усаар дутмагийн дээр монгол үндэстэн лус савдгийг дээдлэн шүтдэг тул нуур голд хувцсаа угаан, угаал үйлдэхийг цээрлэх хэрэгтэй. Түүхэнд исламчууд гол нуурын усанд биеэ угааж, монголчуудын ариун шүтээнийг бузарласнаас болж тэдний хооронд цус урсгасан тулалдаан олонтоо болж байсан удаа бий. Тийм болохоор нуур голын усанд сэлж болохгүй шүү” хэмээн аминчлан захиж байсан сан. Түүний улмаас усанд сэлэх дуртай Бээжингийн залуус хоёр ч жилийн турш өөрийн дуртай бахтай хэргийг тэвчсээр өдий хүрсэн юм. Гэтэл тариалангийн бүс нутгаас ирсэн эдгээр монгол үндэстнүүд тал нутгийн ёс заншлыг ийнхүү уландаа гишгэх юм гэж хэн санах билээ дээ.

Ян Кө тэр бүхнийг тэвчиж чадалгүй ухасхийн босоод Чэнь Жэньтэй цаашид яахыг ярилцахаар шийджээ. Тэр хэд алхгал шавар тагзны ханын шийрэнд тав зургаан том үндэс байхыг хараад палхийгээд явчихлаа. Арай хунгийн чинээ том цээнийн цэцгийн үндэс биш байгаа даа гэж тэр санаад гүйн очиж нарийвчлан ажиглав. Тэр урьд өмнө цээнийн цэцэгсийн үндсийг огт харж байгаагүй юм. Харин хонины толгойн чинээ энэ үндэс том том төмсөн

булцуутай ажээ. Цэцгийг тайрч хаясан болохоор дөнгөж цухуйсан хэдэн нахиа л үлджээ. Хамгийн том хэдэн үндсийг чийгтэй элс бүхий нэжгээд хувинд хийж тавьсан нь ургуулах санаатай бололтой.

“Энэ цээнийн цэцгийн үндэс мөн үү? Хаанаас тайрч ирсэн юм бэ?” хэмээн Ян Кө асуулаа.

Арь Шүнь түүний хариуд “Цагаан цээнийн үндэс байгаа юм аа. Уулнаас түүсэн. Харин яг хаанаас гэдгийг чамд хэлж чадахгүй. Хэд хоногийн өмнө машины тэвш шахмыг ачаад хот оруулан хятад эмнэлгийн хороонд зарсан” гэлээ. Бао Шүнь Гүй түрүүчийн удаа баахныг зарсан нь юу ч биш, хөлсний ажилчид наашаа орж ирээд уулын цээнэ цэцгийг үндсээр нь ухан үгүй хийж байгааг Ян Кө мэдээгүй явсан байж. Өөрийн эх нутгаа хүртэл хайрлах сэтгэлгүй энэ өөдгүй амьтад хүний нутагт ийнхүү дураар дургиж эхэлжээ.

Ян Кө гэртээ эргэн хариад Чэнь Жэнь, Гао Зянь Жун хоёрт өнөөдрийн үзсэн харсан болгоноо ярьж өгөв.

Чэнь Жэнь удтал дуугаа хурааж байснаа сая арай уужраад “Чиний саяын ярьсан болгон чинь хэдэн мянган жилийн турш зүүн азийн нүүдэлчин болоод суурьшмал үндэстний харилцааны хураангуй дүр зураг байна. Суурьшмал соёлд автсан нүүдэлчид эргэн тал нутаг руугаа халдаад түүний горьг аль аль нь амсдаг байсан юм” гэлээ.

Ян Кө түүний үгийг сайтар ойлгосонгүй “Аль аль тал горьг нь амсана гэдэг чинь юу гэсэн үг вэ? Адилхан нэг үндэстэй байж түүнийгээ шатаах гэдэг юусан билээ. Нүүдэлчин нь нүүдэлчнээрээ, суурьшмал нь суурьшсан чигээрээ байвал хэн хэндээ хал балгүй биш үү?” хэмээн асуулаа.

Чэнь Жэнь “Энэ жаахан дэлхий дээр хэн ч гэсэн сайхан амьдрахыг л бодно шүү дээ. Хүн төрөлхтний түүх гэдэг чинь угаасаа л харилцан тэмцэл, амьдрах орон зайгаа хамгаалахын төлөөх түүх байсаар ирсэн. Хятадын жижиг тариачид угаасаа л хамрын дорх хагалсан жаахан газраа гэсээр байгаад холч уужим ухаанаа гээчихсэн улс. Чи бидэн ч гэсэн наашаа ирээгүйсэн бол тэдэнтэй адилхан ухааны сүв битүү амьтад байх байсан юм” гэлээ.

Гадаа гурван нохой ширүүн боргоход Ян Кө “Энэ лав Ван гуай морь буцааж өгөхөөр ирж байх шиг байна” хэмээн хэлэв. Ууртай догшин Арслан Ван гуайг урчих шахан дайрахад цаадахь нь айсандаа Ян Көг дуудлаа. Ян Кө яаран гарч нохой хорин Ван гуайг оруулаад мориныхоо эмээлийг авав. Хагас өдөржин унуулсан морины хар хөлс гоожиж гөлөм чийгтээд уур савсахыг хараад Ян Кө гэрийн хаалгыг ууртай татан оржээ. Ван гуай архи сармисны үнэр ханхлуулан “Хунгийн махны амттайг гайхуулан ярина” Ян Кө түүнд хар төрүүлчихгүйн тулд өөхөн тосоо атгуулав. Цаадахь нь хагас сав өөхөн тосыг аваад арилж өглөө. Өглөөхөн үүлэн цацаг шүргэн нисэж байсан эр хун энэ мөчид Ван гуайн өмхий гэдсэнд сармистай холилдон байгаа гэж бодохоор Ян Көгийн сэтгэл шимшрэн уйлмаар санагджээ.

Тэр гурав хэсэг дуу шуугүй сууцгаалаа. Ван гуайг барьж аваад сайн гөвшөөд орхихгүй яасан юм бол оо? Гэвч хүний олноор хүч түрэх дуртай энэ үл бүтэх амьтдыг зодьё гээд сайнаа үзэхгүй, учир зүй яриад ч илжигний чихэнд ус хийсэн ч сэгсэрнэ, алт хийсэн ч сэгсэрнэ гэдэгтэй адил болохыг мэдэж байв. Одоо ганцхан хорьг хороор гэдэг шиг л үзэх ёстой

гэдгийг тэд ойлгожээ. Чэнь Жэнь, Гао Зянь Жун хоёр Ван гуайн салыг дахин сэргэхгүй болтол эвдье гэсэн саналыг уухайн тас дэмжив. Тэгсэн цагт хунгийн дэгдээхэйнүүд сая эсэн мэнд эндээс холдож чадна. “Ирэх жил хунгууд наашаа зүглэхгүй дээ” хэмээн Ян Көг санааширангүй өгүүлэхэд гурвуулаа дахин барайцгаалаа.

Гэвч тэд нар мөн орой багийн улс төрийн семинараар дээд шатны зааварчилгааг танилцуулах тул чөлөө авч болохгүй гэдгийг мартсан байжээ. Энэ нь тэдний салыг эвдэх ганц боломжийг тасалдуулж орхив.

Олонбулгийн талд хунгийн мах идэх эхлэлийг Бао Шүнь Гүй анчдын отог дээр тавьсан билээ. Тэр өдөр бусад анчид болон Ян Кө нар ам ч хүрээгүй тул Бао Шүнь Гүй ганцаараа давснаас өөр амтлагчгүй тогоотой усанд хунгийн махыг чанаад архиар даруулан идсэн болж билээ. Ямар сайндаа л тэр нутгийнхаа эрдэнэ шишийн шөлөнд чанасан галууны махнаас хунгийн мах илүү амттай байж чадахгүй юм байна гэж байхав.

Харин энэ удаа тэр барилгачдын байранд хүрэлцэн ирэхдээ хятад маягийн амтлагчаар амтлаж чанасан хунгийн махан шөлөн дээр бууж орхижээ. Дээр нь хэдэн арван хүн хуруудан дугараа барих тул ёстой л хар гэртээ хаан бор гэртээ богд байхын жаргалыг амссан байна.

Гэвч хунгийн мах хэмжээтэй, идэхийг санаархсан өмхий бахнууд олон тул Бао Шүнь Гүй, Ван даамал хоёр нэг том түмпэнтэйг тэврээд суучихаар нөгөө хэдэд шальтай юм оногдсонгүй. Хунгийн махтай найр өндөрлөхөд Бао Шүнь Гүй амаа шилэмдэн улс төрийн семинарыг даргалахаар явахад цаадуул нь үлдэгдэл дээр нь зодолдохоос наагуурхан юм бололгүй хаачихав. Хорхой нь гозгоносон золигнууд маргааш үүр цүүрээр зэгсэн тор малгайгаа өмсөөд хавчаахай нумаа барин дахин анд гарахаар тохиролцжээ. Бүр багтай араанд нь хийхийн тулд тэд нар Бао Шүнь Гүйгийн хагас автомат бууг ч түр хэрэглэхээр авсан байна. Хун агнаж чаддаггүй юм бол бор галуу, зэрлэг нугас ч болов агнаж бүгдээрээ сайхан гэдэс гарцгаая гэж тохирцгоожээ.

Хоёрдахь өдрийн хар өглөөгүүр Ян Кө, Чэнь Жэнь, Гао Зянь Жун гурав буун дуунаар цочин сэрцгээгээд хөлөө дэвсэн бухимдацгаалаа. Ян Кө галзуу амьтан шиг морио унан нуурын эрэг рүү хурдлахад Чэнь Жэнь ч гэсэн Гомбод хонио захин орхиод Гао Зянь Жун лугаа хамт араас нь давхицгаалаа.

Мань гурав сэтгэл түгшин мөнөөх салны гарч ирэхийг хүлээж байв. Нүдний өмнөх аймшигтай дүр зургийг Ян Кө, Чэнь Жэнь хоёр хараад төрөл төрөгсдөө алдсан мэт харууслаа. Салан дээр нэг том хун, хэдэн бор галууны хамтаар мөнөөх хоёр өндөг цусанд хутгалдан хэвтэнэ. Ижлээсээ хагацсан хөөрхий эм хун энэ хорвоод мэндэлж завдаагүй байгаа хоёр хөөрхөн үрээ гэсээр энэ аймшигт нуурт хоргодон үлдсэний горыг амсаж эр нөхрийнхөө хойноос одох нь тэр. Тархиа зад буудуулан хайртай ханиасаа ч золгүй өнгөрсөн тэр амьтан алаг үрсдээ эцсийн удаа ч болов илчээ өгье гэсэн шиг хос өндөгнийхөө дээр халуун цусаа асгажээ.

Хэрвээ хоёр өндгийг үүрэнд нь буцааж тавиагүй бол эм хун ийм эмгэнэлд унахгүй байсан ч юм бил үү гэж бодоод Ян Кө нулимсаараа нүүрээ угаана.

Ван ахлагчийг эрэг дээр гарч ирэхэд баахан хөлсний ажилчид, малчид болон илгээлтийн эзэд цугларсан байлаа. Ван гуай их л маадгар атлаа заналтай дүр эсгэн “Чи бас өөхөн тосоор өндөг солино гэж бодож байна уу? Мөн горьдов оо. Энэ удаа би өндөгнүүдээ Сяо Пэнд өгнө. Тэр өчигдөр намайг өвчтэй үхэр авахаар очиход хагас сав өөхөн тосоор хунгийн өндөг сольдог нь алдаатай наймаа болжээ гээд байсан юм. Тэр надтай бүтэн ваар өөхөн тосоор хунгийн өндөг солихоор тохироо хийсэн” гэв.

Түүнийг үгээ гүйцээгээгүй шахам байхад Сяо Пэн аахилсаар мориноос бугаад цустай өндгийг шүүрэн авч хонины ноос чихсэн цунхэндээ хийгээд буцаж мордон бараа туруугүй алга болов.

Хар ажилчид ч баяр тэмдэглэх гэж байгаа мэт олзоо аваад гал зуух руугаа явцгаажээ. Малчид тэднийг ууртайгаар харах зуур хятад хувцас өмссөн энэ монголчууд яахаараа тал нутгийн нандин шүтээн тэнгэрийн амьтанд аюумшиггүй халддаг билээ гэдгийн учрыг олж ядацгаана. Билиг өвгөн ч амьдралдаа анх удаа ийм айхтар зүйл үзэж байгаа тул ямаан сахлаа чичрүүлэн Ван даамалд “Тэнгэрийн ёсонд тэрсэлж, бөө мөргөлийн хувилгаан шувууг хөнөөдөг монголоо алдсан өөдгүй амьтад” хэмээн хараан зүхэв.

Ван даамал ч түүний савыг яаж хоосон буцаахав гэсэн шиг чанга дуугаар хашгичин “Чиний тэр бөө мөө чинь ямар хамаа байсан юм бэ? Тэгж яривал бид чинь Бурхан бодисатвагийн хөргийг эвдлээд хаячихсан улс. Наад бөө мөө гэж донгосдог чинь дөрвөн хуучинсагийн илрэл шүү” хэмээн загнав. Билиг өвгөн мөнх тэнгэрийн ёсоор Ван даамлыг номхруулж чадахгүй гэдгээ мэдээд Мао даргын улаан номын монгол орчуулгыг гарган эргүүлэх зуур Чэнь Жэньгээс “Аль ишлэлийг авбал энэ хогийн дээрэмчдийг засаж болохоор байна вэ?” хэмээн асуув. Чэнь Жэнь, Ян Кө нар дээд удирдагчийн сургаалын аль ишлэлийг хэрэглэвэл ховор шувууд агнасан этгээдийг номхотгож болохыг бодоод олсонгүй.

Барилгачид хүн хүч олонтойн дээр ардаа татаа чангаатай тул ус цас шиг монгол хэлээрээ Билиг өвгөнтэй зад хэрэлдэнэ. Малчид ч гэсэн тэдэнд мөчөөгөө өгөх янз алга. Маргалдагч хоёр тал бүгд монгол үндэстэн, ядуу дорд гарал үүсэлтэй, үндэс угсаа нэг мөртлөө нүүдэлчин суурьшмал соёлын мөргөлдөөнд ийнхүү татагдан оржээ. Хоёр талын маргаан улам ширүүсэн хамар хамраа тулгах дээрээ дөхөв. Лхамжав тэргүүтэй хэдэн омголон адуучид малиагаа шүүрэн дайрах янзтай болох үеэр Бао Шүнь Гүй амжин давхиж ирлээ. Тэр олон хүмүүсийн дундуур дайран ороод ташуураа толгой дээгүүрээ эргэлдүүлэн хашгичиж “Бүгдээрээ чимээгүй болцгоо. Нударга зөрүүлэхээр зориглосон хүн байвал пролетарийн диктатурын хэсгээс хүн ирүүлж бариулаад сахилгын гянданд хорино гэж мэдээрэй” гэхэд бүгд нам боллоо.

Бао Шүнь Гүй мориноосоо үсрэн бууж хунгийн өмнө хүрч ирээд “Хун гэдэг чинь Зөвлөлтийн ревизионистуудын дуртай амьтан. Бээжинд хунгийн тухай сахалтай Иваны жүжгийг тас хориглоод гол дүрийн жүжигчинг нь хүртэл шийтгэсэн гэдэг шүү. Гэтэл манай энд хунг өмөөрөөд байгаа тухай дээшээ дуулдах юм бол сүрхий юм болно гэдгийг мэдэж л байгаа биз дээ. Аягүйдвэл улс төрийн хэрэгт ч унахыг хэн байг гэхэв. . . . . Цөмөөрөө хувьсгалаа эрчимжүүлж, үйлдвэрлэлээ шуурхайлцгаая. Хэрвээ барилгын ажлын эрчийг хурдасгая гэвэл энэ хүнд ажилтай улс мах идэх хэрэгтэй байна. Гэтэл багийн зүгээс тэдэнд эцэнхий туранхай хонь малаа ч илүүчлэхгүй байхад тэд өөрөө өөрсдийгөө ийнхүү болгож байгаа нь

сайн хэрэг биш үү?” гэв.

Бао Шүнь Гүй олон хүмүүс рүү хандан “Энэ их ажилтай байхад энд юугаа хийгээд зогсоод байна вэ? Тарцгаа” гэхэд

Олон хүмүүс бүгдээр уур унтуутай тарцгаалаа.

Ян Көгийн уур гаралгүй байсаар гурван цаасан буу авч морио унан нуурын эрэг рүү очоод пис пас хийлгэн тэслэв. Зургаан удаагийн хүчтэй тэслэлтэнд бор галуу, зэрлэг нугас тэргүүтэй олон хэлийн усны шувууд зүг бүр тийшээ дэрхийн нислээ. Бао Шүнь Гүй уулын энгэр дээрээс ууртай амьтан эргэн давхиж ирээд ташуураараа Ян Көгийн хамар руу чичлэн “Чи хэдэн толгойтой болоод ахынхаа архины даруулгыг үргээж байгаа юм бэ? Чиний эсэргүү эцэг чинь тэрсүүд нөхөдтэйгөө засан хүмүүжүүлэх ангид байсаар байгаа гэдгийг мартаагүй биз дээ? Энэ барилгачин нөхөд бид нар болвоос бүгд ядуу дорд гаралтай улс. Чи биднээс суралцах учиртай” хэмээн хашгирлаа.

Ян Кө ч түүнд мөчөөгөө өгсөнгүй “Бид энэ нутагт илгээлтээр ирсэн болохоор юуны өмнө ядуу дорд гаралтай малчдаас суралцах ёстой биз дээ” хэмээн нүдээ бүлтийлгэн мэтгэлцэв.

Билиг өвгөн хэдэн адуучдын хамт ирээд түүний мөрнөөс түшин авч явлаа. “Чи энэ удаа цаасан буу тавьдаг чинь аавыгаа тун их баярлууллаа” хэмээн өвгөн хэлэв.

Ян Көгийн хожим дуулснаар өөхөн тосоор хунгийн өндөг сольдог Сяо Пэн болвоос ховор эд зүйлс цуглуулагч бөгөөд хунгийн өндгийг муутгахгүй хадгалах аргыг мэддэг байжээ. Тэр багийн “Хөл нүцгэн эмч”<sup>30</sup> болохоор тарианы зүүгээр өндөгний шар цагаан уургийг соруулан аваад нүхийг цавуугаар бөглөснөөр хоёр дэгдээхэй амьдрах аргагүй болсон боловч өндөгний хальсыг муутгахгүй хадгалах бололцоотой болжээ. Тэр аж ахуйн төв дээр хоёр жижиг шилэн хорго хийлгүүлэн шар торгоор өнгөлсөн эсгий дэвсээд өндөгнүүдийг урлагийн бүтээл шиг хадгалах болсон байна. Сяо Пэн энэ хоёр эрдэнэсээ авдрын мухарт хүнд үзүүлэхгүй хадгалж байгаад хэдэн жилийн дараа ажилчин, тариачин, цэрэг гаралтай оюутан элсүүлэхээр ирсэн албан хаагчид бэлэглэсний хүчинд мань эр талын хунгийн жигүүрээр дэвэн ниссээр хот орж их сургуулийн оюутан болсон гэдэг.

Дөрөвдэхь өдрийн орой Гао Зянь Жун үхрээ туугаад гэртээ эргэн ирэв. Тэр Ян Кө, Чэнь Жэнь хоёрт хандан их л аминчханаар “Ван гуайн худалдан авсан өвчтэй үхэр тэдний тагзнуудаас холгүйхэн чононд бариулсан байна гэнэ ээ” гэж яриу.

Нөгөө хоёр нь ч мэл гайхаж хоцров. Ян Кө ам нээж “Нээрэн ч барилгачид чинь туу гэх нохойгүй болохоор айхтар том гарзтай тохиожээ” гэлээ.

“Би тэдний тэрүүгээр очиход үхрээ байшингийн өмнө арван хэдэн алхмын тэртээд уядаг байсан юм билээ. Одоо зөвхөн толгой, дөрвөн тагалцаг, хэлхээтэй хэдэн яс л үлджээ. Ажилчдын хагас сарын хоолны мөнгөөр авсан үхэр шүү дээ. Дахиад л ногоо идэх нь гээд Ван гуай бөөн уур байдаг шүү” хэмээн Гао Зянь Жун инээснээ “Үнэндээ тэр үхэр гэдэсний цагаан хорхойтой болохоос биш нэг их сүртэй өвчингүй байсан ажээ. Ван гуай ч мал эмнэлэг жаахан гадарладаг болохоор гэдэсний хорхойг нь туулгаар хөөж гаргаад жаахан таргалуулж

байгаад нядлах санаатай байсан юм гэнэ. Гэтэл санаагаар нь болсонгүй чонын хоол болчихдог байна шүү” гэлээ.

Ян Кө болж гэсэн байдалтай уртаар санаа алдаад “Тэр муусайн тариалах орноос ирсэн люмпенгүүд шөнө орой үхсэн гахай шиг үхширтэл унтахаас биш малчидтай адилхан сонор сэрэмж хаанаас байх вэ? Олонбулгийн овсгоотой чононууд эдгээр цагаачдын бүтэлгүйг олж хараад гэрийн үүдэн дээр нь үхрийг нь цохичихоо мэдэлгүй яахав. Энэ он жилүүдэд чононоос өөр ядуу дорд тариачдыг элэг барих хэн байх билээ дээ?” гэлээ.

“Элэг барих биш, өшөөгөө авах гэх ёстой” хэмээн Чэнь Жэнь залрууллаа.

Ян Кө дахин уртаар санаа алдаад “Галт зэвсгийн үед чонон сүргийн өшөө авах боломж улам хомсодсоор л байна. Өвөрмонголын тал нутаг дахь сүүлчийн хунт нуурын амыг барьчихлаа. Надад хэрвээ дахин Бээжин рүү буцах боломж олддог юм бол би дахин “Хунт нуурыг” үзэж чадахгүй байх аа. “Хунт нуурыг” үзэх бүр л ихэмсэг хунгийн омог бардам тэргүүн тогоотой шөлөнд цуу цутгуулж байгаа дүр зураг санагдаад байж таарна. . . Би урьд нь хятадын сууршмал соёл өрнөдийн хүчирхэг соёлын нөлөөнд автах вий гэж эмээдэг байсан юм. Гэтэл тариачны суурьшмал соёл нүүдэлчдийн соёлыг ийм хэрцгий догшин сүйтгэдэг гэдгийг үнэхээр бодож байгаагүй шүү. ” гэв.

Гао Зянь Жун түүний үгийг таслаад “За тэр өнө холын юм ч яахав. Чонон сүрэг хаяанд ирчихээд байгаа тул бид хэд онцгой анхааралтай байх хэрэгтэй. Тэд манай гэрт бэлтрэг байгааг шиншилчихвэл бидний үхэр хоньд сүйд болж мэдэх юм шүү” гэлээ.

## Хорин дөрөв

*Цин Мү Гүн . . . . . Арван хоёр Рун улсыг мөхөөж нутаг дэвсгэрээ мянганы газарт өргөсгөөд баруун Рунгийн эзэрхэгч болжээ. Баруун Жоу улс мөхсөний хойно, баруун Жоугийн хуучин нутагт Рун Ди холилдон суужээ. . . . . Баруун Жоугийн соёл Рун Дигийн заншил болон Шангийн соёлд эвдэгджээ. Цин улс эдгээр хоцронгуй тогтолцоо болон соёлыг авч хэрэгжүүлсэн учраас хэдийгээр баруун этгээдийн их гүрэн болсон боловч Хуа Шягийн 31 олон ханлигуудад Рун Ди улс хэмээн харагдаж, түүний чуулганд оролцохыг эс зөвшөөрчээ.*

*Фан Вэнь Лань*

*“Хятадын нэвтэрхий түүхийн товчоон”*

Өвөрмонголын зуны шөнө яах ийхийн зуургүй орой намар мэт сэрүү татаад явчихдаг. Хэдхэн өдрийн ажин түжинг залгаад шумуулын аймшигт дайралт эхэлнэ. Хөглөрсөн ноосоо хяргуулж хөнгөрсөн хоньд шүдээ хяхруулан тайван хивцгээнэ. Арслан, Анч шар хоёр толгой өргөн агаар үнэрлэж байснаа Ирвэсийг гурван гөлөгтэй нь дагуулан хотны баруун хойгуур эргэж тойрно.

Чэнь Жэнь гар чийдэнгээ асаан хоттой хоньдын баруун хойхонтоо ширдэг дэвсэн хуучин хөдсөн дээлээ хэдрээд завилан суулаа. Шинэ нутагт ирснээс хойш хонь хариулах, шөнийн манаанд гарах, ноос хяргах, бэлтрэгээ тэжээх, ном унших, тэмдэглэл хөтлөх түмэн ажлын зэрэгцээ өдөр урт, шөнө богино болохоор хангалттай сайн унтаж амжихгүй байлаа. Тийм болохоор хэвтээд өгвөл ноход яаж ч хуцалдаж байсан сэрэхээргүй унтаад өгч мэднэ. Тэр уг нь шумуул гараагүй байгаа хэдэн шөнийг ашиглан унтаад өгөхөд болохгүй газар үгүй боловч талын чоно чухам тийм л сиймхийг анддаггүй их мастер болохоор яахин сэрэмж алдаж болох билээ.

Хэдэн чоно барилгачдын өвчтэй үхрийг шоглочихсоноос хойш тэр гурав улам ч сэрэмжтэй байх болжээ. Чонон сүрэг өвчтэй үхрийг идсэн нь тэд зээр, тарвага, зурмыг орхиод арай өөр зүг хөдлөлөө шүү гэдэг дохиог малчдад өгч байгаа юм. Зээр өсөж томроод гүйцэгдэхээ байсан, тарвага зурам ч илүү сонор соргог болсон тул талын өлөн чонод мал сүрэг рүү дайрч эхэлжээ. Шинэ нутаг бэлчээрт хүн малгүй сайтар дасаж амжаагүй тул Билиг өвгөн хэдэн ч удаагийн үйлдвэрлэлийн хурал дээр хэсгийн малчид илгээлтийн эздэд онцгой сэрэмжтэй байж унтдаг юм бол ядаж чоно шиг нүдээ аньчихаад чихээ сортойлгож байгаарай даа хэмээн захисан билээ. Ингэснээр Олонбулгийн талд бас л нэг удаагийн хүн чонон дайн дэгджээ.

Чэнь Жэнь өдөр болгон бэлтрэгний хэвтэр, баас шивтрийг арилгаж цэвэрлээд дээгүүр нь шороо цацдаг болжээ. Ингэснээр бэлтрэгийг өвчин олуулахгүй ариун цэврийн дэглэм сахиулахаас гадна чонон сүрэгт хэн болохыг таниулахгүй байх зорилготой юм.

Чэнь Жэнь ойрын хэдэн өдөр бэлтрэгийг үүрнээс нь гэртээ авчирч байсан үеийн нарийн ширийн бүхнийг толгойгоо өвдтөл боддог болов. Эргээд бодоход бүхий л зүйл дээр алдаа гарган өлөгчин чононд сэжүүр өгсөн байж мэдэхээр санагдана. Тухайлбал хуучин нутагт байхад өлөгчин чоно бэлтрэгний шивтрийг шиншлэн мэдэх бүрэн боломжтой. Тэр шөнө болгон чонон сүрэг хоньд руу нь дайрч бэлтрэгийг булаагаад зугатах вий гэж санаа зовнино.

Түүний ганц олзуурхууштай нь шинэ нутаг руу нүүхдээ бэлтрэгийг шээзгийнд хийж ганц удаа буулгаж ул мөрийг үлдээгээгүй явдал юм. Тэгснээр өлөгчин чоно хуучин буурин дээр бэлтрэгний үнэрийг авч болох ч чухам хаашаа аваачсаныг мэдэх аргагүй.

Агаарт чонын үнэр үгүй байгаа бололтой овоо томорсон гурван паацгар гөлөг түүнийг бараадан ирж эрхлэлээ. Анч Шар, Ирвэс хоёр ч мөн тэднээс хоцорсонгүй. Гагц ажил үүрэгтээ үнэнч Арслан л хотны баруун хойхно зогсчихоод шөнийн харанхуйг харуулдана. Тэр ердийн нохойноос илүү чонын араншинг сайн мэдэх болохоор тэднээс дутуугүй сэрэмжтэй байх ажээ.

Шөнийн салхи улам жихүүсэхэд хоньд бөөр бөөрөө нийлүүлэн улам шахалдав. Гурван гөлөг ч мөн Чэнь Жэньгийн хөдсөн дээлийн хормой руу шургаллаа. Шөнө дундаас хойш Чэнь Жэнь хажуухандаа байгаа хонин сүргийг багцаалах аргагүй өтгөн харанхуй нөмрөв. Шөнө дундаас хойш салхи намжсан боловч жихүүцэх нь улам нэмэгдсэн тул Чэнь Жэнь нохдоо байх газар руу нь явуулаад дээлээрээ биеэ чанга ороон гар чийдэнгээ асаагаад хоттой хоньдоо хоёр тойрчээ.

Чэнь Жэньг ширдэг дээр дөнгөж буцан суух үед холгүй байх толгодын тэртээгээс чонын сэтгэл сэрхийлгэм уртаар улих дуун “Ау. . . .Ау. . . .” хэмээн сонсогдлоо. Чонын цээлхэн жигд улиан эрч хүчийг илтгэн энгүй холд дуурсана. Түүний улиан чичирхийлэн төгсөхтэй зэрэгцээд зүүн, өмнө, умард гурван өндөр уулсын бүдэг давтсан цууриа нь тал хөндий, хотгор хонхор, зүлэгт тан, нуурын мандлаар дамжин намуун салхины аясаар найгах зэгсний шаргианд уусаж чонын улиан, зэгсний шаагиан, салхины исгэрээ хоршсон яруу найрлыг үүсгэвэй. Энэхүү жихүүн аялгуу Чэнь Жэньгийн бодлын оронг аглаг Сибирийн тайгад аваачих шиг.

Чэнь Жэнь хавь ойрд шөнө дундын нам гүмийн дунд талын чонын шөнийн хоршлыг ийм нарийн сонсож байгаагүй билээ. Түүний голд хүртэл жихүүцэл хургаад хөдсөн дээлээ улам чанга ороосон боловч мөсний ан завсраас гарсан мэт жихүүн авиа хөдөрсөн дээлийг нэвтлэн зулайн арьсыг цоолоод нуруу нугасыг дамжин ахар сүүжинд хүрэх шиг санагдав. Тэр анч Шарыг энгэртээ наахад арай дулаацах мэт болжээ.

Уйтгартай урт оршил аялгуу замхрахад залгуулаад хэдэн том чонын эршүүд найрал аялгуу өндөр хоолойгоор ульж гарлаа. Энэ удаагийн чонын улианд нийт багийн бүх хот айлын ноход шаагисан хуцалтаар хариу барив. Чэнь Жэньгийн ойролцоо байсан том жижиг ноход ч баруун хойд зүгт хонин сүргээ хүрээлээд ширүүн хуцаж гарлаа. Арслан чонын ульсан зүг рүү ухасхийн дайрсанаа ар хударгаар дайрч магадгүй гэж айсан уу, хонин сүргээ бараадан эргээд чанга чанга хуцав. Хотгорын уулсын энгэрийг бараадан эгнэсэн хот айлуудын шөнийн манааныхан бүгд гар чийдэнгээ гялалзуулан зуу гаруй ноход хагас цаг шахам хуцсаны хойно сая арайхийж нэг юм намжив.

Харанхуй шөнийн жихүүнд нохдын хуцах чимээ намжихад тал нутаг даяар зэгсний сэрчигнээг сонсож болохуйц нам гүм болжээ. Удалгүй мөнөөх гоцлон дуулаач чоно дахин ульж эхлэв. Түүний хариуд умард өмнөд баруун талын гурван уулын тэртээгээс улам ч олон чоно улилдахад тэдний улиан сүрлэг хана болон босоод хот айлыг бүслэн авч, нохдын хуцах чимээг ч дармаар сүрлэг сонсогдов. Нийт багийн сүрэг ноход улам ч улангасан хуцалдлаа.



Айл бүрийн шөнийн манаанд гарсан эмэгтэйчүүд чоно ульсан зүгт гар чийдэнгээ гялалзуулан өндөр дуугаар “Ай хай. . . . Уу. . . . хай. . . ” хэмээн хашгиралдлаа. Тэдний цангинасан хоолой сүр жавхлантай давалгаа болон хувирч чонон сүргийн зүг дайрав. Тал нутгийн уртын дуучид шөнийн манаанд чоно үргээх гэж хашгирсаар тийм цээлхэн хоолойтой болсон ч юм бил үү?

Ноход эздийнхээ сүрэнд дулдуйдан улам хүчтэй боргоцгоов. Нохдын хуцах, боргох, архирах, сүрдүүлэх чимээ тэр гэхийн тэмдэггүй нижигнэх дайны их хэнгэргийн дуу мэт тэнгэр газрын энгээр дуурьсахад анч догшин ноход удахгүй эхлэх сүрт тулалдаанд дайран ороход бэлэн болжээ.

Чэнь Жэнь ч амьхандаа хоолой шахан хашгирах боловч талын охид бүсгүйчүүд болон нохдын цангинасан эрчтэй дууны хажууд нялх тугалын мөөрөөн төдийхөн тул шөнийн агаарт замхран арилна.

Тал нутагт хавь ойрд ийм өргөн цар хүрээтэй дуу гэрэл цахилгааны хамгаалах дайн болоогүй юм. Шинэ нутагт хот айлуудаа ийм нягт шигүү тараан байрлуулсан нь малчдад гэрэл дууны хариу цохилт үзүүлж, нам гүмхэн тал нутгийн нэгэн хэвийн шөнийн амьдралыг бачим түгшүүртэй дайны уур амьсгалтай болгожээ. Агшин зуурын төдийд Чэнь Жэньгийн урам зориг сэргээд “Хэрвээ тал нутагт чоно байхгүй байсан бол нүүдэлчид оюун санааны хувьд унтаа үндэстэн болон хувираад түүний хор нөлөө дотор газар ч тусаж, хятад үндэстэн цагаан хэрмээ байгуулах хэрэггүй байсан байж мэдэх юм. Тэгвэл хятад үндэстэн айх аюулгүй атаат дайсангүй амар жимэр тогтоол нуурынхаа ёроолд бүрмөсөн мөхөх байсан ч юм бил үү?” хэмээн бодов.

Чонон сүргийн улиан дарагдан нам жим болов. Өлзий болон Билиг өвгөн хоёрын зохион байгуулсан шигүү байрлал ач тусаа өгч, чонон сүрэг хот айлуудад халдахын аргагүй гэдгээ мэджээ.

Чэнь Жэнь гэнэт төмөр гинжний харжигнааныг сонсоод бэлтрэгний дэргэд гүйн очив. Өдөр халуун нар халдах дайснаасаа хол амарч тэнхэрсэн бэлтрэг энэ мөчид араа шүдээ ярзайлган цовхчих нь хүн чоно нохдын улиан хуцаан хашгираан болон гэрэл цахилгаан ашигласан дайнд оволзон хөөрсөн бололтой. Тэр төмөр гинжээ тасар татан хаяад холгүй байгаа дайсныхаа хүрээ рүү дайран орж чадахгүйдээ тэчъяадан байгаа нь илт. Бэлтрэг болзошгүй дайнд оролцож чадахгүй өнгөрчихвөл өмнөө байсан махыг үмхэж чадалгүй алдсанаас ч илүү харамсалтай хэрэг хэмээн санасан бололтой аахилна.

Харанхуйд дуртай чоно шөнө дунд хамаг биеийн эрч хүч бадардаг шиг, тулалдах одонд төрсөн чоно харанхуй шөнө халз тулаанд дайран орохоор омогшин хөөрөхөөс ч яах билээ. Харанхуй шөнө гэдэг талын чонын айлын хот руу дайрч, ан гөрөөний олзоо хуваан амаараа дүүрэн мах үмхлэн, цус сордог цаг бус уу. Гэтэл төмөр гинж, түнэр харанхуй нүх хоёр түүний шөнийн дайнч зан чанарыг хорьсон нь харин ч хий гаргалгүй хав тагласан өндөр даралтын тогоо хэзээ мөдгүй дэлбэрэх гэж байгаа мэт болгож орхижээ. Тэр төмөр гинжийг тасалж чадахгүйгээ мэдээд галзуурсан мэт уурлаж цамнаж гарлаа. Дайнч омогтоо шатсан бэлтрэг ноосон бөмбөг шиг биеэ хурааж байснаа гэнэт тэсрэн сунаж чонын хүрээг тойрон ааг амьсгаагүй гүйж эхлэв. Тэр ийнхүү гүйхдээ ийш тийш хий хазлан, огцом зогссоноо ухасхийн дайрч, дорoo

өнхрөн, шүдээ тачигнуулж, толгойгоо сэжлэх нь аварга том анг барьж аваад амин газар нь хазан үхүүлж байгаа дүр зургийг илтгэнэ.

Хэсэг зуур ийнхүү цамнаснаа чонын хүрээний хойд талд оцойн суугаад чих талбин чагнаж өчүүхэн төдий чимээ л гарах юм бол хий хоосонтой үхэлдэн тулалдаж эхлэнэ. Чонын дайнч зөв совин тэртэй тэргүй түгшүүртэй байсан дайны цагийн уур амьсгалыг улам өдөөлөө. Тэр дайсан нөхрөө ялгахгүй тул болзошгүй дайнд оролцуулах л юм бол аль ч талд ордог бай хамаагүй, ганц гөлөг бэлтрэгний алийг ч хазан алсан сэтгэл ханахаар байдал илт байлаа.

Бэлтрэг Чэнь Жэньг хүрэлцэн ирэхийг үзээд дайран ирсэн боловч гинжиндээ татагдан хэдэн алхам ухрав. Чэнь Жэнь нэлээд айсан байдалтай чонын хүрээ рүү орж явган суутал бэлтрэг өлөн барс гөрөөс барих мэт түүний өвдгийг шүүрэн авч хазахыг завдлаа. Азаар Чэнь Жэнь бэлтгэлтэй байсан тул гар чийдэнгийн гэрлээ бэлтрэг рүү тусгаж холдуулав. Бэлтрэг хориондоо хэтэрхий цухалдан багтарч байгаа болохыг Чэнь Жэнь үзээд сэтгэл нь ихэд үймэрнэ.

Багийн бусад айлуудын ноход хуцаж эхлэхэд Чэнь Жэньгийн ноход ч тэднээс хоцорсонгүй, заримдаа бэлтрэгний дэргэд гүйлдэн ирэх боловч удалгүй хоньдынхоо дэргэд буцан очих ажээ. Гурван бяцхан гөлөг дайнд оролцогчийн хувиар цовоо цолгин хуцалдах нь түүнээс хэдхэн алхмын зайд байгаа бэлтрэгийг уурлуулан дагжин чичрээх ажээ. Түүний зөн бэлгэ, омог бардам дайнч занг ийнхүү үл ойшоож байгаа нь хичнээн зовиуртай агаад яадаг ч байсан энэ шөнийн тулалдааны гадна үлдээхтэй эвлэрч чадахгүй нь гэдгийг гагц Чэнь Жэнь л ойлгож чадахаар байв.

Бэлтрэг том нохдын эршүүд дайчин хоолойг толгой гилжийлгэн атаархсан байдалтай сонсож байснаа доош тонгойн ноход шиг хуцаж чадахгүйгээ олж мэдээд анх удаа их л гутрах мэт болов. Гэвч тэр гэнэт энэ эвгүй байдлаа засья гэсэн шиг амаа ангалзуулах нь нохдын хуцахыг сурах гэж оролдож байх шиг санагдана. Энэ Чэнь Жэньгийн санаанд багтамгүй хэрэг тул тэр доош суугаад бэлтрэгний үйл хөдлөл болгоныг ажиглаж байлаа. Бэлтрэг амаа ангалзуулан гав гув гэх эв хавгүй дуугарахаас биш нохдын хав хав гэх авиа эс сонсогдох ажээ. Тэр маш их бухимдах боловч хэрээ тавихгүй хоёр бөөрөө хонхолзуулан нохдын хуцалтыг дууриах боловч урьдын адил нохой гэхэд нохой биш, чоно гэхэд чоно ч биш этгээд авиа гарах тул арга барагдан дороо эргэцнэ.

Чэнь Жэнь бэлтрэгний арга ядсан байдлыг хараад тун их өхөөрдөв. Чоно шиг ульж ч чадахгүй түүний хувьд нохой шиг хуцаж сурна гэдэг хичнээн хэцүү байх нь ойлгомжтой. Нохой чоно хоёр хэдийгээр нэг өвөгтэй гэдэг боловч хувьслын явцад дэндүү холдоцгоож дээ. Олонх ноход чоно шиг ульж чаддаг бол нохой шиг хуцаж сурья гэдэг чоно байхгүй төдийгүй том боохойнууд түүнийг таашаадаг ч үгүй байж таарна. Харин нохдын дунд өссөн бэлтрэг хуцаж сурахаар оролдож байгаа нь өөрийн хэн гэдгээ эс мэдсэний илрэл байлтай.

Бэлтрэг бачимдахын хэрээр хуцаж сурах гэж улам их улайрна. Чэнь Жэнь түүний дэргэд чихэнд ойртон нохой шиг хуцаж үзүүлэв. Бэлтрэг эзнийхээ зааж өгөх гэж байна гэдгийг ойлгох боловч царайд нь бүтэлгүй шавийн төрх тодорч байснаа улмаар ууртай сурагчийн харц илрэв. Арслан түүний дэргэд гүйж ирээд удаан атлаа чанга чангаар хуцах нь тэвчээртэй багшаас өөрцгүй харагдана. Гэнэт Чэнь Жэнь бэлтрэгний “Хав хув” хэмээн нохойтой нэлээд

төстэй хуцах чимээг олж сонсов. Хэдийгээр нохойны хав хав хэмээн хуцахаас тэс өөр боловч бэлтрэг өөрийн амжилтандаа их л урамшин бахдаж байгаа шинжтэй Арслангийн уруул амыг долоолов. Дараа нь бэлтрэг зургаа долоон минутын зайтай “Хав хув” хэмээх дуугаа гаргах бүрд Чэнь Жэнь элгээ хөштөл инээж байлаа.

Түүний энэхүү тэр гэхийн тэмдэггүй хачин авиа том ноход гөлөгнүүдийн анхаарлыг татсан бололтой бүгдээрээ давхин ирж шоолонгуй харцгаана. Чэнь Жэнь ч эг маггүй хөхрөн түүний “Хав хув” гэх тоолонд “Жан жан” хэмээн дуугарахад хот даяар “Хав хув, жан жан” гэх авцалдаагүй авиа сонсогдож байлаа. Бэлтрэг ч хүн ноход өөрийг нь шоолоод байгааг ойлгосон бололтой улам ч бачимдуу дуугарах болов. Гөлөгнүүд түүний эргэн тойрон хөгжилдөн ноцолдож байснаа хэдэн минутын дараа бүх багийн ноход нам гүм болцгоолоо. Бэлтрэг ч нохдын хуцалт намжихыг дагалдан чимээгүй болов.

Нохдын дуу намжингуут гурван талын уулнаас чонон сүргийн улиан дахин хүчээ авах нь сонсогдов. Энэхүү дуу авиа, сэтгэл зүйн дайн таван удаа халз явагдсаны эцэст хүн ноход бүгд хашгирч хуцсаар ядарцгаажээ. Бөөнөөрөө хомрогolon дайрахдаа эрлэгийн элч мэт чимээ гаргадаггүй чонон сүрэг энэ удаа ийм их дуу чимээтэй байгаа нь цаанаа дайрах санаа агуулаагүй хий хоосон сүрийг үзүүлж байгаа хэрэг ажээ. Гурван талын уулнаас чононууд дахин дуу дуугаа авалцан ульж эхлэхэд хүмүүс гар чийдэнгээ унтраан, хашгиралдахаа болиод нохдын дуу ч илт цөөрчээ. Чонодын улиан дахин ширүүсэх нь цаанаа ямар нэгэн далд нарийн ов мэх агуулсан байгаа гэдгийг Чэнь Жэнь мэдэж байлаа. Сүрэг чоно хүн нохдын маш шигүү хамгаалалтыг үзээд оюун санаа бие бялдрын хувьд ядрааж байгаад гэнэдүүлэн дайрах гэж байж мэдэх юм. Иймэрхүү дуу авианы дайн хэдэн ч өдөр үргэлжилж магадгүй. Найман замын цэргийн партизаны отрядууд “Дайсан амарвал бид дайрна” гэсэн тактик барьж, хөндий төмөр хоолой дотор цаасан буу тэслэн пулемётын чимээ гаргаж дайснаа айлгадаг байсан тухай Чэнь Жэнь эргэн санав. Гэтэл тэрхүү дуу авиагаар дайснаа төөрөгдүүлэх энэ аргыг талын чонод хэдэн түмэн жилийн өмнөөс мэддэг байжээ.

Чэнь Жэнь анч Шарыгаа дэрлэн газар жаахан хажууллаа. Хүн нохдын чимээ гарахгүй тул тэр чонын улианыг анхааралтай чагнан чухам юу хэлэлцэж байгааг мэдэх гэж оролдов. Тал нутагт ирсэн цагаасаа хойш Чэнь Жэнь чонын улианыг ч маш их сонирхох болсон юм. Сонссон хүний зүрхийг чичрээдэг болохоор чонын улиан хятад нутагт ч их алдартай. Ямар сайндаа л хятад хүмүүс чонын улианыг чөтгөрийн дуутай адилтгаж байх билээ. Тэр тал нутагт ирсэнээс хойш чонын улианыг юман чинээнд тоохоо больсон боловч яахаараа тэд “Ау уу, ау уу” хэмээн уйлж байгаа юм шиг сэтгэл сэмэрмээр гунигтай ульдагийн учрыг ерөөсөө олдоггүй байлаа. Дотор газрын хань ижлээ алдсан бүсгүйчүүд л булшин дээр нь тиймэрхүү янзтай уйлж байгаа харагддаг. Чэнь Жэнь анх удаа чонын “уйлааныг” сонсоод хорвоод хосгүй эр зоригтой амьтны дуу хоолой яахаараа ийм зовлон гуниг дүүрэн байдаг байна вэ гэж ихээхэн гайхаж билээ. Тал нутагт оршин амьдрахын төлөөх амаргүй тэмцлийн явцад үй олноороо өлсөж, хөлдөж, алуулж үхсэн болохоор өөрийн гаслант хувь тавиландаа гомдон ульдаг юм болов уу? Гаднаа хэрцгий догшин төрхтэй чонын дотоод сэтгэл уян зөөлөн, эмзэг нандин ч байж мэдэх юм гэж Чэнь Жэнь бодож үзсэн удаа бий.

Харин чонотой хоёр жил харьцсаны сүүлийн хагас жил гаруй хугацаанд тэр энэ бодлоо үгүйсгэх болжээ. Хагуу чанга сэтгэл, халшрам гашуун хувь тавилантай чоно эр эм гэлтгүй

бүгд эцсийн цусаа дуустал тулалдан, эгц харсаар үхдэг. Чонын үгсийн санд уян зөөлөн гэсэн үг байдаггүй болохоор бэлтрэгээ алдсан өлөгчин чоно, хөлөө тас хазсан эрэгчин чоно бүгд л түр зуурын зовлонг өшөө авах боломж болгон хувиргаад улам ч улайрсан дайралтыг хийдэг. Бэлтрэг тэжээсэн хэдэн сарын хугацаанд түүний энэ бодол улам ч батажсан юм. Бэлтрэг хэвийн нойр хүрч нозоорохыг эс тооцвол ямар ч үед нүд нь цогтой гялалзан, сэргэлэн цовоо үсэрч тонгочихоос биш, улбайж сулбайсан байдлыг ерөөсөө гаргадаггүй. Хэдийгээр тэр хоёр адуучинд хүзүүгээ таслуулах шахсан боловч удаж төдөлгүй хуучин байдалдаа орсон юм даг.

Чэнь Жэнь чонын улианыг сонсоод айлгаж сүрдүүлсэн өнгө аяс байгааг ойлгов. Гэтэл яахаараа тэд “уйлаанаараа” хүн малыг айлгах гэдэг билээ. Тэд ойрдоо хүн болон байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан том гай барцдад өртөөгүй болохоор ингэтэл шаналаад байх учиргүйсэн. Арай малчдын ярьдагчлан чонын “уйлаан” хүн малын үсийг өрвийлгөж, тулалдахаас өмнө сүр сүлдийг нь үхүүлэх гэдэг юм болов уу? Талын чоно арай сэтгэл зүйн хувьд сүрдүүлэх тактикийг мэддэг юм биш байгаа. Малчдын ярьдаг оргүй зүйл биш боловч чонон сүрэг яахаараа хань ижлээ эрэх, ав хомрог зохион байгуулах, хол байгаа нөхдөдөө ан амьтны байдлыг мэдээлэх, олзоо хуваах гээд юм бүхэн дээр энэ уйлаанаа хэрэглэдэг хэрэг вэ? Энэ бүхэн чинь сэтгэл зүйн дайнтай хамаагүй эд шүү дээ.

Тэгвэл талын чоно уйлах дуун үүсгэдэг нь чухам ямар учир шалтгаантай юм бол оо? хэмээн Чэнь Жэньгийн бодол шөвөгний үзүүр мэт асуудлын голыг чиглэлээ. Хатуу чанга араншинтай чоно зарим үед гаслан гуних тохиолдол байж мэдэх боловч тэд ямар ч цаг үед хаана ч байсан, уурлаж баярлах, гаслаж гуньсаны улмаас уйлна гэж үгүй. “Уйлаан” гэдэг хэрхэвч чонын зан араншингийн үндсэн хөг байж таарахгүй хэмээн Чэнь Жэнь бодов.

Шөнийн хугас чоно нохдын улих, хуцах дууг сонссоор Чэнь Жэньгийн нойр бүр сэргээд ирлээ. Байнга харьцуулан жиших гэдэг аливаа нууцыг тайлах түлхүүр билээ. Тэр гэнэт чонын улиан, нохойн хуцалтын ялгаанд асуултын хариулт нуугдаж байж мэдэх юм гэж боджээ. Тэр чонын улиан, нохойн хуцалтын ялгааг харьцуулан жишвээс ноход ойр ойр богино хуцаж, чоно уртаар ульдаг ажээ. Энэ хоёр авианы үр дүн туйлын адилгүй байсан нь юу гэвээс чонын уртаар улих дуу, нохойн богино хуцалтаас хавьгүй өргөн, хол орон зайд тархаж байлаа. Багийн хамгийн хойд талын монгол гэрийн нохдын хуцах чимээ тэр хавиас сонсогдох чонын улианд дарагдана. Түүнчлэн Чэнь Жэнь зүүн уулын тэртээд байгаа чонын улианыг сонсож байхад нохдын дуу тэнд хүртэл сонсогдоно гэж үгүй юм.

Чэнь Жэнь аажмаар асуултынхаа хариуг олов. Чоно хэдэн арван сая жилийн байгалийн хувьслын явцад чухам уйлах мэт уртаар уянгалуулан улих нь л тал нутагт хамгаас өргөн уудам орон зайд тархаж чаддагийг олж мэдсэн байх нь. Энэ нь ойр байгаа лимбэ, хол байгаа бишгүүр лугаа адил сонсогддогтой агаар нэгэн юм. Богино цангинасан хөгтэй лимбэ үнэндээ нүргэлсэн яруу бишгүүртэй адил хол дуурсаж чаддаггүй билээ. Эртний морин цэргүүдийн эршүүд дуутай эвэр бүрээгээр дохио өгөх болон сүмийн хонхны нүргэлсэн хонх зэрэг хол дуурсдагаараа зартай биш үү?

Талын чонод хол гүйдэлтэй, тархан тандаж, хуран дайрахдаа сайн. Чоно нөгөө талаар асар уудам орон зайд сүрэглэн дайтаж ан барьдаг амьтан. Хол орон зайд хэл чимээ дамжуулан, сүргээр дайтахад дөхөмтэйг бодолцон, чонон сүрэг тал нутгийн хамгийн дэвшилттэйд тооцогдох дохионы дуу авиаг сонгон авсан байх нь. Хатуу ширүүн тулалдаанд эцсийн үр дүн

л чухал болохоос биш, уйлах, инээх сайхан муухай дуу гэдэг чонын хувьд ямар ч хамаагүй асуудал. Хүчирхэг арми шилдэг холбооны хэрэглүүртэй байх хэрэгтэй шиг, шилдэг холбооны арга хэрэгсэл армийн хүч чадлыг нэмдэг билээ. Эртний чонон сүрэг чухам тал нутгийн дэвшилт холбооны хэрэглүүр болсон улианыг ашигласнаар өөрсдийн байлдах чадварыг нэмэгдүүлэн, хүнийг эс тооцох юм бол хамгийн хүчирхэг арми болон хувираад бар, ирвэс, баавгай зэрэг өөрсдөөсөө илүү хүчтэй дайснуудаа хээр талаас хөөн гаргаж чадсан байж болох юм.

Балар эрт цагт ноход холбооны хэрэглүүрийн хувьд чононоос хоцрогдонгүй болохоор хүний нөмөр нөөлөг дор орж гэрийн амьтан болон хувирсан нь гарцаагүй хэмээн Чэнь Жэнь бодлоо үргэлжлүүлэв. Талын чонын эрх чөлөөтэй, бие даасан, хатуу зоримог зан чанар нь өөрийн гаргууд чадвартаа дулдуйдсан ажээ. Хүн ч мөн түүнээс өөрцгүй бөгөөд аливаа нэгэн үндэстэн чадвар мөхөс, зан араншингийн хувьд сул дорой байх аваас, хичнээн бие даасан эрх чөлөөтэй, ардчилсан баян чинээлэг байя гэж бодоод ч хоосон мөрөөдөл төдийхөн хоцорно. Чадвар сайтай болохоор л чонын зориг агуу их, чонын агуу зориг нь эргээд чадвараа тэтгэдэг ажгуу хэмээн бодоод Чэнь Жэнь уртаар санаа алдав. Талын чонын хүмүүнд хайрладаг ухаарал, сургамж шавхагдашгүй ажээ. Дэлхийн дайдыг морин туурайгаар дэлдэж явсан монголын морьт цэргүүд харилцаа холбооны хэрэглүүр дээр ч гэсэн чононоос суралцаад эртний тулааны талбар дээр дуурьсаж байсан үхрийн эвэр бүрэн дуу хичнээн олон тулалдаанд зоригт эрсийг уриалан дуудаж байсан бол доо.

Чонын улиан аажмаар шингэрлээ. Гэнэт нарийхан цангинасан чонын улиан хонин сүрэг болоод монгол гэрийн араар сонсогдлоо. Чоно арай хоньдын араас дайран ороод ирэх нь энэ үү хэмээн Чэнь Жэнь давхийн бодов. Тэр малиа гар чийдэн хоёроо шүүрэн аваад ухасийн бослоо. Тэр гэрийнхээ өмнө гүйн очиход Арслан бусад том жижиг ноходтой хамт бэлтрэгийг тойрчихсон хуцаж байх нь тэр.

Гар чийдэнгийн гэрэл дор модон шонд уясан бэлтрэг тэнгэр өөд харчихаад уртаар ульж байлаа. Сая түүний сонссон чонын улиан чухам түүний дуу байжээ. Бэлтрэг бас ульдаг байх нь. Чэнь Жэнь анх удаа бэлтрэгний улианыг сонсож байгаа нь энэ бөгөөд тэр уг нь нас бие гүйцсэн чоно л ульдаг байх гэж бодож байсан юм. Гэтэл дөрөвхөн сартай энэ жаахан бэлтрэг шөнө дунд гэнэт улихаар үл барам түүний төрх байдал хүртэл нас бие гүйцсэн чононоос огт өөрцгүй ажээ. Чэнь Жэнь энэ бүхнийг хараад догдолсондоо түүнийг тэсгэлгүй тэвэрч аваад үнсмээр санагдав. Гэвч тэр бэлтрэгний анхны дууг таслалгүй ойр зайнаас өөрийн хайртай бяцхан амьтны хэрхэн дуулахыг сайтар харж авья хэмээн боджээ. Нэг залуу эцэг өөрийн бяцхан үрийн анх дуулахыг сонсоод тэсгэлгүй баярлах нь Чэнь Жэньтэй ижил байх байсан болов уу? Тэр тэсгэлгүй бэлтрэгний ууцыг илэхэд цаадахь нь ч гэсэн гарыг нь долоосноо залгуулаад уянгалуулан дуулж эхлэв.

Ноход түүнийг хазаад алчих уу, эсвэл дуугүй болгох уу гэдгээ шийдэж ядсан байдалтай бүр алмайрч хоцорлоо. Гэнэт хоньдын дундаас өстнийх нь дуу гараад эхлэхээр хэсгийн бусад ноход ч учраа олохгүй үймэлдэж эхлэлээ. Гомбын нохой хуцахаа байгаад хөрш айлуудын хэдэн ноход тэдний хотонд чухам юу болоод байгааг харах гэж ирээд туслахад бэлдэн зогсоцгоов. Гагцүү Арслан л чонын хүрээнд баяртайгаар явж ороод бэлтрэгний толгойг долоож байснаа түүний хажууд хэвгэн улианыг чих тавин сонсоно. Бэлтрэгний цангинасан

нарийхан улиан нохдын хүрээлэлд хэдэн сар чимээ аниргүйхэн амьдарсан түүнийг нохой биш, хээр талд улилдаж байгаа чонын хамсаатан гэдгийг илчилж өгсөн тул анч Шар, Ирвэс хоёр ууртайгаар ширтэн харж байлаа. Гэвч эзэн нь бэлтрэгний хажууд суучихаад нурууг нь илэн, тааламжтай сонсохыг хараад тэр хоёр яаж ч чадсангүй. Хөрш айлуудын хэдэн ноход хүн, нохой, бэлтрэг гурвын ийнхүү эв найртай хамт байхыг толгой гилжийлгэн хэсэг ажиж байснаа бэлтрэгний нохой, чонын алин болохыг сайтар ялгаж чадсангүй урам муутайхан гэрийн зүг гэлдрэв.

Чэнь Жэнь бэлтрэгний хажууд явган суучихаад түүний уянгалуулан улих дуу болон ульж байгаа үйл хөдлөлийг гярхай ажиглав. Бэлтрэг бүр анхнаасаа л сарьсан хоншоорыг тэнгэр өөд харуулан ульж байлаа. Далайн гахайн зулзага сарны гэрэл дор шөвгөр хошуугаа далайн мандалд цухуйлгахад дугариг яралж үүсгэн бидэртдэг шиг бэлтрэгний улиан ягуухан дуурьсахыг Чэнь Жэнь бахдан ажиглана. Чоно хоншоороо тэнгэр өөд харуулан ульдаг нь дуугаа дөрвөн зүг найман зовхист жигд хол тархаах зорилготой болохыг тэр ойлгов. Түүний хүчинд талын энгээр тархан яваа чонон сүргийн бусад гишүүд бусдынхаа улианыг төвөггүй сонсдог ажээ. Талын чонын тэнгэр өөд харчихаад уйлах мэт уртаар уянгалуулан дуугардаг нь нутаг орондоо зохицон амьдрах, бусадтай эр чадлаа сорин тулалдах бодит хэрэгцээ шаардлагаас үүдэн гарсан байх нь. Талын чоно чухам тэнгэрийн амьтан учраас л ийм төгс төгөлдөр хувьсаж чадсан буй за. Тал нутгийн морин цэргийн эвэр бүрээг ч гэсэн эгц дээш татан дуурьсгадаг байсан бус уу? Эвэр бүрээний өргөсөн чиглэл, гаргасан авиа талын чоныхтой эгээ ижил байгаа нь зүгээр л нэг тохиолдлын хэрэг гэж үү? Үүнээс үзэхэд тал нутгийнхан чонын улиан болоод түүний биеийн байрлалын шалтгаан зэргийг аль эрт нягтлан судалчихжээ. Талын чоно нутгийн хүмүүст дэндүү ихийг зааж сургасан байж шүү.

Чэнь Жэньгийн хамаг биеийн халуун цус оволзон буцлах шиг санагдана. Өвөрмонголын уудам талын гүн дэхь нүүдлийн амьдралын орчинд урьд өмнө хэн нэгэн хүн чонын нурууг илсэн шиг хэрхэн улихыг нь сонсож байгаагүй байж таарна. Бэлтрэгний хажууд түүний цээл яруу улианыг сонсоход мөнөөх л “Ау уу, ау уу” гэсэн уйлаан мөн атлаа гуниг харууслын өнгө аяс өчүүхэн ч мэдрэгдэхгүй ажээ. Харин ч эсрэгээр бэлтрэг өөрийн уртаар уянгалуулан дуулж сурсандаа улам эрэмшин догдлоод түрүү түрүүчийнхээс хавьгүй урт ульж байлаа. Бэлтрэг анх тайзан дээр гараад л үзэгчдийн халуун талархлыг хүртсэн дуучин шиг болих янз огт алга.

Хэдэн сарын хугацаанд бэлтрэг гайхал төрүүлэм зүйлс цөөнгүй үзүүлж байсан боловч Чэнь Жэнь энэ удаа үнэхээр гайхан цочирджээ. Бэлтрэг нохой шиг хуцаж сурах гээд чадахгүй байснаа чонын улианыг хэсэг сонсоод л ульж сурдаг байна шүү. Чонын улианыг сонсоод сурчихаж гэж бодоход тэдний биеийн байрлалыг хаанаас үзсэн байх билээ. Тас харанхуйд чонын хэрхэн ульж байгааг хараагүй тэрвээр багшгүй атлаа өөрөө ийнхүү сурчихдаг байжээ. Чонын улианыг нохойн хуцах дуунаас хурдан сурч чадсан нь чонын араншингийн хүч байж таарна. Түүний хүчинд бэлтрэг нохойн хуцалтыг сонирхож байсан төөрөгдлөөсөө гарч чонын ертөнцдөө эргэн ирж чадлаа. Ёстой нэгэн дуугаар нэрд гарна хэмээх л энэ байх даа. Бэлтрэг одоо жинхэнэ талын чоно боллоо гэж бодоод Чэнь Жэньгийн санаа амрав.

Гэвч бэлтрэгний улиан улам яруусан, сурамгай янзтай болох тусам түүний зүрхийг сарвуугаараа зурж байх шиг санагдаад явчихлаа. Хулгайн хэнгэрэгийг нүдэж болдоггүй гэдэг.

Тэгвэл хулгайлж ирсэн бэлтрэг маань талын хүн, нохой, чононд өөрийнхөө байгааг тунхаглан ульж гарах нь энэ. Чэнь Жэнь дотроо халаглаад “Золиг минь дээ. Хичнээн олон хүн, ноход чамайг алах гэж санаархаж байгааг чи яаж мэдэх билээ. Бас зөндөө олон өлөгчин чамайг оргуулан авч явахыг санаархаж байгаа. Чи тэднээс хамгаалан нүх ухсан биз дээ? Гэтэл яахаараа өөрийн хийсэн үйлдлээ баллаад хаячихдаг байна вэ? Энэ чинь амиа хорлож байгаагаас өөрцгүй хэрэг” хэмээн үглэлээ. Гэвч тэр үхлийн аюулыг үл хайхран ийнхүү чангаар ульж байгаа нь аав ээжээсээ амийг нь аврахыг гуйж байгаа гэдгийг тэр яахин эс мэдэх билээ? Нөгөө талаар бэлтрэг хав хав хэмээн хуцдаг нохой биш, харанхуйд уртаар улих бараан дүрснүүдийн нэгэн гишүүн юм гэдгээ ойлгосон байж таарна. Талын дуудлага талдаа дуурьсдаг шиг бэлтрэгний араншин атар хээртээ л хамаатай ажээ. Чэнь Жэнь хүмүүс болоод чонон сүргийн зүгээс ирэх дарамтыг мэдрэн хүйтэн хөлс чийхарлаа.

Бэлтрэг гэнэт хамаг хүчээ шавхан улив.

Бэлтрэгний улианд Чэнь Жэнь төдийгүй бусад хүмүүс ч, чонон сүрэг ч яах учраа олохгүй байцгаасан юм. Тэр дундаа чонон сүргийн хариу үйлдэл хамгаас хурдан байж, бэлтрэгийг гурав, дөрөвдэх удаагаа улих үед гурван талын уулан дээрх чонын улиан гэнэт огцом зогссон билээ. Айлын хоттой хонин дундаас жинхэнэ чонын улиан сонсогдохыг азарган, хөгшин, эрэгчин болоод өлөгчин чононууд урьд өмнө үзэж дуулаагүй байж таарна. Тэдний хэрхэн гайхаж цочирдсоныг төсөөлж ядах юм үгүй. Аль нэгэн бэлтрэг төөрөөд айлын хоттой хоньд руу ороод явчихав уу гэж тэд бодож байгаа нь лавтай. Хэрвээ тэгсэн байдаг юм аа гэхэд айлын ноход түүн рүү хошууран боргож тасар татан хаях байсан шүү дээ. Гэтэл бэлтрэг яахаараа гаслахгүй, тэр ч байтугай баяр баясгалантай улиад байдаг билээ? гэж бодсон байж таарна.

Тэгвэл бэлтрэг биш, түүн шиг ульж сурсан нохойн гөлөг юм болов уу? хэмээн Чэнь Жэнь чонын логикийг баримтлан сайтар бодож үзэхээр оролдов. Гэвч азарган болоод хөгшин чононууд тэдэн шиг ульж сурсан нохойг огт үзэж байгаагүй шүү дээ. Тэгвэл хэн нэгэн хүн бэлтрэг тэжээсэн юм болов уу гээд бодохоор эртнээс нааш чоно тэжээж ирсэн хүн ганц ч үгүй байдаг. За яахав, хэн нэгэн хүн тэжээсэн байлаа гэж бодоход хэний үүрний бэлтрэг юм бол оо? Хавар хүмүүс цөөнгүй бэлтрэг суйлахад тэд хэлд орох нь байтугай, нүдээ нээгээгүй байсан болохоор өлөгчин чононууд чухам хэний бэлтрэг вэ гэдгийг ялгаж чадахгүй.

Чонон сүрэг лав гайхаж цөхөөд нүдээ бүлийлгэн дуугаа хураасан нь лав хэмээн Чэнь Жэнь таамаглаж байлаа. Бээжингээс ирсэн нэгэн илгээлтийн эзэн залуугийн тал нутгийн ёс заншилд харшилсан үйлдэл хашир хөгшин чононуудын толгойг ганц сайн эргүүлж орхижээ. Гэвч чонон сүрэг хэзээ нэгэн цагт түүний жинхэнэ чоно болохыг ялган таньж таарна. Бэлтрэгээ алдсан өлөгчин чононуудын хувьд ч үрээ эргүүлэн авах итгэлийн гал ноцож мэдэх юм. Бэлтрэг гэнэт ингэж өөрийгөө илчилсэн нь Чэнь Жэньгийн санаа зовж байсан зүйлийг батлаад өглөө.

Бэлтрэгний улианыг сонсоод багийн нийт ноход маш ширүүн хариу үйлдэл үзүүлэв. Тэд хоттой хонин дундаас чонын улиан гарахыг дуулаад хэн нэгний хонь руу чоно оржээ гэж санан зэрэг зэрэг хуцалдаж гарлаа. Тэд хариуцлага алдсандаа ичсэн мэт зэрэг зэрэг боргон хуцаж үүр шөнийн заагт ирсэн тал нутгийн амар тайван байдлыг бүрмөсөн алдагдуулжээ. Чонон сүргийн халдлага эхэлсэн тул эздийгээ зэвсгээ аван шийдвэрлэх тулалдаанд орцгооё гэж тэд сануулж байгаа мэт.

Харин олонх эмэгтэйчүүд ядраад унтчихсан тул нохдын энэхүү боргон хуцах чимээнд сэрээд хол ойрын айлуудын эмэгтэйчүүд чанга дуугаар хашгиралдан тоо томшгүй гар чийдэнгийн гэрлүүд уулсын зүг гялалзав. Шумуулын халдлагаас өмнө чонон сүрэг ийнхүү хоморголон дайрах юм гэж тэд яахин санах вэ?

Чэнь Жэнь өөрөөс нь болж багийн нийт ноход ийнхүү учир зүггүй боргон хуцсанд тун их айж эмээх ажээ. Үүр цайсан хойно багийн малчид өөрийг нь яаж загнах бол? Тэр ч яахав гэхэд зарим малчид бэлтрэгийг тэнгэр өөд илгээх вий гэдгээс л хамгийн их айх ажээ. Гэвч бэлтрэг насанд хүрсэний баяраа тэмдэглэж байгаа мэт баяр хөөртэйгөөр ульсаар байв. Тэр хэд ус балган хоолойгоо чийглэчихээд ульж гарна. Үүр цайж шөнийн манаанд гараагүй бүсгүйчүүд үнээгээ саахаар боссон тул Чэнь Жэнь бэлтрэгийг тэвэрч аваад зүүн гараараа хошууг нь дарж улихыг болиулав. Бэлтрэг ийм гутамшгийг яахин хүлцэх билээ. Тэр хамаг биеийнхээ хүчийг шавхан тийчигнэнэ. Овоо томорсон бэлтрэгнээс тийм их хүч гарна гэж Чэнь Жэнь бодоогүй юм. Ганц гараараа бариад дийлэмгүй янзтай боловч жаахан сулруулчих юм бол хазаад авах вий гэж айна.

Бэлтрэг эзнээ танихгүй догшрон хоёр нүдний шөвөг мэт хурц харц нь Чэнь Жэньгийн нүдийг ширтэх нь аймшигтай. Тэр Чэнь Жэньгийн гараас хошуугаа мулталж чадахгүйгээ мэдээд хоёр сарвуугаараа маажлан самардаж баруун гарынх нь цусыг шүүрүүлэв. Чэнь Жэнь өвдсөндөө Ян Көг дуудлаа. Хаалга онгойж, Ян Кө хөл нүцгэн чигээрээ гүйн гарч ирэхэд түүнтэй хамжин бэлтрэгийг газарт дарж авлаа. Бэлтрэг уухирдан тэлчилж сарвуугаараа самардана.

Чэнь Жэньгийн гараас цус шүүрсэн хэвээр, мань хоёр “Нэг, хоёрын гурав аа” хэмээн хашгираад, гараа зэрэг султган чонын хүрээнээс үсрэн гарцгаалаа. Бэлтрэг ч тэдний араас ухасхийсэн боловч төмөр гинжинд татагдан үлдэв. Ян Кө гэр рүү гүйн ороод эмийн савнаас сэмдсэн боолт, хурдан цагаан нэрт эм авч түүний шархыг боож өгөв. Гао Зянь Жун ч гэсэн цочин сэрээд үүдээр цухуйн “Аа муусайн чононуудыг дээ, чи наадхиа өдөр болгон ноёны агь шиг тойлж байхад чамайг урж байхыг үзэв үү? Та нар айгаад байгаа юм бол би өнөөдөр наадхийг чинь зүйл дуусгаад өгье” хэмээн хашгирлаа.

Чэнь Жэнь гараа савчин “Хэрэггүй дээ. Би сая түүний амыг барьчихсанаас болоод над руу дайрлаа” гэв.

Үүр манхайн цайхад бэлтрэгний уур хилэн намжих янзгүй дороо аахилан тонгочиж, чонын хүрээндээ хэсэг оцойн сууж байснаа баруун хойд зүг ширтээд толгойгоо дээш харуулан уртаар улихыг завдана. Гэвч хамгийн хачирхалтай нь саяын ноцолдооноос болоод бэлтрэг хэрхэн улих эвээ олохоо байчихжээ. Хэсэг дуугүй байснаа “Хуан хуан”, “Хав хув” гэсэн этгээд дуу үүсгэнэ. Арслан түүнийг сүүлээ модгонуулан тойроход мань гурав ч хөгжилдөн инээцгээлээ. Ичсэн хүн хүн ална гэгчээр бэлтрэг гэнэт хуурай аав руугаа шүдээ ярзайлгалаа.

“Бэлтрэг яг л хээрийн чоно шиг улиад сурчихыг багийн нийт хүмүүс сонссон. Одоо ч халуухан юм болно доо. Яадаг юм билээ?” хэмээн Чэнь Жэнь гунигтай өгүүлэв.

“Наадхиа хурдан цааш харуул даа. Тэгэхгүй бол шөнө болгон чонон сүрэг хот эргээд зуу гаруй ноход хуцалдан боргож багийн хүмүүсийн амар заяаг үзүүлэхээ байх нь. Хэрвээ хонин сүрэг рүү чинь халдах юм бол чи сайнаа үзэхгүй нь лавтай” хэмээн Гао Зянь Жун хэллээ.



“Алдаггүй юм аа гэхэд түүнийг тавьж явуулчихаад гинжээ таслаад оргочихож гэвэл болох биш үү?” хэмээн Ян Кө хэллээ.

“Алах ч үгүй, тавих ч үгүй. Ганц өдөр ч гэсэн дэргэдээ байлгах л болно. Тавьдаг юм аа гэхэд одоо цаг нь биш. Ойр хавийн ноход араас нь дайраад түүнийг алчихна. Ойрын хэдэн өдөр чи дандаа хонио хариулаад би шөнө болгон манаанд гарч өдөр нь бэлтрэгээ харж байя” гэж Чэнь Жэнь шүд зуун өгүүлэв.

“Тэгэхээс өөр яах билээ? Хэрвээ багийн зүгээс заавал ална гэсэн тушаал буулгавал цөмөөрөө бэлтрэгийг нохдоос хол газар аваачиж байгаад л тавих ая бодохоос биш” хэмээн Ян Кө хэллээ.

“Та хоёр ч мөн сэрүүн зүүдэлж байна даа. Би хүртэл наадхийн чинь дуунд унтаж чадалгүй толгой маналзаад байхад чинь багийн бусад малчид яалаа гэж зүгээр орхих вэ? Удахгүй пижигнэлдээд ороод ирнэ” гэж Гао Зянь Жун хэлжээ.

\* \* \*

Өглөөний цайгаа ууж байтал гадаа морин туурай пижигнэв. Чэнь Жэнь, Ян Кө хоёр санд мэнд үүдээр гарвал Өлзий, Билиг хоёр гадаа ирчихсэн мориноос буулгүй гэрийн энэ тэрүүгээр бэлтрэгийг хайж байв. Тэд гинжээр баримжаалан бэлтрэгний үүрийг олов. Өвгөн мориноос бугаад нүх рүү тонгойн харсанаа “Энд нуугдчихаад харагдахгүй байж л дээ” гэлээ. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч тэдний цулбуурыг тосон авч үхэр тэрэгний хүрднээс уялаа. Тэр хоёр ямар лүндэн буух бол гэдгийг үг дуугүй чагнацгаана.

Өлзий, Билиг хоёр чонын хүрээний гадна явган сууцгаан ажиглав. Бэлтрэг гадны хүмүүсийн ирж үймүүлэхийг таашаахгүй байгаа бололтой шүдээ ярзайлган ярдаглана.

“Өө, энэ бэлтрэг чинь үе тэнгийнхнээсээ хавьгүй том биетэй юм байна шүү” хэмээн өвгөн Чэнь Жэнь рүү эргэн хараад “Чи түүнд нүх ухаж өгөөд тун их эрхлүүлж байгаа юм байна даа. Би энэ халуун наранд уяатай бэлтрэг яаж тэсдэг юм, зөнгөөрөө үхэх нь гэж бодож байсан юм” гэлээ.

“Аав аа, наад нүхийг чинь бэлтрэг өөрөө наршиж үхэхийн даваан дээр ухсан юм” гэж Чэнь Жэнь их л эмээнгүй байдалтай өгүүлэв.

Өвгөн бүлтийтлээ гайхаад “Эхийн зааваргүй өөрөө нүхээ ухна гэдэг чинь тэнгэр түүний амийг таалж байгаа хэрэг байх нь ээ” гэлээ.

“Чоно ч зарим тал дээр нохой байтугай хүнийг дагуулахгүй ухаантай амьтан шүү” гэж Өлзий хэлэв.

“Би ч гэсэн. . . Ийм жаахан амьтнаас тийм том ухаан яаж гардаг байна вэ гэж гайхаад л байгаа юм. Анх манайд ирэхдээ ээжийгээ ч хараагүй нялх юм байсан шүү” гэж хэлэхдээ Чэнь Жэньгийн зүрх пэл пэл цохилно.

“Чоно угаас хувилгаан чанартай болохоор ээжгүй байлаа ч гэсэн тэнгэр түүнд тусладаг юм. Чи урьд шөнө наад бэлтрэгээ тэнгэр өөд харан улихыг хараа биз дээ? Тал нутгийн үхэр, хонь, ямаа, морь, нохой, үнэг, зээр, тарвага гээд өөр ямар л амьтан тэнгэр өөд харан дуугарч байлаа даа. Гагцхүү чоно л тэнгэр өөд харж ульдагийн учир юу болохыг мэдэж байна уу? Би урьд нь ч чоныг тэнгэрийн хайртай хөвгүүн гэж зөндөө ярьдаг байсан. Тийм болохоор чоно тал нутагт бэрхшээлтэй тулгарах үед тэнгэрээс тусламж эрэн ульдаг юм. Тэгэхээр чонын тэр их чадварыг тэнгэр хайрласан байж таарна. Талын чоно өглөөдөө тэнгэрийн соёрхлыг гуйж, орой гүйцэтгэлийг мэдээлдэг. Тал нутгийн хүмүүс ч элдэв асуудал тулгарахаар тэнгэрээс аврал эрэн залбирдаг биз дээ? Тэр утгаараа талын түмэн бодисын дундаас гагц хүн чоно хоёр л тэнгэртээ хүндэтгэл үзүүлдэг юм.” хэмээн Билиг өвгөн өгүүлэв.

Өвгөн бэлтрэгний нүд зөөлрөхийг хараад цааш өгүүллрүүн “Тал нутгийнхан тэнгэрээ дээдлэх ёсыг ч чононоос сурсан байх шүү. Монголчууд тал нутагт ирээгүй байхад ч чоно тэнгэр өөд толгойгоо өргөн ульдаг л байсан байж таарна. Тал нутагт амьдрах гэдэг амаргүй, чонын сэтгэлийн шаналлыг ойлгодог болохоор өвлийн шөнө өвгөд, хөгшид чонын улианыг сонсоод нулимс унагадаг юм” гэлээ.

Нээрэн ч элчилгүй уудам талд зөвхөн хүн чоно хоёр л тэнгэртэйгээ харьцдаг болохыг санаад Чэнь Жэньгийн сэтгэл сэрхийв. Талын хүн, чоно хоёр үзэсгэлэнтэй атлаа үржил шим муутай нутагт амьдарна гэдэг үнэхээр бэрх болохоор өөрт тохиолдсон хүнд хэцүү бүхнээ өндөр тэнгэртээ айлтгаж зовлонгоо хугасладаг байнам. Шинжлэх ухааны үүднээс үзэх юм бол чоно дээш харж ульдаг нь өөрийн дуу хоолойг улам хол түгээх зорилготой гэдэг нь ортой байж мэднэ. Гэвч сэтгэл санааны үүднээс авч үзвэл Билиг өвгөний тайлбар Чэнь Жэньд их л ойр дотно санагдав. Хүний хорвоод хэрвээ ямар нэгэн Бурханлиг далд хүчний түшиг тулгуур байдаггүйсэн бол амьдрал хэмээгч хичнээн хэцүү байх байсан бол доо. Чэнь Жэньгийн нүд нойт оргиод ирлээ.

Өвгөн Чэнь Жэнь рүү эргэн хараад “Битгий гараа нуугаад бай. Би урд шөнө юу болсныг бүгдийг сонссон. Хүү минь, чи биднийг бэлтрэг алахаар ирлээ гэж бодсон биз дээ. . . . . Өнөө өглөө хэд хэдэн малчид чиний тухай хов мэдүүлж, бэлтрэгийг чинь үгүй хийе гэцгээж байсан. Гэвч би Өлзийтэй ярилцаад түүний амийг үлдээхээр боллоо. Урьд өмнө чамтай адилхан чоноор ингэж өвчилсөн хятад хүнийг бид үзээгүй юм” гэлээ.

Чэнь Жэнь хэдэн секунд бүр алмайрч хоцров. Тэгсэнээ “Үнэхээр намайг тэжээ гэж байгаа хэрэг үү? Яагаад тэр билээ? Би багийн малчид болон та бүхэнд баахан төвөг удчихлаа гэж айж байсан шүү. Би түүнд нэгэн хошуувч хийж өгөөд улихыг болиулдаг юм бил үү гэж бодож байсан” гэлээ.

“Одоо оройтсоон. Өлөгчин чононууд танайд нэг бэлтрэг байгааг мэдчихсэн. Тийм болохоор өнөө шөнө ч гэсэн чонон сүрэг дахин ирнэ гэж би бодож байна. Гэхдээ хот айлууд ойрхон хаяа хатган буусны дээр, ийм олон буу зэвсэгтэй хүмүүс, хоточ ноход байгаа болохоор тэд лав наашаа халдаж чадахгүй. Харин танайхыг биднээс салаад намаржаандаа буухад л асуудал үүсэж мэдэх юм” хэмээн Өлзий хэллээ.

“Тэр үед манай гурван гөлөг ч том болчихно. Дээр нь Арслан гэж түшигтэй нохой байгаа болохоор бид шөнийн манаагаа сайн хийгээд цаасан буу шатаагаад байхад алзахгүй байх аа”

гэж Чэнь Жэнь хэлэв.

“Харж л байж болохоос” гэж өвгөн хэллээ.

Чэнь Жэнь санаа нь сайн амарсангүй шинжтэй асууруун “Аав аа, тийм олон хүн бэлтрэгийг ал гээд байхад та яаж тэднийг аргалаа вэ?” гэв.

“Ойрдоо чонон сүрэг унага шоглоод тун их гарз учруулж байна. Хэрвээ бэлтрэг тэдний анхаарлыг наашаа татаад байвал адуун сүрэгт учрах хохирол багасч, адуучдын яс жаахан ч гэсэн амрах байгаа даа” хэмээн өвгөн хэлэв.

“Чи бэлтрэг тэжээсэн чинь бас ч гэж адуучдад ийм ашиг тустай байна шүү. Харин чи дахин түүнд уруулчихалгүй шиг байгаарай даа. Тэгвэл ч тоглоом биш болно. Саяхан нэг барилгачин айлын аргал хулгайлах гэж яваад нохойд нь бариулан галзуу тусаж үхэхээс наагуур юм болсон байна. Би Сяо Пэнг аж ахуйн төвөөс жаал жуул эм олж ир гэж явуулсан” гэж Өлзий хэлэв.

Өвгөн Өлзий хоёр ч мориндоо мордон адуун сүргийн зүг шогшуулцгаав. Адуун сүрэгт ямар нэгэн асуудал гарч дээ гэж бодонгоо Чэнь Жэнь тэдний араас ширтэн зогсоход сэтгэл нь хөнгөрөх ч шиг, хүндрэх ч шиг сонин мэдрэмж төрөөд явчихлаа.

## Хорин тав

*Жинь улс уг нь Рундигийн бэлчээр нутаг байжээ. Чэнь Ван түүний эх нэгтэй дүү Шү Юйг Тан Хоу цолд өргөмжилж, Тан улсын нутаг дэвсгэрт “Хилийг Рунгийн заншлаар тогтоосугай” хэмээжээ. Даруй Рундигийн амьдралын зан заншлаар нутаг бэлчээр хуваан, Лү Вэйгийн тариалах улс шиг Жоу улсын хууль ёсоор тариан газрыг эс хуваав. Шү Юйгийн хөвгүүн Ся Фү улсын цолыг Жинь болгон өөрчилжээ.*

*Фань Вэнь Лань*

*“Хятад улсын нэвтэрхий түүхээс”*

Чэнь Жэнь гэртээ байсан хоёр жижиг годгор махыг жаал өөхөн тостой хольж шар будааны өтгөн зутан чанав. Бэлтрэгний идэш улам бүр дийлдэхээ байгаад түмпэн дүүрэн зутан өгөөд ч цадахаа байжээ. Өнөө шөнийн манаанаар юу ч болж мэдэх тул чимх боловч нойр авахаас гээд гэртээ орлоо. Үд дундын нэг цагаас хойхно гэрийн гадаа хашгирах дуунаар цочин сэрээд гүйн гарчээ.

Жан Зи Юань цээжин бие нь нэл цус болсон морин дээрээ нэг том юм дүүрчихээд гэрийн өмнөхөн зогсож байлаа. Ноход түүнийг тойрон сүүлээ шарвагануулна. Чэнь Жэнь нойрмог нүдээ нухлан харваас Жан Зи Юань нэг шархтай унага дүүрчихсэн байхыг үзээд давхийн цочив. Тэр ухасхийн очиж жолооноос нь барьж морийг тогтоолоо. Унага өвдсөндөө толгойгоо өргөн тийчигнэхэд хүзүүний шархнаас цус олгойдон морины биеийг будна. Морь нүдээ бүлтэгнүүлэн хамраа тачигнуулаад туурайгаараа газар цавчлах ажээ. Жан Зи Юань эмээлийн араар суусан тул газар буухад амаргүй, барьсан унагаа алдчихвал морь нь үргэн давхих гээд тун зовж байгаа бололтой. Чэнь Жэнь өрөөсөн гараа суллаад унаганы урд хоёр хөлөөс барихад Жан Зи Юань арайхийж нэг юм баруун хөлөө дөрөөнөөс мултлаад мориноосоо болгоомжтой буухдаа газар унах шахлаа.

Мань хоёр морины хоёр талаар орж унагыг дамжлан буулгаад газар зөөлөн тавив. Морь нь шархтай унагыг хараад үргэх янзтай ажээ. Унага толгойгоо ч өргөж чадахгүй тормогор хар нүдээ бүлтэлзүүлэн зовиуртай аахилаад урд хоёр хөлөө тийчигнэн босохыг оролдоно. “Амь гарах найдлага байгаа юу?” хэмээн Чэнь Жэнь яаран асуулаа. Жан Зи Юань түүний хариуд “Бат шархыг үзээд найдлагагүй гэсэн юм. Бид хэд хичнээн ч удаан махны бараа хараагүй билээ дээ, түүнийг амьд байгаа дээр нь нядалчихъя. Лхасүрэн ч Билиг өвгөнийхөнд нэг шархтай унага өгч байна лээ” гэв.

Чэнь Жэньгийн сэтгэл сэрхийгээд Жан Зи Юаньд түмпэнтэй ус өгөх зуур “Адуун сүрэгт бас л осол учраа юу? Хэр зэрэг хохирол гарав даа?” гэлээ.

Жан Зи Юань их уруу царайтай амьтан “Ярих ч юм биш. Өчигдөр орой хоёр унага чононд бариулж, нэг шархдаад байгаа нь энэ юм. Лхасүрэнгийн адуун сүргээс ойрын хэд хоногт тав зургаан унага бариулсан. Бусад сууриудад ч хэцүү л байгаа байлгүй. Багийн дарга нар ч адууны сууриудаар эргэж тойроод л байцгаана лээ” гэв.

“Урд шөнө чонон сүрэг манай багийн хот айлуудын эргэн тойронд улилдаад байсан чинь

хэдий завандаа адуун сүрэг рүү давхиад оччихдог байна вэ?” гэж Чэнь Жэнь хэлэв.

“Наадхийг чинь чонон сүргийн бүх тал руу дайрч дөрвөн зүгээс цэцэг ургуулах арга гэдэг юм даа. Баруун зүгт дуугаран зүүн зүг рүү халдаж, хуурамч довтолгоогоор гол дайралтаа халхалж байгаа нь тэр. Тэгснээр хүмүүсийн анхаарал сарнин толгойгоо аварья гэхээр тэдний өмнө сүүл нь ил гарна гэсэн үг. Чонын наад арга чинь төвлөрсөн хүчээр дайрах, эсвэл ганц ганцаар цохих тактикаас ч илүү аюултай байдаг юм” хэмээн Жан Зи Юань гараа угааж гүйцээд Чэнь Жэньд хандан “Хурдан унаганыхаа амийг таслаадах. Үхсэн хойно янзлавал мах нь амтгүй болчихно шүү” гэлээ.

“Адуучдыг чонын араншинтай гэлцдэг үнэн байх шүү. Чи ч одоо догь адуучин болжээ. Дууны чинь өнгө аяст хүртэл эртний баатар эрийн шинж байна гээч” хэмээн Чэнь Жэнь хэлэх зуур зэс иштэй хутгаа түүнд өгөөд “Чи өөрөө учрыг нь олохгүй бол ийм хөөрхөн унагыг ална гэхээр нүд халтираад байна” гэлээ.

“Энэ унагыг хүн биш чоно бодийг хөтлөсөн болохоор хүнд нүгэл нь нялзахгүй. . . . За яахав. Би зүйл дуусгая. Харин чи янзалж төхөөрөөрэй” гэж Жан Зи Юанийг хэлэхэд Чэнь Жэнь уухайн тас зөвшөөрлөө.

Жан Зи Юань хутгыг авч унаганы цээжин дээр гишгэн толгойг нь тал нутгийн заншил ёсоор тэнгэр өөд харуулаад гүрээнийх нь судсыг таслав. Унаганы цус учиргүй олгойдсонгүй горхилон урслаа. Жан Зи Юань амь тавин тийчигнэх унагыг харан зогсоно. Ноход сүүлээ шарвагануулан зогсоход гөлөгнүүд урссан цусыг долоолно. Бэлтрэг цусны үнэр аваад үүрнээсээ гарч ирэн гинжээ харжигнуулахад харцанд нь ховдог шинж тодорчээ.

Жан Зи Юань өгүүлрүүн “Би уржигдар нэг шархтай унагыг нядлахад ийм тарган байгаагүй юм. Бид хэд хоёр удаа бууз хийж идсэн. Зуны унаганы мах ч тун амттай шүү. Малчид хүртэл их хорхойсдог юм. Унаганы махан буузыг тал нутгийн тансаг амттаны нэгд тооцож болно” гээд Жан Зи Юань дахин гараа угаачихаад үхэр тэрэгний арал дээр сууж Чэнь Жэньгийн унага өвчиж байгааг харлаа.

Чэнь Жэнь унаганы тарган махыг хараад нүүрэнд нь баясал тодорч “Энэ унага ч тарган ирэгний хэрийн махтай юм байна шүү. Энэ нэг сарын хугацаанд махны амт гэдгийг бараг мартаж шахаад байсан юм. Бид яахав гэхэд цаад бэлтрэг чинь мах идэхгүй байсаар байгаад хонь болон майлах л дутаад байна” гэлээ.

“Наад унага чинь энэ хаврын ууган төл, эцэг эх нь биерхүү болохоор ийм өсгөлүүн байх нь аргагүй. Хэрвээ та нарт таалагдвал би хэд хоногоос өөр нэгийг авчирч өгье. Зуны улирал адуун сүргийн хамгийн гарлагатай үе л дээ. Өдийгийн унага чононд шоглуулах нь амар байдаг болохоор адуун сүрэг яаж ч хамгаалаад тав гурав хоноод л төлийн гарз амсдаг. Олонбулгийн тал өвс сайтай, гүү сүү арвинтай болохоор унага хурдан бойжиж, тоглон тонгочоод азарга гүүнд захирагдахгүй байх нь олонтой” гэж Жан Зи Юань хэллээ.

Чэнь Жэнь унаганы толгой, хүзүү, цээжний чононд уруулсан хэсэг махыг огтлон ганпанз дээр тавиад хэдэн хэсэг хуваав. Зургаан нохой Чэнь Жэньг тойрч шаваад сүүлээ хулсны сахал мэт шарвагануулахад гагц Арслан л сүүлээ хөдөлгөхгүй түүний мах хэрхэн хуваахыг харж

байлаа. Олон өдрийн турш шинэ махны бараа хараагүй бэлтрэг цусны үнэр аваад дороо эргэлдэн “Хон хон, хав шув” хийн нохойтой төстэй дуу гаргана.

Чэнь Жэнь мах ясыг гурван том, гурван жижиг хэсэгт хуваав. Чэнь Жэнь унаганы толгой, хүзүүг таллан Арсланд өгөхөд цаадахь нь сүүлээ шарвагануулан зуусаар үхэр тэрэгний сүүдэр бараадлаа. Анч шар, Ирвэс хоёр гурван гөлөгнийхөө хамтаар хувиа аваад гэрийн сүүдэр рүү очив. Чэнь Жэнь нохдыг явуулсаны дараа өвчүүний бүдэрхий, яс зэргийг жижиглэн цавчиж түмпэнгийн талаар болгоод дээрээс нь унаганы хэнхдэгэнд хурсан цусыг хамж хийлээ. Дараа нь “Бэлтрэг ээ, бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн хаширсаар түүн рүү дөхөв.

Бэлтрэг цустай шинэ махыг хараад шүлсээ гоожуулан хүзүүвчээ сунган зүтгэлээ. Чэнь Жэнь түмпэнтэй махыг тойрог руу нь түлхэхэд бэлтрэг амьд унага руу дайрах өлөн чоно мэт дайрангаа шүдээ ярзайлган архирч Чэнь Жэньг хөөж явуулав. Чэнь Жэнь буцаж очоод унаганы махыг шулангаа нүдний булангаар бэлтрэгийг харж байлаа. Бэлтрэг ум хумгүй үмхэлэнгээ хүн нохой дайрах юм бол махаа зуугаад нүх рүүгээ ороход бэлэн байдалтай биеэ эвхрэн хураажээ.

Чэнь Жэнь “Малчид унаганы гэдэс дотрыг иддэг үү?” хэмээн Жан Зи Юанаас асуухад “Малчид шархтай унаганы гэдэс дотрыг иддэггүй юм” хэмээн хариуллаа. Чэнь Жэнь эхлээд унаганы ходоод болон бүдүүн нарийн гэдсийг үнсний хажууд хаяхад ноход зуун одов. Дараа нь унаганы зүрх, элэг, уушиг, бөөр зэргийг гэрээс авчирсан хоёр хоосон түмпэнд хийгээд сэрүүн газар тавьсан нь дараа нохой бэлтрэгийг хооллох гэсэн хэрэг байлаа.

“Адуучид та нар тэгээд чоныг яагаад ч аргалж чаддаггүй юм биз дээ?” хэмээн тэр асуув.

“Тал нутагт ирээд хоёр жил болохдоо адуун сүрэг эндхийн хамгийн эмзэг нарийн хэсэг болохыг яс махандаа шингэтэл мэдрээд байна. Суурь адуун дээр хоёрхон адуучин байдаг. Илгээлтийн эзэн, туслах малчинтайгаа гурвуулхнаа өдөр шөнө ээлжилдэг болохоор яахин хүч хүрэх билээ?” гэж Жан Зи Юань хэллээ.

“Ахиу адуучид тавьчихаж болдоггүй юм уу?” хэмээн Чэнь Жэнь асуув.

Жан Зи Юань хариуд нь “Адуучин гэдэг тал нутагт нисгэгчээс өөрцгүй нарийн мэргэжил юм. Тийм болохоор сайн адуучин бэлтгэгдэхэд цаг хугацаа их шаардлагатай. Хэрвээ барагтайхан адуучин бэлтгэчихвэл жилийн дотор хамаг адуугаа тавиад туучихна гэсэн үг. Дээр нь адуучин гэдэг өөрөө дэндүү ядаргаатай, адармаатай ажил. Өвлийн шөнийн гуч дөчин хэмийн хүйтэнд цасан шуурганаар адуугаа манахад гурав дөрвөн давхар хөдсөн дээлтэй байгаад ч нэмэргүй, хөл гарын хуруугаа хөлдөөх бол энүүхэнд шүү дээ. Зуны халуунд хүн малгүй шумуулын хоол болж зовдог болохоор адуучин хүн сайндаа л арав хүрэхгүй жил хийгээд болих буюу өөр ажилд шилждэг. Манай багийн дөрвөн илгээлтийн эзэн адуучдаас хоёр жилийн хугацаанд гэхэд ганц би үлдсэн байна гээд бод доо. Тийм болохоор адуучин нэмж өгөх нь байтугай байнга л дутагдаж байдаг юм. Сүрэгт агт, гүү, унага, даага гээд үргэмтгий нь дэндүү олон болохоор адуу их хөдөлгөөнтэй. Адуугаа нэг л алдчих юм бол хэд хоногоор хайх хэрэгтэй болохоос гадна өлсөж даарах бол энүүхэнд. Ойрын хэд хоногт чоно унага бариад амраахаа болилоо. Дээхэн дөрөвдүгээр багийн нэг адуучны морь бүдрээд толгойгоо хагалж ухаангүй

байх хооронд адуу нь хил даваад арилсан тохиолдол гарсан. Аж ахуйн захиргаанаас хилийн отрядад мэдэгдэж арван хэд хоног хөөцөлдөж байж эргүүлж авсан байна лээ. Арван хэд хоног эзэнгүй байсан адуу багагүй гарз хохирол амсаж таарна” гэлээ.

Чэнь Жэнь асууруун “Хоёр орны харилцаа ийм тааруухан байхад тэдний тал манай морьдыг эргүүлж өглөө гэж үү дээ?”

“Тэр ч харин гайгүй шүү. Хоёр орны хоорондын хэлэлцээр байдаг болохоор хилийн отрядынхан хичнээн тооны ямар зүсмийн азаргатай морь аль хэсгээр хил гарав гэдгийг л мэдэгдчих юм бол хүн томилж олуулаад эргүүлж өгдөг юм. Манай тал ч мөн өөрцгүй тэгдэг. Харин адуун сүрэг энэ хооронд чононд бариулсан бол хоёр талын хилийн отряд хариуцахгүй. Нэг удаа монголын талаас 120 адуу хил давсаныг манай тал хайсаар 90 адуу эргүүлж өгсөн гэдэг. Тэр дутсан адуунууд чононд бариулсан байх гэж бид ярилцдаг юм” хэмээн Жан Зи Юань хэлэв.

“Адуу яахаараа амь тавих гэж байгаа мэт давхилдаж байдаг юм бэ?” гэдгийг би ерөөсөө ойлгодоггүй юм хэмээн Чэнь Жэнь хэллээ.

Жан Зи Юань түүний хариуд “Тэр ч олон шалтгаантай л даа. Өвөл даарсандаа давхилдаж болно, зун гэхэд хурдлан давхиж байж үсээ гуужуулах учиртай. Шумуул ихтэй үед салхи сөрөн давхих нь ч бий. Намар хонь үхрийн бэлчээрээс хумслах гэж хулгайгаар давхилдана. Гол нь чонон сүргийн дайралтаас зугатах сургууль болгон жилийн дөрвөн улирлын турш давхилдаж байдаг юм. Морины явдал хол болохоор нохой авч явахад тохиромжгүй. Тийм болохоор нохдын хамгаалалтгүй нөхцөлд аймхай адуунуудыг шөнө ганцаараа харж байгаа хүн юу хийж чадах билээ? Ялангуяа саргүй шөнө чоно адуун сүрэг рүү дайрах нь их байдаг. Хэрвээ чоно цөөхөн бол азрага адуучин хоёр алзахгүй л дээ. Харин олон өлөн чонотой тааралдвал сүрэг үргэж давхиад адуучин азарга хоёр яаж ч чаддаггүй” гэлээ.

Жан Зи Юань цааш залгуулан өгүүлрүүн “Би одоо л Чингис хааны морин цэргүүд мянганы газрыг тийм хурдан туулж байсны учрыг улам сайн ойлгох болсон. Монгол морьд өдөр шөнөгүй чонон сүрэгт элдүүлсээр хурд хүч, тэсвэр хатуужлын сургуультай болжээ. Би адуу маллаж байх зуураа чоно, морь хоёрын дэндүү хатуу ширүүн гэмээр тэмцлийг үзэхээрээ нэг болсон. Харанхуй шөнө чонон сүрэг адуу руу нэг дайрахаараа амьсгаа авахын завдалгүй шавдуулан хөөнө шүү дээ. Тэр дунд явдал гүйцэхгүй хөгшин, өвчтэй, хашин, хээлтэй гүү юм уу, унага дааганууд үлдэж хоцроход чонон сүрэг тал талаас нь дайран бариад идэж орхидог. Чи ч чононд элдүүлж байгаа адуун сүргийг хараагүй болохоор яахин мэдэх билээ? Амнаасаа цагаан хөөс сахруулаад хамаг хөлс нь цувсан байдаг юм. Зарим морьд эцсийн хүчээ шавхан давхисаар газар дээрээ бахардан үхнэ. Харин хурдан давхилтай морьд жаахан сэхээ авах юм бол хавь ойр байгаа хатсан зэгсний толгой ч байсан мэрг, үхэр хонины шинхэгтэй булингартай усыг ч болов ууж хүч тамираа сэлбэхийг урьтал болгодог. Монгол морьдын хүч тэнхээ, хоол боловсруулах чадвар, халуун хүйтэн өвчинд тэсвэртэй зэрэг нь хорвоод хосгүй л дээ. Гэхдээ тэр бүх гоц чадваруудыг талын чонон сүрэг үхлээр далайлган хөөсөөр буй болгосон гэдгийг адуучин эрсээс өөр хэн мэдэх вэ?” гэлээ.

Чэнь Жэнь түүний ярианд бүр алмайрч хоцорлоо. Тэр унаганы шулсан болон ястай махыг гэрт оруулаад арьсыг нь гэр дээр хатаахаар тавив. “Чи ч нэг жил адуучин хийсэн биш бүр

мэргэжилтэн болчихжээ. Чиний энэ ярьж байгаа бүхэн маш чухал шүү. Энэ халуунд гадаа зогсоод юу хийхэв. Дотогш орж яриагаа үргэлжлүүлээрэй. Би чамайг гар бие оролцуулалгүй сайхан бууз хийгээдэхье” гэж тэр хэлээд Жан Зи Юаньтай цуг гэртээ орцгоолоо. Чэнь Жэнь буузны мах татан сонгино, халуун ногоогоор амтлаад гурил зуурч малчдын идэх дуртай мах голдуу бууз хийж эхлэв.

Жан Зи Юань аяга хүйтэн цай залгилчихаад “Би ойрдоо дандаа адууны тухай боддог болоод байна. Талын чоно хорвоод хосгүй тэсвэр хатуужилтай морьдыг бэлтгэн гаргаад зогсохгүй, улмаар дэлхий дахиныг донсолгосон Хүннү, Түрэг болон Монголын хүчирхэг морин цэргийг ч буй болгожээ. Шиньжаан, араб, Дон үүлдрийн дэлхийд алдартай морьд байдаг л даа. Гэсэн атлаа яахаараа тэднийг хөлөглөсөн дундад ази, орос, кипчак, араб болон европын рыцариудын морьт цэргүүд монголын морин цэргүүдэд бут ниргүүлсэн юм бэ? Монголын морин цэргүүд баруун зүгт Польш, Унгар, Австри, Египет хүртэл дайран довтолж байсан түүхтэй. Дэлхий дээр ямар улсын морьд ийм гайхалтай тэвчээр хатуужлыг үзүүлж чадах билээ?” гэхэд

Чэнь Жэнь түүний үгийг таслаад “Түүхийн номонд өгүүлснээр монголын талд хүн цөөн адуу олонтой болохоор холын аянд яваа нэг цэрэг дөрвөөс зургаан морь хөлөглөн ээлжлэн унасаар хоногт хэдэн зуун километр хол замыг туулдаг байсан гэнэ лээ. Тийм болохоор монголын морьт цэрэг тухайн үедээ л моторжуусан армитай адилхан цахилгаан дайн хийх боломжтой байжээ. Дээр нь морь олонтой болохоор шархтай морио нядлаад хүнсэнд хэрэлэхинэ. Цангасан үедээ адууны цус уучихдаг тул ар талын хангамжийн ачаа бараа гэж санаа зовох хэрэггүй” гэж хэлэв.

Жан Зи Юань ч толгой дохин инээгээд “Тэр ч үнэн шүү. Цуань Рун, Хүннү, Сяньби, Түргээс авахуулаад одоогийн монголчууд хүртэлх тал нутаг дээр амьдарч байсан бүхий л үндэстнүүд чонын нууц болоод үнэ цэнийг маш сайн мэддэг байжээ гэж чи байнга ярьдаг биз дээ. Наадахь чинь тун үнэн юм байна гэдгийг би улам сайн ухаарах боллоо. Талын чоно монголчуудад нугаршгүй дайчин зан чанар, дайтах арга ухаан болоод байлдааны гарамгай морьдыг буй болгож өгчээ. Энэ гурван давуу тал нь монголчууд дэлхий дахиныг донсолгож байсны гол нууц учир шалтгаан юм” гэлээ.

Чэнь Жэнь гурил зуурангаа өгүүллрүүн “Монголын байлдааны морьдыг талын чоно бэлтгэн сургадаг гэсэн чиний наад нээлт чинь үнэхээр чухал юм боллоо. Би уг нь талын монголчуудын эрэмгий зан чанар болоод цэрэг дайны арга ухааныг чонон сүлдтэй холбон ойлгодог байсан чинь чоно тэдэнд үнэ өртөггүй сургалт явуулан дэлхийд хосгүй байлдааны морьдыг буй болгож чаджээ. Монгол хүний дайчин чанар, дайны арга ухаан дээр тийм айхтар морьд нэмэгдэхээр жигүүртэй барснууд болон хувиралгүй яах вэ? Чи ч хоёр жил адуучин хийсний хэргээ гаргасан байна шүү” гэв.

Жан Зи Юань инээд алдаад “Түүнд бас чи гэдэг чонын хэнээтний нөлөө байж таарна. Чи надад хоёр жилийн турш тийм олон түүхэн үйл явдлуудыг тайлбарлан ярьсан байтал би чинь хүн байна даа, хааяа бас аяганы хариу барилгүй яахав” гэж хэлэв.

Чэнь Жэнь ч мөн инээд алдан “Тэгвэл тун ашигтай наймаа болж байгаа юм байна даа. Нээрэн ингэхэд чоно араас нь элдэн хөөхөөс гадна өөр ямар аргаар унагыг ийм амархан



барьчихаад байна вэ?” хэмээн асуулаа.

“Тун олон арга бий. Адуун сүрэг өвс өндөртэй юм уу, газрын байрлал эвгүй нөхцөлд би тун их болгоомжилдог юм. Чоно хананд наалдсан гүрвэл шиг газар наалдан хэвтээд зөвхөн үнэр, сонор хоёроороо ангийн хаана байгааг мэдэх чадвартай. Гүү байнга зөөлөн үүрсэж унагаа дуудаж байдаг болохоор чоно унаганы байршлыг тогтоогоод түүн рүү сэмээрхэн мөлхдөг. Азарга нь унаганы ойр байхгүй тохиолдолд чоно ухасхийн унаганы хүзүүнээс хазаж алаад далд газар аваачин үмхэлж гарна даа. Хэрвээ азарга, гүү түүн рүү дайран ирэх юм бол зугатаад явчихна. Адуу ямар үхсэн унагаа аваад явах юм биш холдсон хойно нь ирээд идэж эхлэдэг. Чонын өөр нэгэн зальжин арга унагыг хуураад өөр дээрээ ирүүлчихэж чаддаг. Чоно хэрвээ сүргийн захад эхтэйгээ байгаа унагыг харах юм бол өндөр өвсөн дундуур мөлхсөөр дөхөж очоод дөрвөн хөлөө дээш харуулан гозгонуулж эхлэнэ. Түүнийг холоос харахад туулайн дэлдэн чих ч юм уу, эсвэл зурам шиг харагдахаас биш чоно гэдгийг хэр барагтай ялгах аргагүй. Хөөрхий гэнэн унага чухам юу байгааг үзэхээр очих гэвэл гүү яаж урдуур нь ээрээд нэмэргүй. Чоно дөхөж ирсэн унагыг хав хийгээд хүзүүдээд авдаг юм” хэмээн Жан Зи Юань хэллээ.

“Заримдаа чоно надад жирийн амьтан биш, хүлчин чөтгөр ч юм болов уу гэж санагдах үе байдаг юм шүү” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

“Хэлээд яахав. Хүлчин чөтгөөрөөс огт өөрцгүй. Өдөр адуун сүрэг тархаад бэлчиж байгаа тохиолдолд чухам хаанаас аюул гараад ирэхийг адуучин хүн яахин мэдэх билээ? Шөнө болохоор чоно булааж дээрэмдэх нь улам ч цагаандаа гардаг. Хэрвээ тэгээд ч санасандаа хүрч чадахгүй бол бөөн хүчээр дайралт зохион байгуулна. Азарга унагатай гүүнүүдээ адуун сүргийн голд хашчихаад тэднийг өшиглөж, тангаран, хазсаар үзэлцэж гарна даа. Жирийн нөхцөлд чоно арван хэдэн азарганы хамгаалалтыг дайран орж унага барина гэж байхгүй л дээ. Тэгэх юм бол азраганд зад өшиглүүлээд амиа алдаж мэднэ. Харин цасан шуургатай үед олон өлөн чоно дайрах юм бол азарганууд ч хүчин мөхөсддөг. Тэр үед хоёр адуучин азаргатайгаа хамжилцах хэрэгтэй. Заримдаа гар чийдэн тусгаж, буу тавиад байхад дайрсаар унага барих тохиолдол бий. Зуны улиралд бэлтрэгнүүд өсөж том болоод хоол унд нь дийлдэхээ байдаг. Дээр нь зээр тарвага барихад амаргүй болдог тул унага руу дайрах нь ихэсдэг юм” гэж Жан Зи Юань өгүүлэв.

“Адуун сүрэг жилдээ хичнээн тооны унагаа алддаг вэ?” гэж Чэнь Жэнь асуулаа.

Жан Зи Юань хэсэг зуур бодож байснаа “Бат бид хоёрын хариуцдаг сүрэг өнгөрсөн жил 110 унага хүлээн аваад одоо 40 үлдсэн гэхээр далаад унага тавиад туучихжээ. Жаран хувийг нь алдсан мөртлөө нийт багийн бусад сууриудтай харьцуулбал гайгүй дээ орно шүү. Дөрөвдүгээр хэсгийн адууны суурь арван хэдхэн унагатай үлдсэн гэхээр бүр наян хувийн хохиролтой гэсэн үг. Өлзий гуайгаас би нийт аж ахуйн хэмжээнд ямархуу хувьтай байдаг юм бэ гэж асуусан чинь дал хол давна гэж байна лээ” гэв.

“Унаганд ийм халтай болохоор адуучид чоныг тэгтлээ үзэн яддаг юм байжээ” гэж Чэнь Жэнь хирдхийн өгүүлэв.

“Тэгээд бас болоогүй ээ, дааган насандаа ч дайсныхаа дайралтын бай болсоор байдаг.

Шүдлэн насанд хүрсэн хойноо чоныг аргалахтайгаа болж байгаа юм. Тэглээ гээд өлөн чоно юм уу, сүрэг чонотой таарах юм бол амьд гарна гэдэг хэцүү. Адуучин хүний ажил амаргүй байгаа биз дээ? Зэрлэг хүнээс өөрцгүй хээрээр гэр хийж явсаар авсан төлийнхөө гуч дөчхөн хувийг л бойжуулж байна. Хэрвээ жаахан хайхрамжгүй байх юм бол хамаг адуугаа тавиад туучихаж мэднэ” гэж Жан Зи Юань хэллээ.

Чэнь Жэнь хэсэг дуугаа хураан буузны гурил элдэв.

Жан Зи Юань гараа угаагаад Чэнь Жэньд бууз чимхэж өгөнгөө “Гэхдээ хичнээн хэцүү бэрх байлаа гээд чоногүй байж болохгүй. Хэрвээ чоно байгаагүй бол адуун сүргийн чанар муудах байсан гэж Бат ярьдаг шүү дээ. Чоно байхгүй бол морьд таргалаад хурдан давхиж чадахаа болино. Дэлхий дээр монгол морьд давжаад тооцогдоно. Хэрвээ тэдний хурд хүч, тэсвэр хатуужил алга болчихвол үнэ цэнээ алдаад байлдах чадваргүй болох юм. Дээр нь чоно байхгүй бол сүргийн бүтэц алдагдах аюултай. Сүрэг адуу жилдээ зуу хол давсан унага төрүүлдэг. Хэрвээ унаганууд бүгд хорогдолгүй бойжих юм бол гуравхан жилийн дотор сүргийн тоо нэг дахин нэмэгдэнэ. Адууг соёолон, хязаалан нас хүргэж байж улсын бэлтгэлд нийлүүлдэг. Тэр болтол тэднийг адгуулна гэвэл хичнээн их өвс бэлчээр сүйдлэх билээ? Монгол морь идэш ихтэй болохоор жилдээ наанадаж хэдэн арван хонины тэжээл болох өвсийг үгүй хийдэг. Зээр, туулай, морь гурав бэлчээрийн том дайснууд гэж ямар сайндаа Өлзий гуай хэлж байхав. Одоо хэр нь малчид адуун сүргийг бэлчээр талхлалаа гэж дургүйцдэг байтал тоо толгой нь үүнээс олшроод ирвэл хэдхэн жилийн дараа үхэр хоньд идэх өвсгүй болоод Олонбулгийн тал цөлжих аюултай тулгарах юм. . . . .” гэж ярив.

Чэнь Жэнь гурилын модоороо ганпанзаа цохиж аваад “Тэгэхээр тал нутгийн нүүдэлчид чонын хүчийг ашиглан адуун сүрэгтээ төлөвлөгөөт төрөлтийг хэрэгжүүлдэг байх нь байна шүү дээ. Тоо толгойг нь тэгж хязгаарлаж чадсаны үр дүнд монгол морьдын үүлдэр угсааг сайжруулдаг байх нь” гэлээ.

“Тэгэлгүй яахав. Монголчууд үнэндээ тал нутгийн диалектик аргыг гаргууд эзэмшсэн улс шүү. Тэр тусмаа тал нутгийн “Хэв дундад ёсыг”<sup>32</sup> нэвтэрхий мэддэг юм. Манай хятадууд сав л хийвэл туйлшраад нэг болохоор дорнын салхи өрнийг давна гээд эсвэл өрнийн зүйлс дорныхоос илүү гэж хошуураад байдаг шүү дээ. Монголчууд тал нутгийнхаа элдэв зөрчлийн тэнцвэрийг хадгалснаараа өөртөө давхар хожоо гаргаж чаддаг” хэмээн Жан Зи Юань хэлэв.

“Гэхдээ наад тэнцвэрийг чинь бас ч хатуу ширүүн аргаар хадгалж байгаа юм шүү. Хавар адуучид бэлтрэг суйлаад нэг үүрнээс арван хэдээр нь гаргаж ирээд нийт нэг хоёр зуун бэлтрэгийг тонилгоно. Гэхдээ бүгдийг нь хүйс тэмтэрнэ гэж хэзээ ч үгүй. Зун болохоор чоно нь эргээд унага руу дайрч зууны жар далан хувийг үгүй хийнэ. Харин адуучид тэдэнд зуун хувь ажиллах боломж олгохгүй. Малчдын энэхүү цуцалтгүй цусан гол татуулсан тэмцлийн үр дүнд сая тэнцвэр тогтоож чадна. Монголын энэхүү голч ёсон нь хятадын хэв дундад үзлээс илүү дайчин чанартай агаад үнэнд илүү их нийцдэг юм” хэмээн Чэнь Жэньг хэлэхэд

Жан Зи Юань үгийг өлгөж аваад “Сүүлийн жилүүдэд тариачин гаралтай дарга нар мал аж ахуйг удирдах гэж хөглүүлээд тооны хойноос хөөцөлдсөөр эцэс сүүлдээ бүгдийг тавиад туучих нь шиг байна. Чоно байхгүй болчихвол монгол морийг тоох хүнгүй болно. Өвөрмонголын тал нутаг тэр аяараа элсэнд дарагдан хонь мал нь харангадаж үхээд бид хэд

Бээжин рүү пүүгээгээ үүрээд буцах байлгүй” гэлээ.

“Чи мөн сэрүүн зүүдлэв ээ, Бээжин түүхэнд хэдэн ч удаа талын нүүдэлчдэд эзлэгдэн тэдний нийслэл болж байсан билээ дээ. Бээжин хот талын морин цэргийн довтолгооныг ялан давж чаддаггүй юм чинь түүнээс хэдэн арван сая дахин хүчтэй “Шар түйрэнгийн аюулыг” яахин торгоож чадах вэ?” гэж Чэнь Жэнь хэлэв.

“Чи бид хоёр шиг амьтдад ч энэ ёстой хамаагүй зүйл байх аа. Хэдэн зуун сая хүн амьдрахын төлөө үхэн хатан газар хагалаад жилд нэг мужийн хүн амтай тэнцэхүйц нөхөн үржил явагдаж байна. Тэгээд тэр олон илүүдэл хүн ам тал нутаг руу дайжин орж ирэхийг хэн тогтоож чадах билээ?” гэж Жан Зи Юань хэллээ.

Чэнь Жэнь санаа алдаад “Нээрэн ч тийм дээ. Гэхдээ л санаа зовниод байх юм. Хятадын Күнзийн суртал үнэн хэрэг дээрээ зөвхөн хаан эзэн жижиг тариачдын үзэл сурталд тохирсон тогтолцоо юм. Хаан нь өөрөө том нударга гэсэн үг. Харин өрхийн тэргүүнүүд жижиг хаад байдаг. “Хааны алба халаатай, эзний алба ээлжтэй” гэх буюу “Ус завийг хөвүүлж ч чадна, хөмрүүлж ч чадна” гэж бас сургадаг. Хүн амын далай мэт их урсгалд хэн нийцэж чадахгүй байна тэр хүнийг хөмөрсөн завь шиг хувь тавилан хүлээж байгаа. Тариачдын хөрс зөвхөн хаан эзнийг л төрүүлэн гаргахаас биш, бүгдээрээ найрамдахыг зөвшөөрдөггүй. “Ус завийг хөвүүлж ч чадна, хөмрүүлж ч чадна” гэдэг үнэн хэрэг дээрээ “Тариачид хаанаа өргөмжилж чадна, бас авч хаяж чадна” гэсэн санаа шүү дээ. Тэгээд эцэс сүүлдээ өргөмжилсөн ч бай, хөмөрч хаясан ч бай адилхан бахь байдгаараа хаадууд байж л байдаг. Хэдэн мянган жилийн турш хятадын хүн ам хэт олширохоороо дайн самуун үүсгэн хүн амаа хядаж хорогдуулаад, хаан эзнээ авч хаясны дараа дахин үржиж олширох гэх мэтээр нэг байран дээрээ дэвхэцсээр өнөөг хүргэжээ. Хэдийгээр суурьшмал соёлын өөдлөн хөгжих үе шатанд хаан эзэн харц ардгүй бүгдээр газар тариалангаа гол болгон мушгираа шураг маягийн дээш эргэх дэвшилтэт хүч болж байсан бол оргилдоо хүрэхээр эргээд энэ хүч уруу эргэх шураг маягтай буцахдаа шинээр төрөн гарч байгаа үйлдвэрлэлийн харилцааны үр хөврөлийг тасдах хадуур болон хувирдаг ажээ. . . . .” гэв.

Жан Зи Юань толгой дохин зөвшөөрч гаднаас аргал хормойлон орж ирээд гал асааж тогоо тавив. Тэр хоёр буузаа болохыг хүлээх зуур яриа нь улам халлаа.

“Морин дэл дээр босоо заяатай төрсөн монголчууд яахаараа морийг өөрсдийн сүлд шүтээнээ болгон дээдлэхгүй түүний дайсан чоныг сүлдээ болгодгийн учир өнөөдөр чи бид хоёрын ярианаас тодорлоо. Энэхүү этгээд логикийн дунд харин ч тал нутгийн гүн ухаан нуугдаж байдгийг би одоо л ойлголоо. Монгол морь гэдэг талын хүн чоно хоёрын хамтран сургасан “Шавь” юм байна. Тэгэхээр багш нь юу боллоо гэж өөрийн шавийг сүлдээ болгон дээдлэх билээ. Харин чоно бол хүний эрхэнд ороогүй, тэр ч байтугай хүнд маш олон зан чанар, чадварыг заасан амьтан. Түүгээр зогсохгүй өнөө хэр түүнээс сурч судалж гүйцээгүй зүйл зөндөө байгаа шүү дээ. Чоно үнэндээ тал нутгийн аливаа бүгдийг зохицуулж, олон нарийн төвөгтэй харилцаануудын учгийг зангидаж байдаг ажээ. . . . .” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

“Би Цуань Рун болон Хүннүчүүдийг өнөө хэр халаглан дурссаар байдаг юм. Тэр гарамгай үндэстнүүд л чонон сүлдийг буй болгож өвлүүлсэн нь өнөө хэр тасралтгүй уламжлагдсаар иржээ” гэж Жан Зи Юанийг хэлэхэд

Чэнь Жэнь “Чонон сүлд үнэндээ хятадын Күнзийн суртлаас өнө эртний уг сурвалжтай болохоор байгалийн залгамж чанар, амьдрах хүчтэй байж таарна. Тухайлбал күнзийн суртлын үзэл санааны тогтолцоон дахь “Гурван хэлхээ таван ашдыг”<sup>33</sup> аваад үзэхэд тэрхүү ухагдхуунууд одоо аль эрт хуучран үеэ өнгөрөөгөөд байна. Гэтэл чонон сүлдийн гол үзэл санаа өнөө хэр амьдрах чадвараа халгалж буйгаар үл барам тэргүүний хөгжилтэй үндэстнүүд чухам түүнийг л улаачлан авч яваа юм. Үнэндээ монголын чонон сүлд хэмээх үзэл нь нийт хүн төрөлхтний оюуны нандин өв билээ. Хэрвээ манай хятадууд өөрсдийн оюун санаан дахь Күнзийн суртлын ялзарсан хэсгийг тайрч хаяад тэрхүү орон зайд чонон сүлд хэмээх модны суулгацыг шилжүүлэн суулгаж, түүнийг Күнзийн аядуу үзэл, боловсрол, ном хэрхэн сурах зэрэг уламжлалтай сайтар уялдуулан үндэсний зан чанарыг дахин буй болгож чадсан цагт сая манай хятад хөгжих найдлагатай байж мэдэх юм. Гэвч харамсалтай нь чонон сүлд гэдэг нь бичиг үсгээр тодорхой зааж өгсөн үзэл санааны тогтолцоо биш юм л даа. Нүүдэлчин үндэстний хамгийн гол дутагдал гэвэл бичиг соёлын хоцрогдол мөн. Тэгээд ч нүүдэлчидтэй хэдэн мянган жилийн турш дайтсан Күнзийн сурталт түүхчид чонон сүлдийн тухай бичиж тэмдэглэх нь байтугай тэр талын сурвалжуудыг зориуд устгаж байсан нь лавтай. Тийм болохоор бид өнөөдөр хятадын түүхийн сурвалжаас чонон сүлдийн тухай тэмдэглэл олно гэдэг өвсөн дундаас зүү эрэхтэй адил хэрэг болоод байна. Бидний нааш чирч ирсэн хэдэн зуун номон дунд тэр талаар хайгаад нэмэргүй болохоор дараа гэртээ харихдаа л дахиж шинэ материалууд олж ирэхээс дээ” гэв.

Жан Зи Юань галдаа хэдэн хуурай аргал нэмээд “Манай нэг хамаатан цаасны үйлдвэрт хар ажил хийдэг юм л даа. Үйлдвэрт нь хуучны тоо томшгүй их гар бичмэл номуудыг түүхий эд гээд хураачихсан байдаг гэнэ лээ. Номын хорхойтой хүмүүс ажилчдад нь тамхи өгөөд л хуучны нандин судар бичгүүдийг авч болдог гэсэн. Би чинь сардаа далан юаний овоо цалин авчихдаг болохоор тамхиар ном солих ажлыг надад даалгачих. Гэвч улс байгуулагдсан цагаас хойш засгийн газар чоно алж устгах явдлыг урамшуулан дэмжээд одоо чинь чоно алдаг хүн л тал нутгийн жинхэнэ баатар гэгдэх нь холгүй байна. Бага дунд боловсролтой монгол үндэстний залуус бараг төлөв чонон сүлдийн тухай мэдэхгүй талдаа болчихож шүү. Тийм болохоор бид энэ тухай судлаад ямар ач тустай юм бэ?” гэлээ.

Чэнь Жэнь тогооны тагийг аван эргэж хараад “Жинхэнэ шинжлэх ухааны судалгаа ач тусыг гол болгодоггүй эхлээд сонирхол, сониучирхал хоёр дээр тулгуурласан байдаг. Тэгээд ч бид урьд өмнө мэддэггүй байсан зүйлээ ойлгож авна гэдэг чинь хэрэггүй зүйл юм уу?” хэмээн хэлэв.

Унаганы махан бууз уур савсуулан гарч ирлээ. Чэнь Жэнь буузыг сэвэх зуур тэсгэлгүй нэгийг авч үмхээд “Ай мөн амттай байна шүү. Үүнээс хойш шархтай унага гарах болгонд гэр рүүгээ зөөж байдаг юм шүү” хэмээн дуу алдана.

“Нөгөө гурван илгээлтийн эздийн гэрүүд ч надад захиад байгаа юм. Ээлжилж байсан нь дээр биз дээ” гэж Жан Зи Юань хэллээ.

“Чи тэгвэл ядаж чононд уруулсан хэсгийг авчирч бэлтрэгэндээ өгч байгаарай” хэмээн Чэнь Жэнь захив.

Мань хоёр бүтэн жигнүүр бууз идсэний дараа Чэнь Жэнь их л сэтгэл хангалуун босоод “Би

хэдэн удаа чонын хишиг хүртэж байгаагаа санахаа байжээ. Алив хоёулаа явж бэлтрэгээ буузаар дайल्या” гэлээ.

Бууз хөрсөний дараа тэр хоёр нэжгээд бууз бариад бэлтрэгний зүг очицгоолоо. “Бэлтрэгээ хоолондоо” хэмээн Чэнь Жэнь чанга дуугаар хашгирав. Хоёр бууз бэлтрэгний толгой, бие дээр оноход цаадахь нь айсандаа сүүлээ хавчин үүр рүүгээ шургав. Газар унасан буузнууд Анч Шар, Ирвэс хоёрын хоол болжээ. Тэр хоёр хэсэг зуур алмайрсанаа Чэнь Жэнь инээд алдан “Чи бид хоёр ч мөн тэнэг улс юм даа. Бэлтрэг махан бууз идэх нь байтугай ерөөсөө үзэж ч байгаагүй шүү дээ. Тэгээд ч чоно руу шидсэн бууз яалаа гэж эргэж ирэх билээ? Чоно тун сэжигч болохоор тэжээсэн эзэн надад хүртэл итгэхгүй байна. Тэр шидсэн буузыг чулуу гэж бодсон байх. Энэ хавиар өнгөрдөг монгол жаалууд түүнийг чулуугаар шидэхгүй үе гэж байх биш” гэлээ.

Жан Зи Юань нүхний дэргэд очоод “Бэлтрэг их хөөрхөн болж шүү. Би түүнийг тэвэрч үзмээр байна” гэлээ.

“Бэлтрэг зөвхөн Ян Кө бид хоёрт л тэврүүлдэг юм. Гао Зянь Жунд хүртэл тэврүүлдэггүй гээд бод доо. Түүнийг гараа явуулахаар урах гээд байдаг юм. Тийм болохоор тэврээд хэрэггүй байх аа” гэв.

Жан Зи Юань доош тонгойн нүх рүү шагайгаад бэлтрэгийг дуудан “Бэлтрэг ээ, би чамд унаганы мах авчирч өгсөнийг мартаагүй биз дээ? Цадсан хойноо намайг тоохгүй байгаа юм уу даа?” гэхэд бэлтрэг нүхэндээ улам шурган шүдээ ярзайлган архирав. Тэр гинжнээс нь татан гаргах гэтэл бэлтрэг ухасхийн урахаар завдахад Жан Зи Юань айсандаа арагш ухран лагхийтэл суучихав. Чэнь Жэнь бэлтрэгний хүзүүгээр тэврэн авч түүнийг хориглоод толгойг нь илж тайвшрууллаа. Жан Зи Юань хувцасныхаа шороог гөвөх зуур “Овоо болж шүү. Хээрийн чонотой адилхан догшин байна. Бэлтрэгийг нохойноос өөрцгүй юм болгочихвол ямар олиг байх билээ. Би дараа түүнд унаганы мах авчирч өгч байя” гэлээ.

Чэнь Жэнь түүнд бэлтрэгний хэрхэн ульсан тухай болон аюултай ааш гаргасан зэргийг ярьж өглөө. Жан Зи Юань “Далайн чоно” номоо дэлхийн нэвтэрхий түүхээр сольж аваад Чэнь Жэньд хандан “Өнөө шөнө чонон сүрэг гарцаагүй ирэх юм шиг санагдаад байна. Тийм болохоор болгоомжтой байдаг юм шүү. Хамгийн гол нь хөөрхөн бэлтрэгээ тэдэнд тавиад туучихаж болохгүй. Чоно даринаас их айдаг болохоор бүр болохгүй бол цаасан буу хэдийг тавиарай. Би түрүүчийн удаа та нарт авчирч өгсөн нэг боодлыг сайн шалгаарай. Чийг авчихсан бол тэсрэхгүй шүү” гэж захив.

“Ян Кө түүнийг лаагаар шаваад хоймрын модон авдар дээр тавьчихсан. Тийм болохоор чийг аваагүй байж таарна. Хэдэн өдрийн өмнө цаадахь чинь люмпенгүүдэд уурлахдаа гурван ширхэгийг тэслэнэ билээ” гэж Чэнь Жэнь хэллээ.

Жан Зи Юань адуун сүрэг рүүгээ яаран буцжээ.

## Хорин зургаа

*Чэнь Гуан өгүүлрүүн: . . . . Ү Ди хаан дөрвөн И-г довтлоход гавьяа үлэмж, төрд эрэлхэг баатар үхэхээс аюухгүй түшмэдээр дүүрч, газар нутаг ихээр өргөжсн, санаанд хүрчээ.*

*Түүний хойно ардыг амаржуулан, тариаланг хүндэтгэн. . . . Ард бас түүний ач тусыг хүртэвэй. Энэ нь эзэн хаан нэгэн хүмүүний дур бах, эрс ондоо байж, түшмэд харин аялдан дагаснаар үнэхээр Ү Ди хаан гурван вангийн эрдмийг бүрдүүлэн Шан Жоугийн засгийг сэргээжээ. . . . . Чэнь Гуан өгүүлрүүн: Ү Ди хаан Цин Ши Хуан лугаа дэмий зөрөө үгүй болой хэмээжээ.*

Сы Ма Гуан

“Засаг дор туслах нэвтэрхий толь”

Оройн хоолны дараа Бао Шүнь Гүй Билигийнхээс шууд Чэнь Жэньгийн зочлон ирлээ. Тэр өгөөмөр зан гаргаж Чэнь Жэнь, Ян Кө хоёрт урьд нь адуучид л хэрэглэх эрхтэй байсан зургаан зайгаар ажилладаг том гар чийдэн өгчээ. Хэрвээ өнөө шөнө чоно тэднийх рүү халдах юм бол цаасан буу шатаалгүй, гар чийдэнгээ асаагаад нохдоороо хоргоолгож байгаарай. Би ойр хавийн айлуудад та хоёрын хурц гэрлийг харах юм бол очиж тусла гэсэн гэж аминчлан захижээ.

“Та нарын бэлтрэг тэжээсэн чинь ийм ач тустай байх юм гэж санасангүй шүү. Хэрвээ энэ удаа чонон сүргийг дуудан ирүүлээд зургаа долоон том чоно агначих юм бол маш том ялалт байгууллаа гэсэн үг. Ганц хоёр өлөгчин агнасан ч болж л байна. Өнөө шөнө өлөгчин чоно гарцаагүй ирэх учраас танай бэлтрэгийг алаад арьсыг туламлан өлгөж, махыг нь хээр хаячихвал тэд горьдлого тасрах болно гэж малчид намайг ятгаад байгаа юм. Гэвч би зөвшөөрөөгүй л дээ. Би харин ч тэднийг наашаа ирээсэй гэж хүсээд байтал бэлтрэг тэднийг даллан ирүүлжээ. Ийм сайхан боломж гэж байх уу даа? Энэ удаа ч чононууд хууртагдах нь гарцаагүй байж таарна. Гэхдээ та хоёр мэдээтэй байдаг юм шүү. Наад том гар чийдэнгийн гэрлийг харсан хүн хэдэн минутын турш сохор юм шиг болчихдог. Чоно бол бүр ч хэцүүдэж таарна. Юмыг яаж мэдэх вэ? Төмөр хүрз, царил бэлтгээрэй” гэж Бао Шүнь Гүй инээн өгүүлэв.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч дуун дээр зөвшөөрөлгүй яахав. Бао Шүнь Гүй бусад айлуудаар орж буу тавин хүн мал шархдуулж, чоно үргээж болохгүй шүү гэж захижээ.

\* \* \*

Энэ удаа бэлтрэгээр чоныг урхилах аргын эцсийн үр дүнг хэлэх эрт боловч нэгэн хэвийн хөдөө нутгийн амьдралд бас л сонирхолтой хэрэг болов. Бэлтрэгэнд өширхөөд удтал үүдээр шагайхгүй байсан хэдэн залуу малчид энэхүү ангийн аргыг ихэд сонирхон тэднийхээр ирж байр байдлыг асууж сонирхоно. “Өлөгчин чоно бэлтрэгэндээ их л харам болохоор энд нэг бэлтрэг байгааг мэдсэн юм чинь хэд хэдээрээ наашаа ирэх нь гарцаагүй. Тийм болохоор бид өдөр болгон чоно агнаж болох нь ээ” гэж нэгэн хоньчин өгүүлэв. “Чоно нэг хохирол амсвал дахин ирээд байхгүй нь лавтай” гэж нэг адуучинг хэлэхэд өөр нэгэн хоньчин өлгөж аваад “Чоно сүрэглэн дайрвал яадаг юм билээ?” гэлээ. Адуучин түүний хариуд “Чоно хичнээн

олон байлаа ч ноход шиг олон байв гэж дээ. Хүн ноходгүй хамсаад гэрэл гарган хашгирч, буу тавихад зугаталгүй хаачдаг юм” гэжээ.

Хүмүүс явсаны дараа Чэнь Жэнь, Ян Кө хоёр бэлтрэгнээс холгүйхэн нэгэн эсгий дээр суухад сэтгэл нь их хүнд байцгаалаа. “Хэрвээ энэ удаагийн арга амжилттай болвол тун тоогүй хэрэг болох нь дээ. Бүх бэлтрэгнүүдийг суйлчихаад дээр нь эхийн хайрыг ашиглан өлөгчин чоныг алах болж байна шүү дээ. Чи бид хоёр ч хожим насан туршдаа харамсах үйлийг хийлээ” хэмээн Ян Кө их л эмзэглэсэн байдалтай өгүүлэв.

Чэнь Жэнь ч толгой гудайлгаад “Би энэ бэлтрэгийг анх тэжээсэн нь зөв эсэхэд эргэлзэж эхлэлээ. Ганц бэлтрэг тэжээхийн төлөө зургаан ахан дүүсийнх нь аминд хүрсэн. Цаашид хичнээн ч чоно алах юм бүү мэд. Гэхдээ одоо ухрах гарцгүй болсоон. Шинжлэх ухааны туршилт гэдэг заримдаа малын яргачингаас өөрцгүй байхыг шаарддаг юм. Билиг аав тал нутгийн тэнцвэрийг хадгалах гэж бүр ч амаргүй байна шүү дээ. Нэг талаар мал сүрэг чонын халдлагад өртөхийг тэвчих хэрэгтэй. Нөгөө талаар чоно агнахын зовлонг амсаж байгаа. Гэтэл түүний гаргаж байгаа хоёр тэвчээрийн аль аль нь цус урсгах хэрэгтэй байдаг. Гэвч тэр тал нутаг болоод нутгийн ардын төлөө сэтгэлээ хатамжлан энэ нарийн харилцааны тэнцвэрийг барьж байх ёстой юм. Өнөө маргааш, ер нь хэзээ ч наашаа битгий зүглэ гэж өлөгчин чононд дуулгаач хэмээн дээд тэнгэрээс маш их хүсэж байна. Хэрвээ бидэнд жаахан цаг боломж олговол бид бэлтрэгийг өсгөж том болгоод эхийнх нь тийш тавьж явуулах юм шүү дээ. . . . .” хэмээн хэлэв.

Шөнө дундаас өмнө Билиг өвгөн тэднийд ирж хэр зэрэг бэлтгэлтэй байгааг шалгалаа. Өвгөн гаансаа хоёр ч удаа нэрэх зуур хоёр шавийгаа тайвшруулж байгаа юм уу, эсвэл өөрийгөө тайтгаруулж байгаагийн алин болохыг бүү мэд намуухан дуугаар “Хэд хоногоос шумуул гараад ирэхээр адуун сүрэг айхтар аюултай тулгарах болно доо. Чоныг жаахан алж байхгүй бол өнөө жилийн унаганууд бараг үлдэхгүй байж ч мэднэ. Тийм зүйлийг тэнгэр яахин таалах билээ” гэв.

“Аав аа, таны бодлоор өлөгчин чоно өнөө шөнө ирэх болов уу?” хэмээн Ян Кө асуув.

“Хүний тэжээсэн бэлтрэгээр өлөгчин чоныг дуудан агнахыг үзэх нь байтугай дуулж ч байгаагүй болохоор тэгнэ гэхийн тэмдэггүй болчихоод байна. Бао Шүнь Гүй дарга л бэлтрэгийг ашиглан чоно авлана гэж хөөрцөглөөд байна. Ийм их унага үхчихээд байхад Бао дарга болон хэдэн адуучдын уурыг өөр ямар аргаар гаргах билээ дээ” гэж өвгөн хэлэв.

Өвгөн явсаны дараа хонь ямаад тайван хивж, ирэг сэрх чихээ хөдөлгөн шумуул үргээхээс өөр уудам нутаг тэр аяараа нам гүм болов. Тал нутагт тагнуулын онгоц мэт ганц нэг шумуул гарч ирчихээд байгаа нь жинхэнэ шумуулын аймшигт бөмбөгдөлт дайралт эхлэхийн дохио юм.

Мань хоёр шивэр авир хэмээн жаахан хууч хөөрч байснаа Чэнь Жэнь эхлээд жаахан унтаж амрав. Ян Кө фосфортой цаг зүүн, гартаа гар чийдэнгээ барьчихаад ийш тийш сэрэмжлэн харуулдана. Тэр юмыг яаж мэдэхэв хэмээн хэдэн цаасан буу цүнхэндээ хийгээд хүзүүнээсээ зүүжээ.

Унаганы мах цадталаа идсэн бэлтрэг харуй бүрий болохоос өмнө чонын тойргийн баруун

хойно гинжээ чивчиртэл хүзүүгээ сунган хөдлөх ч үгүй оцойн суучихаад өөрийн хүсэмжлэх дуу хоолойг байж ядсан байдалтай хүлээж байлаа. Түүний нүдээ ухаад өгөхөөс буцахгүй энэ байдал төрөл төрөгсдөө хүсэмжлэх асрамжийн газрын өнчин хүүхдээс ч илүү сэтгэл шимшрэм ажээ.

Шөнө дунд болонгуут чонын улиан эхлэлээ. Гурван талын уулнаас чонын улиан дуу дуугаа авалцан эхлэлээ. Нийт багийн олон нохдын шаагилдан хуцах дуун чонын улианд хариу барив. Чонын улиан намжсан боловч нохдын хуцах зогсонгуут улам ч хүчтэй сэргэлээ. Тэд хэдэн удаа дуугаараа халз тулалдсаны дараа шөнөжин хуцсан ноход чонон сүрэг хий хоосон сүр үзүүлж байна гэж бодсон уу, өөрийн хүчээ гамнан тоотойхон хуцаж эхлэв.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр бэлтрэгний дэргэд очоод оддын гэрэлд юу болохыг ажиглаж эхлэв. Бэлтрэг төмөр гинжээ харжигнуулан чонын хүрээг бачимдан тойрно. Тэр чонын улианыг давтах гэтэл ойрхон хуцалдах Арслан, Анч Шар хоёрын дуунд үймрэн автах ажээ. Тэр хэдэн ч удаа “Хон хон, хав хув” хэмээн хуцах гэснээ урам хугарч толгой ганзагалав. Бэлтрэг хэдэн ч сарын турш ноходтой өдөр шөнөгүй хамт байсан болохоор тэдний хуцаанаас холдож өөрийн унаган дууг олж авахад маш амаргүй байгаа бололтой.

Арслан дайсны байдлыг олж мэдсэн бололтой бусад нохдоо дагуулан хотны баруун хойд талаар нааш цааш гүйлдэнэ. Гэнэт баруун хойд талд Чэнь Жэньгийн хонин сүргээс холгүйхэн чонын улиан сонсогдлоо. Бусад айлуудын нохдын хуцаан цөөрсөн тул чонон сүрэг Чэнь Жэньгийн гэрийн баруун хойд талын толгод дээр зугуухан цугларч эхлэв бололтой. “Чонон сүргийн гол хүч манайхыг онилжээ. Тэд ч мөн айхтар ойтой юм даа” хэмээн Чэнь Жэньгийн уруул чичрэн шивэгнэв.

Ян Кө ч чамгүй айж байгаа бололтой гар чийдэнгээ тас атгалаа. Тэр цүнхэн дэх цаасан буунуудаа тэмтрээд “Хэрвээ чонон сүрэг наашаа халдан дайрдаг юм бол чи гар чийдэнгээрээ дохио өгөөрэй. Би олон таван үггүй “Гранатаа” шиднэ ээ” гэлээ.

Ноход хуцахаа болив. Чэнь Жэнь оцойн суугаад “Бэлтрэг одоо ульж эхлэнэ. Харж байгаарай” хэмээн шивнэлээ.

Нохдын дуунд үймрэхгүй тохиолдолд бэлтрэг чонын улианыг тайван ажиглах боломжтой юм. Тэр цээжээ цэхлэн, чихээ сортойлгоод анхааралтай чагнав. Бэлтрэг эхлээд харанхуйн цаанаас ирэх дуунд чихээ дасгаж байгаад дараа нь дуудаж сурах гэж байгаа нь тун ухаалаг хэрэг байлаа.

Чонон сүргийн улиан бэлтрэг рүү чиглэжээ. Бэлтрэг ч чонын улиан хойд зүгт гарахад тийш харан, баруун зүгт сонсогдоход толгойгоо тэр чигт хандуулна. Харин гурван зүгээс улихад дороо эргэцэх ажээ.

Чэнь Жэнь чих тавин сонсвоос өнөө шөнийн улиан өчигдөр шөнийнхөөс эрс өөр байжээ. Урьд шөнийн улиан нэгэн хэвийн сүрдүүлсэн шинж илт байсан бол өнөө шөнийнх олон өнгө аястай, нэг хэсэг аядуухан байснаа дуугаа өндөрсгөх нь асуусан тандсан, тэр ч байтугай үрээ эрэн дуудах өлөгчин чонын сэтгэлийг илтгэж байв. Чэнь Жэнь үүнийг олж мэдээд сэтгэл нь жихүүцэв.



Тал нутагт үрээ хайрлан хамгаалах өлөгчин чонын тухай домог маш өргөн тархсан байдаг. Тэд бэлтрэгээ анд сургахын тулд амь насаа ч үл хайхран хурга хулгайлдаг. Бэлтрэг суйлахаар очсон анчидтай амиа ч хайрлалгүй тэмцэнэ. Бэлтрэгнүүдийнхээ аюулгүй байдлыг бодсондоо шөнө дөлөөр тэднийгээ нэг нэгээр зууж өөр үүр рүү нүүнэ. Бас өөрөө өлсөж цангах хамаагүй гэдсэндээ байгаа хоолны үлдэгдлийг гулгиж бэлтрэгнүүдээ тэжээдэг. Өөрийн бэлтрэгнүүдээ алдсан өлөгчин чоно өөр бусад өлөгчингүүдийн бэлтрэгт хөхний сүүгээ харамгүй хөхүүлдэг нь нийт чонон сүргийнхээ эрх ашгийг бодсон хэрэг юм. Олонбулгийн талд дээр үед нэгэн хөгшин анчин гурван өлөгчин чоно нэг үүрийн бэлтрэгнүүдийг хөхүүлж байхыг харсан тухай өр өвдөм түүхийг Билиг өвгөн өгүүлэх дуртай. Тэр жилийн хавар хэсэг анчид аглаг уулнаа бэлтрэг суйлахаар очиход гурван өлөгчин чоно цагариг үүсгэн хэвтээд гурав гурван бэлтрэг хөхүүлж байхыг харан сэтгэл сэмрээд тэр үүрний бэлтрэгнүүдийн амийг өршөөсөн гэдэг. Талын анчин, адуучин эрс чонын бэлтрэгийг хувхайлан хоослодоггүй тул амьд үлдсэн жаахан бэлтрэгнүүд бусад өлөгчингүүдийн сүүг тэлээлэн хөхсөний хүчээр монголын чоно дэлхийн хамгийн хүч тэнхээтэй, ухаалаг үүлдэр болж чаджээ гэж өвгөн бас ярьдаг. . . . Түүгээр ч үл барам өлөгчин чонын хайр өөрийн төрөл зүйлийн хүрээнээс хальж, хамгийн аймшигт дайсан хүний үрийг хүртэл бүлээн сүүгээрээ тэжээн өсгөж байсан биш үү? Энэ нь манай дэлхий дээрх хамгийн ухаан санаанд багтамгүй уужим агаад уярам хайрын жишээ билээ хэмээн тухайн үед Чэнь Жэнь бодож билээ.

Харин энэ мөчид бэлтрэгээ алдан элэг эмтрэн хоцорсон өлөгчин чононууд төрсөн үрээ олохын горьдлого өвөрлөсөөр ирсэн нь лавтай. Тэд энэ хавийг Олонбулгийн талын хүн ноход буу хамгийн шигүү хуралдсан газар гэж мэдсэн хэр нь аюулыг сөрөн нааш зүглэжээ. Чэнь Жэнь энэхэн мөчид бэлтрэгнийхээ хүзүүвчийг мултлан олон эхийн хайранд умбуулахсан гэж маш их хүсэж байлаа. Хэрвээ тэр түүнийг тавьчих л юм бол бусад айлын ноход түүнийг өөрийн хотноос холдонуут зэрлэг чоно гэж бодоод тасар татан хаях нь гарцаагүй юм. Хэрвээ жаахан сэлүүхэн газар тавья гэх юм бол өөрөө өлөн чонын хоол болж мэдэх болохоор бас л тэгж зориглосонгүй. Бэлтрэгт гурван тал зургаан зовхисоос дуулдах чонын улиан өчигдрийнхөөс хавьгүй өөр эмзэг уян сонсогдсон бололтой яахаа мэдэхгүй үймцэнэ. Тэр энэхүү элдэв янзын хувиралтай чонын улиан ямар учиртай болох, хэрхэн хариу өгөхөө яахин мэдэх билээ. Чонон сүрэг хариу улилт сонсогдохгүй болохоор дуу нь намжаад ирэв. Урьд шөнийн бэлтрэгний улиан чухам ямар учиртай, өнөөдөр яагаад дахин сонсогдохгүй байгаагийн учрыг тэд ойлгохгүй байгаа нь лавтай.

Энэ үед бэлтрэг баруун хойш харан оцойн суугаад толгойгоо дээш харуулан улыж эхлэв. Эхэндээ түүний улиан жаахан эв хавгүйхэн сонсогдоно. Чонон сүргийн улиан нам гүм болох нь бэлтрэг чухам юу хэлээд байгааг ойлгоогүй нь илт. Сүрэг чоно цааш юу болохыг дуугүй хүлээнэ. Хэсэг байзнаснаа сүргийн дундаас монгол гэрийн хажууд байгаа бэлтрэгтэй төстэй нарийхан улиан сонсогдох нь өнөө жилийн бэлтрэг бололтой. Түүний юу асууж байгааг ойлгоогүй өөрийнх нь бэлтрэг гайхан гөлрөхийг Чэнь Жэнь ажиглав. Дөнгөж саяхан төрөлхийн хэлгүй дүлийгээ эмчлүүлсэн чоно бусдын яриаг ч ойлгохгүй, өөрийн санаагаа ч илэрхийлж чадахгүй байх нь аргагүй ч юм. Ядаж дохио зангаагаар ярилаа ч бие биесээ харахын аргагүй харанхуй байдаг.

Бэлтрэг хэсэг зуур хариу чимээ хүлээж байснаа өөрийнхөөрөө улыж гарав. Тэр амьсгаагаа түгжиж байгаад уртаар улысан нь өчигдрийн хамгийн оргил сайн үетэй дөхөж очив. Түүний

цангинасан шингэн хоолой урт бишгүүр, жижиг хонх, жижиг эвэр бүрээ мэт тасралтгүй хол дуурьсана. Тэр өөрийн ийнхүү ульж байгаад сэтгэл их л хангалуун байгаа бололтой, ойр ойрхон залгуулаад уртаар ульсаар байв. Бэлтрэг хошуугаа тэнгэр өөд эгц цоройлгон ульна. Ингэсээр түүний улих дуун, биеийн байрлал зэрэг жинхэнэ чононоос огт өөрцгүй болов. Бэлтрэг баяртайгаар “Уйлан хайлж”, чонон сүрэгт хандан хөгжилтэйгөөр “Чөтгөрийн уйлаан чонын улианыг” үзүүлэх нь тал нутгийн яруу дуурьсал болон хувирав. Бэлтрэгний дуу хүүхдийн цовоо цолгин аялгууг санагдуулна. Уртаар улих зуураа тэр өөрийн үзэмжээр чичирхийлэл, хувирлыг үүсгэх ажээ.

Мань хоёр энэ дуунд автаж гүйцэхэд Ян Кө сэмээрхэн амандаа чонын улианыг давтах гэж хөглөнө.

Чэнь Жэнь Ян Көд хандан “Би чонын улианыг сонсож байхдаа монгол ардын уртын дууны шуранхай түүнтэй их төстэй болохыг олж мэдлээ. Монголын уртын дуу, хятадын ардын дууны хэв маягаас тэс өөр шүү дээ. Тэр хэв маяг нь чонон сүлдийг дээдлэдэг Хүннү нараас уламжлагдан ирсэн гэж би таамаглаж байна. Түүх сударт ч тэр талаар тэмдэглэж бичсэн зүйл бий. Тухайлбал Вэй улсын бичиг, Хүннүгийн шастирт өгүүлэхдээ “Эрт дээр цагт Хүннүгийн нэг хааны үзэсгэлэнт хоёр гүнжийн бага нь чонотой ханилаад олон үр хүүхэд төрүүлсэн. Түүнээс үүдээд тэдний дуулах нь чонын улиан мэт сонсогдмуй” гэсэн байдаг” гэж хэлэв.

“Хүннүгийн шастирт үнэхээр тэгж тэмдэглэсэн байдаг гэж үү дээ?” хэмээн Ян Кө яаран асуулаа.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Тийм юмыг худлаа ярьж болно гэж үү дээ? “Хүннүгийн шастирыг” би хэдэн ч удаа уншсанаа мартчихжээ. Монголын талд амьдарч байгаа хүн “Хүннүгийн шастирыг” уншихгүй байж болно гэж үү дээ? Тал нутагт чонон сүлдийн нөлөөг бүх зүйл дээр харж болох юм байна. Аливаа үндэстэн өөрийн сүлдээ дээдлэн дуурайж байдаг болохоор чонон сүлдтэй ард түмэн бүх зүйл дээр түүнээс суралцахгүй ч яахав. Тэд чононоос ан ав хийх арга барил, дуут дохио дамжуулах арга, цэргийн урлаг, стратеги, тактик, дайчин зан чанар, хамтач ухамсар, сахилга, зохион байгуулалт, тэвчээртэй зан, хамгийн эрдэм чадал төгс нэгнийгээ удирдагчаар сонгох, түүнийхээ удирдлагыг дагах, гэр орон болоод үндэс угсаагаа хайрлах, тал нутгаа хайрлан хамгаалах, дээд тэнгэрийг шүтэх гэх мэт. Тийм болохоор монголчуудын дуу хөгжимд чонын улианы нөлөө ороод зогсохгүй ухамсартайгаар суралцсан зүйл ч бишгүй байна гэж би үзэж байгаа юм л даа. Тал нутгийн бусад амьтад болох үхэр, хонь, ямаа, морь, нохой, зээр, тарвага, үнэг зэрэг дуугарахдаа хүн чоно хоёр шиг уртаар уянгалуулан шуранхайлдаг бил үү? Хүн чоно хоёр л гагцхүү ингэж чадна. Чи дахин сайтайр сонс доо” гэлээ.

“Нээрэн тун адилхан юм байна шүү. Хэрвээ чи энэ тухай яриагүй бол би хувьдаа үүнийг бодохгүй байсан юм. Ху Сун Хуагийн<sup>34</sup> дуулдаг монгол “Магтаал” дууны эхний шуранхайлдаг хэсэг яахын аргагүй чонын улианыг санагдуулж байна. Энэ хоёр жилд бидний сонссон уртын дуу болгон шахам л шуранхай түрлэгтэй байсан шүү дээ. Хэрвээ дуу хураагуур байсан бол ардын уртын дууг чонын улиантай харьцуулан судлаж болох байсан юм” хэмээн Ян Кө толгой дохин өгүүлэв.

“Манай хятадууд ч гэсэн уудам талын энгээр дуурьсах уртын дууг сонсох дуртай боловч

түүний гарал үүсэл чонотой холбоотой гэдгийг тэр болгон мэдэхгүй л болов уу? Харин захын өвөрмонголчууд өөрсдийн уртын дууг чононоос гаралтай гэдгийг хүлээн зөвшөөрөх дургүй юм билээ. Би хэдэн ч малчдаас тэр тухай асууж үзэхэд дүлэгнээд л байхаас биш тоймтой юм ярьдаггүй. Арга ч үгүй биз дээ. Одоо чинь “Улаан дэнлүүний тэмдэглэл” зэрэг зохиолд “. . . . Гяндангийн хуягийн дуу чонын улиан мэт цахиртлаа” гэх мэтээр дүрсэлсэн байхад чинь хэн л өөрсдийн уртын дууг чононоос гаралтай гэж хүлээн зөвшөөрөх билээ. Хэрвээ тэгээд хэлчих юм бол аугаа удирдагчийг магтан дуулсан “Магтаал” дууг хориглоод, дуулсан дуучинг нь хувьсгалын эсэргүү хэрэгт оруулаад хаячих байлгүй. Гэвч бодит байдал үнэхээр ийм л байгаа болохоор яая гэхэв” хэмээн Чэнь Жэнь хэлээд санаа алдаж “Гагцхүү чонын улиан ардын уртын дуу хоёр л монгол талын үзэл санааг илэрхийлж чадна” гэжээ.

\* \* \*

Арслан бусад нохдоо хошуучлан баруун хойд зүг рүү агсран дайрав. Нохойн хуцалт намжихад бэлтрэг дахин ульж эхлэв. Одоо тэр нохдын хуцаанд үймрэхээ байгаад жинхэнэ чоно шиг ульж чаддаг болжээ. Бэлтрэг тав зургаан удаа ульсанаа идүүр дээрээ гүйн очиж хэд ус балган хоолойгоо чийглээд дахин баруун хойш харан чангаар хэд ульсанаа чихээ соотойлгон хариу чимээ хүлээж эхлэв. Хэсэг хугацаа өнгөрсөний дараа олон чонын улианыг дарахуйц эршүүд бүдүүн хоолой баруун хойд уулнаас сонсогдлоо. Азарган чоных болов уу гэмээр тэрхүү эршүүд улиан тушаасан байдалтай богино тод төгсгөлтэй ажээ. Өргөн цээж, өндөр том биетэй азарган чоно л ийн улих байх даа гэж Чэнь Жэнь бодож байв. Тэр хоёр чонын сүрлэг улианд дарагдаж дуу ч гарах зүрхгүй болжээ.

Бэлтрэг ч хэсэг зуур чимээгүй болсноо удалгүй хөгжилтэйгөөр тонгочиж гарав. Тэр хэрхэн хариулахаа мэдэхгүй боловч биеэ цэхлэн урт амьсгаа аваад цангинасан нарийхан хоолойгоор саяын чонын улианы давтамжийг яг адил дууриажээ. Бэлтрэг хэдэн ч удаа давтан дуугарсан боловч цаад чоно нь хариу өгсөнгүй.

Чэнь Жэнь энэхүү харилцан ярианы цаад санааг олох гэж амихандаа хичээж байв. Азарган чоно бэлтрэгнээс “Чи хэн бэ? Хэний хүүхэд вэ? Хурдан хариулаарай” хэмээн асуусан болов уу? Гэвч бэлтрэг өөдөөс нь “Чи хэн бэ? Хэний хүүхэд вэ? Хурдан хариулаарай” гэсэн азарган чонын тушаангуй өнгө аястай асуултаар хариу барьсан байж таарах юм. Азарган чоно үүнд тэсэртлээ уурлахаар үл барам тэрхүү бэлтрэг чухам ямар учиртайд эргэлзсэн нь гарцаагүй. Ийм харилцан ярианы үр дүн ямар байх нь ойлгомжтой.

Бэлтрэг чонон сүргийн байр суурь, ах захын ялгааг яахин мэдэх билээ дээ. Тэр сүргийн ахлагчийн сүрлэг тушаалыг давтан хэлнэ гэдэг эрх мэдлийг уландаа гишгэн ах захыг үл хүндлэж байгаагаас өөрцгүй хэрэг юм. Чонон сүрэг богинохон улилдах нь уур хилэндээ багтран, дор бүрнээ энэ хэргийг хэлэлцсэн санааг илтгэнэ. Хэсэг азнасан хойно чонон сүргийн улиан тасрахад бэлтрэг харин ч эрч хүч ороод явчихав. Хэдийгээр тэр сүргийн ахлагчийн асуулт болон чононуудын уур хилэнг ойлгохгүй боловч харанхуйд байгаа бараан дүрснүүд өөрийг нь анхааралдаа аваад, харилцах санаатай гэдгийг мэджээ. Бэлтрэг ч гэсэн тэдэнтэй дотносох санаатай боловч түүнийгээ хэрхэн илэрхийлэхийг мэдэхгүй дөнгөж сая сурсан “Чи хэн бэ? Хэний хүүхэд вэ? Хурдан хариулаарай” хэмээх ганц өгүүлбэрийг л харанхуйд хандан давтан хэлээд байлаа.

Чонон сүрэг хэдэн түмэн жил тал нутагт амьдрахдаа анх удаа л ийм бэлтрэгтэй тааралдаж байгаа учраас бүгд учраа олж ядан гайхацгаана. Тэр бэлтрэг байтлаа нохдын хажууд, хонин сүргийн дунд орчихоод инээж хөхрөн шулганаж байдаг. Тэр жинхэнэ чоно мөн юм болов уу? Хэрвээ мөн юм бол чонын атаат дайсан хүнтэй ямар харилцаа байна вэ? Бэлтрэгний дууны өнгийг сонсоход өөрсөдтэй нь харилцах хүсэл маш их атлаа хүн нохойд дарлуулж байгаа шинж үгүй, харин ч их цатгалан байгаа бололтой. Хүн ноход түүнд тийм сайн байдаг атал тэр өөрөө яах санаатай юм бол доо?

Чэнь Жэнь харанхуйд гялалзах ногоон нүднүүдийг ажиглангаа тэд чухам юу гэж бодож байж болохыг толгойдоо ийнхүү ургуулан төсөөлжээ. Энэ мөчид сүргийн толгойлогч болон бусад чононууд нүдээ бүлтийлгэн тун сэжигтэйгээр бэлтрэгийн чухам ямар учиртайг эрэгцүүлж байж таарна.

Бэлтрэг дуугаа хураан дороо эргэж хургах нь харанхуйд байгаа бараан дүрснүүдийн хариултыг тэсэн ядан хүлээж байгаагийн шинж юм.

Чэнь Жэнь түүний энэхүү байдалд урам хугаран гонсойв. Саяын тэр сүрлэг дуутай чоно бэлтрэгний эцэг байж мэдэх л юм. Гэтэл багаасаа эцгийн хайраас холдсон бэлтрэг аавдаа хэрхэн эрхэлж ярилцахыг мартсан байдаг. Хэрвээ энэ удаа л эцгийн хайрыг алдвас тэр дахин хэзээ ч түүнтэй учрахгүй гэж Чэнь Жэнь санаа зовниж байлаа. Тэгвэл ганцаардсан бэлтрэг үүнээс хойш түүнээс цааш хүний нөмөр нөөлөг дор, бүр тодруулбал Ян Кө тэр хоёртой байж чадах болов уу?

Гэнэт нэгэн өлөгчин чонын уртаар улих дуун сонсогдов. Тэр улианд халуун бүлээн сэтгэл, үрээ алдсан эхийн шаналал, гуниг гутрал, горь хүсэл дүүрэн шингэсэн ажээ. Гэвч тэр нь цаанаа гүн утга агуулгатай олон зүйлийг агуулсан чонын хэл байж таарна. Чэнь Жэнь тэр улианы цаад утгыг “Хүү минь, чи ээжийгээ таньж байна уу? Би чиний ээж байна шүү дээ. . . . .Ээж нь чамайг маш их санаж байна. Чамайгаа би хичнээн удаан эрсэн гэж санана аа. Гэтэл ингэж нэг юм чинийхээ дууг сонсдог байжээ. . . . . Үр минь, хурдан ээждээ эргээд ир. . . . . Бид бүгдээрээ чамайгаа их санаж байна. . . . . Ау. . . ” гэсэн байж таарна.

Өлөгчин чонын сэтгэлийн гүнээс ундарсан энэхүү хорвоогийн зовлонт эхийн шаналлын дуу эхэр татан уйлах мэт сэтгэл шимшрүүлж, он цагийн урсгалыг туучсаар буурал талын чихийг дэлдэхэд Чэнь Жэнь нулимсаа барьж чадсангүй, Ян Көгийн нүд ч гялтганана.

Бэлтрэг ч энэхүү тасалдангуй эмгэнэлтэй улианд гүнээ уясчээ. Тэр зөн совингоороо төрсөн эх нь түүнийг дуудаж байгааг ойлгожээ. Бэлтрэг хоол руу дайрдгаас ч илүү хүчтэй гинжээ харжигнуулаад боож үхэх шахан хүзүүвчиндээ татагдав. Өлөгчин чоно эмгэнэлтэй нь аргагүй уртаар улихад улам олон өлөгчингүүд үрээ санагалзан хайх тэрхүү эмгэнэлийн дууг даган түрж тал нутаг тэр аяараа хайлан мэлмэрэв. Өлөгчин чононуудын эмгэнэлийн дуу угаас уйлах мэт өнгө аястай чонын улианы утга учрыг бүрэн илтгэх ажээ. Энэ шөнө дуу дуугаа авалцан цурхиран уйлалдах өлөгчин чононуудын улиан Олонбулгийн талд тэнгэр газрыг цочоон, хүлчин чөтгөрийг уясаан, хүмүүний сүнсийг цочоом мянган оны гаслангийн дууг хайлжээ. Өлөгчин чононууд мянга түмэн оны турш, жил болгон хайртай үрээсээ хагацахын гаслан шаналлыг шөнийн талд мэлмэрүүлэн тоочих мэт.

Чэнь Жэнь дув дуугүй зогсоход яс жиндэм жихүүцлийн сүүдэр сэтгэлийг дайран өнгөрөх шиг санагдана. Ян Кө нулимс мэлтэгэнүүлэн бэлтрэгний дэргэд очоод хүзүүвчнээс атган, толгой нурууг нь илж тайвшруулна.

Өлөгчин чононуудын гаслантай улих чимээ зугуухан намжихад бэлтрэг харанхуйгаас сонсогдох тэр дуун дахин сонсогдохоо больчих вий гэсэн байдалтай Ян Көгийн гараас тонгочин мултарч, баруун хойд зүг рүү харан цовхчлоо. Дараа нь дуртай дургүй толгойгоо дээш өргөн нэлээд уртаар улилаа. Чэнь Жэньгийн сэтгэл сэрхийгээд намуухан дуугаар “Баларлаа шүү” хэмээн хэллээ. Ян Кө тэр хоёр бэлтрэгний улиан өлөгчин чононуудынхаас маш их зөрүүтэй болохыг тэр даруй ойлгов. Хэдийгээр бэлтрэг өлөгчин чононуудын улианыг дууриах гэж оролдох боловч түүний тамир гүйцээгүй болохоор тэдэн шиг уртаар уянгалуулан ульж яахин чадах билээ? Бэлтрэг тэр гэхийн тэмдэггүй хэд ульсаны дараа чонын улиан тал нутагт бүрмөсөн замхран алга болов.

Чэнь Жэньгийн урам бүрмөсөн хугарчээ. Бэлтрэг бодвол өлөгчин чононуудын гаслан шаналлыг элэглэн шоолсоноор үл барам сая азарган чононоос сурсан хэдэн үгээ ч хэлэхээ мартаагүй байж таарна. Түүний хэлсэн санааг тоймловоос “Хүү минь, . . . . Чи намайг санаж байна уу? Чи хэн бэ?. . . . Ээждээ эргээд ир. Хурдан хариулаарай. Ау . . . Ау . . .” гэсэн байж таарна.

Магадгүй түүний хэлсэн үг Чэнь Жэньгийн бодсоноос ч илүү бүтэлгүй зүйл байсан байж мэдэх юм. Яадаг ч байсан дөнгөж төрсөн цагаасаа хойш хүн нохдын дэргэд өссөн бэлтрэгний хувьд саяынх шиг хэцүү асуултын зөв хариуг олж хэлнэ гэдэг тун амаргүй байх нь ойлгомжтой.

Чэнь Жэнь гэнэт чимээ аниргүй болон хувирсан толгодын зүг нүд бэлчээлээ. Үрээ гэсэн эхийн сэтгэл рүү ус цацан егөөдөх энэхүү үл бүтэх этгээд өлөгчин чононуудын уур унтууг ёстой хүргэж өгөө дөө хэмээн тэр бодож байлаа. Энэхүү үл бүтэх этгээд өөрсдийнх нь хайж явсан, үхэн хатан тэмцээд суллаж авах учиртай төрөл төрөгсөд нь биш байна хэмээн угаас сэжигч зантай чонон сүрэг бодоод бэлтрэгний хэн болоход эргэлзэн уурандаа шатаж байж ч мэдэх юм. Бусдыг занганд оруулан авлахдаа гарамгай чонон сүрэг, хүний тавьсан занганд бусдынхаа унахыг харахаараа нэг болсон азарган чононууд энэ бяцхан бэлтрэг магадгүй хүмүүсийн өөрсдөд нь тавьсан өхөөрдмөөр атлаа аюул занал ихтэй “Чонон занга” байж мэдэх юм хэмээн бодсон нь лавтай. Харин тэр чонон занга нь өөрөө хий зайгаа харуулж орхижээ.

Тийм болохоор чонон сүрэг чухам ямар учиртай зулбасга үймүүлээд байгаад эргэлзэж эхэллээ. Жил бүрийн хавар морь унаж чаддаг хоёр хөлтөн нохой дагуулан чонын үүрийг эрж олоод утдаг. Хурц нүдтэй өлөгчин чононууд далд газраас хүмүүс бэлтрэгийг суйлж тэнгэр өөд шидэн алахыг харахаараа нэг болсон. Тэгээд тэд сүйтгэгдсэн үүрэндээ эргэн ирээд хавь ойроос цусны эхүүн үнэрийг мэдэрнэ. Зарим өлөгчин чононууд хаяж нүүсэн хот айлын бууцны ойролцоо арьсыг нь өвчсөн бэлтрэгний хүүрийг ухаж гаргах нь ч бий. Гэтэл чоныг үзэн яддаг хүн яахаараа бэлтрэг тэжээдэг билээ?

Чонон сүрэг аягүй бол энэ ульж чаддаг бяцхан золиг чоно биш, нохой байж магадгүй гэж бодож болох юм. Олонбулгийн чонон сүрэг хилийн отрядын буу агссан байлдагчид тав зургаан чоно шиг ульж чаддаг соотон чихтэй нохдыг дагуулан явахыг харж байсан. Тэр том

ноход нутгийн нохдоос ч айхтар тул жил болгон цөөнгүй чоно тэдэнд бариулдаг. Энэ ульж чаддаг бяцхан золиг тэдний үр төл ч байж болох биш үү?

Магадгүй тэр орой болгон бэлтрэгээ зугаалуулахаар холхон явахад толгодын орой дээр цөөнгүй удаа сарьж байсан тул түүний хэн болохыг чонон сүрэг мэдэх боломжтой гэж Чэнь Жэнь үргэлжлүүлэн таамаглаж байлаа. Тийм болохоор цөөнгүй өлөгчин чоно түүний шээсний үнэрийг авсан байх магадлалтай. Тал нутгийн чоно хэдийгээр гоц ухаантай боловч хэл нэвтрэлцэхгүй суучихаад байж мэдэх л юм. Гэвч тэр үнэхээр жинхэнэ чоно юм бол сүрэгт байгаа бусад бэлтрэгнүүдтэй адилхан чонын хэлээр ярьж, өлөгчин чононуудтай харилцаж чадах ёстойсон. Тийм болохоор энэхүү чонын хэлээр ярьж чадахгүй бэлтрэг лав бүрэн санаа хувираад хүнд урвасан амьтан болж таарах нь. Эс тийм бөгөөс тэр өөрөө гүйгээд ирэхгүй яах гэж чонон сүргийг ирүүлэх гээд байх билээ?

Тал нутагт хэдэн түмэн жил амьдарсан чоно урвахаас үхлийг илүүтэй үздэг шөрмөслөг зантай атал яахаараа ийм урвагч өөдгүй амьтан хаанаас гараад ирсэн юм бол? Тийм чоныг сургаж гаршуулж чадсан энэ айлд ямар нэгэн ид шид, ад зэтгэр шүглэсэн байж мэднэ. Магадгүй талын чоно монголчууд болон хятад хүний үнэрийг ялган таньдаг болохоор энэ хот айлд монгол чонотой урьд өмнө тохиож байгаагүй этгээд хэрэг үүсчээ гэж бодсон байж таарна.

Чонон сүрэг бүрмөсөн чимээгүй болжээ.

Нам гүмхэн шөнийн талд төмөр гинжээр уяуулсан хөөрхий бэлтрэг хоолойгоо хорсгон цус шүүртэл улина. Гэвч түүний амнаас гарсан улиан бүр ч холион бантангийн туйл болж байлаа. Чонон сүрэг дахин бэлтрэгний зовлон болоод аврал эрсэн дууг тоохоо больсон мэт ямар нэгэн тандалт оролдлого хийхээ больжээ. Бэлтрэг чонон сүрэгтэй хэлд орох сургууль хийх боломжоо алдсанаар тэдний харилцаа дахин хэзээ ч сэргэхгүйгээр алга болсон байж ч мэдэх юм.

Чонон сүрэг хижиг үзсэн мэт бүслэлтээ цуцлаад холдон явчих шиг Чэнь Жэньд санагдлаа.

Бараантан дүнсийх толгод Цагаан уулын ар бэл дэхь хүн тавьдаг газар мэт нам гүм оргиод явчихав.

\* \* \*

Чэнь Жэнь, Ян Кө хоёрын нойр хүрэхгүй тул энэ тухай чимээгүйхэн хэлэлцэж эхлэв. Гэвч тэр хоёрын хэн нь ч яагаад эцэстээ ийм үр дүнд хүрэв гэдгийг үнэмшилтэй тайлбарлаж чадахгүй байлаа.

Үүр манхайн цайхад бэлтрэг сая нэг юм улихаа болилоо. Тэр өвсөн дээр сулбайн хэвтэж, өглөөний манан дунд сүүмэлзэх баруун хойд талын толгодыг нүд бүлтийлгэн ширтэх нь урд шөнийн бараан дүрснүүдийн хэн болохыг харах гэсэн мэт. Манан будан зугуухан замхрахад түүний нүдний өмнө дасал болсон толгод тодрохоос биш, түүний хүсэл мөрөөдөл болсон төрөл нэгтний бараа, дуу тасарчээ. Тэр үнсэнд хаягдсан шалз мэт болсоноо ойлгож нүдээ анихад үхэл тулгарснаас өөрцгүй цөхрөл түүнийг нөмрөн авлаа. Бэлтрэг чонон сүрэгтээ

эргэн нийлж, эрх чөлөөтэйгөө дахин учрах боломж хаагдсанд сэтгэл шимширсэн Чэнь Жэнь түүний нурууг зөөлөн илбэв.

Нийт баг хэсгийнхэн энэ шөнө мөн л эсэн мэнд өнгөрчээ. Багийн хот айлууд бүгдээрээ чонын довтолгоонд өртөөгүй тул ганц ч үхэр хонины гарз амссангүй. Эцсийн үр дүн тэдний төсөөлж байснаас өөрөөр эргэсэн тул хүмүүс янз бүрээр хэлэлцэж байлаа. Бэлтрэгнийхээ төлөө амь насаа ч гаргуунд гаргахад бэлхэн байдаг өлөгчин чононууд яахаараа энэ шөнө дайран ирсэнгүй вэ гэдэг асуултын хариуг хүмүүс олж цөхнө. Өвгөд настангууд хүртэл энэ тал дээр толгой сэгсрэн гайхалдах ажээ. Энэ бол Чэнь Жэньгийн тал нутагт арван жил амьдрахдаа тохиолдсон хамгийн гайхалтай хэргийн нэг билээ.

Бао Шүнь Гүй болон бэлтрэгээр өлөгчин чоныг урхидахаар санаархсан малчид дэмий горьдоод хоцорчээ. Гэвч Бао Шүнь Гүй хар өглөөгүүр тэдний гэрт хүрч ирээд “Бээжингийн оюутнууд тун сайн ажиллан, Өвөрмонголын тал нутагт анх удаа дайсантай тулгарахгүй ухраах гайхамшигтай тулалдааныг хийлээ” хэмээн амаа олохгүй магтав. Түүгээр үл барам мөнөөх их гарын гар чийдэнг тэдэнд урамшуулал болгон өгөөд аж ахуйн хэмжээнд тэдний туршлагыг дэлгэрүүлэх юм болов. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч бэлтрэгээ үргэлжлүүлэн тэжээх боломжтой болсондоо уртаар амьсгаа авцгаажээ.

Өглөөний цайны үеэр Билиг өвгөн, Өлзий хоёр тэднийхээр айлчлан унаганы махан бууз сүүтэй цайтай уулаа.

Өлзий шөнөжин нүд хамхиагүй боловч их л сэргэлэн байх ажээ. “Урьд шөнө ч мөн эвгүй байлаа шүү. Дөнгөж улиад эхлэх үед би ч тун их айсан. Гурван талын уулан дээрээс хэдэн арван чоно цуглараад танай гэрийн зүг бүслэн хамгийн эхнийх нь лав зуугаад метр ойртсон байх. Бид ч танай гэрийнхнийг чонон сүрэг сүйд хийгээд хаячих вий дээ гэж айж байлаа” гэв.

“Аав та чонон сүрэг яагаад хонь руу дайрч бэлтрэгийг булаасангүй гэж бодож байна вэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Өвгөн сүүтэй цайнаас оочлон тамхиа нэг сороод “Танай бэлтрэг чинь цэвэр чоно шиг улиагүй хааяа нохой хуцах мэт дуу гаргаад байснаас болсон болов уу даа?” гэж хэлэв.

“Та чоныг далдын увдистай гээд байдаг. Гэтэл тэнгэр тэдэнд яагаад үнэн мөнийг хэлээгүй юм бол?” хэмээн Чэнь Жэнь лавшруулан асуув.

“Танай гурвуул хэдэн ноходтойгоо тэдний өмнө юм болохгүй боловч манай багийнхан бүгдээрээ анаад байж байгаа болохоор тэд шийдэмгий дайрлаа ч гэсэн их хохирол хүлээх байсан юм. Бао Шүнь Гүй даргын энэ аргыг тэнгэр яахин мэдэхгүй байх билээ? Мөнх тэнгэр тэдний талд байсан болохоор чонон сүргийг ухар гэсэн байж таарна” гэж өвгөн өгүүлэхэд

Чэнь Жэнь, Ян Кө хоёр бүгд баясан инээлдэв. “Тэнгэрийн таалал үнэхээр мэргэн ажгуу” хэмээн Ян Кө хэллээ.

Чэнь Жэнь Өлзийгөөс асууруун “Өлзий дарга аа, шинжлэх ухааны үүднээс үзэх юм бол чонон

сүрэг яагаад дайраагүй байж болох вэ?” гэлээ.

Өлзий хэсэг зуур бодож байснаа “Би ийм хэргийг үзэх нь байтугай дуулж ч байгаагүй л дээ. Миний бодлоор чонон сүрэг энэ бэлтрэгийг гадны золбин амьтан байна гэж санасан байх. Учир нь чонон сүрэг болгон өөрийн гэсэн нутагтай байдаг. Харин харьяа нутаггүй чонон сүрэг хаана ч оршин тогтнох аргагүй байдаг болохоор түүнийгээ аминаасаа илүү хамгаалдаг. Эндхийн чононууд өөрсдийн харьяа нутгаа гадны тэнэмэл чононуудтай булаацалдан үхэх сэхэхээ үзэн тулалдана. Тэгэхээр энэ бэлтрэг тэдний ойлгогдохгүй гадны хэлээр яриад байхаар тэд хар хүний төлөө шар хүн болоод яахав гээд явчихсан байж таарна. Урьд шөнө азарган чоно нь ч ирэх шиг болно лээ. Тэр лав энэ бүхнийг занга байна гэж мэдэлгүй яахав. Цэргийн мэх цээргүй гэдгийг сайн ойлгодог азарган чоно хүн ноходтой ийм шадар бэлтрэгийг хараад сэжиглэж таарна. Азарган чоно угаас гарцаагүй юман дээр хөдлөдөг болохоор өөрийнхөө мэдэхгүй хэрэгт орооцолдоогүй нь лав. Азарган чоно өлөгчингүүдээ хамгаас илүү хайрлах тул нэг л сэжигтэй санагдахаар тэднийгээ аваад буцсан байж таарна” гэв.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч толгой дохин зөвшөөрчээ.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр тэднийг гэрээс үдэн гаргаж өглөө. Бэлтрэг их л гундуу царайлан эрүүгээ урд хоёр хөл дээрээ тавьчихаад урд шөнийн сайхан муухай зүүднээс салж ядан байх шиг урагш ширтэн хэвгэнэ.

Билиг өвгөн зогсож түүнийг харсанаа “Хөөрхий дөө, чонон сүрэг болоод аав ээж нь түүнийг таньж авсангүй төмөр гинжнээс дөнгөлүүлчихээд байж байдаг. Танай хятадууд тал нутагт ирээд эндхийн дэг ёсыг ч баллаж өглөө дөө. Ийм сэргэлэн амьтныг боол мэт дөнгөлчихсөнийг үзэх болгонд сэтгэл шимшрээд байх юм. . . . Чоно тэвчээртэй амьтан болохоор хэзээ нэгэн өдөр оргох л болно доо. Чи харж байгаарай. Өдөр болгон тарган хурганы махаар хооллосон ч түүнийг тогтооно гэж үгүй” хэмээн хэлэв.

Гурав дөрөв дэхь өдөр хоёрдугаар хэсгийн эргэн тойронд чонын улиан сонсогдсонгүй, гагцхүү өнчрөн гансарсан бэлтрэгний дуу л хавь ойрын уул толгодоор цангинасан боловч хариу чимээ эс гарах ажээ.

Долоо хоногийн дараа бэлтрэг сүр сүлдгүй амьтан болон хувирч улих нь ч эрс цөөрөв.

Үүнээс хойш хэсэг хугацааны турш Чэнь Жэнь, Ян Кө хоёрын хонин сүрэг болоод нийт хоёрдугаар хэсгийн мал сүрэг шөнө орой чонын халдлагад өртсөнгүй. Шөнийн манаанд гарсан охид бүсгүйчүүл бүгд л тэр хоёрт хандан “Шөнө болгон үхэр саах цаг болтол унтдаг боллоо” хэмээн баяртай өгүүлнэ.

Тэр үеэс хойш малчид Чэнь Жэньгийн бэлтрэг тэжээсэн тухай ам сайтай байх болжээ. Гэсэн хэдий ч ирэх жилийн хавар нэг бэлтрэг тэжээнэ ээ гэсэн малчин ганц ч үгүй байлаа. Дөрөвдүгээр хэсгийн өвгөд хөгшид харин ч “Цаадуул чинь тэжээж л байг. Өсөж томроод хүн хавьтахын аргагүй болохоор яахыг нь харья” гэгцгээнэ.



## Хорин долоо

*Ли Бай түрэг цустай хүн байсан нь түүний охин хүү хоёрын нэрнээс андашгүй. Түүний хүү Пөли гэдэг хятадаар тайлбарлахын аргагүй нэртэй байсан нь түргээр чоно гэсэн утгатай үг юм. Чоно нь түргийн сүлд болохоор Пөли гэдэг нэртэй хүмүүс хятадад Луу нэртэн олон байдагтай ижил. Ли Байгийн охин ч “Сарангэрэл” гэдэг түрэг нэртэй байжээ. Ли Бай өөрөө түрэг хүнтэй адил их хурц нүдтэй нэгэн байсан гэдэг.*

*Мөн Чи Бэй “Талын соёл ба хүн төрөлхтний түүх”*

Хэд хоноод л Жан Зи Юань унаганы мах авчирч өгөх тул бэлтрэг нэг хэсэгтээ л махан хоолоор хангалттай байлаа. Гэвч чонон сүргийн дунд байгаа үе тэнгийн бэлтрэгнүүд нь олон өлөгчингийн хайр халамжинд умбаж байгааг Чэнь Жэнь санах бүр бэлтрэгээ илүү сайн хооллож хөдөлгөөнтэй байлгах учиртай гэж бодно. Ядаж унаганы гэдэс дотор нохдод нэг л удаа хоол хийж өгөхөд хангалттай болохоор түүний санаа зовж эхлэв.

Уржигдар Гао Зянь Жун түүнд баруун урд уулын хормойд нэгэн амбан шар аянганд ниргүүлээд үхчихсэн байна лээ гэж байсныг санах. Тэр удаах өдөр монгол хутгаа шуудайгаар ороож бариад очтол чонон сүрэг түүний өмнө амжиж очоод махны үртэс үлдээлгүй мөлжиж орхисон байжээ. Тэр араг ясыг сайтар ажиглаваас зөндөө олон бэлтрэгний шүдний ором гарсан байхыг харлаа. Том чононууд том махыг үмхэлж, бэлтрэгнүүд үлдсэн жаахныг мэрсэн болохоор ялаанууд хүртэл дээгүүр нь хэсэг дүнгэнэж байгаад нисэн одно. Гуравдугаар хэсгийн нэгэн настай үхэрчин тэр сэгэн дээр ирэхийг үзвэл аяганд цохиулж үхсэн амбан шар түүнийх байсан бололтой. Өвгөн Чэнь Жэньд хандан “Чонон сүрэг хонь мал руу дайрахгүй болохоор тэнгэр тэдэнд энэ амбан шарыг бэлэглэж шүү дээ. Чи хар л даа. Өглөө ч биш, шөнө орой ч биш харуй бүрийгээр унагасан болохоор барилгачид маргааш нь авч явахаас өмнө чоно найрлаад өнгөрчээ. Залуу минь, тал нутгийн дэг ёсыг тэнгэрийн тааллаар тогтоосон болохоор түүнийг зөрчвөл эрт орой хэзээ нэгэн цагт үйлийн үрээ амсдаг юм шүү” гэхчээд царайгаа барайлган морио давиран уулын хормойд идээшлэх үхэр сүргийнхээ зүг оджээ.

Малчдын амны уншлага болсон талын дэг ёс гэдэг нь байгалийн зүй тогтол байж мэдэх юм. Байгалийн зүй тогтол гэдэг нь мэдээжийн хэрэг мөнх тэнгэр огторгуйн таалал байж таарна. Гэтэл өөрөө нэг бэлтрэг тэжээсэн нь нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэвшлийг зөрчсөн хэрэг. Тийм болохоор бэлтрэг тал нутагт зөндөө олон төвөг бэрхшээл авчирлаа даа хэмээн Чэнь Жэнь бодоод хоцров. Тэжээсэн бэлтрэг нь түүнд болоод малчдад дахин хичнээн олон төвөг бэрхшээл авчрахыг тэр яахин мэдэх билээ? . . . Чэнь Жэнь ийнхүү үймрэн бодсоор гэрийн зүг ганзага хоосон буцлаа. Тэр толгой өргөн дээр асарлан дүнхийх мөнх тэнгэрийг ширтэв. Хөх тэнгэрийн дор хөхөлбөр ногоо салхины аясаар найгах боловч чонын бараа сураг ч үгүй ажээ. Тал нутагт чонон сүрэг чөтгөрийн гал мэт барих биегүй, дуу сонсогдож, гай нь үзэгдэх боловч бараа туруу нь тэр болгон харагдахгүй тул хүмүүст улам ч нууцлаг, сонирхон судлахын донг өөрийн эрхгүй өдөөнө. Бэлтрэг тэжээсэн нь Чэнь Жэнь анх удаа чонон сүлдийн сүсэг шингэсэн амьд чоныг тэвэрч үзсэн хэрэг билээ.

Түмэн бэрхийг туулан, давхар дарамтыг амсах зуур больё гээд болохгүй байгаа зүйлийг тэр яахин амар орхиж чадах аж.

Чэнь Жэнь барилгын талбай дээр очин өндөр үнээр хагас шуудай шар будаа худалдан аваад дараачийн хонь нядлах хүртэл бэлтрэг болон нохдын хоолонд ахиухан будаа хаяж байх боломжтой болов. Чэнь Жэнь гэртээ ирээд жаахан дугхийх гэтэл гурван гөлөг баруун хойд зүг рүү баясгалантай хуцалдахыг сонсов. Чэнь Жэнь гарч харваас Арслан, Ирвэс, Анч шар гурав уулнаас буун ирж байлаа. Арслан Анч Шар хоёр амандаа ямар нэг том зүйлийг зуусан нь дориун ангийн олзтой ирсэний шинж байв. Ойрдоо гурван нохой ихэд өлсөх тул байн байн Арсланг дагалдан хээр ан хийдэг болсон юм. Харин өнөөдөр овоо том ан барьж өөрсдөө гэдсээ цүдийлгээд зогсохгүй, бусаддаа ч олзтой ирж байгаа бололтой. Чэнь Жэнь тэднийг угтан очвоос гурван гөлөг том нохдын аман дахь олзыг булаалдана. Арслан ангаа газар тавин гөлөгнүүдийг холдуулаад буцаж зуун гэрийн зүг шогшуулав. Арслан Ирвэс хоёр нэжгээд тарвага зууснаар үл барам, Ирвэс ч тохой хирийн урт жирх зуусан байхыг Чэнь Жэнь гайхан харжээ. Өөрийнх нь ноход анх удаа ангийн олзтой эргэн ирсэнд тэр баярлан тосож авлаа. Анч Шар, Ирвэс хоёр өөрсдийн байгуулсан гавьяаг магтуулах гэсэн мэт авчирсан ангаа түүний хөл дор тавиад сүүлээ шарвагануулан аахилсаар Чэнь Жэньг тойрч гүйлдэнэ. Анч Шар тэр ч байтугай тэр болгон харуулаад байдаггүй хөдөлгөөнийг үзүүлэн авчирсан тарвагыг цээж хүзүүн дороо тээн хэвтэх нь өөрөө агнасан гэдгээ хэлээд байгаа бололтой. Тарваганы хэвлийнээс улаан дэлэн цухуйх нь мөндөлтэй нагай байсан бололтой. Чэнь Жэнь хоёр нохойн толгойг илэн “Сайн байна” хэмээн урамшууллаа.

Харин Арслан зуусан тарвагаа газар тавилгүй Чэнь Жэньг тойрон бэлтрэгний зүг явав. Тэр том тарвага зуусан байхыг хараад араас нь ухасхийн гүйж сүүлнээс барьж тогтоогоод амнаас нь салган авлаа. Арслан ч түүнд нэг их дургүйцсэнгүй харин ч сүүлээ хэдэнтээ шарвагануулна. Чэнь Жэнь тарваганы өрөөсөн гуянаас өргөн үзвэл гялалзсан үстэй, лав гурван килограмм хол татахаар овоо өөхөлж байгаа бурхи ажээ. Тэр хоёр нөхрийн хамт ойрдоо ангийн мах амсаагүй байгаа тул түүнийг өөрсдөө идэхээр үлдээв.

Чэнь Жэнь зүүн гартаа бурхи, баруун гартаа нагай, жирхийг хамт бариад гэр рүүгээ их л баясгалантай ороход гурван ноход ноцолдон тоглож дагав. Чэнь Жэнь бурхины махыг газарт тавиад хаалгаа хаалаа. Гөлөгнүүд тарваганы мах ерөөсөө идэж үзээгүй тул энэ тэрүүгээр сониучирхан шиншилнэ.

Чэнь Жэнь туранхай нагайн махыг гөлөгнүүдэд хаяж өгөөд, жирхийг бүтнээр нь бэлтрэгэнд хаяж, арьстай махыг идэж сургахаар шийджээ.

Зуны тарваганы арьсыг худалдаа бэлтгэлийн ангид өгөөд ч олигтой үнэ хүрдэггүй юм.

Тэгээд Чэнь Жэнь хутгаараа тарвагыг мах яс, гэдэс дотор, арьс үс юутай хээтэй нь дөрвөн хэсэг болгон хуваав. Гурвыг нь гөлөгнүүдэд өгч, нөгөө нэгийг бэлтрэгэнд хувь болгон үлдээжээ. Тэр гөлөгнүүдэд хувийг нь өгөхөд булаалдалгүй авч холхон очоод хөлөөрөө даран идэж гарав. Гурван том нохой Чэнь Жэньгийн шударга хувааж байгааг тааламжтай нь аргагүй харж зогслоо. Чэнь Жэнь ноходод ийнхүү шудрага хандах хүмүүжлийг Жек Лондонгийн “Талын дуудлага” зохиолоос олж авсан билээ. Тэр номыг нэгэнд нь зээлүүлтэл хоёр бригадын илгээлтийн эздийн гар дамжаад алга болсон юм даг.

Гурван том нохой гэдсээ цүрийтэл идэцгээжээ. Гэхдээ гавьяа байгуулсан этгээдийг шагнадаг нь эрт эдүгээгийн гадаад дотоодын цэргийн журам төдийгүй монголд ч бас энэ ёс дэлгэрсэн

болохоор тэр гэртээ орж дөрвөн “Бүжин” чихэр авчирч тэднийг шагналаа. Чэнь Жэнь эхлээд Арсланд хоёрыг өгөв. Цаадахь нь чихэр рүү шууд дайрсангүй нөгөө хоёрыг эзэн нь хэрхэн урамшуулахыг харж байв. Тэгээд нэжгээд чихэр өгөхийг хараад санаа амарсан байдалтай хөлөөрөө чихрийн цаасыг задлан шалир шалир идэж эхлэлээ. Анч Шар, Ирвэс хоёр ч Арслангаас дутуу шагнуулсандаа гоморхсонгүй даруйхан идэцгээв. Тэр хоёрын авчирсан анг ч гэсэн Арслан барьсаныг мань хоёр авчиралцаж тусласан байх гэж Чэнь Жэнь сэжиглэж байлаа.

Бэлтрэг цусны үнэр аваад бүр сэргэн хойд хоёр хөл дээрээ зогсож, гэдсээ ил гарган урд хоёр хөлөө сарвалзуулна. Чэнь Жэнь түүнийг хараагүй дүр үзүүлж байв. Хэрвээ хүн харж байгааг мэдчихвэл гинжээ улам чангаагаад байдаг гэмтэй юм. Чэнь Жэнь гөлөгнүүдийн хоолны аяыг олчихоод мөнөөх жирхийг янзалж эхлэлээ. Тал нутагт хулганы төрлийн амьтад олон байдгаас хамгийн түгээмэл нь жирх, үхэр оготно, зурам юм. Тэр тусмаа гэрээс гараад хэд алхахад жирх энэ тэрүүгээр үсчин дуугарч байхыг харж болно. Заримдаа оготно хулганы нүх ихтэй газар буучихвал гурил будаа, ааруул өрөм хулгайлаад зогсохгүй, номын хайрцаг руу орж сүйтгэх нь элбэг. Тэгээд нүүдэл суудлын үеэр хуучин муусайн гуталд үүрлэхчээд улаан нялзрай гөлчгийгөө гаргасан байх нь тун эвгүй. Малчид оготно хулганыг угаас таашаадаггүй, тэр тусмаа Чэнь Жэнь, Ян Кө нар хоёр ч хайрцаг сонгодог номнуудаа тэдэнд сүйтгүүлсэнээс хойш бүр ч үзэж чадахаа байсан юм.

Жирх нь урт сүүлгүй л болохоос биш Бээжингийн баруун ууланд байдаг хэрэмтэй бараг ойролцоо биетэй. Харин хэрэм шиг бүлтгэр том нүдтэй, ногоондуу судал, шаргал толбо бүхий эрээн арьстай сагсгар сүүл бүхий амьтан билээ.

Жирх бол эрт дээр цагаас нааш монгол хүүхдүүдийн харваж намнадаг амьд бай байсаар ирсэн гэж Билиг өвгөн ярьдаг.

Жирх нь олон нүхтэй, их хурдан амьтан тул сум жаахан л сүүлдэх юм бол онолгүй өнгөрөх болно. Монгол хүүхдүүд өдөрт аавынхаа зааж өгсөн тооны жирхийг алж чадаагүй бол гэртээ харьж хоол идэх эрхгүй. Гэхдээ иймэрхүү ан хийх нь хүүхдийн хувьд маш зугаатай тоглоом болохоор монголын тал тэдний хувьд асар том зугаацлын ордон болон хувираад унд хоолоо ч умартан улайрна. Хүүхэд жаахан томроод ирэхийн алдад түүний нумыг арай том болгон сольж, морин дээрээс харвах сургууль хийлгэдэг. Тухайн үедээ Оросыг байлдан эзлэж явсан Чингис хааны есөн өрлөгийн нэг Зэв жанжин чухам энэ аргаар сургуулилсаар эрхий мэргэн харваач болсон гэдэг. Зэв морины давхил дунд зуун алхмын цаана байгаа жирхний толгойг алдалгүй харвадаг байсан гэлцдэг. Хэрвээ жирхийг л намнадаг болчихвол цагаан зээр, үнэг, чоно, дайсны цэрэг морьдын амин цэгийг алдалгүй харвахад асуудал үгүй болно гэсэн үг. Хятад цэргүүдийн морь тааруу, дээр нь хөдөлгөөнгүй бай харваж сургуулилдаг тул монголчуудын харвах намнах эрдмийг хэрхэн гүйцэх билээ. Дайны талбар дээр хоёр талын цэрэг халз тулгарахад монголчууд хоёр гуравхан ээлж сум харваад дайсныхаа талыг хиаруулдаг байжээ.

Монголчууд хүүхдээ оготно зурамхан харвуулж сургадаг нь бас л чононоос сурсан эрдэм гэж Билиг өвгөн ярина. Өлөгчин чоно бэлтрэгнүүддээ зурам туулай барьж сургадаг нь нэгд зугаацуулан тоглуулахаас гадна гэдсийг давхар цагтаж өгдөг.

Эрт дээр цагт монголын талд оготно зурам харваж намнах сургуулиар дамжин жил болгон хичнээн олон сайн чоно, баатар эрс бэлтгэгдэн гардаг байсан бол доо. Тэр олон оготно зурмыг алахын хэрээр нутаг бэлчээрээ давхар хамгаалж таарна. Монголчууд чонон сургагч бүхий тал нутгийн ийм сайн цэргийн сургуультай байсныг Чэнь Жэнь үнэхээр бахдан биширдэг. Монголчууд “Тэнгэр хүмүүн амь нэгтэй”<sup>35</sup> гэдэг ухагдахуунд итгээд зогсохгүй, түүнийг улмаар “Тэнгэр адгуус, хүн өвс” амь нэгтэй болгон хөгжүүлжээ. Энэ нь хятадын “Тэнгэр хүмүүн амь нэгтэй” гэдэг ойлголтоос ч илүү гүн нарийн агаад үнэ цэнэтэй ажгуу. Оготно зурам зэрэг бэлчээр сүйтгэгч нар хүртэл монголчуудын амьдралд ийм амин чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн байна.

\* \* \*

Чэнь Жэнь тэр жирхний сүүлнээс өргөн сайтар ажиглалаа. Тэр хонь хариулж явахдаа зөндөө л жирх харж байсан боловч тохой шахам урт байх нь ховор байдаг юм. Уулын сугын өндөр өвстэй газар л ийм том жирх байх боломжтой. Махлаг тарган ийм жирх лав бэлтрэг болон том чонын дуртай хоол байж таарна. Бэлтрэг нь жирхний шархны цусыг үнэртээд унаганы мах руу дайрдагтай адил ухасхийн үмхлэх байх гэж тэр төсөөллөө.

Чэнь Жэнь жирхийг уруу харуулан өргөхөд түүний шархны цус хамрыг даган урссаар газар дуслана. Тэр чонын хүрээний гадна очоод “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн өндөр дуугаар хашгирлаа.

Бэлтрэг ийм хоол урьд өмнө үзээгүй боловч цусны үнэр түүнд их л амттайг илтгэх тул хорхойсч байна гэдэг жигтэйхэн. Бэлтрэг түүнийг авах гэж үсрэн цоройх тусам Чэнь Жэнь жирхийг улам өндөрт өргөж байлаа. Бэлтрэг Чэнь Жэньг харахгүй зөвхөн жирхийг ширтэнэ. Харин Чэнь Жэнь тэгэхээс тэг гэсэн шиг өөр рүүгээ харсан цагт жирхийг бэлтрэгэнд өгье гэж бодож байлаа. Гэвч түүний хүсэл талаар болох янзтай. Бэлтрэг жирхийг харсан цагаас хойш хээрийн догшин чонын төрхийг илтгэсэн дөрвөн хурц соёогоо байдгаар нь ярзайлган, сарвуугаар самардан тонгочино. Чэнь Жэнь бэлтрэгний тэр байдлыг хараад жихүүцэл төрөх шиг болов. Чэнь Жэнь дахин хэдэн удаа савлахад өөрийг нь тоох янз үгүйг үзээд жирхийг түүнд хаяж өгөв. Бэлтрэг жирхийг урж тасдан том том үмхлэхийг тэр чонын хүрээний гадна явган суучихаад ажиглая гэж боджээ.

Гэвч бэлтрэг жирхийг тосож авсанаас хойшхи үйл хөдлөл түүний бодсоноос тэс өөр, тэр ч байтугай тайлбарлахын эцэсгүй, насан турш мартахын аргагүй хэрэг болон хувирав.

Бэлтрэг жирхийг улайсгасан бөөрөнцөг мэт болгоомжтой зуусаар газар зөөлөн тавиад метр орчмын хол очиж хэвтэн хүзүүгээ сунгачихаад айсан мэт гурван минут орчим ажиглан харав. Тэгснээ зугуухан босож биеэ хураан мярааж байгаад ухасхийн жирхийг барьж аван нэг хазчихаад буцаж байрандаа очив. Хэсэг хэвтэн ажиглаж байснаа эргэж дайран хазах энэ үйлдлийг гурав дөрвөн удаа давтсаны хойно нэлээд тайвширав бололтой.

Энэ мөчид түрүүчийн догшин чонын харц бэлтрэгний нүдэнд эс үзэгдээд төрөл арилжсан мэт их л үнэнч хүндэтгэлтэй төрх бүхий болон хувирахыг Чэнь Жэнь олж үзлээ. Бэлтрэг жирхний дэргэд зугуухан алхаж хүрээд өрөөлдөн зогсож байснаа баруун урд хөлөө бохирон цээжээрээ жирхний биед хүрэн цааш түлхэн өнхрүүлэв. Тэр үсрэн босож биеийн тоос

шороог гэвсөнөө жирхний нөгөө талд очин саяын үйл хөдлөлийг яг ижилхэн давтлаа.

Чэнь Жэнь бэлтрэгний чухам юу хийх гээд байгааг сониучирхан ажиглах зуур энэ бүх үйл хөдлөлийг хаанаас сурсан, чухам ямар учиртайг ойлгож ядна. Бэлтрэгний энэ бүх үйл хөдлөл амьдралдаа анх удаа амтлан шарсан тахианы бүхэл мах олж үзээд идэх дур байвч хайрлаад ам хүрч чадахгүй байгаа хөвгүүний төрхийг санагдуулав.

Бэлтрэг саяын төвөгтэй үйл хөдлөлийг жирхний баруун зүүн талд гурав гурван удаа давтжээ.

Урьд нь тэр зөндөө олон амттай мах, тэр ч байтугай цустай унаганы мах хүртэл өгч байхад ийм хөдөлгөөн хийж байгаагүй атлаа яахаараа энэ тарган жирхийг үзээд ийм өвөрмөц өөр хөдөлгөөн үзүүлдэг билээ хэмээн Чэнь Жэнь маш их гайхан бодож байв. Энэ арай чонын ангийн олз олсон үедээ хийдэг нэгэн төрлийн зан үйл биш биз дээ? Эсвэл аливаа амьтныг идэхийн өмнө хийдэг ёсолгоо юм болов уу? Түүний тэрхүү үнэнч хүндэтгэлтэй төрх нь ариун идээ зооглох гэж байгаа сүсэгтнээс огт өөрцгүй.

Чэнь Жэнь энэ талаар тархиа гашилтал бодсоны эцэст энэ удаагийн өгсөн зүйл урьд өмнө өгч байсан хоолнуудаас чанарын хувьд тэс өөр болохыг тэр гэнэт ухаарав. Тэр урьд нь бэлтрэгт хичнээн чанартай сайн хоол өглөө гэж бодож байсан нь сайндаа л хэсэг бусаг мах, яс болон хүний гараар боловсорсон зүйлүүд байсан. Харин энэ удаагийн хоол нь жинхэнэ байгалийн төрхөө алдаагүй биет зүйл байгаагаараа онцлог юм. Толгой, сүүл, арьс үстэй яг л үхэр хоньд шиг, тэр ч байтугай өөртэй нь төстэй амьтан санагдсан байж таарна. Өөрийгөө эрхэмсэг бардам авч явдаг чонын төрөлтөн л гагцхүү ийм биет зоогийг эрхэмлэдэг байх нь аргагүй юм. Харин өөрийн хэлбэр дүрсээ алдчихсан яс, мах хичнээн амттай байгаад ч явж явж хүний хоол ундны шавхруу төдийхөн зүйл шүү дээ. Тэр бүхнийг горилоод байх юм бол чонын эрхэмсэг байр суурийг алдана гэсэн үг. Хүмүүс ч гэсэн үхэр, хонь, гахай, нугасны шарсан махыг хамгийн эрхэм зоогт тооцож, түүнийг хүртэхээс өмнө тусгай ёслол үйлддэг нь байтлаа чононоос сурсан хэрэг биш биз дээ?

Бэлтрэг юутай боловч ийм эрхэм тансаг зоогтой учраад түүний төрөлхийн эрхэмсэг зан нь өдөөгдөн тодроод ийм үнэнч хүндэтгэлтэй үйл хөдлөл ёслолыг үйлдсэн байж мэдэх юм.

Гэвч бэлтрэг чонон сүрэгтэйгээ ганц удаа нийлж байгаагүй атлаа яаж энэхүү нарийн үйлдлийг гурван ч удаа цогцоор нь алдаа мадаггүй хийж чадаж байна вэ? Мөртлөө хатуу чанга сургагчийн удирдлаган дор тоо томшгүй олон удаа давтсан юм шиг сурамгай хийж байдаг. Чэнь Жэнь тэр бүхний учрыг цөхөртлөө бодоод олж чадсангүй.

Бэлтрэг хэсэг аахилан хэвтэх боловч жирхний арьсыг хүүлсэнгүй. Тэр биеэ сэгсрэн үс ноосоо цэвэрлээд гэнэт урд хөлөө өргөн жирхийг тойрон алхаж эхлэлээ. Бэлтрэг нүдээ тааламжтай анивхийлээд Зөвлөлтийн циркийн сургуультай цагаан морь мэт хөлөө зугуухан зөөж тавих нь Чэнь Жэньд урлагийн тоглолт үзүүлж байх шиг санагдав. Тэр хэсэг удаан алхсанаа гэнэт хурдаа нэмнэ. Гэвч хурдан удаан алин боловч алхааны хэмжээгээ алдахгүй тул түүний хөлийн мөрөөр дув дугуй тойрог үүслээ.

Чэнь Жэнь хаврын эхээр цэргийн агтны осолд орсон газар харсан чонын тойргийг санаад толгойтой үс нь босох шиг санагдав. Тэгэхэд цэргийн агтнуудын сэгийг тойрон гүйсэн хэдэн

арван чонын мөрөөр чөтгөрийн тойрог мэт хүрээ үүссэн байж билээ. Хөгшчүүл түүнийг талын чоно тэнгэрт талархсаны дохио хэмээн үздэг. . . . . Хавар үзсэн чонын хүрээ болон энэ удаа бэлтрэгний гаргасан тойрог хоёулаа дув дугуйгаас гадна, голдоо арьс үстэй бүтэн ангийн мах тавиастай байдаг.

Бэлтрэг ийм нандин ангийн олзтой учраад шууд хүртчихэж чадалгүй тэнгэрт талархал илэрхийлж байгаа нь энэ юм болов уу?

Бурхангүй үзэлтэн үлгэр домог мэт үнэн бодит явдалтай учирсан, эсбөгөөс бодит амьдралын дундахь энэхүү үлгэр домог мэт зүйлийн алин ч бай хамаагүй Чэнь Жэнь өөрийн нүдээр харсан бэлтрэгний энэхүү этгээд сонин үйл хөдлөлийг зөн совин, удамшил зэргээр тайлбарлаж боломгүй санагдаж байлаа. Ер нь ч тэр талын чонотой холбоо бүхий олон баримтыг хүний ердийн сэтгэхүйгээр тайлбарлах аргагүй гэдгийг мэднэ л дээ.

Бэлтрэг баярлан хөөрсөн байдалтай тойрон гүйсээр байв. Гэвч тэр өдөржин юм идээгүй өлөн чоно болчихоод байгаа шүү дээ. Өлөн чоно гэдэг цустай мах үзэхээрээ галзуу чоно болон хувирдаг. Гэтэл бэлтрэг яахаараа түүнээс тэс өөр, чин ариун сүжигтэн шиг авирлана вэ? Тэр өлөн зэлмүүнийг үл тоомсорлон, ийм нарийн төвөгтэй “Шашны ёслолыг” үйлдэхийг үзвээс чонын ертөнцөд ч гэсэн балар эртний шашны ул мөр байдаг юм биш байгаа даа? Тэр нь асар хүчтэй оюуны хүчээр талын чонын үйл хөдлөлийг залж чиглүүлж байдаг байж ч мэднэ. Түүгээр ч үл барам тэр нь нүдээ нээгээгүй байхдаа чонон сүргээсээ холдсон жаахан бэлтрэгт хүртэл хүртээлтэй байдаг юм биш биз? Арай хүй нэгдлийн хүмүүсийн балар эртний шашин амьтнаас тэдэнд уламжлагдан очсон байж болох биш үү хэмээн Чэнь Жэнь өөрөөсөө асуув. Балар эртний хүн чоно хоёр эрт балар цагт шашны хэлхээ холбоотой байсан байж болох уу? Нууцлаг тал нутаг хүмүүсийн тайлж мэдээгүй ямар их нууцыг агуулна вэ. . . . .

Бэлтрэг тэгж тэгсээр дороо зогсов. Тэр жирхний өмнө амьсгаагаа дарж аваад хэлээрээ хоёр завьжаа тойруулан хоёронтоо долоолоо. Түүний нүдэнд баран идэхүйн зэрлэг харц тодроход балар эртний чин сүжигтнээс хээрийн өлөн чоно болон хувирав. Тэр ухасхийн урд хоёр хөлөөрөө жирхийг дарж аваад цээжийг нь хүү татан сэгсрэхэд хэсэг арьс сэглэгдэн ярагдаж мах цус нь ил гарч ирэв. Бэлтрэг жирхний гэдэс дотор, үс ноос, баас шээс гэж цэрвэж цээрлэх юмгүй бүгдийг хаман идэх ажээ.

Бэлтрэг идэх тусам улам шунамхайран баясгалантай гийнахыг үзээд Чэнь Жэньгийн хамаг бие жихүү даах шиг болов. Бэлтрэг идэх тусмаа улам зэрлэг төрхийг олж, түүний хувьд гашуун цөс, шинхэгтэй давсаг цөм л таван тансагийн дээд мэт санагдаж байгаа бололтой. Тэгсээр нүд ирмэхийн хооронд жирхний гавлын яс, сагсгар сүүл хоёр л үлдэв. Бэлтрэг улмаар амсхийсэнгүй урд хоёр хөлөөрөө жирхний толгойг барьж урд хэсгээс нь мэрэн идэж эхлэлээ. Тэр жирхний хурц шүднүүдийг хүртэл тургин хаяхгүй иднэ. Түүгээр ч үл барам мах гээд байх юмгүй жирхний сагсгар сүүлийг хүртэл хаяж төвдөлгүй хоёр хуваан тас хазаад залгиж орхижээ. Халцгай газар жаахан цус, шээсний ул мөр төдийхөн л үлдлээ. Бэлтрэг сэтгэл нь ханаагүй бололтой Чэнь Жэньг хэсэг зуур харж байснаа хоёр гарт нь юм байхгүйг үзээд түүн рүү хэдэн алхам дөхөж урамгүйхэн хэвтээд өгөв.

Бэлтрэг оготно, зурам, жирхэнд ер бусын дуртай болохыг Чэнь Жэнь сая ойлголоо. Саяын

жирх бэлтрэгний далд зөн совинг бүрэн өдөөн гаргаж чаджээ. Олонбулгийн тал хэдэн мянган жилийн турш оготно зурмын гамшгийг амсаагүйн учир илхэн болж ирэв.

Чэнь Жэнь өдөр болгон шахам бэлтрэгний өөр өөр сонирхолтой жүжгүүдийг үзсээр улам ч хайр бахдал төрөх болжээ. Тэр тусмаа чонын жүжиг сэтгэл хөдлөм гүн нарийн агаад хүнд ухаарал нэмэх тул Чэнь Жэнь өөрийн мэдэлгүй бэлтрэгний үнэнч фен болон хувирсан байлаа. Харамсалтай нь бэлтрэгний тайз дэндүү жижигдэх ажээ. Хэрвээ тэр нийт монголын нутаг дэвсгэрийг өөрийн тайзаа болгочихвол хичнээн сүрлэг агаад хүний сэтгэлд юм бодогдуулсан гайхалтай жүжиг тоглох байсан бол доо? Гэвч хээрийн чонын хэдэн мянга түмэн жилийн турш монголын уудам талд тоглосон жинхэнэ баатарлаг жүжгүүдийн ихэнх нь түүхийн тоосонд дарагдан үгүй болсон юм. Тэгсээр одоо тоотойхон хэд үлдээд байгаа чонон сүрэг мөртлөө хил орчмын бүс нутагт шахагдаад байна. Тэр хэрээр хятад хүмүүс нүд баясган, ухаарал нэмэх боломжийг алдаж байгаа хэрэг.

Бэлтрэг яс мэргэж байгаа гөлөгнүүдийг бүлтийн ширтэв. Чэнь Жэнь гэртээ орж нөгөө том тарваганы арьсыг өвчин, нохойд уруулсан хүзүү хавийн махыг огтлон орой бэлтрэгтээ өгөхөөр идүүрт хийв.

Чэнь Жэнь гэдэс дотрыг нь арилгаж цэвэрлээд тарваганы махыг дангаар нь чаналаа. Тогооны тал шахам зуны дунд сарын тарвага гэдэг гурван хүнд подхийсэн амттай зоог билээ.

\* \* \*

Оройхон тийш бэлтрэг халцгай газар баруун тийш харан суугаад, зугуухан тал дугуй болон хувирах нарыг догдлонгуй ширтэж эхлэв. Шингэх нарны үлдэл туяаны сүүлчийн хэдэн цацраг уулын цаагуур далд оронгуут тэр монгол гэрийн хаалга руу биеэ эргүүлж ан барих, дороо хөлбөрөх зэрэг этгээд сонин хөдөлгөөн гаргаж гинжээ харжигнуулах нь Чэнь Жэнь, Ян Кө хоёрт миний мэдлийн цаг эхлэлээ шүү гэдгийг сануулж байгаа хэрэг юм.

Чэнь Жэнь тарваганы махаа идчихээд бэлтрэгний гинжнээс хөлтлөн салхилахаар явахад Арслан, Анч шар хоёр бас дагалдав. Харуй бүрий болохын өмнөх энэ зурвас үе нь бэлтрэгний хувьд хоол идэхээс ч илүү жаргалтай цаг мөчүүд байдаг. Чоныг салхинд гаргана гэдэг цэргийн овчарк нохойг дагуулж яваатай адилгүй. Хэдийгээр энэ нь Чэнь Жэньгийн хувьд бас л сайхан юм шиг санагдавч цаагуураа их ядаргаатай ажил билээ.

Бэлтрэг хоол унданд сайн болохоор үе тэнгийнхнээсээ хавьгүй биерхүү болон өсчээ. Бэлтрэгний хөөвөр гуужин, гялалзсан шар саарал өнгөтэй болсон төдийгүй сэрвээнд нь ширүүн хар хялгас ургасан нь хээрийн чононоос огт өөрцгүй харагдана. Багын зантгар толгой нь хавгайн шөвийж, хар өнгийн сарьсан хоншоор чийг даан гялтайна. Чэнь Жэнь түүний сарьсан хоншоорыг чимхэхэд толгой сэгсрэн найтаах бөгөөд энэ үйлдэл түүнд тааламжтай байгаа нь илт. Бэлтрэгний хоёр чих нь ч соотойгоод холоос харахад хээрийн чоно дүрээр зогсож байх ажээ.

Бэлтрэгний хоёр нүд болвоос хүний сэтгэл сэрхийлгэм атлаа түүний биеийн хамгийн харууштай хэсэг юм. Чонын нүд хүн болон бусад амьтдынхаас тэс өөр шаргал мана мэт өнгөтэй. Автомашины аваарын гэрэл улбар шар өнгөтэй байдаг нь манан будан дундаас тод

харагддаг гэлцдэг. Тэгвэл чонын энэхүү манан шаргал өнгө нь хүн амьтны сэтгэлийг нэвт харж чаддаг байх гэж Чэнь Жэньд санагдана. Бэлтрэгний хүүхэн хараа харьцангуй жижиг болохоор Шерлок Холмс зохиолд гардаг нэгэн хар арьстны хортой зүү үлээдэг гуурс мэт хүний сэтгэлийг шөвөгдөх шиг харна. Чэнь Жэнь бэлтрэгний уурлах нүднээс аминд хүрдэг хорт зүү гараад ирмээр юм шиг санагдах тул түүний нүд рүү эгцлэн харж чаддаггүй юм.

Чэнь Жэнь бэлтрэгийг өөртөө дасгаснаас хойш тайван байх үед нь хоёр чихийг маажиж, хоёр шанааг нь бариад нүүр нүдгүй ширтсээр зуу гаруй хоносон тул одоо түүний нүүрийн хэлбэрийг маш сайн хэлж чадахаар болсон юм. Түүнд хэдийгээр бэлтрэгний нүүр царай өхөөрдөм санагдах боловч сэтгэлд нь цаанаа л нэг жийрхмээр байдаг байлаа. Зөвхөн нүдийг нь харах төдийд ар зоогоор хүйт даагаад явчихаж байгаа юм чинь, наж могойн хорт шүднээс хурц дөрвөн соёогоо ярзайлгах ярдаглахад ямар аймаар байх нь тодорхой. Тэр хааяа хааяа бэлтрэгний амыг ангайлган шүдийг нясалж үзэхэд никель мэт жингэнэх нь их л хатуугийн шинж байж таарна. Мөн хуруугаараа үзүүрийг тэмтрэхэд гутлын хадааснаас ч хурц, паалан нь хүний шүднийхээс бөх байгаа нь илт мэдэгддэг.

Мөнх тэнгэр талын чононд элэгтэй учраас л үзэсгэлэнтэй атлаа сүр хүчтэй зүс царай, аймшигтай хурц зэвсгийг хүртээсэн байж таарна. Тал нутгийн олонх амьтад чонотой халз тулахаас өмнө аймшигт араа шүднээс нь сүрдээд зэвсгээ хураалган бууж өгдөг билээ. Бэлтрэгний өдөр ирэх тусам хурцлагдсаар байгаа дөрвөн соёо Чэнь Жэньгийн сэтгэлийг улам бүр тавгүйтүүлэх болов.

Харин азаар салхинд гарах нь бэлтрэгний хамгийн баяртай мөч тул тэр үедээ эзэн рүүгээ аймшигт араа шүдээ ярзайлгана гэж үгүй. Харин ч зөөлөн хазлах нь бэлтрэгний эзэндээ дотносож байгаагийн илрэл тул Чэнь Жэнь түүнд хуруу гараа өгч мэрүүлдэг. Бэлтрэг ч түүний хуруунуудыг маш болгоомжтой долоон, ахан дүүстэйгээ ноцолдохдоо ам хүрэхийн төдий байдаг шиг зөөлөн хазлахаас биш өвгөж цус гоожуулна гэж айлтгүй.

Сүүлийн нэг сарын хугацаанд бэлтрэг суга өссөнөөр үл барам хүч чадал ч түүнээс дутуугүй нэмэгджээ. Чэнь Жэнь үнэн хэрэг дээрээ өдөр болгон бэлтрэгээ зугаалуулж байгаа биш, харин өөрөө чирэгдэж, хөтлөгдөж яваа мэт санагдана. Бэлтрэг чонын хүрээнээс холдонгуут тэрэг чирсэн амбан шар шиг түүнийг татан довцог толгой өөд довтолгоно. Түүний хөлийн чадлыг сайжруулахын тулд Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч араас нь даган гүйдэг байв. Эзэн нь мэдээжийн хэрэг ядраад гүйж чадахгүй болохын хэрд бэлтрэг түүнийг чирсээр дахин хагас цаг шахам гүйнэ. Чэнь Жэнь ийнхүү гар хөлөө өвдтөл чирэгдэн, хар хөлсөө цувуулахдаа өдөржин ажилласнаас ч илүү ихээр ядарна. Өвөрмонголын өндөрлөг агаарын хувьд Бээжингээс хавьгүй сийрэг тул Чэнь Жэнь бэлтрэгэнд чирэгдсээр тархин дахь хүчилтөрөгчийн хангамж муудан, царай цонхийгоод хөлийн шөрмөс татах энүүхэнд. Тэр анхандаа бэлтрэгийг даган гүйсээр тал нутгийн хүдэр эрсээс дутуугүй болохыг мөрөөдөж байсан юм. Гэвч бэлтрэгний хурдлан давхих эрч хүч улам нэмэгдэхийн хэрээр түүний итгэл бүрмөсөн алдраад ирэв. Монголын хамгийн алдартай үзэмчин морь хүртэл талын чонын гүйдлийг барааддаггүй байтал жирийн нэгэн хятад залуугийн хоёр хөл түүнийг яахин гүйцэх билээ? Чэнь Жэнь, Ян Кө хоёр тэр ч байтугай, бэлтрэгийг нас бие гүйцэхээр яахин салхилуулж байна даа хэмээн санаа зовних болжээ. Аягүй бол түүнд чирэгдсээр чонон сүрэг дээр давхиад хүрчихийг хэн байг гэх билээ?



Заримдаа Чэнь Жэнь, Ян Кө хоёр бэлтрэгэндээ чирэгдэн унахыг холоос ажиглан харж байсан охид хүүхдүүд эг маггүй шоолон инээлдэх нь харагддаг. Хэдийгээр малчид бүгдээрээ л чоно тэжээнэ гэдэг утгагүй хэрэг хэмээн санах боловч тэд бэлтрэг салхилуулан явахыг харах дуртай байдаг байлаа. Багийн малчид бүгдээрээ Бээжингийн оюутнуудын “Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа” гээчид мөнх тэнгэр хэрхэн тохирсон шийтгэл оноохыг харах гэж хичээцгээнэ. Орос хэл жаахан гадарладаг дунд эргэм насны нэгэн малчин ямар сайндаа “Шинжлэх ухаан байтугай хүн төрөлхтөн тэр аяараа чоныг сургаж чадаагүй юм шүү дээ” гэж учирлаж байх вэ. Түүний тайлбарт итгэх хүн үгүй боловч чоно нохойн эрлийз гөлөг гарган авах гэж байгаа юм гэнэ лээ гэсэн цуу яриа аж ахуй даяар тархсан байлаа. Ян Кө тэр хоёрын бэлтрэгэндээ чирэгдэн унасан хөгтэй явдлууд малчдын архины ширээний ард ярьдаг амны зугаа болон хувирч удахгүй чоно нь жингэр нохойгоо барьсан хэрэг дуулдана даа гэцгээнэ.

\* \* \*

Бэлтрэг баяртайгаар урд нь орон давхихад Чэнь Жэнь аахилсаар араас нь гүймэр аядлаа. Урьд нь салхинд гаргах болгонд бэлтрэг баярласандаа зүг чиггүй гүйдэг байсан чинь ойрын хэдэн өдөр тэр нэгэн шөнө өлөгчин чононууд ульсан газар руу очих дуртай болсон нь гайхалтай. Чэнь Жэньгийн сониучирхал ч гэсэн өдөөгдөөд чухам ямар учиртайг мэдэхийг хичээнэ. Энэ удаа бэлтрэг урьд урьдынхаас хавьгүй хол гүйн нэгэн жалгыг гатлаад налуу энгэр дээр авч ирэв. Чэнь Жэнь гэрээсээ хоёр километр шахам холдсон байхыг үзээд нэлээд санаа зовнисон боловч Арслан, Анч Шар хоёроос гадна, малиагаа авсандаа жаахан уужирч, учиргүй буцъя хэмээсэнгүй. Дахин хоёр зуун метр орчим гүйгээд бэлтрэг хурдаа сааруулан, чулуу, өгөр яс, аргал, хомоол зэрэг сэрийсэн болгоныг шиншлэн үнэрлэж эхлэлээ.

Тэгсээр нэгэн шивээ өвсний дэргэд хүрч үнэрлэн үзсэнээ хамаг бие нь чичрэн сэrvээний үс нь зарааны өргөс шиг босоод ирэв. Түүний нүдэнд баярын оч гэрэлтэн болдогсон бол шивээ өвс рүү толгойгоо шаагаад оруулчихмаар байгаа мэт шунамхай шиншлэнэ. Тэр гэнэт толгой өргөн баруун зүгт жаргах нарны улбар туяаг харан уртаар ульж эхлэв. Бэлтрэг болон том ноход бүгд хээрийн чонын үнэрийг авсан болохыг Чэнь Жэнь даруй ойлгов. Тэр хэсэг шивээний бутыг даавуу шаахайтай хөлөөр ярж үзвээс дийлэнх хэсэг нь хээрийн амьтны шээсэнд шарлаад чонын шинхэг ханхийн хамар цоргив. Энд чонын шинэхэн шээс байхыг үзвээс урьд шөнийн чононууд энэ хавиар эргэлдсэн болохыг мэдэж Чэнь Жэнь нэлээд бачимдлаа. Тэнгэрийн хаяаны улбар туяа бүдгэрээд харуй бүрий нөмөрч, намуун салхины аясаар халиурах өндөр өвсний цаанаас олон чонын сэrvээ цухуйн үзэгдэх шиг болоход өлөгчин чонын отоонд орох вий хэмээн сэтгэл зовнив. Тэр олон юм ч бодсонгүй бэлтрэгийг аваад гэртээ харья хэмээн боджээ.

Энэ мөчид бэлтрэг хөлөө өргөн шивээ өвсний бут руу сарихаар завдаж байлаа. Чэнь Жэнь айсандаа бэлтрэгийг хүчлэн татлаа. Үрээ марталгүй санасаар байгаа өлөгчин чононд бэлтрэг хэл чимээ дуулгахаас тэр айсан хэрэг л дээ. Хэrvээ бэлтрэг өлөгчин чонотой нэг л уулзчихвал чухам юугаар төгсөхийг төсөөлөхөд ч бэрх юм. Чэнь Жэнь хамаг хүчээрээ бэлтрэгийг суга татан холдуулав. Ингэснээр түүний шээсийг тасалдуулж, эхийгээ эрж хайх халуун хүсэл, төлөвлөгөөг тасалж орхижээ. Бэлтрэг нүдээ бүлтийлгэн уурлаж, жинхэнэ хээрийн зэрлэг чоно шиг хамаг биеэ хурааж байснаа Чэнь Жэнь рүү ухасхийн дайрлаа. Чэнь Жэнь ч яаран биеийг зайлах гэтэл бут өвсөнд тээглэн унахад бэлтрэг түүний шилбэнээс

хазаад авав. Чэнь Жэнь “Аа” хэмээн хашгирах мөчид зүрх зүсэм өвдөлт айдас хоёр түүний хамаг биеийг эзэмджээ. Бэлтрэгний хурц соёо дан өмдийг нэвглэн эрээн булчинд шигджээ. Чэнь Жэнь ухасхийн босоод малианы үзүүрээр амыг нь түлхэн холдуулах гэсэн боловч бэлтрэг бүр улангасч хэсэг мах өм татахаас нааш санаа амрахгүй шинжтэй дайрна.

Хоёр том ноход ч ухасхийн хүрч ирэхэд Анч Шар бэлтрэгний шилэн хүзүүнээс хазан угз татан хойшлуулав. Арслан ч мөн бэлтрэгний чихэн дээр чанга чанга хуцахад цаадахь нь айсандаа дагжин арагш ухарсанаар Чэнь Жэнь сая нэг юм аврагдав.

Чэнь Жэнь айсандаа бараг л ухаан мэдрэлээ алджээ. Өөрийн тэжээж өсгөсөн чонын шүдэнд хазуулсан шархны халуун цусаа олж үзэв. Арслан, Анч шар хоёр бэлтрэгийг хэмхчиж байхыг хараад ухасхийн хориглож цээжиндээ тэврэх гэсэн боловч цаадахь нь хурц шүдээ ярзайлган дайрахаас буцахгүй шинжтэй.

Чэнь Жэнь хоёр том нохойгоо хориглон холдуулснаар бэлтрэг ч тонгочихоо больжээ. Тэр гараа сулруулахад бэлтрэг биеэ сэгсрэн Чэнь Жэньгээс хоёр алхмын зайтай холдоод хорсолтой харцаар түүнийг ширтэхэд сэрвээний үс нь буух янз алга. Чэнь Жэнь айх уурлах хослоод “Бэлтрэг ээ, чи байтлаа намайг урж байгаа хэрэг үү? Арай сохроогүй биз дээ?” хэмээн ууртай зандрахад танил дуу хоолойгоо сонссон бэлтрэг галт уулын дэлбэрэлт мэт улангассан уур хилэнгээс сая нэг юм ангижрав. Тэр Чэнь Жэньг толгой гилжийлгэн харж байснаа арайхийн таних шиг болжээ. Гэвч түүний нүдэнд гэмшсэн шинж огт эс үзэгдэнэ.

Шархнаас урсах цус даавуу шаахайг нэвглэв. Чэнь Жэнь ухасхийн босож малиагаа нэг хулганы нүх рүү шаагаад гинжний цагаригийг түүнд углалаа. Тэр бэлтрэгийг цус хараад улангасч магад хэмээн эмээж нэлээд хол очин, өмдний шуумгаа эргүүлж харав. Шилбэний өрөөсөн бөөрөнд дөрвөн жижиг соёоны мөрнөөс цус урсана. Азаар ажлын өмд бэрзээнтнээс дутуугүй зузаан байсан тулдаа учиргүй гүн шигдээгүй ажээ. Тэр тал нутгийн малчдын шарх эмнэх хар домьг хэрэглэн шархыг тойруулан шахаж шфрицний тал хэртэй цус гоожуулж хорьг тайлаад цамцаа уран чивчиртэл боолоо.

Чэнь Жэнь босож бэлтрэгний гинжнээс бариад гэрийн зүг зааж “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн хашгирав. Энэ бол салхилуулж дууссаны дараа бэлтрэгийг гэрийн зүг залах Ян Кө тэр хоёрын хамгийн шалгарсан арга билээ. Бэлтрэг “Хоолондоо” гэх үгийг дуулангуут саяын болсон явдлыг ор тас мартав бололтой шүлсээ гоожуулан Чэнь Жэньг чирэх шахам гэрийн зүг хурдаллаа. Гэртээ харьсаны дараа ч тэр идүүрийнхээ дэргэд суучихаад ус хоол тавихыг хүлээв. Чэнь Жэнь гинжний цагаригийг шонд углаад, тарваганы хүзүү сээрийг бэлтрэгт өгч, идүүрт ус дүүргэлээ. Бэлтрэг их цангасан бололтой толгойгоо идүүр рүү шаачихаад нэг амьсгаагаар талыг нь шахуу ууж орхив. Орой салхилуулсаны дараа гэр рүүгээ авчрахад амрыг бодон өглөө өдөртөө бэлтрэгт ус өгдөггүй юм.

Чэнь Жэнь гэрт орж шархандаа эм түрхэхийг хараад Гао Зянь Жун түүнийг явж тариа хийлгэ хэмээн шаардав. Чэнь Жэнь ч аз мэдэг гээд орхисонгүй морио унасаар гуравдугаар хэсгийн илгээлтийн эзэдтэй хамт амьдардаг хөл нүцгэн эмч Сяо Пэнгээр галзуугийн эсрэг вакцин тариулж, эм түрхүүлэн боолгожээ. Чэнь Жэнь бас түүнээс бэлтрэгэнд уруулсан тухай хүмүүст битгий хэлээрэй хэмээн аминчлан захив. Түүний хариу болзол болгож Сяо Пэнгийн алдаж үрэгдүүлсэн “Өрнө зүг зорчсон тэмдэглэл” нэрт номыг дахин нэхэхгүйн дээр

“Наполеоны намтар”, “Гао өвгөн” гэдэг хоёр номыг өгч уншуулахаар болжээ. “Аж ахуйн эмнэлгээс тавхан тариа өгсөн юм. Барилгачид айлын нохойд уруулаад ганцхан үлдсэн байсныг чамд тарьчихлаа. Одоо энэ хар халуунд бас л аж ахуйн төв рүү явах нь” гэж Сяо Пэн их л дурамжхан бувгнана. Чэнь Жэнь ч түүнийг сайн үгээр тайвшруулах гэж хирхэндээ чармайна. Гэвч түүний толгойд бэлтрэгээ хэрхэн хамгаалах ганц бодол эргэлдэх тул чухам юу хэлсэнээ ч сайн анзаарах сөхөөгүй байлаа. Тал нутгийн тогтсон заншлаар хонь барьсан нохой газар дээрээ алуулдаг байтал хүн рүү халдсан бэлтрэгийг ямар хувь тавилан хүлээх нь ойлгомжтой. Чоно тэжээх гэдэг угаас тэнгэрийн ёсонд харш хэрэг байтал хүн урсан бэлтрэгний амь дээсэн дөрөөн дээр очлоо гэсэн үг. Тэр мориндоо мордонгуут шархандаа санаа зовохоо байгаад тархи нь ахиухан шүүс ялгаруулан бэлтрэгийг аврах арга боддог ч болоосой хэмээн толгойгоо шаах нь холгүй бачимдана.

Гэртээ харихад Гао Зянь Жун, Ян Кө хоёр хүн урдаг болсон бэлтрэгийг хэрхэн учрыг олох талаар маргалдацгааж байлаа. “Муу хар золиг Чэнь Жэньг хүртэл урж байгаа юм чинь бусад хүнийг хазахгүй хаачих юм бэ? Дараа өөр хүн урчихвал яах болж байна аа, тийм болохоор заавал алах хэрэгтэй. Бид намаржаандаа буусан хойно айл хунар, аж ахуйн төвөөс хорь гучин километр холдох тул чононд уруулчихвал хаашаа тариа хийлгэнэ гэж явах вэ? Чонын галзуу өвчин, нохойн галзуугаас аюултай байдаг гэнэ лээ. Тэгж байгаад хүний аминд хүрвэл юу болох вэ?” хэмээн Гао Зянь Жун хашгичина.

“Аж ахуйгаас Чэнь Жэнь бид хоёрт галзуугийн вакцин тарихгүй байх аа. Тийм вакциныг чоно нохойд санамсаргүй тохиолдлоор уруулсан хүнд хийдэг болохоос санаатай бэлтрэг тэжээж байгаа хүмүүст хаанаас хийв гэж дээ? Тийм болохоор өнөө шөнөдөө багтаан бэлтрэгийг тавьж явуулах хэрэгтэй. Дахиад жаахан оройтох юм бол аж ахуйгаас түүнийг устгах гээд хүрээд ирэх нь лавтай” хэмээн Ян Кө дуу шуу муутайхан өгүүлэв.

“Чоно хүн урчихаад байхад чи түүнийг тавиад явуулна гэж байдаг. Чи ч мөн Дунгуо36 ноёнгоос илүү донгио амьтан юм даа. Тийм ч амар хэрэг гэж байхгүй байлгүй” гэж Гао Зянь Жун хэллээ.

Тэдний маргааныг сонссоор Чэнь Жэньгийн ухаан санаа бүр сэргээд иржээ. Тэр шүд зуун өгүүлрүүн “Би энэ тухай сайн бодсоон. Бэлтрэгийг тавих ч үгүй, алах ч үгүй. Хэрвээ түүнийг цохиод алчих байсан бол би зөвхөн ганц удаа хазуулаад өнгөрөх гэж түүнийг тэжээсэн байх уу? Энэ олон өдрийн хөлс хүчийг талаар урсгасан хэрэг болно биз дээ? Хэрвээ түүнийг тавиад явуулна гэвэл алж байгаагаас өөрцгүй. Тэр хэрвээ чонон сүрэг дээрээ эсэн мэнд хүрч очлоо ч гэсэн түүнийг өөр овгийнх юм уу, эсвэл хүний заншлаач байх гээд азарган чоно алчих нь гарцаагүй” хэмээн хэлэв.

“Тэгээд яана гэж вэ?” хэмээн Ян Кө их л гуниглангуй хэллээ.

“Одоо цорын ганц арга гэвэл бэлтрэгний дөрвөн соёог бахиар суга татах л ганц арга байна. Хэрвээ түүний хурц зэвсгийн ирийг алга болгочихвол хүн урлаа ч гэсэн цус гаргаж чадахгүй. Тийм болохоор тариа хийлгэнэ гэж ийш тийш гүйхгүй амар болно. Харин бид түүнд махаа сайн жижиглэж өгч байх хэрэгтэй” гэж Чэнь Жэнь хэлэв.

Ян Кө толгой сэгсрээд “Наад арга чинь үр нөлөөтэй боловч түүнийг алснаас өөрцгүй. Хурц

соёогоо алдсан чоно хожим тал нутагт амьдарч чадах уу даа?” гэлээ.

Чэнь Жэнь толгойгоо унжуулаад “Надад үнэхээр өөр арга үгүй болчихлоо. Би тэртэй тэргүй чононд дахин уруулж чадахгүй, ёстой л сүүнд халсан хүн тараг үлээнэ гэгч болчихоод байна. Тэгээд ч чонын шүд дахиад ургачихдаг байлгүй. Харин одоохондоо түүний ирийг үүнээс өөр мохоох арга алга” гэв.

“Байтлаа барын амнаас шүдийг сугална гээч болох нь шив дээ. Тэгж байгаад дахин хазуулах нь л дээ” гэж Гао Зянь Жун түүнийг егөөдөв.

Хоёрдахь өдрийн өглөө хонио бэлчээсний дараа Чэнь Жэнь, Ян Кө хоёр бэлтрэгт мэс засал хийлээ. Тэр хоёр эхлээд бэлтрэгийг сайтар цаггаж баясгасны дараа Ян Кө бэлтрэгний дагзнаас тэвэрч хоёр эрхий хуруугаараа завьжны угаар шахан амыг ангайлгахад огт эсэргүүцэл үзүүлсэнгүй. Бэлтрэг угаас тэр хоёрын янз бүрээр элдэвлэхэд дассан төдийгүй энэ удаа харин ч зугаатай байгаа бололтой. Мань хоёр бэлтрэгний соёог нарны өөд харуулан ажиглахад тунгалаг паалангийн цаанаас шүдний мэдрэлийн судас төдийлөн урт яваагүй нь харагдав. Хэрвээ судсыг нь гэмтээлгүй соёоны үзүүрийг бахиар хавчаад хугалчихвал бэлтрэгт ч нэг их айхтар өвдөлт мэдэгдэхгүй байж таарна. Тэгвэл бэлтрэг дөрвөн соёотойгоо үлдэхээс гадна, хожим сэргээд ургачихыг хэн байг гэх билээ?

Чэнь Жэнь эхлээд бэлтрэгт бахийг үнэрлүүлэн дасгахад цаадахь нь хөлөөрөө оролдон тоглов. Бэлтрэг бахинд овоо дасахын хирд Ян Көгөөр амыг нь ангайлгаж байгаад маш хурдан тас тас хийтэл соёоны үзүүрийг тайрлаа. Ингэснээр хурц соёоны бараг дөрөвний нэгийг амжилттай тайрч чадав. Тэр хоёр уг нь энэ ажилбар бараг л барын амнаас шүд сугалах хэрийн амаргүй хэрэг болж мэдэх тул бөөн ноцолдоон шуугиан болох байх гэж санаж байсан билээ. Гэтэл нэг минут хүрэхгүй хугацаанд бэлтрэг ч сүйдтэй шаналсангүй бүх юм аятайхан өнгөрчээ. Бэлтрэг соёоны хугархайг долоож үзсэнээ нэг их сүртэй харамсахгүй байгаа бололтой. Манай хоёр бэлтрэгийг урамшуулан амттай зүйлээр шагнах гэсэнээ шүдийг нь хөндчих байх гээд болив.

Дахин чононд уруулна гэж айлтгүй болсондоо Чэнь Жэнь, Ян Кө хоёр санаа нь амарчээ. Гэсэн атлаа тэр хоёр хэдэн өдрийн турш их л урвагар байцгаалаа. “Чонын соёог авна гэдэг хүн хөнгөлж байгаагаас илүү харгис хэрэг болох шиг боллоо” хэмээн Ян Кө хэлэв. Чэнь Жэнь ч гэсэн яах учраа олохгүй “Бид анх чоно тэжээж байсан зорилгоосоо нэг л холдоод байгаа юм биш үү?” гэж заримдаа өөрөөсөө асууна.

Сяо Пэн удаа дараа гурван номыг нь аваад явсанд мань хоёр амь тавих шахжээ. Аж ахуйн хэмжээнд Бээжингээс ирсэн зуу гаруй илгээлтийн эзэд дотор Чэнь Жэнь, Ян Кө хоёр л хэдэн хайрцаг “Феодал, хөрөнгөтөн болоод засварлах үзэлтнүүдийн” сонгодог зохиолыг хадгалж байдаг юм. Хоёр жилийн улс төрийн хатуу ширүүн харгислал өнгөрсөний дараа нэгэн хэвийн хөдөөний амьдралд уйдсан илгээлтийн эзэд тэдгээр хориотой номнуудыг үхэн хатан уншицгаах болсон билээ. Тийм болохоор нэг л ном бусдад өгчихвөл эргүүлж авна гэж санасны гарз болно. Гэвч Чэнь Жэнь түүнд номоо зээлэхээс өөр арга байсангүй. Учир нь гурван дарга чоно хүн урсан тухай дуулвал Бао Шүнь Гүй бэлтрэгийг гарцаагүй алахаар ирж таарна. Сонгодог зохиолууд үнэхээр хэргээ гаргаж, аж ахуйн хэмжээнд нэлээд удаан хугацааны турш Чэнь Жэнь бэлтрэгэнд уруулсан тухай ганц ч хүн дуулаагүй өнгөрсөн юмдаг.



## Хорин найм

*Ши Минь37 цэрэг гарснаас хойш урд хожид хэдэн арван удаа байлдаж, ерөөс биеэр түрүүлэн эрэлхэг баатарлагаар урагшилж, морьт гавшгай цэргээр гүн орж, олон удаа хүнд аюулд тулгарсан боловч ер зэвийн шарх олоогүй. . . . .*

*Ши Минь биеэр хэдэн арван хүмүүнийг алж, хоёр илд нь бүр эмтрэн сэтэрч, хоёр ханцуйд цус дүүрэн атал цусаа сэгсэрмэгц дахин байлдахаар оровой. Ли Юаний цэрэг дахин бадран хөгживэй. . . . .*

*Хаан өгүүлрүүн: “. . . . Ямарваа цэрэг хэрэглэх арга болгон ашигтай бол түргэн урагшилж, ашиггүй бол түргэн ухармуй”*

*Сы Ма Гуан*

*“Засагт туслах нэвтэрхий толь”*

Хэдэн ч удаагийн ширүүн борооны дараа Олонбулгийн талын гол горхиуд үерлэн, шинэ нутаг дахь нуурын усны түвшин дээшилж, эрэг хавийн өвс ногоо чийг дааснаар хэдэн зуу, мянгаар тоологдох нугасны дэгдээхэй идэш эрэх, нисэж сурах таатай орчин болон хувирчээ.

Бээжингийн илгээлтийн эздийн хувьд шумуулын хоол болно гэдэг зуд турхан, хар зуд, салхи шуурга, гал түймэр, ган гачиг, өвчин тахал, чонын аюулаас ч илүү аймшигтай гамшигт тооцогдоно. Олонбулгийн талын шумуул гэдэг амьсгалах агаартай адил хаанаас ч гараад ирж мэднэ. Хэрвээ шумуулаас хамгаалах малгай өмсөөгүй тохиолдолд амьсгаа авахын төдийхөнд хамраар хэдэн шумуул давхиад орчихдог. Өвөрмонголын дунд болон зүүн хэсгийн нутаг дэлхий дээр шумуул хамгийн шигүү олноор үүрлэсэн газарт зүй ёсоор тооцогдох буй за. Учир нь энд гол нуур элбэг, өвс өтгөн сахлагийн дээр шумуулын өвөлжих байр болсон тарваганы үүр маш олон байдаг. Энд шумуулын хоол болох хүн, чоно, үхэр, хонь, ямаа, адуу, тарвага, туулай, үнэг, могой, цагаан зээр зэрэг амьтдын цус далай шиг арвин. Тэдгээр чонын цусаар хооллосон шумуулын сүрэг ямар сайндаа л саяхан Бээжингээс ирсэн арван зургаан настай хүүг сэтгэцийн өөрчлөлттэй болгоод нутаг буцааж байхав дээ. Чонын цусаар хооллосон шумуулнууд чонон сүргээс ч илүү улангассан зангаараа тал нутгийн халуун хүйтэн цустай амьтан болгон руу хошууран дайрч эхлэв.

Ялангуяа шинэ нутаг бэлчээрт түрүү жилийн өвлийг эсэн мэнд өнгөрөөсөн шумуулнууд хавьгүй олон тул бүр ч илүү их гай тарьж байлаа.

Үдээс хойш Чэнь Жэнь монгол гэр дэхь шумуулын хамгааллалтын торондоо сууж хэсэг ном уншиж байснаа толгойдоо шумуулнаас хамгаалах дуулгаа өмсөөд, сайтар битүүмжилсэн гэрээсээ гарлаа. Тэр гартаа адууны сүүлээр хийсэн шумуул үргээгчээ барьчихаад шумуулын сүрэгт ээрэгдэх бэлтрэгэн дээр очив. Одоо шумуулын гол дайралтын бэлтгэл үе болохоор Чэнь Жэнь дөнгөж гаруугаа дайны түгшүүрийн дохионоос ч аймшигтай дүнгэнэсэн чимээн дунд ороод явчихлаа.

Олонбулгийн талын том шар шумуулнууд хэдийгээр чонын ухаан байхгүй боловч тэднээс үл

дугах амь хайргүй дайчин давшингуй зантай байдаг. Тэд нар нэг л амьтны үнэр авах юм бол үхэр адууны сүүлэнд ороолгон үхэх хамаагүй, нисдэг зүү, зэрлэг сумнууд мэтээр шунган орцгооно. Араас нь ирэгсэд үхэгсдийнхээ цусан суунаг татуулсан мөрийг хараад харин ч бүр улангасан дайрцгаадаг.

Чэнь Жэньгийн өмссөн тохой хэрийн өргөн шаа торгон шумуулын халхавч агшин зуурын төдийд тоо томшгүй олон шар шумууланд бүчүүлэв. Тэд шаа торгоны завсар зайгаар зүүний үзүүр мэт урт хошуугаа шургуулцгаахыг Чэнь Жэнь хараад адууны сүүлэн гөвүүрээр үргээж хэдэн арвыг доош унагасан боловч нүд ирмэхийн зуур бас баахан шар шумуул шавчихав. Тэр дэвүүрээр сэвж байгаа мэт адууны сүүлэн гөвүүрээр ширвэсний хүчинд сая урдаа байгаа зүйлсийг харах боломжтой болно. Чэнь Жэнь толгой өргөн харвал шумуулан сүрэг дайны бэлтгэл хийж байгаа мэт хоёр метр орчмын өндөрт шавааралдан нисэх бөгөөд тал нутаг тэр аяараа дайны галд шатаж, агаарт өтгөн шар утаа суунаглах мэт үзэгдэв. Жинхэнэ аймшигтай “Чонын утаа” гэвэл тал нутгийн шар шумуулын энэ бөөгнөрлийг хэлэх байх даа. Зуны энэ үед л тал нутгийн хүн мал бүгдээр дайны байдалд орчих юм даа” хэмээн Чэнь Жэнь бодож байлаа.

Тэр өнөө шөнийн манаанд хэрхэн гарахдаа бэлтгэж шумуулын байдлыг ажиглав. Өнөөдөр шумуулын сүрэг илүү олширсоноос гадна, тэдний толгой бүр ч аймшигтай томорчээ. Шумуулнууд далавчаа хурдан дэвэх тул нүдэнд үзэгдэхгүй, харин бие нь зулзаган хавчны хайрс мэт харагдана. Энэхэн мөчид тэр буй биеээрээ нуурын ёроолд зогсчихоод дээш харахад нуурын мандлаар тоо томшгүй зулзаган хавчнууд хөвж байх шиг санагдлаа.

Чэнь Жэньгийн чөдөртэй цагаан морь өвс идэх тэнхэлгүй, шумуул сийрүүхэн хонины бууц бараадан зогсоно. Гэвч түүний бие дээр бас л бөөн бөөн шар шумуулнууд суусан нь холоос харахад будааны хивэг цацсан мэт үзэгдэх ажээ. Цагаан морь эзнээ шумуулын гөвүүр барьсан байхыг хараад түүн рүү догонцон дөхөж ирлээ. Чэнь Жэнь ч түүний чөдрийг тайлан хөтөлсөөр шумуул арай цөөхөнтэй үхэр тэрэгний хажууд аваачин чөдөрлөв. Цагаан морь сүүлээрээ гэдэс, гуя, ууц нуруугаа ороолгон шумуулыг үргээх бөгөөд цээжин хэсгийн шумуулыг хошуугаараа аргалсан болж байлаа. Мянга түмэн шумуулнууд хөлөөрөө морины арьсыг яраад зүү шиг урт хатгуураа шигтгэхэд удаж төдөлгүй гэдэс нь цүдийн томроно. Цагаан морь тэсэж ядсандаа сүүлээрээ хүчтэй ороолгоход түүний мөрөөр цусан судал татна. Ингэсээр цагаан морь чонон сүргийн дундуур дайран гарч ирсэн шархтай адуу шиг харагдаж байлаа.

Чэнь Жэнь гөвүүрээр бие дээрх шумуулыг нь үргээж өгөхөд цагаан морь их л баярлаж байгаа бололтой толгой дохин үүрсэв. Гэвч хичнээн үргээж хөөгөөд ч нэмэргүй, морины бие цаг ямагт будааны хивэг цацсан мэт харагдана.

Чэнь Жэнь бэлтрэгээ юу болж байгаа бол гэж бодоод чонын хүрээ гүйлээ. Түүний үүр борооны усанд автсан тул бэлтрэг дотогш орж шумуулаас зайлах аргагүй болжээ. Бэлтрэгний зуны тачир үстэй их бие болон үсгүй шахам чих, хамар, нүдний зовхи, гэдэс, дөрвөн мөч зэрэг нь сүрэг шумууланд бариулаад галзуурахад ганц хуруу дутаж байгаа янзтай. Талын шумуул чонын цусыг шимтэй гэж үздэг бололтой өтгөн “Шар утаа” бэлтрэгний зүг хошууран дайрна. Бэлтрэг газар хөлбөрөн өнхрөөд бүр болохгүй болохоор ааг амьсгаагүй хэсэг гүйснээ амаар нь шумуул орчихвий гэсэн үү хэлээ ч гаргаж зүрхлэлгүй аахилна. Удалгүй бэлтрэг хойд

хоёр хөлөө бие дороо хумьж, урд хоёр мөчөөрөө хамраа таглан хэвглээ. Тал нутгийн энэ догшин амьтан шумууланд ааглуулаад нэвширтлээ гөвшүүлсэн гуйлгачин мэт тартагтаа тулан хэвтэх юм гэж Чэнь Жэнь яахин санах билээ? Гэсэн хэдий ч бэлтрэгний нүд очтон гялалзаж, үл мохох догшин ширүүн занг илтгэнэ.

Цаг агаар улам бүгчимдэж, агаарын нам даралтанд дээгүүр дүнгэнэлдэх сүрэг шумуулууд бүр ч тарах янз алга. Чэнь Жэнь нэг гараараа бэлтрэгний толгой биеийг илж, нөгөө гар дахь шумуулын гөвүүрээр цохилоход бөөн бөөн “Будааны хивэгнүүд” цусан зам татуулан ойчно. Энэ урсах цус түүний цаг хугацаа, сэтгэл хүч шингэсэн зүйл шүү дээ гэж бодоход Чэнь Жэньгийн сэтгэл шимширнэ. Бэлтрэгт их тааламжтай байгаа бололтой Чэнь Жэньгийн гарт наалдсан цусыг долоонгоо түүний өвдөгт загатнасан биеэ үрлээ. Бэлтрэг Чэнь Жэньг авралын од гэж ойлгосон бололтой харцанд нь талархсан шинж илэрхий. Чэнь Жэнь хээрийн чононууд хэрхэн зовж байгаа бол доо хэмээн бодов. Эргэн тойрны бэлчээрийн өвсийг мал идээд сийрэгшсэн. Гэтэл онгон зэрлэг уул талын өвс ногоо хавьгүй өндөр болохоор шумуул ч эндхээс бүр арвин байж таарна. Үүрэндээ нуугдья гэхээр араас нь дагаад салахгүй, салхи сөрөн давхиад ч өмнө нь бас л баахан шумуул тосоод байж байх тул хээрийн чоно улам ч илүү зовох нь гарцаагүй юм. Тарвага баригдахаа байсан. Ганц нэгийг барьлаа гэж бодоход шумууланд алдсан шим тэжээлийг нөхөхөд амаргүй. Шумуул чонон сүргийн хамаг байдаг цусыг сорж улангассан өлөн юмнууд болгодог тул түүний горьг хүн мал амсдаг хэмээн Билиг өвгөний ярьдаг ортой юм. Шумуул чонон гамшиг шил шилээ даран тал нутгийг дайрах болохоор ойрын үед аж ахуй даяар хүмүүсийн сэтгэл санаа тавгүй байлаа.

Бэлтрэг нэлээд алжаангуй боловч турсан шинж үгүй. Тэр өдөр шөнөгүй шумууланд хазуулах боловч хөдөлгөөн нь ч бүр илүү нэмэгджээ. Улангассан шумуулын дайралтын өмнө түүний эрс хатуу зан чанар мохсонгүй, хоол унданд урьдын адил сайн байгаа билээ. Зуны ид халуунд шумуулын гамшгийн нөлөөгөөр мал сүргийн өвчлөл ихэссэн болохоор Чэнь Жэнь энд тэндээс үхсэн хонь ямаа олж ирээд бэлтрэгээ тэжээнэ. Бэлтрэг ч хувь илүү хоол хүртэж шумуулын тарчлааныг давах сэтгэл зүйн бэлтгэлтэй болжээ. Тийм болохоор энэхүү гамшгийн улиралд урьдын адил тарга хүчээ хадгалсан хэвээр байлаа. Чэнь Жэнь ч хүүхдээ хичээл номоо хий гэж шахдаггүй ухаалаг гэрийн эзэн шиг намбатай байв. Түүний ганц хүсэх юм гэвэл бэлтрэг хоолоо цадтал идэж байвал болох нь тэр. Идэх мах уух ус нь л байж байвал бэлтрэг хичнээн хэцүү бэрх зовлон сорилтыг даван туулж өдөр болгон амжилттай дүн үзүүлж чадна гэдэгт тэр итгэнэ. Чоно тэжээсэн хүн алсдаа үр хүүхдэдээ дааж давшгүй том үүрэг хүлээлгэе гэж бодохоо байх мэт түүнд санагдана. “Хүүгээ луу болохыг”<sup>38</sup> хүсэх нь байтугай “Чоно болгоно” гэдэг ч бүтэшгүй хэрэг байх бус уу?

Ямар адтай шумуул бэлтрэгний салтаа доогуур шурган ороод шодойг нь хазчихсаныг бүү мэд тэр год үсрэн босов. Тэр хойд хөлөө өргөн толгойгоо салтаа руугаа шургуулан загатнасан амин газрыг хошуугаар үрэв. Гэвч түүнийг босох төдийд хэдэн зуун шумуул, гэдсэн доогуур нь хошууран дайрахад бэлтрэг байж ядсандаа шодойгоо хазаад авах нь холгүй тэлчлэв.

\* \* \*

Чэнь Жэнь бэлтрэгийг орхиж, гар хадуур аргаа аваад баруун уулын судагт агь өвс хадахаар очив. Өнгөрсөн жил шумуул бага байсан болохоор Чэнь Жэнь Галсмаатай цуг ганц л удаа агь хадахаар явж билээ. Шинэ нутагт нүүж ирснээс хойш Чэнь Жэнь хаагуур агь өвс их ургасныг



энэ тэрүүгээр явж тогтоосон юм. Бороо хур тал нутагт шумуулын гамшгийг авчирснаас гадна хэсэг бусад агь өвс өтгөн ургах боломжийг олгожээ. Шумуулын дайралт ид улангасах үе нь морин агьны ааг амт боловсорч гүйцэхтэй давхцдаг юм. Хэрвээ агь өвс гэж байдаггүй байсан бол нүүдэлчид тал нутагт оршин тогтнож чадах байсан болов уу гэж бодоод Чэнь Жэнь тэнгэр өөд ширтэн харав.

Ноход нь өвсөн доторх шумуулаас айгаад Чэнь Жэньг дагалгүй үхэр тэрэгний сүүдэр бараадан хоцорсон билээ. Чэнь Жэнь баруун уулыг чиглэн алхахдаа хэсгийн хонин сүргүүд өвс багатай хадархаг уулын орой хярыг бараадан бэлчиж байхыг харлаа. Хоньчид энэ хар халуунд шумуулын малгайгаа тайлж зүрхлэхгүй хөлсөө урсгана.

Судагт өвс сахлаг, шумуул элбэг салхигүй тул Чэнь Жэньгийн ууцыг даган хөлс урслаа. Түүний зузаан даргар даавуугаар хийсэн ажлын цамц хөлсөнд норж гүйцээд хэд гурван том шумуул хошуугаа шургуулчихаад авч чадахгүй зовно. Ингэсээр Чэнь Жэньгийн цамцан дээр хошуундаа дөнгөлөгдсөн шумуул улам бүр олшроод ирэв. Чэнь Жэнь ч тэднийг буянаараа болог гэж бодон үргээж хөөсөнгүй. Гэвч удалгүй түүний мөрөн дээр часхийн загатнахад тэссэнгүй алгадаад авгал алга нь цусан толбод будагдав.

Чэнь Жэнь хэсэг морин агь дээр явж очтол тэнд шумуул харьцангуй цөөхөн байлаа. Газраас дээш метр өндөр ургасан морин агийн цагаан саарал ишин дээрх навч шүүслэг зөөлөн өдөрхөг зүйлээр бүрхэгджээ. Агь өвс гашуун эм шиг амттай, хонь мал тоож иддэггүй тул ийнхүү тааваараа ургана. Чэнь Жэнь өндөр өвсийг үзээд алхаагаа сааруулан хадуураа чанга атгаад байлдааны бэлэн байдалд оров. Зун өндөр ургасан агин дунд шумуул харьцангуй цөөн байдаг болохоор чоно хоргодох нь элбэг. Чоно шумуул үргээхийн тулд агин дунд хөрвөөж түүний гашуун үнэрийг шингээн шумуулаас хамгаалах зэвсэг болгодог юм шүү гэж хашир малчид илгээлтийн эздэд байнга сануулдаг юм.

Тэр нохойгүй гарсан болохоор шууд дөхөн очиж зүрхэлсэнгүй, хэд чанга хашгираад сэжигтэй зүйл үгүйг үзээд сая өвс рүү очив. Чэнь Жэнь амь аврах арш өвстэй учирсан мэт хамгийн өтгөн хэсгийг хадаж эхлэв. Өвсний шүүс хадуурыг ногоон өнгөөр будаж, агаарт эмийн ургамлын гашуун үнэр ханхлахад, тэр гүн амьсгаа авч, болдогсон бол таван цул зургаан саваа тэр чигт нь агийн үнэрээр дүүргэмээр санагдлаа.

Чэнь Жэнь том арагтаа агь өвс оцойтол дүүргээд гэрийн зүг яаран алхав. Тэр нялх агийн шүүсийг шахаж гар дээрээ түрхсэнд шумуул төдийлөн халдаж чадахгүй ажээ.

Гэртээ эргэн ирээд зуухандаа хуурай аргал хийн галлав. Тэр чингэлэгээ ухаж байгаад жилийн турш энд тэндээс цуглуулсан хуучин муусайн долоо найман түмпэнгээс хамгийн томыг шилж аваад дээр нь улайсан цогшсон хэдэн аргал хийж атга хадсан өвс тавихад удаж төдөлгүй агийн сэнгэнэсэн үнэртэй цагаан утаа суунаглав.

Чэнь Жэнь утаа суунаглах түмпэнг чонын хүрээний салхины аман дээр аваачин тавьлаа. Агийн утаа нь тал нутагт шумуул айлгадаг ганц зүйл юм. Түүний үнэрийг авсан шумуул хошуугаа санд мэнд сугалж аваад дайжин нисдэг. Агшин зуурын төдийд чонын хүрээнд эргэлдэж байсан шумуулнуудын олонх нь бараа туруугүй алга болов.

Агийн үнэр бэлтрэгт шумуулнуудыг үргээж өгөв. Гэвч бэлтрэг галын оч, цагаан утааг харчихаад хамаг бие нь чичрэн, нүдэнд нь айдас тодроод гинжээ татан чонын хүрээний урд хэсэг рүү цахлан зүтгэв. Галаас айдаг чонын төрөлхийн зан нь илрэхэд, тэр шумууланд хазуулахын зовлонгоо ч умартан цагаан утаа хүрээгүй газар руу очихыг санаархана. Талын чоно хэдэн мянган жилийн турш үүрээ угуулсаар өвөг дээдсийнх нь галаас айдаг зан бэлтрэгэнд удамшиж дээ гэж Чэнь Жэнь бодож байлаа. Тэр дахин атга агь авч түмпэнд хийгээд утааг бэлтрэгний зүг чиглүүлээ. Агийн утаа бэлтрэгийг шумуулнаас аврах цорын ганц арга зам тул түүнийг утаанд дасгах ёстой гэж боджээ. Хээр талд өлөгчин чононууд бэлтрэгнүүдээ дагуулан уулын орой болон агь өвсийг бараадан шумуулнаас зайлж байгаа. Харин энэ хот айлд тэр өөрөө л өлөгчин чонын үүргийг биелүүлж агь өвсний утаагаар бэлтрэгнээс шумуулнуудыг холдуулах учиртай гэж Чэнь Жэнь бодож байв.

Цагаан утаа боргилох тусам бэлтрэг айсандаа тэлчлэн зүтгэж өөрийгөө боомилох нь холгүй юм болов. Тэр ийнхүү тэлчилсээр сүүлдээ хөдлөх ч тэнхээгүй болон цагаан утааны дор чичрэн хэвтлээ. Бэлтрэг хэдийгээр маш их айж сандрах боловч хэдэн өдрийн турш өөрийг нь ээрч хоргоон тарчлаасан бяцхан хорхойнууд дүнгэнэн нисэлдэх үзэгдэхгүй болоод бие нь овоо тавирч байгаа бололтой. Тэр ийш тийш гайхан ширтэх зуур салтаа руугаа тонгойн үзвээс өөрийг нь байж ядтал хаздаг өчүүхэн амьтан хаашаа ч юм алга болжээ. Бэлтрэгний нүдэнд эргэлзээ, баяр хөөр холилдон тодроод хавьгүй сэргээд ирэв.

Гэвч тэр боргилон суунаглах цагаан утааг харах болгондоо навтгас хийнэ. Түмпэнгээс гэнэт хэдэн оч үсрэн түүнийг чиглэхэд бэлтрэг айсандаа чонын хүрээний утаагүй хэсэг рүү ухасхийн үсрэв. Түүнийг утаанаас холдонуут шумуулан сүрэг бүчин авахад дээш доош тонгочин нүүрээ самардлаа. Тэр бүр тэсэхээ байгаад чонын хүрээг даган ааг амьсгаагүй гүйж гарлаа. Ийнхүү арван хэд тойроод хурдаа сааруулахдаа тэр шумуултай шумуулгүй хэсгийн ялгааг ойлгож эхлэв. Түүнийг утаатай хэсэг рүү ороход биед нь байсан шумуул дайжин нисэж, утаагүй хэсэгт гарахаар сарьсан хоншоор дээр нь хэд гурваараа час хийтэл хазаж байхыг тэр мэджээ. Бэлтрэгний нүд цагаан утааг гайхан ширтэж, түүн дотор байх хугацаа аажмаар уртассаар байлаа. Тэр угийн ухаалаг сэргэлэн тул өмнөө буй болсон энэхүү шинэ үзэгдлийн тухай толгойгоо ажиллуулан бодно. Гэвч түүний утаанаас айх нь бүрмөсөн арилсангүй утаатай, утаагүй зурвасын заагт эргэлзэн зогслоо.

Үхэр тэрэгний сүүдэрт шумуулаас дайжих аргаа хайж байсан том ноход цагаан утааг олж харав. Тал нутгийн том ноход агийн утааны ашиг тусыг мэддэг тул нүдэнд нь баясал тодроод гөлөгнүүдээ дагуулсаар гүйн ирцгээлээ. Том ноход утаан дунд ормогц бие дээр суусан шумуулнууд үргэн нисцгээв. Тэд утаа арай шингэвтэр хэсгийг сонгон олоод тааламжтай цагариглан хэвтэж, шууд дугжрах төлөвтэй болжээ. Гөлөгнүүд агийн ашиг тусыг төдийлөн мэдэхгүй боловч том нохдыг даган утаан дунд оронгуут тааламжтай сайхныг мэдрэн аятайхан газрыг булаалдаж эхлэв. Удаж төдөлгүй дөрвөн метрийн радиустай бяцхан чонын хүрээнд зургаан нохой цагариглан хэвтэхийг үзээд бэлтрэг ёстой мэл гайхан цэл хөхөрч орхилоо.

Тэр баярласандаа нүдээ аньж, уруулаа шазайлган, сүүлээ моодойтол өргөжээ. Урьд нь тоглох санаатай хоёр хөлөө гозолзуулан дуудахад тоох ч үгүй яваад өгдөг байсан ноход өнөөдөр урилга заллагагүй бүгдээрээ хүрээд ирнэ гэж тэр яахин санах билээ? Тэдний дунд өөрт нь тун тааламжгүй ханддаг Ирвэс хүртэл байгаа нь түүнийг ер бусын ихээр баярлуулж, зургаан

жирх хаяж өгснөөс илүү тааламжтай байгаа бололтой. Тэр хэсэг зуур утаанаас айхаа умартаад нэг болохоор Арслангийн нуруу руу авирч, тэгж байснаа охин гөлөгийг ноцож ноолно. Өнчин бэлтрэг эцсийн эцэст өнөр бүлийн баяр жаргалыг эдлэн, гэрийнхэнтэйгээ уулзсан бяцхан хоригдол мэт нохой болгоныг үнэрлэж, шиншлэн, үнсэж, долоох ажээ. . . . . Чэнь Жэнь бэлтрэгний ийм баяртай байхыг огт үзэж байгаагүй болохоор өөрийн эрхгүй нүд нь чийг даагаад явчихжээ. . . . .

Ноход олон зай багатайн дээр бас нэг чоно нэмэгдээд агийн утаа хүрэлцэхгүй янзтай болов. Бэлтрэг уг нь энэ газрын эзэн боловч хойноос ирээд хотыг эзэгнэсэн ноходод шахагдан утааны гадна хоцорлоо. Ноход байраа булаацалдахын дээр хоёр эр гөлөг зочломхой бэлтрэгийг утаанаас бүр ч хол шахан холдуулжээ. Бэлтрэг шумуулын хазахыг ч үл тоомсорлон нохдын үйлдэл чухам ямар учиртай болохыг бодолхийлэв. Удалгүй түүний нүдэнд оч гэрэлтэн, ноход өөрийг нь биш, утааг зорин ирсэн болохыг ойлгожээ. Түүний айгаад байсан цагаан манан болвоос шумуул үгүй жаргалын орон бөгөөд энэ хэсэг газрыг чухам түүнд түүнд зориулан бэлдсэн билээ. Угаас бусдад дээрэлхүүлэхийг хүлцдэггүй зантай бэлтрэг том алдсанаа ухаараад мах руу дайрч байгаа мэт араа шүдээ ярзайлган чонын хүрээ рүү гүйн ороод хоёр эр гөлгийг хөөж гаргав. Нэг эр гөлөг нь газар хэвтчихээд хөдлөх янзгүй байх тул бэлтрэг түүний чихэн дээрээс хазан хүрээнээсээ гаргалаа. Цаадахь нь өвдсөндөө гаслаж гангинав. Бэлтрэг утаа харьцангуй багатай аятайхан газрыг булаан эзлээд шумуулгүй байхын жаргалыг эдлэж эхэллээ. Сониуч агаад аливааг ажиглаж мэдэх дуртай бэлтрэг хөдлөлгүй хэвтчихээд утаа савсуулах ямбий түмпэнг анхааралтай ширтэнэ.

Хэсэг азнасны эцэст тэр ухасхийн босоод утаатай түмпэн рүү юу байдгийг үзэхээр зугуухан дөхөв. Гэвч хэд алхсангүй утаанд хахаж цацан буцаж ухрах боловч сониуч зандаа хөтлөгдөн бас л ойртон очно. Бэлтрэг толгойгоо утаа арай багатай газар наачихаад элэглэн мөлхсөөр утаатай түмпэн дээр дөхөж очлоо. Тэр түмпэнгийн хажууханд ирээд толгойгоо өргөн харах гэтэл нэг оч маналзан үсэрч түүний хоншоорыг түлэхэд гал хүрсэн тэсрэх бөмбөг дэлбэрэх мэт бондгосхийн үсрээд хуучин байрандаа эргэн очжээ. Бэлтрэг сэрвээний үсээ босгон, сүүлээ хавчсаар Арслангийн хажуугаар орон хэвтэв. Арслан ч юмны наад цаадхийг мэдэхгүй тэнэг амьтныг тохуутай харж байснаа хэлээрээ бэлтрэгний хоншоорыг долооход цаадахь нь томоотой хэвтээд түмпэнг ширтэх боловч дахин ганц ч алхам тийш зүглэсэнгүй. Удалгүй бэлтрэг нойрмог нялх хүүхэд мэт нүд нь анилдаж байснаа унтаад өглөө. Хэдэн өдөр шумууланд ээрэгдсэн бэлтрэг ингэж нэг тайван унтах боломж олддог ажээ. Гэвч тэр ийн унтах зуур хоёр чих нь соотгоносоор байх нь үүргээ гүйцэтгэж байгаа хэрэг юм.

Чөдөртэй цагаан морь цовхчсоор хүрч ирэхэд Чэнь Жэнь түүнийг чонын хүрээний салхин дор хөтлөж аваачаад зогсооход түүний бие дээр шаваастай шар шумуулнууд дэрхийн дээш нисэцгээв. Цагаан морь санаа нь амрав бололтой нүдээ анин зүүрмэглэж эхлэв.

Агийн утаа цасан дунд байгаа хүнд нүүрс аваачиж өгөх мэт нэжгээд чоно, морь болон зургаан нохойг шумуулын гамшгаас аварлаа. Амь шигээ хайртай дотнын зургаан нөхөртөө цагийг нь олсон туслалцаа үзүүлж чадсандаа Чэнь Жэньгийн сэтгэл их л тэнүүн байв. Бэлтрэг болон гурван гөлөг нялх амьтад болохоор хэрхэн талархахаа ч мэдэхгүй дугжирч өгөв. Харин гурван том нохой, цагаан морь байн байн Чэнь Жэнь рүү тааламжтай харц чулуудан сүүлээ зөөлөн хөдөлгөнө. Тэд хэдийгээр нялуун зусар үгс хэлж чадахгүй боловч тал

шигээ адил үнэнч болохоор Чэнь Жэнь энэ амьтдын төлөө илүү их зүйл хийхсэн гэж хүснэ. Ухаалаг бэлтрэг нэг л том болчих юм бол нохдоос илүү түүнтэй хэрхэн харьцахаа мэдэх байх даа хэмээн Чэнь Жэнь бодлоо. Гамшиг зовлонгийн үеэр тэр эдгээр амьтдад илүү чухал юм гэдгээ ойлгожээ. Тэр галтай түмпэнд хэсэг аргал, агь өвс нэмчихээд нойтон аргал эргүүлэн хатаав.

Шумуулын гамшиг эхэлсэн энэ үед судгийн агь өвсийг хадаад барахгүй, харин хатаасан аргал дуусчихаж мэдэх юм. Тийм болохоор багийн бүх хүүхнүүд хүүхдээ дагуулан эрвийх дэрвийхээрээ аргал хатаана.

Олонбулгийн талд аргал хоргол гол түлш болдог юм. Өвлийн улиралд аргалыг голчлон гал асаахад хэрэглэхээс биш, гол түлш нь хонь ямааны хоргол байдаг. Өглөө хонио бэлчээсний дараа хотон дахь хорголыг түүж цуглуулаад нар салхинд хэд хонуулан хатаагаад түлэхэд аргалаас илүү илчтэй. Харин зуны цагт хоргол нялцгайдуу байх тул зөвхөн хатсан аргал түлнэ. Гэхдээ зуны улиралд үхэр шимтэй өвс идэж, ус их уух тул үхрийн баасыг заавал наранд эргүүлж тойруулан хатаах шаардлагатай.

Зуны цагт үхрийн нойтон аргал эргүүлэн хатаана гэдэг тун төвөгтэй, амаргүй ажил юм. Айл болгоны хүүхэд, хүүхнүүд зав л гарвал хавь ойрынхоо чийгтэй нойтон үхрийн баасыг нэгд нэгэнгүй савраараа эргүүлэн наранд хатаана. Дараа нь урьд өмнө эргүүлсэн аргалуудаа гурав гурваар нь түшүүлэн тавьдаг. Тэгээд бүр сайн хатсан аргалыг арагтаа дүүргэн үүрээд гэрийн гадаа авчирч асгаад үзэхэд голдоо амь чийгтэй байх нь элбэг. Авчирсан аргалаа цэгцтэй хурааж борооноос хамгаалах хэрэгтэй. Зуны цагт бороо хур элбэг болохоор олон хоног сэтгэл гаргаж хатаасан аргал ширүүн бороонд шалба цохиулах гэмтэй. Тийм болохоор бороо дусагнаж эхлэнгүүт хуучин муусайн эсгийгээр хучаад борооны дараа дахин хатаана.

Тал нутагт айлын эзэгтэйн хэр зэрэг ажилтай эсэхийг үүдэнд хураасан аргалын том багаар мэдэж болдог. Илгээлтийн эзэд дөнгөж тусдаа гараад байхдаа бороонд аргалаа норгочихоод гал алдах буюу гашуун утаанд нүдээ хорсгох нь их байсан тул айл хунараас хуурай аргал зээлэн борооны улирлыг өнгөрөөж билээ. Хоёр жилийн дараа гэхэд Ян Кө, Гао Зянь Жун тэр гурав аргал хатаах, хураахын чухлыг оройдоо ортол ойлгосон тул тэдний хураалттай аргал малчдынхаас дутахааргүй болжээ.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр угаас гэр орны аахар шаахар ажилд яс махнаас дургүйн дээр, ном унших цагийг нь ихээхэн хумслах тул дотроо тун ч дурамжхан. Гэвч бэлтрэг тэжээж эхлэсэн цагаас хойш тийм аар саархан гэр орны ажил чоныг амжилттай өсгөх гол гогцоо болон хувирсан юм. Өөрөөр хэлбэл гэр орны ажил дайнд ялах эсэхийг шийдвэрлэх арын албаны стратегийн үүрэг тул мань хоёр аргал түлээ, будаа, тос, давс, мах, цай бэлдэх гэсэн гэр орны ажлыг уралдан амжуулдаг болов.

Урьд жилийн туршлагаас үзэхэд тэдний гэрийн гадаа хураалттай аргалыг зуны турш түлэхэд хүрэлцээтэй боловч шумуулын гамшгийн үеэр хоёр дахин их түлэхээр маш амархан хорогдох төлөвтэй. Тийм болохоор Чэнь Жэнь чонын эрч хүчийг үзүүлж хураалттай аргалаа хэд дахин нэмэгдүүлэхээр шийджээ.

Талын нар улам хүчтэй шарж эхлэхэд химийн ангийн цэрэг шиг өмсгөлдөө түүртсэн Чэнь

Жэнь амьсгал ч авахад хэцүү болж ирэв. Тэр хоёр гурван араг аргал түүж ирээд толгой эргэн алхаж гишгэхэд хэцүү санагдана. Хөлс нь урсаж хатсаар цамцны ар нуруу цоохортон дарайжээ. Гэвч тэр утаан дор тааламжтай унтаж байгаа хэдэн амьтдыг хараад шүд зуун ажилласаар байлаа.

Түүнээс гадна Чэнь Жэньгийн мөрөн дээр үүрсэн чийгтэй аргалаас ч илүү хүнд нэг дарамт бий. Тэр зөвхөн бэлтрэг нохдын төлөө төдийгүй мөн хонин сүргээ бодсондоо ийнхүү зүтгэхээс өөр аргагүй юм. Энэ хоёр мянга гаруй хонин сүрэг болвоос Ян Кө тэр хоёрын хөдөлмөрийн үр шим билээ. Тэд хоёр ч хавар хоёр мянга гаруй төл хүлээн авч хоёр суурь болгон тасадсан юм. Тэр хоёр цасан шуургыг сөрж, шумууланд хазуулан, наранд шаруулж, өдөр шөнөгүй чонотой тэмцэлдэх зэргээр өдөр шөнийн хорин дөрвөн цаг тасралтгүй ажиллан хоёр оныг ардаа үдсэн билээ. Хонин сүрэг бол нийгмийн өмч тул өчүүхэн төдий ч алдаа эндэл гаргаж болохгүй. Харсаар байтал айхтар том хоёр гамшиг нүүрлээд байгаа энэ цаг үед өчүүхэн л цалгардвал улс төрийн хэрэгт ч орж мэднэ. Ийм том хонин сүргийг шумуулаас хамгаалахын тулд шөнөдөө наанадаж тав зургаан удаа утаа уугиулах хэрэгтэй. Хэрвээ агийн утаа хонин сүргийг нэлэнхүйд нь бүрхэж чадахгүй бол тэд шумууланд хазуулан үргэж гүйгээд ганц хүнд дийлдэхээргүй юм болно. Хонио алдаад ууланд бүгсэн чоно руу оруулчихвал “Нохойн хөвгүүн”<sup>39</sup> чоно тэжээсэн гэдэг нэрмэхээс зугатах аргагүй юм. Чэнь Жэнь чонын зориг, ухаан, тэвчээр, хатуужил, хэрсүү зан болон аюулыг сөрөх үзэл санаагаар асар их эрсдэл дарамтын дор чоно тэжээн судлах ажлаа үргэлжлүүлсээр байгаагийн хэрээр талын чоно мэт хатуу чанга зан чанартай болохыг тэр зорьжээ.

Тэр алжааж залхах сэтгэл зүйн хориг саадыг даван туулчихаар хавьгүй хөнгөрөөд явчихдаг. Чэнь Жэнь нэг хэсэг үхрийн баас хатааж байснаа түүнийгээ орхиод аргал үүрэх зэргээр ажлаа солих тусам зорилготой хөдөлмөрийн баяр баясгаланг мэдэрч байлаа. Түүний зэрэгцээ тэр анх бэлтрэг тэжээхээр улайрах болсон нь зөвхөн чоныг судлах зорилготой төдийгүй улмаар эцэг эх, ах дүүс нь мэт бэлтрэгийг үнэн сэтгэлээс хайрладаг болсноо ойлгож эхэлжээ. Бэлтрэг нь түүний хувьд дусал сүү, халбага зутан, үмх мах зэргээр тэжээж өсгөсөн зэрлэг зан, араатан шинжтэй агаад гаршиж өгдөггүй хар элгийн хөвгүүнээс өөрцгүй юм. Зүрхний угаас үүдэлтэй хүн адгуус хоёрын тайлагдашгүй гүн нууцлаг, балар эртний сэтгэлийн холбоо нь Чэнь Жэньг бараг солиоруулах шахаж, хүмүүсийн гадуурхал болон хэл амны бай болгоод байгаа. Гэсэн хэдий ч энэ хагас жилийн хугацаанд түүний цусаар эрч хүч дүүрэн араатанлаг цус урсаж, тэр хэрээр амьдрал нь ч утга учиртай санагдах болжээ. Бэлтрэг тэжээснээс хойш Чэнь Жэнь дөрвөн мөчөө хөдөлгөдөггүй, таван амуугаа ялгадаггүй “Харгис хөрөнгөтний” хөвгүүн байснаа, маш хөдөлмөрч нэгэн болон хувирсан нь муугүй хэрэг шүү хэмээн Гао Зянь Жун өөр нэгэн илгээлтийн эзэнд ярьсан байж билээ.

Чэнь Жэнь ёстой л чонын эрчээр араг дүүрэн аргалыг гэр рүүгээ зөөхийн хэрээр хураалттай аргал борооны дараах хар мөөг мэт дорхноо томроод ирлээ. Хөрш айлын авгай түүний чухам ямар учиртай ийнхүү үхэн хатан ажиллаад байгааг гайхан хөдлөхгүй ажин зогсоно. Зарим илгээлтийн эзэд түүнийг “Чонотой нөхөрлөвөл чоно болно” гэдэг л энэ байх даа хэмээн явуулдаг болж билээ.

\* \* \*

Харуй бүрийн үеэр хонин сүрэг уулнаас хотондоо эргэн ирлээ. Ян Көгийн унасан морь үргэж

бусгаад хоолой нь сөөж, уургаа ч даах тэнхэлгүй болтлоо ядарсан харагдана. Уулнаас хэдэн зуун сая шумуул тээж ирсэн хонин сүрэг хээрийн түймэрт хуйхлагдаад шар утаа суунаглаж байх шиг харагдана. Хоёр мянган хонины дөрвөн мянган чих шумуул үргээж, хот тэр аяараа хонь ямааны дуунд дарагдав. Агаарт тогтчихоод оройн хоолоо ирэхийг хүлээж байсан шумуулан сүрэг бөөн бөмбөгдөгч онгоц мэт доош шуугин орцгоов. Ноосоо хяргуулан нүцгэрсэн хоньд өдөржин шумууланд хазуулсаар бахын арьс мэт бижрүүтсэн нь харахад нүд халтирам. Гэтэл шинэ сүрэг шумуулын дайралт тэднийг бараг л галзууруулах шахах нь аргагүй. Толгойд явсан хэдэн хоньд Ян Көгийн шилбүүрдэхийг ч тоосон шинжгүй баруун хойд зүг салхи сөрөн зүтгэцгээв. Чэнь Жэнь ч газраас нэг мод шүүрч аваад түрүүчийн хоньдыг цохиж нүдсээр арайхийж нэг юм хотонд оруулж чаджээ. Гэвч хоньдын толгой салхи сөрөөд хэзээ мөдгүй хошууран давхихад бэлхэн харагдана.

Чэнь Жэнь яах ийхийн зуургүй зургаан түмпэн аргал уугиулж, хоттой хонины дээхэн талд тавьлаа. Зургаан өтгөн утаа зургаан цагаан луу мэт шумуулын сүрэг рүү дайран оров. Агшин зуурын төдийд хортой шумуулын сүрэг илүү хортой тэнгэрийн луутай халз тулгарсан мэт дэрхийн дээшээ нисэцгээлээ. Аминд ордог агийн утаа нийт сүргийг бүрхэн авахад эцэтлээ ядарсан хонь хурганууд газар сөхрөн хэвтэцгээв. Бүтэн өдрийн тамлал арайхийж нэг юм эцэслэх нь энэ. Цагаан утаанд амгаланг олсон хонин сүрэг хивэх ч тэнхэл үгүй байх шиг харагдана.

Ян Кө мориноосоо пидхийтэл үсрэн буув. Тэр шумууланд бариулж гүйцсэн морио утаан дунд хөтлөн оруулаад шумуулнаас хамгаалах малгайгаа авч, зузаан даавуу цамцаа тайлаад “Ямар сайхан юм бэ? Өнөөдөр хариугүй бүтэж үхэх шахлаа. Маргааш чи хонио хариулж миний ямар зовлонг амссан болохыг үз дээ” хэмээн хашгирав.

“Би ч гэсэн гэртээ ер зүгээр суусангүй. Маргааш намайг хонинд явсан хойгуур чи бэлтрэгтээ утаа уугиулж, зургаан түмпэн аргал шатаагаад байж байгаарай” гэж Чэнь Жэнь хэллээ.

Ян Кө хариуд нь “Тэр бололгүй яахав” гэлээ.

“Чи бэлтрэгээ очиж үзэхгүй юм уу? Цаад золиг чинь юмны сайн мууг айхтар ялгах юм гээч. Одоо утаан дунд дугжирч байгаа” гэж Чэнь Жэнь хэлэв.

Ян Кө их л гайхширан “Чоно чинь гал утаанаас их айдаггүйсэн биш үү?” гэж асуулаа.

Чэнь Жэнь инээд алдаад “Гэхдээ чоно чинь шумуулаас бүр их айдаг юм байна. Ноход түүний байрыг эзлээд авчихаар утааны ямар ашиг тустай болохыг ойлгочихож байна лээ. Би түүнийг хараад бүр элгээ хөштөл инээснийг яана. Харин чи тэр гоё жүжгийг үзэж чадаагүй нь жаахан тусгүй” гэв.

Ян Кө чонын хүрээн дээр гүйн очвол бэлтрэг дөрвөн мөчөө дээш сарвайлгачихаад тарайн унтаж байдаг байгаа. Хоёр том найзынхаа алхааг сонсоод тэр зөвхөн нүдээ хяламхийн харснаа эргээд аньчихав.

Бүхэл шөнийн турш Чэнь Жэнь утаатай түмпэнгээ малласаар хоножээ. Тэр хагас цаг болоод л түмпэнд аргал болон агь өвс нэмэхгүй бол болохгүй. Мөн салхины чиглэл өөрчлөгдвөл түүнд

тааруулж түмпэнгээ зөөж тавих хэрэгтэй. Заримдаа хонь ямааны байрыг булаах гэсэн үхрүүдийг хөөх хэрэг гарна. Үхрийн арьс хэдийгээр шумуул дийлэхээргүй хатуу боловч хамар, зовхи, чих зэрэг зөөлөн арьстай хэсгийг шумуул юу гэж зүгээр байлгахав. Үүний улмаас Чэнь Жэнь үхэр сүргийн салхины дээр ч гэсэн утаатай түмпэн байрлуулжээ. Мал сүрэг чоно нохдоо утааны дор байлгах гэж тэр шөнө Чэнь Жэнь бараг цурамхийлгүй хонов. Харин гурван том нохой л өөрсдийн үүргээ умартсангүй, тэд утаан хөшигний аман дээр шахам тарж хэвтээд сонор соргог ажиглана.

Өлөн зөгийнүүд багшран дүнгэнэлдэх боловч утаан хөшиг дотор орж зүрхлэхгүй. Шөнийн хугасыг амрах чөлөөгүй шахам өнгөрөөсөн Чэнь Жэнь хүчирхэг дайсныхаа ялагдаж буйг хараад сэтгэл нь ялгуусан баяр хөөрөөр дүүрлээ. Тэр шөнөжин нийт багийн хот айлууд хэдэн зуун түмпэнд утаа баагиулж хонов. Сарны гэрэл дор хэдэн зуун өтгөн утаа савсан хөөрөх нь агаарт төдий тооны цагаан луунууд эргэлдэн бүжиж байх шиг. Эсвэл тал нутаг тэр чигтээ аж үйлдвэрийн эрин үе рүү шилжээд хэдэн зуун аварга үйлдвэрийн яндангаас цагаан утаа олгойдож байгаа мэт сүртэй сайхан харагдах ажээ. Энэ нь шумуулан сүргийг үргээгээд зогсохгүй, шумуулын гамшгаас болж өлсөхийн туйлд хүрсэн чонон сүргийг ч их айлгасан нь лавгай.

Чэнь Жэнь сарны гэрэл дор утаа савсуулах их талыг хараад номхон далайн сүрт тулалдааны дүр зургийг олж үзэх шиг болжээ. Хэдэн зуун янз бүрийн хөлөг онгоцнуудаас бүрдсэн дэлхийд хамгийн томд тооцогдох америкийн флот мянга түмэн их буугаа гозолзуулж утаа савсуулсаар япон тэнгист орж ирж байхтай тун төстэй. Тэр бол орчин үеийн өрнөдийн далайн чоно дорно дахины давжаа биетэй далайн чоныг намнах аян дайн байсан юм. Хүн төрөлхтний түүхэнд өнөөг хүртэл дэлхийн хөгжлийг манлайлагч нь ихэнхдээ чонын үзэл санаагаар зэвсэглэсэн үндэстнүүд байсан билээ. Дэлхийн хатуу ширүүн өрсөлдөөний тавцан дээр хонь нам гүмийг эрхэмлэх тусам чоно улам гаарсаар иржээ. Чоно ч гэсэн өөрөөс хүчтэй чононд идүүлэх аюул тулгардаг байхад дорой хонь, өвчтэй хонь юу болох нь ойлгомжтой. Хятад үндэстэн сүрэг чонын өрсөлдөөн дундахь дэлхий дахинд байр сууриа эзлэе хэмээвээс тариачин үндэстний зан чанарын дундахь хонин шинж, гэрийн тэжээвэр амьтны хэв шинжийг гээж, өөрийгөө хүчирхэг чоно болгон хувиргах хэрэгтэй. Ядаж л чонын үзэл санаа, чонон сүлдийг дээдлэх хүсэл эрмэлзэлтэй байлгүй горьгүй юм. . . . .

Уудам тал өтгөн утааг номхотгох чадалтай ажгуу. Нийт багийн айлуудын асаасан галын утаа хотгорын голд очоод үүлэн далай болон тогтжээ. Үүлэн далай шумуулан сүрэг дураар дургиж байсан гол нуурын энг бүрхээд эргэн тойрны уулс болон төгрөг сарыг алган дээрээ тосон авахад тал нутаг аж үйлдвэрийн эрин үеэс байгалийн унаган төрхөндөө эргэн шилжлээ.

Чэнь Жэнь өөрийн эрхгүй Ли Бай найрагчийн

“Үүлсэн далайн уудам цээлийг нэвтрэн

Үүлгэр саран Тэнгэр уулнаа мандлаа.

Хараа цуцаам түмэн бээрийн салхин

Хас үүдэт боомтыг даван одлоо” хэмээх шүлгийг амандаа уншив. Чэнь Жэнь багаасаа л Ли

Байгийн шүлэгт ухаангүй дуртай нэгэн билээ. Си Юй буюу баруун хязгаарт төрж, тухайн газрынхаа түрэг үндэстний зан суртхаалын нөлөөнд ихэд автсан уянгын дуулалч маань эрх чөлөөт, омог бардам чонон цусныхаа оргилохыг хичнээн удаа мэдэрч байсан бол доо? Буурал талын сартай шөнө Ли Байгийн шүлгийг унших, Бээжингийн хичээлийн танхимд цээжээр уншихаас тэс өөр байдаг юм. Чэнь Жэньгийн сэтгэлд гэнэт Ли Бай маягийн омгорхол төрөхөд түүнийг удтал шаналгасаар байгаа нэгэн бодол түүнийг эзэмдэв. Хятадын найрагчид бүгдээрээ л Ли Байг бишрэн шүтдэг хэрнээ түүний билиг танхай, омог бардам зангаас суралцсан нь харин нэгээхэн бээр ч үгүй. Ли Байгийн яруу найргийн омог бардам өнгө аясанд чонон сүлдийг дээдлэдэг түрэг үндэстний зан суртхаалын нөлөө туссан төдийгүй хувь хүнийхээ хувьд сүрэг чонын шандсыг шалгадаг тал нутаг шиг уужим сэтгэлтэй байсныг хэрийн хүн яаж ч сурч чадах билээ дээ? Ли Байгийн шүлэг дууллын үүлэн цацаг шүргэсэн омог бардам өнгө төрх нь хятадын яруу найргийн сүмбэр оргилд түүнийг аваачиж чадсан байж таарна. Күнзийн сурталт ямар хятад найрагчийн ганц өгүүлбэр түмэн бээрийг туулж, нэг үсэг нь есөн тэнгэрийн чанадад зорчиж чадах билээ дээ? Түүний шүлэгт:

“Салхитай уралдах галбинга шувуу хоногийн зуур

Сааргүй хурдлан түмний газрыг туулж чадна” гэх буюу

“Тэнгэрээс буух шар мөрний усан

Тэнгист хүрээд эргэж ирэхийг үзсэн үү?” гэсэн байдаг бус уу?

Ямар л хятад найрагч өөрийн билиг танхай шүлгээрээ Күнз богдыг шоглож, их Тан улсын хаан эзний өмнө Ян Гүй Фэй нэрт гоо хатнаар нь бэх зууруулж, Гао Ли Ши нэрт түшмэлээр гутлаа тайлуулж байх билээ дээ? Ай яа яа, мөн айхтар бөх зүрх шүү. Ли Бай шиг болох гэж оролдсоноос тэнгэрт авирья хэмээн санасан нь аминд өлзийтэй байж мэднэ. Тийм болохоор эрхэм найрагч дөрвөн түм найман мянган жилийн турш найргийн хааны алтан сэнтийдээ заларсаар байх буй за.

Талын чонын араншин, хятад соёлын охьтой нийлэхээр хүнийг тийм гайхам өндөр оргилд хүргэж чаддагийг Чэнь Жэнь сүслэн бодож зогсчээ.

\* \* \*

Шөнө дундаас хойш зарим айлуудын түмпэнгээс утаа савсахаа больж, улмаар охид хүүхнүүд болон илгээлтийн эзэд үймэрсэн хонь малаа хашгичиж гуугачин тогтоохыг Чэнь Жэнь бүрэг бараг олж харав. Тэд бодвол агь өвсөө дууссан буюу аргал түлээгээ гамнасан хэрэг байж таарна.

Шумуулан сүрэг үймэлдэн дүнгэнэлдэх чимээ чангараад ирэв. Багийн зарим хотонд хүн хашгирч, нохой хуцан үймэлдэв. Тэр хэрээр гар чийдэнгийн гэрлүүд ч гялсхийн асаж хамгийн арын хотонд нохой боргон хуцаж, хүмүүс шуугилдаад явчихав. Бодвол тэдний хоньд салхи сөрөн явснаас гарцаагүй. Харин аргал түлш, агь өвсөө хангалттай бэлдсэн айлуудын хот нам гүм хэвээрээ байлаа. Чэнь Жэнь холгүй байх Билиг өвгөний хот руу харвал үймж шуугисан зүйлгүй нам гүм байх ажээ. Хэдэн ч газар галын дөл улалзах нь бодвол Галсмаа



утаа уугиулж байгаа хэрэг биз. Тэр “Талын цэгийг бөхлөж, хөдөлгөөнт утаагаар утах” гэсэн аргыг хэрэглэж байгаа бололтой. Тэр хонин сүргийн гурван талд аргал овоолж тавиад салхи хаанаас үлээнэ тэр зүгт гал асааж байлаа. Овоолсон аргал шатаах нь ямбий түмпэнд асааснаас хавьгүй илүү нөлөөтэй боловч түлшинд жаахан гарлагатай байдаг юм. Гэвч Галсмаа шиг ажилч хүнд хонин сүргийн тав тухыг хангаж байвал тэр зэргийн асуудал ч юухан байх билээ.

Гэнэт хойд талын хотноос хоёр удаа буун дуу тасхийн дуугарав. Чонон сүрэг шумуулын халдлагыг тэвчиж байгаад нэгэн боломж олж харж дээ хэмээн Чэнь Жэньгийн сэтгэл сэрхийлээ. Чухам ямар айлд энэ том гай буугаа бол гэж бодоод Чэнь Жэнь уртаар санаа алдав. Тэр чононд сүсэгтэй болохын ач тусыг бодоод сэмхэн өөртөө баярлаж байлаа. Талын чоныг хичнээн гүн ойлгох тусам тэр хэрээр алдаж осолдохгүй байх боломжтой юм.

Удалгүй тал нутаг нам гүм боллоо. Үүр цүүрээр шүүдрийн усанд далавчаа норгосон шумуулнууд нисэх тэнхэлгүй болжээ. Утаа унтрахад ноход анхаарлаа сулруулсангүй хонин сүргийн баруун хойд талаар эргэж тойрон гүйлдэнэ. Хүүхнүүдийн үнээ саах цагаар чонон сүрэг хот эргэхээ болино гэж Чэнь Жэнь тооцоолж байв. Тийм болохоор сармай дээлээ толгой дээгүүрээ нөмрөөд унтаад өгчээ. Энэ бол өдөр шөнийн хамгийн урт унтдаг хугацаа буюу дөрвөн цаг орчим үргэлжилдэг билээ.

\* \* \*

Удаах өдөр Чэнь Жэнь уулын бэлд хүнд эрүү шүүлт амсчихаад хонио туусаар буцаж ирэхэд гэрт нь эрхэм зочин ирсэн бололтой гэр дээр хоёр хонины арьс хатаачихсан байх ажээ. Бэлтрэг бусад нохдын хамт хонины ястай мах идсэн шиг байж байв. Гэрт орвол аяганы эрэгнэг болон хана дагуулан годгор махнууд өлгөөд тогоо дүүрэн чанасан мах даргилан буцална.

“Урд шөнө хамгийн арын Эрдэнийн хонинд чоно оржээ. Тэднийх Доржийнхтой адил олон жилийн өмнө цагаачлан ирсэн зүүн хойд орны монгол үндэстэн юм гэсэн. Тэднийх хуучин нутгаасаа нэгэн шинэ бэр буулгасан нь үд болтол унтаж үхрийн дуугаар сэрдгээрээ зартай хүүхэн ажээ. Тэр хүүхэн шөнө хэдэн хэсэг аргал овоолж асаасан болоод унтаад өгсөн байна. Гэтэл гал унтарсаны дараа хонь нь салхи сөрж яваад зуун ная гаруй хонь чонон сүрэгт бариулж үхжээ. Шархадсан хонь харин гайгүй юм байх. Азаар ноход хаалга самардан, хуцаад гэрт байсан эздийг сэрээсэн байна. Эрчүүд нь морио унан буугаа агсаж мордоод хонио чононоос салгаж авч чаджээ. Хэрвээ жаахан оройтсон бол үнэр авсан өөр сүрэг чоно ирээд бүр ч сүйд болох байж шүү” хэмээн Ян Кө сонин ярив.

Гао Зянь Жун ч ярианд оролцож “Өнөөдөр Бао Шүнь Гүй Билиг гуай хоёр бүх хүмүүсийг дайчилж үхсэн хонь өвчүүлж янзлууллаа. Зуун ная гаруй үхсэн хонины махны талыг аж ахуйн төв рүү оруулан хямд үнээр борлуулаад үлдсэнийг нь багийн айлуудад үнэгүй тарааж өгсөн. Харин арьсыг нь авах юм гэсэн шүү. Манайх энэ хар халуунд тэр их махыг хаанаа агуулах билээ гээд үхсэн шархадсан нэжгээд хонь авч янзаллаа” гэлээ.

Чэнь Жэнь ч хөл нь газар хүрэхгүй баярлаж “Чоно тэжээж байгаа айл чинь махны ихээс айдаг бил үү?” гэснээ “Бао Шүнь Гүй тэр айлыг тэгээд яаж шийтгэхээр болсон бэ?” хэмээн

асуув.

“Төлж л таарна шүү дээ. Тэр айлын хүмүүсийг төлж дуустал сарын цалингийн хагасыг суутгаж байх болсон гэнэ. Галсмаа болон нутгийн авгай хүүхнүүд бүгдээрээ л цаад нөхөршүү юмыг хадам ээжтэй нь буруутгаж байна лээ. Энэ айхтар шумуул дунд шинэ бэрээрээ хонь мануулж байдаг дүүрсэн дотортой улс юм гэцгээж байдаг шүү. Биднийг анх ирэхэд Галсмаа хоёр сар салахгүй хамт манаанд гарч байсан даг. Бао Шүнь Гүй ч тэднийхнийг нутаг нугын нэр баастлаа гээд зад загнаж байна лээ. Цаадахь чинь нутгийнхаа барилгачдыг ч харж үзэхээ яахин мартаж вэ? Жараад хонийг тэдэнд үнэгүй өгсөнд цаадуул нь баярлаж байна гэж жигтэйхэн” гэж Гао Зянь Жун хэллээ.

“Тэр хэд ч тэгвэл чонын буяныг эдлэж гүйцжээ” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

Гао Зянь Жун нэг шил талын хар архи гаргаад “Ийм сайхан хоол зүгээр олдож байхад чинь тэмдэглэлгүй яахав. Алив гурвуулаа хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй архи уудаг хэрэг ээ” гэлээ.

Ян Кө ч архи хараад инээд алдан “Өнөөдөр сайхан ууна аа. Хүмүүс биднийг чоно тэжээгээд сайнаа үзэхгүй л гээд байсан. Гэтэл өөрсдөө сайнаа үзэж байгаа нь хаана байгаа юм бэ? Чоно хүмүүст аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ гэдгийг зааж сургадаг болохыг тэд яахин мэдэх билээ дээ?” гэхэд

Гурвуулаа хөгжилдөн инээцгээлээ.

Утаан дунд хөдлөж чадахаа больсон бэлтрэг идүүрээ сахин хэвтэх нь цадталаа идсэн хээрийн чоно барьсан ангаасаа холдож чаддаггүйтэй адил үлдсэн махыг цоо ширтэнэ. Энэ махыг өөрийнх нь төрөл төрөгсөд бэлэглэсэн болохыг тэр яахин мэдэх билээ?

*Бидний цусанд, ялангуяа хаад язгууртнуудын цусанд нүүдэлчний үзэл санаа шингээстэй байдаг юм. Тэр нь хойд үеийнхэнд өвлөгдөн очихдоо зан төлвийн тодорхой хэсгийг бүрдүүлэх болно. Бид илүү уудам орон зай руу тэмүүлэх тэрхүү үзэл санааг зан төлвийн энэ шинэстэй холбон ойлгох хэрэгтэй. Тэр чанар нь улс орон болгоныг боломж л олдвол илүү уудам орон зай руу чиглүүлж, тэдний эрх ашгийг тэнгэрийн хаяа газрын гав хүртэл өргөсгөж байдаг юм.*

*Жорж Уэльс*

*“Дэлхийн түүхийн товчоон”*

Бат Жан Зи Юань хоёр дөрвөн морь сэлгэж, хоёр өдөр нэг шөнө явсаар адуун сүргээ шинэ нутгийн арын уулын оройд авчрав. Уулын оройд сэвэлзсэн салхитай тул адуун сүрэг салхи сөрөн явчихна гэж айлтгүй болжээ. Тэр хоёрын хонго мэдээ алдаад эмээлээс хөндийрөх янзгүй санагдахад хэд уртаар амьсгаа аваад мориноос бууж газар сууцгаалаа. Тэд энгэр заамаа яран сэрүүцэцгээв.

Хотгорын голд нуурын ус мэлтэлзэж, баруун хойноос салхи үлээхэд ангасан адуун сүрэг ус, салхи хоёрын алийг сонгохоо шийдэж ядан эргэлзэнэ. Адуун сүрэг уулын энгэрт хэдэнтээ эргэцсэний хойно түрүүнд явдаг хэдэн азарга уртаар унгалдан янцгаагаад усны зүг давхилаа. Сүрэг адуу арга тасран ус бараадахаар давхихад өвсөнд нуугдсан өлөн шумуулнууд хэдэн мянгаараа босож морьдын хөлстэй бие рүү хошуугаа шаахаар хошууран дайрав. Олон адуу шумууланд хазуулаад тэсэж ядахдаа булгиж бусган давхилдав. Бат Жан Зи Юань хоёр адуун сүрэг нуурын ус руу хошууран давхихыг үзээд энгэрийн товчоо ч товчлолгүй унтаад өглөө. Олон шумуул тэр хоёрын хүзүүн дээр суухад шөвөг шиг хошуутай байлаа ч сэрэх янзгүй бөх унтжээ. Шумуулын гамшиг эхэлснээс хойш мань хоёр долоо хоногийн турш дээд тал нь гуравхан цаг л унтаж байсан юм. Шумуулнаас дайжсан адуун сүрэг зэрлэг адуу, галзуу морьдоос өөрцгүй болон хувирч, ташуур, уурга, хашгичаан, гуугачаан байтугай чононоос ч айж эмээхээ байжээ. Салхигүй үед адуун сүрэг бөөгнөрөн жаахан тогтмор аядсанаа салхилаад эхлэнгүүт түүнийг сөрөн давхилдана. Хэдэн өдрийн салхи сөрөн давхисан адуун сүрэг нь хариугүй хил даваад явчих шахсан бөгөөд хэрвээ салхины чиг жаахан өөрчлөгдөөгүй бол мань хоёр хилийн застав дээр хоёр талын уулзалтын үр дүнг хүлээгээд сууж байсан байж мэдэх юм. Нэг шөнө тэр хоёр арайхийж адуугаа өөрсдийн харьяаны бэлчээрт аваачтал шумууланд хазуулсан адуун сүрэг азарга азаргаараа ялгаран хэдэн тийш салаад явчихжээ. Тэгээд бас л хонон өнжин хөөцөлдсөөр арван хэдэн азрага адуугаа хураагаад тоолж үзтэл хорь гаруй морьд сох дутсан байлаа. Бат Жан Зи Юанийг ганцаараа адуун сүргээ харж бай гэчихээд өөрөө нэг хурдан морь сольж унаад дөч гаруй километрийн зайтай нэгэн элсэн довцогийн өвөрт сүрэг адуугаа олтол хамаг унаганууд нь чононд бариулсан байж билээ. Шумууланд хазуулан галзуурах дөхсөн чонон сүрэг алдсан цусаа сэлбэхийн тулд унаганы туурай, дэлийг хүртэл үлдээлгүй идсэн байлаа.

Адуун сүрэг шар түйрэн мэт шумуулан сүргийг дагуулсаар нугаст нууранд хүрэлцэн ирлээ. Шумууланд хамаг цусаа хануулж, хөлс ч ялгарахаа байтал цангасан адуу ус руу цүл палхийн явж орчихов. Тэд шууд ус уусангүй харин биеийг тамлах шумуулнаас салахын түйс болж усны

гүнийг чиглэнэ. Ус шилбэ, гуя, гэдсээр нь татахад хошуугаа сугалж амжаагүй өлөн шумуулнууд живж үхэцгээлээ. Адуун сүрэг цааш амь тэмцэн зүтгэлэхэд туурайнд булингартсан ус морьдын нуруугаар давав. Нуурын тунгалаг ус шумуул алж загатнаа намдаах тул адуун сүрэг уртаар янцгаалдаж, биеэ сэгсрэхэд усны мандлаар будааны хивэг шиг үхсэн шумуулууд хөвнө.

Адуун сүрэг сая нэг санаа амарсан байдалтай гэдсээ цэрийтэл ус гүзээлж авлаа. Дараа нь гэдсээр татсан усанд зогсоод хамраа тачигнуулан үүрсэх ч үгүй чимээ аниргүй зүүрмэглэцгээв. Нуурын мандал дээр толгойгоо унжуулан зүүрмэглэх адуун сүргийг холоос харахад шумуул, чонын хавсарсан дайралтад амиа алдсан анд нөхдөө үгүйлэн гашуудаж байгаа мэт ажээ. Уулын орой дахь адуучид болон нуурын мандал дахь адуун сүрэг зэрэг унтаад өгөх нь энэ.

Хичнээн ч цаг өнгөрсөнийг бүү мэд тэд бараг зэрэг шахам өлсөөд сэрцгээлээ. Хүн морьдгүй хэдэн ч өдөр шөнө юм идээгүй байсан ажээ. Бат Жан Зи Юань хоёр ойролцоо байх нэгэн монгол гэрт очоод хүйтэн цай, хоормогтой залгилан чанасан мах идэж авчихаад бас л унтаад өгөв. Адуун сүрэг эрэг дээр гарч өвс идэхэд шумуул тэдэн рүү дахин дайрлаа. Нуурын эрэг орчмын өвсийг үхэр хоньд идээд өнгөрсөн тул адуун сүрэг чонон сүрэгтэй үргэлжлүүлэн тулалдах хүчээ нөөхийн тулд шумуулын дайралтыг үл ажран өтгөн өвс бараадан идээшилж эхлэв.

\* \* \*

Багийн захиргаа Билиг өвгөнийд хуралдлаа. “Тэнгэрийн царай бороо орох шинж алга. Шөнө айхтар бөгчим хонож байгаа тул адуун сүрэг шумууланд бариулж гүйцэх нь. Багийн хэмжээнд хүн хүч дутмаг, саяхан хонин сүрэгт осол учирсан тул адуучдыг амраах арга одоохондоо алга” гэж яригдав. Тэгээд Бао Шүнь Гүй Билиг өвгөн хоёр аж ахуйн захиргааны ажилчдыг нааш авчран хонь хариулуулж, суларсан хоньчдоор туслах адуучин, илгээлтийн эздийн халааг авахуулж хэд хоног амраан, шумуулын гамшгийн ид үеийг даван туулах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргажээ.

Ядарч туйлдаж гүйцсэн Жан Зи Юань үхэр шиг мугуйдлан амрахгүй гэж зүтгэсээр байв. Энэ айхтар шумуулын гамшгийн ард гарчих юм бол тэр монгол талын жинхэнэ адуучин болж чадна гэдгийг ойлгосон ажээ. Чоно тэжээдэг илгээлтийн эздийн монгол гэрээс яагаад ганц шилдэг адуучин гарч болдоггүй билээ хэмээн Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч түүнийг урамшуулжээ.

Үдээс хойш улам бүгчим болоод ширүүн бороо байтугай, шиврээ бороо хаялах ч найдлага алга. Тал нутагт бороо хэрэгтэй ч бас уршигтай байдаг. Ширүүн борооны үеэр шумуул хэдийгээр намждаг ч борооны дараа улам үржин олшрох гэмтэй. Чонын цусаар хооллосон шумуулын үр төл улам ч чоно мэт улангасан гаардаг юм. Олонбулгийн тал тэр чигээрээ амьдын там болон хувирахад Жан Зи Юань түүн рүү орохоор зориг шулуудан, бусад адуучидтай хамт адууны бэлчээр рүү явжээ.

Билиг өвгөн Бат Жан Зи Юань хоёрыг дагуулан багийн төвөөс хоёр өртөө шахам зайтай элсэрхэг талд аваачлаа. Тэнд өвс ус багатай тул шумуул ч харьцангуй бага ажээ. Багийн бусад

гурван суурь адуу ч гэсэн өвгөний зааж өгсөн улсын хилээс тавь гаруй километр зайтай энэ элсэрхэг газар хүрэлцэн иржээ.

Өвгөн Жан Зи Юаньд хандан “Баруун өмнө зүгийн элсэрхэг тал уг нь Олонбулгийн хамгийн сайн бэлчээр нутгийн нэг байсан юм. Товхийсэн жижиг гол, цөөрөмтэй болохоор өвс ч сахлаг шимтэй байж билээ. Хонь мал гэдсээ цүрийтэл идэхгүй мөртлөө тарга тэвээрэг сайн авчихна” хэмээн хэлээд тэнгэр өөд харж уртаар санаа алдаад “Хэдхэн жилийн хугацаанд ийм янзтай болчихоод жижиг голын сайр хүртэл элсэнд даруулчихсан байх юм гэж хэн санах билээ?” гэв.

“Тэгээд яахаараа ийм янзтай болчихдог хэрэг вэ?” хэмээн Жан Зи Юань асуулаа.

Өвгөн адуун сүргийг заагаад “Адуун сүрэг, дотор газрын хүмүүс хоёр л ийм болгосон хэрэг. . . Тэр үед улс дөнгөж байгуулагдаад байсан тул, машин техник гэх сүртэй юм үгүй, армид адуу хэрэгтэй, дотор газрын тариалан тээвэрт морь хэрэгтэй болохоор өвөрмонголын талд адуу үржүүлэх хэрэгтэй болж таарна аа даа. Олон сайн морь үржүүлэх дээд газрын тушаал шийдвэрээр Олонбулгийн хамгийн сайн нутгийг адууны бэлчээр болгосон нь энэ. Дотор газрын хүмүүс морь шилж сонгон худалдаж авах гэж наашаа л ирдэг байсан. Тэгээд хүн морьд ирж очсоор энэ газар морин тойруулга шиг талхлагдаж гүйцэхгүй хаачихав. Урьд нь хэдэн зуун жилийн турш ямар ч ван ноёд энэ сайхан бэлчээрт адуу үржүүлж зүрхлээгүй ирсэн юм шүү. Хэдэн жилийн дараа морьд өсөж олширсон боловч энэ нутаг бэлчээр улаан элс болон үлдсэн юм даа. Харин энэ элсэрхэг талын ганц ашиг тус нь шумуул ихтэй үед адуун сүргийг авчрахад тохиромжтойд байгаа юм. Тэр уг нь энэ газрыг хэдэн жилийн дараа унаган төрхөндөө орохыг харах гэсэн боловч өнөө жил шумуул ихтэй, адуу амь тэмцээд байгаа болохоор Өлзийтэй зөвшилцөн наашаа авчирсан юм” гэж ярьлаа.

“Аав аа, одоо чинь машин, трактор олшроод, дайтахад хүртэл танк хэрэглэн морьт цэрэг бараг хэрэггүй болж байгаа юм чинь үүнээс хойш тийм олон адуугаар яах ч билээ. Тийм болохоор тал нутаг зөнгөөрөө сэргээд ирэх биш үү?” хэмээн Жан Зи Юань асуулаа.

Өвгөн толгой сэгсрээд “Гэвч хүн трактор олшроод ирвэл бүр ч тусгүй юм болж мэднэ. Дайны бэлтгэл улам эрчимжиж, тал нутагт барилгын цэргийн нэгтгэл байрлуулах шийдвэр гарсан. Тийм болохоор удахгүй Олонбулгийн талд баахан хүн трактор орж ирэх болно” гэлээ.

Жан Зи Юань хэсэг зуур балмагдаад үг дуугарч чадсангүй. Түүний цээж дүүрэн омогшил хавьгүй шалчийгаад явчихжээ. Сураг төдийхөн байсан барилгын цэргийн нэгтгэл ийм хурдан хүрээд ирнэ гэж хэн санах билээ дээ?

“Тал нутагт урьд өмнө тариачид, хүрз жоотуу, түймэр гэж айхтар аюул байдаг байсан бол одоо трактор гэж том гай гарч ирлээ. Хэд хоногийн өмнө Өлзий Олонбулгийн талын хэдэн ахмад малчдын гарын үсэгтэй бичгийг Өөртөө засах орны төв рүү илгээж нутаг бэлчээрээ хагалуулахгүй байх талаар хүсэлт тавьсан л даа. Түүний хариу юу гэж ирэхийг хэн мэдэх билээ? Бао Шүнь Гүй ойрдоо их л баяртай яваад байгаа юм. Энэ уудам нутгийг хагалахгүй байлгаад байх нь эдийн засгийн хувьд ашиггүй. Тийм болохоор эрт орой хэзээ нэгэн цагт хагалж л таарна гээд байх болсон байна лээ” гэж өвгөн хэлэв.

Тракторын эрин эхлэхээр нүүдэлчин, тариачин хоёр үндэстний гүн зөрчил дуусгавар болж таарах нь ээ хэмээн Жан Зи Юань дотроо халаглан бодов. Зүүн өмнө зүгийг хамарсан тариалах хөдөлгөөн баруун умард зүгт хүрээгээ тэлснээр эцсийн үр дүнд аварга том шар түйрэн улс орны хэмжээнд босох болно.

Харуй бүрийн үеэр дөрвөн суурь адуу бүгд Баянговийн талд орж ирлээ. Хавь ойрын хэдэн арван километр газарт дэрс, бор шаваг, чөдөр өвс зэрэг армаг тармаг сөрдийн ургасан нь хүний сэтгэл сэрхийлгэм ажээ. Энэ хэсэг газар тал нутгийн унаган төрхөө алдаад, дотор газрын атаршаад олон жил болсон талбайгаас өөрцгүй харагдана. “Талын амь тун эмзэг байдаг юм. Жинхэнэ сайн монгол өвс нягт шигүү үндсээрээ зэрлэг өвсний ургалтыг хамгаалж байдаг. Харин түүний үндсийг гэмтээчихээр зэрлэг өвс, элс хоёр дураараа дургих боломжтой болж байгаа юм” хэмээн Билиг өвгөн ярьлаа.

Адуун сүрэг элст тал руу зугуухан сажлана. Адуу шөнөдөө идээшлэхгүй бол тарга тэвээрэг сайн авдаггүй боловч энд морь малын гоочилчих идэш тэжээл үнэндээ бараг үгүй ажээ. Азаар шумуул маш ховор тул адуугаа амрааж тэнхрүүлэх боломжтой байлаа.

Бао Шүнь Гүй Өлзий хоёр морио унасаар давхин ирэв. Билиг өвгөн тэдэнд хандан “Шөнө морьдоо энд сайхан амрааж аваад өглөөний шүүдэр бууж шумуул намдахаар бэлчээрт аваачин идээшлүүлье. Тэгээд шумуул ихсэхээр адуугаа нааш тууж ирээд байвал тарга тэвээрэг авахуулж чадахгүй ч гэсэн амь насыг нь аварч болох юм” гэв.

Бао Шүнь Гүй санаа амарсан байдалтай “Та хоёрын ачаар адуун сүргээ аварч чадах нь байна. Би ч ойрдоо санаа зовоод өвчин олоход ойрхон байсан шүү” гэлээ.

“Хүний бодсон хэргийг чоно бодохгүй байна гэж юу байх билээ? Тийм болохоор энд чонон сүрэг бүгж байх вий гэж би эмээж байна” хэмээн Өлзий хөмсгөө атируулан хэлэв.

“Би адуучдад хангалттай сум тавьж өгсөөн. Чоно олох юмсан гээд зовж байхад өөрсдөө хүрээд ирвэл түүн шиг сайн юм гэж хаана байх билээ дээ?” хэмээн Бао Шүнь Гүй хэллээ.

Жан Зи Юань гурван даргаа дагалдан нэгэн өндөр довцог дээр гарч ийш тийш харав. Билиг өвгөн ч гэсэн санаа зовсон байдалтай “Өнөө жил бороо хур элбэг болохоор дэрс, шаваг айхгар өндөр ургажээ. Тийм болохоор чоно нуугдсан байж мэдэх юм шүү” гэв.

“Бүх адуучдад хашгичин чимээ өгч, гар чийдэнгээ байн байн асааж бай гэж сануулъя” хэмээн Бао Шүнь Гүй хэллээ.

“Адуу ийш тийш давхихгүй тогтуун байвал ч азарга нь чононоос хамгаалаад байна л даа” гэж Билиг өвгөн хэлэв.

Хоёр морин тэрэг хүрэлцэн ирэхэд адуучид хоёр майхнаа босгон, гал түлээд цай чанаж гоймонтой хоол хийлээ.

Шөнө аараг толгодтой элсэрхэг талд чийг буугаад адуун сүргийг дагаж ирсэн шумуулнуудын ихэнх сүүлэнд нь цохиулан үхэв. Шумуулын зовлонгоос ангижирсан адуун сүрэг тун тогтуун

болжээ. Шөнө дүлээр ч гэсэн монгол морьд шөнийн байлдаанд оролцож байгаа цэргийн агт мэт чихээ сортолзуулан байнга дайны бэлэн байдалд байх ажээ. Адуун сүрэг аян дайнд оролцож байгаа цэргүүдээс өөрцгүй гамшиг зовлон тохиолдоход хоол ундыг ч тэвчин, өргөстэй хатуу дэрс харганыг ч болов голж шилэхгүй гэдэс рүүгээ хийж, хүч тамираа сэлбэхийг боддог. Жан Зи Юань шөнө манаанд гарч байхдаа хамгийн эрэмгий догшин азарга болон хурдан хүлгүүд өөрийн гэдсээ цүдийлгээд авахыг олж мэджээ.

Эхний шөнө шумуул багатай, чоно ч дайраагүй болохоор хүн морьдгүй амар тайван хоноцгоов. Шүүдэр буух цагаар шумуул нисэж чаддаггүй тул адуучид адуун сүргээ ойролцоох сахлаг өвстэй бэлчээрт аваачлаа. Шимт өвсний амтанд орсон адуун сүрэг өлөн чононоос өөрцгүй улайран хазлана. Нар өндөрт хөөрөхийн үест адуун сүрэг элсэрхэг талдаа эргэн очжээ. Хоёр дахь шөнө ч мөн адил тайван өнгөрөв. Гуравдахь өдөр Бао Шүнь Гүй морин тэрэгтэй хүнээр хоёр хонь хүргүүлжээ. Харуй бүрийн үеэр сайн нойр авсан адуучид түмпэнтэй махаа тойрон архи ууцгаалаа. Олон хүмүүсийн ууж наргин дуулалдах чимээнд чоно ч үргэж дайжих нь мэдээж хэрэг юм. Сүүлийн нэг жилийн хугацаанд Жан Зи Юань архи сайн даадаг болж, хэдэн ч дуу хөөрхөн аялчихдаг болсон билээ.

Дөрөвдэх өдрийн үдээс өмнө аж ахуйн холбоочин давхин ирээд “Барилгын цэргийн нэгтгэлийн ажилтан шинэ нутагт ирээд Өлзий, Билиг хоёртой уулзаж ярих хэрэг байна гэнэ ээ” хэмээн дуулгав. Тэр хоёр багийн төв рүү буцахад Билиг өвгөн анзааргагүй байдлаасаа болж алдавзай хэмээн дахин дахин захижээ.

Хоёр дарга нь холдон явахад хэдэн залуу адуучид авгай хүүхнээ санасаар үлджээ. Харуй бүрийн үеэр хоёр залуу адуучин ойролцоо шөнийн манаанд гарч байгаа хүүхнүүдийг эргүүлэхээр давхиад явчихав. Олонбулгийн талд шөнийн манаа гэдэг үг хоёрдмол утгатай болохоор хүүхнүүдэд тоглоом шоглоомоор ч ингэж хэлж болохгүй. Учир нь цаадахь чинь чамайг шөнөжин хүлээгээд хонож мэдэх л юм шүү.

\* \* \*

Олон адуу ойр хавийнхаа зэрлэг өвсийг ч хуу хаман идсэн тул шөнө идэх юмгүй морьд хэцүүдэх янзтай болж ирэв. Гэвч азарганууд хатуу чанга шоронгийн хуяг шиг сүргийн гишүүдийг чандлан сахиж, өвс бэлчээр рүү зүглэсэн ганц нэг морьдыг буцаан хөөнө. Адуун сүрэг ийнхүү өлөн зэлмүүнийг тэвчин зогсоход азарганууд харин тэдний эргэн тойрон харуулд гарна.

Холын дэрс шавгийн дунд тэвчээртэй нуугдан, мэхийтлээ өлссөн өлөн чононууд тогоотой махны тааламжтай үнэрийг аваад байж ядацгаана. Чонон сүрэг шумуул багатай энэ газар бага сага амсхийсэн тул завшааныг анаж байлаа. Олонбулгийн талын талаас илүү чононууд энэ элсэрхэг талын эргэн тойронд нуугдаж байгаа боловч тэдэн рүү халдаж чадахгүй байгааг Бат гадарлаж байв. Буу сум агссан адуучид хөлхөлдөж, эрэмгий догшин азарганууд энд тэндгүй хэрэн давхилдана. Яахаас ч буцахгүй шинжтэй хэдэн том азарга, харанхуйд сүүтэлзэх чонын барааг хараад хамраа тачигнуулан, туурайгаа цавчлах нь ар шилэн дээрээс зууж дээш шидээд эргэн буухад толгойг нь туурайгаар хага дэвсэх юмсан гэж байх шиг харагдана. Тал нутгийн хүмүүс адуун сүргийг хамгаалдаг монгол нохдыг өсгөж чадаагүй нь энэ удаагийн хамгийн том сул тал байлаа.

Оройн хоолны дараа Бат Жан Зи Юанийг дагуулан холхон байх дэрсэн дунд чонын мөрийг хайлаа. Тэр хоёр энэ тэрүүгээр нэлээд явсан боловч чонын шинэхэн мөр олж харсангүй. Хэд хоногийн өмнө холуур тойроход ганц хоёр чонын мөр байсан атал хүн морьд нэлээд суларчихсан энэ үед ор мөргүй болсонд Бат харин ч нэлээд зовниж эхэллээ. Чонон сүрэг том дайралт хийхээс өмнө ул мөрөө баллан ухарч хүн малын анхаарлыг сулруулдаг болохыг тэр яахин эс андах билээ.

Жан Зи Юань ч гэсэн ийм нам гүм оргих адууны бэлчээрийг хараад санаа нь чамгүй зовнив. Тэр хоёр тэнгэрийн байдлыг ажваас бараан үүлс бүрхэн тэднийг чиглэн айсуу тул морины амыг гэрийн зүг эргүүлэв. Бусад гурван суурийн адуучдаас нэжгээд хүн алга болсны учрыг асууваас зарим нь аж ахуйн төв рүү зай авахаар явсан, зарим нь багийн төв рүү биеэ үзүүлэхээр явсан байлаа. “Би тэдний хаашаа явсаныг мэдэлгүй яахав. Хэрэвзээ өнөө шөнө ямар нэгэн асуудал гардаг юм бол тэднийг аж ахуйн захиргаанд шилжүүлж хатуу шийтгүүлнэ гэж мэдээрэй” гээд Бат их л уурсан өгүүлээд бусад адуучдад хандан “Өнөө шөнө хэн ч унталгүй, хамгийн сайн морио сольж унаад адуугаа манах хэрэгтэй. Энэ шөнө чонон сүрэг гарцаагүй ирнэ” гэлээ.

Адуучид санд мэнд гар чийдэнгийн шинэ зайг сольж, буугаа сумлан, борооны цуваа бэлдэж, унаагаа юүлээд тулалдаанд бэлэн болов.

Шөнийн талыг адуучдын хашгирах дуун гар чийдэнгийн гэрэл цочоож, чонын үнэр авсан азарганууд сүргийн голд унагатай гүү, даага шүдлэнгээ хийгээд чанд хамгаалан зогсов. Бяцхан унаганууд эхийнхээ хажуугаас алхам ч холдохгүй ажээ. Жан Зи Юань мянгаар тоологдох олон адууны зүрх өөрийнхтэй нь ижил нэгэн хэмээр түг түг цохилохыг мэдрэх шиг санагдав.

Шөнө дундаас хойш хүчтэй салхи өнгөрсөний дараа уулс доргим хүчтэй аянга нижигнэхэд адуун сүргийн голд дарьтай агуулах тэсрэх мэт болов. Агшин зуурын төдийд хоёр мянга гаруй адуу сад тавин давхилдлаа. Азарганууд хойд хоёр хөл дээрээ босон урд хоёр хөлөөрөө цавчилж айж үргэсэн адууг тогтоох гэж оролдоно. Адуучид ч гэсэн азарганд хамжилцан адуугаа арайхийн тогтоож авлаа. Гэтэл тэнгэрээс аварга том мэдрэлийн ширхэг мэт цахилгаан цахиж адуун сүргийн чанх голд харвалаа. Адуун сүрэг өндөр уулсаар хүрээлэгдсэн усан сан газар хөдлөлтөд далангаа сэтлэх мэт азарганууд болон адуучдын хамгаалалтын шугамыг зад дайран давхилдав. Аяндын дуу хүн морьдын хашгирах, янцгаахыг дарж, гар чийдэнгийн гэрэл цахилгааны хүчинд дарагдав. Цахилгааны гялбаанд том том мөнгөлөг саарал чононууд адуун сүргийн дөрвөн зүгээс дайран хүрч ирлээ. Адуучид бүгд царай нь зэвхийрэхэд Жан Зи Юань “Чоно ирлээ, чоно ирлээ” хэмээн хашгирах дуу нь цахиртаад явчихав. Тэнгэрийн аянга цахилгаан нүргэлсэн нөхцөлд чонон сүрэг ийм ширүүн дайралт хийж байхыг тэр урьд өмнө үзээгүй юм. Чонон сүрэг мөнх тэнгэрийн зараалыг хүртсэн шударга журамт цэрэг эрс, тэнгэрийн ёсыг тунхаглан зарлаж, талын өвсийг там болтол талхалдаг монгол морьдоос өшөө авах гэж буй мэт довтолгон ирлээ.

Аянга цахилгаанд зүрхээ зүсүүлсэн адуун сүрэг араа шүдээ ярзайлган дайрах араатан чонын бүслэлтийг үзээд хамтач үзэл нь сарнин бутарч зөн совингоороо амиа бодон урагш зүтгэлнэ. Ялагдсан цэргийг уул нурахтай адилтган зүйрлэдэг. Тэгвэл үргэсэн адуу гэдэг ялагдсан цэргээс долоон дор байдаг ажээ. Аянга цахилгаан, харанхуй шөнийн халхавчин дор чонон



сүрэг сум мэт олон моьдын дунд шунган орж хазаж хайрсаар адуун сүргийг яах ийхийн зуургүй асгасан элс шиг тарааж орхив.

Чонон сүргийн довтолгооны хамгийн түрүүчийн бай нь унаганууд байлаа. Нижигнэсэн аянгын дууг урьд өмнө сонсож байгаагүй хөөрхий унаганууд айсандаа модон морь мэт хөдлөхгүй хөшиж орхижээ. Том чононууд тэднийг ганц хазаад л зүйл дуусгана. Хэдхэн минутын хугацаанд арван хэдэн унага элсэн дээр хөсөр унав. Гагцхүү зоримог бяцхан унаганууд ээжээсээ салахгүй давхиж, эхээсээ салсан нэг нь эрэмгий догшин эцгийгээ бараадсанаар өлөн чонын дайралтаас амь хэлтэрлээ.

Харанхуйд цагаан морь хамгаас содон байдаг тул Жан Зи Юань өөрийн амь шигээ хайрладаг “Цасан гүнжийн” хаана байгааг хайж байв. Цахилгааны цахих зуур хоёр хурдан азарга цасан гүнжийн араас элдэх гурван том чоныг түүнд хавьтуулахгүй хазаж хайрч байхыг үзэв. Цасан гүнж ч азаргаа даган давхихын хамт мөчөөгөө өгөлгүй өшиглөж тангарч байлаа. Чонон сүрэгт хамгаас эрхэм юм хурд тул тэд учраа олохгүй унагануудыг эхлээд хурдан зүйл дуусгахаар шийджээ. Азарганууд чангаар янцгаалдан гүүгээ дуудав. Адуун сүрэгт азарганаас гадна үрээ хайрлах гүүнүүд хамгийн сийрэг, зоримог байдаг ажээ. Тэд азарганы дууг сонсоод өшигчиж тангарсаар тэр зүг тэмүүлэв. Хамгийн эрмэг догшин азарга болон зоримог гүү унаганууд аянга цахилгаан чонон сүргийн хавсарсан дайралтын дор учраа олж, нэг дор цугларч чадав.

Гэвч адуун сүргийн олонх нь тарж бутарч гүйцсэн байлаа. Өлөн чонын сүрэг нуурын давалгаа мэт ар араасаа нүүгэлтэн ирэв. Өлсөж гуринхатсан чононуудын хувьд гар чийдэнгийн гэрэл, хашгичаан болон буун дуу, нүд гялбам цахилгаан аянгын дуутай харьцуулахад юу ч билээ. Энэ харанхуйд намайг уургалаад авахыг чинь харъя л даа гэсэн байдалтай адуучдыг юман чинээ тоохгүй дайрцгаана. Ингэсээр адуучид яваандаа хүчин мөхөсдөж, хагас цагийн дараа гэхэд хоорондоо ч харилцаа алджээ. Бат адуучид руу гар чийдэнгээр дохио өгч хоолойгоо сөөнгөттөл хашгиран “Зүүн өмнө зүгийг орхиод хамаг хүчээрээ баруун хойд зүгийг хамгаал. Адуун сүрэг хил даваад явчихвал баларлаа гэсэн үг” гэхэд адуучид сая сэхээ орон баруун хойт зүг рүү давхицгаалаа.

Аянга цахилгаан түр намдсаны дараа том том дусалтай бороо хаялж эхлэв. Энэ үед адуун сүрэг өвстэй бэлчээрт явж орсон боловч бороонд цохиулсан шумуулан сүрэг энэхүү цуст тулалдаанд оролцож чадахааргүй болжээ. Аянгын дуу аажмаар холдон тэнгэрийн хаяанд л цахилгаан цахилна. Хэсэг усан шамрага өнгөрсөний хойно тэнгэрт одод ганц нэгээр анивчихыг Бат хараад Жан Зи Юань болон ойролцоо байгаа хэдэн адуучдад хандан “Морьдоо тогтоохгүй бол хөх түр түрүү дайрч мэдэх нь байна шүү” хэмээн хашгирав. Адуучид унасан морьдоо улам шавдуулан ташуурдлаа.

Эхний тулалдаанд амжилт олсон нь чонон сүргийн ховдог хүслийг улам оволзуулжээ. Сүрэг чоно нэг л боломж олдвол түүнийгээ төгс амжилт болгон хувиргахын төлөө улайрдаг жамтай. Чонон сүрэг эхээс салсан унага болон хашин морьдыг алж дуусгаад даага шүдлэн байдсууд руу ч дайрч эхэллээ. Тэд эхлээд ганц ганцаараа дайрч байсан бол одоо хоёр гурваараа бүлэг болон давхилдана. Бяцхан унаганууд гүрээний судаснаас цус годгодуулан унацгаахад айсан адуу тал бүр тийшээ таран бутарчээ.

Энэ эгзэгтэй мөчид багийн зүгээс гурван морьтон гар чийдэнгийн гэрэл гялалзуулсаар хүрч ирсэн нь “Шөнийн манаанд” явсан гурван адуучин байлаа. Тэд зам зуур цаг агаар хувьсахыг үзээд эргэн ирсэн нь тун цагаа олсон хэрэг болов. Адуун сүрэг хүн гэрэл хоёрыг үзээд хурд нь арай жаахан сулрав. Бат энэ завшааныг ашиглан хоёр талаас нь хумин тогтоогоод буцаах маягтай болгож чадлаа.

Аянга цахилгаан намжсанаар адуучдын хашгирах болон гар чийдэнгийн гэрэл хэргээ өгч эхлэжээ. Тарсан адуунууд эргэн нийлж, азарганууд ижил сүргээ дуудан янцгаалдана. Адуун сүрэг ирсэн замаараа буцаж урагшлахад зам зуур салж бутарсан морьд эргэн нийлсээр байлаа. Гуч дөчин эрэмгий догшин азарга сүргийн өмнө нэгэн эгнээ болон жагсаад чонон сүрэг рүү хариу довтолгоог эхлэв. Чонон сүрэг ч зүүн өмнө зүг салхи мэт хурдан ухарцгаав. Адуун сүрэг тэр чигтээ унага даагаа дуудан янцгаах, эцэг эхээ таньж үүрсэх дуунд дарагдаад азарга азаргаараа ялгаран жигдрэв.

Түр зуур ухарсан чонон сүрэг нэгэнт унагаж бэлэн болгосон идшиндээ яарсангүй адуучид болон азарганууд учраа бүрэн олж амжихаас өмнө адуун сүргийн зүүн өмнө зүгээс довтоллоо. Бат болон хэдэн адуучин адуун сүргийн өмнө очиж азаргануудаа тоолвол гуравны нэг орчим нь дутуу байжээ. Бат яаран адуун сүргийн хойно гарч дөрвөн адуучинг хоёр хоёроороо морьдын хоёр талаар хашиж, хүрээг хумиад үлдсэн нь адуугаа хурдан тууцгаа гэж тушаалаа. Тэр Жан Зи Юанийг зүүн өмнө талаар чоно хөөхөөр явуулав.

Баруун хойд зүг рүү ухарсан чононууд зүүн урд зүгт байгаа чонон сүрэгтэйгээ нийлээд хөгшин болон хашин морьдыг барьж эхлэжээ. Баруун хойд зүгээс хүмүүсийн хашгирах чимээ ойртох боловч тэд барьсан олзоо идэх гэж мөн л яарахгүй байлаа. Жан Зи Юань ганцаараа чонон сүргийг хөөнө гэдэг худлаа болохыг мэдэж нөхөдтэйгөө хамтран адуун сүргээ туухаар шийджээ. Тал нутгийн цаг агаар болон нөхцөл боломжийг андахгүй мэддэг чононууд улам ч ашигтай сиймхий гарахыг хүлээж байгаа нь илт.

Элсэрхэг талаас хоёр километр орчим зайтай чийгтэй нугаар өнгөрөх үед өвсөн дунд нуугдаж байсан сүрэг шар хэдгэнэ тосны агуулах дэлбэрснээс үүдэлтэй өтгөн утаа мэт багшран босож адуун сүргийг бүчин авлаа. Хэдэн зуун улайрсан хэдгэнүүд хортой хошуугаа морьдын биед шаажээ. Аянга цахилгаан, араатан чонын довтолгоонд сүнс нь зайлах шахсан олон адуу хэдгэний дайралтад автан үргэж бусган давхилдав.

Энэ үед хамгийн хатуу ширүүн эрүү шүүлт адуун сүргийн хамгаалагч сахиус болох азарганы бие дээр буужээ. Азарганууд чилгэр биетэй, тачир үстэйн дээр ойрын хэдэн өдөр зай завсаргүй савчсан сүүлний хялгаснууд шумуулын цусанд ширэлдэн барьцалдсан болохоор үүргээ гүйцэтгэж чадахаа байсан аж. Хэдгэний хорт хошуу азарганы амин цэг болох гэдэс хэвлий, цавь хуухнагийг хазах нь бүр ч хорлонтой. Догшин ширүүн азарганууд байж ядсандаа өөрийн ухаан мэдрэл, үүрэг хариуцлагыг ч умартаж орхижээ. Ядаж энэ үед салхины эрч сулран хэдгэнүүд улам гаарсан тул галзуурахад ганц хуруу дутуу болсон азарганууд ижил сүргээ ч умартан салхи сөрөн давхилдав.

Шумуулгүй элсэрхэг талд байсан адуучдын олонх нь хамгаалах малгайгүй байсан тул нүүр, хүзүү, гар хөлийг нь хэдгэнэ хазаход нүд нь онийж, уруул нь памбайгаад, хуруу гар нь уурга барихын эцэсгүй хавдан өвдөв. Адуучдын унасан хүлэг ч өвдөж, загатнасандаа байж ядан,

үргэж бусгаж гарав.

Хүн морьдгүй аюулт хэдгэний дайралтад өртөн дайтах чадвараа бараг алдлаа. Адуун сүрэг жолоогоо алдан баруун хойд зүгийн салхийг сөрөн хурдлалаа.

Аянга цахилгаан, хэдгэнэ, чонын дайралт энэ шөнө Олонбулгийн талын адуун сүргийг хавсарчээ. Ямар ч суурьшмал үндэстэн ийм хэцүү бэрх орчин нөхцлийг даван туулж чадахгүй байсан болов уу гэдгийг Жан Зи Юань энэ шөнө яс махаараа мэдэрлээ. Тэр хорт хэдгэний хошуунд хатгуулаад тэсэж ядахдаа унасан мориныхоо амыг элсэрхэг тал руу эргүүлэн давхимаар санагдана. Монгол талын адуучид бүгдээрээ Чингис хааны аюумшиггүй морин цэргүүд байдаг болохоор халдаад ирсэн дайсныг хараад харьж няцан зугатна гэж үгүй. Гэвч морин цэргийн хувьд шөнө дүлээр давшина гэдэг цээртэй хэрэг. Учир нь хараагүй хүмүүн сохор морь унаснаас өөрцгүй тул тарвага, туулай зэргийн нүхэнд бүдрэн унаад шархдах нь байтугай үхэж ч мэдэх аюултай. Батын царай хүрлийчихээд морио хорсолтой ташуурдах нь хэдгэний тамлалыг мартуулах гэсэн хэрэг байлаа. Жан Зи Юань ч гэсэн талын морьтон баатрын үхэхээс үл буцах омог сүрэнд авгаад зоригоо чангалан үхлийг сөрлөө.

“Морьдоо баруун тийш туу. Тэнд нэг хэсэг элс байдаг юм. Адуугаа хилийн дээс алхуулж болохгүй шүү” хэмээн Бат давхиан дундаа хашгирлаа. Бусад адуучид ч “Хайя хайя” хэмээн тэнгэр доргиом зоримог уухайгаар хариу барив. Нэг адуучны унасан морь бүдэрч дуу алдан хөсөр унахыг Жан Зи Юань сонслоо. Харин хэн ч мориноосоо буун түүнд туслахаар очсонгүй адуугаа үргэлжлүүлэн туусаар байв.

Гэвч уургын морьд яахин чоно, хэдгэнэд хөөгдсөн сүрэг адууг гүйцэх билээ? Адуучид адуун сүргийг баруун зүг тийш эргүүлж чадсангүй. Гэсэн хэдий ч Бат болон бусад адуучид горь тасарсангүй чанга гуугалан араас нь нэхсээр байлаа.

\* \* \*

Гэнэт тэртээх толгодын цаанаас олон гар чийдэнгийн гэрэл гялсхийн гарч ирэв. “Багаас туслах хүч иржээ” хэмээн Батын хашгирахад адуучид уухай хашгиралдан гар чийдэнгээ гялалзуулж цаадуулдаа адуун сүргийн байрлалыг таниулав. Туслахаар ирсэн хүмүүс уухай хашгиралдан гэрлээ гялалзуулсаар үргэсэн адууны замыг хаалаа. Адуун сүргийг дахин хурааж тогтоогоод бөөр бөөрөөр нь нийлүүлэн хэдгэнийг няцлан алав.

Билиг өвгөн овгийн ахлагч тусламжийн цэргээ удирдан хамгийн эгзэгтэй цаг үед, хамгийн тохиромжтой газар хүрч ирсэн нь тун цагаа олсон хэрэг болов. Тэд чонон сүргийг зад цохин дайрлаа. Чонон сүрэг өмнөөс гарч ирсэн хүмүүсийн хашгирах дуун, гэрэлд цочирдсоны дээр, ялангуяа Билиг өвгөний дууг таньсан азарган чоно сүргээ хураан даруй ухарлаа. Одоо тэдний гол зорилго гэвэл түрүүчийн унага даага унагасан газартаа давхин хүрээд гэдсээ цатгаж аваад аглаг уулыг бараадах явдал юм.

Билиг, Өлзий, Бао Шүнь Гүй нар арван хэдэн хоньчин, илгээлтийн эздийн хамтаар адуучидтай хамжин адуун сүргийг хураалаа. Мөн хоёр хүнийг унаж бэртсэн адуучин руу явуулав. Чэнь Жэнь Жан Зи Юань дээр гүйн очиж өнөө шөнө юу болсныг асуух далимаар Өлзий, Билиг хоёр тэнгэр муухайрахаас өмнө адуун сүрэгт аюул тулгарлаа гээд хүн хүч

зохион байгуулж ирсэн тухай дуулгав. Жан Зи Юань уртаар амьсгаа аваад “Мөн аймаар юм боллоо шүү. Хэрвээ та нар ирээгүй бол хамаг адуугаа алдах байлаа” гэв.

Элсэрхэг талд ирэхэд үүр манхайн цайлаа. Алдагдсан адуугаа цуглуулаад тоолж үзвэл тун ноцтой хохирол учирчээ. Нийт дөрөв таван хөгшин морь, арван хоёр даага, сарваа, тавь жаран унага гээд нийтдээ дал гаруй адуу амь хохирчээ. Энэ удаагийн гамшигт аянга, цахилгаан, хэдгэнэ том нөлөө үзүүлсэн боловч гол гэм буруутан нь гарцаагүй чоно байлаа.

Бао Шүнь Гүй морьдын хүүр сэг хаа сайгүй хөглөрөх элст талыг хараад уурандаа шатан “Би тал нутгийн эн тэргүүний зорилт бол чоно устгах явдал мөн гэж хэлээд байдаг биш бил үү? Гэтэл та нар огт дэмждэггүй байсан. Одоо тэгээд юу болсоныг харж байгаа биз дээ? Үүнээс хойш хэн нэгэн хүн чоныг өмгөөлж хамгаалаад байвал түүнийг албан тушаалаас нь буулган хамаг төлбөрийг хар толгойд нь оногдуулна гэж мэдээрэй” хэмээн хашгичлаа.

Билиг өвгөн нэг гараараа нөгөө гараа барьчихаад тэнгэр өөд харж ямар нэгэн юм бувтнана. Чэнь Жэнь, Жан Зи Юань хоёр түүний юу хэлж байгааг яахин эс андах билээ? “Тал нутгийн амьдралын хэмнэлийг уялдуулан зангидаж байсан хүн эцэс сүүлдээ өөрөө золигт гараад дуусах шив дээ” хэмээн Чэнь Жэнь Жан Зи Юаньд хандан өгүүлэв.

Жан Зи Юань Бао Шүнь Гүй руу дөхөж очоод “Ийм айхтар байгалийн гамшигийг хүний хүч яахин дийлэх билээ? Манайх харин ч гайгүй адуун сүргийн ихэнхийг авч үлдэж чадсан. Харин бусад нэгдэл, аж ахуйнууд айхтар хохирол үзсэн нь лавгай. Манай адуучид аюулын өмнө айж хулчийлгүй, сэтгэлээсээ ажилласан төдийгүй нэг маань унаж бэртэнэ гэдэг чинь бага хэрэг үү? Харин ч Билиг аав, Өлзий гуай хоёр тав хоногийн өмнө багийн нийт адуун сүргийг элсэрхэг талд хураасны хүчинд өдий зэрэгтэй гарч байгаа юм. Тэгээгүй бол хамаг адуугаа тавиад туух байсан байх шүү” гэж хэлэв.

Лхамжав ч мөн хошуу нэмэрлэж “Тийм шүү. Хэрвээ Билиг өвөө, Өлзий гуай хоёр байгаагүй бол өдийд хамаг адуугаа хилийн дээс гаргаад алдчихсан бол бид дээлээ нөмөрч, та ч гэсэн албан тушаалаасаа хусуулж таарах байсан даа” гэлээ.

“Унаганы хохирол жил болгон үүнээс ч их байдаг. Өнөө жил харин ч гайгүй байгаа. Тийм болохоор адуучид бид жаахан анхааралтай байж чадвал унаганы гарзыг урьд жилийнхтэй дөхүү байлгаж болох байлгүй дээ” хэмээн Бат хэлэв.

“Яадаг ч байсан энэ олон морьд чононд бариулсан нь үнэн биз дээ? Шумуул хэдгэнэ хэдийгээр аюултай ч гэсэн адуу барьж чадах бил үү? Хэрвээ чоныг эртхэн устгачихсан бол ийм хохирол гарахгүй байсан юм. Барилгын цэргийн нэгтгэлийн дарга нар энэ хэдэн өдөр аж ахуйн төв дээр байгаа. Тэд хэрвээ ийм олон морьд нэг дор үхсэнийг харсан бол намайг ажилгүй болгож таарна. Хорт чонон сүргийг хоггүй болгон устгахаас нааш тал нутгийн хүн мал амар заяагаа үзнэ гэж үгүй. Та нар чоно агнадаггүй юм бол би цэргийн ангийнхныг гуйж байгаад агнуулаад өгөхөө мэдэх байлгүй. Автомат буу, ачааны тэрэг, жийптэй улсад юухан байхав” гэж Бао Шүнь Гүй шүд зуун өгүүлжээ.

Малчид царай барайлган шуухитнасаар үхсэн морьдын учрыг олцгоов. Хэдэн адуучид хоёр морь тэргэндээ гэмтэж сэвтээгүй бүтэн үхсэн унагыг ачиж аж ахуйн төвийн айлуудад

өгөхөөр авч явлаа. Тал нутгийн өлөн чоно мах ховордсон зуны тарчиг цагт хүний хамар дороос шахам өөрийн идэш тэжээлийг бэлдэж чаддаг ажээ.

Амьд гарсан унаганууд үхсэн нөхдөө хараад дөрвөн хөл нь чичрэн салганана. Энэ удаагийн цуст сургамж амьд үлдсэн унагануудад дараачийн гамшиг тохиолдоход эрэлхэг зоригтой, ухаалаг байхыг сургасан байж таарна. “Гэвч дараачийн удаа ийм явдал болох болов уу?” гэж Чэнь Жэнь өөрөөсөө асуухад зүрх нь палхийх шиг болов.

## Гуч

*Дөрвөн зуун дөчин есөн онд Вэй улсын Сяо Вэнь хаан язгууртан, бичиг цэргийн сайдууд болон хоёр зуун мянган Сяньбичуудыг дагуулан Пин Чэн хотоос Луо Ян руу нүүжээ. Эдгээр хүмүүс садан төрөл, боол зардсантайгаа нийлээд саяас илүү гарахааргүй байв.*

.....

*Сүй Тан улсын үе шар мөрний сав газраар суурьшин амьдарч байсан Хань үндэстэн нь үнэн хэрэгтээ арван зургаан улс болон баруун умард зүгийн хоцрогдсон бүдүүлэг үндэстнүүд уусан холилдсоноос буй болсон юм.*

*Фань Вэнь Лань*

*“Хятадын нэвтэрхий түүх”*

Жүзигийн үгсийн төрөл зүйлийн зуун арван зургаа, эл төрийн төрөл зүйлийн гуравт өгүүлсэн нь: “Тан улсын эх үүсгэл нь И Ди аймаг, иймээс охид авхайгийн өргөөнд ёс алдсан явдлыг сонин хэрэг хэмээн үзэх хэрэггүй”

Чэнь Янь Гө

“Тан улсын үеийн улс төрийн

өгүүллийн ноорог”

Намрын уйлагнасан хүйтэн бороо өвөрмонголын богинохон зуныг залган авахад улангассан шумуулын сүрэг бээрч бээцийж хоцорлоо. Олонбулгийн талыг ширтэн гөлөрч хоцорсон Чэнь Жэнь богинохон зун намрыг залгаад урт өвөл үргэлжилдэг болохоор эндхийн чоно шумуул хоёр ийн улангасдаг нь аргагүй юм даа хэмээн бодно. Өвөл гэдэг ичдэггүй хорхой шавьжийн хувьд үхэлтэй адил байдаг болохоор хэдийгээр тарваганы үүрэнд өвөлждөг ч шумуулнуудын ихэнх нь үхдэг юм. Зун олигтой тарга тэвээрэг авч үс ноосныхоо өнгийг засаж авахгүй бол өлөн, хөгшин, өвчтэй, шархтай чононуудын хувьд ч үхэл дайрах нь гарцаагүй. Тийм болохоор өвлийг өнтэй өнгөрөөж, хаврын хатуу тарчиг цагийг мэнд гэтлэхийн тулд чоно шумуул хоёр үхэн хатан хүн мал руу дайрдаг байж таарна.

Чэнь Жэньгийн хуваарилан өгсөн унаганы муудаж бээсэн гэдэс дотор болон хоёр хаа нь байгаа болохоор бэлтрэг нэг хэсэгтээ гэдэс цатгалан хэдэн өдрийг ардаа үджээ. Бэлтрэгний үнэрч хамар нь түүнд бас дахин хэдэн өдрийн амтат хоол байгааг сануулна. Тийм болоод ч тэр үү, бэлтрэг ойрын хэдэн өдөр их л хөгжилтэй сэргэлэн байлаа.

Бэлтрэг түүхий мах, тэр дундаа өтөж муудсан маханд бүр ч их дуртай. Ямар сайндаа л Гао Зянь Жун “Энэ бэлтрэг манай гэрийн хогийн сав болж гүйцлээ л дээ. Хамаг байдаг муудсан хоол хүнсээ түүний гэдэс рүү чихэж байдаг болчихлоо” гэж байхав.

Хамгийн хачирхалтай нь яаж ч муудаж өмхийрсөн мах, гэдэс дотрыг түүнд өгөхөд өвчин олно гэж үгүй. Чэнь Жэнь, Ян Кө хоёр бэлтрэгний халуунд халдаггүй, хүйтэнд өлчир, өл

даамхай, өмхий самхайд өвчин эс олох чадварыг гайхаж биширч гүйцжээ. Хэдэн мянга түмэн он жилийн шалгуурыг давж гарсан энэхүү төрөл зүйл үнэхээр гайхамшигтай боловч Дарвин Өвөрмонголын Олонбулгийн талд ирж байгаагүй нь харамсалтай. Хэрвээ тэр наашаа ирж үзсэн бол монгол талын чоныг биширч гүйцээд хувьслын онолдоо тусгай бүлэг нэмж оруулах байсан биз.

Бэлтрэг өдөр хоног өнгөрөх тусам өсөж томорсоор сүр жавхаатай талын чоно болон хувирчээ. Чэнь Жэнь түүний гинжийг уртасгаснаар үл барам нэрийг нь хүртэл өөрчилж “Том чоно” хэмээн нэрлэх л үлджээ. Гэвч тэр өөрийн “Бэлтрэг” гэсэн нэрэнд нэгэнт дассан болохоор Чэнь Жэньг дуудангуут гүйж ирээд гар хөлийг нь долоон, хөлөө сарвалзуулан дээш харж хэвтээд маажуулдаг хэвээр ажээ. Хааяа түүнийг том чоно гэж дуудахад тоосон шинжгүй өөр тийш харна. “Тэнэг золиг чи өөрийгөө том болсныг мэддэггүй юм уу?” хэмээн Чэнь Жэнь шоолоход цаадахь нь хэлээ гарган аахилна.

Бэлтрэгний биеийн эд эрхтэн бүхэн тун зохицолтой боловч сүүлийн үед түүний чих Чэнь Жэньгийн таашаалыг онцгой ихээр татах болжээ. Түүний цэвэрхэн, соотон агаад сонор хоёр чих нь биеийн бусад эрхтнүүдийг бодвол хамгийн түрүүнд чонын төрхөө олжээ. Бэлтрэг ч энэ хоёр чихнийхээ хүчээр өөрийгөө талын чоно гэж ялган таних зөн совинтой болсон юм. Чэнь Жэнь завилж суугаад бэлтрэгтэйгээ тоглох үедээ ёс юм шиг чихийг нь илэх дуртай. Гэвч бэлтрэг чихний уг, хүзүү хоолой зэрэг загатнасан газар бүхнээ маажуулж дууссаны дараа сая түүний зоргоор чихээ илүүлнэ. Чэнь Жэнь бэлтрэгний чихийг арагш нь нугалж дараад гараа гэнэт тавихад пүдхийтэл эргээд соотойхыг харах дуртай. Хэрвээ хоёуланг нь зэрэг дарж байгаад тавивал заавал нэг нэгээрээ эргэн соотойно. Энэ үед бэлтрэг өөрөө ч юу болов гэсэн байдалтай гайхан хардаг.

Арслангаас бусад хотны ноход түүний хоёр соотон чихийг атаархсан, тэр ч байтугай үзэн ядсан байдлаар ширтэх нь бий. Чоно нохойн яс чанарын ялгаа арай чихний мөгөөрсөнд байдаг юм биш байгаа гэж бодох үе Чэнь Жэньд цөөнгүй тохиолдоно. Нохойн өвгийн чих чонотой адил соотон байснаа хүнд гаршин дассанаас хойш налмайн буугаад тэр хэрээр сонстол нь муудсан ч юм бил үү? Балар эртний хүмүүс нохойн зэрлэг занд дургүйцэн чихнээс нь мушгиж татан чангаасаар мөгөөрсийг нь зөөлрүүлснээс болж нохойн яс чанар муудаад доогуур харж дорой дуугарсан гэрийн боол төдийхөн болон хувирсан байж бас мэдэх л юм. Монгол адуучид ч гэсэн эмнэг хангал даагыг сургахдаа чихдэж байгаад морддог, хятадын газрын эздийн авгайчууд шивэгчингийнхээ чихийг мушгиж шийтгэдэг байсан шүү дээ. Боол зардсангууд чихдүүлж байж өөрийнхөө хэн бэ гэдгийг ухаарах нь цөөнгүй.

Бэлтрэг нь Чэнь Жэньд чих болон байр суурь ямар холбоотой болохыг ухааруулж өгсөн юм. Тухайлбал хүчирхэг үндэстнүүд сул дорой үндэстнийхээ чихнээс атгах дуртай байдаг. Тэгвэл сул дорой үндэстэн бүр жижиг үндэстэн ястныг чихдэж авдаг байна. Нүүдэлчдийн хувьд зэрлэг үхэр, зэрлэг адуу, зэрлэг хонь ямаа болон нохойг чихдэж номхруулаад гарын аясаар болгожээ. Улмаар тэд өөрийн энэхүү туршилтыг бусад үндэстэн ястны хувьд хэрэгжүүлж ноёрхох байр суурь эзлэж чадсан байна. Түүнээс үүдэн хүний хорвоод “Хоньчин”, “Хонин сүрэг” гэсэн харилцаа үүсчээ. Лю Бэй анх Сюй Жоу мужийн Мү40 хэргэмтэй байсан бол ард иргэд нь Сюй Жоу мужийн хоньд байсан байж таарна. Дэлхий дээр хамгийн анх ноёлогч бүлэглэлд чихээ атгуулсан хүмүүс гэвэл суурьшмал иргэд юм. Өнөө хэр бусдын халуун чихийг

атгах нь олон хүмүүс болон бүлэглэлийн мөрөөддөг зүйл биш гэж үү? “Үхрийн чихийг атгах” гэсэн үг өнөө хэр хятад хэлний толь бичгүүдэд байдаг нь тэдний нүүдэлчин өвөг дээдсээс улбаатай байж таарна. Харамсалтай нь умард Сүн улсаас хойш хятадууд бусдад чихдүүлсээр ирсэн түүхтэй билээ. Өнөөдөр “Үхрийн чихийг атгах” гэсэн үг нь байгаа хэрнээ түүний үзэл санаа ул мөргүй алга болжээ. Орчин үеийн үндэстнүүд бусдыг эзэрхийлэн дарлаж болохгүй боловч “Үхрийг чихдээд авахаас” үл няцах хүчирхэг үзэл санаа байхгүй бол хэзээ нэгэн өдөр чихээ бусдад алдсан байж мэднэ.

Ойрын хэдэн өдөр улам олноор үзэгдэх болсон цэргийн ангийн жийп машинуудыг хараад Чэнь Жэньгийн сэтгэлд гунигийн будан татах болсон ажээ. Тэр анхны бөгөөд хамгийн сүүлчийн удаа өвөрмонголын унаган байгалийн нөхцөлд мал адгуулж өнгөрөөсөн хятад хүн байж мэдэх л юм. Тэр бол дуулиан шуугиан хөөцөлдсөн сэтгүүлч сурвалжлагч биш, нүүдлийн амьдралтай тал нутгийн хоньчин хэмээх бахархалтай мэргэжил бүхий нэгэн билээ. Түүнээс гадна тал нутгийн хамгийн арвин чонотой Олонбулагт газар дээр нь ажиглалт хийх боломжтой нь хамгийн бахархууштай хэрэг мөнөөс мөн. Мөртлөө тэр өөрийн гараар суйлсан бэлтрэгээ тэжээн өсгөж байгаа. Бэлтрэгнийхээ өдөр тутмын үйл хөдлөлийг нарийн ажиглаж холбогдох бодол эрэгцүүллийг тэр марталгүй сэтгэлийн гүндээ хадгалсаар ирсэн. Тийм болохоор энэ хорвоог орхих хүртлээ өөрийн найз нөхөд төрөл төрөгсдөдөө энэ тухай ярьсаар байх болно. Харамсалтай нь хятад үндэстэн дэндүү эрт тал нутгийн амьдралаас холдож, хээр талын нүүдлийн амьдралын амьсгал тасрах мөч ойртож байна. Тийм болохоор хятад хүмүүс дахин буурал талд эргэн ирж эрт балрын элэнц хуланцын сүнсэндээ мөргөх хувь дутагч дээ. . . . .

Чэнь Жэнь бэлтрэгнийхээ чихийг зугуухан илбэнэ. Энэ бол түүний сүүлийн жилүүдэд хамгийн ойроос харж байгаа чонын чих болохоор дуртай байлгүй яахав. Яагаад гэвэл энэ хоёр жил түүний харсан амьд чоно, үхсэн чоно, өвчсөн арьс болон туламласан арьсан дээрх чихнүүд бүгд сэвтэй байсан юм. Заримынх нь чих маркны хүрээ шиг салмараад, өөр бусдынх нь чихний үзүүр тас хазагдсан эсвэл салмаран унжсан байдаг байлаа. Тэр ч байтугай угаараа тас хазуулсан чихтэй чонотой ч тааралдаж байв. Чоно нас өтлөх тусам чихний хэлбэр улам алдагддаг шиг санагдсан. Эргээд бодоход ямар ч өө сэвгүй сайхан чихтэй чоно тэр хараагүй юмдаг. Хатуу ширүүн талын нөхцөлд салмарсан, салбархай гэдэг чонын чихний жинхэнэ үзүүлэлт байж таарна гэж Чэнь Жэнь бодов.

Тэгвэл бэлтрэгний өө сэвгүй чих нь жинхэнэ чонын чих биш гэж үү дээ? Ингэж бодтол Чэнь Жэньгийн сэтгэл харууслаар дүүрээд эхлэлээ. Бэлтрэгний чих өө сэвгүй гэдэг нь хамгийн том согог болон хувирсаныг тэр ухаарчээ. Чоно бол тал нутгийн дайчин баатар бөгөөд эрэмгий азарга, ярдаг догшин анч ноход, алалцахаас эс буцах хүний нутгийн чоно болон эрэлхэг зоригтой тал нутгийн анчинтай тулалдан байж өөрийн эрх чөлөөтэй хатуу ширүүн амьдралаа хамгаалж ирсэн билээ. Хатуу ширүүн олон тулалдааны ард гараагүй, өө сэвгүй соотон хоёр чихтэй амьтныг энэ хорвоод чоно гэж хэлэхэд хэцүүхэн хэрэг болох биш үү? Тэр бэлтрэгнээс тал нутгийн баатрын хувь тавиланг булаан авч, чонон чихтэй боловч үнэн хэрэгтээ нохойноос долоон дор хоригдол болгон хувиргасан хатуу харгис зангаа гэнэт мэдэрчээ.

Тэгвэл түүнийг сэмээрхэн тавьж явуулаад тал нутгийн эрх чөлөөт чонын амьдралыг нь



эргүүлэн өгчихдөг юм бил үү? Гэвч тэр яахин тэгж зүрхлэх билээ? Чэнь Жэнь түүний дөрвөн хурц соёог хурц бахиар тайрсан цагаас хойш бэлтрэг тал нутагтаа эрх дураар амьдрах хурц зэвсгээ алдсан. Бэлтрэгний шөвөг мэт дөрвөн хурц соёо одоо нохойны соёог ч гүйцэмгүй дөрвөн мөлийсөн эд болчихоод байгаа юм. Хэдийгээр тухайн үедээ судсыг нь гэмтээчихгүй юм шүү гэж маш болгоомжтой ажилласан боловч нэг соёоны хугархайн ан цавыг даган хар хүрээ үүссэн нь өвчилсөний шинж болохыг хараад Чэнь Жэньгийн сэтгэл маш их хямарсан билээ. Нэг жил бололгүй энэ өвчтэй шүд мултарч унах болно гэж бодохоор түүний зүрх базлах шиг санагдана. Соёо гэдэг талын чонын амь амьдрал байдаг болохоор дөрвөн мохоо соёотой чоно амьтан барих нь байтугай хоолоо ч идэхэд амаргүй болж таарна.

Цаг хугацаа өнгөрөхийг дагалдан Чэнь Жэнь тухайн үед өөрийн хөнгөн гоомой гаргасан шийдвэртээ улам харамсаж эхлэв. Одоо тэр бэлтрэгийг тал нутагт нь эргүүлэн тавьж, хожим талын гүнд чоно андтайгаа уулзан учрах боломжгүй болсон. Түүний романтик мөрөөдлийг тэр нэг удаагийн харгис мэс ажилбар үгүй хийснээр үл барам ийм хөөрхөн бэлтрэгнийхээ эрх чөлөөг ч алга хийж орхижээ. Тэр тусмаа удаан хугацааны турш уяанд дассан энэ амьтан тулалдааны туршлага байхгүй болохоор Олонбулгийн талын чононууд түүнийг гадны амьтан гэж бодоод хайр найргүй тасар татан хаях нь ойлгомжтой. Нэг сарын өмнө өлөгчин чоно бэлтрэгийг дуудан улиад байхад тавиад явуулчихаагүйдээ тэр маш их харамсан халаглана. Тэр сэтгэл зүрхнийхээ угаас “Шинжилгээ судалгааны ажлыг” зэвүүцэн хорсож, өөрийгөө жинхэнэ судлаач шинжээч биш юм гэж цайруулан бодох үе цөөнгүй тохиолдоно. Бэлтрэг бол анагаах ухааны задлан шинжилгээний зориулалттай цагаан оготно биш, харин түүний сайн анд багш нь юм шүү дээ уг нь.

\* \* \*

Тал нутгийнхан өвөрмонголын үйлдвэрлэлийн барилгын цэргийн нэгтгэл албан ёсоор хүрэлцэн ирэх өдрийг сэтгэл түгшин хүлээж байлаа. Билиг, Өлзий болон бусад хөгшчүүлийн нэр хавсран гарын үсэг зурсан бичиг үр дүнгээ өгч Олонбулгийн талыг мал аж ахуйн бэлчээр хэвээр нь үлдээж харин аж ахуйг мал аж ахуй голлосон, газар тариаланг хавсарсан хөдөө аж ахуйн хамтрал болгон өөрчлөхөөр цэргийн ангиас шийджээ. Харин бусад аж ахуй, нэгдлүүд бүгд газар тариалангийн хамтрал болсоноор монгол талын алдарт үзэмчин адууны нутаг болох Унаган голын сав газар тэр аяараа өргөн уудам тариалангийн талбай болон хувирав. Тун цөөхөн тооны аж ахуй мал аж ахуй газар тариалан хослосон хамтрал болжээ.

Цэргийн нэгтгэлээс гаргасан сүрлэг төлөвлөгөөний сүр дуулиан Олонбулгийн талд хүртэл дуулдах болов. Түүний гол утга санаа гэвэл: “Тал нутагт хэдэн мянган жилийн турш оршин тогтносон балар эртний нүүдлийн хоцрогдсон үйлдвэрлэлийн хэвшлийг дуусгавар болгож олон тооны суурин цэгүүдийг байгуулна. Цэргийн нэгтгэл өөрсдийн асар их хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, хүн хүчийг ашиглан малчдад тоосго вааран байшин болон цемент чулуун бөх бат малын хороо барьж өгч, худаг гаргаж, сургууль, эмнэлэг, шуудан, сүм, дэлгүүр, кинотеатр зэргийг байгуулах ажээ. Түүнчлэн үржил шимтэй газруудыг сонгон элдэв төрлийн ногоо, үр тариа, малын тэжээл тариалахаар төлөвлөжээ. Түүнээс гадна тэд механикжсан өвс хадах бригад, тээврийн анги болон тракторын станцыг байгуулна. Чоно, өвчин тахал, хорхой шавьж, оготно зурмын гамшгийг бүрмөсөн эцэс болгоно. Ингэснээр хэдэн мянган жилийн турш хүнд бэрх нөхцөлд аж төрсөөр ирсэн малчид аажмаар аз

жаргалтай амар түвшин амьдралд шилжих болно” хэмээн заажээ.

Аж ахуйн илгээлтийн эзэд, залуу малчид, хүүхдүүд болон авгай хүүхнүүд голцуу хүмүүс барилгын цэргийн нэгтгэл хурдан хүрэлцэн ирээд Бао Шүнь Гүй тэдний төсөөлөн ярьж байгаа сайн сайхан төлөвлөгөөг хэрэгжүүлээсэй гэж хүсэж байцгаав. Харин олонх хөгшчүүд болон ид дунд насны эрчүүд хар цагаан дуугүй байх ажээ. Чэнь Жэнь Билиг өвгөнийд асуухаар очтол хөгшин санаа алдаад “Малчид үр хүүхдээ сургууль соёлтой болгоод өвдөж хавдахаар үхэр морь тэргээр аймаг хошууны эмнэлэг барааддаг байсныг больё гэж хүсэлгүй яахав. Олонбулагт эмнэлэг байхгүйгээс болж үхэх учиргүй хүмүүс амь алдаж байсан тохиолдол цөөнгүй. Гэтэл тал нутаг маань яах болж байна вэ? Одоо хэр нь бэлчээрийн даац хэтэрчихээд байгаа шүү дээ. Тал нутаг модон хүрдтэй үхэр тэрэг шиг хэврэг болохоор иймхэн тооны хүмүүсийг л багтааж чадна. Гэтэл тэр олон хүн хар машин техник ороод ирвэл тал нутаг маань онхолдлоо гэсэн үг. Тал нутаг онхолдоод өгөхөөр танай хятадууд ч яахав нутгаа бараадаад буцчихна. Гэтэл малчид яах болж байна вэ?” хэмээн халаглана.

Харин Чэнь Жэньгийн тухайд талын чононд хамгаас илүү санаа зовж байлаа. Тариачин гаралтай хүмүүс ирээд хун, галуу, нугас зэрэг шувуудыг алж идсээр үлдсэн цөөхөн нь дайжаад явчихсан. Гэтэл нүүдлийн шувуудтай адилгүй Олонбулгийн талд хэдэн мянган жилээр амьдарсан чонон сүргийг алж устгаад улсын хилээр хөөгөөд явуулах хэрэг үү? Гадаад монгол хахир хүйтэн, өвс тачир, хүн мал цөөнтэй болохоор тэндхийн гуринхатсан чононууд эндхийн цаггалан чононоос илүү догшин ширүүн байдаг. Тэнд очсон хойноо манай эндхийн чононууд гадуурхагдсан “Цагаачид” болон хувирах болно. Чэнь Жэнь тал нутгийн чонон сүргийн талаарх ажиглалт судалгаагаа дөнгөж эхэлж байтал талын чонын амьдрах хугацаа дуусгавар болох юм гэж яахин санах билээ?

Харуй бүрий болохын алдад Ян Кө хонин сүргээ хол саахалтын хэртэй газар гэр рүүгээ чиглүүлж орхичихоод өөрөө түрүүлэн ирж хүйтэн хар цай залгилав. Удахгүй нутаг сэлгэх гэж байгаа болохоор хонин сүргээ гэрийн ойролцоох бэлчээрийн өвсийг идээд аваг гэж бодсон нь тэр ажээ.

Ян Кө хоёр аяга хүйтэн цай залгилаад Чэнь Жэньд хандан “Цэргийн нэгтгэл ийм хурдан хүрээд ирэх юм гэж хэн санах билээ дээ? Би энх цагийн хагас цэрэгжсэн амьдралыг үзэн яддаг болохоороо л Хар мөрөн мужийн барилгийн цэргийн нэгтгэлээс наашаа зугатааж ирсэн юм. Гэтэл энэ өвөрмонголын талд бас тэдэнтэй нүүр тулдаг байх нь ээ. Олонбулгийн тал цаашид яах нь тодорхойгүй болж байгаа тул хоёулаа хурдхан талын чонын судалгаагаа гүйцээх хэрэгтэй болж дээ. . . . .” гэв.

Тэр хоёр ийнхүү ярьж байтал зам дагуу нэгэн хүн морины хар хурдаар улаан тоос босгосоор давхин ирэх үзэгдлээ. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч Жан Зи Юань ээлжнээсээ бугаад гэртээ амрахаар ирсэн болохыг төвөггүй таньжээ. Жан Зи Юань одоо тал нутгийн жинхэнэ сайн адуучнаас өөрцгүй олон сайн эрэмгий хурдан хүлэгтэй тул түүндээ эрдэж хурдлан давхих дуртай болсон юм. Гао Зянь Жун их л атаархангуй байдалтай инээвхийлээд “Түүний ийн хурдлан давхиж байхыг харсан олон айлын охид бүсгүйчүүд гэрийн гаднаа нүдээ унагаж гүйцэхийг та нар үзэв үү?” гэлээ.

Жан Зи Юань мориноосоо үсрэн бугаад “Та нар миний юу авчирсаныг хар даа” гэж хэлэв.

Тэр эмээлээсээ дотор нь амьтан хийсэн бололтой түнтэгэнэн хөдлөх уутыг тайлан авчирлаа.

Ян Кө мөнөөх уутыг илж үзсэнээ “Чи байтлаа бэлтрэгтээ хань ижил олоод ирж байгаа хэрэг биш биз дээ?” гэв.

Жан Зи Юань хариуд нь “Өдийгийн бэлтрэг хаанаас ийм жаахан байх билээ? Наадхиа битгий алдчихаарай” гэж хэлэв.

Ян Кө уяаг нь тайлан үзвээс хоёр дэлдэн чих цухуйхад ухасхийн бариад гаргаж ирэв.

Хар сортой зэгэл шаргал гялалзсан үстэй том муурын хирийн бор туулай Ян Көгийн гарт тийчигнэх нь лав гурван килограмм жин татахаар ажээ.

“Өнөө орой цугаараа соустай туулайн шарсан мах идэцгээе. Дандаа хонины мах идсээр байгаад бүр уйдаж орхилоо” хэмээн Жан Зи Юань морио уянгаа хэлэв.

Ийн хэлж байх зуур түүнээс долоо найман алхмын цаана байсан бэлтрэг туулайг үзээд ухасхийн дайрлаа. Хэрвээ төмөр гинжиндээ татагдаагүй бол лав өдийд туулайг булаан авч одох байсан буй за. Бэлтрэг ухасхийн үсэрч гинжиндээ татагдан годройтон уналаа. Тэр хөлбөрөн босож урд хоёр хөлөө цоролзуулан, хэлээ төө хирийн урт сунгаад нүдээ бүлтийлгэн цовхчих нь туулайг болдогсон бол амьдаар нь залгихсан гэж байгаа мэт харагдана.

Гэрийн бусад ноход үсэрч дэгдээд баригдаж өгдөггүй тэр хээрийн амьтныг үзээд тойрон шиншлэх боловч булаан авч зүрхлэх нь нэгээхэн бээр ч үгүй.

Ян Кө бэлтрэгний шүлхтэн шунахайрах царайг үзээд туулайн чихнээс өргөн түүн рүү дөхөн очоод хоёр тийш савчууллаа. Бэлтрэгний сарвуу туулайн хөлөнд хүрэнгүүт жинхэнэ зэрлэг догшин чоно болон хувираад шүдээ ярзайлган, хэлээрээ амаа долоолж, хортой зүү шиг хурц хоёр нүд нь гялалзаад тун аймшигтай харагдана. Амьд туулай Ян Көгийн гарт савчихад бэлтрэг хүн ноход руу ч хорсолтой харах нь хэдэн сарын турш оршоор ирсэн нөхөрлөлийн сэтгэл ор мөргүй алга болсон мэт. Одоо түүний нүдэнд Чэнь Жэнь, Ян Кө болон өөрт нь хамгаас дотно ханддаг Арслан хүртэл дайсан лугаа адил харагдаж байлаа.

Ян Кө айсандаа арагш хоёр гурван алхам ухарлаа. Тэр арай сэхээ ороод “Бэлтрэг маань өдий болтол амьд амьтан барьж идэж байгаагүй тул өнөөдөр түүний хүслийг ёсоор болговол ямар вэ гэсэн саналтай байна. Тийм болохоор би хувьдаа соустай шарсан туулайн мах идэлгүй түүнийг бэлтрэгт хаяж өгье. Өнөөдөр цугаар ойр зайнаас жинхэнэ чоно хээрийн туулайг хэрхэн барьдагийг харцгаавал ямар вэ?” гэв.

Чэнь Жэнь ч уухайн тас зөвшөөрч “Туулайн махыг сойрын махтай хамт битүү чанах л амттай байдаг юм. Энэ зун бэлтрэг маань бидэнтэй цуг манаанд гарч чонон сүргийг хавьтуулаагүй болохоор түүнийг урамшуулан шагнах нь зүйтэй” гэлээ.

Гао Зянь Жун ч гэсэн толгой дохиод “Бэлтрэг зөвхөн хонин сүрэг төдийгүй манай тугалнуудад ч их өлзийтэй байсан тул би хувьдаа дэмжиж байна” хэмээн хэлэв.

Жан Зи Юань шүлсээ гүдхийтэл залгиад дуртай дургүй “За яахав, тэгвэл цөмөөрөө манай бэлтрэг хэр зэрэг овоо чоно болсон эсэхийг харъя л даа” гэжээ.

Тэр дөрөв дор бүрнээ догдлон хөөрцгөөв. Хүмүүний сэтгэлийн гүнд нуугдаж байсан адгууслаг чанар, эртний ромын зэрлэг араатантай тулалдан цусыг нь үзэх гэсэн атгаг харгис хүсэл ийнхүү зохистой шалтгийн далбаан дор биеллээ олон тодорч ирлээ. Зэрлэг догшин чоно, бүргэд, үнэг, хярс, анч ноход зэрэг атаат дайсныхаа мөрдлөг мөшгилтөөс амь мултран ирсэн талын цовоо сэргэлэн туулайны хувь заяа Бээжингийн дөрвөн илгээлтийн эздийн хөнгөн гоомой шийдвэрээр эцэслэн шийдэгдэв. Ашгүй туулай бэлчээр сүйтгэдгээс гадна түүний үүрэнд унасан морь бүдэрч адуучид гэмтэх нь олонтой байдаг болохоор алах ялаар шийтгэсэнд сэтгэлийн дарамт арай бага байх ажээ. Тэр дөрөв адгуусны тулалдааны дүрмийг хэлэлцэв.

Тал нутагт бэлтрэг туулай хоёрыг давчуухан зайд хашаад тулалдуулчих газар үгүйд дөрвөн залуу маань жаахан гонсгор байцгаав. Эцэст нь тэр дөрөв туулайны хойд урд хоёр хөлийг тус тусад нь уяж үсэрч чадахаас биш зугатаж чадахааргүй болгоё гэж тохирчээ.

Хатуу бэрх орчин нөхцөлд нас бие гүйцсэн туулай яаж зүгээр байхав гэх шиг хөлийг нь уяж байх зуур Ян Көгийн гарыг самардан цус гоожуулж орхилоо. Газар ухахдаа гарамгай туулайн хурц сарвуу түүний гарын ар дээр хэдэн мөр гүн цусан зам татуулахад тэр өвдсөндөө дуу алдан ёолж “Айсан туулай хүн хаздаг гэсэн үг байдаг. Гэтэл бас хүн самарддаг байх нь ээ. Гайгүй дээ, чи тэгж л бай. Удахгүй манай бэлтрэг чиний арьсыг өвчөөд өгөхөө мэдэх байлгүй.” гэхэд Чэнь Жэнь ч яаран гэрт ороод хурдан цагаан эм, сэмдсэн боолт авч ирэн түүний шархыг боож өгөв.

Тэр дөрөв эрвийх дэрвийхээрээ хамжилцан зэрлэг туулайн хөлийг уялаа. Зэрлэг туулай газар хөдлөхгүй хэвтэх боловч хоёр нүдэнд нь яаж ч мэдэх зальхай харц тодорно. Жан Зи Юань туулайн сэтэрхий уруулыг дээш сөхөөд “Та нар хар даа. Шүд нь шарлачихсан хөгшин туулай байж шүү дээ. Хүн өтлөхөөр зальхай, морь өтлөхөөр зальтай, туулай өтлөхөөр бүргэдэд баригдахаа больдог гэж жолооч нар ярьдаг юм. Тийм болохоор манай бэлтрэг ч үүнийг барьж чадахгүй байж мэднэ дээ” гэлээ.

Чэнь Жэнь түүн рүү толгойгоо эргүүлэн хараад “Яахаараа хөгшин туулайг бүргэд барьж чаддаггүй билээ?” хэмээн асуув.

Жан Зи Юань өгүүлрүүн “Бүргэд агаараас шунган дайраад өрөөсөн сарвуугаар туулайны бөгсийг атгахад өвдсөндөө хөндөлсөөд өгдөг юм байна л даа. Тэр мөчид нь бүргэд нөгөө сарвуугаар туулайны нуруунаас шүүрэн бариад хөдөлгөхгүй болгодог ажээ. Бүргэд түүнийг дээш авч нисэн нэлээд өндрөөс газарт няц унагаж алдаг. Тэгээд үхсэн туулайг үүрэндээ аваачин иддэг ажээ. Харин хашир хөгшин туулай болохоор бүргэд түүний бөгснөөс зуурахад хэдий өвдөж байсан ч биеийг эргэлүүлэлгүй хамгийн ойрын бургас, харгана зэрэг рүү зүтгэн ордог юм. Нэг хашир туулай бүргэдийг чирсээр шигүү бургасан дунд гүйн ороход мөчирт савуулсан бүргэдийн өд сөд бутран үлдэхийг би өөрийн нүдээр харж л байсан. Цаад бүргэд нь мөчирт манартлаа цохиулаад туулайгаа алдаад явуулчихаж билээ. Тэгээд тулалдаад ялагдсан зодоонч азарган тахиа шиг өвсөн дунд хэсэг сууж байгаад нисээд явчихсан. . . . .” гэв.

Ян Көгийн хоёр нүд гялалзаад “Наадхийг чинь харин мэдүүшгэй юм байна шүү” гэлээ.

“Одоо туулайгаа бэлтрэгт хаяад өгчих. Нэг нь ухаантай хэрсүү хөгшин туулай, нөгөө нь гэнэн томоогүй соёо нь мохсон чонын бэлтрэг. Дээр нь бас нэг нь хөлөө уяулсан, нөгөө нь төмөр гинжтэй болохоор энэ харин их шудрага тулалдаан болох шинжтэй” гэлээ.

“Бид нар Спартак романыг уншсан шүү дээ. Ромын мэсчин боолуудын тулалдааны дэгээр бол хөгшин туулай хэрвээ ялах юм бол амь хэлтрэх эрхтэй байх ёстой” хэмээн Ян Кө хэлэв.

“Тэр ч зүйтэй шүү” хэмээн нөгөө гурав нь дэмжлээ.

Ян Кө туулай руу хандан “Хэн чамайг тийм олон нүх ухаж, бэлчээр нутаг сүйтгэ гэсэн юм бэ?” гэж амандаа бувгнаснаа бэлтрэг рүү харж “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн хашгираад туулайг чонын хүрээ рүү шидлээ. Туулай газар унангуут биеийг хөлбөрөн дороо үсрэн тонгочив. Бэлтрэг дайран ороод шууд хазаад авсангүй хөлөөрөө цохин унагахад цаадахь нь айсандаа биеийг байдгаар атиран цээж нь оволзож, хамаг бие нь дагжин чичирлээ. Гэвч туулайн хоёр нүд туйлын амгалан тайвнаар бэлтрэгний үйл хөдлөл болгоныг ажиглан харж байв. Энэ хашир туулай хичнээн олон удаа чонын соёо бүргэдийн сарвуунаас амь мултарсаныг хэн мэдэх билээ?

Туулай чичрэх явцдаа биеийг улам атируулан хураасаар зангидсан нударга шиг бөөрөнхий юм болон хувирав. Тэр бас өөрийн хурц сарвуугаа ханцуйдаа нуусан нууц зэвсэг мэт зэхэн бэлджээ.

Бэлтрэг урьд өмнө үхсэн жирх идэж байсан болохоор туулайг түүнээс өөрцгүй гэж санасан нь лавтай. Тэр шүлсээ дуслуулан дөхөж очоод үнэрлэн шиншлэв. Бэлтрэг бөмбөгөнөтөл чичрэх туулайг урд хөлөөрөө дарж шиншлэн хаанаас хазахаа шийдэж ядна.

Туулай чичрэхээ байх агшинд бэлтрэгний толгой түүний хойт хөлийн харалдаа очсон байлаа. “Болохоо байлаа шүү” хэмээн мань дөрөв хашгирсан боловч тэдний сэрэмжлүүлэг нэгэнт оройтжээ. Туулайны хамаг биедээ хураасан хүч мина адил дэлбэрч хойд хөлийн хурц хумсаараа чонын нүүрийг самардав. Бэлтрэг гавхийн хойш тийрэгдэн унаад босож ирэхэд түүний нүүр хэдэн газраа самардуулж, өрөөсөн чих нь сэт татагдаад толгой нь тэр аяараа цус болчихсон жаахан эвгүйдвэл нүдээ сохлуулж мэдэхээр байжээ.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч сэтгэл шимширсэндээ царай нь барайн босож ирцгээлээ. Ян Кө хурдан цагаан эмийн тагийг онгойлгон бэлтрэгний шархыг боож өгөхөөр завдав. Чэнь Жэнь зориггоо хөвчлөн түүнийг хориглоод “Шарх олж үзээгүй талын чоно гэж хаана байх билээ? Түүнд жаахан юм амсуулж байхад гэмгүй” гэв.

Бэлтрэг ийм айхтар хохирол амсаж байгаагүй болохоор биеийг хураагаад айсан, уурласан, бас гайхсан шинжтэй туулайг ширтэж байлаа. Хөгшин туулай санасандаа хүрсэний хойно биеийг эргүүлэн маажиж, тийчигнэхийг хослуулан чонын хүрээний гадагш зүтгэлэв. Хэдэн том ноход уурсан босож ирээд түүн рүү боргон хуцалдана. Арслан энэ бүхнийг харж тэсэлгүй чонын хүрээ рүү дайран ороод туулайг тасар татан хаях гэсэн боловч Чэнь Жэнь хориглож болиулав.

Хөгшин туулай чонын хүрээ рүү зугуухан дөхөхөд бэлтрэг ч араас нь тохой хэрийн зайтай салахгүй дагаж, туулайн хойт хөл сарваганах бүр хилэнцэт хорхойд хатгуулсан мэт арагш огло харайн үсрэх ажээ.

“Энэ удаагийн тулалдаанд хөгшин туулай ялсан биш үү? Хэрвээ хээр талд ийм юм болсон бол тэр бэлтрэгийг шархдуулж орхиод аль хэдийн арилж өгөх байсан юм. Энэ золиг хорин минутын хугацаанд нэжгээд хүн чоныг шархдуулж орхидог айхтар амьтан байжээ. Тийм болохоор түүнийг тавьчихвал яасан юм бэ? Адилхан өвсөн тэжээлт амьтан юм байна. Хэрвээ хятадууд адаглаад энэ талын хөгшин туулайны хэрийн үзэл санаатай байсан бол юу боллоо гэж бусдын хагас колони болж байх билээ дээ?” хэмээн Ян Кө хэлэв.

Чэнь Жэньгийн сэтгэл үймэрсэн байдалтай “Бэлтрэгт дахин нэг удаа боломж олгоё. Хэрвээ одоо тэр чонын хүрээнээс гараад явчихвал түүнийг ялсанд тооцъё. Харин гарч чадахгүй бол өөрсдөө учраа олцгооно биз?” гэлээ.

“За яах вэ? Тэгвэл чонын хүрээний шугамаар бүх асуудлыг шийдье” хэмээн Ян Кө зөвшөөрөв.

Хөгшин туулай амьд гарах боломж олж харсан бололтой өнхөрч тийчигнэсээр чонын хүрээний шугам руу зүтгэнэ. Өөрийн хүрээнд багтаж байсан нэгэн амьтан удахгүй түүний мэдлээс гараад явчихаж мэдэхийг үзээд бэлтрэг ч чамгүй уурлаж байгаа бололтой. Тэр зараатай тулалдаж байгаа мэт хазаж, барьж чадахгүй тонгочин тойрох боловч боломж л гарвал түүнийг чонын хүрээний дотогш цохиж түлхчихээд холдон зайлах ажээ. Харин туулай бэлтрэгийг өөрөөс нь холдох агшинд хүрээний гадагш зүтгэлнэ. Ийнхүү хэдэн удаа халз тулгарсаны эцэст бэлтрэг хөгшин туулайны эмзэг цэг юу болохыг даруй ойлгожээ. Тэр туулайн хойд хоёр хөлөөс зайлан “Үхэр чихдэх” тактик хэрэглэж, түүний хоёр чихнээс хазан дотогш чирлээ. Хөгшин туулай тийчигнэхэд бэлтрэг амаа султган тавьна. Эцэс сүүлдээ тэр туулайны айхтар хойд хоёр хөл өөрийг нь самардаж чадахгүй гэдгийг мэдээд зориг орон туулайн чихнээс зуусаар модон шонгийн дэргэд аваачив. Туулайн нүдэнд айдас тодрон эрэг дээр гарган хаясан том мөрөг загас шиг тонгочин тийчигнэсээр бэлтрэгт хазаад авах боломж эс олгох ажээ.

Чэнь Жэнь бэлтрэгт сэхээ өгөх санаатай “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн хашгирав. Энэ хаширах дуун бэлтрэгт өлсөж байгааг сануулсан тул тэр даруй өлөн чоно болон хувирчээ. Бэлтрэг ухасхийн дайрч туулайн толгойг дарж байгаад өрөөсөн чихийг араагаараа тас хазан юутай хээтэй нь залгиж орхив. Туулайн толгойноос садрах цусыг үзээд бэлтрэг улам ч улангаслаа. Тэр улам ч ховдоглон дайрч нөгөө чихийг нь таслан гэдэс рүүгээ гулгуулав. Хоёр чихээ тасдуулсан хөөрхий туулай том тарвага мэт үхэн хатан тийчигнэн тэмцэнэ. Чонын хүрээнд нүүр дүүрэн цустай бэлтрэг цус нь садран урсах хөгшин туулай хоёр үхэн хатан зууралдан тулалдав. Ингэснээр чонын хүрээ жинхэнэ утгаараа цусан шивэр татуулсан тулалдааны талбар болон хувирлаа.

Гэвч бэлтрэг эхлээд туулайг эд бад хийчихээд махыг нь идэх ухаан хараахан суугаагүй байжээ. Тэр аль тааралдсан газраасаа үмхэлж, хазлан хөгшин туулайг ан ав хийх сургуулийн амьд бай болгов. Бэлтрэгний соёо хэдийгээр мохоо боловч бахь мэт хүчтэй хэвээр тул туулайны арьсыг хүрсэн газар болгондоо хүү хүү татна. Тэр хэдийгээр туулайн амин газар болон хүзүүг мэдэхгүй боловч өөр нэгэн эмзэг цэг гэдэс рүү нь дайрчээ. Хөөрхий хөгшин

туулай бэлтрэгт гэдсээ хүүлүүлэн чонын хамгийн дуртай зоог болох дотор эрхтэн бүлтрэн гарч ирэв. Бэлтрэгний нүд гялалзан гэдэс дотор, элэг уушиг зэргийг үмхлэхэд хөгшин туулай зүрхээ сугартал амь тэмцэн тэлчилсээр байж билээ.

Чэнь Жэнь ийнхүү бэлтрэгт жинхэнэ чоно мэт амьдрах боломж олгож чадсан юм. Бэлтрэг нь ч нүүр нүдээ самардуулан “Жинхэнэ чонын сэтэрхий чихтэй” болоод зогссонгүй амьд амьтан барьж чаддаг талын чоно болон хувирлаа. Хэдийгээр түүний бэлтрэг ялсан боловч тэр хөгшин туулайг өрөвдөн гашуудаж сэтгэл нь хямарна. Тэр эцсээ хүртэл тэмцсээр үхсэн хөгшин туулайг бахдан бишрэхээс аргагүй. Тэр хэдийгээр өөртэйгээ адилхан эрэлхэг зоригтой талын залуу чононд алагдан идүүлсэн боловч үзэл санааны хувьд түүнд огтхон ч ялагдаагүй билээ. Монгол талын хониноос бусад өвсөн тэжээлт болон махчин зэрэг бүхий л амьтад газар эхийн хайрласан туйлбартай зоримог үзэл санаатай байдгийг ганц үгээр “Нүүдэлчдийн үзэл санаа” хэмээн нэрлэж болох юм.

Хонин сүрэг өөрсдөө хотлов. Чэнь Жэнь, Ян Кө хоёр энэ орой бэлтрэгийг салхилуулсангүй. Бэлтрэг өнөө орой маш их догдлон баярласан болохоор өдөр болгон олддог богинохон эрх чөлөөтэй хугацааг ч умартаж орхижээ.

\* \* \*

Тэр дөрөв хэр барагтай бол бөөндөө цугларан хоол идэх боломж олддоггүй болохоор монгол гэрт ер бусын халуун дулаан уур амьсгал бүрэлджээ. Чэнь Жэнь Жан Зи Юаньд цай аягалангаа “Чи бидэнд тэр хөгшин туулайг хэрхэн барьсанаа яриагүй байгаа шүү дээ” гэж хэлэв.

Жан Зи Юань ч талын адуучид шиг өөрийгөө үнэд оруулах дуртай болсон тул жаахан дүлэгнэж байснаа “Тэр туулайг үнэндээ чоно бидэнд бэлэглэсэн юм” гэлээ.

Нөгөө гурав нь ч чамгүй гайхаж хоцров. Жан Зи Юань хэсэг зуур дуугаа хурааж байгаад Бат бид хоёр адуугаа хайсаар нэг довцгийг тойртол нэг чоно бөгсөө оцойлгочихсон газар ухаж байдаг байна шүү. Бид хоёр ч хурдан морьтой явсан тул ташуураа эргүүлээд орж явчихлаа. Чоно ч яахав довцгийг өгсөөд алга болж өгсөн. Харин бид хоёр түүний ухсан нүхэн дээр ирж үзвэл баахан шороо ил гарган хаяжээ. Шинэ шороо ил гарган хаяагүй бол тэр нүхийг олохын эцэсгүй далд газар байрласан байлаа. Бат түүнийг харангуутаа туулайн түр оромж байна гэж таньсан юм. Манай хятадын хэлц үгэнд “Хашир туулай гурван үүртэй” гэдэг шүү дээ. Гэтэл талын туулайнууд түүнээс ч олон түр оромж нүхтэй болохоор дайсан халдаад ирэх үед хамгийн ойр байсан руу ухасхийн ордог ажээ. Тийм түр орогнох нүхнүүдэд морь унаа бүдрэх нь их байдаг болохоор адуучид хамгаас үзэн яддаг юм. Өнгөрсөн жил Лхамжавын хайртай хурдан хөлөг туулайн үүрэнд бүдрээд доголлон болсон. Бид хоёр ч тэр туулайн үүрийг хараад уурандаа үсрэн бууцгааж ухан гаргаж алахаар шийдсэн юм. Метр гаруй гүн тэр туулайн үүр рүү уурганы бөгсөөр ёворч үзэхэд зөөлөн байсан нь амьд туулай байгааг батлаж байлаа. Чоно ч газар ухагдаа сайн болохоор тэр туулайг ухаад гаргачих байсан байх л даа. Харин чоно яваад өгсөн болохоор бид хоёр яадаг билээ? Бат гэтэл надад нэг арга байгаа гэчихээд уурганы нарийн ишийг салган үзүүрийг нь хутгаар ялимгүй зүсэж ангайлгаад түүн рүүгээ хэсэг бүдүүн ширхэгтэй өвс хавчуулан сэрээ хэлбэртэй болгов. Түүнийгээ туулайн үүр рүү шургуулан биед нь хүргээд эргүүлэхэд өвс үс хоёр барьцалдан мушгирсаар арьсыг нь хүртэл

таган эрчлээд хөдлөхөө байхад Бат ганц шуд татаад туулайг гаргаж ирсэн юм даа. Туулайн толгой цухуйхад би чихнээс нь барьж авсан” хэмээн ярьлаа.

“Үнэхээр гайхалтай арга байжээ” хэмээн нөгөө гурав нь дуу алдацгаав.

“Би дээхэн нэг туулайг үүр рүү нь оруулаад алдчихсан юм. Харин одоо түүнийг яаж гаргах аргаа оллоо. Малчид тариаланч үндэстнээс илүү ухаалаг сийрэг гэж та нарын ярьдаг яахын аргагүй үнэн юм байна. Хүний эрхэлж байгаа ажил үйл нь тухайн эзнээ хэн болохыг тодорхойлдог ажээ. Манай хятадууд өвөр зуураа тэмцэлдэхээр хэнээс ч илүү атлаа гадагшаа дайтахаар болохоо байчихдаг нь ямар учиртай юм бол оо гэж би урьд нь гайхдаг байсан юм. Ийм олон хүн амтай, өргөн уудам газар нутагтай хятад улс давжаа жаахан япончуудад найман жил эзлүүлсэн гэж байгаа. Хэрвээ Зөвлөлт улс цэрэг гаргаж туслаагүй бол, Америк атомын бөмбөгөө тэдэн дээр хаяагүй бол дахин хэдэн жил ч дарлуулах байсныг бүү мэд дээ. Гэтэл нөгөө ялагдсан япончууд чинь хэдхэн жилийн хугацаанд эдийн засгийн хүчирхэг гүрэн болсон гэж дуулдана лээ. Далайн өчүүхэн чоно японы үндэстний зан чанар үнэхээр мундаг байгаа юм шүү” гэж Гао Зянь Жун хэлэв.

Нөгөө гурав нь түүнийг сонсоод зэрэг инээлдлээ. Жан Зи Юань Чэнь Жэньд хандан өгүүлрүүн “Алтны дэргэд байсан гууль шарлана гэж мөн үнэн үг юм даа. Гао Зянь Жун хүртэл чиний үзэл бодолд бүр автчихсан байна шүү дээ” гэв.

Тэр дөрөв ширээ тойрон суугаад шар будааны шөл, мөөгтэй жигнэсэн үхрийн махыг даршилсан жууцайтай хольж идэцгээлээ.

“Чи биднийг бодвол хол ойр явдаг хүн барилгын цэргийн нэгтгэлийн талаар ямар мэдээтэй ирэв дээ?” хэмээн Ян Кө Жан Зи Юаниас асуулаа.

“Манай аж ахуйн төв тэдний штаб болон хувираад хятад монгол цэргийн дарга нар хөлхөлдөх болсон байна лээ. Тэдний хамгийн эн тэргүүний зорилго чоно устгах юм гэнэ ээ. Тэр дарга нар өч төчнөөн унага даага чононд бариулсаныг үзээд маш их уурсчээ. Армийн анги нэгтгэлүүд тал нутагт ирээд дээрэмчдийг устгасан бол одоогийн зорилт нь хамгийн шилдэг хүн хүчээрээ чоно устгаж малчдад буян болох ёстой гэж тэд үзэж байгаа юм байна. Тэдний сайхан сэтгэлийн хариуд өвгөд хөгшид л хэлэх үгээ олж ядаж байх шиг байна лээ. Тариачин гаралтай цэргийн дарга нарт чонын ашиг тусыг ярих нь илжигний чихэнд ус хийхээс ямар ялгаа байх билээ? Тэгээд чонын арьс үс хөрсжиж гүйцсэн болохоор овоо үнэ хүрч байгаа. Барилгын цэргийн нэгтгэлийн дарга нар цалин цаваг багатай. Штабын дарга, туслахууд нь л гэхэд сардаа жар далан юаний цалинтай байхад ганц чонын арьс хорин юань хүрнэ шүү дээ. Дээр нь бас урамшуулалтай болохоор тэд ч алгаа үрэн чонын авд гарахаар зэхэж байгаа бололтой.” хэмээн Жан Зи Юань ярьлаа.

“Монгол талын чонын баатарлаг замнал ингээд дуусгавар болдог байжээ. Тэд хурдхан гадаад монгол руу дүрвэн дайжаасай билээ” хэмээн Ян Кө хэлээд санаа алдав.



*Ли Юань41 язгууртан гаралтай. . . .Эх нь Сяньбигийн язгууртан Дү Синь Гүйгийн охин болой. Сюй Улсын Вэн Ди хааны хатан лугаа үеэл эгч дүүс болмуу.*

*Жан Цуань Си*

*“Хятадын эртний түүхийн товчоон”*

Өглөөгүүр хоёр цэргийн зориулалттай задгай машин Чэнь Жэньгийн гэрээс холгүйхэн ирж зогсов. Бэлтрэг урьд өмнө үзэж харж байгаагүй хоёр том зүйл болон бензиний үнэрээс жийрхэн үүр рүүгээ шурган орлоо. Том жижиг ноход жийп машиныг тойрон хуцалдана. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч яаран гэрээс гарч нохдоо хөөж холдуулав.

Машины хаалга онгойход Бао Шүнь Гүй дөрвөн жавхалзсан цэргийн дарга нартай цуг буугаад чонын хүрээг чиглэн явлаа. Чэнь Жэнь, Ян Кө болон Гао Зянь Жун нар чухам юу болохыг эс мэдэх тул яаран сандран араас нь дагацгаав. Чэнь Жэнь жаахан уужуухан хандахаар шийдэж эхлээд амар мэндийг мэдээд “Бао дарга хүмүүст чоно үзүүлэх гэж байгаа юм уу?” хэмээн асуув.

Бао Шүнь Гүй инээмсэглээд “Алив би та нарыг танилцуулаадахья.” хэмээн гараа алдлаж гуч эргэм насны хоёр цэргийн даргыг зааж өгүүлрүүн “Энэ хоёр бол барилгын цэргийн нэгтгэлээс манай аж ахуйд томилон ирүүлсэн Сюй зөвлөгч, Баатар зөвлөгч нар байгаа юм” гэснээ мөн Лю, Ван овогт хоёр жолоочийг ч танилцуулахаа мартсангүй. Тэр цааш нь “Тэд манай энд суурьшиж байшин саваа барьсаны дараа гэр орныхноо татаж авчрах юм. Харин энэ удаа барилгын цэргийн нэгтгэлээс тэднийг манай баг руу чоно авлуулахад тусла гэж илгээжээ” гэв.

Чэнь Жэньгийн зүрх амь зулбан зугатах чонынхоос өөрцгүй булгилан цохилно. Тэр цэргийн хүмүүстэй гар барин мэндлээд малчдын заншил ёсоор гэрт орж цай уухыг урьлаа.

“Хэрэггүй дээ. Чи харин бэлтрэгээ дуудаад гаргаж ир. Манай хоёр офицер чоно харах гэж ирсэн юм” гэж Бао Шүнь Гүй хэлэв.

Чэнь Жэнь муухан инээмэр аядаад “Та нар чононд тийм сонирхолтой юм уу?” хэмээн асуулаа.

Шаньси аялгатай ярьдаг Сюй зөвлөх их л эелдгээр “Эндхийн чоно дэндүү гаараад байгаа тул дивиз хороон дарга нар тэднийг авла гэж тушаасан юм. Өчигдөр Ли хорооны дэд захирагч өөрийн биеэр багуудаар явж үзэхээр хөдлөсөн. Бид хоёр өөрсдөө талын чоно ямархуу байдгийг үзээгүй болохоор Бао Шүнь Гүй гуай наашаа авчирлаа л даа” гэж хэлэв.

“Бао Шүнь Гүй гуайн ярьснаар бол та хэд чонын тухай их судалгаатай. Бэлтрэг суйлахдаа их гаршсан улс юм гэх шив. Түүгээр ч зогсохгүй чонын араншинг судлахын тулд бэлтрэг тэжээж эхлэсэн нь мөн айхтар зоригтой хэрэг болжээ. Тийм болохоор бид чоно авлахдаа та бүхний туслалцааг авах хэрэг байна” гэж зүүн хойд нутгийн аялгатай Баатар зөвлөх хэллээ.

Хоёр зөвлөх албархуу төрхгүй их л аятайхан хүмүүс ажээ. Тэд бэлтрэгийг нь алах гэж ирээгүйг сонсоод түүний санаа жаахан уужраад явчихлаа. “Чо . . . Чоно. . . Чонын тухай хэдэн өдөр шөнө ч яриад дуусахгүй байж мэднэ. Тийм болохоор цөмөөрөө бэлтрэгийг очиж үзэцгээе дээ. Та хэд харин арагш жаахан ухарч бай. Чонын хүрээ рүү дөхөж болохгүй шүү. Танихгүй хүнийг ураг гээд байдаг юм. Дээхэн аймгаас ирсэн нэг төлөөлөгч хариугүй уруулах шахсан шүү” хэмээн ээрч түгдрэн өгүүлэв.

Чэнь Жэнь гэрээс хоёр хэсэг чанасан махыг хуучин ширээний тавцантай барьж ирээд чонын үүрний хажууд тавив. Дараа нь чанга дуугаар “Бэлтрэг ээ, хоолондоо” хэмээн чанга дуугаар дуудлаа.

Бэлтрэг үүрнээсээ ухасхийн гарч ирээд чанасан махыг шүүрэн авчээ. Тэр хооронд Чэнь Жэнь ширээний тавцанг нүхний аман дээр орхиод өөрөө даруйхан холдлоо. Урьд өмнө чоныг үдээс өмнө буюу хойно хооллодог байсан юм. Бэлтрэг ийм эрт хоол өгөхийг үзээд тэсгэлгүй баярлан гарч ирээд ястай махыг ховдоглон үмхлээ. Бао Шүнь Гүй болон цэргийн хүмүүс бүгд хойшоо яаран ухарцгаав.

Чэнь Жэньгийн заавраар бүгд чонын хүрээнээс метр шахам зайд ойртон хүрээлэн сууцгаав. Ийм олон цэргийн хувцастай танихгүй хүмүүсийг үзээд бэлтрэг хазах гэж ухалзан дайрсангүй харин ч сүүлээ хавчин хулмаганасаар нэг махыг зуун чонын хүрээний нөгөө захад аваачин тавиад эргэн ирж үлдсэнийг зуун одов. Тийм олон хүн түүний хоол идэхийг харж байгаад дургүйцсэн бололтой сэрвээнийхээ үсийг босгон хурдан хурдан зажлана. Тэр хоёр үмх мах залгисны дараа гэнэт шүдээ ярзайлган цэргийн хүмүүс рүү ухасхийн дайрлаа. Гэнэт цочмог ширүүн дайрсан тул тэгнэ гэж бодоогүй цэргийн хүмүүсийн гурав нь айсандаа лагхийтэл бөгсөөрөө газар суучихав. Бэлтрэг шүдээ ярзайлган төмөр гинжийг харжигнуулан тэдэн рүү метр орчмын зайнаас дайрна.

Баатар зөвлөх завилан суугаад гартаа наалдсан шороог гөвж “Мөн айхтар амьтан юм гээч. Цэргийн ангийн овчарк нохойноос илүү догшин юм байна. Хэрвээ гинжлээгүй байсан бол хазуулах байлаа шүү” гэв.

“Энэ хавар гарсан бэлтрэг гэхэд овчарк нохойноос өөрцгүй томорчээ. Бао дарга биднийг өнөөдөр наашаа авчирдаг нь тун сайн хэрэг боллоо. Жинхэнэ ангийн талбар дээр очсоноос өөрцгүй санагдаж байна шүү” гэснээ Сюй овогт Баатар зөвлөхөд хандан “Чонын үйл хөдлөл нохойныхоос хурдан шалмаг тул буудахдаа анхаарах хэрэгтэй юм байна шүү” гэлээ.

Баатар зөвлөх толгой дохин зөвшөөрөв. Бэлтрэг эргэн хараад хааяа нэг архирсан шиг хоолоо иднэ.

Хоёр зөвлөх холоос бэлтрэгний толгой их биеийн харьцааг хэмжиж, чонын арьсыг сонжино. Тэд чонын хажуу талаас дал хавсран буудвал аминд нь хүрэхийн зэрэгцээ арьсыг нь гэмтээхгүй юм байна гэж тогтжээ.

Тэр хоёр мэргэжлийн үүднээс ийм дүгнэлт гаргасанд Бао Шүнь Гүйгийн царайд туяа гийж “Бүх малчид болон олонх илгээлтийн эзэд бүгд чоно тэжээлгэхгүй гээд байсныг би ганцаараа сөрж зөвшөөрөл өгсөн юм. Дайснаа өөрөөсөө дутуугүй мэдэж байж сая ялалт байгуулна биз

дээ? Энэ зун би хэдэн ч удаа дарга нарыг наашаа авчирч чоно үзүүлэв дээ байз. Тэр тусмаа чононоос айдаг хятад хүмүүс илүү их үзэх дуртай байх юм гээч. Тэд бүр амьтны хүрээлэнгийн чононоос ч илүү сүрлэг юм. Монголын талд ийм ойрхон зайнаас жинхэнэ чоно үзнэ гэдэг ховор завшаан, өвөрмонголд өөр ийм тохиолдол байхгүй байх гэлцэж байдаг шүү. Цаашдаа барилгын цэргийн нэгтгэлийн дарга нар наашаа ирэхэд би тэдэнд энэ чоныг үзүүлье байз” гэж ярина.

Дарга нар ч энэ тухай дуулах юм бол наашаа ирж үзэж таарна л даа гэснээ Сюй зөвлөх Чэнь Жэньд хандан “Гинж шонг байнга шалгаж байгаарай” гэв.

Бао Шүнь Гүй бугуйн цаг руугаа хяламхийн харсанаа “Бид хар өглөөгүүр шахам танайхыг зорьж ирдэг нь бэлтрэгийг чинь үзэхээс гадна танайхаас нэг хүн дагуулж чоно авлахаар явах санаатай юм. Энэ хоёр зөвлөх морин цэрэгт байсан мэргэн буудагч нар л даа. Барилгын цэргийн нэгтгэлийн дарга нар чонын хөнөөлийг даруулах гэж наашаа томилон ирүүлжээ. Өчигдөр Сюй зөвлөх тэнгэрт вандуйн чинээхэн харагдах бүргэдийг ганц сумаар буудаж унагаж байдаг шүү. . . . Тэгэхээр та хоёрын хэн чинь бидэнтэй явах вэ?” гэлээ.

“Олонбулгийн талын чонон сүрэг баларч гүйцэх нь л дээ. Хурдан жийп хөлөглөсөн мэргэн буудагч нараас гадна үй олон хүмүүс энд суурьшихаар ирвэл тэдэнд хил даван одохоос өөр ямар гарц байх билээ?” гэж Чэнь Жэнь сэтгэл сэрхийн бодох зуур дургүйлхсэн өнгөөр “Адуучид биднийг бодвол чоно хаана байгааг андахгүй мэдэж таарна. Тэднээр хөтөч болговол дээр дээ” гэв.

“Настай нь болохоор хөдлөж өгөхгүй, залуучууд нь ямар ч нэмэр байх билээ. Харин туршлагатай адуучид бүгд уул бараадан явсан болохоор бидэнд олдохгүй. Хоёр зөвлөх наашаа зорьж ирсэн болохоор та хоёрын нэг нь л бидэнтэй заавал явна даа. Дараа дахин та нарт төвөг удахгүй” гэж Бао Шүнь Гүй шавдуулав.

“Та багийн ганц урдаа барьдаг анчин Доржийг авч явахад яагаад болдоггүй билээ?” хэмээн Чэнь Жэнь хэллээ.

“Доржийг Ли хорооны дэд дарга аваад явчихжээ. Ли дарга өөрөө ч ангийн их хорхойтой хүн юм байна. Зөвлөлтийн “Газ” маркийн ачааны машины тэвшин дээрээс чонын толгой алдалгүй бууддаг гэнэ” гээд Бао Шүнь Гүй цагаа харсанаа “Битгий цаг үрээд бай. Шалавхан хөдөлцгөөе” гэлээ.

Чэнь Жэнь Ян Көд тэр үүргийг ацаглачих санаатай “Чи яваад ирэхгүй юу?” гэв.

“Би чамайг яаж гүйцэх билээ? Чи явсан нь дээр” гэж Ян Кө цааргалав.

Бао Шүнь Гүй байж ядсан байдалтай “Чэнь Жэнь чи л яв. Битгий харин заль мэх хэрэглэх гээд байгаарай. Хэрвээ Билиг өвгөн шиг чоныг тавьж явуулаад ганзага хоосон ирэх юм бол чиний бэлтрэгийг тонилгоно гэж мэдээрэй. Хурдан явцгаая” гэлээ.

Чэнь Жэньгийн царай зэвхийрэн бэлтрэгний урдуур зөнгөөрөө халхлаад “Би явъя аа. Одоохон явъя” гэлээ.

Хоёр задгай жийп машин баруун зүг тоос манаруулан давхина.

Намрын эхэн сарын нарны туяанд Чэнь Жэньгийн нүд гялбана. Тэр жолоочийн хажуугийн суудалд суусан болохоор салхины хүчтэй сэвшээнд малгай нь хийсэн алдах ажээ. Тэр хурдан агтын нуруун дээр ч ийм хүчтэй салхи сөрөн давхиж байгаагүй санагдав. Хоёр шинэвтэр жийп хурд хүч сайтай моторын дуу бараг сонсогдохгүй шахам давхина. Олон жил цэргийн ангид жолоо мушгиж, тал хээрийн нөхцөлд цөөнгүй цэргийн сургуульд оролцож байсан туршлагатай жолооч нар хөдөөгийн овон товонтой замд донсолгоо гарган хурдлан давхина.

Чэнь Жэнь сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд жийп машинд сууж үзээгүй юм. Хэрвээ тэр энэ нутагт дөнгөж ирээд, чоноор өвчлөөгүй байсансан бол, хэрвээ тэр талын чоноор хоёр жилийн турш хичээл заалган цусаа сэлбээгүйсэн бол энэхүү орчин үеийн аргаар чоно авлах боломж тохиолдсонд баярлаад барахгүй байсан буй за. Ногоон талын дундуур задгай жийпэнд суучихаад монгол талын чоныг салхи исгэрүүлэн хөөж явах гэдэг эр хүний хувьд бас л нэг бахархал бус уу? Энэ нь английн язгууртнууд эвэр бүрээгээ дуугарган морь уначихаад сүрэг нохдоо дагуулан үнэгчлэх, аль эсвэл оросын тайж нар ойн цасыг туучин баавгай ангуучлах, монгол манжийн ноёдууд түмэн морьтонг дагуулан ав хомрого хийдгээс ч илүү зугаатай хэрэг л дээ. Харин энэ мөчид Чэнь Жэнь дайсны цэргийг дагуулсан урвагч этгээд анд нөхрөө барихаар явж байгаагаас өөрцгүй санагдах тул унасан унаа нь эвдрээд зогсчихоосой гэж үнэн голоосоо хүсэж явлаа. Тийм болохоор өнөөдөр тэр том чононуудыг зугатаалгахын зэрэгцээ бэлтрэгнийхээ амийг хэрхэн авч үлдэхээ үнэхээр мэдэхээ байж орхижээ.

Барилгын цэргийн нэгтгэлийн чоно устгах хөдөлгөөн өргөн талын энгээр нэгэнт сүр дуулиантай эхэлжээ. Хүннү, Сяньби болон Чингис хааны үеийн стратеги, тактикийн чулуужмал хэв болон балар эртний зохион байгуулалтаа ягштал хадгалж чадсан чонон сүргийн арми орчин үеийн цэрэг ангийн бүслэлтэнд орж устах цаг ийнхүү нүүрлэн ирэв. Гэвч тэдний үнэлж баршгүй гавьяа болон нөлөөг үгүйсгэн, муу нэр луу дансыг зүүлгээд, тэдний ашиг тусыг хангалттай хүртсэн хятад хүмүүс өөрсдөө улсынхаа хилээр хөөн гаргаж түүхийн тавцангаас арчиж хаяхаар шийдсэн нь энэ юм. Чэнь Жэньгийн энэхүү эмгэнэл шаналлыг зөвхөн Билиг аав, чонон сүлдийг дээдэлдэг талын хүмүүс болон тоонот гэрт толгой холбож байгаа хоёр нөхөр нь ойлгож байгаа. Түүний энэхүү харуусал шаналал нэгэн бодлын түүнээс дэндүү ахадсан, нөгөө талаар дэндүү эрт балрын хэрэг билээ.

Олонбулгийн талд салхины чиглэл тогтворгүй болохоор нар хур ээлжлэн солбицож байдаг онцлогтой. Цэргийн жийп машин чийгтэй элсэрхэг замаар салхи татуулан хурдлахад Чэнь Жэньгийн сэтгэл сэргээд ирэв. Тэр энэ хүмүүст чоно амархан нуугдаж болох газар барааг нь харуулья гэж шийджээ.

Тэр Бао Шүнь Гүй руу эргэн хараад “Миний мэдэх чонотой газар дов сондуул зэгс ихтэй тул жийп машин явж өгөхгүй байх аа даа” гэж хэлэв.

“Чи битгий золигтоод байгаарай даа, хө. Одоо зэгс ихтэй газар л шумуул үүрлэх болохоор чоно яалаа гэж тэнд үүрлэх билээ? Би чинь хагас жил чонотой хөөцөлдөж байгаа хүн тэр

зэргийн юмыг мэдэх байх шүү” гээд Бао Шүнь Гүй нүдээ бүлтийлгэн өгүүлэв.

Чэнь Жэнь дууны өнгөө өөрчлөөд “Би зэгстэй газраар явалгүй элсэрхэг, хэвгйдүү газар очвол ямар вэ гэх гэсэн юм л даа” гэж хэллээ.

“Элсэрхэг талд осол гарснаас хойш адуучид тэр хавийн чоныг үлдэн хөөсөн байна лээ. Бид хэд өчигдөр тэрүүгээр баахан яваад ганц чонын бараа хараагүй. Чи өнөөдөр нэг л дургүйд хүчгүй гэгч болоод байна аа даа. Гэхдээ миний хэлсэн үгэндээ хүрдгийг мэдэж байгаа биз дээ? Бид хэд өчигдрөөс хойш ганзага хоосон яваа болохоор их ууртай байгаа шүү” хэмээн Бао Шүнь Гүй Чэнь Жэньг шахамдууллаа.

Тэр тамхиа гүн сороод утааг нь Чэнь Жэньгийн ар дагз руу үлээв.

Чэнь Жэнь бүр анхан шатнаас өдий зэрэгт хүртэл дэвшсэн түүнийг амархан хуурч дөнгөхгүйгээ мэдээд “Цагаан уулын баруун хойд биеэр өөр нэгэн элсэрхэг газар чоно элбэгтэй гэдгийг би мэднэ ээ. Тэнд өвс бага, элсэрхэг тул оготно, тарвага, зурам элбэг байдаг юм. Чоно унага барьж чадахаа байсан тул өдийд лав тэднийг гоочлохоор очсон байж таарна” гэлээ.

Чэнь Жэнь тэднийг нутгийн хамгийн баруун хойд хэсэгт байдаг элсэрхэг талд аваачья гэж шийджээ. Тэнд хэдийгээр шумуул, хөх түрүү багатай ёстой л адууны бэлчээр боловч хилийн дээснээс ойрхон тул адуучид тийш зүглэж зүрхэлдэггүй юм. Чэнь Жэнь тэнд чонын барааг харуулах боловч чонон сүрэг хилийн хамгаалалтын зурвас даван зугатахад амар гэж бодсон санж.

Бао Шүнь Гүй жаахан бодол болж байснаа инээд алдаад “Нээрэн тэнд чинь чоно элбэг байдаг байх шүү. Би яахаараа түүнийг боддоггүй билээ? Лю жолооч оо, арын замыг бариад ширүүхэн давхиарай. Өнөөдөр өөр газар очихоо больё” гэжээ.

“Чоно агнахад явган байсан нь дээр байдаг юм. Тэд машины дуунаас үргэн нугын өвс рүү орчих юм бол харагдахаа байна. Ядаж өнөө жил бороо хур элбэг болохоор өвс өндөр ургасан” гэлээ.

“Чи өнөөдөр надад чонын бараа харуулаадах юм бол цаашид яахыг би өөрөө мэдье” гэж Сюй зөвлөх хэлэв.

Чэнь Жэнь өөрөө том алдаа хийснээ ухаарлаа.

Цэргийн жийп машин малчдын дөрвөн улирлын турш нутаг сэлгэн нүүдэг шороон замыг даган умард зүг давхив. Хоёр тохой гаруй өндөр ургасан намрын өвс халиуран найгаж, бэлчээрийн үнэр хамар цоргиход хэдэн хараацай жийпний чимээгээр үргэн ниссэн царцааг хөөж барих үзэгдэнэ.

Чэнь Жэнь намрын өвс цэцэгсийн үнэр шингэсэн агаарыг цээж дүүрэн амьсгалав. Ирэх жил энэ хавьд хаваржих болохоор тэр хоньчин хүний хувиар өвсний гарцыг шинжин явлаа. Аж ахуйн нийт орлогын далан хувийг хонины ноос болон амьд хонь зарснаас олдог тул хаваржаа

гэдэг бэлчээр нутгийн амин сүнс байдаг билээ. Энэ хавийн өвс харуул хамгаалалттай тариан талбай мэт халиурахыг Чэнь Жэнь бахдан харж явав. Багийн нийт малчид шинэ нутагт бууснаас хойш энд ганц ч монгол гэр нүүж ирээгүй юм. Хэрвээ чонон сүрэг байгаагүй бол энэ сайхан нутаг бэлчээрийн өвс зээр, тарвага, зурманд сүйтгэгдэн үлдэх байсан билээ. Тийм болохоор Чэнь Жэнь дотроо чоно болон адуучдад талархаж явлаа. Бүхэл зуны турш талын чоно өвс хадлангийн дайснуудад боломж олгоогүй ажээ.

Энэ сахлаг өвстэй бэлчээрийн цаана адуучдын нөр их хөдөлмөр зүтгэл нуугдаж байгаа. Учир нь тэд адуун сүргээ уулархаг нутагт адгуулах буюу үхэр хонин сүргийн талхлаад өнгөрсөн бэлчээрт байлгасны хүчинд хаваржаа орчмын нутаг ийм сайхнаараа байгаа юм. Морин дэл дээрх үндэстэн адуугаа амь мэт хайрладаг хэрнээ адгуулж өсгөх үедээ тэднээс нутаг бэлчээрээ гар татан харамладаг. Хэрвээ адуучид байгаагүй бол энэ хавийн нутаг бөөн бөөн хомоол болон адууны шээсэнд түлэгдэж шарласан өвсөөр дүүрэх байсан буй за. Гэвч тариачин гаралтай цэргийн нэгтгэлийн удирдлага яахин тал нутгийн зүй тогтол болон мал аж ахуйн нууцыг ойлгох билээ дээ?

Жийп машин салхи татуулан давхих боловч улбар тоос татуулахаа больжээ. Бүтэн зуны турш тэрэгний мөр гараагүй шороон зам дээгүүр тачир өвс ургасан аж. Нүүдлийн мал аж ахуй гэдэг нь байнгын нүүдэл сэлгээгээр тал нутгийн хүүхдийн зулай шиг нимгэн хөрсийг амсхийлгэхийн зэрэгцээ үхэр хонины өтөг, шингэнээр үргэлж бордож байхын нэр юм. Хэдэн зуу мянган жилийн турш тал нутгийн нүүдэлчид чухам л энэхүү балар эртний хэрнээ хамгийн шинжлэх ухаанч үйлдвэрлэлийн аргаар тал нутгаа өдий зэрэгтэй авч иржээ. Чэнь Жэнь ийн бодох зуур тэсгэлгүй Сюй зөвлөхөд хандан “Та энэ нутаг бэлчээрийг хичнээн сайхан хамгаалж чадсаныг харж байна уу? Энэ хавар манай багийн малчид мал төллүүлэхээр ирэх үед гадаад монголоос ирсэн хэдэн түмэн зээр энд ирж хонь малтай бэлчээр булаацалдан буу зэвсгээр хөөж туугаад ч явахгүй шөнөдөө эргэж ирээд байж билээ? Гэтэл чонон сүрэг тэдэн рүү дайраад хэд ч хонуулалгүй ул мөргүй хөөн одсон юм даа. Тийм болохоор тал нутагт чоногүй болчихвол мал идэх өвсгүй, тэр хэрээр хэдэн мянган төл мал уух сүүгүй харангадаж үхэх болно. Мал аж ахуй гэдэг газар тариалантай адилгүй. Газар тариаланд ган гачиг тохиолдвол сайндаа ганц жилийн ургац алдана. Харин мал аж ахуйн буруу үйл ажиллагааны гамшиг хэдэн арван жилээр ч гарз хохирол дагуулж мэдэх уршигтай юм шүү” гэж хэлэв.

Сюй зөвлөх толгой дохингоо бүргэдийн хурц хараагаар өмнөө байгаа бэлчээрийг ажиглан харлаа. Тэр хэсэг зуур дуугүй байснаа “Зээрийг чоноор агнуулна гэдэг дэндүү хоцрогдсон хэрэг байна даа. Малчдын буу гэж ямар олигтой эд байв гэж дээ? Дээр нь машин тэрэг ч байхгүй. Ирэх жил та нар харж байгаарай. Бид машин тэрэг, автомат, пулемёт буутай ирээд хэдэн түмэн зээр байсан ч агнаад өгөмз. Би өвөрмонголын баруун нутагт байхдаа шөнө машинаар зээр агнадаг байсан юм. Зээр чинь харанхуйгаас айдаг амьтан болохоор машины гэрэлд давхин орж ирээд шүршүүлээд байдаг. Тийм болохоор бид өдөртөө хэдэн зуугаар нь агнадаг байж билээ. Энд зээр их байдаг юм бол тун сайн хэрэг байна. Дивиз болон хөдөө аж ахуйн бригадын хэрэгцээнд нийлүүлж болох тул олон тусмаа сайн шүү” гэлээ.

“Харав уу?” гээд Бао Шүнь Гүй зүүн зүг рүү зааж зөөлхөн хашгирав. Чэнь Жэнь дурангаа авч харсанаа “Нэг том үнэг байна. Хөөцгөөе” гэхэд Бао Шүнь Гүй их л урам хугарсан байдалтай буугаа шагайж эхэлсэн Сюй зөвлөх рүү хараад “Үнэг юм бол хөөгөөд яах вэ? Битгий бууд.

Чонын чих их соргог тул үргээд алга болчихно” гэв.

Сюй зөвлөх буудахаа болиод нүүрэнд нь баясал тодорч “Өнөөдөр ч овоо азтай байна шүү. Үнэгтэй тааралдана гэдэг чинь чоно байгаа гэсэн үг” гэж хэлэв.

Жийп машин элсэрхэг талд дөхөн ирэхэд зам зуур тохиолдох ан амьтад улам олшроод ирлээ. Чэнь Жэнь зугуухан өөдлөх өгсүүрийг зааж “Энэ хөтлийг давчихвал элсэрхэг тал эхлэдэг юм. Хөгшчүүлийн ярихаар бол тэр элсэрхэг тал уг нь их үржил шим сайтай, арвин ус бүхий булагтай бэлчээр байсан гэдэг. Гэтэл хэдэн арван жилийн өмнө жил дараалан ган гачиг тохиож гол нуур хатаж ширгэсэн боловч тэр булаг л устай хэвээр байжээ. Олонбулгийн талын хамаг мал сүрэг энд хуран цугларч булгийн усыг ууж өвсийг идэж талхалсаар хэдэн жилийн дараа гэхэд ийм янзтай болгосон байна. Азаар тэр булаг хатаж ширгээгүй үлджээ. Гэвч хуучин төрхөө олтол дахин хэдэн арван жил хэрэгтэй байж таарна. Талын амь эмзэг болохоор бэлчээрийн даац хэтрэнгүүт л цөлжих гээд байдаг гэмтэй” хэмээн ярьлаа.

Бөөн бөөн үлийн цагаан оготно машины өмнүүр гүйлдэн өнгөрнө. Чэнь Жэнь тэднийг заагаад “Бэлчээрийн даац гэдэгт энэ хулганууд ч мөн хамаарна. Харин чоно бэлчээрийн даацыг тэнцүүлэхэд хамгийн чухал үүрэгтэй байдаг юм даа. Та нар удахгүй нэг чоно авлахаар чинь би түүний гэдсийг нээж харууламз. Чонын гэдсэнд өдийд оготно зурам л их байж таарна” гэлээ.

“Би чоно оготно иддэг гэдгийг анх удаа сонсож байна. Эсгий хийх газар нохой хэрэггүй гэдэг шиг чоно бас оготно барьж яадаг байна вэ?” хэмээн Сюй зөвлөх асуулаа.

“Манай тэжээвэр бэлтрэг л гэхэд оготно идэх маш дуртай. Сүүлтэй нь хамт залгичихна шүү дээ. Малчид чоныг хүйс тэмтрэн алдаггүй болохоор л Олонбулгийн талд угаасаа үлийн цагаан оготны гамшиг тохиодоггүй юм. Харин та нар чоныг алаад дуусгачихвал энэ нутагт ёстой оготны гамшиг нүүрлэнэ дээ” гэж Чэнь Жэнь хэлэв.

Гэтэл Бао Шүнь Гүй түүний үгийг таслаж “Олон үгээр яахав. Чоноо сайн харж яваарай” гэжээ.

\* \* \*

Жийп машин нэг хөтөл рүү ойртоход Сюй зөвлөх газрын байцыг ажигласнаа шийдэмгий янзтай баруун тийш давхи гээд “Хэрвээ элсэрхэг талд үнэхээр чоно байдаг юм бол бид дотогш шууд оролгүй гадуур нь байгаа харуулыг эхлээд устгая” гэлээ.

Жийп машин баруунаас зүүн тийш сунаж тогтсон налуу хотгор рүү явж оров. Хотгорын баруун талаар элсэн манхантай, зүүн талаар нэг уул хөндөлсөх бөгөөд голоор нь нарийхан үхэр тэрэгний зам гарчээ. Сюй зөвлөх байлдааны өндөр хүчин чадалтай дурангаар ийш тийш харж байснаа гэнэт дуугаа намсгаад “Зүүн уулын өмнө биеэр хоёр чоно явж байна” гэснээ арагш эргэн ардаа явж байгаа машин руу гараараа дохио өглөө. Чэнь Жэнь ч мөн түүнээс хоёр километрийн хол зайтай газар хоёр том чоно явж байгааг олж харав.

Сюй зөвлөх Лю жолоочид хандан “Хурдаа нэмэлгүй шороон замаа дагаад яваарай. Чоныг дал

хавсарч буудна гэж бодоод зэрэгцэж очвол сайн шүү” гэв.

Лю жолооч “Ойлголоо” гэснээ чонын гүйж яваа чигийг даган хурдаа ялимгүй нэмэв.

Сюй зөвлөх ч айхтар байлдааны туршлагатай хүн юм гэдгийг Чэнь Жэнь даруй ойлгов. Жийп түүний хэлсэн маягаар давхихад чононд ойртон очиж болохоос гадна тэдэнд үүгээр өнгөрч яваа замын машин байна гэсэн ташаа ойлголт өгч байгаа юм. Олонбулгийн хилийн харуулын жийп машинууд өөрсдийн ажил төрлийн онцлогоос шалтгаалаад онцгой тохиолдлыг эс тооцох юм бол бараг буун дуу гаргахыг цээрлэдэг болохоор энэ хавийн чононууд хэр барагтай бол айж үргэхээ байжээ. Ядаж шороон замын элс чийгтэй, дээр нь тачир өвс ургасан болохоор сүртэй дуу чимээ ч гарахгүй. Хоёр чоно хааяа нэг зогсож жийп машиныг харчихаад баруун зүг тааваараа шогшино. Гэвч чонын явах чиглэл хөтлийн хормойноос бэл рүү өгсөх маягтай болов. Хэрвээ энэ жийпнүүд үүгээр өнгөрч яваа замын машинууд бол тэд цааш тайван мөрөө хөөнө. Харин шууд өөрсөд рүү нь чиглээд ирвэл хөтлийг даван зугатна гэсэн чонын санааг Чэнь Жэнь төвөггүй ойлгожээ.

Олонбулгийн талын чононууд анчны бууны тусгалыг багцаалдаг болохоор тэр хоёр чоно нэгэн хэвийн тайван шогшино. Бууны тусгалаас гадна зайнд тэд зориуд өөрийг чинь даллан дуудаж машин онхолдон, морьд бүдрэхээр эвгүй газар руу дагуулан аваачдаг. Хэрвээ ойр тойронд өөрсдийнх нь нэгэн сүргийн чононууд байвал өртөөчлөн зугатаж аюулд өртөгсдийн аминд орох ч тохиолдол бий. Тэдний суусан машин хилийн харуулын жийп биш, тэгээд ч сумны тусгал илүү холтой хоёр гарамгай мэргэн буудагчид дээр нь сууж яваа болохоор энэ хоёр чоно өнөөдөр лав амь алдах нь дээ гэж бодоод Чэнь Жэньгийн зүрх базлах шиг болов.

Жийп машин хоёр чононоос анх мянга зургаан метрийн хол байсан бол тэр зай одоо долоо найман зуун метр болон хорогдоод бараг зэрэгцээ шахам давхиж явлаа. Чононууд нэлээд айсан байдалтай хурдаа нэмж эхлэв. Гэвч жийп машины нэгэн хэвийн хурдаар давхих нь тэднийг төөрөгдүүлсэн бололтой хангалттай сэрэмж хараахан үгүй янзтай. Хоёр чоно тэр ч байтугай жийп машиныг өөрсөд рүүгээ татах тусгай үүрэг хүлээсэн юм биш биз дээ гэж Чэнь Жэнь эргэлзэж байлаа. Энэ үед хоёр мэргэн буудагч буугаа гарган тэдний зүг онилж эхлэв. Чэнь Жэньгийн зүрх хүчтэй цохилон Сюй зөвлөхийн хараалахыг ажиглах зуур машинаа зогсоогоод буудах агшинд чоно холдчихдог болоосой гэж залбирах нь холгүй байв.

Жийп машин эцэстээ чононуудтай зэрэгцээ шахам дөрөв таван зуун метрийн зайтай давхиж гарлаа. Хоёр чоно хяламхийн машин дээрх бууны амнуудыг харсан бололтой гэнэт хурдаа нэмэн хойно урдаа ороод хөтлийн оройг чиглэн хурдлав. Гэвч зэрэг шахам “Пин пан” хийтэл буун дуу гарахад хоёр чоно ээлж дараагаар годройтон газар унажээ. “Ямар гайхалтай мэргэн буудаж байна вэ?” хэмээн Бао Шүнь Гүй дуун алдан хашгирахад Чэнь Жэньгийн хамаг биеийн хар хөлс цуггасан байлаа. Донсолгоотой замаар хурдлах жийпэн дээрээс ганц сумаар амин газарт ононо гэдэг Чэнь Жэньгийн ч, Олонбулгийн чонон сүргийн хувьд ч тун ухаан санаанд багтамгүй хэрэг билээ.

Хоёр мэргэн буудагч зуу татчихаад бие нь тавирсан харчууд шиг харагдана. Сюй зөвлөх Лю жолоочид хандан “Хурдан элсэрхэг тал руу давхиарай” гэгчхээд арын машин руу бахь хавчиж байгаа маягтай дохио зангаа үзүүлэв. Хоёр жийп машин хурдаа нэмэн баруун талын элсэн манхан руу давхин оржээ.



Жолооч Лю Сюй зөвлөхийн зааврын дагуу нэгэн довцгийг даваад уудам элсэрхэг талын хамгийн өндөр цэг дээр гарч зогслоо. Сюй зөвлөх өмнөх бариулаас зууран босож зогсоод ажиг харвал хоёр хэсэг чонон сүрэг баруун хойд болон чанх хойд зүг рүү бутран зугатаж байх ажээ. Чанх хойд зүг рүү зугатах тав зургаан чоно их биерхүү бол баруун хойд зүг рүү зугатах чонон сүрэгт хоёр гурвыг эс тооцвол бүгд давжаа өнөө жилийн бэлтрэгнүүд болохыг Чэнь Жэнь дурангаараа ялган харав. Сюй зөвлөх Лю жолоочид “Чанх хойшоо давхиарай” гэгчхээд арын тэрэг рүүгээ хандан баруун хойд зүг заалаа. Хоёр жийп зам хуваагдан чонон араас нэхэн давхив.

Үл ялиг овон товонг эс тооцвол элс өвс тэнцүүхэн тэгш тал цэргийн жийп машины давхихад үнэхээр тохирсон газар ажээ. “Та нар сайн барьцгаагаарай. Буудахгүй байлаа ч гэсэн би машинаараа хэдэн чоно дайрчихаж мэдэхээр юм байна” гэж жолооч Лю хашгирна.

Жийп машин нисэх мэт хурдлан давхив. Чэнь Жэньгийн тархинд “Үхлийн хурд” гэсэн үгс гэнэт санагдав. Тал нутагт зээрийн сүрэг л иймэрхүү хурдтай ана мана үзэлцэж чадахаас биш, хамгийн хурдан уургын морьд болон чоно үхэн хатан давхиад ч яахин гүйцэгдэхгүй байх билээ? Хорин минут орчим хөөсний хойно гүнжидийн чинээхэн харагдаж байсан чононууд вандуйн чинээ тодроод эхлэв. Аажмаар шар буурцгийн хэртэй томроход Сюй зөвлөх буудахгүй хэвээр байх ажээ. Энэ зөвлөх вандуйн чинээхэн харагдах бүргэдийг алддаггүй бууддаг хэрнээ яахаараа гохоо дарахгүй байгаа юм бол доо гэж Чэнь Жэнь гайхан бодож байлаа.

“Одоо буудаж болох байлгүй дээ” хэмээн Бао Шүнь Гүйг асуухад

Сюй зөвлөх хариуд нь “Ийм холоос буудахаар тараад зугатчихаж мэднэ. Жаахан ойртуулж байгаад буудвал хоёрыг алж болохоос гадна арьсыг нь гэмтээхгүй сайн талтай” хэмээн хэлэв.

“Өнөөдөр хүн болгонд нэг нэг арьс оногдохоор олон чоно агнавал сайн сан даа” гэж Лю жолооч хөөрцөглөнө.

“Мэдээтэй давхиарай. Хэрвээ онхолдчих юм бол өөрсдөө чонон хоол болохоо мэдэж байгаа биз?” гэж Сюй зөвлөх зандарлаа.

Лю жолооч дуу шуугүй хурдаа нэмэхэд жийп машин улам ч эрчтэй хурдан давхив. Тэд нэгэн элсэн толгойг өнгөрөхөд үхрийн шинэхэн араг яс эртний тулалдааны талбар дээрх байлдааны морьдын хориг саад мэт хэрзийн угтлаа. Лю жолооч айсандаа жолоогоо огцом мушгитал баруун гар талын хоёр дугуй дээш хөндийрөн машинаас шидэгдэх шахсан хүмүүс бүгд дуу алдан хашгиралдлаа. Машины хөндийрсөн дугуйнууд үхрийн араг ясыг шүргэх шахам өнгөрөөд газардахад сүнс нь зайлах шахсан Чэнь Жэнь хэсэг зууртаа сэхээ авч амжсангүй. Чонон сүрэг газрын байршлын давуу талыг барин ухрахдаа хэрэглэсэн жижиг ов мэх нь машинтай хүмүүсийг сүйд хийх шахсан нь энэ байлаа. Бао Шүнь Гүйгийн царай зэвхийрээд “Хурдаа хас, хурдаа хас” гэхэд Лю жолооч хөлсөө шудраад хурдаа хасахад чонон сүргийн зай нэлээд холдлоо. “Хурдаа нэм” гэж Сюй зөвлөх зандрахад жийп машин дахин хурдаа нэмэн бут сондуул дээгүүр харайлган давхилаа. Чэнь Жэнь урьд өмнө энэ хавиар хонио хариулж явсан тул газрын байр байдлыг нэлээд сайн мэдэх болохоор “Энэ хавьд дов сондуул элбэг болохоор машин бүр ч амархан онхолдож мэдэх юм шүү” гэж сануулав.

Гэвч Сюй зөвлөх түүнийг хайхрах сөхөөгүй урд бариулаасаа тас зуурчихаад “Хурдал, хурдан давхиац” хэмээн шавдуулна.

Жолооч хаазаа тулгал гишгэхэд дөрвөн дугуй нь ойж буун хурдлан давхилаа. Чэнь Жэнь ч бариулаас тас зууран таван цул зургаан сав нь амаар гарах гэж буй мэт санагдав.

Чонон сүрэг газрын байрлалыг ашиглан хамаг хурдаараа довтолгон яваа болохыг Чэнь Жэнь ойлгожээ. Хэрвээ тэд балчиг шавартай газар руу давхин орж чадах юм бол араас нэхэн хөөх машин явж чадахаа болино гэсэн үг юм. “Үхэж байсан чононууд чинь ийм золигийн газар руу авч ирдэг байх гэж дээ?” хэмээн жолооч Лю хараал зүхэл урсгана.

“Битгий сандраад бай. Одоо хээрийн сургууль биш, жинхэнэ байлдаан гэж бодоорой” хэмээн Сюй зөвлөх ширүүн зандрав.

Дахин гурав дөрвөн километр зай туулаад балчиг шавартай газар дөхөж хожуул мэт дов сондуул элбэгшсэн боловч чонон сүрэг нэгэнт малчдын бууны ашигтай тусгалд орж иржээ. Сюй зөвлөх “Жаахан жишүүхэн ороогодох” хэмээн хашгирваас Лю жолооч түүний хэлсэн ёсоор болговол чонон сүрэг бүгд Сюй зөвлөхийн бууны аманд ил гарч ирлээ. “Пин” хийх чимээ гарч сум сүргийн дундах хамгийн том чонын толгойг зад буудваас бусад нь айж сандран тал бүр тийш тарж зугатав. Хоёр дахь буун дуу гарахад дараачийн чоно газар харуулдан уналаа. Энэ сацуу бусад чононууд бүгд балчиг шавартай газрын бут сондуул дунд орон үзэгдэхээ байсан тул дахин буудах боломж гарсангүй. Тэд лав хилийн харуулын замыг чиглэн дутаасан нь тодорхой. Баруун хойд зүгт буун дуу гарахаа болиход жийп машин хотгор болон балчиг шаварт газрын уулзварт тоормослон зогслоо.

“Эндхийн чононууд тун зальтай юм гээч. Эс тийм бөгөөс дахин хэдийг намнах байсан юм” хэмээн Сюй зөвлөх хөлсөө арчив.

Бао Шүнь Гүй эрхий хуруугаа гозойлгон “Ганц болгож тавьлаа. Гуч хүрэхгүй минутын хугацаанд гурван том чоно намналаа шүү дээ. Гэтэл би хагас жил оролдоод ганц чоно агнаж чадаагүй л байгаа юм даа” гэв.

“Эндхийн газрын байршил онцгой төвөгтэй болохоор чононууд ингэтэл гаарах нь аргагүй юм байна л даа” гэхэд Сюй зөвлөхийн хөөрөл дарагдаагүй байгаа бололтой.

Жийп машин үхсэн чононууд руу дөхөж очлоо. Хоёрдахь чоно зүрхэн тус газраа буудуулсан тул ойр хавийн газар нэлэнхүйдээ цус болжээ. Бао Шүнь Гүй жолооч Лю хоёр үхсэн чоныг машины ард аваачлаа. Жолооч Лю түүнийг өшиглөж үзсэнээ “Ийм хүнд байхыг үзвээс арван хүнийг өлхөн цатгачих шинжтэй юм байна шүү” гээд ачааны хайрцагнаасаа бэрзээнт зэрэг аар саар зүйлсийг суллан арын суудал дээр тавив. Тэгээд хоёр шуудай гарган үхсэн чоныг чихэж ачааны хайрцганд хийлээ. Ачааны хайрцаг хаагдахгүй дүүжинт тавцан мэт болоход жолооч Лю түүн дээр үлдсэн хоёр чоныг ачъя гэж боджээ.

Чэнь Жэнь тэдэнд чонын гэдсийг ярж харуулъя гэж бодсон боловч цаадуул нь туламлан өвчих санаагүй болохыг үзээд асууруун “Та нар арай чонын мах идэх гэж байгаа хэрэг биш биз дээ? Малчид чонын махыг гашуун гээд иддэггүй юм шүү дээ” гэв.

“Шал дэмий үг байна. Нохойн махнаас өөрц байдаггүй юм. Би нутагтаа хэдэн ч удаа идэж үзэхэд нохойн махнаас ч илүү амттай санагдсан шүү. Чи үүний хичнээн тарган чоно болохыг харахгүй байна уу? Чонын махыг нохойны махтай адил амталдаг юм. Эхлээд нэг хоног хүйтэн усанд сойж шивтрийг нь арилгах хэрэгтэй. Тэгээд сармис, халуун ногоогоор амтлаад идэхэд ч мөн янзтай шүү дээ. Манай нутагт аль нэг айл чонын мах чанах юм бол тосгоныхон тэр аяараа тэднийд цуглардаг байж билээ. Чонын мах идэх нь цөс сайжруулж, хий хуйг туудаг гэлцдэг юм” гэж жолооч Лю өгүүлэв.

Чэнь Жэньгийн дотор эвгүйрхээд “Манай эндхийн малчид үхсэн хүнээ ил тавьсаныг чонон сүрэг иддэг заншилтай. Гэтэл та нар үхсэн хүнээр хооллосон чонын мах идэхээс айхгүй байна гэж үү дээ?” хэмээн асуулаа.

Жолооч Лю тоосон шинжгүй “Түүнийг ч би мэдэлгүй яах вэ? Гол нь чонын ходоод гэдсийг л идэхгүй байхад болчих нь тэр. Нохой ч гэсэн хүний баас иддэг мөртлөө хүмүүс түүний махыг сэжиглэлгүй идэж орхидог биз дээ? Тэгж яривал бид чинь хүний өтгөөр ногоогоо борддог улс. Гэсэн атал чи түүнээс сэжиглэдэг бил үү? Манай хятадууд чинь тэр тусмаа л нохойн мах, хүнсний ногоондоо дуртай байдаг биз дээ? Барилгын цэргийн нэгтгэлийн тэр олон хүн тал нутагт ирчихээд хонины мах нь хүртэл талонтой болохоор махсаж гүйцээд байгаа юм. Энэ хэдэн чоныг бригад дээр аваад очиход амаа олохгүй л идэцгээх болно” гээд марсайтал инээв.

Сюй зөвлөх ч мөн инээд алдаад “Намайг наашаа гарах үед дивизийнхэн чонын мах захиад байсан юм. Тэдэнд жаахныг аваачиж өгнө өө. Хэд хэдэн багтраа өвчтэй хүмүүс чонын мах уушгинд сайн гээд захиад байна билээ. Би чинь байтлаа эмч болж гүйцэх нь шиг байна. Чонын ав гэдэг бодоод байсан чинь их зүгээр ажил юм гээч. Нэгд: Малчдын гол хөнөөлтөнг устгана. Хоёрт: Өөрөө чонын арьстай болчихно. Гуравт: Өвчтэй хүнд тус болно. Дөрөвт: Ховдог золигнуудын хорхойг дарах болно шүү дээ. Тэгэхээр нэг сумаар дөрвөн туулай буудаж байгаа биз дээ?” гэв.

Тэр чонын гэдсийг яран ходоод дүүрэн оготно гаргаж ирлээ ч гэсэн тэдний чоно авлах хорхойг дарж чадахгүй юм байна гэдгээ Чэнь Жэнь ойлгожээ.

Жолооч Лю тэргээ асаан эхний чоныг буудсан газарт хүрэлцэн ирэв. Сум чонын ар дагзаар нэвт гарч, цус нь тархитай холилдон урсчээ. Чэнь Жэнь тэр чоныг халт хараад цээжин дээр нь цагаан үс алга байхыг үзээд цагаан цээжит азарган чоно биш байж хэмээн жаахан уужирлаа. Энэ азарган чоно сүргийн хамгийн хурдан гишүүдээ дагуулан дайсныг төөрөлдүүлэхээр давхиж яваад амиа алдсан нь тодорхой. Тэр тал нутагт шинээр гарч ирсэн жийп машин, мэргэн буудагч нарын талаарх туршлага мэдлэг дутсан нь харамсалтай.

Жолооч Лю, Бао Шүнь Гүй хоёр өвс зулгаан чонын тархи, цус хоёрыг арчиж цэвэрлээд шуудайд хийн, төмөр гинжээр дүүжилсэн арын хайрцагны таган дээр тавин сайтар бөхлөн уялаа. “Энэ чонын толгой бярууныхаас дутуугүй том байж шүү” хэмээн жолооч Лю шагшран магтана. Тэр хоёр гараа өвсөөр арчиж цэвэрлэсний дараа машиндаа сууцгаан Баатар зөвлөхийн жийпийг чиглэн давхилаа.

Хоёр машин нэг дор ирсэний хойно Баатар зөвлөх өөрийн машины хонины хонхорт тавьсан шуудайтай зүйлийг зааж “Энэ хавьд бут сондуул элбэгтэй болохоор машин явахын аргагүй

юм. Тэгээд ч бидний хөөсөн сүрэгт голцуу өлөгчин чоно болон өнөө жилийн бэлтрэгнүүд байлаа” гэхэд

Сюй зөвлөх санаа алдаад “Эндхийн чононууд үнэхээр золиг шиг зальтай юм. Хамгийн бартаа саад элбэгтэй газрыг өлөгчин болон бэлтрэгнүүддээ найр тавьж өгсөн байна шүү” гэв.

“Нэгийг албал нэмэр гэдэг биз дээ? Үүнээс сайн хэрэг гэж хаана байх билээ? Би өнөөдөр ганц сайн бах ханаж авлаа. Ийм сайхан юм болох гэж бас байдаг аа. Одоо түрүүчийн хоёр чоноо очиж аваад миний авчирсан архи хоолыг идэж сайхан наргицгаая” гэлээ.

Чэнь Жэнь яаран босож нөгөө машин дээрх алуулсан бэлтрэгний шуудайг нээж үзэв. Тэр бэлтрэг өөрийнхтэй нь төстэй боловч илүү өсгөлүүн мэт санагдлаа. Өөрөө сэтгэл зүрхээ гарган өсгөсөн бэлтрэг хээрийн чонын бэлтрэгнээс жижиг байх юм гэж тэр яахин санах билээ дээ? Гэтэл хээрийн чонын бэлтрэг хагас жил хүрэхгүй хугацаанд өсөж томроод өөрөө хоолоо олж идэхтэй болсон байдаг байх гэж. . . . . Харамсалтай нь амьдралд хөл тавиад удаагүй байхдаа бууны суманд амь үрэгджээ. Түүний зүрх базлан ийн бодох зуур өөрийн бэлтрэгээ илдэгтэй адил түүний толгойг илээд авав. Тэр өөрийн бэлтрэгний амийг аврахын тулд энэ бяцхан амьтны аминд хүрэх учиртай байжээ.

Хоёр жийп өмнө зүгийг чиглэн давхилдав. Чэнь Жэнь харуусал дүүрэн нүдээр хил орчмын бэлчээрийг эргэн харлаа. Энэ сүрэг чонын гол хүч болон азраган чоно нь ганц цаг хүрэхгүй хугацаанд үгүй болжээ. Тэд лав урьд өмнө ийм айхтар дайралтыг амсаж байгаагүй нь лавтай. Үлдсэн чононууд хил давж одоод дахин эргэж ирэхгүй байх даа. Гэвч азарган чоно болон гол хүчнээсээ хагацсан хөөрхий тэд тэнд яахин амь зуудаг бол? “Харьяа нутгаа алдсан чоно эзэнгүй золбин нохойноос ч долоон дор болдог” гэж Билиг өвгөн байнга ярьдаг билээ.

Жийп машинууд анх ав хийсэн газартаа давхин хүрэхэд хоёр чоно цусандаа хутгалдан хэвтэх бөгөөд баахан ялаа батгана түүн дээр шавжээ. Чэнь Жэнь тэднийг харахаас нүд халтиран ганцаараа газар суучихаад хилийн тэнгэрийг ширтэн харлаа. Хэрвээ Билиг өвгөн түүнийг хоёр жийптэй хүмүүс дагуулчихсан чонон сүргийг авлаж яваа гэдгийг мэдчихвэл яах бол? Өвгөний түүнд харамгүй зааж өгсөн чонын тухайн мэдлэгийг энэ удаа чонын авд ашигладаг байжээ. Тэр хожим яаж тал нутгийн өвгөн аавынхаа царайг харна аа гэхээс сэтгэл нь шархирах шиг болов. . . . Харуй бүрий болоход өлөгчин чононууд бэлтрэгнүүдээ дагуулан азарган болон бусад чононуудын амь тавьсан газар дээр ирээд цусан толбыг нь харж таарна. Тэгээд энэ хавь тэр аяараа чонын уйлаан хайлаанд автах байх даа. . . . :

Жолооч Лю, Ван нар хоёр шуудайтай чоныг Вангийн машины арын хонины хонхорт хийлээ.

Зүлгэн дээр хэдэн том бор цаас дэвсээд дээр нь гурван шил талын хар архи, ууттай хуурсан газрын самар, арван хэдэн өргөст хэмх, хоёр ширхэг соустай үхрийн махан нөөш болон түмпэнтэй чанасан мах зэргийг гарган тавив.

Бао Шүнь Гүй нэг шил архи барьчихаад Сюй зөвлөхтэй хамт Чэнь Жэньгийн дэргэд ирээд хээрийн зоогийн ард аваачин суулгалаа. Бао Шүнь Гүй түүний мөрийг алгдан “Чэнь Жэнь чи өнөөдөр бидэнд маш том тус болж том гавьяа байгууллаа. Хэрвээ чи байгаагүй бол энэ хоёр мэргэн буудагч хийх ажилгүй байсаар ганзага хоосон буцах байлаа шүү дээ” гэв.

Сюй зөвлөх ч бусад гурван нөхрийн хамтаар түүнийг хүндэтгэн сархад өргөн барив. Сюй зөвлөх их л үнэнч байдлаар Чэнь Жэньг ширтээд өгүүлрүүн “Тогтоочих, тогтоочих. Эхний хундагыг чамд өргөн барьж байна. Чи чоно тэжээж судласаар овоо мэдлэгтэй болсон байна шүү. Биднийг шулуухан чонын үүрэн дээр аваад ирлээ шүү дээ. Өчигдөр Бао дарга биднийг дагуулан зуугаад километр давхиад ганц чонын бараа харалгүй эргэн ирсэн. Алив наадхиа тогтоочих. Чамд их баярлалаа” гэв.

Чэнь Жэньгийн царай барайн ямар нэг юм хэлэх гэснээ болиод архиа хөнтөрч орхив. Тэр нэг нууцгайхан газарт очоод сэтгэлээ онгойтол уйлж авмаар санагдана. Хятадуудын болоод цэргийн хүний хэмжүүрээр авч үзэх юм бол Сюй зөвлөх яахын аргагүй сайн хүн байлаа. Тэр дөнгөж тал нутагт ирээд байгаа хүн болохоор тал нутгийн байр суурь болон баримжаагаар түүнтэй зөрөлдөж яахин болох билээ? Гэвч тал нутгийн нүүдлийн амьдрал хэзээ мөдгүй тэдний бууны аман дор үгүй болж, хятад хүмүүс энд байр сууриа эзлэснээр хээр тал цөлжих аюултай тулгарах нь тодорхой болоод байдаг. Тэр нэг том өргөст хэмх аваад том том хазлав. Чэнь Жэнь хоёр жил ч өргөст хэмхийн бараа хараагүй тул барилгачдын тариалсан анхны ургацын өргөст хэмх их л амттай санагдав. Энэ ширээ дүүрэн амттан шимттэнгээс тэр яахаараа заавал өргөст хэмхийг шүүрэн авдаг билээ? Хятад хүний тариачин зан хэзээ ч засрахгүй юм шив дээ гээд бодтол гартаа барьсан өргөст хэмх ямар ч амтгүй мэт санагдаад явчихлаа. . . . .

Сюй зөвлөх Чэнь Жэньгийн дал мөрийг алгадан “Чэнь Жэнь минь, бид ийм олон чоно алчихаад байхад чи ингэтэл урвайхын хэрэг юусан билээ? . . . . Чи чоно тэжээсээр тэдэнд элэгтэй болсон гэдгийг чинь би ойлгож байна л даа. Настай малчид ч чамд нөлөөлөө биз. Чоно туулай, тарвага, зээр, оготно зэргийг барьдаг нь тал нутагт маш тустай нь үнэн л дээ. Гэхдээ тэр бүхэн чинь улирсан баларсан үзэл. Хүн төрөлхтөн хиймэл дагуулаа хүртэл сансарт хөөргөчихөөд байхад бид шинжлэх ухааны аргаар тал нутгийг эзэмшиж яагаад болохгүй байх вэ? Манай барилгын цэргийн нэгтгэлийнхэн “Ан 2” онгоцоор хор цацаж үлийн цагаан оготныг үгүй хийхээр төлөвлөж байгаа” хэмээн ярив.

Чэнь Жэнь юу билээ гэж бодсоноо тэр даруй сэхээ аваад “Тэгж яахин болох билээ? Хоронд хордсон оготныг идсэн чоно, үнэг, хярс, бүргэд зэрэг тал нутгийн бүхий л амьтан түүний улмаас үхэж үрэгдэх биш үү?” хэмээн яаран сандран хэллээ.

“Оготно үхэж дуусчих юм бол чоныг үлдээгээд яах гэсэн юм бэ?” гэж Бао Шүнь Гүй хэлэв.

“Чонын ашиг тус ганцаар дуусахгүй шүү. Адаглаад л зээр, туулай, тарвагыг тэсгээдэггүй амьтан” гэж Чэнь Жэнь мэтгэлцэх санаатай өгүүлэхэд

Лю жолооч архинд мэнчийтэйл улайн инээгээд “Зээр, туулай, тарвага зэрэг чинь бүгд зартай сайхан хоолнууд гэсэн үг. Манай барилгын цэргийн нэгтгэлийнхэн бүгдээрээ хүрээд ирсэн цагт тэр бүхэн чинь аманд ч үгүй, хамарт ч үгүй болох байлгүй” гэлээ.

## Гучин хоёр

*Хүн + адгууслаг чанар = өрнөдийнхөн. . . . Харин хятад хүний хувьд илэрдэггүй энэхүү чанар урьд өмнө байгаагүй гэх буюу одоо устан үгүй болсон талаар яриад нэмэргүй. Хэрвээ хожим үгүй болсон гэж үзэх юм бол аажмаар цэвэршээд зөвхөн хүн чанар нь үлдсэн буюу эсвэл аажмаар номхорсон байж таарна. Зэрлэг үхэр тэжээвэр үхэр, бодон гахай тэжээвэр гахай, чоно нохой болон хувирахад зэрлэг чанар нь устаад малчин эзнээ баясгахаас өөр ямар ашиг тустай зүйл байх билээ. Хүн явж явж хүн л байдаг болохоор элдэв дээдийн шинж чанар холилдоогүй байвал түүнээс сайн юм гэж хаана байх билээ дээ. Гэсэн хэдий ч би жсаахан адгууслаг чанартай байхыг арай илүүд үзнэ. Хэрвээ доорх томъёонд нийцэх хүн байдаг бол хачин юм болно биз дээ: Хүн + гэрийн тэжээвэр амьтны чанар = Хэн нэгэн хүн.*

Лү Сюнь

*“Хятад хүний чанарын тухай дөхөм өгүүлэх нь”*

Хээрийн хоол дууссаны дараа Бао Шүнь Гүй дарга, Сюй зөвлөх лугаа хэдэн үг шивнэлдээд хоёр жийп машин зүүн хойд зүгийг барин давхихад Чэнь Жэнь сандраад “Буруу яваад байгаа юм биш үү? Ирсэн замаараа явбал дээр” гэж хашгирав.

“Багийн төв хүртэл дал гаруй километр зайтай. Ийм хол замд ганзага хоосон буцаж яахин болох билээ?” хэмээн Бао Шүнь Гүй хэлэв.

“Бид сая буун дуу гарсан газраас зайдуухан буцвал дахин ганц хоёр чоно тааралдахыг хэн байг гэх билээ? Чоно тааралддаггүй юм гэхэд үнэг байсан ч дажгүй. Манай армийн үргэлжлүүлэн дайтаж, үр дүнгээ өргөжүүлэх дайчин уламжлалыг бадраах хэрэгтэй биз дээ?” хэмээн асуулаа.

Жийп машин өвөлжөөний өргөн уудам нутгаар дайран өнгөрөхөд хаа сайгүй метр гаруй өндөр хялгана халиурахыг Чэнь Жэнь олж үзэв. Хялгана хичнээн айхтар цас зуданд дарагддаггүй тул өвөл цагт мал сүргийн сайн тэжээл болохоос гадна хонин сүрэг түүгээр баримжаалан цасан дорх өвсийг малтаж иддэг юм. Олонбулгийн талын урт өвлөөр нийт багийн мал сүрэг тарган тавтай онд мэнд орох эсэх нь чухам энэхүү өвөлжөөний бэлчээртэй салшгүй холбоотой.

Намрын салхинд найгах өвс далайн давалгаа мэт долгилсоор жийпний дөрвөн дугуйг дайран өнгөрлөө. Хоёр жийп машин байлдааны хөнгөн усан онгоц мэт өвсөн далайн давалгааг зүсэн урагшилна. Ийм өндөр сахлаг өвсөн дундаас одон орны дурангаар хайгаад ч чоно олж үзэхгүй биз ээ хэмээн Чэнь Жэнь арай уужирлаа.

Чэнь Жэньгийн сэтгэлд дахиад л тал нутгийн чоно адуучин хоёрт талархах сэтгэл өөрийн эрхгүй төрөв. Харахад байгалийн унаган төрхөөрөө байгаа мэт үзэгдэх энэхүү онгон талын үзэмжийг үнэн хэрэг дээрээ чоно адуучин хоёр хөлс хүчээ урсган хамгаалж ирсэн байдаг юм. Үзэсгэлэнт байгалийн унаган төрхөнд тоо томшгүй олон хүн болон чонон хүч шингэсэн байдаг гэсэн үг л дээ. Цас орсоны дараа малчид мал сүргээ туугаад наашаа ирэхдээ чонон сүргийн ач ивгээлийг мэдрэх болно. Малчин ардууд чонон улианаас эхтэй уртын дуугаа

уянгалуулан дуулах бүр Чэнь Жэньгийн сэтгэл санаа уужраад явчихдаг билээ.

Жийп машин хурдаа нэмэн давхихад халамцуу мэргэн буудагчид дурангаа өргөн чонын арьс, мах хоёрыг хайсаар байх ажээ. Чэнь Жэнь урьд өмнө хүн малын хөл хүрээгүй өвөлжөөний бэлчээр дундуур салхи татуулан давхиж байсан нь үгүй тул өөрийн эрхгүй гүн бодолд дарагдлаа. Нүд алдам уудам талд энэ мөчид ганц айлын яндангийн утаа, нэжгээд морь, үхэр, хонь үзэгдэхгүй ажээ. Хагас жил шахам өнжөөсөн өвөлжөөний өвс бэлчээр хэдийгээр халиуран шаргалтах боловч хаваржааны нутгаас хавьгүй эль хуль харагдана. Хаваржаанд чулуун хороо, амбаар сав, худгийн онгоц зэрэг хүний ул мөр хаа сайгүй үлдсэн байдаг билээ. Өвөлжөөн дээр хүн малгүй цасны усаар ундаалж, хурга, ишиг, тугал зэрэг төл мал өсөж томорсон байдаг болохоор тусгай пүнзний хэрэггүй болдог. Мөн мал сүрэгтээ үхэр тэрэг, шон зэрэгт эсгий тогтоож хагас саран хэлбэртэй салхинаас хаах хороо байгуулчихна. Тийм болохоор намрын улиралд өвөлжөөний нутаг бэлчээрийг ажиглахад хялганы толгой найгахаас өөр хүн амьтны ямар ч ул мөр үзэгдэхгүй байх нь арга ч үгүй юм. Хэрвээ энэ мөчид хасаг цэргийн хар хурган малгай өмссөн Григорий давхин гарч ирвээс тэдний ард хүний сэтгэл булаам Доны тал байгаа гэдэгт Чэнь Жэнь огтхон ч эргэлзэхгүй байхсан. Бүр дунд сургуульд байхдаа л Чэнь Жэнь “Дөлгөөн Дон” романыг хоёр гурван ч удаа уншиж киног нь үзэж байсан удаатай. Хожим Бээжингээс тал нутгийг чиглэн мордохдоо “Дөлгөөн Дон” роман болон тал нутагтай холбоо бүхий бусад зохиолуудыг авчирсан билээ.

Ер нь ч “Дөлгөөн Дон” бол түүний сэтгэлийг наашаа чангаахад гол нөлөө үзүүлсэн бүтээл гэж хэлж болох юм. Чухам Григорий, Наталья, Аксения зэрэг эрх чөлөөнд халуун хайртай тэдгээр хүмүүс л түүнийг тал нутаг руу даллан дуудсан сан. Тал нутаг чухам ямар татах хүчтэй болоод түүний сэтгэлийн луужингийн зүүг өөр рүүгээ чиглүүлдэг юм бол? Тэр тал нутгийн гүн дэх чичирхийлэл, дуудлагыг сэтгэл зүрхээрээ байнга мэдэрдэг. Тал нутаг түүний сэтгэлийн гүнд үүсгэсэн тэрхүү чичирхийлэл эх үрсийн сэтгэлийн нандин холбоосноос ч илүү нарийн нууцлаг байж тэр ч байтугай ээж, эмэг эх, элэнц эмэг, хуланц эмгийн үеийг алгасан бүр анхны өндөр эмгийн сэтгэлийн өвийг уламжлан өгөх шиг болно. Ингэснээр тэр урьд өмнө хэзээ ч мэдэрч байгаагүй зүрхний гүн дэх балар эртний сэтгэлийн мөн чанар тодрон гарч ирдэг юм.

Чэнь Жэнь эль хуль эзгүй талд мөрөөдлийн оронд аялан явахдаа хүн төрөлхтний эрт балрын элэнц өвгийг олж харах шиг боллоо. “Хөл дээрээ зогсож хөдөлмөрлөдөг болсон нь хүнийг буй болгосон юм” гэж суут сэтгэгч өгүүлсэн нь буй. Тэгвэл хүн дүрст бич тэгвэл ой модон дотор эсвэл тал хээрийн хаана анх босоогоор явдаг болсон юм бол доо? Энэ бол хүн төрөлхтний үүсэн буй болсон газар чухам хаана байдаг вэ гэдэгтэй холбоо бүхий эргэлзээ юм.

Чэнь Жэнь тал нутгийн зэрлэг араатантай хоёр жил харилцах явцдаа ухаарсан нэг зүйл гэвэл хүн дүрст бич ой модон дотор босоо явж сурах үндэсгүй гэдгийг ойлгосон билээ. Яагаад гэвэл ой модон дотор амьдардаг бич, сармагчингуудын урд мөч илүү хөгжилтэй байдаг шүү дээ. Ой модон дотор холыг харж, зэрлэг араатнаас амиа хамгаалъя гэвэл илүү өндөр модонд авирахаас өөр аргагүй. Өндөр модонд авирч, үр жимсийг олж идэхэд мөн л урд мөч илүү чухал үүрэгтэй байж таарна. Тэр тусмаа бич сармагчингууд ой модон дотор хурдан явахад мөн л урд мөчдөө найдахаас өөр аргагүй. Бич сармагчингуудын урд мөч ийм чухал үүрэгтэй

нөхцөлд хойд хоёр хөл нь зөвхөн туслах үүрэгтэй байхаас биш босоо явж сурах хүнд үүргийг гүйцэтгэж чадахгүй. Тийм болохоор бич сармагчингууд ойд дотор босоогоор явж сурах боломжгүй, тийм шаардлага ч үгүй юм.

Яваандаа амьтад өсөж үржихийн хэрээр ой модон дахь идэш тэжээлийн нөөц хомсодсон хатуу ширүүн орчин нөхцлөөс үүдээд зарим нэг амьтад тал хээр рүү шахагдахад тийш очсон хүн дүрст бичний хойд хөлний үүрэг өөрчлөгдсөн байж таарна. Нэг талаар чоно, барс зэрэг аюултай араатан нуугдаж байгаа тал нутагт өндөр өвсөн дундаас тэднийг ялган харахын тулд зайлшгүй босоо зогсох хэрэгтэй. Нөгөө талаар талд авирч дүүжлэгдээд байхаар мод, мөчир байхгүй тул хүчтэй хөгжсөн урд мөчнийх нь үүрэг саарч эхлэж таарна. Тэгснээр хойд хөлийн үүрэг өсөн нэмэгдэж, хэдэн арван түмэн жилийн турш байнга давтагдан хэрэглэгдсээр хүн дүрст бичний хөл, нуруу цэх босоо болон хувирсан байж болох биш үү? Босоо зогсдог болсноор хүн дүрст бич бусад амьтдын хувьд аймшигтай зэвсэг болох “гарыг” бүрэн чөлөөлж өгсөн нь бүр ч аймшигтай зүйл болох их тархины хөгжлийг түргэсгэжээ. Үүний хүчинд бүхий л араатан амьтдыг эрхшээлдээ оруулж, хамаг амьтдын хаан болсноор хүн болон хувирсан байна.

Гартаа чулуун сүх далайж, бамбар барьсан балар эртний хүн дайчин төрх байдалтайгаар хөл дээрээ босож ирсэн юм. Чулуун сүх анх араатан амьтадтай тулалдах байлдааны зэвсэг байснаа улмаар идэш тэжээлээ олж идэх үйлдвэрлэлийн хэрэгсэл болон хувирчээ.

Тулалдааны явцад оршин тогтнож чадсанаар хөдөлмөрлөх боломжтой болсон байна. Зөвхөн босоо явалт болон хөдөлмөр хүнийг бий болгоод зогсохгүй, босоо явахад тус дөхөм үзүүлсэн тоо томшгүй олон удаагийн тэмцэл тулалдааны эцэст жинхэнэ хүн буй болсон байж таарна. Харин босоо явах дургүй дөрвөн мөчөөрөө гүйдэг бич, сармагчингууд байгалийн шалгарлаар арслан, барс, араатан чонын хоол болох тавилантайгаа үлджээ. “Хүн дүрст бич анх удаа тал нутагт явж сурсан бөгөөд түүнийг явж сурахад талын чоно маш чухал үүрэгтэй байсан” гэдгийг Чэнь Жэньгийн олон жилийн судалгаа, ажиглалт дүгнэлт болон зөн совин нь түүнд хэлээд байгаа юм.

Тийм болохоор хатуудаа хатуу атлаа ер бусын үзэсгэлэнтэй тал нутаг бол зөвхөн хятад үндэстний төдийгүй нийт хүн төрөлхтний анх үүссэн өлгий нутаг билээ. Тийм болохоор тал нутаг бол хүн төрөлхтний хөлд орж, дэлхийн дайдад мөрөө гаргахын эхлэл болсон нутаг, хүн төрөлхтний хамгийн эрт балрын эх орон юм аа. Өвс бүрийн толгой, элсэн ширхэг бүхнээс эрт балрын бүлээн зөөлөн сэтгэл ундарч өөрийг нь бүчин авах шиг Чэнь Жэньд санагдав. Түүний зэрэгцээ тал нутгийг шатаан сүйтгэж, хагалж эвдэж байдаг тариачид бол хамгийн адгийн харгис мунхаг нүгэлтнүүд юм гэсэн бодол төрөхөд цээж дүүрэн харуусал халаглал дүүрээд ирлээ.

\* \* \*

Жийп машин намхан өвстэй балархай замаар орон зүүн тийш довтолгов. Балархай замын дагтаршсан хөрсөн дээр айл хунар нүүх үеийн адуу малын аргал, хоргол их тул өвс нь тачир атлаа шим шүлт сайтай хар ногооноороо ажээ. Алсаас харахад энэхүү балархай зам талын гүн рүү хөтлөсөн хар ногоон судаг шиг харагдана.

Баруун өмнө зүгт холгүйхэн гурван хар цэг харагдах нь үнэг болохыг Чэнь Жэнь төвөггүй



мэдэв. Тэр үнэг өвсөн дунд урд хоёр хөлөө өргөн шовойгоод жийп машиныг ажиглан харах ажээ. Их үдийн наранд үнэгний толгой, хүзүү, цээжний шаргал үс хялганы толгойноос бараг ялгарахгүй шахам бүүдийгээд хоёр чих, хамар нь гурван хар цэг болон харагдсан нь тэр ажээ. Чэнь Жэнь Билиг аавтайгаа үнэгчлэхээр явах бүрт өвгөн түүнд тэр гурван хар цэгийг ялган таньж сурахыг сануулдаг юм. Хэрвээ туршлагатай анчин бол тэр гурван хар цэгийн доохонтой бариад буудах учиртай. Тал нутгийн зальжин үнэгний өнгөлөн далдлалт, бүдүүн зүрх хашир анчныг хуурч дөнгөхгүй боловч бүргэд мэт хурц хараатай мэргэн буудагчдыг таг сохор мэт болгож чаджээ. Чэнь Жэнь дахин цус үзэхийг хүсээгүйн дээр талын үзэсгэлэнт үнэг гэгч амьтан оготно зурмын сайн ангуучин тул юу ч хэлэлгүй өнгөрөв. Жийп машин зугуухан гурван хар цэг рүү дөхөхөд үнэг гэнэт бултгасхийгээд өвсөн дунд орон алга болжээ.

Тэд дахин хэсэг зуур явсаны дараа нэгэн хээрийн бор туулай өвсөн дунд босож зогсоод тэднийг ширтэн харна. Цээжний өнгө нь өвсөн толгойноос бараг ялгарамгүй шахам боловч түүний хоёр дэлдэн чих өнгөлөн далдлалтыг баллаж орхилоо. “Тэр тарган туулайг харав уу? Туулай ч тал нутгийн том хортон шүү дээ” хэмээн Чэнь Жэнь шивээнэв.

Бао Шүнь Гүй жаахан урам муутайхан шиг “Одоохондоо түүгээр юу хийхэв. Эхлээд чоноо алж дуусгаад дараа нь тэднийг тонилгоход оройтохгүй” гэлээ.

Туулай жийпээс огт айхгүй байгаа бололтой хэдэн ямх өндийн харж байснаа арван хэдэн метр дөхөн очиход сая ухасхийн далд оров. Өвсний үнэр мансуурам сэнгэнэж, хялганы толгой далайн давалгаа мэт үелзэнэ. Өвөлжөөний өвсөн дунд ан хийх газар биш гэдгийг мэдсэн ангуучид хялганатай талыг дайран өмнө зүгийг барин хурдлалаа. Тэгсээр тэд аараг толгод үелзэн сунайсан намаржааны бэлчээрт орж ирлээ. Эндхийн өвс хэдийгээр тачирдуу намхан боловч уураг, цардуул, тослогоор баян үр нь боловсорч гүйцсэн тул малчид хэдэн зуун мянган жилийн турш чухам энэ газарт малаа намаржуулдаг уламжлалтай юм. Мал сүрэг энд ирээд хар буурцаг, арвайн хүчит тэжээл идэж байгаа юм шиг өвсний толгойг зулгааж гардаг. Олонбулгийн талын хонин сүрэг энэхүү эрдэнэ мэт өвс бэлчээрийнхээ хүчинд намрын намарт тосон таргаа авч, сүүл нь гурван хуруу зузаардаг билээ. Энэхүү эртнээс улбаатай шинжлэх ухаан, технологийг ойлгодоггүй гадны цагаачид хонин сүрэгтээ тосон тарга авахуулж чадаагүйн улмаас мал сүрэг нь онд мэнд орж чаддаггүй, өвлийг арайхийн давж гарлаа ч гэсэн хавар жилбэ муутайн улмаас төл олноороо хорогдох шалтгаан болдог. Харин Билиг өвгөний хоёр жилийн уйгагүй зааж сургасны хүчинд Чэнь Жэнь энэ талаар хүний дор орохооргүй мэдлэгтэй болжээ. Тэр доош тонгойн нэг өвсний үр авч гартаа имэрч үзэхэд боловсорч гүйцсэн нь хүн малыг наашаа нүүн ирж болохын дохио юм.

Өвс улам тачирсаж харааны талбай ихэссэн тул машин улам хурдаа аван урагшиллаа. Бао Шүнь Гүй гэнэт зам дээр хэдэн чонын баас байгааг олж харахад анчид урам орж, харин Чэнь Жэньгийн сэтгэл базлах шиг болов. Энд буун дуу гарсан газраас гуч гаруй километрийн хол зайтай тул хэрвээ чоно байдаг юм гэхэд хүн харгүй хойд зүгээс чимээ шуугиангүй шахам орж ирсэн жийп машинаас сэрэмж авч чадах нь юу л бол.

Жийп машин нэгэн намхан довцгийг өнгөртөл тэнд сууж явсан гурван хүн нэгэн зэрэг “Чоно, чоно” хэмээн хашгиралдлаа. Чэнь Жэнь нүдээ нухлан үзвээс өмнө талд гурван зуун метр орчмын зайтай нас бие гүйцсэн ирвэс мэт том биетэй чоно давхиж явлаа. Олонбулгийн талд хурд хүч жигдэрсэн том биетэй чононууд сүргээс тасран ганцаар ан хийх нь цөөнгүй

байдаг бөгөөд тэд үнэндээ ижил сүрэгтээ боломж хайн яваа туршуулууд гэсэн үг юм.

Дугхийж байсан чоно машины чимээнээр цочин сэрээд гуу жалга, өндөр өвстэй газар бараадан зугатсан нь энэ байж таарна. Жолооч Лю хаазаа нэмээд “Ийм ойрхон зайтай байхад зугатаад гарна гэж бодоо юу?” хэмээн хашгирав. Жийп машин чонын зугатах замыг хаахад тэр чиглэлээ өөрчлөн бараг л зээрийн хурдаар шахам хөтлийн оройг чиглэн довтолгоход Баатар зөвлөхийн жийп машин түүний урдаас амдан шахлаа. Хоёр жийп машин чоныг хавчсан байдалтай хөөж эхлэв. Хэдийгээр чоно хамаг хурдаа шавхах боловч жийп машин хаазаа тултал гишгэх яагаа ч үгүй байлаа.

Сую зөвлөх “Чиний байрлал аятайхан юм чинь чи бууд” гэхэд Баатар зөвлөх өөдөөс нь “Чи надаас илүү мэргэн болохоор түрүүлж бууд” хэмээн бие биесдээ найр тавив.

Бао Шүнь Гүй гараа савчин өндөр дуугаар хашгираад “Хэн ч буудах хэрэггүй. Өнөөдөр цөмөөрөө сумны ором гараагүй бүтэн арьстай болцгооё. Амьдаар нь өвчсөн чонын арьс үс сайн гэгддэг тул ахиухан үнэ мөнгө хүрдэг юм” гэлээ.

“Маш зөв” гэж хошоод мэргэн буучид болон жолооч нар түүний үгийг зөвшөөрлөө. Лю жолооч Бао Шүнь Гүй рүү эрхий хуруугаа гозойлгоод “Энэ муу чоныг сүг болтол хөөгөөд өгөхөө мэдэх байлгүй” гэхэд жолооч Ван ч мөн хэрээ тавьсангүй “Би ч гэсэн цусыг нь садартал хөөгөөд өгье л дөө” гэв.

Тачир өвстэй хэвгий талд жийп машин явахад маш тохиромжтойгоос гадна ийм ойрхон зайтай хоёр машинд хавчигдсан чоно яаж амьд гарах билээ. Чоно сүүлдээ цагаан хөөс сахруулан хурдлахад жийп машинаар чоно хөөх нь осолтой ан боловч эцэс сүүлдээ зугаа цэнгэл болон хувирлаа. Чэнь Жэнь тал нутагт ирсэн цагаасаа хойш хүн чоныг ийм айхтар ааглах хүчтэй болсон гэдгийг огт бодож байгаагүй юм. Тал нутгийг хэдэн түмэн жилийн турш эзэгнэсээр ирсэн чоно гээч хийморьлог амьтан энэхэн мөчид хээрийн бор туулайнаас ч өрөвдөлтэй нэгэн болон хувирчээ. Чэнь Жэньгийн толгойд гэнэт хүчтэний өмнө хүчгүй нь буруутай гэсэн үг гялсхийн орж ирлээ. Мөнх тэнгэр минь, эх байгаль арай ийм энэрэлгүй юм гэж үү дээ?

Хоёр туршлагатай жолооч жийп машины дуут дохиог хамаг чангаар хангинуулан тавь жаран метрийн зайтай хоёр талаар нь хашин давхиулна. Чоно хэдийгээр хурдан боловч арваад километр давхисны эцэст амаа байдгаар нь ангайн цагаан хөөс сахруулах нь бахардах дөхөж байгаа бололтой. Чэнь Жэнь урьд өмнө машинд суучихаад чонын давхилыг ийм удаан ажиглаж байсан удаа үгүй. Талын чоно ч гэсэн ааг амьсгаагаа тасартал атаат дайсандаа хөөгдөж байсан нь үгүй байж таарна. Чэнь Жэнь хэдийгээр тэр бүхнийг харахаас сэтгэл шимшрэх боловч бас ч гэж тэсгэлгүй нүд нээн харж явлаа. Чоно улам хурдлан харайсаар газрын гав руу яваад орчихдог ч болоосой. Эсвэл нисдэг чонын тухай домогт гардагчлан тэнгэрт дүүлэн нисээд үүлс хөлөглөн одоосой. Бүр ядаж өөрийн гүн ухсан нүх тааралдаад шурган ордог ч болоосой хэмээн тэр чин сэтгэлийн угаас хүсэмжлэн залбирна. Гэвч тэр том чоно дээшээ дүүлэн ниссэнгүй, дэргэд тааралдах газрын гав руу шурган орсонгүй. Талын чонын үлгэр домог орчин үеийн дэвшилтэт техникийн өмнө үнэхээр хүчин мөхөсддөг ажээ. Гэвч тэр том чоно зөвхөн чононоос гарах зориг тэвчээрийг харуулан эцсийн хүчээ шавхан давхисаар байлаа. Гагцхүү араас нэхэх атаат дайсан нь хөөхөө больтол харайлгасаар байя гэх

мэт давхиад л байв. Өөрөө шидэгдэн унадаг байлаа ч хамаагүй тэдний машины өмнө гүн жалга, хавцал тааралддаг болоосой гэж Чэнь Жэнь тэр үед ямар их хүсэж байсан гээч . . . . .

Хоёр машинтай хүмүүс өмнө нь ийм сайхан сүрлэг том чоно гараад ирсэнд уусан архинаасаа ч илүү урам зориг орж нүүр нь улаа бутраад ирэв. “Энэ бидний түрүүнд агнасан чононуудаас ч хамаагүй том болохоор арьсаар нь залгаасгүй чонон гудас хийж болох юм байна” хэмээн Бао Шүнь Гүй хашгирна.

“Энэ чонын арьсыг худалдаад хэрэггүй. Манай барилгын цэргийн нэгтгэлийн даргад бэлэглэвэл яасан юм бэ?” гэж Сюй зөвлөх хэлэв.

Баатар зөвлөх түүнийг дэмжин “Зөв шүү. Даргад бэлэглэвэл эндхийн чоно ямар том гэдгийг харахаас гадна чонын хөнөөлийг ойлгох нь лавтай” гэлээ.

Лю жолооч жолоогоо дэлдээд “Өвөрмонголын баян талд ганц жил хүрэхгүй хугацаанд хотын баячуулаас ч илүү тансаг сайхан амьдралыг цогцлоож болох юм байна” хэмээн хөөрцөглөнө.

Тэр мөчид Чэнь Жэнь хөлс чийхарсан нударгаараа тэр Лю овогтын дагзан дундуур татаад авмаар санагдаж явлаа. Гэвч түүний нүдэнд бэлтрэг нь үзэгдэхэд хөхүүл хүүхдээ гэртээ орхисон эх шиг сэтгэл нь зөөлрөөд явчихлаа. Тэр зангидсан нудрагаа дуртай дургүй өвөр дээрээ татан авахад хамаг бие, толгой түрүү нь тэр чигээрээ мод мэт хөшиж орхижээ. Хоёр жийп машин чоныг хөөсөөр гуу жалга, балчиг шавар гэх юм үгүй уужим талын энд авчирсан нь амь гарах ямар ч найдлагагүй болгов. Жийп машинууд дуут дохиогоо чихний хэнгэрэг хагалах шахам хахир муухайгаар орилуулсаар явна. Тэр тоолонд том чонын дөрвөн мөч нь татваганан сүнс нь зайлан алдах ажээ. Хөөрхий чоно яваандаа гүйх ч тэнхэлгүй болон хурд нь саарахын зэрэгцээ амнаас нь цагаан хөөс сахрахаа болив. Хоёр жолооч дуут дохиогоо яаж ч хангинуулаад чонын хурд нэмэгдэх төлөвгүй.

Бао Шүнь Гүй Сюй зөвлөхийн бууг авч чонын тархин дээгүүр хоёр удаа хий буудахад сум нь үсийг зуран өнгөрөв. Чонын хамгийн их айдаг буун дуу түүний чөмгөнд үлдсэн сүүлчийн хүчийг шавхан гаргажээ. Том чоно гурван зуун орчим метр зайд уушиг зүрхээ амаараа гартал давхив. Тэр гэнэт зогсон хамаг хүчээ шавхан оцойгоод суучихлаа.

Хоёр жийп машин түүнээс гурав дөрвөн метр зайд ирж зогсов. Бао Шүнь Гүй буугаа барин үсрэн буугаад хэдэн секунд ажиглахад чоно хөдлөхгүй байхыг үзээд жадаа угсран түүн рүү дөхөн очлоо. Том чонын хамаг бие татваганан харц нь сүүмийж хүүхэн хараа нь томорчээ. Бао Шүнь Гүй түүн рүү бүр дөхөн очиход цаадах нь хөдлөх янз алга. Тэр бууныхаа жадаар чонын амыг сэтгэхэд ч хөдлөхгүй байлаа. Бао Шүнь Гүй тас тас инээн “Энэ чоно чинь бүр айсандаа элий балай болчихжээ” гээд нохой илж байгаа юм шиг түүний толгойг илбэв. Тэр лав хэдэн мянган жилийн турш монгол талын энд амьд чонын толгой илж үзсэн ганц хүн болсон байж таарна. Чоно түүний хариуд ямар ч хариу үйлдэл эс үзүүлнэ. Бао Шүнь Гүй дахин түүний чихийг илэх үед том чоно мянган жилийн чулуун хөшөө мэт газарт пидхийтэл уналаа. . . . .

\* \* \*

Чэнь Жэнь гэмт хэрэг үйлдсэн хүн мэт тал нутгийн монгол гэрийнхээ босгоор алхан орж зүрхэлсэнгүй. Тэр хэсэг зуур эргэлзэн зогссоны эцэст гэртээ оржээ.

Жан Зи Юань, Ян Кө, Гао Зянь Жун хоёрт нийт дивизийн хэмжээнд чоно авлах дайн өрнүүлж байгаа тухай ярьж байв. Тэр их л ууртай маягаар “Одоо дивизийн хэмжээнд дээр доргүй чоно авлаж, арьсыг нь өвчихөөр улайрцгааж байна. Мэргэн буудагчид, өрхийн цэргүүдтэй хамтран хангалттай буу сум, шатахуунаар хангагдаад ачааны болон хөнгөн тэрэг хөлөглөн хөдөлцгөөсөн. Хорооны эмч нар тэдний эгнээнд нэгдээд Бээжингээс өнгө, үнэр, амтгүй хор захиулан авчирч, үхсэн хонь малд тарьсан нь хичнээн олон чонын аминд хүрсэн бол доо? Хамгийн айхтар нь барилгын цэргүүдийг дагалдан ирсэн замчид чоно агнах шинэ арга сэджээ. Тэд уулын чулуу тэслэх бодисыг хонины чөмөгний ясанд хийж өөхөн тосонд дүрээд чоно элбэгтэй газар хаядаг болсон байна. Түүнийг хазсан чонын гавлын яс зад үсэрдэг болсон гэнэ лээ. Тэдний хаясан чөмгөний ясан бөмбөгт чононоос гадна айл хунарын ноход их өртөх болжээ. Талын чонотой тэмцэх ард нийтийн дайн өрнөөд хаа сайгүй “Хэдэн үеэрээ ч хамаагүй тулалдан Хээрийн чоныг үгүй хийцгээе” гэж дуулалдаж байна. Харин малчид цэргийн тойргийн удирдлагуудад энэ тухай хов мэдүүлсэн гэнэ лээ. . . . .” хэмээн өгүүлнэ.

“Манай эндхийн барилгын ажилчид ч ойрдоо зүгээр суусангүй тав зургаан том чоно агнасан гэдэг шүү. Энэ малчин гаралтай суурьшмал иргэдийн чоно агнах арга ухаан улам ч нарийн ажээ. Би хоёр шил цагаан архиа гарздан байж тэдний яаж чоно агнаад байгаа тухай асууж мэдсэн л дээ. Тэд мөн л хавхаар чоно авладаг мөртлөө манай эндхийн малчдаас ч илүү зальжин ухаан гаргасан байна лээ шүү. Эндхийн анчид үхсэн хонь малын хажууд хавхаа булдаг болохоор түүнийг нь чонон сүрэг мэддэг болчихоод хамгийн туршлагатай азарган чоно үнэрлэж олоод хавхыг ухаж гарган тавьсан өгөөшийг идээд явчих нь цөөнгүй байдаг. Тэд чоно элбэгтэй газар хавхаа тавиад хажууд нь малын сэг зэм орхиж үлдээдэггүй. Гэсэн атлаа тэд нар юугаар өгөөш тавьдаг гэж та нар бодож байна даа?. . . . .Хөлсний ажилчид адууны хомоолыг хайлуулсан өөхөн тосонд хийж хатаагаад нунтаглан нэлээд холоос тараан цацсаар хавх байгаа газартаа аваачдаг байна. Тэр хавиар чоно өнгөрөхдөө үхсэн малын сэг зэм, яс үс байхгүй болохоор тайвшран өөхөн тосны үнэрийг шиншилж гүйсээр хавханд орчихдог ажээ. Будаа цацалгүй тахиа хулгайлах энэ арга үнэхээр хорон байгаа биз дээ? Тэд энэ аргаараа нутгийнхаа чоныг зүйл дуусгасан гэж Ван гуай ярьж байдаг шүү” хэмээн Гао Зянь Жун яриу.

Чэнь Жэнь сонсоод байх сонирхол байсангүй гадаа гарч чонын хүрээ рүү бэлтрэгэн дээрээ очлоо. Өдөржин түүний барааг хараагүй бэлтрэг нь ч түүнийг маш их санасан бололтой чонын хүрээний дэргэд сүүлээ өргөчихөөд зогсож байлаа. Чэнь Жэнь явган суугаад бэлтрэгнийхээ толгойг нүүрэндээ удаан гэгч нь наав. Цалин цагаан саран, цавцгар мөнгөн хяруутай уйтай намрын шөнө тэртээх алсад өлөн чонын улих дуун сонсогдоно.

Чэнь Жэнь өлөгчин чоно дайран орж ирээд бэлтрэгийг булаах вий гэж санаа зовох биш, харин ч энэ мөчид тэд бэлтрэгийг нь дагуулан умард хилийн чанадад оччихоосой гэж хүсэмжлэх ажээ. . . .

Хэн нэгний хөлийн чимээ түүний ард ирж зогсоход Ян Көгийн дуу гарч “Цагаан цээжит азарган чоно сүргээ аваад хил хамгаалах зурвасыг даван одсон. Хорооны “Газ” машинаар араас нь хөөгөөд гүйцээгүй гэнэ гэж Лхамжав ярьж байна лээ. Миний санахад тэд лав дахин

Олонбулгийн талд эргэн ирэхээсээ өнгөрсөн байх аа” хэмээн ярив.

Тэр шөнө Чэнь Жэнь шөнөжингөө хөрвөөсөөр цурамхийлгүй хонож билээ.

## Гучин гурав

*Христийн ертөнцийн хувьд 13-15 зууны хоорондох гурван зуун жил бол доройтлын үе байсан юм. Энэ гурван зуун бол монгол үндэстний цаг үе билээ. Төв азиас гаралтай нүүдлийн амьдралын хэвшил тухайн үеийн дэлхий ертөнцийг захирч байлаа. Энэ цаг үеийн оргил үед Хятад, Энэтхэг, Перс, Египет, Умард африк, Балканы хойг, Унгар, Оросыг ноёрхож байсан нь Монголчууд болон тэдэнтэй уг гарваль нэгтэй түрэгчүүдийн хойчис болох Түркүүд байсан билээ.*

*Ж.Вэльс “Дэлхийн түүхийн товчоон”*

Баавгай, бар, арслан, зааны алийг ч аргандаа оруулан хөтлөж болно. Харин гагцхүү талын чоныг л тийн хөтлөж болдоггүй ажгуу.

Нийт багийн үхэр хонин сүрэг үүр цүүрээр хөдлөж баруун хөтлийг даваад түүнээс цааш хэсэг сууриараа салан өөр өөрсдийн намаржаагаа зорин явцгаалаа. Харин хоёрдугаар хэсгийн илгээлтийн эздийн зургаан тэрэг хөдлөж өгөхгүй байсан тул Билиг өвгөн, Галсмаа нар хоёр ч удаа давхин ирж шавдуулав.

Жан Зи Юань гэр орноо нүүлгэлцэхээр ирээд байсан юм. Гэвч мугуйдлан догшрох бэлтрэгний өмнө Чэнь Жэнь, Жан Зи Юань хоёр арга мухардан хоцров. Чоно тэжээгээд хагас жил болох зуур юу эсийг үзсэн боловч түүнийг нүүлгэж суулгах дээр ингэж аргаа барах юм гэж Чэнь Жэнь яахин бодох билээ?

Хаваржаанаас наашаа нүүх үед бэлтрэг тохой хэрийн өндөр байсан тул түүнийг шээзгийд хийчихээд авчирсан. Харин хавар зуны турш чамгүй сайн тэжээж тордсон бэлтрэг одоо дунд зэргийн бие бялдартай чоно болон өсчээ. Гэрт түүнийг хийгээд явчих том төмөр авдар сав байхгүй. Байлаа ч гэсэн Чэнь Жэнь яаж түүнд хийж чадах билээ? Ядаж Ян Кө тэр хоёрын хэдэн хайрцаг ном гэхэд хагас тэрэг зай эзлэх тул бэлтрэгийг суулгаад явах үхэр тэрэг тэднийд алга байв. Данхайтал ачсан зургаан үхэр тэрэг зам зуур эвдэрч саатахыг ч хэн байг гэхэв. Тал нутгийн нүүдэл суудал тэнгэрийн аяыг хардаг болохоор багийн захиргаанаас бороо орохоос өмнө амжиж гэнэт нүүх шийдвэр гаргасан нь Чэнь Жэньг ихэд балмагдуулжээ.

Жан Зи Юань сандарсандаа хөлсөө цувуулж “Чи урьд нь бэлтрэгээ хөтлөж сургахгүй юугаа хийж байсан юм бэ?” хэмээн бухимдав.

Чэнь Жэнь их л уруу дорой байдалтай “Би яаж сургах билээ дээ? Бага байхад нь хөнгөн болохоор хөтлөж явах хэрэг байгаагүй. Харин жаахан том болсон хойно хөтлөж сургах нь байтугай, хөтлөгдөж гүйсээр байгаад таарсан. Жаахан хөтлөж чангаах гэхээр урчих гээд болдоггүй байсан юм. Чоно чинь нохой биш болохоор зодоод алсан ч хүний үгэнд орно гэж байхгүй. Арслан барсаас ч илүү гөжүүд болохоор циркэд тоглодог чоныг чи үзсэн бил үү? Хамгийн мундаг амьтан сургагч ч чоныг эрхэндээ оруулж чадахгүй болохоор Зөвлөлтийн бар тоглуулдаг эмэгтэйг урьж авчраад ч нэмэргүй байж таарна. Чи намайг бодвол олон удаа чонын бараа харсан хүн түүнийг яахин ойлгохгүй байх билээ?” гэв.

Жан Зи Юань шүдээ зуугаад “За би нэг оролдоод үзье. Тэгээд болдоггүй юм бол арай хатуу

гараар үзнэ ээ” гэснээ малиагаа авч Чэнь Жэньгийн гараас төмөр гинжний гархийг аваад бэлтрэгийг чирлээ. Бэлтрэг шүдээ ярзайлган ярдаглаж, дөрвөн мөч нь газар зоолттой мэт арагш цахлан чаргууцалдахад Жан Зи Юань түүнийг ганц алхам хөдөлгөж чадсангүй. Жан Зи Юань ч мөчөөгөө өгсөнгүй олс татаж байгаа юм шиг хамаг хүчээрээ татсан боловч хөдлөх янз алга. Тэр олон юм бодсонгүй төмөр гинжийг мөрөндөө углаад Хөх мөрний гатлага онгоц эрэг рүү чирэгч шиг урагш зүтгэлээ. Бэлтрэгийн бие сая нэг юм газраас ховхорсон боловч дөрвөн хөлийн мөрөөр газарт хоёр ховил жим зурагдан гарав. Бэлтрэгний хоёр нүд цагаанаар эргэлдэн хүндийн төв нь урагшилж ухасхийн дайрлаа. Гинж огцом сулрахад Жан Зи Юань эрчиндээ нүүрээрээ газар харуулдан унахад чоно араас нь тээглэдэн бүдрээд ам нь түүний хүзүүнээс хагас тохойн зайтай ангайн харагдана. Чэнь Жэнь айсандаа ухасхийн очиж бэлтрэгний хүзүүгээр тэврэн авлаа. Чэнь Жэньгийн суганд хавчуулагдсан бэлтрэг Жан Зи Юанийг хазаж чадаагүйдээ хорсож амаа ангайлган хөлөө самардан зүтгэлнэ.

Тэр хоёр зэвхий царайлан амьсгаадан зогсов. “Энэ удаа гурав хоногийн зайтай газар нүүх болохоор баларч дууслаа шүү. Хэрвээ ганц өдрийн зайтай байсан бол бэлтрэгээ энд орхичихоод хоёр тэрэгтэй эргэж ирээд авч болох байсан юм. Гэтэл гурав хоногийн зайд эргэж буцсаар байтал тав хоногийн хугацаа өнгөрнө гэсэн үг. Ноосны агуулахын нярав, хөлсний барилгачид нүүгээгүй байгаа болохоор ганц чоныг үлдээгээд явчихаар тэд нухчихалгүй хайчив гэж. Адаглаад чонын ангуучид амьд үлдээхгүй. Тийм болохоор хоёулаа яадаг ч байсан чоноо тэрэгний ардаас чирээд ч болов авч явъя” хэмээн Жан Зи Юань өгүүлэв.

“Хэд хоногийн өмнө түүнийг үхэр тэрэгний ардаас чирээд явах гэж үзсэн чинь боож үхчих гээд байх юм билээ. Ёстой үхсэн ч бууж өгөхгүй чанар ганц чононд байдгийг тэгэхэд би мэдсэн дээ. Тийм болохоор түүнийг боож алах гээгүй бол тэрэгний араас чирээд нэмэргүй. Ёстой арга мухардана гэдэг энэ байх даа” хэмээн Чэнь Жэнь хэллээ.

“Түүнийг би өөрөө үзмээр байна. Чи нэг жингэр хажууд нь ханьтай уяад үз” хэмээн Жан Зи Юань өгүүлэхэд

Чэнь Жэнь хариуд нь “Би бас туршиж үзсэн. Нэмэргүй юм билээ” гэв.

“Дахин нэг туршаад үзье л дээ” хэмээн Жан Зи Юань хэлээд нэг хүнд ачаатай үхэр тэрэгний арлаас олсоор нэгэн жингэр нохойг оосорлон уяжээ. Жан Зи Юань үхэр тэргээ хөтлөн бэлтрэгийг тойрон явахад жингэр араас нь зөөлөн шогшив. Жан Зи Юань тийн явах зуураа бэлтрэгт хандаж “Бид нар сайхан газар очих гэж байгаа болохоор үхэр тэргийг дагаад явж сураарай. Чи нохойноос ухаантай байж яахаараа ийм амархан зүйлийг сурчихдаггүй билээ” хэмээн аргадна.

Бэлтрэг жингэрийг тоомжиргүй байдалтай харан зогсоно. Чэнь Жэнь түүнийг хууран жингэрийн араас хэд алхав. Бэлтрэг дуртай дургүй хэд алхсан нь үнэн хэрэг дээрээ Чэнь Жэньг чирэн явах ажээ. Тэр охин нохойд татагдсандаа ийн алхсанаас биш үнэндээ явах дуртайдаа биш байлаа. Дахин хэд тойрсоны дараа Чэнь Жэнь гинжний цагаригийг үхэр тэрэгний хөндөл модонд сэмээрхэн углачихав. Тэгэнгүүт бэлтрэг үхэр тэргийг чахартал улам ч илүү хүчлэн цахлалаа.

Уужим талд тэр аяараа ганц ч монгол гэр, нэжгээд хонь мал үзэгдэхгүй болсныг хараад Чэнь Жэнь балмагдан сандрав. Харанхуй болохоос өмнө түр буудаллах газраа очихгүй зам зууртаа төөрч будилж орхивол Ян Көгийн хонин сүрэг, Гао Зянь Жунгийн үхрүүд яах билээ? Өөрсдөө ч хаана очиж хоол цайтай залгах вэ? Нохойгүй ядарсан хүмүүсийн хувьд шөнө орой хамгаас аюултай. Хонин сүрэг аюулд өртөөд чоно тэжээснээс үүдэлтэй гэдгийг тогтоочихвол бэлтрэгийг буудаж, өөрт нь гарцаагүй шийтгэл ирэх болно.

Эцэстээ тэр санаа шулуудан “Түүнийг тавьсан ч чирсэн ч гарцаагүй үхэх болно. Тийм болохоор дүүрсэн хэрэг гээд чирээд явцгаая. Чи үхэр тэргээ хөтлөөд би морийг чинь унаж түүнийг харж явахаас даа” гэлээ.

Жан Зи Юань уртаар санаа алдаад “Нүүдлийн амьдралын нөхцөлд чоно тэжээнэ гэдэг үнэхээр боломжгүй зүйл байжээ” гэв.

Чэнь Жэнь бэлтрэг жингэр хоёрыг чирсэн үхэр тэргийг цувааны хамгийн хойно аваачиж цулбуурыг нь урдах тэрэгний араас уяад “Хөдөлцгөө” хэмээн хашгирлаа.

Жан Зи Юань түрүүчийн үхрийг хөтлөн алхлаа. Үхэр тэрэгнүүд ар араасаа цувран хөдөлцгөөхөд жингэр даган шогшив. Харин бэлтрэг л ганцаараа гурван метр урт төмөр гинжнээсээ чаргууцалдан чирэгдлээ. Гао Зянь Жун үхэр сүргээсээ сонгон өгсөн зургаан амбан шарыг ус голдуу уулган гэдсийг гурван өдөр сойсон тул гэдэс нь шуугдаад хүч тэнхээ нь жагсан нүүдлийн замд шуудран оржээ. Зургаан амбан шарын ширүүн алхаанд явах бэлтгэл ч үгүй байсан хөөрхий бэлтрэг гуд татагдан уналаа.

Бэлтрэг багтартлаа уурлан дөрвөн мөчөөрөө тийчигнэн босож ирсэнээ мөн л арагш цахлан чирэгдэв. Үхэр тэрэг ч замдаа орон алхааны хурд улам ширүүсэв. Бэлтрэг хүзүүгээ гүрдийлгэн арван хэдэн метр газар чирэгдэж байснаа дахиад газар чаргуулдан уналаа. Тэр гинжиндээ үхсэн нохой мэт гулдайн чирэгдэхэд хатсан өвсөнд туг үс наалдан хоцроно. Бэлтрэгний хамгийн амин газар болох багалзуур хүзүүвчиндээ шахагдан хэл нь бултайж, нүд нь цагаанаараа эргэлдэв. Бэлтрэг амаа ангалзуулан амь тэмцэн тийчигнэхэд Чэнь Жэнь айсандаа тэргийг зогс хэмээн хашгирах шахлаа. Энэ мөчид бэлтрэг замын ховилын хажууг хөлөөрөө тийрэн биеийг хөлбөрөн босож ирсэн нь гайхалтай. Гинж тэгширэхээс өмнө бэлтрэг амжин хүндийн төвөө улам хойшлуулан дөрвөн мөчөөрөө газар зуран чирэгдэхэд намрын хатсан өвсийг тармуур мэт хаман урагшлав. Өвс ихсэх тусам түүний гулсахад тээг болоод бэлтрэг мөн л урагш годройтон унах шахлаа. Тэр урагш хоёр алхам гүйснээ мөн арагш цахлан чаргууцалдав.

Жингэр бэлтрэгийг өрөвдсөн мэт харж зөөлөн гийнаад өрөөсөн хөлөө сунгах нь над шиг явахгүй бол боож үхэх нь байна шүү гэдгийг сануулах мэт. Гэвч бэлтрэг түүнийг тоож ч харалгүй өөрийнхөөрөө гэжүүдлэн эсэргүүцлээ илэрхийлсээр байх ажээ. Татагдан унахаараа замын хажуу ирмэгийг тийрэн босож, хэд шогшсоноо хүзүү цахлан чирэгдэж, дахин шургаж унана. . . . Тэр үхэр тэргийг даган нохойтой мөр зэрэгцэн гүйж чадахгүйдээ биш, харин үхлийн цаламтай ингэтэл үйлээ үзэн тэмцдэг нь нохой шиг хүний аясаар хөтлүүлэхгүй гэсэн хэрэг болохыг Чэнь Жэнь төвөггүй ойлгов. Тал нутагт энэ хил хязгаарыг даван гарч хүнд бууж өгсөн чоно урьд өмнө ганц ч гараагүй билээ. Бусдын гарын аяыг дагахгүй байх нь талын монголын зоригт чонын хатуу мөрдлөг бөгөөд чонон сүрэгтэй огт нийлж байгаагүй



бэлтрэгний хувьд ч мөн өөрцгүй байдаг ажээ.

Бэлтрэг ийнхүү үхэн хатан тэмцэлдэх зуур зүлгүүр мэт хатуу элсэрхэг хөрсөн дээр түүний дөрвөн сарвуу зурагдан цус шүүрч эхлэв. Чэнь Жэньгийн өр зүрх хүчтэй базлан өвднө. Түмэн оны турш тал нутгийн баатарлаг үндэстний оюун санааны сүлд болсоор ирсэн чоно гэгч амьтанд хүмүүс биднийг ичээм атлаа хүндэтгэн бишрэхээс өөр аргагүй оюуны далд хүч байдаг ажгуу. Чухам хэд хичнээн хүн талын чоно мэт нугаршгүй зориг хүслийнхээ дагуу амьдарч, хэрэгтэй цагт даван туулж болшгүй гадны хүчийг амь насаа гаргуунд нь гаргаад ч хамаагүй сөрөн зогсож чаддаг билээ дээ?

Чэнь Жэнь үүнийг үзээд талын чонын тухай өөрийнх нь ойлголт дэндүү мөчид болохыг ухаарсан юм. Тэр удаан хугацааны туршид чонын туйлын зорилгыг алах идэх төдийхнөөр төсөөлж явжээ. Одоо эргээд бодоход тэр бодол нь чонын уужим дотрыг өчүүхэн хүмүүний сэтгэлээр шинжсэн хэрэг байлаа. Гэтэл талын чонын туйлын зорилго алах идэх төдийхөн биш харин өөрийн халдашгүй дархан эрх чөлөө, бие даасан байдал, нэр төрөө эрхэмлэх сэтгэл байдаг ажээ. Чухам тэр халдашгүй ариун байдал өөрийг нь сүслэн дээдлэгч тал нутгийн малчдыг насны эцэст огтхон ч эргэлзээгүй мөнөөх нууцлаг хүн тавьдаг газар аваачин сүнсээ талын чонын сүр сүлд лугаа нэгтгэж чадсанаар чөлөөтэй өөдлөн нисэх шидийг олж чаддаг байнам. . .

Гөжүүд бэлтрэг ийнхүү хоёр километр шахам замыг чирэгдэн хүзүүний үс зулгаран халцраад, сарвууны ул хагаран зүсэгдэж цус нь гоожжээ. Бэлтрэг дахин татагдан унахдаа босох тэнхлээ бүрэн алдаад ав хомрогын талбайд уургалагдсан чоно мэт хөдлөх ч үгүй гулдайн чирэгдэв. Удалгүй түүний амнаас цус садран годгодсон нь хүзүүвчиндээ хоолойгоо гэмтээсэн хэрэг байжээ. Чэнь Жэнь айсандаа хөсгийг зогсоогоод мориноос үсрэн бууж бэлтрэгийг тэврэн аваад гинжийг султгав. Бэлтрэг багтран амьсгаадах зуур бөөн цус Чэнь Жэньгийн алган дээр палхийн дусаад хүзүүвчний холгоос ч гарыг нь мөн цустлаа. Бэлтрэг амь голтой төдийхөн цусаар тургиж өвдсөндөө Чэнь Жэньгийн гарыг самардах боловч хурц хумс нь замд зурагдан мөлийгөөд сарвуу язран мах нь цухуйжээ. Чэнь Жэньгийн самсаа шархиран том том нулимс чонын цусан дээр дуслав.

Жан Зи Юань ч гүйн ирж цусандаа хутгалдсан бэлтрэгийг хараад нүдээ бүлтийлгэн цочирдлоо. Тэр яах ийх учраа мэдэхгүй бэлтрэгийг хэд тойрсоноо “Ямар гөжүүд амьтан гэж ийм байдаг байна вэ? Ингэж байгаад үхчихвэл яадаг билээ?” хэмээн халаглана.

Чэнь Жэнь бэлтрэгийг тас тэврэн яахаа мэдэхгүй бачимдахад бэлтрэг өвдсөндөө хамаг бие дагжин тийчигнэж зүрхийг нь улам шимшрүүлэх ажээ.

Жан Зи Юань духны хөлсөө шудран хэсэг зуур бодолхийлж байснаа “Зургаахан сарын настай амьтанг хөтлөж болохгүй байдаг. Гэтэл бид намаржаандаа буусны дараа сардаа нэг удаа нүүх хэрэгтэй болно. Тэр үед бүр ч арга мухардана шүү дээ. Тэгж байснаас .. түүнийг энд . . . заяа нь мэдэг гээд орхичихоод явбал яасан юм бэ?” гэв.

Чэнь Жэньгийн царай байдгаараа зэвхий даагаад “Чи бэлтрэгийг өөрийн гараар өсгөөгүй болохоор яахин ойлгох билээ? Заяа нь мэдэг гэнэ ээ? Тэр чинь үхэг гээд орхисноос өөрцгүй хэрэг. Би түүнийг нас бие гүйцтэл нь тэжээх учиртай юм. Тэр амьд үлдэх учиртай” хэмээн

хашгираад сэтгэл шулуудан ухасхийн босоод хэрэгтэй хэрэггүй зүйлс болон аргал ачсан тэрэгний дэргэд очин сурыг тайлаад хатсан аргалыг замын хажууд асгаж орхилоо. Чэнь Жэнь хашлагатай тэргэндээ бэлтрэгийг ачиж явахаар шийджээ.

Жан Зи Юань учиргүй хориглохгүй боловч “Чи чинь галзуураа юу? Зам зууртаа наад аргалаар чинь хоол ундаа хийж явах гэсэн юм шүү дээ. Гэтэл бороо орвол бид гал алдаж хоолгүй хоцрох болно. Шинэ нутагт ч гэсэн наад аргалаар чинь хэд хоног аргалах байсан юм. Аргалаа асгаж араатныг зөөлөө гээд малчид чамайг элэг доог болгох байлгүй. Цаад Гао Зянь Жун чинь чамд яаж уурлах бол доо?” хэмээн хашгирлаа.

Чэнь Жэнь аргалаа асгах зуураа шүд зуун “Би өнөөдөр хоноглох газартаа хүрээд Галсмаагаас аргал зээлчихнэ ээ. Шинэ нутагт очсон хойноо ч гэсэн би өөрөө аргалаа түүж та нарыг гал алдуулахгүй” гэлээ.

Саяхан амь нас нь дээсэн дөрвөн дээр дэнжигнэж байсан бэлтрэг дөрвөн мөчнийхөө өвдөлтийг үл хайхран босож ирээд амнаасаа цус савируулан цахлан зогссон нь үхэр тэрэгний гэнэт ухасхийхэд унахгүй чирэгдье гэсэн хэрэг ажээ. Түүний нүд шийдэмгий гялалзан шийдвэртэй байрлал эзлэн зогсох нь тавхайны ул цоорч яс нь цухуйсан ч хамаагүй гэсэн шинж илт байлаа. Чэнь Жэньгийн сэтгэл шимшрэн бэлтрэгийг өргөн хажуулдан хэвтүүлж дөрвөн хөлийн зовиурыг нимгэлэв. Дараа нь чингэлэгнээс хурдан цагаан нэрт шархны эм гарган түүний дөрвөн хөл болон хүзүүний холгоосонд түрхэж өглөө. Мөн хоолойны цусыг тогтоох санаатай нэг бүтэн шил эмийг бэлтрэгт цутгав.

Чэнь Жэнь тэрэгний ачааг зайчлан хуучин банз, ширээний тавцан зэргээр хашлагыг өндөрлөөд адсага дэвсэж дээгүүр нь хуучин эсгийгээр хучлаа. Тэгээд бүхий л бэлтгэл хангагдсаны дараа бэлтрэгээ түүнд хийх гэж бөөн асуудал тулгарчээ. Бэлтрэг үхэр тэргийг үхтэл үзэн ядах тул түүнд хавьтах ч үгүй дөлж зугатна. Чэнь Жэнь үхэр тэргэнээс гинжийг салган ханцуй шамлаад бэлтрэгийг тэврэн ачихаар завдлаа. Гэвч тэрэг рүү ганц алхахын төдийд бэлтрэг архиран тийчигнэхэд Чэнь Жэнь яадаг ч байсан тэргэнд ачаадахья гээд цааш хэд алхах гэтэл цаадахь нь ухасхийн гараас нь хавхийтэл хазаад салах янзгүй зууралдав. Чэнь Жэнь “Ёо ёо” хэмээн хашгираад айсандаа хамаг биеийн хар хөлс цутгажээ. Бэлтрэг газар буусан хойноо сая амаа тавихад Чэнь Жэнь өвдсөндөө гараа сэгсэрлээ. Тэр шархаа харвал хэдийгээр цус гараагүй боловч хөл бөмбөгийн хадаастай шаахайнд гишгүүлсэн мэт дөрвөн газар хүрэгтэн хөхөрчээ.

Жан Зи Юаний царай барайгаад “Чи дөрвөн соёог тайрдаг нь болж дээ. Тэгээгүй бол гараа тас хазуулах байлаа шүү. Энэ бэлтрэг том болсон хойно дөрвөн мохоо соёогоор гарыг чинь тас хазаж мэдэх тул түүнийг тэжээхээ больсон нь дээр байх аа” хэмээн хэлэв.

Чэнь Жэнь их л ууртайгаар “Битгий бэлтрэгний соёог тайрсан тухай яриад бай. Хэрвээ би түүний соёог тайраагүйсэн бол өдийд лав хээр талд тавиад явуулчих байсан байж ч мэдэх юм. Гэтэл миний гарын махыг ч даахааргүй зэрэмдэг болсон амьтан хээр талдаа яаж амьдрах билээ дээ. Би л түүнийг ийм эрэмдэг амьтан болгосон болохоор насны эцсийг нь хүртэл тэжээж тэтгэх үүрэгтэй юм. Одоо чинь барилгын цэргийнхэн малчдыг суурин амьдралд шилжүүлэх юм гээ биз дээ? Тэгвэл би түүний гинжийг тайлаад чулуун хороо барьж өгнө” хэмээн хэлэв.

“За за чамайг хориглоод нэмэргүй юм шив дээ. Тийм болохоор аргалж байгаад хөдлөхөө бодъё. Гэтэл . . . наадхийг чинь яаж ачдаг билээ? Чи шархадсан болохоор би туршаад үзэхээс дээ” гэж Жан Зи Юань хэллээ.

“Би тэвэрье. Наадхи чинь чамд сайн дасаагүй болохоор хамрыг чинь тас хазчихаж мэднэ. Би бэлтрэгээ тэргэнд ачингуут чи эсгийгээр хурдан хучаадахаарай” гэж Чэнь Жэнь хэлэв.

“Чи аминаасаа уйдаа юу? Хэл мэдэхгүй адгуусыг дахин тэврэхэд хоолойг чинь тас хазахыг хэн байг гэх вэ?” хэмээн Жан Зи Юань уурсан хашгирлаа.

Чэнь Жэнь хэсэг зуур бодлогоширч байснаа “Хазвал хазахаас биш дээ. Тэгвэл нэг борооны цуваа гарзанд гаргахаас. . . .” гээд чингэлэг тэргэний дэргэд гүйн очоод хальсан дотортой бэрзээнтэн цэрэг ногоон цув гаргаж ирлээ. Мөн бэлтрэгийг тайвшруулахын тулд хоёр хэрчим мах хаяж өгөв. Чэнь Жэнь чичирхийлсэн гараа тогтоогоод бэлтрэгийг мах идэхээр тонгойх зуур ухасхийн цуваа нөмөргөн ороож авлаа. Бэлтрэгний нүд харанхуйлан хэсэг зуур юу хазахаа мэдэхгүй алмайрах зуур Чэнь Жэнь цувгай юутай хээтэй нь тэвэрч аван тийчигнүүлсээр үхэр тэрэгний чингэлэг рүү хийхэд Жан Зи Юань ч амжиж эсгийг дээгүүр нь бүтээлээ. Бэлтрэг цувыг сэгчин ураад толгойгоо гаргаж ирэх үед Чэнь Жэнь, Жан Зи Юань хоёр түүний дээгүүр нөмөргөсөн эсгийг дээсээр хашлагатай нь бөхлөн уяж амжив. Бэлтрэг хашлагатай тэргэн дотроо эргэлдэхэд нөмөргөсөн эсгийгээ урж хаях вий гэж айсандаа Чэнь Жэнь давхийн босож ирлээ.

Ачаа хөсөг хөдлөхөөр болоход нарийн бургасан хашлагатай үхэр тэрэг энэ догшин араатанг тогтоож чадмааргүй мэт Чэнь Жэньд санагдана. Тэгээд тэр бэлтрэгт хэдэн том хэрчим чанасан мах өгч урамшуулав. Тэр намуун дуугаар бэлтрэгийг тайвшруулаад том жижиг нохдоо түүнд хань бараа болгох санаатай тэрэгний ойролцоо дуудан авчирлаа. Жан Зи Юань түүчээ тэргэн дээр суун ташуур өгч хөсөг тэрэг замдаа орцгоов. Чэнь Жэнь бэлтрэгийг догшрох үед бургасан хашлагыг цохиж номхруулахаар тэргэн дээрээс бүдүүн саваа олж барьжээ. Өөрийг нь жаахан холдонгуут бэлтрэг хашлаганы бургасыг тас хазаад үсрэн буух вий гэсэндээ тэр морьтойгоо үхэр тэргэнээс алхам холдохгүй дагаж явав. Төмөр гинжийг хүртэл хүлцдэггүй бэлтрэг яахин бургасан хашлагатай эвлэрэх билээ? Чэнь Жэнь ийнхүү түгшсээр бэлтрэгний архан талд гэлдрүүлнэ.

Гэвч цаашид үүссэн хэрэг явдал Чэнь Жэньгийн бодсоноос огт өөрөөр эргэв. Бэлтрэг мухлаг тэргэн дотор цамнаж сандаачсангүй нүдэнд нь тэр болгон үзэгддэггүй айдсын өнгө тодроод хэвтэж ч зүрхлэлгүй, толгой тонгойн нуруу нумлаж, сүүлээ хавчаад дагжиж чичрэн тэрэгний араас дагах Чэнь Жэньг ширтэн харна. Бэлтрэг донслон дайвалзах тэргэн дээр айсандаа биеэ эвхсэн зараа шиг бөмбөгөнөн атирахыг бургасан хашлаганы завсраар Чэнь Жэнь олж харлаа. Тэр ууж идэн, урж тасдахыг ч умартан усан онгоцон дээр толгой нь эргэсэн хоригдол шиг эсэргүүцэн тэмцэх хүч чадлаа алдаж орхижээ.

Чэнь Жэньд энэ нь нэг л этгээд санагдаж, модон муна барьсаар нэгэн хөтлийг давлаа. Тэр хашлаганы завсраар дахин бэлтрэгээ харваас сүүлээ хавчин хойд хоёр хөлөө хагас нугалсхийн айсан нүдээр Чэнь Жэньг хөөрхийлөлтэй ширтэнэ. Хөлийн тавхай шархтай, амаар нь цус савирсан бэлтрэг ядарч туйлдсан атлаа хэвтэж зүрхлэхгүй, гагцхүү гялалзсан харц нь тархи сэргэлэн байгааг илтгэнэ. Бэлтрэг үхэр тэрэгний донсолгоо болон газрын хөрснөөс

хөндийрсөнд зөн совингоороо айж байгаа бололтой. Хагас жилийн турш бэлтрэгний оньсог мэт олон олон нууцлаг үйл хөдлөлийг Чэнь Жэнь яаж ч бодоод учрыг олохгүй буюу эсвэл тайлбарлах арга мухарддаг байлаа.

Амбан шарнуудын ширүүн алхааны хүчинд тэрэг хөсөг шуурхай урагшилна. Чэнь Жэнь морины зөөлөн явдал дунд гүн бодолд дарагдлаа. “Дөнгөж саяхан тийм ширүүн догшин авирлаж байсан бэлтрэг яахаараа гэнэт ийм аймхай сул дорой нэгэн болон хувирдаг билээ? Энэ байдал талын чонын ааш авиртай зохицохгүй хэрэг биш үү? Хорвоод төгс төгөлдөр баатар эр гэж байдаггүйтэй нэгэн адил ертөнцийн баатар зоригтнуудад адилхан аминд хүрч мэдэхээр сул дорой чанар бас байдаг юм болов уу? Чэнь Жэньгийн хувьд хамгийн төгс хувьссан мэт санагдаж байсан талын чононд зан араншингийн сул тал бас байж болох уу?”

Чэнь Жэнь бэлтрэгийг харан тархиа гашилтал бодох зуур цаадахь нь хэн нэгэн хүн буюу ямар нэгэн зүйлтэй адилтгаж болмоор санагдана. Тийнхүү эрэгцүүлэн бодсоор байтал түүний тархинд гэнэт эртний Герегийн домог үлгэрт гардаг аруухан баатар<sup>42</sup> Антейгийн нэр харван орж ирэв. Үнэхээр талын чоно Антей баатартай адилхан аминд хүрэхээр сул талтай юм гэж үү дээ? Герегийн домог үлгэрийн Антей баатар хорвоод хосгүй эрдэм чадал, эрэлхэг зоригтой боловч өөрийг нь төрүүлж өсгөсөн газар эх Гайягаасаа хөндийрөнгүүт хамаг хүч чадлаа алдаж орхидог сул талтай байсан гэдэг. Түүний хүчтэй өрсөлдөгч Геркулес баатар энэ сул талыг мэдчихээд түүнийг агаарт өргөн боомилж алдаг шүү дээ. Талын чоно ч гэсэн өөрийг нь төрүүлж өсгөсөн газар эхээс хөндийрөнгүүт хувилгаан чадлаа алдаад сул дорой нэгэн болон хувирдаг юм болов уу? Талын чоно эх газартаа тийм их ээнэгшин дасдаг юм гэж үү? Түүний эр зориг эрч хүчний ундарга тал нутагтайгаа амин хүйгээр холбоотой байдаг байж болох уу?

Антей баатар болон түүний газар эх Гайя нарын тухай домог үлгэр арай талын чононоос үүдэлтэй хэрэг биш байгаа гэсэн бодол түүнд төрөв. Ямартай боловч нүүдэлчин Арийчуудаас гаралтай Герегчүүдийн өвөг дээдэс эрт балар цагт бэлтрэг тэжээж байсан байх магадлал тун өндөр юм. Тэд бэлтрэгийг хол газар зөөн аваачих явцдаа түүний ухаан санаанд багтамгүй агаад сайтар бодууштай энэ сул талыг ажигласны үндсэн дээр сая мөнөөх агуу гайхамшигтай домог үлгэрийг туурвисан байж ч мэднэ. Антей баатар газар эх Гайя нарын тухай домог үлгэрийн далд гүн ухаан өрнө дорнын олон олон хүмүүсийн оюун санаа итгэл үнэмшилд ихээхэн нөлөө үзүүлсээр ирсэн. Ямар сайндаа л большевик намын түүх зохиолын төгсгөлийн үгэнд “Даян дэлхийн коммунистууд өөрсдийн газар эх болсон ард түмнээс холдон хөндийрч болохгүй. Эс бөгөөс хичнээн хүчирхэг нам байгаад ч хий агаар дахь дайсандаа няц боомилогдон үхэх болно” гэсэн байдаг билээ. Чэнь Жэнь большевик намын түүх зохиолын хамгийн сүүлчийн хоёр хуудсан дахь домог үлгэртэй холбоо бүхий хэсгийг цээжээр мэддэг болсон юм.

Гэвч тэр монголын уудам талд мөнөөх агуу их домог үлгэрийн уг сурвалжийг биетээр нь олж үзэх юм гэж яахин санах билээ? Герегийн домог үлгэр хоёр мянган гаруй жилийн тэртээ зохиогдсон боловч талын чоно хэдэн мянганы тэртээх өөрийн зан араншин болоод сул дорой талыг хадгалсаар иржээ. Талын чоно хэмээх энэ эрт балрын амьд чулуужмал орчин үеийн хүмүүст хүн төрөлхтний тэргүүлэх үндэстнүүдийн оюун санааны уг сурвалж болоод хөгжлийн оньсыг судлаж тогтооход туйлын чухал үнэ цэнэтэй ажгуу. Чэнь Жэнь Ром хотын

сүлдэн дээр дүрслэгдсэн өлөгчин чоно болоод түүний сүүг хөхөн томроод тус хотыг үндэслэсэн ах дүү хоёр жаалын дүрсийг өөрийн эрхгүй эргэн саналаа. . . . . Чоно өрнө дорнын хүмүүсийн оюун санаанд шавхагдашгүй нөлөө үзүүлээд зогсоогүй өнөө хэр чонын үзэл санааны гүн ухаан урьдын адил тэргүүлэх үндэстнүүдийг залж чиглүүлсээр байнам бус уу? Харин бодит амьдрал дээр чоно гээч амьтад тэнэг мулгуу хүмүүсийн хайр энэрэлгүй харгислал аллагад өртсөөр л байна. . . . .

Чэнь Жэньгийн гарын шарх зүрх зүсэм өвдлөө. Гэвч тэр бэлтрэгээ буруушаасангүй, харин ч цаг ямагт ухаарал нэмж байдаг түүнд талархаж явав. Тэр яадаг ч байсан бэлтрэгээ сүрлэг сайхан чоно болгон өсгөөд үр төлийг нь үлдээх учиртай.

Гүн ухаан дэндүү гүн нарийн учраас Чэнь Жэнь арга буюу нүдний өмнөх бодит амьдралдаа эргэн ирэв. Намаржаа өвөлжөөнд буугаад ойр ойрхон нүүдэл суудал хийх үед яадаг билээ? Ялангуяа бэлтрэгийг том чоно болсон хойно хэн өргөж тэргэнд ачих вэ? Түүнд зориулсан тусгай тэрэг тоноглохгүй бол болохгүй байж мэднэ. Гэтэл өвлийн цагт нэг тэргэн дээрээ мах хадгалдаг болохоор тийм илүүдээ гарсан тэрэг хаанаас олох билээ? Зам зуур хэрэглэх аргалаа асгаад хаячихсан улс одоо яаж хоол цайгаа хийх вэ? Дандаа Галсмаагаас зээлээд байна ч гэж юу байхав гэсэн элдэв бодол түүний толгойд хөвөрнө.

Хөтлийг уруудаад үхэр сүргийн үнэрийг авсан зургаан амбан шарын алхаа ширүүсэж алсад цацсан гүнжид мэт бөртийн харагдах их нүүдлийн барааг чиглэн хурдлалаа.

\* \* \*

Нүүдлийн цуваа зуслангийн бэлчээрийн зааг болох нэгэн уулын амаар дайран өнгөрөх үед “Газ” маркийн ачааны машин өөдөөс нь тоос босгосоор давхин хүрч ирлээ. Үхэр тэрэг зам тавьж өгөхөөс өмнө мөнөөх машин тэднийг тойрон давхижээ. Машины тэвшин дээр хоёр буутай цэрэг, аж ахуйн төвийн хэдэн ажилтан болон нэг дан тэрлэгтэй малчин тэдэн рүү гар даллах нь Дорж болохыг Чэнь Жэнь төвөггүй танив. Чонын ангууч Дорж болон боохойн эрлэг болсон “Газ” машиныг хараад Чэнь Жэньгийн уушиг зүрх амаараа гарах шахлаа. Тэр хөсгийн эхэнд гүйн очоод “Цаад Дорж чинь буутай хүмүүс дагуулаад чоно авлах гэж байгаа юм болов уу?” хэмээн Жан Зи Юанаас асуув.

“Энэ гүвээ даваа элбэг, нуур цөөрөм ихтэй газар машин яаж хурдан давхиж чадах вэ? Агуулахын ажилчдыг зөөх гэж яваа биз дээ?” хэмээн Жан Зи Юань хэллээ.

Тэд нэг өргөн нуга руу орох үед өөдөөс нь нэгэн морьтон давхин ирэх нь Билиг өвгөн байлаа. Өвгөний царай барайн амьсгаадаад “Та хоёр саяын машин дээр Дорж байхыг харав уу?” хэмээн асуув.

Нөгөө хоёр нь ч харсан гэхэд өвгөн Чэнь Жэньд хандаж “Хоёулаа хуучин бууриараа очоод ирье. Харин Жан Зи Юань чи ганцаараа түрүүлээд явж бай. Бид удахгүй эргээд ирнэ” гэлээ.

“Чи арын тэргэнд байгаа бэлтрэгээ сайн харж байдаг юм шүү. Тонгочоод тэргээ эвдэлчихвэл намайг иртэл хүлээж байгаарай” хэмээн Чэнь Жэнь Жан Зи Юаньд хэлчихээд өвгөнийг дагалдан ирсэн замаараа ширүүхэн хагируулав. Өвгөн өгүүлрүүн “Цаад Дорж чинь чоно

авлахаар хүн дагуулж яваа байх нь. Ойрдоо цаадахь чинь чоно авлах чадвараа ганц сайн харуулж байх шиг байна. Тэр хятад хэлэнд ус цас болохоор чоно авлах хорооны зөвлөх болсон гэнэ лээ. Үхэр сүргээ дүүдээ ацаглаж үлдээчихээд өөрөө том жижиг тэрэг хөлөглөн чоно авлаж явдаг болсон. Тэгээд дээд доод шатны дарга нартай сүжрэн хэдэн өдрийн өмнө дивизийн даргыг дагалдан хэдэн том чоно авлаад жинхэнэ чоно агнагч баатар болсон сурагтай” гэв.

“Гэвч энэ гүвээ толгод нуур ус болсон газар цаадахь чинь яаж чоно авладаг билээ гэдгийг би нэг л сайн ойлгохгүй байна шүү” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

“Нэг адуучин Доржийг баахан хүмүүс дагуулан хуучин бууриа эргэхээр явсан гэхээр би яах санаатайг нь ойлголоо л доо” хэмээн өвгөн өгүүлэхэд

“Яах санаатай хэрэг вэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Өвгөн хариуд нь “Тэр айлуудын хуучин бууриар хор цацаж, хавх тавих гэж байгаа хэрэг. Олонбулгийн талын хөгшин, доголон, өвчтэй чононууд хөөрхийс минь, өөрсдөө ан хийж чадахгүй болохоор чонон сүргийн үлдээсэн араг яс төдийхнийг мэргэ амь зогоодог юм. Тэд бас хүн нохдын үлдээсэн зүйлийг олж гэдэс гарах нь ч бий. Тийм чононууд айл хунар нүүсний дараа хуучин буурины хавиар эргэлдэн яс үс, хонины толгой, газар булсан өвчтэй малын сэгийг ухан гаргаж иддэг. Манай нутгийн хөгшчүүд түүнийг андахгүй л дээ. Зарим малчид хуучин буурин дээрээ ямар нэгэн зүйлээ мартчихаад авахаар ирэхэд чоно тэр хавиар эргэсний ул мөрийг олж үздэг юм. Бурхан номд сүжигтэй малчид угаас сэтгэл сайтай тул хуучин буурийг нь эргэдэг өвчтэй, хөгшин чононд хавх тавьж хор хаян жудгаа алдахгүй. Харин ч зарим хөгшчүүл нүүдэл суудлын үеэр зориуд хоол хүнсийг тийм ядарсан дорой чононд үлдээж орхих нь ч бий.

Гэвч гадны цагаач айлууд манай нутагт он удаан жил оршин суухдаа тэр сиймхийг олж харж л дээ. Доржийнхон бүр эцгийнх нь үеэс эхлэн хуучин буурин дээрээ үхсэн хонинд хор шингээн, ойролцоо хавх тавьж чоно агнан арьсыг өвчиж сурсан улс. Тэднийхэн угаас Бурхан ном шүтдэггүй, чоныг дээдлэдэггүй, хамгийн болж бүтэхгүй хорон аргуудыг хэрэглэж хөгшин, өвчтэй чоныг хүртэл тэсгээдэггүй болохоор бусдаас олон чоно улсад тушаасан нэр зүүлгүй яахав дээ. Чоно хэдий муу нэртэй боловч хүний хорон муухай аргын дэргэд бол юухан байх билээ?” хэмээн өвгөн хэллээ.

Түүний харц будангуйрч ямаан сахал нь чичирхийлээд өгүүлрүүн “Тэд ойрдоо өч төчнөөн чоно алсан болохоор эр чадалтай чононууд идэш тэжээлийн асуудлыг ч хойш тавин бүгж нуугдсан байж таарна. Тийм болохоор багийн хүн малыг нүүгээд явчихаар тэд нар хүртэл манай хуучин буурийг эргэх нь гарцаагүй. Цаад Дорж чинь чононоос илүү зальхай золиг болохоор түүнийг яахин эс андах билээ? Энэ маягаар агнаад байвал Олонбулгийн хүмүүс өөд болохын цагт тэнгэрт одож чадахгүй, тал нутаг маань там болж хувирах нь дээ” гэв.

Цөвүүн цагийн түрүүчтэй учирч яваа тал нутгийн хөгшний шаналлыг тайтгаруулах арга Чэнь Жэньд үнэхээр олдсонгүй. Тариачин хүн амын хэт олшрол болон суурьшмал соёлын тал нутаг дахь түрэлтийг хэн зогсоож чадах билээ? Чэнь Жэнь арга мухардсандаа хөгшин аавдаа хандан “Та харж л байгаарай, би өнөөдөр тэдний тавьсан хавхыг бүгдийг нь сугалаад

хаячихна” хэмээн өгүүлэв.

Тэр хоёр хөтлийг даван ойролцоох нэг айлын буурь руу давхилаа. Хуучин буурины ойролцоо үнэхээр хөнгөн тэрэгний дугуйн мөр үлджээ. Машин гэдэг хурдтай эд болохоор аль хэдийн гүвээ даван одсон байлаа. Тэр хоёр морины туурайг хавханд орохоос болгоомжлон хамаагүй дөхөж чадсангүй. Мань хоёр мориноос буугаад өвгөн ийш тийш харж байснаа үнс асгасан нүхийг зааж “Дорж тэр хавхыг тун айхтар тавьсан байна шүү. Тэр цацсан үнсний дэргэд хавх тавиад хажууд нь хоёр хонины шийр орхижээ. Хэрвээ хоёр хэсэг хонины мах тавьсан бол чоно харин ч сэжиглэх байсан юм. Хоёр муу шийр хогон дотор хэвтэж л байдаг зүйл тул чоно амархан хууртагдаж мэднэ. Тэр хавхаа тавихдаа гараа үнсэнд дүрсэн тул үнэрийг нь дарсан байж таарах нь. Уг нь азарган чоно бол ч хавхных нь үнэрийг андахгүй л дээ. Харин хөгшин чонын хамар муудсан байдаг тул үнэртэж чадахгүй. . . .” хэмээн хэлэв.

Чэнь Жэнь уурлаж цочирдоод үг ч дуугарч чадсангүй.

Өвгөн тугалын баасны хажууд орхисон өвчтэй хонины өрөөл сэгийг зааж “Тэр хонины маханд лав хор шингээсэн байж таарна. Тэд нар Бээжингээс чоно ч үнэртэж чадахааргүй сайн чанарын хор захиалан авчирсан. Түүнийг идсэн чоно тамхи нэрэхийн зуур нүд аньдаг гэлцэх болсон юм” гэв.

“Би энэ хонийг чирэн хаягдмал худагт хаячихаад ирье” хэмээн Чэнь Жэньг хэлэхэд

Өвгөн хариуд нь “Чи олон буурин дээр хаясан сэгүүдийг зөөж барна гэж үү?” гэжээ.

Тэр хоёр мориндоо мордон дөрөв таван бууриар эргэж үзэхэд Дорж дандаа өөр өөр арга хэрэглэжээ. Заримд нь хор хаяж, хавх тавьсан бол өөр нэг газарт хоёуланг нь зэрэг хэрэглэсэн төдийгүй тэр бүхнийгээ тун овжин далдалсан байв. Тийм болохоор нэг газар чоно хордон, хавханд орсон байлаа гэхэд нөгөө буурин дээр үргэлжлүүлэн хууртаж мэдэхээр ажээ.

Дорж хор түлхүү хаяж, хавх цөөн тавьсан болохыг мань хоёр олж үзэв. Мөртлөө хавх тавих гэж газар ухалгүй шулуухан үнсний нүхэнд булсан байлаа. Тийм болохоор Дорж маш шуурхай ажиллан хагас өдөр хүрэхгүй хугацаанд нийт багийн айлуудын буурийг эргэж амжих нь тодорхой юм.

Тэд цааш явбал Доржид мэдэгдэх болно гээд морины амыг татав. Билиг өвгөн мориныхоо амыг татан буцах замдаа “Ийм цөөхөн чоно аврах боломжтой байх гэж” хэмээн үглэнэ. Тэр хоёр нэгэн хотны хуучин буурин дээр ирэхэд өвгөн хонины өмхий гуяны дэргэд болгоомжтой дөхөн очоод өврөөсөө жижиг ууттай нунтаг цагаан бодис гарган түүн дээр цацлаа. Энэ бол ханган нийлүүлэх хоршоонд зардаг муу чанарын чононы хор болохыг үзээд Чэнь Жэнь өвгөний санааг төвөггүй ойлгов. Хүч багатай, үнэр ихтэй энэхүү хорыг хэр баргийн чоно андахгүй мэднэ. Муу хорыг сайн хорон дээр цацсанаар Доржийн санаархал талаар болж таарна.

Өвгөн хаанаас Доржийн дор орох билээ гэж бодоод Чэнь Жэнь асууруун “Наад хор чинь салхинд хийсчихгүй байгаа даа?” гэхэд

“Үгүй дээ, яадаг ч байлаа гэсэн чоно үнэртэж таарна” хэмээн өвгөн хэлэв.

Өвгөн хэдэн хавх тавьсан газарт ирж Чэнь Жэньгээр булууны яс зэрэг томоохон зүйл олуулан дээр нь хаяуллаа. Энэ бол зальтай хашир чонын хавхыг дөнгөдөг аргуудын нэг юм.

Тэр хоёр дараачийн хот айлын буурийг зорин явлаа. Ингэсээр өвгөний хор дуусахад тэд сая хөлгийн жолоог эргүүлэв.

“Аав аа, хэрвээ тэд эргэж ирээд хавх нь ажиллагаагүй болсоныг үзвэл яадаг билээ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа. Өвгөн хариуд нь “Тэд нар цаашаа чоно алах гэж яваад нааш зүглэхгүй байж таарна” гэв. “Тэгвэл тэд хэд хоногийн дараа нааш ирээд хавхыг нь хүн хөндсөнийг мэдээд чоно авлах хөдөлгөөнд саад учрууллаа гэж асуудал босговол яах вэ? Баларсан хэрэг болохгүй юу?” гэж Чэнь Жэнь асуув.

“Миний балрах Олонбулгийн талын учрах аюулын хажууд юухан байх билээ. Чоно байхгүй болчихоор талын хөрс улаанаараа эргэлдэж таарна. Тал нутаг байхгүй болохоор тэд нар өөрсдөө ч хаашаа оргон зайлах вэ? . . . Би яахав хэдэн чонын амийг хэлтрүүлээ биз. Олонбулгийн чононууд хурдан дайжин алга болоосой доо. Тэртээх очих ёстой газартаа хүрэх хэрэгтэй. . . . Хэрвээ Дорж тэд нар над дээр олон юм ярьж ирэх юм бол надад ч уураа гаргах боломж тохиох нь тэр дээ” хэмээн өвгөн хэллээ.

Тэр хоёр нэгэн хөтөл дээр гарахад ижлээ эрэн гаслантай ганганалдах хэдэн хээрийн галуу агаарт эргэлдэн ниснэ. Өвгөн морины амыг татан дээш харж санаа алдаад “Хээрийн галууд хүртэл тэдэнд алуулсаар зэллэн нисэх бүлгүй болжээ” гэснээ өөрийн нээж ашигласан шинэ нутаг бэлчээрийг эргэн харахад нүдэнд нь цийлэн хөх нулимс мэлмэрч байлаа.

Чэнь Жэнь тэр хоёрыг анх наашаа ирэхэд хосгүй үзэсгэлэнгээ гайхуулан байсан энэ нутаг ганцхан зуны хугацаанд хун, галуу, нугас болон талын чонын булш болон хувирчээ. “Аав аа, та бид хоёр буянтай сайхан үйлийг бүтээж байгаа атлаа буруу замын хулгай нар шиг ингэж явах ч гэж дээ. Аав аа, би ганц сайн уйлж авмаар байна шүү. . . ” гэж Чэнь Жэнь хэлэв.

Өвгөн хариуд нь “Уйл уйл хүү минь. Аав нь ч гэсэн нулимсаа барьж чадахгүй нь. Талын чоно олон үеийн монголчуудын сүнсийг тэнгэрийн оронд аваачсан юмсан. Гэтэл яахаараа аавынх нь үед бидний бүтэл ингэтлээ айхтар хазайдаг байна даа. . . . ” хэмээн өвгөн хэллээ.

Хөх тэнгэрээ ширтэх хөөрхий өвгөн нус нулимсандаа хутгалдаад “Ий. . . ий ий. . . ” хэмээн хөгшин чоно улих мэт цурхиран уйлж гарлаа. Чэнь Жэньгийн нүд ч бүрэлзэн хөгшин аавынхаа нулимстай хамсан горхилоод Олонбулгийн талын хөрсөнд шингэж билээ. . . .

\* \* \*

Бэлтрэг өвчнөө тэсвэрлэн хоёр өдрийн турш мухлаг тэргэнд зогсоогоороо явжээ. Хоёрдахь өдрийн харуй бүрийн үед Чэнь Жэнь, Жан Зи Юань нарын тэрэг хөсөг намрын шаргал өвс халиурсан нэгэн уужим дэвсэгт хүрэлцэн ирвэл хөрш Гомбынх тэнд гэрээ барьж байлаа. Гао Зянь Жун Билиг өвгөний зааж өгсөн шинэ хотны буурин дээр үхэр сүрэгтэйгээ ирчихсэн хүлээж байна. Ян Кө ч хонио туугаад дөтлөн айсуй гэнэ. Чэнь Жэнь нөгөө хоёртойгоо



хамжин гэрээ барилаа. Галсмаа Баяр хоёр үхэр тэргэндээ хоёр араг аргал ачаад хүргэж ирэв. Хоёр өдөр нэг шөнийн турш амсхийлгүй аяны мөр хөөсөн тэр гурав ингэж нэг гал хөс, халуун хоол цайтай залгах боломжтой болжээ. Оройн хоолны өмнөхөн Ян Кө ирэх зам зуураа хуучин үхэр тэрэгний эвдэрхий арал олж ирсэн нь хоёр ч удаа хоол хийчихэж болохоор ажээ. Чэнь Жэньг хагас тэрэг шахам аргал асгасны төлөө хоёр өдөр баргар царайлан явсан Гао Зянь Жун түүнийг хараад овоо дуу шуутай болов.

Чэнь Жэнь, Жан Зи Юань, Ян Кө хоёрыг дагуулан мухлаг тэрэг рүү алхацгаалаа. Тэд тэргэн дээгүүр хучсан зузаан эсгийг хуулж авбаас бэлтрэг тэрэгний өндөр хашлагыг мохоо шүд, мөлгөр хумсаараа хазлаж урсаар хөл бөмбөгийн чинээ том онгорхой гаргаж, үртэс нь хуучин цэрэг цуван дээр унасан байхыг олж үзэв. Урьд шөнө тэрэг хөсөг хоноглохоор буудаллах үед бэлтрэг ийм ажил хийснийг ойлгоод Чэнь Жэньгийн зүрх пэл пэл цохиллоо. Хэрвээ жаахан л оройтсон бол бэлтрэг тэр нүхээр оргон зайлах байсан нь гарцаагүй. Гэвч түүний гинжийг мөн л хашлаганы үзүүрт өлгөсөн тул түүнд татагдан боомилогдох буюу эсвэл тэрэгний хүрдэнд дайрагдан үхэх байжээ. Бургасны үртсэн дээр багагүй цус тогтсон байхыг Чэнь Жэнь олж үзээд Жан Зи Юантай хамжин хашлагыг тэрэгнээс өргөн буулгалаа. Бэлтрэг зүлгэн дээр сэвхийн буухад Чэнь Жэнь гинжний үзүүрээс барин монгол гэрийн өмнө тийш зүглэв. Ян Кө ч даруйхан газар ухаж модон шонг суулгаад гинжний гогцоог түүнд углажээ. Үхтлээ айж цочсон бэлтрэгт газар дайвалзаад байгаа бололтой хажуулдан хэвгэхэд тамтран шархалсан тавхай нь хатуу юманд хөндөгдөхөөргүй болов. Тэр ядарсандаа толгойгоо ч даахгүй болжээ.

Чэнь Жэнь бэлтрэгний ар дагзнаас барьж байгаад хоёр эрхий хуруугаараа завьжийг нь шахан амыг нь ангайлгав. Түүний хоолойн цус овоо тогтсон боловч мохоо соёонуудын буйлнаас цус шүүрнэ. Тэр амыг нь сайн барьж байгаад Ян Көгөөр тэмтрүүлж үзүүлвээс цаадахь нь “Соёонууд нь хөдлөөд хариугүй унах нь ээ” гэхэд Чэнь Жэнь өөрийнх нь шүд унаснаас илүү шаналжээ. Хоёр өдрийн турш бэлтрэг халуун цус хайран амиа ч хайхрахгүй эрх чөлөөгөө эрэн тэмцэхдээ дөрвөн соёогоо хүртэл гаргуунд гаргадаг байна шүү. Чэнь Жэнь гараа тавихад бэлтрэг байн байн соёонуудаа долоох нь чамгүй өвдөж байгаа бололтой. Ян Кө болгоомжтойгоор бэлтрэгний дөрвөн сарвуунд эм түрхэж өгөв.

Оройн хоолны дараа Чэнь Жэнь гурилтай хоолны үлдэгдэл дээр махны өвдөл цөвдөл нэмж хөргөөд бэлтрэгний өмнө аваачиж тавьлаа. Бэлтрэг маш их өлссөн тул яах ийхийн зуургүй идүүрийн ёроолыг гялтайлгав. Гэвч бэлтрэг урьдын адил шаламгай залгих биш хоолойн хөндүүртээ зовиурлан байн байн өвчтэй соёогоо долоож байхыг Чэнь Жэнь олж мэджээ. Түүгээр зогсохгүй идэж дууссаны дараа хахаж цацахад нь хоолны цустай үлдэгдэл амаар нь гарч ирэв. “Бэлтрэг шүдээ гэмтээснээр үл барам залгиур болон улаан хоолой нь ч ноцтой шархалжээ. Гэтэл түүнийг үзэхээр ирэх малын эмч хаанаас байх билээ дээ?” хэмээн Чэнь Жэнь халаглан бодлоо.

“Чонон сүрэгт угаас урвагчид болоод унхиагүй амьтад байдаггүй болохоор бүгд үхэхийг үл тоох, халширашгүй хатуу чанга зоригтонгууд байдаг ажээ. Байсан цөөн хэд нь тал нутгийн хатуу хүтүү нөхцөлд арчигдан үгүй болсон байж таарна” хэмээн Ян Кө Чэнь Жэньд хандан өгүүлэв.

Чэнь Жэнь их л шаналангүй байртай “Хөөрхий энэ бэлтрэг өөрийн нугаршгүй хатуу чанга

зангаасаа болж дэндүү их өр төлөөс амслаа даа. Хүнийг ямар хүн болохыг гурван настайд нь, яаж өтлөхийг долоотойд нь шинж гэсэн үг байдаг. Тэгвэл ямар чоно болохыг гурван сартайд нь яаж өтлөхийг долоон сартайгаас нь харж болох ажээ” гэв.

Хоёр дахь өдрийн өглөө Чэнь Жэнь дадал ёсоор чонын хүрээг цэвэрлэхээр очиход түүний баас зэгэл цайвар бус, тас харласан байхыг олж үзээд айсандаа бэлтрэгний амыг ангайлган харваас хоолойных нь цус шүүрсээр байлаа. Тэр Ян Көгөөр амыг нь ангайлгаж байгаад савхны үзүүрт жижиг эсгий бөхлөн хурдан цагаан эмийг түрхэх гэсэн боловч хоолойд нь яагаад ч хүрэх янзгүй ажээ. Мань хоёр хар аргаар домнох гэж үйлээ үзэж байх зуураа эртхэн мал эмнэлэг судлаж байх минь яалаа гэж халаглацгааж байв.

Дөрөв дэх өдрөөс эхлэн бэлтрэгний баасны өнгө хэвийн байдалд орж цовоо цолгин зан нь сэргэхэд мань хоёр жаахан уужуу амьсгаа авцгааж билээ.

## Гучин дөрөв

*Маш урт хугацааны туршид аливаа соёл иргэнийл нь хаант төрийн тогтолцооны замаар оршин хөгжиж ирсэн байдаг. Бараг бүх хаад болон төр улс нь эхэндээ хамаг хүчээ шавхан улс гэрээ төвхнүүлж авсаны дараа цэнгэл жаргалдаа ташууран уруудан доройтсоор эцэс сүүлдээ говь цөл, тал хээрээс гаралтай илүү эрч хүчтэй үндэстэнд эзлэгдсэн үйл явцыг олж үзэж болох юм.*

.....

*Хувь хүний үүднээс авч үзэх юм бол бидний мэдэх Нордик, Шумит болон Монгол үндэстнүүд бүгд суурьшмал үндэстнүүдээс илүү цовоо сэргэлэн хатан зоригтой зан чанарыг өөртөө шингээсэн байдаг.*

*Ж.Вэльс “Дэлхийн түүхийн товчоон”*

Барилгын цэргийн нэгтгэл болон өрхийн цэргийн дивизийн үйлдвэрлэлийн хуралд Билиг өвгөнийг оролцуулахгүй болсон тул тэр гэрээс гаралгүй дуу шуугаа хураагаад арьс нэхий элдэн суудаг болов.

Зун намрын улиралд малчдын хазаар, ногт, чөдөр, тушаа зэрэг суран эдлэл дэвтэж, хатсаар бөх баг чанараа алдан эдэлгээ даахааргүй болсноос адуу морьд хазаар ногт ногтноос мултран, чөдрөө тасдаж сүрэг рүүгээ гүйх явдал цөөнгүй гарах болжээ.

Тийм болохоор цаг завтай болсон Билиг өвгөн ар гэрийнхэн болон хэсгийн малчид, илгээлтийн эздийн суран эдлэлийг сэлбэж янзлаж буй нь энэ билээ. Чэнь Жэнь, Ян Кө, Гао Зянь Жун гурав ч зав л гарвал тэднийхээр очиж суран эдлэл хийх арга ухаанд суралцдаг болов. Арван хэдэн өдөр болоход тэр гурав овоо боломжийн ногт, ташуур зэргийг хийж сурсанаар үл барам Ян Кө бүр хамгийн адармаатай үйл болох чөдөр хүртэл зангидаж сурсан байна.

Өвгөний уужим монгол гэр арьсан эдлэлийн урлан болон хувираад овоолоостой идээлсэн ширний үнэр хамар цоргин сэнгэнэнэ. Бэлэн болсон бүтээгдхүүнд тарваганы тос түрхсэнээр сая сүүлчийн дамжлага гүйцэх ажээ.

Тарваганы тос нь тал нутгийн хамгийн үнэтэй нандин бүтээгдхүүн юм. Өвөрмонголын өндөрлөг нутагт өвлийн улирал онцгой хүйтэн байдаг тул өөхөн тос, шар тос, дизелийн тос зэрэг бодис барьцалдан хөлдчихөөд байхад гагцхүү тарваганы тос л халуун чанар онцгой болохоор дүн өвлийн гучин градусын халуунд ч шилэндээ зунгааралдасхийгээд байж л байна.

Тал нутгийн өвөрмөц бүтээгдхүүн болох тарваганы тосыг малчин айл болгон нандигнан хадгалж байдаг. Идэр есийн хүйтэн жаварт нүүрэндээ тарваганы тос түрхсэн адуучид хацар нүүрээ хөлдөөлгүй өнгөрч чадна. Тарваганы тосонд шарсан тослог шаргал боорцогны амт үнэрийн сайхныг яана гээч. Тийм сайхан амттай боорцогийг зөвхөн хурим найрын зоогийн ширээн дээрээс л олж хүртэх боломжтой. Тарваганы тос түлэнхийн шарханд тун сайн эм болно.

Тийм болохоор тарваганы тос, арьс хоёр нь малчдын орлогын чухал эх үүсвэрийн нэг юм. Тарваганы арьс үс боловсорч, тарга тэвээрэг ханасан намрын улиралд малчид ууланд тарвагачилахаар явна. Тэд тарваганы махыг өөрсдөө идээд тос, арьсыг нь ханган нийлүүлэх хоршоо, түүхий эд бэлтгэлийн цэгт тушааж, дугуй булантай цай, торго дурдан, цахилгаан зай, савхин гутал, чихэр зэрэг өдөр тутмын өргөн хэрэглээний бараагаар арилждаг. Том тарваганы арьс дөрвөн юань<sup>43</sup>, нэг жин тарваганы тос нэг юань гаруй үнэ хүрчихдэг. Тарваганы арьсан шуба их үнэтэй эдлэлд тооцогддог болохоор гадаадад гаргаж валютаар арилжина. Бурхины өөхнөөс л гэхэд хоёр жин гаруй тос гардаг гээд бодвол малчид нэг тарваганаас зургаан юаний ашиг өлхөн олчихдог. Намартаа зуугаад тарвага агнасан малчин тав зургаан зуу гаруй юань өвөртлөдөг нь хоньчны жилийн цалингаас илүү их орлого гэсэн үг юм. Олонбулгийн талд малчид ан аваар туслах аж ахуйгаа болгодог боловч гол орлогоо ангийн олзноос олох нь олонтой. Ганц тарваганаас олох ашиг нь хонь маллахаас илүү орлоготой байгаа юм чинь дээр нь нэмээд чоно, үнэг, хярс, зээр тушаасан мөнгөө нэмбэл хэр зэрэг овоо юм болох нь тодорхой. Тухайн үед Олонбулгийн малчдын элбэг хангалуун байдал Бээжингийн дунд зэргийн албан хаагчдаас хавьгүй илүү байсан төдийгүй тэдний нүдийг бүлтийлгэхээр их хадгаламжийн мөнгөтэй байж билээ.

Гэвч малчдын ангаас олох орлого төдийлөн тогтвортой байж чаддаггүй. Тал нутгийн зэрлэг амьтад дотор газрын жимсний модтой адилхан цаг уур, бэлчээрийн гарц, байгалийн гамшиг зэрэг хүчин зүйлсээс хамааран их бага янз бүр байдаг. Олонбулгийн талын малчид ангийн нөөц жилд төдөн хувиар өснө гэсэн тогтсон жишиг байхгүй гэдгийг сайтар ухамсарладаг юм. Тийм болохоор ангийн нөөц ихтэй жил ахиу агнаж, цөөн үед бага авлан хомс болвол нэг жил өнжих нь ч бий. Энэ маягаар мянга түмэн жил агнасан ч байгаль эх ангийн олз омгон дээр гар таталгүй иржээ.

Малчид агнасан тарваганы арьсыг худалдаад тосыг нь бараг тушаадаггүй. Тарваганы тосны хэрэглээ өргөн, зарцуулалт их боловч явж явж дийлэнхийг арьс суран эдлэлд хэрэглэх нь олонтой. Тарваганы тос түрхсэн арьс суран эдлэл тос дааварлан хүрэлтээд, уян зөөлөн гоёмсог харагдана. Хэрвээ бороо хуртай үед морины тоног хэрэгсэлд тарваганы тос байнга түрхэж байвал эдэлгээний хугацаа уртсан тэр хэрээр осол цалгар гарах нь бага байдаг.

Тарваганы тосны хэрэглээ ийм өргөн болохоор айлуудын хураасан нөөц ирэх жилийн ангийн улиралтай залгана гэдэг бараг л үгүй шахуу даа.

Өвгөн ширдэг дээр хаялсан суран эдлэлийг харсанаа Чэнь Жэньд хандан “Эндхийн тарваганы мах амттай болохоор би хорхойсоод олигтой тос хурааж чадсангүй. Урьдын цагт ихэс ноёд намрын хайлган цагаар хонины мах иддэггүй байсан юм. . . . Би маргааш чамайг дагуулан тарваганд явья байз” гэлээ.

“Би тарваганы тос хайлаад та хэдийг амттай боорцогоор дайлна аа” хэмээн Галсмаа ч тэндээс хэлэв.

“Ямар сайн хэрэг вэ? Би ч гэсэн өнөө жил ахиухан тарваганы тос нөөцөлье гэж бодож байгаа. Дандаа та бүхний гарыг харсаар яаж болох билээ?” хэмээн Чэнь Жэнь хэллээ.

“Чи бэлтрэг тэжээснээс хойш намайг бүр мартчихаад байгаа шүү. Чи манайд ойрын хэдэн

сард хэдэн удаа ирсэнээ мэдэж байна уу?” гээд Галсмаа инээв.

“Та чинь хэсгийн дарга хүн. Гэтэл би чоно тэжээж та бүхэнд төвөг удсан болохоор яахин байн байн орж гарч зүрхлэх билээ?” хэмээн Чэнь Жэнь хэллээ.

“Хэрвээ би чамайг өмөөрдөггүй байсан бол бусад хэсгийн адуучид танай бэлтрэгийг алчих байсан байх шүү” гэж Галсмаа хэлэв.

Чэнь Жэнь асууруун “Та тэдэнд юу гэж хэлдэг байсан бэ?” гэхэд

Галсмаа инээд алдаад “Хятадууд бүгд чоныг үзэн ядаж, махыг нь хүртэл иддэг байхад ганцхан Чэнь Жэнь, Ян Кө хоёр л чононд дуртай байдаг юм. Тэр бэлтрэг тэдний хувьд өргөмөл хүүгээс нь өөрцгүй юм шүү. Цаад хоёр чинь чонын учрыг сайн олдог болохоор манай монголчуудаас өөрцгүй болно гэсэн юм” гэлээ.

Чэнь Жэньгийн сэтгэл уясан хайлж дахин дахин талархал илэрхийлжээ.

Галсмаа тас тас хөхрөн “За тэр талархах ч яахав. Харин намайг нэг гуанздуулчихвал барав. Би танай хятадуудын хийдэг “Том дунд хонины махан үндсэн хуулийн цэрэгт”<sup>44</sup> их дуртайг мэднэ биз дээ?” гэхэд Чэнь Жэнь эг маггүй хөхрөв. Галсмаа түүн рүү нүд ирмэснээ бухимдангуй суугаа өвгөн рүү сэмээрхэн зааж “Танай хөгшин аав ч гэсэн “Үндсэн хуулийн цэрэгт” их дуртай шүү” гэлээ.

Чэнь Жэнь дуу шуу орж “Жан Зи Юань аж ахуйн төвөөс баахан сонгино авчирсан нь хэвээрээ шахуу байгаа. Би өнөө орой хоолонд орох зүйлсээ авчраад танайхныг цадтал хуушуураар дайल्या” гэв.

Өвгөний царайд инээмсэглэл тодрон “Манайх саяхан хонь муулсан болохоор махыг нь бид даая. Цаад Гао Зянь Жун чинь хошууны гуанзнаас ч илүү амттай хуушуур хийдэг юм. Тийм болохоор Ян Кө, Гао Зянь Жун хоёртойгоо манайд ирээрэй. Цөмөөрөө жаахан наргицгаая” гэлээ.

Орой нь Гао Зянь Жун Галсмаад хуушуурын мах амтлах, чимхэж шарах аргыг зааж бүгдээрээ сайн идэж уун наргицгаалаа. Өвгөн гэнэт аягаа доош тавиад асууруун “Барилгын цэргийн нэгтгэлийнхэн малчдын эрүүл ахуй, амар тайван байдлыг хангах үүднээс суурьшуулах бодлогоо хэрэгжүүлэх юм гэсэн. Та нар тэр бодлогыг хэрхэн үзэж байна вэ? Танай хятадууд байшин балгасанд суух дуртай биз дээ?” хэмээн асуулаа.

“Хэдэн мянган жилийн турш үргэлжилсээр ирсэн нүүдлийн мал аж ахуйг суурьшмал байдалд шилжүүлнэ гэдэг ч дээ юу л болдог бол? Тал нутгийн тачир хөрс, эмзэг нарийн. Тийм болохоор нэг хот айлынхан сайндаа ганц хоёр сар болоод л нутаг сэлгэх хэрэгтэй. Хэрвээ тэднийг суурьшуулчихвал ганц жил хүрэхгүй хугацаанд хавь ойрын газраа талхалж гүйцээд тал нутаг тэр аяараа элсэн цөл болон хувирах ч юм бил үү? Тэгээд ч яг чухам хаана суурьшуулах вэ гээд л олон асуудал босож ирнэ дээ” хэмээн Ян Кө өгүүлэв.

Өвгөн ч толгой дохиод өгүүллрүүн “Монголын хөдөө талыг суурин амьдралд шилжүүлнэ гэдэг

шал утгагүй зүйл. Тариалангийн бүс нутгаас ирсэн хүмүүс өөрсдөө суурин амьдралд дуртай болохоороо бусдыг хомроголж байгаа нь тэр. Суурин амьдрал ч биед амар л даа. Гэхдээ тэнгэрийн тааллыг дагасандаа л өвөг дээдэс маань үеийн үед нүүдэллэсээр ирсэн хэрэг. Наад зах нь дөрвөн улиралдаа тохируулсан нутаг бэлчээр өөр өөрийн ашиг тустай байдаг. Хаваржааны өвс хэдийгээр сайн ч тачир намхан тул аль нэг айлыг тэнд бүрмөсөн суурьшуулчихвал өвөл цасанд дарагдчихаад мал сүрэг онд мэнд орж чадах уу даа? Өвөлжөөний өвс өндөр тул цасанд дарагдана гэж айхын зовлонгүй. Гэвч хэн нэгэн айлыг тэнд суурьшуулчихвал хавар, зун, намар хамаг өвсөө идэж барчихаад өвөл яах болж байна вэ? Зуслангийн бэлчээр ус голондоо ойрхон байхгүй бол хамаг мал харангадаад үхчихнэ. Гэтэл уулархаг газар ус элбэгтэй байх тул тэнд суурьшсан айлын мал уулын жаварт осгочихно биз дээ? Намаржааны бэлчээр үр боловсордог өвсийг голлодог болохоор мал сүрэг хавар зундаа хамаг өвсийг хамаад идчихвэл юуных нь үр байх билээ дээ? Улиралдаа тохирсон бэлчээр болгон өөр өөрийн ашиг тус, сул талтай болохыг та бүхэн харж байна уу? Нүүдэллэнэ гэдэг чинь тэгэхээр дөрвөн улирлын бэлчээрийн сул талаас зайлсхийж ашиг тусыг хүртэх ухаан байгаа юм. Хэрвээ нэг газар суурьшихвал бүх сул талууд нь бөөгнөрөөд ганц ч ашиг тус үгүй болчихоор яаж мал маллах болж байна вэ? ” гэхэд

Чэнь Жэнь, Ян Кө, Гао Зянь Жун нар толгой дохин магтацгаав. Суурьшмал амьдралд ганц л ашиг тус байгаа нь чоно тэжээхэд дөхөмтэй боловч Чэнь Жэнь энэ талаар үг дуугарсангүй.

Өвгөн дөрвөн том хуушуур идээд овоо архи уусан боловч сэтгэл нь нэг л онгойхгүй байгаа бололтой.

\* \* \*

Хоёр дахь өдрийн өглөө Чэнь Жэнь Ян Көд хонины хишгээ ацаглаад Билиг өвгөнийг дагалдан ууланд тарвагачлахаар явлаа. Өвгөн эмээлийнхээ араар хэдэн арван урхи хийсэн шуудай ганзагалжээ. Тарваганы урхины бүтэц тун энгийн бөгөөд хагас тохой модон гадас болон нэг үзүүрийг нь цагаригласан төмөр утас хоёроос бүрдэнэ. Тэгээд гадсаа тарваганы дошин дээр бэхэлж төмөр цагирагийг тарваганы нүхнээс хоёр хуруу өндөр байхаар байрлуулвал тарваганы хүзүү буюу гэдсээр урхилан барих боломжтой болдог. Чэнь Жэнь уг нь тарваганд урхи зүүдэг боловч ганц нэгхэн мөндөлнөөс хэтэрч байсан удаа бараг үгүй. Харин энэ удаа өвгөнөөр жаал жуул юм заалгаж авья гэж санажээ.

Хоёр морь зүүн хойд зүг зуузай холбон ергүүлэв. Тохой гаруй өндөр ургасан өвс толгойноосоо эхлэн шарлаж эхэлжээ. Тарвага тарга тэвээргээ зузаалах сүүлийн боломжийг ашиглан ойрдоо ойр ойрхон гарч байх учиртай. Тэд долоон сар гаруй ичдэг болохоор хангалттай өөх хуримтлуулахгүй бол ирэх хавартай эсэн мэнд золгож чадахгүй. Тийм болохоор өдий үед тарвага хамгийн тарган байдаг. “Би уг нь танаас авсан урхиа тавьсан боловч яагаад том тарвага ороогүй юм бол?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Өвгөн хүд хүд инээгээд “Би чамд тэгэхэд урхи тавих аргыг хэлж өгөөгүй байна лээ. Олонбулгийн анчид хамаг амьтдыг хуурайлчихна гээд өөрсдийн арга ухаанаа гадны хүмүүст тэр болгон задладаггүй юм. Гэхдээ аав нь нас дээр гарсан болохоор чамд тэр аргыг зааж өгөлгүй яахав. Хашир бурхинууд гадныхны тавьсан урхийг андахгүй арагш ухраад мултарчихдаг юм. Харин миний тавьсан урхинд нэг л хүрэх юм бол тас зуурчихаар уян хатан

тул хүзүү, гэдэс хаагуур нь ч урхилсан мултарна гэж үгүй. Урхи тавих үедээ гогцоог нь сайн багасгаж байгаад томсгохоор эргээд агшина биз дээ?” гэв.

“Тэгээд яаж бөхлөх хэрэг вэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

“Гогцооны уулзвар хавийн төмөр утсаа жаахан гүдийлгэж нугалаад түүн дээрээ үзүүрийг нь эвтэйхэн тогтоож өгнө. Тийм урхинд орсон тарвага хэр барагтай мултарна гэж байдаггүй тул арван урхиар наанадаж зургаа долоон тарвага барьж болдог юм даа” гэж өвгөн хэлэв.

Чэнь Жэнь духаа алгадаад “Яасан уран арга вэ? Миний тавьсан урхинд тарвага орохгүй байх нь аргагүй юм байна л даа” хэмээн дуу алдлаа.

“Гэхдээ тийм санаан зоргоор бүтэх ажил ч бас биш ээ. Нүхний том жижиг болон сарвууны мөрний овор хэмжээнд бас тааруулах хэрэгтэй. Яг тааруулж тавихдаа нэлээд нарийн ажиллагаа хэрэгтэй тул тэр бүхнийг би газар дээр нь чамд зааж өгье. Харин чи тэр аргыг өөр бусдад зааж өгч болохгүй шүү” гэж өвгөнийг хэлэхэд

“Тэгэлгүй яахав” хэмээн Чэнь Жэнь батлан өгүүлэв.

“Хүү минь, тарвага агнахдаа өөр нэг анхаарах зүйл бол зөвхөн бурхи буюу мөндөлгүй тарчийг<sup>45</sup> л авлаж болно. Харин нагай<sup>46</sup> мөндөл зэргийг барьсан бол эргүүлэн тавих учиртай юм. Манай монголчууд эцэг өвгөдөөс уламжлан ирсэн энэ хатуу дэг ёсыг чанд баримталдаг болохоор өдий хүртэл тарваганы махаа тааваар зооглож, арьсыг худалдан тосыг хэрэглэсээр байгаа юм шүү дээ. Тарвага хэдийгээр өвс бэлчээрт халтай амьтан боловч монголчууд бидэнд хишгээ харамгүй хайрласаан хөөрхий. Урьдын цагт хичнээн олон ядуус тарвага агнан амь зууж, хатуу хүтүү өвлийг давдаг байсныг танай хятадууд яахин мэдэх билээ?” гэж өвгөн хэллээ.

Хоёр морь намрын сахлаг өвсийг туучин хатирахад дэвхрэг царцаа, дэнгийн эрвээхэй зэрэг амьтад үргэн нисэлдэнэ. Гурав дөрвөн хараацай шувуу тэдний морины хондлойг шүргэх шахам нисэнгээ морьдын туурайгаар үргэсэн хорхой шавьжийг барьж иднэ. Хоёр морьтон арваад километр хатируулах зуур царцаа хорхойнд цадсан хосуудыг холдон нисэхэд араас нь өөр хос хараацай залган гарч ирэх ажээ.

Билиг өвгөн малиагаараа өмнө харагдах хэдэн том довцог толгойг зааж “Тэр бол манай Олонбулгийн тарваганы эх орон болсон газар даа. Түүний өвөр ар бэлээр ч тарвагатай газар цөөнгүй бий. Хэд хоногоос айлууд тарвагачлахаар наашаа гарцгаана. Өнөө жил ч тарвага агнахад бүр ч амар болсон доо” хэмээн өгүүлэхэд

Чэнь Жэнь өөдөөс нь “Яагаад тэр билээ?” хэмээн асуулаа.

Өвгөний харц сүүмийгээд “Чоно ховордсон болохоор тарвага хавханд орохдоо амар байлгүй яахав. Чоно намар цагт тарган том тарвага барьж тарга тэвээргээ сэлбэдэг юм. Харин мөндлийг амь хэлтрүүлж ирэх жил идэх тарваганы нөөцөө хадгалж байдаг. Монгол малчин талын чоно хоёр л тэнгэрийн таалсан дэг ёсыг сайтар ойлгодог юм даа” гэлээ.

Тэр хоёр Тарвагатай уулнаа дөхөж очив. Гэнэт тэр хоёр уулын хормой дахь хоёр бэрзээнтэн майхны амнаас угаа суунаглаж, ойролцоо нэжгээд ачааны болон усны тэрэг тавьсан байхыг олж үзэв.

“Баларлаа. Тэд биднээс түрүүлчихжээ” гэхдээ Билиг өвгөний царай хувьсхийж майхны зүг давхицгаав.

Тэр хоёр майхны ойролцоо давхин очиход тарваганы махны тааламжтай үнэр хамар цоргино. Хөгшин залуу хоёр майхны үүдэн дээр ирж мориноос буун үзвэл газар зуухан дээр тавьсан том тогоон дотор хэдэн том тарваганы махыг бүхлээр хийж халаасанд хамаг өөх тос нь хайлж урсаад зөвхөн хар мах нь хожийн үлджээ. Нэг залуу ажилчин яз шарагдсан тарваганы махыг гарган оронд нь өвчиж, гэдэс дотрыг цэвэрлэсэн өөр нэг тарган тарваганы бүтэн махыг хийхээр зэхнэ. Ван даамал, өөр нэгэн ажилчингийн хамтаар халуун ногоо, сонгино зэрэг зүйлс тавьсан эвдэрхий модон хайрцагны хажууд сууж байв. Тэр хоёр тарваганы шарсан мах зооглон шилтэй архиа амаар нь хөнтөрсөн шиг жаргалаа эдлэж сууцгаана.

Тогооны хажуугийн юм угаадаг төмөр ваннанд мөндөл голдуу баахан өвчсөн тарваганы мах овоолон дүүргэжээ. Зүлгэн дээр тавьсан хэдэн арван хаалганы хавтас, ширээний тавцан зэрэг дээр зуу хол давсан том жижиг тарваганы арьс дэлгэн тавьсан байна. Майхны голд байрлуулсан том жижиг тосны савнуудад тарваганы тосоо юулж байгаа бололтой.

Өвгөн майхны өмнөх төмөр ванны дэргэд гүйж очоод малиагаар дээр нь байсан хэдэн мөндлийг ярж үзвэл цаанаас нь хэдэн тарган нагайн мах гарч ирлээ.

Билиг өвгөн уурандаа шатаж малиагаар төмөр ванныг дэлсэж аваад Ван даамалд хандан “Хэн та нарт нагай мөндөл агнахыг зөвшөөрсөн юм бэ? Энэ бол Олонбулгийн хэдэн үеийн өвөг дээдсийн сэтгэл зүрхээ гарган бидэнд өвлүүлсэн нийт багийн өмч хөрөнгө юм шүү. Та нар багийн захиргааны зөвшөөрөлгүй ийм олон тарвага хядаад арай дэндэж байгаа юм биш үү?” хэмээн хашгирав.

Ван даамал хөлчүү янзтай архи махаа гудрангаа тайвуухан “Би ямар танай мэдлийн газар дээр ан хийсэн биш дээ. Тэгээд ч танай баг тэр аяараа барилгын цэргийн нэгтгэлд харьяалагдах болсон байх шүү. Тэгж ярих юм бол биднийг барилгын бригадаас наашаа тарвагачил гэж явуулсан юм. Тарвага намар цагт чонын гол хоол болдог. Хэрвээ тарвагыг нь дуусгачих юм бол чоно онд орж чадахгүй гэж Сүнь штабын дарга хэлсэн. Тийм болохоор барилгын цэргийн нэгтгэлийн захиргаанаас чоно устгах нийтийн дайны явцад тарвагыг хамт үгүй хий гэсэн тушаал буулгаад байгаа. Тарваган тахал гоц халдварт өвчин мөн гэж өрхийн цэргийн дивизийн эмнэлгийн эмч нар хэлж байсан. Гэтэл энэ хавьд олон тооны хүмүүс ирж тарвагачилж байгаад тийм өвчин туссаны хариуцлагыг та хүлээх юм уу?” гэлээ.

Өвгөн дотроо хэсэг зуур цухалдаж байснаа дуугаа чангаруулж “Барилгын цэргийн нэгтгэлээс тушаал буулгасан эсэх хамаагүй ээ. Хэрвээ тарвагыг хядаад хаячих юм бол малчид арьс сураа юугаар боловсруулж байх болж байна вэ? Хазаар ногт тасарч, морь үргээд хүн хар гэмтвэл хэн хариуцлагыг хүлээх юм бэ? Та нар үйлдвэрлэлийг хорлон сүйтгэж байгаагаа мэдэж байна



уу?” гэв.

Ван даамал амнаасаа архи сэнгэнүүлээд “Дарга нар агнаж устга гэсэн болохоор хариуцах эзэн олдох байлгүй дээ. Та бид мэт рүү агсраад байлгүй чадал чинь хүрдэг юм бол хөлөө хүрэх газартаа очиж заргалдсан нь дээр байлгүй” гэснээ өвгөний ганзагалсан шуудайнуудыг хяламхийн хараад “Та өөрөө ч гэсэн тарвага агнахаар ирсэн байна шүү дээ. Тэгсэн мөртлөө яахаараа биднийг нүд үзүүрлээд байдаг юм бэ? Хээрийн амьтдыг агнаж чадсан нь хувь хишгээ хүртэх учиртай биш үү?” гэв.

“Би одоохон адуучдыг дагуулан ирээд наад арьс тосыг чинь бригадын төв рүү аваачин улсад тушаалгахаа мэдэх байлгүй” хэмээн өвгөн өгүүлэхэд ямаан сахал нь чичирхийлж байлаа.

“Энэ тарваганы мах тосыг барилгын цэргийн нэгтгэлийн гуанзнаас бидэнд захиалсан юм. Та яахав араа даах юм бол хүн дагуулж ирээд булааж явдаг л юм байгаа биз. Энэ арьснууд ч гэсэн том дарга нараас Бао Шүнь Гүйд захисан эд шүү” гэж Ван даамал тайвуухан өгүүлэв.

Өвгөн багтарсандаа хахаж цацан гараа дэмий савчина.

“Та нар ч нэгэн амьсгаагаар том жижиг гэлтгүй ийм олон тарвага агнадаг айхтар улс юм даа. Бүтэн үүрээр нь хядаад байвал хойтон жил юугаа агнах болж байна вэ?” гэж Чэнь Жэнь ёозгүйхэн хэлэв.

“Та нар биднийг хэрмэл цагаачид гээд байдаг биз дээ? Тэгвэл хэрмэл цагаач улс хойтон жил энд байгаа ч үү, үгүй ч үү? Та нар ч яахав тарваганд санаа тавьдаг юм байж. Гэтэл хэрмэл цагаач бид өөрсдийгөө л бодохгүй бол хэн биднийг гэх билээ?” гэж Ван даамал хариулав.

Ийм мал шиг бүдүүлэг амьтадтай учир ёс хэлэлцээд амны гарз гэдгээ Чэнь Жэнь мэдэхтэйгээ нэгэн билээ. Тэр харин цаадуул нь чухам ямар арга замаар том жижиг энэ олон тарвагыг хядаж байгааг мэдье гэж боджээ. Тэд арай уян урхи хэрэглэдэг юм биш биз гэж санаад “Та нар ямар арга замаар ийм олон тарвага агнасан юм бэ?” хэмээн дууны өнгөө өөрчлөн асуув.

“Биднээс сурмаар байгаа юм уу? Тэгвэл оройтсоон. Энэ тарвагатай ууланд одоо тун цөөхөн бүл тарвага үлдсэн. Уржийн уржигдар бид бригадын төв рүү ачааны машин дүүрэн тарваганы мах, тос ачаад явуулчихсан. Харин яаж агнаж байгааг уул руу очоод үзэж болно. Жаахан оройтох юм бол үзэх ч юмгүй болно гэж мэдээрэй” гэж Ван даамал хэллээ.

Чэнь Жэнь өвгөнийг түшин моринд нь мордуулаад хөтлийг даван явцгаав. Хамгийн зүүн хойт талын нэгэн довцог толгой дээр дөрөв таван хүн тонгойчихсон ажиллаж байхыг үзээд тэр хоёр давхин хүрцгээлээ. “Больцгоо, больцгоо” хэмээн хашгирах чимээнээр хөлсний ажилчид хийж байсан ажлаа орхиод түүн рүү харцгаав. Чэнь Жэнь нүдний өмнөх байдлыг хараад хамаг бие нь агзасхийн чичрэв. Толгодын орой дахь хоорондоо холбоо бүхий тав зургаан нүхний гол болон туслах гарцаас бусад бүх амыг шороо чулуугаар битүүлэн таглажээ. Тэдний ахлагч бололтой нэгэн этгээд гартаа тохой хүрэхгүй жижиг мөндлийг барьсан нь сарвалзан тийчигнэж байлаа. Мөндлийн сүүлэнд нэг хэлхээ цаасан буу уяад үзүүрт нь халуун чинжүү цацсан шар эсгийг олсон утсаар холбон уяжээ. Эсгий дээр дөнгөж саяхан бензин цацаад байгаа бололтой хамар цоргин үнэртэнэ. Хажууд нь нэг хөлсний ажилчин шүдэнз зурахаар

бэлэн болсон байдалтай зогсоно. Хэрвээ тэд жаахан хожимдсон бол цаадуул нь мөндлийг үүр рүү нь тавиад араас нь гал тавьж цаасан буугаа дэлбэлэн утах байсан нь ойлгомжтой.

Билиг өвгөн ухасхийн очоод өрөөсөн хөлөөрөө тарваганы нүхийг таглан гишгэв. Тэр дошны хажууд суугаад нөгөөдүүлийг хийж байгаа зүйлээ орхи хэмээн зандарлаа. Зунжин тэднийг захирч зандарч байсан хариуцлагатай хүн ингэж хэлсэнд цаадуул нь ч олон таван үггүй олсон утсыг тайлав.

Чэнь Жэнь тал нутагт анх удаа ийм харгис шунахай аргаар ангийн нөөцийг хоослох аргыг үзсэн нь цөөрмийг хатааж загас барьж байгаагаас ч гатлуу хорон муухай санагджээ. Хэрвээ бяцхан мөндөл цаасан бууны чимээ, халуун чинжүүний утаа, бензинд дүрсэн шатсан эсгий зэргийг араасаа дагуулаад үүр рүүгээ орсон бол нэг бүл тарвага тэр чигээрээ зүйл дуусах байжээ. Тарваганы нүх бол тал нутагт хамгийн эгц, гүн, нарийн бүтэцтэй, утаанаас хамгаалах чадвартай байгууламж билээ. Тийм болохоор анчид тарваганы нүхийг утлаа ч бачуу хонгилоо бөглөн амь гарцгаадаг. Харин малчин тариачны алин ч гэхэд бэрхтэй энэ хэцүүхэн анчдын сэдсэн хорон аргыг хөөрхий тарваганууд яахин тэсэх билээ дээ? Айсан бэлтрэг араасаа цаасан бууны пижигнээн гал утаа дагуулсаар тарваганууд олноороо бөөгнөрсөн нүх рүү гүйн очиход тэсрэлтийн чимээ, гал утаанаас айсан тарваганууд ум хумгүй гадагш зүглэцгээх нь гарцаагүй. Ганц онгорхой гарцан дээр нь малиа шуудай тэднийг хүлээж байгаа. Хэрвээ ганц мөндөл урхиар барьчихад энэ хорон аргыг хэрэгжүүлэхэд тун амархан ажээ. Хэдхэн хоногийн хугацаанд энэ бүлэг хүмүүс хэдэн мянган жил хишгээ хайрласаар ирсэн тарвагатай уулыг хоослож чаджээ.

Өвгөн малиагаараа чулуу бутартал газар тогшиход нүд нь бүлтрэх вий гэмээр томорсон харагдана. “Одоохон наад цаасан буу, халуун чинжүүтэй эсгийгээ тайлаад наад мөндлөө үүр рүү нь буцааж тавь” хэмээн тэр хашгирав.

Хөлсний ажилчид олс, цаасан буу зэргийг тайлсан боловч мөндлийг тавихгүй байгаад байлаа.

Ван даамлын архи нь сэргэсэн бололтой морьтой давхин ирээд нялганан инээж өвгөнийг тамхиар дайлсанаа нөгөөдүүлээ загнаж зандарч гарлаа. Тэр мөндөл барьсан ажилчны гараас хутга авч нарийн олсыг таслаад өвгөний зүг хандан “Та одоо уужраа биз дээ? Түүний амийг хэлтрүүлчихье” гэв.

Өвгөн хувцасны шороогоо гөвөөд “Чи наадхиа тавьлаа ч гэсэн үүнээс хойш манай багийн нутагт барилгын ажил хийнэ гэж бодвол санасны чинь гарз байх шүү” гэж заналтай хэллээ.

Ван даамал зусардан инээгээд “Яалаа гэж тэгж болох вэ? Би чинь тушаал гүйцэтгэж байгаа амьтан шүү дээ. Тарвага устгана гэдэг чинь чонын арыг үгүй болгож байгаа ард нийтэд тустай хэрэг. Гэхдээ тарваганы тос байхгүй бол хазаар, ногт, чөдөр зэрэг суран эдлэл бөх бат чанараа алдаад осол эндэл гарна гэж таны хэлдгийг ч бодолцох учиртай. Тийм болохоор би зарим тарвагыг үлдээх нь зүйтэй гэж үзлээ” гээд бэлтрэгийг дошин дээр нь тавиваас цаадхи нь годхийн нүх рүүгээ орчихов.

“Ойрдоо баахан галлачихсан болохоор тарваганууд гарч ирэхээ байгаад арай ядан ганц

мөндөл урхидаад байсан юмсан” гээд Ван даамал санаа алдлаа.

“Асуудал ингээд дуусахгүй ээ. Чи бүх агнасан зүйлсээ багийн төвд аваачиж тушаах хэрэгтэй. Хэрвээ чиний ингэж аашилсаныг чинь Лхамжав зэрэг цөстэй адуучид дуулах юм бол ачааны тэрэг, майхан савыг чинь буулгаад өгөхөө мэдэх байлгүй” хэмээн өвгөн салах янзгүй шийдэмгий тулгав.

“Бид нар Бао даргад ажлаа тайлагнах учиртай тул юм хумаа хамж аваад одоохон явлаа” гэв.

Өвгөн цагаа харсанаа хойд талын тарвагатай толгод руу санаа зовж Ван даамалд хандан “Бид хүнтэй уулзчихаад одоохон эргээд ирнэ” гэхээд хоёул мориндоо мордон явцгаалаа.

Тэд хоёр довцог давсаны дараа ард нь цаасан буу пижигнэх чимээ бүгтхэн сонсогдоод чимээгүй болоход өвгөн “Болохоо байлаа шүү. Бид дахиад л хууртагдчихлаа” гээд тэр хоёр морины амыг яаран эргүүлэв. Толгодын оройд давхин хүрэхэд Ван даамал ам хамартаа даавуу уячихсан хүмүүсийг удирдан баахан тарвага алчихсан сууж байлаа. Хахаж цацам халуун ногооны утаанд байж ядсан сүүлчийн хэдэн тарвага тэдний малианд өртөн үхлээ. Билиг өвгөн ч утаанд байж чадалгүй нус нулимсаа урсган ханиалгаж гарахад Чэнь Жэнь түүнийг эрүүл салхитай газар дагуулан аваачаад ууц нурууг нь илж цохилгов.

Амандаа даавуу уясан бүлэг хүмүүс далайн дээрэмчид мэт арван хэдэн тарвагыг ачааны машины тэвшин дээр шидлээд ум хумгүй арилж өгцгөөлөө.

“Тэд нар яахаараа ийм хурдан тарвага урхилж амждаг билээ гэдгийг би ерөөсөө ойлгохгүй байна” хэмээн Чэнь Жэнь асуухад

Өвгөн хариуд нь “Тэд нар сая хоёр мөндөл урхилсаны нэгийг нь шуудайд хийсэн байсныг бид хараагүй хэрэг байж таарлаа. Тэгээд ч тэд нар урт модны үзүүрт цаасан буу уяж нүхэн дотор тэслээд тарвагыг гаргаж ирэх боломжтой. Урьд цагт тал нутгийн дээрэмчид ч арай ийм жудаггүй хорон муухай авирлаж байгаагүйсэн” гээд өвгөн малиагаа тулан босож хүйс тэмтрүүлээд онгойн харлах тарваганы үүрүүдийг харж, чичирхийлсэн хоолойгоор “Аль насандаа хийсэн үйлийн үр юм бол доо? Би мэдээ орох цагаасаа л аавыгаа дагалдан тарвагачилж байсан болохоор энэ үүрийг андахгүй сайн мэднэ. Хэдэн зуун жилийн турш олон үеийн хүмүүс хишгийг нь харамгүй хүртэж байсан энэ бүл тарвага тамхи нэрэхийн хооронд онгойсон хар нүх болон хоцрох юм гэж хэн санах билээ дээ. . . ” гэж хэлээд халуун нулимсаа цувруулж гарав.

Чэнь Жэньгийн дотор ч эвгүйрхэн “Та битгий шанал даа. Цөмөөрөө ямар нэгэн арга бодоцгооё” хэмээн тайвшрууллаа.

Өвгөн санаа зовнингүй хэсэг сууснаа гэнэт сэхээ орж “Ингэхэд Дорж энэ хавьд яагаад байдаггүй билээ? Тэр лав машинтай хүмүүсийг дагуулаад арын толгодууд руу явсан байж таарна.Шалавлацгаая” гээд мориндоо мордон хойт зүгийг чиглэн хатируулав.

Тэр хоёр хэдэн толгодыг даваад Гадаад монголын хилийн цаана орших нэгэн том уулын барааг харлаа. Хилийн шугам тэр уулын өмнөд хормойг эмжин өнгөрдөг юм.

Өвгөн алсад орших нэгэн зэгэл ногоон толгодыг заагаад “Дээхэн бол тэр толгодод очин тарвага агнаж болно л доо. Одоо байдал түгшүүртэй болохоор очуулахаа байсан юм. Ойрдоо шумуул багассан болохоор чононууд тийшээ тарвагачлахаар явсан байж таарна. Чонын бодсон зүйлийг Дорж бодоогүй байна гэж үгүй” гэлээ.

“Хилийн цэргийнхэн тэднийг саатуулдаггүй юм уу?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

“Тэнд дов толгод элбэгтэй. Хилийн цэргийнхэн тэр болгон анзаарахгүй. Тэдэнтэй тааралдлаа ч адилхан цэргийн улс болохоор үг хэлээ амархан ололцоно” гэж өвгөн хэлэв.

Тийн явсаар байтал хоёр морьдын хурд удаашран доош тонгойн өвс хаман идэж эхлэлээ. Тэдний аман дахь өвс ногооноороо шахуугийн дээр тал нутгийн үр нь боловсорсон хамгийн шимтэй ургамал байхыг Чэнь Жэнь олж үзэв. Сайн ажиглаваас намрын шаргал өвсний дор шаазгайн үүр шиг том хулганы хөөөнүүд энд тэнд байх ажээ. Хулганууд хэдхэн хоногийн өмнө өвс шарлахаас урьтаж хөөөгөө бэлдэж тавьсан байж таарна. Морьд энэ сөлтэй амтат өвсийг зүгээр орхиж яахин чадах билээ?

Өвгөн мориныхоо амыг татаж хулганы хөөө хамгийн ихтэй газар зогсоод “Жаахан амрангаа морьдоо жаахан идүүлээд авъя. Чонон сүрэг байхгүй болонгуут оготно газрын хөрсийг улаанаар эргүүлэх нь шив дээ. Энэ жилийн хөөө ноднин намрынхаас хэд дахин илүү байхыг үзэв үү?” гэв.

Тэр хоёр мориноос бууж амгайг аваад тааваар идэшлүүлэв. Хоёр морь хулганы хөөө рүү хүзүү сунган дайран ороод хараахан шим шүүс нь хатаж амжаагүй байгаа ногоон өвсийг сонгон идэж гарав. Өвгөн нэг хөөөг хөлөөрөө өшиглөвөөс аяганы амсрын хиртэй нүх байлаа. Нэгэн оготно толгойгоо цухуйлгаж байснаа өвлийн идшийг үрэн таран хийсэнд өширхсөндөө өвгөний гутлын хоншоорыг хазчихаад цаашаа бултгасхийн далд оров. Удалгүй морьд нь хамраа тачигнуулан үргэхийг эргэн үзвээс нэгэн том оготно хөөөг нь хамж байсан морины хамрыг хазчихсан юмсанжээ.

Өвгөн уурандаа багтран “Энэ хорвоогийн жам хүртэл юу болох нь энэ вэ? Оготно байтлаа морины хамар хазна гэнэ ээ? Чоныг энэ маягаар хядаад байвал оготно хүртэл хүн барьдаг болох вий дээ” гэв. Чэнь Жэнь морин дээрээ очин цулбуураар урд хоёр хөлийг тушив. Морь нь ч хаширсан бололтой туурайгаар хулганы нүхийг таглаж байгаад хөөөг нь хаман иднэ.

Өвгөн хөөөнүүдийг өшиглөн эргүүлж үзсэнээ “Долоо найман алхмын зайтай газар болгонд энэ хавийн хамгийн шим сайтай өвсийг сорчлоод хяргачихжээ. Үржүүлгийн станцын Шиньжаан хоньд ч ийм сайн тэжээл идэхгүй байгаа даа. Өвсөн хадуур сайн муу гэж ялгагдаггүй бол оготно хамгийн сайныг сорчилдог болохоор түүнээс ч хортой байдаг юм. Өнөө жил оготно өвс сайн нөөцөлсөн болохоор онд сайн орж үржин олшроод хойтон талын хөрсийг эргүүлж өгөх юм байна л даа. Талд чоно цөөрөөд ирэхээр оготно хүртэл оодроод эхэлж байгааг харж байна уу? . . . ” хэмээн халаглав.

Чэнь Жэнь энд тэндгүй хөглөрөх хулганы хөөөг үзээд айдас хүйдэст авглаа. Жил бүрийн намар Олонбулгийн тал нутагт хүн мал нэг тал болоод оготнотой дайтаж гардаг юм. Талын оготно хэдийгээр овгой ч нойтон өвсийг үүрэндээ нөөцөлвөл муудчих гэмтэй тул намар

амжин хатаах хэрэгтэй болдог нь тэдний хувьд хамгийн том сул тал болдог. Оготнууд өвсөө хатаахаар шамдан ажилладаг нь хүн малд тэднийг илчлэн өгч устгах сайхан боломж олгоно. Малчид аль хэсэгт оготны хөөө хамгийн их байгааг олж тогтоогоод бүх хэсэг суурийн малыг үхэр, адуу, хонь ямаа гэж ялгалгүй туун оруулж идүүлдэг. Намрын шаргал талд шим шүүс, боловсорсон үрээ хадгалсан хөөө ногооноороо байдаг тул мал сүрэг хоёр гуравхан өдрийн дотор хамж идээд оготны бүлийг өвөл идэх тэжээлгүй өлсөж үхэх аюулд учруулна. Энэ бол монгол малчдын эртнээс нааш оготны хөнөөлийг устгахад хэрэглэсээр ирсэн үр ашигтай арга юм.

Энэ аргыг талын чонотой хавсарч байж сая үр дүнгээ өгдөг. Намар цагт оготно зурам тарган байдаг тул чонын гол идэш тэжээл болохоос гадна тэдний бэлтгэсэн хөөө хаана байгааг нь илчилнэ. Нөгөө талаар чононоос айдаг оготно тэр болгон чөлөөтэй хөдлөж хөөөгөө хураах боломж хязгаарлагдмал болдог. Тийм болохоор жил бүрийн намар оготны хувьд тоо толгойн хорогдол хамгийн их байдаг. Тэр дундаа талын чоно оготны өвс тэжээлээ бэлтгэдэг ид улиралд айж тэвдүүлэн саад болсноор өвөл идэх идэшгүй болгож өлсгөж алахын зэрэгцээ хүн мал хоёр ч оготны гамшиггүй сааруулахад ихээхэн нэмэртэй билээ. Олон мянган жилийн турш хүн, мал, чоно гурав уялдаа сайтай ажилласнаар оготны аюулыг үр дүнтэй хазаарласаар иржээ. Түүний зэрэгцээ хулганы бэлтгэсэн хөөөнд тэжээл сайтай ногоон өвс голдуу байдаг нь малын тарга тэвээрэгт нэмэртэй болохоор хүн мал чоно гурвын намар болгон огогтнотой хийх дайн олон талын ашиг тустай байдаг юм. Харин өвөлжөөний бэлчээрийн тухайд гэвэл гагцхүү чоно тэндхийн оготны хөөө бэлтгэхэд саад болон ганцаараа тэмцэнэ. Тариалангийн бүс нутгаас ирсэн хурган дарга нар яахин энэхүү тал нутгийн хувь заяатай холбоо бүхий энэ нарийн нандин учгийг мэдэх билээ?

Хоёр морь хагас цаг гаруй хөөө түүж идсээр гэдсээ цүрдийлгэж амжив. Гэвч энэ том цар хүрээтэй оготны хөөөг идэж дуусгахад нийт багийн мал сүрэг ч цөөдөхөөр ажээ. Билиг өвгөн урьд өмнө ийм төвөгтэй байдалтай тулгарч байгаагүй болохоор хэсэг зуур бодож байснаа “Адуун сүргийг тууж авчирах уу? Гэвч энэ бол эртнээс нааш үхэр хонины бэлчээр байсан болохоор тогтсон жаягийг эвдэж яахин болох вэ? Ийм их хөөөг тармуураар хамаад ч барахааргүй ажээ. Ирэх жил оготны гамшиг гарцаагүй нүүрлэж таарах нь дээ. . . ” хэмээн үглэв.

“Энэ бол хүний тарьсан гай гамшиг мөн” гэж Чэнь Жэнь заналтай өгүүлэв.

Тэр хоёр мориндоо мордоод хойт зүгийг чиглэн гунигтай сажлуулахад энд тэнд хэсэг бусаг оготны хөөө зам зуур хөглөрсөөр байх ажээ.

\* \* \*

Тэр хоёр тарвагатай ууланд дөхөн очтол винтов цаасан бууны алинтай ч төсгүй пан пан хийх чимээ хэдэн удаа дуугараад чимээ алдрав. Өвгөн арга тасарсан байдалтай “Барилгын бригадаас Доржийг чоно алах зөвлөхөөр томилсон нь мөн ч хүнээ олж дээ. Хаана чоно байж болох газруудыг андахгүй шиншилсээр хамгийн сүүлчийн орогнох газар хүрээд ирсэн байдаг” гээд санаа алдав.

Тэр хоёр морио давиран ухасхийтэл урдаас нь нэг цэргийн жийп машин гараад ирлээ. Мань

хоёр морины амыг татан хүлээвээс хоёр мэргэн буудагч Дорж нарын гурван хүний суусан машин тэдний өмнө ирж зогслоо. Сүй зөвлөх өөрөө машинаа барьчихсан Дорж арын суудалд суужээ. Машины хонины хонхрыг дүүртэл шуудайтай тарвага ачаад багтахгүй болохоор шалан дээр хүртэл тавьсан байна. Өвгөний хараанд Баатар зөвлөхийн барьсан урт амтай буу юуны түрүүнд өртөв. Чэнь Жэнь түүнийг бага калибрийн спорт загварын буу болохыг таньсан боловч өвгөн тийм сонин зүйлийг анх удаа үзсэн байж таарна.

Тэд “Та сайн уу?” хэмээн өвгөнтэй мэндлэсний дараа Баатар зөвлөх “Та нар тарвагачилахаар явж байгаа юм уу? Тийшээ яваад хэрэггүй. Бид та нарт хоёр тарвага өгчихье” гэв.

“Яагаад явж болдоггүй билээ?” хэмээн өвгөн гайхан асуулаа.

“Бид шовойсон болгоныг нь буудчихсан болохоор одоо мөддөө тарвага гарч ирэхгүй болсон” хэмээн Баатар зөвлөх хариулав.

“Чиний наад урт амтай чинь юу гээчийн эд вэ?” хэмээн өвгөн асуулаа.

Баатар зөвлөх хариуд нь “Зэрлэг нугас агнах зориулалттай шувууны буу байгаа юм. Жижиг амтай болохоор тарваганы арьсыг гэмтээхгүй янзтай эд дээ” гэлээ.

Өвгөн бууг тосож аваад эргүүлж тойруулан үзэв.

Баатар зөвлөх өвгөнд мөнөөх бууныхаа шидийг үзүүлэхийн тулд машинаасаа бууж ирээд ийш тийш харж байснаа хориод метрийн цаана байгаа нэгэн жирх рүү онилов. Буун дуу панхийхтэй зэрэгцээд жирхний толгой тэр хол үсрээд бие нь нүхнийхээ хажууд намсхийн унахад өвгөн давхийн цочлоо.

“Чонон сүрэг бүгд гадаад монгол руу зугатаад явчихжээ. Өнөөдөр Дорж бид нар баахан тэнэж тэнэж ганц чонын бараа олж харсангүй. Харин энэ шувууны бууныхаа хүчээр овоо олон тарвага аллаа шүү. Эндхийн тарвага хүнээс айна гэж байхгүй. Арваад алхам ойртож очоод буудахад болж байна лээ” гээд Сүй зөвлөх инээв.

“Хоёр зөвлөх тавин метрийн цаана байгаа тарваганы толгойг алдахгүй болохоор бид зам зуур харсан болгоноо хамсаар явж байна шүү дээ” гэж Дорж хөөрцөглөнө.

“Би замаараа танайхаар дайраад хоёр бурхи үлдээчихье. Та ингэсхийгээ буцахгүй юу даа” гэж Баатар зөвлөх хэллээ.

Өвгөн шинэ зэвсгийн сүр хүчинд автан сэхээ орж амжаагүй байтал жийп машин шурхийн давхин одов. Ганцхан сарын хугацаанд ийм олон шинэ хүн, хүчит зэвсэг техник, хатуу ширүүн арга хэрэгслийг үзэхээрээ нэг болсон болохоор тэр балмагдаж гүйцэх нь ч аргагүй юм. Жийп машины тоос замхрахад өвгөн жолоогоо сулхан дугтарваас итгэлт хөлөг нь гэрийн зүг чиглэв. Чэнь Жэнь түүний араас зугуухан гэлдрэх зуур “Ганхсан төрийн сүүлчийн эзэн хаан байх амаргүй гэдэг. Тэгвэл цөвүүн цагийн талын малчин байх түүнээс ч хэцүү хэрэг юм даа. Түмэн онд унаган төрхөө хадгалсаар ирсэн тал нутгийн сүйрлийг үзэх гэдэг төрийн багана ганхан унахаас яаж дээр байх билээ?” хэмээн бодож байв. Шувууны бууны сум

Өвгөний цусыг юүлээд хамаг бие нь улам давжаа жаахан болсон шиг харагдана. Цийлэн хөх нулимс түмэн үрчлээт хацрыг даган урссаар хээрийн цагаан удвал цэцэгсийг дэвтээж байлаа.

Чэнь Жэнь өвгөний сэтгэлийн гунигийг хэрхэн үргээх ая эвийг олж ядна. Тэр хэсэг зуур ээрч түгдэрч байснаа “Аав аа, өнөө жилийн өвсний гарц онцгой сайн байлаа шүү. . . . Манай Олонбулгийн тал. . . Ирэх жил магадгүй. . . ” гэхэд

“Ирэх жил гэнэ ээ? Ирэх жил бас дахин ямар айхтар хэрэг босож ирэхийг хэн мэдэх билээ дээ? Урьд өмнө сохор хүн ч тал нутгийн минь сайхныг мэдрэхээр байсан даа. . . .Харин одоо өнгөө алдсан талыг харж байснаас сохор болсон минь ч дээр байж үү? Хайран сайхан нутгийг минь ингэж сүйтгэх гэж?” хэмээн өвгөн халаглав.

Өвгөн жолоогоо сул тавиад морины аяар сажлуулав. Өвгөн нүдээ анивхийлээд эрдүү хоолойгоороо нэгэн дууг гунигтай аяллаа.

“Хөөрөн нисэх хайргацай уяхан хаврыг зална

Хөөрхөн мөндөл гүйлдэхэд цахирмаа цэцэг дэлгэрнэ.

Хөх тогоруу донгодоход шиврээ бороо зүсэрнэ

Хорьдын саран дэгдэхэд саарал чоно улина”

. . . . .

Тэртээ холоос урсан ирсэн бяцхан горхи талын энг гүйцэлгүй хөрсөнд шингэн далдрах шиг өвгөний аялсан дууны үг яваандаа бүдэгрэн сонсогдохоо байлаа.Цуань Рун, Хүннү, Сяньби, Түрэг үндэстний хүүхдүүд төдийгүй Чингис хаан ч энэ дууг багадаа дуулж байсан нь лавтай. Гэвч хайргацай шувуу, цахирмаа цэцэг, тарвага, цэн тогоруу, саарал чоно зэрэг амьтдын барааг ч хараагүй хойч ирээдүйн тал нутгийн хүүхдүүд энэ дууны үгийг ойлгох болов уу?

Шаргал талын дээгүүр хэдэн зуун хайргацай шувуу агаарт далавчаа дэвэн тогтоод уран хоолойгоор жиргэлдсээр авай. . . . .

## Гучин тав

*Янь Ди хааны овог Цян . . . . . Цян овог болвоос баруун Рунгийн Цян аймгийн нэгэн салаа болмуй. Баруун газраас малаа даган нүүдэллэсээр дундад оронд ирсэн ажгуу.*

*Фань Вэнь Лань*

*“Хятадын нэвтэрхий түүх”*

*Баруун Рунчууд . . . . . байлдаж үхэхийг өлзий дэмбэрэлтэй, өвчнөөр үхэхийг муу ёртой гэж үздэг. Хүйтнийг дагаж бэрхийг тэсвэрлэх нь адгуус малтай адил. Бүсгүй хүн амаржсан ч цас шуурганаас аюухгүй. Зан чанар нь эрс хатуу, эрэлхэг зоригтой нь баруун газрын төмөр махбодийн амьсгалыг шингээжээ.*

*“Умард Хань улсын бичиг”*

*Баруун Цянгийн намтар”*

Энэ жилийн анхны цас удаж төдөлгүй хайлан ууршаад тал нутгийн агаар жиндүү атлаа цаанаа л нэг сэтгэл ариусам сэнгэнэнэ. Хаяа хатган айлсан буусан зуслангийн зугаатай өдрүүд ард хоцроод, хот айлууд хоорондоо нохойн дуу сонсогдохооргүй хол хол зайтай бууцгаажээ. Өтгөн шаргал өвсөөр хучигдсан өвөлжөөний ойр тойрон ээрэм говь мэт уйтайхан дүнсийнэ. Тоотойхон хундан цагаан үүлс хөвөх тэнгэр нуурын хиргүй мандал мэт хөхрөн цэнхэртэх нь намар цагийг санагдуулах ажээ. Талын хүрэн бүргэд ажигч хүн л сая олж харахаар асар өндөрт элин халин ниснэ. Тарвага зурам аль хэдийн ичээндээ орчихсон тул бүргэд шувуу үзэгдэх орчныг ихэсгэх гэж тэртээ өндөрт дүүлэн гарсан боловч талын өнгөнөөс ялгарахааргүй шахам болон хувирсан хээрийн бор туулайг өвөл цагийн өтгөн өвсөн дундаас үнэг ч ялгаж танихад бэрхтэй буй за. Тийм ч болохоор жил бүрийн өвөл цөөнгүй бүргэд өлсөж үхдэг гэлцдэг нь ортой үг юм.

Чэнь Жэнь ханган нийлүүлэх хоршооноос ороолттой бүдүүн төмөр утас худалдан авч ирээд бэлтрэгний хазаж эвдэлсэн үхэр тэрэгний бургасан хашлагыг засаж сэлбэв. Тэр бүтэн өдрийн хугацаа зарцуулан байж бургасан хашлагыг төмөр утсаар битүү ороож, төмөр торон тагтай болгожээ. Төмөр утас савхнаас дутахааргүй бүдүүн болохоор бахийг хоёр гараараа атган байж таслах боломжтой юм. Одоо бэлтрэг нэг соёогоо унатал оролдоод ч энэхүү шинэ хашлагыг эвдэж чадахгүй, тэгээд ч төмөр утас хангалттай байгаа болохоор эвдэрнэ гэж айлтгүй боллоо гэж тэр бодож байлаа. Өвлийн цагт бэлчээр цасанд дарагдчихдаг болохоор малын хамар хатгах өвс ховордохын хэрээр сардаа нэг удаа нүүж нутаг сэлгэх хэрэгтэй болдог. Харин үхэр хоньдын дайраад өнгөрсөн бэлчээрийн цасан дорх өвсийг адуун сүрэг туурайгаараа малтаж иднэ. Өвөл цагийн нүүдэл төдийлөн хол биш ихэвчлэн хагас өдрийн зайтай байдаг. Тийм болохоор бэлтрэг хичнээн айхтар догширлоо ч хагас өдрийн дотор төмрөөр бөхлөсөн хашлагыг эвдэнэ гэдэг бараг л бүтэшгүй зүйл юм. Чэнь Жэнь хагас сар тархиа гашилган байж өвөл цагийн олон нүүдэл дунд бэлтрэгээ эвтэйхэн аваад явчих арга олсондоо уужуу амьсгаа авчээ.

Нүүдлийн амьдрал гэгч хүний ухааныг үнэхээр задлаж өгдөг билээ. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч



бэлтрэгийг үхэр тэргэн дээр ачих хялбар аргыг бодож олжээ. Тэд эхлээд газар дээр нь бэлтрэгийг хашлагандаа оруулж аваад дараа нь үхэр тэргэн дээрээ өргөж тавиад сайтар уяж бөхлөнө. Ингэснээр бэлтрэг өөрийгөө болоод өрөөлийг шархдуулалгүй тэргэн дээр тайван гарч чадах юм. Тэгээд шинэ нутагт очсоны дараа хашлагаа өргөж буулгаад бэлтрэгээ гаргачихад болох нь тэр. Тэр хоёр энэ аргаа суурьшмал амьдралд шилжитлээ хэрэглээд түүнээс цааш тусгайлан чулуун хороо бариад өгчихвөл амар сайхандаа жаргах юм шиг санаж байжээ. Дараа нь бэлтрэгтэй багаасаа ижилдэн дассан охин гөлгийг хамт нэг дор байлгачихвал байгалийн жамаар улам дотносоод хороо дүүрэн хөөрхөн эрлийз гөлөгнүүд гаргачих ч юм бил үү хэн мэдлээ. Тэр цагт жинхэнэ талын зэрлэг чонын үр төлийг тэжээнэ гэсэн үг.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр сав л хийвэл бэлтрэгнийхээ толгойг илсэн шиг энэ тэрийг хүүрнэлдэнэ. Тэр үед бэлтрэг нь тэр хоёрын аль нэгийнх нь хөл дээр эрүүгээ тавьчихаад чихээ сортолзуулан яриаг нь сониучирхан чагнаж байх шиг байдаг байлаа. Сонсож залхахаараа толгойгоо сэгсрэн хүзүүгээ тэр хоёрын өвдөгт шөргөөн маажна. Заримдаа хүзүүгээ өлийлгөн тэр хоёроор маажуулах дуртай. Мань хоёрын ярианы сэдэв ихэвчлэн өөрсдийн болоод бэлтрэгний ирээдүйн амьдралтай холбоотой байх нь элбэг. Ян Кө бэлтрэгийг тэврээд үсийг нь самнангаа өгүүлрүүн “Чоно угаас гэр бүлсэг амьтан, тэр тусмаа эр чоно маш хариуцлагатай эцэг байдаг болохоор манай бэлтрэг алсдаа үр төлтэй болчихвол оргоод явчихгүй байх аа. Тэр цагт зэрлэг чононд л уруу татагдчихгүй бол түүнийг гинжнээс нь суллагчигсан ч гэсэн өөрөө үүрэндээ эргээд ирдэг болж мэдэх юм” гэлээ.

Чэнь Жэнь толгой сэгсрээд “Хэрвээ тэгвэл бэлтрэг маань жинхэнэ чоно биш болчихно. Тэгээд ч би түүнийг энд үлдээсэй гэж бодохгүй байгаа юм. . . . Би багаасаа л жинхэнэ зэрлэг чоно найзтай болох юмсан гэж мөрөөдсөөр ирсэн. Би морьтойгоо баруун хойд хил хамгаалах зурвасын наахантай байдаг өндөр довцог дээр гараад тэртээд байх аглаг уулын зүг хандаж “Бэлтрэг ээ, бэлтрэг ээ. Хоолондоо” хэмээн хашгирахад манай бэлтрэг араа шүд хурцтай олон сүргээ манлайлсаар давхин гарч ирээд надтай зүлгэн дээр ноололдон наадаж эрүүг минь долоон, гарыг маань зөөлөн хазладаг байвал мөн сайхан аа. . . . Гэхдээ бэлтрэг маань багаасаа л хурц соёогүй болсон болохоор миний мөрөөдөл хоосон зөгнөл төдийхөн хоцрох байх даа” хэмээн хэлэв.

Тэр хөнгөн санаа алдаад “Ай, хүний хүсэл мөрөөдөл гээч хүчрэгдэшгүй зүйл байх юм даа. Би ойрдоо өөрийгөө нэг шүдний эмч байсан бол бэлтрэгтээ ган дөрвөн соёо хийж өгөөд ирэх хавар хил хамгаалах зурвасын ойролцоо очоод гадаад монголын хилийн тэртээд байх өндөр уул руу тавьж явуулах юмсан гэж боддог боллоо. Түүний эцэг цагаан цээжит азарган чоно тэндхийн чонон сүрэгтэй нэгийгээ үзэлцэн цусан зам татуулсаар өөрийн гэсэн эдлэн нутагтай болсон байхыг хэн мэдэх билээ? Манай ухаантай бэлтрэг аавыгаа эрсээр очих үед цагаан цээжит азарган чоно үр төлөө үнэрээр нь таньж өөрийн сүрэгтээ багтаах нь гарцаагүй. Ган дөрвөн соёогоор зэвсэглэсэн бэлтрэг маань тэндхийн талд халдах дайсангүй санаа амар амьдрах болно. Хэдэн жилийн дараа цагаан цээжит азарган чоно өөрийн толгойлогчийн байр суурийг түүнд найр тавин өгөх ч юм бил үү? Хэн мэдэх вэ? Манай бэлтрэг угаасаа харьшгүй хатан зоригтой, гоц ухаантай нэг л анги амьтан болохоор ирээдүйд гарцаагүй чонон сүргийн толгойлогч болох нь тодорхой байсан юм. Бэлтрэг маань уугуул монгол нутагтаа тэмцсээр хүрч чадах юм бол тэнд газар нутаг өргөн уудам, хүн ам нь хоёр

сая хүрэхээргүй цөөн, ёстой л чонон сүлдийн үзэл санааг дээдлэн амьдарч байгаа цэнгэлийн орон төдийгүй чоныг үзэн ядаж, хүйс тэмтэрдэг тариачин соёлын хүчин зүйлс үгүй болохоор тэр ид хаваа ганц сайн гайхуулж чадах биш үү? . . . . . Би тийм гайхалтай сайхан ирээдүйг нь баллаж орхидог мөн айхтар нүгэлтэй амьтан аа даа” гэлээ.

Ян Кө умард хилийн тэртээх хөхөмдөг уулсыг ширтээд харц нь сүүмийгээд явчихав. Тэр хэнгэтэл санаа алдаад “Чиний түрүүчийн мөрөөдлийн тухайд гэвэл арваад жилийн өмнө энд ирсэн бол бүтэх бүрэн боломжтой байсан юм. Харин сүүлчийн мөрөөдлийн тухайд гэвэл хэрхэвч бүтэхгүй байх аа. Тийм үнэ цэнэтэй шүдний эмнэлгийн төхөөрөмж манай хошууны эмнэлэгт ч байхгүй шүү дээ. Хөгшчүүл шүд хийлгэхийн тулд дөрвөн зуу гаруй километр хол сэгсчүүлэн байж аймгийн эмнэлгийг зорин очдог. Чи байтлаа нэг чоно тэвэрчихээд аймгийн эмнэлэгт очих гээ юу? Чи энэ маягаар мөрөөдөөд байвал удахгүй чононоос өөр юм ярьж мэдэхгүй үглээ авгай болон хувирч мэднэ шүү. Тийм болохоор хоёулаа бодит байдалтайгаа эвлэрсэн нь дээр байх аа” гэж хэлэв.

Бодол санаандаа авгалгүй бодит байдал дээр эргэн ирэхэд тэр хоёрын санаа зовоох асуудал гэвэл бэлтрэгний шарх болоод байлаа. Түүний дөрвөн тавхайны шарх бүрэн эдгэрсэн боловч харлан хорхойтсон соёо нь улам хөдлөн ганхаж, буйл нь айхтар үрэвсэн улайжээ. Бэлтрэг заримдаа идэш хоолоо ховдоглон хазлаж байгаад өвчтэй шүдээ хөндөн уртаар амьсгаа аван азнаж байснаа өвчин намжсаны дараа нөгөө талын шүдээрээ болгоомжтой хазладаг болов.

Чэнь Жэнь хэдийгээр хоолонд нь хурдан цагаан эмийг холин өгсөөр байгаа боловч бэлтрэгний хоолойн шарх бүрэн эдгэрэлгүй юм залгихад зовиуртайн дээр байн байн ханиалгадаг болсон нь түүний сэтгэлийг ихэд зовоох болжээ. Чэнь Жэнь малын эмч дуудах аргагүй тул тэр чиглэлийн хэдэн ном олж аваад өөрөө уншин судлаж эхлэлээ.

\* \* \*

Илгээлтийн эзэд өвлийн идшээ бэлдэж хөлдөөцгөөжээ. Тэдний гэрт тухайн үеийн жишгээр 24 хонь нэг үхэр өвлийн идэш болгон хуваарилан өгөв. Түүнчлэн хүн болгон 15 кг гурил будааныхаа нормыг хүртэнэ. Тэгвэл малчдын махны норм тэдэнтэй адилхан буюу нэг хүнд зургаан хонь мөртлөө гурил будаа арав хүрэхгүй килограмм оногдож байлаа. Тийм болохоор Чэнь Жэньгийн гэрийн хүн, нохой, чоно бүгд хүрэлцэхүйц идэх хоолтой болжээ. Түүнчлэн өвлийн цагт өвдөж, хөлдөж үхсэн хонь мал цөөнгүй байдгийг малчид идэлгүй нохдоо тэжээдэг уламжлалтай тул Чэнь Жэнь бэлтрэгний хоол тэжээлд санаа зовох зүйлгүй байлаа. Чэнь Жэнь, Гао Зянь Жунтай цуг ихэнх хөлдүү махаа тэдний суурийн нийтийн эзэмшлийн агуулах болох гурван өрөө шавар тагзанд аваачин хадгалав. Харин өөрсдийн идэх махаа чингэлэг тэргэнд хадгалж байгаад дуусахаар агуулахаас авчирч иднэ.

Өвлийн өдөр богино болохоор хонио зургаа долоон цаг бэлчээдэг нь зуны улирлаас нэг дахин богино гэсэн үг юм. Хааяа нэг цасан шуурга нүдэхийг эс тооцвол өвлийн хахир хатуу цаг малчдыг овоо амсхийлгээд авдаг билээ. Тийм болохоор Чэнь Жэнь бэлтрэгээ маллахын зэрэгцээ ном уншиж, өдрийн тэмдэглэлээ цэгцлээд авья гэж санажээ. Тэр мөнгөн хуягаа өмссөн уудам талд хайртай бэлтрэг нь шинэ сонирхолтой жүжиг тавихыг хүлээж байлаа. Бэлтрэгний нугаршгүй зан, хурц ухаан, нууцлаг чанар тал нутгийн тайзнаа тавигдах жүжгийн гол эх ундарга тул өөрийн үнэнч шүтэн бишрэгчдээ гомдоохгүй гэдэгт Чэнь Жэнь итгэнэ.

Хахир хагуу урт өвөл хилийн чанадад зугатан гарсан чонон сүрэг таньж мэдэхгүй шинэ орчинд үйлээ үзэж байхад тэдний бэлтрэг нь дулаан өвөлжөөний нөмөрт мах шөлөөр тасрахгүй өнтэй өвөлжиж байлаа. Бэлтрэгний арьс үс хөрсжиж гүйцээд том чонын төрхөө олжээ. Чэнь Жэнь алгаа бэлтрэгний өтгөн үсэнд шургуулахад таван хуруу нь харагдахгүй, ямар ч дулаан бээлийнээс дулаахан санагдана. Бэлтрэг “Том чоно” гэсэн нэрэндээ дасаагүй тул дуулаагүй дүр эсгэж байгаад “Бэлтрэг ээ” хэмээн дуудахад ихэд тааламжтай гүйж ирээд түүний өвдгийг шөргөөнө. Охин гөлөг чонын хүрээнд орж ирээд түүнтэй тоглоход дахин хазаж гаслуулахаа байгаад дор нь орон ноцолдон тоглодог болжээ. Ян Кө түүнийг хараад жийхайтал инээж “Ирэх жил ч нэг юм дуулгаж мэднэ шүү” гэнэ.

Гуравдахь цас орсоны дараа Олонбулгийн тал цасан хөнжлөө бүрэн нөмөрсөн ч суугаад харахад өвсөн толгой шаргалтсан хэвээр харагдана. Галсмаагийн хэсэг эртний нүүдэлчин овог шиг тал нутгийн гүн рүү зугуухан нүүдэллэж байлаа. Чэнь Жэнь ч гэсэн бэлтрэгээ аваад гадныхан үймүүлэхгүй ертөнцөөс бүрэн тусгаарлагдмал хялганатай тал руу нүүжээ.

\* \* \*

Чэнь Жэнь, Гао Зянь Жун хоёр гурван үхэр тэргэнд үхрийн хуурай аргал, модон хүрз, шивээ хашаа, түүн дээр нөмөргөх эсгий зэргийг ачаад шинэ нутагт түрүүлэн хүрч цас арилгахаар очлоо. Тэр хоёр удтал ажилласны эцэст хонины хороо, үхрийн хороо, чонын тойрог болон монгол гэр барих талбайн цасыг арилгаад тэргэн дээрх зүйлсийг буулгав. Үдээс хойш гурван үхэр тэргээ хөллөөд буцахдаа бэлтрэгээ авчрах унаатай боллоо гээд түүний сэтгэл маш өг байлаа.

Дараах өдрийн өглөөгүүр мань гурав гэрээ буулгаж ачаалж баглаад, чоноо хашлаганд хийн үхэр тэргэн дээрээ тавьж бөхлөв. Бэлтрэг уурандаа төмөр торыг хэд хазсанаа өвчтэй шүдээ хөндөн арай номхорчээ. Үхэр тэрэг хөдлөхөд бэлтрэг айсандаа сүүлээ хавчин хагас оцойн суугаад шинэ нутагт очтол хэвтэхгүй явлаа.

Чэнь Жэнь бэлтрэгээ газар буулгасны дараа хүйтнийг давахад тустай өөх тос сэлбэг хэмээн түүний хувьд тансаг амттан болох сайн болгож чанасан хонины сүүл өгөв. Чэнь Жэнь сүүлийг хутгаар нарийхан зүсэж өгсөн нь залгихад ч тустай байгаа нь илт. Гинжиндээ нэгэнт дассан бэлтрэгт хоёр хувиршгүй зарчим байдгийн нэг нь хоол идэж байхдаа хүн адгуус хэнийг ч байсан хавьтуулдаггүй. Тэр ч байтугай Чэнь Жэнь, Ян Кө хоёрыг ч танихгүй мэт аашаа хувиргана. Хоёрдугаарт салхилуулах үед хүнээр хөтлүүлнэ гэж огт үгүй. Тийм болохоор Чэнь Жэнь бэлтрэгний энэ хоёр зарчимд аль болохоор хүндэтгэлтэй хандахыг хичээнэ. Цас мөсөөр хучигдсан дүн өвлийн улиралд бэлтрэг идэш тэжээлийг хүсэмжлэн нандигнах нь хавар, зун, намрын аль ч үеэс илүү хүчтэй мэдрэгдэж байв. Хоол өгөх бүрт бэлтрэг шүдээ ярзайлган архирч, нүднээсээ “Хорт зүү” ялгаруулаад Чэнь Жэньг чонын тойргоос алхам хол зайтай очсон үед сая жаахан тайвширч хоол руугаа анхаарлаа хандуулна. Гэвч зэрлэг чоно мэт байн байн Чэнь Жэнь рүү хяламхийн архирч сүр хүчээ харуулах дуртай. Бэлтрэг хэдийгээр шархтай боловч тэнхлүүн хэвээр, хоол ундандаа сайны хүчинд цус алдалтад ажрахгүй байлаа.

Гэвч түүний соёо болон хоолойн шарх чонын төрөлх араншинд нөлөөлж урьд нь хоёр гуравхан хазаад л үмхчихдэг байсан хонины сүүлийг одоо долоо найм хувааж идэх болжээ. Түүнийг хараад Чэнь Жэнь бэлтрэгний шарх бүрэн эдгэрэх байгаа даа хэмээн битүүхэн санаа

ЗОВНИНО.

Хүний хөлд төдийлөн дарагдаж амжаагүй хил хязгаарын тал нутаг орой намрын үеэс ч илүү эль хуль оргиж, цасан дороос цухуйх өвсөн толгой салхинд ганхах нь хүний сэтгэл дэх хөнгөн гунигийг хөвсөлзүүлэх ажээ. Богинохон зуны улирал ард хоцроод, бууны сумнаас амьд үлдсэн нүүдлийн шувууд өмнийг зорин нисэж, учир битүүлэг үйлдлээрээ шуугиулж явсан чонон сүрэг ул мөргүй үзэгдэхээ больсон нь уйтайхан талын амьдралыг улам ч амьгүй уйтгартай болгосон мэт. Эрт цагт Сү Ү жанжин Хүннүгийн талд урт удаан он жилүүдийг хэрхэн өнгөрөөж байсан бол хэмээн бодох бүрт Чэнь Жэньгийн сэтгэлд харуусал жихүүдэс төрдөг юм. Энэхүү хүн амьтангүй эзгүй цасан талд хэрвээ бэлтрэг болон Бээжингээс авчирсан хэдэн хайрцаг номнууд нь үгүй бол тэр өдийд галзуу солиотой, эсвэл элий балай, гөлрөө мэлрээ амьтан болон хувирсан байхыг ч хэн мэдэх билээ? Аав нь залуудаа Англид суралцаж байхдаа хойд туйлд ойрхон оршдог умард европын орнуудад амиа хорлох үзэгдэл илүү ихээр тохиолддогийг ажигласан гэнэ лээ гэж Ян Кө ярьдаг. Оросын тал болон Сибирыг олон зууны турш дэлгэрсээр ирсэн Славын сэтгэлийн гутрал өвчин ч гэсэн урт өвлийн уйтайхан цастай холбоотой байж мэдэх л хэрэг. Гэтэл хүн ам цөөнтэй монгол талын малчид нүд алдам ээрэм талдаа хэдэн мянган жилийн турш оюун санааны эрүүл байдлаа хадгалан урт өвлийг хэрхэн яаж даван туулсаар ирсэн юм бол? Тэд лав тал нутгийн чонон сүрэгтэй ширүүн тэмцлийг явуулах явцдаа олсон хатуу чанга хийморь зориг болон сэтгэл санааны хүчийг хойч үеийнхэндээ өвлүүлэн өгсөөр ирсэн байж таарна.

Чоно хэмээгч амьтан тал нутгийнхны махан бодийн хувьд ихээхэн дайсантай боловч оюун санааны хувьд оройдоо залсан сүлд нь билээ. Хэзээ нэгэн өдөр түүнийг үндсээр нь устгаад үгүй болгочихвол гал улаан наран тал нутгийг бүрэн гийгүүлж чадахаа байгаад тогтоол ус шиг үхмэл налгар байдал, уйтгар гуниг, гутрал, гансрал зэрэг оюун санааны аймшигтай дайснууд мянга түмэн жил эрч хүч омогшлоо багтааж ядан байсан тал нутгийн үндэстний оюун санааг бүрмөсөн үгүй хийх нь лавгай.

Талын чоно устаснаар Олонбулагт талын хар архины борлуулалт бараг нэг дахин нэмэгдсэн гэдэг. . . . .

Сү Ү жанжин тэртээх он жилүүдэд лав монгол талын омогт догшин чонон сүрэгтэй нүдэлдсээр уйтгартай он жилүүдийг эсэн мэнд ардаа орхисон байж таарна. Талын чонын хүрээлэлд амьдарч байгаа хүнд уйтгарлан гансрах цаг зав хаанаас байх билээ дээ хэмээн Чэнь Жэнь өөрийгөө итгүүлэхийг оролдох болжээ. Тэгээд ч Хүннүгийн хаанаас түүнд гэргий болгон өгсөн малчин хүүхэн лав Галсмаатай адилхан эрэлхэг зоригтой, ухаалаг бүсгүй байсан байж таарна. Тэр хоёрын дундаас төрсөн хөвүүн Баяртай адилхан чонын үүрэнд шурган орж байсан нь лавгай. Тийм бүлээн дулаан гэр бүлийн орчноос Сү Ү оюун санааны эрч хүчийг олж авдаг байжээ. Хамгийн харамсалтай нь хожим тал нутагт очсон Хань улсын элч гагцхүү Сү Үг эхнэртэй нь хамт авч буцаад тэр хоёрын дундаас гарсан бяцхан “Баярыг” гэрт нь үлдээсэн гэдэг. Яваандаа Чэнь Жэнь талын чоно, чонын үзэл санаа хоёр л элчийн үүргээ умарталгүй хятад суртхаалаа хадгалан үлдэж чадсан агуу их Сү Үг буй болгосон гэдэгт хатуу бат итгэх болжээ. Ганц Сү Үд тэгтлээ нөлөөлж байхад олон мянган жил тал нутагт амьдарсан нүүдэлчин үндэстнүүд ямар болох нь ойлгомжтой.

Чонон сүлд хэмээгч нь тал нутгийн амин сүнс төдийгүй тал нутгийн нүүдэлчдийн оюун

санааны амин сүнс билээ.

Илгээлтийн эздийн уйтайхан амьдралын турш Чэнь Жэньгийн тэжээсэн бэлтрэг онгон зэрлэг зан чанараа хадгалсан хэвээр байсан нь азтай хэрэг юм.

Бэлтрэг өсөж томрохын хэрээр төмөр гинж нь улам богиноддог болов. Аливаад эмзэг мэдрэмхий бэлтрэг төмөр гинж биеийн урттай харьцаа алддагдаад байгааг мэдрэх юм бол тарчлаан амссан омог шартай хоригдол эсэргүүцлээ илэрхийлж байгаа юм шиг хамаг хүчээрээ төмөр гинж болон модон шонгоо татаж чангаан арай тавиу болгохыг шаардана. Хэрвээ түүний хүслийг үл гүйцэлдүүлвээс боомилж үхэхийг юман чинээ бодохгүй. Бэлтрэгний хоолойн шарх бүрэн эдгэрээгүй байгаа болохоор Чэнь Жэнь түүний гинжийг хорин сантиметр л сунгаж өгчээ. Нас бие гүйцсэн чононоос өөрцгүй том болсон түүний хувьд энэ нь бас л богинодсон хэрэг боловч Чэнь Жэнь түүнээс урт сунгаж зүрхлэхгүй ажээ. Хэрвээ гинжийг илүү уртасгах юм бол гүйдэг тойрог нь ихсэж түүний хирээр хүч чадал улам нэмэгдэх магадлалтай. Төмөр гинж хэзээ нэгэн өдөр хоорондоо үрэгдсээр тасрах вий гэдэгт тэр бас нэлээд санаа зовнино.

Шоронгийн хоригдлоос өөрцгүй тэмцэн байж олсон ямх гинж бүрийг бэлтрэг маш нандигнан хайрлаж тэр хэрээр өөрт оногдох боломжтой сөөм эрх чөлөөндөө баясан чонын хороог тойрон галзуу юм шиг давхидаг байв. Бэлтрэгний дөрвөн хөл халцгай тойргийн гаднахь цасан дээр гишгэнгүүт шинэ нутаг эзлэн авсан юм шиг тарган унага барьсан хээрийн чононоос ч илүү баяртай байгаа нь илт харагддаг. Эзэн нь түүний хөл дорх цасыг арилгаж өгөхийг ч хүлээлгүй сүр сүр хийтэл хурдлан давхих нь арван хэдэн чоно ар араасаа хөөцөлдөн давхиж байгаа ч юм шиг. Бэлтрэг ийнхүү хуй салхи мэт эргэлдэн давхихад хажууханд нь харж зогссон Чэнь Жэнь түүнийг төвөөс зугатах хүчиндээ дийлдэн бөөрөнцөг мэт шидэгдээд аглаг уул руу зугатан улсын хил даваад явчих вий дээ хэмээн битүүхэн зовнино.

Чэнь Жэнь чонын хүрээний хажууд суух бүрт сэтгэлийн гуниг гутрал үргээд түүний оронд асар хүчтэй араатанлаг чанарт эзэмдэгдэж, чонын халуун цус биед нь юүлэгдэн амьдрах эрч хүч дүүрээд ирэх шиг санагдана. Түүний сэтгэлийн хөдөлгүүр бэлтрэгний эрчтэй давхианд татагдан асаж нүргэлэн хөдөлснөөр догдлол хөөрийг нэлэнхүйдээ мэдрэх шиг болдог.

Чэнь Жэнь бэлтрэгнийхээ шинэ тоглолтыг бахдан таашааж эхлэв. Бэлтрэг нь зөвхөн баяр хөөртөө автсан төдийхөн хэрэг биш цаанаа өөр санаа агуулан гүйсээр байгааг тэр төвөггүй ойлгожээ. Бэлтрэг гинжнээсээ салах эрмэлзэл зун намрынхаас хүчтэй мэдрэгдсэн нь хурд хүчээ сэлбэж, оргох бэлтгэлээ хангаад байгаа мэт түүнд санагджээ. Улам бүр өсөж томорсоор байгаа бэлтрэг нүд алдам уудам талыг харж, сарвуугаа сарвайхын төдийхөнд хүрчихмээр эрх чөлөөнд татагдахын хэрээр хүзүүн дэхь дөнгөтэйгөө эвлэрч чадахаа байжээ. Чэнь Жэнь бэлтрэгний хүсэл сэтгэлийг бүрэн ойлгож байлаа. Эрх чөлөөт талд эрх тааваараа амьдрах дуртай чононд хэдхэн алхмын цаана эрх чөлөөг харуулчихаад түүнийг нь эдлүүлэхгүй байна гэдэг энэ хорвоогийн хамгийн хатуу бэрх ял шийтгэл байж таарна. Том чоно хүртэл оршин амьдрахад бэрхтэй тал нутгийн урт өвөл бэлтрэгийг тавьж явуулна гэдэг гарцаагүй үхэл байж мэдэх тул Чэнь Жэнь түүнийг гинжинд нь байлгахаас өөр аргагүй байлаа. Бэлтрэг гинжтэйгээ ноцолдохын хэрээр хоолойныхоо шархыг улам сэдрээсээр байв. Чэнь Жэнь бэлтрэгний энэ байдлыг харах тусам сэтгэл нь чим чим өвдөнө. Тэр хамар дороос нь оргон

босож чөлөөт үхлийн замыг сонгох вий гэсэндээ тэр гинж, шон, хүзүүвчний бөх бат чанарыг ойр ойрхон шалгадаг болов.

Бэлтрэг амаа ангайлган эцэж цуцахаа мэдэхгүй гүйх зуураа Чэнь Жэнь рүү хааяа нэгхэн тааламжтай хяламхийн харах боловч тэр харц нь хэт цахих шиг хоромхон зуур алга боллоо. Тэрхэн мөчид Чэнь Жэньгийн сэтгэлд ер бусын бүлээн дулаан мэдрэмж төрөв. Арай өөрийнх нь амьдрах эрч хүч сулраад хүсэл зориг нь мохчихоод байсан юм биш биз дээ? Бэлтрэгний араатан зан, цовоо цолгин байдлыг хараад Чэнь Жэнь ичингүйрэн өөрөөсөө ийн асуулаа. Бэлтрэгний оргилсон амьдрах хүч өөрийнх амь насны гол дахь утаа баагиулсан нойтон түлээг эрчтэй хатаах болсныг тэр мэдэрчээ. Тэгвэл бэлтрэг тэр түлээг ноцож шатгал нь зоргоороо гүйж л байхаас даа.

Бэлтрэг ийн хэсэг гүйсээр яваандаа хөл нь туйван дороо огцом зогсчихов. Тэгээд амьсгаадан зогсож байснаа салганан гуйвж газар пидхийтэл унаад өглөө. Чэнь Жэнь чухам юу болсныг мэдсэнгүй яаран гүйж очоод түшин босгохоор завдав. Чонын хоёр нүд осолгүй хараатай байх боловч тогтож өгөхгүй сөлийжээ. Бэлтрэг тийчигнэн босож ирсэнээ шал умаахан амьтан шиг гуйвж дайвсаар дахин унаад өгөв. Тэр эргэлдэн гүйсээр толгой нь эргэж унасан болохыг Чэнь Жэнь мэдээд ихэд баясан инээлээ. Бэлтрэг урьд нь шонгоо тойрон ийм олон удаа хурдтай гүйж байгаагүй юм. Чоно байтугай тээрмийн илжигийг хүртэл толгой эргэхээс сэргийлэн нүдийг нь боодог шүү дээ. Бэлтрэгний толгой ихэд эргэсэн бололтой огьж байхыг Чэнь Жэнь олж үзэв.

Чэнь Жэнь яаран сандран түмпэнтэй бүлээн ус түүнд ойртуулахад цаадах нь гуйвсаар хүрч ирээд данхийтэл хамраараа түмпэнгийн ирмэг мөргөлөө. Тэгсээр арайхийж түмпэнтэй усанд хошуугаа хүргэн ууж эхлэв. Бэлтрэг ус ууж гүйцээд газар хажуулдан хэвтэж хэсэг зуур амьсгаадан хэвтэж байснаа дахин босож ирлээ. Хамгийн хачирхалтай нь тэр жаахан хүч сэлбэж аваад дахин сэнс мэт эргэлдэн гүйж гарав.

Чэнь Жэньгийн сэтгэл сэмрэх шиг шархираад өөрийгөө улам ч илүүтэй ихээр зэмлэн буруутгажээ. Энэ цөллөгнөөс өөрцгүй хүн амьтангүй эзгүй талд чонын хүрэн дахь амьд хөдөлгүүр түүнд байнга цэнэг өгч байсны хүчинд тэр эцэс төгсгөлгүй мэт үргэлжлэх өвлийг давах эрч хүчийг олж авсан билээ. Энэ үржил шимтэй атлаа хатуу ширүүн нутагт хоёр өөр үндэстний зан чанар болоод хувь тавилан хэрхэн харшилдан мөргөлдөхийг харсан нь түүний хувьд насан туршид эс мартагдах дурсамж болон үлдэх юм. Гэвч түүний чоныг дээдлэн бишрэх сэтгэл, хятад үндэстний чонын талаарх нүдэн балай мэдлэг болон өрөөсгөл үзлийг гэтлэн давах судалгаа чармайлтын золиосонд хөөрхий бэлтрэгийг хорьж цагдан эрх чөлөөг нь заавал хасах хэрэгтэй байсан гэж үү дээ?

Чэнь Жэнь өөрийн энэхүү бусармаг үйлдэлдээ улам бүр эргэлзэн шаналах болжээ.

Ном уншья гээд барьж авахаар олигтой явахаа байсан тул тэр заримдаа өөрийгөө оюун санааны хувьд чоносох өвчин туссан юм биш байгаа даа хэмээн эргэлзэнэ. Тэр эргэн эргэн харсаар бэлтрэгнээсээ холдохдоо түүний төлөө чухам юу хийж болохыг эс мэднэ.

Тэгсээр бэлтрэгний зан чанар өөрийнх нь хувь заяаг шийдсэн юм.

Тэр хүйтэн өвөл бэлтрэгээ алддаг нь мөнх тэнгэрийн таалал төдийгүй, мөнх тэнгэр түүний гэнэн сэтгэлд оноосон насан туршийн гэсгээл байсан гэж тэр өнөөг хүртэл боддог. Түүнчлэн Чэнь Жэнь сайхан сэтгэлийнхээ өмнө гэмтэн болон хувирсан нь хэзээ ч уучлал хүртэхээс өнгөрсөн билээ.

Салхигүй, саргүй, од мичидгүй, нохойн хуцаан ч үгүй пад харанхуй нэгэн шөнө бэлтрэгний шарх гэнэт сэдэрсэн юм. Олонбулгийн буурал тал чулуужсан ургамлын хатаамал мэт амьгүй дүнсийнэ.

Шөнө дундаас хойхно гинжний ширүүн харжигнаанд Чэнь Жэнь цочин сэржээ. Тэр айж цочсондоо толгой нь маш сэргэг, сонсгол нь туйлын сонор болсон байлаа. Чих тавин чагнаваас гинжний харшаан дунд хилийн чанад дахь бараан уулын тэртээгээс чонын гаслангуй улиан бүдэгхэн агаад тасалдангуй сонсогдоно. Мөнөөх орон гэрээсээ хөөгдөн улсын хил давсан чонон сүрэг тэндхийн улам олон тоотой чононуудын дайралтад ялагдан цагаан цээжит азарган чоно цөөн хэдэн шархтай цэргүүдтэйгээ хилийн шугамын өмнөх хүнгүй бүсэд орж ирсэн нь тэр байж таарах нь. Гэвч тэд нар цусан шивэр татуулсан хуучин нутагтаа буцан ирж зүрхлэхгүй байгаа ажээ. Азарган чоно тарж бутарсан цэргүүдээ цуглуулан эцсийн шийдвэрлэх тулалдаан хийхээр ульж байж ч мэднэ.

Чэнь Жэнь сар гаруйн хугацаанд Олонбулгийн талын чонын улианыг сонсоогүй байсан юм. Харин тэрхүү бүгтхэн улилт түүний битүүхэн зовниж байсан бүхий л сураг зангийг агуулах ажээ. Энэ чонын гаслантай улианыг сонссоноос дуулаагүй нь дээр байж мэдэх тул Билиг аав нь өдийд нулимсаа урсгаж байгаа даа гэж тэр бодож байлаа. Олонбулгийн талын хамгийн эрэлхэг зоригтой, ухаалаг, чадалтай чононууд мэргэн буучдын суманд хамгийн түрүүнд өртсөн. Цас орсоны дараахан жийп машин явж чадахаа байсан боловч морин цэргийн гаралтай мэргэн буучид хурдан морь сольж унаад үлдсэн чоныг хөөн одсон билээ. Тийм болохоор Олонбулгийн талын чонон сүрэг дахин өөрсдийн гэсэн шинэ газар орныг нээх хүч чадлаа гээсэн ч байж мэднэ.

Тэгсээр Чэнь Жэньгийн сэтгэлийг хамгийн ихээр зовоож байсан хэрэг үүсэн гарлаа. Удтал тасраад байсан чонын улиан бэлтрэгний хамаг итгэл найдвар, хөөрөл догдлол, эсэргүүцэл болон дайтах хүслийг бадрааж орхив. Бэлтрэг тал нутгийн гэрийн хорионд байсан хунтайз эцэг хааныхаа тусламж эрсэн дууг сонссонтой адил болж орхижээ. Тэр багтран бачимдахдаа их бууны сум болон хувиран чоно улих зүг рүү тэсрэн одмоор санагдаж байгаа бололтой. Гэвч түүний хоолой нь шархалсан болохоор эцэг чоно болон төрөл төрөгсдийнхөө улих дуунд хариу өгч чадахгүй, төмөр гинж, модон шон, хүзүүвчээ тасар татан хаяад тийшээ гүйн очих боломжгүйдээ галзуурах шахаж байлаа. Чонын хорооны тэндэх хөлдүү газар цовхчих чимээг сонсоод бэлтрэг хэрхэн ухаан мэдрэлгүй шахам тойрон гүйж, цамнан цусаа урсгаж байгааг төсөөлж ядах юмгүй.

Чэнь Жэнь айсандаа хөдсөн хөнжлөө яран босож дээл хувцсаа хам хумхан өмсөөд гарлаа. Гар чийдэнгийн гэрэлд нэлийсэн цус асгараад нумын хөвч шиг чивчирсэн төмөр гинжин дээр унжсан хэлнээс гоожсон цус хонгорцоглон хөлджээ. Чонын хүрээ нэлэнхүйдээ уур савссан цус, уур хилэнгээр дүүрсэн байв.

Чэнь Жэнь олон таван юм бодох сөхөө байсангүй бэлтрэгний хүзүүгээр тэврэн авах гэтэл

цаадах нь хавхийтэл хазаад ханцуйных нь хэсэг хөдсийг хүү татаад хаячихав. Ян Кө ч гэсэн ухасхийн гарч ирсэн боловч бэлтрэгний сэтгэлд удтал бөглөрч байсан шаналал нэгмөсөн тэсрээд улангассан шулам галзуу чононоос өөрцгүй болсон тул тэр хоёр ойртох арга өчүүхэн ч үгүй болжээ. Тэр хоёр арга ядахдаа аргал бүтээдэг том эсгийг бэлтрэгний дээрээс хаяад өөрсдөө дарж авцгаав. Цусаа үзэн улангассан бэлтрэг газар, эсгий, төмөр гинж гээд амандаа хүртсэн болгоныг хазлан тийчигнэлээ. Чэнь Жэнь ч гэсэн өөрөө галзуурах гэж байгаа мэт санагдахад биеэ барих хэрэгтэйгээ ухаараад “Бэлтрэг ээ, бэлтрэг ээ” хэмээн аргадан дуудаж байлаа. . . . . Хэдий хэр хугацаа өнгөрсөнийг бүү мэд бэлтрэгний хамаг хүч шавхагдсан бололтой бие нь сулбайгаад ирэв. Тэр хоёр зэрлэг чонотой улаан нүцгэн гараараа тулалдсан улс мэт газар лагхийтэл суугаад уур савсуулан амьсгаадацгаана.

Гэгээ орсоны дараа тэр хоёр эсгийг яраад эрх чөлөө эцгийн хайрын төлөө эрслэн тэмцсэн бэлтрэг ямархуу хохирол амссаныг олж үзэцгээв. Мөнөөх хорхойтсон соёо нь эсгий хазах зуур угаараа хугарсан бололтой завьжаараа ёрдойн цухуйгаад цус тогтохгүй урсана. Бодвол эсгийний тоос шороо шархыг нь бохирдуулсан байж таарна. Сүгтээ тултал ядарсан бэлтрэгний хоолойноос анх наашаа нүүхэд гарснаас их цус гоожихыг үзвэл хуучин шархаа айхтар сэдрээсэн бололтой. Бэлтрэг цустай нүдээ бүлтийлгэн ширтэж том том балга цусыг гүдхийтэл залгиж байлаа. Хөдсөн дээл, шар эсгий, чонын хүрээ гээд хаа сайгүй үхэр нядласан мэт бөөн бөөн цус нэлийн хөлджээ. Чэнь Жэньгийн хоёр өвдөг салганан чичирхийлсэн хоолойгоор “Баларлаа. Энэ удаа ч ганц баларлаа даа. . . .” гэхэд Ян Кө ч гэсэн “Бэлтрэг маань хамаг цусаа юүлчих нь шиг байна. Одоо яадаг юм билээ?” гэв.

Тэр хоёр бэлтрэгний цусыг тогтоох арга эвээ олохгүй хий дэмий л дороо түнтгэнэцгээнэ. Чэнь Жэнь Билиг ааваасаа тусламж эрэхээр мориндоо ухасхийн мордов. Өвгөн ч хамаг хувцсаа цустаж орхисон Чэнь Жэньг үзээд түүнийг дагалдан хүрч ирлээ. Тэр бэлтрэг цус алдсан хэвээр байгааг үзээд “Цус тогтоох эм байна уу?” хэмээн асуув. Чэнь Жэнь яаран сандран дөрвөн шил хурдан цагаан эм гаргаж ирлээ. Билиг өвгөн түүнийг авч гэрт ороод чанасан уушиг зүсэн шархны эмийг цацаад Чэнь Жэньд өгөв. Тэр идүүрийг чонын тойрогт тавихад бэлтрэг нэг дэлбэнг зуугаад залгиж орхилоо. Хонины уушиг улаан хоолойд орж цусыг шингээн томорсоноор бэлтрэг хариугүй хахах шахав. Хурдан цагаан эм түрхсэн хонины уушиг хоолойд нь хэсэг зуур тогтсоноо арайхийн цааш давжээ. Хөөсөн хонины уушиг цусны судсыг дарж улаан хоолой дахь шарханд хурдан цагаан эмийг түрхэж чадав. Бэлтрэг арай ядан хоёр дэлбэн уушиг залгиснаар шархны цус овоо тогтоод ирэв.

Өвгөн толгой сэгсрээд “Цус дэндүү их алдсан болохоор амь гарах найдлагагүй болжээ. Ядаж шарх нь амин газар байгаа болохоор энэ удаа аргаллаа ч дараачийн удаа чонын улианыг сонсоод дахиад л хөндөх болно шүү дээ. Ай мөн хөөрхийлөлтэй болжээ. Би чамд чоно тэжээж болохгүй гээд байхад чи үгэнд ороогүй. Нохойноос долоон дор амьдарч байгаа чоныг үзнэ гэдэг яасан айхтар хэрэг вэ? Талын чоно боолын боолоос долоон дор амьдарч байсанд орвол шулуухан үхсэн нь ч дээр дээ. . .” хэмээн халаглав.

“Аав аа, би түүнийг өөд болтол нь асарч тэжээмээр байна. Та ямар нэгэн арга бодооч дээ. Та надад өвчин эмгэг засах аргаа харамгүй зааж хайрлаач . . .” хэмээн Чэнь Жэнь гуйж гувшлаа.

“Чи ийм болгож хаячихаад бас тэжээх санаатай юу? Одоохон чонын төрхтэй байгаа дээр нь түүний бодийг хөтлөж зөв заяа төөрөгт нь оруулагтун. Битгий өвчтэй нохой шиг үлбийсэн



амьтан байлгаад бай. Түүний сүнсийг хурдан тонилго” хэмээн өвгөн нүдээ бүлтийлгэн зандрал.

Чэнь Жэнь түмэн бэрх, мянган зовлонг туулан байж өдий хүргэсэн чоноо өөрийн гараар тонилгох тухай огт бодож байгаагүй болохоор хоёр гар нь өөрийн эрхгүй салгалав. Гэвч тэр нулимсаа хүчлэн бариад “Аав аа, би түүнийг яахин тонилгож чадах билээ? Өчүүхэн төдий ч найдлага байлаа гэсэн би түүнийг аврах ёстой биш үү? . . . ” хэмээн тэр өвгөнөөс дахин гуйлаа.

Өвгөний царай барайн хэдэнтээ ханиаж байснаа газарт том цэр хаяад “Танай хятадууд хэзээ ч талын монгол чоныг ойлгохгүй улс” хэмээн хашгирав.

Билиг өвгөн мориндоо ууртайгаар мордон хондлой дээр нь ташуураа ширүүхэн буулгаад гэрийн зүг эргэж ч харалгүй давхин одлоо.

Чэнь Жэньгийн сүнс ташуурын амтыг амссан мэт зүрх нь хүчтэй базлав.

Тэр хоёр цастай газар хадагдсан модон гадас мэт сүр сүлдгүй юмнууд болж хоцорчээ.

Ян Кө цастай газрыг өшиглөнгөө намуухан дуугаар “Аав урьд нь бидэнд ийм ширүүн хандаж байсан удаа байхгүйсэн. . . . Бэлтрэг маань том чоно болчихоод эрх чөлөөнийхөө төлөө бидэнтэй амь хайргүй тэмцдэг болжээ. Чоно гэгч эрх чөлөөг үхлээс илүүтэй үздэг амьтан юм байна. Энэ маягаар бол бэлтрэг маань амь гарах найдлагагүй боллоо. Тийм болохоор аавын үгэнд ороод түүнд чоно байх нэр төрийг нь ганц удаа боловч олговол ямар вэ?” хэмээн хэлэв.

Чэнь Жэньгийн нулимс хацарт нь барьцалдан хөлджээ. Тэр уртаар санаа алдаад “Би аавын санааг яахин эс ойлгох билээ? Гэхдээ чи намайг яаж тийм хатуу сэтгэл гарга гэв ээ? Би алсдаа хүүтэй боллоо ч гэсэн энэ бэлтрэг шиг ухаангүй хайрлаж чадах болов уу? . . . Тийм болохоор би эхлээд сайтар бодох хэрэгтэй байна” гэлээ.

Цус их алдсан бэлтрэг салганан босож ирээд чонын хүрээний гаднах цасыг сарвуугаар малтан идэхээр завдахад Чэнь Жэнь түүний хүзүүгээр тэвэрч аваад “Тэр цас идэж өвчнөө намдаах гэж байх шиг байна. Идүүлэх үү, яахав?” хэмээн Ян Көгөөс асуулаа.

“Наадахь чинь цус их алдсан болохоор маш их цангаж байгаа. Одоо түүний аяар байлгаж заяа төөргийг харах л үлдээд байна” хэмээн Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь гараа султгаваас бэлтрэг цаснаас том том үмхэлж эхлэв. Тамир тэнхээгээ алдаж гүйцсэн бэлтрэгт өвдөлт дааралт хоёр нэрмээд давжганатал чичрэх нь эрт цагийн гадаа нүцгэн зогсохоор шийтгүүлсэн гэрийн боол мэт харагдана. Бэлтрэг эцэстээ зогсох ч тэнхээгүй болоод газар сулавхийн хэвтэж том сүүлээрээ нүүрээ халхаллаа. Бэлтрэг хүйтэн агаар сорох бүртээ салганан чичрээд амьсгаагаа гаргахдаа арай жаахан уужирна. Чэнь Жэньгийн сэтгэл ч пэлпэгэнэн бэлтрэгээ ийм сул дорой байхыг огт үзээгүй болохоор яаран нэг эсгий олж ирээд хучихад түүний сүнс биеэс зугуухан ангижран салж байх шиг санагдав.

Үд дунд Чэнь Жэнь хонины сүүл, махны өвдөл цөвдөлтэй зуган буцалган цасны усаар бүлээсгээд бэлтрэгтээ аваачиж өгөв. Бэлтрэг хамаг хүчээ шавхан босоод өлөв доловхийн залгихаар завдсан боловч чонын төрх нь нэгэнт үгүй болжээ. Тэр байн байн амсхийн идэх зуур цус гоожин, ойр ойрхон ханиалгаж байлаа. Хоолойн шархнаас цус алдсан хэвээр байгаа тул урьд нь ганц амьсгаагаар идчихдэг зугангаа хоёр өдөр дараалан гурав хувааж идсэн юм.

Тэр хоёр өдрийн хугацаанд Чэнь Жэнь, Ян Кө хоёр сэтгэл зовнин бэлтрэгээ өдөр шөнөгүй ээлжлэн асарч байцгаалаа. Гэвч бэлтрэгний идэш улам улмаар багассаар сүүлдээ бүр юу ч залгиж чадахаа байв. Түүний ганц залгиж чадах зүйл өөрийнх нь цус болон хувирчээ. Чэнь Жэнь гурван шил талын хар архи өвөртлөөд хурдан мориндоо мордон багийн малын эмчийнх рүү довтолгон хүрэв. Малын эмч газарт нэлийх цусыг үзээд “Нэмэргүй болжээ. Чоно тулдаа л тэсэж байна. Нохой байсан бол аль эрт мажийх байж” гэв.

Малын эмч хүний урманд ганц ширхэг эм өгсөнгүй бусад айлуудаар орохоор яваад өглөө.

Гуравдахь өдрийн өглөөгүүр Чэнь Жэнь гэрээс гараад бэлтрэгний эсгийг сөхөж үзвэл тэр хүзүүгээ хойш өлийлгөн амьсгаадан хэвтэж байлаа. Ян Кө ч түүний дэргэд ирэн яахаа мэдэхгүй зогсоно. Бэлтрэгний хүзүү хүзүүвчиндээ багтахааргүй хавдаад толгойгоо өлийлгөсөний хүчинд жаахан амьсгаа авах боломжтой болжээ. Чэнь Жэнь бэлтрэгний хүзүүвчийг сунгаж өгвөл жаахан уужим амьсгаа аваад тийчигнэн босож ирлээ. Тэр хоёр хамжиж байгаад амыг нь ангайлган үзвэл өрөөсөн талын буйл болон хоолой нь тэр чигээрээ бамбайн хавдаад үрэвсэн идээлсэн байлаа.

Чэнь Жэнь горьдлого тасраад газар лагхийтэл суучихав. Бэлтрэг түүний өмнө арай ядан оцойн суугаад цустай хэлээ бултгануулан аахилах нь хөгшин чонотой уулзаад ямар нэгэн юм ярих гэсэн боловч дуу гарахгүй байгаатай адил харагдана. Чэнь Жэньгийн нулимс жолоогүй бөмбөрөөд сүүлчийн удаа хайртай бэлтрэгтэйгээ дух хамраа нийлүүлээ. Бэлтрэгний урд хоёр хөл биеэ даахгүй байгаа бололтой бөмбөлзтөл чичирнэ.

Чэнь Жэнь ухасхийн босоод монгол гэрийн араас төмөр царил олж бариад бэлтрэгний зүг гүйн ирэв. Бэлтрэг багтран амьсгаадаж, хоёр хөл нь салганан хэзээ мөдгүй унахад бэлэн болжээ. Чэнь Жэнь бэлтрэгний ард гарч төмөр царилаа өндөрт өргөөд хамаг хүчээрээ дагзан дундуур нь буулгаж орхив. Бэлтрэг эцсийн мөчийг хүртэл монгол чонын эр зоригийг гайхуулсаар өчүүхэн ч чимээ гаргалгүй газарт пидхийн уналаа. . . . .

Тэрхэн мөчид Чэнь Жэньгийн сүнс дагзыг чичрүүлэн биеэс гараад эргэн ирэхээргүй одох шиг санагджээ. Тэр цонхийсон мөсөн хонгорцог шиг амьтан чонын хүрээнд удтал гөлрөн зогссоор байлаа. . . .

Тэдний том жижиг ноход юу болсныг бүү мэд бүгдээрээ үхсэн чонон дээр гүйн ирээд хэсэг үнэрлэж байснаа бут үсрэн зугатацгаав. Гагцхүү Арслан л хоёр эзэн рүүгээ харан ууртайгаар хуцсаар байх ажээ.

“Цаашдын хэргийг Билиг аавын хэлсэнчлэн гүйцэлдүүлэхээс дээ. Би түүнийг туламлан өвчих хооронд чи гэртээ ороод жаахан амсхийгээдэх” хэмээн Ян Кө нулимс мэлтрүүлэн хэлэв.

“Чи бид хоёр бэлтрэгээ хамтдаа суйлан гаргасан болохоор арьсыг нь ч цуг өвчиж дээд тэнгэрт сүнсийг нь үдье дээ” хэмээн Чэнь Жэнь мэлрэн өгүүлэв.

Тэр хоёр чичирсэн гараар бэлтрэгээ туламлан өвчихөд үсний сор гялалзсан хэвээр боловч бие нь гэж шулдайсан туранхай мах л үлджээ. Ян Кө туламлан өвчсөн арьсаа монгол гэрийн дээвэр дээр тавихад Чэнь Жэнь цэвэрхэн шуудайд бэлтрэгний махыг хийгээд эмээлийнхээ араар ганзагалав. Тэр хоёр морио унан нэгэн довцгийн орой дээр гарч бүргэдийн сангасаар дүүрсэн хэдэн том чулууны цасыг нудрагаараа зайлуулан цэвэрлээд бэлтрэгний цогцсыг түүн дээр зөөлөн тавьлаа. Тэр хоёрын сонгосон оршуулгын газар хүйтэн жавартай агаад арьсаа өвчүүлсэн бэлтрэг тэр гэхийн тэмдэггүй болсон тул Чэнь Жэнь хүртэл таньж ядна. Түүний хувьд бэлтрэг нь эрс хатуу тулалдаанд амиа алдаад арьсаа өвчүүлсэн талын чононуудаас огт өөрцгүй харагдаж байв. Чэнь Жэнь, Ян Кө хоёр амь шигээ хайртай бэлтрэгнийхээ цайвгардуу цогцсыг үзээд дусал нулимс унагасангүй. Монгол талын чоно болгон арьс үстэйгээ ирээд бараг бүгдээрээ шахуу нүцгэн буцахдаа эр зориг, эрс хатуу зан чанар, хурц ухаан болоод үзэсгэлэнт тал нутгаа хүний орчлонд үлдээгээд оддог жамтай хойно доо. Бэлтрэг нь энэ мөчид хэдийгээр дээлээ тайлсан боловч гинжнээсээ ангижраад дайны талбарт амь үрэгдсэн талын чонон сүргийн бусад гишүүдийн нэгэн адил уудам талын хөрсөндөө чөлөөтэй тааваараа шингэж байна. Бэлтрэг нь энэ мөчөөс эхлэн тал нутгийн зоригтон баатрууд болох чонон сүргийнхээ эгнээнд буцсан тул мөнх тэнгэр ч түүний сүнсийг таалан болгоож буй нь лавтай.

Тэр хоёр зэрэг шахам толгой өргөн үзвээс хоёр хүрэн бүргэд тэдний дээгүүр элин халин нисэж байлаа. Бэлтрэгний мах царцаж эхлэхийг үзээд тэр хоёр яаран мориндоо мордоод толгодын уруу бууцгаав. Тэр хоёр тал руу буусан хойноо эргэн харвал нөгөө бүргэдүүд бэлтрэгийг тавьсан чулууны ойролцоо суусан харагдав. Бэлтрэгний бие хараахан царцахаас өмнө талын бүргэд түүний сүнсийг тэнгэр өөд аваачих нь тодорхой болжээ.

Гэртээ эргэн ирвээс Гао Зянь Жун зургаа долоон метр орчим урт хусан уурга гэрийн үүдэнд босгоод бэлтрэгний арьсанд хатсан өвс чихэж байлаа. Чэнь Жэнь бэлтрэгний хамрын нүхээр нарийн сур сүвлэж түүнийгээ хусан уурганы үзүүрт холбон уяв. Тэр гурав хусан уургаа хамжиж байгаад монгол гэрийн өмнөх цасан хунгарт тогтоолоо.

Баруун умрын ширүүн салхи бэлтрэгний туламласан арьсыг хөндлөн болтол үлээхэд үс нь сэврэн гялалзаад тэнгэрийн найрын гоёлын хувцас мэт үзэсгэлэнтэй харагдана. Монгол гэрийн яндангийн цагаан утаа арьсан доогуур савсахад бэлтрэг үүл манан хөлөглөн дүүлэн нисэх мэт жавхаатай. Энэ мөчид түүний хүзүүнд төмөр дөнгө үгүй, хөл дор нь хавчиг тойрог ч алга.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр агаарт дарцаглах бэлтрэг болон мөнх тэнгэрийг удтал ширтэн зогслоо. “Бэлтрэг минь, бэлтрэг минь, мөнх тэнгэр чамд өөрийн чинь хэн гэдгийг болон бүхий л үнэн мөнийг өгүүлэн хүүрнэх буй за. Чи харин зүүдэнд минь орж ирээд намайг сайн хазаарай даа. . . .” хэмээн Чэнь Жэнь амандаа үглэнэ.

Чэнь Жэньгийн сүүмийсэн харц бэлтрэгнийхээ томоогүй агаад цовоо цолгин бүжиглэхийг харан зогсоход түүний орчлонд үлдээсэн арилж баларшгүй үзэсгэлэнтэй төрх байдлын дунд эрх тааваараа атлаа нугаршгүй хатуу чанга сүнс нуугдсан мэт санагдлаа. Гэнэт бэлтрэгний

урт бие саглагар сүүл луу мэт намилзан хөдлөхөд хөвөх үүлс хөвсгөр цасан дунд Чэнь Жэнь чонын тэргүүтэй луугийн биеийг олж үзэх шиг болоод сэтгэл нь сэрхийн хөдлөв. Салхинд далайн гахай шиг овгонон хөдлөх чонын арьс хурдаа аван сэлж байна уу гэлтэй. . . . . Салхи исгэрэн шуугисаар . . . Үүлс хөлөглөсөн алтан луу шиг бэлтрэгний арьс цасыг яран дүүлсээр мөнх тэнгэр, тэнгэрийн чоно одон, хязгааргүй уудам огторгуй дахь мянга түмэн жилийн туршид эр зоригоо гайхуулан эрсэдсэн талын монгол чононуудын сүнс хуран чуулах тэр зүгийг зорин ниссээр байх авай. . . .

Тэрхэн мөчид Чэнь Жэнь сэтгэлийн гүндээ чонон сүлдийг тодхон олж харсан гэдэгтээ баттай итгэж билээ.

## Төгсгөлийн дуун

Олонбулгийн талд чонон сүргийн бараа үзэгдэхээ байсны удаах жилийн хавар барилгын цэргийн нэгтгэлээс нохдын тоог цөөрүүлэх тушаал буулгав. Түүний цаад санаа нь хэмнэгдсэн махыг тариалангийн аж ахуйнуудад хуваарилан олгох гэсэн хэрэг байлаа. Энэ тушаалын балгийг хамгийн түрүүнд дөнгөж хорвоод мэндэлсэн гөлөгнүүд хүртэж бараг бүгдээрээ шахам тэнгэр өөд илгээгдэж билээ. Олонбулгийн талын хаа сайгүй жингэр ноход гаслалдан, эзнийхээ газарт булсан гөлөгнүүдийг сэмээрхэн ухааж гарган зуучихаад галзуурах нь холгүй давхилддаг болов. Тал нутгийн бүсгүйчүүд цурхиртал уйлалдан, эрчүүд сэтгэлдээ мэгшицгээж байлаа. Олонбулгийн талын том сүрлэг анч нохдын бие улам улмаар давжааран өнгө зүсээ алдаж эхлэлээ.

Хагас жилийн дараахан Арслан гэрээсээ нэлээд зайдуу өвсөн дунд зогсож байтал цэргийн нэгтгэлийн дайчид ачааны машинтай давхин ирээд буудаж алчихаад ачаад явчихав. Чэнь Жэнь, Ян Кө, Жан Зи Юань болон Гао Зянь Жун нар улаан галзуу амьтад хороо болон хоёр ч сумангийн удирдлагатай уулзан энэ тухай мэдүүлсэн боловч хэргийн эзнийг тодруулж чадсангүй. Шинээр тал нутагт ирсэн хятадууд нохойн мах идэх тал дээр нэгэн фронтод нэгдэж чадсан болохоор нохойн алуурчныг харь үндэстэнд хөөгдөж туугдсан баатар эр мэт хаацайлаад өнгөрөхөө мэдэлгүй яахав.

Дөрвөн жилийн дараах нэгэн цасан шуурга хуйсагнасан үүр цүүрээр хөгшин хөвөө хоёр морьтой хүн нэгэн үхэр тэргийг хөтлөн явж одов. Мөнөөх үхэр тэргэн дээр Билиг өвгөний цогцсыг тээж явжээ. Багийн хэмжээний гурван хүн тавьдаг газрын хоёр нь ч орхигдож, зарим айлууд хятад заншлаар талийгаачийг хөдөөлүүлэх болсон билээ. Билиг өвгөн амьд сэрүүн ахуйдаа өөд болохын цагт холын хамаатан хоёр хүнээр цогцсыг нь чоно байж мэдэх хил хамгаалалтын замын хойхон талын хүнгүй газарт хөдөөлүүлээрэй гэж гэрээсэлсэн ажээ.

Хөгшний дүүгийн ярьсанаар хил хамгаалалтын замын архан талд тэр шөнийн турш чонын улиан тасраагүй гэнэ лээ.

Билиг өвгөн нэгэн бодлын их азгүй, нөгөө талаар харин ч маш их хувьтай хүн юм хэмээн Чэнь Жэнь, Ян Кө, Жан Зи Юань гурав өвөр зуураа ярьцгааж билээ. Учир нь тэр Олонбулгийн талын хамгийн сүүлчийн гэгээн сүнсээ тэнгэрт илгээж чадсан хөгшин хүмүүн болон үлдсэн бөгөөд түүнээс хойш тал нутагт чонын бараа туруу дахин огт харагдаагүй юм.

Удаж төдөлгүй Чэнь Жэнь, Ян Кө болон Гао Зянь Жун нар төв суурин газарт ажиллахаар дуудагджээ. Тэгснээр Ян Кө бага сургуулийн багш, Гао Зянь Жун механикжсан бригадын тракторчин, харин Чэнь Жэнь агуулахын нярвын ажил хийх болов. Гагцхүү Жан Зи Юань л урьдын адил адуучин хэвээрээ үлджээ. Тэд явахдаа Ирвэсийг гөлөгнүүдтэй нь цуг Бат Галсмаа хоёрт захиж үлдээсэн бөгөөд эзэндээ үнэнч Анч шар “Эхнэр хүүхдээ” ч хайхралгүй Чэнь Жэнь даган суурин газрыг бараадав. Галсмаагийн үхэр тэрэг аж ахуйн төвд ирэх бүр Анч шар эхнэр хүүхэдтэйгээ уулзан ганц нар нь гарах бөгөөд эргээд буцахад нь яаж ч хориглоод дийлдэхгүй дагаад явчихна. Тэгээд ёс юм шиг хэд хоносны эцэст өөрөө Чэнь Жэнь дээр гүйгээд ирдэг болов. Батынх хичнээн хол зайтай байлаа ч хамаагүй дөч тавин километрийн цаанаас эзнээ гэсээр хүрээд ирнэ. Гэртээ эргэж ирсэний дараах хэдэн өдрийг их л уйтгартай амьтан гуниглан өнгөрөөнө. Хэдийгээр зам зууртаа осол цалгарт өртчих вий

гэж санаа зовох боловч удаа бүр эсэн мэнд эргээд ирдэгт нь яваадаа дасчээ. Тэр хайртай нохойнхоо элгэн садан, эрх чөлөөт талаа санагалзах сэтгэлийг яахин боомилж болох билээ дээ. Гэвч нэг жилийн дараа мөн л ор сураггүй алга болчихов. Талын ноход төөрнө гэж огт үгүй. Түүнчлэн чонон сүрэг үгүй болсон болохоор боохойд бариулсан байх учиргүй. Ер нь ч чонон сүрэг хээр хөдөө ганцаараа явж байгаа нохой руу дайрсан тохиолдол байдаггүй юм. Харин түүнийг харь холоос цагаачлан ирсэн хүмүүс л шоглосон байх магадлал хамгаас их байлаа. . . . .

Чэнь Жэнь, Ян Кө хоёр дахиад л хятадууд голлосон цэвэр хятад маягийн суурин амьдралдаа эргэн оров. Тэдний дийлэнх нь мэргэжлээ сольсон цэргийн хүмүүс буюу гэр бүл төрөл төрөгсөд болон Тяньжинь, Таншань хотын илгээлтийн эзэн байлдагчид байлаа. Гэвч тэр хоёр сэтгэл санааны хувьд хятад маягийн амьдралын хэвшилдээ ээнэгшин дасах хөг нэгэнт өнгөрсөн болохыг бие сэтгэлээрээ мэдэрчээ. Тэр хоёр ажлын хажуугаар биеэ дайчлан суралцахын завсар зайгаар суурингийн ойролцоо байх нэгэн довцог толгой дээр гарч суучихаад баруун умрын хөх тэнгэрийг ширтэн удтал дуугүй суух дуртай болов. Тэр зуур нүд гялбам сэмжин цагаан үүлсийн дунд хайртай бэлтрэг болон Билиг аавынхаа царай төрхийг эрэлхийлнэ. . . . .

1975 онд өвөрмонголын үйлдвэрлэлийн барилгын цэргийн нэгтгэлийг албан ёсоор татан буулгав. Гэсэн хэдий боловч ус өвс жигдэрсэн Унаган голын сав газар тэр чигээрээ цөлжиж гүйцсэн байлаа. Байшин балгас, машин техник, трактор, олонх ажилчин албан хаагчид болон амьдралын хэвшил зэрэг нь тал нутагт үлдэж хоцорчээ. Олонбулгийн талын өнгө зүс жилээс жилд гундсаар л. Хэрвээ хэн нэгэн айлын ганц хонь чононд бариуллаа гэж дуулах юм бол аймаг хошуугаар ам дамжин яригдах сонин содон зүйл болов. Харин хулгана зурмын үлийд бүдрэн хүн морьгүй гэмтэх тохиолдол бараг л хэвийн үзэгдэл болон хувирчээ.

Хэдэн жилийн дараа Чэнь Жэнь Бээжин рүү аспирантын шалгалт өгөхөөр явахынхаа өмнөхөн хүнээс нэг морь зээлж унаад Бат Галсмаа нартай салах ёс гүйцэтгэх далимаар бэлтрэгнийхээ төрсөн үүрийг эргэж очсон билээ. Чонын үүр хэвээр онгойн харлах боловч хагас тохой хэрийн аалзны торонд хэрэгдээд түүнд орсон хоёр царцаа тийчигнэж байх ажээ. Чэнь Жэнь нүхний аман дээр ургасан өвсийг яран дотогш шагайн үзвээс чонын шинхэгний хамар цоргим хурц үнэр аль хэдийн үгүй болсон байлаа. Харин түүний оронд хөрс шорооны үнэр л сэнхийв. Нүхний амны өмнөх долоо найман бэлтрэг тоглодог байсан хэсэгхэн талбайд шарилж өвс саглайн ургажээ. Чэнь Жэнь нүхний амсар дээр удтал ганцаараа суухад түүний хажууд бэлтрэг, анч ноход байтугай нохойн гөлөг ч алга байж билээ. . . .

\* \* \*

Бээжингийн илгээлтийн эзэн залуус Олонбулгийн талд анх очиж байснаас хойш яг гучин жилийн дараа Чэнь Жэнь, Ян Кө хоёр гоёмсог хөх өнгийн Бээжин жийп хөлөглөн тал нутгийг зорин давхилаа.

Чэнь Жэнь нийгмийн шинжлэх ухааны аспирантурыг төгссөний дараа нэгэн их сургуулийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнд улсын онцлог байдал болон бүтцийн өөрчлөлтийн судалгааг хийсээр ирсэн ажээ. Ян Көгийн хувьд хуулийн дээд мэргэжил эзэмшин улмаар мастериин зэрэг хамгаалж өмгөөллийн эрхтэй болсноор Бээжин хотод нэрд гарсан нэгэн

хуульзүйн товчоог үүсгэн байгуулсан юм. Зуугийн талыг хэдийн насласан хоёр дотны анд тал нутгийг сэтгэлдээ тээсээр байдаг боловч тийшээ эргэн очно гэхээр цаанаа л нэг зүрхшээгээд байдаг байв. Гэвч гучин жил гэдэг хүний амьдралын хувьд эрийн цээнд хүрэх настай дүйцэх болохоор мань хоёр Олонбулгийн талдаа эргэн очихоор санаа шулуудацгаасан нь энэ юм. Тэр хоёр харахаас нэг л халшрих болсон Үзэмчингийн талд үлдсэн хуучин анд нартайгаа уулзах далимаараа бэлтрэгнийхээ үүрийг ч эргэе гэж боджээ. Чэнь Жэнь дотроо өөрийн судалгааны үр дүн үзсэн харсантай нь хэр зэрэг нийлэхийг харъя гэсэн бодлыг мөн дотроо тээж явлаа.

Жийп машин өвөрмонголын хилийн дээсийг алхахад тэнгэр урьдын адил гүн цэнхэр хэвээрээ ажгуу. Гэсэн атал тал нутагт урьд өмнө амьдарч байсан хүмүүсийн хувьд тэнгэрийн царай бөртийх үүлгүй нэг л уйтай гундуу төрхтэй болсныг хараад мэдэхээр байв. Талын тэнгэр бараг л цөлийн тэнгэр болон хувирчээ. Гандуу халуун тэнгэрийн дор өтгөн саглагар өвс ногоо үзэгдэхээ байгаад армаг тармаг дэрс бударганы хооронд хатаж хагарсан элсэрхэг хөрс л зайгүй үргэлжилнэ. Тал нь шахуу элсээр хучигдсан засмал зам дээгүүр үхэр хонь ачсан сараалжин бүхээгтэй ачааны тэрэгнүүд тоос манарган дотор газрыг чиглэн давхилдана. Зам зуур монгол гэр, адуу, үхэр сүрэг гэх юм бараг үзэгдэхгүй. Хааяа нэгхэн хонин сүрэг тааралдах боловч дийлэнх нь нооройсон багил хар ноос үсэндээ сүр нь дарагдаад давжаа жаахан гэдэг жигтэйхэн. Урьд өмнө Олонбулгийн заазалсан хонинууд ч арай ийм давжаа жаахан юмнууд байгаагүйсэн. . . . . Тэр хоёр энэ байдлыг хараад бараг буцдаг ч юм бил үү гэсэн бодол төрж эхлэв. Мань хоёрын сэтгэлд хоногшин үлдсэн тал нутгийн өнгө үзэмж хуйлран босох тоос тортогт дарагдаж гүйцэх юм биш байгаа даа.

Ян Кө замын хажууд зогсоод аяны тоосыг гөвөх зуур Чэнь Жэньд хандан “Хэдэн арван жил ажил ажил гэсээр тал нутагтаа эргэн ирэх ч зав гарсангүй. Ойрын хэдэн жил хамт ажиллагсад маань бие дааж ажил албаа аваад явчихтай болсон болохоор энэ удаа талын зүг хөлгийн жолоо залах боломж олдлоо. Гэсэн атал би тал нутагтаа эргэн хөл тавина гэхээр нэг л зүрхшээгээд байна шүү. Энэ жилийн хавар Жан Зи Юань Олонбулгийн талд очоод ирсэнийхээ дараа тал нутаг цөлжиж байгаа тухай зөндөө олон зүйл ярьсан юм. Би амьхандаа чамгүй удаан хугацааны турш сэтгэл зүйн бэлтгэл хийсэн боловч цөлжилтийн явц миний бодож байснаас хавьгүй их байх юм гэж яахин санах билээ дээ?” гэхэд

Чэнь Жэнь жолоог нь цохиж аваад “Алив би жаахан бариадахъя. . . . Билиг аав тэнгэрт халиад хорь гаруй жил болоход түүний урьдчилан зөгнөж байсан таагүй хор уршиг биелэгдэх юм гэж хэн санах вэ? Хоёулаа Олонбулгийн талдаа очоод түүнийг хөдөөлүүлсэн газар усыг тахих юм шүү. Бас бэлтрэгнийхээ үүрийг эргэж тойрч байхгүй бол энэ маягаараа элс шороо дүүрчихсэн байж мэднэ. Тэр хуучин үүр л тал нутгийг хэдэн арван мянган жил эзэгнэж байсан чоно гээч амьтны орчлон хорвоод үлдээсэн цорын ганц ул мөр болж хоцрох нь дээ” гэв.

Ян Кө өгүүлрүүн “Тэр хэдэн зуун жилийн настай хуучин үүр хорин хэдэн жилийн хугацаанд нураад сүйдчихнэ гэж юу байх билээ? Тийм гүн үүрийг дүүргэх элс шороо ч гэж хаана байх вэ?” гэлээ.

“Би Өлзий гуайтай уулзаж чоно судлал болон тал судлалын талаар жаал жуул юм асууж авах санаатай байсан юм. Гэтэл тэр хөгшин тал нутгаа сүйдэж байхыг харж тэсэлгүй хот руу шилжээд одоо охиныдоо биеэ сувилуулж байгаа гэнэ лээ. Манай хятадад эрдэм чадалтай хүнээ шигшээд гаргаад ирэх шинжлэх ухааны үндэслэлтэй ардчилсан тогтолцоо байхгүй

болохоор шулуун шудрага шилдэг тэргүүний хүмүүс дандаа дарагдаад л өнгөрөх юм даа. Түүний уршгаар хятадад хуруу дарам цөөн тоотой байгаа чоно судлал болон талын судлалаар мэргэшсэн хайран сайхан хүн насаараа дээшээ гарахгүй байсаар дууслаа шүү. “Тогтолцооны шар түйрэн”, талын шар түйрэнгээс ч аймшигтай зүйл юм. Ер нь талын шар түйрэнгийн гол гэм буруу нь бүтцийн гажигт байна гэж бодогдоод байх боллоо” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

Жийп машин гангийн халуун наранд хуурай салхи сөрөн мянга гаруй километр давхисны эцэст сая нэг юм Олонбулгийн талд дөхөн иржээ. Удаах өдөр тэд Үзэмчингийн уудам талын зах хязгаар болох Олонбулгийн талын барааг олж харав. Тачир өвс үргэлжилсээр Олонбулгийн талыг алсаас харахад бас ч гэж ногооноороо байх ажээ. Харин доош тонгойн харах юм бол армаг тармаг өвсний зай завсраар элс шавар шаргалтан үзэгдэнэ. Урьд өмнө байсан бол өтгөн сахлаг өвсний завсар чөлөөгөөр аргал, хоргол, хомоол хөглөрөн буурцгийн чичээс мэт нялх мөөгнүүд ургасан байдагсан.

Тэр хоёрын урдхан талд адууны гэдэс давахаар гүнзгий том гол байдгийг санаад яаж гатлана аа гэхээс палхийгээд явчихав. Урьд нь зөвхөн том тэрэг л голыг гатлах боломжтой бөгөөд хилийн цэргийн жийп машинууд хар эрчээрээ дайран гатлах боломжтой байсан билээ. Тал нутгийн борооны улирал тохиоход гол үерлээд хагас сарын турш, шуудан харилцаа, хүнс бараагаар тасалдах үе цөөнгүй байдаг сан. Тэр хоёр голыг яаж гатлах тухайгаа хэлэлцсээр эрэг дээр хүрч ирээд ус балгасан юм шиг таг чиг болцгоочихов. Тэднийг тал нутгаас явах үед гатлахын аргагүй ширүүн урсгалтай байсан гол өдгөө тэр чигээрээ хатаж ширгээд чийгтэй нойтон сайрын дундуур чийгийн улаан хорхойн төдийхөн нарийн урсгал амь тавьж ядан урсах шүү аядаж байлаа. Жийп машин голын сайрыг дайран өнгөрөх агшинд тэр хоёрын сэтгэл улам ч илүү хөндүүрлэцгээв.

Гол гатлаад цаашаа жаахан явтал Олонбулгийн талд хаа сайгүй цементэн баганатай төмөр утас хэрсэн нь фронтын галын шугамд яваад очив уу гэмээр сэтгэгдэл төрүүлнэ. Жийп машин төмөр утсан хашаануудыг сүлжин явахаас өөр аргагүй болов. Төмөр утсаар хашсан бэлчээр наанадаж хэдэн зуун мү газрыг эзлэх бөгөөд доторх өвс нь хашааны гадна талынхаас хавьгүй өндөр ургасан мэт боловч хөрс нь цөлжиж байгаа байдал илхэн байхыг Чэнь Жэнь олж үзэв. Ян Кө өгүүлрүүн “Сүүлийн үед яригдаад байгаа өвсөн хүрээ гэгч чинь энэ дээ. Бэлчээр, мал сүрэг малчдын эзэмшилд очсоноос хойш тэд хаврын мал төллөлтийн үеэр хэрэглэхээр энэ хашсан газартаа зун, намар, өвлийн цагт мал оруулдаггүй юм гэнэ лээ” гэхэд Чэнь Жэнь хариуд нь “Иймхэн өвс ямар нэмэр байх билээ дээ?” хэмээн асуулаа. “Миний дуулснаар сүүлийн хэдэн жил малчид мал сүргийн тоог цөөлж, зарим нь бүр хагасыг нь арилжсан гэдэг шүү” гэж Ян Кө хариулав.

Хэд хэдэн тийм хашсан бэлчээрийг өнгөрсөний дараа “Өвсөн хүрээний” гол дунд вааран дээвэртэй гурав дөрвөн өрөө бүхий тоосгон байшин болоод төлийн пүнз байхыг мань хоёр олж үзжээ. Гэвч тэдгээр байшингийн яндангаар утаа савсаж, үүдээр нь нохой тугал мэтийн амьтад гүйлдэхгүй байхыг бодвол жилийн энэ улиралд хүн суурьшдаггүй болох нь илт ажээ. Малчид бодвол аглаг уулын эзэнгүй бэлчээр рүү оторт гарсан байж таарна. Бэлчээр нутгийг зайгүй хэрсэн энэхүү төмөр утсан хашаануудыг хараад Чэнь Жэнь их л санааширангуй байдалтай “Монгол даяар зартай Үзэмчин морьдын уугуул нутаг төмөр утсан хашаагаар хэрэгдэх юм гэж урьд өмнө хэн санах билээ дээ? Харуй бүрийгээр бол морь мал тээгчээд



аминд нь хүрч мэдэхээр юм байна даа. Үүний уршгаар дэлхий дахиныг айлган чичрүүлж байсан монгол морьд монголын талаас хөөгдөн гарсанаас өөрцгүй болжээ. Малчид мотоциклоор малаа хариулдаг болсон нь амьдрал ахуй баян чинээлэг болсоны илрэл мэтээр сурталчлаад байдаг. Гэтэл үнэн хэрэг дээрээ морьдоо тэжээх өвс бэлчээргүй болсон хэрэг байна шүү дээ. Чоногүй болсноор морьгүй, морьгүй болсноор одоо үхэр хоньдоо барахын цондон болжээ. Морин дэл дээрх үндэстэн мотоцикл унасан үндэстэн болон хувираад яваандаа экологийн сүйрэлд учирсан үндэстэн болохыг хэн байг гэхэв ээ? . . . . Чи бид хоёр ингэж нэг юм суурьшмал соёл иргэншил нүүдлийн соёл иргэншлийг бутниргэхийг хардаг байна шүү. Манай улс уг нь улс төрийн хувьд нэг улс хоёр систем гэсэн тогтолцоог хэрэгжүүлж байгаа атлаа хятад үндэстний ухамсрын гүнд янз бүрийн бүс нутгуудыг нэг хэв маягаар удирдах үзэл амь бөхтэй оршсоор л байна. Түүний уршгаар газар тариалан, мал аж ахуй, ойн бүс, загас агнуур, тэр ч байтугай хөдөө хотыг ялгалгүй нэг хэв загвараар удирдан хөгжүүлэх гэсээр ёстой алинг нь алдуулж, бантан хутгаж гүйцжээ. Агуу их ялалтынхаа горьг асар их хэмжээний санхүүгийн татаасаар нөхөх санаатай боловч зуун жил татаас олголоо ч тал нутгийн амссан хохирлыг нөхөх нь юу л бол доо?” хэмээн өгүүлэв.

Тэр хоёр хүний бараа олж харах санаатай урьд нь багийн төв байсан газрыг чиглэн хурдаллаа. Гэвч танил дасал болсон хөтлийг даван үзвээс урьд нь багийн төв байсан газар дэрс шарилжинд дарагдан улаан элсэн дундуур оготны мөр хаа сайгүй могой мэт мурилзан оджээ. Урьд өмнө байсан хэдэн эгнээ тоосгон болон шавар тагзнууд ганц ч нь үлдээгүй байлаа. Хананууд нь нэгэнт нурж унаад элс шороонд дарагдан хулганы үүрэнд эзлэгдэж гүйцжээ. Мань хоёр энэ газраас холдон одоод хорин жил болохын хооронд багийн төв элсний нүүдэлд бүрэн эзлэгдсэн нь энэ аж.

Чэнь Жэнь гүнээ санаа алдаад “Тал нутагт чоно үгүй болсноор оготно хулгана гаардаг ажээ. Хулганад ингэж ааглуулах юм гэж хэн санах билээ дээ? Манай хятадад хэдийгээр гудамжаар гүйн өнгөрсөн хулганыг хүн болгон хашгиран элдэх хэрэгтэй гэлцэх боловч тэдний далд ухамсарт хулганыг дээдлэх үзэл бөх оршсоор байдаг бус уу? Адгийн наад зах нь арван хоёр жилийн эхэнд хулганыг аваачаад залчихсан байдаг. Хятадын жижиг тариачны ухаан санаа, үржиж өсөх, газар сэндийлэх болон мугуйд зан зэрэг нь хулганаасаа ямар өөрц байх билээ дээ?” гэв.

Ян Кө, Чэнь Жэньгээс жолоогоо шилжүүлж аваад ойролцоох довцгийн зүг хар хурдаараа давхив. Довцгийн орой дээр гараад сая нэг юм хэдэн үхэр ганц хоёр утаа суунагласан байшингийн барааг олж харсан боловч ганц монгол гэр үзэгдсэнгүй. Ян Кө хамгийн наад захын байшинг чиглэн хурдласаар тав зургаан километр замыг туулаад байтал алсад суунагласан урт тоос босохыг хараад Чэнь Жэнь хурдан морьтон байгаасай гэж хичнээн их хүссэн гээч. Гэтэл ойртоод ирэхийг үзвэл нэгэн Ямаха маркийн мотоцикл унасан хүн байлаа. Савхин хүрэм, дуулга малгай өмссөн арван тав зургаа хэрийн настай нэгэн залуу хөвүүн жийпний дэргэд ирээд тоормослон зогслоо. Залуу хөвүүн бага калибрийн буу үүрч, арын суудалд ганзагалсан бүргэдийн биенээс цус шүүрч байхыг Чэнь Жэнь машинд гайхан харав. Билиг өвгөн ийм төрлийн бууг анх удаа хараад хирдхийн цочиж байсан дүр төрх түүний нүдний өмнө урган тодрох шиг боллоо. Монгол залуус аль хэдийн тийм төрлийн зэвсгийг эзэмшээд орчин үеийн хоёр хүрдэт хурдан хүлгээр ан хийдэг болсон байх юм гэж хэн санах билээ дээ?

Ян Кө түүнтэй монголоор мэндлээд нэр усаа мэдэлцэв. Залуу хөвгүүний царайд тоомжиргүй жихүүн байдал тодрох боловч харин Бээжин жийпийг сониучирхан ширтэнэ. Тэгснээ зүүн хойд нутгийн хятад аялгуугаар Цолоо гэгчийн бага хүү, аймгийн дунд сургуульд сурч байгаад зуны амралтаараа энд ирсэн хэмээн хариу өгүүллээ. Цолоо гэж мөн л харь нутгаас цагаачлан ирээд аж ахуйн төвийн барилгын ангид даамлын ажил хийдэг байсан хүн болохыг Чэнь Жэнь сая нэг юм бүүр түүрхэн санав. Тал нутагт барилгын цэргийн нэгтгэл болон аж ахуй нэгдлүүдийг татан буулгасны хойно тэнд ажиллаж байсан албан хаагчдад ч мал бэлчээр хуваарилан олгосон болохоор хятад маягийн суурьшмал амьдралтай малчид болон хувирсан гэж Жан Зи Юань нарын нөхөд нь түүнд ярьж байсан билээ.

“Чи бүргэд агнаж яах гэсэн хэрэг вэ?” хэмээн Чэнь Жэнь асуулаа.

Хүү хариуд нь “Зүгээр л зугаацсан юм. . . .” хэмээн хариулав.

“Чи чинь сургуулийн сурагч хүн байж зэрлэг ан амьдтыг хамгаалах ёстойг мэддэггүй хэрэг үү?”

“Бүргэд чинь хурга барьдаг муухай амьтан. Манай Олонбулагт оготно хулгана элбэг болохоор хэд гурван бүргэд цааш харууллаа гэхэд гадаад монголоос нисээд л хүрээд ирэх юм чинь”

Ян Кө түүнээс Бат Галсмаа нарын гэрийг асуулаа. Залуу хөвүүн хойд зүгийг зааж “Хил хамгаалалтын засмал замын арын хамгийн том чулуун хороо бол тэднийх” гэгчихээд шурдхийн бүргэд шувуу элин нисэх нэгэн довцгийг чиглэн одлоо.

Олонбулгийн тал нутаг дахь бүхий л зүйлс орвонгоороо хувиран өөрчлөгдөөд өөрсдөө хүртэл хар элгийн хүмүүс болсон юм шиг этгээд сэтгэгдэл тэр хоёрт төрөх болов. “Хоёулаа өөр ямар ч айлаар дайралгүй шулуухан Батынд давхин очъё. Тэгсэн цагт сая чи бид хоёр энд хүнийрхүү зангаа гэж мэдэх юм” хэмээн Ян Кө хэллээ.

Жийп машин хурдаа нэмэн танил дасал хил хамгаалалтын замыг чиглэн давхилаа. Чэнь Жэнь хажуугаар жирэлзэн өнгөрөх довцог толгодын энгээр тарваганы бараа олж үзэх санаатай ажиглаж явлаа. Хуучин тарваганы дошнуудын эргэн тойрон өндөр сахлаг өвс ургасан хэвээрээ боловч хэдэн арван километр явах зам зуур ганц ч тарваганы бараа олж үзсэнгүй. “Хүүхэд хүртэл бага калибрийн буу үүрчихсэн явж байхад тарвага яаж байх билээ дээ?” хэмээн Ян Кө хэлэхэд түүний горьдлого бүрмөсөн тасарчээ.

Жийп машин хэд хэдэн айлын байшингийн өмнүүр давхин өнгөрөхөд хоёр гурван нохой үзэгдэх боловч Бээжингийн хувийн тохилог сууцнуудын тэжээдэг овчарк нохойноос хавьгүй давжаа жижиг амьтад болон хувирчээ. Машин тэрэгний бараа харуут долоо найм байтугай арван хэдүүлээ сүрэглэн боргож, арслан хүрхрэлтээрээ араатан чонын цөсийг чичрүүлдэг байсан үс ноос ихтэй талын сүрлэг монгол нохдын бараа туруу ч үгүй болж дээ. “Чоно гээч амьтан монгол нохдыг хүртэл дагуулан үгүй болчих гэж? Түүний хэрээр тэмцэл тулалдааны сураг тасарч, назгай, давжаа төрх байдал ноёрхоо шив. . . . Монгол ноход уг нь Бээжингийн нохдоос ч өмнө хүний хамгийн хайртай дотно амьтан байсан байх шүү” хэмээн Ян Кө хэллээ.

“Хэрвээ манай Арслан байсан бол энэ гоолиг амьтдыг нохой гэхэд ч мөн хэцүүхэн болох байх

даа” гээд Чэнь Жэнь санаа алдлаа.

“Чоно үгүй болсноор монгол талын олон амин сэжмүүд тасран унаж дээ. Сүрлэг анч ноход эрх танхи амьтдаар солигдоод, эрэлхэг монгол морьд жуулчдын зугаа, дурсгалын зураг авахуулах хэрэгсэл төдийхөн болон хувирчээ” хэмээн Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь тоос орсон нүдээ нухлангаа “Хятадууд тал нутгийн тухай ямар ч ойлголт байхгүй байсаар ирсэн. Тийм ч учраас өнөөгийн түвшинд хүртэл тал нутгийн ач холбогдлыг сайтар тодорхойлж чадалгүй эдийн засгийг чухалчлан экологийн онцлогийг орхигдуулсаар байна. Өвөрмонголын тал нутаг бол уг чанартаа дотор газрын экологи амь амьдралын халхавч юм шүү дээ. Тийм болохоор өвөрмонголыг экологийн онцгой бүс гэж зарлаад тэр чиглэлийн томоохон санхүүгийн татаас олгож, газар тариалан, аж үйлдвэр эрхлэн, дотор газраас хүмүүс шилжин суурьшихыг хатуу чанд хориглон, зөвхөн тусгай зөвшөөрлөөр зорчдог болгох хэрэгтэй юм” гэв.

Тэдний жийп машин хоёрдугаар багийн хаваржаа байсан нутагт орж ирэв. Гэвч нүдний өмнө армаг тармаг дэрс бударганыг эс тооцвол халцгай өвс нэлийгээд шар хуй салхи байн байн хуйсагнах ажээ. Чэнь Жэньгийн нүд арган хорссоор байвч алсад сүүмэлзэн харагдах Хар чулуут уулын барааг хараад машины жолоог шулуухан тэр зүгт зал гэж Ян Көд хэлмээр санагдаж байлаа.

“Би зурагтаар сүүлийн хорин жилийн турш амьтны ертөнц нэвтрүүлгийг үзэх болгондоо хоёр биенээ байнга харааж зүхэж байдаг юм. Хэрвээ чи гэж бүтэлгүй амьтан байгаагүй бол бид хоёр юу боллоо гэж тал нутагтаа тийм том сэтгэлийн өртэй хоцрох билээ дээ? Өвөрмонголын өр зүрхэнд оршиж байсан хамгийн шилмэл омгийн долоон хөөрхөн бэлтрэг бүгд чамаас болж амь тавьсан. Тэр тусмаа би чиний хамгийн том хамсаатан гэж байгаа. Манай хүү тэр тухай сонсох бүртээ бидний мулгуу тэнэгийг гайхдаг юм. Тариачид гэж мөн ч харгис улс шүү. Орчин үеийн хууль зүйн үүднээс ярих юм бол миний хүлээх хариуцлага ч чамгүй их байж таарна. Би л чамайг дэмжиж бэлтрэг суйлах ажилд хамт явсан шүү дээ. Хэрвээ би явахгүй гэсэн бол чи тэр харанхуй шөнө юу боллоо гэж ганцаараа явж зүрхлэх билээ? Шанхайн илгээлтийн эзэн залуу Юнь Наньд үйлдсэн нүглийн өр төлөөсийг цайруулаад мөнөөх гомдоож байсан охинтойгоо эргэн учирсаныг дуулаад би хичнээн их атаархсан гэх билээ? Харин чи бид хоёрын тарьсан үйлийн үрийг яахин эргүүлэн төлж болох вэ? . . . Явж явж охидууд л арай аясаар зөөлөн юм даа. Манай хүү гэр орондоо чононоос өөрцгүй хэр нь гадуур гарахаараа хониноос долоон дор амьтан болон хувирах юм. Ангийнхаа атамануудад гурван ч удаа мөнгөө дээрэмдүүлчихээд тэр тухай ганц үг ганхийгээгүй байсан гээд бод доо” гэж Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь дуу шуугүй явсаар л байв. Ян Кө дахин ам нээж “Чи сүүлийн хорин жилийн турш гадаад дотоод, бүтэц загвар, эдийн засаг улс төр, хот хөдөө гээд судлаагүй сэдэв бараг үгүй шахам атлаа яахаараа адаг сүүлдээ үндэстний зан чанар гэсэн судалгаан дээр эргэлт буцалтгүй зогсдог билээ?” хэмээн асуулаа.

“Хэрвээ энэ асуудлыг шийдэхгүй бол бусад асуудлуудыг үндсээр нь шийдэж болно гэж чи бодсон хэрэг үү?” хэмээн Чэнь Жэнь сөргүүлэн асуув.

Ян Кө хэсэг зуур бодолхийлж байснаа “Нээрэн ч тийм юм байна шүү. Лү Сюнь зохиолч үндэстний зан чанарын асуудлыг анх дэвшүүлэн тавьсан цагаас хойш өнөө хүртэл бүрэн дүүрэн шийдэгдээгүй байгаа. . . . Манай улс өөрчлөлт шинэчлэлтийг эхлээд хорин жил болоход чамгүй их амжилт олсон боловч тулгарч буй асуудал ч мөн зөндөө их байсаар байна. Чи надад энэ талаар хожим завтай үедээ тухтай ярьж өгөөрэй” гэлээ.

Жийп машин хил хамгаалалтын засмал замыг даган давхисаар нэгэн өндөр довцгийг давтал нүдний өмнө хилийн шугам зурайн үзэгдэхэд мэл гайхаж хоцорлоо. Урьд нь арав гаруй километрийн өргөнтэй хилийн хориотой бүс өдгөө хүн малын хөлд дарагдаж гүйцсэн байлаа. Мянга гаруй километр давхисны эцэст олж үзсэн бэлчээр нутаг гэсэн нэрэндээ дүйцэх газар гэвэл чухам эндхийг л хэлэх буй заа. Бэлчээрийн өвс хэдийгээр урьдынхтай зүйрлэхийн аргагүй тачир тарчиг болсон ч хилийн хориотой зурваст хэдэн арван жилийн турш хашигдсан хөрс хараахан цөлжөөгүй ажээ. Нөгөө талаар хилийн нөгөө талд орших онгон талын нөмөр нөөлгийг ч хүртсэн байж болох талтай. Замын турш нүдний өмнө дурайн өнгөрсөн уйтай шаргал төрх агшны төдийд ул мөргүй арилан оджээ. Вааран дээвэртэй улаан тоосгон байшингууд хашсан бэлчээрийн гол дундах өндөрлөг газрыг эзлэн байрлаад хэдэн арван хонин сүргүүд энд тэнд налайн бэлчинэ. Сүрэг хоньдын тоо гурав дөрвөн мянгаас цөөнгүй байгааг үзээд тэр хоёр ёстой л нэг алмайрч хоцорчээ.

Ян Кө таталт сайтай дурангаа гаргаж ирэн харсанаа “Чи бид хоёрын хариулах нь байтугай харж ч байгаагүй олон хоньд гэж энэ байх даа. Ямар ч байсан бидний үеийнхээс хоёр дахин олон байх шиг байна. Хоньчин нь ядарч үхдэгүй юм байх даа” гэлээ.

“Урьдын хонин сүрэг чинь нийгмийнх байсан шүү дээ. Харин одоо хонь мал бүгд хувьд шилжсэн болохоор тоо толгой хичнээн олон байлаа ч гэсэн торох юмгүй хариулж л таарна. Өөрөө хариулж дийлдэггүй юм бол хүн хөлслөөд ч болов хариулуулна шүү дээ. Тэр хэрээр ажлын байр буй болж байгаа хэрэг. Эдийн засгийн ашиг сонирхол хөдөлмөрийн идэвхийг дэмжих гэдэг чинь энэ шүү дээ” хэмээн Чэнь Жэнь хэлэв.

Чэнь Жэнь ийм олноор суурилсан хоньдыг хараад үнэндээ дотроо маш их бэргэж байв. Урьд нь зуны цагт энэ мэтээр олон хоньдыг нэг дор бэлчээх явдал байдаг боловч цаана нь гурван улирлын нөөц бэлчээр байсан тул хүмүүс тэгтэл санаа зовох зүйл үгүй байсан юм. Харин одоо суурин маллагааны нөхцөлд “Өвсөн хүрээ” нэрт хашсан бэлчээрээс өөр нөөц гэх юм үгүй болчихсон шүү дээ. Малчид энэ байдлыг хэрхэн даван туулж байгааг мэдэхээр тэр хоёр улам ч яарцгааж эхлэв. Энэ байдал нь өвөрмонголын тал нутгийн хамгийн эцсийн хөгжил цэцэглэлтийн хуурамч дүр төрх байж болох юм хэмээн Чэнь Жэнь бодож явлаа.

Хоёр мотоциклтон болоод нэг морьтон Бээжин жийпийг чиглэн хүрч ирлээ. Чэнь Жэнь ийнхүү тал нутагт нүдний гэм болоод байгаа морьтны барааг сая нэг юм олж харлаа. Дан тэрлэг өмссөн хүдэр биетэй мотоциклтон морьтноос түрүүлэн тэдний дэргэд ирэхэд Чэнь Жэнь, Ян Кө нар зэрэг шахам “Баяр, Баяр байна шүү дээ” хэмээн хашгиралдав. Манай хоёр жийпнээсээ үсрэн бууцгаахад баавгай шиг бахим зузаан эр болсон Баяр Чэнь Жэньг тэврэн шуухитнангаа “Чэнь Жэнь, ээж машины бараа харуутаа та нарыг мөн байна гэж таньсан юм. Тэгээд намайг тосоод ир гэж явуулсан нь энэ” гэснээ Чэнь Жэнь, Ян Кө нарыг ээлжлэн чанга чанга тэврэнгээ “Чэнь Жэнь ирж байхад Ян Кө хамт байлгүй хайчихав гэж ээж хэлээд байсан нь онож шүү. Алив манайх руу явцгаая” гэлээ.

Арван тав зургаа орчим насны хоёр хөвүүн морь мотоциклоосоо бууцгаахад Баяр дуудан ойртуулаад “Алив Чэнь Жэнь ах, Ян Кө ах нартайгаа танилц” гэв. Нөгөө хоёр нь хоёр шинэ танилтай уулзан золгосны дараа Бээжин жийп рүү хамаг анхаарал нь явчихав. “Энэ хоёр хүүхэд зуны амралтаараа нааш ирээд байгаа юм. Эднийг удахгүй та хоёрын гарт атгуулаад их дээд сургуулийн бараа харуулах санаатай. Алив машиндаа сууцгаа. Ээж Жан Зи Юаниас та нарыг ирэх гэж байгаа гэдгийг дуулаад хариугүй бэтгэрэх шахсан амьтан байгаа” гэжээ.

Жийп машин мотоцикл морьтой хүмүүсийг дагалдан хамгийн алсын утаа гарч байгаа зүгийг чиглэн давхилаа. Бат Галсмаа хоёр аль хэдийн цал буурал хөгшид болчихоод бие биеийгээ түшсээр нэлээд хол зайтай тэднийг угтжээ. Чэнь Жэнь машинаас үсрэн буугаад “Эгч ээ, Бат ах аа” хэмээн нулимс мэлмэрүүлэн тэднийг тэврэн авахад Галсмаагийн халуун нулимс мөрөн дээр нь под подхийтэл дуслаж байлаа. Тэр Чэнь Жэньгийн мөрийг цохилонгоо их л ууртайгаар “Хорь гаруй жилийн хугацаанд ганц удаа эргэж ирэхэд яадаг байна вэ? Бусад илгээлтийн эзэд хоёр гурван ч удаа ирчихээд байхад чинь. Байтлаа хадан гэртээ харьсан хойно минь ирэх чинь дутаа юу?” гэхэд Чэнь Жэнь “Ёстой харласан бүтэлгүй толгой гэж намайг л хэлэх байх даа” хэмээн өөрийгөө зүхэв. Галсмаа эвэршсэн алгаараа Чэнь Жэньгийн нулимсыг арчиж өгөөд “Чи чинь нэг ном бариад авахаараа төрсөн аав ээжийгээ хүртэл ор тас мартчихдаг хүн болохоор тал нутгийн бор гэрээ яахин санах билээ дээ?” гэв. Чэнь Жэнь хариуд нь “Өнгөрсөн он жилүүдэд өдөр шөнөгүй тал нутгаа санагалзан дурсаж ном хүртэл бичээд байгаа шүү. Тэр номондоо аав болон та нарынхаа тухай оруулсан. Би яахин тал нутаг болон та нарыгаа мартаж билээ. Харин ч сэтгэл санаагаар та бүхэнтэйгээ амьдарсаар өдий хүрлээ” гэснээ хоёр хөгшнийг түшин машинд суулгаад гэрийнх нь зүг давхив.

Тэднийх дээр үеийнхээс хоёр дахин том чулуун хороотой болжээ. Чулуун хорооны баруун талд вааран дээвэртэй сансрын антенн, салхин сэнс суурилуулсан гоёмсог байшин тэднийг угтлаа. Байшингийн баруун цонхны харалдаа дээхэн үеийн бэрзээнтэн бүрхүүлтэй хуучин Бээжин жийп тавиастай байх ажээ. Байшин болон чулуун хорооны эргэн тойронд хааяа нэг хэсэг бусаг лууль шарилж ургасныг эс тооцвол улаан халцгай болсон харагдана. Чэнь Жэнь машинаасаа буулаа. Хорин жилийн дараа Олонбулгийн талдаа эргэн ирэхэд хөгшин аавынхаа нүдэнд дулаахан монгол гэрт дахин саатан морилж чадахгүй болсондоо сэтгэл нь огшоод ирэв.

Чэнь Жэнь, Ян Кө хоёр машин дээрээс архи тамхи, нөөш, ундаа, чихэр, хантааз, суран бүс, асаагуур зэрэг бэлэг сэлтийн зүйлсийг буулган монгол гэрийн хэв маягтай тохижуулсан зочны өрөөнд оруулав. Дөч гаруй хавтгай дөрвөлжин метр талбайтай зочны өрөөнд буйдан, явган ширээ, зурагт, дүрс бичлэгийн магнитофон, гоёмсог шилэн хорго гээд л байхгүй юм бараг алга аа. Чингис хааны цээж хөрөг бүхий жижиг хивсийг хананы голд өлгөжээ. Их хаан амгалан дөлгөөн харцаар өөрсдийн үр хойчис болоод алсын зочныг таалан ширтэж байлаа. Чэнь Жэнь хөргийн өмнө хэсэг зуур хүндэтгэлтэй номхон зогсов.

“Наадхи хивсийг чинь манай аавын нэгэн хамаатан гадаад монголоос нааш зочлон ирэхдээ бэлэглэсэн юм. Манай эндхийг зам харгуй сайтай, амьдрал ахуй баян чинээлэг хэрнээ соёл боловсрол, өвс бэлчээрийн хувьд тааруухан юм гэж байсан шүү” хэмээн Галсмаа өгүүлэв.

Тэднийхэн эрвийх дэрвийхээрээ хөдлөн сүүтэй цай аягалж, өрөм цагаан идээ таваглалаа.

Галсмаа бүжин чихрийг төдийлөн таашаахаа больжээ. Гэвч тэдний авчирсан чихэр жимснээс амсахаа мартсангүй. Тэр инээд алдаад “Чи ч намайг овоо мартаагүй байгаа юм байна аа. Дээр үед надаас нуугаад нохойдоо чихэр хаяж өгөөд байдаг байж билээ” гэв. Галсмаа Чэнь Жэньгийн авчирсан цэлцэгнүүр чихрийг ар араас нь амандаа хийнгээ “Чи ч над шиг шүдгүй болсон хүнд ганц таарсан амттан авчирсан байна шүү. Намайг шүдгүй болсон гэдгийг яаж мэдээ вэ?” гээд тас тас хөхрөнө.

“Миний өөрийн хэдэн шүд унаад үсэн буурал өвгөн болчихоод байхад та хэдийгээ яахин мартаж вэ? Би Бээжинд байдаг найзууддаа таныг залуудаа том чоныг сүүлдэж байгаад ахар сүүлийг нь хуга мушгичихдаг байсан тухай ярихад бүгдээрээ шахам тал нутагт айлчлан очиж тантай учран золгох юмсан гэгцгээдэг юм шүү” гэж Чэнь Жэнь хэлээд ов тов бууралтсан санчгаа иллээ.

“Хүүе, тэгж яаж болох вэ? Манай гадаад монголын хамаатан энд ирэхдээ тэнд чоно алахыг хориглодог тусгай бүс нутаг байдаг гэж байсан шүү. Сүүлийн үед зурагтаар чоно алж болохгүй гэж ярих болсон байна лээ. Гэтэл чи хүмүүст миний урьдын нүглийг ярьж байдаг чинь яаж байгаа хэрэг вэ?” хэмээн Галсмаа уулга алдан өгүүлэв.

Харуй бүрий болохын алдад байшингийн гадна хонь малын хөлийн танил чимээ сонсогдлоо. Чэнь Жэнь, Ян Кө хоёр гэрээс гарахад хонин сүрэг үерийн ус мэт нүүгэлтэн ирэхийг үзэв. Нэгэн хятад хувцастай хоньчин морь уначихаад тэдний сүргийг туун ирж байлаа. Тэр бодвол Олонбулгийн талд шинээр дуулдах болсон хөлсний малчин байх гэж Чэнь Жэнь таамаглалаа. Тэр хоёр хоньдыг зөөлөн тууж хороо руу нь оруулав. “Та хоёр ч цадтал идсэн хонин сүргийг ширүүн тууж болдоггүй гэсэн хорин жилийн өмнөх хоньчны мэдлэгээ мартаагүй байх шив дээ” гээд Бат инээд алдав.

Чэнь Жэнь ч мөн инээд алдаад “Тал нутгийн ажил үйлсийг яахин мартаж чадах вэ? Овоо олон хоньд байх шиг байна шүү. Хэдэн хонь байгаа юм бэ?” хэмээн асуулаа.

“Гурван мянга найман зуу” гэж Бат хариулав.

“Нэг хонь 150-170 юань хүрнэ гэж бодвол танай хөрөнгө хогшил 600-700 мянган юань давчихжээ. Дээр нь байшин сав, машин мотоцикл, үхэр адууг нэмбэл та чинь саятан болчихсон байна шүү дээ” хэмээн Ян Кө дуу алдав.

“Элсэрхэг хуурай газарт байгаа хөрөнгө ямар найдвар байх билээ. Хэрвээ цаашдаа манай эндхийн бэлчээр цагаачдын нутаг шиг цөлжөөд улаан халцгай болчихвол бид ч гэсэн ядуу дунд орлоготой малчдын эгнээнд шилжинэ гэсэн үг” гэж Бат хэлэв.

Ян Кө асууруун “Танай хуваарьт бэлчээрт уг нь хичнээн тооны мал өсгөх боломжтой вэ?” гэхэд

Бат хорооны хаалгыг хааж бөхлөнгөө “Уг нь бороо хур сайтай бол 2000 хонь өсгөх боломжтой. Харин гандуу үед бол 1000 хонь өсгөж болох байх. Гэтэл сүүлийн дөрөв таван жилийн турш гандуу байгаа болохоор 1000 хонь өсгөхөд ч хүчиртэй болоод байна” гэлээ.

Чэнь Жэнь үүнийг сонсоод давхийтэл цочиж “Тэгээд та яахаараа ийм олон хонь өсгөдөг билээ?” хэмээн асуулаа.

“Чи намайг бэлчээрийн даац хэтрүүллээ гэх гээд байна аа даа. Манай энэ хавийн малчид бүгдээрээ Галсмаагийн суурийн малчид, тэд танай хөгшин аавын чинь сургаалаар хүмүүжсэн улс болохоор бэлчээрийн даацыг тохируулах тухай мэдэлгүй яахав. Би энэ олон хоньдын зөвхөн хагасыг нь л онд оруулдаг юм. Тухайн жилийн 1400 хурга, болон зургаан зуун хөгшин сувай хоньдыг зарж борлуулчихдаг. Тэгээд хонь зарж олсон ашгаасаа тодорхой хэмжээний мөнгөөр өвс тэжээл худалдаж аваад хонин сүргээ онд мэнд оруулахад асуудал байхгүй. Зун намрын заагаар хонин сүргээ туугаад аглаг хүнгүй бэлчээрт оторлон тарга тэвээрэг авахуулчихна. Ойрын хэдэн жил гандуу хуурай байгаа болохоор шумуул хүртэл бараг үзэгдэхээ байсан шүү дээ. . . . .” хэмээн Бат хуучлав.

Зочны өрөөнд эргэж ирэнгээ Бат цааш нь “Манай хуучин суурийн малчид монголын уламжлалт арга ухааны дагуу өвсний гарцад тохируулан хонь малаа өсгөж байгаа. Өвсний гарц сайтай жил ахиу өсгөөд, бага үед нь тоо толгойг нь цөөрүүлнэ гэсэн үг. Гол нь тэнгэрийн тааллыг дагахаас биш, сувьдаг шунахай сэтгэлдээ хөтлөгдөж яахин болох билээ. Гэтэл цагаачид хуучны сайхан уламжлалыг уландаа гишгээд өөрсдийн бэлчээрийг талхалж дуусахаар бусдын нутаг бэлчээр рүү малаа хулгайгаар идээшлүүлдэг болсон нь ганц уур барж байна даа. Манай эндхийн зарим уугуул иргэд архинд толгойгоо мэдүүлчихээд хамаг малаа барж, авгай хүүхдээ хөөж явуулчихаад өөрт ногдсон бэлчээрээ бусдад ганц хоёр түмэн ардын зоосоор түрээсэлж архиа гударч суудаг болсныг юу ч гэлтэй билээ дээ” хэмээн хүүрнэв.

“Тэдний бэлчээрийг тэгээд хэн түрээслэх болж байна даа?” гэж Чэнь Жэнь асуулаа.

Бат их л ууртайгаар “Газар тариалан мал аж ахуйн холимог бүсээс ирсэн цагаач иргэд л байж таарна. Тэд таван зуун хонь бэлчээх газар нутагт 2000-3000 хонь өсгөж газрыг улаан халцгай болтол мэрүүлээд цөлжсөн хойно нь түрээсийн гэрээгээ цуцлан хонь малаа арилжиж аваад алга болчихдог болсон” гэхэд

“Муусайн газрын холоос ирсэн люмпенгүүдийн үйл ажиллагаа улам л гаарч байгаа юм байна даа. Тал нутаг маань удахгүй тэдний гарт талхлагдаад дуусах нь ээ” хэмээн Ян Кө Чэнь Жэньд хандан өгүүлэв.

Бат Галсмаа хоёрын нутаг бэлчээр арай л өнгөтэй өөдтэй байгааг үзээд Чэнь Жэньгийн урам бага ч гэсэн сэргэж “Манай хуучин гэрийн амьдрал ийм сайхан байгааг үзээд бид их баяртай байна” гэхэд

Галсмаа толгой сэгсрэн “Том нутаг бэлчээр сүйрчихээр бидний энэ алгын чинээ газар яаж тэсэх билээ? Тал нутаг талхлагдаад гүйцэхээр хурмаст тэнгэр хүртэл хур бороондоо харам болдог бололтой. Манай энэ хавийн өнгө зүс ч гэсэн жилээс жилд тааруухан болоод байгаа шүү. Бид чинь дөрвөн хүүхдийн сургуулийн мөнгийг даана. Дээр нь алсдаа тэдэнд байшин сав бэлдэж өгөхгүй бол болохгүй. Бие хаагаа үзүүлэх, байгалийн гамшигт бэлтгэлтэй байх зэрэгт мөнгө зоос хадгалж байлгүй горьгүй. . . . . Дээр нь одоогийн хүүхдүүд чинь харсан үзсэн аятайхан зүйл бүрт л хорхойсох болж шүү дээ. . . . . Сая та хоёрын гоё машиныг

харчихаад зарах болов уу асуугаад өг гэж Баяраас шалаад байцгаана билээ. Хөгшид настангууд өөд болоод дуусахаар эдгээр учир мэдэхгүй залуус олон тооны хонь үхэр өсгөж, тэднийгээ байшин сав, машин тэргээр арилжаад дуусах вий гэж айх юм. . . . ” хэмээн халаглав.

“Намайг машинаасаа буухад энэ хоёр хүү ямар үнэтэй машин бэ гэж асуугаад байсан юм аа, даанч” гэж Ян Кө өгүүллээ.

“Манай монголчууд ч гэсэн төлөвлөгөөт төрөлтийн бодлогыг хэрэгжүүлмээр байгаа юм. Хүүхэд олшроод ирэхээр тал нутаг энэ олон хүнийг тэжээж дийлэхээ болих нь байна шүү. Хэрвээ энэ хоёр хүүхэд их сургуульд орж чаддаггүй юм бол алсдаа тал нутагтаа эргэж ирээд авгай хүүхэдтэй болж байшин сав бариулан хонь мал тасдуулах хэрэг болно шүү дээ. Цөөн хэдэн хонь таслаад өгөхөөр ахиу тоотой болгох гээд зүтгэж таарна. Гэтэл нутаг бэлчээр нь аль хэдийн хомсодсон байдаг. Хэрвээ энэ алгын чинээ бэлчээрт дахин хэдэн өрх ам бүл нэмэгдвэл нутаг нуга маань сүйрнэ биз дээ? . . . ” хэмээн Галсмаа хэлэв.

Баяр гадаа хонь мал төхөөрч байгаа бололтой. Удаж төдөлгүй түүний эхнэр болох биерхүү хүүхэн шинэ хонины гэдэс, уур савсуулсан мах сэлтийг оруулж ирэв. Чэнь Жэнь, Ян Кө хоёр ч мөн янз бүрийн нөөц, ууттай даршилсан ногоо зэргээр зоогийн ширээг чимэв. Хараахан гэгээ тасраагүй байтал зочны өрөөний цахилгаан гэрэл мэлсхийн аслаа.

Чэнь Жэнь Батад хандан “Ямар сайхан гэгээтэй юм бэ? Малчид өөхөн дэнгийн гэрлээсээ бүрэн ангижирч шүү. Би дээхэн өөхөн дэнгийн гэрэлд ном уншиж байхдаа байн байн үсээ шатаачихдаг байж билээ” гэв.

“Салхин сэнсээр гаргасан цахилгаан хэр зэрэг удаан ажиллах вэ?” гэж Ян Кө асуулаа.

Бат хариуд нь “Салхитай үед нөөцөлсөн цахилгаан хоёр цаг өлхөн ажиллачихна. Манайх нөөцөндөө бас бага оврын Хонда мотортой л доо” хэмээн хариулав.

Удалгүй байшингийн гадаа машин мотоциклийн дуу нүргэлээд Галсмаагийн хуучин суурийн малчид бараг тэр чигээрээ хүрч ирээд Батын зочны өрөөг зайгүй шахам дүүргэлээ. Тал нутгийн хуучин андуудын халуун уулзалтыг юутай ч зүйрлэмээр юм билээ дээ? Чэнь Жэнь, Ян Кө хоёр дал мөр рүүгээ өвдтөл алгадуулж, хатуу архиар шахуулсаар хэл ам нь тултирч орхив. Лхамжавын шөвөг шиг хурц нүд, бухан хүзүү хэвээр бөгөөд шинэ юм гэвэл ооч сахал тавьсан харагдана. Тэр Ян Көд хандан чанга дуугаар “Чи яагаад Саранцэцэгтэй суугаад Бээжингийн бэр болгоогүй юм бэ? Алив торгоно оо, хө. . “ гэж хашгирав.

Ян Кө ч бүр согтож орхиод том том ам гарч “Чи хайргацай шувууны хос далавчинд хатуу дарс хэдэн хундагыг өлгөх гэж байна даа?” хэмээн асуулаа.

Хуучин андууд нь энэ үгийг дуулаад ихэд алмайрцгаав. Архийг тэр жилийнх шиг гудрахаа больсон Лхамжав үгийн өнгийг өөрчлөн “Үгүй ээ, чамайг архиар торгохоо болилоо. Харин чиний энэ гоё унааг чинь ганц өдөр шавайгаа ханатал барьж үзмээр байна” гэв.

“Чи л намайг хурга шиг амьтан байж, тал нутгийн хамгийн үзэсгэлэнтэй “Өлөгчин чонотой”



яаж тохирдог юм бэ гэж явуулсаар байгаад бид хоёрыг холтгосон биз дээ? Машинаа унуулж бололгүй яахав, харин чи маргааш ганц дусал архи амсахгүй шүү” хэмээн Ян Кө хэлэв.

Лхамжав хатуу хухан дарсыг шилээр нь гүд гүдхийтэл залгиад “Би л гэж ухаанд нь ухна ишиг үхсэн амьтан байхгүй юу? Чи Саранцэцэгтэй суугаагүй нь хамаа алга. Харин би чамд өөрийн охин дүү Улааныгаа өгчихсөн бол өдийд хэрэг зарга тохиолдоход Бээжингийн том өмгөөлөгчөөр араа даалгаж байх байсан юм. Ойрын жилүүдэд манай энд бэлчээр нутгийг талхлан хаа хамаагүй уурхай ухах нэрээр газар сэндийчээд нөхөн сэргээлт хийлгүй орхих боллоо. . . . Бээжингээс бидэнд мөнгө хөрөнгө бага өгөх нь хамаа алга. Харин хамгийн гол нь хууль, хуульчид хоёрыг л түлхүү өгмөөр байгаа юм” гэснээ дахин нэг балга архи уугаад “За тохирсон шүү. Маргааш надад машинаа өгөөрэй. Харин одоо түлхүүрээ аль” гэв.

Лхасүрэн, Санжаа нар ч мөн Ян Көгийн машиныг нэг нэг өдөр ээлжлэн барьцгаах юм болцгоолоо.

Ян Кө ч согтсондоо туйлын өгөөмөр амьтан болон хувираад “Бололгүй яахав. Үүнээс хойш та бүхэн хэрэг зарга үүссэн цагт надтай холбоо барьж байгаарай” гэчихээд машиныгаа түлхүүрийг Лхамжавт атгуулав.

Бүгдээрээ инээд хөөрт автан найрын дуу үүсгэцгээлээ. Хамгийн сүүлд тэд монгол үндэстний нэрт дуучин Тэнгэрийн дууг дуулцгаав. “Энэ бол. . . монгол хүн. . . эх орондоо. . . хайртай хүн. . . ”

Найр наадам үүр цүүр болтол үргэлжилж, найз нөхдийн халуун нулимс хацрыг даган урсана.

Хуучин найз нар нь Чэнь Жэнь, Ян Кө хоёрыг өдөр өдрөөр гэртээ урин найр наадам үүсгэхээр тохиролцов. Харин цэнхэр өнгийн гоёмсог Бээжин жийп машин найз нөхдийн дундын унаа, архи идээ зөөх үүрэгтэй хөсөг болон хувирчээ. Хоёрдахь өдрийн өглөө гэхэд Батын гэр машин мотоциклоор зайгүй шахам дүүрлээ. Морь унаж ирсэн хүн бараг алга байв. Хэрвээ өвөл цас ороод мотоцикл унахад тохиромжтой биш байсан бол монгол морь бараг ул мөргүй алга болох байсан байх шүү. Хуучин тэдний багийн дөрвөн суурь адуунаас одоо ердөө ганц нь л үлдээд байгаа. Тэгсэн атлаа тоо толгой нь хуучны суурийн хагаст ч хүрэхгүй шүү дээ гэж малчид өгүүлнэ. “Чоно байхгүй болсноос хойш морьдын хүч тэнхээ доройтон давжаа биетэй амьтад болон хувирсан болохоор тоох хүн ч бараг үгүй болсон” гэж Бат хэлэв. Билиг өвгөний үе тэнгийн хөгшид бүгд өөд болцгоогоод Ян Көгийн багшилж байсан бага сургуулийн сурагчид эндхийн гол хүч болсоныг Чэнь Жэнь олж мэдэв.

Гурван өдрийн турш мань хоёр завсаргүй архидсаар цусны даралт ихсэн зүрх нь пэлбэгэнэтэл цохилж орхив. Харин азаар тал нутагт хятад газрын ногоо цагаа элбэг болсон тул найрын ширээн дээр шинэ ургацын ногоо, амтлагчууд арвин байх болжээ. Эс бөгөөс тэр хоёрын цусан дахь холестриний хэмжээ улам ихсэх байсан буй за. Хавтгайрсан найр наадам ихсэнээс үүдэн суурь хэсгийн малчдын ажил цалгардах болсон тул их төлөв хөлсний туслах малчдыг гаднаас авч ажиллуулах болсон ажээ. Чэнь Жэнь тийм хөлсний ажилчидтай уулзаж үзэхэд сарын цалинд хоёр зуун юань хоёр хонь авдаг төдийгүй байр хоолыг сүргийн эзэд даадаг гэж байв. Тэгээд ч зогсохгүй сайн ажиллавал оны сүүлчээр шагнал урамшуулал авдаг гэнэ. Олонбулгаас баруун өмнө чигт хоёр зуу гаруй километр хол газар нутагтай гэх нэгэн хөлсний

малчин хэдэн жилийн өмнө 1700 гаруй хоньтой товхийсэн амьдралтай нэгэн байжээ. Тэр үед өөрөө ч гаднаас туслах малчин хөлсөөр ажиллуулдаг байж. Гэтэл бэлчээр нутаг нь улам доройтсоор уржнан жилийн айхтар ган гачгаар хамаг малаа бараад арга буюу энд туслах малчнаар ажиллахаар ирсэн байна. Гэвч жилдээ хорь гучин хонь ацаг хөлсөнд аваад нутаг оронд нь өвс тэжээл байхгүй тул эндээ арилжчихаад мөнгөө аваад буцдаг гэж байлаа.

Мань хоёр өдөржин нам унтаж байж сая нэг юм жаахан сэргэхчээ аядацгаав. Дөрөвдэх өдөр нь Чэнь Жэнь Галсмаа тэд нартай шөнөжин хуучилж хонолоо.

Тэгсээр тав дахь өдрийн хар өглөөгүүр Чэнь Жэнь, Ян Кө хоёр Хар чулуут уулыг зорин хөдлөв.

\* \* \*

Оюунлаг эрэлхийлэл буюу

чонон сүлдийн тухай харилцан яриа

Жийп машин хилийн хамгаалалтын зурвасыг өнгөрүүт зүүн өмнө зүгт бүртэлзэн харагдах Хар чулуут уулын барааг харлаа. Ян Кө тэргээ жолоодон тал нутгийн энхэл донхол шороон замаар гэлдрүүлж гарав.

Чэнь Жэнь санаа алдаад “Чоно гэдэг тал нутгийн ахуйн экологийн хэмжүүр байдаг ажээ. Чоно үгүй болсноор тал нутаг маань бүр нэг сүр сүлдгүй болчихсон байгааг харж байна уу? Би урьдын номин ногоон атар онгон талыг хичнээн их үгүйлж байна гэж санана. Орчин үеийн хятад хүний тухайд урьд үеэ санагалзах гэхээр хамжлага, феодал, захиргаадалт болон нийтийн тогооноос хооллож байсан гашуун дурсамжууд руу халтираад орчих гээд байдаг. Гэтэл тал нутгийн тухайд хуучныг санагалзах сэтгэлгээ нь бүхий л орчин үеийн хүмүүсийн тухайд хамгийн шинэлэг сэтгэгдэл төрүүлэх юм даа” хэмээн өгүүлэв.

Ян Кө өрөөсөн гараар чамархайгаа нухлангаа “Би ч өөрцгүй хуучнаа маш их үгүйлж байна. Тал нутагт ирсэн даруйд нүүдлийн ахуйн амьдралын дүр зураг бодогдоод болох биш. Хорь гучин жилийн өмнөх явдлууд яг л өчигдөр болсон юм шиг санагдах юм даа” гэснээ залгуулан “Хөдөөнөөс хот руугаа буцаад бид бүгдээрээ тус тусын зам мөрийг хөөцгөөсөн. Чи өдий олон жил нухсан судалгааны ажлынхаа үр дүнгийн талаар надтай жаал жуул хуучлана байгаа” гэхэд

“Сүүлийн жилүүдэд хятадын тариалангийн соёл болон хятад үндэстний зан чанарыг шинэ өнцөг байр сууринаас авч үзсэний үндсэн дээр нүүдэлчид хятадын соёл иргэншлийн тухайд амь насны үнэ цэнэтэй гэж болохуйц том хувь оруулсан болохыг олж тогтоолоо. Түүний үндсэн дээр “Хятад өвчний” урхаг юу болохыг тодруулсан. Хятад өвчин гэдэг маань хонины өвчин, гэрийн тэжээвэр амьтны өвчин юм л даа.” гэхэд

“Нээрэн ч бид өөрсдийн үзэж туулсан дээрээ тулгуурлан тал нутгийн нүүдэлчдийн оюун санааг сайтар нягтлан үзэх хэрэгтэй юм шүү” гэж Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь үндсэн сэдэв рүүгээ орж их л нухацтайгаар “Хятад өвчний урхаг нь газар тариалан болоод тариаланч зан араншинд байгаа юм. Урьд нь манай оюунлаг хүрээний цөөнгүй хүмүүс хятад өвчний урхаг чухам энд байгааг зааж байсан нь цөөнгүй боловч сайтар ухааж төнхөөгүй буюу ширүүн эсэргүүцэл шүүмжлэлтэй тулгарч байв. Хятадын өөрийн хувь заяатай холбоо бүхий энэхүү үзэл санааны тэмцэл бүтэн зууны турш үргэлжлээд нэг тийш шийдэгдээгүйн учир гэвэл хятадын тариаланч зан чанар бүхий хүчин бат суурьтайн дээр түүнийг шүүмжлэгч тал үндэслэл бүхий хүчирхэг зэвсгээ гаргаж тавиагүйд оршино. Хятадын газар тариалангийн ухамсрын бат бөх уламжлалыг хальт мөлт шүүмжлэх төдийгөөр өнгөрч хэрхэвч болохгүй, түүхийн үүднээс системтэй дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ хамгийн гол нь газар тариалангаас хавьгүй урт удаан жилийн түүхтэй, илүү амьдрах, тэмцэх хүч чадал бүхий нүүдэлчний оюун санааны зэвсгийг ашиглан шүүмжлэх хэрэгтэй.

Миний дээр өгүүлсэн нүүдэлчний оюун санаа гэдэг маань зөвхөн талын нүүдэлчний оюун санаа төдийгүй, далайн нүүдэлчний оюун санаа болон сансрын нүүдэлчний оюун санааг багтаасан том ухагдхуун билээ. Энэ бол дэлхийн түүхэнд эртнээс нааш эдүгээг хүртэл тасралтгүй дэгжин дээшилж, дэлхийн дайдад байр сууриа бэхжүүлсээр ирсэн шинийг эрэлхийлэх ухамсар юм. Түүхэнд энэхүү нүүдэлчний том ухамсар Ромын зэрлэг балмад боолын тогтолцоог эвдэн, дундад зууны харанхуй феодалын тогтолцоог халж, тэр хэрээр гадаад зах зээлийн асар том шинэ “бэлчээрийг” эзэмшээд зогсоогүй өдгөө сансрын уудам руу хальж, хязгааргүй уудам асар баялаг сансрын бэлчээрийг эзэмшиж эхлээд байна. Тэр хэрээр нийт хүн төрөлхтөнд хавьгүй өргөн уудам амьдрах орон зайг буй болгосоор байна. Харин энэхүү нүүдэлчний ухамсар нь хүчирхэг нүүдэлчний зан чанар болон ялангуяа чонын зан чанарт суурилсан байдаг юм. Бидний сайн мэдэх тал нутгийн нисдэг чоно эцэс сүүлдээ тэнгэр огторгуйд дүүлэн нисэж байгаа нь энэ биш гэж үү?” гэхэд

Ян Кө их л бахадсан байдалтай “Эхлэл нь ч тун дажгүй болж байна шүү. Шууд л миний сонирхож байсан хэсэг рүү яваад орчихлоо” гэв.

Чэнь Жэнь цүнхэн доторх бичгийн хавтсыг гаргаж ирвэл дотор нь компьютерээр хэвлэсэн зузаан ноорог байх ажээ. Тэр хоолойгоо засаад “Миний энэ талаарх судалгаа бараг ном болчихоор том эд л дээ. Би зөвхөн тойм төдийхнийг авч яваа юм. Энэ удаа чамтай тал нутгийн зүг ганзага нийлсэний хэрэг юу билээ чиний саналыг сонсоод авья гэж бодсон хэрэг. Би чамд гол санаагаа ярьж өгье. Харин чи санаа авууштай зүйл байвал надад харамгүй хэлдэг юм шүү” гэлээ.

“Тэр бололгүй яахав” хэмээн Ян Кө дуун дээр зөвшөөрчээ.

“Хятадын тариалангийн соёл иргэншлийн дотор ангийн тэмцлийг эс тооцвол илүү гүн гүнзгий хурц ширүүн тэмцэл байдаггүй нь түүний аминд хүрэхүйц гол дутагдал байсаар иржээ” гээд Чэнь Жэнь яриагаа зугуухан эхлэв.

“Гэтэл нүүдлийн соёл иргэншил түүнтэй харьцуулах юм бол яг эсрэг буюу нүүдлийн амьдралын дотоодод оршин амьдрахуйн төлөөх хатуу ширүүн тэмцэл маш өргөн хүрээнд явагдаж байдаг. Нээрэн ч эргээд бодоход тариалангийн нийгэмд тал нутагтай адил тасралтгүй ширүүн оршин тогтнохын төлөөх тэмцэл хаанаас байх билээ дээ? Багшийн эрдэм шавиас гэдэг шиг хатуу ширүүн тэмцлийн явцад чанга хатуу зоригтой чонон сүрэг, байлдааны морьд

болон үндэстэн бүрэлдэн буй болдог ажгуу.Хоёр ахуй орчинг харьцуулаад үзэхэд тариаланч болон нүүдэлчин хоёр үндэстний зөрөө буюу яг л нэг чоно хонь хоёрын ялгаа зааг харагдаад байдаг.Тал нутгийн малчид өөрсдийгөө чонотой, тариачдыг болохоор хоньтой зүйрлэдэг нь ч аргагүй. Ямар сайндаа л урьд нь Лхамжав намайг Ян Кө гэлгүй Ян Гао47 гэж дуудаж байх вэ дээ? Би ч ямар түүнийг бариад авлаа гэхэд дийлэх биш гүлдийгээд л дуугүй явдаг байсан. Нийтээрээ ажил хийгээд амсхийхийн завсар Лхамжав хурга шүүрч байгаа чоно шиг намайг барьж аваад зургаа долоон удаа авч шидэхэд хөөрхөн монгол охидууд түүнд тал өгөн инээлддэг байж билээ.Лхамжав бас Саранцэцэг рүү заагаад: Олонбулгийн талын сор болсон залуу өлөгчин чоныг энэ хургатай суулгачихвал удаж төдөлгүй бариад идчихлээ гэж дуулдах байлгүй хэмээн явуулахад цугларсан хүмүүс бүгдээр нирхийтэл инээлдэхэд би хэдийгээр дотроо хичнээн эвгүй байсан ч бас дагаад л инээмэр аялдаг байсансан. Сая найрлахад ч гэсэн мань хүн тэр тухай ярьж байна лээ” хэмээн Ян Кө өгүүлэв.

“Тэр үед ч бид нар үнэхээр нялцгай байсан шүү. Хэдэн жил хичээж чармайгаад ч хонь гэсэн хочоо гээж чадаагүй юм даг. Гэтэл хэдэн зуун сая биднээс хавьгүй долоон дор хятад хүмүүс байгааг яах билээ? Миний тухайд ч өөрцгүй монголчууд өөрсдийгөө чонотой, биднийг хоньтой зүйрлэдэгт тухайн үед хэрхэндээ л их Хань үндэстний үзэлтэн байсан надад маш том сэтгэл зүйн цохилт болдог байлаа. Тэр байдал даамжирсаар яваандаа чоно хонь хоёр болон хятад монгол хоёр үндэстний оюун санаа, зан араншинг судлахаар шийдэхэд нөлөөлсөн юм” гээд Чэнь Жэнь гашуунаар инээвхийллээ.

Жийп машин тэр жил Билиг өвгөний удирдлагаар ан ав хийж байсан уулын хөндий рүү орж ирлээ. Ян Кө их л сэтгэл нь хөдөлсөн байдалтай “Тэр удаагийн ан ав хийж байсан дүр зураг нүдний өмнө илхэн байна шүү. Чи бид хоёр ч тал нутгийн морьт цэргүүдийн зориг зүрх болон дайчин чанарыг хараад авсан азтай улс. Мөртлөө тэр нь жирийн нэг ан ав гэж байгаа шүү. Уг нь бид зуны амралтаар хөдөө тосгонд очоод тариачдын ан хийхийг харж л байсан. Тун уйтгартай юм байдаг шүү дээ” гэлээ.

“Жоу, Цин, Хань, Тан улсын үед хятадууд тухайн үеийн Цуань Рун, Шань Рун, Хүннү болон Түрэг зэрэг нүүдэлчдийг ёстой болгоод өгч байсны учрыг чи бодож үзсэн үү? Хань, Тан улсын үед хэдэн зуун жилийн шаргуу дайн тулалдаан хийсний үр дүнд хүчирхэг Умард Хүннү болон баруун Түрэг нарыг устгасан буюу нутгаас нь хөөн зайлуулсан шүү дээ. Тэр бол хятадын эртний түүхийн хамгийн бадрангуй үе юм. Соёлын хувьд ч гэсэн олон олон одод гялалзсан оргил сүмбэр үедээ байсан гэж болно. Яагаад хятадууд тэр үед тийм айхтар байсан гэж чи бодож байна даа? Ёстой л нэг чоно унаж чулуу хазахаас буцахааргүй гал халуун зоригтой ган төмөр зүрхтэй үндэстний зан араншинтай байсан байгаа юм шүү” хэмээн Чэнь Жэнь өгүүлэв.

Ян Кө олон таван юм бодолгүй “Тэр үед ч яахав, манай хятадуудын сэргэн мандлын үе таарсан байлгүй” гэхэд

“Миний санахад тухайн цаг үед хятад хүмүүсийн судсаар чонон цус гүйж хонин цусны найрлага төдийлөн их байгаагүй байж л дээ. Хүн анх адгууснаас үүссэн гэж ярьдаг. Балар эртний хүмүүсийн араатанлаг болоод чонон араншин хүчтэй хэвээр байсан нь хүн төрөлхтний хэдэн түмэн жилийн хатуу ширүүн тэмцлийн дунд оршин тогтнох гол үндэс болсоор иржээ.Хэрвээ тийм хатуу ширүүн зан араншин нь байгаагүй бол хүн төрөлхтөн аль

хэдийн байгалийн хүнд нөхцөл болон араатны сүрэгт дийлдэн үгүй болох байсан сан. Гэхдээ араатанлаг зан, чонын араншин хүн төрөлхтний соёл иргэншилд маш их хор хөнөөлтэй юм л даа. Хэрвээ аль нэг улсын хүмүүс чонын араншинд хэт дийлдэх юм бол өвөр зуураа алалдсаар ор мөргүй устан алга болж ч мэднэ. Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүх гэдэг бол хүнд заяагдмал адгууслаг шинж болон чонын араншингаа дарж жолоодож ирсэний хүчинд аажмаар хөгжин дэвжих үйл явц юм. Энэ бол эрт эдүгээгийн гадаад дотоодын богд мэргэд, гүн ухаантан, сэтгэгч нарын бодож сэтгэж ирсэн үндсэн асуудлуудын нэг мөн. Гэвч нөгөө талаас хүнд байдаг энэхүү адгууслаг шинж болон чонын араншинг ул мөргүй устгаад алга хийчих юм уу аль эсвэл хонины араншин гэрийн тэжээвэр амьтны хэв шинж зан чанараар орлуулчихвал хүн төрөлхтөн эргээд оршин тогтнох нөхцөлгүй болж хатуу ширүүн өрсөлдөөн дунд шигшигдэн гээгдэж, соёл иргэншлийн тухай ярихын ч хэрэггүй болох юм.

Тийм болохоор хүн төрөлхтөнд зэрлэгдүү атлаа омголон дайчин зан чанар байхгүй бол бадрангуй тасралтгүй урагшлан дэвшсэн соёл иргэншилтэй байж чаддаггүй ажээ. Тийм ч учраас өрнөдийн үндэстнүүд хүний араншин болон омголон зэрлэгдүү байдал хослосон соёл иргэншилт хөгжлийн замыг сонгосон бол хятад үндэстэн зэрлэг зангийн улбаагүй хүний араншин бүхий газар тариалангийн соёл иргэншлийн хөгжлийн замаар замнаж иржээ. Үүнийг дүрслэн хэлвээс өрнөдийнхөн соёлтой чонын замаар явсан бол хятадууд соёлтой хонины жимээр замначихжээ. Тэд балар эртний бүдүүлэг чоно байснаа эртний соёлтой чоно болох үе шатыг туулан улмаар орчин үеийн соёлтой чононууд болон хувирсан төдийгүй өдгөө соёлт хүн болох төлөв нь тодорчихоод байна. Харин бид хэдэн ч үе шатаар хоцрогдчихоод буруу замаар будаа тээсээр байгаа шүү дээ.

Хятадын эртний мэргэд түүхэн хөгжлийн тухайн үе шатны хүрээ хязгаарт автсаны улмаас гэнэн цагаахан хүсэлдээ дулдуйдан өөрийгөө дарж нийтээрээ төгөлдөржих мөрөөдлийг дэвшүүлэн гаргаж ирсэн юм. Тэд үүндээ хүрэхийн тулд хүний зан чанар дахь чонын араншинг устгачихвал бүх юм болоод явчих мэт төсөөлжээ. Тухайлбал хүний зан араншинг засах тухай Күнзийн суртхаалд хэдэн зуу, мянган жилийн турш номхон дөлгөөн байх тухай номлож ирсэн бус уу? Гэтэл хорвоо дээр хонь үхэр хоёроос өөр номхон дөлгөөн амьтан гэж хаана байх билээ? Тэгсэнээр Күнзийн суртхаал нь хонийг дээдлэж, чоныг үгүйсгэх газар тариалангийн шинж чанартай болон хувирсан юм. Хожим Сүн, Мингийн үе хүрэхэд ёс зүйн хувьд бүр ч туйлшран “Хүмүүний хүслийг бөхөөвөөс тэнгэрийн ёсон үлдмүй” хэмээн уриалах болжээ. Хүний байгалиас улбаатай хүслийг хүртэл бөхөөх тухай ярьж байгаа улс чинь хүний зан чанарт хадгалагдан үлдсэн адгууслаг болоод чонын араншингийн тухайд юу гэж үзэх нь ойлгомжтой болно. Газар тариалангийн үндэстний ахуйн үндэс суурин дээр мянган он жилийн турш сургаж номхруулсан хятадын оюунлаг давхаргынхан бүгдээрээ номхон дөлгөөн авгай<sup>48</sup> нар болон хувирсан бөгөөд харин нийгмийн доод давхаргынхан даяараа ноолж ноцоход яадаг ч үгүй номхон хүлцэнгүй албатууд болцгоожээ. Ингэснээр хонины араншин нийт хятадын хувьд иргэний хэв шинж болсон гэхэд хилсдэхгүй. Энэ арга замдаа хэт туйлширсаны харгайгаар хожмын номхон хонин сүрэг маань хэзээ нэгэн өдөр хэрцгий догшин талын чонон сүрэгтэй учрах бүртээ хэрхэн сүйдлүүлж байсан тухай жишээ баримт хорин дөрвөн төрийн түүхэнд цус нэвчтэл дүүрсэн байгаа. Хожим дэлхий багасахын хэрээр хятадын соёлт хонинууд маань өрнөдийн хэрцгийн догшин соёлтой чононууд лугаа тааралдан хоёр соёл иргэншил харилцан мөргөлдөхөд өвдөг сөхрөн унасан нь мэдээжийн хэрэг хонь л байж таараа. Тийм болохоор эртний хятадын явсан зам өрнөдийн арга барилд

бутцохигдож, адаг сүүлдээ өрнөдийнхний хагас колони болон хувирсан ажээ” гэхэд

Ян Кө их л шимтэж байгаа бололтой “Манай хятадууд яахаараа тэгтлээ буруу замаар будаа тээчихдэг билээ? Жоу, Цин, Хань, Тан улсын үед хятадуудын явж байсан түүхэн замнал тун мундаг байсан биш бил үү?” хэмээн асуулаа.

Чэнь Жэнь яриагаа цааш хөврүүлж “Аливаа үндэстэн анх ямар замаар явах вэ гэдгийг бодит түүхэн орчин нөхцөл шийдвэрлэж байдаг юм. Хятад үндэстэн дэлхий дээр газар тариалан эрхлэхэд хамгаас тохиромжтой Хөх мөрөн, Шар мөрний сав газар суурьшиж эхлэсэн. Энэ сав газрууд нь Эртний Мисирийн Нил мөрөн, Вавилоны хоёр мөрөн болоод Энэтхэгийн Ганга мөрний сав газруудаас хавьгүй том байжээ. Тийм болохоор хятадууд дэлхий дээр хамгийн өргөн цар хүрээтэй газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэх боломжтой болсон. Өөрөөр хэлбэл энэ нь хятад үндэстний ахуй юм. Тэр хэрээр үндэстний зан чанарт газар тариалангийн шинж чанарыг агуулсан үндэстнийх нь ахуй шийдвэрлэх нөлөө үзүүлжээ.

Харин өрнөдийн үндэстнүүдийн хувьд хүн ам цөөн, далайд ойр дөт, бэлчээр нутаг өргөн уудам болохоор газар тариалангийн эзлэх хувь хэмжээ төдийлөн их байгаагүй юм. Ан агнуур, мал аж ахуй, газар тариалан, худалдаа арилжаа болон далайн тээврийг тэнцүүхэн хөгжүүлсэнээр талын чоно, ойн чоно, өндөр уулын чоно, хуурай газрын чоно, далайн чононууд тувт эрх чөлөөтэй амьдрах боломжтой байж л дээ. Өрнөдийн үндэстнүүдийн нүүдэлчний тод улбаа болоод зан чанар нь бат бөх хадгалагдан үлдэж, улмаар мянган оны турш худалдаа арилжааны дайн, далайн дайнуудын явцад улам бэхжин, хожим орчин үеийн аж үйлдвэрийн оршин тогтнохын төлөөх хатуу ширүүн өрсөлдөөний явцад чонын араншин нь улам хурц тод харагдах болсон билээ. Тэр хэрээр өрнөдийн үндэстнүүдийн дайчин давшингуй зан араншин өчүүхэн ч бүдэгрэн бүүдийлгүй өдий хүрсэн. Үндэстний ахуй зан чанараа тодорхойлдог бол үндэстний зан чанар үндэстний түүхэн хувь заяаг шийддэг ажээ. Энэхүү зан чанар нь өрнөдийн хожуухан дайраад хойморт заларсан төдийгүй өдгөө дэлхийн хамгийн тэргүүний эгнээнд давшиж яваагийн бодит шалтгаан юм.

Дэлхий дээр эртнээс өдгөөг хүртэл ан агнуур, нүүдлийн аж ахуй, газар тариалан, худалдаа, далайн тээвэр болон аж үйлдвэр гэсэн зургаан салбар аж ахуйг эрхлэдэг зургаан төрлийн үндэстэн байдаг. Тэр дундаас газар тариалангийн аж ахуй хамгийн өвөрмөц буюу өөрөө өөрийнхөө хэрэгцээг ханган, түгжигдмэл маягтай, өөрөө өөртөө тоос хүртээн, улмаар зулгаран унах гэх мэтээр үндсэндээ ямар ч өрсөлдөөнгүй холилдож сүлэлдэн амьдарсаар ирсэн. Харин газар тариалангаас бусад нь бүгд энх тайванч бус салбарууд буюу өөрийн хэрэгцээгээ төдийлөн хангаж чаддаггүй болохоор эрхбиш өрсөлдөн тэмцэлдэж, харилцан солилцож чадсан цагт сая оршин хөгжих боломжтой болдог ажээ. Өөрөөр хэлбэл энэ тав нь бүгд би юу чи юу гэсэн хатуу ширүүн өрсөлдөөн, аюултай эрсдлийн дундах салбарууд юм. Энэ таван салбарууд харьяа үндэстнүүдээсээ чоно мэт хатуу харгис, дайчин давшингуй зан чанарыг шаарддаг бөгөөд тэгж чадаагүй нь оршин тогтнох үндэсгүй болдог ажээ. Тийм ч учраас дээрх үндсэн зургаан салбараас төрөн гарсан зургаан үндэстний дундаас газар тариалан эрхлэдэгээс бусад тав нь бүгд манай гаригийн хамгийн дайчин давшингуй үндэстнүүд байсаар ирсэн юм.

Түүнчлэн эдгээр таван салбарт харьяалах үндэстнүүд бүгд залгамж чанартай буюу ан агнуур, нүүдлийн мал аж ахуйгаас арилжаа, далайн аялал руу шилжиж, улмаар орчин үеийн аж

Үйлдвэрийг үүсгэн байгуулжээ. Эдгээр таван хүчирхэг салбар нь хүчирхэг үндэстэнд л зориулагдсан юм гэж хэлж болно. Бүдүүлэг хүчирхэг салбараас орчин үеийн дээд зэргийн хүчирхэг салбар хүртэл шилжсэн нь дэлхийн түүхийн гол чиг хандлагыг тодорхойлж байна.

Эртний тариаланч үндэстнүүдийн түүх бол хувиа болгож довоо шарлуулсан түүхийн салаа урсгал байсан боловч эртний гялалзсан соёл иргэншлийг бүтээж чадсан юм шүү. Гэвч нүүдэлчид болон тэдний үр хойчис тариаланч үндэстний салаа голдрил руу халин орж буй болгосон соёл иргэншлийн үр шимийг булаан аваад, улс үндэстнийг мөхөөх буюу эрхшээлдээ оруулан, өөрсдөө харин хүчит ширүүн давалгаан дунд далбаагаа босгоод улам илүү дэвшилтэт соёл иргэншлийг цогцлоон байгуулж билээ. Хятад үндэстний тухайд гэвэл хөлд орохдоо л тариалангийн шан дээр гишгэсэн тул газар тариалангийн хөгжлийн түүхэн салаа руу халтиран ороод уруудаж доройтсон тул үндэстний зан чанарын хувьд мордохын хазгай гэгч болсон.

Харин хятадын өндөр өвгөдийн зан чанарын тухайд гэвэл өрнөдийн үндэстнүүдээс сул дорой байгаагүй, адилхан эр зориг, билиг оюун, дайчин давшингуй чанар цогцолсон, чонын араншингаа хадгалсан байж таарна. Харин хятад хэмээх манай гаригийн хамгийн үржил шимтэй тариалангийн бүс нутагт хүрэлцэн ирсэнээр хичнээн чанга хатуу чонын араншинтай байгаад ямар нэмэр байх билээ дээ. Эртний хятадын өргөн уудам, үржил шимтэй тариан талбайнууд, талын чоно болоод чонын араншинг номхруулан зөөлрүүлэх шимтэй хөрс болжээ” гэв.

\* \* \*

Жийп машин хил хамгаалах зурвасын өмнөх бэлчээр нутагт явж орвоос автын дороом мэт өвс гэхээр зүйл бараг үгүй улаан халцгай газар тэднийг угтлаа. Ян Кө шороон замаар Хар чулуут уулыг чиглэн давхив.

Чэнь Жэнь бичгийн цааснуудаа эргүүлж тойруулан харсанаа цааш залгуулан “Шар мөрний сав газар болвоос хятадын эртний соёлын цорын ганц өлгий нутаг биш юм аа. Манай улсын баруун хойт орон ялангуяа өвөрмонголын тал нутаг бол хятадын эртний соёлын өлгий нутаг мөн. Өвөрмонголын түүхэн газарзүй номонд өгүүлсэнээр хуучин чулуун зэвсгийн үед өвөрмонголд балар эртний хүмүүс аж төрж байсны ул мөр болох археологийн олдворууд олон байдаг ажээ. Алдарт Да Яогийн соёлын өнө эртний түүхэн улбаа хүмүүсийн гайхширлыг төрүүлдэг. Да Яогийн туурь нь одоогийн өвөрмонголын Хөххотын зүүн хойд дүүрэгт оршдог манай улсын түүх соёлын чухал өвүүдийн нэг яах аргагүй мөн. Тэндээс эртний хүмүүсийн чулуун зэвсэг үйлдэж байсан дархны газар гэж болохуйц нэгэн томоохон илэрцээс олдсон олдворууд нь хуучин чулуун зэвсгийн эрт, дунд, хожуу үеүүдэд хамрах буюу цаг хугацааны алслалын тухайд зуугаад мянган жилийг хамарч байгаа юм. Хамгийн эртний олдворууд нь долоон зуугаад мянган жилийн настай<sup>49</sup> байгаа нь Бээжингийн синантроп хүнээс даруй нэг зуугаас таван зуун мянган жилийн өмнө амьдарч байсан гээд бод доо. Шинэ чулуун зэвсгийн үе болоход өвөрмонгол дахь эртний хүмүүсийн ул мөр бүр ч өргөн хүрээг хамардаг. Одоогийн байдлаар өвөрмонголын шинэ чулуун зэвсгийн үеийн тууриуд зуугаад газарт бүртгэгдсэн бөгөөд тэндээс гарсан сав суулганы өнгө будаг, хэлбэр хэмжээ зэрэг нь хятадын дотор газрын Ян Шаогийн соёл болон Лун Шаньгийн соёлоос ихээхэн ялгаатай байдаг.

Түүнээс гадна зүүн хойд орны Шаньсигаас олдсон Лань Тяний хүмүүс МЭӨ 800 000-600 000 жилийн тэртээ амьдарч байсан буюу Бээжингийн синатроп хүнээс бас л хавьгүй урьд өмнө оршиж байжээ. Юутай боловч Бээжингийн синантроп хүн бол шар мөрний сав газрын эртний хүн болон балар эртний умард нутгийн хүнд хамаарагдахгүй юм. Эрт балар цагт умард болон баруун умард нутгийн тал хээр нутаг өвс ус тэгширсэн, цаг уурын хувьд хүн амьдрахад туйлын тохиромжтой нутаг байжээ. Тал нутгийн эртний хүмүүс ан агнуур, нүүдлийн мал аж ахуй, үр жимс түүх зэргээр амьдарч байсан бол Да Юй ус засахаас 50 өмнө Шар мөрний сав газрын дунд, доод хэсэг нь байнга үерлэдэг тул хүн амьдрахад туйлын тохиромжгүй газар байв. Дотор газар нь шар мөрнөөр урсаж ирсэн өндөрлөг газрын элс шавраас тогтсон хурдаснаас тогтсоныг чи юу эс андах билээ? Тийм болохоор зүүн хойд орны өндөрлөг нь дотор газрын эцэг бол Шар мөрөн эх 51 нь гэж болох юм. Үүгээр би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр зүүн хойд орны тал нутгийн хүмүүсийн түүх дотор газрын хүмүүсийн түүхээс хавьгүй өнө эртнийх бөгөөд дотор газрын балар эртний хүмүүсийн дээд өвөг нь баруун хойд орны өндөрлөг болон тал нутгаас гаралтай ажээ.

Хятадын тал нутгийн эртний хүмүүс өөрсдийн дайчин давшингуй нүүдэлчний ухамсар болон зан чанартаа тулгуурлан дотор газарт зугуухан нэвтэрч, эзэмшсэнээр яваандаа тэндэхийн уугуул овгууд болон хятадын унаган соёл иргэншил бүрэлдэн хөгжихөд зонхилох нөлөө үзүүлжээ.

Хятад үндэстний хүмүүнлэгийн дээд өвгөд болох Яньди болон Хуанди хоёр баруун хойд орны нүүдэлчин үндэстнээс гаралтай тухай түүхэн сурвалжид тэмдэглэхдээ: Янь, Хуан хоёр хаан нь балар эртний Шаодянь овгоос гаралтай хэмээн дурдсан байдаг. Фань Вэнь Лань түүхэн сурвалжууд дахь домгуудыг цэгцлэн үзсэний эцэст Яньди хаан Цян овогтой байжээ. . . Цян овогтнууд бол Баруун Рунгийн Цян үндэстний нэгэн салаа бөгөөд баруун зүгээс нүүдэллэсээр дотор газар суурьшин аажмаар газар тариалан эрхлэх болсон гэсэн байдаг. Эртний хятадуудын дээд өвөг болох Шаодяньчууд жинхэнэ нүүдэлчид байсан юм. Баруун Цянгууд зан чанарын хувьд ширүүн дориун, эрэлхэг зоригтой гэгддэг байсан нь домог төдийхөн биш бодит зүйл байжээ. Хожуу Хань улсын бичиг Баруун Цянгийн шастирт тэмдэглэснээр: Баруун Цянгууд дайн байлдаанд насан эцэслэхийг эрхэмлэдэг, өвчнөөр өөд болохыг муу ёр хэмээн үзмүй. Араатан гөрөөс лүгээ адил өлчир тул эмэгтэйчүүд цасан шуурган дунд хүүхдээ төрүүлэхдээ ч сийхгүй. Тэдний зоримог дайчин нь баруун зүгийн төмөр махбодийн 52 агаарыг шингээсний улмаас болой хэмээсэн байдаг. Энэ хэсгийн дүгнэлт ямар гоё байна вэ? Эгээ л тал нутгийн чоно болон нүүдэлчдийг тодорхойлсоноос өөрцгүй байгаа биз дээ? Чухам талын чоно, нүүдэлчин үндэстэн хоёр л өвчинд баригдан үхсэнээс өшөөтөн лүгээ нэгийгээ үзэлцэн тулалдахыг эрхэмлэдэг бус уу? Энэхүү түүхэн сурвалж болон түүн доторх дүгнэлтүүд нь баруун Цян үндэстэн болоод хятадын бусад нүүдэлчин үндэстнүүдийн нийтлэг хам шинж болох чонон араншинг оновчтой дүгнэжээ. Тухайлбал Баруун умард зүгийн нүүдэлчин үндэстнүүдийн зан чанарын уг сурвалж нь омогт хүрэн бүргэд, орог саарал чоно байж болохоос гадна хятад үндэстний төмөр мэт хатуу зан чанар баруун болоод баруун умард зүгээс сурвалжтай гэдгийг бидэнд хэлж өгч байна. Би хятадуудын өвөг дээдэс энэ лүгээ хад мэт зориг хатуу чанга зан чанартай байсанд хичнээн их баярлаж бахадсан гэх билээ.

Цянгууд хятадын эртний тун хүчирхэг үндэстэн төдийгүй хятадын дээд өвгүүдийн нэг яахын



аргагүй мөн. Тухайн цагтаа Цуань Рун, Байгөү53, Байлан54 зэрэг зарим нэгэн баруун Рунгуудыг багтааж байсан төдийгүй хожим, Хань, Дансян, Турфан, Төвд зэрэг үндэстнүүд тэднээс салаалан үүссэн билээ. Хятад төвд овгийн үет хэлнүүд эртний Цян үндэстний хэлнээс үүдэлтэй гэж зарим судлаачид үздэг нь оргүй зүйл биш болов уу? Өдгөө хүртэл хятадын ханз үсэгт дээд өвөг нь болох Цян үндэстний нүүдэлчин цусны хөх толбо тодорхой үлдсэн байдаг. Тухайлбал өдгөө бидний сайн мэдэх 美 буюу гоё, үзэсгэлэнтэй гэсэн ханз үсэг 羊 буюу хонь 大 буюу том гэсэн хоёр утгат хэсгээс бүрэлдэж байгаа. Үүнээс үзэхэд хятадын өвөг дээдсийн гоо сайхны таашаал нүүдэлчдийнхтэй ямар ижил байна вэ? Чи бид хоёр шиг хоньчин байсан улс тийм гоо сайхны мэдрэмжийг юу эс андах билээ? Хонины мах малчдын гол хүнс байдаг болохоор хургыг том хонь болгох шиг гоё сайхан хэрэг гэж хаана байхав? Хонь том байна гэдэг нь талын чонын гоо сайхны гол хэмжүүр яахын аргагүй мөн. Том тарган ирэг барьсан чонын сэтгэл яасан сайхан байдаг бол доо? Хэрвээ хятадын эртний өвөг дээдэс тариачин гаралтай байсан бол гоё сайхан гэдэг ханз том хонь гэсэн утгатай биш, том будаа байх байсан нь гарцаагүй. Эрт цагт том хонь гоо сайхны хэмжүүр байсан бол одоо гоо бүсгүй түүнийг орлоод байгаа боловч үсгийн хэлбэрийн хувьд том хонь хэвээрээ л байгаа юм.

Цян үндэстний агуу нь түүний хатуу чанга зан чанар болоод гоц гойд оюун билигтэйд байжээ. Эртний Цян лугаа зэрэгцэн оршиж байсан Хүннү зэрэг нүүдэлчин үндэстэнүүд аль эрт түүхийн тавцангаас арчигдан үгүй болсон байтал тэд өдгөө хүртэл амь бөхтэй оршиж үр ач нарынх нь тоо дэлхий даяар тэрбумыг хол даван гарчээ...

Би жаахан сэдвээсээ хадуурчихлаа, одоо хоёулаа Янь Хуан хоёр хааны үе рүүгээ эргэн орёё. Домогт өгүүлдгээр Зю Ли үндэстний удирдагч Чи Ю дотор газрыг эзлэн авахаар умард зүг рүү цэрэглэн хөдлөөд газар тариалан эрхэлж эхлээд байсан Яньди хааныхантай ширүүн тулалдсаны эцэст Жуолү газар хүртэл шахсан гэдэг. Яньди хаан илүү хүчирхэг Хуанди хааныхантай хүч хавсран тулалдаад тэднийг Жуолүгийн орчимд бутниргэснээр дотор газраас үлдэн хөөж чаджээ. Хожим Хуанди хааныхан Яньдичуудтай тулалдан Хөх мөрний сав газар руу хөөж явуулсанаар дотор газрын жинхэнэ эзэн болцгоожээ.

Яньхуанчууд55 баруун хойт орны нүүдэлчдээс гаралтай болохоор тал нутгийн нүүдэлчдийн гол шүтээн болох тэнгэрийг шүтэж байсан байж таарна. Хуанди хаан Чи Юг барьж алсаны дараа олон ихэс язгууртнууд түүнийг тэнгэрийн хөвгүүнд өргөмжилжээ хэмээн Түүхэн тэмдэглэл зохиолд дурьдсан байдаг.

Чэнь Жэнь бичгийн хавгаснаас нэгэн шошго гарган ирээд “Хятадын баруун умардын нүүдэлчид үе улиран дээд тэнгэрийг шүтэж ирсэн нь судалгаагаар тогтоогдсон зүйл юм. Тал нутгийн эзэнт гүрний зохиогч, францын азийг судлаач эрдэмтэн Рене Гроссе энэ тухай хэрхэн бичсэнийг чи сонс л доо” гээд цааш нь “Манай эриний гуравдугаар зууны хожуу хагаст Хүннүчүүд нэгдмэл хүчирхэг улсыг байгуулж чаджээ. Тэдний удирдагчийг Шаньюй56 гэх буюу бүтэн нэрийг нь тэнгэрийн хүү Шаньюй57 гэдэг байжээ. Тэнгэр гэдэг үг нь түрэг монгол хэлэнд ч ижил дуудлагатай байдаг. Өөрөөр хэлбэл Хүннүгээс авахуулаад түрэг монгол хүртэлх бүхий л нүүдэлчин үндэстнүүд бүгд нэгэн адил тэнгэрийг дээдлэн шүтдэг байжээ. Хүннү хэмээх энэхүү эртний үндэстнийг хятадын түүхийн янз бүрийн цаг үед Хүнжөү,

(羣粥), Чүньвэй (淳維) гэх мэт өөр өөр нэрээр дууддаг байснаа Хань улсын үед 匈奴 буюу

Хүннү гэдэг нэрэн дээр тогтсон юм. Хуанди хаан Хүнжөү нартай холбоотой байсан тухай Түүхэн тэмдэглэл зохиолын таван хааны язгуурын товчоон бүлэгт өгүүлэхдээ: Хуанди хаан. . Хүнжөү нарыг умард зүг үлдэн хөөв хэмээсэн байдаг. Дээр өгүүлсэнээс үзэхэд Хуанди хааны үед баруун умард орны нүүдэлчид тэнгэр шүтлэгтэй байсан бөгөөд эс бөгөөс бусад овог аймгууд яахин түүнийг тэнгэрийн хөвгүүнд өргөмжилж байх билээ. Тийм болохоор тэнгэр шүтлэг болон тэнгэрийн хөвгүүн гэсэн энэхүү цол нь балар эртний үеийн баруун болон умард зүгийн нүүдэлчдээс улбаатай ажээ.

Хуандичүүд нүүдэлчид байсан болохоор эрхбиш чоно мэт эрс хатуу зан чанартай байсан байж таарна. Таван хааны угийн товчоонд энэ талаар өгүүлэхдээ: Хуанди хаан баавгай, барс, ирвэс зэрэг зургаан зүйл зэрлэг араатныг сургаж Баньцуань газар Яньди хаан лугаа тулалдахдаа ашигласан хэмээн тэмдэглэсэн байдаг. Эдгээр аймшигтай араатан амьтдыг сургаж дайн тулалдаанд хэрэглэж байна гэдэг нь тэднийг нүүдэлчдийн армийн хэв шинжтэй байсныг харуулж байгаа юм. Дээр өгүүлсэн зургаан зүйл зэрлэг араатан амьтдын дунд чоно байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Хятадуудын тухайд эртнээс нааш хүн бус арш сахиулсан мэт хүндлэгддэг байсан Хуанди хааны эрхэнд ороогүйгээс үзвэл чоныг угаас сургаж болдоггүй гэдэг нь батлагдахаас гадна, нөгөө талаар чоныг дээдлэн шүтдэг нүүдэлчид угаас түүнийг сургах гэж оролдоогүй нь мэдээж юм.

Хань үндэстэнгүүд уг нь баруун хойд орны нүүдэлчдийн хойчис атлаа хожим нүүдэлчин үндэстнүүдийг дорд үзэх болсон нь үндэс гарвалиа мартаж байгаагаас өөрцгүй хэрэг билээ. Хэрвээ хань үндэстэн нүүдэлчдээс гаралтай юм бол тэдний цусанд лавгайяа чонын араншингийн ул мөр үлдсэн л байж таарна. Тэгэхээр хятад үндэстний сэргэн мандахын уг сурвалж нь энэхүү очын төдийхөн үлдчихээд байж мэдэх өөрсдийн цусан дахь чонын араншингийн өчүүхэн улбааг бөхөөчихөлгүй хадгалж дэвжээн хөгжихөд л байгаа юм” гэлээ.

\* \* \*

Янкөгийн нүд нь сэргээд “Тал нутгийн нүүдэлчид үе улиран мөнх тэнгэр шүтэж ирсэн төдийгүй хятадын тариачин үндэстэнгүүд ч мөн өөрцгүй дээд тэнгэрийг дээдлэдэгийг гайхаад байх зүйл үгүй ажээ. Яньхуанчууд тал нутгаас тэнгэр шүтлэгийг хятад оронд залж авчирсан хэрэг байх нь шүү дээ” гэхэд

Чэнь Жэнь инээмсэглээд “Тийм болохоор хятадын эх газар дахь нүүдэлчин үндэстэн болон тариачин үндэстнүүд нэг үндэс гаралтай, тэнгэр эцэгтэй, тал нутаг гэсэн эхтэй ахан дүүсүүд бөгөөд энэ утгаараа тал нутгийн нүүдэлчид ах нь, хятадууд дүү нь болж таарах юм. Хэзээ нэгэн өдөр хятад үндэстэн газар тариалангийн орчин нөхцлийн улмаас доройтон сулрах үед энэрэл сүрийг хослуулсан эцэг тэнгэр нь чонын араншинтай нүүдэлчин үндэстнийг дотор газар руу томилон ирүүлж хоньжиж гүйцсэн тариаланч үндэстний цусыг удаа дараа дайчин давшингуй цусаар сэлбэж хятад үндэстнийг дахин шинээр өндийлгөн босгодог байжээ. Хожим сул дорой дүү нь босох тэнхэлгүй болох үед хүчирхэг ах нь дотор газрыг эзлэн сууж төрийг төвшитгөн захирч, соёл иргэншлийг нь өөд татсаар өрнөдийн соёл иргэншил лугаа уулзуулж өгсөн юм. Ах дүү хоёр үндэстэн ийнхүү өвөрмөц хэлбэрээр дундадын<sup>58</sup> гайхамшигт соёл иргэншлийг буй болгож дэлхийн дөрвөн том соёл иргэншлийн дундаас гагцхүү дундадын соёл иргэншил амьсгал хураачихалгүй өдий хүрсэний нууц чухам энд оршиж байна.

Дундадын соёл иргэншлийн зам бол дэлхий дээрх хамгийн хүчирхэг тал нутаг болон дэлхий дээрх хамгийн том атлаа сул дорой газар тариалангийн үйлдвэрлэлийн дундаас төрөн гарсан юм.

Янь Хуан хоёр үндэстний тулалдаанд Хуандичууд ялан гарсан нь яахын аргагүй анхаарал татах асуудал мөн. Хэдийгээр тэд адилхан нүүдэлчин гаралтай боловч Яньдичүүд Хуанди нарыг бодвол хэдэн зуун жилийн өмнө дотор газар<sup>59</sup> оршин сууж газар тариалан эрхэлж эхлэснээр өнөөгийн бид Яньдичуудыг хятадын газар тариалангийн анхдагчууд хэмээн зүй ёсоор нэрлэдэг билээ. Өөрөөр хэлбэл хавьгүй эрт газар тариалан эрхлэж эхэлсэн Яньдичууд газар тариалангийн соёлын сулруулах хүч нөлөөнд автаж эхлэсэн тул Хуандичуудад ялагдсан байж таарна. Янь Хуан хоёр үндэстний дайн нь дундадын соёл иргэншлийн түүхийн хамгийн тод зурвас шугамын эхлэл болсон бөгөөд энэхүү зурвас шугамын түүх нь ангийн тэмцлийн түүхээс ч өнө эрт, урт удаан төдийгүй ангийн ялгарлаас бүр өмнө эхлэснээрээ онцлогтой. Энэхүү гол зурвас шугамын түүх дундадын соёл иргэншилд гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн бөгөөд өнөө ч тэр байдал үргэлжилсээр байгаа юм” хэмээн ярив.

Ян Кө их л сэтгэл догдолсон байдалтай “Үнэхээр сонин юм гээч. Тал нутагт хүрэлцэн ирж талын чоно болоод чонон сүлд лүгээ учраагүй бол бид шинэ байр суурин дээрээс дундадын соёл иргэншлийн уг сурвалж, угсаа гарлыг ойлгох боломжгүй байжээ. Тал нутагт хүрэлцэн ирээд чонотой харьцсанаас хойш миний толгой дахь их Хань үндэстний үзэл ул мөргүй арилан одсон шүү” гэлээ.

“Сүүлийн жилүүдэд би эдгээр асуудлыг бодож судлаж байгаа. Дундадын түүх болон хятад үндэстний зан чанарын бүрэлдэн тогтож хувирч хувьссан үйл явц маш нарийн ээдрээтй асуудал боловч түүний зүй тогтол учир начрыг тогтоогоод байна хэмээн хэлж болох юм” гэж Чэнь Жэнь өгүүлэв.

“Цааш нь ярь л даа. Хэрвээ чи л ядраагүй бол би дуустал сонсоход бэлэн байна” хэмээн Ян Кө шавдууллаа.

“Би ярихаас төвөгшөөх юу байх билээ? Ярьж хөөрч байж л сая цэгцтэй зүйл гарч ирдэг шүү дээ. Чи сонсох дуртай байгаа чинь миний яриаг улам ч хөгжөөж байна. . . . . Гэхдээ бэлтрэгнийхээ үүрэнд хариугүй очих гэж байгаа болохоор хоёулаа азнаж байгаад яриагаа үргэлжлүүлэе. Би ч өөрийн бэлтрэг багшдаа судалгааныхаа үр дүнг танилцуулмаар байна. Бэлтрэг, Билиг аав хоёр маань миний жинхэнэ удирдагч багш нар маань байсан төдийгүй талын чонон сүрэг болон тал нутгийн ард түмэн бол миний хүндэт багш нар байгаа юм” гэж Чэнь Жэнь хэлэв.

\* \* \*

Уулын хормой дахь халиурсан зэгснүүд ор мөргүй алга болжээ. Жийп машин армаг тармаг дэрс, бударганыг тойрон туучсаар Хар чулуут уулын хормойд хүрч ирлээ.

“Чи бэлтрэгнийхээ үүрийг өнөө хэр санасаар байгаа хэрэг үү?” хэмээн Ян Кө асуулаа.

“Шавь нь байтлаа багшийнхаа гэрийг мартаж болох бил үү? Бид бэлтрэгний үүрний наахна

байдаг нэгэн довцог ирсэн байна. Цаашаа хэсэг явган явах хэрэгтэй” хэмээн Чэнь Жэнь өөртөө их л итгэлтэй өгүүлэв.

Жийп машин цааш зугуухан хөдөллөө. Бэлтрэгний үүрэнд ойртох тусам Чэнь Жэньгийн зүрх догдлон амьсгаа нь дээрдээд ирэв. Нэгэн дайны гэмт хэрэгтэн өөрийн гарт амь үрэгдэгсдийн булшинд нүглээ наманчлахаар яваа мэт түүнд санагдаж байлаа. Монгол талын долоон бэлтрэгний тав нь хөхнөөс гарах байтугай нүдээ ч нээгээгүй байхдаа амьсгаа хураасан бол арай азтай нэг нь хөлд орж хөрсжих үе дээрээ алуулсан. Хамгийн сүүлчийн нэг бэлтрэгний амин зуулгын гол эх үүсвэр болсон соёо шүдийг бахиар тайран, адаг сүүлд нь өөрийн гараар егүүтгэж билээ. Төрөлхийн эрх чөлөөг эрхэмлэж өнөө хэр улам ч дээдлэн шүтэх болсон Чэнь Жэнь хамгийн дарангуй хатуу харгис нүглийг үйлдсэн тул залуу цагийн болчимгүйгээс үүдэлтэй цуст хэргийн хуучин ул мөртэй дахин учрахаас эмээх нь аргагүй юм. Тэр заримдаа өөрийн судалгааны үр дүнг жигшин зэвүүцэх нь олонтоо. Чухам түүний сониуч, адал явдалд хорхойсох зан нь долоон бэлтрэгний баяр хөөр, эрх чөлөөг үгүй болгосон болохоор түүний номын ноорог нь долоон хөөрхөн бэлтрэгний халуун цусаар бичигдсэн ч гэж болох. Тэд бол цагаан цээжит азарган чонын эрхэм дээд цусыг өөртөө шингээсэн монгол талын сүрэг чонын удам байж билээ. . . . .Хорь гаруй жилийн турш түүний дотоод сэтгэлийг энэхүү цусан өртөлөөс шаналган зовоосоор ирсэн. Чоныг алж агнасаар байдаг тал нутгийнхан яахаараа насан эцэслэсэн хойноо өөрийн биеийг чонон сүрэгт найр тавьдагийн учрыг тэр улам илүү ухаарах болсон юм.Тэр нь зөвхөн сүнсээ тэнгэрт илгээж, махыг махаар гэсэн өрийг дарах төдийхөн бус, нөгөө талаар дотоод эмзэглэлээс улбаатай, тал нутгаа аминаасаа илүү хайрлах сэтгэлийн илэрхийлэл байдаг ажгуу. . . . .Гэтэл тал нутагт одоо хүн тавьдаг газар нэгэнт үгүй болжээ.

Хорь гаруй жилийн турш өхөөрдөн хайрламаар, өрөвдөн хүндэлмээр бяцхан бэлтрэг түүний зүүдний орон бодлын бэлчирийг эзэмдсээр байдаг боловч тэр болгонд ганц удаа ч болов түүнийг хазаж хайран, өшөөгөө авах байдал гаргасан нь үгүй. Зүүд зөнгийн ертөнцөд хуучин бууриа эргэдэг бэлтрэг нь дандаа л хойгуур урдуур эрхлэн наадаж, өвдөг шилбийг шүргэн, эрүү хурууг нь долоохоос хэтрэхгүй. Нэгэн удаа тэр зүлгэн дээр унтаж байгаад цочин сэртэл бэлтрэг нь толгойны хажууд хэвтэж байгаагаар зүүдлэж билээ. Тэр зөн совингоороо хоолойгоо гараар даран хамгаалахад бэлтрэг түүний сэрэхийг хараад газар хөлбөрөн эргэж гэдсээ түүнд өгөөд маажуулсан юм даг. . . . .Хорь гаруй жилийн турш тоо томшгүй олон удаа бэлтрэг зүүд нойронд морилон ирэхдээ эрх хонгорхон жаалхүү мэт дотносон тоглож байгаад л явчихна. . . . .Тэр болгонд бэлтрэг түүн рүү араа шүдээ ярзайлган архирахгүй, гагцхүү чононд л байдаг хайр энхрийллийг түүнд илэрхийлдэг. Чонын нүдэн дэх хайр гэж чухам юу байдгийг хүмүүсийн дундаас олж үзэхгүй. Учир нь бэлтрэгнийх нь хайр эрт балрын эль хульхан атлаа этгээд ээвэргүү гэнэн санагддаг байсан сан. . . . .

Ян Кө энэхүү хад чулуу өргөст бутнуудыг сүлжин явж байхдаа хорин долоо найман жилийн өмнөх хүйс тэмтрэлтийг санах шиг болжээ. Түүний нүдэнд гүн эмзэглэл болон өөрийгөө зэмлэсэн гунигтай харц тодорно.

Жийп машин уулын хормойд хүрч ирээд зогсоход Чэнь Жэнь холгүйхэн байгаа хэсэг тэгш газрыг зааж “Тэр бол чонын бэлтрэгнүүдийн түр оромж байсан газар байна. Тэднийг ухан гаргасан гол гэмт хэрэгтэн би байгаа юм даа. Би Олонбулгийн талаас явахдаа тэгшилж

булсан болохоор одоо ямар ч ул мөр үлдээгүй байж таарна. Тийм болохоор хоёулаа шулуухан хуучин үүр рүү явцгаая” гэхэд мань хоёр машинаасаа буюгаад холгүй байх нэгэн довцгийг чиглэн алхацгаалаа.

Довцгийн орой дээр гарч ирэхэд ойр хавьд үргэлжилдэг байсан нохойн хошууны өргөст бут болон өтгөн зэгснүүд юу ч үгүй болчихсон улаан халцгай газраар дахин хэдэн арван метр замыг туултал зуун зууныг туулсан чонын хуучин үүр холгүй онгойн харагдаж байв. Чонын үүр улам ч том болчихсон мэт санагдах нь Шаньбэй нутгийн шар шороон эрэг гангад ухаад хаясан нүхэн оромж шиг тэдний нүдэнд тусах ажээ. Чэнь Жэн амьсгаа даран яаран алхсаар нүхний амсар дээр очиход томорсон зүйл үгүй, гагцхүү халхалж байсан ургамлан бүрхэвч алга болсноос хавьгүй том харагдсан байх нь. Олон жил үргэлжилсэн ган гачгийн улмаас чонын үүр хуучин төрхөө хадгалан үлдэж чадсан боловч амсар орчмын нэлээдгүй газар шороо чулууны нурангид дарагджээ. Чэнь Жэнь газар сөхрөн суугаад нүхний гүн рүү шагайн харваас чөдөр өвс, элс шороо зэрэг холилдон төө зузаан булсан байлаа. Тэр гар чийдэнгээ гаргаж ирээд хартал чонын үүрний булан тохой бараг битүүлэгдэх шахжээ. Чэнь Жэнь нүхний амсрын багахан чөлөөнд бөгсөөрөө лагхийтэл суугаад чонын үүрийг удтал дуугүй гөлрөв.

Ян Кө дотогш гар чийдэн тусган харсанаа “Яг мөн байна. Чи энэ үүрэнд шурган орж байсан шүү дээ. Тэр үед би дотор өлөгчин чоно байвал яана аа гэж нэг айх, араас дайраад ирэхгүй байгаа гэж нэг санаа зовних гээд мөн хэцүү байж билээ. . . . . Чи бид хоёр ч тэр үед ёстой ирвэсийг боловч чихдээд авахаас буцахааргүй исгэлэн халуун цустай байцгааж дээ. Үнэндээ чиний яриад байгаа онол чинь тал нутгийн гүнд чонын үүрэнд шурган орж байж гарган авсан зүйл шүү дээ. . . . . ” гэв.

Ян Кө чонын үүр рүү тонгойгоод “Бэлтрэг ээ, бэлтрэг ээ, хоолондоо, Чэнь Жэнь бид хоёр ирлээ шүү” хэмээн шинэ бэлчээр нутагт ирсэний дараах байдлыг дууриан хашгирав. Харамсалтай нь нүхнээс годхийн гүйж гарах бэлтрэг л байсангүй. . . . .

Чэнь Жэнь босож биеийнхээ тоос шороог гөвж наалдсан хуурай өвснүүдийг ширхэг ширхэгээр түүсний эцэст цүнхнээсээ долоон ширхэг Бээжинд үйлдвэрлэсэн нарийн хиам гарган ирсэний нэг хавьгүй бүдүүн харагдана. Түүнийг өөрийн хайртай бэлтрэгэндээ зориулан авчирсан юм. Чэнь Жэнь мөнөөх тахил тавигийн зүйлсийг үүрний өмнө эгнүүлэн тавиад цүнхнээсээ мөн долоон ширхэг хүж гарган асаалаа. Тэр бас өөрийн бичмэл материалын дотор хавтсыг сугалан авч шатаагаад тэнгэрт өглөг болгон өргөв. “Чонон сүлд” болон Чэнь Жэнь гэсэн хоёр үсэг галын дөлд шатаж дуусахад Чэнь Жэнь чин сэтгэлийн угаас тэнгэрт залрах Билиг аав болон хайртай бэлтрэгийн гэгээн сүнс түүний амлалт болоод гүн наманчлалыг тосон авч байгаа гэдэгт итгэж байлаа. Галын дөл Чэнь Жэньгийн хурууг төөнөөсөөр сая шатаж гүйцэв. Чэнь Жэнь цүнхнээс Билиг аавынхаа амсах дуртай байсан Бээжингийн хавтгай шилтэй арз архийг гарган чонын үүрний ойр орчимд тойруулан цацлаа. Олонбулгийн талын хоёрдугаар багийн нутаг дэвсгэр дэх чонын хуучин үүр болгонд өвгөний хөлийн ул мөр шингээстэй байдгийг тэр мэдэх юм. Тэр өвгөний үгэнд оролгүй чоно тэжээснээр түүний сэтгэлийг шархлуулсан алдас нүглийг юугаар ч цайруулах аргагүй билээ.

Тэр хоёр тэнгэр өөд алгаа тосон дээш хараад суунаглах цэнхэр утааны хамтаар Билиг аав болон чонын бэлтрэгний сүнсийг тахицгаав. . . . .

Тэр уг нь “Бэлтрэг ээ, бэлтрэг минь, Аав аа, аав аа, би та хоёр дээрээ ирлээ” хэмээн хашгирмаар байсан боловч зүрхэлсэнгүй, өөрт нь тийм эрх байхгүй мэт санагдаж байв. Тэр нөгөө талаар тэдний гэгээн сүнсийг цочоочихвол нүдээ нээгээд харахад нь сүр сүлдгүй гандуу хуурай тал угтах вий гэхээс эмээжээ.

Асар тэнгэр аргуу бүрсгэр царайлах нь уйлья хэмээвч усан нулимс нь хатчихаа юм болов уу. . . . .

\* \* \*

Цаг хараахан эрт байгаа болохоор мань хоёр хоолны цүнхээ авч машиныхаа сүүдэрт хээрийн цай ууцгаав. Чэнь Жэнь шархирсан сэтгэлээ тайвшруулах гэж архинаас хоёр том балгатал буруу хоолойгоор орсон юм болов уу хахаж цацаад нус нулимстайгаа хутгалдан чонын уул бүрэлзээд явчихлаа.

“Чи тэгтлээ битгий шанал даа. Нэгэнт л амласан зүйлсээ биччихсэн болохоор аав бэлтрэг хоёрын ариун сүнс тайвшран амаржаа буй за. Бэлтрэг маань сүүл рүүгээ бид хоёрт дасаад ялангуяа чамд хуурай ааваас өөрцгүй байдаг байсан шүү дээ. Мөнх тэнгэр түүнд үнэн мөнийг дуулгасан болохоор лав чамд элдэв муу юм бодоогүй байж таарна. Одоо цагт хүний мөс чанар улам л муудах боллоо. Би арван хэдэн жил өмгөөлөгчийн ажил хийх явцдаа өөрийн хятадуудад бүр ч сүжиг алдраад байдаг болсон шүү. Аав нь амьсгал хураагаагүй байхад өвчтний орны өмнө үр хүүхдүүд нь эд хөрөнгийг булаацалдаад санаа амар нүд аниулахаа больчихсон байна гээд бод доо. Орчин үеийн хот газрынхан хайртай тэжээвэр нохойгоо алдахдаа л жинхэнэ үнэн сэтгэлийн нулимсаа унагаж байдаг болжээ. . . . Алсдаа хүн төрөлхтөн амьтдын ертөнц рүү үнэн мөн, сайн сайхан бүхний эрэлд гарч мэдэх юм” хэмээн Ян Кө хэлэв.

“Үнэн мөн, сайн сайхнаар яахин тогтох билээ дээ?” гээд Чэнь Жэнь санаа алдлаа.

Ян Кө өгүүлрүүн “Чи өөрийнхөө яриаг үргэлжлүүлж үз. Талын чонын хуучин буурин дээр чонон сүлдийн тухай яриаг өрнүүлнэ гэдэг бэлтрэг болоод уудам талын энд дайтаж байгаад үхсэн чонон цэргүүдийн хувьд хамгийн өндөр дээдийн хүндлэл тахил болох ёстой. Бэлтрэг маань дээд тэнгэрийн орондоо толгой гилжийлгэн, чихээ соотойлгож байгаад чиний яриаг сонсох нь лавтай” гэв.

Чэнь Жэнь нэг балга архи гүдхийтэл балгаваас чонын ааг багтаж ядсан цус зулай өөд хөөрөхөд өөрийн яриагаа үргэлжлүүлэн хөврүүлж эхлэлээ.

“Эндээ гэхэд чонын араншин бүхий тал нутгийн орчин нөхцөл чонын араншин бүхий зан чанар болон цусыг бүрдүүлэн төлжүүлэх үүрэгтэй байдаг юм. Харин үүний эсрэг хонины араншин бүхий газар тариалангийн орчин нөхцөл хонины араншин бүхий зан чанар болон цусыг төлжүүлэн бүрэлдүүлдэг байна. Яньди хаан болоод Хуанди хаан өөрийн овог аймгынхнаа дагуулан дотор газар анх явж очиход тухайн үеийн нөхцөл байдал ямархуу байсан бэ гэхээр

Нэгдүгээрт, Янь Хуан хоёр хааны овог аймгынхан бүгдээрээ омог хүчтэй чонын араншин

болоод чонын цустай байцгаажээ.

Хоёрдугаарт дотор газар болон баруун хойд орон тухайн цаг үед нэлэнхүйдээ асар том бэлчээр байсан тул чонон сүрэг элбэг байсан байж таарна. Тийм болохоор тухайн үеийн дотор газар нь чонон цусыг төлжүүлэх үүргээ эрчимтэй гүйцэтгэж байв.

Гуравдугаарт газар тариалан эрхэлж ирсэнийг дагалдан хонины араншин бүхий цусыг төлжүүлэх үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна.

Дөрөвдүгээрт Күнзийн сургаал буй болоогүй байсан үе гэдгийг дурьдах хэрэгтэй. Хожим тодрон гарсан Күнз газар тариалангийн ухамсрыг цэгцэлсэний үндсэн дээр өөрийн сургаалаа буй болгосноор хятад үндэстний зан чанар бүрэлдэн тогтноход асар их нөлөө үзүүлсэн юм. Түүрүү үеийн Күнзийн сургаал хагас мал аж ахуйн болоод хагас газар тариалангийн үйлдвэрлэлийн хөрс суурин дээр бүрэлдсэн болохоор хэдийгээр гурван хэлхээ, таван ашид зэрэг хуучинсаг эвэргүү газар тариалангийн үзэл суртал нэвт ханхалдаг ч гэлээ тэр үеийн сонгодог бүтээлүүдэд нь бас ч гэж нүүдэлчдийн хүчирхэг үзэл санааны ул мөр болох авгай өөрийгөө ямагт хүчирхэгжүүлэн боловсруулмуй гэх зэрэг үгс мэр сэр байдаг нь хожуу үеийн Сүн Мингийн үеийн Күнзийн суртхаалаас ихээхэн ялгаатай.

Тийм болохоор анхандаа Янь Хуан зэрэг өвгөдийн чонын араншинт цус зарим нэгэн тариачин овог аймгуудын тайван амгалан амьдрал дунд шингэрээгүй бөгөөд чанга хатуу чонын цус болон нүүдэлчдийн оюун санааг тийм ч амархан мохоогоод мөлийлгөчихнө гэж байхгүй л дээ.

Ян Хуан овгууд хагас малчин, хагас тариаланч маягтай амьдралын хэвшил рүү шилжжээ. Ингэснээр тэд эрэлхэг дайчин зан чанартай, цэргийн гарамгай авьяастай болохоор улс гэрээ сахин хамгаалахын зэрэгцээ харьцангуй амар жимэр хөдөлмөр үйлдвэрлэлийн нөхцлийг буй болгож чадсан байна. Энэ шинээр буй болсон үндэстэн асар их энергийг ялгаруулах болжээ. Ян Хуан үндэстэн дотор газар хүчээ аван өндийхийн хэрээр хүн ам асар хурдацтай өсөн нэмэгдэж, газар нутаг нь тэлснээр Шар мөрний сав газраас Хөх мөрний сав газар хүртэл хүрээгээ тэлэв.

Харин аажмаар цар хүрээгээ тэлсэн тариачны ахуй амьдрал нүүдэлчин үндэстэн байхаас улбаатай чонын араншин зан чанарыг элэгдүүлэн, улам бүр хумигдсаар байсан дотор газрын чонын араншинг бүрэлдүүлэгч үүргийг эвдэн хаяжээ. Шан улсын сүүлч үе болоход баруун зүгийн Жоу улс хүчээ авч эхэлсэн байна. Жоу улс тухайн цаг үед хэдийгээр газар тариалан эрхэлж эхэлсэн боловч хүн амын дийлэнх нь Рун, Ди зэрэг нүүдэлчин үндэстнүүд байсан юм. Тэр бүхний үр дүнд Жоу үндэстэн зан чанарын хувьд чоно хонины холимог, зэрлэгдүү атлаа соёлжингуй, бичиг цэрэг хослосон, билиг оюун эр зориг цогцолсон байв. Тэд дотор газрын тариаланч үндэстнүүдээс хавьгүй илүү чонын цус давамгайлсан, дайчин давшингуй чонын араншинтай атлаа соёл боловсрол зэрэгт элгэмсүү ханддаг ажгуу.

Манай эриний 11 дүгээр зууны үеэр Жоу улсын Ү Ван, баруун зүгийн Рун, Ди нарын найман том аймгуудыг удирдан гурван зуун байлдааны тэрэг, дөчин таван мянган хуягтан цэргүүдээ дагуулсаар зүүн зүгийн Шан улсын Жоу ванг дайлаар оджээ. Жоу улсын Ү Ван нь Шан улсын Жоу вангийн долоон зуун мянган их цэрэгтэй тулалдахын өмнө нийт цэргүүдийн хамтаар

архирах барс, араатан чоно лугаа тулалдья хэмээн тэнгэрийн нэрийг барьж тангарагласан гэдэг. Жоу улсын бар чоно мэт цэргүүд тооны хувьд хавьгүй цөөн байсан атлаа их ялалтыг байгуулан Шан улсыг устгаад дундадын соёл иргэншлийн түүхэнд асар их нөлөө үзүүлсэн баруун Жоу улсыг байгуулсан юм.

Жоу улс Рун, Ди зэрэг нүүдэлчидтэй холилдон амьдарч байсан болохоор нүүдэлчдийн тэнгэр шүтлэг болон сүлд шүтээний нөлөөнд автан түүнийгээ хожим нь хятад нутагт нэвтрүүлжээ. Ингэснээр нийт хятад даяар тэнгэрийг дээдлэн шүтэж хаан эзнийгээ тэнгэрийн хөвгүүн хэмээн нэрийдэж байв.

Жоу үндэстний энэхүү чоно хонины холимог араншин нь Жоу болон баруун Жоу улсууд үнэн хэрэг дээрээ тухайн үеийн нийт хятад үндэстэнг тал нутгийн чонын цусаар сэлбэж чадсан юм. Тэгснээр мянгаад жилийн турш газар тариалангийн хонины цусанд дарангуйлагдаад байсан чонын цус байх ёстой хэмжээндээ эргэн иржээ. Энэхүү цус сэлбэлт60 нь Жоу улсын Вэнь Ван, Жоу улсын Ү Ван болон Жоу Гүн зэрэг хятад үндэстэн болон түүний соёл иргэншилд гүнзгий нөлөө үзүүлсэн суут хүмүүсийг төрүүлэн гаргасан юм. Тухайн цаг үед хятадын богд мэргэдүүд бүгд хатуу чанга нүүдэлчний ухамсартай, уужуу тэнүүн бодолтой, урт холын ухаантай хүмүүс байжээ. Авгай өөрийгөө ямагт хүчирхэгжүүлэн боловсруулмай гэх үзэл чухам энэ үед л бүрэлдэн тогтсон нь нөгөө талаар тухайн цаг үеийн үндэстний зан чанарын бодит тусгал болж байв. Энэхүү үндэстний оюун санаанд нүүдэлчний ухамсар нэвт шингээстэй байлаа.

Газар тариалангийн соёлын зүй ёсны бүтээл болох ахиж дэвшихийг боддоггүй ялзарсан хандлага нь Шан улсын мөхөх үндсэн шалтгаан болжээ.Өөрийгөө ямагт хөгжүүлэн боловсруулж ирсэн Жоу улс энэхүү ялзарч гүйцсэн Шан улсын халааг авсан нь зүй ёсны хэрэг байлаа. Бичиг соёл, эрдэм сүрийг чадамгай хослуулж чадсан баруун Жоу улсын сэргэн мандал нь хятад үндэстний бүрэлдэн хөгжих үндэс суурийг буй болгосон юм” гэснээ Чэнь Жэнь машины дугуйг налж хөлөө жийн суугаад цааш нь өгүүлрүүн:

“Хятад үндэстний цаашдын зам мөр нь хятадын онцлогтой чиг шугамын дагуу хөгжиж иржээ. Газар тариалангийн үйлдвэрлэл нь тухайн үндэстний зан чанарыг мохоож мөлийлгөдөг бол тал нутгийн нүүдлийн мал аж ахуй нүүдэлчдийн зан чанарыг байнга хурцалж байдаг онцлогтой. Тийм болохоор эртний хятадын соёл иргэншлийн хөгжил болон түүний залгамж чанар нь байнга нүүдэлчин үндэстний тогтмол болон тогтмол бус тасралтгүй цус сэлбэсний үндсэн дээр явагдах болсон юм. Энэ бол эртний хятадын хэдэн мянган жилийн соёл иргэншлийн хөгжлийн зүй тогтол, харин энэхүү зүй тогтол нь үндэстний тогтнон хөгжих үндсэн асуудал болох үндэстний зан чанарын асуудлыг хөндөж байдаг.

Түүх гэдэг баахан санамсаргүй тохиолдлуудын цуглуулга биш, харин ч өөрийн гэсэн дотоод зүй тогтолтой болохыг хятадын болоод дэлхийн түүх батлан харуулсаар байна. Харин дундадын соёл иргэншлийн мандан буурах хөгжлийн онцгой зүй тогтол нь өнөө хэр мөнөөх “баахан санамсаргүй тохиолдлуудын овоолго” дунд дарагдчихаад байгаа юм. Хэрвээ үндэстний ахуй, үндэстний зан чанарын судалгааны арга зүйн үүднээс эдгээр овоолгуудыг судлахгүй юм бол бид хэзээ ч хятадын онцлогтой соёл иргэншлийн мандал бадралын хөгжлийн зүй тогтлыг ойлгож, тус улсын хувь заяаны эзэн байж чадахгүй.



Зан араншин гэдэг бол тухайн хүний хөгжиж дэвжих шийдвэрлэх хүчин зүйл болж байдаг. Харин үндэстний зан чанар нь тухайн үндэстний хувь тавилангийн үхэл сэхлийг шийдэх гол зангилаа болж байдгаараа аливаа улсын хувьд яах аргагүй том хэрэг мөн. Дэлхийн үндэстнүүдийн мандал мөхлийн түүхээс харахад үндэстний зан араншин тухайн үндэстний нуруу нугастай дүйцэхээр гол асуудал байдаг. Аливаа үндэстэн зан чанарын хувьд дайчин давшингуй байж чадваас тухайн үндэстний оршин хөгжих боломж төдий хэрээр их байдаг бол харин зан чанарын хувьд сул дорой байх нь түүхийн хог дээр шидэгдэх магадлалыг ихэсгэдэг байна. Дэлхий дээр бодитой оршиж байгаа үндэстний үнэ цэнэтэй хэмжүүрээр цэгнэж үзвэл үндэстний зан чанар дорой буурай байх нь тухайн үндэстнийг мөхөлд хүргэх нигууртай байдаг ажээ. Яагаад гэвэл сул дорой үндэстний зан чанар нь хамаг бузар булай бүхний үндэс байдаг болохоор хамгийн жигшүүртэй, уучилж боломгүй гэм нүглүүдийг үүтгэдэг. Тэдгээрийн тоонд хойшоо ухарч доошоо малтах, аминч явцуулах үзэл, улс орноо өнгөтэй өөдтэй авч явах чадалгүй, газар нутгаасаа бусдад найр талбин өгөх, урваж шарвасан харимхай чанар, ард түмнээ алуулж, боолчлуулах гэх мэт багтана. Дэлхийн тоо томшгүй олон эртний тариаланч үндэстнүүд чухамхүү дээр өгүүлсэн сул дорой зан чанарын уршгаар хатуу хүтүү хорвоогийн хүнд буулганд өвдөг сөгдөн үгүй болж байсан удаатай. Дэлхий нийт хөгжин дэвшиж, хүн ам олшрон амьдрах орон зай байгалийн баялаг хомсдож байгаа өнөө цагт үндэстний зан чанарын асуудал улам ч хурцаар тавигдаж байгаа болохоор үндэстний зан чанарын асуудлыг улам ч цогцоор авч үзэх шаардлагатай. Тийм учраас үндэстний зан чанарын өнцгөөс дундадын соёл иргэншлийн хувьсан өөрчлөгдсөн түүхийг дахин шинээр авч үзэх хэрэгцээ шаардлага урган гарч ирж байна.

Миний санахад нүүдэлчид оюун санаа болон зан чанарын хувьд хятад үндэстний соёл иргэншилд агуу их гавьяа байгуулсан гэж боддог. Дайчин давшингуй үндэстний зан араншин бол хятад үндэстний соёл иргэншлийг бүтээн дэмжих гол тулгуур юм. Эртний хятадын тариаланч үндэстнүүд дундадын соёл иргэншлийн тархи гарыг нь бүтээж өгсөн бол харин нүүдэлчдийн оюун ухаан зан араншин нийт дундад үндэстэн болон түүний соёл иргэншлийн нуруу нугасыг буй болгожээ.

Баруун Жоу улсаас хойш хятад үндэстний мандал буурлыг шийдвэрлэх зүй тогтол чухам ийм маягаар явагдаж ирсэнийг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал хэзээ нэгэн цагт хятад үндэстний зан чанарт хонин араншин чонынхоос хавьгүй давамгайлаад ирэх үед харь нүүдэлчин үндэстнүүд халдан довтолж нутаг дэвсгэрийг эзэгнэн, хүн амыг нь санаан зоргоор алж хяддаг байсан. Харин чонын араншин нь хонины араншингаа даваад ирэх үед хятад нутагт харгис диктатур тогтож, цэргийн эрхтнүүд толгойгоо өндийлгөн, ард түмний бослого самуун хаа сайгүй гардаг байжээ. Гагцхүү хятад үндэстний чоно хонины араншин эн тэнцүү буюу чонын араншин нь ялимгүй давамгайлах үед хятад орон газар нутгаа өргөтгөн тэлж, улсын хүчин чадал нэмэгдэн, эдийн засаг соёл нь цэцэглээд ирдэг байлаа.

Одоо тэгвэл хоёулаа хятадын түүхэн хөгжил миний саяын ярьсан зүй тогтлын дагуу явагдаж, хятадын түүхэн хөгжлийн бодит баримтууд миний дэвшүүлсэн зүй тогтлыг батлаж чадах эсэхийг харцгаая.

Баруун Жоу улсын сүүлчээр урт удаан хугацааны газар тариалан эрхэлж ирсэн харьцангуй амар тайван орчинд хаад ноёд нь ужид цэнгэлд авган, эд ашигт шунахын хэрээр зан чанарын

хувьд сулраад улсаа хөгжүүлж цэргээ багатгах хүсэл сэтгэлгүй болсон байлаа. Түүний горьг удалгүй амсаж Жоу улсын Ю ван харгис түрэмгий Цуань Рун нарт алагдан хайртай хатан Бао Ни нь олзлогдсоноор Хятадын эрх мэдлийн бэлгэ тэмдэг болсон “Есөн хөлт тулга” Цуань Рун нарын эзэмшил газар болох тал нутаг руу зөөгдөн очоод нийслэл хот нь нүүдэлчдийн морин туурай дор талхлагджээ. Ингэснээр гурван зуу гаруй жилийн турш сүр хүчээ гайхуулж байсан Баруун Жоу улс сөнөн мөхсөн түүхтэй. Түүнээс хойш Цуань Рунчууд хятад үндэстний хувьд хамгийн аймшигтай дайсан нь болон хувирсан бөгөөд Тан<sup>61</sup> улсын үед хятадууд баруун хойд зүгийн нүүдэлчдийг бүхэлд нь Цуань Рун буюу эсвэл Рун Ди гэсэн хоёр нэрээр нэрийдэх болжээ. Тан улсын Дай Зун хааны үед Лю Кан нэрт эрхин сайд хаанд өргөн барьсан бодрол бичигтээ: “Цуань Рун нар Дү Лун газраар дайран орж илдийн ир цусталгүй нийслэл хотыг эзлэлээ. . . ” гэх буюу Тан улсын Дө Зун хааны үед их сайд Лю Хунь хаанд айлтгахдаа “Рун Дичүүд болвоос тангараг журмаар барилдаж боломгүй цөөвөр чононууд бөлгөө” гэсэн байдаг. Цуань Рун гэдэг үгийн Цуань нь нохой гэсэн утгатай, хятадуудын зүгээс илт доромжилсон санаа бүхий нэрийдэл бөгөөд Ди Рунчуудыг цөөвөр чоно хэмээн тодотгож байгаа нь тэдний чонын араншинтай байсныг илтгэнэм бус уу? Хятадын түүхэнд хавар намрын үе хэмээн нэрлэгдэх зурвас үед Цуань Рунчууд Цин улсын гол дайсан болон хувирчээ. Нүүдэлчин үндэстэн, нүүдэлчний оюун санаа болоод тэдний сүлд шүтээнийг судлая хэмээвээс эрхгүй эртний Хүннү, Хүньжөү болон Цуань Рунчуудаас эхлэх хэрэгтэй.

Түүхэн сурвалжид тэмдэглэснийг үзвээс Цуань Рунчууд өөрсдийн өвөг дээдэс хоёр цагаан нохойгоос гаралтай гэж үздэг төдийгүй цагаан нохойгоор сүлдээ болгосон баруун умардын хамгийн эртний нүүдэлчин үндэстэн болно. Харин баруун Цянгууд болвоос Янь Хуанчуудын<sup>62</sup> дээд өвөг болох юм. Бүр эрт Янь Хуан нарын үед Цуань Рунчууд тэдний хамгийн хүчирхэг дайсан болж байжээ. Хожуу Хань улсын шастирт тэмдэглэснээр: Гао Синь хааны үед Цуань Рунчууд халдан довтлоход, хариу тэмцээд ч арга мухарддаг байлаа гэжээ. Түүхэн сурвалжид Цуань Рунчуудын сүлд нь цагаан нохой байсан гэдгээс өөр зэрлэг нохой байв уу, тэжээвэр нохой байсан юм уу гэх зэрэг өөр тоймтой зүйл олж мэдэх боломжгүй байдаг. Зэрлэг нохой, эсвэл тэжээвэр нохойн алин байсан нь нүүдэлчдийн зан араншин болоод тэдний сүлд шүтээний уг сурвалжийг тодруулахад маш чухал үүрэгтэй юм.

Миний санахад цагаан нохой гэдэг нь цагаан чоно л байсан болов уу? Хожуу Хань улсын шастирт энэ талаар тэмдэглэхдээ: Хань улсын үед Цуань Рунчуудын ноёрхож байсан нутаг дэвсгэрт хүн ам маш олонтой цагаан чоно хэмээх улс гарч ирсэн байдаг. Зүүн Хань улсын Мин Ди хааны үед “Цагаан чоно, . . . зэрэг зуу гаруй улс алба татвар өргөж байхаар шийдсэн бөгөөд тэдний хүн амын тоо зургаан сая гаруй байсан” хэмээн дурджээ. Цагаан чоно улсын хаан өөрийн улсын нэгэн найрагчаар “Цагаан чонын дуулал” хэмээх шүлгийг зохиолгон Зүүн Хань улсын эзэн хаанд өргөн барьж байжээ. Үүнээс үзэхэд цагаан чоно улс гэдэг бол Цуань Рунчуудын хожмын өөр нэрийдэл төдийгүй тэд нийтээрээ цагаан чоныг сүлдээ болгон дээдэлдэг байсан байх нь. Тэгэхээр Цуань Рунчуудын сүлд болгон тахидаг цагаан нохой нь уг чанартаа мөн л цагаан чоно байжээ гэж үзэх үндэслэлтэй.

Нөгөө талаар цагаан чоно биш цагаан нохой байлаа ч гэсэн одоогийн төвд банхартай адил талын чононоос өндөр сүрлэг зэрлэг догшин нохой байж болох биш үү? Би тал нутгийн нүүдэлчний түүхийг харьцангуй урт удаан хугацаанд судласан судлаачийн хувьд эртний Цуань Рунчууд шиг зэрлэг догшин үндэстэн жирийн нэг номхон дөлгөөн гэрийн тэжээвэр

нохойг өөрсдийн сүлд шүтээнээ болгоно гэж огт боддоггүй. Энэ нь тал нутгийг эртнээс нааш эзэгнэж ирсэн ганц ч нүүдэлчин морийг өөрсдийн сүлд шүтээнээ болгож байгаагүйтэй адил хэрэг юм. Учир нь тал нутгийн нүүдэлчид морийг өөрийн эрхэнд оруулан номхруулж чадсан болохоор омголон догшин нүүдэлчид нохой зэрэг бусад гэрийн тэжээвэр адгуустай адил тэднийг хичнээн хайрлаж дээдэлдэг ч гэсэн яахин өөрийн сүлд шүтээнээ болгох билээ? Сүлд гэдэг бол тал нутгийн нүүдэлчдийн оюун санааны ариун шүтээн байтал унаж эдлэж, зодож нүүддэг гэрийн тэжээвэр амьтад тэдний сүлд болох ямар ч үндэсгүй юм. Бид тал нутагт арав гаруй жил амьдрахдаа нүүдэлчдийн сэтгэл зүрхэнд чоно нохой хоёр ямархуу байр суурь эзлэдэгийг мэдэхээрээ нэг болсон. Нохой бол тэдний хайртай дотно, дайчин туслагч байдаг бол харин чоно тэдний сэтгэлд тэнгэрлиг амьтан гэсэн хүндтэй байр эзлэдэг.

Тийм болохоор би Цуань Рунчуудын шүтдэг байсан цагаан нохой нь цагаан чоно байсан гэдэг гаргалгааг хийхийн хамт тэд бол бичиг үсэгт анх тэмдэглэгдэн үлдсэн хамгийн эртний цагаан чонон сүлдтэй нүүдэлчин үндэстэн байжээ гэж баттай хэлэх гээд байгаа юм.

Чонон сүлдийн шүтлэг нь эртний Цуань Рун, Хүннү Хүнжөү, Цагаан чоно улс, Хүннү, Гаочө, Сяньби, Түрэг, Хятан зэрэг нүүдэлчин үндэстнүүдээр уламжилсаар өнөөгийн монгол үндэстэнд улаачлан иржээ. Баруун умард орон болон монголын хээр талд хүчирхэг нүүдэлчин үндэстнүүд дайн тулалдааны явцад нэг нэгийгээ даран сөнөөж өөрсдийн сүр хүчээ ээлжлэн тунхаглаж байсан боловч дэлхийн түүхэн дэх хамгийн өнө эртнийх болох чонон сүлд л өнө мөнх оршоор ирсэн байна. Энэхүү чонон сүлдийн соёл болон үзэл санаа нь зуун зууныг дамнасан түүхийн урсгалд тасраагүй хятадын газар тариалангийн соёлоос ч хавьгүй илүү урт он жилүүдийг туулан өнгөрөөжээ. Харамсалтай нь чонон сүлд хэмээх энэхүү оюуны нандин өв нь чононоос айж, түүнийг үзэн яддаг хятадуудад төдийлөн анхааран судлагдаж байгаагүй юм.

Дундадын нутагт ул мөр нь татраагүй энэхүү хоёр соёл иргэншлийн дотроос явж явж чонон сүлдийн соёл нь илүү амьдрах эрч хүчтэй, илүү үнэ цэнэтэй гэдэг хамгаас чухлыг дурьдах хэрэгтэй. Учир нь чонон сүлдийн үзэл болоод соёл байгаагүй бол хятадын хэдэн мянган жилийн түүхтэй газар тариалангийн соёл болон соёл иргэншил тасалдаж мэдэх байсан юм шүү. Дэлхийн дөрвөн том эртний соёл иргэншлийн дотроос ганцхан хятадын газар тариалангийн соёл иргэншил тасалдалгүй өдий хүрсэн нь гайхамшиг хэмээн тооцогддог, бол энэ гайхамшигийн цаадахь гайхамшиг нь түүнээс хавьгүй урт удаан жилийн түүхийн явцад огт амьдрах чадвараа хадгалсаар өдий хүрсэн чонон сүлдийн соёл мөн. Чонон сүлдийн ийнхүү баруун хойд орон болоод монголын хээр талд оршин байсан үй түмэн үндэстэн ястангуудын сүлд шүтээн байсаар ирсэний нууц нь талын чонын шүтэж дээдлэхээс аргагүй сүр хүч, оюун ухааны эзэмдэх чадалд байгаа юм. Энэхүү агуу дайчин чонон сүлдийн үзэл санаа нь нүүдэлчдийн оюун санааны гол цөм болоод зогсохгүй, зөвхөн хятадын соёл иргэншилд төдийгүй нийт дэлхий дахинд гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн билээ.

Маш урт удаан жилийн түүхтэй чонон сүлдийн шүтлэг нь амьдрах эрч хүч бүхий эртний болоод эдүгээгийн нүүдэлчин үндэстнүүдийн оюун санааны эх сурвалж мөн гэж би судлаачийн хувьд үзэж байна. Хятад нутагт ийм аугаа нандин, урт удаан жилийн түүхтэй баялаг оюун санааны өв хадгалагдсаар ирсэнд орчин цагийн хятад хүмүүс бахдан баярлах хэрэгтэй. Одоо түүнд нөмөргөсөн газар тариалангийн хонины арьсыг хуу татаж хаяад, чонон

сүлдийн үзэл санааны өнгө гэрэл, сүр хүчийг бадраах цаг иржээ. Тэр бол орчин цагийн хятад үндэстний зан араншинг хувирган өөрчлөх их ажлын хамгийн үнэтэй нандин оюун санааны эх булаг мөн. “Дорно зүгийн унтаж байгаа арслан” чонон сүлдийн үзэл санааг өвлөн авсанаар жинхэнээсээ сэргэж сэхэх нь гарцаагүй.

\* \* \*

“Уухайс, тун мундаг байна шүү” хэмээн уулга алдаад Ян Кө нэг лааз шар айргийг пүдхийтэл онгойлгон Чэнь Жэньд өгөв. Тэр өөр нэгийг задлан том балгаад “Чи ч аливаа юмыг ухаж төнхөхдөө цагаан цээжит азарган чоно үүрээ ухдагаас илүү хүн юм аа. Бүр байтлаа Янь Хуаны үе хүртэл ухаж төнхчихдөг байна шүү. Цуань Рунчуудын шүтэж байсан цагаан нохой нь цагаан чоно байсан гэдэг чиний саналыг би дэмжиж байна. Бид өнөө хэр Арслангаа бахдан дээдлэдэг байтал Цуань Рунчуудын шүтээн тэр нохой нь адаглаад л өнөөгийн төвд банхар шиг амьтан байсан байж таарна. Эс бөгөөс дорно зүгийн нүүдэлчин үндэстнүүд тийм их эрч хүч өөртөө агуулж байдгийг яахин ойлгох билээ дээ? Чиний үзэл бодолд би үнэхээр автаж гүйцээд байна. Цааш нь яриарай” гэв.

Нэг лааз шар айраг гүзээлээд урам зориг сэргэсэн Чэнь Жэнь биеэ цэхлэн завилж суугаад “Баруун Жоу улс мөхсөний дараа хавар намар болон байлдаанч улсын үе эхлэхэд хятад үндэстний өвөг дээдсээсээ өвлөн авсан эрэмгий дайчин чанарын гени багтай хадгалагдаж байсны дээр одоогийн Шаньси, Хөбэй зэрэг газар ихээхэн хэмжээний бэлчээр нутагт нүүдэлчин үндэстнүүд амьдарч байжээ. Түүнчлэн Хөбэйгийн Дин Сянь хошуунд Цагаан Хүннү нарын байгуулсан Жун Шань улс оршиж байсан. Хэдэн зуун жилийн түүхтэй Жуншань улсын ард иргэд эрэмгий дайчин зан чанартай бөгөөд тухайн үеийн Хань, Янь, Сүн<sup>63</sup> зэрэг улсуудтай зэрэгцэн оршиж байв. Тэд Янь улсын ихээхэн хэмжээний газар нутгийг булаан авч байснаас үзэхэд тухайн үеийн дотор газрын цөөнгүй хэсэгт чонын араншин ноёрхож байжээ. Түүнчлэн тухайн үеийн дотор газарт оршиж байсан улсууд байнга баруун умард зүгийн нүүдэлчдийн халдлага дайралтанд өртөн цус сэлбэгдэж байлаа. Тийм болохоор хавар намар болон байлдаанч улсын үед нийт хятад үндэстэнд чонын араншин нь давамгайлж, төвлөрсөн нэг засаглалын дор нэгдэж чадахааргүй хэмжээнд хүрчээ. Энэхүү галт уулын тэсрэлт мэт хатуу ширүүн цаг үе таван зуу гаруй жил үргэлжилсэн юм. Энэхүү цаг үед Күнз, Даозы, Мэзы болон цэргийн сурталтангууд үзэл суртлын тал дээр хоорондоо өрсөлдөж, тэр хэрээр соёлын бүтээн байгуулалтанд хувь нэмрээ оруулж байв. Энэ үед хятад үндэстэн үзэл санаа болон соёлын хувьд урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрсэн учраас хожим хэдэн ч удаа түүнийг сэргээхээр оролдоод амжилт олоогүй боловч бас ч үгүй чамгүй ололттой хоцорсоныг тэмдэглэх хэрэгтэй. Тан улсын Хань Юй болон Сүн улсын Оу Ян Сю, Сү Ши нарын хуучныг сэргээх оролдлогууд утга соёлын тавцанд гайхамшигтай үр дүнд хүрсэн нь энэ бүхнийг батлана. Улс төр эдийн засгийн хувьд хуучныг дууриах гэвэл ухралт болж уналтанд хүрдэгийг түүхэн сургамж бидэнд батлан харуулдаг. Харин оюун санаа зан чанарын хувьд хуучныг дууриаж байх хэрэгтэй. Өрнөдийн сэргэн мандлын үе бол агуу их амжилттай хуучныг дууриах үйл явц байсан шүү дээ.

Цин<sup>64</sup> улсын үе болоход Баруун Жоу улсаас тэс ондоо нөхцөл байдал үүсчээ. Цин улс нь баруун бүсэд оршиж байсан болохоор баруун умардын өргөн уудам бэлчээр нутгийг эзэмшихээс гадна, чамгүй их газар тариалан эрхэлдэг бүс нутагтай тул энэхүү үндэстний

ахуйн өвөрмөц суурин дээр бүрэлдэн тогтсон хонь чононы холимог үндэсний араншинтай байжээ. Дайчин давшингуй зан чанар нь өөрчлөлтийг шаргуу шаардах хүчирхэг хөдөлгөгч хүч, хүсэл зориг байдаг болохоор Цин улсын хууль журмын өөрчлөлт амжилт олсон бол газар тариаланг үйлдвэрлэлийн гол салбараа болгож, Жоу улсын ёсыг голлодог бусад зургаан ханлиг улсын үндэстний зан чанар доройтон ялзарч байв. Цин Ши Хуан хааны үед Цин улс дээрх зургаан улсыг нэгтгэн авч чадсан юм. Ингэснээр манай эриний өмнөх 221 онд Цин Ши Хуан хятадын түүхэн дэх анхны нэгдмэл улсыг байгуулжээ. Цин Ши Хуаний чоно мэт араншингийн эрхээр бичиг үсгийг нэгдсэн журамд оруулж, Күнзийн сурталтангуудыг хэдэн зуу мянгаар нь газарт булж, цагаан хэрмийг байгуулан, морьт цэргийг эмхлэж, Хүннү нартай дайтаж эхлэсэн юм. Хятадын түүхэн дэх анхны нэгдмэл төр улсыг Күнзийн сурталт хаан, вангуудын аль нэг нь байгуулаагүй, харин ч чонын зан араншинтай Цин Ши Хуан байгуулсаныг энд тэмдэглэх хэрэгтэй. Түүнчлэн чухам энэ үеэс эхлэн хятад үндэстний зан араншин хонь мэт номхрох чиг хандлага ажигдаж ирсэнийг дурьдахгүй өнгөрч болохгүй.

Хоёр зуу гаруй жил оршин тогтноод мөхсөн Цин улс хятадын түүхэнд асар гүн ул мөрийг үлдээсэн бөгөөд тэр дунд нүүдэлчдийн чонын араншин чухал үүрэгтэй байжээ. Хэрвээ Цин улсын эзэн хаан, иргэн албатуудын чонын араншин байгаагүй бол хятадын хожуу үеийн Хань, Тан улсын мандал цэцэглэлт ч мөн үгүй байх байлаа.

Цин улсын үед түүний хүрээлэлд багтаж байсан умард зүгийн нүүдэлчид мянган он жилийн турш газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх явцад суларч доройтсон хонины араншинтай цусыг шинэ эрч хүчээр сэлбэж өгчээ.

Манай эриний өмнөх 206 онд Лю Бан баруун Хань улсыг байгуулав. Баруун Хань улс Цингийн тогтолцоо болон чонын араншинг өвлөн авчээ. Хань улсын Ү Ди хаан зан араншингийн хувьд Цин Ши Хуанаас өөрцгүй нэгэн байсан гэж түүхчид тэмдэглэдэг. Тэр омголон дайнч зан араншинтай байсан болохоор улс орны нийт цэрэг зэвсэг, эд хөрөнгийг дайчлан Хүннүг устгахаас нааш санаа амрахгүй гэсэн тангараг хүртэл тавьж байлаа. Тухайн цаг үед үхэхийг үл бодон, дайтах талыг баримтлагсад хавьгүй давуу байсан нь эртний Цян үндэстний өвчилж үхэх муу ёр, дайны талбарт үхэх өлзий буянтай хэрэг гэж үздэг байсан үндэстний зан араншинг илтгэн харуулдаг. Хань улсын Ү Ди хаан Ли Гуан, Вэй Цин, Хуо Цю Бин зэрэг чонын араншин бүхий эрэлхэг жанжингуудыг ашиглан морьт цэргээр, морьт цэргийн эсрэг, харвалдан тулалдаж, тал нутгийн гүнд давшин ороод Хүннүчүүд лүгээ хэдэн арван жилийн турш дайтаж байсан түүхтэй. Ү Ди хаан тэр ч байтугай хамгаалалтын шинж чанартай цагаан хэрмийг тал нутгийг эдийн засгийн хувьд хавчин хяхах идэвхитэй арга хэрэглүүр болгон ашиглаж, төмөр эдлэл, зэр зэвсэг, эм тан зэргийг хил нэвтрүүлэхийг чанд хориглон, цаазыг зөрчсөн худалдаачдыг алах ялаар шийтгэж байлаа.

Тухайн цаг үед хүчээ аван сэргэсэн Күнзийн сурталтангууд газар тариаланг гол болгож энэрэлт засгийг байгуулах бодлогоороо хаан эзний хүндлэлийг хүртэж байр сууриа бататгаснаар харьцангуй урт удаан жил нийгмийн тогтвортой байдлыг буй болгож чадсан боловч үндэстний зан араншинг доройтуулахад гол хувь нэмрээ оруулжээ. Гэвч Хань улсын Ү Ди хаан Күнзийн суртлын үүргийг Цин Ши Хуанаас илүү сайн ойлгож байсан тул түүнийг өөрийн бодлогодоо сайтар захируулж чадсан байна. Тийм ч учраас баруун Хань улсын үед чоно, хонины араншин тэнцэж ирсэн юм. Баруун Хань улсын үед хятад үндэстэн зан

араншингийн хувьд Цин улсын зэрлэг чононоос Хань улсын соёлтой чоно болон хувирчээ. Тэр үеийн нутаг дэвсгэрийн цар хүрээ болон үндэстний зан араншингийн хувьд тухайн цагийн Ромын эзэнт гүрнээс нэг их дутахааргүй түвшинд хүрсэн юм. Нийт хятад үндэстэн нутаг дэвсгэрээ өргөтгөн, хүчирхэг дайсныг устгах тал дээр нэгдмэл хүсэл зорилготой байж чаддаг байжээ. Тэд одоогийн дундад ази зэрэг газрыг эзлэн авч Хүннүгийн эд баялгийн гол эх үүсвэрийг таслаад, хүчин чадлыг бууруулснаар дөрвөн зуу гаруй жилийн турш амар тайван, элбэг баян амьдрах боломжтой болжээ. Тийм ч учраас Их Хань улс бол хятад үндэстний хамгийн бахархууштай цаг үе яахын аргагүй мөн. Харамсалтай нь хожмын олон төр улсуудын үндэстний зан араншин дахин тийм өндөр түвшинд хүрч чадаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Түүнээс хойш хятад үндэстэн дангаараа өөрсдийн соёл иргэншлийн их асрыг олигтойхон авч явж хүчрэхээ больсон юм.

Хань улс болон түүний дараа тогтсон Жинь улс зэрэг нь хил орчмын бүс нутгийг тариалангийн зориулалтаар хагалах, нүүдэлчид рүү халдан довглох болон нутаг дэвсгэрээсээ тэднийг хөөн гаргах зэрэг арга хэмжээ авч байсан нь зүй ёсны ширүүн эсэргүүцэл тэмцэлтэй тулгарч эхлэжээ. Эцэстээ тал нутгийн нүүдэлчид хятадуудаас хариугаа авах хангалттай хүчийг хуралдуулж чадсан юм. Жинь улсын сүүлчээр Хүннү, Се, Ди, Цян болон Сяньби зэрэг тал нутгийн таван нүүдэлчин үндэстэн дотор газар руу дайран орж арван зургаан улсыг үүсгэсэн нь түүхэнд “Таван Ху65гийн арван зургаан улс” хэмээн нэрлэдэг. Цин, Хань улсаас хойш хэдэн зуун жилийн газар тариалан эрхлэх явцад хятад үндэстний зан чанар хонин хэв шинжийг олж дайтах үхэхээс үнхэлцгээ хагартал айдаг болсон тул ганц удаагийн дайралтыг тэсэлгүй ийнхүү ялагдсан нь тэр юм. Таван Ху буюу дээр дурьдсан нүүдэлчин үндэстэнгүүд хоттой хонин дунд орсон чоно шиг дураараа дургиж, дотор газрыг талын чонын тааваар зугаацах нутаг болгон хувиргасан нь 120 гаруй жилийн турш үргэлжилжээ. Энэ хугацаанд дотор газарт чонын араншин зонхилж, сүрэг чононууд хоорондоо уралцан, хүний хүүр хөдөө гадаагүй хөсөр хэвтэн, хүн амын тоо ч тэр хэрээр эрс цөөрсөн байна. Гэвч энэ удаагийн асар их гай гамшгийн дотоод шалтгаан нь газар тариалангийн соёлд хэт автан дайтах чадваргүй болсон үндэстний зан араншинд байсан нь тодорхой.

Манай эриний 386 онд байгуулагдсан Умард Вэй улсад чоно хонины араншин зохистой хольцолдсон байжээ. Тийм ч учраас би энэ улсын түүхийг онцгой их сонирхдог юм. Умард Вэй улсыг байгуулсан Сяньбичууд болон хожмын монгол үндэстэн бүгд Дунхуб6гийн бүрэлдхүүнд багтаж байсан болохоор хэлний гарал үүслийн хувьд ч нэгдмэл байдаг нь аргагүй. Сяньбичууд Их Хянганы нурууны умард үргэлжлэл болох Сяньби уулын орчимд анх нутаглаж байжээ. Монголын түүх судлалын нэрт эрдэмтэн, Юань улсын түүх судалгааны хүрээлэнгийн захирал агсан Хань Рү Лин авгай “Сяньбичууд бол монгол үндэстэн байсан” гэж багтай нотолдог билээ.

Бүр эрт Зүүн Хань улсын Хөди хааны үед Хань улсын нэрт жанжин Дөү Сянь Хүннүчүүдийг бутцохих үед Сяньбичууд тэдний нутгийг эзлэн сууж зуун хэдэн мянган Хүннү өрх айл тэдэнд дагаар орохын хамт өөрсдийн соёл, сүлд шүтээнийг ч уламжлан өгсөн байж таарна. Тэгэхээр Сяньбичууд бол Дунху болон Хүннү нарын дундаас төрөн гарсан үндэстэн байжээ. Сяньбигийн Тоба аймаг маш харгис түрэмгий боловч соёлын хувьд бичиг үсэг ч үгүй маш хоцрогдонгуй байлаа. Гэвч тэд монгол талын чонотой адилхан эрэмгий дайчин, хурц сийрэг толгойтой, дайн байлдааны гарамгай авьяастай үндэстэн байсан тул таван Ху нарын дунд

авьяас билгээрээ онцгой шалгарч байжээ. Ялангуяа Умард Вэйгийн Ү Ди хаан Тоба Тао азарган чоно мэт цэрэг дайныг удирдан зохион байгуулахдаа туйлын гарамгай нэгэн байсан гэдэг. Тэр арав хүрэхгүй жилийн хугацаанд Сяньбигийн морин цэргийг удирдан, сүрэг чоно мэт давхилдсаар умард хятадыг бүрэн эрхшээлдээ оруулж чаджээ. Ингэснээр Баруун Жоу улсаас хойш анх удаа нүүдэлчдийн хүчирхэг төр улс байгуулагдсан түүхтэй.

Сяньбигийн Тоба аймгийнхан тал нутгийн чонотой адилхан маш сийрэг толгойтой, аливааг амархан сурдаг тул хятадын соёлоос шимтэн суралцаж эхэлсэн нь нүүдэлчин үндэстнүүд шинийг сэдэж, хичээнгүй суралцдаг үндэстний зан араншинг батлан харуулсан юм. Тэр нь яваандаа даамжирсаар Фэн их дагина болон Сяо Вэнь Ди хааны үед бүх нийтээр хятад бичиг соёлд суралцан, хятадуудтай ураг барилдах бодлогыг явуулснаар бүрэн хятаджиж эхэлжээ. Хожим нэг сая Сяньбичууд Луоян хотноо суурьшихдаа бараг бүгд хятадаар ярьж, хятад хувцас өмсдөг болсон байсан гэдэг. Тэр ч байтугай өөрсдийн Сяньби овгоо хүртэл хятад овгоор сольчихсон тул өмнөд төрийн хятад элч ирчихээд нүүдэлчдийн улсад ирсэн эсэхдээ эргэлзэж байсан хэмээн түүхэн сурвалжуудад тэмдэглэсэн байдаг.

Тал нутгийн нүүдэлчид хятадын соёлд амархан уусдаг нь гүн гүнзгий учир холбогдолтойг энд тэмдэглэх хэрэгтэй.

Нэгдүгээрт хятад соёлд тэнгэрийг дээдлэн шүтдэг. Үнэн хэрэгтээ энэ заншил нь нүүдэлчдийн мөнх тэнгэрийг шүтэх үзлээс улбаатай юм. Тийм учраас хоёр соёл нь шүтлэгийн хувьд хоорондоо мөргөлдөөд байх зүйлгүй.

Хоёрдугаарт түрүү үеийн Күнзийн суртхаал нь авгай өөрийгөө ямагт хүчирхэгжүүлэн боловсруулмуй, баян чинээлэг ахуйд ужидлаж болохгүй, ядуу буурай байлаа ч гуйвж дайвж болохгүй гэх зэрэг дайчин давшингуй үзлийг номлодог байсан нь нүүдэлчдийн чонон сүлдийн соёлын үзэл санаатай нийцэж байгаа юм.

Гуравдугаарт Күнзийн суртхаал нь тэнгэрийн хүүгийн эрх ашгийг дээдлэн хамгаалдаг нь тэдний хүсэл сонирхолд нийцэж байдаг байна. Гэхдээ Сяньби, Монгол, Манж зэрэг үндэстэнгүүд хятадын соёл дахь дутагдалтай зүйлсийг олж хараад нүүдлийн соёлын зарим элементүүдийг түүнд шингээн оруулсан байдаг.

Нүүдэлчид зэвсгийн хүчээр хятад нутгийг эзлэн авдаг байсан боловч хятад үндэстэн тэднийг өөрсдийн соёлоор эрхшээлдээ оруулчихдаг гэж үзэх уламжлалт ойлголт нь үнэн хэрэг дээрээ их Ханьгийн үндэсний үзлийн илрэл төдийхөн юм гэдгийг энд хэлэх хэрэгтэй. Энэ үзлийн хамгийн том алдаа нь хятадын тариалангийн газар нутгийн уусгах үүрэг хэмээх соёлын бус хүчин зүйлсийг үгүйсгэж байгаад оршино. Хятадын асар өргөн тариалангийн газар нутаг нь ямар ч хүчирхэг нүүдэлчдийг өөртөө уусган шингээх чадвартай нь соёлын хүчин зүйлсээс хавьгүй илүү байдаг ажээ. Нүүдэлчин үндэстнүүд хятад соёлын нөлөөнд уусан шингэдэг хэмээх үзлийн өрөөсгөл тал нь бас хятадын соёл дахь нүүдлийн соёлын ул мөрийг үгүйсгэж байгаад оршино.

Сяньби Тобачуудын өөрчлөлт шинэчлэл амжилттай болсноор Умард Вэй улс улс төрийн хувьд тогтвортой, эдийн засаг цэцэглэн хөгжиж, хүн ам эрс өссөнөөр дорно дахины том улсын хэв шинжийг олж чаджээ. Түүнчлэн Сяньбигийн хөгжингүй соёл, Буддын шашны дэлгэрэл

зэргийг өнөө хэр бид бүхэн Юнь Ган, Лун Мэнь Шань уулын энгэрт сийлсэн Бурханы чулуун хөргүүдээс харж болно. Энэ бүх ололтыг харанхуй мунхаг, дотоодын үймээн самуунд автсан өмнөд төрийн Хань үндэстний улстай жиших ч юм биш. Өнөөгийн хятад хүмүүс суу алдраа дуурсгасан Умард Вэй улсыг маш сайн мэддэг хэр нь хань үндэстэн зонхилсон өмнөд төрийн Сүн улс, Ци улс зэргийн тухайд бараг дуулаагүй байх нь олонтоо. Умард Вэй улс болон Өмнөд төрийн энэ мэт илэрхий ялгаа зөрүү нь хятадын газар тариалангийн соёл болон үндэстний зан чанар дахь хонины араншин илт ялгаран харагдаж эхэлсэнийг батлаж байгаа юм. Нүүдэлчид үндэстний эв нэгдлээ бататган олдсон боломжийг ашиглангуут дотор газар эзэн суугаад хэдхэн үе өнгөрөх хооронд хятад үндэстний хэдэн мянган жилийг зарцуулан байж бүтээсэн соёлыг гартаа оруулахаар үл барам бүтэн толгой илүү гараад явчихаж чаддаг. Харин дайчин давшингуй үзэл дутмаг Хань үндэстэн хэдийгээр соёлын хувьд нүүдэлчдээс илүү боловч байн байн цус сэлбүүлсэний хүчинд өдий зэрэгтэй оршин тогтносоор иржээ. Хэрвээ хэдэн зуун жил алгасаад нэг удаа чонын араншинтай цусаар сэлбэгдэж байхгүй бол түүний сийрэгжиж гүйцсэн яс нь хятадын соёл иргэншлийн агуу том асрыг тулж тогтоох арга мөхөсддөг байна. Таван зуун жил тутамд ван өөрийн эрхгүй тодрон гарна гэсэн эртний үг байдаг. Үнэн хэрэг дээрээ тэр ван хэмээгч нь нүүдэлчний зан чанар болоод үзэл санаа юм л даа. Бүр тодруулбал тэр ванд нүүдэлчний зан чанар, оюун санаа цогцолсон байдаг.

Сяньбичууд умард хятадыг 140 гаруй жил эрхшээлдээ байлгах зуур тариачин үндэстний цусыг сайтар сэлбэж өгсөний ач холбогдол үүрэг нөлөө нь маш их байжээ. Миний цус сэлбэлт гэж хэлээд байгааг хоёр утгаар ойлгож болно. Нэгдүгээрт нүүдэлчид дотор газрыг эзлэн суусны дараа тэдний үзэл санаа, зан араншин тариачин үндэстэнд маш том нөлөө үзүүлж ирсэн. Нөгөөтэйгүүр хоорондоо ураг барилдан цус холилдсоноор цоо шинэ зан араншин бүхий бүлэг хүмүүс буй болж байжээ. Таван бүдүүлгүүд дотор газрыг эзэгнэн суусаар урьд хожид байгаагүй үймээн самуун дэгдэж, нийслэл Луоян хот тэр аяараа шатаад, хятад орон цусаар бялдсан тул Хань үндэстэн хүн амын жар далаад хувь нь Хөх мөрний өмнө зүгт дүрвэн дутаасан байна. Умард хятадад хань үндэстэнгүүд ийнхүү цөөрсөний дараа умард зүгээс Сяньби голдуу нүүдэлчин үндэстнүүд нүүн ирж тэдний зайг бөглөн суух болжээ. Арван зургаан улс болон нийт Умард төрийн ноёрхлын 260 гаруй жилийн түүхийн явцад Сяньбигийн язгууртнууд олон арван татвар эмс авч цус сэлбэж байсны үр дүнд хань үндэстэн болон нүүдэлчдийн тоо толгой ойролцоо түвшинд хүрч ирсэн байдаг.

Энэхүү цус сэлбэлтийн үр дүнд умард нутгийн хятадын тариачин үндэстнүүд оюун санаа болон зан араншингийн хувьд дахин сэргэж хүчирхэгжих хандлагатай болж иржээ. Нүүдэлчдийн энэхүү цус сэлбэлт нь тариачин үндэстний хувьд хичнээн зовиуртай, ичгүүртэй хэрэг боловч “Хятад өвчнийг анагаах” хамгийн үр дүнтэй, зайлшгүй эмчилгээний арга болохыг тэмдэглэх хэрэгтэй. Хэрвээ энэ бүх цус сэлбэлтийн үйл явц байгаагүй бол хожмын агуу их Сүй, Тан улсууд төрөн гарахгүй байх нь тодорхой юм.

Хожим нь Умард Вэй улс Зүүн Вэй, Баруун Вэй хэмээн хоёр хуваагдахад мөн л Сяньбичууд төрийн эрхийг атгаж байлаа. Манай эриний 550 онд Гао Ян Зүүн Вэй улсыг устгаж өөрийгөө эзэн хаанаар өргөмжлөн Умард Ци улсыг байгуулсан. 556 онд Юй Вэнь Зюэ нэрт Сяньби хүн Баруун Вэйг устган Умард Жоу улсыг байгуулжээ. Энэ хоёр улсын төрийн эрхийг мөн л Сяньбичууд атгаж байсныг хэлэх хэрэгтэй. Жоу улсын Ү Ди хааны үед Сяньби үндэстний шалгарсан хаан Юй Вэнь Юн умард Ци улсыг байлдан эзлэснээр умард хятадыг дахин



нэгтгэсэн байна.

Манай эриний 581 онд умард Жоугийн их чансан Ян Зянь, Жоу улсын Жин Ди хааныг ширээнээс нь огцруулж, Сяньби гаралтай умард Жоу улсын оронд Сүй хэмээх шинэ төр улсыг тунхаглан зарлаад өөрийгөө Сүй улсын Вэнь Ди хаанд өргөмжилжээ. Тийм болохоор Сүй улс нь Сяньби нарын улсын суурин дээр байгуулагдсан юм. Нөгөө талаар Сүй улс нь үнэн хэрэг дээрээ 260 гаруй жилийн турш таван нүүдэлчин үндэстэн тасралтгүй цус сэлбэлтээс үүссэн нүүдэлчид болон хань үндэстний холимог шинжийг агуулж байлаа. Гэсэн хэдий ч засаг төрийн толгойд Сяньбичууд тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээр үлдэж чаджээ. Тэр ч байтугай Сүй улсын Вэнь Ди хааны хатан нь Сяньби үндэстэн байжээ. Тэгэхээр Сүй улсад засгийн эрхийн хуваарилалт болон үндэстний бүрэлдхүүний хувьд Сяньбичууд зонхилж байлаа гэж үзэх бүрэн боломжтой. Сүй улсын Вэнь Ди хааны үед хятад үндэстэн зан чанарын хувьд омголон дайчин, хөгжингүй соёлтой, чоно хонины араншин тэнцсэн цаг үе байсан юм.

Тийм ч учраас Сүй улсын үед тариан талбайг тэгш хуваарилж, суваг шуудуу татан, төрийн сайд түшмэдүүдийг эрдэм чадлаар нь сонгон шалгаруулах тогтолцоог анх хэрэгжүүлж чаджээ. Энэ үед түрэгийн дөрвөн зуун мянган морьт цэргийн хүчийг бутцохиж, өмнөд хятадыг эзлэснээр хоёр зуу гаруй жилийн тархай бутархай байдлыг эцэс болгожээ.

Умард хятад нүүдэлчдийн түрэмгийлэлд өртөн үймээн самууны хөлд дарагдаад байсан болохоор хүчин чадлын хувьд тийм аюулыг амсаагүй өмнөд нутгаасаа сул дорой байх ёстойсон. Гэтэл хэрэг явдал шал эсрэгээр эргэж удаж төдөлгүй умард нь өмнөдийгөө өөртөө нэгтгэж чадсан билээ.

Үүнээс хойш хятадын түүхэнд нэгэн шинэ жишиг тогтсон нь нүүдэлчдийн довтолгоонд өртөн тэднээр цус сэлбүүлж чадсан умард нутаг хичнээн их гай гамшиг амслаа ч олонхидоо өмнөдийн засгийн эрхийг байлдан авч чаддаг байлаа. Харин өмнөдийн Хань үндэстний засгийн эрх умардынханд амархан түлхэгдэн унасаар иржээ. Энэ байдал бүр эртний Цинши Хуаний үеэс эхтэй бөгөөд хожим Юань улс өмнөд Сүнг мөхөөсөн, Манж Цин улс өмнөд Минг сөнөөн дарсан зэрэг нь нүүдэлчдийн зан араншин тариачин үндэстний зан араншингаас хавьгүй хүчтэй юм шүү гэдгийг харуулаад байнам биш үү? Тэгэхээр аливаа хүчирхэг үндэстний зан араншин гэдэг бол бусад үндэстнүүдийн хүрээлэл дунд оршин тогтнох шийдвэрлэх хүчин зүйл болж байдаг байна. Цэвэр газар тариалан эрхлэх болсон өмнөд хятад Янь Хуаний үеэс үлдэж хоцорсон нүүдэлчний оюун санааг бүрмөсөн алдаж, нүүдэлчдийн цус сэлбэх боломж үгүй болсноор хэдийгээр хөгжингүй соёл, хүчирхэг эдийн засагтай боловч өөрийн улсын тусгаар байдлыг хамгаалах хүч тэнхээгүй болсон нь харагддаг” хэмээн ярьлаа.

\* \* \*

Чэнь Жэнь чонын үүр рүү хяламхийн харсанаа уртаар санаа алдаад “Гэвч Сүй улс богинохон настай байсан нь чоно хонины тэнцвэр алдагдсанаас болсон юм. Өөрөөр хэлбэл Сүй улсын ноёрхогч бүлэглэлийн чонын араншин хэт давамгайлж эхэлжээ. Сүй улсын Ян Ди хаан үнэн хэрэг дээрээ Сяньби болон хань үндэстний цус холилдсон эрлийз хүн байсан гэдэг. Түүний төрүүлсэн эх Дүгү хатан бол Вэнь Ди хаан өөрөө ч жийрхдэг айхтар Сяньби эмэгтэй байжээ.

Тэр Вэньди хааны таалсан татвар эмсийг санаан зоргоор алчихдаг байснаас ямархуу эрх сүртэй байсныг ойлгож болно. Ямар сайндаа л Тан улсын үеийн Ү Зө Тянь хатан хаан түүнийг өөрийн даган дууриах үлгэр жишээ болгож байх билээ дээ. Тийм болохоор Сүй улсын Ян Ди хаан нь чонын сүү хөхөж өссөн чоно байжээ гэж хэлэх бүрэн үндэстэй юм. Тэр ард түмнээ амар заяа үзүүлдэггүй харгис хэрцгий нэгэн байсан тул Солонгос руу хэдэн сая цэрэг хөдөлгөн дайтаад ялагдсанаар үл барам улсынхаа сан хөмрөгийг хоослосон тул олон газар бослого самуун дэгдэж эцэст нь нүүдэлчдийн цусны хольц бүхий том язгууртан Ли Юань, Тан улсыг байгуулсан түүхтэй.

Хятадуудын бахархан дурсах дуртай Тан улс үнэн хэрэг дээрээ бас л Сяньби болон Хань үндэстнүүдийн хамтран байгуулсан талын чонын араншин, хятадын соёлын охь дээж холилдсон төр улс байсан юм шүү дээ. Энэ үеийг өнөө хэр хятадын соёл иргэншлийн ноён оргил байсан гэж дурсацгаадаг. Тан улсын түрүү үеийн хаадууд бүгд Сяньби цусны хольцтой эрлийзүүд байжээ. Тан улсын Гао Зү хаан Ли Юаний төрсөн эх, хатан, бэр нь бүгд Сяньбичууд байсан гэдэг. Тэгвэл Тан улсын Тайзун хаан Ли Ши Миний эмэг эх, төрсөн эх болон хатад нь цөм Сяньби үндэстэн байсныг чи мэдэх үү? Хэдэн үеийн турш цус холилдож, Сяньбичуудын чонын араншинг өвлөн авсанаар Тан улсын хаадын цусан дахь хань үндэстний хувь хэмжээ дөрөвний нэгээс доош хэмжээнд хүрч, цус холилдсоны давамгайл байдал тод томруун харагддаг юм. Ялангуяа Тайзун хаан Ли Ши Миний дайчин эрэмгий чонын араншин хятадын хаадуудад дахин давтагдашгүй гэж хэлж болно. Ямар сайндаа л Ли Ши Миний хүү хунтайз Чэн Цянь түрэг хэл сурч, түргийн хоол ундыг таашаан, чонон сүлдэт тугийг мандуулан хэзээ нэгэн цагт тал нутагт очин түрэг хүн болох мөрөөдөлтэй байх билээ дээ. Энэ хэт туйлширсан хандлагаас нь болоод түүний хаан ширээ залгамжлах эрхийг хассан гэдэг. Гол нь энэ жишээ бидэнд Тан улсын хаадын дунд нүүдэлчний соёлын хүч нөлөө хэр зэрэг их байсныг харуулж байна.

Бас хятадын анхны бөгөөд цорын ганц хатан хаан Ү Зө Тянь Сяньби үндэстэнгүүд олноор суурьшдаг байсан Шаньсигаас гаралтай гэдгийг хэлэх хэрэгтэй. Сяньбичүүдийн нийслэл хот Пин Чэн Шаньсид байжээ. Ү Зө Тяний эцэг Ли Юань хааныг дагалдан Сүй улсын эсрэг бослогод оролцож байсан гэдэг. Ү Зө Тяний үйл ажиллагаанаас харахад чоно мэт араншин, ухаалаг, зоримог чанар илт ажиглагддаг. Түүний хүчинд Тан улсын хүчирхэг байдлыг хагас зуун жил гаруй үргэлжлүүлж чадсан юм” гэснээ Чэнь Жэнь “Чи Ү Зө Тяний төрх байдлыг сайтар ажиглаж үзсэн үү?” хэмээн Ян Көгөөс асуулаа.

“Үгүй ээ, харин чи юу олж ажиглаа вэ?” хэмээн Ян Кө гайхасхийн асуув.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Би түүний хөргийг харахад махлаг мариалаг их буянтай хүний төрх байдал харагддаг юм. Тан улсын үед хятадууд мах мариа сайтайг гоо сайхны дээд хэмжүүр хэмээн үздэг байсан шүү дээ. Хэдэн ч үеийн Тан улсын хаадууд мах мариа сайтай эмэгтэйчүүдийг сонгон хатан болон татвар эмс болгодог байсан нь хятадын уламжлалаас тэс ондоо байгааг ажиглав уу? Ямар сайндаа л Чү улсын хаан нарийхан бэлхүүстэй охидуудад дуртай байснаас болоод татвар эмс нь хоолоо сойсоор өлсөж үхэх тохиолдол олонтаа гардаг байсан байв гэж. Хань улсын Чэнди хааны эрхэм татвар Жао Янь Фэй нарийхан бэлхүүснийхээ хүчээр их хатанд өргөмжлөгдөж байсан удаатай.

Өөр өөр цаг үеийн түүхэнд нэр алдар нь ижил хэмжээнд дуурьсаж байсан энэ хоёр том гүрэн

яахаараа гоо сайхны таашаалын хувьд ийм тэс ондоо байдаг билээ гэдгийн гол шалтгаан нь Тан улсын хааны ордныхон угсаа гарлын хувьд хятадын бусад хаадаас тэс ондоо байсанд байгаа юм. Тан улсын хаадын олонх нь Сяньби гаралтай буюу ямар нэгэн байдлаар цусан төрлийн холбоотой байжээ. Би урьд төрийн хаадууд яахаараа туранхай хүүхнүүдийг таашаадаг байснаа Тан улсын үед гэнэт мариалаг бүсгүйчүүд моодонд ордог билээ гэдгийн учрыг ерөөсөө олж чаддаггүй байсан юм. Дараа нь Тангийн хаадууд Сяньби цустайд хамаг учир оршиж байгааг олж мэдсэнээр үл барам хожим тал нутагт ирсэн хойно миний таамаглал бүрэн батлагдаж билээ. Бид нар анх тал нутагт ирэнгүүт монгол малчид мариалаг хүүхнийг сайхан гэлцдэг болохыг олж мэдсэн шүү дээ. Биднийг илгээлтээр ирэх үед хоёрдугаар багийн хамгийн үзэсгэлэнтэй согоо гэгддэг Наранцэцэг нэрт хүүхэн л гэхэд мах мариа тэнцсэн сайхан амьтан байсан даг. Тэр лав Ян Гүй Фэйгээс 67 ч илүү мариалаг байсан байх аа. Багийн бүх л адуучид түүнд нүдээ унагах шахдагсан. Одоо эргээд санахад Олонбулгийн талын хамаг сайхан хүүхнүүд бүгд мариалаг бүсгүйчүүд байсан. Тэгээд ч Сяньби болон Монголчууд бүгд цусан төрлийн холбоотой тал нутгийн нүүдэлчид шүү дээ. Сяньбичууд лавтайяа өөрсдийн чонон сүлд болон мах мариаг гоо сайхны хэмжүүр болгодог уламжлалыг монголчуудад өвлүүлэн үлдээсэн байж таарна. Нүүдэлчид эртнээс нааш том тарган хонийг гоо сайхны дээд хэмээн тооцож байсан тухай би ярианыхаа эхэнд өгүүлсэн. ” гэхэд

Ян Кө толгой сэгсрэн инээгээд “Жаахан алсуур тойроод явчихаагүй бол ч мөн айхтар онож байна шүү” гэв.

“Алсуур тойрсон юм огт байхгүй ээ. Тан улсын хаад мах мариаг дээдлэдэг байсан нь гоо сайхны түвшинд Тан улсын аугаа хүчирхэг зан араншингийн эх сурвалжийг батлан харуулж байгаа юм. Хятадууд Тан улсын нүүдэлчний оюун санаа болон тал нутгийнхантай цусан төрлийн холбоотой байснаас тувт зайлсхийж ирсэн нь хятадын түүхэн дэх хамгийн аугаа том төр улсын байгуулсан дийлэнх гавьяаг тал нутгийн нүүдэлчдийн дансанд тэмдэглүүлчихгүй гэсэндээ тэр юм. . . . .

Ли Ши Минь түшмэдийн шалгаруулалтыг боловсронгуй болгож, боловсролыг дээдлэн, татварыг багасгаж, эдийн засгийг урамшуулж байснаар улс орон дэгжин хөгжиж газар нутгийн хувьд урьд өмнө байгаагүй өргөн уудам орон зайг эзлэх болсон билээ.

Ли Ши Минь хятад болон харь нүүдэлчдийн тэгш эрхийг тунхагласан анхны хаан гэдгийг энд тэмдэглэх хэрэгтэй. Тэр өгүүлэхдээ: Эртний хаадууд бүгд хятадыг дээдлэн харь нүүдэлчдийг гадуурхсаар ирсэн бол би тэднийг ч мөн адил энэрэн хайрлахаа тунхаглаж байна гэсэн байдаг. Өөрийн судсаар нүүдэлчний цус урсаж байгаа хүн хонь чононы араншин тэнцэж ирсэн нөхцөлд ийм бодлого дэвшүүлнэ гэдэг нь ойлгомжтой. Ли Ши Минээс урьд болон хожуу үеийн хятадын күнзийн сурталтангууд хятадыг дээдлэн нүүдэлчдийг ад шоо үздэг байсан тул нүүдэлчдийн оюун санаа болон тэдний зан араншинд байгаа асар их үнэ цэнэ болон түүний хятадын соёл иргэншилд оруулсан амь насны үнэ цэнэтэй дүйцэхүйц хувь нэмрийг ойшоолгүй ирсэнээр үл барам энэхүү чонын зан араншинг Күнзийн суртхаалтан бүгд дайралтынхаа гол бай болгож байжээ. Харин нүүдэлчний цустай Ли Ши Минь хаан л гагцхүү Хань үндэстэн болон тал нутгийн нүүдэлчдийн давуу болон дутагдалтай талуудыг хурц соргогоор ажиглан олж харж чадсан төдийгүй өөрийн биеэр хятад, нүүдэлчид гэлтгүй бүгд тэгш эрхтэй байх бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тан улс эртний хятадын соёлын

иргэншлийн ноён оргилд хүрч чадсаны үндсэн шалтгаан нь тал нутгийн нүүдэлчдийн дайчин давшингуй зан араншинг хятадын Күнзийн суртхаалын охь шимтэй бүрэн төгс хослуулж чадсанд байгаа юм. Харамсалтай нь хятадын тариачны соёлын хөрс суурь дэндүү гүн зузаан тул хятад болон нүүдэлчид тэгш эрхтэй байх Ли Ши Миний бодлогыг хятадын тариачны ухамсарт идэгдэж гүйцсэн Күнзийн суртхаалтангууд таягдан хаясан билээ. Хожим хойно ч гэсэн хятад үндэстэнг сэхээ оруулах цус сэлбэлтийг тал нутгийн нүүдэлчид явуулсаар байжээ. Гэвч газар тариалангийн соёлоос үүдэлтэй хятад өвчин үгдрэн даамжирсаны харгайгаар яаж ч хүчтэй цус сэлбэлт явууллаа гэсэн Хань, Тан улсын үндэстний хүчирхэг зан төлөв бүрэлдэж чадахаа байжээ. Ингэснээр дорно зүгийн унтаж байгаа арслан Тан улсын дунд үеэс эхлэн жинхэнэ урт удаан хугацааны унтаа төлөв байдалд шилжсэн бөгөөд хятадын өргөн уудам газар тариалангийн соёл түүний тайван нойрсох ор болон хувирчээ. Харин Күнзийн суртхаал түүнийг сэрэлгүй унтуулах ховс буюу нойрны эм байсаар ирсэн юм. Түүнээс хойш хятад үндэстэн ганц нэг удаагийн бага зэрэг сэргэлтийг эс тооцвол улам бүр уруудан доройтох шатаар эргэлт буцалтгүй гулсжээ” хэмээн ярив.

\* \* \*

Чэнь Жэнь цааш залгуулан өгүүллрүүн “Танг залган гарч ирсэн Сүн улс бол хятад үндэстний зан араншингийн хувирлын үетэй давхцдаг юм.

Юуны өмнө Сүн улс Хань, Тангийн үеийн нүүдэлчдийн өргөн уудам нутаг дэвсгэрийг тогтоох чадалгүй болсон байв. Бид хэдийгээр Их Сүн улс л гээд байдаг боловч үнэн хэрэг дээрээ нутаг дэвсгэрийн хувьд Хань, Тангийн үеийн хагаст ч хүрэхээргүй хумигдсан байжээ. Түүний умард талд одоогийн хятадын умард нутаг болон Монголын уудам талыг тэр чигээр нь эзэгнэсэн хүчирхэг Хятан улс оршиж байв. Харин баруун талаараа Тангуд болон Цян үндэстний Турфан улсуудтай хиллэж байжээ. Тэгвэл баруун өмнө талаараа Дали улстай хил залгаж байсан нь тун ашиггүй нөхцөл байдлыг үүсгэсэн юм. Өөрөөр хэлбэл хүчгүй сул дорой Сүн улсын эрх баригчид хятадын чонон цусыг сэлбэгч гол эх булаг болсон баруун умардын тал нутгийг өөрийн хяналтаасаа алдаж орхижээ. Ингэснээр хятад үндэстний зан чанар улам суларч доройтох үндсэн шалтгаан болсон байна.

Дээр нь Күнзийн суртхаалын том мод Сүн улсын газар тариалангийн соёлын шимтэй хөрсөнд улам бахим өндөр болон ургах болжээ. Хамгийн хорлонтой нь тэд хүмүүний хүслийг бөхөөвөөс тэнгэрийн ёсон үлдмүй гэж номлох болсонд байгаа юм. Тэнгэрийн ёсон гэдэг нь гурван хэлхээ таван ашид бөгөөд түүгээр дамжуулан хүмүүний хүслийг бөхөөх тухай сургаал юм л даа. Ингэж номлож байгаа улстай чонын араншин энэ тэрийн тухай юу ярих билээ? Күнзийн суртхаалтангууд чухам тэр үед хятад үндэстнийг хонь үхэр мэт номхруулж чадсанаар үйлдвэрлэх хүчин түргэн хурдацтай хөгжиж, тухайн цаг үед дэлхий дээрх хамгийн дэвшилттэй зэр зэвсэг болох галт зэвсэг, гунан буу, галт ямаан зангуу зэргийг зохион бүтээж чадсан ажээ. Гэвч тэр бүхэн нь хятад үндэстний хонины араншингийн сул талуудыг нөхөж чадаагүй юм.

Аливаа нэг үндэстэн сэргэн мандья гэвээс гагцхүү үйлдвэрлэх хүчинг хөгжүүлнэ гэдэг үндсийн үндэс байж чаддаггүйг дэлхийн түүх батлан харуулж байна. Түүний зэрэгцээ хүчирхэг, дайчин давшингуй үндэстний зан чанарыг зэрэг төлөвшүүлэх хэрэгтэй юм. Тэгж чадсан цагт тухайн үндэстэн тэнгэр огторгуйд дэвэн нисэх хос далавчтай болж чаддаг ажгуу.

Чухам Сүн улсын үед хятад үндэстэн Хань, Тан улсын соёлтой чоно байсантай харьцуулбал сул дорой соёлтой хоньд болон хувирсан юм.

Гэсэн хэдий боловч Умард Сүн улс 160 гаруй жилийн харьцангуй тогтвортой цэцэглэлтийн үеийг туулж чаджээ. Энэ нь өөрсдөө хүчирхэг байсан гэсэн хэрэг огт биш, харин түүний Умардын хүчирхэг дайсан болох Хятанчууд үндэстний зан чанарын хувьд томоохон өөрчлөлттэй тулгарсанд байгаа юм. Хятанчууд Сүн улс байгуулагдахаас арван хэдэн жилийн өмнө хятадын умард нутгийн арван хэдэн газар тариалангийн мужийг эрхшээлдээ оруулж авчээ. Түүнээс хойш тэдний газар тариалан эрчимтэй хөгжиж зүүн хойд орны хар шороот хөрсийг хүртэл хамрах болсон байна. Тэр хэрээр олон тооны малчид газар тариалангийн үйлдвэрлэл рүү шилжих болсноор цэвэр нүүдэлчдийн улс газар тариалан давамгайлсан мал аж ахуйн орон болон хувирчээ. Газар тариалан үндэстний зан чанарыг доройтуулдаг хатуу зүй тогтлын дагуу Хятанчуудын чонын араншин зөөлөрч эхэлсэн байна. Хятангийн Сяо эх дагины үед Сүн улс тэдэнд жил болгон хүнд алба гувчуур барьдаг болсоноор хоёр талын дайн тулалдаан намжиж аль аль тал нь хөгжин цэцэглэж ирсэн юм.

Гэвч хонь амар жимэр байя гэвч чоно зүгээр суулгадаггүй зүй тогтол дэлхийн түүхийг жолоодсоор ирсэн билээ. Хятан улсад газар тариалан улам бүр цэцэглэн хөгжиж байх үед Сунгаар мөрний сав газарт Зөрчдүүд хүчээ авч эхэлжээ. Хятангийн хүнд дарлалд нэрвэгдэж байсан Зөрчидийн удирдагч Вангин Агуда хүчирхэг морин цэргүүдээ удирдан Хятан улс руу халдан довлоод маш богино хугацааны дотор ихэнх газар нутгийг эрхшээлдээ оруулж Алтан улсыг байгуулжээ. Тэд нийтдээ хорин жилийн хугацаанд Хятан улсыг бүрмөсөн мөхөөж чадсан юм. Хонь чонын араншин хослосон Хятан улс хүртэл чонын араншин бүхий Зөрчдүүдийн өмнө хүчин мөхөстөж байхад соёлтой хонь болон хувирсан Умард Сүн улс тэдний өмнө яаж чадах билээ дээ?

Жинь улсын Тайзун хаан азарган чонын хурц соргог ухаанаар Сүн улсын хонины араншинг тогтоож чадсан байв. Алтан улсын цэрэг Хятан улсыг мөхөөгөөд амсхийх завдал өгөлгүй Хөх мөрнийг гатлан давшихад Сүн улсын Хүй Зун хаан айн бэмбэгэнэж хаан ширээгээ өөрийн хөвгүүн Жао Хуаньд найр талбин өгчээ. Энэ хоёр бол хятадын түүхэн дэх хамгийн олхиогүй хаадууд байсан юм. Удаах онд Алтан улсын цэргүүд дахин Сүн улс руу довтолж ёстой л хоттой хонин дунд орсон чоно мэт аяглахад Сүнгийн цэргүүд чоно харсан хонь шиг үргээд бажгадан зугатацгаажээ. Кайфэн хот хаалгаа дэлгэх нь холгүй бууж өгөөд хөгшин залуу хоёр хаан, хэдэн мянган гоо хатад эмсийнхээ хамтаар олзлогдсон түүхтэй. Тухайн үед дэлхийн хамгийн олон хүн амтай, хүчирхэг эдийн засагтай, галт зэвсэг болон цэргийн урлагийн сор бүтээл болсон Сүнзийн дайтах арга номтой умард Сүн улс дайсныхаа бараа сүрээр ялагдан хоёрхон жилийн дотор мөхсөн гээд бод доо. Өөрөөр хэлбэл Сүн улсад байхгүй юм үгүй, гагцхүү үндэстний оршин тогтнох нуруу нугас болсон хатуу чанга зан чанар л үгүйлэгдэж байжээ. Аливаа нэгэн үндэстэн хүчирхэг зан чанар төлөвшүүлэхийг улсын үндсэн бодлого болгож байхгүй бол эдийн засаг соёл хичнээн хүчирхэг, хүн ам цэрэг зэвсэг олонтой байлаа ч эцэс сүүлдээ Умард Сүн улсын замаар орно шүү гэдгийг байнга бодож байх хэрэгтэй юм.

Азаар Хятад улс тухайн үеийн Христ болон Лалын соёл иргэншлээс хол байсан нь яамай даа. Хэрвээ Алтан улсын цэргүүд өндөр соёл иргэншил бүхий арми байсан бол хятад үндэстэн өдийд бичиг, соёл, нэр овог, шашин шүтлэгээ хүртэл сольчихсон байж мэдэх л юм. Дундад

ази урьд нь Буддын шүтлэгтэй байснаа хүчирхэг Лалын эзлэн түрэмгийллийн дор шашин соёлоо өөрчилсөн гэдэг биз дээ?

Газар тариалангийн үйлдвэрлэл өсөн нэмэгдэж боловсронгуй болохын хэрээр Хятад үндэстний зан чанар өдөр ирэх тусам сулран доройтсоор, өргөн уудам нутаг дэвсгэрээ алдсаар байлаа. Хятадын нийслэл анх нүүдэлчдийн нутаг дэвсгэрээс холгүй баруун умард зүгт байснаа зүүн өмнө зүгт шилжин, улам бүр урагшлан нүүхийн хэрээр үндэстний зан араншин улам доройтон ялзарч байжээ. Цин, Хань, Сүй, Тангийн үеийн нийслэл Чан Ань, Зүүн Хань, Жинь улсын Луоян руу нүүсэн. Тэгсэнээ Умард Сүнгийн үед Кайфэн хот руу нийслэлээ нүүлгээд адаг сүүлдээ өмнөд Сүнгийн үед Наньжин, Ханжоуд нийслэлэн суух болцгоожээ. Ханжоу бол тухайн цаг үедээ хятадын хамгийн утга уянга, дуу бүжгээр халгисан нутаг байсан юм. Хэрэв аливаа нэг үндэстэн хөгжингүй гар толгойтой, хүчирхэг нуруу нугасгүй байх юм бол үндэстнүүдийн дундахь сээр нуруугүй нялцгай биетэн болон хувирах болно. Сул дорой Өмнөд Сүн улс эцэс сүүлдээ эрэлхэг дайчин Монголчуудад өөрсдийн хасбуу тамга болон нутаг дэвсгэрээ найр талбин өгөөд зүйл дууссан шүү дээ. Хятадын умард нь хүчирхэг, өмнөд нь сул дорой байдал саяхан болтол үргэлжилсээр өрнөдийн соёлт чонын эдийн засаг, шинжлэх ухаан техник болон үзэл санаа өмнөд хятадад түлхүү нэвтэрсэний үр дүнд тэр байдал үндсээрээ хувьсан өөрчлөгдсөн юм” гээд Чэнь Жэнь уртаар санаа алдав.

Тэр цааш залгуулан өгүүлрүүн “Би заримдаа тэнгэр өөд ширтэн харах бүртээ түүний зөв болохыг ойлгодог юм. Ийм өргөн уудам нутгийг эзлэн суусан ард түмэн хонь мэт сул дорой зан араншинтай байж яахин болох билээ? Ёстой тэнгэр эцгийн нэр сүрийг гутаасан хэрэг болно биз дээ? Тэнгэрийн ёсонд эс нийцэх тул тоглоомноос хасаж шийтгэдэг нь зүй ёсны хэрэг мөн. Сул дорой тариачид тэнгэрийн ёс болон бусдын хатуу харгисыг харааж зүхээд байхын хэрэггүй. Үнэндээ тариачид ч гэсэн өөрсдөө тэнгэрийн ёсны дагуу сул дорой, ургах чадваргүй тариа, ногооны чих, суулгацыг тасдаж тайран хүч тэнхээтэйд нь өсөж ургах боломж олгодог шүү дээ. Гэвч тэнгэр эцэг хятадуудын тоглох эрхийг бүрмөсөн хасчихаагүй юм. Яагаад гэвэл тэд өөрсдийн гар толгойн хүчээр зэрлэг тутрагыг гэршүүлж, торго, цай, шаазан, чий будаг зэргийг буй болгон хүн төрөлхтний соёл иргэншилд дөрвөн их нээлтүүд болох луужин, дарь, цаас болон хэвлэх технологийг хандив болгон өргөсөн. Өрнөдийнхөн чухам л энэ дөрвөн нээлтэнд тулгуурлан дундад зууны харанхуй бүдүүлэг нийгэм болон феодал язгууртнуудын хэрэм цайзыг зад эвдлэн хаяж чадсан. Хятад үндэстэн дэлхийн соёлд иргэншилд оруулсан энэ их хувь нэмрийг дээд тэнгэр хурмастын гэгээн мэлмийгээр болгоон үзээд өөрийн ууган хөвгүүд болох тал нутгийн нүүдэлчдийг илгээн бүтэлгүй тариачин дүүг нь сайтар гөвшүүлэн цээрлүүлж, байн байн цус сэлбэж, ууц нурууг нь бэхжүүлж байсны үр дүнд өдий зэрэгтэй тогтож чадсан ажээ.

Газар тариалан үндэстний зан чанарыг доройтуулан сулруулдаг энэхүү зүй тогтол цаашид ч үүргээ биелүүлсээр ирсэн байна. Хятан улсыг мөхөөсний дараа Их Алтан улс удаж төдөлгүй тэдний араас замнаж эхлэжээ. Алтан улсад газар тариалангийн үйлдвэрлэл оргил үедээ Умард Сүн улсыг даван гарахын хэрээр хүн амын тоо эрс өсөн Алтан улс байгуулагдаж байх үеийн гурван сая өрхөөс дунд хожуу үедээ долоон сая зургаан мянган өрхийн дөчин таван сая хүн амтай болсон гэдэг. Энэ үеэс Алтан улсын үндэстний зан чанар доройтон буурч эхэлжээ” гэв.

Нар баруунаа хүүшлэхэд урьд нь сүрэг чонын зоргоор туучих талбар болж байсан Олонбулгийн уудам талд уулсын сүүдэр сунайж эхлэв. Чэнь Жэнь босож сунайгаад чонын үүр рүү хяламхийн харлаа. Хоньчин байх үед нар хүүшлэхэд чонын аюулаас илүү сэрэмжтэй байхгүй бол болдоггүйсэн. Чонын аюул могойд хатгуулсан сургамжаас илүүтэй хүний сэтгэлд хадагддаг байх нь ээ. Хорь гаруй жил өнгөрчихөөд байхад чонон сүргийг бодонгуут ууц нуруугаар хүйт дааж байдаг байна шүү. Тэр хөл гараа хэд хөдөлгөснөө Ян Көд хандан “Буцахгүй бол цаад Галсмаа тэд нар санаа зовж байгаа” гэв.

Ян Кө бүр түүний ярианы амтанд орж гүйцсэн тул гараа сэгсчээд “Зүгээр дээ, Галсмаа бид хоёрын нэг хуучлаад суучихвал цаг нарыг мартчихдаг гэмтэйг мэдэхгүй биш. Би наашаа гарахдаа өөр айл хунараар ороод ирэхгүй байж магадгүй гээд хэлчихсэн. Чи чинь байтлаа үлгэрч туульч нартай адилхан үйл явдлын хамгийн гоё хэсэг дээр очоод цаашид юу болсоныг маргааш сонсоно уу гэх нь холгүй байх шив дээ. Одоо монголын морьт цэргүүд түүхийн тавцан дээр гарч ирэх болж байна. Би суудлын түшлэгийг буулгачихъя. Хоёулаа хажуулж байгаад ярьцгаая” гэлээ.

Чэнь Жэнь машин дээр гарч хажуулан хэвтэх зуур “Бэлтрэгний үүрний хажууд ярьж байтал нэг л мэдсэн чинь үйл явдалдаа авгчих бололтой юм аа. Чонын үүр надад онгод хайрласан нь лавгай” гэснээ

“Монгол үндэстэн сэргэн мандах үед зөвхөн хятад төдийгүй нийт дэлхий дахины тариаланч үндэстнүүд бүгд үндэстний зан чанарын гүн доройтолд авгчихаад байсан юм. Монголын зуун хорьхон мянган морьт цэрэг европ азийг хөндлөн гулд байлдан эзлэсний үндсэн шалтгаан хоёр зүйлд байдаг.

Нэгдүгээрт: Монголчууд бол дэлхий дээр чонон сүлдээ үнэн сэтгэлээс сүслэн дээдлэж, чоныг өөрсдийн үндэстний шүтээн, өвөг дээдэс, дайны сахиус, тал нутгийг хамгаалагч хэмээн үзсээр ирсэн.

Монголчуудын өвөг дээдсийн дунд Бөртэ чоноос авахуулаад чоно гэсэн нэртэй хүмүүс маш олон байжээ. Тэр ч байтугай чоноор овоглосон бүхэл бүтэн овог байдаг шүү дээ. Тухайлбал чонос овог гэдэг үгийн язгуур нь чоно гэдэг нь ойлгомжтой. Харин “с” үсэг нь олон тооны дагавар болох тухай Юань улсын түүхийг судлаач манай улсын нэртэй эрдэмтэн Хань Ру Линь авгайн дүгнэлт маш зөв зүйтэй юм.

Энэ жишээнээс үзвэл талын хөх чоно монголчуудын зүрх сэтгэлд хичнээн хүндтэй байр суурь эзлэдгийг төвөггүй ойлгож болно. Харин манай хятадуудын дунд чоно гэсэн нэртэй хүн ганц ч байдаггүй. Дэлхийн дахины зүрхийг чичрүүлж байсан Чингис хаан талын чонын дунд төрж өссөн төдийгүй, үнэн хэрэг дээрээ чонон сүлдийн үзэл санаагаар хүмүүжсэн чононоос өөрцгүй эрэмгий баатруудыг захирч байжээ.

Тийм болохоор чонон өвөг, чонон сахиус, чонон багш, чонон бахархалтай монгол үндэстэн насны эцэст чонын амаар дамжин мөнх тэнгэртээ сүнсээ илгээдэг байсан манай дэлхийн эртний хамгийн эрэлхэг дайчин, оюунлаг ард түмэн яахын аргагүй мөн. Харин монголын төмөр морьт цэрэг гэдэг бол дэлхийн хамгийн харгис, хамгийн ухаалаг, хамгийн дайчин монгол талын чонын сургаж бэлтгэсэн арми байсан юм шүү.

Монголын морьт цэргүүд дэлхийн дайдыг дэлт морины туурайгаар дэлдэж байсны өөр нэгэн нууц гэвэл хэдэн мянган жилийн турш газар тариалангийн соёл иргэншил дэлхийн бүхий л тариаланч үндэстнүүдийн зан чанарыг сулруулан атгахын төдий няцрахаар болсон тоор жимс мэт болгосон байлаа. Тэгсэнээр чонон сүлдийн үзэл санаагаар зэвсэглэсэн монголын морьт цэргүүд дэлхий дахинд гайхамшигийг тунхаглан, манай гаригийн түүхэн дэх хамгийн өргөн уудам нутаг дэвсгэртэй улсыг байгуулж чадсан юм.

Газар нутгийн хэмжээгээр Монголын эзэнт гүрний дараа орохуйц том эзэнт гүрнийг байгуулж байсан эртний Ромчууд мөн л чоныг дээдлэх үзэлтэй байсныг нь өнөө хэр Ром хотын сүлд өлөгчин чоно байгаагаас харж болно. Дэлхийн түүхэн дэх хамгийн өргөн уудам нутаг дэвсгэртэй хоёр эзэнт гүрэн бүгд чоныг дээдлэн шүтдэг байсан энэхүү жишээ чонын үзэл санаа хичнээн агуу их үүрэг нөлөөтэй болохыг бэлээхэн харуулам биш үү?

Сул дорой Алтан улс, Өмнөд Сүн улсын мөхөл болоод монголын морьт цэргийн ялалт нь үйлдвэрлэх хүчний их багатай төдийлөн хамааралгүй, харин газар тариалангийн ахуй болон түүнээс үүдэлтэй үндэстний зан чанартай шууд холбоотой юм. Хэрвээ аливаа нэгэн үндэстэн түүхийн хог дээр шидэгдэхгүй хэмээн хүсэх юм бол үндэстний хүчирхэг зан чанарыг төлөвшүүлж байдаг үйлдвэрлэлийн хэлбэр болоод үндэстний ахуйг хадгалан үлдэх хэрэгтэй. Товчоор дүгнэн хэлбэл аливаа үндэстэн өөрийн хатуу чанга үндэстний зан чанарыг төлөвшүүлж чадсан цагт сая өөрийн хувь заяаны жинхэнэ эзэн болж чадна.

Монголчуудын байгуулсан Юань гүрэн дорно өрнийн соёлын солилцоонд маш чухал үүрэг гүйцэтгэсэнээс гадна хятад орон, хятад үндэстний хувьд ч үнэлж баршгүй гавьяа байгуулсан билээ.

Юуны өмнө монголчууд хятадын түүхэнд Хань, Тангийн оргил үед ч байгаагүй өргөн уудам нутаг дэвсгэрийг эргүүлэн авчирч чадсан юм.

Түүнчлэн үндэстний хүчирхэг зан чанарын төлөвшилд дахин нэг удаа цус сэлбэж өгсөн. Үүнийг дараах хэдэн жишээгээр тайлбарлаж болно.

Юуны өмнө монгол үндэстэн хятад нутагт эзэн сууснаар монгол талын нүүдэлчдийн эрэмгий зан төрхийн илрэл болсон бөх барилдах, хурдан морь, сур харваа, ан гөрөө, дуу хуур, том хөлтэй бүсгүйчүүд зэргийг хятадуудад таниулсан.

Хоёрдугаарт: Хубилай зэрэг цөөн тооны хаад язгууртнуудыг<sup>68</sup> эс тооцвол дийлэнх монголчууд тал нутгийн эрэмгий дайчин зан чанараа хадгалж Күнзийн суртхаалд<sup>69</sup> авгалгүй байсан тул хятад даяар Күнзийн суртхаалын хүч нөлөөг ихээхэн сулруулж чадсан юм.

Гуравдугаарт: Аливаа ноёрхогч үндэстэн дарлагдагч үндэстэнд өөрсдийн дадал заншил, зан суртхаалыг тулган хүлээлгэж байдаг зүй тогтолтой. Нөгөө талаас дарлагдагч үндэстэн ч ноёрхогчдын төлөв байдлыг даган дууриах хандлага өргөн байдаг. Энэхүү дээр дороос харилцан нийлсэн хандлагыг би цус сэлбэлт гэсэн хүрээнд оруулаад байгаа юм. Түүнээс гадна үндэстэн хоорондын харилцан ураг барилдах явдал нэмэгдэхийн хэрээр хятад үндэстний цусан дахь зан чанар илт өөрчлөгдөх нь ойлгомжтой.



Дөрөвдүгээрт: Хүн ам цөөнтэй монголчууд дэлхийн хамгийн олон хүн ам бүхий хятад оронд ноёрхлоо тогтоосноор эртнээс нааш омог бардам аашилж, дөрвөн харийнхныг дорд үзсээр ирсэн Хань үндэстэнд ихээхэн цочрол өгсөн байж таарна. Тэр хэрээр хань үндэстэн өөрийн сул дорой зан чанар болон гутамшигт ялагдалдаа ичингүйрч, хятадын шилдэг хөвгүүд охид монгол үндэстний эрэмгий дайчин зан чанараас суралцаж эхэлсэн юм. Мин улсыг байгуулагч Жу Юань Жан бол монголчуудын тэрхүү зан чанарыг ихэд бишрэн дээдлэгч Хань үндэстний хаан байсан юм шүү.

Юань гүрний монгол үндэстэн хятадуудад энэ удаа дахин нэг цусыг сэлбэж өгсөн нь тун их цаг үеэ олсон хэрэг байлаа гэж би хувьдаа боддог. Бүтэн зууны турш үргэлжилсэн харь үндэстний нөлөө болон цус сэлбэлтийн үр дүнд хятад үндэстэн дахин сэргэн босож ирлээ. Юань гүрний сүүлчээр хятадын энд тэндгүй талын чононоос дутахааргүй эрэлхэг зоригтой бослогын удирдагч нар төрөн гарсан нь энэхүү цус сэлбэлтийн шууд үр дүн байлаа.

Монгол үндэстэн хожим нь ялагдан нутаг буцсан нь Сяньби, Хятан, Зөрчдүүдтэй адилхан шалтгаантай байсан юм. Хичнээн хүчирхэг нүүдэлчин үндэстэн байлаа ч гэсэн дэлхийн хамгийн өргөн уудам газар тариалангийн соёл дунд хутгалдан ороод Күнзийн суртлын үзэл санааны дөнгийг зүүчихээр хэдэн үеийн дараа чонын араншин нь сулраад явчих нь ойлгомжтой. Дэлхий дээр хятадын газар тариалангийн талбай хамгийн өргөн уудам болохоор сулруулах хүч нөлөө ч хавьгүй хүчтэй байдаг. Монгол үндэстний дэлхий дээр байгуулсан дөрвөн хаант улсын дотроос Юань гүрэн хамгийн түрүүнд задран мөхсөн нь санамсаргүй хэрэг биш ээ. Хятадын Хань үндэстэнгүүд наян есөн жилийн дараа хамгийн түрүүнд монголчуудыг тал нутаг руу нь хөөж явуулаад 1368 онд Жу Юань Жан хаан Мин улсыг байгуулсан түүхтэй.

Мин улсын Тайзү хаан Жу Юань Жан болон түүний хүү Чэн Зү хаан Жү Ли нар болвоос хятад нутагт төрөн гарсан гарамгай хаадын нэг байлаа. Тэд хятад хүний хувьд ховорхонд тооцогдох чонын араншинтай, эрэмгий зориг, хэрцгий догшин байдал, ухаалаг зан зэрэг нь тал нутгийн орог саарал чоныг өөрийн эрхгүй санагдуулдаг юм. Жу Юань Жан хаан Тан улсын Тайзун хаан лугаа адил цэргүүдийнхээ өмнө дайсны байрлал руу дайран орж тулалддаг байсан гэдэг.

Энэ хоёр гарамгай хааны төрх байдал Умард, Өмнөд Сүн улсын сул дорой хаадуудаас эрс ялгаатай. Хань, Тан улсаас хойшх хятадын хөрс суурин дээр ийм эрэмгий хаад төрөн гарах боломж үнэндээ байгаагүй юм. Монгол үндэстний хүчтэй цус сэлбэлт Жу овогт эцэг хүү хоёр хаанаас гадна, талын чонын араншинг өөртөө шингээсэн Сюй Да, Чан Юй Чүнь зэрэг Хань үндэстний шалгарсан жанжингууд төрөн гарах урьдчилсан нөхцөл болж өгсөн юм. Мин улс оргил үедээ Монголын тал нутгийг эс тооцвол Хань, Тан улсын үеийн газар нутгийг үндсэндээ эргүүлэн авч чадсан байлаа. Энэхүү сэргэн мандалт нь монгол үндэстний сэтгэл харамгүй цус сэлбэлт болон чонон сүлд хятад нутагт дахин амилсаны хүч байсанд бид бүхэн талархах ёстой.

Гэвч зан чанарын хувьд цус сэлбүүлэгч 70 нь цус сэлбэгчээсээ заавал сул дорой байх жамтай байдаг. Анхандаа ер бусын хүчирхэг байсан Мин улс Монголын Умард Юань улсыг ялж чадаагүй юм. Чонын араншинтай тал нутаг монголын төмөр морьт цэргийг төрүүлэн гаргасан эх булаг нь болохоор монголчууд тал нутагтаа эргэн очингуут өөрсдийн эрэлхэг

дайчин хэв шинжиндээ эргэн орж чаджээ. Мин улсын Чэн Зү хаан таван ч удаа монгол руу өөрийн биеэр цэрэглэн халдсан боловч эхний удаагийнхыг эс тооцвол бусад дөрөвт нь олигтой ялалт гэх юм байгуулж чадаагүй билээ. Чоно мэт зальжин монголын морьт цэргийн гол хүч тэднээр даажин хийгээд олдож өгөхгүй байсан гэдэг. Харин ч эсрэгээр монголын морьт цэргүүд Сюй Да жанжингийн цэргийг ялж, Цюй Фүгийн удирдсан зуун мянган их цэргийг хядсан гашуун түүх бий. Хамгийн эмгэнэлтэй нь Төмөр цайзын тулалдаанаар Монголын Эсэн тайшийн удирдсан хорьхон мянган морьт цэрэг Мин улсын таван зуун мянган цэргийг бутцохиж, Ин Зун хааныг олзлон авч явж байлаа. Хэрвээ түүний хариуд цэрэг ард хамтдаа Бээжин хотыг үхэн хатан хамгаалаагүй бол Юань гүрэн дахин сэргэж мэдэхээр нөхцөл байдал үүссэн гэдгийг тэмдэглэхгүй байхын аргагүй. Түүнээс хойш тариаланч үндэстний хонины араншингийн өвчин улам даамжирсаны дээр Сүн, Мингийн ёс зүйн сургаал үндэстний үзэл санааг улам ч үхээнц болгон хувиргасан юм. Тэр байдал улам бүр даамжирсаар цагаан хэрмийн чанад дахь нутаг бэлчээрийг алдаж гүйцээд адаг сүүлд нь Манж Цин улсад мөхөөгдсөн билээ. Хань үндэстэн Юань гүрний үед монголчуудын цус сэлбэлтээр дамжуулан олж авсан жаахан амин хийгээ алдаж гүйцээд хятад соёл иргэншлийн том асрыг аваад явчих тэнхэлгүй болсон үедээ умардын өөр нэгэн нүүдэлчин үндэстэн болох Манж нарт уг хүндтэй үүргийг оноосон ажээ”

Чэнь Жэнь өөрийн бичсэн зүйлсээ эргүүлж тойруулан харсанаа залгуулан өгүүлрүүн “Зөрчидийн Манж угсаатан нарын байгуулсан Цин гүрэн бол хятадын түүхэн дэх чамгүй айхтар улс байсан юм шүү. Тийм ч учраас би Цин гүрний түүхийг ихэд сонирхон таашаадаг. Хэдэн зуухан мянган 71 хүн амтай Манж нар Дайчин гүрнийг 72 байгуулж хэдэн зуун сая хүн ам бүхий хятад орныг бүхэлд нь захирч Монголын Юань гүрний дараа орох өргөн уудам нутгийг эзлэж чаджээ. Энхамгалан, Тэнгэр тэтгэгч хоёр хааны үед зуун хорь гаруй жил үргэлжилсэн амар тайван, цэцэглэлтийн үе нь хятадын аль ч түүхийн зурвас үетэй харьцуулшгүй урт юм. Гэвч манж нар яваандаа хятадын газар тариалангийн соёл болон Күнзийн суртхаалын хүлээсэнд суларч доройтож эхлэх үед өрнөдийн хүчирхэг гүрнүүд аж үйлдвэрийн эрин зуунтай аль хэдийн золгосон байлаа.

Тэгвэл яахаараа өчүүхэн жижиг манж үндэстэн ийм гайхамшигтай том эзэнт гүрнийг байгуулж чадсан хэрэг вэ? Миний санахад эртний түүхэнд гагцхүү манж нар л хятадын мандал буурлын зүй тогтлыг гярхай ажиглаж, газар тариалан болон нүүдлийн соёл иргэншлийн сул давуу талуудыг оновчтой хослуулж чадсан байгаа юм. Тэд өөрсдийн үндэстний зан чанар дах чонын араншин хичнээн чухал үүрэгтэй болохыг сайтар ойлгосон тул хоёр зуу гаруй жилийн турш дорнод азийг эрхшээлдээ байлгаж чаджээ. Хэрвээ чоно адил дайчин давшингуй зан чанар үзэл санаатай байх аваас хятадын соёлыг суралцахад төвөгтэй биш, харин ч түүнийг даван гарч чадна гэж тэд үздэг байв.

Тэд нүүдэлчдийн чонын зан араншинг хадгалахын тулд эрх баригч давхарга нь Сяньби нарын Умард Вэй улс, Хятан, Алтан улс болон Монголын Юань гүрний мөхсөн түүхэн сургамжаас суралцан, тэдний засаглалын уламжлалыг шинэ агуулгаар баяжуулжээ. Тэр нь долоон зүйл бүхий төрийн бодлогоор илэрдэг.

Нэг: Манж нарын харваж намнах, моринд эрэмгий уламжлалыг бүх нийтээр дагаж мөрдүүлэх болов.

Хоёр: Хаан ихэс дээдсийн хамтаар ав хомрогыг тогтмол зохион байгуулдаг байлаа. Энхамгалан хаан л гэхэд тал хээрийн хэдэн зуун чоныг өөрийн гараар авлаж байсан тухай мэдээ түүхэн сурвуулжуудад хадгалагдан үлджээ.

Гурав: Монголын тал болон зүүн хойд болон баруун хойд нутгийн бэлчээр нутгийг дархлан үлдээж, тариачид суурьшихыг хатуу хориглосон юм. Нийт нутаг дэвсгэрийнх нь хувь хэмжээг харьцуулан үзэхэд нүүдлийн мал аж ахуй дийлэнх байсан бөгөөд тэр хэрээр нийт үндэстэнд чонын араншин бүрдүүлэх шимтэй хөрс болж өгчээ.

Дөрөв: Манж монголчуудын ураг барилдахыг бүх талаар дэмждэг атлаа манж хятад хүмүүс гэрлэхийг цаазлан хориглосон журам гаргажээ. Ингэснээр чонын араншинтай цус цэврээр хадгалагдан хонины араншин бүхий цустай холилдохоос сэргийлж чадсан байна. Эртнээс нааш Зөрчид, Монгол хоёр үндэстэн цусан төрлийн ойр холбоотой бөгөөд Манж дайчин улс Монголын хүчирхэг морьт цэргийн хүчийг хэдэн зуун сая хятад үндэстэнг ноёрхох хэрэгсэл болгон ашиглаж байжээ. Ингэснээр манж монгол<sup>73</sup> хоёр үндэстэн хаад ноёдоос эхлээд харц ардын түвшинд хүртэл цусан төрлийн

холбоогоо улам бүр бэхжүүлж байлаа. Алдарт Бумбатай<sup>74</sup> хатан л гэхэд Монгол үндэстний шалгарсан гарамгай эмэгтэй улс төрч байсныг бид мэднэ.

Тав: Улс орон даяар дайн байлдааны гавьяаг ихэд эрхэмлэдэг байсан нь чонын араншинг хадгалахад их тустай байсан нь мэдээж.

Зургаа: Манж нарыг гол цөмөө болгож Монгол, Төвд зэрэг бусад нүүдэлчид лугаа холбоотны харилцаа тогтоон хүн ам олонтой хань үндэстнийг ноёрхох үйл хэрэгтээ ашиглаж байв.

Долоо: Хань үндэстний ямар ч өрсөлдөөнгүй угсаа залгамжлах маягаар хаан ширээнд залрах тогтолцоог халж, ширүүн өрсөлдөөний явцад эрдэм чадал хэтийдсэн нэгнийг хаанд өргөмжилдөг болжээ.

Гэвч өчүүхэн жаахан арлын улс англи наран үл шингэх том нутаг дэвсгэртэй эзэнт гүрэн болж, Москвагийн гүнлэгээс эхтэй Орос орон Ази Европыг тэгнэсэн өргөн уудам нутагтай болсон лугаа харьцуулахын аргагүй боловч, хэрвээ манж нар хүчээ аван гарч ирээгүй бол хятадууд өдийд зүүн гурван муж, Ил Тарвагатай, тэр ч байтугай нийт Шиньжаан, Түвдийг тавиад туучихсан байхыг үгүй гэх газаргүй юм.

Хятадын одоогийн байгаа нутаг дэвсгэр нь Хань үндэстэн зонхилсон Хань төрийн үед эх сууриа тавьж, Сяньби Хань цус холилдсон Тан улсын үед хүрээгээ тэлж, Монгол үндэстний Юань гүрний үед улам өргөжин, Манж дайчин улсын үед батжин хадгалагдаж ирсэн түүхтэй. Эдгээр дөрвөн хүчирхэг гүрэнд нэгэн ижил хэв шинж харагдаж байгаа нь нүүдэлчдийн чононы араншин давамгайлсан байжээ. Харин гагц Хань улсаас бусад тохиолдолд дан нүүдэлчид зонхилон төрийн эрхийг барьж байсан байна.

Түүнчлэн хамгийн гарамгай эмэгтэй улс төрчид болох Хань, Тан улсын Люй Хоу хатан, Ү Зө Тянь хатан болон Цин улсын Бумбатай хатан нар чухам дээрх дөрвөн төр улсын үед төрөн гарсаныг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр гурван гарамгай эмэгтэйчүүд бүгд бие сэтгэлийн хувьд

эрэмдэг шувуун хөлтөнгүүд байгаагүй, харин ч Бумбатай хатан эмэгтэйчүүдийн хөлийг боож өсөлтийг зогсоох харгис үйлдлийг эсэргүүцэгчдийн нэг байсныг хэлэх хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн хөлийг бооно<sup>75</sup> гэдэг нь хятадын түүхэнд гарсан хамгийн хүнлэг бус харгис заншлын нэг бөгөөд Күнзийн суртхаал хамгийн их хүчээ авч байсан Сүн улсын үеэс эхтэйг энд тэмдэглэсү. Күнзийн суртхаал нь хятад үндэстнийг оюун санааны хувьд номхон хонь болгон хувиргаад зогсохгүй, хань үндэстний бүсгүйчүүдийг ч эрэмдэг доголлон хонь болгож байсан бэлээхэн жишээ энэ юм.

Манж нар дотор газрыг эзлэн сууснаар таван мянган жилийн түүхтэй эртний хятадын түүхэнд цэг тавьсан билээ. Хятадын эртний түүх нүүдэлчин гаралтай Яньхуанчууд төр барьж эхлээд нүүдэлчин угсааны манж нар төр барьсанаар дуусаж байгаа нь санамсаргүй хэрэг биш харин ч хятадын өвөрмөц нөхцөл байдал болон хоёр үндэстний түүхэн хөгжлийн зүй ёсны үзэгдэл юм. Хятадын газар тариалангийн соёл иргэншил хэмээх энэхүү салаа урсгал нүүдэлчдийн дахин дахин цус сэлбэж байсны хүчинд дэлхийн соёл иргэншлийн голдрил лугаа эргэн нийлж чадсан байна. Харин энэхүү түүхэн баримт бидэнд үндэстний соёл иргэншлийг урсгалтай зүйрлэвээс түүний ундрага нь үндэстний зан чанар байдаг юм шүү гэсэн хатуу үнэнийг ухааруулж байгаа юм. Хүчирхэг зан араншингүй үндэстэн өөрийн соёл иргэншлийг бүтээн буй болгож чадах боловч тэр бүтээсэн соёл иргэншил байтугай өөрийгөө ч хамгаалах чадваргүй болж хоцордог байна. Дэлхийн болоод Хятадын эртний соёл иргэншлүүдийн олонх нь түүхийн үзмэрийн тавцан дээр хэвтэж байхад нүүдэлчдийн чононоос өөрцгүй дайчин давшингүй үзэл санаа болон зан чанар урьдын адил амьдрах чадвараа хадгалсаар өөр олон олон эртний соёл иргэншлүүдийг түүхийн үзмэрийн санд илгээсээр байгаа юм.

Товчоор дүгнэн хэлэх юм бол дэлхийн соёл иргэншлүүдийн өрсөлдөөн гэдэг бол үнэн хэрэг дээрээ үндэстний зан чанарын өрсөлдөөн юм шүү дээ. Өрнөдийнхний дэвшилтэт ардчилсан тогтолцоо болон шинжлэх ухаан техник нь тэдний дайчин давшингүй үндэстний зан чанарын суурин дээр байгуулагдсан. Хятад үндэстэн хэрвээ тэднийг гүйцье хэмээвээс газар тариалангийн үндэстний ахуй болон газар тариалангийн үндэстний зан чанарыг өөрчлөхөөс эхлэх хэрэгтэй.

Би нүүдэлчдийн чонон сүлдийн самаар хятадын түүхчид Күнзийн үзэл санааг баримтлан зориуд самууруулаад хаячихсан хятадын түүхийг цэгцлэн самнах гэж оролдоод үзлээ. Чонон сүлдийг гол цөмөө болгосон нүүдэлчдийн үзэл санаа болон хятад үндэстэнд байнга цус сэлбэж байсан түүх нь дэлхий дээр яагаад гагцхүү хятадын соёл иргэншлийн түүх тасалдалгүй өдий хүрсэн бэ гэдгийн нууцыг тайлаад зогсохгүй, хятад улс цаашид үсрэнгүй хөгжихийн нууц ч чухам энэ чонон сүлдийн үзэл санаанд байж болох юм шүү.

Гэвч чонон сүлдийн үзэл санааг ойлгож ашиглана гэдэг туйлын амаргүй хэрэг. Түүний өмнө нүүдэлчид чухам яахаараа чонон сүлдийг дээдлэн шүтэж байдгийн учрыг тодруулах хэрэгтэй. Хятадын түүхчид бараг бүгдээрээ шахам нүүдэлчид чонон сүлдийг шүтдэг гэдгийг мэддэг боловч яагаад шүтэж байгаа юм гэдэг асуултын хариултыг хэлж мэддэггүй. Тухайлбал монгол судлаач нэрт эрдэмтэн Хань Ру Линь авгай бээр бичихдээ: Түрэгчүүд өөрсдийгөө чононоос гаралтай болохоор бусад үндэстнээс давуутай хэмээн үздэг. Тэр нь ямар учиртайг бүү мэд боловч ямар ч байсан Гүчан хаан түүгээр их бахархдаг байжээ гэсэн байдаг. Түүний

цаад учрыг мэдэхгүй байгаагийн шалтгаан гэвэл Хань үндэстэн тал нутгаас холдон хөндийрөөд, чонон сүлдийн тухай ойлгоц нь дэндүү явцуурсанд л байгаа юм. Зарим чухал хүнд сэдвийг албан тасалгаанд суучихаад шийднэ гэж байхгүй л дээ. Чи бид хоёр монголын буурал талд арав гаруй жил амьдрахдаа сониучирхал, эргэлзээ тээнэгэлзэлдээ хөтлөгдөн монголын чонотой ойр дөт харьцаж байсны хүчинд хятад хүмүүсийн дээрх явцуурлыг гэтлэж чадсан байж таарна. Одоо хоёулаа өөрсдийн ойлгож мэдсэн зүйлсээ хятад хүмүүстээ хэлж өгөөд тэдний ойлгоцын талаарх алдаа эндүүг засаж чадсан цагт сая үндэстний зан чанарын асар том гажиг тэгширэх боломжтой юм” гэхэд

Ян Кө санаа алдаад “Хэрвээ чиний наад онол чинь батлагдвал хятадын хорин дөрвөн төрийн түүхийг дахин шинээр бичих хэрэг гарч мэдэх юм шүү. Күнзийн суртхаалтангуудын бичсэн түүх бичлэгт өрөөсгөл, нэг талыг барьсан зүйл мундахгүй их байж таарна. Тийм болохоор сайн муу нь хамаа алга түүхийг дахин шинээр бичих тал дээр би чамтай ижил санаа бодолтой байна” гэлээ.

“Хатуухан хэлэх юм бол түүхийн үнэн мөнийг сэргээх асуудал л даа. Хятадын эртний соёл нь газар тариалан, Күнзийн суртхаалыг дээдлэж, нүүдэлчин гаралтай дөрвөн харийнхныг үгүйсгэхэд чиглэгдэж ирсэн. Тийм болохоор хятадын түүхийг шинээр бичээд зогсохгүй, түүх бичлэгт хувьсгал гаргах цаг болсон. Би Лян Ци Чао авгайн бичсэн “Шинэ түүх судлал ба хятадын хуучин түүх бичлэг” өгүүллийг хувьдаа маш их олзуурхан хүлээж авсан шүү. Түүнд өгүүлэхдээ: Түүх бичлэгт эргэлт хийхгүй бол манай улс цаашид авралгүй болно. Бидний өмнө тулгараад байгаа олон олон асуудлын дундаас энэ л хамгийн том нь байж магадгүй гэсэн байгаа юм даа. Миний санахад чоныг түүхийн салбар руу оруулахгүй бол, хятадын түүхэнд асар их нөлөө бүхий чонон сүлдийн үзэл санааг түүх бичлэгт нэвтрүүлэхгүйгээр манай улсын түүхийн салбар өмхий тогтоол ус чигээр хоцорч хорин дөрвөн төрийн түүх Күнзийн суртхаалт мулгуу оточ нарын хятад өвчнийг ташаа оношлосон өвчний зузаан түүх болон үлдэх юм. Ингэснээр хятадыг зөв оношилж, өөрчлөх асуудлыг хойш чангаасаар байх болно. Одоо манай нийгэмд жижиг тариачны ухамсар болон Күнзийн феодалын тогтолцоог сурталчилсан түүхэн олон ангит кинонууд тасралтгүй хөвөрсөөр байгаа нь ямар сэтгэл шимширмээр эмгэнэлтэй хэрэг билээ” гэсэнээ

Чэнь Жэнь тал нутгийн шингэх нарыг хараад өлсөж ундаассан шинжгүй цааш өгүүлрүүн “Би энд хятад үндэстний оюун санааны асуудлыг хөндөлгүй орхиж боломгүй санагдана. Одоо хүн болгон л шахам хятад үндэстний оюун санаа гэж ярьдаг боловч түүний уг сурвалж бодит мөн чанар нь Яньхуанчуудын нүүдэлчний оюун санаа, талын үзэл санаанаас эхтэй гэдгийг тэр болгон мэддэггүй. Түүний гол цөм нь чонон сүлдийн үзэл санаа бөгөөд хэдэн мянган жилийн турш нүүдэлчид тасралтгүй зөөвөрлөн нөхвөрлөж байсны үндэс суурин дээр тогтсон хэрэг шүү дээ. . . . .

Хэрвээ дундадын нийгмийн оюун санаан дахь нүүдэлчдээс гаралтай чонон сүлдийн үзлийг аваад хаячихвал чухам юу үлдэх билээ? Үлдэж хоцрох нь Сүн, Мин улсын үеийн ёс зүйн үзэл л биз дээ? Одоогийн нийгэмд хэн л байтлаа гурван хэлхээ, таван ашид, гурван эвэргүү, дөрвөн эрхэм суртал зэргийг хятад үндэстний оюун санаа болгон тунхаглаа аж дээ? Дундадын оюун санаа гэдэг бол үнэн хэрэг дээрээ хятад нутаг дээр хамтран аж төрж байсан нүүдэлчин, тариаланч үндэстний хамтын бүтээл бөгөөд тэр дундаа нүүдэлчний ухамсар,

чонон сүлдийн үзэл түүний амин сүнс нь байгаа юм.

Тийм болохоор бид тал нутгийн үндэстнүүд нийт дундад үндэстэнд үзүүлсэн аугаа хувь нэмрийг зөв ойлгон үнэлж, талын чоно, талын үндэстэнгүүдээс суралцах хэрэгтэй. Тэр хэрээр тал нутаг, талын чоно, талын хүмүүст хамгийн том хариуг барих цаг болсон” гэхэд

“Одоо чинь том хариу барих нь байтугай тал нутгийн баялгийг булаан дээрэмдэж, буруу зөрүү удирдаж байгааг засаж залруулж чадахгүй байхад чинь. . “ хэмээн Ян Кө уурсангуй өгүүлэв.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Миний санахад хятадын уламжлалт Күнзийн суртхаал болон соёлд нэг зэвүү хүрмээр зүйл байдаг нь юу гэвээс нүүдэлчдийн хятад үндэстэн болон соёл иргэншилд оруулсан хувь нэмрүүдийг ор мөргүй үгүйсгэдэг явдал юм. Хятадын эртний соёл иргэншил хичнээн давуу талтай, Күнзийн суртхаалын агуу их амьдрах чадвартай, дэлхийн бусад гурван том соёл иргэншил бүгд дампууран унасан байхад хятадын соёл иргэншил өнөөг хүртэл хөгжин дэгжсээр ирсэн гэж хөөрцөглөхийг бид сонсохоороо нэг болсон. Гэвч үнэн хэрэг дээрээ хятадын түүхийн таван мянган жилийн хөгжлийн явцаас харахад хятадын соёл иргэншил өнөөг хүрсэний гол нууц нь нүүдэлчин үндэстэнгүүд байнга цус сэлбэж байсантай салшгүй холбоотой байдаг шүү дээ. Харин нүүдэлчдийн амь насны үнэ цэнэтэй дүйцэхүйц цус сэлбэлтийн гавьяаг үгүйсгэнэ гэдэг тун хуншгүй хэрэг. Энэ үзэл амь бөхтэй оршсоор байх юм бол жижиг тариачны ухамсар болоод Күнзийн суртхаалыг шүүмжлэх эрч хүчийг сулруулан, тэр хэрээр хятад үндэстний зан чанар оюун санааг доройтуулан сулруулж хятад өвчинг даамжруулах талтай юм.

Шинэ хятад улс байгуулагдсанаас хойш улсыг засах чиг бодлогын хувьд зөв жорыг олж, газар тариалангийн өвчнийг шийдвэртэй эмчлэх тал дээр хүч тавих нь байтугай харин ч газар тариалангийн байр суурь, соёлыг дээдлэн тариачин гаралтай боловсон хүчнийг дэвшүүлэн гаргах болсон. Тэр ч байтугай соёлын хувьсгалын үед хотын сэхээтнүүдийг хөдөө тосгон руу хомроглон хөөж явуулсанаар жижиг тариачны үзэл хот хөдөөгүй дэлгэрэх хандлагатай болжээ.

Зуу зуун жилийн турш хятад өвчин байн байн сэдэрч, түүнийг эмчилж засах гэсэн оролдлогууд бүтэлгүйтэж ирсэний үндсэн шалтгаан нь хятад үндэстний зан чанарыг өнөө болтол өөрчилж чадаагүйд байгаа юм. Тийм ч учраас өнөө хэр манай хятад үндэстэн өөрийн хувь заяаг баттай зөв залах шатандаа хүрч чадаагүй байна.

Харин сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд амаргүй замыг туулж ирсэн өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд хятад оронд өрсөлдөөн бүхий зах зээлийн эдийн засаг бүрэлдэн тогтож, үндэстний ахуй өөрчлөгдөж эхлэлээ. Үндэстний ахуй зан чанараа тодорхойлдог зүй тогтлын дагуу хүчирхэг чиглэл рүү хөгжих чиг хандлага ажиглагдаж байна. Хятадуудын зан чанар чонон сүлдийн үзэл санаа руу эргэж байгааг “Том саарал чоно” хүүхдийн сэтгүүл багачуудын таашаалыг хүлээж, “Умардын чоно” дуу хятадын хаа сайгүй эгшиглэн, чоно нэрийн бараа бүтээгдхүүн зах зээл дээр эрэлттэй борлуулагдан, чоно гэсэн хаягтай дэлгүүр зоогийн газрууд ашигтай ажиллаж байгаа зэргээс харж болох юм. Дэлхий дээр чононоос хамгийн их айдаг байсан үндэстэн чоныг хүндлэх үзэлтэй болж эхэлж байгаа нь хорь гаруй жилийн өөрчлөлт шинэчлэлтийн хамгийн чухал ололтын нэг мөн. Хятад үндэстэн сэргэн

мандахын найдлага чухам энд байгааг дурьдах хэрэгтэй.

Чонон сүлдийн үзэл санаа хонины үзлийг ялан дийлэгч учраас гагцхүү түүнийг бадраан тунхаглаж чадваас манай өөрчлөлт шинэчлэлт ухралтгүй урагшлан хөгжих болно. Хятадын шинэчлэлтийн бодлого зөвхөн улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг хамраад зогсохгүй, үндэстний зан чанарын хувьсгалыг өөрийн шийдвэрлэх гол агуулгаа болгох учиртай” гэхэд

Ян Кө өгүүлрүүн “Чи ч мөн айхтар ухаж төнхсөн байна шүү. Чонон сүлд хэмээх энэхүү үзэл суртлын зэвсэг тал нутагт дарагдан үлдээд байсныг ухан гаргаж ирээд үзэхэд өчүүхэн ч зэвэрч өнгөө алдаагүй байдаг байна. Түүнчлэн эрт балрын чонон сүлд өдгөөгийн дэлхий дахины хамгийн дэвшилттэй оюун санааны эрдэнэсийн санд ч гэсэн өнгө гэрлээ гайхуулсаар байтал харин Күнзийн гурван хэлхээ таван ашдын үзэл ялзарч муудчихаад хэвтэж байдаг. . . .” гэснээ цааш нь өгүүлрүүн “Үндэстний ахуй үндэстний зан чанарыг тодорхойлдог гэсэн наад үзэл чинь түгээмэл чанартай юу?” хэмээн асуулаа.

Чэнь Жэнь хариуд нь “Түгээмэл байлгүй яахав. Тухайлбал япончуудын үндэсний ахуй тун айхтар шүү дээ. Цаадуул чинь урьд нь тутрага энэ тэрийг тариалдаг байсан нь үнэн. Гэхдээ Япон бол арлын улс болохоор япончууд эртнээс нааш далайн үндэстэн байсаар ирсэн. Загас агнуур, далайн аялал, далайн худалдаа байтугай далайн дээрмийг ч хийж байсан гэдэг. Энэхүү үндэстний ахуй нь тэднийг далайн чоно болгон хувиргасан юм. Тэгээд хуурай газрын баахан хонин дунд орохоор юу болох билээ? Тэд эрт дээр үед Наньжин, Ханжоуг эзлэж байсан төдийгүй Юань гүрний далайн хүчирхэг флотыг бутцохисон удаатай. Орчин үеийн өрнөдийн хүчирхэг чоно хүрч ирэнгүүт тэд азиас холдон европ хэмээх сүрэг чонын сүрэгт нэгдэн орсон. Тэгсэнээр хятадын Күнзийн суртхаалыг таягдан хаяад өрнөдийн соёл иргэншил, хууль цааз, шинжлэх ухаан, боловсрол, аж үйлдвэрийн технологи зэргийг сурах болжээ. Япончууд өрнөдийн боловсролыг суралцахад үндэстний зан чанарын саад бэрхшээл гэх юм үгүй байсанд амжилтынх нь гол учиг байгаа юм. 1868 онд японы Гэгээн засагч тэнгэрлиг эзэн хаан шинэчлэлийн бодлогоо 76 тунхаглаад гучин зургаан жил болоход хүчирхэг аж үйлдвэрийн бааз суурийг байгуулан Манж Дайчин улс, Цагаан хаант Орос улсуудыг дараалан ялж, дэлхийн хүчирхэг гүрнүүдийн эгнээнд элсэн орсоноо тунхагласан. Гэтэл Гэгээн засагчийн шинэчлэлээс хойш бараг бүтэн хагас шахам зууны хугацаа өнгөрчихөөд байхад манай хятад улс хөгжиж байгаа улсын байр суурин дээрээ хэвээр, Тайванийг нэгтгэж чадаагүй, хүн ам тутамд оногдох үндэсний нийт бүтээгдхүүн болон боловсролд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээгээр дэлхийд хойноосоо жагссаар байна. Хөрөнгө оруулалтын үр ашигийн үзүүлэлт ч мөн хойгуур байр эзлэдгийн зэрэгцээ, шинжлэх ухаан техникийн түвшингийн хувьд Нобелийн шагналтан ганц ч байхгүй, цөлжилт, хөрсний усны доошлолт зэрэг нь эдийн засгийн өсөлтөөсөө хол түрүүлээд явчихсаны зэрэгцээ хэдэн зуун сая тариачид жил болгон хэдэн арван саяараа өсөж үржсээр байна. Хятадын сул дорой хөл бөмбөгчид япон чоно, их туйлт 77 бар зэрэгт яаж хонь шиг ноолуулж байгааг чи бид харж байгаа шүү дээ. . . .

Мянга гаруй жилийн турш хятадууд Күнзийн суртхаалын хонин судраараа япон чоно хэмээх шавиа сургах гээд айлын хүүхдийг баллах шахаж билээ. Япончууд хятадын Күнзийн суртлаар замнаад мянга гаруй жил болоход дэлхий дахинд дуудах нэргүй дуурсах алдаргүй шахам байсан. Харин өрнөдийн далайн чононуудаас гуч гаруйхан жил суралцаад ёстой тэнгэрээр

дүүлэхийг үзүүлж өгсөн. Хятад яасан бэ гэхээр өрнөдийн шинэ соёл орж ирэнгүүт чоно үзсэн хонинууд шиг сайн мууг нь ч тэнсэж үзэх юм байхгүй нийт үндэстнээрээ гадуурхаж, хаанаасаа харц ардыг хүртэл хажиглан тэмцсээр эцэс сүүлдээ хагас колони орон болоод дууссан шүү дээ.

Япон Хятад хоёр адилхан азийн, Күнзийн суртхаал Буддын шашинтай орнууд байсан атлаа яахаараа японы шинэчлэл маш хурдан хугацаанд амжилт олж, харин хятадын шинэчлэл зуу гаруйхан өдөр хэрэгжсэн болоод дампуурдаг билээ? Үндэстний ахуй, зан чанарыг нь ухаж төнхөх юм бол хятадууд хэзээ ч өөрийн үндэстний хувь заяагаа зөв жолоодож чадахгүй” гэв.

“Тэгвэл яахаараа Түрэг, Монгол, Араб зэрэг гурван том нүүдэлчин үндэстэнгүүд бүгд сулран доройтсон хэрэг вэ?” хэмээн Ян Кө толгой сэгсрэн асуулаа.

“Араб, Түрэг үндэстнүүд хожим нь газар тариалан эрхлэх болсон. Харин монгол үндэстний тухайд гэвэл нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлсээр байсан боловч түүхийн голдрил галт зэвсгийн эрин үе рүү шилжин орсон дээр хүн ам хэт цөөтэй учраас хятад орос хэмээх хоёр том гүрний дунд хавчуулагдан түгжигдэж хоцорсон юм. Тал нутгийн нүүдлийн мал аж ахуй илүү хөгжингүй далайн үе шат руугаа орж амжихаас өмнө илүү харгис хүчирхэг далайн нүүдэлчин үндэстний зан чанарт ялагджээ. Үндэстний зан чанар үндэстний хувь заяаг шийднэ гэдэг чинь энэ юм л даа. Түүнчлэн хүчирхэг үндэстний зан чанар эргээд үндэстний ахуйдаа нөлөөлдөг байна.

Орос улсын сэргэн мандсан түүх ч үүнийг батлан харуулдаг. Петр хаан газар тариаланг голлосон хятадаас ч хоцрогдсон бүдүүлэг хамжлагын орос орныг хувирган өөрчлөөд Европын хүчирхэг улсуудын нэг болгож чадсан. Гол учир нь Петр хаан чоно адил харгис хэрцгийгээр хуучинсаг хоцрогдсон хамжлагын эздийн хүчийг мохоож, өрнөдөөс зоримог суралцан тэнгис далайд гарцтай болгосон билээ. Ямар сайндаа энгийн хүний дүрээр европын улсуудаар аялан, сахлаа хусаж, костюм өмсөн, хиймэл үс тавьж, тэнгисийн флот байгуулан, сүмийн хонхнуудыг хайлуулж их буу цутгуулж байхав дээ. Оросын нийслэлийг газар тариалангийн бүс нутгаас нүүлгэж далайн эрэг дээр Санкт Петербург хотыг байгуулсан түүхтэй. Би тэр омог сүрийг бодох бүртээ сэтгэл маань их догдолдог юм. Соёлын хувьсгалын өмнө би “Их Хаан Петр”, “Адмирал Ушаков” зэрэг кинонуудыг тав зургаан удаа үзсэн байх аа. Би тал нутагт очсон хойноо талын хөх чонын биенээс Петр хааны зан чанарын уг сурвалжийг олж харсан юм. Оросын удам талд амьдарч байсан Орос үндэстэн угаасаа газар тариаланд тааруухан нүүдэлчин үндэстэн байсан. Түүнээс гадна Оросууд Алтан ордны хаант улсын үед хоёр зууны турш монголчуудын ноёрхол цус сэлбэлтийг амссан хүмүүс. Хэрвээ тал нутаг болон талын чоно байгаагүй бол Аугаа их Петр хаан яахин төрөх билээ дээ?

Энэ хоёр хоцрогдсон бүдүүлэг хөршүүд маань чонын араншингийн хүчээр хожим хятадын толгой дээр сууж чадсан юм даа” хэмээн Чэнь Жэнь хариулав.

“Чи ч угаас улс орон ард түмнийхээ төлөө санаа тавьж явдаг хүн л дээ. Харин чи энэ олон жилийн ажиглалт судалгааныхаа ажлын эцэст ямар дүгнэлтэнд хүрээд байна вэ?” хэмээн Ян Кө асуулаа.

Чэнь Жэнь хариуд нь “Миний гуч гаруй жилийн судалгааны ажлын гол зорилт бол хятадын



хоцрогдол өвчний урхагийг тогтоож, хөгжлийн гарцыг олох явдал байлаа. Одоо нэгэнт таван мянга гаруй жил үргэлжилсэн хятадын архаг хууч өвчний урхагийг олж тогтоосон болохоор тохирох жороор эмчлэн улс үндэстнийхээ хувь заяаг зөв залах л үлдээд байна даа” гэлээ.

Юуны өмнө хятадын хоцрогдол арчаагүй байдлыг өөрчлөн, хятад үндэстний ахуйг эдийн засаг, улс төрийн хувьд өрсөлдөх чадвар бүхий үндэстний ахуй болгон хувиргаж дайчин давшингуй, байдалдаа сэтгэл ханадаггүй үндэстний зан чанарыг аль болохуйц хурдан төлөвшүүлэх хэрэгтэй байна.

Түүний удаад үндэстний зан чанарын хувьд соёлтой чонын замыг тууштай хэрэгжүүлэх нь хэдийгээр амар хялбар бус боловч зайлшгүй шаардлага болон тулгарч байна. Чонын араншин гэдэг нь харгис, эрэмгий, амьдрах чадвар сайтай атлаа сувьдаг, эзлэмхий, эвдэн бусниулах хүчээр дүүрэн байдаг юм. Хүний зан чанар дахь чонын араншин халуун цөмийн урвал мэт асар их энергийг агуулж байдаг болохоор эвдэн бусниулах хүч нь ч мөн тийм хэмжээтэй байж таарна. Харин тэр их хүчийг зөв зүйтэй залж удирдаж чадваас хүн төрөлхтөнд ач тусаа харамгүй хүртээн, буруу тийш залвал гариг ертөнцийн сүйрэлд ч хүргэж мэднэ. Дэлхий дээр тоотой хэдхэн үндэстэн л энэ энергийг эрхшээн залж жолоодож чадсаны үндсэн дээр хүчирхэг улс гүрнийг байгуулах боломжтой болж байжээ. Гэхдээ энэ зам харгуй асар их бартаа саадтай болохоор орчин үеийн хүчирхэг улс гүрэн ч гэсэн осолдож мэдэх аюултай юм. Дэлхийн хоёрдугаар дайны үед Герман, Япон, Итали гурван улс үндэстнийхээ чонын араншинг зөв залж чадаагүйн улмаас фашист тэсрэлтэд өртөн өөрийн үндэстэн төдийгүй, дэлхий дахинд хичнээн ноцтой хор хохирол учруулсаныг бид мэднэ.

Хятадын соёлын хувьсгал ч гэсэн томоохон асуудалтай тулгарч байсан. Түүхийн явцад, ялангуяа шинэ түүхийн эхэн үед хятад үндэстний зан чанарт чонон араншин дутмаг, сул дорой учраас өрнөдийн хүчирхэг гүрнүүдэд гутамшигтайгаар бутцохигдон хагас колонийн дарлалд орж байсан удаатай. Хятад үндэстэн түүнд бухимдан дургүйцэж шилдэг тэргүүний хэсэг нь өрнөдөөс дайчин давшингуй үзэл санаа, өрсөлдөөн бүхий өрнөдийн аж үйлдвэр зэргийг оруулж ирсэнээр хятад үндэстний цусанд нуугдаж байсан чонон араншингийн үлдэгдэл сэргэж үндэстний зан чанарын хувьд хүчирхэгжиж эхэлжээ. Зуун жилийн тэмцлийн үр дүнд өрнөдийн хүчирхэг гүрнүүдийг нутаг орноосоо хөөн зайлуулж, үндэстний тусгаар тогтнолоо олж, солонгосын дайнд ялж чадсан. Гэвч соёлын хувьсгалын үеэр зарим нэгэн улс төрчид чонон араншинг санаатайгаар хэт дэвэргэсний улмаас буруу чонон араншинд идэгдэж гүйцсэн улаан хамгаалагчид улсын удирдагчид, маршал, жанжин, үйлдвэр худалдааны элитүүд, соёл, боловсрол урлагийн томоохон төлөөллүүдийг алж хядан, гутаан доромжилж, эцэг эх, багш захирлыгаа хүртэл, шүүмжлэн зодож, ном хэвлэлийг шатаан, соёлын дурсгалт зүйлсийг эвдлэн сүйтгэж, нэг үгээр хэлбэл хэт туйлширсан адал балмад хэргүүд үйлдэж байсны улмаас улс орон даяар маш том гай гамшиг учирч билээ.

Нийт хүн төрөлхтний болон хятадын дээр өгүүлсэн зурвас түүхийн үйл явц юуг харуулж байна вэ гэхээр хүмүүний зан чанарт байгаа чонын араншинг залж жолоодно гэдэг туйлын амаргүй хэрэг байдаг ажээ. Хятадын Күнзийн суртхаалтангууд болон феодал эзэд хүмүүний араншин дахь чонын араншинг үгүй болгох гэж оролдсоноор үндэстний зан чанар хонь шиг номхон хүлцэнгүй болж гүйцдэг бол, фашистууд шиг чонын араншинг хэт дэвэргэх юм бол дэлхий тэр чигээрээ амьдын там болон хувирахад ойрхон очдог байна. Чонон араншингийн

энергийг зохистой ашиглан түүнийг оновчтой зөв залж жолоодож чаддаг жинхэнэ ардчилсан хууль цаазат тогтолцоог хэрэгжүүлэх нь хятад үндэстний цаашдын хөгжлийн цорын ганц зөв зам мөн билээ. Жинхэнэ ардчилсан хууль цаазат тогтолцоо бол чонын араншин хэмээх “халуун цөмийн урвалыг” зөв залж жолоодож чаддаг байна. Харин жинхэнэ ардчиллыг тогтоохын тулд үндэстний зан чанарыг түүнд бэлтгэх хэрэгтэй бөгөөд тэгж чадаагүй тохиолдолд ардчиллын оосор бүчгүй орд цагаан өргөөг цогцлоож чадлаа ч гэсэн хэзээ мөдгүй нурж мэдэх аюултай юм. Хэрвээ тэр байгуулсан өргөө нь нурчихвал ардчиллын нэр хүнд ноцтой сэвгэн, түүний оронд харин ч урьд өмнөхөөс илүү чанга хатуу дэглэм тогтож мэднэ. Тийм болохоор үндэстний зан чанарыг зөв тийш нь багтай хувирган өөрчилж чадаагүй тохиолдолд ардчилал гээч нь хятадын цөөхөн хүмүүсийн хүрээн дэх өнө мөнхийн мөрөөдөл төдийхөн болон үлдэх нь тодорхой. Хэрвээ ардчилал, үндэстний зан чанарын хувьсгалын үйл хэргийг алгуурлаваас үндэстний өнөөгийн зан чанар дахь хууч өвчин авилгал, үргүй зардал, хүн амын хэт олшрол, хүрээлэн буй орчныг сүйтгэх зэрэг вирусуудыг улам бүр халдаасаар цаг алдалгүй эмчлэх боломжийг бүрмөсөн алдагдуулж ч мэдэх юм” хэмээн өгүүлэхэд

Ян Кө толгой дохиод “Тийм л дээ. Өрнөдийн үндэстний зан чанар маш хүчирхэг болохоор хатуу чанга диктатураар тэднийг захирна гэдэг амаргүй. Хятад маягийн төвлөрсөн удирдах тогтолцоо тэнд хол явахгүй гэдэг нь ойлгомжтой. Тийм болохоор тэд ардчиллыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болжээ. Харин дорно зүгийн хонь эрх чөлөө, тусгаар байдлаас хамгийн их айдаг шүү дээ. Сюй Жоу мужийн хоньчин<sup>78</sup> байхгүй бол хонин сүрэг чононд баригдчих вий гэж айдаг тул сул дорой тариаланч үндэстэн бүгд л диктатурыг сонгодог байна. Тийм болохоор хятад үндэстний үндэстний ахуй болон үндэстний зан чанар өөрчлөгдөхгүйгээр хятадын төвлөрсөн засаглал хэзээ ч хувьсан өөрчлөгдөхгүй байх аа” гэлээ.

Чэнь Жэнь өгүүлрүүн “Чонын араншин сул дорой үндэстэн хэзээ ч ардчиллыг сонгон түүнийг хэрэгжүүлж чадахгүй. Үнэн хэрэг дээрээ ардчилал гэдэг бол хүчирхэг үндэстнүүд ноёрхогчдыг эсэргүүцэн үнэ хаялцан наймаалцсаны үр дүн юм шүү дээ. Сурсан юмыг сураар боож болдоггүй гэлцдэг. Манай хятадад тариачин хүн ам хэт олон, хотжилтын орон зай бага болохоор хятад хонийг соёлтой чоно болгон хувиргана гэдэг маш төвөгтэй урт удаан хугацааны үйл явц болж таарна. Тийм болохоор цаашдаа манай улс төрийн тогтолцооны өөрчлөлт үндэстний зан чанарын сул дорой байдлыг даван туулахад чиглэгдэж байвал сайнсан. Эдгээр төвөгтэй асуудлыг гагцхүү гандан бууршгүй хүчирхэг чонон сүлдийн үзэл санаанд тулгуурлан явуулах хэрэгтэй гэсэн дүгнэлтэнд би хүрсэн юм даа” гээд гол яриагаа дуусгав.

\* \* \*

Олонбулгийн буурал талыг харуй бүрий нөмрөөд малчдын сууриуд цахилгаан гэрлээ асаасан нь холоос бүдэг бадаг жирвэлзэнэ. Ян Кө өөр юм асуух гэтэл Чэнь Жэнь жолоогоо зөөлөн цохиод “Харихгүй бол цаад Бат чинь мотоциклтойгоо бидний араас давхиад ирэх болно шүү. Чи бид хоёр Бээжин хүртэл ганзага нийлэх улс чинь юу эсийг ярьж амжихгүй байх билээ дээ?” гэхэд

Ян Кө өгүүлрүүн “Эргээд бодоход чонон сүлд болоод нүүдэлчний оюун санаа дундадын соёл иргэншилд үнэхээр том үүрэг гүйцэтгэж шүү. Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэлцдэг. Чамаас асуух өөр зүйл мөн ч их байна даа” гэлээ.

Тэр хоёр машинаас буугаад Хар чулуут уулын чонын үүр рүү гар даллан салах ёс хийсэн атлаа явчихаж чадалгүй удтал зогсоор байв. “Бэлтрэг минь, би Бээжин рүүгээ явья даа. Гэхдээ би дахин өөр дээр чинь эргэж ирэх болно” хэмээн Чэнь Жэнь амандаа сүслэн шивэгнэв.

“Хоёулаа бэлтрэгнийхээ үүрэн дээр дурсгалын самбар, сүлдэт багана босгох юмсан” хэмээн Ян Кө хэлэв.

Чэнь Жэнь хариуд нь “Надад ч гэсэн тийм бодол байсан боловч харамсалтай нь тал нутагт цагаач иргэд дэндүү олширсон болохоор бэлтрэгний маань дурсгалын самбарыг яаж тэсгээв гэж дээ? Аягүй бол энэ хэдэн зуун жилийн настай хуучин чонын үүрийг ч баллаад өгөхөө мэдэх байлгүй. Тийм болохоор байгалийн зүйл байгаагаараа үлдсэн нь дээр. Харин хүн бүрийн сэтгэлд чонон сүлдэт багана сүндэрлэн босоосой билээ” хэмээн өгүүлжээ.

\* \* \*

2002 оны хавар Бат, Галсмаа хоёр Олонбулгийн талаас Чэнь Жэньтэй утсаар ярихдаа: “Олонбулаг сумын нийт нутаг бэлчээрийн ная гаруй хувь нь цөлжсөн тул хойтон жилээс эхлэн бүх малыг өвөл зунгүй хашиж тэжээх шийдвэр гарсан нь хятадын дотор газрын тариачдын мал тэжээдгээс өөрцгүй хэрэг болж байна. Тийм болохоор айл болгон хонь малаа хаших хэдэн эгнээ байшин сав барьж эхлэлээ. . . . . ” гэхэд Чэнь Жэньд үнэндээ хэлэх үг олдсонгүй.

Хэдхэн хоногийн дараа цонхны цаана тэнгэрт тулам шар түйрэн босоод өдрийн наран үзэгдэхээ болив. Хятад үндэстний хааны нийслэл Бээжин хот шар будангийн дунд харагдахаа байгаад амьтан хүн амьсгалахын аргагүй шахам болж хахаж цацацгаана.

Чэнь Жэнь компьютерийн өмнөөс холдон цонхны өмнө зогсоод умард зүгийг удтал ширтлээ. Чонон сүрэг түүхийн нугачаанд бүдгэрч, тал нутаг дурсамж төдийхөн болон хоцроод нүүдэлчний соёл иргэншил ч бүрмөсөн замхран алга болж байна. Тэр ч байтугай монгол талын чонон сүргийн Өвөрмонгол дахь сүүлчийн ул мөр болох эртнээс улбаатай бэлтрэгний үүр нь хүртэл шар түйрэнд дайрагдан үгүй болох цаг хаяанд тулан ирсэн нь энэ ажгуу.

*2003 оны өвөл Бээжин хот*

## Тайлбар

1 Хятадын эртний Хань улсын үеийн мэргэн чинсан Жү Гө Лян хэдэн түмэн дайсны цэрэг хот руу нь дайрах үед эсэргүүцэх чадваргүй цөөхөн цэрэгтэй байжээ. Тэгээд тэр хэрмийн бүх хаалгыг нээж орхичихоод харуулын цамхаг дээр пиипаа хөгжим тоглож байхыг харсан дайснууд нь ямар нэгэн уран арга сэдсэн байж мэдэх юм гээд буцаж явсан лугаа жишин өгүүлжээ

2 Заарцаг гэдэг нь загасан сүрэг гэсэн утгатай. Орч

3 Соёлын хувьсгалын үеэр хятад даяар хорин сая гаруй оюутан залуусыг хөдөө тосгон руу тариачдын хүнд хүчир ажилд туслуулахаар явуулж байсан удаатай. Чэнь Жэнь нарын залуус өвөрмонголын талд мөн л энэ шугамаар очсон боловч хувь тавилан нь манай илгээлтийн эзэдтэй нэлээд төстэй учраас ийм нэр оноов. Орч.

4 Юэ Фэй гэж нүүдэлчин гаралтай Хятанчуудтай тулалдаж явсан Сүн улсын цэргийн нэрт жанжин.

5 Хав загас халиун хөхөч шувуу лугаа ноцолдсоор далайн хөвөөнд салж чадахгүй болсон байхад загасчин өвгөн таараад олз омог дүүрэн харьсан гэдэг хятадын эртний домгийг хөнджээ. Орч

6 Газар хэмээх хятадын уртын хэмжүүр. Ойролцоогоор хагас километр орчим. Орч

7 Унжиж хөлдсөн мөс. Орч

8 Эртний түрэг үг. Чоно хэмээх утгатай.

9 Хүннүд элчээр очин тэндээ олон жил суурьшин амьдарсан Хань улсын элч. Орч.

10 Хүлчин гэж нэгэн зүйл, сайн талын хий биет амьтан. Орч.

11 Хятад ханзаар атом, бөөрөнхий гэдэг хоёр үсэг ижил дуудлагатай өөр бичлэгтэй байдаг. Өвгөн түүнийг андууран сонсчээ. Орч.

12 Хятадын эртний гучин арга гэж байдаг. Барсыг уулнаас холдуулах, гархи холбох буюу гоо бүсгүйн арга, хоосон хотын арга . . . гэх мэт. Өнөө цагт ч гэсэн хятад, япон, солонгос зэрэг зүүн азийн улс орнуудын улс төрч, бизнесмэнүүд энэ аргын тухай уран сайхнаар өгүүлсэн “Гурван улсын үлгэр” нэрт бүтээлийг өөрийн ширээний ном болгосон байдаг. Орч

13 Энэ нь “Барын үүрэнд эс орвоос бамбарыг нь яахин барих вэ?” гэсэн хятад зүйр үгийг хувирган хэлжээ. Орч

14 Сохор муур үхсэн хулганатай таарах гэсэн хятад зүйр үг байдаг. Манай тэнгэрийн умдаг атгах гэсэнтэй санаа дүйцэх юм. Тэр зүйр үгийг энд шилжсэн утгаар хэрэглэжээ. Орч

15 Нэгэн үеийн тэнгэрийн бахархал Чингис хаан харвах намнахаас өөрийг мэдэхгүй гэсэн

Мао Зэ Дунгийн үгийг тойруу замаар хэрэглэжээ. Орч

16 Нэг мүн нь хааш хаашаа арван метртэй тэнцэнэ.

17 Чонын тэжээж өсгөсөн нялх хүүхдийг ийн нэрлэдэг. Орч.

18 Газар гэдэг нь хятадаар ли буюу 465 метртэй тэнцэх уртын хэмжүүрийн нэгж. Орч.

19 Хүйтэн уулын бичээс зохиол дээр гардаг ах дүү хоёрын нэр. Дүү Ү Сун өндөр сүрлэг гоолиг биетэй баатар эр бол түүний ах Ү Да Лан намхан, бөгтөр хүн байсан тухай гардаг.

20 Халуун ногооны амт үнэрийг ийн нэрлэдэг. Орч.

21 Хятадад яг ийм зүйр үг байдаг. Орч

22 Өмнөд Хүннүгийн хаанд богтлогдон очсон хятадын хааны ордны татвар эм. Хятадын түүхэн дэхь дөрвөн алдартай гоо бүсгүйн тэргүүн гэгддэг. Орч.

23 Бар унасан хүн бууж болдоггүй гэсэн хятад зүйр үгийг хувиргажээ. Аливаа том үйлийг эхлүүлсэн хүн буцаж няцах аргагүй гэсэн утгатай юм. Орч.

24 Тан улсын үеийн хатан хаан. Хятадын түүхэн дэх цорын ганц хатан хаан гэгддэг. Орч.

25 Зосыг бараадвал улайна, бэхэнд ойр байвал харлана гэсэн хятад зүйр үгийг хувирган хэлжээ. Орч.

26 Хятадын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч, хятадын Горький ч гэж нэрлэгддэг алдарт зохиолч. Орч.

27 Хараагүй хүн сохор морь уначихаад харанхуй шөнө гүн хөвийг чиглэх гэсэн хятадын зүйр үгийг хувиргажээ. Орч.

28 Цөөвөр чонын өөр нэр. Орч.

29 Зарим хүний үхэл хун галууны өд шиг хөнгөн байхад заримынх нь үхэл Тайшань уулнаас ч хүнд хэмээх хятадын зүйр үгийг хувирган хэрэглэжээ. Орч

30 Түр курсээр бэлтгэгдсэн орон нутгийн эмч. Орч.

31 Хятадын гэж ойлгож болно. Орч

32 Хэв дундад ёс гэдэг нь Күнзийн суртлын ухагдхуун. Аливаа зүйлийн голыг олж замнахыг сургадаг. Орч.

33 Хаан түшмэд, эцэг үр, эхнэр нөхрийг төрийн гурван хэлхээ гэж үздэг. Орч.

34 Хятадын алдартай дуучин, монгол ардын уртын дууг сурч, түүнээс суралцан өөрийн

бүтээлдээ хэрэглэдэг. Жаахан шарга зэрэг монгол ардын уртын дууг чадварлаг дуулна. Орч.

35 Энэ уг нь оюун ухаанаа дээд түвшинд хөгжүүлж чадсанаар тэнгэр болон сансрын оюун ухаантай харьцаж болно гэж үздэг дияаны ухагдхуун юм.

36 Дунгуо ноён чоно хоёр гэдэг хятад ардын үлгэрийн баатар. Уг үлгэрт Дунгуо нэртэй нэгэн эр амьдралын туршлагагүй, номын хэнээтэйгээс болоод чононд хууртан амиа алдах шахсан тухай өгүүлдэг. Орч.

37 Тан улсын Тайзун хаан. Орч.

38 Хүн болгон хүүгээ луу болгохыг хүсдэг гэсэн хятад зүйр үг байдаг. Цаад санаа нь хаан эзэн болгох гэсэн утгатай. Орч.

39 Тухайн үед улс төрийн хэрэгтний хүүхдийг ийн нэрлэдэг байжээ. Орч.

40 Лю Бэй бол хятадын Гурван улсын үеийн Шү ханлигийн эзэн хаан юм. Анх Сүй Жоу мужийн захирагч байжээ. Мү гэдэг хэргэм нь адгуулагч, маллагч гэсэн утгатай. Манай монгол хэлний дарлах, дарангуйлах, дарах гэсэн язгуураас үүдэлтэй дарга гэдэг үг нь одоо шилжсэн утгаар хэрэглэгдэж байгаатай ижил юм.

41 Тан улсыг үүсгэн байгуулсан хаан. Тан улс нь хятадын түүхэнд хамгийн өргөн уудам нутгийг хамарсан хүчирхэг улс байсан бөгөөд түүний түрүү үеийн хаадуудын эх нь бүгд нүүдэлчин гаралтай хүмүүс байсан гэдгийг нотлох гэж зохиолч энэ ишлэлийг татжээ. Орч.

42 Аруухан баатар гэдэг нь хосгүй баатар гэсэн утгатай үг. Орч.

43 Тухайн үед хот газрын ажилчдын дундаж цалин сардаа 20-30 юань байсан. Орч.

44 Галсмаа хятад хэлэнд тааруухан болохоор “Сонгинотой хонины махан хуушуур” гэхийг ийм хазгай дуудлагатай хэлсэн байна. Орч.

45 Гурван нас хүрч яваа мөндөлгүй эм тарвага. Орч.

46 Мөндөлтэй эм тарвага. Орч.

47 Ян Гао гэдэг нь хурга гэсэн утгатай үг. Орч.

48 Авгай гэдэг нь Күнзийн суртхаалаар гүн боловсорсон төгс хүмүүний нэрийдэл юм. Орч.

49 Энэ мэдээ нь манай улсын сүүлийн үеийн археологийн олдворуудтай яв цав нийцэж байгаа нь анхаарал татаж байна. Орч.

50 Шар мөрний үерээс хамгаалах даланг удирдан байгуулсан эртний түүхт хүн. Орч.

51 Хятадууд өнөө хэр Шар мөрөнгөө ээж гол гэж хүндлэн нэрлэдэг. Орч.

- 52 Таван махбодын онолоор төмөр нь баруун зүгт харьяалагддаг. Орч
- 53 Цагаан нохой гэсэн үг. Орч
- 54 Цагаан чоно гэсэн утгатай. Орч
- 55 Өнөөгийн хятадууд өөрсдийгөө Яньхуаний үр хойчис гэж нэрийдэх нь олонтоо. Орч
- 56 Хятадаар 单于
- 57 Хятадаар 撑梨孤涂单于
- 58 Дундад гэдэг нь Зөвлөлт гэдэгтэй адил хятадын 56 үндэстнийг бүгдийг хамруулан хэлдэг нэрийдэл юм. Орч
- 59 Дотор газар гэдэг нь хятадын уугуул газар нутгийг хамардаг ойлголт юм. Орч
- 60 Зохиолч энэ номондоо цус сэлбэлт гэдэг үгийг маш олонтоо хэрэглэсэн байгаа. Юань гүрний үед арван хятад өрхийн дунд нэг монгол даргач суулгаад монгол эхнэр нь хоол хийх үеэр хутга заазуур хятад айлуудад хэрэглүүлээд хурааж авдаг. Тэр даргалдаг арван айлын нас бие гүйцсэн охин хадамд гарахын өмнө гурван шөнө монгол даргачын “хоноод явдаг” байсан тухай хятадын сул түүхчдийн тэмдэглэлд бичээстэй байдаг. Мөн монгол даргачийн эхнэрийг “Галын Бурхан” хэмээн тухайн үед нэрийддэг байжээ. Өнөө хэр хятадын галын Бурханы хөрөг нь монгол дээлтэй эмэгтэйгээр дүрслэгддэг юм. Энэ “цус сэлбэлтийн” уламжлал бүр Сяньби зэрэг түрүү үеийн нүүдэлчдээс улбаатай болох нь тус номыг уншиж байх явцад аяндаа ойлгогдоно. Орч
- 61 Энэ Тан улс нь МЭ-ний 7-10 дугаар зууны үед оршиж байсан Тан улсаас бүр өмнөх ханлигийн нэр юм. Хятадын 24 төр улсын түүхэнд өмнөх ханлигуудын нэрийг хожуу үеийн улсууд зээлдэн авч байсан нь олонтоо. Орч
- 62 Өнөөгийн Хань үндэстний өвөг дээдэс. Орч
- 63 Энэ Сүн улс ч гэсэн бидний мэдэх Юань гүрний мөхөөсөн Сүн улсаас хавьгүй өмнө оршиж байсан ханлиг болохыг анхаарна уу. Орч
- 64 МЭӨ хятадын анхны нэгдмэл төр улс. Орч
- 65 Ху гэдэг нь хятадаар зэрлэг, бүдүүлэг гэсэн утгатай тухайн үеийн нийт нүүдэлчин үндэстний ерөнхий нэрийдэл юм. Орч
- 66 Зүүн зүгийн зэрлэгүүд гэсэн утгатай. Орч
- 67 Тан улсын Тайзун хааны хайртай үзэсгэлэнт хатан, хятадын эртний дөрвөн гоо бүсгүйн нэг гэгддэг. Орч
- 68 Хубилай хаан үйл ажиллагааныхаа эхэн үед Күнзийн суртхаалыг нэвтрүүлэхээр оролдож

байснаа 1270-аад оны дунд үеэс Буддын соёл тэр дундаа Төвдийн Сажагийн урсгалыг шүтэж, үйл ажиллагааныхаа мөрдлөг болгож ирсэн. Орч

69 Үүний тодорхой жишээ нь нийт улсын иргэдийг монгол, хотон, умард хятад, өмнөд хятад хэмээн дөрөв зэрэглэхийн сацуу ажил мэргэжлийн хувьд найм хуваасны хамгийн дээд нь малчин. . . ., долоод нь янхан эм, наймд нь Күнзийн суртхаалтныг оруулж байсан тухай хятадын сул түүхэн олонтоо тэмдэглэсэн байдаг. Орч

70 Германы хятад судлаач Гюрен хэмээх хатагтай Зян Рун зохиолчийн цус сэлбэлт гэдэг ойлголт нь германы хувьд фашист хандлагын илрэл хэмээн тооцогдоно гэж мэдэгдсэн нь хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг хэсэг шуугих шалтаг болсон. Орч

71 Манж нар анх хүчээ авч эхлэх үедээ зургаан зуун мянган хүн амтай байсан гэж хятадын түүхчид үздэг. Орч

72 Дайчин гэдэг нь хятадаар Их ариун улс гэсэн утгатай. Орч

73 Хятадууд “Манж Монгол хоёр амь нэгтэй” хэмээн ярьж бичдэг. Орч

74 Хятадаар Сяо Жуан буюу Бумбатай хатан бол Энхамгалан хааны эмэг эх, Амбагай сэцэн хааны хатан байжээ. Манжийн түрүү үед монгол хатад хааны ордонд өндөр дээд эрх ямбатай байсны бодит жишээ бол Бумбатай хатан юм. 25 дугаар телевизээр гарсан Тайваний Монгол хатны домог кинонд түүний үйл амьдралын тухай тодорхой тусган харуулсан байдаг.

75 Хятадын эртний дөрвөн гоо бүсгүйн нэг болох Си Шы жижиг хөлтэй байсан нь сүүлд эмэгтэй хүний гоо сайхны гол хэмжүүрийн нэг болсон юм. Түүнээс улбаалаад бүсгүйчүүдийн хөлийг боож жижигсгэх заншил дэлгэрчээ. Гурван настай охин хүүхдийг өндөр сандалд суулган хөлийнх магнайг дотогш нугалан боосоор тавхайтайгаа нийлэхэд өсөлт нь бүрэн зогсдог байжээ. Гэвч энэ хатуу харгис үйлдэл наанадаж хоёр сарын турш тасралтгүй үргэлжилнэ гэхээр жаахан хүүхдийг хичнээн их тамлан зовоодог байсан нь ойлгомжтой. Орч

76 Манайхан Мэйжигийн шинэчлэл гэдэг нэрээр нь сайн мэднэ. Орч

77 Өмнөд солонгосын төрийн далбааны хос загасыг ийнхүү нэрлэдэг. Орч

78 Энэ нь Гурван улсын үеийн Шү улсын хаан Лю Бэйгийн хуучин хэргэм зэрэг юм. Сюй Жоугийн захирагч гэсэн далд утгатай. Орч